



**МОНГОЛ УЛСЫН ТӨР,
ЭРХ ЗҮЙН ТҮҮХ**

/МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе/

ТЭРГҮҮН БОТЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
УЛААНБААТАР ЭРДЭМ СУДЛАЛ ДЭЭД СУРГУУЛЬ

Их Монгол Улс байгуулагдсаны
800 жилийн ойд зориулав

ИШИЙН ДАШНЯМ

МОНГОЛ УЛСЫН ТӨР, ЭРХ ЗҮЙН ТҮҮХ

Тэргүүн боть
/МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе/



ХАННС

ЗАЙДЕЛИЙН

САН

Редактор: Ж.Амарсанаа /Академич /
Ж.Болдбаатар /Академич /
О.Амархүү /Доктор (Sc.D) /
Ц.Сарангуяа /Доктор (Ph.D)/
Б.Баярсайхан /Доктор (Ph.D)/

УЛААНБААТАР ХОТ
2005 он

DDC
342'09'517
Д - 395

**“Монгол улсын төр, эрх зүйн түүх”
зохиолын редакцийн зөвлөл**

Ж.Амарсанаа Академич /Зөвлөлийн дарга/

С.Нарангэрэл Академич

Б.Чимид Монгол Улсын гавьяат хуульч, доктор

Ж.Болдбаатар Академич

Н.Лүндэндорж Доктор /Sc.D/

О.Амархүү Доктор /Sc.D/

Ц.Сарантуяа Доктор /Ph.D/

Г.Баярхүү Доктор /Ph.D/

Б.Баярсайхан Доктор /Ph.D/



ХУУЛЬ ТОГТООМЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

2002 оны 8 дугаар
сарын 14 -ны өдөр

Дугаар 45/1

Утас: 976-11-315734
Факс: 976-11-315735

УЛААНБААТАР ЭРДЭМ СУДЛАЛ ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДОКТОР, ПРОФЕССОР И.ДАШНЯМ ТАНАА

Бүтээлийн захиалга өгөх тухай

Таныг Монгол Улсын төр, эрх түүхийг олон жил дагнан судалж буй томоохон эрдэмтэн гэдгийг мэдэх билээ.


Та, Монгол Улсын төр, эрх зүйн түүхээр өргөн цар хүрээтэй судалгааны ажил явуулж, их дээд сургуульд тасралтгүй лекц уншин, олон арван бүтээл туурвиж, Монгол Улсын төр, эрх зүйн түүхийг хууль зүйн шинжлэх ухааны тэргүүлэх салбарын түвшинд гарган манлайлж, олон сайхан эрдэмтдийг төрүүлсэнд Тань монголын хуульчид гүнээ талархаж байна.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хөгжлийн үзэл баримтлалын үзэл санааг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын төр, эрх зүйн түүхийн асуудлыг нэгтгэн бичиж, иргэд, хуульчид, оюутан, судлаачид болон гадаадын иргэд, судлаачдын хэрэгцээнд зориулан бүтээн гаргах нэн шаардлагатай байна.

Монгол Улсын төр, эрх зүйн түүх нь Монголчуудын бүтээсэн соёлын их өвийн агуу том хэсэг мөн. Монгол овогтон хүн бүр монгол төр, монгол хууль цаазынхаа 2000 гаруй жилийн түүхийг гүнээ мэдэж, түүний буурал уламжлалаар бахархаж, мөн түүнээс суралцаж, мэдлэг олж авч бас хойч үедээ өвлүүлэн үлдээхийг хүсч байдаг бөлгөө. Монголын залуучууд үндэснийхээ төр, эрх зүйн хөгжиж ирсэн түүхийг гүнзгий мэдэж байхыг хүсч байна. Эл аугаа их соёл тэдэнд туйлын их хэрэгтэй байна. Тэд Монголын эртний Хүннү гүрэн, Чингис, түүний залгамжлагчдын Их Монгол улс, Монгол Юан гүрний төр, хууль уламжлал, бидний өвөг дээдсийн бүтээсэн Евразийн их соёл, тусгаар тогтносон бүрэн эрхт Монгол Улсын төр, хууль цаазын түүх, монгол үндэстний төрийн зүтгэлтнүүд, цэргийн жанжнууд, төрийн түшээнүүдийн баатарлаг замнал, гавъяа зүтгэл, монгол төр, хууль цаазын эрхэмсэг ёсон, монгол заншлын ариун нандин эрх, монголчуудаас биеэ засаж, өрхөө тэгшилж, төрөө мандуулж ирсэн түүхэн үнэнийг мэдэхийг хичээнгүйлэн хүсч байна.

Иймд хүндэт эрдэмтэн багш Танд "Монгол улсын төр, эрх зүйн түүх" бүрэн хэмжээний зохиол туурвихыг санал болгож, нийгмийн захиалга хэмээн өргөн барьж, асар их итгэл найдвар тавьж байна. Бидний захиалгыг бүрэн биелүүлж чадна гэдэгт эргэлзэхгүй байна.

Таныг гүнээ хүндэтгэсэн;



ЗАХИРАЛ

АКАДЕМИЧ Ж.АМАРСАНАА

ГАРЧИГ

Мялаалгын үг	8
Оршил	10
Удиртгал	11
ТЭРГҮҮН АНГИ	21
Монгол нутагт үүсэн тогтнож байсан эртний улсуудын төр, эрх зүй (МЭӨ III-МЭ XII зууны эхэн)	22
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Эртний улсууд, тэдгээрийн төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, судалгаа, шинжилгээний бүтээл	22
§1. Эртний улсуудын товчоон	22
§2. Эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, судалгааны тойм	25
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Хүннү улсын төр, эрх зүй /МЭӨ III-МЭ 93/	32
§1. Хүннү улсын оршин тогтнохуй	32
§2. Хүннү улсын гадаад харилцаа	39
§3. Хүннү улсын төрийн байгуулал	42
§4. Хүннү улсын цэргийн зохион байгуулалт	54
§5. Хүннү улсын эрх зүй	56
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Сяньби, Муюн, Тоба, Тогоон улсын төр эрх зүй /156-235/	60
§1. Сяньбийн түүх, удам угсаа	60
§2. Сяньбийн төрийн байгуулал	64
§3. Сяньбийн цэргийн зохион байгуулалт	67
§4. Сяньбийн эрх зүй	68
§5. Муюн улсын төр, эрх зүй /285-410/	69
§6. Тоба улсын төр, эрх зүй /313-581/	71
§7. Ухуанийн төр, эрх зүй	76
§8. Тогоон улсын төр, эрх зүй /IY зууны эхээс YIII зууны эцэс/	78
ДӨРӨВДҮРГЭЭР БҮЛЭГ. Жужан улсын төр, эрх зүй /МЭ 330-555/	81
§1. Жужан улс байгуулагдсан нь	81
§2. Жужан улсын гадаад харилцаа	86
§3. Жужан улсын төрийн байгуулал	88
§4. Жужан улсын эрх зүй	83
ТАВДУГААР БҮЛЭГ. Монгол нутагт оршин тогтнож байсан Түрэг угсааны хаант улсуудын төр, эрх зүй	96
§1. Түрүү Түрэгийн хаант улс /552-630/	96
§2. Түрэгийн хожуу хаант улс /YII зууны 90-ээд оноос 745/	98

§3. Түрэг улсын төрийн байгуулал	104
§4. Түрэг улсын эрх зүй	108
§5. Уйгурын хаант улсын төр, эрх зүй /745-840/	108
§6. Хиргисийн хаант улсын төр, эрх зүй /818-900 оны орчим/	114
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. Хятан гүрний төр, эрх зүй (МЭ 917-1125)	118
§1. Хятан нарын удам угсаа, аймгийн холбоо	118
§2. Хятан гүрэн	120
§3. Хятан гүрний төрийн байгуулал	126
§4. Хятан гүрний эрх зүй	130
§5. Хар Хятан улс /1132-1212/	131
Тэргүүн ангийн тайлбар зүүлт	134
Тэргүүн ангийн түүхэн он цагийн хэлхээс	147
Тэргүүн ангийн ном зүй	152
ДЭД АНГИ	159
IX-XII зууны үеийн монгол ханлиг, аймаг	160
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. IX-XII зууны үеийн монгол ханлиг, аймгуудын түүхийн сурвалж, бичиг, судалгааны зохиол	160
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Монгол угсаатны гарал, аймгууд	164
§1. Монгол угсаатны удам гарал	164
§2. Монголчуудын аймгийн холбоо	168
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монголын ханлиг /хант/ улс, аймгийн холбоод	170
§1. Хамаг Монголын хант улс	170
§2. Татарын холбоо	177
§3. Хэрэйдийн хант улс	179
§4. Найманы хант улс	182
§5. Бусад холбоо, аймгууд	184
Дэд ангийн тайлбар зүүлт	192
Дэд ангийн түүхэн он цагийн хэлхээс	203
Дэд ангийн ном зүй	206
ГУТГААР АНГИ	211
Монголын нэгдсэн улсын төр, эрх зүй /1206-1227/	212
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, судалгааны зохиол	212

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь, түүний дотоод, гадаад бодлого	222
§1. Монголын нэгдсэн улс байгуулагдахын урьдач нөхцөл	222
§2. Монголын нэгдсэн улсыг байгуулсан үе шат, үйл явц	225
§3. Монголын нэгдсэн улс байгуулсныг тунхагласан нь	230
§4. Монголын нэгдсэн улсын дотоод бодлого	235
§5. Монголын нэгдсэн улсын гадаад бодлого	244
§6. Монголын нэгдсэн улсын гадаад харилцаа	259
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Монголын нэгдсэн улсын төрийн байгуулал	270
§1. Төрийн хэлбэр ба улсын хаан	270
§2. Их хуралдай	277
§3. Сэцэдийн зөвлөл	280
§4. Засаг захиргааны хуваарь	282
§5. Түшмэдийн тогтолцоо	289
§6. Цэргийн зохион байгуулалт, стратеги тактик	300
§7. Төрийн бэлэгдэл	307
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Монголын нэгдсэн улсын эрх зүй	312
§1. Монголын нэгдсэн улсын эрх зүйн үүсэл хөгжил	312
§2. “Их засаг” хэмээх нэрийн тухайд өгүүлэх нь	319
§ 3. “Их засаг” хууль батлагдсан цаг хугацааны тухай	322
§ 4. “Их засаг” хуулийн судлагдсан байдал	325
§ 5. “Их засаг” хуулийн бүтэц	333
§ 6. “Их засаг” хуулийн агуулга уламжлагдах шинж	336
Гутгаар ангийн тайлбар зүүлт	366
Гутгаар ангийн түүхэн он цагийн хэлхээс	382
Гутгаар ангийн ном зүй	385
ДӨТГӨӨР АНГИ	393
Чингисийн дараахь үеийн Их монгол улсын төр, эрх зүй /1227-1260/	394
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Чингисийн дараахь үеийн Их Монгол улсын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, судалгааны зохиол	394
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Өгөдэйн хаанчлалын үеийн Их монгол улсын төр, эрх зүй /1227-1241/	400
§1. Өгөдэй хаанд өргөмжлөгдөж төр барьсан нь	400
§2. Өгөдэйн хаанчлалын үеийн Их монгол улсын төрийн байгуулал	404
§3. Өгөдэйн хаанчлалын үеийн төрийн дотоод бодлого	412
§4. Өгөдэй хааны гадаад бодлого, гадаад харилцаа	420
§5. Өгөдэйн хаанчлалын үеийн Их монгол улсын эрх зүй	427

ГУРАВДУГААР БҮЛЭГ. Гүюгийн хаанчлалын үеийн Их монгол улсын төр, эрх зүй /1246-1251/	436
§1. Гүюг хаанд өргөмжлөгдөж төр барьсан нь	436
§2. Гүюгийн хаанчлалын үеийн Их монгол улсын төрийн байгуулал	441
§3. Гүюгийн хаанчлалын төрийн дотоод, гадаад бодлого	444
§4. Гүюгийн хаанчлалын үеийн Их монгол улсын эрх зүй	450
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Мөнхийн хаанчлалын үеийн төр, эрх зүй /1251-1259/	456
§1. Мөнх хаанд өргөмжлөгдөж, төр барьсан нь	456
§2. Мөнхийн хаанчлалын үеийн Их монгол улсын төрийн байгуулал	462
§3. Мөнх хааны дотоод бодлого	466
§4. Мөнхийн гадаад бодлого, гадаад харилцаа	470
§5. Мөнхийн хаанчлалын үеийн Их монгол улсын эрх зүй	473
Дөтгөөр ангийн тайлбар, зүүлт	480
Дөтгөөр ангийн түүхэн он цагийн хэлхээс	487
Дөтгөөр ангийн ном зүй	490
ТАВДУГААР АНГИ	495
Чингис хааны түүхэн гавъяа, дэлхий дахинд үзүүлсэн нөлөө	496
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Сурвалж бичиг, судалгааны зохиол	496
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Чингис хааны үзэл баримтлал, түүхэн гавъяа	502
§1. Чингис хааны улс төрийн үзэл бүрэлдэн төлөвшсөн нь	502
§2. Чингис хаан-Их монгол улсын төр, эрх зүйн үзэл, онолыг боловсруулаж хэрэгжүүлэгч	509
§3. Чингис хаан-Евразийн соёлыг бүтээсэн суу билэгтэн	515
§4. Чингис хааны түүхэн гавъяа	518
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Чингис хаан, Монголын эзэнт гүрний дэлхий дахинд үзүүлсэн нөлөө	528
Тавдугаар ангийн ном зүй	543



МЯЛААЛГЫН ҮГ

МУИС-ийн 1967-1968 оны хичээлийн жил эхэллээ. Шинэхэн оюутан бидэнд юм бүхэн сонин содон. Анх Нийслэл хотноо хөл тавьсан хөдөөгийн жулдрай хүү надад хэцүү, шантармаар үе ч тохиолдож байв. Манай ангийн их зонхи нь ажиллаж байгаад ирсэн, ажил амьдралын хашрууд. Бид ангийн ахлагчаар МХЗЭ-ийн Төв Хорооны боловсон хүчний тасгийн эрхлэгчээр ажиллаж байсан, ЗХУ-д комсомолын сургууль төгссөн 30 шахам насны Дашням хэмээх бор залууг сонголоо.

Тэрээр аливаад нягт нямбай, хий нь гарсан, шаггүй сайн орос хэлтэй, эхнээсээ л ангийн бидэндээ түшиг тулгуур болж эхэлсэн юм. Дашням улирал тутам онц сурсаар Сүхбаатарын цалинтай болов. Мөн удалгүй нөхөр маань МУИС-ын оюутны зөвлөлийн даргаар сонгогдлоо.

Бид үе мултрам насны зөрөөтэй байсан учир эхэн үедээ гуайлж байснаа сүүлдээ “Хашрууд” маань оюутны амьдралд орж, насны зөрөө арилан, чи, би дээ хүрсээр сүүлдээ би ч Дашням хэмээн томрох болсон юм.

1971 онд бид МУИС-ийг дүүргэж түүхч, түүхийн багшийн диплом өвөртлөн томилогдсон ажилдаа орцгоолоо. Дашням бид хоёр сургуулиа “Онц” дүнтэй төгсөж, би Түүхийн тэнхимд багшаар, нөхөр маань Хууль зүйн тэнхимд багшаар үлдсэн юм. Тэрбээр мэргэжлийн бус ангид “төр, эрх зүйн үндэс”, мэргэжлийн ангид “БНМАУ-ын төр, эрх зүйн түүх”-ийн хичээл зааж багшлах ажлын гараагаа эхэлсэн билээ. Ингэж Дашням маань түүхч, хуульч хос мэргэжил эзэмшсэн түүхтэй.

Тэр цагаас хойш төрөлх сургуульдаа багш, тэнхимийн эрхлэгч, МАХН-ын хорооны нарийн бичгийн дарга, Хууль зүйн сургуулийн захирал зэрэг алба хашиж, сургуулийн эрдмийн “тогоонд” 34 жил чанагдсан хугацаа бол түүний авьяас оюуны аргамж алдуурсан он жилүүд байлаа. Хуулийн болон бусад мэргэжлийн ангид хичээл зааж, мянга мянган шавь нартаа нэр хүндтэй багш, сурган хүмүүжүүлэгч, манай орны хууль зүйн шинжлэх ухааны нэртэй эрдэмтдийн нэг болжээ. Түүний хууль зүйн ухааны доктор (Ph.D), доктор (Sc) хамгаалсан бүтээлүүд нь нийтийн хүртээл болж, олон мянган шавь нарынхаа билэг ухааныг ирлэсээр байна.

И.Дашнямыг Монголын төр, эрх зүйн түүхийн толгойлох эрдэмтэн хэмээн зүй ёсоор хүлээн зөвшөөрөх ёстой. Үүний тодын тод нотолгоо нь уншигч Танаа өдгөө толилуулан буй “Монгол Улсын төр, эрх зүйн түүх” хэмээх дөрвөн боть зохиол болой. Монгол улсын хууль тогтоомж, Шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл сурталчилгааны үндэсний төвийн захиалгаар бичиж буй эл олон боть зохиол нь Монгол Улсын төр, эрх зүйн 2000 гаруй жилийн түүхийг бүхэлд нь багтаасан асар том бүтээл болно.

Зохиолын эхний буюу тэргүүн боть нь Монгол нутагт төр ёс үүссэн эрт дээр цагаас дэлхийн талыг эзэгнэсэн их гүрэн байгуулан, дэлхий дахин монголоор “амьсгалж” байсан үе буюу 1480 жилийн түүхийг хамарч байна. Монголын эртний улсууд, Чингис хааны байгуулсан Монголын Нэгдсэн улс, Их эзэнт гүрэн, Түүний дараах их хаад-Өгөдэй, Гүюг, Мөнхийн хаанчлалын үеийн төр, эрх зүйн түүхийг өргөн дэлгэрээр бүтээж, баримтыг баримтаар яриулан нотолж, төр, эрх зүйн онолын хууль, категориудыг удирдлага болгон нутгай гаргалгаа, дүгнэлт хийсэн судалгааны дорвитой бүтээл юм. Энэхүү зохиолыг өөрийн орон болон дорно, өрнө дахины баялаг сурвалжид тулгуурлан, шинэлэг арга зүйгээр туурвиж, Чингис хаан, Монголын эзэнт гүрний түүхэнд эзлэх байр суурь, дэлхий дахинаа үзүүлсэн агуу нөлөөг нухацтай гаргаж, анги бүрд зураг, бүдүүвч, зүүлт, тайлбар, ном зүйг хавсаргасан нь эрдэм судлалын ач холбогдол, үнэ цэнэ, үр өгөөжийг өндөр түвшинд гаргаж чадсан онцлогтой юм.

Зохиолд сайн түүхч, даацтай хуульч, нэртэй эрдэмтний оюун билгийн цар, бичиглэх эрдмийн ур дүй хаван нэвт шингэжээ. Түүнчлэн эл бүтээлд түүний багшлах болон судалгааны ажлын 40 шахам жилийн арвин их туршлага шингэж, бийр бэхсийн мөр бүрт оюун билгийн шим шүүс тунан амилжээ.

1985 оны Утга зохиолын салбар дахь Нобелийн шагналд Клод Симон: “Бүү нотол, харин үзүүл. Битгий хуулбарлацгаа, харин бүтээцгээ. Бүү илэрхийл. Харин шинийг эрэлхийл” хэмээжээ. Доктор (Sc.D), профессор И.Дашням эл номондоо Монголын төр, эрх зүйн түүхийг “үзүүлж”, “бүтээж”, “илэрхийлж”, “эрэлхийлж” нэгэн цогц болгож чаджээ.

Нэг ангийн, номын эрхэм нөхөр Танд лагшин тунгалаг, оюун санаа өгөөмөр талбиун, чигч шударга, түүх гэгээн, ид хав нэвт, идэрийн золбоо өнөд бат гялалзаж байхын өлзийт ерөөлийг өргөн дэвшүүлж байна.

Академич



Ж.Болдбаатар

ОРШИЛ

Монгол Улсын төр, хууль цаазын түүх, Үндсэн хууль, төрийн байгуулалтын сургалт, судалгааны ажилд бие хүчээ зориулсан өчүүхэн миний бие гуч гаруй жил судалж цуглуулсан баримт, материал, хичээл заасан туршлагадаа тулгуурлан **“Монгол улсын төр, эрх зүйн түүх”** /МЭӨ III зуунаас XX зууны эцэс/ гэсэн энэхүү дөрвөн боть зохиолыг **“Хууль тогтоомж, Шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв”**-ийн захиалгаар бичиж байгаа нь энэ бөлгөө.

Хэдийгээр уламжлалт таван ухаанд мөхөс авч, хэмжээнийхээ хэрээр түүхэн сурвалж бичиг, хууль цааз, түүхч, археологич, антропологич, сэтгэл зүйч, гүн ухаанч, улс төр судлаач, эдийн засагч, улс төрийн зүтгэлтэн зэрэг дотоод, гадаадын нэлээдгүй хүний туурвил, бүтээлийг судлан тунгаахыг хичээсэн зүтгэл чармайлтдаа түшиглэн **“Монгол улсын төр, эрх зүйн түүх”**-ийг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс бичиж түмэн олондоо хүргэх чин сэтгэлээр жигүүрлэн, ихэд хичээнгүйлэн зүтгэж байж энэ дөрвөн боть номыг бэлтгэснээ зориглон хэвлүүлж байгаадаа сэтгэл өөдрөг байна.

Эрдэм ухаанд сургасан ард түмэн, аав, ээж, эрхэм хүндэт багш, эрдэмтэн мэргэд, судлаач, хамтран зүтгэгч хийгээд мянга мянган шавь нарынхаа захиас, итгэлийн мэлмийд залбирч, өчүүхэн биедээ хуримтлагдсан номын өлзийг түмэн олондоо хүртээх буяны үйлс бодсоныг минь эрх биш ойлгон дэнсэлбээс өвгөн доктор мөхөс би урамшихын ихээр урамших нь тэр буй.

“Монгол улсын төр, эрх зүйн түүх”-ийг бүхэлд нь илэрхийлэн гаргахдаа түүхэн он цагийн дарааллын дагуу бичиж, тухайн цаг үед оршин тогтнож байсан тодорхой улсуудын төр, эрх зүйн түүхээр хэлбэршүүлэн гаргасан амой. Чингэхдээ тэр улсын оршин тогтнохуй, түүний туулсан цаг хугацаа, нутаг дэвсгэр, хүн ам, түүхэнд эзэлж байсан байр суурь, төрийн байгуулал, дотоод, гадаад бодлого, гадаад харилцаа, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн агуулга, шинж чанарыг аль болох тодорхой үзүүлэхийг гол зорилго болгосноо өчмүй.

Монгол Улсын төр, эрх зүй эрт цагаас /МЭӨ III зуунаас XX зууны эцэс/ эдүгээ хүртэл хөгжиж ирсэн түүхийг дөрвөн боть зохиол болгон улмаар боть бүрээ дотор нь анги, бүлэг, зүйл болгон бичиглэсэн болой.

“Монгол улсын төр, эрх зүйн түүх” нь Монголын соёл иргэншлийн түүхийн үе шат бүр дэх төр, эрх зүйн түүхийг тухайн цаг үед холбогдох сурвалж бичиг, археологи, этнографи, антропологи судалгааны дүнд тулгуурлан бичигдсэн бүтээлүүд хийгээд түүхэн нэгэн сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны ном зохиол, архив, хууль цаазын эх баримт бичгүүдэд түшиглэн бичиж, өмнөх өв уламжлалаа аль болох тодорхой харуулахыг хичээн, улмаар мэдлэгээ лавшруулах ач холбогдол бүхий схем, зургийг

хэвлэж, тайлбар, зүүлт хийн, түүхэн он цагийн хэлхээс ба ашигласан ном, бүтээлийн жагсаалтыг анги бүрээр нь бүлэглэн хавсаргалаа. Энэ нь танд улам өгөөжтэй ойлгомжтой байх болтугай хэмээн өргөсөн сэтгэлийн итгэлийг илэрхийлмүй.

“Монгол улсын төр, эрх зүйн түүх” цуврал дөрвөн боть зохиолыг магистрант, докторант, профессор багш, эрдэм шинжилгээний ажилтан, оюутан, суралцагсад, түүхч болон нийгмийн ухаан, монгол үндэстний төр, хууль цаазын түүх, өв уламжлалыг танин мэдэхийг хүссэн хэн бүхэн уншин болгоох бололцоо бүрнээ бийг алжаан тунгаамуй.

Миний бие энэ удаа “Монгол Улсын төр, эрх зүйн түүх” олон боть зохиолын тэргүүн ботийг нь /МЭӨ 209-МЭ XIII дунд үе/-ийг Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан хэвлүүлж байна. Энэ боть нь 5 анги, 20 бүлэг, 77 зүйл, 5 бүлэг тайлбар, зүүлттэй 20 зураг, бүдүүвчээс бүрдэж байгаа болно.

“Монгол улсын төр, эрх зүйн түүх”-ийн тэргүүн ботийг бүтээхэд гүн тусалцаа үзүүлсэн хууль зүйн үндэсний төв /академич Ж.Амарсанаа/, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар /доктор /Ph.D./, профессор Ц.Сарантуяа/, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль /академич С.Нарангэрэл/, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн онол, түүхийн тэнхим /доктор, профессор Н.Лүндэндорж/, МУИС-ын ХЗС-ийн Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв /эрхэм шавь, доктор Б.Баярсайхан/, “Улаанбаатар-Эрдэм судлал” дээд сургуулийн төр, удирдлагын тэнхим /доктор, профессор Г.Баярхүү/, редактор академич Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, доктор /Sc.D/ О.Амархүү, доктор /Ph.D./, профессор Ц.Сарантуяа болон номын эх бэлтгэсэн “Улаанбаатар-Эрдэм судлал” дээд сургуулийн захирал Д.Дэлгэрмаа, компьютер мэдээлэл зүйн лабораторийн ажилтан Д.Бямбадаваа, Л.Эрдэнэ-Оюун, Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төвийн ажилтан Б.Батбаяр, Ц.Одмаа, Х.Наранцацрал, Хууль зүйн үндэсний төвийн мэргэжилтэн У.Мөнхбат, Б.Баян-Амгалан, Ц.Цэрэнням нарт гүн талархлаа илэрхийлье.

Эл боть нь Монголын үндэсний шинжлэх ухааны академи, Монголын боловсролын шинжлэх ухааны академиас надад өгсөн даалгаврын нэгэн биелэл болохыг өчмүй.

Монгол төр, эрх зүйн өв уламжлал улам арвижих болтугай.

Зохиогч: Ишийн Дашням

/Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор,

Монголын үндэсний шинжлэх ухааны академи,

Монголын боловсролын шинжлэх ухааны академийн академич/

2005 оны 9 дүгээр сарын 17-ний өдөр

УДИРТГАЛ

Монгол Улс бол төр, эрх зүйн 2200 гаруй жилийн түүхэн баялаг уламжлалтай.

Энэ уламжлалд тулгуурлан өдгөөгийн төр, эрх зүй өнгөрснийхөө шууд үргэлжлэл нь болон хөгжиж байна. Ингэх нь ч зүйн хэрэг. Учир нь өнгөрснөөс өдгөө үүсдэг нь хүн төрөлхтөний хөгжлийн жам ёс ажгуу. Монголын соёл иргэншлийн хөгжлийн эхний үе шатанд төр ба эрх зүй хөгжиж ирсэн түүх хийгээд уламжлалыг танин мэдэж, түүний мэдлэг, соёл, сургамжид үндэслэн дараа дараагийн үеийн төр, эрх зүй хөгжиж улмаар мөн залгамж үедээ уламжлуулсаар ирсэн нь өнгөрсөн ба эдүгээгийн төр, эрх зүйн хөгжлийн дотоод амин холбооны гол шинж мөн.

Ийм зүй тогтол, гол шинжийг иш үндэс болгон эрх зүйн мэргэжил, бакалаврын зэрэг олгох, сургалтын агуулгад багтааж үндэснийхээ төр, эрх зүйн түүхийг судалдаг нь дэлхийн улс орнуудын хууль зүйн их, дээд сургууль, факультетуудад нэгэнт “стандарт” болон тогтжээ. Монгол Улсад ийм “стандарт” 1960 оноос эхлэн хэрэгжиж эдүгээ эрх зүйн мэргэжил, бакалаврын зэрэг олгож буй бүх сургуульд “Монгол Улсын төр, эрх зүйн түүх” хичээл үзэж байна. Улс орныхоо төр, эрх зүйн буурал түүх, түүний үнэн бодит баримт, өв уламжлал, сургамж, ирээдүйн төрх, төлөвийг танин мэдэхийг хүссэн монгол түмэн, түүний залуу үеийн хүсэл тэмүүлэл ч улам бүр өсөн нэмэгдсээр байгаа нь бахархал төрүүлнэм. Монгол Улсын төр, эрх зүйн түүх нь эрх зүйн шинжлэх ухааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг, түүний нэгэн чухал төрөл болно.

Эрх зүйн түүхийн шинжлэх ухаан нь төр, эрх зүйн үүсэл, хөгжлийн зүй тогтол, агуулга, үйл явц, өв уламжлалыг хамаарахын хамт эрүү, иргэний эрх зүй зэрэг эрх зүйн салбар шинжлэх ухаан бүрийн өнгөрсөн түүхийг хөгжлийнх нь үе шат бүрээр өөртөө агуулж байдаг өргөн агуулгатай. Түүхийн шинжлэх ухаан нь соёл иргэншлийн түүхийг бүхэлд нь судалдаг бол төр, эрх зүйн түүх нь төр ба эрх зүйн түүх түүний хөгжлийн зүй тогтол, үйл явцыг судалдаг. Чингэхдээ төр, эрх зүйн түүх нь төр, эрх зүйн өнгөрсөн түүхийн тухай мэдлэгийн ердийн цуглуулга биш, харин төр ба эрх зүйн хөгжлийн түүхэн зүй тогтол, үйл явцыг танин мэдэх зорилтыг өөртөө тавьдаг бөлгөө. Монгол Улсын төр, эрх зүйн түүхийн судлах зүйлийн үндсэн объект, гол цөм нь монголын төр ба үндэсний эрх зүй, түүний хөгжиж ирсэн мянга мянган жилийн түүх болно. Монгол Улсын төр, түүний түүхээр Монголын төрийн хөгжлийн үе шат бүрийн төрийн хэлбэр, онцлог шинж, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, дотоод, гадаад бодлого, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь, төрийн байгууллагын тогтолцоо, түүний төрөл, бүтэц, эрх хэмжээ, төрийн алба, цэргийн зохион байгуулалт, алба, татварын тогтолцоо, төрөл, агуулга, онцлогийг судалдаг юм. Үндэсний эрх зүй, түүний түүхээр Монгол Улсын эрх зүйн хөгжлийн үе шат бүрийн эрх зүйн эх сурвалж

түүний бүтэц, агуулга, онцлог, эрх зүйн хэм хэмжээ, институт, салбаруудын хөгжил, үүрэг ролийг судална. Ялангуяа өмч, гэрээ хэлэлцээр, өв залгамжлал, гэр бүлийн эрх зүй, эрхлэх аж ахуй, мал сүрэг, газар бэлчээр, ус ургамал, ан амьтдыг эзэмших, ашиглах, хамгаалах эрх зүйн үндэс, хүний амь нас, бие махбодь, эд хөрөнгө, нэр төр, эрх ашгийг хамгаалах асуудал, эрүүгийн бодлого, гэмт хэрэг, ялын төрөл, хэлбэр, хэм хэмжээ, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны арга, хэлбэр, хэрэгслийг судална.

Төр, эрх зүйн түүхийн судлах зүйлийн хоёр дахь үндсэн объект болох төр ба үндэсний эрх зүй хоорондоо харилцан салшгүй холбоотой. Төр нь эрх зүйн акт, түүний хэм хэмжээг тогтоож, тийнхүү тогтоох нь төрийн өөрийнх нь үйл ажиллагааны нэгэн онцгой хэлбэр байхын хамт эрх зүйн хэм хэмжээг заавал сахин биелүүлэх явдлыг хангаж байдаг. Тэгвэл эрх зүй нь явцуу утгаараа төрийн бодлого, үүрэг зорилтыг хангах хэрэгсэл болж, төрийн байгууллага, албан тушаалтны зохион байгуулалт, үйл ажиллагааны хууль зүйн үндсийг бүрэлдүүлж байдаг байна. Ийнхүү төр ба эрх зүй нь бие биенийгээ ямагт хамт оршихыг шаардах зүй тогтолт холбоотой. Үүнийг үндэс болгон төр, эрх зүйн түүхийг судлан үзэхдээ эдгээр хоёр объект, тэдгээрийн илрэх хэлбэрүүдийг харилцан уялдаа холбоонд нь авч үзэх шаардлагатай билээ.

Монгол Улсын төр, эрх зүйн түүх¹ нь төр ба үндэсний эрх зүй ямар өвөрмөц онцлог, бүтэц, агуулга, ач холбогдолтойгоор яаж хөгжин, хэрхэн уламжлагдаж ирсэн зүй тогтол, үйл явцыг төр, эрх зүйн түүхэн хөгжлийн үе шат бүрээр он цагийн дэс дарааллынх нь дагуу судална.

Монгол Улсын төр, эрх зүйн түүх нь төр, эрх зүйн онол, эрх зүйн философи, дэлхийн улсуудын төр, эрх зүйн түүх зэрэгтэй нягт холбоотой. Жишээлбэл, төр, эрх зүйн онол нь төр, эрх зүйн түүхийн онол, арга зүйн үндэс болдог. Тэгвэл төр, эрх зүйн түүхийн үйл явдал, баримтууд нь төр, эрх зүйн онолын асуудлыг танин мэдэх, онолын сэтгэлгээ хөгжин төлөвшихөд үндсэн хүчин зүйл болж үйлчилдэг жамтай. Төр, эрх зүйн түүх нь Монгол Улсын түүх, гүн ухаан, логик зэрэгтэй нягт холбоотой. Тухайлбал, Монгол Улсын түүх судлах зүйлийнхээ хүрээ агуулгаар төр, эрх зүйн түүхээс өргөн төдийгүй төр ба хууль цааз нь улсын түүхийн судлах зүйлийн чухал элемент нь болдог. Тэгвэл төр, эрх зүйн түүхийн судлах зүйл, түүнийг судлах арга зүй нь хууль зүйн шинжлэх ухаанд үндэслэн зөвхөн төр ба эрх зүй, түүний зүй тогтол, үйл явц байдаг онцлогтой. Төр, эрх зүйн түүх нийтийн болон хувийн эрх зүйн өнгөрсөн түүх, уламжлалыг хөгжлийнх нь үе шат бүхнээр өөртөө агуулж цаашид гүнзгийрэн хөгжих үндэс нь болж байдаг билээ. Төр, эрх зүйн түүх нь хууль зүйн мэргэжлийн суурь мэдлэгт хамаарагдана. Төр, эрх зүйн түүх нь хууль зүйн боловсролын агуулгыг бүрдүүлдэг, хууль зүйн мэдлэгийн тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болохын хамт энэхүү

мэдлэгийн тогтолцоондоо өөрийн гэсэн онцлог бүхий тодорхой байр суурь эзэлдэг. Төр, үндэсний эрх зүйн түүхээр олгодог мэдлэг, чадвар нь суурь шинжтэй бөгөөд хууль зүйн дээд боловсролын мэдлэг олоход үндэс тулгуур болж үйлчилдэг. Энэ нь уг хичээлээр Монгол Улсад үндэсний төр, эрх зүйн үүсэн хөгжиж ирсэн зүй тогтол, үйл явцын агуулга, учир холбогдлыг танин мэдэж, орчин үеийн эрх зүйн салбаруудын өнгөрсөн түүхийн тухай системтэй мэдлэг олж авдагтай холбоотой.

Төр, эрх зүйн түүх өвөрмөц онцлог бүхий суурь, шинжтэй болох нь түүний зорилт, агуулга, ач холбогдолд илрэлээ олж байдаг. Төр, эрх зүйн гол зорилт нь Монголын төр ба эрх зүй үүсэн хөгжиж ирсэн зүй тогтол, үйл явц, түүхэн уламжлалын тухай системтэй мэдлэг олгож, үүнд холбогдох түүхэн сурвалж бичиг, зохиол бүтээл, хууль цаазтай танилцуулан, үндэснийхээ төр, эрх зүйн түүхийг хөгжлийнх нь үе шат бүрээр сайн мэдэж түүгээр бахархах хүмүүжил төлөвшүүлэхэд оршино. Төр, эрх зүйн түүхийг судлах нь онол, практикийн төдийгүй бие хүний хүмүүжил төлөвшин хэлбэршихэд нөлөөлөх чухал ач холбогдолтой юм. Төр, эрх зүйн онолын асуудлыг үндэсний төр, эрх зүйн түүхэн баримт, үйл явдлаар батлан танин мэдэж мэдлэг, үнэмшил олж авах, хувь хүний төр, эрх зүйн онолын сэтгэлгээ хөгжин тэлэх, төр, эрх зүйн асуудлын өнгөрсөн түүхэн талын нь баримт, үйл явдлыг мэдэж авах, цаашид түүний уламжлалыг амьдрал, ажил үйлсдээ хэрэглэж болох арга зүй эзэмшихэд төр, эрх зүйн түүх үйлчилдэг бөлгөө. Төр, эрх зүйн түүх нь төр, эрх зүйн хөгжлийн янз бүрийн шатан дахь түүхэн асуудлыг тайлбарлахад гүн ухааны арга зүйг түгээмэл хэрэглэнэ. Төр, эрх зүйн түүхийн асуудлыг авч үзэхэд олон ургальч үзлийн үүднээс хандах зарчим чухал ач холбогдолтой. Олон ургальч үзлийн зарчмыг хэрэглэснээр түүхийн нарийн үзэгдэл, үйл явцыг олон талтай янз бүрийн хувилбараар судалж тухайн үеийн түүхэн бодит нөхцөл, үнэнд тохирсон бүтэц, дүгнэлт гаргах бололцоо бүрдэнэ. Эсрэг, тэсрэгийн нэгдэл, тэмцлийн диалектик, зохицох, өөрчлөхийн диалектик, нийгмийн хөгжлийн хуулийн объектив, субъектив талуудын диалектик, төр, эрх зүйн түүхийн үзэгдэл үйл явцад бодитой хандахыг төр, эрх зүйн түүхийг судлахад үндсэн зарчим болгон мөрдөнө. Эдгээр зарчмыг хэрэглэснээр төр, эрх зүйн түүхийн үзэгдэл, үйл явцын асуудалд шинжлэх ухааны үнэлэлт, дүгнэлт өгөх, зөв томъёолол гаргах, түүхэн баримт, үйл явцыг бодитой тусгаж тодорхойлох боломж бүрдэнэ.

Төр, эрх зүйн түүхийг судлахад түүхчлэх, харьцуулах, системчлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хэм хэмжээг тодорхойлох болон индукц, дедукц, загварчлах, баримт бичиг, түүхэн үйл явдал, хууль, түүний заалтуудад задлан шинжилгээ хийх, таамаглал, дүгнэлт дэвшүүлэх зэрэг судалгааны тодорхой аргуудыг өргөн хэрэглэдэг.

Төр, эрх зүйн түүхийн асуудалд түүхчлэх аргыг хэрэглэхдээ тэрхүү асуудлыг анх үүссэнээс нь эхлэн цаашид хэрхэн хөгжсөн үйл явцыг он цагийн дарааллынх нь дагуу

судалж нэгтгэн дүгнэнэ. Төр, эрх зүйн түүхийн үзэгдэл, үйл явдлыг түүний оршин байгаа тодорхой цаг хугацаа, орон зайд нь авч үзэж боловсруулалт, дүгнэлт хийвэл түүхэн үнэн, бодит байдлыг зөв тогтоож, уламжлагдах шинж чанарыг нь олж харж хадгалж чадах билээ. Харьцуулах арга нь Монголын соёл иргэншлийн янз бүрийн үе шат дахь төр, эрх зүйн түүхийн асуудлыг өөр хооронд нь болон бусад улс орны ижил буюу ойролцоо төрлийн асуудалтай жишин үзээд улмаар тэдгээрийн нийтлэг болон ялгагдах шинж, онцлогийг танин мэдэх боломж олгодог. Монгол Улсын төр, эрх зүйн түүхийг судлахад төр, эрх зүйн түүхэнд холбогдох сурвалж бичиг, судалгаа шинжилгээний зохиол, хууль цаазын акт ялангуяа хуулийн жинхэнэ эхүүдийг тулгуур материал болгон хэрэглэх нь зүйн хэрэг.

Энэ талаархи материал нэн баялаг агаад олон төрөлтэй. Товчлон дурдвал; Хятад, Энэтхэг, Орос, Иран, Армян, Сири улсын төрийн судар, он дарааллын бичиг, алдарт “Монголын нууц товчоо”, Ираны түүхч А.Жувейны “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”, Б.Хэбрүсийн “Сирийн түүхэн тэмдэглэл”, Рашид-ад-Дины “Судрын чуулган”, Сыма Цяны “Түүхэн тэмдэглэл”, Ф.Айлтхамын “Хүннү нарын түүх”, Хань улс, Сун улс, Вей улс, Тан улс, Ляо, Юан, Орос улсын түүх, он дараалалын бичиг, Мэн-Хуний “Монгол-татарын бүрэн шастир”, Лувсанданзаны “Алтан товч”, Инжинашийн “Хөх судар”, Саган-Сэцэний “Эрдэнийн товч”, А.Амарын “Монголын товч түүх”, Л.Дэндэвийн “Монголын түүх”, Ч.Бат-Очирын “Монгол Улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг”, Г.Сүхбаатарын “Эртний улсуудын түүх /Хүннү, Сяньби, Жужан/”, Ш.Нацагдоржийн “Халхын түүх”, Д.Гонгорын “Халх товчоон” I, II боть, Ч.Далайн “Монголын түүх” 3 боть, Б.Ширэндэвийн “Ардын хувьсгалын түүх”, М.Санждоржийн “Монгол төрийн түүхээс”, “Ардын төрийн түүх”, Монгол нутагт хийсэн археологийн шинжилгээний дүн, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанжан нарын “Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал”, “БНМАУ-ын түүхийн нэгэн боть”, “БНМАУ-ын түүх” 3 боть, Монгол Улсын түүх 5 боть зэрэг олон бүтээл Монгол Улсын төр, эрх зүйн түүхийн сурвалж, бичиг, зохиолын гол цөмд хамаарагдах нь лавтай билээ. Зарим томоохон төлөөлөгчдөөс цухас боловч нэрлэвээс: Эртний Хятадын Сыма-Цян, Ираны Ата-Малик Жувейни, Мира-Хуанд, Рашид-ад-Дин, Египетийн Макриз, Сирийн Бар Хэбрус, Абул Фаражи, Армяны Магаки, Ибн-Батути, Вартан, Английн Ж.Саундерс, Э.Латимор, Гарольд Дэмбэ, Оросын Е.И.Кичанов, В.А.Рязановский, Н.Я.Бичурин, В.В.Бартольд, Н.Н.Березин, Л.С.Тихвинский, В.Владимирцов, Б.Кафаров, А.П.Окладников, Н.С.Таскин, Н.Ц.Мункуев, Л.Н.Гумилов, А.Дугин, Эренджен Кара Даван, К.П.Патканов, М.И.Кукушкин, Хятадын Чжоу Яотин, Бань Гу, Вэй Чжэн, Линьган, Ван Говэй, Оуян-сю, Токто, Лихи-чэн, Чжао-хун, Пен Дая, Сютин, Сайшаал, Ян на, Японы Ооба Яхай, Окушикэ Ширу, Вад Сейн, Осаке Широ,

Янай Ватар, Сакеэ Шигаитак, Эгами Намио, Окода Хидэ Хиро, Отаки Мацуэ, С.Иванмура, Америкийн Жорж Вернадский, Германы Ф.Эрдманн, Р.К.Дуглас, Э.Краузе, Италийн Марко Поло, Плано Картини, Гильен де Рубрук, Францын Рене Груссе, Петис Кройкс, П.Пеллио, Э.Картмер, Туркийн Д.Оссон, Энэтхэгийн Жузжани, Ж.Неру, Солонгосын Жон Ён Сук, Ким Жон Ре, Ким Сон Жун, Монголын Саган Сэцэн, Лувсанданзан, Гомбожав, А.Амар, Ч.Бат-Очир, Б.Баянчулуун, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Б.Ширэндэв, Ч.Далай, Г.Сүхбаатар, Н.Сэр-Оджав, Д.Гонгор, М.Санждорж, Н.Ишжамц, Ч.Жүгдэр, Л.Жамсран, С.Жалан-Аажав, О.Содовсүрэн, Д.Цэвээндорж, Ц.Пунцагноров, Д.Сангиданзан, Э.Авирмэд, Г.Совд, Г.Баярхүү, О.Амархүү, Б.Чимид, Т.Сэнгэдорж, Н.Лүндэндорж, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан, С.Төмөр, Д.Дашцэдэн, А.Очир, З.Лонжид, О.Батсайхан, Х.Сэлэнгэ, Ч.Дашдаваа, Б.Баярсайхан зэрэг эрдэмтэн судлаачдын бүтээл Монголын төр, эрх зүйн түүхэнд холбогдох чухал баримт бичиг, материал агуулж байгааг юуны өмнө дурдаж болох юм. Энд үүнээс олон эрдэмтэн судлаачдыг нэрлэж болох боловч яахан барах билээ. Иймээс номын анги бүрийн эхэнд өгүүлэх сурвалж бичиг, ном зохиолд дэлгэрүүлэн дурдсан учир эдгээрээс олж мэдэх өргөн боломж буйг болгоохыг хүснэм. Монгол Улсын төр, эрх зүйн эх сурвалжид монголын соёл иргэншлийн янз бүрийн үе шатанд үйлчилж байсан монгол хуулиуд зүй ёсоор хамаарагдана. Чингис хааны алдарт “Их засаг” хууль, түүний дараа дараагийн хуулиуд, тухайлбал; “Арван буянт номын цагаан түүх”, “Их Юаны нэвтэрхий хууль”, “Түмэдийн Алтан хааны хууль”, “Хутагтай сэцэн хун тайжийн шашны цааз”, “Түмэн хааны хууль”, “Халхын үйсэн дээрхи бичиг”, Монгол, Ойрдын “Их цааз”, “Галдан бошготын цааз”, “Лигдэн хааны цааз”, “Монгол цаазын бичиг”, “Гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”, “Халх журам” Шашин төрийг хосолсон Монголын хаант улсын “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг” гэсэн жинхэнэ монгол хөрсөн дээр боловсорч гарсан хуулиуд нь Монголын хууль цаазын хамгийн үнэ цэнэтэй дурсгалт сурвалж болно.

Монголын шинэ үеийн хуулиуд эл үеийнхээ төр, эрх зүйн хөгжил, үүрэг роль, онцлогийг тусган илэрхийлж байсныхаа хувьд төр, эрх зүйн түүхийн эх сурвалжийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг байв. Монгол Улсын 4 удаагийн Үндсэн хууль, Монгол Улсын Их, Бага хурал, түүний гишүүд, Тэргүүлэгчид, Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчид, Байнгын комисс, Депутатын тухай хууль, дүрмүүд, Засгийн газар, Сайд нарын Зөвлөлийн тухай хууль, дүрэм, аймаг, хот, хошуу, сум, баг, хороо, хорины тухай анхны дүрэм, аймаг, нийслэл, сум, баг, хороо хорины дүрмүүд, Сонгуулийн хууль, дүрмүүд, БНМАУ-ын шүүх цаазын анхны бичгүүд, БНМАУ-ын хүчнээ үнэлэгчдийн хууль, Хөдөлмөрийн хуулиуд, БНМАУ-ын иргэн, эрүүгийн хууль, тэдгээрийн байцаан шийтгэх хууль, Засан сайжруулах хууль, Шүүх, прокурорын зохион байгуулалтын

тухай хууль, Гэр бүлийн хууль, Газар бэлчээр, нутаг ус, ой, ан агнуурын тухай хууль, улсын төсөв, гааль, татварын хууль зэрэг шинэ үеийн анхны ба түүний дараачийн хууль нь тухайн үеийн төр, эрх зүйн түүхийг судлах хууль цаазын үндсэн хэрэглэгдэхүүн болно. Төр, эрх зүйн түүхийг судлахад тухайн үеийн хууль тогтоомжийг заншлын эрхтэй /хэв хууль/ нягт холбож судлах нь чухал. **Заншлын эрх** нь эрх зүйн хэм хэмжээ, шударга ёс хэрэгжихэд зайлшгүй шаардлагатай хүчин зүйл мөн болой. Эрх зүй, заншлын эрхтэй хэдий чинээ нягт уялдаа холбоотой байвал түүний амьдралд хэрэгжих үйл явц төдий чинээ үр дүнтэй байна.

Заншлын эрхийн хэм хэмжээ төрийн хамгаалалтад орж, түүний хэм хэмжээг заавал биелүүлэхийг төр хүлээн зөвшөөрсөн цагт эрх зүйн эх сурвалж болно. Төрийн хуульд бэхжигдсэн хэм хэмжээг бид заншлын эрх зүй гэж үздэг билээ.

Монгол Улсын төр, эрх зүйн түүхийг өгүүлэхдээ түүний хөгжлийг үечлэн авч үзэх явдал чухал ач холбогдолтой юм. Ийнхүү түүнийг үечлэх нь Монгол Улсын төр, эрх зүйн талаар системтэй мэдлэг олж авах, гүнзгий танин мэдэх, судалгааны болон амьдрал практикт хэрэглэхэд ихэд нөлөөлөх ач холбогдолтой юм. Монголын төр, эрх зүйн түүхэн хөгжлийг үечлэхдээ хүн төрөлхтөний болон монголын соёл иргэншлийн хөгжлийн ерөнхий үе шат, алив үзэгдлийн хөгжлийг үечлэхэд баримталдаг түгээмэл зарчим, шалгуур, арга зүйг харгалзан үзнэ. Монголын төр, эрх зүйн түүхийн хөгжлийг үечлэхэд хамгийн шийдвэрлэх хүчин зүйл нь нийгэм-эдийн засгийн байдлаар нөхцөлдсөн төр, хууль цаазын хөгжилд гарсан өөрчлөлт, хүрсэн хөгжлийн түвшин болно. Төрийн бүрэн эрхт байдал, үүрэг, зорилт, төрийн хэлбэр, улс төрийн дэглэм, төрийн байгууллагын тогтолцоо, хууль цаазын эх сурвалж, шинж чанар, агуулга, бүтцэд гарсан эргэлтийн шинжтэй өөрчлөлт, үр дүн, онцлог бол төр, эрх зүйн хөгжлийг үечлэхэд харгалзах хүчин зүйлсэд хамаарагдана. Эдгээр нь төр, эрх зүйн хөгжлийн шинж төлөвийг илэрхийлж үечлэх шалгуурт багтах төр, эрх зүйн хөгжлийн дотоод гол элемент юм. Хүн төрөлхтөний ба монголын соёл иргэншлийн хөгжлийн үндсэн үе шат, монголын төр, эрх зүйн түүхэн үйл явц, түүний хандлага, чиглэл, агуулга, онцлог болон үечлэлийн гол шалгуур, арга зүйг харгалзан Монгол Улсын төр, эрх зүй үүсэн хөгжиж ирсэн түүхийг дараах дөрвөн үндсэн үед хувааж байна. Үүнд:

1. Монголын эртний үеийн төр, эрх зүй /МЭӨ III зуунаас XII зуун/;
2. Монголын дундат үеийн төр, эрх зүй /XIII зуунаас XX зуун/;
3. Монголын шинэ үеийн төр, эрх зүй /XX зууны эхнээс XX зууны эцэс/;
4. Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй /XX зууны эцэс 1992 оноос/.

1. Монголын эртний үеийн төр, эрх зүй. Энэ үе нь манай эриний өмнөх III зуунаас манай эриний XIII зууны эх хүртэлх 1400 гаруй жилийг хамарна. Өгүүлэн буй үед монгол нутаг дээр Хүннү, Сяньби, Ухуань, Тоба, Тогоон, Жужан, Уйгур, Түрэг,

Хятан, Хар Хятан гэсэн улсууд ээлжлэн оршин байжээ. Сүүлчийн улс болох Хятан улс 1125 онд мөхсөнөөр эртний улсуудын үе дуусаж, аймаг, ханлигаар орших шинэ зурвас үе эхэлж 80 жилийн нүүр үзжээ.

Ийнхүү монголын эртний үеийн төр, эрх зүй нь эртний улсуудын төр, эрх зүй, монгол ханлиг, аймгуудын төр, эрх зүй гэсэн хоёр хэсгээс бүрдэж байв. Монголын эртний үед төр ба эрх зүй үүсэж тэдгээрийн үндсэн шинж, бүрдүүлэх элемент хэлбэрших үйл явц эхэлсэн байна.

Энэ үед төр, эрх зүй нь шилжилтийн шинжийг агуулж, овгийн байгууллаас төрт байгуулалд, хэв хуулиас бичмэл хуульд шилжиж байсан онцлогтой. Монгол төрийн үүслийн талаар монголын судлаачид нэгдмэл дүгнэлтэд хүрээгүй байгааг тэмдэглэж болох юм. Тухайлбал, Хүннүгийн төр нь анхны монгол төр¹, Их Монгол Улс бол монгол төрийн анхны хэлбэр², Хамаг Монгол Улсын хаант төр өвөг монголын улсуудын төр ёсыг тасралтгүй уламжилсан нь түүний төрийн бүтэц, зохион байгуулалт, төрөө засах арга ухаанаар илэрч байсан байна.³ Хамаг Монголын хаант төрөөр монголын хаант төрийн түүхэн үе эхэлжээ⁴ гэх мэтээр бичжээ.

Эрдэмтэд, судлаачдаас дэвшүүлсэн эдгээр санал бүр өөр өөрийн зохих үндэслэлтэй хэдий ч түүхэн үнэнд нийцэж байх нэг л шалгуурт захирагдах учиртай. Үүнд харгалзвал зохих түүхэн үнэн бол Хүннү улс монгол угсаатны анхны улс мөн үү? Хүннүгийн төр анхны монгол төр үү гэдгийг нотолж, нэгдмэл саналд хүрэх явдал. Энэ талаар нэрт судлаач, эрдэмтэн судлаач А.Амар, Б.Баянчулуун, Ц.Доржсүрэн, Н.Сэр-Оджав, Д.Наваан, Г.Сүхбаатар, Ц.Хандсүрэн, Х.Пэрлээ, Л.Н.Гумилев, А.Н.Бентам, Н.Я.Бичурин зэрэг олон эрдэмтэн судлаач Хүннү улсын талаар дагнан судалж, монголын анхны төр, улс нь Хүннү байсан хэмээн нотолсныг онцлон тэмдэглэж болно. Монгол Улсын түүхийн нэгэн боть, гурван боть, таван боть суурь зохиолуудад Монгол Улсын төрийн түүх Хүннүгээс эхэлж буйг түүх, археологи, этнографи, антропологийн шинжлэх ухааны үүднээс нотолж нэгэн мөр дүгнэлтэд хүрсэн ажээ.

Хүннүгийн орд, өргөө нь одоогийн Архангай аймгийн хөшөө цайдам орчимд байсныг харгалзахгүй байхын аргагүй.

2. Монголын дундат үеийн төр, эрх зүй. 700 гаруй жилийг хамарч XIII-XX зууны эхэн хүртэл үргэлжилсэн энэ үе нь монголын төр, эрх зүйн түүхийн үнэ цэнэтэй өв уламжлалыг үлэмж гүнзгий шингээж байснаараа онцлог юм.

1. Монголын төрийн байгуулалт, улс төрийн сэтгэлгээний хөгжил /МЭӨ III-МЭ XX зуун/. Тэргүүн боть. УБ.,1995. 4 дэх тал

2. Ш.Бира. “Монголын нэгдсэн тусгаар төр байгуулагдсан нь “ УБ.,1996. 4 дэх тал

3. Ч.Жүгдэр. “Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр гүн ухааны сэтгэлгээ” УБ.,1987, 78-89 дэх тал, 90-147 дахь талд үзнэ үү.

4. Н.Лүндэндорж. “Төрийн онол” УБ.,1997. 170 дахь тал.

Энэ үеийг дотор нь дараах байдлаар ангилж болох юм. Үүнд:

А. Монголын нэгдсэн улсын төр, эрх зүй /1206-1260/

Б. Монголын Юан гүрний төр, эрх зүй /1260-1368/

В. XIV-XVI зууны Монгол улсын төр, эрх зүй /1368-1758/

Г. Манжийн ноёрхлын монголын үеийн төр, эрх зүй / 1691-1911/

Д. Монголын хаант улсын төр, эрх зүй /1911-1920/

Энэ үед монгол угсаатнууд нэгдэж Чингис хааны удирдлагаар Монголын нэгдсэн улсыг байгуулан улмаар дэлхийн хэмжээний том гүрэн болсон юм.

Мөн монголчууд Хятад, Монголын газар нутаг, хүн амыг нэгтгэн захирсан Монголын Юан улсыг байгуулж байв. Бас ХҮШ зуунд шинэ, хүчирхэг Манж улсад эзлэгдэн түүний ноёрхолд 200 гаруй жилийг өнгөрөөж 1911 оны үндэсний хувьсгалаар, манжийн ноёрхолыг устгаад Монголын хаант улсыг байгуулж, сэргэн мандлын үедээ орсон юм.

Түүхийн өгссөн, уруудсан ийм ээдрээтэй нөхцөл, цаг үед монголчууд төр, үндэсний эрх зүйгээ хамгаалан, төр ёс, хууль цаазын уламжлалаа хадгалж ирсэн төдийгүй төрийн тогтолцоо, хууль цаазаа хөгжүүлэн, жинхэнэ монгол хөрсөн дээр, монголын өвөрмөц онцлогийг шингээсэн олон хууль бүтээсэн нь түүхэн их үнэ цэнэтэй ажгуу.

3. Монголын шинэ үеийн төр, эрх зүй. Энэ үе нь 1921 оны 3 дугаар сард үндэсний ардчилсан хувьсгалыг удирдах төв штаб болж Бүгд Түр Ерөнхийлэн Шийтгэх Газар байгуулагдсан цагаас эхлэн 1990 оны дунд үеэр БНМАУ-ын Үндсэн хуульд эргэлт гаргасан нэмэлт, өөрчлөлт орох хүртэл 70 шахам жил үргэлжилжээ. Монголын шинэ үеийн төр, эрх зүй нь:

• **Хэмжээт эрхт хаант улсын төр, эрх зүй**

/1921 оны 3 дугаар сараас 1924 оны эцэс хүртэл/;

• **Монгол Улсын анхдугаар үндсэн хууль үйлчлэх үеийн төр, эрх зүй**

/1924-1940/;

• **Монгол Улсын хоёр дахь үндсэн хууль үйлчлэх үеийн төр, эрх зүй**

/1940-1960/;

• **Монгол Улсын гурав дахь үндсэн хууль үйлчлэх үеийн төр, эрх зүй**

/1960-1990 оны эхэн үе/-ийг хамаарна.

Монгол орон соёл иргэншлийнхээ шинэ үед дэвшин орж, үндсэн хуульт байгууллыг сонгон авсан нь томоохон түүхэн дэвшил байлаа. Монголын дундат үеийн нийгэм, эдийн засаг, төр, эрх зүйн тогтолцоог өөрчилж, шинэ үед зохицсон нийгэм, эдийн засаг, төр, эрх зүйн шинэ тогтолцоог бүрэлдүүлэх нь түүхэн зохих цаг хугацааг шаарджээ.

Үүнд Монгол улс хөгжлийнхөө 20 шахам жилийг зарцуулсан түүхтэй. Энэ үед Монгол улс социалист онолыг үндэс болгон улс төр, нийгэм, эдийн засаг, төр, эрх зүйн тогтолцоогоо бүрэлдүүлж, социалист онол, үзэл суртлыг удирдлага болгосон нэг

нам засгийн эрх барих болсон нь эл үеийн төр, эрх зүйн тогтолцоо, агуулга, хэлбэр хөгжлийн хандлага, шинж төрхөд тодорхойлогч үндсэн хүчин зүйл болж нөлөөлсөн байна. Гэвч монголын төр, эрх зүйн хөгжилд олон чухал дэвшил, шинэ зүйл гарсан билээ. Тухайлбал, үндсэн хууль, Ром-Германы эрх зүйн тогтолцоо, иргэний тэгш эрх, Улсын Их, Бага Хурал, аймаг, сумын хурал, сонгуулийн тогтолцоо, Шүүх, Прокурорын байгууллага, өмгөөлөл, эрүү, иргэн, гэр бүл, хөдөлмөрийн хууль зэрэг олон шинэ зүйл төр, хууль цаазын амьдралд нэвтрэн хэвшжээ. Шинэ төр, эрх зүйн тогтолцоо бүрэлдэн хөгжих явцад хууль ёс гажуудах, туйлшрах, хэлбэрдэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд олон шат дамжлага хэлбэрдэл, хүнд суртал, намчирхах, хуулбарлах, дууриах, үндэсний суурь хөрс, өвөрмөц онцлог, өв уламжлалаас хөндийрөх явдал гарч төр, эрх зүйн хөгжилд эерэг бусаар нөлөөлж байсан нь түүх болон нэгэнтээ үлджээ.

4. Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй. Энэ үеийн үүсэл 1980-аад оны сүүлчээс Монгол оронд үүссэн ардчиллын төлөө хөдөлгөөний үр дүнд нийгэм, улс төр, эдийн засгийн тогтолцоонд гарсан эргэлтийн шинжтэй өөрчлөлт, социалист системийн задрал, улс орон, ардчилал, зах зээлийн харилцаанд шилжин орох болсонтой холбоотой байв. 1990 оны 5 дугаар сард БНМАУ-ын Ардын Их Хурлын 11 дэх удаагийн сонгуулийн 9-р чуулганаар БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийг баталж, Монгол Улсын нийгэм эдийн засаг, улс төр, төр эрх зүйн тогтолцоог цоо шинээр өөрчлөн шинэтгэх хууль зүйн үндсийг тавьсан нь Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүйн хөгжлийн үе эхэлсэн байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуульд олон намын тогтолцоотой байхыг зөвшөөрч, байнгын ажиллагаатай парламент-Улсын Бага Хурлыг байгуулах, Монгол Улсын Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн албан тушаал бий болгохоор тогтоожээ. Энэхүү Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн дагуу 53 хүний бүрэлдэхүүнтэй Улсын Бага Хурлыг байгуулан, Монгол Улсын ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг сонгож, орон нутгийн хурлуудад хурлын тэргүүлэгчдийн даргын орон тоог бий болгон ажиллуулсан байна. Энэ үеэс Улсын Бага Хурлын, Ерөнхийлөгчийн, Засгийн газрын тухай хууль болон өмч хувьчлал, албан татвар, хөдөлмөр, аж ахуйн нэгжийн тухай хуулиудыг баталж, эрүү, иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар тус улсын нийгэм-эдийн засаг, төр, эрх зүйн тогтолцоо өөрчлөгдөн шинэчлэгдэж эхэлжээ. Монгол Улсад шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулж улмаар БНМАУ-ын Ардын Их хурлын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаан 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр шинэ Үндсэн хуулийг баталжээ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь нийгэм эдийн засаг, төр, эрх зүйн цоо шинэ тогтолцоог бүрэлдүүлэн хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах эрхэм зорилгыг хуульчлан тунхаглажээ. Ийнхүү Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй Үндсэн хуулиар баталгаажин хөгжиж байна.



ТЭРГҮҮН АНГИ

**МОНГОЛ НУТАГТ ҮҮСЭН ТОГТНОЖ
БАЙСАН ЭРТНИЙ УЛСУУДЫН
ТӨР, ЭРХ ЗҮЙ**

ТЭРГҮҮН АНГИ
МОНГОЛ НУТАГТ ҮҮСЭН ТОГТНОЖ БАЙСАН
ЭРТНИЙ УЛСУУДЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ
(МЭӨ III-МЭ XII зууны эхэн)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**Эртний улсууд, тэдгээрийн төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг,
судалгаа, шинжилгээний бүтээл**

§1. Эртний улсуудын товчоон

Монголын төр ба эрх зүйн түүх 2000 гаруй жилийн тэртэйгээс эх үүсэлтэйг Монгол улсын болон төр, эрх зүйн түүхийн шинжлэх ухаан нэгэнтээ нотолсон бөлгөө. Энэ нь сүүлийн үеийн палеонтологи, палеоботаник, палеозологи, археологи, шашин судлал, түүх судлал, төр ба хууль судлалын ололт, түүхэн баримт, эд өлгийн зүйлс, олон орны эрдэмтдийн судалгааны ажлын бүтээл, дүгнэлтээр улам бүр баталгаажиж байна.

Чингэхдээ Монгол Улсад төр, эрх зүй анхлан үүсэж бүрэлдсэн нь гэнэтийн буюу тохиолдлын үйл явдал бус харин хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн салшгүй нэг хэсгийн хувьд түүний үйл явцын хүрээнд, мөн түүний нийтлэг зүй тогтлын дагуу явагдаж, улмаар түүхийн урт удаан хугацааны хөгжлийн хандлага, үр дүнтэй амин холбоотой байсан аж.

Манай нутагт хүн анх амьдарч байсан тэр цаг үеэс буюу одоогоос 800000 жилийн тэртэйгээс эхэлсэн түүхэн хөгжилт, түүний үр дүнтэй холбож үзвэл зохистой. Монгол нутагт хүн анх амьдарч байсан цагаас анхны төр байгуулагдах хүртэлх хугацаанд буюу доод палеолит /80000-100000 жил/, дунд палеолит /МЭӨ 100000-40000/, доод палеолит /МЭӨ 40000-15000/, мезолит /МЭӨ 15000-8000/, неолит /МЭӨ 8000-3000/-ийн хөгжлийн үйл явцад аажим аажмаар бэлтгэгдсээр хүрлийн үе /МЭӨ 3 дахь мянган жилээс 1 дэх мянган жил/-д шилжсэн цагаас цаашид боловсорч улмаар төмөр зэвсгийн үе /МЭӨ 1 дэх мянган жил/-ийн төгсгөл рүү орсон цагаас төр үүсэн тогтох нийгэм-улс төрийн нөхцөл бүрэлдэн бий болж эхэлжээ. Эл үйл явц нь овгийн байгууллын хөгжил, хүмүүсийн амьдрал, аж ахуй, гэр бүлийн харилцаанд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийг өөртөө агуулж байв.

Нийгмийн байгууллын дотоод мөн чанарт гарсан эдгээр өөрчлөлтийн үр дүнд цусан төрлийн холбоо болох овгийн байгуулал задарч, хэд хэдэн овгийн дундаас хүмүүсийн өөр шинэ нэгдэл үүсэх болжээ.

Ийм шинэ нэгдэл үүсэх үйл явц түүхэн тодорхой цаг хугацааг хамран явагдсан нь овгийн байгууллын задралыг илтгэн харуулж улмаар төр, улс үүсэн тогтох нөхцөл

бүрэлдэхэд хүргэсэн аж. МЭӨ 2 дахь мянган жилд монгол нутагт амьдарч байсан овог аймгийн нийгэмд хүй нэгдлийн овгийн байгууллын задрал хүчтэй явагдсанаар нийгмийн бүтцийн шинэ хэлбэрүүд бүрэлдэж эхэлсэн юм /44.175/ хэмээн түүхийн шинжлэх ухаанд нэгэнтээ нотолсон бөлгөө.

МЭӨ III зуун болж ирэхэд овгийн байгууллын задрал эцсийн шатандаа орж, аймгийн холбоод үүсэв. Энэ нь монгол газар нутагт анхны улс, төр үүсэх угтал болжээ.

Монгол нутагт амьдарч, түүхийн сурвалжид тэмдэглэсэн аймаг овгийн дотроос анхных нь Ди нар байжээ. Ди зэрэг монголжуу шар арьстай овог аймгууд нь монгол, түрэг, манж-тунгус угсааны аймаг овгуудын өвөг дээдэс бөгөөд монгол оронд байсан хэсэг нь монгол угсаатны өвөг дээдэс²/44.183/ болсон байна. Хүрлийн үеийн монгол нутагт Ди, Хянь Юнь, Хяньюй, Жун, Гүй, Ху, Дунху, Сихү, Хүннү, Жич, Юэчжи, Динлин зэрэг гол төлөв монгол угсааны аймаг овгууд оршиж байв. Үүнээс Ди нар монгол нутагт оршин амьдарч умард Ди /бэйди/ цагаан ди гэсэн хоёр хэсэгт хуваагдаж байсан аж. Эртний хятадууд бэйди /умард ди/ нарыг Хань юнь, Хяньюй, Гуй гэх зэргээр нэрлэсний доторхи Хянь, Хунь, Гуй үгс нь Хун, Ху хэмээн дуудагдан цаашид Ху, Хун, Хүннү гэдэг нэрээр монгол угсаатан аймгуудыг нэрлэдэг байжээ. Хүннү нарын талаарх түүхийн судалгаанаас үзэхэд Энэтхэг, АНУ, Түрэг болон Европын олонхи улс оронд “Хүннү” нарын нэрийг гол төлөв “Хүн”, Хятад, Монгол, Орос улсад “хүннү” нэрийг “Хүннү”, “Сюннү”, “Хүннү-Сюнү” хэмээн нэрлэх уламжлал тогтож иржээ /43.186,187/. Төмөр зэвсгийн үеэс Хүннү нар 24 аймаг болж хуваагдан тус бүрдээ бие даан аж төрж байв. Нэг талаар овгийн байгуулалт задарч, цусан төрлийн барилдлага суларч, гэр бүл, өмч хөрөнгө, эрх мэдлийн харилцааг хүй нэгдлийн байгууллын үеийн овог аймгийн зохион байгуулалт, уламжлал, зан заншил зохицуулж чадахгүйд хүрэв. Үүн дээр нэмж тэмдэглэвээс зохих зүйл бол дэлхийн дорно, өрнийн газар нутагт шинэ соёл иргэншил бүхий суурьшмал амьдралтай улсууд үүсэн хөгжиж байсан үйл явц монголчуудтай хөршлөн оршдог улс орнуудаар /Хятад, Энэтхэг зэрэг/ дамжин монголд нөлөөлж байсан явдал мөн. Тухайлбал, МЭӨ дөрөв дэх мянган жилийн үеэс Миссир, Египет, Шумер, Вавилон, Энэтхэг, МЭӨ III-II дахь мянган жилд Хятад, Ассир, Финики, МЭӨ нэгдэх мянган жилд өмнөд Арабын Сабей, Азийн Сири, Өвөр Кавказын Урарат, Иран зэрэг дорно дахины соёл иргэншилт суурьшмал улсууд тогтнон хөгжсөн байна. Мөн Өмнөд Европын нутагт МЭӨ гуравдахь мянган жилд Крит /арал/, МЭӨ хоёрдахь мянган жилд Микенд, МЭӨ нэгдэх мянган жилд Грек, Ром, Византид өрнөдийн суурьшмал соёл иргэншил үүсэн хөгжиж /90.688-696/ байсан нь монголчуудад аль нэг хэмжээгээр мэдрэгдэж хөрш улсууд, худалдаачид, жуулчдын мэдээллээр дамжин нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй билээ. Нөгөө талаар МЭӨ 307 онд байгуулагдсан умард хятадын Чжао улс, Янь улс, МЭӨ 221 онд байгуулагдсан умард

Хятадын Цин улсын байнгын довтолгоон нь Хүннүчүүдэд хүчээ нэгтгэн нэгдмэл зохион байгуулалтад орохыг шаардсан байна.

Ийм түүхэн нөхцөлд МЭӨ 209 онд Модун Хүннүгийн 24 аймгийг нэгтгэн Хүннү улсыг анх үүсгэн байгуулжээ. Хүннү улс нь Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ анх удаа одоогийн Монгол Улсын нутгаар төвлөрөн бүрэлдэн тогтсон цоо шинэ улс байсан ажээ. Анхны улс болох Хүннү бүрэлдэн тогтсон цагаас 1125 онд Хятан улс мөхөх хүртэлх мянга гурван зуу гаруй жилийн хугацаанд Сяньби, Тоба, Муюн, Ухуань, Жужан, Түрэг, Уйгур, Хятан улс ээлж дараалан оршин тогтнож байжээ. Дээрхи улсуудыг Монголын түүхэнд эртний улсууд³ хэмээн нэрлэдэг. Эртний улсуудыг монгол угсаатны байгуулсан улсууд, монгол бус угсаатны байгуулсан улсууд гэж хуваадаг явдал бий. Монгол угсаатны байгуулсан улсуудад Хүннү, Сяньби, Муюн, Тоба, Ухуань, Жужан улс, монгол бус угсаатны байгуулсан улсуудад Түрэг, Уйгур, Хятан улс хамаарагдана. Сүүлийн үед эрдэмтэн, судлаачид Хятан улсыг монгол угсаатан улсад хамааруулан нотлох болсон нь ажиглагднам.

Монголын эртний улсууд нь Хятадын их цагаан хэрмээс Байгал нуур хүртэлх нутаг дэвсгэрт оршин тогтнож, түүн дээр амьдарч байсан хүмүүсийг харъяалан захирч, улс бүр өөрийн нутаг дэвсгэр, төр, хууль цааз, цэрэг, захиргааны тогтолцоо, нүүдэлчдийн маягийн аж амьдрал, соёл иргэншлээ төвхнүүлэн хойч үедээ уламжлагдах олон нандин өвийг үлдээжээ.

Эртний монгол угсаатны байгуулсан улсуудад монголчууд нь улс, төрөө байгуулан толгойлж, төрийн байгууллаа тогтоон, хууль цаазаа батлан мөрдөж, харъяат иргэдээ захиран засаж байжээ. Харъяалан захирах иргэдийн дотор монголчуудаас гадна монгол бус угсаатан иргэд оршин амьдарч, монголчуудын байгуулсан төрд харъяалагдан захирагдаж байв. Түүнчлэн монгол бус угсаатны байгуулан төвхнүүлсэн улсуудад монголчууд харъяалагдан захирагдаж, соёл иргэншлээ хадгалж, амьдарч байсан болой.

Төв Азийн нутгаар төвлөрөн оршиж байсан эртний улсууд нь овгийн байгууллын заримдаг шинжийг агуулахын хамт, нийгэм, улс төр, эдийн засаг, хууль цаазын шинэ тогтолцоонд шилжин, тэдгээрийг бүрэлдүүлэн бий болгох замаар замнаж, хөгжлийн түвшин нь хүн төрөлхтөний соёл иргэншлийн дундат үеийн, түрүү үеийн хэмжээнд байсан ажээ. Доктор Г.Сүхбаатар Хүннү, Сяньби, Жужан, Хамаг Монгол Улсуудын түүхийг олон жилийн турш судалж “Хүннү, Сяньби, Жужан зэрэг эртний нүүдэлчдийн түүхэн хөгжлийг нягтлахад түрүү феодализм⁴ монгол нутагт мянга гаруй жил үргэлжлэн хөгжиж дөнгөж XIII зууны эхээр дууссан байна” /64.90/ гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Тэгвэл Монголын нэгдсэн улсын түүхийг гүнзгий судалсан академич Ш.Нацагдорж “Монголын нэгдсэн улс байгуулагдахаас өмнөх ханлигууд нь /хант улс/ аймгийн холбоо бус түрүү үеийн феодалын улс мөн” /50.38/ гэжээ. Феодалжих үйл

явц удаан үргэлжилэх нь ерөнхийдөө хүн төрөлхтөний түүхэн дэх түгээмэл үзэгдэл байсан ажээ. Оросын нэрт түүхч А.П.Новосельцев, В.Т.Пашуто, Л.В.Черепнин нар “Эцгийн эрхт хүй нэгдлийн байгууллаас феодализм аажмаар тун удаан урган гарсаар феодализмыг ялуулсан нийгмийн эргэлт нь олон зуун жил үргэлжилснийг Европын түүх гэрчилж байна” /127.21/. Мөн Оросын түүхч Ю.В.Кичановский “Эртний дорно дахин, Колумбын өмнөх африк, Колумбын өмнөх Америкийн нийгэм нь бүрэлдсэн ... нийгэм болохдоо, мөн болчихсон хойноо урьдах хэлбэршлээс /формацаас/ үндэстэй хүй, овгийн бүтцийг хадгалсаар байсан юм” /107.120/ гэж дүгнэн бичсэн байдаг.

Эдгээрээс үзэхэд монгол оронд түрүү феодализм удаан хугацаагаар үргэлжилсэн нь хүн төрөлхтөний түүхийн хөгжлийн зүй тогтолд түрүү феодализмд шилжих удаан хугацааны үйл явцыг өөртөө агуулсан үзэгдэл байсан нь тодорхой байна.

Түүхээс үзэхэд “Герман, Слав, Япон, Солонгосчууд, Төв Азийн нүүдэлчид цөм иймэрхүү замаар хөгжсөн байна” /90.264/. Харин нүүдлийн соёл иргэншилтэй улс болохын хувьд монголын эртний улсууд өөрийнхөө нийгэм-эдийн засаг, газар нутаг, соёл, зан заншлаа тусгасан байснаараа ихээхэн онцлогтой болой. Эдгээрээс үүдэн эртний улсуудын төр, эрх зүй нь дундад үед шилжих шилжилтийн заримдаг шинжийг илэрхийлж байсан хэмээн үзэж болно. Ингэхдээ эхний улсаас сүүлийн улс хүртэл төр, эрх зүйн хөгжил нь өмнөх уламжлалаа залгамжлан эрчимтэй хөгжсөн гэдгийг анхаарвал зохино. Эртний улсуудын төр, эрх зүй нь монголын дундат үеийн төр, эрх зүй үүсэн хөгжих нөхцлийг бүрэлдүүлж, түүний үр үндэс нь болсон ажгуу.

§2. Эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, судалгааны тойм

Эртний улсууд нь монголын нутаг дэвсгэр дээр оршин тогтнож байсан нүүдлийн соёл иргэншилтэй, жилийн дөрвөн улиралд зохицон ус, бэлчээрийн зохистойг сонгон нэг нутгаас нөгөө нутагт нүүдэллэн аж төрж амьдардаг онцлогтой бөлгөө. Тэгээд ч эл онцлогт нийцсэн төр, эрх зүй бүхий ард түмэн байсан ажгуу.

Монголчууд тухайн цаг үед тогтсон бичгийн соёлгүйн улмаас тэдний түүх шастир Уйгур, Хятад, Перс, Армянчуудын бичиг, тэмдэглэлүүдэд хадгалан үлджээ. Ингэхлээр “Аугаа их монголчуудын түүхийн он дарааллын бичгийг тэдний дайснууд л хамгийн сайн үйлдэж байсан байна” /20.10/ гэж Гарольд Дэмбийн бичсэн бодит байдлыг анхаарахын ялдамд тэдгээрийн сурвалж бичигт монголчуудын тухай дурдсан баримтыг нягтлан судалж ашиглах нь төр, эрх зүйн түүхийн хувьд эх сурвалжийн ач холбогдолтой хэмээн үзвэл зохино. Учир нь эртний дэлхий дахины өөр улсууд ялангуяа хөрш улсын бичмэл түүх, шастирт монголчуудын удам угсаа, газар нутаг, эрхлэх аж ахуй, худалдаа арилжаа, соёл, зан заншил, төрх төлөв, аж амьдрал, нүүдэл

суурьшил, төр, түүний бүтэц, дотоод, гадаад бодлого, хаад ноёд, элч түшмэл, дайн байлдаан, гэрээ хэлэлцээр, хууль цааз гэх мэт тэдгээрийн нийгэм, эдийн засаг, соёл, мэдлэг ухаан зэрэг өргөн хүрээнд хамаарах эерэг ба эерэг бус шинжтэй олон янзын мэдээлэл баримтыг тэмдэглэсэн байдгийг болгоон үзэхээс өөр аргагүйг анхаарах нь зүйтэй болов уу. Эдгээр баримт, мэдээллийг шинжлэх ухааны дэвшилт арга, арга зүй, технологиор боловсруулж өөрийн улсын төр, эрх зүйн түүхийг бичих нь бидний хувьд чухал ач холбогдолтой бөлгөө.

Эртний улсуудын төлөөлөгч болох Хүннү, Сяньби, Тоба, Муюн, Жужан, Түрэг, Уйгур, Хятан улсуудын судлал олон зуун жилийн турш хөгжиж бие даасан салбар болсныг түүх нэгэнтээ хүлээн зөвшөөрсөн билээ. Үүний нэг гол тулгуур нь сурвалж бичгүүд мөн юм. Монголчууд хятадтай мөнхийн хөрш байсны улмаас хятадын нутагт оршин тогтнож байсан суурьшмал улсуудын түүх нь монголчуудын төр, эрх зүйн түүхийг судлахад түүхэн ач холбогдолтой болно. Баруун Хань улсын түүх /Ханьшу/, Суй улсын түүх /Суй шу/, Шинэ түүх /Синь Тан шу/, Түүхэн тэмдэглэл /Ши-Цзу/, Өмнөд Ци улсын түүх /Нань Ци шу/, Ляо улсын түүх /Ляо-Ши/, Цинь улсын түүх /Цзинь шу/, Хожуу Хань улсын түүх /Хоу Хань шу/ гэх зэрэг төрийн түүхийн бичигт эртний монголчууд, тэдний төр, хууль цаазын түүхийн баримтууд аль нэг хэмжээгээр тэмдэглэн үлдсэн нь ихээхэн үнэ цэнэтэй мэдээллүүд мөн юм.

Эдгээрийн дотроос Хятадын түүхч Сыма Цянь /МЭӨ 145-МЭ 871/-ний бичсэн “Түүхэн тэмдэглэл” хэмээх 130 бүлэг бүхий бүтээлийн 110 дугаар бүлэг нь зөвхөн Хүннү нарт зориулагдсан байдаг. Мөн Бань-гу /МЭ 32-92/-ийн бүтээсэн “Баруун Хань улсын түүх” 120 бүлэг зохиолын Хүннүгийн бүлэг, Фань Е /398-445/-ийн бичсэн “Зүүн Хань улсын бичиг” 130 бүлэг бүхий зохиолын Хүннүгийн бүлэг зэргийг онцлон дурдаж болно. Доктор Г.Сүхбаатар хятадын 24 төрийн түүхээс дөрөвт нь Хүннүгийн тухай тусгай бүлэг буй боловч эдгээр 4 түүхийн бичгийн бусад бүлэгт ч Хүннүгийн тухай мэдээлсэн, тодотгосон, нөхвөрлөсөн зүйлс нилээд байдгийг тэмдэглэсэн байдаг бөлгөө./64.9/. Цзинь улсын судрын 97 дугаар бүлэг, Чжэн Сюй-Тянь-Линий “Си хан Хой-Янь”-ийн 40 дүгээр бүлэг, Ли Янь-Шоугийн “Умард төрийн түүх”-ийн 98 дугаар бүлэг, Чжэн Цяо “Тун-Чин”-гийн 199, Ма дуань-Линь “Вень-Сянь Тунхао”-гийн 340-341 дүгээр бүлэгт “Хүннү нар, түүний урьд, хожид үеийг судлахад сурвалж болох ихээхэн материалыг хятад түүхч нар үлдээсэн байна” /43.40/.

Эртний улсууд болох Сяньби, Ухуаны тухай “Зүүн Хань улсын түүх”-ийн 120 дүгээр бүлэг, Чэнь-Шоугийн “Гурван улсын ойллого бичиг”-ийн 1 дүгээр хэсэг, Вэй улсын судрын 30 дугаар бүлэг, Чэнь Иогийн “Сүй улсын судар”-ын 96 дугаар бүлэг, Сюй Тянь-Линь “Дун хан Хай-Яо” судрын 40 дүгээр бүлэгт Сяньби улсын мандсан ба хожуу үеийн гол төлөв улс төрийн түүхэнд холбогдох материалууд тэмдэглэн үлдээжээ

/43.40/. Бас Вэй улсын тухай сударч Вэй Шоу-гийн “Вэй улсын судар” хэмээх түүх, “Умард төрийн түүх”-д Тоба-Вэй улсын урьд, хожуу үеийн түүхийг бичсэн нь буй.

Мөн Жужан /Нирун/ улсын тухай YI-YIII зууны Яо Сы-Лянь-ий “Лин улсын түүхийн судар”-ын 54 дүгээр бүлэг, Тан улсын үеийн сударч Ли Янь-Шоу-гийн “Өмнөд төрийн түүх”-ийн 79 дүгээр бүлэг, мөн “Умард төрийн түүх”-ийн 98 дугаар бүлэг, XII зууны үеийн Чжэн Цяо-гийн зохиосон “Тун Чжи”-гийн 199-200 дугаар бүлэг, “Вэнь Сянь Тунхао”-ийн 342 дугаар бүлэгт Жужан улсын төрийн түүхийг судлахад холбогдох нилээд баримт тэмдэглэн үлдээжээ. /43.40/

1950 оны сүүлчээр хятад эрдэмтэд “Хятадын төрийн түүхэн дэх харь угсаатны тухай тусгай тэмдэглэлүүдийн эхний хэсгийг хоёр боть болгон эмхэтгэн хэвлүүлжээ. Энэ бүтээлд Жужан /Нирун/-ны тухай тусгай тэмдэглэл анх удаа бүрэн бүтнээр хэвлэгдсэнийг нь Жужаны судлалд том ахиц болсон” /65.4/ хэмээн билгүүн доктор Г.Сүхбаатар тэмдэглэсэн байдаг. Мөн 1962 онд Хятадын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн Жужан улсын төрийн түүхэнд холбогдох хятад сурвалж бичгийн мэдээг түүхэн он дарааллаар нь байрлуулсан бүрэн эмхэтгэлийг “Нируны тухай хэрэглэгдэхүүний эмхэтгэл” нэртэйгээр хэвлүүлсэн нь Жужаны судлалд шинэ үеийг нээсэн байна. /65.5/

Монгол нутагт оршин тогтнож байсан Түрэг, Уйгур улсын тухай баримт мэдээлэл хятад судар түүхэнд тэмдэглэн үлдсэн байна. YII зууны үеийн түүхч Вэй Чжэний “Суй улсын судар”-ын 84 дүгээр бүлэг, Ли Янь-шоугийн “Умард төрийн түүх”-ийн 9 дүгээр бүлэг, X зууны үеийн түүхч Ли Сюань-ны “Тан улсын судар”-ын 194, 195, 198, 199 дүгээр бүлэг, X зууны үеийн Ван-Пу-гийн “Тай Хай Яо”-ийн 94, 96, 98 дугаар бүлэг, XI зууны Су-Янь-Сюй-гийн “Тан улсын шинэ судар”-ын 215, 217 дугаар бүлэг, XII зууны үеийн Чжэн-Цяо-гийн “Тун чжи”-гийн 199, 200 дугаар бүлэг, Ма Дуань-Лин ий “Вэнь-Сянь-Тунхао”-ийн 343, 344, 347 дугаар бүлэгт Түрэг, Уйгур ба тэдний нэгэн удмын аймгуудын тухай мэдээлэл тэмдэглэн үлдсэн байна /43.40/.

Эртний улсуудын сүүлчийнх нь болох Хятан улсын тухай мэдээлэл хятадын түүхэн сурвалжид нилээд баялагаар тэмдэглэн үлдсэн хэмээн түүхч судлаачид үздэг бөлгөө. Ялангуяа YII зууны үеийн түүхч Вэй Чжэний “Сүй улсын судар”-ын 84 дүгээр бүлэг, “Тай Хай-Яо”-гийн 96-р бүлэг, Вэнь-Шиний “Туэхао”-гийн 345, 346 дугаар бүлэгт Хятан, Шивэй, Си /Кумо-Си/ нарын тухай арвин материал байдаг ажээ /43.40; 12.22/. Тэрчлэн хятад хэлээр зохиогдсон “Ци-дань-Го-Чжи”, “Да-Чзинь-Го-Чжи” болон Юан улсын үеийн түүхч То-То Тогтуга-гийн зохиосон “Ляо улсын судар”, “Цзинь улсын судар”-т Хятан, Алтан улсын харилцааны тухай нилээд баримт материал орсон байдаг ажээ. /12.22-23/

Дээр өгүүлсэн хятадын сурвалж бичиг, тэдгээрт тэмдэглэгдсэн баримтуудаас үзэхүл монгол нутагт оршин тогтнож байсан монголын эртний улсуудын тухай мэдээ,

баримтууд эхний улс-Хүннүгээс эхлээд сүүлчийн улс болох Хятад улсыг багтаасан төр, эрх зүйн түүхэнд холбогдох үлэмж материал байдаг нь тодорхой байна. Хэдийгээр эдгээр төрийн түүх нь хятад нутагт оршин байсан Хятадын улсуудын түүх боловч хөрш монголчуудын тухай, тэдгээрийн улс төрийн нэгдлүүд, гарал үүсэл, төр, хууль цаазын тухай тэмдэглэн үлдсэн мэдээ, баримт нь монголын эртний улсуудын төр, эрх зүйн түүхийг судлахад холбогдох эх сурвалжийн шинжтэй хэрэглэгдэхүүн болж иржээ. Монгол Улсын түүхч, хуульч, монголыг судлаачид эдгээр мэдээлэл, баримтыг эх сурвалжийн түвшинд авч үзэн судалж ирсэн ба цаашид ч улам лавшруулан судлах шаардлагатай бөлгөө.

Эртний улсуудын төр, эрх зүйн түүхийг судлахад монголын нутагт явуулсан археологи, этнографийн шинжилгээ, судалгааны үр дүн чухал ач холбогдолтой.

Хүннүгийн түүхэнд холбогдох археологийн анхны том бүтээл нь Хараа голын ойролцоох Ноён уулын Сүжигт, Зурамтын аманд 1924-1925 онд П.К.Козловын удирдлагаар Хүннүгийн булш малтаж бичсэн шинжилгээний тайлан /43.12/ байжээ. Энэхүү тайлан нь Хүннү судлалын хөгжилд асар их түлхэц болжээ. /65.12/

Монголын түүхч, археологич Ц.Доржсүрэн монгол нутагт Хүннүгийн 43 булшийг малтсан шинжилгээ, Ц.Доржсүрэн, В.В.Волков нарын хамтран 1962-1976 онд Ховд, Архангай аймаг, Улаанбаатарын орчимд хийсэн археологийн шинжилгээ, В.В.Волков, Д.Наваан нарын Хэнтий, Дорнод, Архангай, Хөвсгөл, Өвөрхангай аймагт нийт 50 орчим булшийг малтан шинжилсэн дүн, алдарт түүхч Х.Пэрлээгийн Монголын эртний үеийн хот суурингуудын судалгаа, П.Б.Коноваловын Өвөрбайгаль дахь Хүннүгийн булшийг малтсан харьцуулсан судлал, археологич Д.Навааны Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга ууланд Хүннүгийн булшийг шинжилсэн дүн, академич Б.Я.Владимирцовын Хэрлэнгийн Тэрэлжид явуулсан Хүннүгийн булшны шинжилгээ, доктор Н.Сэр-Оджавын Чехсловакийн эрдэмтэдтэй хамтран явуулсан Түрэгийн булш, түүх дурсгалын зүйлсийг шинжилсэн судалгаа, мөн Х.Пэрлээ, Д.Цэвээндорж, Д.Эрдэнэбаатар, Д.Баяр зэрэг монгол судлаачдаас Монгол-Оросын, Монгол-Унгарын, Монгол-Германы, Монгол-Францын, Монгол-Унгар-Зөвлөлтийн, Монгол-Орос-Америкийн хамтарсан экспедицид оролцон олон аймаг сумын нутагт хийсэн шинжилгээний дүн нь монгол нутагт оршиж байсан эртний улсуудын төр, эрх зүйн түүхийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болж ирсэн бөлгөө. Энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний тайлангууд биет байдлаараа төдийгүй, эдгээрийн үр дүнд тулгуурлан дотоод, гадаадын судлаач, эрдэмтдийн бичсэн тодорхой сэдэвт бүтээлүүд олон гарсан бөгөөд тэдгээр нь бүхэлдээ эртний улсуудын төр, эрх зүйн янз бүрийн талыг хамарч, эх сурвалжийн шинжтэй үнэтэй нээлтүүд хийснийг онцгойлон тэмдэглэж болох билээ.

Үүнээс гол гэж хэлж болохоор эрдэм шинжилгээ, судалгааны томоохон бүтээлийг дурдвал: С.В.Киселев “Монгол орон эрт цагт” /1947/, “Эртний Монголын хотууд” /1968/, В.В.Радлов “Орхоны шинжилгээний ангийн бүтээлүүд” /I, II, III, IV боть. 1892-1899/, П.Козлов “Умард Монгол. Ноён уулсын дурсгалууд” /Л.,1925/, А.М.Бернштамын “Ноён уулын Хүннүгийн булшнууд, түүний түүх, археологийн ач холбогдол” /1947/ “Монголын археологийн эмхэтгэл” /1962/, Ж.Цэвээн “Монголын эртний судлалын асуудал” /1976/, С.И.Руденко “Хүннүчүүдийн соёл ба ноён уулын хөндийнүүд” /1962/, Э.А.Новгородова “Эртний Монголчууд” /1989/, “Монголын хадны зураг”, С.И.Малов “Эртний түрэгийн бичгийн дурсгалууд” /1951/, Н.Сэр-Оджав “Эртний түрэгүүд” /1970/, Ц.Доржсүрэн “Умард Хүннү”, Х.Пэрлээ “Монгол түмний гаралыг тамгаар хайж судлах нь” /1975/, “Хятан нар, тэдний Монголчуудтай холбогдох нь” /1959/, “Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон” /1956/, Д.Цэвээндорж “Монголын эртний урлагийн түүх” /1983/ зэрэг болно. Үүнээс гадна Монголын ба Олон улсын шинжилгээний ангиудын тайлан, олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл байдаг нь монгол нутагт оршин байсан эртний улсуудыг судлахад их үнэтэй сурвалж мөн.

Монголын эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн эх сурвалжийн бас нэг чухал эх төрөл бол эрдэмтэн судлаачдын үе үеийн туршид бүтээн туурвисан ном зохиол аргагүй мөн бөлгөө. Олон орны эрдэм номтой хүмүүсийн оюуны эдгээр бүтээл нь үнэ цэнийхээ хувьд асар их гэдгийг хүлээн зөвшөөрөх нь хамгаас шударга болой.

1240 онд туурвисан “Монголын нууц товчоо”⁵ хэмээх түүхнээ мөнхөрсөн алдарт бүтээл нь монголчуудын удам угсаа, овог, аймгийн түүхийг Монгол мэлмийгээр нь тодорхойлон гаргаснаараа эртний улсуудын төр, хууль цаазын олон чухал мэдээг агуулж байдаг бөлгөө.

Ираны их түүхч Рашид-ад-Дины 1310 онд бичсэн “Судрын чуулган”⁶ зохиолын 1-р боть нь монголын эртний улсуудад холбогдох алтан хэрэглэгдэхүүн болох нэн үнэтэй материалыг агуулж байгаагаараа түүхнээ алдаршсан билээ. Рашид-ад-Дин “Судрын чуулган” бүтээлээ туурвихдаа олон хэл мэддэг монгол эрдэмтэд болон, Чингис хааны алтан ургийн түүхийн тухай өгүүлсэн “Алтан дэвтэр”⁷ хэмээх монгол зохиолыг ашиглан бичснийг сурвалж бичигт дурдсан байдаг. Үүн дээр В.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгуулал” номыг нэмэн судалбаас асар их өгөөж хуримтлагддаг бөлгөө. Н.Я.Бичурин, В.С.Таскин, Н.В.Кюннер хэмээх Оросын нанхиадч эрдэмтэд “Ши Цзи”, “Цинь Хань Шу”, “Хоу хань шу” гэсэн хятадын судар дахь Хүннүд холбогдох материалыг орчуулан хэвлэхийн хамт хэд хэдэн судалгааны өгүүллийг бичсэн нь Хүннү судлалд асар чухал ач холбогдолтой нь нэгэнтээ хүлээн зөвшөөрөгдсөн бөлгөө.

Японы эрдэмтэн К.Сиратори хятадын сурвалжуудыг нягтлан үзэж, Төв Азийн нүүдэлчдийн түүхийг судалж “Хүннү ямар угсаатанд хамаарагдах вэ”, “Хүннү Дунху нарын хэлний тухай”, “Хүннү угсаатны тухай”, “Монгол үндэстний гарвал”, “Монгол түрэгийн гарал” зэрэг бүтээл нь /64.11/ Монгол, Түрэг угсаатны судалгаанд өөрийн гэсэн байраа эзэлдэг аж.

К.Иностранцовын “Хүннү ба Гунны” /1926/, Л.Н.Гумилевийн “Хятад дахь Хүннү нар”, “Хүннү, Дундат Ази ба эртний үе” /1960/, “Хүннү” /1960/, Ф.Айлтхамын “Хүннү нарын түүх” 4 боть /1969/, О.Мэнчэн Хэлфэний “Хүннү нарын ертөнц” /1973/ О.Голлын “Ираны Хүннү нар”, Х.Шрайберын “Хүннү нар” /1976/, Упенро Такурын “Энэтхэг дэх Хүннү нар” /1967/, Хятадын түүхчдийн хэвлүүлсэн “Хүннүгийн материалын тухай цуглуулбар”, “Уйгурын тухай материалын цуглуулбар”-ыг хятад эх сурвалжийн баримтуудад тулгуурлан бичсэн нь эртний улсуудын төр, эрх зүйн түүхэнд холбогдох олон чухал баримт мэдээллийг агуулсан байдаг.

Эртний улсуудын түүхэнд холбогдох зохиол бүтээлд монгол эрдэмтэд дорвитой хувь нэмэр оруулж, олон бүтээлийг туурвиж, хойч үедээ үлдээсэн болой. Ц.Доржсүрэнгийн “Умард Хүннү” /1961/, “Хүннүгийн шинэ суурин” /1986/, “БНМАУ-ын нутагт байсан эртний улсууд” /1955/, Г.Сүхбаатарын “Монголчуудын эртний өвөг” /1980/, “Сяньби” /1971/, “Монгол Нирун улс” /1992/, Ж.Хандсүрэнгийн “Жужан улс”, Н.Сэр-Оджавын “Эртний түрэгүүд” /1970/, Х.Пэрлээгийн “Хятан түүний монголчуудтай холбогдох нь” /1959/, Д.Гонгорын “Халх товчоо” II боть /1970/, Л.Мөнх-Эрдэнэийн “Европын Хүннү ба Атилла” /2000/ зэрэг бүтээлийг онцлон тэмдэглэж болох юм. Дээр дурдсан эрдэм шинжилгээний зохиолууд нь монгол нутагт оршин байсан эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн баримтыг хамарч байгаагаараа нэн чухал юм.

Эртний улсуудын төр, эрх зүйн түүхийг судлах сурвалж бүтээлд Монгол Улсын түүхийн бүтээлүүд зүй ёсоор хамаарагдаж, тулгын чулуу нь олж ирснийг тэмдэглэх нь зүйтэй юм. Үүнд, Монгол Улсын түүх⁸ ба БНМАУ-ын түүх⁹ гэсэн тулгуур бүтээл хамаарагдана. Мөн А.Амарын “Монголын товч түүх” /1992/, Ч.Бат-Очирын “Монгол Улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг” /1928/, Л.Дэндэв “Монголын товч түүх” /1934/, “БНМАУ-ын түүх” /нэгэн боть. 1954/, “БНМАУ-ын түүх” тэргүүн боть /1966/, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын “Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал” /1997/, “Монгол Улсын түүх” тэргүүн боть /2003/ зэрэг нь дэлхийн Монгол судлал, Монгол Улсын эрдэмтдийн судалгааны ололт, амжилтыг аль болохоор өргөн тусгаж, “Монголын түүхийг бүхэлд нь дэс дараатай улируулан авч үзсэн” /43.6/ бүтээл болохын хувьд Монгол Улсын төр, эрх зүйн түүхийн тулгуур хэрэглэгдэхүүн болох онол, түүх, арга зүйн их ач холбогдолтой болой.

Дээр дурдсаныг болгоон үзвэл монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн судлалд холбогдох эх сурвалжийн материал арвин агаад үүнийг хичнээн гүнзгий судалваас эл үеийн төр, эрх зүйн түүхийн судлалд төдий чинээ бодитой нөлөөлөх үндэслэлтэй бөлгөө.

Монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг, эрдэм шинжилгээний бүтээлийн тойм ийн оршвой.



Ноён уулнаас олдсон Хүннү ширмэл ширдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Хүннү улсын төр, эрх зүй
/МЭӨ III- МЭ 93/

§1.Хүннү улсын оршин тогтнохуй.

МЭӨ III зууны сүүлчээр Модун шаньюй /209-176/ умард, өмнөд зүгийн олон аймгийг нэгтгэн Хүннү улсыг үндэслэн байгуулжээ. Модун шаньюйгийн үед Хүннү улсын нутаг дэвсгэр нь өмнө зүг цагаан хэрэм, Ордос нутаг, умар зүгт Байгал нуур, баруун зүгт Ил тарвагатай, Синьзянь, Дорно зүгт Солонгос хүртэл уудам их болжээ.

Монгол нутаг дээр үүсэн тогтсон Хүннү улс өргөн уудам нутаг дэвсгэр бүхий монгол ба монгол бус олон угсаатан иргэдийг харъяалан захирч, Төв Азид бараг дөрвөн зууны турш оршин тогтнож нүүдэлчдийн болон дорнод, өрнөдийн соёл иргэншилд гүн ул мөр үлдээсэн түүхтэй. Алив “нийгмийн үзэгдэл юмсыг түүхэн тодорхой нөхцөлтэй нь холбож тухайн оюунлигийн түвшинд нь авч үзэх ёстой” гэсэн үзэл бодлыг урьдал болгож, “түүхийг тухайн тодорхой нөхцөлд тэр үеийн сэтгэлгээний түвшинд нь судлах зарчмын” үүднээс нягтлан үзбээс Хүннү улсын төр, эрх зүйн түүхийг МЭӨ III-МЭ I зууны үеийн бодит нөхцөл, орон зай, цаг хугацаанд нь авч үзэх явдал түүхэн үнэнийг мэдэх, ойлгох, зүй зохистой сургамж авах, уламжлалыг нь хойч үедээ өвлүүлэн үлдээхэд үлэмж үнэ цэнэтэй юм.

Хүннү улсын төр, эрх зүйн түүхийг судлахдаа Хүннү судлалд¹⁰ хамаарах түүхэн эх сурвалж, эд өлгийн соёл, хүмүүсийн амьдрал, зан заншил, түүхэн үйл явдал, гадаад орчин зэрэг хүчин зүйлтэй нягт холбон судалж, мөн тухайн цаг үеийн нийгмийн сэтгэлгээний түвшинг анхааран харгалзах нь зайлшгүй буюу.

Хүннү нь түрүү үеийн феодалын улс байв. Үндсэн аж ахуй нь сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй¹¹ байжээ. Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэдэг нь тухайн байгаль, газар зүйн өвөрмөц нөхцөлд таван төрлийн малыг маллагааны нарийн технологийн үндсэн дээр үржүүлж аж ахуйн үндсэн салбар болгон, аж ахуйн талаар цогцолбороор ашиглаж, ан агнах, багахан тариаланг туслах аж ахуйн байдлаар ашигладаг нүүдлийн мал аж ахуй юм /64.215/. “Хүннүчүүдийн үндсэн аж ахуй болох нүүдлийн мал, аж ахуйн малын толгойн тоо, сүргийн бүрэлдэхүүн, бүтээгдэхүүний ерөнхий байдал, малыг маллах ба аж ахуйд хэрэглэх арга хэлбэр, түүнтэй холбогдсон тоног хэрэгсэл, туслах чанарын аж ахуйн төрөл зэргийг үзэхэд тэдний аж ахуй нь сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуйн шатанд бүрэн орсон байсан” /64.215/ хэмээн монголын түүхийн нэгэн зохиолд бичжээ. Нүүдлийн ийм сонгодог хэлбэрийн аж ахуй нь Хүннүчүүдийн нийгмийн хөгжилд хөдөлгөгч хүчин зүйл болон үйлчилж байлаа.

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд тэд хятад сурвалж дахь бичгийн мэдээг нягт харьцуулан судлаад “Монгол нутагт амьдарч байсан Хүннүгийн өвөг аймаг бол Гуйфан, Вэйфан, Гуньи, Сянь Юнь, Сюньюй, Но хой жун, умард ди аймгууд юм” /65.192/ хэмээн нотолсон байна. Дээр дурдсан аймгуудын урт хугацааны хөгжлийн явцад Хүннү хэмээх монголчуудын төлөвшилт явагдан монгол угсаатны цөм болж, түүнийг нь илэрхийлэн харуулсан нэгэн нийтлэг шинж бүхий газар нутаг байгаль газар зүйн орчин, эдийн засаг, аж ахуй, соёл, заншлын хэв маяг бүрэлдсэн амой. Хүннүчүүд монгол угсаатан мөн болохыг Монгол оронд явуулсан түүх археологи, антропологи, угсаатны зүйн шинжлэх ухааны судалгаа, ололт, эд хөрөнгө, мал сүрэг, соёлын хэрэглэгдэхүүний талаар олсон олдвор баримт материал баталж байгаа билээ. Н.Сэр-Оджав, В.В.Волков, Д.Наваан, Э.А.Новгородова, Д.Дорж, И.Эрдели, Ц.Доржсүрэн, А.В.Давыдова, хэл судлаач Ма Чан-шөу, Я.Прушек, Л.М.Мюлли, В.Эберхард, Ван Го-Вэй, Мэн Вэньтун, Чэнь-Мэн-Цзя, О.Прицак, Р.Грусе, Х.Кордьер, П.Пеллио, Ф.Хирт, К.Сиратори, А.П.Окладников, Н.Н.Мамонова, Т.Тотын, Л.Н.Гумилев зэрэг судлаачийн бүтээлүүд Хүннүгийн монгол хэмээсэн гарал үүсэл, удам угсааг тодорхойлоход их үүрэг гүйцэтгэсэн юм. Доктор Г.Сүхбаатар “Хүннүд холбогдох антропологийн мэдээнээс үзэхэд Хүннү нарыг монгол угсаатан гэж бүрэн болно” /64.163/ хэмээн дүгнэсэн байна. Хүннүгийн үеэс эхлээд газар нь нүүдлийн соёл иргэншилт монгол орны хувьд амьдралын чухал нөхцөл болохын хамт мөн нэгэн зэрэг хөдөлмөрийн зүйл, хөдөлмөрийн хэрэгсэл болж, түүнийг гол төлөв малын бэлчээрийн хэлбэрээр ашиглах явдал хэвшин тогтсон онцлогтой. Үүнтэй холбоотойгоор нийгмийн үйлдвэрлэл нь тэдний үндсэн аж ахуй болох нүүдлийн мал аж ахуй болж байв. Хүннү улсын үеэс газрыг улс оршин байхын үндэс хэмээн төрөөс эрхэмлэн хамгаалж байсан ажгуу. МЭӨ 198 онд Хүннү улс хятадын Хань улстай газар нутаг, хил хязгаарын асуудлаар гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түмэн газрын цагаан хэрмээс өмнөх газрыг хятадын хаан, цагаан хэрмээс хойшхи газрыг Хүннү улсын хаан захирахаар тогтоосон байна. Энэ тухай хятадын сурвалж бичигт “Урт хотоос /Цагаан хэрэм/ хойш нум сум барьсан улс шаньюйн цаазыг дагатугай. Урт хотоос дотогш дээл, малгайн улсыг би захиртугай” /64.94/ гэж зарлигласныг “Баруун Хань улсын түүх”-ийн 94 дүгээр дэвтэрт тэмдэглэжээ. Хүннү улс Хятадын Хань улстай гэрээ байгуулсан нь өөрийн газар нутаг, хил хязгаарыг албан ёсоор тогтоож, улсынхаа бүрэн эрхт байдлыг баталгаажуулсан улс төр, хууль зүйн ач холбогдолтой байв.

Хүннүгийн газар нутагтай харьцах, түүнийг хамгаалах, ашиглах, эзэмших, өмчлөх нь нүүдлийн соёл иргэншил, түүний үндсэн хэв шинж болсон мал аж ахуйтайгаа салшгүй холбоотойг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Хүн ам нь бараг үндсэн /дийлэнх нь/-дээ мал аж ахуйгаа эрхэлж, түүнээ шүтэн жилийн дөрвөн улирлын турш нүүдэллэн амьдардагаас чухам энэ л хэрэгцээг хангахад газар нутаг нь зориулагдах

явдал зайлшгүй бөгөөд зүй тогтолт шинжтэй байсан гэж хэлэх бүрэн үндэслэлтэй бөлгөө. Сыма Цзяний “Түүхэн тэмдэглэл”-д “Хүннүгийн малын олонхи нь адуу, үхэр, хонь, ямаа. Этгээд мал гэвэл тэмээ, илжиг, луус, куайти, тадту, таньси юм. Тэд өвс, ус эрэн нэг нутгаас нөгөөд ажил эрхэлдэггүй боловч хувь газартай... Тэд тайван цагт мал маллахын зэрэгцээгээр араатан, жигүүртэн агнаж амьжиргаандаа нэмэрлэдэг заншилтай” /134.34/ гэж тэмдэглэжээ. Эндээс Хүннү нарын эрхэлдэг аж ахуйн ерөнхий дүр зураг харагдаж байна. Доктор Г.Сүхбаатар чухам үүнээс дүгнэлт хийн, Хүннү нар “Мал аж ахуй голлон, ан агнан, нүүдэллэж амьдардаг нь тодорхой боловч малын тоо, сүргийн бүрэлдэхүүн, мал ажиллагааны байдал зэрэг нь мэдэгдэхгүй байна /64.22/” гэж өгүүлжээ. Хүннү судлаачид энэ асуудалд анхаарлаа хандуулж олон чухал баримтуудыг гарган тавьсан байдаг. Японы эрдэмтэн Н.Эгами МЭӨ 72 онд Хятадын цэрэг 6 замаар Хүннүг довтлох үеэр олзолсон хүн ба дээрэмдэж авсан малын тоог харьцуулан үзээд “Хүннүгийн нэг хүнд 19 толгой мал ногдож байсан” /64.29/ гэсэн тоо гаргажээ. Оросын эрдэмтэн И.М.Майский 1918 оны Монголд явуулсан мал тооллогын мэдээг баримтлан нэг хүнд 17,8 толгой мал ногдож /122.127/ байсантай харьцуулбал тун ойролцоо маягийн дүн харагднам. Мэдээж эдгээр нь бүрэн бус мэдээлэл боловч анхаарвал зохих баримт мөн нь тодорхой байна. Хүннүгийн мал сүргийн тоо, түүний бүрэлдэхүүний харьцаа ямар байсныг археологийн шинжилгээний дүнгээс харж болох юм. П.К.Козлов, Ц.Доржсүрэн зэрэг Монгол, Оросын эрдэмтэд, археологичдын Хүннүгийн үеийн булш, суурин, түүх дурсгалын зүйлсийг судалсан шинжилгээний дүнгээс үзэхэд Хүннүчүүд таван хошуу малыг голлон эрхэлж байсан нь харагдаж байна. Ганцхан жишээг авч үзэхэд Иволголын Хүннүгийн сууринг малтахад гарсан бүх малын ясны 22 хувийг хонины, 17 хувийг үхрийн, 12 хувийг адууны, 4 хувийг ямааны яс эзэлж байсан аж /64.30/. Үүнчлэн Хүннүгийн үеийн булшны дийлэнх нь ийм дүр зургийг үзүүлдэг юм.

Хүннүчүүд нүүдлийн мал аж ахуйг голлон эрхлэхдээ түүндээ тус нэмэр болгохын тулд ан, ав хийж, бага зэргээр тариа тарьж, гахай үржүүлж байсан ажээ. Сурвалж бичигт тэмдэглэснээс үзэхэд Хүннүчүүд тус тусдаа буюу олуулаа ав хийдэг байжээ. МЭӨ 160 онд Модун шаньюй 100000 морьт цэрэгтэйгээр их ав хийж байсан удаатай /134.30/. Түүхийн сурвалж бичгээс үзэхэд Хүннүчүүд хангайн нурууны урд шувтарга орчим Орхон, Хэрлэн, Туул зэрэг том голын хөндийгөөр тариа, будаа тарьж байжээ.

Оросын эрдэмтэн П.Ф.Кононков, С.Н.Кононкова нар “Монголын ардын тариаланд 13 янзын хар будаа байгаа эртний уламжлалтай бөгөөд бүр Хүннүгийн үед тарьж байсан нь сонирхолтой” /114.84/ хэмээн бичжээ. Дээрхи эрдэмтэд монгол нутаг дахь тариалан Хүннүгийнхтэй холбоотой байж болох юм. Монголын тариалангийн голомт үндсэндээ гол мөрний хөндийгөөр байсан тухай /114.13/

Хүннү нар МЭӨ 66 онд баруун, зүүн их жанжныг тус бүр 10000 гаруй морьт цэрэгтэйгээр баруун хязгаарт /Синой/ явуулж цэргийн тариалан тариалж байсан тухай сурвалж бичигт тэмдэглэсэн нь бий. Монголын ноён уулын булш, Баруун дөрөөгийн хэрэм, Иволголийн балгас зэрэгт явуулсан археологийн шинжилгээгээр хар будаа, улаан буудайны үр, хүрз, анжисны хошуу, зээтүү зэрэг тариалангийн багаж олдсон байдаг /27.20; 74/. Энэ мэтийн баримтууд монгол дахь археологийн шинжилгээгээр олонтоо илэрсэн байдаг бөлгөө.

Дээр дурдсан баримт, дүгнэлт нь Хүннү улсад ан ав, газар тариаланг амьдралын гол хэрэгцээг хангах бус, тус нэмэр болгох зорилгоор баг сагаар эрхэлж, амьдрал ахуйдаа хэрэглэж байсныг харуулж байна. Харин нүүдлийн мал аж ахуй амьдралын гол хэрэглээ болохын хувьд айл өрх бүрийг хамран, зайлшгүй хэрэгцээт зүйлүүдэд зориулагдан, өөрийнхөө жам ёсны дагуу хөгжиж байв. Учир нь мал аж ахуй нь нүүдэл суурьшил ан ав хийх, алба татвар залгуулах, цэрэг байлдаанд орох, өргөө сууц төхөөрөх, хувцас хунар, гэр орон, ахуйн хэрэгцээт зүйлсийг үйлдэх, малаа маллах, ашиг шимийг нь авах, ашиглах, худалдаа арилжаа явуулах, хоол хүнсээ хангах, үр хүүхдээ өсгөн бойжуулах, үр удмаа үлдээн хадгалах зэрэг насан туршийн ба өдөр тутмын амьдралын тогтвортой бөгөөд найдвартай хэрэгцээ болж цааш цаашдын уламжлал, хөгжлийг агуулж байсан ажгуу.

Хүннү улсын төрийн бодлогын нэг чухал чиглэл нь алба гувчуур юм. Хүннү улс харъяат хүн амаасаа алба гувчуур авч байсан аж. Чухам хэдий хэмжээний юу авдаг байсан нь сурвалж бичигт тодорхой бичигдээгүй. Юун боловч тэр гувчуур Хүннү улсын шаньюй тэргүүтэй төрийн түшмэдийн хэрэгцээнд зориулагдаж байсан нь маргаангүй гэж Хүннү судлаачид тодорхойлсон байдаг /68.67/.

Төрийн онолын үүднээс төр үүсэж, оршин тогтнохын нэг гол нөхцөл нь алба татвар байдаг учир Хүннү улсад алба гувчуур үүсэн үйлчилж байсан нь зүй тогтлын хувьд маргаангүй юм. Хятадын “Ши Цзи” хэмээх сурвалж бичигт “Намар морь таргалахад Дайлиньд Их хуралдаан хийж хүн амын тоог бүртгэн шалгадаг” цаашилбал “Хүн ам, мал хөрөнгийг тоолон гувчуур авах бүртгэл хөтлөхөд шаньюйн шадар хүмүүсийг сургасан хэмээн МЭ III, II зуунд холбогдох баримтуудад тэмдэглэсэн нь Хүннү улсад алба гувчуур авахын тулд жил бүр хүн, малын бүртгэл гаргадаг байсныг харуулж байна.”

Энэ бол алба гувчууртай байсныг нотлох баримт мөн. Ингэхдээ алба гувчуурыг хүн, малын тоог харгалзан оногдуулж байсан бололтой.

Хүннү улс эзлэгдсэн орноос алба авдаг журам тогтоон мөрдөж байжээ. МЭӨ 198 онд Хүннү, Хань улс хоёрын гэрээгээр Хань улс жил бүр Хүннүд тогтоосон хэмжээний торго, бөс бараа зэргийг өгч байжээ.

МЭӨ I зууны үед Ухуаньчууд Хүннүд жил бүр барьдаг үхэр, адуу, хонь, арьс шир нийлүүлэх албаа хугацаа хожимдуулсан учир Хүннүчүүд довтолж байжээ. Дээрхи хоёр баримтаас үзэхэд Хүннү улс эзлэгдсэн орноос гэрээ хийж түүнээ үндэслэн торго, бөс бараа, бод, бог мал болон малын арьс ширээр жил бүр алба авдаг байсан нь тодорхой бөлгөө.

Хүннү улс Модун шаньюйгийн үед Дундат Азийн орнуудыг эрхшээлдээ оруулаад “тунпу ду Вэй” хэмээх алба татвар хураах ажлыг хариуцсан тусгай захиргаа байгуулан жичжу вангаар захируулж байжээ. Тус захиргаа эдгээр орноос тариа, будаа, гар урлалын зүйлээр алба оногдуулж, хураах ажлыг хариуцан гүйцэтгэж байсан байна. Эзлэгдсэн орноос авдаг алба нь Хүннүгийн төрийн түшмэдийн хэрэгцээг хангахад зохих байр суурь эзэлж, цэргийн зардалд зарцуулагдаж байсан бололтой.

Хүннү нь өөрийн бичиг үсэгтэй¹² улс байв. Хүннү бичиг үсэгтэй байсан нь Төв Азийн нүүдэлчдэд бичиг үүсч дэлгэрсэн ерөнхий үйл явцын салшгүй хэсэг байсныг анхаарахгүй байж үл болном. Доктор Ч.Далай Хүннү нар бичигтэй байсан гэх бүрэн үндэслэл байгааг хэд хэдэн хүчин зүйлээр нотлон тодорхойлжээ. Үүнд: *Нэгдүгээрт*, Хүннүгийн нийгэм бол онолын хувьд бичиг хэрэглэх шатанд хүрсэн. *Хоёрдугаарт*, Хүннү нар гадаад харилцаа ба дотоодын нийгмийн хэрэгцээнд ямар нэг бичиг хэрэглэж байсан. *Гуравдугаарт*, Модун шаньюйгээс эхлэн хятадын хаанд захидал илгээж байсан. *Дөрөвдүгээрт*, Хүннүд дагаар орсон Чжунхан Юэ хүн ам, мал хөрөнгийг тоолон, гувчуур авах бүртгэл хөтлөхөд шаньюйн шадар хүмүүсийг сургасан. *Тавдугаарт*, МЭ 46 онд Хятадад Хүннүгийн газрын зураг өгснийг /64.112/ нягтлан үзээд тус улс бичиг үсэгтэй байсан гэсэн дүгнэлт хийсэн бөлгөө.

Хятад сурвалж бичигт Хүннү нар бичигтэй байсан тухай бичсэн нь бий. Хятадын түүхч Фэн-Цзя Шэнь, Ма Чан-Шоу нар Хүннү нар хятад бичиг хэрэглэж байсан /64-113/ гэж бичжээ. Хүннү улсад хятад бичгээс гадна өөр Дундат Азид хэрэглэгдэж байсан бичгийн аль нэгийг хэрэглэж байсан байх боломжийг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Е.Блогис “Хүннү нар МЭӨ III зууны үед ямар нэг армей бичгээс зээлдэж авсан бичигтэй байсныг нь Жужанаар дамжуулсан Түрэгчүүд уламжлан авсан” /64.115/ хэмээн үзэж байжээ.

МЭӨ IV-II зууны үед армей бичгийн үндсэн дээр Согд бичиг үүсэж эхэлжээ хэмээн Б.Г.Гафуров үзсэн байна /64.114/. Хүннү улс бичигтэй байсныг нотлох өөр нэг баримт нь Европын хүннү нар бичиг үсэгтэй байсан явдал юм.

Европод Атилла хааны үед бичиг үсэгтэй байсан болон Кавказын Хүннү нар руни бичиг хэрэглэж байсан хэмээн эрдэмтэд баримтаар нотолсон нь бий. “Герман, Скандинавын руни бичиг, монголын археологийн тамга, тэмдэг, хятадын утга бичиг дэх зарим тэмдэг мөн тэр үед байсан болохоор Орхон-Енисейн бичгийг хүннүгийн үеэс

хойшгүй үед үүссэн бөгөөд хүннү нар хэрэглэж байсан гэж үзэх үндэс байна” гэсэн дүгнэлтийг доктор Г.Сүхбаатар хийсэн байдаг /64.123/. Доктор А.Лувсандэндэв, Төв Азийн нүүдэлчдийн бичгийн хөгжлийг судлаад “Хүннү нарт Орхон бичгийн цагаан толгойн дээр үндэслэсэн бичиг байх нь бүх талаар маш магадтай” /130. 187,188/ гэж дүгнэжээ. Л.Н.Гумилев “Хүннү нар бичигтэй байсан” гэж бичжээ /97.98/. Хэл бичиг судлаач Б.Сумьяабаатар уйгур монгол үсгээр бичсэн үгийн хэлбэрийг монгол үсгийн хамгийн эртний хэлбэр гэж үзсэн байдгийг дурдвал зохино.

Ийнхүү Хүннү судлаачдын дийлэнх нь тус улсад өөрийн бичиг үсэгтэй байсан төдийгүй энэхүү уламжлал нь дараа дараагийн улсад өвлөгдсөн нь түүхэн баримтуудаар батлагдаж нэгдмэл дүгнэлтэд хүрсэн ажгуу. Хүннү нь үлэмж их газар нутагтай улс байв. Тус улсын баруун хил нь Ил Тарвагатайн нуруу, хойд хил нь Байгаль нуур, зүүн хил нь Солонгосын хойг, өмнөд хил нь хятадын Цагаан хэрэм хүрч байжээ. Хүннү нь өрнө, дорныг эзэлсэн хүчирхэг улс байв. Модун шаньюйгийн үед Хүннү нь 36 улсыг байлдан эзэлж захирч байсан хэмээн сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Модун шаньюй МЭӨ 176 онд Хятадын хаанд баруун хязгаарын 26 улсыг түвшитгэн Хүннүгийн захиргаанд орууллаа гэж бичиж байжээ /134.43/. “Монгол Улсын түүх” /2003/ зохиолд Модун шаньюйгийн үед “Тухайн үед хүн амын тавны нэгээс дөрөвны нэг нь цэрэг болдог байсан учир Хүннүгийн хүн амын тоо 1 сая 350 орчим байсан” /43.227/ хэмээлтэй. Гэсэн ч Хүннү улс мөхсөний дараа Ар Монголд 100000 өрх буюу 5-6 зуун мянган Хүннү үлдсэн. Өмнөт Хүннүд 237000 хүн дээр 100000 умард Хүннү нар нийлсэн, баруун зүг нүүсэн умард Хүннүгийн тоо 100000 орчим байсан гэж үзвэл Хүннүгийн хүн амын тоо 1,7 сая байсан баймаар. Хүннү нь өргөн уудам газар нутаг, харъяалан захирсан хүн ам, төрийн хүчирхэг тогтолцоо, хууль цааз, өөрийн гэсэн өвөрмөц соёл, бичиг үсэг, аж төрөх ёстой Төв Азийн нүүдэлчин ард түмний хүчирхэг улс бөгөөд тив дэлхийн соёл иргэншлийн түүхэнд баларшгүй ул мөрөө үлдээж үлэмж чухал үүрэг гүйцэтгэсэн бөлгөө. Хүннү гүрэн МЭӨ 55 онд умард, өмнөд Хүннү болон хуваагджээ. Умард Хүннүг¹³ Жи-жи шаньюй толгойлох болсон хэдий ч хүчирхэг Сяньбийн захиргаанд ихэнх хэсэг нь нэгдэн орж, үлдсэн нь МЭ 155 оноос өрнө зүгт нүүдэллэн явжээ. Нүүдэлчин Хүннү явсаар МЭ IY зууны дунд үеэс Европын түүхэнд Хүн буюу Гунну нэрээр гарч иржээ /49-8/. Умард Хүннүгийн нүүдэл нь замд тохиолдсон хүмүүсийг хөдөлгөөнд оруулж, “ард түмнүүдийн их нүүдэл” үүсэхэд хүргэж улмаар Европын буюу “өрнөд”-ийн ард түмний шинэ нийтлэг бүрэлдэн тогтоход хүчтэй нөлөө үзүүлжээ. Энэ үйл явцын үр дүнд ром, герман угсааны ард түмнийг багтаасан Европын буюу өрнөдийн ард түмний нийтлэг бүрэлдэн бий болсон түүхтэй.

Европод нүүдэллэн очсон Хүннү нарын тоо тодорхойгүй боловч МЭ 430 онд Атилла хааны үед 600-700 мянган Хүннүчүүд байсныг түүхэнд тэмдэглэжээ /49.8/.

Хүннү нар нь Монголын Хүннү, Хятадын Хүннү, Энэтхэгийн Хүннү, Дундад Азийн Хүннү, Европын Хун гэх зэргээр нэрлэгдэж түүхнээ үлдсэн нь Хүннүчүүд олон улсад шингэн амьдарч байсныг харуулахын хамт, Хүннүгийн соёл дэлхий дахинаа түгэн дэлгэрснийг нотолж буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл Хүннүчүүд дэлхий дахины хүрээнд удам угсаагаа үлдээсэн ард түмэн болой. Үүнийг зөвхөн монголын түүхчид, монгол нутагт хийсэн археологийн шинжилгээний дүн төдийгүй Хятад, Орос бусад олон оронд хийсэн археологийн шинжилгээ болон Ф.Айлтхаймын “Хүннү нарын түүх” 4 боть, Э.Мэнчен-Хэлфены “Хүннү нарын ертөнц”, О.Голлын “Ираны Хүннү нар”, Бактрын “Энэтхэгийн түүхийн баримт” 4 боть, Х.Шрайберын “Хүннү нар”, Упендра Тагурын “Энэтхэг дэхь Хүннү нар” гэсэн судалгааны ном нотлон харуулдаг юм. Хүннү нарыг Утигур, Кутригур гэсэн хоёр хүүтэй нэгэн хаан захирч байв. Эл хааныг насан өөд болсны дараа Хүннүчүүд хоёр хуваагдан Утигур, Кутригур хэмээн нэрлэгдэх болжээ. Хүннүчүүд Ругила хааны үед нэгдмэл байдалтай болж ирснийг Атилла¹⁴ хаан бүрмөсөн нэгтгэж нэгэн захиргаанд оруулж Хүннү гүрнийг байгуулжээ.

Атилла хаан /445-453/ МЭ 450 онд Хүннүг хүчирхэгжилийн туйлд хүргэсэн байна. Хүннү улс өрнө зүгт Рейн мөрөн, дорно зүгт Ижил мөрөн, умар зүгт Балтын тэнгис, өмнө зүгт Адриатын тэнгис Ирантай хиллэсэн асар уудам газар нутгийг эзэмшиж, герман, славян, скиф болон бусад нүүдэлчин ард түмнийг харъяалан захирч байжээ /49.40/. Атилла хаан “нутаг дэвсгэрийн хэмжээгээр Чингис хаан, түүний хөвгүүд, ач нарын байгуулсан Монголын их гүрний дараа орохуйц их гүрнийг тэднээс зургаан зуун жилийн өмнө Европоор төвлөрүүлэн байгуулсан хэрэг билээ” /49.15/ Тэрээр олон жил төрийн эрх барьсан хугацаандаа Хүннүгийн хүчирхэг улс байгуулж, Европын ард түмнийг Хүннү нарын манлайлал дор нэгтгэж, түүхийн аугаа их хаадын нэг болсон билээ.

Тэр бол Европчуудыг захирсан цорын ганц харь угсаатны нүүдэлчид, монголчуудын өвөг дээдсийн удмын хаан байсан /49.70/ ажээ. Атилла хаан бол Европ дахь Хүннү улсын их хаан, сод жанжин, онцгой дипломатч, түүхийн аугаа их хаадын нэгэн байсан аж. Атилла хаан МЭ 450 онд насан эцэслэжээ. Хүннү нар IY зууны дунд үест Европын түүхийн тавцан дээр бие тодрон гарч ирээд 300 гаруй жил буюу YII зууны сүүл хүртэл оршин тогтнож Европ тивийн түүхэнд өөрийн гүнзгий ул мөрөө үлдээн, түүхэн хувь нэмрээ оруулсан бөлгөө.

§2. Хүннү улсын гадаад харилцаа.

Хүннү улс тэр үеийн Хятадын Хань улстай зэрэгцэхүйц Төв Азийн том улс байв. Төв Азийн хүчирхэг том улсын хувьд Хүннү улс биеэ даасан гадаад бодлого явуулж, улс хоорондын харилцаа, гадаад худалдаагаа хөгжүүлж байсан ажгуу.

Хүннү улс урд хөрш Хань улстай харилцаа холбоогоо хөгжүүлж, худалдаа арилжааг өргөжүүлэхийг гадаад бодлогынхоо нэг гол чиглэл болгосон байна. Эл хоёр улс бие биерүүгээ довтолох, найрамдах, гэрээ, хэлэлцээр байгуулах, элч, төлөөлөгч илгээлцэх, бэлэг зүйлс солилцох, худ ураг боллоцох, алба барилцах зэрэг үйлдэл, үйл ажиллагаа байнга явуулж байжээ.

Сурвалж бичгээс үзэхэд Хятадын У-ди хааны үед /МЭӨ 140-87/ МЭӨ 129-90 хүртэлх хугацаанд Хүннү рүү 16 удаа, МЭӨ 72 онд Хятадын таван жанжин их цэргийн хүчээр Хүннү рүү довтолж байсныг тэмдэглэжээ. Хань улсын Гао-ди /Лю бан/ хаан МЭӨ 198 онд Пинчэ хотод Хүннү нарт бүслэгдэн ялагдах болмогц Хүннүд элч илгээн Модун шаньюйтай найрамдал, ургийн гэрээ байгуулж, хоёр хилийг цагаан хэрмээр тогтоон, алба барьж, хятадын Хань улсын хааны гүнжийг шаньюйд хатан болгон өгч байсныг Баруун Хань улсын түүхийн 74 дүгээр дэвтэрт бичсэн ажээ. Энэ гэрээг зарим үед лавшруулан баталж, хоёр зуу гаруй жилийн турш хэвээр баримталсаар иржээ /64.95/. Мөн Хань улсын Сяо-Вэньди /Лю-Хэн/ хаан МЭӨ 162 онд Лаошан шаньюйд илгээсэн захидалдаа “Хальсан эзний дээд зарлигаар цагаан хэрэмнээс хойшхи нум сум агсагчдын улс нь шаньюйгийн засгийг дагаж, цагаан хэрэмнээс урагшхи түшмэдийн бүс, малгай өмсөгчид суудаг орон нь харин надад захирагдана ... Хань, Хүннү хоёр бол мөр зэрэгцэх хүчирхэг хөрш улсууд юм” /134.47-48/ хэмээн бичсэн болой. Хүннүгийн шаньюй Учжулю Жоти МЭӨ 8 оны үед Хятадын эзэн хаад Сяо-Сюань /МЭӨ 74-49/, Сяо Юань /МЭӨ 49-33/ “... Цагаан хэрэмнээс хойшхи бүхэн нь Хүннүд харьяалагдана” хэмээн зарлиг буулгасан хэмээжээ. Хүннүгийн шаньюй МЭӨ 1 оны үед яг тэр санааг давтан хэлсэн болой. Тэгээд ч Сяо Сюань эзэн хааны үеийн Хүннү, Хятадын гэрээ бичмэлээрээ Хүннүд хадгалагдаж /34.53/ байжээ.

Мөн Зүүн Хань улсын анхны хаан Гуан /МЭ 25-57/ найрамдлаа сэргээхээр Хүннүд бэлэг бүхий элч илгээж байсан байна.

МЭӨ 51 онд Хүннүгийн шаньюй Хуханье хятадад айлчлах асуудлыг хятадын хаан Сюань-ди түшмэдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн Хань улстай зэрэгцэх хүчирхэг том улсын хэмжээнд хүлээн авсан бөлгөө. Хятадын нийслэл Чаньян хот хүртэлх замын дагуу 7 муж тус бүр 2000 цэргийн хүндэт харуулаар угтан ёсолж Хятадын Ганьцюань ордонд залрахуйд хаан өөрөө тосон авч гүн хүндэтгэл үзүүлжээ /134.99/

Эдгээр баримт нь Хүннү, Хань хоёр улс эвтэй найртай байх бодлого баримталж байсны илэрхийлэл мөн. МЭӨ 3 онд Хүннүгийн Учжуль жоти шаньюй Хятадад айлчлах хүсэлт тавьсан авч хятадын Ай ди хүлээн авахыг татгалзсаны улмаас харилцаа муудаж байв. Хятадын хаан Ван Ман /МЭ9-23/ ч мөн дайсагналцах бодлогыг дэвэргэж байсан байна. Эдгээрээс шалтгаалан мөргөлдөөн довтолгоон үргэлжилж, МЭ 33-45 онд хоёр улсын хооронд 4 удаа дайн болсон удаатай.

Харин МЭ 50-иад оны эхнээс Хүннү, Хятадын эвийн харилцаа сэргэх болсон байна. Хятадын хаан МЭ 50 онд Хүннүгийн шаньюйд элч илгээж, үлэмж их бэлэг барьснаар хоёр улсын харилцаа хэвийн болж 198 оны гэрээ сэргэсэн болой /134.72/.

Хүннү умард, өмнөд Хань, баруун, зүүн Хань улс болж хуваагдсан болон хүчирхэг өөр аймаг, улсууд тогтон хөгжсөн нь Хятад, Хүннүгийн цаашдын харилцаанд хүчтэй нөлөөлж, түүхэн үр дагавар үлдээсэн бөлгөө. Хүннү, Хань улс эвтэй найртай байхын хирээр хоёр улсын худалдаа арилжаа сэргэн хөгжиж байв. Тус хоёр улсын хоорондын худалдаа нь нүүдэлчид, суурьшмал иргэдийн худалдаа, арилжаа болж хөгжсөн онцлогтой. Хүннү нарын мал, мал аж ахуйн бүтээгдэхүүн, ангийн үс нь суурьшмал иргэдэд зайлшгүй хэрэгцээтэй байсны адил Хүннүчүүдэд суурьшмал иргэдийн үйлдвэрлэдэг гурил, будаа, чихэр жимс, хувцасны төрөл бүрийн материал, гэр ахуйн сав суулга, аяга таваг, тогоо шанага гэх мэт зүйл мөн ч зайлшгүй хэрэгцээтэй байсан билээ. Хүннү улс барууны улс орнуудтай харилцаа тогтоож худалдаа арилжаа хийх бодлого явуулсан байна. Барууны 20 гаруй улс оронтой харилцаж, элч төлөөлөгчид солилцон, худалдаа арилжаа хийж байсан ажгуу. Ялангуяа Туркестан, Усунь, Лоулань улс, Бага ази, Кавказ, Дон, Ижил мөрөн, хар тэнгисийн хавийн улс орнуудтай харилцаа холбоо тогтоож байжээ. Хүннү улс МЭӨ I зуун хүртэл “торгон зам”¹⁵-ыг мэдэлдээ байлган хянаж байсан нь худалдаа арилжаа хөгжихөд ихээхэн нөлөөлсөн бололтой. Торгон зам Дорнод Туркестанаас Монголд шууд нэвтрэн орж байсны дээр одоогийн Монгол орны урд хэсгээр өнөөгийн Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутгаар дайран Бархөл хот ордог “шар зам” буюу худалдааны жингийн зам Хүннүгийн гадаад харилцаа, худалдааны хөгжилд түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн бөлгөө. Хүннү улс гадаад харилцаанд баримтлах зарчим, ёс горимыг бий болгон хэрэглэж байжээ. Хүннүгийн хаан нь “тэнгэрийн ивээлээр суусан” учир сүр хүчтэй байх, хааны элч бүхэн гэрэгээтэй явах, хааны элчийг хүлээн авах, элч хүлээн авах ажлыг төрийн тусгай түшмэл хариуцан гүйцэтгэх зэрэг ёсыг тогтоон хэрэгжүүлсэн нь их хаан, түүний төрийн бодлого, төрийн чиг үүрэг, түшмэдийн ёс бүрэлдэн төлөвшихөд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болой.

Хүннүгийн Модун шаньюй Хань улсын хаанд МЭӨ 176 онд илгээсэн захидлаа “Тэнгэрийн ивээлээр суусан Хүннүгийн их шаньюй эзэн хааны амгаланг айлтгаж байна” /134.43/ гэж эхлэн хааны нэр төр, эрх мэдэл сүр хүчийг илэрхийлэн бусад улс оронд хүргүүлэх албан бичиг, захидал, илгээлтээ хэрэглэдэг албан ёсны горим байсныг харуулмой. “Түүхийн тэмдэглэл” хэмээх хятадын эртний сударт МЭӨ 112 оны үйл явдлын талаар “Хүннүгийн хуулиар хятадын элч гэрэгэгээ гадаа орхиод, нүүрээ бэхээр будалгүйгээр шаньюйн өргөөнд орох эрхгүй байсан” /134.56-57/ тухай тэмдэглэсэн байна.

Гадаад улс орны элч төлөөлөгчийг хүлээн авах, хүндэтгэн харилцах, хэлэлцээр хийх, хаанд бараалхуулахад нь тусгайлан тогтоосон ёс журамтай байсныг эл баримт нотолж буй юм. Хааны элч, төлөөлөгчийг хүлээн авах ажлыг хариуцан тусгай түшмэл /Чэдиэ Цзянь чжэ/ ажилладаг байсан бөгөөд тэр нь элч төлөөлөгчийг хүлээн авах, байрлуулах, хооллуулах, дайлах, хэлцэл хийх, хаанд бараалхуулах, хүндэтгэн буцаах зэрэг үйл ажлыг эрхлэн гүйцэтгэж байсан амой. Түүхэн сурвалж бичигээс үзэхэд МЭӨ 122 онд Хүннүд ирсэн Хань улсын элчийг Шаньюй хүлээн авахын өмнө зочин эрхэлсэн түшмэл “Чжи кэ Цзянь Чжэ” хүлээн авч байсныг тэмдэглэжээ /134.58-57/.

Хүннүгийн шаньюйн элч нар хятад болон барууны орнуудад явахдаа шаньюйгийн олгосон гэрэгээг заавал авч явна. Хүннүгийн элч нар хятадын болон Дундат Азийн орнуудад явахдаа гэрэгээг үзүүлэн итгэмжлэгдэж үүргээ гүйцэтгэж байсныг сурвалж бичгүүдэд дурдсан байдаг. Жишээлбэл, МЭӨ 122, 125 онд Хятадад явсан Хүннүгийн хааны элч нар гэрэгээг үзүүлэн эзэн хаанд нь бараалхдаг байжээ.

§3. Хүннү улсын төрийн байгуулал

Шаньюй. Хүннү нь хаант засагтай улс байжээ. Хүннү гэдэг нь хятад дуудлагаар “Сюннү” гэдэг угсаатны нэрийг монголчилсон нэр ажээ. Хүннүгийн хааныг “шаньюй”¹⁶ хэмээнэ. Шаньюй нь Сюйлянъти овогт хамаарагдана. Шаньюйг “Тэнгэрийн хүү” /Чэнли гуту/ гэж өргөмжилнэ. Шаньюйг дуудахдаа “Чэнли гуту шаньюй” гэнэ. Шаньюй гэдэг үг нь өргөн уудам, чэнли нь тэнгэр, гуту хүү гэсэн утгатай. “Тэнгэр шиг уудам шаньюй” гэсэн утга нь шашны үүднээс тэнгэрээс заяасан хэмээсэн хааны гарвал, нэр сүрийг өргөн дээдлэх үзэл, бодлогод шилжиршин, “тэнгэрийн хүү” гэдэг ойлголт болон хаант засгийн ёс, эрх мэдлийн бишрэл, хүндэтгэлийг илэрхийлэн батажсан байна. Хүннүг үндэслэн байгуулсан анхны шаньюй нь Модун бөгөөд тэрбээр МЭӨ 209-134 онд төр барьж байв. Хүннүгийн түүхэнд Модун /МЭӨ 209-134/ Лаошан /МЭӨ 134-163/, Гунь-чэн /161-126/, Хуханье /МЭӨ 58-31/ хаан зэрэг 14 шаньюй нар ээлж дараагаар төр барьж байжээ.

Шаньюй нь төрийг тэргүүлэн их эрх мэдэл эдэлж байв. Шаньюй нь улсын хуралдааныг хуралдуулах, хууль дүрэм батлах, улсын гадаад, дотоод бодлогын асуудлыг шийдвэрлэх, Хятадын хаадтай захидлаар харилцах, гэрээ байгуулах, Хятад ба бусад орны элчин төлөөлөгчийг хүлээн авах, харь улсад дайн зарлах, довтлох, түмтийн дарга зэрэг том тушаалтныг томилох, огцруулах, шийтгэх, тэр ч байтугай алах бүрэн эрхтэй байжээ /64.56/. Модун шаньюйгээс эхлэн гагцхүү Сюйлянътай /Люанъти/ овгийн хүнийг шаньюйгаар өргөмжлөх ёс тогтжээ. Хүннүгийн шаньюй нарын үед төрийн тэргүүн хаан хүний бүрэн эрх, нэр төр, зэрэг, цол, ахуй хангамж, гадаад, дотоодод явуулах бодлогын үндэс бүрэлдэн бий болж эхэлсэн байна.

Хүннүд хаант төр тогтон цаашид уламжлагджээ. Шаньюй нь 24 аймгийн дарга нарын хуралдаанаар өргөмжлөгдөж байв. Хаан өргөмжлөгдөх нь хааныг тодруулан залах үндсэн зарчим болж төр, улсын цаашдын амьдралд уламжлал болон тогтсон аж. Энэ нь нэг ёсондоо түшмэдийн чуулган, хуралдай байсан бөгөөд хааныг сонгон шалгаруулж өргөмжлөх нь түүний үндсэн үүрэг юм. Хааныг сонгон тодруулж өргөмжлөхдөө угсаа залгамжлах зарчмыг баримталж, ихэнхдээ хан хүүг өргөмжилж байв. Хэдийгээр энэ нь гол зарчим болж төрийн амьдралд хэвшсэн ч гэсэн зөрчигдэх явдал тохиолдож байжээ. Жишээлбээс, Хуханье шаньюйг /МЭӨ 58-31/ хүртэл 14 шаньюй байсны найм нь эцгийгээ, гурван дүү нь ахыгаа хөнөөж, бусад нь угсаа залгаж өргөмжлөгдөх бус замаар хүч хэрэглэж хаан болж байсан ажгуу.

Хүннүгийн үед шаньюйд цол олгох ёсон бий болжээ. Модуныг залгамжилсан хүү, шаньюй Цзиюйд “Лаошан” хэмээх цол олгосон байдаг. Хүннүгийн шаньюй төрийн гадаад, дотоод бодлогыг тодорхойлох, хууль дүрэм батлах, засаг захиргааны хуваарийг тогтоох, төрийн байгууллагыг байгуулах, түшмэдийг томилох, цэрэг арми байгуулах, улсын цэргийг удирдах, алба татвар тогтоох, төрийн сан хөмрөгийг бүрэлдүүлэх, зарцуулах, хянах, газар нутгийг эзэмших, улсын хил хязгаарыг тогтоох, гэрээ хэлэлцээр байгуулах, гадаад орны элч төлөөлөгчдийг хүлээн авах, иргэнийг захирах, эрүүгийн бодлого явуулах, ял шийтгэлийн төрөл, хэлбэрийг тогтоох, ял оногдуулах зэрэг бүрэн эрхтэй байлаа. Ийм замаар хааны бүрэн эрх үүсэн хэлбэрших үйл явц явагдаж байсан бөлгөө. Шаньюй нь төрийг тэргүүлж, түүний хэргийг шийдвэрлэж, улсыг жолоодон, төрийн тамга, туг, исэр, шүхэр зэрэг төрийн бэлэгдлүүд бий болгон орд өргөөг байгуулсан түүхтэй. Хүннүд Модун шаньюйгийн үеэс төрийн бэлэгдлүүд бий болж хэрэглэсэн нь Хүннү хэмээх улс байгуулагдан, оршин тогтнож, тухайн үедээ түүхэн том үүрэг гүйцэтгэж байсны илэрхийлэл мөн. Монголын төрт ёсны томоохон бүтээл болох “Цагаан түүхэн”-д хааны есөн их бэлэгдэлд туг, исэр, тамгыг оруулан тодорхойлсон нь хүннүгээс уламжлалтай ч байж болох юм.

Хүннүгийн шаньюй төрийн тэргүүн болохыг илтгэн харуулсан хаш тамгайтай¹⁷ байжээ /134.84/. Доктор Г.Сүхбаатар “Хүннүгийн шаньюй төрийн бүрэн эрхт эзний бэлэгдэл болсон төрийн хаш тамгатай байсан” хэмээн нотолсон байдаг. Шаньюйн шийдвэр, албан бичиг, гэрээнд хаш тамга хэрэглэж байсан баримтууд түүхэнд тэмдэглэн үлдсэн нь цөөнгүй. Жишээлбэл, Түүхэн сурвалжид Хүннү улс сэргэн мандалтын эхнийхээ жилд Хятадад тамга дарсан захидал явуулж байжээ /134.45/. Мөн умард Хүннүгийн шаньюй МЭ 90 онд хаш тамга байсныг тэмдэглэсэн байна /134.84/. Төрийн тамга нь улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын илэрхийлэл болой. Хүннүгийн төрийн хаш тамгын бэлэгдлийг Монголын нэгдсэн улс төр хүчирхэг бат бэх байхыг бэлэгшээн уламжлан авснаас хойш Монгол төрийн

түүхэнд хаш тамгыг хэрэглэх болсон түүхтэй. Хятадын хаан Линди “Хүннү исэр”-г дуртай байсан хэмээн “Хао Хань шу” сударт тэмдэглэжээ. Исэр бол хааны сүр хүч, нэр төр, эрх ямбыг илтгэсэн албан ёсны хүндэтгэлийн тусгай суудал юм. Хаан энэ хүндэтгэлийн суудал дээр заларч үйл хэргээ явуулна. XIX зууны эхээр зохиогдсон “Кан-юй цин син” зохиолд “Хүннү исэр нь хөдөлдөг түшлэгтэй, зөрүүлсэн дөрвөн модон хөлтэй, арьсаар бүрсэн сандал юм” гэж В.Эберхард бичжээ /134.22-23/. Үүнийг Ноён уулын булшнаас олдсон археологийн олдвор давхар нотолдог юм /131.256/. Шаньюй их бэлгэдэлдээ төрийн туг хэрэглэж байв. Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” зохиолдоо Умард Хүннүгийн Чжиннем Шаньюй 5 өнгийн тугтай байсныг дурдсан /64.57/ байдаг.

Хүннүгийн хаан тусгайлан барьж байгуулсан орд өргөөтэй байв. Хааны орд өргөө нь төрийн тэргүүний үйл ажиллагаагаа явуулж, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг илэрхийлэн, аюулгүй байдлыг нь хангаж, аж төрж амьдрах байгууламж юм. Шаньюйн орд өргөө одоогийн Архангай аймгийн Хөшөө цайдам орчим байв. Хүннү нь нүүдлийн соёл иргэншилтэй улс хэдий ч төв орд өргөөнөөс нь өөр суурин газар, суурьшиж амьдрах ёс огт байгаагүй хэмээн үзэж үл болмой. Хүннүчүүдийн археологийн шинжилгээнээс үзэхэд Хятадад Хүннүгийн суурин газрыг “чэн” гэж тэмдэглэж байжээ. Энэ нь жижиг суурин гэсэн утгыг илэрхийлж байсан аж. Хүннүгийн суурингууд гэвэл, Газел /Инь Шань/ уулын хойно “Түмэн суурин”, Хархорум орчмын “Лу хот”, Хангайн нуруун дахь “Чжаосинь” суурин, Халхад байсан “Фаньфужэнь” /Фань хатны/ суурин, Төв аймгийн Баянжаргалан сумын Цагаан арал дахь “Туа дов”, Төв аймгийн Мөнгөн морьт сумын “Тэрэлжийн дөрвөлжин”, Хэрлэн голын “Бүрхийн дөрвөлжин”, Дорнод аймаг дахь “Баруун дөрөөгийн хэрэм”, Өмнөговь аймгийн “Баянбулаг” /64.36-38/ зэрэг сууринг нэрлэж болно. Хүннүгийн шаньюйгийн явуулсан төрийн дотоод, гадаад бодлого нь тус улсын бие даасан, тусгаар тогтносон, бүрэн эрхт байдлыг хангах, гадаад харилцааг хөгжүүлэх, Хүннү улсыг хүчирхэг болгох, шинэ засаг төрөө бэхжүүлэх, аж ахуй соёлоо дэмжин тэтгэхэд чиглэж байв.

Хүннүгийн шаньюй газар нутгийг улсын тусгаар тогтнолын гол хэмжүүр, түүнийг хамгаалах нь төрийн бодлогын цөм хэмээн ихэд анхаарч байжээ. Хүннү улсад газар улсын өмч бөгөөд түүнийг хувь газар болгон олгох, эзэмшүүлэх эрхийг гагцхүү шаньюй эдэлж байв. Энэ үүднээс шаньюй нь улсын газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах үүрэг хүлээж түүнээ хааны онцгой эрхэд хамруулж байсан аж. “Ши-Цзи”-ийн 8 дахь талд тэмдэглэснээр Модуныг шаньюй болмогц тухайн үедээ хүчирхэг байсан дорнод ху нар элч ирүүлэн Түмэн шаньюйд байгаа мянган газрын хүлэг морийг нь авъя” гэхэд шаньюй “Хөрш орноосоо нэг морь харамлаад айлсан тогтнож болох гэж үү” гээд морийг өгчээ.

Азнаж байснаа дорнод ху нар шаньюйд элч ирүүлж “нэг гүнжийг чинь авъя” гэхэд мөн л “Хөрш орноосоо нэг эм хүн харамлаад айлсан тогтнож болох гэж үү” гээд хайртай хатнаа дорнод ху нарт өгсөн байна. Дорнод ху нарын эзэн улам бардамнан төдий л удалгүй манай хоёрын хооронд хүн нутагладаггүй 1000 газар эзэнгүй байна гээд “Танай , манай хоёрын хил болох Одтогийн цаана эзэнгүй нутаг байна. Та нар түүнд хүршгүй. Бид авъя” гэжээ. Эл үед Модун маш их хилэгнэн “Газар бол улсын үндэс мөн. Яахан өгч болно” гээд газрыг өгнө гэсэн түшмэдийг цаазалж, цэрэг хөдөлгөн, дорнод ху нарыг гэнэт довтлон бут цохиж байжээ. Үүнтэй холбогдуулан Монгол, хятадын хилийг Түмэн газрын цагаан хэрмээр тогтоосон Хүннү, Хань улсын МЭӨ 198 оны гэрээг дурдаж болно. Эдгээр нь газар улсын оршин тогтнохуйн үндэс, улсын хил хязгаарыг тогтоон хамгаалах нь улсын тусгаар тогтнолын үндэс, газар нутгаа хайрлан хүндэтгэх нь төрийн тэргүүн, хаан хүний үүрэг хэмээхүйн баримт мөн. Улсын газар нутаг хэмээх нь улсаа, хаан эзнээ, ард түмнээ, тусгаар тогтнолоо, улсынхаа бүрэн эрх, халдашгүй дархан байдлыг юунд ч хуваагдашгүйгээр, юугаар ч солихгүйгээр шууд илэрхийлэн харуулдаг аугаа их хүч, материаллаг бодит зүйл ажгуу.

Хэдийгээр хаан газрыг өмчлөгч дээд эзэн бөгөөд улсын дэвсгэр нутаг улсын өмч байжээ хэмээн ерөнхийд нь хүлээн зөвшөөрдөг ч гэсэн Хүннү улс дахь газрын асуудал маш нарийн агаад өвөрмөц онцлогтой болох нь эрдэмтэд судлаачдын анхаарлыг ихэд татсаар ирсэн ажээ. Сыма-Цзянь, “Хүннү нар газар боловсруулалтыг эрхэлдэггүй боловч тус бүр мөн хувь газар /Фэньди/-тай. Хүннү улсын зүүн, баруун гарын бүх ван, жанжин, өөрөөр хэлбэл түмтийн дарга нар тус бүр өвс даган нүүх хувь газартай, гэхдээ зүүн баруун эцэн ван, зүүн баруун Гули ван нар хамгийн том эзэмшилтэй байсан” /134.40/ гэж бичжээ.

Хятадын Сыма-Цзянь, Бань-Гу зэрэг сударчид “Фэнь-ди” гэдгийг Хятадын “го” гэдэгтэй адилтгасан аж. В.С.Таскин, Хань улсын үед язгууртан нарт эзэн хаанаас олгосон феодалын эзэмшлийг “го”/фэньди/ гэж нэрлэдэг “хувь газар” байсан юм. “Хувь газар” гэдэг ойлголтод дэвсгэр нутаг, түүн дээр оршигч аль нэгэн тооны хүмүүс багтана. Гэхдээ газар бус харин хүмүүс нь хамгийн их ач холбогдолтой байв. Хүмүүсийн тооноос цэргийн тоо шалтгаалдаг байв /134.13/ хэмээн нотолсон байна. Ц.С.Таскин “хувь газар” гэдгийг ХҮИ зуун хүртэл Орост байсан оросын вангуудын феодалын газар эзэмшил гэж үзэж байжээ. Хүннүд холбогдох сурвалж бичгүүд дээр ажилласан эрдэмтэд мөн л ийм саналтай байв /64.62/. Чингэхдээ “хувь газар” бол хэлбэрээрээ удел ч бус, баруун европын аллод, бенефиум, феодал, лен, оросын вотчина, поместье-гийн аль нь ч бус. Эдгээр нь цөм гол төлөв Европод феодализм нилээд хөгжсөн үеийн феодалын газрын аль нэг хэлбэр учир Хүннүгийн нийгмийн төвшингээс хөгжлийн өөр төвшний үзэгдэл /64.62/ болов уу. Хүннүгийн нийгмийн амьдралыг нягтлан

үзвээс “Хүннү мэтийн нүүдэлчдийн “хувь газар” бол түмтийн дарга нар гэх ерөнхий нэрээр нэрлэгдсэн ван, жанжин нарын захиргаанд байсан нутгийг ойлгох хэрэгтэй нь тодорхой харагднам. “Фэньди” гэдгийг чингэж ойлговол “Го” гэдэг хятад үг нь МЭ XI зууны үеэс овог аймгийн нэгж, ханлиг гэсэн утгатай байсан /88.73/ болохоор Сыма-Цзянь Бань-Гу нар “Го”-г чухам үүнтэй ойролцоо утгаар хэрэглэсэн гэж үзүүштэй. “Ингэхээр “фэньди” бол Хүннүгийн шаньюйгаас нутаглаж буй хүмүүсийнх нь хамт түмтийн дарга нарт захируулан ашиглуулахаар өгсөн нутаг, өөрөөр хэлбэл Хүннү улсын ван гэх мэтийн хэргэмтэй түмтийн даргын албан тушаалтай хүмүүс, хэргэм, албан тушаалтайн эрхээр улсын захиргааны нэгж болох нутгийг орших хүмүүсийн нь хамт захирч байсан явдал юм” гэж доктор Ч.Далай үзсэн бөлгөө. МЭӨ 46 онд Хүннүгийн Жичжу ван Хүннүгийн газрыг олгож байсан” /134.70/ нь үүнтэй ч холбоотой байж болох юм. Хүннүд 24 түмтийг дарга захирч, түүний харьяаны нутгийг “хувь газар” гэж үзэж байсан бололтой. Г.Сүхбаатар судлаачын тодорхойлсноор Хүннүгийн захиргааны нэгж болох түмтийн нутаг, “фэньди” хоёр хоорондоо давхцаж байжээ /64.63/.

Хуралдаан. Хүннү улсын төрийн байгууллын бүтцийн салшгүй хэсэг нь хуралдаан мөн. Хүннүчүүд нэгдмэл улсаа байгуулж, төрийн зохион байгуулалтаа бүрдүүлж тогтоохдоо овог, аймгийн үеэс монголчуудын уламжилж ирсэн “Хурал” гэсэн зохион байгуулалтын хэлбэрийг өвлөн авч хэрэглэжээ. Ийнхүү “Хурал”-ыг өвлөн хэрэглэхдээ түүнийг байгуулах горим, эрх мэдэл, хэлэлцэх асуудал, хуралдах дэг, жаяг, гаргах шийдвэр, биелүүлэх ёс үйлийн талаар олон үеийн турш хэрэглэн хэвшүүлж ирсэн ёс заншил, хэм хэмжээг шинэ түүхэн нөхцөл, улсыг жолоодох ур ухаандаа уламжлан авч ашиглахын хамт хааны зарлиг, төрийн цаазаар хуульчлан тогтоосон хэм хэмжээг шинээр бий болгон хэрэгжүүлсэн болой. Гэхдээ энэ нь Хүннү гүрний хөгжил, төрийн тогтолцооны бүрэлдэлт, түшмэдийн ёсны төлөвшилт, төрийнх нь бодлогын хэрэгжилттэй нягт холбоо бүхий зохих цаг хугацаа шаардсан нарийн үйл явц байсан хэмээн үзвэл зохино.

Хүннүгийн үеийн түүхэн гол сурвалж бичиг болох “Түүхэн тэмдэглэл”-д /Ши Цзи/ бичсэн баримт болон доктор Г.Сүхбаатарын судалгааны бүтээлийг нягтлан үзэхүл Хүннүд хуралдаан бүрэлдэн хөгжсөн түүхийг харьцуулан харж болох юм. “Ши Цзи”-д “Тавдугаар сард Лу хот /Лунчэн/-д их хуралдаанд цугларч өвгөд тэнгэр, дэлхий, онгон хайрханд тахилга үйлдэнэ.

Намар морь таргалахаар Дайлинд их хуралдаанд цугларч хүн малын тоог бүртгэн шалгаж олон аймаг цуглаж, төрийн хэрэг хэлэлцэн морь тэмээ уралдуулан наргидаг” байсныг тэмдэглэсэн байна. Их хуралдаан хэмээн нэрлэж буй эдгээр хуралдаан жилд 2 удаа тав, есдүгээр сард нохой өдөр болж тэнгэр хайрханыг тахин, наргидаг журамтай байснаас үзэхэд бөө мөргөлийн ёсыг хадгалахын хамт төрийн зарим гол хэргийг

хэлэлцэн шийдвэрлэдэг нь тодорхой байна. Энэ нь тахилгад оролцож буй бүх олныг хамарсан нийтийн хурлын ёсноос даван төрийн хэрэг шийдвэрлэхэд оролцдог болж буй хуралдааны шинэ ёсонд шилжих шилжилтийг агуулж төрийн төлөөлөгчдийн хуралдаан үүсэн төлөвшихэд зохих үүрэг гүйцэтгэсэн биз ээ.

“Ши Цзи”-д “Цагаан сард шаньюйн өргөөнд бүх дарга /чжан/ бага хуралдаанд цугларч, тахилга үйлдэнэ” Энэ хуралдаан нь “бага хуралдаан” гэж нэрлэгдэн зөвхөн төрийн түшмэдүүд оролцох агаад түүний цөм нь 24 аймгийн зонхилогч /дарга/ буюу 24 түмтийн дарга нар байсан аж. Улсын гол түшмэд буюу ноёд язгууртнууд энэхүү хуралдааныг бүрэлдүүлж байсан учир “язгууртны хурал”, “ноёдын хурал”-д ойртож, төрийн хэргийг шийдвэрлэх хамтын удирдлагын байгууллага болох шинжийг улам бүр бүрэлдүүлж байснаараа онцлог болой. Зарим сурвалж бичиг, ном зохиолд Хүннүгийн 24 аймгийн зонхилогчид оролцсон хурлыг төрийн зөвлөл хэмээн нэрийдэж байсныг дурдсан нь буй. Судлаач О.Прицак Хүннүд 24 гишүүнтэй төрийн зөвлөл байсан тэр нь жил бүрийн 1, 5, 9 дүгээр сард хуралдаж төрийн чухал асуудал хэлэлцдэг байжээ. /164. 179-180/ хэмээсэн нь төрийн зөвлөл гэсэн хуралдаан байсан мэт ойлголтыг төрүүлж байна. Гэсэн ч энэ нь нэр томъёоны утга бүхий зохиогчийн саналыг илэрхийлэхээс бус агуулгын хувьд тодорхой бүрэлдэхүүнтэй язгууртны хурлын илэрхийлэл байсан гэж хэлж болно. Дээр дурдсан хуралдааны дотроос Хүннүгийн 24 түмт болон бусад төрийн түшмэдийн /бүх дарга нарын/ оролцсон хуралдаан нь язгууртны төлөөлөгчдийн хурал буюу Хүннүгийн хаант улсын хуралдааны эх үүсгэл бөгөөд түүний төлөвшилт нь төрийн чуулган буюу их хуралдай төлөвшин бэхжих үндэс суурь болсон бөлгөө. Доктор Г.Сүхбаатарын судалгаанаас үзэхэд “бага хуралдаан” хэмээн нэрлээд байгаа зөвхөн ихэс дээдэс, түшмэд оролцдог хуралдаан нь угсаа язгууртан хүмүүс буюу ноёд /түшмэд/-оос бүрэлддэг агаад зөвхөн төрийн хэрэгт холбогдох зарчмын шинжтэй асуудлыг дагнан хэлэлцдэг байгууллага байх зорилготой нь харагднам. Их эрдэмтэн эл байгууллагын талаар дүгнэлт хийн бичихдээ “Хүннү улсад наана хэлэхэд МЭӨ I зууны сүүл үеэр ноёдын чуулга байсан нь үнэнтэй. Хулугу шаньюй МЭӨ 85 онд хүүгээ балчир учир өөрийгөө насан өөд болохоор өөрийн дүү, баруун гарын гули ванг шаньюй болгохоор хуралдаанаар хэлэлцүүлэх зарлиг буулгасан байдаг. Бас МЭӨ 60 онд Хэси цолтой Синьвэйян ван шаньюйг насан өөд болохоор вангуудыг цуглуулж хуралдуулахаар элч илгээж байсан хэмээгээд энэ бол Чингисийн үеийн их хуралдаантай /ноёдын чуулгантай/ төстэй байна” /64.74/ гэжээ.


Эдгээр баримтыг түшихүйд Хүннү улсад төрийн хуралдаан /хуралдай/ бий болж, төрийн байгууллын бүтцэд орж ирсэн нь тодорхой байна. Эл хуралдаан нь дараа дараагийн улсад уламжлагдан хөгжиж Их Монгол Улсын үед жинхэнэ ёсоор төрийн их чуулган болон төлөвшсөн ажгуу.

Хүннү улсын Хуралдаан /хуралдай/ нь шаньюйд зөвлөх эрхтэй байгууллага байсан аж. Учир нь хуралдааны хэлэлцэн шийдвэрлэх гол асуудал нь шаньюйг өргөмжлөх явдал мөн байв. Хуралдаан нь хааныг өргөмжлөх, дайн зарлах, найрамдал байгуулах, алба татвар оноох, хил хязгаар, төрийн байгууллагын бүтэц, засаг захиргааны хуваарийг тогтоох болон улсын дотоод, гадаад бодлогын зарим гол асуудлыг хэлэлцэн санал, дүгнэлт, шийдэл гаргах эрх, үүрэгтэй. Харин хуралдааны санал дүгнэлт, шийдлийг шаньюй /хаан/ төрийн бодлого, үйл ажиллагааг явуулахдаа харгалзан үзэх ёстой байжээ. Нийгэм, улс төрийн үүргийн хувьд хуралдаан нь Хүннүгийн төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хаанаас зөв, оновчтой шийдвэр гаргах, төрийн түшмэдийг бэлтгэн төлөвшүүлэх, зон олондоо хүндлэгдэхэд нэн чухал үүрэгтэй байсан ажээ.

Засаг захиргааны хуваарь. Хүннүгийн засаг захиргааны хуваарь нь аравтын тогтолцоонд үндэслэж байв. Арван өрх нийлж аравт, арван аравт нийлж зуут, арван зуут нийлж мянгатыг бүрэлдүүлэх нь аравтын тогтолцооны гол утга учир юм /27.84;14-16/.

/бүдүүвч/

ХҮННҮ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВААРЬ



Хүннү улс нь газар нутаг, засаг захиргааны хувьд юуны өмнө шаньюйгийн шууд харьяалах гол хэсэг ба зүүн, баруун гарт хуваагдана. Нийт 24 түмтээс бүрдэнэ. Хүннү нарын аравт, зуут, мянгат, түмт гэх аравтын тогтолцоо бол нүүдэлчдийн амьдралын хэв маягт илүү зохицсон цэрэг-захиргааны өвөрмөц зохион байгуулалт байсан /27.84; 14.16/ ажээ. Аравтын тогтолцоо бүрэлдэн тогтсон нь Хүннүчүүдийн нүүдэллэн аж төрөх хэв маяг, эрхлэх аж ахуй, түүнийг хөтлөн явуулах ур ухаантай хүйн холбоотой. Аравтын тогтолцоог төрийн байгуулалтадаа оруулж ирсэн нь монгол угсаатан, түүний дотор Хүннүчүүдийн хүн төрөлхтөний өмнө бүтээсэн түүхэн сонголт, баларшгүй ул мөрийг үлдээсэн өвөрмөц соёл мөнөөс мөн билээ. Эл соёлыг 1000 шахам жилийн дараа эзэн богд их Чингис хааны үед төгөлдөржүүлэн хэвшүүлсэн нь Их Монгол Улсын оршин тогтнохуйн нэн гол үндэслэл болсон түүхэн заяатай юм.

Хүннү улсын засаг захиргааны хамгийн том нэгж буюу засаг захиргааны хуваарь нь **хэсэг /гар/** болно. Төвийн хэсгийг Шаньюй, зүүн хэсгийг Шаньюйн ууган хүү, зүүн сэцэн /туци/ ван, баруун хэсгийг, түмтийн ноён баруун сэцэн ван тус захирч байв. Улсыг хэсэг /гар/-т хувааж байсантай холбоотойгоор төрийн түшмэдүүд нь зүүн, баруун гарын /хэсгийн/ хэмээн хуваагдаж байжээ. Ма Чан-шоугийн шинжилгээг доктор Г.Сүхбаатарын нягтлан бичснээр үзэхүл “Хүннүгийн зүүн гарын нутаг нь Хэбэй мужийн Яньцин Сяниэс яг хойшхи Цахараас зүүн тийш Ляонин Пиньмань сянь хүртэлхийг оролцуулан Монголын Хэрлэн Ононгийн сав нутгийг хамарч байсан аж. Тэгвэл баруун гарын нутаг нь Шэньси мужийн Сүйцэ Сяниэс хойшхи Өвөр Монголын Алаша, эзэн хороо, зүүн гар, Монголын Сэлэнгэ, Ховд голын сав хэсгийг хамарч байсан ажээ.” /64.5/

Харин шаньюй өөрөө Орхон, Туул голын сав, тэдгээрээс Цагаан хэрэм хүртэлх нутгийг хамарч, Архангай аймгийн Хөшөө цайдамын орчимд ордон өргөөгөө байгуулж байжээ /64.56/. Хүннү улсыг гурван гар болгон бүсчилсэн эл хуваарь цааш цаашид нүүдэлчдийн аж амьдралд улам бүр зохицож эзэн богд Чингис хааны үед уламжлагдан шинэ агуулгаар баяжсан түүхтэй. Хүннүгийн аравтлах тогтолцооны дараагийн хуваарь нь **түмт** бөгөөд эл хуваариар улсын засаг захиргааны зохион байгуулалтын үндсэн нэгж болж улсыг удирдахад чухал үүрэг гүйцэтгэж байснаараа онцлог юм. “Ши-Цзи”, “Цянь Хань шу”, “Хоу Хань Шу” хэмээх түүхэн сурвалж дахь мэдээ, доктор Г.Сүхбаатарын судалгаанаас үзбээс улсын гурван гар нь 24 түмт болж хуваагдаж байжээ. Түмт бүр эзэмшил нутаг, хүн ам, морьт цэрэгтэй. Гэхдээ түмтийн эзэмшил нутаг, хүн ам харилцан адилгүй хэмжээтэй. Түүгээр ч барахгүй түмтийн дарга бүр түмэн морьт цэрэг захирдаггүй байв.

Түмт нь газар, бэлчээр нутгийн эзэмшил, нүүдэл суурьшлыг зохицуулан, гувчуур авна.

Бас морьт цэргээ зохион байгуулан удирдах, иргэдээ харъяалан захирч, шаньюй болон зүүн, баруун сэцэн вангийн бодлого, шийдвэрийг шууд биелүүлэх үүрэгтэй.

Хүннүгийн засаг захиргааны дараагийн шатны хуваарьт **мянгат, зуут, аравт** орно. Түүхэн сурвалж бичигт эдгээрийн талаар тодорхой мэдээлэл үлдсэнгүй ажээ. Гэвч эдгээр хуваарь бүр байгуулагдах зарчим, журам, ангилал, ёс жаяг, иргэнээ харъяалан захирах, нарийн горимтой.

Хүннүчүүд жилийн дөрвөн улиралд аж төрөх үйл явц, аж ахуйгаа хөтлөн явуулах ёс заншил, удам угсаагаа бэлтгэн авч явах, иргэд хүмүүс, газар нутгаа хамгаалах, захирч захирагдах нарийн зохион байгуулалттай байсан бөлгөө. Энэ нь гагцхүү аравтын тогтолцоогоор дамжин, аравт бүхэн шууд газар дээр нь зохион байгуулан хэрэгжүүлэх үйл явцаар амьдралд биелэгддэг байсан ажээ.

Түшмэдийн ёсон. Хүннү улсад яамлах ёсон байхгүй байсан. Гэвч энэ нь төрийн зорилго, зорилтыг гүйцэтгэн биелүүлэх төрийн түшмэдүүд байхгүй байсан гэсэн хэрэг бишээ. Төрийн зорилго, зорилтыг амьдралд хэрэгжүүлэх үүрэгтэй төрийн түшмэд /орчин үеийн ойлголтоор төрийн албан хаагчид/-ийн албан тушаал, зэрэг, цол, эрхлэх ажил үүрэг, эдлэх эрх ямба, авах хангамж, аж төрж амьдрах улс төр, эрх зүй, зохион байгуулалт, аж ахуйн тогтолцоо бүрэлдсэн.

Энэ л жам ёсоор Хүннү улсад төрийн түшмэдийн ёсон анхлан бүрэлдэн бий болж цаашид уламжлах төлөвийг олсон бөлгөө. Тухайлбал, “Ши-Цзи”, “Цянь Хань-Шу”, “Хоу-Ханьшу”, “Цзинь-Шу” гэх дөрвөн сурвалж бичиг дэх тэмдэглэлийг судлаач, их эрдэмтэд /Г.Сүхбаатар, Н.Сэр-Оджав, Г.Гонгор, Ц.Доржсүрэн гэх мэт/ судлаж тунгаасныг нягтлан авч үзэх нь зүйтэй юм.

Сурвалж бичиг хийгээд судлаачдын шинжилгээнээс үзвэл Хүннү улсын Модун шаньюйгийн үед төрийн том түшмэдийн тогтолцоо бий болж, дараа дараачийн хаадын үед улам төлөвсөн байна.

Төрийн түшмэдийн тогтолцооны шатлал, хэсгийн үндсэн цөм нь 24 түмтийн даргын тогтолцоо байжээ. Эдгээр дарга нар төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, шийдвэрлэхэд оролцдог үндсэн гол хүч байсан учир тэдгээрийг батлах, томилох журам, зэрэг, цол, эрх мэдэл, ажиллах горим, үүрэг хариуцлага нилээд дэлгэрэнгүй байдлаар бүрэлдэн тогтсон ажгуу.

Энэ нь Хүннүгийн төрийн түшмэдийн ёсны нэгэн гол онцлог мөн. Үүний нэгдэх хэсэг нь 10 том эвэртэн¹⁸ ван /түшмэл/ юм. Эдгээрийн дотроос “Ши-Цзи”-д тэмдэглэсэнээр зүүн, баруун сэцэн ван /Сянь ван/, зүүн, баруун Гули ван нар бөгөөд хамгийн өндөр албан тушаал хашиж, зэрэг цол, том газар нутаг эзэмшинэ.

Жишээлбэл, зүүн сэцэн ван нь хааны ууган хүү байх бөгөөд улсын зүүн гарын түмэн цэргийг захирч, асар уудам газар нутгийг эзэмшиж байв.

Зүүн сэцэн ван шаньюйгийн дараа орох хамгийн том албан тушаалтан мөн юм. Дараагийн том албан тушаалтан нь баруун гарыг захирагч зүүн Гули ван бөгөөд тэр нь баруун зүгийн уудам газар нутгийг эзэмшиж түмэн морьт цэрэг захирч байв. Дөрвөн том эвэртэн нь бүгд шаньюйгийн овгоос гаралтай бөгөөд угсаа залгамжилна. Мөн бүгдийг нь шаньюй томилно. Төрийн 10 том эвэртэн түшмэдийн дараагийн 6 түшмэл нь зүүн, баруун их жанжин /да цзян/, зүүн, баруун их дувэй /да дувэй/, зүүн, баруун их данху /да данху/ болно. “Ши-Цзи” сурвалжид бичиж “Хоу Хань-шу” сурвалжид тодруулж, улмаар Хүннү улсын нийгмийн хөгжлийн гүнзгийрэлтийг харуулж буй дээрх 6 том эвэртэнд зүүн, баруун жич жи ван /их жанжин/, зүүн, баруун вэнь-юйти ван /их дувэй/ зүүн, баруун чжинь цзян ван /их данху/ орно гэж тэмдэглэсэн байна.

Хүннү судлаач М.Мооригийн судалгаагаар албан тушаалын өөрчлөлт нь албан тушаалын агуулга, зэрэг, цолын хэмжээ, эрх мэдэл зэрэгтэй холбоогүй ажгуу. 6 эвэртэн түшмэдийн аль аль нь Шаньюйн хүү юмуу дүү нар байх ёстой аж. Ийм болохоор 10 том эвэртэн нь хаан угсааны овгийн хүмүүс байжээ. Хуянь, Лань, Сюйбу гэх 3 овог нь Хүннүгийн сурвалжит аймгууд гэгдэнэ.

Зүүн гарын бүх ван, жанжин нь шангу мужийн өдөөс харан цааш дорно зүгт Хуйхэ, Чаосяньтай хиллэн зүүн гарт нутаглана. Баруун ван, жанжин нар Шанзюнь мужийн өдөөс харан цааш Юэчжи, Дицзян нартай хиллэн баруун гарт оршино.

Эдгээр эвэртэн түшмэл нь “их” гэсэн чимэгтэй бөгөөд бүгд түмэн морьтон цэрэг захирах, өндөр албан тушаалд ажиллах, эзэмшил газартай байх эрхтэй. Жишээлбэл, МЭӨ 176, 174 онд жич жу ван гадаад орнуудад элчин төлөөлөгчөөр явж ажилласан болон Хүннүгээс баруун хязгаарыг /Дундат Азийн орнуудыг/ эзлэн аваад түүнийг захируулахаар жич жу ванг томилж байсан нь түүхнээ тэмдэглэгджээ.

Вэнь юйти ван Хүннүгийн баруун хэсэг цагаан хэрэмнээс хойш Чжан Е мужийн чигт Увай мужаас баруун тийш Лоб нуур хүртэлх газар нутгийг эзэмшиж байв. Дээрх 6 том эвэртэн түшмэл нь 24 түмтийн дарга нарын тогтолцооны хоёр дахь хэсэг болно. 10 том эвэртэн түшмэл нь том түшмэлийн бэлэг тэмдэг болсон эврийг толгой дээрээ зүүнэ.

Эвэр зүүх нь нэг талаар овгийн байгууллын уламжлалыг тусгасан, нөгөө талаар тэдгээрийн тушаал, эрх мэдэл, сүр хүчийг бусад түшмэдээс нь ялгаруулсан тодорхой зүйл болов. Эвэртэн түшмэл тушаалаас огцорвол эврийг нь хурааж авна.

Нас барвал эврийг нь булшин дээр толгойны нь дэргэд тавьж орны нь хүнийг сонгогдтол байлгадаг заншилтай байжээ.

Хүннүгийн түмтийн 24 даргын тогтолцооны гуравдахь хэсэг нь 14 түмтийн дарга орно. Түмтийн эдгээр дарга нар түмтээ захирч төрийн тодорхой албан тушаалд ажиллана.

Төрийн хэргийг шийдэхийн хамт олгосон газар нутгийг эзэмшиж, харъяат иргэдээ захирч, аж ахуйн хэргийг зохицуулж, түмтийн цэргээ захирна. 14 түмтийн дарга нар нь хэдэн мянган цэрэг, тэгэхдээ хамгийн бага нь 1000 цэрэг захирдаг жижиг вангууд юм. Эдгээрийн дотроос хамгийн том нь зүүн, баруун гудохоу юм.

Гудохоу нар захирах, цагдах, шүүх ажил эрхлэнэ. Түмтийн дарга нар “Сэцэн” мэтийн цол, “ван” “данху” зэрэг хэргэм хэрэглэнэ. Түмтийн дарга тус бүрийн харъяанд мянгат, зуут, аравтын дарга, жижиг ван, гол туслах, дувэй, данху, цецной зэрэг албан тушаалтнууд ажиллана. МЭӨ 162 онд Хань улсад цецной тушаалтай хүн элчээр очиж байсныг сурвалж бичигт тэмдэглэсэн байна.

14 түмтийн дарга нар түүнээс доошхи түшмэлүүд хааны овгийн бус байна. Хүннүгийн төрийн түшмэдийн тогтолцооны хоёр дахь шатлал нь мянгат, зуут, аравтын дарга нарын тогтолцоо болно.

Хэдийгээр түүхэн сурвалж бичигт Хүннү улсад хэдэн мянгат, зуут, аравт байсан мэдээ бичигдэн үлдээгүй аж. Харин тооны хувьд тийм ч бага бус байсан бололтой. Хүннү улсын засаг-захиргааны нэгжийг удирдаж байсан түмт бүрийн мянгат, зуут, аравтын дарга нар эл түмтийн дарга нартаа захирагдаж, түүний бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэн, засаг захиргааны хэргийг зохион байгуулах түшмэлүүд байсан нь лавтай.


Энэ бол бүхэлдээ орон нутагт засаг захиргааны ажлыг эрхлэн явуулах түшмэдийн тогтолцоо, түүний ёсон бүрэлдэн тогтсон хэмээсэн гэсэн хэрэг юм. Аравтын дарга нь зуутын даргадаа, зуутын дарга нь мянгатын даргадаа, мянгатын дарга нь түмтийн даргадаа шууд захирагдан хариуцлага хүлээх тогтолцоо тогтсон байна.

Үүний хамт тэдгээрийг томилох, огцруулах эрх бий болох нь зүйн хэрэг, “Ши-Цзи”-гийн 1 дэх талд “24 түмтийн дарга тус бүр мянгат, зуут, аравтын даргыг томилно” хэмээн бичсэн байдаг бөлгөө.

Үүний хамт мянгат, зуут, аравтын дарга нар өөрийн харъяат цэргийг захирч цэргийн үйл ажиллагаа явуулах нь тэдгээрийн засаглан захирах үйл ажиллагааны салшгүй хэсэг болж, энэ утгаараа төрийн хэрэгт тус бүр тодорхой үүрэг гүйцэтгэж байсан ажгуу. Хүннүгийн төрийн түшмэдийн тогтолцооны гурав дахь шатлал нь Хүннүгээс эзэлж авсан аймаг, улс орныг захирах зохион байгуулалтын бүтэц, түшмэдийн тогтолцоог бий болгосноор илэрнэ.

/бүдүүвч/

Хүннүгийн төрийн байгууллагын тогтолцоо



Ийм бүтэц, тогтолцоог бий болгохдоо Хүннү улсыг хүчирхэг болгох, эзлэгдсэн аймаг, улсыг захирах байгууллага, түшмэдийг бүрэлдүүлэх, зохимжтой холбоо харилцаа тогтоох, тэдгээрээс алба татвар хураах журам нэвтрүүлэх зорилт тавьжээ. Түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдсэнээс үзэхэд Хүннү улс өөртөө эзлэгдсэн баруун хязгаарыг /дундат азийн орнуудыг / захирах Жичжу ванг томилж ажиллуулжээ. Мөн баруун хязгаарт “тунну дувэй захиргаа”-г байгуулсан байна. МЭӨ II зууны үед баруун хязгаарын орнуудаар хятадын элч Чжан цяны аялах үед хуянь овогт жич-чжу вангаар ажиллаж, түүнд газарчилж байсныг сурвалж бичигт тэмдэглэжээ. Мөн эзлэгдсэн орныг шууд захирах үүрэг бүхий “динлин ван”, “дунху ван”, “хуцзе ван” гэсэн албан тушаалтан томилж ажиллуулсан байна /64.59/.

Ийм байдлаар Хүннү улсад зүүн, баруун гарын зүүн сэцэн, гули ван 24 түмтийн даргаас бүрэлдсэн түшмэдийн дээд хэсэг, мянгат, зуут, аравтын дарга нараас бүрэлдэн засаг захиргааны байгууллагад ажиллах, орон нутгийн түшмэдийн хэсэг, эзлэгдсэн аймаг, орныг захирах байгууллагад ажиллах, зориулалт бүхий түшмэдийн хэсгүүд тус бүрдээ нэгэн шатлал болон үүсэн бүрэлдсэн болой.

§4. Хүннү улсын цэргийн зохион байгуулалт

Цэргийн зохион байгуулалт нь аравтын тогтолцоонд үндэслэж байв. Хүннү улс өөрийгөө хамгаалах, бусад аймаг, улс орныг эзэлж нутгаа өргөтгөх зорилгоор улсын цэрэг байгуулж, цэргийн нэгдсэн зохион байгуулалт тогтоожээ.

Цэргийн зохион байгуулалтын аравтын тогтолцоо нь улсын бүх цэргийг аравт, зуут, мянгат, түмт, зүүн, баруун гарын цэрэг хэмээн хувааж, бүх цэргийг шаньюй нэгтгэн удирдахад чиглэгдэж байв. Цэргийг аравтлах, зуутлах, мянгатлах нь цэргийн зохион байгуулалтын үндэс болсон аж. Их хааны цэрэг, зүүн, баруун гарын цэрэг, түмтийн цэргийн аль нь ч аравт, зуут, мянгатаар зохион байгуулагдана. Энэ нь Хүннүгийн цэрэг овог, аймгийн бус харин нэгдмэл, нарийн зохион байгуулалттай, хатуу сахилгатай, зэвсэг сайтай хүчирхэг цэрэг байхын үндэс болсон бөлгөө. “Ши-Цзи”-ийн 1 дэх талд “зүүн, баруун сэцэн вангаас дань хүртэлх тушаалтны хамгийн том нь түмэн морьт /цэрэг/, бага нь мянган морьт /цэрэг/ захирна. Эдгээр 24 даргыг түмтийн дарга гэнэ” хэмээн бичжээ. Энэ нь Хүннүгийн цэргийг 24 түмтээр зохион байгуулж байсныг харуулнам. Мөн “Ши-цзи”-д “24 түмтийн дарга тус бүр мянгат, зуут, аравтын даргыг ... томилно” гэж бичсэн нь цэргээ аравт, зуут, мянгатаар зохион байгуулах үндэслэл болсон буй зээ. Хүннүгийн төрөөс цэргээ бэхжүүлэхийн төлөө анхаарал тавьж, зохион байгуулалтын арга хэмжээнүүд авч, сайтар зэвсэглэж чадсан нь түүхэн баримтаас тодорхой байна. “Хүннү цэрэг дуудсан цагт татлагын газарт хүрч ирэх ёстой. Хэрэв хожимдвол цаазаар авах” хатуу хуультай байв.

Шаньюй Хүннүгийн газрыг авах гэсэн дорнод ху нарын саналыг эрс няцааж, газар өгөхийг зөвшөөрсөн түшмэдээ цаазлаад “мориндоо мордоод татлагад хожигдогсдын толгойг авна” /134.39/ гэж тушаагаад цэрэглэж мордсон нь дээрхи хуулийг хэрэгжүүлж байсныг нотлох хөдлөшгүй жишээ мөн бөлгөө.

Хүннүгийн цэргийн шинж чанар, хүчирхэг байсан эсэх нь түүний зохион байгуулалт төдийгүй тоо хэмжээ, дотоод бүтэц, байлдах тактик, зэр зэвсэг, түүнийг хэрэглэх ур чадвар, цэргийн ар тал, сэтгэл зүй зэрэгт илэрч байсныг товч боловч авч үзэх нь зүйтэй болов уу. Хүннүгийн цэргийн тоо хэд байсныг илэрхийлсэн баримтууд сурвалж бичиг, тэмдэглэлд бичигдэн үлдсэн нь бий. Хань улсын түүхч Цзя-И-гийн /МЭӨ 200-168/ мэдээгээр 5 хүнд нэг цэрэг оногдож байжээ /64.69/. Ма Чан-Шоугийн тооцоолсноор тэр үед Хүннүгийн нийт хүн ам 1500000 байсан /443.28/-тай харьцуулж үзвэл цэргийн тоо нь 300000 байсан гэж үзэж болох юм.

Өөр нэг сурвалж бичигт “Модун дээд тал нь 300000 нум сумтай цэрэгтэй байсан” /134.39/ гэсэнтэй дээрхи тоо адил байгааг тэмдэглүүштэй. Доктор Г.Сүхбаатарын шинжилснээр Модун шаньюй Хань улсын Гаоди хааныг Пинчэн хотод /одоогийн Датун хот орчим/ бүслэхдээ 400000 шилдэг морин цэрэг гаргасан /64.69/ аж. Эдгээр баримтыг харьцуулан үзбээс Хүннү улс дээд тал нь 400000 хүртэлх цэрэгтэй байсан нь харагднам. Харин жирийн үед байсан цэргийн тоо нь 24 түмтийн даргын 10 нь түм гаруй, үлдсэн 14 нь 1000-2000 цэрэгтэй байна гэж шаньюйн тогтоосныг үндэс болговоос 150000-200000 цэрэгтэй байсан байж болмоор. Доктор Г.Сүхбаатар “Хүннүгийн цэрэг улсын цэргийн нэгдсэн зохион байгуулалттай байсны гэрч бол зүс нийлүүлсэн морьт цэрэгтэй байсан явдал” /64.69/ гэж дүгнэсэн байдаг. Үүний жишээ нь шаньюй, Хань улсын хааны цэргийг Пинчэн хотод 400000 морьт цэргээр бүслэхдээ өрнө этгээдэд нь дан цагаан морьтой, дорнодод халзан морьтой, умардад хар морьтой, өмнөдөд саарал морьтой цэрэг байрлуулж довтолсон явдал юм. Хүннүгийн цэрэг, дайнд гэргий, хүүхдээ авч явах, тэд нь ачаа, ар талыг хариуцаж сэтгэл санаагаар дэмжих, зориг итгэл төрүүлэх ёсон байжээ. Тийм байдлаар гэргий, хүүхдээ авч явж буй цэргийг “гэр цэрэг” хэмээн нэрлэдэг байсан аж. Мөн дайнд эрсэдсэн цэргийн цогцсыг авчирсан хүнд хөрөнгийг нь өгдөг ёс хэвшмэл байжээ. Хүннүгийн цэрэг морьт цэргүүд байсан нь тодорхой байна. Шаньюйн цэргийн зохион байгуулалт хийсэн үйл ажиллагаанаас үзэхэд 24 түмт бүрийн цэрэг нь бүгд морьтон цэрэг байхаар тогтоож байгуулсан нь үүний нэгэн баримт болой. Пинчэн хотыг бүслэхэд 400000 морьтон оролцсон нь бас л чухал нэгэн баримт мөн. Хүннүгийн цэргийн зэвсэг нь нум, сум, илд, жад байсныг сурвалж бичигт тэмдэглэн өгүүлсэн нь бий. Алдарт “Ши-Цзи”-д “Алсын тусгалтайгаас нум, сум, ойрынхоос илд, төмөр бариултай жад байна” гэж бичсэн нь Хүннү цэргийн зэвсгийн гол төрлийн нэр мөн нь тодорхой.

Зэвсгийн төрлөөс нум, сум гол зэвсэг байжээ. Энэ зэвсэг нь нум, сум гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Археологийн олдворуудыг шинжилсэн эрдэмтдийн тодорхойлсноор “Хүннү нум бол ерөнхийдөө шулуувтар эвэр гичиртэй, эврэн ар элэгтэй, мөрөөрөө тэнэгэр матаастай, 140 см урт давхар зүймэл нум байсан тул хүчтэй, алсын тусгал сайтай байжээ” /64.70/ Иймээс Хүннүгийн нум сумны хүч чадал нууц нь нум сайн байснаас шалтгаалдаг байсан ч байж болох нь. Мөн сум нь дуут сум, өдтэй сум, хүрэл, төмөр зэв, гурван хянгат зэв гэх мэт төрөл зүйл байхын хамт хэрэглэх зориулалт нь бас өөр өөр байсан ажээ. Модун шаньюй 300000 нум, сумтай цэрэгтэй байсныг бодоход нум, сум цэргийн гол зэвсэг байж цэрэг байлдааны ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байсныг харуулнам. Энэ бүхнээс үзэхэд Хүннүгийн цэрэг тооны хувьд харьцангуй олон, нэгдмэл зохион байгуулалттай, сайн зэвсэглэсэн, байлдах өндөр ур чадвартай, сайн ар талтай, хатуу сахилгатай байсан хэмээн хэлж болох байна.

§5. Хүннү улсын эрх зүй

Төв Азийн нүүдэлчдийн түүхнээ монгол угсаатан Хүннүчүүд Модун шаньюйгийн удирдлагаар бусад овог аймгуудаа нэгтгэн хүчирхэг хаант улсыг байгуулж, гурван зуу гаруй жил оршин тогтнохдоо хүн төрөлхтөний өмнө асар их хариуцлага хүлээж түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь тус улсад үндэсний эрх зүй үүсэн хөгжих үндэслэл, нөхцөл болсон ажгуу. Хүннүгийн хаад тодорхой эрх мэдэлтэй байж, төрийн өмнө тулгарч буй үүрэг, зорилтуудыг тодорхойлох, цоо шинэ төрийн тогтолцоо бий болгох, төрийн байгууллагуудыг байгуулах, түшмэдийн ёс, цэргийн зохион айгуулалт, засаг захиргааны хуваарь, алба гувчуур, улсын хил хязгаарыг тогтоох, үйл ажиллагааг хууль цааз, эрх зүйн хэм хэмжээ тогтоож, түүнээ сахин биелүүлэх замаар хэрэгжүүлэх явдал зайлшгүй шаардагдсан ажээ. Төр улсын хэмжээнд хэрэгжүүлэх эл шаардлагыг зөвхөн заншлын хэм хэмжээгээр хангаж чадахгүй болсон ба тэгж чадахгүй нь ч зүй тогтолт шинжтэй бөлгөө.

Иймээс төр эл шаардлагыг хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй хууль цааз, хэм хэмжээг хуульчлан тогтооход хүрсэн ажгуу. Ийм байдлаар Хүннү улсад эрх зүй түүний хэм хэмжээ үүсэж бий болсон байна. Хүннү улсад хууль цааз байгаагүй, зөвхөн хэв хууль л үйлчилж байсан мэтээр ойлгож бичих нь онолын хувьд үндэслэл муутай, түүхэн үнэн, амьдралын бодит байдалд төдий л нийцэхгүйг санууштай юм. Доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын “Хүннү нарын үүсгэн байгуулсан анхны төр нь нэгэнт тухайн үеийн нийгмийн зохион байгуулалтын хуульчлагдсан илэрхийлэл учраас эрх зүйн тодорхой эх сурвалжийг бий болгожээ” /14.19/ гэж тодорхойлсончлон Хүннүд эрх зүйн эх сурвалж, хууль цааз бий болох онолын үндэслэлтэй төдийгүй зайлшгүй практик хэрэгцээ байсан болой.

Хүннү улсын хууль цааз бидний үе хүртэл уламжлагдан өөрийн эхээрээ үлдэж чадаагүй нь нүүдэлчдийн соёл иргэншлийн амьдралтай хүйн холбоотойг гүнээ анхаарахын хамт ийнхүү хууль тогтоомжийн актууд уламжлагдаж чадаагүй, олодоогүй байгааг энэ улсад зөвхөн хэв хууль үйлчилж байсан хэмээн нотлох нь өрөөсгөл талтай болно. Хүннү улсад эрх зүйн эх сурвалж үйлчилж, эрх зүй, түүний хэм хэмжээ бүрэлдэн бий болж байсан үйл явцыг дор дурдсанаар авч үзэж болох юм. Хүннүд эрх зүйн эх сурвалжийн хоёр төрөл, тухайлбал төрөөс тогтоосон хууль цааз болон заншлын хэм хэмжээнээс бүрэлдсэн хэв хууль хоёр харилцаа холбоотойгоор хослон үйлчилж байжээ. Төрөөс тогтоосон хууль цааз нь хааны тогтоосон хууль зарлиг, зүүн, баруун хэсгийн сэцэн, гули ван, түмтийн дарга нарын шийдвэрээс голлон бүрэлдэнэ. Хууль цааз, эрх зүйн шийдвэр гаргах нь дээрхи эрх бүхий хүмүүсээс төрийн нэрийн өмнөөс явуулж буй, тодорхой үр дагавар бүхий хууль зүйн үйл ажиллагаа бөгөөд заншлын хэм хэмжээг мөрдөх буюу түүгээр орлуулах боломжгүй байдгаараа онцлог юм.

Ийм актууд нь бүхэлдээ Хүннүгийн эрх зүйн эх сурвалжийн шинээр бүрэлдэж байсан төрөл бөгөөд Хүннү улсын төрийн байгуулалтын эрх зүйн гол үндэс болж үйлчилсэн байна. Эл эх сурвалжийн төрлийн ирээдүйн хандлага нь улам бүр өргөжин төлөвшихөд чиглэж байв. Хүннү улсын эрх зүйн эх сурвалжийн нөгөө төрөл болох хэв хууль буюу заншлын хэм хэмжээ нь Хүннүгийн төрөөс хүлээн зөвшөөрч, нийгмийн амьдрал, хүмүүсийн хоорондын харилцаанд дагаж мөрдөж байсан хэм хэмжээний цогц агаад олон арав, зуун жилээр боловсрон төлөвшсөөр заавал биелүүлэх нь заншил болж ёс суртахууны шинжийг агуулж байснаараа онцлог юм. Хүннү улсын төрийн засаглалын хэлбэр, хааны эрх хэмжээ, төрийн гадаад бодлогын асуудал, засаг, захиргааны хуваарь, төрийн байгууллагын тогтолцоо, түшмэдийн ёс, зэрэг, цол, цэргийн зохион байгуулалт, алба гувчуур, ял шийтгэлийн төрөл, хэлбэр, ял эдлүүлэх журам зэрэг нь зөвхөн эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажин тогтоогдож амьдралд хэрэгжсэн байна. Доктор Г.Сүхбаатар түүхэн сурвалж бичиг, үе үеийн судлаачдын зохиол, бүтээлүүдийг нарийвчлан шинжлээд “Шаньюй нь ордондоо түшмэдийн чуулганаар төрийн хэргийг удирдан хэлэлцэх зэрэг улсын дотоод бодлого, мөн хятадын хаадтай захидлаар харилцах, гэрээ байгуулах, хятад ба бусад орны элчин төлөөлөгчдийг хүлээн авах, харь улсад дайн зарлан довтлох мэтийн гадаад бодлогын асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байжээ. Хүннүгийн Шаньюй бол түмтийн дарга зэрэг ийм тушаалтныг томилох, огцруулах, шийтгэх тэр ч байтугай алах эрхтэй байжээ” /64.56/ хэмээн дүгнэн бичсэн байдаг. Шаньюйгийн эдгээр бүрэн эрх нь шинээр бий болсон эрх зүйн хэм хэмжээний чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Эдгээрийг заншлын хэм хэмжээ гэж яахин болох билээ. Хүннүгийн Шаньюй зүүн, баруун сэцэн ван, гули ван, их жанжин, их дувэй, их данху нарын 10 эвэртэн түшмэдийн албан тушаал, цол,

эрх мэдэл, эзэмшил газрыг тогтоож, тэдгээрийг томилон ажиллуулсан нь эрх зүйн актаар гүйцэлдсэн нь эргэлзээгүй. Мөн бусад 14 түмтийн дарга нарыг томилж, гурван гар, түмт, мянгат, зуут, аравтыг байгуулан аравтлах тогтолцоонд үндэслэсэн цэргийн зохион байгуулалтыг тогтоосон нь эрх зүйн актын дагуу явагдсан байна. “Ши-Цзи”-д “24 түмтийн дарга тус бүр мянгат, зуут, аравтын дарга, жижиг ван, гол туслагч, дувэй, данху, цецзюй нарыг томилно” гэж БНМАУ-ын түүхийн дээжис бичгийн 19-р талд бичсэн нь түмтийн даргын шийдвэрээр явуулах үйл ажиллагаа мөн юм.

Хятадын ба баруун хязгаарын улсуудтай дайн хийсэн, дайныг зогсоосон, гэрээ хэлэлцээр байгуулсан, элч төлөөлөгч томилон явуулсан, мөн элч төлөөлөгчийг нь хүлээн авсан үйл ажиллагаа эрх зүйн хэм хэмжээний үндсэн дээр явагдсан байж таарна. Эрх зүйн эх сурвалж болох хууль цааз гарч, тэдгээрийн заалтыг зөрчвөл гэмт хэрэг гэж үзэн ял шийтгэл оногдуулан эдлүүлж байсан нь эрх зүйн хэм хэмжээ бүрэлдэн бий болж, үйлчилж байсныг харуулж байгаа тодорхой баримт мөн.

“Ши-Цзи”-д тэдний /Хүннүгийн/ баримталдаг хуулиар ирт үзүүртнийг гаргавал цаазаар аваачина, хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана, хөнгөн хэрэгтнийг бэрээдэнэ, хүндийг цаазаар авна гэж бичсэн байдаг /64.71/. Үүнээс үзэхүл “тэдний баримталдаг хуулиар” гэсэн нь хууль цааз байсныг харуулахын хамт, мэс хүнд гаргах, хулгай хийх, тодорхой үйлдлээр хүнд, хөнгөн хохирол учруулбал гэмт хэрэг гэж үзэн цаазаар авах, бэрээдэх, хөрөнгө хураах ял оноож байсан нь харагднам. Энд ирт үзүүртэн гэдэг үг тодорхой бус байгаа боловч хутга, хянгар, шөвөг мэт ирт мэсийг хэлж байна хэмээн ойлгож болно. Доктор Г.Сүхбаатар гэр бүлийг хураана гэдэг нь өрхийн хөрөнгийг /өмчийг/ хураана /64.71/ гэдгийг хэлж буй хэрэг гэж тайлсан нь зүйтэй юм. Хүннү судлаач эрдэмтэн Ц.Доржсүрэн умард Хүннү номондоо “гэмт хэрэг үйлдэж ялд унасан хүнийг үйлдвэр урлалд зүтгүүлдэг байсныг” дурдсан нь гэмт хэрэг үйлдэж ял авсан хүнээр төрийн хүчээр албадан ажил хийлгэх ял байсан гэсэн хэрэг мөн. Дээрхи баримтуудыг нэгтгэн дүгнэж үзвээс Хүннү улсад ялын дараах хэлбэрүүд тухайлбал, цаазаар авах, хорих, бэрээдэх, хөрөнгийг нь хураах, хүнд ажилд зүтгүүлэх /ажил хийлгэх/ ялууд байсан нь тодорхой байна. Хүннү улсад эрх зүй үүсэн бүрэлдэж байсны нэгэн илрэл нь эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдийг шүүн байцаах талаар тогтоосон хэм хэмжээ, үйл ажиллагаанд илэрдэг. Ши-Цзи-д гудухоу түшмэл шүүхийн ажлыг эрхэлж байсныг бичсэн /64.59. 164-197/ “Хоу-хань шу”-д “зүүн гарт хамаарагдах хуянь, баруунд орох лань, Сюйбу овог нь шүүхийн хэргийг эрхлэн ял оноож, тэр тухайгаа Шаньюйд амаар илтгэнэ” хэмээн бичжээ. Дурдсан баримт, мэдээллүүдийг харьцуулан жишвэл Хүннүд гэмт хэрэгт сэжиглэгсдийг мөшгөн байцаах болон шүүн таслах ажлыг дагнан эрхэлсэн түшмэл ажиллаж, хааны өмнө хариуцлага хүлээж байсан нь харагдаж байна.

Энэ бол эрх зүйн хэм хэмжээний шаардлагын түвшинд хэргийг илрүүлэн мөрдөж, байцаан шийтгэх ажиллагаа явагдаж байсныг нотолж буй хэрэг болно. “Ши-цзи”-д “Арав хоногоос илүү хугацаагаар хорихгүй, улс даяар хоригдол хүн хэдхэнээс хэтрэхгүй” /134.40/ гэж дурдсан нь ял эдлүүлэх талаар төрөөс тогтоосон хэм хэмжээний гол агуулгыг илэрхийлж байна. Энэ баримтыг ажиглахуйд 10 хоногоос илүү хорихгүй гэсэн нь хорих ял юм уу эсвэл таслан сэргийлэх арга хэмжээ юм уу гэдэг нь тодорхойгүй байна. Ямар ч гэсэн хорих ял байсан боловч энэ нь 10 хоногоос хэтрэхгүй байна. Эсвэл 10 хоног хорих нь ял биш бөгөөд зөвхөн урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түр саатуулах, хэргийг тодруулах хугацаа хэмээн үзэж болох талтай.

Энэ нь удаан хугацаагаар баривчилж саатуулах, эсвэл хорих бодит шаардлага нүүдлийн соёл иргэншилтэй улс оронд төдий л байхгүй байсантай холбоотой юм. Нүүдэллэн амьдрах хэв маяг нь суурьшмал шорон гяндан барих, гэмт хэрэгт сэжиглэгчдийг удаан хугацаагаар байцаах, хорих явдлыг хязгаарлахад хүргэж байсныг тэмдэглэвэл зохино. Нөгөө талаар Хүннүгийн ялын бодлого нь гэмт хэрэгт холбогдвол хамгийн богино хугацаанд гэм бурууг нь байцаан тогтоох, ялыг удаан хугацаанд хорихгүйгээр бусад хэлбэрээр шууд аргаар эдлүүлэхэд чиглэж байснаар тодорхойлогдоно. Энэ бүхэнтэй холбоотойгоор гэмт хэргийг илрүүлэн тогтоох, ял оноож, эдлүүлэх үйл ажиллагаа явагдаж байжээ. Тийм учраас эдэлж буй хүний тоо цөөн байсан бөлгөө. Хүннүд шүүн тасалж, ял оногдуулах дээд эрхийг шаньюй эдэлж байв. Шаньюй ял оноох, ял хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх эрхтэй байжээ. Үүнийг Модун шаньюй МЭӨ 198 онд улсын газрыг дорнод ху-д өгөхийг зөвшөөрсөн түшмэдийг цаазаар аваачсан бол, Хүннү, хятадын гэрээг зөрчсөн баруун сэцэн ванг дайнд явуулсан төдийгээр ялаас хэлтрүүлсэн зэрэг баримтууд нотолж байна.

Төв Азийн нүүдэлчдийн их улс Хүннүд эрх зүй үүсэн хөгжсөн нь тус улсын оршин тогтнохуйн нэгэн нөхцөл, шаньюй тэргүүтэй хаант улсын дотоод гадаад бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл, цааш цаашдын төр улсууд байгуулагдаж өөр өөрсдийн үндэсний эрх зүйгээ үүсгэн хөгжүүлэхэд уламжлал болох үлэмж ач холбогдолтой байсан ажгуу.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

Сяньби, Муюн, Тоба, Тогоон улсын төр, эрх зүй

/МЭ 156-235/

§1.Сяньбийн түүх, удам угсаа

Хүннү гүрний захиргаанд байсан Дунхү аймгуудын дийлэнх нь монгол угсааны аймгууд байжээ. Тухайлбал Хянганы нурууны зүүн талд оршиж байсан Сяньби¹⁹, баруун өмнөд хэсэгт оршиж байсан Ухуань, баруун хойт хэсэгт оршиж байсан Муюн, Тоба аймгууд цөм монгол угсааны аймгууд байсан нь хэл шинжлэл, түүх угсаатны зүйн шинжилгээгээр нотлогдсон болно /43.246/. Тэд цөм хүннү нарын нэгэн адил Төв Азийн нүүдэлчин овог аймгууд байсан бөгөөд хэл ярианы хувьд Алтай язгуурын өвөг монгол хэлтнүүд байжээ /43.246/.

Эрдэмтэд, судлаачдын үзэж байгаагаар Сяньби гэдэг нэр хожмын үед Шивэй хэмээх аймгуудын нэр болж, тэгэхдээ уг нь Шивэй хэмээх нэр байсныг хятад сурвалжид Сяньби, бүр дээр үед тийнхүү Сюйни, Шиби, Сива гэж тэмдэглэн үлдээсэн байна /63.76-77/. Доктор Г.Сүхбаатар “Монголын эртний судлал II боть, Сяньби” хэмээх зохиолдоо “Хүннү, Сяньби хоёрын дунд нэн эртний үеэс овгийн байгууллын үүслийн үеийн давхар байгууламж байсны ул мөр тодорхой мэдэгдэж байна. Энэ бол Хүннү, Сяньби хоёрын гол мөхлөг нь нэгэн угсаатан болохын нэн чухал гэрч юм. Хүннү, Сяньби хоёрын нутаглаж байсан уугал нутаг, овог, аймгийн түүх, хэл, соёл түүхэн хөгжлийг шинжлэхэд тэр хоёр нэгэн угсаатан мөн болох нь давхар нотлогдов” /63.172/ хэмээн дүгнэжээ. Хүннү, Сяньби хоёр нэгэн угсаатан болохоор Сяньбигийн угсааны Ухуань, Муюн, Тоба нар мөн монгол угсаатан болох нь тодорхой юм. Чингэхлээр Хүннү, Сяньби, Муюн, Тоба улсууд болон Ухуань аймаг нь нэгэн угсаатны буюу монгол угсааны улс, аймгууд болой. Эртний монгол хэл, түүх судлаач П.Пеллио, С.Ширатори, П.Базен, А.Будбург, Л.Лигети, Б.Ринчен, Г.Сүхбаатар нарын зэрэг эрдэмтэд “Сяньби, Ухуань нартай нэгэн төрлийн Муюн, Тоба, Түгүхүн, Юйвинь нар ч өвөг монгол хэлтэй байсан нь нотлогдож байна” /43.249/. Эртний хятадын түүх судруудад “Сяньби нарын хэл, заншил нь Ухуаньтай адил төстэй” /43.249/ хэмээн шууд заасан байдаг нь бас нэгэн чухал нотолгоо мөн. Сяньби бол Хүннүтэй бараг нэгэн зэрэг түүхийн тайзнаа нэрд гарч, Хүннү гүрний дараагаар хүчирхэг засаг байгуулан Төв Азийн түүхнээ их нөлөөтэй байсан нүүдэлчин том аймгийн нэгэн билээ /63.5/. Сяньбийн угсааны аймагт Тоба, Муюн, Ухуань аймгууд хамаарагдана.

Эдгээр нь Монгол нутагт Сяньби /150-235/, Муюны Түрүү Янь /285-370/, Хожуу Янь /384-409/, Баруун Янь /384-394/, Тобагийн Дай улс /338-376/, Их Вэй улс /386-538/, Ухуань улс /IY-ҮII зуун/ гэсэн нэрээр оршин тогтнож байжээ.

Дээрх улсууд нь Төв Азийн ялангуяа монголын түүхнээ тод ул мөр үлдээж, түүхч, судлаачдын анхаарлыг ихэд татаж ирсэн бөлгөө.


Сяньби улс байгуулагдсан нь. МЭ 93 онд Сяньбичууд Хятадын цэрэг, Ухуань, Өмнөд Хүннүгийн цэргийн хамт хүчтэй байлдаан хийж Умард Хүннү улсыг мөхөөн, хүн ам, газар нутгийн ихэнх хэсгийг, тухайлбал ар Монголыг эзлэн, хангайн нуруу, Орхон голын хөндийд төвлөрөн орших болсон нь Сяньби улс үүсэн байгуулагдахад шийдвэрлэх роль гүйцэтгэжээ. Гэвч энэ үед Сяньбичууд нэгдэж чадаагүй байсан ч хүчээ төвлөрүүлсээр байжээ. Жишээлбэл, 97-132 он хүртэл Сяньбичууд Хятад руу удаа дараа довтолж, Өмнөд хүннү, Хятад цэргүүдтэй олон удаа байлдаж амжилт олон, нөлөөгөө ихэд дээшлүүлсэн байна.

МЭ II зууны дунд үе болж ирэхэд Сяньбийн дотоод, гадаад байдалд ихээхэн ахиц гарч, үлэмж хүчирхэг, дайчин болж, нэгдмэл улс байгуулах нөхцөл бүрджээ. Энэ нь эр зоригт Таньшихуайн үйл ажиллагаатай холбоотой байв. Таньшихуай²⁰ Сяньбийн зүүн этгээдийн цэргийн жанжины гэрт 141 онд төржээ. Биеэр том, бяр чадал ихтэй, оюун билиг төгөлдөр ихээхэн эрэмгий чадалтай эр болон /43.249/ өсөж, улс тэргүүлэх ур чадвараа удаа дараа харуулсан ухаалаг хүн байжээ. Нэгэн удаад эцгийнх нь эзгүйд эхийнх нь гэрт хэсэг дээрэмчид довтлон ирж, үхэр малыг нь туун оджээ. Үүнийг Таньшихуай сонсмогц тэдний хойноос ганцаар хөөн очоод бүгдийг нь дийлж, үхэр малаа эргүүлж авчиржээ. Тэр цагаас хойш овог, аймгуудын ахлагч нар түүнийг ихэд хүндэтгэн нийт Сяньби даяар мэддэг болжээ. /43.253/ Энэ мэтээр нэр нөлөө нь өссөөр байв. Цэргийн эрдэмд гарамгай, эр зориг эрэмгий шинж чанараараа Сяньбийн аймаг, овгууд хүчээ нэгтгэж, нэгэн улсыг байгуулан сүр хүчийг олж, нэр нөлөөгөө дээшлүүлж, олз ашгаа нэмэгдүүлэхийг хүсэж, бас ч ийм нөхцөл бүрэлдэн байжээ. Нэгэн хүчтэй удирдагчтай болохыг ч дэмжицгээж байв. Иймд өөрсдийнх нь дунд нэр хүндтэй болсон Таньшихуайг Сяньбийн аймаг, овгуудын зонхилгогч, ахлагч, нар хүлээн зөвшөөрч улмаар 156 онд нийлж хуралдаад хаанаа болгон өргөмжилжээ. Ийнхүү Таньшихуай ноёдын хуралдаанаар хаанд өргөмжлөгдөн Сяньби улсыг толгойлох болжээ.

Таньшихуай хаан болмогцоо хуучин Хүннү гүрний нийслэл, түүний ойр орчимд шилжин суурьшиж, хэд хэдэн том аймаг, 200 гаруй овгийг нэгтгэж, улсаа улам хүчирхэг болгожээ. Сяньбичууд Таньшихуайд ямар ч эсэргүүцэл үзүүлэлгүй даган захирагдаж, Таньшихуай ч тэднийг ихээхэн ухаалаг, уян хатан бөгөөд хатуу чанга хууль журмаар нэгтгэн барьж нэгэн зангидмал хүчин болгож чадсан байна /43.254/. Энэ нь Таньшихуайн том гавъяа мөнөөс мөн байлаа. И.Бичурины судалгаанаас үзбээс 155-183 онд Таньшихуай тэргүүтэй Сяньби улс Өмнө зүгт цөмрөн орж, Хань улс, Умард Хятад, Шаньси, Ганьсу мужийг эзэлсний дээр Умардаас Динлин нарын довтолгоо

явдлыг зогсоон, зүүн талд Фуной нарт цохилт өгч, баруун чиглэлд Үсүн нарыг бут цохиж Хүннү нарын эзэлж байсан дорноос өрнөд хүртэлх 14 мянган бээр газар нутгийг бүх уул нуруу, гол мөрөн, гашуун нууруудын хамт эзлэн захирсан байна /84.169/.

СЯНЬБИ УЛС



Зургийг “Монгол Улсын түүх” номын тэргүүн ботиос ашиглав.

Сяньбичууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн, эдийн засаг, аж амьдралынхаа үндэс болгож байв. Аж ахуй, эдийн засаг нь Хүннүгийнхтэй ойр төсөөтэй байв. “Монгол Улсын түүх” /2003/ зохиолд “Сяньбийн эдийн засаг, аж ахуй нь ялангуяа өмнөх үеийн Хүннү нарынхтай нэн асар төсөөтэй байсан” /43.274/-ыг онцлон тэмдэглэсэн байна. Сяньби нарын уугуул нутаг нь их төлөв хангай болон тал хээрийн бүс голлосон эрс тэс цаг ууртай, хуурайдуу уур амьсгалтай нутаг байсан болохоор нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд илүү зохицсон унаган төрхтэй байжээ. Энэ нь өмнөх уламжлалд тулгуурласан нүүдлийн мал аж ахуй тус улсын гол аж ахуй байхыг түүхэн хувь зохиолоор заяагдах нөхцөл болсон ажээ. Сяньбийн аж ахуйн үндсэн цөм нь хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ байсан гэх үндэслэл бий. Сүргийн бүтэц, бүрэлдэхүүний хувьд нүүдэлч малчдын хэрэгцээтэй салшгүй холбоотой байсан хэмээн хэлж болно. Хонь, ямаа, буюу бог мал хүнсний хэрэгцээг хангахад голлон чиглэж байсан бол үхэр, тэмээ нь гэр ахуйн ба тээврийн хэрэгцээнд илүүтэй зориулагдаж, харин адуу нь уналгад бараг тэр чигээрээ хэрэглэгдэж, цэрэг оршихуйн чухал хүчин зүйл болж байсан онцлогтой. Сяньбид чухам хичнээн тооны мал байсан тухай мэдээлэл түүх сударт тодорхой тэмдэглэгдээгүй байна.

Гэсэн ч малын бүтэц бүрэлдэхүүний тухай болон мал сүргийн талаар хэсэг бусад баримтууд дурдагдсаныг эрдэмтэд судалсан байна. Сяньбийн аж ахуйд холбогдох “Хоу Хань шу”-д гэрийн мал болох үхэр байсан тухай бичжээ /63.154/. Манай улсын зүүн хэсгийн шинэ чулуун зэвсгийн булшнаас үхрийн яс их гардгийг үзвээс Монгол нутагт үхэр эрт үүсч гарсан /63.154/ гэсэн дүгнэлтэд хүргэдэг. Доктор Г.Сүхбаатар “Сяньби” хэмээх судалгааны зохиолдоо тус улсад холбогдох хятад сурвалж бичиг, номыг судлаад Сяньбийн мал аж ахуйд хамаарагдах хэд хэдэн чухал баримтыг дурдан дүгнэлт хийжээ. 222 онд Сяньбийн хаан Кэбинэн 3000 гаруй морьтой хүн дагуулан 7 түм гаруй үхэр, адуу туун аваачиж Хятадтай худалдаа хийсэн. Сяньби нар Вэй улсад хүлэг морь бэлэглэж байсан зэрэг баримтууд нь Сяньбид үхэр, адуу олон байсны гэрч мөн. Сяньби нарт хонь зэрэг бог мал бас олон байжээ. Сяньбийн мал аж ахуй нь байгалийн шалгарлаар шилэгдсэн, байгалийнхаа байдалд сайн зохицсон гэж хэлж болно гэсэн дүгнэлтийг эрдэмтэд хийсэн байдаг /63.154/. Мөн ан гөрөө, гар урлал, худалдааг амь зуулгын нэгэн төрөл зүйл болгож, ашиглаж байсны дээр бага зэрэг тариа, будаа тарьдаг байжээ. Тэд алт, мөнгө, хүрэл, төмөр, малын арьс, ангийн үсээр багаж зэвсэг, эд хэрэгсэл, хувцас, гэр ахуйн хэрэглэл хийдэг байсан аж.

Хүннүг бодвол Сяньбийн морь хурдан, зэвсэг хурц гэсэн сурвалж бичгийн мэдээ нь /63.164/ цэргийн зэвсэг сайн хийж байсныг нотолж байна. Сяньбичууд Хятад, Хүннү, Туркестан улсууд болон Монгол ба Монгол бус угсааны аймгуудтай өргөн худалдаа хийж байжээ. Ялангуяа хятадын улсуудтай худалдаа хийхийг ямагт эрмэлзэж

үүний төлөө олон удаа довтолгоон байлдаан хийж байсан түүхтэй. Сяньбичууд зарим үед жил бүр хилийн худалдаа хийж байжээ. Кэбинэн хаан 222 онд өөрөө удирдан Хятадтай өргөн худалдаа хийж байсныг дээр дурдсан билээ.

Сяньби, улс байгуулагдсаны дараа бичиг үсэг, утга зохиол, шашин шүтлэг зэрэг соёлын үнэт зүйлс хөгжжээ. Эртний “Вэй улсын түүх” сударт Сяньби нарыг “Мод сийлэн таних тэмдэг болгож, хол ойрын хэрэг явдлыг хүмүүст улируулан уламжилсан нь түүхч түшмэлийн тэмдэглэл мэт болсон байдаг” /16.33/ гэсэн нь зурж сийлэх бичиг үсэгтэй байсныг илэрхийлнэ. Нэрт судлаач Э.Блоше, П.Пеллио, Л.Лигети, Б.Ринчен, Х.Пэрлээ, Г.Сүхбаатар зэрэг хүмүүс Сяньбийн бичиг үсгийн талаар жинтэй судалгаа явуулж, үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Э.Блоше эртний Түрэгүүд, Хүннү, Сяньбигээс Жужанаар дамжуулан Орхон-Енисейн шаантаг үсэг хэмээх Руни бичиг хэрэглэсэн /55.279/ хэмээсэн нь Сяньби ийм Руни бичиг хэрэглэж байсныг нотолсон хэрэг болно. Сяньби улсад дан ганц бөө мөргөл зонхилж байжээ. Сяньбичууд Жаолед очиж их тахилга үйлддэг байсан нь үүний баримт мөн. Сяньби улсын нийгмийн байгуулал бол феодалын эхэн үеийн байгуулал буюу феодалын өмнөх үеийн байгуулал мөн. Энэ нь аймгийн холбоо, түрүү үеийн феодалын байгуулал хоёрын завсарын үеийн байгуулал гэсэн хэрэг болой. “Өөрөөр хэлбэл уг нийгэм хөгжлийнхөө түвшинээр түрүү феодалын үед тун ойр гэсэн хэрэг” /63.168/.

§2.Сяньбийн төрийн байгуулал

Сяньби нь хаант засаг бүхий монголын эртний улс мөн. Төрийн бүх эрх мэдэл хааны гарт төвлөрч, улсыг тэргүүлэх, төрийг жолоодох, их цэрэг захирах, газар нутаг эзэмших, ял, шийтгэл оногдуулах онцгой эрхийг зөвхөн хаан эдэлж байв. Таньшихуай Сяньби улсын анхны хаан болоод өндөр эрх мэдэлтэй болжээ. Тэрбээр хууль зарлиг гаргах, түүнийгээ биелүүлэх, засаг захиргааны хуваарь тогтоох, бэлчээр нутаг хуваарилах, төрийн түшмэдийн албан тушаалыг бий болгох, тэдгээрт ажиллах хүнийг томилох, улсын дотоод, гадаад бодлогын асуудлыг шийдвэрлэх, дайн байлдаан хийж, цэрэг захирах, найрамдал гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг өргөн эрх мэдэл эзэлж байв. Таньшихуай хаанд өргөмжлөгдөж, түүний нэр сүр, хүч чадал өсөх, эрх мэдэл нь төлөвших, улсаа жолоодох ур ухаан суухад нь Хүннү улсын шаньюй нарын үйл ажиллагаа, уламжлал ихээхэн нөлөө үзүүлсэн нь мэдээж хэрэг. Хүннү нь монгол нутаг дахь анхны монгол угсаатан улс учраас түүний жишээ, туршлага, сургамжаас суралцах, өвлөн авах нь Сяньби улсын хувьд ч зайлшгүй чухал байсан болох нь эргэлзээгүй буй зээ.

Таньшихуай өөрийн үеэс “хаан” хэмээх цолыг хэрэглэхээр тогтоож, үүнээс хойшхи бүх төрийн тэргүүн нь “хаан” цол хэрэглэдэг уламжлал тогтсон байна.

МЭ 181 онд Таньшихуай нас барсны дараа түүний хүү Холянэ эцгийнхээ ор суурийг залгамжлан “хаан” болжээ. Холянэ эцгийнхээ бодлогыг үргэлжлүүлэн Хятад руу хэд хэдэн удаа довтолсон боловч амжилт ололгүй нас барсан байдаг. Түүний дараа хаан ширээнд үеэл Күйтүтэй суусан боловч бас төдий л удалгүй нас барж, дүү Бүдүгийн, түүний дараа Кэбинэн Сяньбийн сүүлчийн хаан болсон байна.

Сяньби улсад гадаад харилцаа хөгжиж байсан ажээ. Сяньби нар анх Цзяньугийн 25 онд буюу МЭ 49 онд Хятадтай элчийн харилцаа тогтоож байжээ. /63.156/ Сяньби 220 онд Вэй улстай найрамдлын гэрээ байгуулж байсан /14.100/.

Холяны хаанчлалаас Сяньби улс задралд орж, сүүлчийн хааны үед улам гүнзгийрэн МЭ 235 онд Сяньби гүрэн буюу Сяньбийн холбоо задарч Сяньби, Ухуань, Муюн, Тоба, Юйвынь, Түгүхунь, Дуань гэсэн хэд хэдэн аймаг улс болж, салсан байна /29.240/. Сяньбийн нийгэмд засаг төрийн үр хөврөл МЭ II зууны үед бүрэлдсэн байна. Эд хөрөнгийн “тэгш бус байдал гүнзгийрсээр, улмаар овог аймгийн ахлагч, толгойлогчид нь эзэн ноён болж, ардын хуралдаан нь язгууртны хуралдаан болон өөрчлөгдөж, овгийн хэв ёсны оронд бичигдмэл хууль, хэв хууль буй болж, нэн эртний давхар байгууламжаас уг сурвалж бүхий баруун, зүүн гар болгох ёс нь засаг захиргааны хуваарь бий болгон эцэст нь хүчирхийлэлийн зэвсэг болох төр үүссэн түгээмэл зүй тогтолт процесс Сяньбийн нийгмийн хөгжлөөс тод харагдаж байна” /63.169/. Сяньби улсад зонхилогчдын хуралдаан буюу язгууртны хуралдаан байсан бөлгөө. Эл хуралдаан нь овгийн байгууллын үеийн хуралдаан биш, харин язгууртны хуралдаан болон цэгцэрсэн шинжтэй юм. Сяньбичууд жил бүрийн хаврын сүүл сард Жаоле гол дээр хуралдаан хийдэг байжээ. Хуралдаан нь хааныг өргөмжилнө. Мөн гадаад, дотоод бодлогын асуудлыг хэлэлцэнэ. Таньшихуайг аймаг, овгийн зонхилогч, ахлагчдын хуралдаанаас хаанд өргөмжилсөн билээ. Гэвч хуралдаан нь улам бүр язгууртны шинжтэй болж зарим үед ширүүн тэмцлийн дунд болдог байжээ. Жишээлбэл, хаан Кэбинэний үеийн нэгэн хуралдаан маш өрсөлдөөнтэй болж, хаан овгийн байгууллыг хатуу дэмжигч, төвлөрсөн төрийг эсэргүүцэгч, аймгийн зонхилогч Фулоханыг хүч хэрэглэн хороож, харъяат нарыг нь эрхэндээ оруулан эзлэн авсан удаатай.

Ийнхүү овог аймгийн хуралдаан нь язгууртны хуралдаан болон өөрчлөгджээ /63.169/ хэмээн доктор Г.Сүхбаатар нотолсон бөлгөө. Таньшихуай Сяньбийн бүх газар нутаг, хүн амыг гурван хэсэг /гар/-т хуваажээ. Хятадын “Хоу-Хань-шу” бичигт дурдсанаас үзбээс Юбэйпингээс /одоогийн Хэбэй мужийн Пинцюаниас баруун тийшхи нутаг/ зүүн тийш Пуё /Фуюй солонгос аймаг/ Елюк /Веймо хэмээх солонгос аймаг/ хүртэлх 20 гаруй аймгийг зүүн хэсэг, Юбэйпингээс баруун тийш Шангу /Хэбэй мужийн Хуайлай тосгон/ хүртэлх 10 гаруй аймгийг гол хэсэг, Шангугаас баруун тийш Дуньхуань хүртэл 20 гаруй аймгийг баруун хэсэг /87.173/ болгожээ.

Монгол Улсын түүхийн тэргүүн ботид Таньшихуайн үед гурван их хэсэг буюу гурван аймгийн төв буюу голынх нь Ар Монголыг хамарч хангайн нуруу, Орхоны хөндий дэх хааны өргөө ордон, нийслэл хотод төвлөж байжээ. Зүүн хэсэг нь Хянганы нуруунаас манж-түнгус Фуюй, Ляодун хойг хүртэлх уудам нутгийг хамарч, дархан уулан дахь Таньшихуайн хуучин өргөө ордны ойр суурин дээр төвлөн суурьшжээ. Баруун хэсэг нь Алтайгаас Дуньхуан, Үсүнх хүртэлх нэн өргөн уудам нутгийг хамарч байжээ /43.255/ Ингэж улсаа гурван хэсэгт хуваасан нь овог аймгийн зохион байгуулалтыг нутаг дэвсгэрийн хуваариар сольсон хэрэг мөн байжээ. Эл гурван хэсэг нь аймгуудад хуваагдана. Хоу-Хань-шу-д дурдсанаар зүүн хэсэг нь 20 гаруй аймаг, голын хэсэг 10 гаруй, баруун хэсэг нь 20 гаруй аймгаас бүрдэж байв. Сяньбид 200 овгууд байсан ч тэд аймаг, хэсгүүдэд хуваагдан тэдгээрт нэгдэж, тэдгээрт харьяалагдан захирагдаж байснаараа тус улсын засаг захиргааны нэгдмэл хуваарийг бүрдүүлж төвлөрсөн хүчирхэг улс байх суурь дэвсгэр нь болсон ажээ. Сяньби улсаа гурван хэсэгт хуваасан нь Хүннүгийн уламжлалыг өвлөн авч хэрэглэсэн хэрэг байлаа. Мөн Хүннүгийн аравт, зуут, мянгатын систем Сяньбид байсан хэмээн доктор И.Бичурин, Г.Сүхбаатар нар нотолсон байна.


Сяньби улсад төрийн түшмэдийн ёсон бүрэлдэн бий болжээ. Сяньбийн баруун, зүүн, гурван хэсгүүдийг хааны томилсон 12 зонхилогч 50 гаруй аймгийн толгойлогч, 200 гаруй овгуудыг ахлагч хэмээх албан тушаалтнууд удирдаж байв. Эдгээр албан тушаалтнууд нь аажмаар “эзэн ноён”, “захирагч” гэсэн утгатай болж, овог, аймгийн удирдахуйн ёсноос нэгдмэл улсын удирдахуйн ёсонд шилжиж байжээ. Хаан гурван хэсэгтээ их анхаарал тавьж тэдгээрийг өөрийн томилсон 12 зонхилогч /захирагч/-оор дамжуулан захирч байв. Хэсгийг захирах зонхилогч нь хааны бодлого, шийдвэрийг шууд биелүүлэх үүрэг хүлээсэн төрийн дээд албан тушаалтан, захирагч, цэргийн жанжнууд байсан бөгөөд хаанд зөвлөх, нөлөөлөх өндөр эрх мэдэлтэй байсан аж.

Сяньби улсад хаан, зонхилогч, толгойлогч, ахлагч, бичээч /бидэчжэнь²¹/, бичиг хэргийн түшмэл /63.120/ сэцэн ван /17.23/ дажень, даши /63.168/ гэх зэрэг албан тушаалтнууд бий болсон байна. Хэсгийн удирдагчийг зонхилогч гэнэ. Таньшихуай зүүн хэсгийн зонхилогчоор Мицзяцюежун, Суликуайтоу нарыг, төв хэсгийн толгойлогчоор Кэцунцюецю, Муюн нарыг, баруун хэсгийн толгойлогчоор Чжицзяньпо, Ложилуй, Тугуйань, Сею нарыг томилжээ. Аймаг удирдагчийг толгойлогч, овог удирдагчийг ахлагч, бичиг хэргийн түшмэлийг /бидэчжэнь/ хэмээнэ. Мөн үйзэн /Чжи-Чжэнь гадаад баруун, зүүн хэсгийн түшмэл/ ямутан, хорчин /зэвсэг хариуцсан түшмэл/, буурч, богтогчин /хувцас хэрэглэл хариуцсан түшмэл/, замчин /өртөөчин/ гэх зэрэг хожим язгуур монголчуудын хэрэглэж байсан албан тушаал Сяньби улсад бас байжээ /63.23/. Тобаг хэрэглэж байсан фучжэнь /буурчин/, чжичжэнь /сэцэн/, /дотоод

баруун хэсгийн түшмэл /янчжэнь /ямутан/ уайжэнь /үйзэн/ /гадаад баруун зүүн гарын түшмэл/ фучжучжэнь /өртөөчин/, цванчжэнь /хэлмэрч/, уихайчжэнь /гэсгээгч/ зэрэг албан тушаал монголчууд /түүний дотор Сяньби /-д хэрэглэгдэж байсныг доктор Г.Сүхбаатар “Сяньби” бүтээлдээ дурдсан байдаг билээ /63.171/. Лидай /Хань-ци-шу/ түүхэн сударт ч энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлан өгүүлсэн байдаг байна /63.35-36/. Энэ бүхэн нь Сяньбид төрийн түшмэдийн тогтолцоо бүрэлдэж байсныг харуулж байна.

Сяньби улсын төрийн байгуулал

/бүдүүвч/



§3. Сяньбийн цэргийн зохион байгуулалт

Сяньби хүчирхэг, сайн зэвсэглэсэн цэрэгтэй байжээ. Тэгэхдээ Хүннүгийн түүхээс үзсэн ч, одоо Сяньбийн түүхээс харахад ч монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудад эр зоригт цэрэг, сайн зэвсэгтэй байсан нь монголчуудын хувь заяатай зайлшгүй холбоотойг тэмдэглэх хэрэгтэй. Юу гэвэл энэ нь суурьшмал соёл иргэншилтэй улстай хэвийн харилцаж, чөлөөтэй худалдаа арилжааг тогтмол хийж байхыг төрийн бодлогын дээд түвшинд баримталж байсантай шууд холбоотой байжээ. Энэ аугаа их агаад зайлшгүй чухал хэрэгцээг хангах эрх ашиг нь цэргийн хүчээ бэлтгэх, эвийн аргыг хэрэглэх нөхцөлгүй болбол шууд довтлон орох чадвартай байх

шаарддагаас урган гардаг байсан байна. Бусад улс, аймгийг эзлэн нутгаа тэлэх, хил хязгаар, нутаг ус, иргэд, хөрөнгөө хамгаалах, бусад улсад цэргийн тусламж үзүүлэх нь Сяньбийн цэргийн үндсэн үүрэг байв. О.Иакинф Бичурины судалгааны бүтээлд Хань улсын нэгэн сайд хаандаа өргөсөн бодрол бичсэн тодорхой баримтыг дурдсан байдаг. 177 оны орчим хаандаа өргөсөн тэр бичигт “Сяньби 100 мянган цэрэгтэй, биеийн хүчин чадал ихтэй, мэдлэг боловсрол нь нэмэгдсээр байна... Сяньби нарын овгууд нь олон бөгөөд урьд цагийнхаас сул доройгүй. Хоёр жилийн турш бид яаж ч чадахгүй байна шүү дээ” /87.172-173/ гэсэн нь Сяньбид хүчирхэг цэрэг бүрэлдэж байсныг харуулж байна. 156 оны үед Таньшихуай 3-4 мянган цэргээр Хятадын умард хязгаарт довтолж байсан бол 158-166 онд хэдэн мянган морьт цэргээр довтолдог болжээ /43.255/. Хань улсын сайд Цай Юин 178 онд хаандаа айлтгасан бичигт “Хүннү улс буруулан зайлснаас Сяньби улс хүчирхэг болж, түүний /Хүннүгийн/ хуучин газрыг эзлээд арван түмэн цэрэг байгуулжээ... Зэвсэг хурц, морь хурдан, Хүннү улсаас хэтэрчээ” /87.173/ хэмээн өгүүлжээ. Дээрхи баримтуудаас үзвэл Сяньбийн цэргийн тоо зуун мянгаас давж, сайн зэвсэглэсэн, цэргийн эрдэмд гарамгай суралцсан чадварлаг цэрэгтэй байсан нь тодорхой байна. Цэрэг нь морьт цэрэг бөгөөд нум, сумаар голлон зэвсэглэж байжээ.

§4. Сяньбийн эрх зүй

Сяньби нь Хүннүгийн уламжлалаас авч өөрийн хэмээсэн эрх зүйг үүсгэн бий болгож байсан ажээ. Сяньбийн эрх зүйн эх сурвалж нь хааны тогтоосон хууль, зарлиг, дүрэм хэмжээ, гэрээ, зонхилогчдын шийдвэр зэргээс бүрдэж байв. Таньшихуайг хаанд өргөмжилсөн, бусад хаад угсаа залгамжилсан, хаанаас улсаа 3 хэсэг, аймаг, мянгат, зуут, аравтад хуваасан, төрийн албан тушаалтнуудыг бий болгосон, 3 голын, баруун, зүүн хэсгүүдэд газар нутаг хуваарилан олгосон, тэдгээрт аймгуудыг харъяалуулсан, хятадын улсуудтай найрамдал, гэрээ хэлэлцээр байгуулсан, хэрэг шийдвэрлэж ял оногдуулсан шийдвэрүүд зэрэг нь эрх зүйн эх сурвалж, түүний хэм хэмжээ үүсэж бий болж байсныг харуулах баримтууд мөн. Сурвалж бичигт Таньшихуай “Цааз тогтоон зөв бурууг шийдэж байсан” /16.32/ хэмээн дурджээ. Сяньбийн Кэбинэн хаан, хойт Хятадын Вэй улсад адуу худалдахыг цааз хориглосон хуулийг “тангаргын гэрээ” нэрээр гаргасан хэмээн дурдсан /43.275/ нь мөн тодорхой баримт юм. Эдгээр нь овгийн байгууллагаас бус төрөөс тогтоогдсоноороо эрх зүйн шинжийг агуулж байсан юм. Ийм акт, хэм хэмжээг тогтоож байсан нь Сяньби хүчирхэг улс болохын хууль зүйн эх үндэс мөн болно. Төрөөс тогтоосон акт, хэм хэмжээний үр дүнд төрийн бодлого, шийдвэр хэрэгжиж, төрийн байгууллагын тогтолцоо бүрэлдэн, үйл ажиллагаа нь эдгээрийн үндсэн дээр явагдах болсон нь чухал ач холбогдолтой юм.

Үүний зэрэгцээгээр төрөөс заншлын хэм хэмжээний тодорхой хэсгийг улс орны хэмжээнд дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрч, тийнхүү хэрэгжих нөхцлийг хангах болсон аж. Үүний дагуу заншлын хэм хэмжээ Сяньбийн эрх зүйн эх сурвалж болж үйлчилж байсан ажгуу. Ялангуяа аж ахуй, хүмүүсийн хоорондын харилцаанд заншлын хэм хэмжээ үлэмж хэмжээгээр мөрдөгдөж байсан түүхтэй. Чингэхдээ төрөөс тогтоосон хэм хэмжээ үргэлж өсөн нэмэгдэх хандлагатай байсныг тэмдэглэвэл зохино. Энэ талаар доктор Ч.Жүгдэр “Сяньби нар анхандаа хэв хуультай байсан авч, хожмоо бичмэл хуультай болсон”/33.83/ хэмээн бичсэн нь зүй тогтлыг харгалзсан үндэслэл бүхий дүгнэлт болно. Таньшихуай цааз тогтоон, түүнээ баримтлан зөв, бурууг шийдэж байсан нь эрх зүй үүсэн бий болж байсны чухал нотолгоо болно.

Энэ нь Сяньбид хэрэг шийдвэрлэх ажиллагаа хууль цаазын дагуу явагдах болсныг илэрхийлнэ. Үүнийг нотлох нэгэн баримт нь Вэй улсад адуу худалдахыг хориглосон хуулийг зөрчиж 1000 адууг Вэй улсад худалдсан аймгийн зонхилгч /тэргүүн/ Су-лид ял асуун цэрэглэн дайрсан үйл явдал мөн. Ял шийтгэлийн төрөл, хэлбэрийн тухай сурвалж бичиг, зохиолуудад тэмдэглэгдэн үлдсэн зүйл хомс боловч төрд тэрсэлсэн этгээдийг цаазаар авч, харъяат иргэдийг хөрөнгийг хураах ял байсныг харуулах баримт бий. Тухайлбал, Хаан төрд тэрсэлсэн аймгийн зонхилгч Фулоханыг цаазалж, харъяат нарыг нь газар нутгийн хамт хураан авч өөртөө захируулсан байна. Сяньбид цаазаар авах ял байсан ч үхэр, хониор золио өгч ялаас хэлтэрч болдог байжээ. Түүнчлэн эцэг, эхээ алсан хүнд алах ял оногдуулалгүй харин хойд эх, бэргэнтэйгээ заавал сууж тэднийг тэжээх хуультай байв. Ийнхүү Сяньбид эрх зүй үүсэж, түүнийг биелүүлэхэд хатуу шаардлага тавьж, зөрчвөл мөн хатуу хариуцлага хүлээлгэж байсныг харуулах бөлгөө. Сяньбид эцэг нь нас барвал хойд эхээ, ах нь нас барвал гэргийг нь эхнэр болгох ёсон ноёрхож байсан аж. Сяньбичууд гэрлэхдээ хүргэн болох хүн нь хадам болох айлд хоёр жил сууж, хамаг ажилд нь туслан өөрийгөө ойлгуулж таниулсны дараа хадам болох тал нь бэлэг сэлт өгч охиноо хүргэнийдээ хүргүүлдэг заншилтай байжээ.

§5. Муюн²² улсын төр, эрх зүй /МЭ 285-410/

Муюн нь Хянганы нурууны баруун хойд хэсэгт оршиж байсан монгол угсааны нүүдэлчин аймаг юм. Түүний хэл, соёл, шашин шүтлэг, зан заншил нь Хүннүтэй бараг адил буюу олон талаар төсөөтэй байжээ. Муюн нь Сяньбитай төрөл угсааны өвөр монгол хэлтэн болно. Муюнчууд Хянганы нуруунаас аажмаар урагшилсаар Хятадын зүүн хойд хил орчим нутаглах болсон цагаас Хятадын түшмэд харъяат болох юм уу эсвэл Сяньбитай хамтарч Хятадыг довтлох үйл ажиллагааг байнга явуулж байжээ. 285 онд Муюн Хой муюнчуудын их ноён болж нилээд нэрд гарсан байна.

Тэрбээр 294 онд Муюн улсыг байгуулж Хятадын Янь улсыг эзлэн, Яньцзун / Бээжин/-д төвлөрч Өвөр Монголын зүүн хэсэг, Хятадын зүүн хойд хэсэг газар нутгийг засаглан захирах болсон байна. Яньцзин хотод төвлөрсний улмаас Муюн улсыг Муюны Янь улс, хожуу Янь улс хэмээн нэрлэж байжээ. 333 онд Муюн Хой хааныг нас барсаны дараа түүнийг Муюн Хуан залгамжилж, 337 онд өөрийгөө Хожуу Янь улсын ван хаанаар өргөмжилжээ. 341 онд Муюны нийслэл нь Лунь чэн хот болжээ. 348 онд Муюн Хуаныг нас барахад түүнийг Муюн Цзюнь залгамжилж Муюны Янь улсын ван цолтой болсон байна. Муюн Цзюнь 349 онд умард Хятадыг, 352 оны үест Өмнөд Хүннүгийн Чжао улсыг эзлэн авч Бээжин хотыг нийслэлээ болгон өөрийгөө умард Хятадын эзэн хаанаар өргөмжлүүлж байжээ. Хүннүг мөхсөний дараа Муюнчууд Өвөр Монголын зүүн хэсэгт шилжин очжээ. Янь улс нилээд хүчирхэг болж байсан боловч дотоодын зөрчилдөө самууран удалгүй хоёр хэсэг болон салсан байна. 410 онд Янь улс Тоба Вэй улсын цэрэгт цохигдон мөхсөн ажээ.

Муюн улс мөхсөн боловч бүхэл бүтэн аймаг овгуудын хувьд устан үгүй болоогүй бөлгөө. Муюнчуудын нилээд хэсэг нь удам угсаа хэл заншлаа хадгалан оршиж байгаад Тангудын хаант улс зэрэг бусад улсын бүрэлдэхүүнд орсон байна. Тоба, Жужан улсууд оршиж байх үед тэд эдгээр улсын бүрэлдэхүүнд багтаж байсан түүхтэй. Муюн бол Төв Азийн нүүдлийн иргэншилт улс орны тоонд багтан түүхийн тавцан дээр гарч иржээ. Түрүү феодализмын хөгжилтэй улс орон, аймгуудын нөлөөгөөр Муюны хаад, ноёд, язгууртнуудын дунд феодалжих үйл явц явагдсан байна. Гэхдээ Муюн улсад феодалжих үйл явц түрүү феодализмын эхэн шатнаас төдий л хэтэрсэнгүй /43.267/ ажээ. Муюн нь нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн, Төв Азийн нүүдлийн соёл иргэншилтэй улс байв. Нүүдлийн малчид нь өвс, усны аяыг дагаж, нэгээс нөгөөд шилжин нүүдэг хэмээн сурвалж зохиолд тэмдэглэжээ. Газар, бэлчээр цөм хааны гарт төвлөрч, хаан, ихэс, ноёд, сурвалжтанууд, тус тусын эзэмшил газартай байв. III зууны үед Муюн улсын хаан Муюн Гүй, Түгүхүн хоёр хүүдээ 1700 өрхийг газар нутгийн хамт эзэмшил болгон тасалж өгсөн байна. Мөн худалдаа арилжаа хийх, бага зэргийн тариа тарьж, гар урлал эрхэлж, дайнд олзолсон хүмүүсийг зарцлан ажиллуулж байжээ. Муюн улс Руни бичиг соёлын нилээд амжилтад хүрсэн улс байв.

Муюн улс Ху-гийн Руни бичгийг хэрэглэж, бас ном зохиол бичиж, орчуулж байсан аж. Муюнчууд бас хятад боловсрол олж, хятадын бичигт суралцаж байжээ. Муюнчууд бөө мөргөл шүтэж өвөг дээдэс, удам угсаагаа их л хүндэлдэг байжээ. Муюн нь хаант төртэй улс байлаа. Төрийн тэргүүн нь шаньюй, хаан, ван хэмээх цол хэрэглэнэ. Муюны төрийн түүхэнд Муюн Шэгүй /221/, Муюн Хой, Муюн Чуй, Муюн Бао, Муюн Хуан, Муюн Цзюнь хаад төр барьж байжээ. Хятадаас Муюн Шэгүйд их шаньюй хэмээх цол өгч байсан бол Муюн Хой өөрийгөө Сяньбийн их шаньюй хэмээн

тунхаглаж байжээ. Мөн Муюн Хуай 337 онд хожуу Янь улсын ван, Муюн Цзюнь 348 онд Муюны Янь улсын хаан хэмээх цолтой байсан аж. Муюны хаад нь Муюн улсын төлөө хүчээ өгсөн, эрдэм ухаан, эр зоригтой хаад байсан нь түүхээс харагдана. Муюн Хой өндөр боловсролтой хятад сайд, түшмэд нарыг урьж, тэдний мэдлэг чадвар, санал зөвлөгөөг авч төр улсаа удирдаж байжээ. Муюн Хуай эцгийнхээ байгуулсан тусгай сургуульд суралцаж сайн боловсрол, мэдлэг эзэмшсэн хаан байсан ажгуу.

Муюн Хуай ухаантай, боловсролтой, зоригтой хүн байсан гэдэг. Тэрбээр “Хаан ширээнд суугаад хатуу ширүүн цаазаар улс орныг удирдаж байжээ /43.260/”. Муюн улсад түшмэдийн ёс бүрэлдэн бий болж эхэлсэн байна. Цэргийн жанжин, цэрэг дайны бүх хэргийг ерөнхийлөн захирагч, төрийн сайд, хааны туслах, сайдын орлогч, тойргийн ерөнхийлөгч зэрэг албан тушаалтнууд ажиллаж байжээ.

§6. Тоба улсын төр, эрх зүй /313-581/

Тоба улс байгуулагдсан нь. Тоба²³ гэдэг нэр бол уг аймаг, улсын нэрийг Хятадын дүрс үсэг, утга бичгээр ойролцоо дуудлагатайгаар тэмдэглэн үлдээсэн нэр юм. Эртний түрэгийн гэрэлт хөшөөний бичээсүүдэд Тоба Вэй улс, Тоба нарыг “табгач” хэмээн нэг мөр болгон нэрлэсэн нь бий. Түүнчлэн арабчууд түүнийг “тамгаж”, византичууд “таугас” гэж нэрлэдэг байсан нь табгач хэмээх нэр болохыг нотолж байна /43.249/. Судлаач А.Будберг Тоба гэдэг үгийг “дабага-даваа, гүвээ” гэсэн Монгол үг хэмээсэн нь илүү үнэний хувьтай ажээ. Энэ нь үндэслэлтэй агаад учир нь Тоба нар анх Хянганы нурууны умард хэсэг, Хэнтийн нурууны зүүн хойд хэсэгт, Орхон голын адаг, Эргүнэ мөрний эхний уул даваа ихтэй нутагт оршин амьдарч байжээ. Эртний улсуудын их судлаач доктор Г.Сүхбаатар А.Будбергийн дүгнэлт “Миний таамаглалтай ойролцоо байна” /63.92/ хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг бөлгөө.

Хүннү гүрний үед МЭӨ II зууны орчим Мао Хань аймгийн холбооны зонхилогч тэргүүтэй Тоба нар нэгдэж, 36 аймаг, 99 овогтны холбоо болж, хүчирхэгжиж эхэлсэн байна. Тоба нар аймгийн холбооны зонхилогчоо хан хэмээн нэрлэх болжээ. Хүннүг мөхсөний дараа Тоба нар өмнө, баруун өмнө зүг нүүж, Туйнь хааны үед Өвөр Монголын хойд талын Шилийн гол, Долоннуур, Далай нуурын орчим нутаглах болсон аж. Үүнээс 160 орчим жил өнгөрсний хойно Тоба аймгуудын холбооны хан Линь аймгуудаа 10 хэсэг болгон захирч байв. Линь ханы хүү Гэфын хааны үед Тоба нар Өвөр Монголын түмэд, Юншээбү аймгуудын нутагт очиж, өмнөд Хүннүгийн зарим овгуудтай хольцолдон нутаглах болжээ /43.261/. 295 онд Тобагийн холбооны зонхилогч Лигуань хан засаг захиргааны хуваарь, түшмэдийн ёсны чиглэлээр өөрчлөлт хийж умард нийслэл Пинчэн хотыг байгуулсан байна. Тэрбээр Умард хятадын нилээд хэсгийг эзэлж, өмнөд Хүннү Хань улсын цэргийг бут цохин үлэмж хүчирхэг болсон аж.

Лигуаний дараа 313 онд Тоба Илү зонхилогч болж, улмаар Тоба улсыг үндэслэн байгуулж анхны хаан болжээ. 315 онд Хятадын Цзинь улс Тоба улсыг хүлээн зөвшөөрч, хаанд нь “Их ван” хэмээх цол олгосон байна. Үүний дараа Тоба Илүгийн нэр хүнд ихэд өсөж, Тоба улсын сүр хүчин мэдэгдэхүйц нэмэгджээ. Тоба Илүг Тоба Юйлюй зэрэг хэдэн хүн дараалан залгамжилсан түүхтэй. Хаадын дотроос 338 оны орчим хаанд өргөмжлөгдсөн Шэйг Янь ухаантай, зоригтой, боловсролтой хүн байсны хувьд засаглал, хууль цаазын чиглэлээр нилээд өөрчлөлт хийсэн байна. 386 оны эхээр Тоба Гүй хаан ширээнд сууж “Дай улсын ван” хэмээх цол хүртжээ. Тоба Гүй өргөө ордоо Ченло хотод төвлөрүүлж, мал аж ахуй, газар тариалан, албан татварын талаар зарим өөрчлөлтүүд хийж олны талархалыг хүлээсэн ажгуу. Тоба Гүй хаан 386 оныхоо хавар /5-р сард/ Дай гэсэн улсынхаа нэрийг “Тоба Вэй” хэмээн өөрчилж, өөрийгөө Тоба Вэйгийн ван гэж өргөмжилжээ. Тоба Гүй ван, Тоба улс Муюны хожуу Янь улсын түшмэг хараат улс байсныг өөрчлөхөөр 395 онд Хожуу Янь улсад дайн зарлан ялалт байгуулсан байна. Тоба Гүй улсын нийслэлийг Пинчэн шилжүүлэн төвлөрүүлж, улс орон даяар жин хэмжүүрийг жигдэлж, хууль цаазыг чангатгаж, зурхайн хэрэгсэл, тооцоог сайжруулах зэрэг өөрчлөлтүүд хийсэн байна. 397 оны эхээр Тоба Гүйг хаан ширээнд суух ёслол үйлдэж Тоба Вэй улсын хаанаар өргөмжлөн нийт даяар зарлан тунхаглажээ. Тоба Вэй улсыг бас Юань Вэй улс хэмээн нэрлэдэг бөгөөд Тоба Гүй хааныг Юань Вэй улсыг үндэслэн байгуулагч гэж үздэг байна. Тоба Вэй, Юань Вэй улсын нутаг дэвсгэр, хүн амын ихэнх нь хятадууд болж, хятад, тоба холимог, нүүдэл, суурьшил хосолсон улс болж хувирсан байна. /43.265/. Тоба Вэй, Юань Вэй улсын нийслэл нь эртний хятадын зүүн Хань улсын нийслэл байсан Лоян хот болж, хятад маягаар оны цол хэрэглэж түүнээ хятадаар нэрлэх болжээ.

Тоба улсын хаад аажмаар хятадын нөлөөнд автаж, тоба нарыг хятаджих бодлого явуулж, Сяо Вэньда хааны үеэс тоба үндэсний хувцас өмсөх, тоба хэлээр ордны дотор ярилцах, тоба хэлийг албан хэрэгт хэрэглэхийг хориглосон зарлиг буулгаж байжээ /12.106/. 535 онд Тоба Вэй улс зүүн, баруун хоёр хэсэгт хуваагджээ. Зүүн Вэй улс 535-549, Баруун Вэй улс 535-556 онуудад оршин тогтнож, үлэмж хятаджсан улсууд болж байгаад 581 онд хятад хаад, ноёд засгийн эрхийг авснаар бүр мөсөн мөхсөн бөлгөө. Ийнхүү Тоба улс 313-581 онд буюу 280 шахам жил оршин тогтнож байсан түүхтэй.

Тоба улсын эрхлэх үндсэн аж ахуй нь мал аж ахуй байжээ. Харин Тоба Гүй хаан улсын нийслэлийг Пинчэнь хотод нүүлгэснээс хойш Тоба нарын зарим хэсэг нь газар тариалан эрхлэх болжээ. Тоба Гүй хаан олон муж, тойргоос 100000 хүнийг авчруулан тариа тариулж, тариа тарих цэргийн хуарангуудыг байгуулан, тоба хүнийг тариа тарих ажилд сургаж байсан аж. Улсын хаан газар, бэлчээрийг мэдэн зохицуулна. Хаан, ихэс ноёд бүр тус тусын эзэмшил газартай байжээ.

Тобагийн Ли Вэй хааны өвөг эцэг нь өөрийн хүн ам газар нутгийг долоон ах дүүдээ хуваан эзэмшүүлж байжээ.

Нүүдэлчин малчид тус бүрдээ газар өмчлөн эзэмшдэггүй боловч чөлөөтэй нүүдэллэн эзэмшинэ. Тоба нь бичиг соёлын хувьд нэлээд амжилтанд хүрсэн улс юм. Тобачууд Руни бичиг хэрэглэж байжээ. Францын эрдэмтэн П.Пеллио тоба хэл бичгээр бичсэн 60x50 хэмжээтэй дардас байсныг дурдсан байна. Тобачууд бас хятад боловсрол олж авч байжээ. Тоба улсад бичиг хэргийн асуудлыг хариуцсан “бидэчжэнь” хэмээсэн тусгай түшмэл ажиллаж байсан аж. Тоба нар Юань Вэй улсыг байгуулан Лоянь хотыг нийслэл болгосны дараа Хятад бичгийн зурлага, дуудлагын үндсэн дээр 1000 гаруй үсгийг зохиож 425 оны билгийн улирлын гуравдугаар сараас эхлэн төрийн албан ёсны “Шинэ үсэг” болгон хэрэглэсэн байна /43.283/. Тоба нар Руни, “Шинэ үсэг”-ээр олон ном, зохиол бичиж, орчуулж, хэвлэж байжээ. Тобад анхны үед бөө мөргөл шүтдэг байснаа, Тоба Вэй улсыг байгуулсны дараа буддын шашинд орж, Энэтхэгийн соёл, иргэншлийн нөлөө их дэлгэрч байсан аж. Тоба Вэй улсад бурхны шашин төрийн шашин болж байжээ. Тоба Гүй хаан буддын шашны суварга барьж, буддын шашны захиргаа байгуулж, тэргүүнээр нь алдар хүнд, нөлөө бүхий лам нарыг томилон ажиллуулж байв. Энэ нь Тоба Вэй улсад төрийн ёс, шашны ёс хоёр нягт холбоотой, зарим талаар хамтарсан маягтай байсан, гэхдээ төрийн ёс давамгайлж байсныг харуулж байна /43.284/. Тийм ч учраас төрийн ёс, шашны ёс хоёрын аль алиныг нь зэрэгцүүлэн хэрэглэх хоёр ёсны үзэл, үйлдлийн үндэс суурь нэгэнт тавигдаж эхлээд байсан ажээ /43.284/. Тоба Вэй улсад буддын шашин дэлгэрснээр сүм хийд, лам нарын тоо тасралтгүй нэмэгдсээр байв. Ся–Вэньди хааны үед нийслэл Лоян хотод 2000 ламтай 100 илүү сүм дуган байсан ба нийт улсын хэмжээгээр 678 сүм, 77258 лам байжээ /12.105/. 510 оны үед хүрээ хийд 13000 болж, лам нарын тоо нэгэн саяд хүрсэн /12.105/ аж. Ийм байдлаар Тоба улсад буддын шашин үлэмж хүчтэй дэлгэрч байсан болой.

Төрийн байгуулал. Тоба Вэй, Юань Вэй улс засаглалын хэлбэрийн хувьд хаант улс байв. Төрийн эрхийг хан буюу хаан барина. Хятадын Ганму бичигт нүүдэлчдийн түүхэнд “хан” цол анх удаа чухамхүү Тоба нарын үест үүссэн болохыг заагаад энэ цол уг утгаараа эртний Хүннүгийн шаньюй цолтой адил гэжээ /10.167/. Тобагийн түүхэнд Мао, Туийнь, Линь, Лигуань, Тоба Илу, Тоба Юйлюй, Шэигянь, Тоба гүй, Гао цзу, Вэнь Чэн-ди, Тоба-До зэрэг хаад төр барьж байв. Тобагийн хаад нь зонхилогч, толгойлогч, хан, ван, хаан гэсэн цолуудыг хэрэглэж иржээ. Тобагийн хаад үе залгамжилж хаан болдог байв. Тоба Гүй хаан эзэн хааны ширээ залгамжлах журам гаргаж байжээ.

Тобагийн хаад нь хууль цааз гаргах, хил хязгаарыг тогтоох, засаг захиргааны хуваарийг тогтоох, тэдгээрт газар нутаг хуваарилах, төрийн түшмэдийг томилох, тэдэнд цол зэрэг олгох, алба татвар оногдуулах, дайн байлдаан хийх, найрамдал, гэрээ

хэлэлцээр байгуулах, ял шийтгэл оноох, орд өргөө барих, цэргийн зохион байгуулалт хийх, аж ахуй, үйлдвэрлэл, эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээ авах, шашин, соёл, бичиг үсэг дэлгэрүүлэх зэрэг нилээд өргөн эрх эдэлж, улсаа удирдаж байсан ажээ. 295 онд Тоба аймгуудын холбооны зонхилогч Лигуань хан аймгуудын холбоогоо Хүннү, Сяньбийн уламжлалын дагуу зүүн, голын, баруун гэсэн гурван хэсэг болгон хуваажээ. Зүүн хэсэг нь Бээжингээс хойгуур Хожуу Янь улс буюу Муюны Янь улсын Шандуу гол, түүнээс баруун тийших нутгийг харьяалж, Лигуань өөрөө захирах болжээ. Голын хэсэг нь одоогийн Өвөр Монголд Датунгийн хойд талд оршиж Тоба Ито толгойлж байжээ. Баруун хэсэг нь одоогийн Хөх хотын баруун хойд, Бугат хотын хойд талд оршиж Тоба Илу удирдаж байв. Тоба Ито Жужан, Гаогюй болон баруун зүгийн 30 гаруй овог аймгуудыг байлдан дагуулж өөртөө нэгтгэсэн ажээ. 338 оны үед Шэйгянь хаан, төрийн ажилд дадлага, туршлагатай хятад, сайд түшмэдийг өргөнөөр ашиглаж, засаг захиргаа, хуулийг жигдлэн тогтоох арга хэмжээ авсан байна.

Тобагийн Дай улсын үед зүүн хэсэг нь Хатон гол, Шар мөрнөөс зүүн тийшхи хэсгийг харьяалж, Лю Кужинь ноён, баруун хэсэг нь Шар мөрнөөс баруун тийшхи ордос нутгийг хамарч Лю Вэйчэнь ноён захирч байжээ. 386 онд Тоба Гүй хаан мал аж ахуй, тариаланг хөхүүлэн дэмжиж, алба татварыг хөнгөлөн, олон түмний аж амьдралыг хөнгөвчлөх арга хэмжээ авсан байна. Мөн урт, хүнд, хөнгөний нэгдсэн хэмжүүрийг тогтоон, хэсэг аймгуудад газар таслан өгч, тэдний хил хязгаарыг тогтоосон байна. Тобагийн хаан Мао, Лигуань, Шэнгянь, Тоба Гүй хаан нар тус улсын төрийн байгуулалт, эдийн засаг, соёлын салбарт дорвитой өөрчлөлт хийж тус улсын түүхэнд ул мөрөө үлдээсэн хаад байжээ. Тоба улсад төрийн түшмэдийн тогтолцоо бүрэлдэн тогтож эхэлсэн түүхтэй. Хаан, хан, зонхилогч хэмээх албан тушаалууд бий болсон нь төрийн дээд албан тушаалууд бөгөөд тэдгээрт ажиллагсад нь улс, аймгийн холбооны болон баруун, зүүн голын хэсгийн тэргүүнүүд байжээ. Шэйгянь хаан түшмэдийн орон тоог бий болгон захирах, тушаах ажлыг эрхлүүлэн, засаг захиргааны талаар зарим арга хэмжээнүүд авсан байна /12.104/. Тоба Гүй хаан хятад бичгийн хүмүүсийг төрийн ажилд өргөнөөр оруулж, засаг захиргааны газрыг хятад маягаар байгуулан, сурвалжтан нарыг 9 зэрэг дэвтэй болгожээ /12.104/. Тобагийн аймаг бүрт ахлагч ажиллах бөгөөд тэдгээрийг хаан томилно. Тоба улсад сургагч, зааварлагч, ахлагч, бидэчжэнь /бичээч/, цайчжэнь /үйзэн/, циваньчжэнь /хэлмэрч/, янчжэнь /ямутан/ зэрэг алба бий болж, мэдлэг боловсролтой хүмүүсийг томилон ажиллуулж байв. Тобад наад зах нь 120 аймаг байсан бөгөөд тэдгээрийг удирддаг ахлагч нар нь төрийн орон нутгийн албан тушаалтны үндсэн цөмийг бүрэлдүүлж байсан аж.

Алба татвар. Тоба Вэй улсын албан татвар ихээхэн хүнд байв. Тоба Вэй улсын хаад нүүдэлчин аймгуудаас малын алба, тариачдаас газрын түрээс, олбор бүхий аж

ахуйгаас ашгийн татвар авах тогтолцоог бий болгожээ. Тоба Вэй улсын хаан Тоба Гүй 413 онд 60 өрхөөс байлдааны нэг морь авах зарлиг гаргасан байна. Дараа нь 421 онд 100 толгой бог, бод мал тутмаас нэг морь татах цааз тогтоожээ /12.106/. Эл үед байлдааны нэг морь 20-30 хоньтой тэнцэх үнэтэй байсан нь дээрх татварын үлэмж өндөр байсныг харуулна. Тоба Гүй хаан нүүдэлчин малчин аймгуудаас мал, мах, арьс, үсээр алба авч байсан нь дараагийн хаадын үед улам нэмэгдсэн байна. Тоба Вэй улс нүүдэлчид ба суурьшмал иргэдийн аль алинаар биеийн хүчний янз бүрийн хүнд алба гүйцэтгүүлж байжээ. Мөн цэргийн албанд өргөн хэмжээгээр дайчилж байв. Дээр дурдсанаас үзэхэд Тоба Вэй улсад алба татварын үлэмж нарийн тогтолцоо бий болон үйлчилж байсан нь тодорхой байна.

Цэрэг. Тоба Вэй улс үлэмж тооны хүчирхэг цэрэгтэй байжээ. Тобагийн цэрэг хэд байсан, түүний зохион байгуулалт ямар байсан тухай баримт сурвалж бичигт харьцангуй бага тусгагдсан байна. Гэвч Тоба нарын аян байлдааны үйл явцтай холбон үзэж зарим баримт гарган тавьж, дүгнэлт хийж болмоор байна. 396 оны намар Тоба Гүй хаан 400000 явган, морьт цэрэгтэйгээр Муюны хожуу Янь улсыг дайлаар байлдсаныг үзэхэд эл үед Тоба Вэй улс дөрвөн зуун мянган цэрэгтэй байсан нь илт байна. Тоба Вэй улс явган ба морьт цэрэгтэй байжээ. Цэрэг нь нум сумаар гол зэвсэглэнэ. Тоба нар ба бусад овог, аймаг, улсын хүмүүсийг цэрэгтэй дайчлан татаж, цэргийнхээ тоог нэмэгдүүлж, аян байлдаанд оролцуулдаг байжээ. Мөн албан тариа тарих үүрэг бүхий цэргийн суурингуудыг байгуулан ажиллуулж байв. Тоба Вэй улс дайнд ялагдан олзлогдсон цэргүүдэд хатуу хандаж байжээ. Тоба Гүй хаан өөрийн эсрэг дайтсан Ордосын захирагч Лю Вэйчжэний цэргийг бут цохиод 5000 хүнийг нь цаазаар авч байсан /43.264/ нь түүний нэгэн нотолгоо болно.

Эрх зүй. Тоба Вэй, Юань Тоба улсад өөрийнх нь онцлогийг илэрхийлэн харуулсан эрх зүй бүрэлдэн тогтож байжээ. Хаадын тогтоосон хууль дүрэм болон төрөөс дагаж мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээнүүд эрх зүйн эх сурвалжийг бүрэлдүүлж, тэдгээрийн агуулга нь хаант улсын бодлого, үйл ажиллагаа явагдах эрх зүйн үндэслэл болж байсан бөлгөө.

Түүхэн сурвалж, бичиг зохиолоос үзэхэд 338 онд Шэйгянь хаан хууль гаргаж, тогтоож, засаг засаглал, цааз хууль, ял шийтгэл зэрэгт нилээд шударга байдлаар хандсан нь олны талархлыг хүлээж байжээ /43.263/. Тоба Вэй улсын хаан Тоба Гүй “Хууль цаазыг нарийсган чандалж, эрүүгийн хууль зохион, ёслолын дуулал, хөгжмийн дүрмийг шинэчлэн, цаг тооны холбогдолтой тэнгэрийн зурхайн хэрэгсэл, тооцоо зэргийг нягтлан шалгаж, засаж сайжруулах үүргийг харьяат сайд, түшмэд, эрдэмтэн, мэргэжилтэн нартаа үүрэг болгож байжээ /43.264/”. Мөн түшмэдийн эрх хэмжээний дүрэм зохион, ордны ба бусад дэглэмийг буй болгож, иргэний ба цэргийн

хэрэг шийтгэгч түшмэдийг дэвшүүлэх, бууруулах журам тогтоож байжээ /12-177/. Энэ бүхэн нь Тоба Вэй улсын хаад хууль, зарлиг, дүрэм батлан гаргаж түүнээ хэрэгжүүлж байсныг харуулна. Эдгээрийг үндэслэн хааныг угсаа залгамжлуулж, улсын баруун, зүүн, голын хэсгийг байгуулж, тэдгээрт газар нутгийг хуваарилан олгож, албан тушаал, орон тоог бий болгон тэдгээрт зохих хүмүүсийг томилж, цэрэг дайны үйл ажиллагаа явуулан, алба татвар хурааж, ял шийтгэл оногдуулж, эдлүүлж байсан ажгуу. Түүхэн сурвалж дахь баримтуудаас үзэхэд цаазаар авах, албадан ажил хийлгүүлэх, гэр орноор ял халдаан оногдуулах, боол болгох ял хэрэглэж байсан нь харагдана. Төрд тэрслэх, төрийн эсрэг бослого гаргах, тариалангийн ажилд муу зүтгэх, цэрэг дайчилгаанд ирэхгүй байх, бослогыг толгойлох, түүнд оролцох зэрэг үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж, тийм хэрэг үйлдэгчид ял оногдуулж байсан аж. Жишээлбэл, Тобагийн Вэнь Чжэнди /452-466/ хааны үед ял халдсан тариачид, боолчуудыг тариалан мэтийн хүнд хүчир ажилд зүтгүүлсэн байна /43.265/. Юань Вэй улсад цэрэг дайчилгаанд ирээгүй хүнийг хатуу цээрлүүлэн шийтгэж, гэр хотлоор нь хүйс тэмтрэн алсан байна /43.305/. Тоба Вэй улсад Сюань-ээр толгойлуулсан бослогыг дараад бослогыг толгойлсон, түүнд оролцсон хүмүүсийг цөмийг нь барьж цаазаар авч байжээ /43.266/.

§7. Ухуанийн төр, эрх зүй

Ухуань²⁴ нь Хүннү гүрний үед түүнд эзлэгдэн захирагдаж, Сяньби улсын үед бүрэлдэхүүнд нь багтаж байсан монгол угсааны аймаг болой. Ухуаньчууд Хүннү, Сяньбичүүдтай хамтран хятадын эсрэг олон удаа довтолж байсны дээр мөн хятад улсад хүчээ өгч хил хязгаарыг нь хамгаалж агсан түүхтэй. Сяньби улс задрахад Ухуань аймаг салан гарсан байдаг. Ухуань нь Сяньби, Муюн, Тоба нартай ойр төрлийн аймаг юм. Ухуань аймаг их хүчирхэг, том аймаг байгаагүй боловч бие даасан, түүхэнд ул мөрөө үлдээсэн монгол угсааны аймгийн нэгэн байсан болой.

Ухуань нар Хүннү, Сяньбийн харьяанд оршин байснаа Сяньбийн оршин тогтнохуйн сүүл үед биеэ даан гарч ирсэн түүхтэй. Баруун Хань улсын хаан Вань Мань ухуаньчуудыг зүүн хойт хилдээ аваачин хилээ хамгаалуулахаар суулгасан авч нутаг руугаа зайлан одож, хүннүчүүдтэй эргэн нийлж, зүүн хойд хятад руу удаа дараа довтолгоон хийж байжээ. Ухуаньчууд зүүн Хань улсын Гуан Удгийн үед Хятадаас түшмэг, хараат байдалтай байж, цэрэгт нь хавсарсан хүч болж, алба төлөн Хүннү, Сяньбийн эсрэг тэмцэж байсан өвөрмөц түүхтэй болой.

109 оны зун Ухуаньчууд 1000 орчим хүннүчүүдтэй нийлж, хятадын зүүн хойт хэсэг рүү довтолсон байна. Эл үед Ухуанийг Үхэ хэмээх ноён удирдаж байжээ. Эл ноёны удирдлагаар тэд Өмнөт Хүннү, Сяньбичүүдтэй нийлэн 7000 цэрэгтэй болж хятадын умард хил рүү довтолсон байна.

168 оны үест Ухуаньчуудын ноён Кюлигюй хүчээ нэгтгэн, Сяньби нарын дэмжлэг авч Хятадтай хүчтэй сөргөлдөж эхэлжээ. 188 онд Кюлигюй нас барсны дараа түүний хамаатан Датунь, ухуань нарын тэргүүн ноён болсон байна. Хятадын тал Ухуаний хэд хэдэн овог, аймгийн ахлагчдыг шаньюй хэмээн өргөмжилж тамга тэмдэг олгожээ. Ухуаньчуудаас хятадын эсрэг тэмцэж, удаа дараа довтолж байсан нь гол төлөв худалдаа арилжаа хийгдэхгүй саатах, алба төлөх, түүний хэмжээ нэмэгдэх зэргээс шалтгаалан аж амьдрал нь хүндэрдэг байсан гэх мэттэй холбоотой байсан аж. Мөн Ухуань нар хүн цөөн, хүч буурай байсан учир Хүннү, Сяньбичуудтай нэгдэн нийлж байсан бололтой.

Ухуань нарын голлон эрхлэх аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй байжээ. Мөн ухуаньчуудын нилээд хэсэг нь мал, газар тариалангийн ажлыг хослох, эсхүл зарим нь тариаланг дагнан эрхлэх явдал ч байсан аж. Тэд бас ан гөрөө, гар үйлдвэрлэл эрхэлж байжээ. Ухуаньчууд эдийн боловсрол, оюуны соёлтой, бөө мөргөлтэй, өөрийн гэсэн өвөрмөц зан заншил, ёс суртахуунтай, нүүдлийн соёл иргэншилтэй байжээ. Ухуань нь Ху-гийн бичиг хэмээх руни үсэг хэрэглэж байсан байна. Ийм бичиг нь яс, мод, чулуу, хүрэл, төмөр дээр цохих, сийлэх аргаар бичигдэн үүссэн түүхтэй. Ху-гийн бичгийг ч мөн тэгж бичиж байсан /43.281/ ажээ. Хүннү, Сяньбийн нэгэн адил бичиг үсгийн асуудлыг хариуцсан “бидэчжэнь” буюу “бичээч” ажиллаж байсан ажээ.

Ухуань нарын заншил Төв Азийн бусад аймаг, улсынхтай адил төстэй хэдий ч бас ялгаатай зүйл ч байсан аж. Сурвалж бичигт /Эртний Хятадын гурван улсын түүх/ Сяньби нарын “Хэлний дадал, заншил нь Ухуанийхтай адил ... Хаврын сүүл сард олноор Жао Цоле голд хуралддаг. Эрд гарах, ураг барилдахдаа үсээ хусч найрлаж хуримладаг” Ухуань нар нь “ураг барилдах гэвэл эхлээд хүүхэнд сэм хэлдэг, магадгүй хагас жил болоод эсхүл зуу хоноод хүн явуулж, адуу, үхэр, хонь хүргүүлэн, сүй билэг тавьдаг. Хүргэн нь хадмындаа очиж байгаад эхнэрээ авч, төрхөмдөө эргэж ирэхэд гэрийнхэн нь цөм босцгоож мөргөдөг ...

Хадмындаа 2 жил зарцлагддаг, түүний дараа хадам нь охиноо хадамд нь элбэг баянаар гаргаж өгдөг” /43.283-284/ хэмээн дурджээ. Энэ нь Ухуаньчуудын гэр бүл болохдоо мөрдөж байсан заншлын хэм хэмжээг илэрхийлэн харуулж байна.

Ухуаньд анхандаа хэв хууль мөрдөж байснаа сүүлдээ хууль гаргаж байсан бололтой. Хууль, шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй агаад хэрэв зөрчвөл хүндээр шийтгэдэг байжээ. Чингэхдээ зольж болох ёс бас байжээ.

Алах ялыг үхэр, хониор зольж ялаас нь хэлтрүүлж байсан бололтой. Энэ бүхэн нь Ухуаньд эрх зүй үүсэж эхэлж байсныг харуулж байгаа хэрэг юм.

§8.Тогоон улсын төр, эрх зүй

/МЭ IY зууны эхээс-ҮШ зууны эцэс/

Түгүхүний үүсэл нь Муюн улсаас салж одсонтой холбоотой. III зууны дунд үе, дэд хагаст амьдарч байсан Муюны Шэгүй хааны хүү Муюнгүй эцгийгээ залгамжилж хаан болжээ. Эцэг нь амьд ахуйдаа Түгүхүнд 1700 муюн, Сяньби өрх айлыг газар нутгийн хамт эзэмшил болгон олгосон байна /123.228/. Түгүхүн²⁵ дүүтэйгээ муудалцсаны улмаас баруун зүг нүүдэллэн Инь шань уулын баруун өмнөд хэсэгт суурьшиж байснаа IY зууны эхээр цааш нүүж, Хөх нуурын орчим нутаглан, тэндэхийн цян угсааны Тангуд аймгуудыг засаглан захирах болсон байна /123.229/. Эл үеэс Түгүхүний харъяаны Муюн, Сяньби овог аймгууд цөм Түгүхүнчүүд гэж нэрлэгдэх болжээ. Түгүхүн үнэн хэрэг дээрээ тэндэхийн Монгол угсааны анхны хаан болсон байна. Түгүхүнчүүд хаанаа “кехан” /каган/, хатнаа /кэцзүнь/ /катунь/ хэмээн өвөг монгол хэлний дуудлагаар цоллох болсон аж. Түгүхүн хаан нас барсаны дараа түүний 60 хүүхдийн дотроос бараг 2 м өндөр Туянь хэмээх хүү нь эцгийн хаан орыг залгамжилжээ. Туянь хааны дараа Еянь, Шилиянь, Шүлогянь зэрэг язгууртнууд 15 үе дараалан хаан ширээнд суусан байна. Тогоон улс 800 оны орчим мөхжээ.

Түгүхүний улс нь нутгийн хэл аялга, хожмын Тангуд, түвд судрын мэдээгээр дамжин Тогоон²⁶ улс хэмээн алдаршсан юм /43.269/. Тогоон улс нь зүүн талаараа Тоба Вэй, Хятадтай, баруун талаараа Хотантай хиллэж байжээ. Өмнө тал нь Анчэн, Лүнхэ газар, Таошуй гол, Байлань ууланд тулж, турфаны урд талын Гаочан хот хүрч байжээ. Тогоон улсын нийслэл нь Хөх нуураас баруун тийш 8-9 км-г орших Фусычэн хэмээх хот байв. Тогоон улсын дэвсгэр нутгийн хэмжээ нь зүүнээс баруун тийш 3000 бээр газар /1700 гаруй км/, өмнөөс хойш 1000 бээр /576 км орчим/ байсан хэмээн түүх сударт тодорхой заасан байна /123.227/.

Тогоон улсын хүн ам мал аж ахуй эрхлэн амьдарна. Гол төлөв хөдөө хээр газар мал маллаж нүүдэлчний ёсоор амьдарна. Мөн бага зэргээр арвай будаа тариалж хүнсэндээ хэрэглэнэ. Тогоон улсын цян нар худалдааг нилээд хэмжээгээр эрхэлдэг байжээ. Овог, аймгууд тус бүр эзэмшил газартай байсны дээр, нүүдлийн малчид бэлчээр, усны ая, цаг улирлын байдлыг харгалзан овог, айл өрхөөрөө чөлөөтэй нүүдэллэн амьдарна. Мөн зарим хаад жишээлбэл Муюн Гүй хаан 2 хөвгүүндээ өрх иргэдийг газар нутгийнх нь хамт өмч болгон өгч байжээ.

Хөрш зэргэлдээ улс, аймгуудтай аль болохоор аядуу зөөлөн, эвийг нь олж харилцахыг эрмэлзэнэ. Тоба Вэй, Хятадын цзинь зэрэг улсуудтай эвсэг найртай байхыг чухалчилж байв. Дипломат харилцаандаа тэднийг ихэд хүндэлж, өөрсдөө даруухан байж, аятай, зохистой уг хэл, нэр томъёо хэрэглэдэг байжээ. Бас бусдад дагаар орохыг хүсэхгүй байсан аж.

Ү зууны 30-40 оны үест Тогоон улсын төрийг барьж байсан Мулиянь хааны ахын хөвгүүн нь Тоба Вэй улсад дагаар орохыг завдмагц Мулиянь түүнийг алж устгаж байсан нь /43.270/ үүний нотолгоо юм. Мулияний дараа Тогоон улсын хаан болсон Шилинь Фулочуань Тоба Вэй улсын цаг тооны бичгийг хүлээн авч жил, сар, өдөр, цаг мөч бүрийг тогтоосон ёсоор дагаж мөрдөж байжээ. Үүнд нь Тоба Вэй улс дургүйцэхэд Хятадын Цинь улс зэрэгтэй нэгэн адил дотно харилцаж, элч илгээлцэн, шилдэг сайн морьд, хонь бэлэг болгон барьж байсан аж.

ҮІ зууны тэргүүн хагас, дунд үед Тогоон улсыг захирч байсан Казалюй хаан, Тоба Вэй улсын хаанд элч илгээж адуу мал бэлэглэн харилцаж байсны дээр Хятадад элч илгээж, бэлэг хүргэн эв найртай байхыг хүсэмжилж байжээ. 591 онд Тогоон улсын хаан болсон Фу хятадын Сүй улсад элч илгээж, бэлэг сэлт хүргүүлэн харилцан найрамдаж, ургийн холбоо тогтоохыг хүссэн байна. 596 онд Сүй улс эл хүсэлтийг хүлээн авч, нэгэн ноёныхоо охиныг гүнж болгон өгч Тогоон улсын хааныг Сүй улсын хааны тавнан /хүргэн/ болгож байжээ.

Тогоон улс өвөрмөц онцлог бүхий нүүдэл, соёл иргэншлээ хадгалан үлдээж, руни бичиг үсэг хэрэглэн, ном зохиолоо эл бичгээр хэвлүүлж байсан аж. Түүхэн сурвалжид Сяньби улс ху-гийн бичлэг хэмээх руни бичиг хэрэглэж байсан болохоор түүний удмын Түгүхүнь өвөг монгол угсааны аймаг их, бага аливаа байдлаар хэрэглэж байсан нь мэдээж хэрэг /43.280/ хэмээн тэмдэглэсэн байдаг. Тогооны хаан, язгууртнууд хятадын боловсрол эзэмшихийн хамт, эртний сургаал номд суралцан Кунзийн сургаал сэлтийг нилээд сайн мэддэг байжээ. Түүх сударт Түгүхүнь нарыг бичгийн боловсрол, эрдэм соёлоор сайтай байв хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг байна. Тогоон улс, Түгүхүнчүүд бөө мөргөлийг шүтэж, бөө удган, мэргэч, төлөгч нар их нөлөөтэй байжээ.

Муюны Янь улсаас салж одсон Түгүхүнь ноёныг эгүүлж ирүүлэхээр Муюн Гүй хааны элчийг хүрэлцэн очиход Түгүхүнь ноён өмнөөс нь Муюн Гүй бид хоёр ч ... бид адуунаас болж хөндийрэн салсан, тэр нь үзтэл тэнгэрийн таалал байсан ажгуу /22.10-11/ гэж өгүүлснээс үзэхэд Түгүхүнь нарын дунд мэргэ төлгө үлэмж дэлгэрч, хүч нөлөөтэй байсныг харуулж байна. Тогоон улс нь хаант төртэй, монгол угсааны улс байв. Төрийн тэргүүн нь хаан бөгөөд хаанд өргөмжлөх ёс нь угсаа залгамжлах ёс юм. Хааныг гол төлөв өөрийн жинхэнээс хатнаас төрсөн хүүхдийн аль нэг нь авьяас билэг, хүч чадал, зориг хатуужил, боловсрол соёл, нэр хүндээрээ тодорч хааны орыг залган, хаан ширээнд сууж, хаан хэмээх цол хэрэглэнэ. Хэрэв хүүхдүүдээс нь хаан болох хүн байхгүй бол хааны дүү зэрэг удмын хүн нь хаан болно.

Төрийн тэргүүн нь “хаан”-аас гадна шаньюй ван, удигбалэдоу зэрэг цол хэрэглэж байв.

Тогооны анхны өвөг монгол угсааны хаан нь Муюны Шэгүй хааны хүү, Хөх нуурын газарт засаглан сууж байсан Түгүхүн байжээ. Түгүхүн хаан 72 насандаа таалал төгссөний дараа түүний Туянь, Еянь, Шилинь, Шулогянь, Ачай, Мулиянь, Шилинь Фулочуань, Куалюй, Фу, Фуюнь, Муюн Шүн, Нохэбо, Муюн Фуд нар угсаа залгамжлан Тогоон улсын хаан болж төр барьж байсан аж.

Тогоон улсын хаад нь өөрийн улсыг аль ч улсын хараат болгохгүйгээр бие даан оршихыг хатуу зарчим болгож, үүнийхээ төлөө бүхнээ зориулж байсан уламжлалтай. Мулиянь хаан ахынх нь хөвгүүн Тоба Вэй улсад дагаж орох гэсэн учир цаазалж байсан явдал үүний тодорхой жишээ мөн. Бас Фуюнгийн хөвгүүн Муюн Шүн хятадын хааны ордонд барьцаалагдан байсныг Тай цзун хаан суллаад Тогоон улсын хаан болгон хүргүүлсэн боловч Тогоончууд түүнийг Хятадын нөлөөнд автсан этгээд хэмээн үзэж, удалгүй барьж алсан удаатай /43.273/. Энэ мэт бусад баримтууд ч бий бөлгөө.

Тогоонд түшмэдийн ёс, тэдгээрийн албан тушаал, цол, хэргэм үүсэж эхэлсэн байна. Зонхилогч, сайд, жанжин, түшмэл, элч гэх зэрэг тушаал, тэдгээрт ажиллах ноёдуудыг хаан томилж байжээ. Муюн Гүйн өвөг эцэг Муянь “мэргэн”, эцэг Ши-гүй нь “шаньюй” цолтой байжээ. Тогоон улс хүчирхэг дайчин улс байсан байна. Цэрэг нь зориг тэсвэртэй агаад байлдааны зэвсэг болгон нум, сум, сэлэм, жад, бамбай зэргийг хэрэглэж байв. Тогоонд харь улсад дагаж орох, урвах, бусад улсын нөлөөнд автахыг жигшүүртэйд үзэж, тийм хэрэг үүлдэх юмуу завдсан байвал барьж авч алдаг байжээ. Энэ талаар дээр өгүүлсэн билээ.

Тогоонд хүн алсан, адуу хулгайлсан хүний амийг өршөөлгүй шууд цаазаар авдаг байжээ.

Эр хүн эцгийгээ нас барсны дараа хойд эхээ, ахын үхсэний дараа гэргий нарыг нь эхнэрээ болгон авдаг заншилтай байсан нь Хүннү, Сяньби угсааны овог, аймгууд дахь ёс заншилтай адил байв.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**Монгол Жужан улсын төр, эрх зүй****/МЭ 330-555/****§1. Жужан улс байгуулагдсан нь**

Жужан²⁷ улс МЭ-ний 330 онд одоогийн Монгол Улсын нутгаар төвлөн байгуулагдсан, Төв Азийн нүүдлийн соёл иргэншилтэй улс юм. Жужан улсын түүх нь Мугулюйтэй салшгүй холбоотой эрэлхэг зоригт дайчин Мугулюйн /Монгол/ хүү Чаругуй, Чуньтулинь аймгийг түшиглэн бусад аймгуудыг нэгтгэж захирснаар Жужанчууд нэгэн захиргаанд оржээ. Судлаачид МЭ IY зууны эхэн үеэс түүхэнд Жужан хэмээх нэр тэмдэглэгдсэн гэж үздэг. Энэ цагаас хойш “Жужан” гэх нэрийг олон улсын төрийн түүх, шастирт янз янзын хувилбараар тэмдэглэж ирсэн боловч тэр нь бүхэлдээ Жужан аймгуудыг ерөнхийлэн зааж /123.264/ ирсний түүх байсан ажгуу.

Хятадын сурвалж бичгүүдэд Жоужань, Жуй-Жуй, Жу-жу, Жуань жуань, Жужуй, Жужань гэх мэт олон янзаар бичиж ирсэн боловч тэр нь цөм Жужаныг зааж байсан түүхтэй.

Хятадын шаньси мужийн Датун хотын Угжоушань уулын Юньган агуйд буй хөшөөнд Жужан гэсэн нэрийг бичсэн нь буй. Хятад судлаач Фэн Цзяшэн хөшөөний бичээсэнд буй “Да Жужу го” үгийг “Их Жужан улс” гэж орчуулжээ /65.11/. Жужанчууд өөрсдөө нэрлэдэг албан ёсны нэр нь “Их Жужан улс” мөн байна /65.11/ хэмээн их түүхч доктор Г.Сүхбаатар нотолжээ. Түүх, хэл шинжлэл, угсаатан зүйн эрдэмтэд тухайлбал Бэйс Хайсан, Б.Ринчен, Б.Карл Грен, Ван Ли, С.Ф.Ким, С.А.Старости, Б.Я.Владиморцов, Г.Сүхбаатар, Рашид-ад-Дин зэрэг эрдэмтэн судлаачид, “Жоужан” нэрийг нягтлан судлаад язгуур монгол угсаатны нэгэн ерөнхий нэр болох Жужан гэсэн нэр мөн байна хэмээн нотолсон бөлгөө. Ираны түүхч Рашид-ад-Дин Нирунчууд бол “угтаа Алунгоогийн сэргээсэн овогоос гаралтай. Монгол аймгуудын түүхнээ “Жужан” гэх нэрийн утга агуулга ихэд анхаарал татаж иржээ. Рашид-ад-Дин “Жужан” гэсэн үг нь персээр “Суло” гэх “нирун” /нуруу/ гэсэн утгатай үг. Алунгоогийн овогос түүний нөхөр Добу мэргэнийг нас барснаас хойш гэрлийн туяанаас жирэмсэн болоод гурван хүү төрүүлжээ. Эдгээр хөвүүний овогт харъяалагддаг хүмүүсийг Нирун гэж нэрлэдэг /59.110/.

Дээрхи гурван хөвүүн, тэдний овог тутмаас гарагчдыг “нуруу” гэнэ. Гэрлээс үүссэн болохоороо цэвэр нуруугаар гарсан хүүхэд болдог /59.135/. Доктор Г.Сүхбаатар Жужан гэдэг нь “Жоужань” гэх хятад үсгүүдийн эртний дуудлагыг баримтлан нөхөн сэргээсэн худам Монгол бичгийн Жужан гэдэг үг мөн бөгөөд орчин үеийн дуудлагаар нуруу гэсэн үг юм гэж бичсэн билээ.

2003 онд хэвлэгдсэн “Монгол Улсын түүх” тулгуур зохиолын тэргүүн ботид “Нирун нь язгуурын монголчуудын эртний нэгэн том салбарын нэр бөгөөд угтаа нуруу гэсэн үг бий” /43.288/ хэмээн тайлбарласан байна.


Чаругуй хаан, өөрийн нэгтгэсэн аймгуудын дотор нуруу, тулгуур болж байсан Жужан аймгийн нэрээр улсаа Жужан гэж нэрлэсэн магадлал ч бас байж болох юм. Гэвч эл үед Жужанчууд Тоба улсад алба барьж, хараат шинжтэй байснаасаа гарч чадаагүй байжээ. Тоба улсын эрхшээлээс бүрмөсөн гарч бие даасан улс болох нь Жужанчуудын гол зорилго байжээ. Жужан аймгуудыг нэгтгэсэн Мугулюйн тэмцлийг түүний хүү Чуругуй үргэлжүүлж, олон Жужан аймгийг нэгтгэн улс байгуулаад, бурхны шашны нэг домгийн монгол хувилбар болох Алун-Гоогийн үндсэн дээр улсаа Нирун /Жужан/ нэрлэж өөрөө хаанаар нь өргөмжлөгджээ. Жужан улс чухам хэдэн онд байгуулагдсан тухай тодорхой мэдээлэл хомс байдаг. Үүнтэй холбогдуулан нэрт судлаач Г.Сүхбаатар “Монгол Нирун улс” хэмээх эрдэм судлалын зохиолдоо эх сурвалжийн баримтуудыг судалж, түүхэн он цагийн нарийн харьцуулалт хийгээд ”Чаругуй анхны хаан учир ойролцоогоор 330 оноос хойш байж таарахааргүй байна” /65.11/ гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Г.Сүхбаатарын судалгааны үндэслэлийг авч үзэхэд үнэнхүү баримттай, тооцоотой агаад Жужанчуудын /нирунчуудын/ анхны толгойлогч бол Мугулюй /Монгол/ байсан. Харин Жужанчуудыг нэгтгэн улсаа Нирун гэж нэрлэн Жужан улсыг үндэслэн байгуулсан хүн нь Чуругуй болой. Түүнийг хүү Тунугуй, түүний хүү Бутай, бас түүний хүү Дэсигүн нар хаан болсон хэдий ч Тобагийн эрхшээлээс гарч чадаагүй ажээ. Дэсгүн хааны дараа Жужан, зүүн, баруун гэсэн хоёр хэсэгт хуваагджээ.

Үүнээс хойш Жужан нар Тоба Вэй улсын довтолгоон, дотоодын хямралд олон жилийн турш өртөгдсөн түүхтэй. IY-Y зууны зааг үеэр Жужаны сурвалжтануудын дотроос Шэлүнь тодрон гарч их элсэн говиос хойш нутаглаж байсан монгол, уйгур, түрэг угсааны олон аймгийг нэгтгэн хүч нөлөөгөө нэмэгдүүлсээр хамгийн сүүлд 402 онд хаан ширээнд сууснаа зарласан байна /43.292/. Ийнхүү Тоба Вэй болон бусад аль ч улсаас хараат бус бие даасан Жужан улс байгуулагджээ. Жужан улсын бүрэлдэхүүнд зохих байр суурийг Дунху, Сяньби нараас гаралтай аймгууд, бас Хүннү нар зэрэг монгол аймгууд эзэлж байжээ. Жужан улс нь нийт язгуур монголыг нэгтгэсэн, төвлөрсөн нэгдмэл улс, нүүдэлчдийн түрүү үеийн феодалын улс, бусад олон улс орныг харьяалан захирсан Төв Азийн хүчирхэг улс байсан байна.

Жужан улс Хань, Карашар, Турфан, Жимса, Куча, Камак, Шаньшань, Усунь, Кашшир зэрэг улс орнуудыг эзлэн авч, харьяалан захирч байсан түүхтэй.

Жужан улс 220 гаруй жил оршин тогтнож байгаад 555 оны орчим мөхсөн түүхтэй.

ЖУЖАН УЛС



Зургийг “Монгол Улсын түүх” номын тэргүүн ботиос ашиглав.

Жужан улс Хүннү, Сяньби зэрэг монгол угсаатны уламжлалыг өвлөн хэрэглэж, үлэмж удам газар нутагтай, олон ястан, овог, аймаг бүхий харъяат иргэдтэй, гадаад өргөн харилцаатай, монгол соёл, бичиг үсэгтэй, хоёр ёсонд тулгуурласан хүчирхэг засаг төртэй, Монголчуудын түүхэнд асар их үүрэг гүйцэтгэсэн улс байсан болой.

Жужан улс байгуулагдсан нь Мугулой Илу /304-316/-ийн нэртэй шууд холбоотой. Зоригт эр Мугулой, Чуньтулинь аймгийг түшиглэн олон жил эрэлхэг тэмцэл хийж Жужан улсыг үүсгэн байгуулахад амь амьдралаа зориулж асар их үүрэг гүйцэтгэжээ.

Жужан улсад төр ба бурхны шашны ёс хослон биелэж байсан онцлогтой. Хоёр ёсны сургаал үүсэж, бурхны шашин төрийн шашин болсноор “Жужан улс тэр үедээ монгол орны бурханы шашны төв болж байв” /65.134/. Жужан улс, төрийн багш өргөмжлөн, бурханы шашны ёс, бичиг соёлыг дэлгэрүүлж, бичгийн сайд, түшмэдийг бэлтгэн, төрийн албан хэрэг хөтлөлтдөө ихэд анхаарч байжээ. 438-489 оны үед Жужан улсын хаан Чуну бурханы шашны ном, ёс, авидарма, санхэ гүн ухааныг тойлж чаддаг лам Дарматрияг төрийн багшаар өргөмжилснөөр бурханы шашин албан ёсоор төрийн шашин болж монголчуудын их соёлын бүрэлдэхүүн хэсэг болон хөгжиж эхэлсэн байна. Үүний зэрэгцээгээр Жужан улсад бөө мөргөлийг мөн шүтэж байв. Энэ үед бөө мөргөлийн гол шүтээн нь тэнгэр байсан бөлгөө. Чингэхдээ бөө мөргөл нь нийгмийн ахуй амьдралын хүрээнд хүчтэй нөлөөлж, удган бөөнүүд ажиллаж байжээ. Жишээлбэл Чуну хааны үед Дивань хэмээх удган бөөлж байсан түүхтэй ажгуу.

Жужан улс өөрийн хэмээсэн бичиг үсэгтэй улс байжээ. Жужан улс өөрийн бичиг үсэгтэй байсныг судлаач эрдэмтэн В.С.Таскин, А.Коллоуц, Х.Миякова, Г.Сүхбаатар, Х.Хандсүрэн, Сурбадрах зэрэг хүмүүс нотлон өгүүлсэн нь бий. Сурбадрах, Жужанчуудын бичгийн мэдээг иш татан Жужанчууд модонд хэрэг учраа тэмдэглэн зурах бөлгөө. Хожуу болоход аажмаар бичиг үсэгтэй болсон байна. Тус улсад эрдэмтэн мэргэд нилээд амой /67.277-278/ хэмээн дурджээ. Доктор Г.Сүхбаатар, Жужан улсын бичиг нь “Худам Монгол бичиг байсан бололтой” /65.116/.

Тэрбээр Хятадын сурвалж бичгүүд дэх Жужаны тухай мэдээ баримтуудыг харьцуулан судлаад “Жужанчууд ямар нэг бичиг хэрэглэж хэрэг явдлаа тэмдэглэдэг байсан нь тов тодорхой байна” гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Жужан улсад бичиг үсэг бий болсон төдийгүй эрдэм номтой хүмүүс олноор төрсөн байна. Түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн баримтаас үзбээс Энэтхэг лам Ратнаманти, Лоян хотод нэгэн Жужан хүнтэй уулзаад “түмэн хуйлаас ном уншсан хүнд ч давагдахааргүй эрдэмтэй хүн гэж хүндэтгэн харь /хятад/ хэлээр өдөржин ярилцдаг байжээ. Тэр хоёр бүр дундат Азийн оронд байхын танил байсан байна. Бодвол тэр Нирун хүн Ратнамантатай санскрит хэлээр хэлэлцдэг байсан байх” /65.117/ хэмээн бичсэн нь бий.

Өөр нэг баримтыг сөхвөл “Хятад түшмэл нэгэн Жужан хүнийг үл тоомсорлосон байдлаар “чавганы модны боловсорсон үрийн тоог гаргаж чадвал морио өгнө” гэж мөрийцөхөд нөгөө жужан хүн бүсэн дэх хавтаганаасаа таван өнгийн утастай нэг дэнсэрхүү юм гарган, чавганы модыг хэдэн тийш нь хэмжин үзээд бодосхийж байснаа чавганы модны үрийн тоог яг хэлэн хятад түшмэлийн морийг хожсон байна” /65.117-118/

Доктор Г.Сүхбаатар “Монгол Нирун улс” номондоо тус улсын төрийн сайд Силинь зурхайн тоо мэддэг, мэрэг тайлж чаддаг, олон хэлээр ярьдаг эрдэмтэй хүн байсныг, мөн Вэй улсын хаад Жужанд явуулах тунхагаа Жужан бичгээр зохиож байсныг дурдан өгүүлжээ. Энэ мэт баримтууд цөөнгүй бий. Эдгээр нь Жужан бичиг үсэгтэй, боловсорсон бичгийн хэлтэй, бичгийн соёл хөгжсөн, эрдэм номтой хүмүүс, бичгийн сайд түшмэлүүдтэй улс байсныг харуулнам.

Жужан улсын иргэд нүүдлийн мал аж ахуй эрхэлж, энэ талаар бий болгосон их соёлтой байснаар барахгүй байгаль, газар шороо, бэлчээр нутаг, уул ус, ургамал, амьтныг хайрлан хамгаалж биширдэг, амьдрах ухаанд суралцсан, удам угсаагаа бэлтгэн, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлж, улс орон, эх нутгаа хамгаалан тэмцэж, арилжаа худалдаа, гадаад харилцаа холбоогоо хөгжүүлж байсан түүхэн уламжлалтай ажээ.

Жужан улсыг судлахад нэн гол агаад чухал үүрэг гүйцэтгэх учиртай сурвалж бичиг, бүтээлд ихээхэн анхаарал тавьбал зүйтэй юм. Ийм сурвалж бичиг, бүтээлд “Нань-шу” /Өмнөд Цин улсын түүх 479-502/, “Лян шу” /Лян улсын түүх 502-567/, “Вэй шу” /Вэй улсын түүх. 386-572/, “Сун шу” /Сун улсын түүх 420-479/, “Нируны тухай хэрэглэгдэхүүний эмхэтгэл” /1962/, “СиньЦзяны хуучны дурсгалыг үзсэн нь” зэрэг сурвалж бичгүүдийг онцлон нэрлэж болно.

Н.В.Бичурины “Хятадын төрийн түүхэн дэх Жужаны тухай бүлгийн хэрэглэгдэхүүн” /Орос орчуулга 1950/, В.С.Таскины ““Нань-Ци-шу”-аас бусад төрийн түүхэн дэх Жужаны тухай бүлэг” /1984/, Г.Учидагийн “Нируны түүхийн үйл явдлын он цагийн жагсаалт” /1944/, А.Коллаци, Х.Мичава нарын “Нируны тухай хэрэглэгдэхүүний эмхэтгэл” /1970/, А.Тойнбын “Түүх судлал” 12 боть /1957/ бүтээлүүд Жужаныг судлахад чухал хэрэглэгдэхүүн болно.

Жужаныг судлахад Монголчуудын туурвисан бүтээлүүд чухал ач холбогдолтойг дурдах нь зүйн хэрэг. Эдгээр бүтээлүүдийн дотроос доктор Г.Сүхбаатарын “Монгол Нирун улс. 330-355” /1992/ хэмээх шинжлэх ухааны зохиол Жужанаас /Нирун/ улсын түүхийг бүхэлд нь хамарсан дорвитой бүтээл мөн.

Энэ зохиолыг Нирун судлалаар туурвисан бүтээлүүдийн ноён оргил нь мөн гэж хэлж болно.

Бас Ц.Хандсүрэнгийн “Жужаны түүхийн зарим асуудал” /1968/ бүтээл Жужаны дагнасан судалгаанд хувь нэмрээ оруулсан болой.

Монгол Улсын түүхийг бүтээсэн “БНМАУ-ын түүх, Тэргүүн боть” /1966/, “Монгол Улсын түүх, Тэргүүн боть” /2003/, “БНМАУ-ын түүх, Нэгэн боть” /1984/, А.Амарын “Монгол Улсын түүх” /1984/, зохиолууд дахь Жужан улсын тухай зүйлүүд Жужан судлалд чухал ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй.

§2. Жужан улсын гадаад харилцаа

Жужан нь өргөн гадаад харилцаатай, арилжаа худалдааг ихэд хөгжүүлэн дэлхийн түвшнээ гаргасан улс гүрэн болой. Жужан нь гадаад харилцаагаа Ази, Европын олон улс орныг хамааруулан өргөн хэмжээгээр хөгжүүлж байжээ. Эл гүрэн нь Византи, Перс /Иран/, Энэтхэг, Хятад, Солонгос, Эфталит, Турфан зэрэг томоохон улсууд болон тухайн үедээ Ази, Европын нутаг дэвсгэр дээр оршин байсан Вэй, Баруун Вэй, Зүүн Вэй, хожуу Цин, умард Янь, умард Лян, Тогон, Варвалид, Парфи, Хотон, Усунь, Жимса, Юэжи, Согд, Куча, Кумоси, Камак, Шаньшань, Карашар мэт улс орнуудтай харилцаа холбоо тогтоож, элчин төлөөлөгч солилцож, гэрээ хэлэлцээр байгуулж, захидал илгээн, тунхаг гаргаж байжээ.

Жужан улс хөрш оршдог Хятадын Вэй улстай /386-534/ хамгийн өргөн харилцаатай байхыг эрмэлзэж байв.

Энэ нь хөрш хоёр улсын аль альных нь ашиг сонирхолтой гүн гүнзгий холбоотой байлаа. Жужан улс хожим нь хоёр улс болж салсан Баруун Вэй /535-581/, Зүүн Вэй /534-550/ улсуудтай ч харилцаагаа хөгжүүлж байсан аж. Эрдэмтэн, судлаач О.Латимор, В.Эберхард, А.Колацу, Х.Миякова, А.С.Мартынов, С.Л.Тихвинский, Г.Сүхбаатар нар энэ талаар нилээд өргөн судалгаа явуулж, дүгнэлт хийсэн байна.

Жужан улс 402-523 онд буюу 104 жилийн хугацаанд Вэй улсад 41 удаа элчин илгээж, бэлэг барин, худалдаа хийж байсан бол Вэй улс хариуд нь 128 элчин төлөөлөгч ирүүлж /65.28/ байжээ.

Жужаны хаан Чуну 511 онд Вэй улсад лам Хун Сюиныг илгээн сувдан бурхан бэлэглэсэн нь түүхнээ тэмдэглэгдсэн байдаг. Мөн 514, 517, 518 онд Юйби, Цзинь, Улюба, Гунчули нарыг Вэй улсад элчээр илгээж байсан аж. Жужаны хаан Тулун 486 онд өөрийн элчээр Мут түшмэлийг илгээхэд Вэй улсын хаан Сяовоно уг элчийг хүлээн аваад элчингийн ёсыг сайн мэддэг хүн байна хэмээн талархаж байсан нь түүхэн сурвалжид тэмдэглэгдэн үлджээ.

Жужан Хятадын бусад улсууд, тухайлбал Сун /420-479/, Ци /479-502/, Лян /502-557/ улстай харилцаатай байжээ. Жужан 463-478 онд Сун улсад 8 удаа элчин илгээсэн байна. Жужан улс 442-441 онд 100 жилийн дотор баруун уртрагийн торгон замаар Сун улсад 10, Ци улсад 3, Лян улсад 8 удаа элч илгээн харилцсан байна. /65.63/ Жужан улс гадаад улсын элчин төлөөлөгчдийг хүлээн авах тусгай журамтай байжээ.

Мөн өөрийн элчин төлөөлөгчдийг төрөөс батламжилсан “гэрэгэ”²⁸-тэй илгээдэг ёсыг бий болгон хэрэглэж байсан аж.

МЭ 450 оны 7 дугаар сард Хятадын Сун улсад илгээсэн Жужаны элч гэрэгээгээ үзүүлж байсныг /65.97/ сурвалж бичигт тэмдэглэсэн байна. Жужан улс Хүннүгийн үеэс уламжилсан “торгоны зам” буюу худалдааны гол замын төлөө бусад улсуудтай байнга өрсөлдөж, түүнийг мэдэлдээ байлган түүгээр худалдаа арилжааг хийх бодлогыг тууштай явуулж байжээ.

Одоогийн Хятадын Сычуань мужаас гаран, Хятадын төв нутгийн баруун талаар тойрч, Тогон улсын нутгаар дайран Монгол, Дундат Ази хүрдэг худалдааны замыг “торгоны зам” хэмээн үзэж байжээ /65.60.61/. Үнэн хэрэг дээрээ торгоны зам нь Хятад, Монголоос өрнө дахин хүрэх худалдааны их зам юм. Торгон зам нь умард, өмнөд гэсэн хоёр үндсэн чиглэлтэй байв.


Өмнөд зам нь Хятадын Юйминь орчмоос эхлэн Лоб нуурын хавь нутгаар дайран, Өмнөд уулын /Кунь Лунь/ умард энгэр даган цааш Яркенд голын хөндийгээр баруун тийш Яркенд хот хүрч, цааш Ташкурган, Вахон орж улмаар тэндээсээ хоёр салж, нэгдэх нь баруун тийш Балхаас цааш Мерв зэрэг хүрнэ /92.364/.

Умард зам нь Крорайна /Лоу Лань/ дайран Тэнгэр уулын хажуугаар явж, Тарим голын хөндийгээр Кашгар /Шулэ/ хүрээд Терекдаван давааг даваад Ферганы хөндий, Мавераннахр, цааш Ижил мөрний доод адаг, Хар тэнгисийн умард эрэг хүрч байжээ /92.369/. Жужан улс умард торгон замыг дангаар ноёрхож байсны зэрэгцээ өмнөд замыг урт хугацаагаар эрхшээлдээ байлган хянаж байсан ажгуу.

“Торгон зам” нь Жужан улсын оршин тогтнохуйд эерэг нөлөө үзүүлэн, өрнө дорнын соёл харилцан нэвтрэх, улсуудын хоорондын болон Жужан улсын гадаад харилцаа өргөжих, бие биенээ итгэх итгэлцэл төлөвших, нүүдлийн соёл иргэншилд чухал үүрэг гүйцэтгэдэг мал аж ахуй, гар үйлдвэрлэл, худалдаа арилжаа хөгжихөд болон хүмүүсийг ийм соёл иргэншлийн наад захын хэрэгцээ, шаардлагыг хангахад томоохон үүрэг гүйцэтгэсэн болой.

§3. Жужан улсын төрийн байгуулал

Жужан улс нь хаант засагтай, нэгдмэл төвлөрсөн улс байжээ. Монгол угсаатны улсын /Хүннү, Сяньби гэх мэт/ уламжлалыг авч хаант засаг, түшмэдийн ёс, засаг захиргааны хуваарь төрийн байгууллагын тогтолцоо бүрэлдэн бий болсон аж.



Улсын хаан. Жужан улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл хаант улс байв. Тус улсын түүхэнд 23 хаан төр барьсан ажээ. Чаругуй /330/ Тунугуй, Бутай, Дэсигүн, Битүбат /376/, Онгудай, Жарун /402-410/, Хөхлүд /410-414/, Булучжэнь /414/, Татар /414-429/, Энгүдэй /429-444/, Тогочин /444-464/, Ижин /464-485/, Тулун /485-491/, Нагай /492-506/, Богд /506-508/, Чуну /508-520/, Брахман /521/, Амгай /522-552/, Тэбэд /552/, Дэнчжу /553/, Годи /553/, Амаржин /554-555/ онуудад тус тус хаанчилсан байна. Жужан улсын хаад өргөмжилсэн нэр хэрэглэж байсан ажээ. Ийм өргөмжилсөн нэрийг Жарун хаан “хутагтай” хэмээн өргөмжилсөн нэр хэрэглэсэнээр эхэлсэн бөлгөө. Цаашид хаан Татар-мохоожих, Энгүдэй-тэнгэрийн, Тогоочин-зөв, Ижин-золбоочин, Тулун-бүгдийн, Хөхлүд-Агуу гоо, Нагай-хөг бүтээгч, Богд-тархан, Чуну-төр бэхбат, Брахман-мохоожих, Амгай-тэнгэрт мэндтэй хэмээн өргөмжилсөн нэртэй байжээ. Хаад өргөмжилсөн нэртэй байх нь хааны сүр хүч, нийгэмд гүйцэтгэх үүргийг илэрхийлж, төр барих хугацаанд баримтлах бодлогын үндэс, утга санааг агуулж байсан болов уу.

Жужан улсын хаад өөрийн хаанчлах үед бурхны шашны сургаалыг дагаж төрийнхөө оршин тогтнохуйг тодорхойлсон оны цолыг бий болгон хэрэглэсэн ажаамуй. Нирун улсын хаан Жарун хаан 402-410 онд “хутугтай”, Булучжэнь 414 онд “Ашид амгалан” оны цолтой болсноо тунхагласнаар Жужан улсад хаан нь оны цол хэрэглэх ёсон тогтжээ.

Үүний дараа Тулун 485-491 онд “машид түвшин” Нагай хаан 492-506 онд “Машид тайван”, Богд хаан 506-508 онд “Эхэн төвшин”, Чуну хаан 508-520 онд, “Мандах бадрах”, Амгай хаан 523-522 онд “Тэнгэрт мэндтэй” гэсэн оны цолууд хэрэглэж байсан ажээ. Жужан улс Сяньби улсаас уламжлан төрийн тэргүүнээ “хаан”, гэргийг нь “хатан” хэмээн өргөмжилж, төрөө хүндлэн дээдлэх ёсыг тогтоосон болой. Мөн хаан ширээг ханхүү залгамжлах ёсыг бий болгон дагаж мөрдөхийг эрмэлзсэн ажгуу. Жужаны 8 хааныг өргөмжлөхөд эл ёсон чандлан хэрэглэгдсэн боловч бусад хаадын үед энэхүү ёс алдагдаж байсан байна. Жужан улсад хаад тэнгэрээс заяатай төрсөн хэмээн дээдлэгдэж, төрийн тэргүүний хувьд бүхнээс дээгүүр эрх ямба эдэлж агсан бөлгөө.

Хуралдай. Жужан улс, Хүннүгийн уламжлалаас улбаалан “Их Хуралдай”-г хаант төрийн тогтолцооныхоо чухал бүрэлдэхүүн хэсэг болгон бэхжүүлсэн аж. Жужан улсын их Хуралдай нь язгууртны их хурал байж, төрийн дээд байгууллага болох байр суурийг эзэлж байв. Тэгэхлээр эл үед Их Хуралдай нь өөрийн бүрэлдэхүүн /язгууртны төлөөлөгчдөөс бүрддэг/ үүрэг зорилго, эрх мэдэл бүхий төрийн дээд байгууллага байлаа. Тэр нь шинж чанар, бүрэлдэхүүний хувьд язгууртны хурал байсан боловч зорилго, зорилтын хувьд төрийн дотоод, гадаад үүргийг ханган биелүүлэх, төрийн бодлогын гол асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хаанаас зөв оновчтой шийдвэр гаргахад

нөлөөлөх, сайд түшмэдийн бодол, саналыг хаанд хүргэхэд чухал үүрэг роль гүйцэтгэж байсан аж. Их Хуралдайн хамгийн гол эрх, үүрэг нь улсын их хааныг өргөмжлөхөд илэрч байлаа. Их хаанд Хуралдайгаар өргөмжилж, хаан Хуралдай дээр тангараг өргөн, өөрийн явуулах бодлогынхоо үндсийг тодорхойлон хэлдэг нь төрийн ёсонд чухал үүрэг гүйцэтгэж байжээ.

Хуралдай, их хааныг өргөмжлөхөөс гадна дайн хийх, найрамдал байгуулах болон улс орны амьдралын зарим асуудлыг хэлэлцдэг. Жужаны Чуну /508-520/ хаан алга болсон хүүгээ олдсоныг тэмдэглэн ёсолж, удган Даванийг хатан болгон өргөмжлөх Хуралдайг хуран чуулуулж байжээ. Хуралдай нь шинж чанар, эрх мэдлийн хувьд хаанд зөвлөх эрхтэй байв.

*Түшмэдийн эелэлдээн*²⁹. Жужан улсад хуралдайгаас гадна түшмэдийн эелэлдээн /зөвлөгөөн/-тэй байсан байх юм. Эелэлдээн нь төрийн хуралдаан бус, харин төрийн том түшмэлүүд оролцдог зөвлөгөөн байсан агаад төрийн дотоод, гадаад бодлогын зарим асуудлыг хэлэлцдэгээрээ онцлог юм. Эелэлдээний дүгнэлт, шийдвэрийг хаан болгоон тунгааж, шийдвэр гаргахдаа харгалздаг байсан бололтой. Хаан шаардлагатай үед түшмэдийн эелэлдээнийг зарлан хийлгэж, дотоод, гадаад бодлогын тулгамдсан зарим асуудлыг хэлэлцүүлж, санал, дүгнэлтийг нь сонсдог байсан ажгуу.

Жужан улс түшмэдийн эелэлдээнийг төрийн зохион байгуулалтын бүтэцдээ оруулсан нь өмнө улсуудад байгаагүй онцлог юм. Жужан улсын хаан Амгай 540 оны хавар зүүн Вэй улсын элчин Чжан Хуйцзуань ураг барилдья гэсэн асуудлыг түшмэдийн эелэлдээн зарлан хэлэлцүүлж байжээ.

Засаг захиргааны зохион байгуулалт. Жужан нь захиргаа, цэргийн аравтын зохион байгуулалттай нэгдмэл улс байжээ. Аравт, туг, мянгат, түмтээс бүрэлдсэн аравтлах тогтолцоо нь нэг талаар засаг захиргааны хуваарь, нөгөө талаар улсын цэргийг зохион байгуулах үндсэн хэлбэр болж байв. Жарун хаан 402 онд 1000 хүнийг мянгат, зуун хүнийг туг болгон, мянгатын ноён, зуутын даргыг томилсноор аравтын тогтолцоо бий болж, /65.94-95/ цаашид хэвшин бэхжсэн байна. Аравтын зохион байгуулалт нь нүүдэллэн амьдардаг жужанчуудыг улсын захиргаа-цэргийн зохион байгуулалтад оруулах тохиромжтой хэлбэр болж үйлчилсэн аж. Арав, аравнаараа зохион байгуулагдаж засаг захиргааны ажил явуулах, иргэний үүргээ биелүүлэх, аж ахуйгаа эрхлэн хөтлөх, удам угсаагаа бэлтгэх, өв хөрөнгө хуримтлуулах, төрийн алба татварыг төлөх, цэргийн алба хаах, улсаа хамгаалах анхдагч зохион байгуулалтын хэлбэр болж үйлчлэх нь аравтын тогтолцооны үндсэн чиг үүрэг байжээ. “Хүрээ, хот айл болон нүүдэллэн амьдардаг нүүдэлчдийг улсын захиргаа-цэргийн зохион байгуулалтад оруулах хамгийн тохиромжтой хэлбэр нь аравтын байгуулалт” байсан /65.95/ ажээ.

Жужан улс аравтын зохион байгуулалтыг Хүннү улсын уламжлалыг өвлөн авах замаар төрийн байгуулалтдаа нэвтрүүлэн өөрийнхөө онцлогт нийцүүлэн хэрэглэсэн байна.

Төрийн түшмэдийн тогтолцоо. Жужан улсад төрийн үүргийг төрд зүтгэх түшмэдүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан ханган биелүүлж байсан нь алив төрт улсад байдаг зүй тогтолд нийцэх бөлгөө. Иймээс Жужан улс өөрийн засаглалыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг бүхий түшмэдийн тогтолцоог бүрэлдүүлэн бий болгосон түүхтэй аж. Жужан улсын түшмэдийн тогтолцоо нь их хаан, төрийн сайд, төрийн багш, том түшмэд, цэргийн жанжин, дархан, ордны түшмэл, бичгийн түшмэл, хаалгач, түмт, мянгат, туг, аравны дарга зэрэг тус тусын эрх үүрэг бүхий албан тушаалтнуудаас бүрдэж байлаа. Хааны дараах албан тушаалтан нь төрийн сайд /госян/ юм. Сылифа цолтой төрийн сайд нь улсын баруун, зүүн хэсгийг захиран хаан угсааны адил үе залгамжлана. МЭ Ү зууны сүүлчээр Сылифа цолтой Силинь хэмээх олон хэл мэддэг эрдэмтэй хүн Жужаны төрийн сайдаар ажиллан, төрийн хэргийг шийдэхэд гаршин ихээхэн үүрэг гүйцэтгэн нэрд гарч байжээ. Жужан улсын хаан Чуну төрийн багшаар их эрдэм, ухаантай агаад бурхны шашны номд мэргэшсэн лам Дарматрияг томилон ажиллуулсан болой. Төрийн багшийг ажиллуулсан нь Энэтхэгийн төрийн уламжлалаас үүдэлтэй аж. Жужанд төрийн багш ажиллуулсан нь төр, шашин хоёрыг хосолсон ёс дэлгэрэхэд нөлөөлсөн буйзээ. Жужаны түшмэдийн тогтолцоонд төрийн хэргийг явуулахад тодорхой үүрэг гүйцэтгэн, хаантай ойр байж итгэлийг нь хүлээдэг том түшмэлүүд ихээхэн рольтой байсан болой. Мохэ, Сыцзинь, Могу, дархан, Дачэнь, Дазуань гэх мэт албан тушаалтай том түшмэлүүд ажиллаж байв. Том түшмэлүүд нь хааны тодорхой албан тушаал эрхлэх, гадаад улсад элчин, төлөөлөгчөөр томилогдох, түмт, мянгатын ноён, цэргийн жанжнаар ажиллах зэргээр төрд зүтгэж байсан бололтой. Мохэ, Сыцзинь тушаалтнууд Вэй улсад элчин төлөөлөгчөөр ажиллаж байсан бол Могухунь хэмээх түшмэл цэргийн жанжин байжээ.

Дархан хэмээх цол, тушаалыг Төв Азийн нүүдэлчдийн дотор анх удаа Жужан улсад хэрэглэсэн түүхтэй. Жужаны Амгай хаан Чуньюй Таныг бичгийн түшмэлээр томилон, төрийн бичиг хэргийн ажлаа эрхлүүлжээ. Ийнхүү Жужанд төрийн албан хэрэг эрхэлсэн тусгай түшмэл /сайд/ ажиллаж байсан нь тодорхой байна.

Жужаны Амгай хаан 534-537 оны үед Ордны түшмэл /Шичжун/, хаалгач /Хуанмэнь/, бичгийн түшмэл /Мишүцзянь/ гэсэн бичгийн түшмэлийн туслах /Хуан мэнлань/, хэрэг зарга эрхлүүлэх түшмэл /Вэньмо/ албан тушаалууд бий болгосноор төрийн түшмэдийн тогтолцоо бүрэн бүрэлдэн тогтсон байна. Төрийн түшмэдийн тогтолцоонд төвийн хэсэг, баруун, зүүн гар, түмт, мянгат, зуутын ноён, арваны дарга нар томоохон байр эзэлж, төрийн хэргийг хөтлөн явуулах гол хүчин болж байв.

Төрийн дотоод, гадаад бодлогыг хэрэгжүүлэх, иргэнийг харъяалан захирах, алба татвар хураах, эдийн засаг, аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагаа чухамдаа эл масс хүчээр дамжиж хэрэгжиж байсан хэмээн үзэх үндэслэлтэй болой.

Түшмэдэд зэрэг олгох, цол өргөмжлөх, өрх соёрхох ёсон үүсэж бэхжсэн байна. Том түшмэдүүдэд үйл хэрэг, эрхлэх ажил, эрдэм чадлыг нь харгалзан цол өргөмжилдөг. Тухайлбал баатар, цэцэн, мэргэн цол олгож байв. Жужаны хаан Чуну төрийн багш Дарматрия ламд 3000 өрх буюу нэгэн түм 5000 орчим иргэнийг соёрхон өгсөн байна. Мөн Чуну хаан Фушэнмоуг түшмэлээр томилон түүнд үхэр, адуу, хонь 3000 толгойг соёрхон өгсөн зэрэг баримтууд байдаг.

Цэргийн зохион байгуулалт. Жужан улс нь захиргаа-цэргийн аравтын зохион байгуулалттай улс болохын хувьд байнгын цэрэг, армитай байжээ. Улсын цэргийг ерөнхийлөн захирагч нь хаан байсан ч цэргийн жанжингуудыг тусгайлан томилж, цэрэг байлдааныг удирдуулж байв. Цэргийн зохион байгуулалтын үндсэн зарчим нь аравтлах систем бөгөөд түүний үндсэн дээр улсын цэргийг аравт, туг, мянгат, түмт болгон хуваарилах замаар зохион байгуулж байжээ. Энэ зохион байгуулалтын дагуу арван цэргийг арваны дарга, зуун цэргийг тугийн ноён, мянган цэргийг мянгатын ноён, түмэн цэргийг түмтийн ноён захирна. Улсын цэрэг нь морин цэргүүд байж, дотроо хөнгөн морин цэрэг, хүнд морин цэрэг гэж хуваагдана. Хөнгөн морин цэргийн морь нь хуяггүй, цэрэг нь хуяг, дуулга, нумаар зэвсэглэдэг бол хүнд морин цэргийн морь нь хуягтай, цэрэг нь дуулгатай байв. Цэргийн гол зэвсэг нь нум сум, жад байжээ. Байлдах үедээ толгойн харуул цэрэг гаргах, тагнан турших, довтлон дайрах, бүслэх, амь хайргүй хүчлэн тулалдах, эгцлэн дайрах, зугтаж зайлах, нэмэгдэл хүч оруулах зэрэг арга тактик хэрэглэдэг байсан аж.

Нүүдлийн маягийн амьдралд зохицсон цэргийн зохион байгуулалт тогтоож, мал аж ахуйг түшсэн ар талыг бэхжүүлж, цэргийн сургуулилыг тогтмол хийж, эр зоригийг эрхэмд үзэж, моринд гарамгай байхыг чухалчилж байсан нь Жужан улсын цэргийн зохион байгуулалтын гол онцлог болно. Ийм үчраас цэрэг дайны ажиллагаа явуулахдаа гэр орон, эхнэр хүүхэд, эд хөрөнгөө авч явдаг байсан аж. Жужан улсын цэргийн тоо үлэмж байсныг сурвалж бичгүүдэд дурдсан байдаг. Ялангуяа томоохон аян байлдааны үед цэргийн тоо ихээхэн нэмэгддэг байсан бололтой. МЭ 424 онд Жужан улс 60000 морин цэрэгтэй байсныг түүхэнд тэмдэглэсэн байна. Г.Сүхбаатар докторын “Монгол Нирун улс” зохиолд “479 оны 8 дугаар сард Жужан улсын хаан 300000 морин цэрэгтэй “/65.60/ Вэй улсад довтолж байсныг дурджээ. Үүнээс үзэхүл Нирун улсын цэрэг нь энгийн цаг үед 60000 байснаа байлдах болоход 300000 хүрч байсан гэж хэлж болохоор байна. Үүнээс гадна Жужан улс хил хамгаалах харуулын цэрэгтэй байжээ.

Жужан улс ба Хятадын Вэй улс, мөн Дундат Азийн улсуудын хооронд хилийн харуул цэрэг байсан тухай мэдээ сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг. А.Хэрманы газрын зургийн цомнолд Жужан улсын хилийн шугамын гадагш түрсэн хамгийн захын цэгүүдийг 81-125-р /зүүн/ уртраг, 70-40-р /хойд/ өргөрөгт багтаасан ажээ. БНМАУ-ын түүхийн нэгэн боть зохиолд Жужаны умард хилийг БНМАУ-ын умард хилээр, өмнөд хилийг нь БНМАУ-ын өмнөд хилийг оруулан урагшлуулж цагаан хэрэм хүргэн зурсан бол Гоможо, Тань Цисян нарын редакторлосон зургуудад Жужаны умард хилийг нь Байгаль нуурыг оролцуулан, өмнөд хилийг нь БНМАУ-ын өмнөд хилийн шугамд ойролцоогоор, зарим талаар бага сага дотогш оруулан зурсан байна /13.122/.

§4. Жужан улсын эрх зүй

Жужан /Нирун/ улсад өөрийн гэсэн эрх зүйн тогтолцоо бүрэлдэж, бичигдмэл хуулиуд гарч нийгэм, төрийнх нь амьдралын гол асуудлууд эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах үйл явц явагдсан нь зүй тогтолт шинжтэй болой. Алив төр улс үүсэн байгуулагдмагц төрийн тогтолцоогоо хууль тогтоомжийн дагуу бүрэлдүүлж, төрд зүтгэх хүчний эрх, үүргийг тодорхойлон, алба татвар тогтоож эрүүгийн бодлого, ял шийтгэлийн хэлбэр хэмжээгээ тодорхойлдог дэлхий дахинаа хэвшсэн зүй тогтол, жишиг Жужан улсад үйлчлэх нь мөн л зайлшгүй шинжтэй байсан ажээ.

Жужан улсад эрх зүйн хоёр төрлийн эх сурвалж үйлчилж байсан нь тодорхой байна. Үүний нэг төрөл нь хаан төрөөс баглан тогтоосон бичигдэл хууль цааз, нөгөө нэг төрөл нь овгийн байгууллын үеэс уламжлагдан заавал биелэгдэх шинж бүхий хэв хууль буюу заншлын хэм хэмжээнүүд болно.

Анхны хаан Чаругуй өөрийн шийдвэрээр Жужан улсыг байгуулсан бол Чуну хаан гадаад улсуудад явах элч, элчингүүд, төрийн сайд, төрийн багш, төрийн түшмэдийг томилон, цол өргөмжилж, соёрхол олгосон байна. Жарун хаан засаг захиргааны хуваарь баталж, Ижин хааны цолыг тогтоосон байхад Амгай хаан ордны түшмэдийн орон тоог шинээр бий болгосон байна.

Эдгээр нь зөвхөн хаадын хууль, зарлиг, шийдвэрээр баталгаажин гүйцэлдсэн ажээ. Өөрөөр хэлбэл Жужан улсын их хаад болох Чаругуй, Чуну, Жарун, Ижин, Амгай нар хууль гаргаж байсан гэж үзэж болно. Жужан улсад хаант засаг тогтож, засаг захиргааны хуваарь бий болж, түүн дээр үндэслэсэн төрийн орон нутгийн байгууллагын тогтолцоо бүрэлдэж, түшмэдийн ёс төлөвших үйл явц явагдсан нь тэдгээрийн эрх зүйн үндэс бүрдэж ирсэний үр дүн мөн юм.

Энэ бол Жужан улсад бичмэл хууль эрх зүй үйлчилж байсны баримт мөн. Жужан улс худам бичиг үсэг хэрэглэж, зурхай, тооны ухаан, олон хэл мэддэг төрийн сайд, бурханы шашны номыг гүнзгий мэддэг, авидирмаа санхъя гүн ухааныг тайлж чаддаг

төрийн багштай байж, эрдэм ухаан, гадаад хэл, үсэг бичигт боловсорсон бичгийн түшмэлийг ажиллуулж, гадаад орнуудын гүн ухаан, соёлтой танилцан, ази, европыг дамнасан худалдаа, арилжаа хөгжүүлж байсан зэрэг нь бичмэл хууль, эрх зүй хэм хэмжээ тогтоон хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлж байсан агаад энэ ч ёсоор бичмэл хууль гарч хэрэгжиж ирснийг илтгэн харуулмой. Нэг хятад түшмэл жужан хүнд хандаж, чавганы модны боловсорсон үрийн тоог гаргаж чадвал морио өгнө гэж амлахад тэр Нирун хүн бүсэн дэх ширэн хавтагнаасаа таван өнгийн утастай нэг дэнсэрхүү юм гарган чавганы модыг хэдэн тийш нь хэмжиж үзээд бодосхийж байснаа чавганы үрийн тоог яг хэлээд хятад түшмэлийн морийг хожсон тухай дээр дурдсан билээ.

Жужанууд “Яваандаа бичиг мэддэг болсон. Эдүгээ эрдэмтэй хүмүүс олон буй” /65.119/ хэмээн сурвалж бичигт тэмдэглэсэн нь буй. Хятадын Лоян хотын нэг сүмд сууж байсан Энэтхэг лам Ратнаманти нэг жужан хүнийг түмэн хуйлаас ном уншсан хэнд ч давагдахааргүй эрдэмтэй хүн гэж ихэд хүндэтгэн харь /хятад бус/ хэлээр өдөржин ярилцаж байжээ /65.117/. Жужан улсаас бусад улсад албан бичиг, захидал илгээх, тунхаг гаргах, гэрээ байгуулах нь нэлээд түгээмэл байсныг бичиг үсэг, бичмэл хууль цаазтай холбож үзвэл зохилтой. Жужан улсын Богд хаан Вэй улсын хаанд албан бичиг, мөн жужан улсын хаад 480, 481 онд Өмнөд Ци улсын хаанд захидал илгээж байсан нь түүхэн сурвалжид тэмдэглэгджээ. Вэй улсын хаан өөрийн түшмэл Ху-Соу, Цзун Шу нарт Жужан бичгээр тунхаг зохиохыг зарлиг болгож байжээ /65.96/.

Жужан улсын хууль бүрэн эхээрээ бидний үед уламжлагдан үлдэж ирээгүй боловч дээр дурдсан нөхцөл байдал, баримт сэлтүүд Жужан улсад бичмэл хууль гарч, тус улсын эрх зүйн нэн гол эх сурвалж байсныг нотлох бөлгөө. Жужан улсад цэргийн цаазыг тусгайлан гаргасан байдаг байсан ажээ. Жужан улсын эрх зүйн эх сурвалжийн нөгөө төрөл нь бичигдэл бус бөгөөд овог, аймгийн байгууллын үеэс хүмүүс ба хүмүүсийн нийтлэг, нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны амьдрал, хүмүүс ба гэр бүл, хүмүүс хоорондын харилцаанд олон арав, зуун жилийн турш хэрэглэгдэн хэвшсээр заавал биелүүлэх шинжтэй болсон заншлын хэм хэмжээнүүд юм. Ийм заншлын хэм хэмжээнүүд нэгдэн нийлсээр бүхэл бүтэн тогтолцоо болон мөрдөгддөг бөгөөд аман буюу бичигдэл бус байдлаар илрэн нийгмийн амьдралын бүх хүрээг хамран үйлчилдэг байжээ. Жужан улсын үед хааныг өргөмжилөх ёс, хааны эрх мэдэл, үйл ажиллагаагаа явуулах горим, явц, Хуралдайг хуралдуулах дэг журамд овог, аймгийн үеэс уламжлагдсан заншлын хэм хэмжээг хэрэглэж байжээ. Газар ашиглах, мал аж ахуй эрхлэх, худалдаа арилжаа хийх, нүүдэллэн аж төрөх, үр хүүхдээ өгөх, гэр бүл болж хуримлах, гэрийн эдлэл хэрэглэл, малын тоног төхөөрөмж хийх, малын ашиг шимийг ашиглах мэтэд заншлын хэм хэмжээг үлэмж хэмжээгээр хэрэглэж байсан аж.

Заншлын хэм хэмжээг даган биелүүлж байсан нь төр улс, засаг төр, их хаан, төрийн байгууллага, төрийн түшмэдээ хүндэтгэх, тэдгээрийн үйл ажиллагаанд сүсэглэн оролцох, төрийн нэр хүнд, үүрэг ролийг хангах, төрийн үйл ажиллагаа хуулийн хүрээнд явагдах, нийгмийн дэг журмыг сахих, хэрэг зөрчлөөс сэргийлэхэд ихээхэн чухал роль гүйцэтгэж байсан болой.

Жужан улсад төрийн эсрэг хэрэг үймээн гаргасан, хууль цааз зөрчсөн, төрд тэрсэлсэн, хаан, түүний нэр хүнд, бие махбодид халдсан, цэргийн цаазыг биелүүлээгүй, дайнаас айж ухарсан, дайснаас айж хулчийсан үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн ял шийтгэл оногдуулж байсан байна. Хэрэг үйлдэгсдэд бэрээдэх, толгойг нь чулуугаар хага цохих, цаазлан алах ял оногдуулж байсан нь сурвалж бичиг, зохиолд тэмдэглэгдсэн байна.

Жарун /Шэлунь/ хааны цаазад дайсны өөдөөс түрүүлж довтлон орвол олсон олзноосоо бусдаас урьтан авах эрхтэйг заасан байна. Мөн цаазад дайснаас айж ухарсан хүний толгойг чулуугаар хага цохих, шийдмээр цохиж алах, дайснаас айж хулчийсан хүнийг бэрээдэж байхаар хуульчлан тогтоосон байна. Төрд тэрсэлсэн, хааны өгсөн үүрэг, цэргийн даалгаврыг биелүүлээгүй этгээдэд шууд амийг нь авах хатуу ял оногдуулж байжээ. Цаазлах ялыг гүйцэтгэхэд хэд хэдэн хэлбэр, тухайлбал бүтээж цаазлах³⁰, цавчин цаазлах, чулуу, модоор цохиж цаазлах хэлбэрийг голдуу хэрэглэж байжээ. Баримт түшбээс, Тулун хаан 485 онд төрд тэрсэлсэн хэрэг үйлдсэн түшмэл Ходиныйг цавчин цаазалсан бол удган Диваанийг бүтээж цаазалжээ. Татар хаан 414 онд түшмэл Булужжень, Шеба нарыг бүтээж цаазалсан байна. Бүтээж цаазлах ялыг цусгүй алах ял гэж нэрлэх агаад хаан угсааны дээдэс, удган зэрэг өндөр зэрэглэлийн хүмүүст хэрэглэдэг байсан ажээ.



ТАВДУГААР БҮЛЭГ

Монгол нутагт тогтнож байсан Түрэг угсааны хаант улсуудын төр, эрх зүй

Монгол нутагт тогтнож байсан Түрэг угсааны улсуудад Түрүү түрэгийн хаант улс, Түрэгийн хожуу хаант улс, Уйгарын хаант улс, Хиргисийн хаант улсууд хамаарагдана.

Эдгээр улсууд YI зууны дунд үеэс X зууны эхэн хүртэлх хугацаанд монгол нутагт оршин тогтнож байсан түүхтэй. Монгол угсааны аймаг, овгууд эдгээр улсуудын бүрэлдэхүүнд орж, тэдгээрт харьяалагдан аж төрж амьдарч иржээ. Дээрхи түрэг угсааны улсууд болон монгол угсааны овог, аймгууд монголын уугуул нутаг Говиос Байгаль нуур, Алтай Хянганы хоорондох газарт төвлөрөн оршин тогтнож байсан түүхтэй.

§1.Түрүү Түрэгийн хаант улс /МЭ 552-630/

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд Түрэгийн өвөг дээдэс нь Хүннү улсын бүрэлдэхүүнд багтдаг “Ашина”³¹ хэмээх аймаг байжээ. Түрэгийн өвөг дээдэс энэ газар оронд дараа дараалан тогтож байсан Хятад, Хүннү, Түгүхүн, Сяньби, Тоба зэрэг олон улсын захиргаанд харьяалагдан явсаар 400-аад оны үеэс Турфан газар нутаглан 460 оноос Жужаны захиргаанд орсон аж. Энэ үед түрэгүүд Алтайн өврөөр нутаглаж, Жужанд алба барьж байв. Энэ үеэс тэдний аймгийг Түрэг гэж нэрлэн, хуучин нэрлэж байсан “Ашина” гэсэн үг нь тэдний ноёлох овгийн нэр болон үлджээ. “Ашина” гэдэг үг нь Монгол хэлний “Чоно” гэсэн үг бөгөөд түрэгүүд ч өөрсдийгөө чононоос гаралтай гэж үздэг байжээ /43.315/. Түрэгүүд угсааны хэв шинжээрээ Төв Азийн түрэг хэлт ихэнх ард түмний нэгэн адил дийлэнхдээ монголжуу төрхтөн байжээ./43.316/. Төв Азийн монгол төрхтөн ийнхүү өвөг дээдсийн голомт нутагтаа бүрэлдэн бий болсон нь бүр хүрлийн үеэс уламжлан хүннү, түрүү нүүдэлчдийн үед өвлөгдөн иржээ хэмээн монголын тулгуур түүхэн зохиолд бичжээ /43.316/.

Цаашид Алтайн уулс, Дундат Ази, Дорнод Түрэг тэнд шилжин суурьшсан монгол төрхтөн, уг нутгуудаар өмнө нь оршиж байсан европ төрхтэй Динлин нартай хольцолдон завсарын төрх үүсэн бүрэлдэх үндэс болжээ. Үүний дагуу яваандаа өөрчлөлт орсоор Дундат Азийн өнөөгийн түрэг угсаатны зонхилох жишиг болсон монгол төрх илүү давамгайлсан өмнөд сибирийн төрх үүсэн бий болох үндсийг тавьжээ /43.316/.

Үүнийг Монгол нутагт их хэмжээгээр тархсан хүн чулуун хөшөөнүүд гэрчилдэг билээ.

546 онд Түрэгийн зонхилогч Буман³² /Түмэн/ Жужаны ноёрхлоос гарах нөхцлийг бүрдүүлээд 552 онд Жужаны эсрэг аян дайн хийж ялалт байгуулан, харьяанд нь байсан олон овог аймгийг захиргаандаа оруулж их улс байгуулах эхлэлийг тавьж, хаан цолыг хэрэглэн биеэ “Эл хаан” хэмээн өргөмжилсөн байна. Ингээд улсынхаа төвийг монголын төв нутаг Орхоны хөндийд шилжүүлж, хангайн нуруу, Орхоны сав газраар төвлөрөн нутаглах болжээ.

553 онд Буман хаан нас барсны дараа хүү Коло нь “Исиги” цолтойгоор хаан ширээг залгамжилсан боловч удалгүй нас барсан учир түүний дүү Кигинь “Муюй” цолтойгоор хаан ширээнд суужээ.

Кигинь хаан гадаад байдлаа бэхжүүлэхийн тулд Тогоон улсын цэргийг бут цохиж, Татабу, Хятан, Гучин татар зэрэг монгол угсааны аймгуудыг эзлэн эрхшээлдээ оруулсан байна. Мөн Буман хааны дүү Истемээр толгойлуулан баруун зүгт аян дайн хийж Арал нуурын умард хэсгээр нутаглаж байсан хионит, вар, огор аймгуудыг эзлэн Ижил мөрөнд тулж очин улмаар Урал хавийн тал нутгийг эрхэндээ оруулжээ /100.35/. Истем жанжин “Ябгу” цолыг хүртэж, Түрэгийн хаант улсын баруун хэсгийг захирах болжээ.

Энэ нь Түрэг улс баруун, зүүн түрэг хэмээн хоёр хуваагдахад хүргэсэн ажээ. Түрэг улсын хил өргөжин тэлж дорно зүгт Солонгосоос Баруун Тэнгис хүртэл 10000км, цөлөөс Байгаль нуур хүртэл 5000-6000 км хүрэх болжээ /84.229/. Ингэж бүх Азийн тал нутгийг хамарсан хүчирхэг Түрэгийн хаант улс бүрэлдэн тогтсон байна.

572 онд Кигинь хаан нас барсны дараа дүү Тобо, Түрэг улсын хаан болжээ. Кигинь хааны үед Түрэг ихээхэн хүчирхэг болж бэхжсэн боловч язгууртан бегүүдийн бие даан орших эрмэлзэл, зөрчил идэвхжин өсөж улс гүрэнд дотроосоо задран бутрах аюул тулгарч иржээ.

Эл тэмцлийн улмаас Түрэг улс 582-603 оны үед Дорнод Түрэг, Баруун Түрэг гэсэн хоёр хаант улс болон задарсан байна.

Дорнод түрэгийн хаант улс Орхоны хөндийд, баруун Түрэгийн хаант улс Дундат Азид төвлөрсөн ажээ. Ийм нөхцөлд хаан ширээг Шаболио 581 онд залгамжилж, 587 он хүртэл төр барьжээ. Шаболио хаан болмогц Монгол нутагт байсан үеэл дүү Яньло, Дальбянь нар бие дааж оршин тогтнох болсны дээр өмнө зүгээс баруун Түрэгийн хаант улс, дорноос Хятан улс довтлон сандаргаж, Хятадын явуулсан бодлого түрэгчүүдэд эерэг бус нөлөө үзүүлж байв. 609-619 онд Түрэг улсын төр барьсан Шиби хаан Дорнод Түрэг, Хятадын Сүй улсын дотоод хямралыг нь ашиглан дайн байлдааны үйл ажиллагааг идэвхитэй явуулснаар Түрэг улс түр сэргэсэн ажээ.

Дараа нь Хиели хааны үед /620-630/ Түрэгчүүд Хятадтай олон удаа байлдсан нь Хятадын Сүй улс мөхөж, Тан улс мандахад ихээхэн нөлөөлсөн ажээ.

Хятадын Тан улс түрэгчүүдийн дотоод тэмцэл, хүчээр захирах бодлогод дургүйцсэн олон аймгийн бослогыг ашиглан, тэдгээрийг биедээ татаж, хятадад дагаар орохыг хөхүүлэн дэмжсэнээр олон түрэг аймгууд хятадад дагаар орох болжээ.

Эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсон Түрэгийн үлдэгдэл хүчийг Тан улсын хаан 630 онд зуун мянган цэрэг хөдөлгөн бут цохиж, Түрэгчүүдийг эрхшээлдээ оруулснаар Түрүү Түрэг улс мөхжээ. Тан улсын ноёрхол 50 орчим жил үргэлжилж, Түрэгчүүд тэдний эрхшээлд аж төрж, мөн эсэргүүцэл үзүүлэн тэмцсээр байсан түүхтэй ажгуу.

§2. Түрэгийн хожуу хаант улс /МЭ ҮII зууны 90-ээд оноос 745/

Тан улсын эсрэг тэмцсээр ирсэн уламжлалд түшиглэн ҮI зууны 80-аад оны үеэр Тан улсыг эсэргүүцсэн хүчтэй бослого гарчээ. Бослогыг Түрэгийн нөлөө бүхий язгууртан Кутулуг, Тоньюк³³ нар толгойлж, олон тулалдаан хийж эцэст нь Тан улс босогчдод ялагдаж, Түрэгийн хаант улсыг сэргээн байгуулсан байна. ҮII зууны 90 оны орчим Түрэгийн олон овог, аймгийн ахлагчдын хуралдаан Орхон голын хөвөөнд болж Кутулугийг Түрэг улсын хаанд өргөмжлөн “Эльтерес” /улсыг хураагч/ цол өргөн олгожээ. Кутулугийн толгойлсон Түрэгийн хаант улс Монголын төв нутаг хангай уулын хавиар төвлөрөн оршиж байв. 693 онд Элтерес Кутулуг хаан насан өөд болоход түүний дүү Можо /Капаган/ хааны орыг залгаж, 716 он хүртэл төр барьжээ. Можо хааны хаанчлалын үед Түрэгийн хожуу хаант улсын хүчирхэгжил туйлдаа хүрч, умард хятад хийгээд эргэн тойрны өвөг аймгуудтай олон удаа амжилттай дайн хийж, газар нутгаа үлэмж тэлжээ. 696-697 онд Хятаныг эрхшээлдээ оруулан дорнод хил хязгаараа төвшитгөв. Баруун Чуйн овгуудыг эзэлж, Байгаль нуур хүртэлх нутгийг эрхэндээ оруулснаар Түрэг улсын умард, өрнөд хил хязгаар нь 708 он болоход Тагнын уул Алтай, Тарвагатай орчмын нутаг болжээ.

Мөн 709 онд Хиргисийг эрхэндээ оруулж, 710, 711 онд Тюргеш нартай байлдан ялж, Долоон нуур орчмын нутгийг эзэлжээ.

Энэ үеэс Хятадын Төв Азийг захирах гэсэн бодлого хүчтэй болж, Түрэгийн захиргаанд байсан олон аймаг үймэн тэмцэх нь ихсэж, Татаби, Хятаны аймгууд Хятадад дагаар орон, баруун түрэгчүүд, Токуз, Огузуу бослого гаргажээ. Гэвч Уйгур, Карлук, Байырку аймгуудыг авъяаслаг жанжин Культегиний ур чадварын хүчинд дахин эрхэндээ оруулсан байна. Цаашид Түрэг улсын дотоод зөрчил хурцдаж, овог аймгууд босож тэмцэх болж, Хятан салж тусгаарлан, улмаар 716 онд Можо /Капаган/ хаан босогчдод алагджээ. Можо хааны орыг түүний бага хүү Бегю залгасан боловч хаан ширээг залгамжлах ёсыг зөрчсөн хэмээн нэрт баатар Культегины удирдсан дайралтад ялагдан нас баржээ. Чингээд Культегины ах Билгэг 716 онд Түрэгийн хаанд өргөмжлөв.

Харин Куль-Тегин зүүн жигүүрийн ноён, бүх цэргийн жанжнаар томилогдсон байна. Билгэ хаан Түрэгт бий болсон зөрчил хямралыг арилгах шийдвэртэй арга хэмжээ авч Уйгур, Хятаныг довтлон бут цохиж, Токуз, Огузын эсэргүүцлийг зогсоон, Хянган хавийг эзэлж эрхэндээ оруулжээ.

Мөн Хятад руу дүрвэж гарсан Түрэгийн овог, аймгууд 718 он болж ирэхэд Билгэ хааны захиргаанд эргэж ирсэн байна. 720 онд Хятадын их цэрэг Билгэ хааны найрамдлын гэрээ байгуулах санал үл тавьсныг хэрэгссэн Хятадын эзэн хаан Сюань Цзуны тушааснаар Түрэг улсад хоёр замаар довтолжээ. Түрэг улс Тоньюкукийн зөвлөсний дагуу их цэргийг тосон байлдуулж, уран нарийн арга хэрэглэн, хоёр замын цэргийг ээлж дараалан бут цохисон байна. Тоньюкукийн толгойлсон цэрэг Басмылыг бут цохин, Бешбалыкыг эзэлж, улмаар Ганьсуд нэвтрэн орж, Лянчжоу тойрог дахь хятадын цэрэгтэй байлдан ялжээ.

Энэ нь Түрэгийн хаант улсаас Хятад гүрэнтэй хийсэн сүүлчийн дайн байлаа /55.322/. Дайнд ялагдсан Хятадын хаан Сюань Цзун найрамдлын гэрээ байгуулах тухай Билгэ хааны саналыг зөвшөөрсөн ажээ.

Түрэг улс дахин сэргэж хүчирхэгжсэн боловч дотоод зөрчил тэмцэл нь зогссонгүй, Огуз, Татарууд бослого гаргажээ. Билгэ хаан бослогыг дарсан байна. Ийм хүнд үед 731 онд Куль-Тегин жанжин нас барж, дараа нь удалгүй 734 онд Билгэ хаан өөрийн шадар хүмүүн Мэйличжэд хорлогдон насан өөд болжээ. Түрэг улсын түүхэнд их гавьяат үйлс бүтээсэн Билгэ хаан, Куль-Тегин жанжин хэмээх ах, дүү хоёрын тахилын онгон эдүгээ Орхоны Хөшөө Цайдамын хөндийд түүхийн их хугацааг элээн мөнхөрсөөр буй бөлгөө. Билгэ хааныг түүний хөвгүүд Ижань /734-739/, Тэнгэри /740-741/ нар дараалан залгамжилсан байна. Гэвч хаан ширээний хямрал, дотоодын зөрчил бутралд гүнзгий автагдсан Түрэгийн хожуу хаант улс 745 онд бүрмөсөн мөхжээ.

Түрэг угсааны улсууд түрүү, хожуу Түрэг улс нэртэйгээр монгол нутагт 200 шахам жил оршин тогтнож байсан түүхтэй.

Түрүү, Хожуу Түрэг улсууд оршин тогтнож байсан цаг хугацаа, нэрийн хувьд өөр өөр байсан хэдий ч үндэс угсаа, хэл соёл, шашин шүтлэг, зан заншил, эрхлэх аж ахуй, засаг төрийн байгуулал, эрх зүйн шинж байдлаараа адил байсан бөлгөө.

Түрүү Түрэг, Хожуу Түрэг улсын аль аль нь феодалын түрүү улсууд байсан ажээ. Түрэг нэгэн үед байгуулагдан хөгжиж, хүчирхэгжиж мөхөж байсан ч дараагийн үед сэргэн мандаж, бас мөхөж байсан нь тус улсын түүхэн онцлог мөн. Түрэгүүд нүүдлийн соёл иргэншилтэй агаад өвс усны аяаг даган жилийн дөрвөн улиралд нэг газраас нөгөө газарт нүүдэллэж, майхан, эсгий гэрт амьдардаг байжээ.

Түрэгүүдийн гол эрхэлдэг аж ахуй нь мал аж ахуй байв. Ялангуяа адуу өсгөж, хамгаалахад ихэд анхаардаг байжээ.

Энэ нь эртний Түрэгийн булшинд унаж явсан морийг нь эмээл хазаар, тоног, хэрэгслийн хамт дагалдуулан тавьсан археологийн олдворуудаар нотлогдож байгаа юм.

Түрэгүүд монгол нутагт оршин амьдрахдаа газар тариаланг өөрсдийн уламжлалаа ашиглан хөгжүүлэхийг эрмэлзэж байжээ.

Можо хаан Хятадаас 100000 ху үр, тариалангийн 3000 багаж зэвсэг өгөхийг шаардаж байсан нь сурвалж зохиолд тэмдэглэгдсэн /43.324/ нь тариалан хөгжүүлэхэд ихэд анхаарч байсны нэгэн баримт мөн.

Түрэгүүд тариа тарьж байсан хэдий ч нийтийг өргөн хамарч чадаагүй аж. Энэ нь үргэлжийн нүүдэл, дайн тулалдаан, цаг уур, газар зүйн нөхцөл байдалтай холбоотой байсан бололтой.

Түрэгүүд ан гөрөө эрхлэн, мах, арьс үсийг хэрэглэж, худалдаа арилжаанд гаргахын хамт, ав хийж байлдааны бэлтгэл сургууль болгодог байсан аж. Мөн төмрийн хүдэр малтан боловсруулж дарханы ажил хөгжүүлэн, зэр зэвсэг, сав хэрэглэл хийхийн зэрэгцээгээр уран дарханаар гоёл чимэглэлийн зүйлс мөн хийдэг байжээ. Энэ нь Түрэгийн булшнаас олсон олдворуудаар давхар нотлогдож байгаа юм. Археологийн тайлан мэдээнээс үзэхэд төмөр, зэс, алт, мөнгө, тугалгаар хийсэн эдлэл, гоёл чимэглэлийн зүйлс, ан амьтны яс түрэгийн булшуудаас нилээд олддог байна.

Түрэг улсад дотоодын арилжаа өрнөж, овог, аймгууд өөр хоорондоо арилжаа хийж байсны зэрэгцээгээр хятадын Ци, Чжоу, Суй, Тан улсууд болон дундат Азийн улсууд, баруун Вэй улстай худалдаа хийж байжээ. Түрэг улс ба Хятадууд 588, 624, 780 онд хилийн худалдаа зохион байгуулж, зах нээж ажиллуулж байсан байна.

Сурвалж бичигт Түрэг улс Хятадын баруун хязгаарын 36 улс, аймагт төмөр эдлэл гарган ... мал, мах, ангийн арьс үсийг гадагш гаргадаг байжээ /12.127/ гэж тэмдэглэжээ.

Түрэгүүд хот, барилга байгууламж барьж байгуулах, хөшөө дурсгал бүтээх талаар нилээд алдаршсан ард түмэн бөлгөө. Түрэгүүд Цун Цай уулын дэргэд Хэ-Ша хотыг барьж байгуулж байсан нь 682 онд түүхэнд тэмдэглэгдсэн байна.

Түрэгт тахил шүтээний барилга, байгууламж барих ажил өрнөлттэй явагдаж байсан нь Архангай аймгийн их Тамир сумын нутагт барьсан Түрүү Түрэг улсын үед хамаарах Бугатын хөшөө, Билгэ хаан, Куль-Тегин, Тоньюкук, Муюнчур хааны гэрэлт хөшөө, алдарт хүн чулуунууд, бусад өвөрмөц булшуудаас тодорхой харагддаг билээ. Археологичид Орхоны хөшөө цайдамд буй Культегин, Налайхад буй Мэргэн сайд Тоньюкух нарын онгоныг малтан судалсан билээ.

Үүнээс 1958 онд Монгол-Чехословакийн эрдэмтэд хамтран малтаж судалсан Куль-Тегины онгон энэ үеийн дурсгалын томоохон нь бөгөөд хэлбэр, төрх зохион байгуулалтын хувьд тэдгээрийг бүрэн төлөөлж чаддаг билээ.

Энэхүү цогцолборын хоймор хэсэгт 10,4x10,8 м хэмжээтэй шүтээний сүмийг шороо дагтаршуулан хийсэн тавцан дээр барьж, эргэн тойронд нь 67x31 м хэмжээтэй, 1,1 м зузаан тоосгон хэрмээр хүрээлэн гадна талаар нь усан татаал татсан байдаг.

Хэрмийн доторхи бүх талбайг хөх тоосго дэвсэн бүрснээс гадна барилгын шал нь мөн хөх тоосго байжээ /43.329/ гэх зэргээс үзвэл энэхүү цогцолбор эл үеийн нэн ховор, асар их үнэ цэнэтэй дурсгал байсныг харуулам.

Энэ бол нэг л томоохон жишээ болой. Түрэгүүд руни бичигтэй байжээ. Ихэнх эрдэмтэдийн үзэж байгаагаар эл руни бичиг нь эртний арамей бичгийн салбар болох согдын бичиг үсгээс үүсэлтэй /43.47/ аж.

Сүүлийн үеийн судалгаагаар “Түрэгийн Руни бичиг нь Төв Азид, тэр тусмаа монгол нутагт анх үүссэн хэмээх үзэл баримтлал бий болжээ /117.45-47/.

Энэ нь “Долоон мөрөн Енисей орчмын нутаг дахь руни бичгийн дурсгалыг хамгийн эртнийхэд тооцож байсан бол сүүлийн үес Монгол Улсын Дорноговь аймгийн нутаг Чойроос олдсон нэгэн хүн чулуун дээр бичсэн бичгийг хамгийн эртнийх гэж үзэх болов” /117.45-47/ хэмээсэнд үндэслэсэн буйзаа. Энэхүү бичиг YII зууны II хагаст үүсч улмаар XIII зууныг хүртэл хэрэглэгдэж, нийт Түрэг овогтны дунд тархсан ажээ.

Орхоны бичээс, Кутулуг, Билгэ, Таньюкук, Куль-Тегин нарын хөшөөний бичээс, Архангайн Тайхар чулууны бичээс, Ховдын Байшинтийн үзүүрийн бичээс зэрэг нь Түрэгт бичиг үсэг дэлгэрмэл байсны гэрчүүд болно. Түрэг улсад бөө мөргөлийг шүтэж байв.

Өөрөөр хэлбэл Түрэгүүд бөө мөргөлтөн байжээ. Орхон-Енисейн бичгийн дурсгалд тэдний эрхэмлэдэг гол шүтээн эцэг Тэнгэр, эх Умай, газар усны савдаг Иер-Суб зэргийн нэрийг дурдсан байдаг /43.332/. Түрэгүүд наран мандах дорно зүгийг эрхэмлэх ба тэнгэр газарт тахил өргөж өвөг дээдсээ хүндлэн шүтэж байжээ.

Мөн Түрэг улсын Тоба хааны үед буддын шашин байсан аж. Буддын шашны сүм хийдүүд барьж, судар ном авчирч, хурал мөргөлийн ёс үйлдэж байв. Тоба хаан YI зууны сүүлчээр сүм байгуулж, хятадаас лам нар урьж ном хуруулж байсан бол Билгэ хаан YII зууны эхээр сүм барьж шашин дэлгэрүүлж байжээ. Бумбын шашныг дэлгэрүүлж байсан баримт байв.

Мөн загалмайтны шашин Дундат Азиар дамжин баруун хязгаарт /Баян-Өлгий аймаг/ нэвтэрч байсныг Даян нуурын хөвөөнд буй Түрэгийн үеийн хүн чулууны дурсгалууд нотолж буй бөлгөө.

Эдгээрээс үзвэл Түрэгт монгол, түрэг, уйгур, хиргис зэрэг олон ястан, угсаатан амьдарч байсантай холбоотойгоор олон янзын шашны урсгал дэлгэрч, энэ нь мөн төрийнх нь бодлогод нөлөөлж байсан ажгуу.

Түрэг улс гадаад харилцаагаа хөгжүүлэхэд их анхаарал тавьж байсан бөлгөө.

Буман хаан хөрш улсуудтайгаа найрамдалт харилцаа тогтоох, худалдаа хөгжүүлэх бодлого явуулжээ. Тэгээд Вэй улстай худалдаа хийж, хоёр улсын хилийн орчим хамтарсан төлөөний түшмэдийн газрыг байгуулж байжээ. Тоба хааны үед хятадтай өргөн харилцаж, олон тооны элч, төлөөлөгч зорчиж, зарим үед хятадын нийслэлд очсон элчийн тоо 1000 хүрч байв /10.233/.

Билгэ хаан найрамдлын гэрээ байгуулахаар Хятад улсад илч илгээж улмаар 726 онд Хятадтай найрамдлын гэрээ байгуулж байсан ажгуу. 720-721 онд Түрэг, Хятадын хооронд их дайн болж, Түрэгийн ялалтаар дууссаны дараа Билгэ хаан, Хятадын Сюань цзун нар найрамдлын гэрээ байгуулж, харилцан довтлолцохгүй байх, худалдааны харилцааг өргөтгөх, умард хилээ тайван байлгасны төлөө шан харамж барихаар тохиролцжээ.

Үүний үндсэн дээр 727 онд Хятадын эзэн хаан Билгэ хаанд 30 агт барьсных нь хариуд 100000 толгой торго бэлэглэж байжээ /43.323/.

Монгол аймгууд ҮI зууны үеэс хүчийг олж, их улсыг байгуулан Төв Азид ноёрхлоо тогтоосон Түрэг угсааны улсын бүрэлдэхүүнд нь багтах буюу хараат аймгийн маягаар оршин амьдарч байжээ. Эдгээр монгол аймгуудаас эх нутаг, өвөг дээдсийн гал голомтоо сахин үлдэж, нүүдэлч малчин, төрхөө хадгалан хожмын монгол угсаатны шууд өвөг, дээдэс болсон нь Шивэй аймаг болой.

Шивэй аймгийн нутаг дорно этгээддээ Зүрчид угсаатан /Хэйшуй мохэ/, өрнө талдаа Түрэг, өмнө талдаа Хятантай хил залгаж, умард Далайд тулж байсан аж /43.354/. Шивэй нь Монгол аймгуудын ерөнхий нэр бөгөөд түүнд 30 аймаг багтаж байжээ. Эдгээр аймгууд хагас нүүдэл, хагас суурьшмал байдлаар оршин тогтнож байсан нь нэн өвөрмөц содон шинж юм.

Тэгэхдээ Шивэйн аймаг тус бүр харилцан адилгүй, зарим нь нүүдэллэн, мал аж ахуйг голлон эрхэлж байхад нөгөө зарим нь хот суурин газарт сууж тариа буудай тарьж, бас зарим нь гар үйлдвэр, ан гөрөө эрхэлдэг байсан ажээ.

ҮII-ҮIII зууны үед Шивэй нар олон аймаг болж салбарлан хуваагдсаар байжээ. Өмнөд Шивэй нар 25 салбар аймагт хуваагдсан гэж тэмдэглэсэн нь бий.


Салбар аймаг бүрийг зонхилогч захирна. Зонхилогчдыг Юй Моррумандо, Мохэдэ, Мохэфу гэдэг.

Тэднээс нас барвал хүү буюу дүүгээр нь залгамжлуулна. Хүү, дүү байхгүй бол аймгийн дотроос аль нэгэн зоригтой, цэцэн мэргэн хүнийг сонгон тавьдаг байжээ. Шивэй аймгийнхан Түрэгийн ноёрхлыг эсэргүүцэж, бослого хүртэл гаргаж байсан аж. Шивэй аймаг түүхийн урт хугацааг туулах замдаа үе удмаа хадгалан оршиж, өсөн бэхжсээр нийт монгол овогтныг нэгтгэн захирах гол цөм нь болсон ажгуу.

§3.Түрэг улсын төрийн байгуулал.

Түрүү, хожуу Түрэг улсын аль аль нь хаант улс байв. Улсыг эзэн хаан захирна. Түрэгчүүд төр улсаа байгуулсан цагаас нь эхлэн “эл улс” хэмээн нэрлэж байжээ. Энэ нь угсаа нэгтэй олон аймгийн зохион байгуулалтын нэгдэл /43.326/ гэж олон эрдэмтэд үздэг байна. Түрэг улсын анхны хаан Буман өөрийгөө эл хаан хэмээсэн нь улсын хаан гэсэн утгыг илэрхийлж байжээ.

Түрэг улсын төрийн байгуулал /бүдүүвч/



Төр толгойлогч нь “хаан”, “хан”, “эл хаан”, “исиги”, “муюй”, “эльтерес” зэрэг цол хэрэглэж нэр сүрээ өргөн мандуулж байсан түүхтэй. Түрэгийн төрийн түүхэнд түрүү Түрэг улсыг 7, хожуу Түрэг улсыг 6 хаан ээлж дараагаар толгойлон төр барьж ирсэн бөлгөө.

Түрүү Түрэг улсын хаад

Хааны нэр	Цол	Төр барьсан он
Буман /Түмэн/	Эл хаан	552-553
Коло	Исиги	553-553
Кигинь	Муюй	554-572
Тобо	-	572-580
Шабوليو	-	581-587
Шиби	-	609-619
Хиели	-	620-630

Хожуу Түрэг улсын хаад

Хааны нэр	Цол	Төр барьсан он
Кутулуг	Эльтерес	690-693
Можо /Капаган/	-	693-716
Бегю	-	716-716
Билгэ	-	716-734
Ижань	-	734-739
Тэнгэри	-	740-741

Түрэгийн төрийн түүхэнд Буман, Кигинь, Күтүлүг, Можо /Капаган/ Билгэ хаад Түрэг улсыг байгуулах, сэргээн мандуулах, улс нутгаа хамгаалах, хөгжүүлэх талаар амжилт олж, их үйлс бүтээсэн хаад байсан болой. Түрэгийн хаанд өргөмжлөх ёс хоёр үндсэн хэлбэрээр хэрэгжиж байжээ. Энэ нь *нэгдүгээрт* овог, аймгийн ахлагчдын хуралдаагаар хаанд өргөмжлөх, *хоёрдугаарт* угсаа ор залгамжлан хаанд өргөмжлөх хэлбэрүүд юм. Жишээлбэл, Хожуу Түрэгийн хаан Кутулүгийг олон овог, аймгийн ахлагчдын хуралдаанаар хаанд өргөмжилсөн байдаг. Энэ хэлбэр төдий л түгээмэл хэлбэр бус бөгөөд хэрэгжсэн практик нь бага юм. Харин угсаа залгамжлах хэлбэр зонхилж байсан агаад Түрэгийн хаадын дийлэнх нь угсаа залгамжлан хаан болж байсан аж. Угсааг хааны ахмад хүү, хааны дүү залгамжлах ёс заншлыг хатуу мөрдөж байв. Үүнийг Можо /Капаган/ хааныг нас барсны дараа хааны орыг ууган хүү нь залгамжлах ёстой байсан атал эл ёс зөрчигдөж өөр хүү Бегю хаан ширээнд суусныг хууль бус хэмээн дургүйцсэн цэргийн нэрт жанжин Куль-Тегин Түрэгийн бүх аймгийн дэмжлэгтэйгээр Бегюг алж, угсааг албан ёсоор залгамжлах ёстой Билгэг хаан ширээнд залсан баримт нотолж байна.

Түрэгийн хаад хэмжээгүй эрх мэдэлтэй байсан бөлгөө. Хаан хууль батлах, дээд шийдвэр гаргах, засаг захиргааны хуваарь тогтоох, төрийн байгууллагыг байгуулах, төрийн түшмэдийг томилох, зэрэг дэв олгох, улсын хил хязгаарыг тогтоох, хот байгууламж байгуулах, худалдаа арилжааг хөгжүүлэх, дайн байлдаан явуулах, гэрээ хэлэлцээр хийх, элч төлөөлөгч илгээх, хүлээн авах, гэмт этгээдийг цээрлүүлэх, ял шийтгэл оногдуулах гэх зэрэг эрх эдэлж байсан бөлгөө. Түрэг улс овог, аймаг, баруун, зүүн, төв хэсэг /гар/ гэсэн зохион байгуулалттайгаар оршиж тогтнож байсан аж. Энэ нь Түрэг улсын засаг захиргааны зохион байгуулалтыг илэрхийлэн харуулдаг. Түрүү Түрэгийн хаан Тоба хаан Түрэг улсыг гурван хэсэг /гар/ болгон хуваасан ажээ.

Ингээд Зүүн гарыг Буман хааны хүүд “Ниетадэрау хан” цол, баруун хэсгийг өөрийн дүү Жутанд “Були хан” цол олгон тус тус захируулсан байна. Харин төвийн хэсгийг өөрөө толгойлсон бололтой. Үүний дараа Шаблио хаан Түрэг улсыг 4 хэсэг /гар/-т хуваажээ. Үүнд Шаблио өөрөө төв хэсгийг, ах Яньло нь Туул голын сав газрыг, нагац ах Дату хан нь Түрэгийн баруун хэсгийг, өмнө хэсгийг Або /Далобян/ хан тус тус захиран суужээ /12.121/. Аймаг, аймгаараа орших нь өмнөх уламжлалаас өвлөн үлдээсэн зохион байгуулалтын өөрийн ахлагч, газар нутаг, хүн ам бүхий харьцангуй бие даасан хэлбэр бөгөөд нийгэм, цэргийн байгуулалтад өвөр байр суурь эзэлж, түрэгүүдийг захирах үндсэн үүр болсон ажээ. Түрэг улсад олон тушаалыг хүлээсэн, өвөрмөц зэрэг, цол бүхий төрийн түшмэдийн өргөн тогтолцоо бүрэлдэн бий болжээ. Түрэг улсын баруун, зүүн хэсэг /гар/ удирдагчийг “хан”, хааны угсаа залгамжлагчийг “тегин” /ханхүү/, улсын баруун хэсэг захирагчийг “ябгу”, хаан

угсааны засаг ноёдыг “шад” хэмээх цол бий болсон байна. Мөн “түдүн”, “мэргэн” хэмээх цол байсан аж. Эдгээр цолыг “Ашина” овогт хамаарах засаг ноёдод олгодог байжээ. Эдгээрээс доошхи цолыг “Ашина” овогт үл хамаарах язгууртнуудад олгоно. Сурвалж бичигт тэмдэглэгдэн үлдсэн баримтаас үзэхүл Түрэг улсад цэрэг иргэний бүгд 28 зэрэг /16.59, 43.326/ бий болон хэрэглэгдэж байжээ. Чингэхдээ бүх цол, зэрэг нь угсаа залгамжлагдан хэрэглэгдэнэ.

Түрэг улсын түшмэдийн тогтолцоо

/бүдүүвч/



Түрэг улсад олон албан тушаалууд бий болж, тэдгээрт мөн олон ноёд, язгууртан, жирийн хүмүүс ажиллаж байжээ. Хааныг залгамжлагч ханхүү, хааны зөвлөх, цэргийн жанжин, хэсэг, аймаг захирах зонхилгогч, буюрук, дархан, түүхэн сурвалжид өгүүлснээр Шэхү, Мо, Тэлэ, Сьлифа /16.58-59/ зэрэг олон зэргийн дээд, доод ноёд

түшмэлүүд төрийн албыг гүйцэлдүүлж байсан ажээ. Түрэгийн доторхи сурвалжит язгууртныг нийтэд нь “бег” хэмээх бөгөөд тэдгээрийн дотроос угсаа гарвал, эрдэм чадвар, зүтгэл хүч, байгуулсан гавъяа зэргээрээ тодрон гарсан нь том сурвалжтанууд болно. Эзлэгдсэн аймаг, улсыг захирах албан тушаалтныг дээрхи бегүүдийн дундаас шалгаруулж томилно. Аймгийг “Түдүг” цолтой зонхилогч /захирагч/ толгойлно.

Түүхэн сурвалжийн баримтаас үзэхэд Буман хааны дүү Истем цэргийн жанжин байсны дээр “Ябгу” цолтой улсын баруун хэсгийг захирч байв. Мөн Мого /Капаган/ хааныг залгамжлагч ууган хүү Билгэ “Тардушын шад” цол зүүж байжээ. Билгэ хааны дүү нь болох Куль-Тегин зүүн хэсгийн ноён, бүх цэргийн жанжинаар ажиллаж байв. Буман хааны үед улсын зүүн хэсгийг хан цолтой өөрийнх нь хүү, баруун хэсгийг хан цолтой өөрийнх нь дүү Жутан толгойлж байсан болой.

Түрэгийн сурвалжит язгууртан, Хиели хааны хамаатан, ханли-Юаны ноён Кутулүг үе улирах “Түдүг” цолтой, “Ашина” овгийн ноён, Тэнгэри хааны авга ах Кутулүг “ябгу” цолтой байсан аж. Түрэгийн хэд хэдэн хааны зөвлөх Тоньюкук “мэргэн” цолтой зөвлөх тушаалын алба хашиж байсан. Буюрук гэсэн тушаалтан нь түүхэн сурвалжид “тушаал олгогч, шийдвэрлэгч” /43.326/ “шүүгч” /12.128/ түшмэл болно” хэмээн тодорхойлжээ.

Түрэг улсад бүрэлдсэн төрийн түшмэдийн тогтолцоо нь Түрэг улсын төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэхэд гол хүчин болон эзэн хаанд үйлчилдэг байсан ажгуу.

Түрүү Түрэг, хожуу Түрэг улсын аль аль нь хүчирхэг цэрэгтэй байсан аж. Түрэгийн цэргийг Буман, Кигинь, Тобо, Кутулүг, Мого /Капаган/, Билгэ зэрэг нэр алдартай хаад, цэргийн жанжнууд удирдаж байв. Түрэгийн цэргийн тооны тухай тодорхой зүйл сурвалж бичигт тэмдэглэгдэж үлдсэнгүй. Гэвч Хятад, Хятан, Уйгур, Араб, Дундат Азийн улсууд баруун зүгийн Байгаль нуур орчмын аймаг, улсуудын цэргийг дараа дараалан бут цохин ялалт байгуулснаас үзэхүл нэлээд тооны сайн зохион байгуулалт, сайтар зэвсэглэсэн, чадварлаг цэрэгтэй байсан болов уу хэмээн үзэж болох талтай. 720 онд Басмыл, Хятан зэрэг холбоотны морин цэргээр цохилтын гол хүч нь бүрдсэн Хятадын их цэрэг Өтүкений уулсын зүг хоёр замаар довтолсныг Түрэгийн цэрэг ээлж дараалан бут цохиод үлдэн хөөх замдаа Бешбалыкийг эзлэн, улмаар Аньсуд нэвтрэн орж Хятадын цэргийг устгаж /43.322/ байсан нь Түрэгийн цэрэг үлэмж тоотой, хүчирхэг болохыг харуулах нэгэн зүйл баримт болно.

Цэргийн зэвсэг нь нум сум, дуут сум, хуяг, сэлэм, жад байсан аж. Цэрэг нь улс, түүний зүүн, баруун, төвийн хэсэг, аймгуудаар зохион байгуулагдсан нэгдмэл цэрэг байсан бололтой.

§4. Түрэг улсын эрх зүй

Түрэг улсад өмнөх улсуудын эрх зүйн үүсэл, хөгжлийн уламжлалыг анхаарч, түрэгчүүдийн төрх, онцлогийг шингээсэн шинэ эрх зүй үүсэн бий болжээ. Шинэ эрх зүй нь нэг талаар өмнө нь овог, аймгуудад мөрдөж байсан заншлын эрхийн хэм хэмжээг төрийн бодлогоор дэмжин мөрдөх, нөгөө талаар шинээр бүрэлдэн буй болж байгаа нийгмийн харилцааны зарим чухал хэсгийг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулан биелүүлэх явдлыг хосолж байсан хэмээн үзэж болно. Хаант төрөөс тогтоосон /хууль, дүрэм, зарлиг шийдвэр гэх зэрэгт/ эрх зүйн хэм хэмжээгээр хаанд өргөмжлөх, улсыг баруун, зүүн, төвийн хэсэгт хуваах, төрийн түшмэдийн тогтолцоо, цол, зэрэг, албан тушаал, эрхлэх ажил, эрх ямба, цэргийн зохион байгуулалт, байлдах, найрамдах, гэрээ хэлэлцээр байгуулах, алба татвар авах, худалдаа арилжаа хийх, хилийн зах ажиллуулах, мал сүрэг, өмч хөрөнгийг хамгаалах, ял шийтгэл тогтоох, оногдуулах зэрэг онцгой эрх эдэлж байсан ажээ. Сурвалж бичигт тэмдэглэгдсэнээс үзэхэд үймээн гаргах, урвах, хүн алах, бусдын эхнэртэй самуурах, чөдөртэй мал хулгайлах юм бол алдаг /16.59/ байжээ. Энэ нь дээр дурдсан үйлдлүүдийг онц, ноцтой гэмт хэрэг гэж төрөөс тогтоож, үүнийг үйлдэгсдийг хатуу чангаар яллаж зөвхөн цаазаар авах ял оноож байсныг харуулж байгаа хэрэг мөн. Мөн хүний бие мах бодид халдан зодож, гэмтэл учруулбал хүнд, хөнгөнийг харгалзан занчиж шийтгэнэ /16.59/.

Үүнээс үзэхүл ял шийтгэлийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх үндэслэлийг тогтоон ял оногдуулахад харгалздаг байсан нь тодорхой байна. Хулгайн хэрэгт хатуу шийтгэл оногдуулж байсан нь сурвалж бичигт өгүүлсэн материалаас илэрхий харагдана. Юу хэмээбээс морь юм уу, эд хөрөнгө хулгайлбаас үндсэн өртгөөс нь 10 дахин илүү юм /хулгайлсан зүйл/ төлүүлдэг байна /16.59/.

Түрэгийн хаант улсад шүүхийн асуудлыг хариуцсан тусгай албан тушаалтан байсан ажээ. Тэр нь буюрук гэдэг шүүгч /12.129/ бололтой. Шүүгч нар хэв хуулийг баримтлан хэрэг зарга шийтгэх боловч, гол төлөв хааны зарлигаар тогтоосон хатуу хуулийг баримталж байжээ /12.129/. Хааны тогтоосон хууль цааз байж, түүнийг хатуу чанд баримталж, хэрэг зарга шийтгэж ирсэн нь тус улсад эрх зүй үүсэн хөгжиж, өөрийн үүргээ биелүүлж байсныг харуулна.


§5. Уйгурын хаант улсын төр, эрх зүй

/МЭ 745-840/

Уйгур³⁴ улс тогтнон хөгжсөн нь.. Уйгурчуудын уг удам нь МЭӨ III зууны үеэс дин-лин, IY зууны үед дили, тэлэ хэмээн нэрлэгдэн түүхнээ гарч иржээ. Уйгурчуудын өвөг дээдсийг Гаогюй буюу өндөр тэрэгтэн гэж нэрлэж байжээ. Y зуунд Уйгур нэрээр түүхнээ тэмдэглэгдсэн түүхтэй /12.134/.

Уйгур нь Юаньгэ, Сяньто, Цибиюй, Дубо, Гульгань, Доланьгэ, Пугу, Баегу, Тунго, Хунь, Сыцзе, Хусце, Цизе, Але, Байси хэмээн арван таван аймагтай байжээ /16.61/. МЭӨ III зуунд Уйгурууд зүүн, баруун хоёр хэсэг болж, зүүн нь Байгаль нуурын урдуур, Сэлэнгэ, Орхоны сав газраар, баруун нь Эрчис мөрөн Балхаш нуур хоёрын хооронд нутаглаж байсан аж /43.333/. Хүннү улс байгууллагдахад бүрэлдэхүүнд нь багтаж байсан Уйгурчууд дараа нь Сяньби, Тоба, Жужан, Түрэг улс зэрэгцэн эрхшээлд орж байсан ч байлдах, найрамдах, тусгаар улс болохын төлөө тэмцэх зэргээр оршиж ирсэн түүхтэй.

УЙГУР УЛС



Зургийг “Монгол Улсын түүх” номын тэргүүн ботиос ашиглав.

ҮШ зууны 40-өөд он хүртэл Түрэгийн хаант улсын бүрэлдэхүүнд байсан уйгурчууд МЭ 744 онд Пэйлогийн удирдлагын дор Түрэгчүүдийн эсрэг бослого гарган 745 онд Түрэгийн хаант улсын цэргийг бут цохин Уйгур улсыг байгуулжээ. Уйгурын хаант улс байгуулагдсаныг тэр үеийн Хятад улс хүлээн зөвшөөрч, төлөөлөгч Пэйлод нь “Тэнгэрээс заяат төр, засаг, мэдэлтэй хаан” /43.334/ цол өргөж байсныг бодохуйд хүчирхэг шинэ улс байгуулагдсан нь тодорхой байна. Нэрт эрдэмтэн Н.Я.Бичурины зохиолоос үзэхэд Уйгурын хаант улсын газар нутаг нь зүүн зүгт Шивэй, баруун зүгт Алтайн уулс, өмнө зүгт их элсэн говь хүрч, Хүннүгийн эзэгнэж байсан бүх газар нутгийг хамарсан /87.309/ Төв Азийн томоохон хаант улс байжээ. Уйгурын хаант улс 100 шахам жил оршин тогтнож байгаад эцэст нь Хиргис, Уйгурын дайнд ялагдан 840 онд мөхсөн түүхтэй. Уйгур нь феодалын түрүү үеийн улс байжээ.

Тухайн үедээ Төв Азийн нүүдэлчдийн хүчирхэг улс болон хөгжиж, эдийн засгийн гол салбар болсон малаа өсгөн үржүүлэхийн хамт газар тариалан, гар урлал, худалдааг нилээд өргөн хэмжээгээр эрхлэн, төмөр боловсруулж уран дарханыг хөгжүүлсэн онцлогтой. Төмрийн хүдэр малтан төмөр боловсруулж чаддаг байсан нь Уйгурын соёлын хөгжилд нөлөө үзүүлжээ /12.145/. Ялангуяа Хятадтай өргөн худалдаа хийн агт гаргаж, Хятадаас цай, торго авч байсныг түүхэн баримтад дурдсан байна /81.29/. Мөн торгоны их замыг ноёрхон харьяалж баруун зүгийн орнуудтай өргөн худалдаа хийж байжээ. Уйгур улсад нүүдэлчдийн төдийгүй суурьшмал соёл иргэншил үүсэж хот, суурин газрууд бий болж хөгжсөн нь тус улсын нэгэн онцлог юм. Одоогийн Архангай аймгийн Хотонт сумын нутагт Балиглиг хот, Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Байбалиг, Тан улсын Гүнж нар суудаг Хатун хот зэрэг арваад хот, суурин газрууд байгуулагдан ажиллаж байсан аж. Уйгурууд нь монгол нутагт оршиж байсан аймаг, улсуудын дотроос нэлээд дээгүүр соёлтой нь байсан бөлгөө. Уйгур нь улсын бичиг үсэгтэй байж, албан бичиг хэргээ түүгээр хөтлөн, эрдэмтэн мэргэд, түшмэд нар нь олон ном зохиол бичиж, бас гадаад хэлнээс олон судар шастир орчуулж байсан түүхтэй болой.

Сурвалж бичгээс үзэхэд анхны үед “Орхон бичээс” гэж тэмдэглэгдсэн шаантаг үсэг хэрэглэж байв. Үүний баталгаа нь хануй, Хүнүй хоёр голын билчэрт цутгагч Могойн голын шинэ ус гэдэг газар оршдог “Сэлэнгийн чулуу”, Сэлэнгэ мөрний хойт эрэгт байдаг “Сүүжийн бичээс”, Архангай аймгийн Тариат сумын нутаг дахь “Тэрхийн бичээс”, Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суман дахь “Тэсийн бичээс”, Хотонтын хар балгасын бичээс, Говь-Алтайн Жаргалан суман дахь Хайрханы бичээс хэмээх алдарт дурсгалууд болно. Уйгурчууд согд бичгийг өөрийн хэлний аялгуунд зохицуулж хэрэглэсэн нь түүхэнд уйгур бичиг хэмээн алдаршиж, аажмаар Уйгур улсын гол бичиг болж дэлгэрчээ.

Уйгур бичиг улсын бичиг болж дэлгэрээд хожмын үед түүгээр олон зохиол бичиг орчуулж байсны зарим нь бидний үед хүрч иржээ /12.147/. Уйгур бичиг улмаар их гүрний үед Монголын албан бичиг болсон /12.147/ түүхтэй.

Уйгур улсын төрийн байгуулал. Уйгур нь хаант улс байв. Уйгурын Яглака овгийн ноён Пэйло 714 онд биеэ Күтүлүг Билгэ Кул хэмээн өргөмжилж хаан ширээнд суужээ. Тэрбээр 744-747 онд төр барьсан бөлгөө. Түүнийг Хятад улс хүлээн зөвшөөрч “Тэнгэрээс заяат төр засах мэдэлтэй хаан” хэмээх цол өгч байжээ /43.334/. Пэйлогийн байгуулсан Уйгурын хаант улс нь хожимоо XIII зууныг хүртэл оршин тогтносоор ирсэн Уйгурын олон хаант улсын анхных нь болно /43.334/ Энэ улсын тухай голлон өгүүлнэм.


Пэйло хаан газар нутгыг зүүн, баруун зүг, өмнө зүгт өргөтгөж, урьд Хүннүгийн эзэгнэж байсан бүх газар нутгийг эзэгнэх болсон байна. Пэйло хааны дараа түүний хүү Моюнчур буюу Баянчур 747-759 онд хаан ширээнд сууж төр барьжээ. Цэргийн гарамгай жанжин Баянчур хааны үед Уйгур улс хүчирхэгийн туйлд хүрч умар зүгт Хиргис, дорно зүгт Хятаны эсрэг дайтаж газар нутгаа ихээхэн өргөтгөжээ. Их хаан 751 онд Орхоны хөндийд Балыклик /Хар балгас/ хэмээх хотыг барьж байгуулан улсынхаа нийслэл болгосон ажээ. Уйгурын нийслэл Балыклик хот нь Орхон, Жирмэнтэй хоёр голын билчэрт 25 км² талбай эзлэн байгуулагдсан том хот байжээ. Хотын талбай нь худалдаа, гар үйлдвэрийн хэсэг, хааны орд харш, сүм дуган зэрэг хэсгүүдээс бүрдэж байв. Хааны орд нь тусгайлан барьсан бат цайзат хэрэмтэй, хойт, урд хоёр талдаа тус бүр хоёр том хаалгатай бөгөөд цэрэг дайны зорилгоор цайзны ханыг тойруулан олон цонж, цамхаг барьсан байжээ. Цайзын хэрэм нь 0,6х0,6 км, арваад метр өндөр, хэрэмний төвд байсан том цайз 12 метр бөгөөд гурван талаасаа шуудуугаар хүрээлэгдэн үүдэндээ гэрэлт хөшөөнүүдтэй байжээ /43.340/. Уйгур улс Хятадын Тан улстай өргөн харилцаа тогтоосон байна. Баянчур хаан нас барсны дараа Идигань хаан ширээнд сууж 759-779 онд төр барьжээ. 763 оноос эхлэн бараг ҮШ зууныг дуустал Уйгурын хаант улс нь Төв Азийн улс төрийн тавцанд хамгийн их нөлөөтэй хүчин болж чадсан бөгөөд тэдэнтэй зөвхөн Түвэд л энэ зэрэгцэн өрсөлдөж /43.337/ байсныг түүхнээ тэмдэглэжээ. 779-795 онд Идигань хааны зөвлөх, хамаатан Тон Бага Тархан Алп Кутулүг Билгэ хаан цолтойгоор хаан ширээнд суужээ. Түүний дараа 795 онд Эдиз овгийнхны шинэ төр тогтож, түүнийг үндэслэгч Алп Кутулүг хаанд өргөмжлөгдөн 795-805 онд төр барьсан байна. 803 онд Алп Кутулүг Түвэд, Карлук, Турфаныг эзэлжээ. 840-өөд онд Уйгурын хаан тулалдааны үед нас баржээ. Ийнхүү Уйгурын түүхэнд дээрх 4 хаан төр барьж байсан түүхтэй ажгуу.

Уйгур улсын хаан угсаа залгамжилж, Кутүлэг Билгэ хэмээх цол хэрэглэж байв. Хаан зарлиг шийдвэр гаргах, цэрэг захирах, дайн байлдаан хийх, байлдааныг зогсоох,

гэрээ хэлэлцээр байгуулах, төрийн түшмэлийн орон тоо бий болгох, томилох, газар нутаг, өмч хөрөнгө хуваарилан олгох, эзлэгдсэн газар орныг захирах, алба татвар авах эрх эдэлж байсан аж. Хаан нь өөрийн ордон өргөөтэй байжээ.

/бүдүүвч/

Уйгур улсын төрийн байгуулал



Уйгур улсын хаад нүүдлийн мал аж ахуйг эрхлэх, худалдаа хийх, хот суурин байгуулах, гар урлал, уран дархан хөгжүүлэх, гоёл чимэглэл, барилгын материал үйлдвэрлэх, уран зураг, бичиг үсэг, шашин соёл, ном судар бичих, хэвлэх, орчуулах ажлыг дэлгэрүүлэх, эрдэмтэн мэргэдийг дэмжих, хүдэр малтаж төмөр боловсруулах, түүгээр зэр зэвсэг, эдлэл хийх бодлого, үйл ажиллагаа явуулж байсан ажээ. Хааны гадаад, дотоод бодлого, үйл ажиллагаа нь хааны эрх мэдэл бүрэлдэх, уйгур улс хүчирхэгжиж, нэлээд дээгүүр соёлтой улс болоход нөлөөлсөн хэмээн үзэх үндэслэлтэй бөлгөө. Баянчур хаан Хятадын Тан улстай найрамдал байгуулж, цэргийн тусламж үзүүлж байжээ. Жишээлбэл, Тан улсын хаан Сюань цзуни бослогыг дарахад цэргийн тусламж гуйсан хүсэлтийг хүлээн аваад цэргийн тусламж үзүүлж, хоёр нийслэлийг нь чөлөөлж өгч байжээ /43.336/. Мөн 762 онд Тан улсад дотоодын бослогоо дарахад нь 14000 цэрэг оруулж тусалцаа үзүүлсэн /45.337/ байна.

Уйгур улсад түшмэдийн ёсон бүрэлдэн бий болж байв. Тус улсад цэргийн жанжин, зонхилогч, тэргүүлэгч, эльтебер, тунтук, заргач, дархан, сайд, түшмэл гэсэн албан тушаалууд бий болж, тэдгээр тушаалд ажиллах хүнийг хаан томилдог байв. Уйгур улсад Баянчур, Кюлүг, Бага Тархан нар “цэргийн жанжин”, аймгийн толгойлогч, аймгийн “зонхилогч” тэргүүлэгч, төрийн сайдыг “эльтебр”, татвар оногдуулж хураах түшмэлийг “дархан”, эзэлсэн аймаг улсыг захирагчийг “Тунтук”, шүүн таслагч, түшмэлийг “заргач” хэмээн нэрийдэж байсан аж.

Мөн төрийн багш гэсэн тушаал байсан бололтой. Түүхэн сурвалжаас үзэхэд Уйгур нь 751 онд Чик Карлукийг эзлэн авсны дараа эдгээр нутгийг ерөнхийлөн захирагч “тунтук” хэмээх албан тушаалтныг томилон суулгаж цэрэг дайны олон шивээ бэхлэлт барьжээ. Эдүгээ Хэмчиг голын хөвөөнд Уйгурын байгуулсан бэхлэлт хот, харуулын шивээ оныг илрүүлэн судлаад байгаа билээ. Сүүжийн бичээсэнд дурдсанаар Кутулүг бага дарханы Өгэ-Буйруг түшмэл гэсэн үг бий /21.77/. Мөн Уйгурын Тумиду Элтебер тушаалтай байсан аж.

Дээр дурдсан албан тушаалтнууд нь хааны бодлого, эрх мэдлийн гол хэсгийг хариуцан, түүнээ биелүүлэх үүргийг хааны өмнө хүлээж, харьцангуй их эрх эдэлж, үлэмж өмч хөрөнгө эзэмшин үйл ажиллагаагаа явуулж байжээ. Сүүжийн бичээсэнд өгүүлэхдээ “Миний багшид 100 эр, газар нутаг таслан өгөв” /121.77/ хэмээн дурдсан юм. Уйгурын хаант улс хүчирхэг цэрэгтэй байжээ. Тан улсын сударт “Уйгурууд эрэлхэг зоригтой ... хулгай дээрэм хийхдээ чадмаг, нийт 10 түмэн хүнтэй, 5 түмэн цэрэг болдог” /87.301/ хэмээн бичжээ. Цэрэг нь нэгдмэл зохион байгуулалттай, зоригтой, чадалтай. Гол төлөв нум сум, дуут сум, хуяг, сэлэм, жад зэргээр зэвсэглэсэн, морьт цэрэг байжээ. Түүхэн сурвалж Синь Тан Шу /Тан улсын түүх/-ийн 217 дугаар бүлэгт дурдсанаар Уйгур цэрэг “морин дээр явуут харвахдаа сайн” байсан аж. Түүхэн сурвалжаас үзэхэд Уйгурууд 762 онд 14000 цэрэг гаргаж Хятадад тусламж үзүүлж байсан /43.337/ аж.

791 онд Уйгур 50-60000 цэрэгтэй байжээ /43.338/. Эдгээрээс Уйгурын цэрэг тооны хувьд цөөн биш, сайн зохион байгуулалт, зэвсэгтэй, чадварлаг байсан аж. Уйгурын цэрэг нь нутаг орон, хил хязгаараа хамгаалах, бусад аймаг улсыг байлдан эзлэх, бусад оронд цэргийн тусламж үзүүлэх үндсэн үүрэгтэй байсан бөлгөө.

Эрх зүй. Уйгур улсад өөрийн онцлог бүхий эрх зүй үүсэн бүрэлдэж байсан байна. Уйгур нь тэр үедээ өндөр соёлтой, бичиг үсэгтэй байсан нь эрх зүй бүрэлдэхэд ихээхэн нөлөөлөх хүчин болсон аж. Уйгур улсад төрөөс тогтоосон хууль цааз ба заншлын эрх тус улсын эрх зүйн эх сурвалжийн үндсэн төрөл болж байсан нь эргэлзээгүй.

“Бичиг үсэгтэй болж, албан хэрэг хөтлөн, ном бүтээл туурвиж, гадаад хэлнээс ном, шастир орчуулж байсан уйгурчуудад бичмэл хууль байгаагүй хэмээн үгүйсгэх

аргагүй болов уу” /14.31-32/ гэж академич Ж.Болдбаатар, доктор Д.Лүндээжанцан нар дүгнэлт хийсэн нь үндэслэлтэй юм.

Төрийн байгуулалтай холбоотой асуудлууд төрөөс гаргасан актуудаар тогтоогдож, аж ахуй, хүмүүсийн хоорондын харилцааг заншлын хэм хэмжээгээр зохицуулж байсан бололтой.

Сүүжийн алдарт бичээсэнд “би дээд заргач байв”/121.77/ гэж бичсэнээс үзэхэд шүүхийн асуудлыг хариуцсан төрийн тусгай түшмэл ажиллаж байцаах, шийтгэх үйл ажиллагааг эрхэлж байжээ. Энэ нь гэмт хэрэг, ял шийтгэл байж, шүүн таслах ажиллагаа явагдаж байсныг харуулна.

§6. Хиргисийн хаант улсын төр, эрх зүй

/МЭ 818-900 оны орчим/

Монгол нутагт ноёрхлоо тогтоож байсан Төв Азийн эртний овог аймаг бол Хиргис нар болно. Түүх сударт Хиргисийн өвөг дээдсийн нэрийг Гэгүнь, Гангунь, Гүйбу, Гйечу, Гйегйес, Хакяньс, Хягас гэх зэргээр тэмдэглэж иржээ. Монгол нутагт оршдог Орхоны Түрэг бичээст Кыргыз гэж тэмдэглэсэн нь бий.

Хиргисийн тухай сурвалж бичигт МЭӨ 201 оны үеэс тэмдэглэгдэх болсон нь Хүннүд эзлэгдсэн овог аймгийн дотор Гэгүнь буюу Гяньгүн гэх нэр байсантай холбоотой байж болох.

Тэр аймаг Минусын хотгор, Енисей мөрөн төдийгүй Саяны уулсаас өмнө тийш одоогийн баруун хойд Монголын нутгаар “Хиргис”³⁵ нэртэй нуурын орчмоор нутаглаж байсан бололтой /105.296/ хэмээн сурвалжид тэмдэглэсэн байна.

Түүхийн урсгалд Гяньгүн, динлинчууд холилдон суурьшиж, холимог төрхтэй болж ирсэн нь жинхэнэ Хиргисийн төрхийг бүрэлдүүлсэн ажээ. Овог, аймгуудын шилжилт хөдөлгөөний улмаас шаргал үст, цэнхэр нүдтэй динлинчүүд түрэг хэлт монголжуу төрхтэй гяньгүн нартай цусан холилджээ /102.199/.

Хиргисүүд Тан, Түрэг улсуудын харьяанд орж захирагдан явсаар 758 онд Уйгур улсад эзлэгдэж түүний ноёрхолд 80 гаруй жил байсны сүүлийн 20-иод жилд тус улсын ноёрхлыг эсэргүүцэн тэмцэж байжээ. Эл тэмцлийн үр дүнд Уйгурын цэргийг ялж, 818 онд Хиргисийн ноён Ажо өөрийгөө Хиргисийн хаанд өргөмжилсөн байна. Ажо тэргүүтэй Хиргисүүд Уйгурыг мөхөөж, Монгол, Зүүн гар, дорнод Туркистан зэрэг Төв Азийн ихэнх нутгийг эрхшээлдээ оруулж 810 он болоход Төв Азид ноёрхлоо бүрэн тогтоожээ. Ажо хаан Уйгурын бүх газар нутгийг эзэмших, Тан улсын эрх дархыг өвлөн авах, Хятадтай харилцаагаа хөгжүүлэх бодлого явуулсан байна. IX зууны II хагас гэхэд Хиргисчүүд дорно зүгийн Хар мөрний эхнээс өрнөдөд Тэнгэр уулын зүүн суга хүртэл газар нутгаа өргөтгөн тэлжээ.

Хиргисчүүд IX зууны II хагаст Төв Азид ноёрхох байр сууринаасаа татгалзаж, Монгол нутгийг орхин нүүдэллэн явжээ. Үүгээр Хиргисчүүдийн монголд 100 гаруй жил оршин байсан түүх дууссан бөлгөө. Эрдэмтэд Хиргисчүүд монгол нутгийг орхин явсныг олон янзаар тайлбарлаж ирсэн боловч энэ нь байгаль цаг уур, тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдал, тэдний өөрсдийнх нь үндэсний онцлог, аж төрөх ёс, зан заншил, хүсэл сонирхол зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой байжээ. Юутай ч гэсэн уугуул нутагтаа газар тариалан голлон эрхэлж байсан Хиргис нарын ахуй нь бэлчээрийн мал аж ахуйд илүүд тохирсон монгол нутгийн уур амьсгалд зохимж муутай байсан хийгээд Хиргисчүүд төрөлх газар нутагтаа байж, өөрсдийнхөө зан заншил, аж ахуйг шүтэн амьдрахыг хүссэнтэй гүн холбоотой болов уу.

Хиргисчүүдийн эрхэлдэг гол аж ахуй нь мал аж ахуй, ан агнуур ба газар тариалан байжээ. Таван хошуу малыг өсгөж байсан ч адуун сүрэгт их анхаарал тавьж байсан аж. Энэ нь адуу бол малчин, анчин, цэрэг эрсийн гол хэрэгцээ байсантай холбоотой. Адуун сүргийн олон, цөөн нь баян, ядуугийн гол хэмжүүр болж байжээ.

Хиргисчүүд газар тариаланд мал аж ахуйгаас дутахааргүй анхаарал тавина. Энэ нь Хиргисчүүдийн зарим хэсэг нь газар тариалан эрхэлдэг байсантай холбоотой. Ялангуяа анжист тариалан нилээд хөгжсөн ажээ. Хиргисчүүд амуу будаа, арвай, буудай, Гимлайн арвай, олс гэх мэтийг тариалдаг байв. Хиргисчүүд гар урлалыг гайгүй сайн хөгжүүлсэн байна.

Шавар сав суулга, төмөр боловсруулж зэр зэвсэг, сав хэрэгсэл, морины тоноглол үйлдвэрлэж байв. Хиргис нар бүх л өмнөд Сибирийн оршин суугчдыг сумын зэвээр хангаж байсан ба эдгээрийн дотор гурван хянгат болон хавтгай, мөн далбан хэлбэрт зэвүүд байжээ. Түүнчлэн хоёр талтай илд, чинжаал хутга, жадны гилбэр, ... анжис, хадуур зээтүү, сүх, мужааны болон дархны ажлын багажийг үйлдвэрлэдэг байжээ /43.347/.

Хиргисчүүд гадаад харилцаа, худалдаа арилжааг нилээд хөгжүүлэхийг хичээж байсан ажгуу. Араб, Уйгур, Түвэд, Хятад, Карлукуудтай харилцаж, худалдаа арилжаа хийж байжээ. Эдгээр оронд төмөр эдлэл, зэр зэвсэг, алтан эдлэл, үслэгийн зүйл, бугын ясан, цусан эвэр зэргийг гаргадаг байв. Хиргис нар торго, бөс бараа, анжис, гоёл чимэглэлийн зүйлс, цай, сав суулга зэргийг их хэмжээгээр худалдаж авч байсныг гэрчлэх эд боловсролын дурсгалууд Хиргисийн нутгаас элбэг олддог /12.144/.

Тан улсын түүх, Орхоны бичгийн дурсгалуудаас үзэхэд Хиргисчүүд олон улс орон, тухайлбал Хятад, Түрэг, Уйгур улсад олон элч төлөөлөгч илгээж, мөн олон удаа байлдаж тулалдаж байсан түүхтэй ажгуу.

Хиргис нар бөө мөргөлтөн байсан бөгөөд бөө нарыг “гянь” буюу “кам” гэж нэрлэдэг байжээ. Тал газар цугларч бөө бөөлүүлэн, лус савдаг тахиж ёс үйлдэнэ.

12 жилийн тоолол хэрэглэнэ. Жил бүрийг бар, хулгана, нохой гэхчлэн амьтны нэрээр нэрлэнэ. Баяр наадам хийж, тэмээн ба морин уралдаан явуулдаг байсан ажээ. Баяр наадмын үеэр бишгүүр, хэнгэрэг, цоор зэрэг хөгжмийн зэмсэг хэрэглэнэ.

Хиргисчүүд бичигтэй байж, хойч үедээ утга зохиол, бичиг соёлын олон сайхан дурсгалыг үлдээсэн соёлтой ард түмэн байжээ. Судлаач эрдэмтэн Л.Р.Кызласовын үзэж буйгаар Енисейн руни бичиг Хиргис нарын дунд ҮII-XIII зуун хүртэл хэрэглэгдэж байжээ /116.148/. Хиргисчүүд монгол нутагт бичиг үсэг, түүхийн олон дурсгалууд үлдээсэн нь өдгөө үед ч хадгалагдсаар байгаа бөлгөө.

Монгол орны нутагт ялангуяа баруун хэсгээр элбэг тааралддаг “Хиргисийн үүр” буюу “Хиргисчүүр”, Хиргис булшууд, археологийн малтвараар олдсон Хиргисчүүдийн эдлэл хэрэглэл, эд өлгийн зүйлс /Өвөрхангайн Хужирт сумын Хөшөөт, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Нахиугийн Манхан дахь булшууд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт буй хадан дээр сийлсэн баатарын зураг зэрэг мэт/ ийм үнэт дурсгалд хамаарагдана.

Хиргис бол хаант улс байсан ажээ. Төрийн тэргүүн нь хаан болно. Хааны дараа тодорхой зэрэг дэв бүхий түшмэлүүд байжээ.

Түшмэдүүдэд сайд, ерөнхий дарга, захирагч, бег, дархан, баатар, хошууч хэмээх албан тушаалтан цолтнууд хамаарагдаж байв. Түшмэдүүдийн тэргүүнд сайд долоо, ерөнхий дарга гурав, захирагч арав байжээ. Эдгээр нь төр ба цэргийн хэргийг их төлөв эрхэлдэг байсан байна /12.142/. Мөн үүний дараа жирийн хэрэг шийтгэн явуулдаг арван түшмэл орж байжээ. Түшмэдүүдийн хамгийн дорд нь хошууч ба дарга хэмээх тушаалтай байжээ /12.142/. Эдгээр баримтууд Хиргисийн хаант улсад төрийн засаглал тогтож, түүнд ажиллах түшмэдийн тушаал, зэрэг дэв бий болж, төрийн үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтан хүмүүс бүрэлдэж байсныг харуулах бөлгөө.

Хиргисийн хаант улс өөрийн цэрэгтэй байв. Түүхэн зохиолд Хиргис улс нь 30000-80000 цэрэг дайчлах чадвартай /84.351/ байсныг тэмдэглэсэнээс үзэхэд цэргийн тоо мөн ийм л байсан бизээ. Цэрэг нь зохион байгуулалттай, төрийн том түшмэдийн нилээд нь цэргийн хэрэг эрхэлж, цэрэг захирч, тулалдаан, довтолгооныг удирдаж байсан аж. Тан-шу /Тан улсын түүх/ хэмээх түүхэн сурвалжид бичсэнээр Хиргисчүүд “Маш хурц зэвсэг хийдэг. Түрэгт байнга өгдөг. Дайнд нум сум, туг хэрэглэдэг, морин цэрэг хөл, гартаа модон бамбайтай байдаг” /43.347/ байжээ. Цэргүүд нь зориг, гэсвэртэй, чадварлаг байлдаж чаддаг байсан аж. Ийм ч учраас Уйгурын хаант улсын хүчирхэг цэргийг ялсан түүхтэй.

Хиргисийн хаант улсад өөрийн гэсэн **эрх зүй үүсэж, түүнээ заншлын эрхтэй хослуулан хэрэглэж байжээ**. Хааны эрх, үүрэг, засаглан захирах, зохион байгуулалт, үйл ажиллагаа, төрийн түшмэдийн тогтолцоо бий болсонтой холбоотой эрх зүйн хэм хэмжээ үүсэн бүрэлдэж байсан.

“Тан-Шу” /Тан улсын түүх/-д Хиргисийн хууль нь их хатуу. “Тулалдаанд сандрах, элчийн алба гүйцэтгэхгүй байх, эзэнд буруу зөвлөгөөн өгөх, хулгай хийх юм бол толгойг нь авдаг. Хулгайч нь эцэгтэй байх юм бол толгойг нь эцгийн хүзүүнд үхэн үхтэл нь зүүдэг” /18.64/ хэмээн бичсэн байдаг байна. Үүнээс үзвэл Хиргисийн хаант улсад дээр дурдсан үйлдлүүдийг гэмт хэрэг хэмээн үзэж хатуу ял оногдуулж байсан аж. Монголын түүх судлалын бүтээлд “Хиргис улсад хууль, дүрэм нарийн чанд байжээ” /12.142/ гэж бичсэн нь Хиргист бичигдмэл хууль дүрэм гарч, түүнийг чандлан биелүүлдэг байсныг харуулам.

Мөн “хэрэг шийтгэн явуулдаг арван таван түшмэл байжээ” /12.142/ гэж сурвалж бүтээлд бичсэн нь ял шийтгэх ажлыг эрхэлсэн түшмэд ажиллуулж байсныг нотолж байна. Хиргист гэр бүлийн харилцаа нилээд өвөрмөц байдлаар хөгжиж байжээ. Вэй улсын сударт бичсэнээс үзэхэд ураг барилдах гэвэл эхлээд хүүхэнд сэм хэлдэг. Магадгүй хагас жил болоод эсхүл зуу хоноод хүн явуулж, адуу үхэр хонь хүргүүлэн, бэлэг, сүй тавьдаг.

Хүргэн нь хадмындаа очиж байгаад эхнэрээ авч төрхөмдөө эргэж ирэхэд гэрийнхэн нь цөм босоцгоож мөргөдөг. Гагцхүү эцэг эхдээ мөргүүлдэггүй. Хадмындаа 2 жил зарцлагддаг, түүний дараа хадам нь охиноо хадамд нь элбэг баянаар гаргаж өгдөг. Хөрөнгийг бүгдийг эхнэрийн гэр орныхон гаргаж өгөх заншилтай байжээ. Түүхэн зохиолд эхнэр богтлон авахдаа адуу, хониор сүй бэлэг барьдаг. Эрд гарсан эмэгтэйчүүд ба эрчүүд нүүрэндээ шивээс тавьдаг байсныг дурдсан /43.348/ байдаг бөлгөө.



ЗУРГААДУГААР БҮЛЭГ**Хятаг гүрний төр, эрх зүй****/МЭ 917-1125/****§1.Хятаг нарын удам угсаа ба аймгийн холбоо**

Хятаг хэмээх нэр Үү зууны сүүл үеэс түүхэн сурвалжид тэмдэглэгдэж эхэлжээ. Хятагны өвөг дээдэс нь Кумоси нарын нутгийн зүүн талаар нутаглаж байгаад 338 онд Зүүн Янь улсын /317-420/ их цэрэгт цохигджээ. Чингээд тэдний зарим нь тасран сарниад Шар мөрний дунд орчимд очиж нутаглан сууж /123.154-155/ өөрсдийгөө Хятаг хэмээн нэрлэсэн байна /43.360/. Ингэж Хятаг нар түүхийн тавцанд гарч ирсэн ажгуу.

Хятаг нарын угсаа гарлын талаарх эрдэмтэд, судлаачдын санал анхандаа зөрүүтэй байсан боловч сүүлийн үеийн судалгааны дүнгээс үзвэл Хятаг нар нь Сяньби нартай нэг удам гаралтай, монголчуудын өвөг дээдэс гэх үзэл давамгайлж байна /43.364/.

Түүхэн сурвалж бичигт өгүүлснээр Хятаг нар нь Дунху буюу Дорнод Ху хэмээн түүхэнд нэрлэгдсэн аймгийн үр хойчис аж /43.364/. Дунху нараас Сяньби нар үүсэн буй болжээ. Сяньбичууд II зууны үед Шар мөрний эргийг даган нутаглан сууж Ляодунгийн Сяньби, Ляосын Сяньби хэмээн нутаг усныхаа нэрээр нэрлэгдэх болсон аж. Үү зууны үед Ляо-дунгийн Сяньбийн нэгэн ноён Ляосын Сяньбид довтлон ялахад Ляосын Сяньбичууд бутран сарниж Юйвэнь, Кумоси гэсэн аймгууд болжээ.

Үүний Кумоси аймгаас Хятаг нар салбарлан гарсан гэдэг. Энэ талаар түүхэн сурвалж бичигт “Хятаг нар Кумосийн зүүн талд оршдог бөгөөд тэдэнтэй нэг язгуур гаралтай, тусгай салбар нь юм” /56.154-155/ хэмээн тэмдэглэж бичжээ. Японы эрдэмтэн Тори нар Дунху, Сяньби, Хятаг нарын археологийн судалгааны үр дүнг судлан үзээд “Дунху, Хятаг нарын үлдээсэн археологийн дурсгалууд нь хоорондоо гарлын холбоотой болохыг тогтоосон /63.11/ байна.

Хятадын судлаачид мөн Сяньби, Ухуань, Хятаг нарын нутгаар хийсэн археологийн дурсгал ялангуяа шавар ваар эдлэлүүд нь хоорондоо холбоотой гэсэн дүгнэлтэд хүрсэн” /43-292-293/ ажээ. Хэл шинжлэлийн эрдэмтэд хятаг хэлнээс монгол хэлтэй язгуур, дуудлага нь адил буюу ойр үгүүдийг түүвэрлэн судлаад энэ хоёр хэл “нэг язгуур үүсэлтэй” /43-365/ хэмээн нотолсон нь бий. Хятаг нарын гарал, хэл нь монголчуудтай холбоотойг “анхандаа Хятаг аймгуудыг тэргүүлж агсан Дахэ аймаг бол хожмын дагуур нар мөн” /39-103/ гэсэн дүгнэлт нотолж байна. Монголын түүхэн сурвалжид “Да-хэ”³⁶ хэмээх нэр нь хожим Хятагны ноёлох аймгийн нэр болсон бөгөөд орчин цагийн дагуур нарын удам байсан бололтой /12.151/.

Эртний Хятадын түүх, тухайлбал, Ляо улсын түүхийн 3 дугаар дэвтэрт “Хятан нарын хэл нь адил, онцын ялгаагүй” /12.150/ гэсэн байхад Рашид-ад-Дин “Эртний монголчууд ба Хятан нарын хэл нь ялгаа багатай” /129.103/ гэж бичсэн байдаг.

Энэ бүхэн нь Хятан нар монгол угсааны Сяньби нартай нэг гаралтай агаад чухамхүү монголчуудын өвөг дээдэс болохыг нотлон харуулж байна. Сурвалж бичигт өгүүлсэн этнографын мэдээ, хятан хэл судлалын дүгнэлт, археологийн шинжилгээний үр дүнг иш үндэс болговоос Хятан нарыг монголчуудтай нийтлэг гаралтай гэж шууд үзэх болж байна /14.149,150/.

Хятан нар Сиваньдан, Хэдахэ, Фуфуюй, Юйлин, Жилян, Пицзе, Пи, Тулуй гэсэн найман аймгаас бүрдэж байв. Аймаг бүрийг зонхилогч /ахлагч/ захирна. Эл үед Хятан нар Хятад, Солонгостой харилцаж, билэг сэлт өргөн эв найртай байх, өөрсдийн залгаа Жужань, Кумоси, Гаозюйли, Дидоуэй зэрэг нүүдэлчин аймгуудтай үргэлж харилцаж байсны дээр эдгээр улс, аймгуудтай хүч хавсрах, эвдрэлцэн тэмцэлдэх, довтлолцох зэргээр оршин тогтнож, түүхийн буурал хугацааг угтаж, үдсээр ирсэн болой.

ҮI зууны сүүлчээр Хятан нар аймгийн холбооны зохион байгуулалтад орж, тэдний дотроос Дахэ аймаг тодрон гарч, эрх баригч аймаг болон бусад аймгуудаа харъяалан захирах болсон байна. Аймгуудын холбооны тэргүүлэгчээр Дахэ аймгийн зонхилогч Шоуку сонгогджээ. Дахэ аймгийн зонхилогч, холбооны тэргүүлэгч нь бусад аймгуудаа удирдан, тэдэнтэй зөвлөлдөн аймгуудыг хамгаалах цэрэг, морь татах, бүх цэргийг удирдах зэргээр үйл ажиллагаагаа явуулж байжээ. ҮI зууны эцэс гэхэд Хятаны холбоо 43000 цэрэгтэй болж /43.361/ хүн ам, эдийн засгийн хувьд нэлээд өсөж хүчтэй болж иржээ. ҮIII зууны эхээр Хятан нар улам хүчтэй болж, бусад нүүдэлчин аймгуудыг эзлэн авч хүрээгээ тэлсээр 10 аймагтай болсон байна. Эл үед аймгуудын зонхилогчдын хуралдаанаас холбооны тэргүүнийг 3 жилийн хугацаагаар сонгох ёс тогтоожээ. Холбооны тэргүүлэгчийн ордны өмнө бөмбөр, туг зэргийг байрлуулж хүндэтгэл үзүүлэх ёсон бий болсон байна. Түрэг улс, Хятадын Тан улс Хятаны холбоонд үлэмж шахалт үзүүлж түрэмгийлэл үйлдэж байсан ч зориг тэвчээртэй тэмцэн туулж, тусгаар байдлаа хамгаалсаар ирсэн ажээ.

718 онд Хятаны аймгийн холбооны тэргүүлэгч Шоу Ку алагдсанаар холбооны тэргүүлэгчийн эрх Яо Нян аймагт шилжжээ. Энэ үеэс Хятан аймгуудын холбооны тэргүүнийг сонгох ёс горим алдагдаж, үе залгамжлах байдал буй болж эхэлсэн байна. Холбооны тэргүүн өөрсөддөө хан цол өргөмжлөх болж тэргүүлэгчээс гадна аймгуудын цэрэг, морийг захирах “или” хэмээх тусгай албан тушаал бий болгон, түүнд ажиллах түшмэлийг нэн хүчирхэг байсан Диле аймгаас томилох болжээ.

Хятаны аймгуудын холбооны үед хүн ам, аж ахуй өсөн дэвжихтэй холбоотойгоор IX зууны сүүлч болж ирэхэд 38 аймгаас бүрдэх болж, шинэ шинэ албан тушаалууд

гарч ирсэн байна. Өмнө нь байсан Илигээс гадна Юй-Юай, Тама-Жуй-сали гэсэн том түшмэлийн тушаалууд буй болжээ.

Хятан аймгуудын эрхлэх гол аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй байв. Тэд адуу, үхэр, бог мал маллан гахай тэжээж байжээ. Мөн ан ав хийж, загас барьж, тариа будаа тарьж байв. Хятан нар гэрт сууж, бэлчээр усны сайныг даган нүүдэллэнэ. Нүүхдээ тэрэг хэрэглэн, буудаллах, суурьшихдаа тэргүүдээ тойруулан тавьж, хүрээ үүсгээд дунд нь буудаг байжээ.

Хятан нар төмрийн хүдэр боловсруулж, хайлуулж, цутгуур хийж, аж амьдралдаа хэрэглэдэг байсан аж. IX зууны дунд үеэс хот байгуулж, байшин барьж суудаг болж эхэлсэн байна. Гар урлалыг хөгжүүлж, худалдаа арилжаа хийн, аж ахуй, эдийн засгаа өөд татан тэтгэхийг эрмэлзэж байсан ажээ.


§2. Хятан гүрэн

Хятан нарын дунд эдийн засаг, нийгмийн ахиц өөрчлөлт гарч, Хятаны язгууртнууд нийгмийн давхрааны шинжийг улам бүр олсоор байсан ажээ. Хүчтэй болж буй язгууртнууд аймгуудын эрх мэдлийг булаан авч, эрх барих овог, аймгуудыг үүсгэх болсон байна. VI зууны 80-аад оноос 718 он хүртэл “Да-хэ”, дараа нь “Яонянь”, X зууны эхэн үеэс “Елюй” аймаг тус тус эрх баригч аймаг болж явсан бөлгөө. Дээд эрх мэдэл нэгэн аймагт төвлөрснөөс тэрхүү аймаг бэхжиж, хүч чадал нь нэмэгдэн бусад аймгаас тусгаарлан ялгарахад хүрчээ. Энэхүү өөрчлөлт нь Хятаны холбооны тэргүүлэгчдийг ноёлох аймгийн дээдчүүлээс сонгон тавих болж, цаашид Хятаны тэргүүлэгчийг үе улираах ёсон буй болжээ.

Дээрхи өөрчлөлтийн үр дүнд VII зууны дунд үеэс Хятан аймгуудын холбоо нь “хан”-аар толгойлуулсан төрийн зохион байгуулалтын том хэлбэрт шилжих үйл явц явагджээ. X зууны эх болж ирэхэд төрийн засаглалын хэлбэр, төрийн аппаратын эх үүсвэр бий болж, төр үүсэх нийгэм, эдийн засаг, улс төр, хууль зүйн нөхцөл бүрдсэн байна. Хятан улс байгуулагдахад 901 онд Хятаны ханд 3 жилийн хугацаагаар өргөмжлөгдсөн “Елюй” ноёлох аймгийн Амбагян³⁷ тэргүүлэгч ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Амбагян тухайн нөхцөл байдлыг ажиглан, нэгдсэн улс байгуулан бүрэлдүүлсээр 917 онд аймгуудын холбооны тэргүүлэгчийг гурван жилээр сонгох журмыг зөрчин өөрийгөө Хятаны хаан /Каган/-д өргөмжилж, хаан төрийн ширээг үе улиран залгамжилдаг ёсыг тогтоосон байна /12.153/.

Ийнхүү Хятан улс байгуулагдсан түүхтэй. Амбагян хаан Хятаны уламжлалт 8 аймгийг үндэс болгож байгуулан улсаа Хятан хэмээн нэрлэж, аймгуудын холбооны зохион байгуулалтыг өөрчлөн, төрийн зохион байгуулалтад шилжүүлж, нилээд өөрчлөлт хийсэн байна.

ХЯТАН УЛС



Зургийг “Монгол Улсын түүх” номын тэргүүн ботиос ашиглав.

Амбагян хаан эрх мэдлээ бэхжүүлэх, газар нутгийг өргөтгөх, аж ахуй, соёлыг хөгжүүлэх 8 бодлого боловсруулан, түүнээ хэрэгжүүлэхийн тулд нилээд арга хэмжээнүүд авчээ. 923 оноос гадаад харилцаагаа хөгжүүлж, Азийн бусад орнуудтай шинэ харилцаа тогтоосон байна. 923 онд Перс улсаас, 924 онд Солонгосын Силла улсаас Хятан улсад элч ирж байсан нь Хятан улсын гадаад харилцаа өргөжиж байсныг нотлох бөлгөө. Амбагян хаан гадаад, дотоод амьдралд шинэчлэлт хийсний дараагаар бусад аймаг, улс орныг байлдан эзлэн авч эрхшээлдээ оруулах өргөн үйл ажиллагаа явуулжээ. Хиргис улсыг довтолж 924 онд Хэрлэнгээс урагши, Алтайгаас зүүн тийшхи газар нутгийг байлдан эзэлж тэр зүгийн бүх аймгуудыг Зү-бу /заримдаа Зү-бу улс гэх/ гэж нэрлэсэн байна. Зү-бу нар Хятан улсад алба төлж, харъяалагдан явсаар XI зууны эхэн хүрсэн байдаг. Мөн 924 онд дорнод тэнгисийн захад орших Бохай улс болон Зүрчидийг эзэлж хараат улс, түшиц газар болгожээ /12.154/. Цаашид 936 оноос эхлэн Хятад руу довтолж, хойт талын 16 муж улсыг нь эзлэн авсанаар Хятан улс их гүрний шинжтэй болж улмаар улсаа Их Ляо улс хэмээн нэрлэх болсон байна. Газар нутаг нь Дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан хэрэм хүртэлх газрыг хамарч байв. 946 оноос Их Ляо улс Хятадын бусад мужууд руу довтолж Шар мөрний өмнөх газар нутгийг эзэлжээ.



Хэрлэн барс хотын суврага

Энэ бүхний эцэст Хятан гүрэнд 50 гаруй улс, аймаг багтан орж харъяалагдах болсон байна. 1049 онд зохиосон тоо бүртгэлээр, Хятан гүрэнд улсын нийслэл хот 5, Чжоу 6, бэхлэлт хот 150, сянь /хошуу/ 200, овог, аймаг 5000, хараат улс 5 байсан /56.42/ ажээ. Хятан улс дээд, дунд, өмнөд, баруун, зүүн гэсэн 5 нийслэл хоттой байсан юм. Дээд нийслэлийг 918 онд одоогийн Өвөр Монголын Баарин Зүүн хошуунд, зүүн нийслэлийг 919 онд Ляонд, Өмнөд нийслэлийг 938 онд Бээжинд, Дунд нийслэлийг 1007 онд одоогийн Өвөр Монголын Пэнчин Сяньд, Баруун нийслэлийг 1044 онд одоогийн Шань Шаньси мужийн Датди хотод тус тус байгуулсан байна. Хятан гүрний газар нутаг нь Дорнод далайгаас алтай уулс хүртэл, Хэрлэн голоос Хятадын Цагаан хэрэм хүртэл өргөжсөн байна /43.367/. Хятад улс ба Их Ляо улсын хооронд хэд хэдэн удаа байлдаан тулалдаан болсон ч 1005 оны үед Их Ляо улс ба Хятадын Сүн улс хоёр найрамдал байгуулсан ажээ. Хятан гүрэн, Хятадын Сүн улстай найрамдсаны дараа аян дайныг зүүн тийш үргэлжлүүлж Солонгосыг, баруун ба баруун хойш үргэлжүүлж Уйгур, Тангад орнуудыг эзэлж эрхэндээ оруулсан байна. Түүхэн үйл явдлын цаашдын явцад Хятан гүрэнд эзлэгдсэн улс, аймгуудын ард түмний тэмцэл, хөдөлгөөн XI зууны дунд үеэс улам хүчтэй болж, XII зууны эхнээс бүр зэвсэгт бослогын хэмжээнд хүрсэн ажээ. Хятан гүрний харьяанд байсан Зүрчид аймаг 1113 онд бослого гаргаж, өөрийн нутгаа чөлөөлсөн төдийгүй, Хятан гүрний зарим газар нутгийг ч эзэлж, улмаар 1115 онд Алтан улсыг байгуулсан байна. Алтан улс үүгээр зогссонгүй 1115-1118 онд Хятан гүрнийг ямар ч завдал өгөлгүйгээр байлдан довтолж, 50 илүү хотыг нь эзэлжээ /43.368/.

Алтан улс, Хятадын Сүн улстай хамтран 1115-1125 онд Хятан гүрэн лүү хоёр чиглэлээр хүчтэй довтолгоон хийж үлэмж их газар нутгийг эзэлсээр ялалт хийж Хятаны гүрний хаан Тяньцзог олзлон авчээ. Үүгээр Хятан гүрэн мөхөж, харъяат газар нутаг, хүн ам нь Алтан улсын эрхшээлд орсон ажгуу. Овог, аймгуудаас аймгуудын холбоо, эл холбооноос Хятан улс, энэхүү улсаас Хятан гүрэн болтлоо өвөрмөц замыг туулж, түүхэн орон зайгаа багтай эзэлж агсан, монголчуудын өвөг дээдэс, өтгөн буурал хятан нар нүүдлийн соёл иргэншлийг суурин соёл иргэншилтэй хослуулсан эрэлхэг зоригт, соёлтой ард түмэн байсан бөлгөө. Хятан гүрний баруун хойт хэсэгт нүүдэлчид голдуу сууж, өмнө, зүүн өмнө, зүүн хэсэгт суурьшмал Хятан ба Хятад оршин, нутгийн төв хэсэгт хагас суурьшсан, хагас нүүдэлчин ард иргэд оршин байжээ /43.371/. Эдгээрээс үүдэн Хятан гүрний хүн ам нь нүүдэлчин, суурьшмал хоёр янзын амьдралтай ард иргэдээс бүрэлдэж, тэдгээр нь эдийн засаг, соёлын хөгжлөөрөө мөн л харилцан адилгүй, жигд бус байсан болой. Эдгээр нь Хятан гүрний эдийн засаг, улс төр, аж ахуйн амьдрал, түүний хөгжил, төрх байдалд нөлөөлж, ул мөрөө үлдээсэн бөлгөө. Хятан гүрний аж ахуйн гол салбар, салаа мөчир нь Хятан овог, аймгуудын үеэс эрхлэх гол аж ахуй нь болж ирсэн уламжлалтай мал аж ахуй байсан аж.

Хятан гүрэнд хичнээн тооны мал сүрэг байсан нь тодорхойгүй. Гэсэн ч зарим сурвалжийн мэдээнээс үзвэл адуу, үхрийн зэрэг зургаан сүргийн мал нь 1065 онд 1000000 байж /56.46/ адуу, үхэр, бог мал үржүүлж, гахай тэжээж байсан нь сурвалж бичигт тэмдэглэгджээ. Хятан гүрний үед хүн амын бүрэлдэхүүн, амьдралын хэв маягтай шууд холбоотойгоор газар тариалан, гар үйлдвэр, худалдаа арилжааг монгол нутагт оршин тогтнож байсан эртний аль ч улсаас илүү өндөр түвшинд эрхлэн хөгжүүлж байсан аж. Бас ан агнах, загас барих ажил мал аж ахуйн ажлын хавсрага болж байжээ. Хятан гүрэнд тариалан, таримлын ажил ихээхэн хөгжсөн байна. Хятаны төрөөс 940, 978 онд тариалан хөгжүүлэх хэдэн арга хэмжээ авч хэрэгжүүлжээ.

Тухайлбал, тариа тарих арга ухаанд сургах тусгай хүн ажиллуулах, зарим аймгаар тариалангийн ажил дагнан эрхлүүлэх, тариаланд төмөр анжис хэрэглэх, үхрээр зүтгүүлэн газар хагалах, суваг татаж тариалан услах арга хэмжээнүүд авсан нь үр дүнгээ өгч байжээ. Эдгээр нь Хятанд тариалан эрхлэх, түүнийг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон аж. Хятан гүрэнд оньсон сууриар нэхмэл сүлжих, төмрийн хүдэр хайлуулах, төмрийн дарх эрхлэх, цэргийн зэвсэг, анжис, сав хэрэглэл үйлдвэрлэх, дарь хийх, мод, чулуугаар эд зүйлсийг урлах үйл ажиллагаа явуулж, эдгээрийг гүйцэлдүүлэх олон газар ажиллуулж байжээ. Хятанд X-XI зууны үед худалдаа арилжааг ихэд хөгжүүлсэн байна. Өмнөд, Умард орд, хот, муж, тосгон, гацаануудад худалдааны газрууд ажиллуулж, алс холын хот, тосгонд явуулын худалдаа гаргаж байжээ.

Худалдааны үнийг зарим үед улсаас зохицуулан тогтоож, барааны үнийг таацуулах журам гарган мөрдөж байсан байна. Жишээлбээс, 1 шуудай амуу X зуунд 5 зоос, XI зуунд 6 зоос, XII зууны эхэнд 100-1000 зоос, 1 үхэр 3 хонь, 1 адуу 5 хонь, 1 тэмээ 8 хонь гэх мэтээр үнэ таацуулан боддог байжээ /56.54/. Худалдаанд цутгамал зоос хэрэглэх болж 907-1121 он хүртэлх хугацаанд 20 удаа зоос цутган худалдаанд гаргасан байна /12.157/. Хятан гүрэн хуурай ба усан замын тээврийг хөгжүүлж, модон тэрэг, байлдааны болон энгийн усан онгоц үйлдвэрлэж, муж, хязгаарын хооронд морин өртөө байгуулж, өртөөлөн явагчдад тусгай тэмдэг-гэрэгэ олгодог байжээ./43.272/ Хятаны үед хот, тосгон байгуулах, орд харш, гүүр, барилга, байгууламж барих, хуучнаа сэргээн засварлах ажил өрнөлттэй хийгдэж байжээ.

X-XI зуунд нэлээд хот, тосгоныг шинээр байгуулж, олон хуучин хот тосгоныг сэлбэн сэргээсэн ажээ. Хятан нар гадна талыг хэрмээр хүрээлүүлж дотор нь орд харш, албан газар, худалдааны зах, оршин суугчдын сууц барьдаг байсан байна. Бас чулуун гүүр, сүм, суварга, мөргөл, түүх дурсгалын газруудаас барьж байгуулж байсан байна. Хятан гүрний үед бүх газар нутаг нь хааны мэдэлд байжээ. Газар нутгийг мал бэлчээрлүүлэх, ан гөрөө хийх, загас барих, тариа тарих газар хэмээн хуваарилж байсан байна.

Нүүдэлчин малчид өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа хэмээсэн дөрвөн улирлын дотоод хуваариар газар нутгийг эзэмшиж байв. Харин суурьшмал иргэд газрыг түрээсний ба эдлэнгийн газар гэсэн хоёр үндсэн хэлбэрээр эзэмшдэг байсан аж. Хятаны хаан, улсын сайд, түшмэдэд тариа тарих, мал бэлчээрлүүлэх болон оршуулгын газрыг олгодог байсан байна. Хятан нь төрийн бичигтэй, тухайн цаг үедээ соёл боловсрол хөгжсөн улс байсан бөлгөө. Эрдэмтэд, археологичдын судалгаанаас үзэхэд ҮШ зууны үед Хятан нь анхны бичиг, зураг бичигтэй болж, хэрэг явдлаа тэмдэглэж байсан хэмээн сурвалж бичигт өгүүлсэн байдаг байна. “Их бичиг” гэсэн нэртэй улсын бичгийг 920 онд Амбагян хааны ач хүү Лубугу, эрдэмтэн Тулуйбу хоёр хятадын утга бичгээр үлгэрлэн зохиожээ. Нэлээд хожуу үед Уйгур бичгийг үлгэрлэн “Бага бичиг” хэмээн нэрлэсэн шинэ бичгийг Амбагяны хүү Елюй Тэло /Жүндүхүн/ зохиосон байна /12.161/. Эдгээр бичгийг зохион хэрэглэсэн нь улсын бичиг үсгийн хөгжилд гарсан том амжилт болсон байна. Хятаны харьяат нүүдэлчин аймгуудын дотор ч хятаны бичгийг хэрэглэж байсан аж. Тухайлбал, зүрчид ба монголчууд, хятан бичиг хэрэглэж байсан болохыг сурвалж бичигт тэмдэглэсэн байна. Мөн Хятан язгууртан сурвалжтаны дунд хятан бичиг хэрэглэх явдал их л дэлгэрч байжээ. Хятан бичгээр бичсэн утга зохиол, шүлэг, магтаал, тэмдэглэл, түүхэн бүтээл гарч байсан байна. Хятан гүрэнд эрдмийн хоёр хүрээлэн байгуулагдан бичиг, боловсрол, эрдэм ухааныг эрхлэн, “Лин-я” хэмээх тушаалтай тусгай эрдэмтэн түшмэлийг ажиллуулж байсан нь бичиг үсэг, эрдэм боловсролд багагүй анхаарал тавьж байсныг харуулнам. X-XI зууны үед Хятан гүрэнд цаг тооны бичиг “хуанли” зохион хэрэглэж, цаг уурч хэмээх тусгай түшмэл ажиллуулж байсан ажээ. Хятан нар үндсэндээ бөө мөргөлтнүүд байсан байна. Дээдсийг онголох, тэнгэр газар тахиx, хавар намрын тахилга хийх ёс хэрэгжиж байсан нь үүнийг гэрчилнэ. Мөн будда, күнз, даосын шашин дэлгэрч, лам нар олширч байсан бололтой. Шашны дотроос буддын шашны лам нар хамгийн олон нь байжээ. Хятан гүрний үед хятан нар өнөөгийн монголчуудын шууд өвөг дээдэс болсон аймгуудтай хамтдаа буюу зэрэгцэн оршиж байсан ажээ.

Эл цагт монгол аймгууд Хятан улсын баруун, баруун өмнө, баруун хойт талаар шууд зах нийлэн нутаглаж байв. Эдгээр аймгуудын нэг хэсэг нь хятанд эзлэгдэж эрхэнд нь орсон бол зарим аймгууд нь хятаны хараат аймгууд болон оршиж байжээ. Өнөөгийн Монголын шууд өвөг дээдэс болох монгол аймгуудыг Хятан нар “Зү-бү” гэдэг ерөнхий нэрээр нэрлэж байсан ажээ. Зү-бү-д 20 гаруй аймаг багтаж байсан бөгөөд тэдгээрийг дотор нь умард Зү-бү, баруун Зү-бү хэмээн зааглаж байв. Умард Зү-бү-д Хэрээд тэргүүтэй аймгуудыг, Баруун Зү-бү-д Найман зэрэг аймгуудыг багтаан оруулж байсан байна. Зү-бү аймгууд Хятан улсад эзлэгдэн олон арван жилийн турш алба төлж, худалдаа хийж, бас Хятаны эсрэг тэмцээр, тэмцэлдсээр байсан түүхтэй.

Түүхэн сурвалжаас үзэхэд монголчуудын шууд дээдэс болох 30 аймаг “Шивэй” гэдэг ерөнхий нэрийн дор, түүний бүрэлдэхүүнд багтан оршиж байсан аж. Шивэй нар Хятаны баруун хойд талаас хойд зүгийн ой хөвч хүртэлх газар нутагт оршин сууж байв. Шивэй бол хожмын Тайчууд аймаг мөн гэж судлаачид үздэг байна. Шивэй аймаг 907 онд Хятанд эзлэгджээ.

Улгу /Олхонууд/ аймаг Хэрлэн голоос урагш оршдог. X зууны эхээр Хятан нарт эзлэгдсэн. Хятанчууд Улгу аймгийг эзэлж аваад гурав хувааж, тус бүрд нь толгойлогч томилон захируулжээ.

Татар. Тэр үеийн сурвалжид “Татар” гэдэг нэрийн дор Тутукулиут, Алчи, Куйн, Биркуй, Тераг, Камаши, Ниучи, Айрагуд, Буйргуд нараас бүрдсэн есөн татаргаас гадна хамаг Монгол мэт зарим монгол аймгуудыг багтаан ойлгож байжээ. Татар нь Хятаны эрхшээлд орж 1005 оноос Хятанд алба өргөдөг болсон байна.

Мэй-Ли-Зи /Мэргэд/ Хятанд эзлэгдэн, 1057 онд У-ду-вэн аймаг Хятанд тэмээ, мориор алба өргөж, 1096 оноос Хятаны эсрэг хүчтэй тэмцэл явуулж байжээ.

Дэлэ аймаг Хятан нартай тэмцэлдэн, түрэмгийлэлийг нь олонтаа эсэргүүцэж байсан аж. Дэлэ нь 8 аймгаас бүрддэг. Судлаачид Дэлэг хожмын Жалайр аймаг байсан байж магадгүй гэж үздэг. Хожим нь Жалайр аймаг 10 аймгаас бүрдэж, Хамаг Монголын нутагт орж ирсэн ажээ.

Монгол /мэньва/ аймаг Далай нуур, Хөлөн нуур хавиар нутаглаж байжээ. Хятан улсын үед тэднийг Мэнгули хэмээж байсан аж. 1087 онд Монгол нь Хятанд амар амгаланг асуун элч илгээж байсан нь эл үе хүртэл Хятанд эзлэгдээгүй байсан болов уу. Энэхүү Монгол нь Хамаг Монгол Улс байсан бололтой.

Элжигин аймаг нь эрт цагийн Хонхирад, Барга аймгуудаас үүссэн хэмээн үздэг. XI зууны эцэс, XII зууны эхээр элжигин нар одоогийн монгол Улсын нутгийн зүүн хэсгээр нутаглаж байжээ. Дээр дурдсан аймгуудаас гадна Диэ-Лиэ-ди, Юань-Цюай, Шимали мэт Монгол аймгууд оршиж Хятантай харилцаж, Хятанд эзлэгдэн бас Хятаны эсрэг тэмцэж явсан түүхтэй.


§3.Хятан гүрний төрийн байгуулал

Хятан нь хаант төртэй улс байжээ. Хятан нар YIII зууны дунд үеэс өмнө овог аймгаар, үүнээс хойш 901 он хүртэл аймгуудын холбооны хэлбэрээр, 917-936 онд Хятан улс маягаар, 936-1125 онд Хятан гүрэн болон оршин тогтнож байсан ажгуу.

Энэхүү 200 гаруй жилийн хугацаанд олон хаан дараа дараалан төр барьж байсныг сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг бөлгөө. Эдгээрийн дотор Хятан аймгуудын холбооны анхны тэргүүн “хан” Шоу Ку, Хятан гүрний анхны хаан, өөрчлөн байгуулагч Амбагян, Хятан гүрний сүүлчийн хаан Тянь Цзо зэрэг нэрд гарсан хаад байсан аж.

/бүдүүвч/

Хятан улсын төрийн байгуулал



Хятан улсын анхны хааныг сонгож байсан бол түүнээс хойшхи бүх хаад үе угсаа залгамжлан хаан болж байжээ.

Хятан улсын хаад их эрх мэдэлтэй байсан аж. Тухайлбал, хууль, дүрэм батлах, улсын хил хязгаар, засаг захиргааны хуваарийг тогтоох, газар нутаг хуваарилан олгох, төрийн түшмэдийн албан тушаал, цол зэрэг бий болгох, албан тушаалтныг томилох, улсын цэрэг байгуулах, цэрэгт татах, алба авах, татвар хураах, мөнгө зоос гаргах, хот, орд харш барих, аян дайн хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, ял шийтгэл оногдуулах зэрэг ихээхэн эрхтэй байв.

Хятан улс засаг захиргааны хуваариа өвөрмөц байдлаар тогтоосон байдаг. Юуны өмнө улсаа хоёр том ордод /хэсэг/ хуваажээ. Орд³⁸ нь засаг захиргааны хамгийн том хуваарь бөгөөд нүүдэлчин, суурьшмал иргэдийн иргэншлийн хэв маяг, газар

нутгийн байдал, эрхлэх аж ахуй, зан заншил, удам угсаа гэх зэргийг харгалзан энэхүү хуваарийг тогтоосон байж болох онцлогтой.

Умард ордод Хятан тэргүүтэй нүүдэлчин аймгуудыг, Өмнөд ордод хятад зэрэг суурьшмал хүн амыг хуваарилан захируулсан байна.

Засаг захиргааны дараагийн хуваарь нь нийслэл хот, чжоу, бэхлэлт хот, сянь болно. Хятанд нийслэл хот 5, чжоу 6, бэхлэлт хот 150, сянь /хошуу/ 200 байсныг өмнө дурдсан билээ. Хятан гүрэнд үндсэн 55 аймаг байсны 16 нь өмнөд замын, 28 нь умард замын, 8 нь гадаад аймгууд байжээ. Аймгууд нь их аймаг, бага аймаг, хараат аймаг гэсэн гурван төрөлд хуваагдана. Үүнээс их аймгууд нь Хятаны гол аймгууд юм. Засаг захиргааны хуваарь бүр нь оршин амьдрах газар нутаг, харьяалан захирах хүн ам, голлон эрхлэх аж ахуйгаасаа хамааран өөр өөрийн засаглах захиргаа, удирдлагатай байсан болой. Хятан гүрний засаг захиргааны хуваарь нь тус улсыг нэгдмэл зохион байгуулалттай, хүчирхэг, удирдлагын өөрт нь зохицсон нарийн бүтэцтэй байхад чиглэгдэж байснаараа онцлог бөлгөө.

Хятан гүрэнд төрийн удирдлагын өөрийн гэсэн бүтэц, зохион байгуулалт, тэдгээрт ажиллах түшмэдийн харьцангуй нарийн тогтолцоо, ёс горим бүрэлдэн бий болсон байна. Амбагян хаан 922 оны орчим төрийн түшмэлийн зэрэг дэв, улсын цэргийг ерөнхийлөн захирах тушаал бий болгон тогтоосон байна. Хааны шууд захиргаанд ажиллах илижин /элтегин эзэн/, юйвэй, тамажуй, сали цэрэг захиргааны том түшмэлийн тушаалууд ч гарч ирсэн байна. Мөн эрдмийн хэрэг эрхэлсэн лин-я хэмээх эрдэмтэн түшмэл, улсын тэнгэрийн улирлыг үзэгч мэргэшсэн түшмэлтэй байжээ. Хятан гүрэн төрийн захиргааны байгууллага, ялангуяа соёл, боловсрол, урлагийн чиглэлээр урлагийн яам, эрдмийн хоёр хүрээлэн, мал эмнэлгийн газар зэргийг байгуулан ажиллуулж байсан ажээ.

Хятан гүрэнд аймгуудын гурван төрлийн захиргаа, тухайлбал Их аймгийн захиргаа, Бага аймгийн захиргаа, Хараат аймгийн захиргааг тус тус байгуулсан байна. Их аймаг бүрийг Илижин хэмээх тушаалтан толгойлж, дор нь зүүн зайсан, баруун зайсан, тайш, сыту зэрэг тушаалтнууд ажилладаг байжээ.

Бага аймаг бүрийг сыту, сыкун хэмээх албан тушаалтнууд удирддаг. Харин эзлэгдсэн Хараат аймгуудын захиргаа нь их аймгийн захиргаанаас төдий л ялгаварлагдахгүй байсан бөлгөө.

Хятан гүрэнд алба, татварын нэгдсэн тогтолцоо бүрэлдэн тогтож, улсын сан хөмрөг, эдийн засгийг бүрдүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэж байсан ажээ.

Хятан улс хүн ам, мал хөрөнгө, тариалангийн газрын данс бүртгэл үйлдэж, түүнийг баримтлан алба, татвар оногдуулж, хурааж авдаг тогтолцоог бий болгосон байна. Энэ нь алба, татвар гэсэн хоёр төрлөөс бүрэлдэж байв.

Албыг эзэлж авсан аймаг, улсаас авна. Татварыг хүн амаас хураана. 927 онд Хятан улс эзлэн авсан Дорнод Дан /Бохай/ улсаас жил бүр бөс бараа 150000 зах, морь 10000 толгойгоор алба авахаар шийдвэрлэн хэрэгжүүлсэн байна. 1070 онд малчин аймгуудаас жил тутам 300-20000 хүртэл мал татварлан авахаар тогтоосон /12.158/ байна. Хятан нь хятадын Цинь улсаас цай, эм, Шичүгулай аймгаас цагаан хүдэр, цагаан шаазгай, Зү-бү аймгаас тэмээ, булга, хэрэмний алба авдаг байжээ /43-372/. Жишээлбэл Зү-бү аймаг Хятанд 923 онд 30 шонхор шувуу, 1019 онд 1700 морь, 440 тэмээ, 1048 онд 20000 морь, тэмээгээр, 1078 онд сайн морьдоор алба барьж байжээ.

Зү-бү нар 194 жилийн хугацаанд Хятанд 53 удаа алба барьсан байна. Энэ нь алба ихээхэн хүнд, нүсэр байсныг харуулна. Алба, татвар их байсан учир олон түмний амьдрал доройтож эгдүүцэн эсэргүүцэж байсан нь сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг бөлгөө. Жишээлбэл, Хятаны эрдэмтэн нар “998-1036, 1070 онд “Цагийг засах бичиг” хэмээх бичгийг хаандаа өргөж алба, татварыг хорогдуулахыг зөвлөж байжээ. Зарим аймаг алба залгуулах чинээгүй болж, хаан зарлиг буулгаж, албанаас хэлтрүүлж байсан байна /12.158, 43.372/

Хятан гүрэн, улсын газар нутаг, бие даасан байдлаа хамгаалах, бусад улс аймгийг эзлэх аян дайн хийх, эсэргүүцэл тэмцлийг дарах зорилготой хүчирхэг цэргийг байгуулсан ажээ.

Хятан улс аймаг, аймгийн холбоо байсан үеэс эхлэн цэрэгтэй болох, цэргийг нэгдмэл зохион байгуулалтанд оруулах бодлого баримталсан байна. Хятаны том аймаг нь 3000, бага аймаг нь 1000 цэрэг дайчлан гаргах чадвартай байсан /43.361/ нь цэргийн ихээхэн нөөцтэй байсныг харуулдаг. ҮИ зууны эцэст Хятан аймгуудын холбооны тэргүүлэгчийн мэдэлд 43000 цэрэгтэй байсныг өмнө дурдсан билээ.

922 онд Амбагян хаан улсын цэргийг ерөнхийлөн захирах тушаал бий болгож, улсын цэргийг 50000 хүнтэйгээр байгуулсан /43.366/ нь Хятаны нэгдмэл зохион байгуулалттай их цэргийн үндэс болж, цаашид цэргийн тоо нь үлэмж нэмэгджээ. Цэргийг дотор нь Ордны цэрэг, улсын цэрэг, хувийн цэрэг, нийслэлийн цэрэг зэрэг төрлүүдэд хувааж байв. “Алтан загастай пайз” олгож цэрэгт татан, “Мөнгөн пайз”-аараа цэргийн агт морьд авдаг байжээ.

Цэрэг бүр 3 морь, 4 төмөр хуяг, 4 нум, 400 сум, богино мод, шөвөг, жижиг дардас, хэт цахиуртай /гал гаргах/ байсан байна. Цэрэгт морин цэрэг их үүрэгтэй бөгөөд анги, ангиар зохион байгуулагдаж байжээ.

Анги бүр 500-700 цэрэгтэй байна. 10 анги нийлж 1 зам болно. Хятан гүрний цэргийн тоо нэг саяас илүү гарч байсныг их эрдэмтэн Х.Пэрлээ “Хятан, түүний Монголчуудтай холбогдох нь” эрдэм шинжилгээний зохиолд дурдсан байдаг бөлгөө.

§4. Хятан гүрний эрх зүй

Хятан гүрэн нь монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудын сүүлчийн улс, тэгэх тусмаа монголчуудын өвөг дээдсийн улс болохын хувьд өмнө нь оршиж, түүхэн дөт замыг туулсан аймаг, улсуудын өв уламжлалаас залгамжлан авч тэдгээрээс илүү өндөр түшвинд эрх зүйгээ үүсгэн хөгжүүлсэн улс болой. Эл их гүрэнд төрөөс тогтоосон хууль цааз болон заншлын эрх, эрх зүйн эх сурвалжийг бүрдүүлж, түүний дотор хууль цаазын эзлэх байр суурь нь улам бүр нэмэгдсээр байсан ажээ. Түүхэн сурвалж бичиг, ном зохиолыг судалсан дүнгээс үзэхүл ҮШ зууны дунд үед Хятанд бичмэл хууль цааз тухайлбал, “Түшмэдийн зэрэг дэвийн тухай хууль”, “Хорих цагдах гянданы тухай хууль” батлагдан гарсан байна /43.366/.

Амбагян хаан Хятан улсыг бэхжүүлэх зорилгоор 921 онд хууль гарган, түшмэдийн зэрэг дэвийг бий болгожээ /43.366/. Түүнчлэн Хятан гүрэнд алба, татварын дүрэм, түрээсний дүрэм, давсны дүрэм, тариалангийн дүрэм, худалдаа арилжааны дүрэм, архи, тамхи хэрэглэхийг хориглох тухай, газар олгох тухай, засаг захиргааны хуваарь, цэргийн зохион байгуулалтын тухай хааны зарлигууд гарч байсан нь Хятанд эрх зүйн эх сурвалжийн төрлүүд бий болж чамламгүй амжилтанд хүрснийг харуулж байна. Хятан гүрэнд төрийн хууль цаазын зэрэгцээгээр мал аж ахуй, газар тариалан, гар урлал, ан агнуурын ажиллагаа, арилжаа солилцоо, боловсрол гэгээрэл, соёл, урлагийн үйл ажиллагаа, хүмүүсийн хоорондын харилцаа, гэр бүл, эд хөрөнгийн харилцаанд заншлын хэм хэмжээ өргөнөөр мөрдөгдөж байсан байна.

Хятан гүрэнд хаант засаглалын хэлбэр тогтох, хааныг өргөмжлөх, хааны эрх мэдэл бүрэлдэх, улсын засаг захиргааны хуваарийг бий болгох, төрийн байгууллагуудыг байгуулах, төрийн түшмэдийн албан тушаал, зэрэг, дэв, хангамж сэлтийг батлах, түшмэдийг албан тушаалд томилох, цэргийн зохион байгуулалтыг тогтоох, цэрэгт татах, цэргийн аян дайн хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, алба, татварын төрөл, хэмжээг тогтоох, газар нутаг олгох, гэмт хэрэгт тооцох, ял шийтгэл оногдуулах нь гагцхүү төрөөс тогтоосон хууль цаазын ёсоор хэрэгжиж байжээ. Эдгээр нь хууль цааз бий болж, тэдгээрийн амьдралд хэрэгжиж байсны бодит үр дүн байсан ажгуу. Энэ тухай нилээд баримт, жишээг Хятан улсын төрийн байгуулал гэсэн хэсэгт өгүүлснийг болгоон үзэхийг хүсмүй.

Хятан гүрэнд бослого үймээн гаргах, хүний амь насанд халдах, мал хөрөнгө хулгайлах, хааны зарлиг шийдвэрийг үл биелүүлэх, алба татвар төлөхгүй байх, албан тушаалаа урвуулан ашиглах, эд хөрөнгийг булаах, шамшигдуулан завших, байлдааны дүрэм журмыг зөрчих, архи уух, тамхи татах, архи нэрэх, худал хэлэх үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж, тэдгээрийг үйлдэгсдэд ял шийтгэл оноож байжээ. Дайнд олзлогдсон хүмүүсийг хураан авч боол болгон ажил хийлгэж байсан байна.

Сурвалж бичиг, зохиолд тэмдэглэгдсэн баримт, материалыг нягтлан үзэхүл цаазаар авах, хөрөнгө хураах ял, боол болгох шийтгэлийг хэрэглэж байсан нь харагдана. Сурвалж бичигт бичигдсэнээс үзвэл Хятан гүрний ял шийтгэл хатуу байжээ. Үүнийг нотлох зарим баримтыг дурдъя. Хятан гүрний хааны дараах албан тушаалтан болох их сайдын нэг Ли-чу ванг гэмт хэрэг үйлдсэн учир цаазаар аваачиж хөрөнгийг нь хураажээ. Хураасан хөрөнгө нь ард олноос мөлжин авсан зоос 70000 хэлхээ, /хэрэв нэг хэлхээ нь 500 зоос гэж бодвол 35000000 зоос/ алт, хаш эрдэнэ сав 70000 байсан байна /43.373/. Цаазаар авсан ялтай эл хэрэг нь албан тушаалаа урвуулан ашигласан, их хөрөнгийг хууль бусаар хураан авч шамшигдуулсан гэмт хэрэг бөгөөд оногдуулсан ялын үндсэн ял нь цаазлах, хөрөнгийг нь хураах нь нэмэгдэл ял байсныг харуулж байна. Хятан улсад өвөг дээдсийнхээ уламжлалыг чандлан баримталж архи хорт ус, тамхийг хорт утаа хэмээн үзэж хэрэглэхийг хориглон зөрчвөл шийтгэл оногдуулж байжээ. Х зууны үед айл өрхөөс архи нэрэхийг хориглож үүнийг зөрчиж архи нэрсэн байвал өрхийн тэргүүлэгчийн толгойг авч байсан байна.

Хятанд хүн амын доод давхарга болох “боолчууд” байжээ. “Боолчууд” нь олзны хүн, ялтан, ядуурагсаас бүрэлдэх бөгөөд тэднийг хан, сайд, түшмэд, том лам нар аж ахуйдаа хэрэглэх явдал байсан /43.273/ гэж эх сурвалжид дурдсан нь олзны хүн, ялтнуудыг ажилд зүтгүүлж байжээ гэдгийг харуулж байна. Түүхэн эх сурвалжид ҮШ зууны дунд үед Хятанд “... хорих, цагдах гянданы хууль тогтоосон нь мэдэгдэж байна” гэж өгүүлсэн нь тус улсад ял эдлүүлэх гяндан байсан гэдгийг нотолж байна.

§5. Хар Хятан улс

/МЭ 1132-1212/

Төрийн түүхэнд Хар Хятан³⁹ улс тодорхой байр суурийг эзэлдэг юм. Хар Хятан нь Хятан гүрний салшгүй хэсэг бөгөөд тус гүрнийг мөхөх үеэр салж, нутаг усаа орхин баруун тийш нүүдэллэн одсон хэсэг Хятанчууд Хар Хятан улс үүсэх мөхлөг хүчин болсон түүхтэй. Хар Хятан улсыг үндэслэгч нь Хятан гүрний хаан Елуй Авуужийн наймдугаар үеийн ач Елуй Даши ажээ. Елуй Даши харъяат иргэдээ толгойлон баруун зүг нүүсэн нь Төв Азийн нүүдэлчдийн өрнө зүгт явуулсан их нүүдлийн ёс заншлыг дагасан үйл явдал, тэрхүү их нүүдлийн үргэлжлэл байсан ажгуу.

Елуй Даши 1124 онд 200 гаруй цэргээ дагуулан баруун зүгт хөдөлж, замдаа хүн хүч хуримтлуулан улмаар өөрийгөө ван хэмээн өргөмжилжээ. Цагаан хэрмийн араар нутаглаж байсан Онгуд аймагт хүрэхэд түүний ноён 400 агт, мөн тэмээ, хонь өгч тусалсан байна. Елуй Даши тэндээсээ Орхон, Туулын билчэр нутагт ирж, Хятан улсын төрийг сэргээхэд туслахыг уриалжээ. Зарим аймгийн ноёд түүнд 10000 орчим цэрэг, мөн тийм тооны агт морьд, олон мянган бог мал өгч тусалсан байна.

Елуй Даши энд хэсэгхэн хугацаанд түр нутаглаж цэрэг элсүүлэх, баазаа бэхжүүлэх, зэр зэвсэг үйлдүүлэх, зохион байгуулалтаа нарийсгах арга хэмжээ авчээ. Эдгээр арга хэмжээг одоогийн Булган аймгийн Чинтолгой, Хадаасан, Эмгэнт, Талын улаан балгас зэрэгт түр сууж байхдаа авч хэрэгжүүлсэн байна /43.368/.

Чингэхдээ 1126 онд Хүсүн-Орду гэдэг хот барьж, нийслэлжиж байсан ажээ. Елуй Дашийн Монгол нутагт хийсэн эдгээр ажил нь Хар Хятан улсыг байгуулах бэлтгэл ажил, эхний алхам болсон байна.

Хятан гүрний хаан Алтан улсад олзлогдож, Хятан гүрэн бүрмөсөн мөхсөн нь Елуй Дашийг Монгол нутагт суурьших аргагүйд хүргэсэн учир баруун зүг нүүх нүүдлээ үргэлжүүлж, Уйгурын нутагт хүрэхэд түүний ноён найр тавин 600 морь, бас тэмээ, бог мал өгчээ. Елуй Даши хөдөлж, Хиргисийг дайран, Имиль голын хөндийд хүрч, тэнд оршин байсан Түрэгчүүдийг эрхшээлдээ оруулан, улмаар зүүн тийш Тэнгэр уул, Чүй мөрөн хүртэл, урагш Ишиг хөл нуураас Балхаш нуур хүртэлх удам нутгийг ээлж дараалан эзлэн авчээ. Дараа нь Харлиг, ханлигийг эзлэн, улмаар баруун тийшхи одоогийн Самарканд, Бухар хот, түүний орчим нутагт довтлон эзлэн авчээ. Тэнд Елуй Даши 1231 онд Гүр /их/ хаанд өргөмжлөгджээ. Мөн авааль хатныг нь улсын эх болгосон байна. Елуй Дашийн улсыг Хятадын түүхэнд Баруун Ляо улс, Араб, Иран сударт Хар Хятан улс гэж бичсэн байдаг. Елуй Даши эл газарт түр нутаглах үедээ төрөө төвхнүүлэх зарим арга хэмжээ авч, хамтран нүүж үнэнч зүтгэсэн бүх хүмүүсээ төр, цэргийн гол албан тушаалд томилсон ажээ. Гүр хаан Елуй Даши 1232 онд их цэргээ зүүн тийш хөдөлгөн Кашгар, Хотан хавийг эзэлж, төлөөний түшмэлүүдийг суулган захируулсан байна. Их цэцэг цааш хөдлөн Хорезмыг байлдан дагуулж байжээ.

1143 онд Елуй Даши их хаан нас барсан учир Сяо-Табу-Ян хар Хятаны төрийг 7 жил бариад Елуй-Илайд хаан ширээг шилжүүлэн өгчээ. Хар Хятан улс 1151-1163 онд төр барьсан Ренжун хааны үед өөрөөр хэлбэл 1160-аад оны үед үлэмж хүчирхэг улс болжээ. Тэр үед Ренжун хаан хүн амаа бүртгэн өрхийн данс хөтлөхөд нийт 84500 орчим өрх байжээ /43.358-359/. Хар Хятан улс нь монгол угсааны аймгуудын үүсгэн байгуулсан Хятан улсын уламжлалыг залган Дундат Азид тогтож байсан төр, улс юм. 1160-аад оны үед тус улсын өмнөд тал нь Каракурмын нуруу, баруун тал нь Арал нуурт дөхөж, хойд хэсэг нь Балхаш нуурын зүүн хойд талаас Эрчис мөрний дунд урсгалд хүрч байжээ /43.370/. Хар Хятаны нийслэл Хос-орд хот нь Чуй мөрний доод урсгалын өмнө эрэгт байжээ. Хар Хятан улс XIII зууны эхэн хүртэл 100 шахам жил оршин тогтнож, Дорнод Туркстан, Дундат Азийн түүхэнд өөрийн ул мөрөө үлдээсэн улс юм. Хар Хятан улс мал аж ахуй, газар тариалан эрхлэнэ. Газар тариалан нэлээд хөгжсөн улс юм. Үүнд газар нь үржил шимтэй, тариаланд тохиромжтой, суваг шуудуу татаж, тариа ногоо тарьж агсан уламжлалтай байсан нь ихээхэн нөлөөлсөн бололтой.

Үүнтэй холбоотойгоор хот, суурин олноор байгуулагдаж байжээ.

Хар Хятаны тариаланчид өндөр албан татвар төлдөг байв. Тариачид нь тарьсан тариа, ногооныхоо гуравны нэгийг албан татварт төлдөг /43-370/ байсан нь үүнийг нотолно. Хар Хятанд, татвар төлөх нэгж нь өрх байсан аж. Хот, хөдөө ялгалгүй өрх бүрээс 1 динар /алтан зоос/ татварлан хураадаг байжээ.

Хар Хятан улсын төрийн байгуулалт нь Хятан улсынхтай их адилхан байсныг сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг. Хар Хятаны хааны өргөмжлөл, оны цол, эрх үүрэг, түшмэдийн зэрэг, цол, засаг захиргааны хуваарь зэрэг олон зүйлийг Хятан гүрнээс уламжлан авч хэрэглэсэн байна. Хар Хятан нь улсаа Хятаны адилаар өмнөд, умард гэсэн хоёр хэсэгт хувааж, язгууртан ноёноор захируулж байжээ. Харьяат улс орныг дотор нь шууд харьяат орон, хараат орон гэж хоёр ялган, тэдгээрийг хааны томилсон тусгай төлөөний түшмэлээр дамжуулан захирч байв.

Энэхүү төлөөний түшмэл нь татварыг тогтоосон цагт нь хураах, тухайн улс орны улс төрийн байдлыг хянах, тогтвортой, тайван байлгах үүрэгтэй байсан ажээ. Хар Хятанд дагаж орсон хүн /ван/ бүр хараат болохыг нь харуулсан мөнгөн тэмдэг зүүдэг байжээ. Хар Хятаны Гүр хааны тухай сурвалж бичигт “Гүр хаан өөрийн дагуулсан улс орныхоо засаг захиргааны байгуулалтанд төдий л гар хүрдэггүй. Хүн ардаас татвар авах нь бага, харьяат улсын ван нарт хандахдаа энэрэнгүй” /43.370/ байсныг дурдсан нь Хар Хятан улсын төрийн бодлогын аядуу, зөөлөн шинжийн илэрхийлэл байсан бололтой.



ТЭРГҮҮН АНГИЙН ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. “Монгол улсын төр, эрх зүйн түүх”-Монгол Улсад төр ба үндэсний эрх зүй үүсч хөгжсөн түүх бол төр, ба эрх зүй нь ямар онцлог, бүтэц агуулага, ач холбогдолтойгоор, хөгжлийн ямар үе шатуудыг туулан, хэрхэн хөгжиж ирсэний түүх мөн. Монгол улсын төр, эрх зүйн түүх нь монголын нутаг дэвсгэр дээр анхны улс-Хүннү улс байгуулагдсан цагаас өдгөө хүртэл Монгол үндэсний төр ба эрх зүй үүсэн хөгжсөн уламжлал, зүй тогтол, үйл явцыг бүхэлд нь илтгэн харуулна. Монгол Улсын төр эрх зүйн түүх 2200 гаруй жилийн буурал түүхийг илээсэн үлэмж баялаг агуулга, уламжлалтай бөлгөө.

Энэ түүхийг бүхэлд нь багтаасан эрдэм шинжилгээ, судалгааны тулгуур зохиол хараахан гараагүй боловч хоёр бүтээлийг онцлон дурдаж болно. Нэгдэх нь БНМАУ-ын шүүхийн 10 жилийн ойг тохиолдуулан 1936 онд Л.Дэндэв нарын бэлтгэж хэвлүүлсэн “Монголын хууль цаазын эрт эдүгээгийн түүхийн сэдэвчилсэн дэвтэр” хэмээх уйгуржин монгол бичгээр хэвлэгдсэн ном болно. Энэ номонд МЭӨ III зуун буюу 209 онд байгуулагдсан Хүннүгийн эрх зүй бий болсон цагаас 1936 он хүртэл Монгол Улсын эрх зүй хэрхэн хөгжиж ирсэнийг товч тоймлон өгүүлснээрээ монголын хууль цаазын түүхийн анхны ном гэж үзэж болно. Хоёрдахь бүтээл нь Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын 1997 онд хэвлүүлсэн “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” гэсэн ном мөн. Энэ томоохон бүтээл нь монгол Улсын төр, эрх зүй хэрхэн үүсэн хөгжиж ирснийг бүхэлд нь багтаасан, монголын төр, эрх зүйн түүх /нэгэн боть/ мөн юм.

2. “Монгол угсаатны өвөг дээдэс”- МЭӨ ХIY зууны үеэс Хятадын Инь улсын үед хятадын сурвалж бичигт Хүннү хэмээх нэр анх Гуйфан, Сяньюнь, нохой жун, умард ди гэх зэрэг нэрээр тэмдэглэгдэн түүхийн тайзнаа гарч иржээ. Эдгээр аймгуудаас эртний хятадууд умард Ди нарыг Хан Юнь, Ханьюй, Гүй гэх зэргээр нэрлэсний доторхи Хянь, Хунь, Гүй гэх үгс нь Хун, Ху хэмээн дуудагдсаар цаашид Ху, Хун, Хүннү хэмээн дуудагдах болж, улмаар монгол угсаатан аймгуудыг ийнхүү нэрлэдэг болсон байна.

Хүннү нарын судалгаанаас үзэхэд Энэтхэг, Америк, Түрэг болон Европын олонхи улс оронд “Хүннү” нарыг “Ху” гэж нэрлэж иржээ. Харин Хятад, Монгол, Орос зэрэг оронд “Хүннү” нарыг Хүннү, Сюннү, Хүннү-Сюннү гэж нэрлэх уламжлал тогтсон /43.186-187/ байна. Төмөр зэвсгийн үед Хүннү нар 24 аймаг болон хуваагдаж тус тусдаа аж төрөх болсноор Хүннүгийн бие даасан түүх эхэлж, МЭӨ 209 он болоход эдгээр аймгууд нэгдэж нэгдмэл улсыг байгуулсан нь тонгол угсаатны эртний анхны улс байжээ.

3. *“Монголын эртний улсууд”*- МЭӨ 209 оноос МЭ 1125 онд Монгол нутагт Хүннү, Сяньби, Тоба, Муюн, Тогоон, Жужан, Түрэг, Уйгур, Хиргис, Хятан, Хар Хятан улсууд оршин тогтнож байсан юм. Дээрх улсууд нь монгол ба монгол бус угсаатны байгуулсан улсууд бөгөөд эдгээрийг нийтэд нь монголын эртний улсууд гэж нэрлэдэг.

Эртний улс тус бүр нь монгол ба монгол бус угсаатны харъяалан захирч, монгол нутагт оршин тогтнож байсан хаант улсууд байжээ Улс тус бүр Монгол Улсын түүх, монгол орны соёл иргэншилд түүхэн ул мөрөө үлдээж, монголын төрт ёсны үндэс суурь, өв уламжлалыг шингээж байсан онцлогтой болой.

4. *“Түрүү феодализм”*- Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын /МЭӨ II-МЭ XII зуун/ хөгжлийн түвшинг түүхийн шинжлэх ухааны үүднээс түрүү феодалын улсууд хэмээн ерөнхийд нь томъёолон тодорхойлдог.

Түрүү феодалын улс нь /Хүннү, Сяньби, Тоба, Муюн, Тогоон, Жужан, Түрэг, Уйгур, Хиргис, Хятан/ хөгжлийнхөө хандлага, агуулгаар феодализмд эргэлтгүй шилжиж буй боловч феодализм бүрэн тогтож арай чадаагүй байгааг илэрхийлэн харуулдаг. Үүнийг Түрүү феодализм гэж томъёолдог бөгөөд энэ нь Монгол оронд үүсэн тогтож байсан нүүдлийн соёл иргэншилтэй ард түмэн, түүний нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, зан заншлын онцлогийг тусган харуулдаг бөлгөө.

Хүннү, Сяньби, Жужан, Хамаг Монгол Улсуудын түүхийг олон жилийн турш судалсан нэрт түүхч Г.Сүхбаатар “Хүннү, Сяньби, Жужан зэрэг этний нүүдэлчдийн түүхэн хөгжлийг нягтлахад түрүү феодализм монгол нутагт мянга гаруй жил үргэлжилэн хөгжиж, дөнгөж XIII зууны эхэнд дууссан байна” /69-90/ гэсэн дүгнэлт хийсэн байна.

5. *“Монголын нууц товчоо”*- 1240 онд туурвигдсан энэ алдарт бүтээл нь монголчуудын удам угсаа, овог аймгийн түүхийг монгол мэлмийгээр нь тодорхойлон бичиглэснийхээ хувьд монголын эртний улсуудын түүхийн хамгийн эхний бөгөөд бас хамгийн яруу сайхнаар үзүүлэн үлдээсэн бичигдэл сурвалж бичиг мөн.

Монголын нууц товчоо өвөг дээдэс, Монгол овог, аймгийн монгол нутагт эрт үед оршиж байсан улсуудын түүхийг хамгийн бодитой харах нэгэн ёсны алдарт толь бичиг хэмээн баттай хэлж болно.

Монголын эртний улсуудын түүх, монгол угсаатны гарвал үүслийг судалсан үе үеийн бүх эрдэм номтой хүмүүс, судлаачид Монголын нууц товчоог судалж, түүнээс иш татаж, түүнийг түүхэн үнэтэй, яндашгүй баялаг, монголын ард түмний оюун ухааны асар том бүтээл, түүх, соёл, утга зохиол, ёс заншлын аугаа их эх сурвалж гэж үздэг болно. Монголын нууц товчоо нь монголын төр, хууль цааз, түүний сэтгэлгээ, төр ёсны юугаар ч үл солигдох дурсгалт бичиг мөн билээ.

Монголын нууц товчооны 282 зүйлийн 200 гаруй зүйл нь төр, хууль цааз, төр ёстой холбоотой баримт, мэдээллийг ямар нэг хэмжээгээр агуулж байдаг нь үүний нотолгоо мөн.

Монголын бичгийн их хүн Ц.Дамдинсүрэн, хятад, орос, герман, иран оронд хэвлэгдсэн нууц товчоонд холбогдох эх бичгүүдийг ашиглан хуучин монгол хэлнээс монгол бичгийн хэлээр хөрвүүлэн 1990 онд хэвлүүлсэн нь дөрөв дэх удаагийнх нь хэвлэл байв. Өдгөө 2000 онд Академич Д.Цэрэнсодном зэрэг судлаачид “Монголын нууц товчоо” /орчин цагийн монгол хэлний орчуулга/ гэсэн шинэлэг том бүтээл гаргасан байна.

6. “Судрын чуулган”- Зохиол бол 1300-1310 онд перс хэлээр бичигдсэн 3 боть түүхэн бүтээл болно. Түүнийг зохиогч Перс /Одоогийн Иран/-ны их түүхч, төрийн сайд, эмч Рашид-ад-Дин /1247-1318/ юм. Тэрбээр Персэд байгуулсан монголын Ил хаант улсын ҮП хаан Хазан /1295-1304/-ы үед төрийн сайдаар 19 жил ажилласан төрийн нэрт зүтгэлтэн, перс, араб хэлийг нэвтэрхий сайн мэддэг хүн байжээ. 1318 оны 7-р сарын 18-нд хилээр цаазлагдаж, 1327 онд цагаатгагдсан.

Энэ алдарт түүхч “Судрын чуулган” хэмээх 3 боть зохиолыг хааны архив, түүх, соёлын үнэт өвүүдийг ашиглан бичиж, монголчууд, түрэг хийгээд ази, европын соёлын түүхнээ их гавъяат үйлс бүтээн мөнхөрсөн бөлгөө. “Судрын чуулган” 3 боть зохиолд Монгол, Түрэг аймгуудын гарал үүсэл, түүх, Добу баянаас Чингис хаан болон Өгөдэй, Гүюг, Мөнх, Хубилай, Төмөр, Хүлэгү /Хулагу/, Абага, Ахмед, Аригун, Хасан зэрэг хаад, тэдгээрийн удам угсаа, төр, хууль цаазын тухай тэр үеийнх нь бодит баримт, мэдээлэлд түшиглэн өгүүлсэн нь үнэнхүү аугаа их үнэтэйг мартагын аргагүй. Монголын эртний ба дундад үеийн түүхийг бичихэд энэ алдарт зохиолыг судалж ашиглах нь зайлшгүй түүхэн үнэн гэж үзвэл зохилтой. Энэ утгаараа Судрын чуулган нь Монгол улсын төр, эрх зүйн түүхийн судалгааны тулгуур бүтээлийн тоонд зүй ёсоор багтана. “Судрын чуулган” 3 боть зохиол нь орос, англи хэлээр орчуулагдан хэвлэгджээ. Харин монгол хэлээр /кириллээр/ эрдэмтэн Ц.Сүрэнхорлоо түүхч орос хэлнээс орчуулан 1994 онд хэвлүүлж, ухааны ариун буян үйлдсэнд гүнээ талархах ёстой ажгуу.

7. “Алтан дэвтэр”- Эртний монгол хэлээр бичсэн, Чингис хааны өвөг дээдэс, удам угсааны түүх буюу Чингисийн алтан ургийн түүхийн тухай бүтээл, “Алтан дэвтэр” гэдэг нэгэн сонирхолтой монгол түүхийн зохиол Перс дэх монгол хаадын сан хөмрөгт хадгалагдаж, түүнийг Рашид-ад-Дин “Судрын чуулган” алдарт 3 боть зохиолоо бичихдээ ашигласан бололтой хэмээн сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдэд гэмдэглэсэн байдаг бөлгөө. “Алтан товч” зохиол өдгөө хүртэл жинхэнэ эхээрээ олддоогүй боловч түүний гол зүйл нь “Судрын чуулган”-нд орж хадгалагдсан гэж судлаачид үздэг.

8. *“Монгол Улсын түүх”*- Ийм нэрээр “Монгол Улсын түүх” хэмээх улсын түүхийн тулгуур зохиолууд хэвлэгдэн гарсан нь Монгол Улсын түүхийн судалгаа шинжилгээний үндсэн эх сурвалжид хамаарах гол бүтээлүүд болно. Нэрт түүхч, эх бичиг сайн мэддэг Ч.Бат-Очир “Монгол Улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг” хэмээх нэгэн сэдэвт зохиолыг бичиж 1928 онд хэвлүүлсэн нь монголын төрт ёсны уламжлалын түүхийг хураангуйлан дүгнэж бичсэн анхны бүтээл байсан юм. Дараа нь А.Амар “Монголын товч түүх”-ийг худам монгол бичгээр бичиж 1934 онд хэвлүүлсэн нь энэ цаг үе хүртэлх Монгол Улсын түүхийг бүхэлд нь багтаасан том бүтээл болсон байна. Энэ зохиол нэн ховордсоны дээр тэр бүр хүн худам монгол бичгээр уншиж чадахгүй байсан тул 1991 онд кирилл үсгээр хэвлүүлэн гаргажээ. Энэ ном монголын түүхийг үнэн бодит байдлаар нь мэдэхэд ихэд тусыг хүргэсэн болой. Мөн Л.Дэндэвийн 1934 онд хэвлүүлсэн “Монголын түүх” үүнд бас хамаарна. Хамгийн сүүлд Монгол Улсын ШУА-ийн санаачлага, Монгол Улсын ерөнхийлөгчийн ивээлээр Монголын түүхч, археологичдын бичсэн хамтын бүтээл “Монгол Улсын түүх” 5 боть зохиол 2003 онд хэвлэгдэн гарлаа. Энэ 5 боть зохиол нь монгол орон ардчилал, зах зээлд шилжин орсон үеийн монгол улсын түүхийн бүтээл мөнөөрөө онцлог юм. Монгол Улсын түүх нэрээр хэвлэгдсэн дээр дурдсан зохиолууд нь Монгол улсын төр, эрх зүйн түүхийг боловсруулахад зайлшгүй харгалзагдах тулгуур зохиол, үе үеийнхний хамтын оюуныг шингээсэн түүх, соёлын тулгуур сурвалж бүтээлүүд болно.

9. *“БНМАУ-ын түүх”*- Улсын түүхийн ийм нэртэй зохиолууд 1954-1969 онд монгол хэлээр, 1983, 1984 онд орос хэлээр хэвлэгдэж байсан түүхтэй. Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн хамтран бичсэн анхны түүх “БНМАУ-ын түүх” /нэгэн боть/ зохиол 1954 онд Монгол, Орос хэлээр хэвлэгджээ. Монголын түүхчдийн дагнан бичсэн түүх “БНМАУ-ын түүх” тэргүүн боть 1966 онд, дэд боть 1968 онд, гутгаар боть 1969 онд монгол хэлээр тус тус хэвлэгдсэн байна. Дээр дурдсан улсын түүх нь монгол Улсын түүхийг бүхэлд нь хамарч, тэр цаг үеийн түүхэн зохиол, баримт бичиг, түүх, археологи, соёлын материалд түшиглэсэн, судалгааны үлэмж их мэдээллийг агуулж байгаараа монгол улсын төр, эрх зүйн түүхийг боловсруулахад эх сурвалж болж ашиглагдах шинжлэх ухааны чухал ач холбогдолтой бөлгөө.

10. *“Хүннү судлал”*- Монголын эртний улсуудын дотроос “Хүннү судлал” хамгийн их хөгжин, үлэмж өндөр түвшинд хүрчээ. Энэ нь Хүннүгийн өөрийнх нь монгол нутагт төдийгүй дэлхийн тайзанд эзэлж байсан байр суурь, гүйцэтгэж байсан үүрэг рольтой холбоотой. Хүннүчүүд Төв Ази, монгол нутагт төдийгүй, Хятад, Энэтхэг, Иран, Дундат Ази, Орос, Түрэг, Унгар, Герман, Дорнод ба Өрнөд Европын зарим орнуудад тархан оршиж, монгол нутагт төвлөрсөн Хүннү гүрэн, Европоор

төвлөрүүлсэн Атилла хааны Хүннү гүрэн байгуулагдаж соёл иргэншлийн гүн ул мөрөө үлдээж байсан түүхтэй. Ийм ч учраас Хүннү судлал дэлхийг хамран хөгжиж, түүнд олон улс орны үе үеийн эрдэмтэн мэргэд хүчээ сорьж олон бүтээлүүд хэвлэгдэн гарч /64-14/, өдгөө ч судлагдсаар, үр дүн нь улам бүр арвижсаар байгаа бөлгөө. Хүннү судлалаар нэрд гарч хамгийн их хувь нэмэр оруулсан хүмүүсийн тоонд юуны өмнө Хятадын Ма Чан-Шоу, Оросын Н.Бичурин, Н.В.Кюннер, В.Таскин, П.И.Коновалов, К.Иностранцев, А.Бернштам, Л.Н.Гумилев, Америкийн Жорж Вернадский, О.Мэнчен-Хельфэн, Ираны О.Голл, Энэтхэгийн У.Такур, Японы Сиратори, Монголын Г.Сүхбаатар, Ц.Доржсүрэн зэрэг олон нэрт судлаач ордог бөлгөө. “Хүннү судлал”-ын хөгжил монголын эртний бусад улсуудын судлал хийгээд Монгол Улсын түүх судлалд асар их ач холбогдол үзүүлсэн ажээ.

11. “Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй”- Нүүдлийн соёл иргэншилтэй улс орны ард түмний мал аж ахуйг эрхэлдэг хэлбэрийг сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй хэмээн томъёолдог. Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй болох хамгийн гол шинж нь таван хошуу мал /хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ/-г ус, бэлчээр, хужир, шүү, байгалийн зохицлыг даган жилийн 4 улирлын турш нүүдэллэн малладаг явдал мөн. Доктор Г.Сүхбаатар “Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэдэг нь тухайн байгаль-газар зүйн өвөрмөц нөхцөлд таван төрлийн малыг маллагааны нарийн технологийн үндсэн дээр үржүүлж, аж ахуйн үндсэн салбар болгон, аж ахуйн талаар цогцолбороор ашиглаж, ан, багахан тариаланг туслах аж ахуйн байдлаар ашигладаг нүүдлийн мал аж ахуй” /64.215/ мөн гэж тодорхойлжээ.

Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй нь нэг талаар гол эрхлэх аж ахуй болох малаа, нөгөө талаар малаа даган амьдарч аж төрдөг хүнээ хослуулан хамарч улмаар энэ хоёр талынхаа харилцан салшгүй холбоо, хосломол үйлсээр амьдран хэрэгждэг маш нарийн нандин, цогц шинжийг агуулсан ойлголт болой.

Хүннү улсад аж ахуй нь сонгодог хэлбэрийн мал аж ахуйн шатанд бүрэн орсон байсан хэмээн эрдэмтэд дүгнэсэн байдаг бөлгөө.

12. “Хүннү бичиг үсэг”- Хүннү улс бичиг үсэгтэй байв. Бичигтэй байсан үн дэслэлийг Ч.Далай нэгдүгээрт, Хүннүгийн нийгэм онолын хувьд бичиг үсэг хэрэглэх шатанд хүрсэн, хоёрдугаарт, Хүннү нар гадаад харилцаа ба дотоодын нийгмийн хэрэгцээнд ямар нэг бичиг хэрэглэж байсан, гурвдугаарт, Модун Шаньюйгаас эхлээд Хятадын хаадад захидал илгээж байсан, дөрөвдүгээрт, Хүннүд дагаж орсон Чжунхан Юэ хүн ам, мал хөрөнгийг тоолон гувчуур авах бүртгэл хөтлөхөд шаньюйн шадар хүмүүсийг сургаж байсан, тавдугаарт, МЭ 46 онд Хятадад Хүннүгийн газрын зургийг өгч байснаар /64.112/ нотолсон. Хятадын сурвалж бичигт Хүннү нар бичиг үсэгтэй байсан хэмээн тэмдэглэсэн байдаг.

Хятадын Фэн Цзя Шэн, Ма-чан-Шоу зэрэг хүннү судлаачид Хүннү нар бичиг хэрэглэж байсан /64.113/ гэж бичсэн байдаг. Хүннү нар Дундат Азид хэрэглэгдэж байсан бичгийн аль нэг, Армей бичиг, Согд бичиг, орхон Енисейн бичиг хэрэглэж байсан гэж Е.Блоше, Б.Г.Гафуров, С.В.Киселев, А.Лувсандэндэв, Г.Сүхбаатар, Л.Н.Гумилев зэрэг олон эрдэмтэд нотлон өгүүлсэн нь бий. Хүннү судлаачдын дийлэнх нь тус улс өөрийн бичиг үсэгтэй байсан гэж нэгдмэл дүгнэлтэд хүрсэн байдаг бөлгөө.

13. “Умард Хүннү”- МЭӨ 55 онд Хүннү гүрэн 2 хэсэгт хуваагдсаны нэг нь Умард Хүннү юм. Умард Хүннүгийн ихэнх нь Сяньби улсын захиргаанд орж, үндсэн хэсэг нь МЭ 155 онд Өрнө зүг нүүдэллэж эхэлжээ. Тэд Орос, Дундат Азиар дамжин, Европод хүрч МЭ IY зууны дунд үеэс Хүн буюу Гунну нэрээр түүхэнд тэмдэглэгдэн гарч иржээ. Хүннү нүүдэлчид өсөн хөгжиж, бусад нүүдэлчин ард түмнийг эзэмшиж, герман, татар, славян, скиф болон бусад нүүдэлчин ард түмнийг харъяалан захирч байжээ. /49.40/. Хүннү улс Ром, Византын эзэнт улсыг хараат байдалд оруулж, “Өрнөд”-ийн ард түмний нийтлэг бүрэлдэн бий болоход түүхэн үүрэг гүйцэтгэжээ.

14. “Атилла”- Европоор төвлөсөн Хүннү гүрний их хаан /445.453/. Атилла хаан МЭ 406 онд Хүннүгийн хаан ургийн сурвалжит язгууртан Мунзукийн гэрт, Ижил мөрний хөвөөнд төржээ. 445 онд ах Бледагаа хөнөөж, Хүннүг ганцаар захирах болсон.

Атилла 434-447 онд Хүннүчүүдийг бүрэн нэгтгэж, варварууд хэмээн нэрлэгдэж байсан ард түмнүүдийг захиргаандаа оруулан, Баруун, Зүүн Ромыг вассаллаа болгожээ. Атилла нутаг дэвсгэрийн хэмжээгээр Чингис хаан, түүний хөвгүүд, ач нарын байгуулсан Монголын их гүрний дараа орохуйц их гүрнийг тэднээс зургаан зуун жилийн өмнө Европоор төвлөрүүлэн байгуулжээ /49-15/. Атилла Европын ард түмнийг Хүннү нарын манлайлал дор нэгтгэж, түүхийн аугаа их хаадын нэгэн болсон ажээ. Тэрбээр Европчуудыг захирсан цорын ганц харь угсаатан нүүдэлчин, монголчуудын өвөг дээдсийн удмын Хүннү хаан байсан /49-70/ ажээ.

Атилла өөрөө аугаа их мөртлөө, асар энгийн, омог бардам, үнэнч шударга хүнийг хүндэлдэг. Догшин, хурц ширүүн ч энэрэнгүй зөөлөн, үндэс угсаа, шашин шүтлэгээр нь ялгаварлаж үздэггүй, холч ухаантай хаан байсан ажгуу.

15. “Торгон зам”- Хятадаас Европод, Европоос өмнөдөд тусгай маршрут бүхий газруудаар аялан явж худалдаа хийдэг замыг “торгоны зам” хэмээнэ. Ерөнхийдөө ХҮИ зуунаас өмнө Хятад, Монголоос өрнө дахин хүрэх худалдааны их замыг “торгоны зам” гэж нэрлэдэг /64.52/ байсан байна. Торгон замыг бас жингийн зам хэмээн нэрлэх нь ч бий. Торгон замаар “хойт хятад, хүннү нарт бага азийн ба эртний Грек Ромын бөс бараа нэвтрэх боломжтой” /131.110/ байжээ. Эл зам МЭӨ I зуун хүртэл зөвхөн Хүннү улсын мэдэлд байсныг Хүннүгийн тухай зохиолд өгүүлсэн байдаг /64.52/.

Ийнхүү монгол нутагт оршин байсан Хүннү улсаас эхлээд монголын эртний бүх улсууд болон Их монгол улс, Юан гүрний үед торгоны зам нь монгол нутгийг дорно, өрнө дахинтай холбосон худалдааны гол зам байж, монгол улсын төрийн бодлогын түвшинд ямагт тавигдаж ирсэн ажээ.

Монголчууд мал аж ахуйнхаа бүтээгдэхүүн, түүхий эд, ангийн үс, гар урлал, гоёл чимэглэлийн зүйлсээ өрнө, дорны улс орнуудад явж худалдан оронд нь гурил будаа, чихэр жимс, гэр ахуйн хэрэгсэл, сав суулга, торго, бөс бараа сэлтийг авчирч хэрэгцээгээ хангадаг байсан тул торгоны зам тэдний амьдралд асар их ач холбогдолтой байсан ажээ.

16. “Шаньюй”- Хүннү улсын хаан. Хүннү улсын хааныг шаньюй гэнэ. Шаньюйг дуудахдаа “Чэнли Гуту шаньюй” хэмээнэ. Үүний “шаньюй” нь “өргөн уудам”, “Чэнли Гуту” нь “Тэнгэрийн хүү” гэсэн утгатай. Бөө мөргөл шүтдэг Хүннүчүүд өөрийнхөө толгойлогчийг тэнгэрээс заяасан хэмээн биширч “Тэнгэрийн хүү” гэж нэр сүрийг нь өргөн дээдэлсэн буй зээ. “шаньюй” гэдгийг бас “тамган”, “дархан”, “явгу”, “тахан”, “удирдагч”, “сайн”, “хаан” гэх зэргээр олон эрдэмтэд янз бүрээр тайлсаны дотор “хаан” гэсэн утга нь монгол улбаатай болохыг дэмжсэн нь илэрхий байдаг.

“Шаньюй” гэдэг үг Сяньби, Ухуань аймагт хэрэглэгдэж байснаа цаашид “хаан” гэсэн утгаар хэвшин хэрэглэгдсэн байж болох магадлалтай. Жужан улс төрийн тэргүүнээ “хаан” хэмээн шууд нэрлэж байсныг бодууштай. Их Монгол Улс Чингисийг “хаан” хэмээн өргөмжилж “Чингис хаан” гэж дууддаг байсан билээ.

17. “Хаш тамга”- Хүннү улсын төрийн /шаньюйгийн/ тамга. Хүннү улсын туурга тусгаар, бие даасан улс болохын нэгэн бэлэгдэл. Хаш тамгыг шаньюйгийн улсыг /төрийг/ төлөөлөн гаргасан бүх шийдвэр, баримт бичиг, гэрээнд дарсанаар Хүннү улс мөнийг гэрчлэн баталж байжээ.

Дорно дахины улс гүрэнд төрийн хамгийн дээд хууль ёсны баталгаа нь тамга бөгөөд монголд ч мөн тийм байв хэмээн билгүүн доктор Д.Гонгор нотлон өгүүлсэн байдаг. Хүннү улс энэ уламжлалыг сахин төрийнхөө бат бэх, ариун нандин чанарыг билэгшээн, хаш чулуугаар тамгаа хийж хэрэглэсэн ч байж болох. Эрдэмтэд Хүннүгийн Шаньюй нь төрийн бүрэн эрхт байдлын бэлэгдэл болсон хаш тамгатай байсан /134.84/ ажээ.

Умард Хүннүгийн шаньюйд МЭ 90 онд хаш тамгатай байсан /134.84/-ыг нотлон өгүүлсэн байдаг. Хүннү улсын хаш чулуугаар тамга хийж байсан уламжлалыг Монгол нутагт оршин тогтнож байсан бусад улсууд хийгээд Чингис хаанаас Лигдэн хаан хүртэлх хаад 430-аад жил өвлөж байсан түүхтэй. Монгол улс 1911 онд тусгаар тогтнолоо сэргээн мандуулснаас хойш ч төрийн тамгаа хаш чулуугаар хийдэг ёс уламжлагдсаар байгаа бөлгөө.

18. “Эвэртэн түшмэл”- Хүннү улсын түшмэдийн тогтолцооны эхний хамгийн өндөр албан тушаал, эрх ямба, хангамж эдэлдэг 10 түшмэлийг хэлнэ. Эдгээр түшмэл нь толгой дээрээ тусгайлан бэлтгэсэн эвэр зүүдэг учир “эвэртэн түшмэл” хэмээн нэрлэгддэг байжээ. Хүннүгийн зүүн, баруун сэцэн ван, зүүн, баруун гуливан, зүүн, баруун их жанжин, зүүн, баруун их дувэй, зүүн баруун их данху хэмээх албан тушаалтай 10 түшмэл эвэр зүүх эрхтэй байв. Эвэртэн түшмэдүүд нь шаньюйгийн овог, угсааныхан бөгөөд бүгд хамгийн өндөр албан тушаалд ажиллаж, мөн хамгийн том газар нутаг эзэмшиж, түмэн морьт цэрэг захирч байжээ.

19. “Сяньби”- Хүннүтэй нэгэн угсаатан аймаг. Сяньби нь Хүннүтэй бараг нэгэн зэрэг түүхийн тайзнаа нэрд гарч, Хүннү улсыг мөхөөн, олон овог аймгийг нэгтгэж Сяньби нэртэй улс байгуулж, Төв Азийн түүхнээ их нөлөөтэй байсан Монгол угсааны нүүдэлчин том аймаг юм. Сяньби гэдэг нэр аажмаар Шивэй хэмээх аймгуудын нэр болж, хожим нь өөрийн эмхлэн байгуулсан монгол угсааны улсаа Сяньби гэж нэрлэсэн гэдэг. Эрдэмтдийн судалгаагаар Хятад сурвалжид Сюинби, Шиби, Сиба, Сяньби хэмээн тэмдэглэн үлдээсэн байдаг /43.256/. “Сянь” гэдэг нь өчүүхэн, “би” гэдэг нь бүдүүлэг гэсэн утгатай гэж тайлсан нь бий /63.81/.

Бас Хятадын Цинь улс цагаан хэрэм барих үед ялтан хүмүүс хэрмээ даван оргож, Сяньби ууланд очсон тул ийм нэртэй болсон гэсэн домог байдаг /63.81/. Мөн зарим судлаачид алтан гархи /арал/-тай бүс бүсэлдэг байсан учир Сяньби гэж нэрлэсэн гэж үздэг /63.82/. Ямар боловч нэгэн монгол угсаатан аймаг нэгдмэл улс байгуулж Сяньби нэрээр түүхнээ алдаршсан болой.

20. “Таньшихуай”- Сяньби улсыг үндэслэн байгуулсан анхны хаан. Тэрбээр 141 онд Сяньбийн зүүн этгээдийн цэргийн жанжины гэрт төржээ. Биеэр том, бяраа чадал ихтэй, оюун билэг төгөлдөр, эрэмгий зоригтой эр болон өсөж /43.249/ улс толгойлох ухаан чадвараа олон удаа харуулсан, цэргийн эрдэмд гарамгай хүн байсан гэдэг. 156 онд Сяньбийн овог, аймгуудын ахлагч, зонхилогчдын хуралдаанаар хаанд өргөмжлөгдөж, 25 жил төр барьсан Монголын эртний улсуудын нэгэн хүчирхэг хаан байжээ. Түүний төр барих арга ухаан дараа дараачийн хаадад ч үлгэр дууриал болсон түүхтэй бөлгөө.

21. “Бидэчжэнь”- Сяньби, Тоба, Жужан улсад төрийн ийм албан тушаалтан ажиллаж байжээ /63.120/. Төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн асуудлыг эрхэлсэн сайд /түшмэл/-ийг “Бидэчжэнь” гэж нэрлэдэг байжээ.

22. “Муюн”- Хянганы нурууны баруун хэсэгт оршин байсан Монгол угсааны нүүдэлчин аймаг. Муюн аймгийн хэл, соёл, шашин шүтлэг, зан заншил нь Хүннүтэй бараг адил. Муюн нь Сяньбитай төрөл угсааны өвөг монгол хэлтэн. Муюн нь Сяньбитэй ойр холбоотой, хамтарч ажилладаг аймаг байжээ.

Муюн аймгийн толгойлогч Муюнхой 294 онд Муюн улсыг байгуулж, аймгийнхаа нэрээр “Муюн” гэж нэрлэсэн байдаг. Харин Хятадын Янь улс, түүний харьяаны Монголын зүүн хэсэг, Хятадын зүүн хойт хэсгийн газар нутгийг эзэлсний дараа “Муюн Янь улс”, “Хожуу Янь улс” гэж нэрлэгдэх болсон ажээ.

Муюн улс 410 онд мөхсөнөөр, Муюн аймгийн уугуул хүмүүс нь бусад улсын бүрэлдэхүүнд багтан орсон байна.

23. “Тоба”- Тоба хэмээх аймаг ба улсын нэр. Монголын түүхэнд Тоба нарыг “табгач” гэж нэрлэсэн нь бий. Тобаг арабчууд “тамгаж”, византичууд “таугас” гэж тэмдэглэсэн байдгаас үзэхэд Тоба нарыг “табгач” хэмээх түрэг нэр болохыг нотолж байна гэж эрдэмтэд үздэг /43.249/. Эрдэмтэн А.Будберг, Г.Сүхбаатар нар “Тоба” гэдэг үгийг “дабага-даваа, гүвээ, дов гэсэн” монгол үг хэмээн тайлсан нь байна /63.92/. Уул нуруу, даваа, гүвээгээр нутагладагаас нь үндэслэн эл нүүдэлчин аймгийг “Тоба” гэж нэрлэсэн байхыг үгүйсгэхгүй. Гэсэн ч шинжлэх ухаан, монголын түүхэнд эл аймаг, улсыг “Тоба” гэсэн нэрээр нь тэмдэглэсээр иржээ. Тоба бол Сяньбитай төрөл нэг монгол угсаатан аймаг болно.

24. “Ухуань”- Хүннү, Сяньби улсын бүрэлдэхүүнд багтаж байсан монгол угсааны аймаг. Сяньби улсын оршин тогтнохуйн төгсгөлөөр бие даан гарч ирж, том, хүчирхэг байгаагүй ч түүхэн ул мөрөө үлдээсэн аймаг болно.

Ухуань аймаг нь Хүннү, Сяньби нартай хамтран Хятад руу удаа дараа довтлохын хамт, мөн эргээд Хүннү, Сяньбийн эсрэг тэмцэж, тэмцэлдсээр ирсэн өвөрмөц түүхтэй. Ухуань аймаг өөрийн толгойлогч болсон Кюлигюй, 188 онд толгойлогч болсон Датунь нарын үед нэлээд хүчирхэг болж бие даан оршиж байжээ.

25. “Түгүхүн”- Ш зууны дунд үед амьдарч байсан Муюн улсын Шэгүй хааны хүү. Тэрээр өөрийн эцгээс өгсөн 1700 Муюн, Сяньби өрхийг газар нутгийн нь хамт эзэмшиж байгаад дүүтэйгээ муудалцсаны улмаас баруун зүг нүүж, IY зууны эхээр Хөх нуурын орчим нутаглан, тэндэхийн Тангуд аймгуудыг эзлэн захирч байжээ. Эл үеэс түүний харьяаны Сяньби, Муюн зэрэг бүх хүмүүс бүгд Түгүхүнчүүд гэж нэрлэгдэн улс нь Түгүхүний улс болж анхны монгол угсааны хаан нь Түгүхүн болсон ажгуу.

26. “Тогоон”- Түгүхүний улсын хөгжлийнхээ явцад алдаршсан нэр.

Өөрөөр хэлбэл Түгүхүний улс нь Тогоон улс хэмээн алдаршсан гэсэн хэрэг юм. Сурвалж бичгээс үзэхэд Түгүхүний улс нь нутгийн хэл аялга, хожмын Тангуд, Түвд судрын мэдээгээр дамжин Тогоон улс хэмээн алдаршжээ /43.269/.

Иймээс Түгүхүн гэдэг хүний үндэслэн байгуулсан улс нь Түгүхүний улс гэж нэрлэгдэж байснаа хөгжлийн явцад энэ нэр нь “Тогоон улс” болж өөрчлөгдөн нэрлэгдсэн байна. Тэгэхлээр Түгүхүний улс, Тогоон улс гэдэг бол нэг л улсыг хэлж буй юм.

Тогоон улс нь зүүн талаараа Тоба Вэй, Хятадтай, Баруун талаараа Хотантай хиллэн оршиж байсан хаант засагтай монгол угсааны улс байжээ.

27. “Жужан”- Эртний Монгол угсаатны үүсгэн байгуулсан улсын нэр. Монголын түүхэнд “Жужан улс”, “Нирун улс” гэж хоёр өөрөөр тэмдэглэгдсэн боловч нэг л улсыг хэлдэг. Судлаачид МЭ IY зууны эхэн үеэс түүхэнд “Жужан” хэмээх нэр тэмдэглэгдэх болсон гэж үзвэг.

Түүхэнд Жужан гэсэн нэрийг Жужан, Жүй-Жүй, Жу-Жу, Жуань-Жуань, Жужуй, Жужань гэх зэрэг олон янзаар бичиж ирсэн боловч тэр нь цөм Монгол угсааны Жужан гэсэн аймгийн нэр бололтой. Хожим нь энэ аймаг бусад аймгуудаа нэгтгээд бие даасан улс байгуулж, түүнээ өөрийн нэрээр “Жужан улс” гэж нэрлэсэн гэдэг. Үгийн утгийн хувьд судлаачдын ихэнх нь өөрийн нэрээр “Жужан” гэдэг нь “нуруу” гэсэн гэж үздэг.

Рашид-ад-Дин Жужан гэдэг нь персээр “Суло” буюу орчуулбал /нуруу/ гэсэн үг гэж тайлжээ /59.110/. Г.Сүхбаатар Жужань гэх хятад үг нь худам монгол бичгээр “Жужан” гэдэг үг мөн бөгөөд орчин цагийн дуудлагаар “нуруу” гэсэн үг хэмээн нотолсон байдаг. Ийнхүү жужан гэх нь “нуруу” /нируун/ гэсэн адил утгатай болох нь харагдмой.

28. “Гэрэгэ”- Эртний улсуудын хааны /төрийн/ элч мөнийг баталсан пайз юм. Гэрэгэг Хүннү, Сяньби, Жужан улсад хэрэглэж байсан түүхтэй.

Элч хүн “Гэрэгэ”-гээ үзүүлэхэд нь хааны элч төлөөлөгч болохыг мэдэж, түүнтэй хүндэтгэн харилцаж, яриа хэлэлцээр хийдэг, хариу өгдөг, захидал, захиас хүргүүлдэг ёсон тогтжээ. Гэрэгэг анх Хүннү улсад хэрэглэсэн байдаг. МЭӨ 122, 125 онд Хятадын хаанд бараалхсан Хүннүгийн шаньюйгийн элч нэр “гэрэгэ”-гээ үзүүлж байсан нь түүхэн сурвалжид тэмдэглэгджээ. МЭ 450 онд Хятадын Сун улсад Жужаны хааны элч “Гэрэгэ”-гээ үзүүлэн хаанд бараалхаж байжээ /65.97/. “Гэрэгэ” нь Их Монгол Улсын үед эзэн хааны элчийн бүрэн эрхийг илэрхийлэн баталж улам өргөн агуулга, нэр хүндтэй болж, дипломат ёсны нэн чухал хэрэгсэл болсон бөлгөө.

29. “Элэлдээн”- Овгийн байгууллын үед овгийг удирдах зохион байгуулалтын нэгэн хэлбэр болон үүссэн байдаг. Доктор Д.Гонгор “Эртний овог, аймаг дор бүрнээ ургийн цуглаантай байжээ. Түүнийг “эе” гэнэ. Эе нь овог, аймгийн нийтийн эрх ашгийг илэрхийлж гол төлөв амьдралын шаардлагаар тавигдсан хэрэгцээг хангах .. ургийн дотоод хэрэг явдлыг зохицуулах зэрэг явдлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байжээ. “Эе”-д ургийн гишүүд оролцож, саналаа хэлж нэгдсэн шийдвэр гаргана” /22.192/ гэж “Халх товчоон” зохиолд бичсэн байдаг. Агуулгын хувьд “Элэлдээн” нь “цуглаан”, “зөвлөгөөн” гэсэн утгатай.

Энэ уламжлалыг Жужан улс авч “түшмэдийн эелэлдээн” бий болгожээ. Энэхүү эелэлдээн нь төрийн хуралдаан бус. Бас язгууртны хурал биш.

Харин төрийн түшмэдүүд оролцож, төрийн ажил хэргийн талаар ярилцан хэлэлцдэг “зөвлөгөөн” юм. Түшмэдийн эелэлдээн /зөвлөгөө/-ний дүгнэлт, санал шийдлийг хаан болон шийдвэр гаргах эрх мэдэлтнүүд зарлиг буулгаж, шийдвэр гаргахдаа харгалздаг байсан байна.

30. “Бүтээж цаазлах”- Монголын эртний улсуудад цаазаар авах ялыг гүйцэтгэж байсан нэгэн хэлбэр. Бүтээж цаазлах нь цаазлагдагч этгээдийг удаан золвоохгүйгээр бас цус гаргахгүйгээр амийг нь авахыг хэлдэг байна. Монголын эртний төр, хууль цаазын түүхэнд бүтээж цаазлах аргыг хаан угсааны дээдэс төрийн том зүтгэлтэн нэр хүнд бүхий түшмэл, удган хүнийг цаазлахад хэрэглэж байсан түүхтэй. Жишээлбэл Жужан улсын хаан Татар 414 онд төрийн нөлөө бүхий түшмэл Булу Чжэнь, Шеба нарыг, Тулун хаан 485 онд удган Диваныг бүтээж цаазалсан нь түүхэнд тэмдэглэгсэн байдаг. Энэ уламжлал хамаг Монгол Улсад хэрэглэгдэж байсан нь Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн нь бий. Чингис хаан нэрт язгууртан Жамухыг бүтээж, төрийн бөө Тэв тэнгэрийг нурууг нь хугалж цус гаргалгүй цаазалсан байдаг билээ.

31. “Ашина”- Хүннүгийн бүрэлдэхүүнд байсан аймаг. “Ашина” аймгийг Түрэгийн өвөг дээдэс гэж үздэг. “Ашина” аймаг Хүннү, Сяньби, Тоба зэрэг улсуудын захиргаанд харьяалагдаж явсаар 460-аад оноос Жужан улсын захиргаанд оржээ. Энэ үеэс Алтайн өврөөр нутаглаж байсан Ашина аймгийн овгууд өөрсдийгөө “түрэг” гэж нэрлэсэн бөгөөд энэ цагаас хойш “Ашина” нь тэдний ноёлох овгийн нэр болон үлджээ. “Ашина” гэдэг нь монгол хэлний “Чоно” гэсэн үг бөгөөд түрэгчүүд ч өөрсдийгөө чоноос гаралтай гэж үздэг байжээ /43.315/.

32. “Буман”- Эртний Түрэг улсын анхны хаан. Буман нь “Дулга” овгийн ахлагч бөгөөд эл овог нь Алтайн өмнө талд нутаглаж байжээ. Дулга овгийнхон Түрэг улсыг байгуулахад их үүрэг гүйцэтгэсэн байдаг. Энэ нь тус овгийн зонхилгогч /ахлагч/ нь байсан Буман язгууртны үйл ажиллагаатай холбоотой. Буман, Жужаны эсрэг боссон Тэлэ аймгийг өөртөө нэгтгэж дотоод, гадаад байдлаа сайжруулаад, мөн баруун Вэ улстай ургийн холбоо тогтоож гадаад байдлаа бэхжүүлсэн байна. Ингээд 552 оны өвөл “Төмөрчдийн их бослого”-ыг удирдан Жужаны хүчийг бут цохин, түүний харьяанд байсан олон овог аймгийг өөртөө нэгтгэж Түрэг улсыг байгуулжээ. Буман эсвэл Түмэн гэвэл нэг л хүнийг /хааныг/ хэлж байгаа хэрэг болно. Энэ нь Хятад сурвалжид “Түмэн” гэж бичиглэсэн байхад Түрэг хөшөөний бичээст “Буман” гэж бичсэн байдагтай холбоотой байж болох.

33. “Тоньюк”- Түүхэнд мэргэн Тоньюк гэж алдаршсан төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин, түрэг улсыг хамгаалан мандуулахад асар гавьяа байгуулсан алдарт хүн. Тоньюк Түрэгийг эзлэн ноёрхсон Тан улсын эсрэг Түрэгийн нөлөө бүхий язгууртан Кутулугийн хамт хүчтэй бослого гарган удирдаж ҮШ зууны 90 оны орчим

Түрэг улсыг сэргээн байгуулалцсан нь түүхэнд Хожуу Түрэг улс хэмээн алдаршсан ажээ. Тоньюк, Кутулуг, Можо, Билгэ хааны үед төрийн сайд, цэргийн жанжнаар ажиллаж байжээ. Түрэгчүүд энэ алдарт хүнээ нас барахад нь ихэд хүндэтгэн бунхалж, хөшөө босгосон нь эдүгээ Налайхад байдаг бөлгөө.

34. “Уйгур”- Монгол нутагт оршиж байсан эртний Уйгур улсын нэр. Уйгур овог, аймгаас Уйгур улс үүссэн түүхтэй. Уйгурчуудын өвөг дээсийг Гаогюй буюу өндөр тэрэгтнүүд гэдэг аж. Ү зуунд Уйгур нэр анх түүхнээ тэмдэглэгджээ /12.134/. Уйгурчуудын 15 аймаг байжээ. Хүннү улс байгуулагдахад бүрэлдэхүүнд нь байсан уйгурчууд дараа нь Сяньби, Тоба, Жужан, Түрэг улсын бүрэлдэхүүнд багтах, зэрэгцэн орших, байлдах, найрамдах, тусгаар улс болохын төлөө тэмцэх зэргээр түүхийн урт хугацааг туулж, МЭ 744 он болж ирэхэд зоригт тэмцэгч Пейлогийн удирдлагын дор Түрэгийн ноёрхлын эсрэг бослого гарган түүнийг бут цохиод “Уйгур” улсыг байгуулжээ.

Хүннүгийн эзэмшиж байсан бүх нутаг дэвсгэрээр төвлөрөн байгуулагдсан Уйгурын хаант улс хүчтэй, хөгжилтэй, өндөр соёлтой улс байсан бөгөөд 100 шахам жил оршин тогтнож, монголчуудын түүхэн амьдралд их нөлөө, гүн ул мөр үлдээсэн бөлгөө.

35. “Хиргис”- Төв Азийн эртний аймаг. Сурвалж бичигт Хиргисийн тухай МЭӨ III зууны эхэн үеэс тэмдэглэгджээ. Монгол нутаг дахь Орхоны түрэг бичээст “Киргиз” гэж тэмдэглэгджээ. Үүнээс үүдэн монгол бичгээр Киргизийг Хиргис гэж бичих болжээ. Эрдэмтэд, овог аймгуудын шилжилт, хөдөлгөөний явцад шаргал үст цэнхэр нүдтэй динлинчүүд түрэг хэлт монголжуу төрхт гяньгүн нартай цус холилдоноос жинхэнэ Хиргисийн төрх бүрэлдсэн гэж үздэг /102.199/. Хиргисчүүд Тан, Түрэг улсуудын харьяанд явсаар 758 онд Уйгурын эрхшээлд орж 80 гаруй жил болсны сүүлийн 20-иод жилд нь Уйгурын ноёрхлын эсрэг тэмцжээ. Ажо тэргүүтэй Хиргисчүүд Тан, Түрэг улсуудын харьяанд явсаар эцэст нь Уйгурын цэргийг ялж, 818 онд Хиргис улсыг байгуулсан бөлгөө. Хиргисчүүд IX зууны II хагаст Төв Ази дахь ноёрхлоосоо татгалзаж монгол нутгийг орхин гарсан түүхтэй. Хиргис нь хүчирхэг, соёлтой, улс байсан бөгөөд Монголд олон сайхан түүхэн дурсгалууд үлдээсэн нь өдгөө ч хадгалагдсаар байгаа билээ.

36. “Да-хэ”- Хятаны ноёлох аймгийн нэр. Хятан нар Сяньбичүүдтай холбогдоно. Сяньбичүүд II зууны үед шар мөрний эргийг даган Ляодунгийн Сяньби, Ляосын Сяньби гэсэн хоёр хэсэгт хуваагдан нутаглаж байжээ. IV зууны үед Ляодунгийн Сяньби Ляосын Сяньбид довтлоход Ляосын Сяньбичүүд бутран сарниж Юйвэнь, Кумоси гэсэн аймгууд болжээ. Үүний Кумоси аймгаас Хятан нар салбарлан үүссэн гэж эрдэмтэд үздэг /56.154-155/.

Энэхүү салбарлан үүссэн аймгууд нь нийтдээ 8 аймаг байжээ. Эдгээр аймгуудын “Да-Хэ” аймаг ноёлох аймаг болж, бусад аймгуудаа харьяалан захирч, ҮІ зууны сүүлчээр холбооны зохион байгуулалтад шилжин оржээ. Аймгуудын холбоог Да-хэ аймаг тэргүүлж, холбооны тэргүүлэгчээр тус аймгийн толгойлогч Шоуку сонгогдсон аж. 718 онд Шоу-ку алагдсанаар холбоог толгойлох аймгийн эрх Да-хэ аймгаас Яо-нян аймагт шилжжээ. Үүнээс хойш Да –хэ аймаг ноёлох аймаг байх эрхгүй болсон түүхтэй.

37. “Амбагян”- “Елюй” хэмээх ноёлох аймгийн тэргүүн. Яо нянь аймаг ноёлох аймаг байхаа болсны дараа “Елюй” аймаг Х зууны эхэн үеэс Хятанчуудын ноёлох аймаг болжээ. 917 онд Елюй аймгийн тэргүүн Амбагян Хятан улсыг байгуулснаа зарлаж, өөрийгөө Хятаны хаанаар өргөмжилж, хаан ширээг үе улиран залгамжлах ёсыг тогтоосон байна.

Амбагян нь Хятан улсыг байгуулах, хаант ёсыг тогтоох, гадаад харилцааг хөгжүүлэх, улсаа гүрэн болгон өргөтгөх, төрийн шинэ тогтолцоо бий болгох үйлсэд их үүрэг гүйцэтгэсэн хаан байсан ажээ.

38. “Орд”- Хятан гүрний засаг захиргааны хамгийн том нэгж. Хятан гүрэн бүх нутаг дэвсгэр, хүн амаа “умард” ба “өмнөд” гэсэн хоёр ордод хуваасан байдаг. Хоёр ордыг бий болгохдоо Хятан гүрэн дэх нүүдэлчин ба суурьшмал иргэншлийн хэв маяг, тэдний газар нутаг, эрхлэх аж ахуй, зан заншил, удам угсааны байдлыг харгалзан, үүнд зохицсон удирдлагын тогтолцоо бий болгохыг зорилго болгосон гэдэг. Умард ордод хятан тэргүүтэй нүүдэлчин аймгууд, тэдгээрийн оршин амьдардаг газар нутгийг харьяалуулан захируулжээ. Мөн Өмнөд ордод Хятад зэрэг суурьшмал хүн ам, тэдний оршин амьдардаг газар нутгийг хуваарилан олгосон ажээ.

39. “Хар-хятан”- Эртний улсын нэр. Хятан гүрнийг мөхөх үед хэсэг хятанчууд Хятан Елуй Аваажуд хааны наймдугаар үеийн ач Елуй Дашийн удирдлагаар уугуул нутгаа орхин баруун зүгт нүүдэллэж 1231 онд Хар хятан улсыг байгуулжээ. Хар хятан улс нь хятанчуудын салшгүй хэсэг бөгөөд 100 орчим жил оршин тогтнож байжээ.



ТЭРГҮҮН АНГИЙН ТҮҮХЭН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

МЭӨ ҮҮ-III зуун	Монгол нутагт Хүннү, Дунху нарын аймгийн холбоо байгуулагдсан
МЭӨ III /209 он/	Хүннү улс байгуулагдсан.
МЭӨ 209 он	Модун Хүннүгийн шаньюй /хаан/ болсон.
МЭӨ 201 он	Модун Шаньюй 400000 морьт цэргээр Баруун Хань улсад довтолж ялалт байгуулсан.
МЭӨ 198 он	Хань улсын хаан Лю Бан, Хүннү улсын хаан Модун шаньюй нарын хооронд найрамдал-ургийн гэрээ байгуулагдаж, Хань, Хүннү улс эн сацуу хоёр их эзэнт гүрэн хэмээн бие биенээ хүлээн зөвшөөрчээ. Энэ гэрээгээр Цагаан хэрмээс өмнөх нутаг Хань улсын, хойшхи нутаг нь Хүннүгийн нутаг мөн гэж тогтоожээ.
МЭӨ 179 он	Хань улсын шинэ хаан Сяо-Вэньди Хань ба Хүннү улсын хооронд МЭӨ 198 онд байгуулсан найрамдал, ургийн гэрээг сэргээн баталжээ.
МЭӨ 174 он	Модун шаньюй нас барсан
МЭӨ 174 он	Модуны хөвгүүн Гиюй эцгийн орыг залгамжилж, Лаошань цолтойгоор Хүннүгийн шаньюй болсон.
МЭӨ 161 он	Лаошань шаньюйн хөвгүүн Гюньчень Хүннүгийн шаньюй болов.
МЭӨ 152 он	Хүннү, Хятадын нутгийн зааг дээр хилийн худалдааны зах нээгджээ.
МЭӨ 126 он	Гюнчэнь шаньюй нас барж оронд нь Ичиси Хүннүгийн шаньюй болсон.
МЭӨ 55 он	Хүннү гүрэн ар, өвөр хүннү болон хоёр салсан.
МЭӨ 51 он	Хүннүгийн шаньюй Хуханье хятадын хаан Сюаньдийн урилгаар хятадад айлчилсан.
МЭ 20 оны үе	Хүннү гүрэн Модун, Лаошань шаньюй нарын үеийн бүх нутаг орныг захиран ноёрхож, сэргэн манджээ.
МЭ 48 он	Хүннү гүрэн өмнөд, умард Хүннү болж хоёр хуваагдсан
50-58 он	Ухуань, Сяньби нар болон Манж Тунгүс угсааны овгууд Умард Хүннүгээс тасран салжээ.
85 он	Умард Хүннүгийн 73 том овог Хятадад дагаар оржээ.

- 87 он** Сяньби умард Хүннү рүү довтолж хааныг нь алсан байна.
- 93 он** Өмнөд Хүннүгийн шаньюй Түньгүхэ Хятадтай хуйвалдан умард Хүннүд довтолж, хүчтэй цохилт өгөн Умард Хүннүг мөхөөжээ.
- 155 он** Умард Хүннүгийн зарим хэсэг нь өрнө зүгт нүүдэллэж эхэлжээ.
- 156 он** Таньшихуай Сяньби улсын хаанд өргөмжлөгдсөн. Таньшихуайн орыг хүү Холян нь залгамжилсан.
- 181 он** Сяньби гүрэн задарч, Сяньби, Ухуань, Муюн, Тоба, Юйвинь, Түгүхунь, Даунь гэсэн аймаг улсуудад хуваагджээ.
- 215 он** Өмнөд Хүннүгийн төр устаж, Хятадын нэг мужийн доторхи аймаг мэт болсон.
- 294 он** Муюн Хой, Хойд Хятадын Дагичэн хот, Хятадын зүүн хойд талын нутгийг эзлэн захирч улсаа Муюны Янь улс хэмээжээ.
- 313 он** Муюн Хой, Сянь овог аймгуудыг бут цохин өөрийн улсад нэгтгэн захирчээ.
- 313 он** Тоба Илү ноён Тоба улсыг үндэслэн байгуулсан анхны хаан.
- 333 он** Муюн Хой нас барж түүний орыг Муюн Хуан хаан ширээ залгамжилсан
- 337 он** Муюн Хуан өөрийгөө хожуу Янь улсын ван хэмээн зарласан
- 338 он** Шэйг Янь, Тоба улсын хаанд өргөмжлөгдөн хаан ширээг залгамжилсан
- 348 он** Муюн Хуа хаан нас барсаны дараа Муюн Цзюнь түүний орыг залгамжлан Муюны Янь улсын ван болжээ.
- 349-352 он** Муюн Цзюнь 349 онд Умард Хятадыг, 352 оны үед Өмнөд Хүннүгийн Чжао улсыг эзлэн, Бээжин хотыг нийслэл болгож өөрийгөө Умард Хятадын эзэн хаанаар өргөмжилсөн.
- 386 он** Тоба Гүй, Тоба Вэй улсын хаан болж, өөрийгөө Вэйгийн вангаар өргөмжилжээ.
- 395 он** Тоба Гүй ван, хожуу Янь улсад дайн зарлан байлдаж ялалт байгуулжээ.
- 397 он** Тоба Гүйг хаан ширээнд суулгах ёслол болж, Тоба Вэй буюу Юань Вэй улсын хаанаар өргөмжилжээ. Тоба Гүй, Юань Вэй улсын үндэслэгч байсан бөгөөд Лоян хотыг улсынхаа нийслэл болгосон байна.
- 430 он** Хүннүчүүд өрнө зүг нүүдэллэхээр Европод хүрч, Атилла хааны үед түүхнээ тэмдэглэгджээ.

- 450 он** Атилла хааны байгуулсан Хүннү гүрэн хүчирхэгжлийнхээ туйлд хүрч, Өрнө зүгт Рейн мөрөн, дорно зүгт Ижил мөрөн, Умард зүгт Балтийн тэнгис, Өмнө зүгт Адриатын тэнгис Ирантай хиллэсэн асар уудам нутаг дэвсгэрийг эзлэн орших болжээ.
- 435 он** Тоба Вэй улс, баруун, зүүн хоёр хэсэгт хуваагджээ. Зүүн Вэй улс 535-549, баруун Вэй улс 535-556 онуудад оршин тогтносон.
- 581 он** Тоба Вэй улс 280 шахам жил оршин тогтнож байгаад 581 онд мөхсөн.
- 535 он** Ухуань аймаг хүчирхэг болж, бие даан оршин тогтнох болжээ.
- 235-ҮШ зууны сүүл** Тогоон улс оршин тогтнож байжээ.
- 402-555 он** Жужан улс оршин тогтнож байв. Жужаныг бас Нирун улс хэмээн нэрлэж байсан бөлгөө. Жужаныг 402 онд Шэлүнь байгуулж, өөрийгөө Жужан Дэудай хаан хэмээн зарлан тунхагласан.
- 410 он** Шэлүнь хааныг нас барсны дараа түүнийг дүү Хулюй залгамжилж, Айкутай хаан цолтой болжээ.
- 402-414** Жарун хаан “Хутугтай”, Булучжень 414 онд “Ашид амгалан” гэсэн оны цолтой болсныг тунхагласнаар хаан нь оны цол хэрэглэдэг ёс тогтжээ.
- 429 он** Датань хааны хүү Ути хаан ширээнд суусан.
- 464 он** Юйгэн Жужаны хаан ширээнд суусан.
- 470 он** Тоба улсын цэрэг Жужанд довтолж ихэд доройтуулав. 492 онд Уйгурын Гаогүй аймгийн тэргүүн Афджило Жужаны эсрэг тэмцэв. Нагай хаан ширээнд суусан. Ү зууны эх Уйгурууд зүүн Уйгур, баруун Уйгур хэмээн хуваагдсан.
- 552 он** Жужаны эсрэг түүний харьяанд байсан түрэгүүдийн “Төмөрчдийн их бослого” гарсан.
- 552 он** Түрэгийн зонхилгоч Буман 552 онд Жужаны эсрэг аян дайн хийж ялан, Түрэг улсыг байгуулан, хааны цолыг хэрэглэн өөрийгөө “Эл хаан” хэмээн өргөмжилжээ.
- 553 он** Буман хаан нас барж, хүү Коло нь “Исиги” цолтойгоор хаан ширээг залгамжилсан
- 555 он** Жужан улс бут цохигдон мөхөв.
- 552-558 он** Түрүү түрэгийн хаант улс оршин тогтнож байв.

572 он	Тоба, Түрэгийн хаан ширээнд суусан
590 он	Түрэг улс зүүн ба баруун түрэг болон салсан
690-745 он	Хожуу түрэгийн хаант улс оршин тогтнож байсан
693-716 он	Можо хаан төр барьсан
716-734 он	Билгэ хаан төр барьсан
734-739 он	Ижань төр барьсан
745 он	Хожуу Түрэгийн хаант улс мөхсөн
745 он	Уйгурын хаант улс байгуулагдаж, Пэйло хаанд өргөмжлөгдсөн
747-759 он	Баянчур хаан ор сууж, Уйгурын төрийг барьсан
751 он	Уйгурын нийслэл Балыклик /хар балгас/ хот байгуулагдсан
759-779 он	Идигань хаан ширээнд сууж, төр барьсан
779-795 он	Алп Кутулуг хаан төр барьсан
780-аад онд	Монголчуудын өвөг дээдэс гурван голд ирж нутагласан
ҮШ-IX зууны	
эхэн	Уйгур улс Монгол нутагт төвлөрөн оршиж байсан
840 он	Уйгурын хаант улс Енисейн Хиргисүүдэд автагдан мөхсөн.
818 он	Ажо ноён өөрийгөө Хиргисийн хаанд өргөмжилсөн
Х зууны эхэн	Хиргисчүүд монгол нутгийг орхин нүүсэн
917 он	Амбагян Хятан улсыг байгуулан хаан болжээ.
917-936 он	Хятан нь Хятан улс маягаар оршин тогтнож байв.
920 он	Хятаны “Их бичиг”-ийг Амбагян хааны ач хүү Лубугу, эрдэмтэн Тулюйбу нар зохиосон
921 он	Амбагян шинэ хууль баталсан
923 он	Хятан нар Хэрлэн гол хавийн Зү-бу /монгол аймгууд/ нарыг эзэлсэн
926 он	Хятан их гүрний шинжтэй болж, улсаа “Их Ляо” улс хэмээн нэрлэжээ.
936-1125 он	Хятан нь Хятан гүрэн маягаар оршин тогтнож байв.
1118-1125 он	Алтан улс, Хятадын Сүн улстай хүч хавсран довтолж, Хятан гүрнийг мөхөөсөн.
1113-1115 он	Зүрчидүүд Хятан гүрний зарим газар нутгийг эзлэн Зүрчидийн Алтан улсыг байгуулсан.
1131-1212 он	Хятаны зарим хэсэг нь Дундат Ази руу нүүж, тэндхийн ард түмнийг эзлэн Хар хятан буюу Баруун ляо улсыг байгуулсан
1128-1131 он	Елюй даши одоогийн Бухар хотын зүүн бие хүртэлх газрыг эзэлж “Гүр” хаан хэмээн өргөмжлөгджээ.
1142 он	Хар хятаны цэрэг Самарканд, Хорезмыг эзлэн авчээ.

1143 он	Елюй Даши нас баржээ.
1151-1163 он	Ренжун хаан төр барьж үлэмж хүчирхэг улс болжээ.
ҮІ-ҮІІ зуун	Монгол гэдэг нэр түүхэнд тэмдэглэгдэх болсон
ҮІІ-ІХ зуун	Гурван голын монголчуудын дунд аймгуудын нэгдэл байгуулагдан, улмаар улсын шинж бүхий төрийн нэгдэл бий болж эхэлжээ.
Х зуун	Боданчар Монгол аймгуудын дийлэнхийг захирах болсон.
1035 он	Монгол аймгуудын удирдагч Хайдуу төрсөн.
1052 он	Байшин хур төржээ.
1069 он	Тумбинай сэцэн төрөв.



ТЭРГҮҮН АНГИЙН НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Айлтхам.Ф. Хүннү нарын түүх УБ.,1969.
2. Азийн нүүдэлчин үндэстний түүх Хөх хот. 1998
3. Алтан-Оргил. Ойрадын түүхэн сурвалж бичиг Хөх хот. 1985
4. Амар.А. Монголын товч түүх УБ.,1992
5. Баянчуулган.Б. Монголын бүх газар нутаг УМГ. Бичмэл
6. Батсуурь.Ж. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгөсөн нь ОУМЭ-ний Ү их хурал. III боть. УБ.,1992
7. Бат-Очир.Ч. Монгол Улсын эртнээс уламжилж ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг. УБ.,1928
8. Баяр.Д. Туулын хөндий дэх Түрэгийн өмнөх үеийн хүн чулууны тухай УБ.,1979
9. Баяр.Д. Төв Монголын нутаг дахь Түрэгийн хүн чулуу
10. Баяр.Д, Эрдэнэбаатар.Д. Монгол Алтайн хүн чулуун хөшөө. УБ.,1999
11. Бира.Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ.,2001
12. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.,1966
13. БНМАУ-ын түүх. Нэгэн боть, нэмж засварласан III хэвлэл. УБ.,1984
14. Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997
15. Бор.Ж. Монгол Улсын төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал. УБ.,1988
16. Болд.П. Монгол нутаг дахь хадны бичээс /Түрэг бичгийн дусгал/ УБ.,1990
17. Булаг. Монгол үсэг бичгийн товч түүх. Хөх хот. 1983
18. Гаадамба.Ш. Монголын нууц товчооны нууцаас. УБ.,1971
19. Галдан туслагч Эрдэнийн эрх. УБ.,1960
20. Гомбосүрэн.Ц. Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү.УБ.,1995
21. Гонгор.Д. Халх товчоон. I боть. УБ.,1970
22. Гонгор.Д. Халх товчоон. II боть. УБ.,1978
23. Гэрэлбадрах.Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. /МЭӨ III-XIX зуун/ УБ.,2002
24. Далай.Ч. Монголчуудын бичиг үсгийн түүхийн зарим асуудал. ШУАМ. 1961. №3
25. Дамба.С. Монгол Улсын үндэсний түүх, төрийн түүхийн тухай. УБ.,2005
26. Дамдинсүрэн.Ц. Монголын нууц товчоо. 1990
27. Доржсүрэн.Ц. Монгол нутагт байсан эртний улсууд. УБ.,1955
28. Доржсүрэн.Ц. Умард Хүннү. УБ.,1961

29. Дэндэв.Л. Монголын товч түүх. 1934
30. Дэндэв.Л. Монголын эрт эдүүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. УБ.,1936
31. Жамбалдорж. Болор толь. Бээжин. 1987
32. Жужаны тухай хэрэглэгдэхүүний түүвэр. Ц.Хандсүрэнгийн орчуулга. 1958
33. Жүгдэр.Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ.,1987
34. Ишжамц.Н. Монголд байсан эртний аймгуудын удам угсааны хамаарлын асуудалд. “Этнографийн цуврал” II боть. 1965
35. Ишжамц.Н. Хүннүгийн удам угсаа, нийгмийн байгуулал. ШУХ-ийн ЭШ-ний бичиг №1. 1956
36. Линь Ган Түрэгчүүдийн түүх. Хөх хот. 1998
37. Линь Ган Дунхүгийн түүх. Хөх хот. 1997
38. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
39. Лею Женсо. Монголын Хураангуй түүх. Хөх хот. 1983.
40. Лею Женсо. Чингис хааны эзэнт улс байгуулагдахаас өмнөх Монголын нийгмийн байгууламж. Монголын түүх судлал. Хөх хот. 1986
41. Майдар.Д. Гэр. УБ.,1977
42. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга. Тайлбар. УБ.,2003
43. Монгол Улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003
44. Монгол Улсын түүх. Дэд боть. УБ.,2003
45. Монгол-Татарууд Ази, Европт. УБ.,1984
46. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ.,1992
47. Монголын археологийн эмхэтгэл. 1962
48. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. /МЭӨ III-МЭ ХХ зуун/ Тэргүүн боть. УБ.,1995
49. Мөнх-Эрдэнэ.Л. Европын Хүннү ба Агтила. УБ.,1992
50. Нацагдорж.Ш. Монголын феодализмын түүхэн замнал.УБ.,1987
51. Нацагдорж.Ш. Чингис хааны цадиг. УБ.,1991
52. Нямбуу.Х. Монгол угсаатны зүй. УБ.,1992
53. Пэрлээ.Х. Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь. УБ.,1976
54. Пэрлээ.Х. Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудал. УБ.,1978
55. Пэрлээ.Х. Монгол Ард Улсын эрт, дундат үеийн хот суурины товчоон. УБ.,1961
56. Пэрлээ.Х. Хятан нар, түүний Монголчуудтай холбогдох нь. УБ.,1959
57. Пүрэв.О. Монголын бөөгийн шашин. УБ.,1988
58. Рамстедт.Г.И. Уйгур улсын түүхийн товч, ШУА-ийн ТХГБСХ. IY хн. 16.Т.56
59. Рашид-ад-Дин. Судрын чуулган. I боть. УБ., 2002

60. Рене Груссе. Азийн нүүдэлчин үндэстний түүх. Хөх хот. 1999
61. Саган-Сэцэн. Эрдэнийн товч. УБ.,1961
62. Сайшаал Чингис хааны товчоон I боть. УБ.,2003
63. Сүхбаатар.Г. Сяньби. УБ.,1971
64. Сүхбаатар.Г. Монголчуудын эртний өвөг. УБ.,1980
65. Сүхбаатар.Г. Монгол Нирун улс. 330-550. УБ.,1992
66. Сүхбаатар.Г. Монголын эртний түүх судлал. II боть. Сяньби. УБ.,2001
67. Сурбадрах. Монгол үндэстний язгуур үүсэл. Бээжин.1988
68. Сэр-Оджав.Н. Эртний түрэгүүд /ҮI-ҮIII зуун/ УБ.,1970
69. Сэр-Оджав.Н. Монголын эртний түүх. УБ.,1977
70. Уйгар угсаатны түүхийн баримтын эмхэтгэл. Бээжин.1958
71. Хаганчулуу. Хабул хааны гавьяа зүтгэлийг магадлах нь. Тайбэй. 1979.
72. Хандсүрэн.Ц. Жужаны хаант улс. УБ.,1994
73. Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.,1966
74. Цэвээн.Ж. Монголын эртний судлалын асуудал. УБ.,1936
75. Цэвээндорж.Д. Монголын эртний урлагийн түүх. УБ.,1999
76. Цэвээндорж.Д, Баяр.Д. Монголын археологи. УБ.,2002
77. Шинэхүү.М. Тариатын Орхон бичгийн шинэ дурсгал. S.A.TVI. F-1.ҮIII. УБ.,1980
78. Шинэхүү.М. Орхон-Сэлэнгийн Руни бичгийн шинэ дурсгал S.A.T.VIII. F-1. УБ.,1980
79. Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. К.Маркс, Ф.Энгельс.
Түүвэр зохиол. I боть. УБ.,1971.

Орос хэлээр

80. Баргольд.В.В. 12 лекций по истории турецких народов Средней Азии. Соч. т.з.М.1968
81. Бернштам.А.Н. Очерк истории Гуннов. Л.,1951
82. Бернштам.А.Н. Социально-экономической стран Орхон-Енисейских турек ҮI-ҮIII веков.М.Л.1946
83. Бичурин.Н.Я. История Тибета и Хухунора. Ч.1. Санктпетербург. 1983
84. Бичурин.Н.Я. Собрание сведений о народах, обитавших в средней Азии в древние времена. В 3-х частях СПб.1851
85. Билэгт.Л. Татары и Монголии.S.A.T. ХҮI. F-10. УБ.,1996
86. Билэгт.Л. Тюрки и Монголии. S.A.T. ХҮIII. F-19. УБ.,1998
87. Бичурин.Н.Я. Записки о Монголии сочиненные монахом Иахинфом. Т. 1-2. СПб.1828
88. Васильев.Л.С. Аграрные отношения и община в древнем Китае. М.,1961.

89. Владиморцов.Б.Я Общественный строй Монголов. Монгольский кочевой феодализм. Л.,1931
90. Всемирная история I. М.,1955. Всемирная история. М.,1975
91. Волков.В.В. Оленные камни Монголии.УБ.,1981
92. Гамкрелидзе.Т.В, Иванов.В.В. Восточный Туркстан в древности и раннем средневековье, очерк истории. М. Наука 1988
93. Гаспин.В.С. Материалы по истории древних кочевых народов. М.,1978
94. Гольман.М.Ц. Многоведение на западе /центры, кадры, общество/ М.,1997
95. Грач.А.Д. Древние кочевники в центре Азии.М.,1980
96. Грумм-Гржимайло.Г.Е. Западная Монголия и Урянхайский край. т.1.п. Л. 1936
97. Гумилов.Л.Н. Хүннү. М.,1960
98. Гумилов.Л.Н. Тысячелетие вокруг каспии М.,1993
99. Гумилов.Л.Н. Хүннү, Средняя Азия в древние времена. М.,1960
100. Гумилов.Л.Н. Древние Тюрки. М.,1967
101. Гумилов.Л.Н. Хунны в Китае. М.,1974
102. Евтюхова.Л.А. Южная Сибирь в древности по следам древних культур. М.,1954
103. Евтюхова.Л.А. О племенах центральной Монголии в IX веке. СА. №2 1957
104. Залкин.Е.М..Хятание и их этнические связи. “Советская этнография” 1948.№1
105. История Сибири. Древняя Сибирь. Л.,1968
106. Иностранцев.К. Хунны и гуны. Л.,1926
107. Кичановский.Ю.В. Фабовладение феодализм или азиатский способ производства.М.,1971
108. Киселев.С.В. Древнемонгольские города.М.,1968
109. Киселев.С.В. Древняя история Южной Сибири. М., 1951
110. Киселев.С.В. Монголия в древности. М.,1947
111. Кляшторный.С.Г. Древнетюркская письменность и культура народов центральной Азии. М.,1973
112. Кляшторный.С.Г. Древнетюркские рунические памятники как источник по истории средней Азии. М.,1964
113. Козлин.Н.П. К вопросу о тюрецко-Монгольском обществе. М-Ц. 1934
114. Кононков.П.Ф, Кононкова С.Н. Земледелие в Монголии. М.,1966
115. Коновалов.П.Б. Хунны В забайкалье. Улан-Удэ.1976
116. Кызласов.Л.Р. Новая датировка памятников Енисейской письменности. Советская археология. №3.1960
117. Кормушин.И.В. К основным понятиям тюркской рунической палеографии Советская тюркология.1975.№2

118. Кюннер.А.В. Китайская известия о народах Южной Сибири, Центральной Азии и Дальнего Востока. М.,1961
119. Кичанов.Е.И. Монголы в XI-первой половине XII в
120. Малов.С.Н.Памятники древнетюркской письменности Монголии и Хиргисии. М.Л.,1959
121. Малов.С.Н. Памятники древней тюркской письменности Монголии и Хиргисы Л-М 1959
122. Майский.П.Н. Монголия наугануне революции. М.,1959
123. Материалы по истории древних кочевных народов группы Дунед. Введение переводы камментарии С.В.Таскина. М.,1984
124. Мэн-Гу-Ю-Шу-Цзи. Заметки о Монгольских кочевьях. М.,1965
125. Новгородова.Э.Л. Древняя Монголия. М.,1989
126. Новгородова.Э.Л. Новые памятники искусства древней Монголии. УБ.,1972
127. Новосельцев.Л.П, Пашуто.В.Т, Черепнин.Л.В. Пути развития феодализма. М.,1972
128. Радлов.В.В. Атлас древней Монголии. СПб.1911
129. Рашид-ад-Динь Сборник летописей.Т.1.К1.1952
130. Роль кочевых народов в цивилизации Центральной Азии. 1974
131. Руденко.С.М. Культура Хүннов и Ноинулинские курганы. М.Л.,1962
132. Советская историческая энциклопедия. Боть II. М.,1962
133. Сыма Цзянь. Исторические записки. М.,1975
134. Таскин.В.С. Материалы по истории Сюнню /По китайским источникам/ М.,1968,1973
135. Таскин.В.С. Материалы по истории древних кочевых народов группы Дунху. М.,1984
136. Цыбыктаров.А.Я. Бурятия в древности, история. Выпуск 3.Улан-Удэ.1989.
137. Якубовский.А.Ю. Из истории изучения Монголов периода XI-XII вв. Очерки и истории русского востоковедения. М.,1953

Дорно дахины хэлээр

А.Хятад хэлээр

138. Бань Гу. “Хань шу /Баруун Хань улсын түүх/”. Бээжин “Бона” 1958
139. Вэй Чжэн. “Суй шу /Сүй Улсын түүх/”. Бээжин “Бона” 1958
140. Вэй Шоу. “Вэй шу /Умард Вэй улсын түүх/”. Бээжин “Бона” 1958
141. Линь-ган “Сюнну шу /Хүннүгийн түүх/”. Хөх хот 1958
142. Линь-ган “Сюннү шу /Хүннүгийн түүх/”. Бээжин. 1986
143. Люй Сюй “Цзю Тан шу /Тан улсын хуучин түүх/”. Бээжин. “Бона”.1958

144. Ма-чан-шу. Умард ди ба Хүннү. Б.,1962.
145. Ма-чан-шу. Ухуань, Сяньби нар. Шанхай. 1962
146. Оуян Сю. “Сынь Тан-шу /Тан улсын шинэ түүх/”. Бээжин “Бона” 1958
147. Сыма Цзянь. “Ши-Цзи /түүхэн тэмдэглэл/”. Бээжин. “Бона” 1958
148. Сяо Цзысянь. “Нань Ци-шу /Өмнөт Ци улсын түүх/”. Бээжин “Бо-на” 1958
149. Токто “Ляо шу /Ляо улсын түүх/” Бээжин “Бо-на” 1958
150. Фане. “Хоу Хань-шу /Хожуу Хань улсын түүх/”. Бээжин “Бо-на” 1958
151. Чжоу шу “Чжоу улсын түүх”. Бээжин.1958
152. Чень Шоу. “Саньгочжи /Гурван улсын түүх/”. Бээжин “Бо-на” 1958
153. Шан-Юэ. “Чжунго лишн гаяню /Хятадын товч түүх/”. Бээжин.1954

Б. Манж хэлээр

154. Дай Ляо гүрини судури

В. Япон хэлээр

155. Вада Сей “Тоа ши Кэнкю” /Моокохэн/ /Дорнод Азийн түүхийн судалгаа. Монголын бүлэг/ Токио. 1959
156. Ивамура Шинобу “Монгору шякай кэйзайши но кэнкю” /Монголын нийгэм эдийн засгийн түүхийн судалгаа/ Киото. 1968
157. Мора Масао “Юбоку Кокка-но сэйрицу то хатгэн” /Нүүдэлчин улсын үүсэл хөгжил/
158. Хондо Минобу “Мокоши Кэнкю” /Монголын түүхийн судалгаа/ Токио. 1970
159. Сиратори Куракичи “Сайгай минзоку” /цагаан хэрмийн гаднах үндэстэн/ 1940
160. Эгами Намио “Киба минзоку кокка” /морьтон үндэстний улс/ 1967

Д. Англи хэлээр

161. Wittfogel.K. History of the Chinese Society Liao /907-1125/ Philadelphia. 1949.
162. Boodberg.R.A. The Language of the T'o-pahsas vol I 12. 1936
163. Camilla Trevel. Excavations in Northern Mongolia. Leningrad. /1924-1925/ 193
164. Faisepvis.W.A. Archaeology of the Southern Gobi of Mongolia. Durham,1993
165. Pelliot.O.Votes sur les T'ou-yu-houen et les Sou-pi-T'oung Pao. 1921. №20
166. Sinor Denis Orienta'sm and History Blaomington London. 1970
167. Togmbec A.J. A study of History. I Wv-London 1965
168. Thomas.J.Barfield. The perilous Frontier. Nomadic Empires and China. Bassl Blackwell. First. Published. 1989

169. Hall M., Honeychurch W., Wright J., Batsaikhan Z., Bilegt L. History of civilisations of Central Asia. II. UNESCO Publishing, 1994.
170. Prttsako. Dte 24 Ta-ch'en. Studie zurhgeschichte des Veiwaltung-saulbaus der Haiung-nu Reish-Oriens Extremus. I.,1954.





ДЭД АНГИ
IX- XII ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ
ХАНЛИГ, АЙМАГ

ДЭД АНГИ
IX- XII ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ ХАНЛИГ, АЙМАГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**IX-XII зууны Монгол ханлиг аймгуудын түүхийн сурвалж бичиг,
судалгааны зохиол**

Монгол улсын төрийн түүхийн нэн өвөрмөц онцлог бүхий түүхэн зурвас үеийг IX-XII зууны Монгол ханлиг, аймгуудын төрийн түүх хамардаг билээ. Энэ үе нь Монгол үндэстний нэгдмэл улсын өмнөх цаг хугацаа, түүний урьдач нөхцөл бүрэлдсэн зурвас үеийг хамардагийн хувьд эрдэмтэд, судлаачдын анхаарлыг ихэд татаж ирсэн ба одоо ч татсаар байна. Иймээс ч эл үеийн Монголчуудын амьдрал, төрийн түүхийн баримт, мэдээлэл түүхэн сурвалж бичиг, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд чамлахааргүй бичигдэн үлдэж, бас энэ чиглэлээр олон бүтээл туурвигдан хэвлэгдэж, өдгөө ч улам арвижсаар байна.

Монгол ханлиг, аймгуудын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичигт анхдагч баримт, мэдээлэл агуулж буй бүтээлүүд тодорхойлогч байр суурь эзэлнэ. Энд юуны өмнө монголчуудын тухай анх удаа өргөн мэдээлэл өгсөн “Монголын нууц товчоо”, “Алтан дэвтэр”, “Судрын чуулган”, “Алтан товч” мэт суурь бүтээлийг авч үзэх нь чухал юм. Цэндийн Дамдинсүрэнгийн хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр орчуулан 4 удаа хэвлүүлсэн “Монголын нууц товчоо”, ялангуяа түүний дөрөв дэх удаагийн хэвлэл /1990 оны/, академич С.Цэрэнсодном нарын “Монголын нууц товчоо” /Эрдэм шинжилгээний орчуулга тайлбар/ хэмээх 2003 оны хэвлэл нь ач холбогдол бүхий сурвалж бичиг болно. “Монголын нууц товчоо”-ны 282 зүүлийн 201 зүйл номын бүх хуудасны 70 хувь нь монгол аймаг, холбооны түүхийн асуудалд зориулагдсаныг анхаарууштай юм. Энд монгол овог, аймгуудын түүх, монголчуудын ялангуяа Тэмүжиний удам гарал, IX-XII зуунд монгол нутагт оршин тогтнож байсан ханлиг улс, аймгийн холбоо, аймгуудын тухай, төрийн удирдлага, засаглал, түшмэд, хууль журам, эрхлэх аж ахуй, соёл заншлын тухай дэлгэрэнгүй өгүүлсэн нь эл үеийн төрийн түүхэнд холбогдох сурвалж бүхий чухал учир холбогдолтой ажгуу.

Ираны их түүхч Рашид-ад-Дины 1300-1310 онд “Алтан дэвтэр” хэмээх монгол зохиолыг ашиглан туурвин бүтээсэн “Судрын чуулган” гурван боть зохиолын тухай дурдахгүй байж яахин болох билээ. Нэн өвөрмөц хэл, найруулга, үлэмж баялаг агуулга бүхий энэхүү овог, аймаг, ханлигууд, тэдгээрийн үүсэл хөгжил зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааны талаар асар өргөн баримт, мэдээлэл буй нь эл үеийн төрийн түүхийг судлахад нэн үнэ цэнэтэй бөлгөө.

Үүнийхээ хувьд “Судрын чуулган” зохиолын эхний хоёр боть нь эл үеийн төрийн түүхийн чухал сурвалж бичиг мөн болой.

Монгол ханлиг, аймгуудын төрийн түүхийг судлахад сурвалж бичигт “Монголын нууц товчоо”-ны ихэнх мэдээллийг багтаахын хамт олон шинэ баримт, үйл явцыг оруулан гүүш Лувсанданзангийн туурвисан “Эртний хаадын үндэслэсэн төр, ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч оршвой” шастир зүй ёсоор хамаарагдана. “Алтан товч”-ын агуулгын ихэнх нь IX-XII зууны монголчуудын удам угсаа, монголчуудын нийгмийн зохион байгуулалт, төрийн уламжлал, заншил, ёс суртахуунд холбогдох үнэтэй мэдээлэл багтааж буй билээ. Өөр нэгэн төрийн түүхийн эх сурвалжид IX-XII зууны Монгол ханлиг, аймгуудын талаар дагнасан судалгаа хийж туурвисан нэгэн сэдэвт зохиолууд хамаарагдана. В.Я.Владимирцовын туурвисан “Монголчуудын нийгмийн байгуулалт”¹, Монголын нүүдлийн феодализм” үүнд багтах хамгийн дорвитой бүтээл мөн. В.Я.Владимирцов энэхүү бүтээлдээ XII зууны эцсээр монгол нутагт оршин байсан нийт аймгуудын нийгмийн байгуулал, хөгжлийн хандлага, монголчуудын эрхлэх аж ахуй, түүний түвшин, соёл заншилд судалгаа хийснээ нэгтгэн дүгнэж өгүүлсэн бөлгөө. Монгол аймгууд, тэдгээрийн нэгдэл, нэр, зохион байгуулалт, гарал угсаа, оршин буй нутаг дэвсгэр, эрхлэх аж ахуйн талаар тодорхой өгүүлсэн нь нэн үнэтэй болно. Академич Ч.Далайн туурвисан “Хамаг Монгол Улс” /1101-1206/ гэсэн судалгааны зохиолыг “Монголын түүх” хэмээх цуврал бүтээлийн тэргүүн дэвтэр болгон 1996 онд хэвлүүлсэн нь XII зууны эхээс XIII зууны эх хүртэл оршин тогтнож байсан хамгийн том “Хамаг Монгол” ханлигийн түүхийг бүхэлд нь багтаасан.

Энэхүү бүтээл нь тус хаант улсын үүсэл хөгжил, төрийн хэлбэр, төрийн байгууллага, түшмэдийн ёс, засаг захиргааны хуваарь, цэргийн зохион байгуулалт, эх сурвалж, шинж чанар, ач холбогдлын талаар өргөн мэдээлэл бүхий чухал сурвалж мөн. Мөн энэ чиглэлээр хятад хэлээр бичигдсэн Ван Говэйн “Татарын судалгаа” болон “Монгол-Татарын бүрэн тэмдэглэл”, “Дөрвөн ойрадын намтар түүх” Лю Женсогийн бичиж хэвлүүлсэн “Чингис хааны эзэнт улс байгуулагдахаас өмнөх монголын нийгмийн байгууламж”, Хаганчулууны “Хабул хааны гавьяа зүтгэлийг магадлах нь”, Алтан-Оргилын “Ойрадын түүхэн сурвалж бичиг”, Ж.Өлзийн “Барга монголын түүх”, Г.Е.Грум-Гржимайлогийн “Баруун монгол ба Урианхайн хязгаар”, Пэн Дая, Сюй Тин нарын “хар татарын хэргийн тэмдэглэл”, Вада Сейн “Урианхайн гурван хязгаарын тухай” бүтээл нь IX-XII зууны монгол ханлиг, аймгуудын түүхийн сурвалж зохиолд хамаарагдана. IX-XII зууны Монгол ханлиг аймгуудын түүхийн сурвалжид монгол улсын түүхийн тулгуур зохиолууд багтана. Эдгээр нь А.Амарын “Монголын товч түүх” /1992/, Ч.Бат-Очирын “Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон

тэмдэглэсэн бичиг”/1928/, Л.Дэндэвийн “Монголын товч түүх”/1934/, Орос-Монголын эрдэмтдийн хамтын бүтээл “БНМАУ-ын түүх” нэгэн боть /1954/, “БНМАУ-ын түүх” тэргүүн боть /1966/, Монгол эрдэмтдийн дагнан бичсэн “Монгол улсын түүх” /2003/ зохиолууд болно. Монголын түүхийн дээр дурдсан зохиолуудад IX-XII зууны монгол ханлиг, аймаг тус бүрийн түүхийг тусгай хэсэг бүлэг болгон бичсэн учир төрийн түүхийг боловсруулахад суурь ач холбогдолтой бүтээлүүд мөн.

Монголын түүхийн эрдэмтэд, судлаачдын туурвисан эрдэм шинжилгээний бүтээлүүдэд IX-XII зууны монгол ханлиг, аймгуудын түүхэнд холбогдох үйл явдлын тухай өргөн дэлгэр бичсэн нь бий. Жишээлбээс Ш.Нацагдоржийн “Монголын феодализмын түүхэн замнал” /1978/, “Чингис хааны цагид” /1992/, Г.Сүхбаатарын “Монголчуудын эртний өвөг”/1980/, Н.Ишжамцын “Монголд байсан эртний аймгуудын удам угсааны хамаарлын асуудалд” /1965/, М.Санждоржийн “Монгол төрийн түүхээс” XIII-XIX зуун /1998/ Д.Гонгорын “Халх товчоон” II боть /1978/, Ч.Далайн “Монголын түүх Их Монгол улс” /1206-1260/, Ч.Жүгдэрийн “Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улстөр, гүн ухааны сэтгэлгээ” /1987/, Ж.Цэвээндоржийн “Дархад, Урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Цахар, Дарьганга, Хасаг, Халимагийн гарал, үүсэл байдлын тухай” /1992/, Сурбадрахын “Монголын үндэстний язгуур үүсэл” /1988/, А.Очир, Т.Дисан нарын “Монгол улсын өөлдүүд” /1999/, Сайшаалын “Чингис хааны товчоон” тэргүүн дэвтэр /1985/, А.Ю.Якубовскийн “XI-XII үеийн монголчуудыг судалсан түүхээс” /1953/ зэрэг бүтээлүүдийг юуны өмнө дурдаж болох юм.

Дээрхи бүтээлүүд нь өөрийн зарим бүлэг хэсэгтээ IX-XII зууны үеийн монгол ханлиг, аймгуудын тухай тодорхой баримт, мэдээллийг дурдсан байдаг.

Хөрш орнуудын төрийн түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн үйл явдал, мэдээлэл энэ үеийн төр, эрх зүйн түүхийг боловсруулахад чухал баримт, хэрэглэгдэхүүн болж байна. Ялангуяа Хятад улс, Алтан улс, Сүн улс, Тангуд улс, Уйгур улс, Ляо улс, Хорезм улс, Иран, Сири, Дундат Азийн улс орнуудын түүх, шастирт эл үеийн монгол аймаг, ханлигуудын талаар нилээд мэдээлэл тэмдэглэн үлдсэн агаад эдгээрийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага бий бөлгөө. Ийм мэдээллийг хичнээн нарийвчлан судалбал эл үеийн төрийн түүхийг төдий чинээ сайн боловсруулж бичих боломж нэмэгдэх учиртай.

Сүүлийн жилүүдэд IX-XII зууны Монгол ханлиг, аймгуудын түүхэнд холбогдох хууль зүйн судалгаа, шинжилгээний ажил дэс дараатай явагдаж багагүй амжилт олсон болой. Түүний дотроос Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын бичсэн “Монголын төр, хууль цаазын түүхэн уламжлал” /1997/, Л.Дэндэв нарын “Монголын эрт, эдүгээгийн хууль цаазын түүх” /1936/, И.Дашнямын “Чингисийн хаант улсын төр, хууль цааз”

/1997/, Г.Баярхүүгийн “Монголын нэгдсэн улсын төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” /1997/, Н.Лүндэндоржийн “Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага” /2002/, С.Нарангэрэлийн “Монголын эрх зүйн түүхэн тойм.

Монголын эрх зүйн хөгжлийн он дараалал, үндсэн үе шат, Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал” /2001/, Х.Сэлэнгийн “XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл” /2004/ зэрэг бүтээлийг онцлон дурдаж болно. Дээр дурдсан бүтээлүүд IX-XII зууны Монгол ханлиг, аймгуудын төр, эрх зүйн түүхэнд холбогдох баримт, мэдээллийг ямар нэг хэмжээгээр дурдсан байдаг бөлгөө.

IX-XII зууны монгол ханлиг, аймгуудын түүхэнд хамаарах археологийн олдвор, түүх дурсгал, эд өлгийн зүйлс ялангуяа Хамаг монгол, Хэрэйд, Найманы ханлигийн түүхэнд холбогдох биет материал, бичиг, соёл урлаг, утга зохиолын дурсгалууд нилээд буй нь түүхэн чухал ач холбогдолтой болно.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монгол угсаатны гарал, аймгууд

§1. Монгол² угсаатны удам, гарал

Монголын эртний улсуудын сүүлчийн улс болох Хятан гүрэн 1125 онд мөхсөнөөс хойш Монголчууд өөрийн нутаг дэвсгэр дээр аймаг, ханлигуудын зохион байгуулалтад орж оршин тогтнох болжээ. Эдгээр нь бүхэлдээ Монголын нэгдсэн улс байгуулагдахын өмнөх үеийн Монгол аймаг, ханлигууд байсан бөгөөд 80 гаруй жилийн турш ийм зохион байгуулалтаар монголчууд аж төрж амьдарч агсан болой. Эл үеийн аймаг, ханлигуудын түүх нь овгийн байгуулал задарч, цусан төрлийн бус нэгдлүүд үүссэн тэр цагаас хойш бүрэлдэн бий болсон аймгуудын хөгжлийн үргэлжлэл нь бөлгөө. Ираны их түүхч Рашид-ад-Дин Монгол аймгуудын удам, гарлын хөгжлийг гурван үед хуваан авч үзсэн байдаг билээ. Тэрбээр 1310 онд бичиж дуусгасан “Судрын чуулган” хэмээх түүхэн зохиолдоо Монгол аймгуудын удам, гарлыг *нэгдүгээрт*, монголчууд хэмээн нэрлэгдээгүй байсан улс түмнүүд, *хоёрдугаарт*, монголчууд хэмээн нэрлэгдсэн улс түмнүүд, *гуравдугаарт* язгуур монголчуудын улс түмэн гэж гурван хэсэгт хуваасан байна /46.45-47/. Энд улс түмнүүд гэж нэрлэсэн нь ерөнхий нэр бөгөөд энэхүү нэрийн дор олон салбар овог, аймгууд байсан ажээ.

Монголчууд хэмээн нэрлэгдээгүй байсан улс түмнүүд нь одоо монголчууд гэж нэрлэгддэг боловч чухам тэр цагтаа ямар ч нэргүй байсан аймгууд юм. Эд нь “монгол” гэж нэрлэгдээгүй ч монгол удмын эхний нэгдлүүд болно. Үүний дараагийн үед “Монгол” гэдэг нэр гарч ирснээр эл үеийн улс түмэн /аймгууд/ нь “Монгол” хэмээх ерөнхий нэртэй болсон байна. Тэгэхдээ энэ нэрээр монгол удмын ба Монгол бус удмын хүмүүс болон аймгийг “Монгол аймгууд” “Монголчууд” гэж ерөнхийд нь нэрлэдэг байжээ. Энэ л ерөнхий нэрийн дор Монгол аймгууд оршин хөгжсөөр байсан ажээ. Харин язгуур Монголчууд гэсэн нэрийн дор зөвхөн Монгол удмын монгол гаралтай аймгууд хамрагдах болсон байна. IX-XI зууны Монгол аймаг³, ханлигууд язгуур монголчуудын улс түмэнд багтах авай. IX-XII зууны Монгол үеийн монгол аймаг, ханлигуудын⁴ түүхийг авч үзэхдээ монгол нутагт оршиж байсан эртний улсуудын түүхийг үл хэрэгсэн түүнээс салангид авч үзэж байгаа хэрэг бус бөлгөө. Харин эл үеийн аймаг, ханлигуудын түүхийг монгол нутагт овгийн байгуулал задарч цусан төрлийн бус аймаг, холбоод үүсэж, дараа нь бие даасан улс, гүрнүүд байгуулагдан хөгжиж ирсэн түүхэн уламжлалын үр дүн болгон өөр цаг хугацаанд /1400 гаруй жилийн дараа/, хөгжлийн өөр түвшин /монголчууд, монгол угсаатай аймаг, улсын хүрээ рүү улам нягтран орж, хөгжлийн дараагийнхаа шатаа бэлтгэн, түүн рүүгээ сааралгүй явж байгаа/-д авч үзэж байгаараа онцлог юм.

Монголчуудын түүхийн эл 80 жилийн хугацаа харьцангуй богинохон мэт санагдавч, бас монголчууд бутарч, тархай аймгууд болон дорой буурай байсан мэт харагдах боловч хөгжлийнх нь үйл явцын хандлага, үр дүн, дотоод амьдрал, хүмүүсийн сэтгэл санаа, бодол төлөвшилд гарсан өөрчлөлт нь эрс эргэлт хийх нөхцлийг хангаж өгснөөрөө агуу гайхамшигтай хэмээн үзэж болмуй. Энэ хугацаа бол монголчуудын хувьд нийгмийн их ухаарал, сургамжийн жилүүд, монгол угсаатан бүрэлдэхэд хэрэгтэй нийгэм, оюун санааны нөхцлүүд бэлтгэгдсэн жилүүд байжээ. Чухамдаа монголчууд монгол угсаатан болж нэгдэж амьдрахын эрхэмсэг оршихуйг энэ л жилүүдэд ухааран цэгцрэх чигийг олсон бөлгөө. Энэ бүхэн нь монгол нутагт эртний улсуудын үүсэн хөгжиж тэдгээрийн хөгжил, тасралт явагдаж, бас монголчууд хөгжлийн энэ их далай дотор зүг чигээ олж, удам угсаагаа бэлтгэн үлдээж, улмаар тэдэнд амьдарч аж төрөхүйн арга ухааныг суулгаж, үрийг нь тарьж ургацыг нь амтлуулж ирсний үр шим мөн юм.

Иймээс IX-XII зууны Монгол аймаг, ханлигуудын түүхийг өмнөх /эртний улсуудын түүх/ ба дараагийн /Монголын нэгдсэн улсын/ түүхийг холбож алтан гүүр нь болж байсныг хичээнгүйлэн анхаарч болгоох нь зүйн хэрэг болов уу. Энэ утгаар нь нягтлаад IX-XII зууны монгол аймаг, ханлигуудын түүхийг тусгайлан нэгэн анги болгож, тэдгээрийн төр, эрх зүйн түүхийг товч үзэхийг зорьсон болой.

IX-XII зууны Монгол аймаг, ханлигуудын төр, эрх зүй нь Монгол улсын төр, эрх зүйн түүхийн салшгүй нандин хэсэг, нэн өвөрмөц онцлогтой бөгөөд түүхийн урт хугацаатай харьцуулахад бага хэдий ч тэр чигээрээ бие даасан зурвас үе болно.

IX зуунаас хойшхи Монголаймаг, ханлигуудын хөгжил, түүний түүх нь Монголын нэгдсэн улс байгуулах урьдач нөхцлийг бүрэлдүүлж, 1206 он хүртэл үргэлжилсэн бөлгөө. Монгол аймаг, ханлигуудын түүх нь Монгол улсын төрийн түүхийн салшгүй хэсгийн хувьд судлаачдын анхаарлыг ихэд татаж, тэдгээрийн судалгааны нэг чухал объект болж үр дүн нь олон ном зохиолд бичигдэн үлдсэн болой. Энэ тухай өмнөх бүлэгт дэлгэрэнгүй дурдсан бөлгөө. Сурвалж бичгүүдэд тэмдэглэснээр “Бөртэ-Чино”⁵ нь Монгол овогтон аймгийн холбооны ахмад удирдагч нь мөн бөгөөд түүний шууд харъяалж байсан аймгуудыг Монгол буюу Монгол овогтон гэж нэрлэж байжээ /29.10/. “Бөртэ-Чино”-ын дараа түүний хүү Батцагаан гол Монголыг захирсан зонхилогч болж “хан” хэмээх цолтой болсон аж /39.31/. Үүнээс хойш Чингис хаан хүртэл 22 үе, “Бөртэ-Чино”-оос Чингис хаан хүртэл 24 үе туулсан хэмээн “Монголын нууц товчоо”-д тэмдэглэсэн байдаг бөлгөө. “Бөртэ-Чино”-ын захирч байсан Монгол нутаг нь Бурхан Халдунаас Онон, Хэрлэн, Туул голын дагуу оршиж, “Язгуур Монгол”⁶-ын нутаг дэвсгэр болон төвхнөх үйл явц эхэлсээр XII зууны дунд үед жинхэнэ ёсоор биелэлээ олсон ажгуу. Монголыг захирч байсан Батцагаан⁷ ханы дараа Монгол аймгийг түүний шууд угсааны Тамача, Тамачийн хөвгүүн Хоричар мэргэн, Хоричар

мэргэний хүү Уужим Борхул, Уужим Борхулын хүү Салы Хачау, Салы Хачаугийн хүү Их Нүдэн, Их нүдэнгийн хүү Сэмсочи, Сэмсочийн хөвгүүн Харчу нар захирч байжээ. Харчугийн хөвгүүн Боржигидай мэргэнээс Монгол овог, аймгийн дотор тодорхой шинэ үе эхэлжээ /32-31/. “Бөртэ-Чино”-ын ес дэх үеийн ач Харчугийн хүү Боржигидай мэргэн⁸ нь язгуурын Монгол аймгийн гол цөмийг бүрдүүлсэн дарилгин салбарын хиад ястны ахлагч байжээ. Түүний хатан Монголжингоо нь ойн иргэний угсаа агаад тэр нь Монгол туургатны нэгэн болох Хори түмэд аймаг мөн бололтой. Монголжингоогоос Борогчингоо төрсөн нь хожим нь Торголжин баяны хатан болжээ.

Цаг үе улирч Борогчингоогоос Дува сохор, Добу мэргэн⁹ хоёр хүү төржээ.

Добу мэргэн нь “Бөртэ-Чино”-ын аравдахь үеийн ач, Чингис хааны арван нэг дэх үеийн дээд өвөг болно. Добу мэргэн Гурван гол, Бурхан Халдун уулын хавиар нутаглан язгуур Монгол аймгийг захирч байгаад насан эцэслэсэн байна. Тэр цагийн Гурван голын монголчууд нь овог, аймаг, аймгийн холбоо, их гэр бүлээрээ салж аж төрөн тус бүрдээ тэргүүлэгч, зонхилогч, газар нутагтай болсноор шинэ нийгмийн үр хөврөл боловсорч эхэлж байсан байна /34.46.47/. Эл үйл явц XI-XII зууны туршид үргэлжилж, монголчууд “хээр талын нүүдэлчин аймаг”, хөвч тайгын “ойн аймаг” хэмээн ялгарах болсон аж. Добу мэргэн нас барсанаар язгуур Монголын ханы суурь Дарилгин Монголоос¹⁰ Нирун Монголд шилжсэн байна /34.47/. Нирун Монгол¹¹ гэдэг бол Алунгоогийн ариун нуруунаас гэрлээр төрсөн хөвгүүдийн залгамж удам гэсэн утгатай /34.47/. Доктор Г.Сүхбаатар “Монгол Нирун улс /330-535/” зохиолдоо “Монгол Нирун улсын Чаругуй хаан барагцаалбал МЭ IY зууны үеэр Алунгоогийн домгийг баримталж, аймгаа “Нирун” гэж нэрлэсэн байна. “Нирун” гэдэг нь нэгэнт дээр өгүүлснээр тэр үед уг нэрийг галиглан тэмдэглэсэн “жоужань” гэх хятад утга үгсүүдийн эртний дуудлагыг баримтлан нөхөн сэргээсэн худам монгол бичгийн “Ниругун” гэдэг үг мөн бөгөөд орчин үеийн дуудлагаар “нуруу /н/” гэсэн үг юм. Энэ “Нирун” гэдэг нэр нь Чингис хаанаас өмнөх үед “Нирун” гэсэн дуудлагатай болсныг Рашид-ад-Дин зохиолдоо авч хэрэглэжээ” /51.174/ хэмээн тайлбарласан байдаг билээ. Нирун овгийн тухай Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо “Алунгоогийн овгоос түүний нөхөр буюу Добу баян үхсэнээс хойш гарсан аймгуудыг Монгол Нирун гэдэг. Нирун гэдгийн утга нь /персээр/ “Солб”/нуруу/ юм” /46.152-153/.

Алунгоогийн ариун нуруунаас гарсан гэх домогтой. Нирунчуудын дотор гурван ялгавар байсныг доктор Д.Гонгор “Халх товчоон” хэмээх зохиолынхоо II ботид тодорхой дурдсан нь бий. Тэрбээр Алунгоогоос Хабул хааныг хүртэлх үеийг нийтэд нь “Нирун”; Хабул хааны хүү дүү нар, ач нарын үеэс Есүхэй баатар хүртэлхийг “Нирун хиад”; Есүхэй баатар, Чингис хаан тэргүүтэн болон түүний хөвгүүдийн удам угсааг “хиад-боржигон” хэмээн тус тус нэрлэдэг байжээ /18.69.70/.

Добу мэргэний хатан Алунгоогоос төрсөн Бэлгүнэтэй, Бүгүнүтэй хоёрын үрс нийлж Дарилгин Монгол, Буха хатаги, Бухату салж, Бодончар гурваас “Нирун-Монгол”¹¹ үүссэн байна. Боржигидай мэргэнээс Бэлгүнүтэй, Бүгүнүтэй овогтон хүртэл дөрвөн үе өнгөрсөн ажээ. Алунгоогийн сүүлийн гурван хөвгүүний нэрээр Хатагин, Салжиуд, Боржигон гурван гол овогтон үүссэн түүхтэй болой. Чингис хааныг Бодончарын есдүгээр үе гэдэг. Бодончар нь хиад яснаасаа салаагүй зөвхөн ах нараасаа салж боржигин овогтонг бий болгосон ажгуу. “Монголын нууц товчоо”-нд өгүүлснээр Бодончараас 16 овог салбарлан гарчээ. Монгол аймгуудын гарал үүсэл нь Байгаль нуураас урагш Ляодунгийн хойг хүртэлх өргөн уудам нутагт манай эриний өмнөх I, II зуун ба манай эриний анхны хэдэн зуун жилд аж төрж байсан нүүдэлчин овог аймгийн ихэнх нь Монгол хэлээр ярилцаж байсан цаг үеэс эхлэлтэй болой. Эдгээрийн нэн холын хуланц дээдсийг эртний сурвалж бичигт нийтэд нь “Дорнот ху” хэмээн нэрлэдэг байсан ажээ. Эдгээр ху нараас гаралтай Сяньби нарыг Шивэй аймгуудын дээдэс хэмээн эрдэмтэд, судлаачид үздэг бөлгөө. Сяньби гэдэг үг сунжирснаас Шивэй хэмээх нэр гарсан хэмээн үздэг судлаачид ч бий. Одоо эрдэмтэд Монгол шивэй /Мэн-Гу шивэй/-г Монголчуудын элэнц дээдэс мөн болохыг санал нэгтэй зөвшөөрөн хүлээх болжээ. Монгол аймгууд YIII зууны үед олон удаа нийлж, салж, заримдаа нутаг сэлгэн хол, ойр нүүдэллэх, дахин буцаж ирэх зэргээр зохион байгуулалт муутай тархан нутаглаж байснаа IX зууны үед Монгол газар нутагт төвлөрч, Хятан улсын /907-1125/ үед Онон, Хэрлэн, Туул гол, тэдгээрийн эрэг хавь, Хэнтийн /Бурхан Халдун/ уулсаар нутаглах болсон байна. Монгол аймгууд нийлж нэгдэх, задрах, алслан нүүх, бусдын эрхшээлд орох, дайн тулааны явцад устаж үгүй болох зэргээр хөдөлгөөнтэй байлаа ч гэсэн тооны хувьд төдий л цөөн бус байсан ажээ. Түүхэн сурвалж бичиг, судалгааны зохиол, бүтээл дэх баримтуудыг нягтлан үзэхэд XII зууны эцэс гэхэд Монгол нутагт 80 гаруй Монгол аймаг оршиж байсан болой. Эдгээр аймгууд нутаг дэвсгэр, хүн ам, соёл, зан заншил, хөгжлийн түвшингээрээ харилцан адилгүй байсан байна. Оросын нэрт эрдэмтэн В.Я.Владимирцов “Монголчуудын нийгмийн байгуулал” хэмээх зохиолдоо Монгол аймгуудын талаар судалгаа явуулаад “хээр талын малчин аймгууд”¹² ба “ойн аймгууд”¹³ гэсэн хоёр үндсэн төрөлд хуваасан байдаг.

XII зууны II хагаст Монгол нутагт оршиж байсан зарим гол аймгуудыг дурдвал: Хиад Боржигон, Тайчууд, Уруд, Мангуд, Дөрвөн, Баарин, Жадран, Урианхай, Хээрийн баяд, Жийдийн баяд, Дуклад баяд, Горлос баяд, Хиад-баяд, Ихэрэс Хонгирад, Горлос Олхонуд, Илжигин, Зүрхэн, Хатагин, Салжиуд, Дөрвөн, Удиуд Мэргэд, Увас Мэргэд, Хаад Мэргэд, Жалайр, Ойрад, Ойн Урианхай, Кори /хори/ барга, Тулас барга, Тумат /түмэд/ барга, Тутукумут Татар, Алчи Татар, Цагаан Татар, Дутау Татар, Алухай Татар, Айурит Татар, Буриут Татар, Урасуд, Тэлэгүд, Куштейм гэх зэргээр нэрлэж болно.

Гэлээ ч гэсэн Монгол аймгууд нь угсаа удам, нүүдлийн соёл иргэншил, эрхлэх аж ахуй, эдийн үндэс суурь, Монгол хэл, ерөнхий төрх байдал, зан заншил, сэтгэл зүй зэрэг олон гол шинжээрээ нийтлэг нэгэн хэв маягт багтаж байсан ажгуу. Монгол аймгууд нь Алтай язгуурт багтах ерөнхий Монгол хэлээр харилцаж, нүүдэллэн амьдардаг, нүүдлийн соёл иргэншилтэй ард түмэн байсан бөлгөө. Монгол аймгуудын эрхлэх нийтлэг гол аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй байв. Ойн аймгуудаас бусад нь, өөрөөр хэлбэл Монгол аймгуудын дийлэнх нь мал аж ахуй эрхлэн, таван хошуу малыг өсгөн үржүүлж хэрэгцээгээ хангадаг байжээ. Таван хошуу малын аль сүргийг нь голлон өсгөхөө өөрсдийн хэрэгцээ, ашиг сонирхлыг харгалзан шийддэг байсан байна. Ан агнах, гар үйлдвэр, худалдаа арилжаа хийх, мал, ангийн арьс шир, ноос үс, мах, сүү саалийг заншил уламжлалынхаа дагуу боловсруулах, ашиглах, хэрэглэх нь туслах шинжтэй байсан хэдий ч Монгол аймгуудын амьдралд мал аж ахуйтайгаа салшгүй холбоотойгоор монголчуудын амьдралд зайлшгүй чухал үүрэг гүйцэтгэж байсан ажээ. Ойн аймгуудын амьдралын гол зүйл нь ан агнаж, мах, арьс шир, үс, сүү, шимийг ашиглах, гэр ахуй, хувцас хунарын хэрэгцээг хангах, явдал байжээ. Ойн аймгууд, тэдгээрийн харьяатын зарим нь мал маллахыг ан агнууртай хослуулж, ой, тайга, цаст уулын нутгаасаа тал нутаг руу нүүдэллэх үйл явц аажим боловч тасралтгүй явагдаж байсан ажээ.

Монгол аймгуудын дотор багтсан бүлэг, их, бага өрх гэрүүд дор бүрнээ өмч, мал хөрөнгөтэй болох, түүнээ угсаа залгамжлан өвлүүлэх, мөн түүнээсээ алба, татвар төлөх зэргээр хувийн өмчөө бүрэлдүүлэн бэхжүүлж бас хамгаалж байжээ.

§2. Монголчуудын аймгийн холбоо

ҮШ-IX зуунаас Монгол нутагт аймгуудын холбоо¹⁴ байгуулагдаж улсын шинж бүхий нэгтгэл бий болж эхэлжээ. Чухамдаа энэ үеэс нийт Монголын хөгжлийн төв энд шилжин ирсэн болой. Монгол аймгууд асар өргөн уудам газарт нутаглаж байсан ч түүнээс Онон, Хэрлэн, Туул гол буюу гурван голын сав газар нь Монгол туургатны өлгий нутгийн төв хүйс нь болж байсан ажээ. Чухам энэхүү газар нутагт Монголчуудын гол овог аймгууд төвлөрөн нутаглаж байсан агаад энэ нь тал, хангай хосолж, ус, өвс ургамал нь жигдэрсэн, үржил шимтэй, үзэсгэлэнт сайхан нутаг, ан гөрөө элбэг, амьдарч аж төрж, хөгжин дэвжихэд үнэнхүү тохиромжтой үзэсгэлэнт төгс байгаль орчин байсантай холбоотой бололтой. Гурван голын сав газар нь Монгол нутгийнхаа төвд оршиж байсан бөгөөд энд аж төрөн амьдарч агсан Монгол аймгууд Монголын түүхийн тавцанд тэргүүлэх байрыг эзэлж, улмаар Монголын нэгдсэн улсыг байгуулах гол цөм нь болжээ. Энэ цагаас Монгол аймгуудыг “жинхэнэ монгол аймгууд”, “Монголжуу монгол аймгууд” хэмээн ялган нэрлэх болсон байна.

“Жинхэнэ Монгол” аймаг нь язгуурын монголчуудаас бүрдэнэ. Язгуурын монгол нь Дарилгин, Нирунаас салбарлан үүссэн төв монголчууд болно. Чингис хаанаас өмнө Нирун Монгол нь Хиад, Тайчууд, Жадаран аймагт харъяалагдан, голдуу Бурхан Халдун уулаар Онон мөрний эх ба доод урсгалаар нутаглаж байжээ. Дарилгин Монгол нь голдуу Урианхай, Хонгирад, Баядууд аймгуудаас бүрдэж, Бурхан Халдун уулын хавиар нутаглаж байсан аж.

Монголчуудын аймгийн үүсэл нь бүр “Бөртэ-Чино”-оос аравдахь үе болох Добу мэргэний бэлбэсэн хатан Алунгоогоос төрсөн хүү Бодончарын үеэс эхлэлтэй бөлгөө. Бодончар¹⁵ нь X зууны эцэс орчмоор Монгол аймгуудын дийлэнх /34-52/ болон зарим ах захгүй иргэдийг нэгтгэн захирч байсан нь Монголчуудын аймгийн холбооны анхны үүсгэл байсан аж. Тэр үед Бодончарын нэгтгэн захирч байсан Монголчууд нь “аймгийн холбоо”-нд орж нэгдсэн байна. Энэхүү холбоог XI зууны үед Хятан нар “Монгол улс” хэмээн нэрийдэж байжээ. Энэ нэрээр түүхэнд тэмдэглэгдэж, дотоодын аймаг, холбоо, Хятадын Сүн улс, Алтан улс болон Дундаг Азийн улсуудтай эдийн засаг соёлын талаар харилцаж, элч төлөөлөгч солилцон, худалдаа арилжаа хийж, цэргийн тусламж үзүүлж байсан байна. Алтан улс, Сүн улсын довтолгоонд доройтож байсан Хятан улсад Монгол улс 1122 онд 50000 цэрэг гарган тусалж байжээ /87.139/.

Хятан гүрэн задран мөхсөний дараагаар Монгол аймгуудын түүх, нийгэм эдийн засаг, соёлын хөгжилд жинхэнэ Монгол төрх, Монгол нутаг дахь хүн, байгалийн харилцан шүтэлцээ, хамаарлыг илэрхийлсэн өвөрмөц өөрчлөлтүүд гарч, тархмал байдлаар оршин байсан том, бага аймгууд нэгдэн томоохон бүлэглэлүүд болох “аймгуудын холбоо” бүрэлдэн бий болох үйл явц явагдсан байна. Ийм холбоодыг Хамаг Монгол улс, Хэрэйдийн ханлиг, Найманы ханлиг тэргүүлж, бусад холбоод болох Татарын холбоо, Мэргэдийн холбоо, Ойрадын холбоо, Баядын холбоо, Хонгирадын холбоо, Баргын холбоо, Ойн иргэдийн холбоо зэрэг холбоо үүсэн бүрэлдэж оршин тогтнож байжээ. Дээрхи холбоо нь ханлиг, холбоо хэмээх хоёр төрөлд хуваагдаж байсан аж. Ханлиг нь “ханлиг” буюу “хант улс” гэсэн утгыг илэрхийлж, төр улсын хэмжээнд арай дөхсөн хэлбэр, нийгмийн хөгжлийн илүү түвшинд хүрсэн нэгдэл байжээ. Харин “холбоо” нь ханлигийн хөгжлийн өмнөх шатанд байсан нэгдэл юм. Монголын аймгуудын холбоод нь 2-8 аймгийг нэгтгэж байсан ажээ. Хотула ханаас хойш Хамаг Монголыг захирах эрх Есүхэй баатарт шилжжээ. Тэрбээр олонхи Монголчууд ба Тайчуудын эзэн /хан/ болжээ. Есүхэй үнэн хэрэг дээрээ 1170 оноос нилээд өмнө үед Хамаг Монголын өргөмжлөгдөөгүй хан болсон бөгөөд улсын тайш нь түүний ах Нэгүн байжээ /5.176/. Хамаг Монгол улсын сүүлчийн хан нь Есүхэйн Тэмүжин агаад тэрбээр 1189 оноос 1206 онд Хамаг Монгол улсын хан байсан байна. Чингээд монгол ханлиг, холбоодын тухай тусгайлан авч үзье.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монголын ханлиг /хант/ улс, аймгуудын холбоо

§1. Хамаг Монголын хант улс

Хамаг Монгол улс байгуулагдсан нь. Хамаг Монгол улс бол IX зууны 3 дугаар хагаст байгуулагдсан Монгол туургатны гол улс болно. Хамаг Монгол улсыг Хятадын түүхэн сурвалж бичигт “Да Мэн-гу”¹⁶ /Их Монгол/ хэмээн тэмдэглэсэн байдаг. Тайваны Монголч эрдэмтэн Хагаанчулуу “Да Мэн-гу” гэдгийг “Олонхийн гол улс” гэж орчуулсан нь бий. Судалгаанаас үзвэл 1130 онд Тумбиной сэцэний¹⁷ хүү, Чингис хааны элэнцэг Хабулыг¹⁸ гурван аймгийн ихэс ноёдын хуралдайгаар хаанд өргөмжлөн Хамаг Монгол улсыг байгуулсан байна. Хамаг Монгол улс нь X зууны эхээр Бодончарын байгуулсан аймгийн холбоо “Монгол улс” өргөжин хөгжсөний үр дүн, түүнийг залгамжлагч нь мөн юм. Дан Монгол туургатныг нэгтгэсэн Хамаг Монгол улс нь Алтан ургийн хаадын эхлэл, Монголын нэгдсэн улс байгуулах суурь бий болох эх үндэс болсон ажээ.

Хамаг Монгол улс байгуулагдах үед Дарилгин 16, Нирун 9 бүгд 25 аймаг түүнд нэгдэн орсон байдаг. Өөрөөр хэлбэл Хамаг Монгол улс нь 25 аймгаас бүрэлдэж байсан гэж хэлж болох юм. Жишээлбэл Хамаг Монгол улсын бүрэлдэхүүнд Нукус, Урианхан, Хонгирад, Хатагин, Салжиуд, Монгол, Тайчууд зэрэг аймгууд орж байжээ.

X-XI зууны үед Хамаг Монголын бүрэлдэхүүний нэг болох Дарилгин 18 аймагт Никүз, Урианхан, Хонгирад, Ихирэс, Олхонуд, Куралас, Илжигин, Хөнхийлүд, Урачуд, Хонхотон, Арулат, Хилингут, Кунжин, Үүжин, Сүлдэн, Илдуркин, Баядууд, Кингит аймгууд багтаж байв /20.39/.

XIII зууны өмнөх үеийн Нирун аймгуудад Боржигин, Жадран, Тайчууд, Салжиуд, Хатагин, Баарин, Барулас, Чинос, Ноёхон, Мангуд, Будагад, Хадархан, Оргуд, Бэсүд /ийсут/, Шишигүд, Дөрвөн, Тугулхуд /Дуклад/, Жүрхэн, Хонхотон зэрэг 19 аймаг орж байв./20-39/

Хамаг Монгол улсын нутаг дэвсгэр нь Байгаль нуураас нааш Хангайн нурууны хоёр тал, Орхон гол, Онон мөрөн, Туул гол, Халх голын хоёр хөвөө, Хөлөн нуур, Буйр нуур, Бурхан Халдун уулыг багтааж байжээ. Хамаг Монгол улсыг түүхэнд гурван голын Монгол, язгуур Монгол хэмээн нэрлэж байсан нь ч бий. “Төрийн хаантай, төрийн хуралдайтай, Хамаг Монгол улс байгуулагдсан нь цааш цаашдаа Монголчууд нэгдэн нийлж, хүчирхэг Монгол улс байгуулагдаж эхлэхийн суурь тавигдсан юм” /34.54/. Монголын төв хэсэг, гурван голын сав газарт Хамаг Монгол улс оршин тогтнож, жилээс жилд хүчирхэгжин хөгжсөөр Хятадын Алтан улстай эн зэрэгцэх түвшинд хүрч байсан удаатай.

Хамаг Монгол улсын түүхэнд XII зууны эцсээр Монгол аймаг, ханлигуудын хоорондын тэмцэл, сөргөлдөөн, бутрал сарнил, гаднын улсын өдөөн хатгалгаа, Татар, Хамаг Монголын язгуур угсаатны өс хонзонгийн улмаас хүч чадлаа алдаж мөхлийн ирмэгт тулж байсан зурвас үе тохиосон боловч түүнийг даван туулж чадсан түүхтэй.

Эл үе нь 20 гаруй жилийг хамарч Хамаг Монголын хаан Амбагайг¹⁹, Татарчууд баривчилж Хятадын Алтан улсад тушааж, цаазлуулж, оронд нь хаан болсон Есүхэй баатар 1150 оны орчим мөн Татарчуудад хорлогдон нас барж, улс нь эзэнгүй болон эзгүйрч, харъяат аймаг иргэд нь нутаг усаа хаяж нүүж байсан гунигт явдлыг агуулж байсан болой. Энэ үе 1189 онд Хамаг Монгол улс сэргээн байгуулагдаж, Есүхэйн хөвгүүн Тэмүүжин “Чингис” цолтойгоор хаанд өргөмжлөгдсөнөөр дуусгавар болсон бөлгөө. Түүхэн баримтаас үзэхэд Хамаг Монгол улс 1130 оны орчмоос 1206 он хүртэл 70 шахам жил оршин тогтнож байсан нь тодорхой байна. Хамаг Монгол улс нь Монголчуудын задрал, бутралыг даван туулах, Монгол туургатныг нэгтгэж нэгэн цул нэгдмэл улсыг байгуулахад гол цөм, мөхлөг нь болж, нэгдсэн улс бий болох нөхцлийг бүрдүүлэхэд түүхэн үүрэг гүйцэтгэн, бусад аймаг, ханлигуудын хөгжилд дорвитой түлхэц өгч, дагуулан манлайлж хүчтэй нөлөө үзүүлсэн ажгуу.

Хамаг Монгол нь нүүдлийн соёл иргэншил бүхий улсын уламжлалыг түшин, нүүдлийн мал аж ахуйг шүтэн эрхэлж, эдийн засгийн үндэс, эрхлэх аж ахуйнхаа гол салбар болгон хөгжүүлэхийн хамт, аж ахуйн бусад олон хэлбэрийг тэтгэн ашиглаж байсан байна. Монгол угсаатны уламжлалын дагуу таван хошуу мал сүрэг, ялангуяа адуу, үхрийг голлон өсгөн үржүүлж, мах, арьс, шир, ноос үсийг нь ашиглаж аж амьдралынхаа гол үндэс болгож байжээ.

Мөн ан агнах, гар үйлдвэр эрхлэх, бага зэргээр тариа тарих, худалдаа арилжаа хийхийг аж ахуйн эрхлэлтийнхээ чухал чиглэлүүд болгон хөгжүүлэхийг хичээж байсан байна. Хамаг Монгол улсад феодалын түрүү үеийн харилцаа хөгжиж, язгууртан, жирийн хүмүүсийн давхраа бий болох үйл явц гүнзгийрэн, ялгарал эрчимтэй явагдаж, хувийн өмч хөгжсөөр байжээ.

Язгууртнууд бэлчээр нутгийг хуваарилах, нүүдэл суудлыг зохицуулах, хүмүүсийг харц болгон харъяандаа оруулж мал сүргээ маллуулах, аж ахуйн ажил хийлгэх, гувчуур гаргуулах зэргээр янз бүрийн биеэр ажиллах, эд хөрөнгөөр алба гувчуур өгөх үүргийг тохих болсон аж. Ийм байдлаар эзэн харъяатын харилцаа гүнзгийрсээр байсан байна. Хөдөлмөрийн хуваарь нарийсч, анчин, гөрөөчин, тариачин, агтач, хоньчин, арилжаачин, урчин, хөтөч, буурч, зарц зэргээр ажиллах хуваариуд бий болж, язгууртнуудад өмч хөрөнгө хуримтлагдан, тэд хоорондоо өмч хөрөнгө, зэрэг зиндаа, нутаг бэлчээр, ашиг орлого, харъяат нарынхаа тоо хэмжээгээр өрсөлдөх болсон ажээ.

Хамаг Монгол, бусад аймаг, ханлигуудтай ч өрсөлдөх, Монголчуудын язгуур угсааг хамгаалах, гаднын хүчний эсрэг хүчээ нэгтгэн тэмцэхийг эрмэлзэх болсон байна. Хамаг Монгол улс Монголын нэгдсэн төр улсыг байгуулах гол цөм, мөхлөг нь болж, нэгдмэл улс байгуулах нөхцлийг бүрдүүлэхэд түүхэн үүрэг хариуцлага хүлээн, бусад аймаг, ханлигуудын хөгжилд ихээхэн түлхэц өгч, манлайлан дагуулах хүчтэй нөлөө үзүүлсэн ажээ. Хамаг Монгол улс гадаад улс оронд нөлөөллийн хүрээгээ өргөжүүлэх, нэр хүнд, хүч чадлаа өсгөн нэмэгдүүлэх, гадаад харилцаа холбоогоо бэхжүүлэх, гадаад худалдааг хөгжүүлэх, хил хязгаар, газар нутгаа хамгаалах, гаднын довтолгоог эсэргүүцэн тэмцэх, бусад улс орнуудтай байлдан цохилт өгөх бодлого явуулж багагүй амжилт олж байсан байна. Хил залган оршиж байсан Хятадын Алтан улс, Тангуд улс, баруун Ляо улстай хөршийн харилцаа тогтоох явдал гадаад харилцааных нь гол чиглэл болж байв.

Алтан улсын хаан Баян Агуда, Баян Үжимэй, Баян Та нар улам бүр хүчирхэг болж байгаа Хамаг Монгол улсын хаан Хабул, Амбагай нартай болгоомжтой харилцах, талдаа аль болохоор татах бодлого явуулж байсныг Хамаг Монгол улсын хаад мэддэг төдийгүй, сайн харилцаатай байхыг эрмэлзэж байжээ. Хабул хаан Алтан улстай харилцахдаа үндсэн гурван зорилго тавьсан байх юм. Үүнд: *нэгд*, Хамаг Монгол сүр хүчтэй гэдгийг үзүүлэх, *хоёрт*, Хамаг Монгол улсын нэр хүндийг олон улсын хэмжээнд өргөх, *гуравт*, Алтан улс, Монгол улс хоёр хөршийн ёсоор шударга харилцаа / Алтан улсад / мэдэгдэх явдал байжээ /34.56/. Алтан улсын хаан Баян Үжимэй 1135 оны эхэн үеэр Хамаг Монголд элч зарж, Хабул хааныг Алтан улсад айлчлахыг урьжээ. Энэ ёсоор Алтан улсын хаан Хабул хоёрын уулзалт 1135 оны орчим болсон байна /20.45/. Алтан улсын хаан Хамаг Монгол улсын хаан Хабул хоёр эвдрэлцэхийг дөхсөн ч Хабул хаан уучлал гуйж, сайн харилцаатай байхыг хэлсэнд Алтан улсын хаан түүнд өчүүхэн ч юм боддоггүй дүр үзүүлэн /92.35/ хүндэтгэн үджээ. Дараа нь Алтан улсын хаан дахин элч зарж Хабул хааныг хоёрдахь удаагаа зочлохыг урьсан ч Хабул хаан татгалзсан төдийгүй элч нарыг нь барьж цаазалсан байна.

Үүнээс хойш хөрш хоёр улсын харилцаа муудаж, дайтах байдалд шилжжээ. Алтан улсын цэрэг 1135 оны эцсээр Монгол руу довтолж ихээхэн хохирол учруулж байжээ. 1150 оны үед Алтан улс Хамаг Монгол улсын харилцаа улам хурцдаж, харилцан дайсагналцахад хүрсэн учир Амбагай хаан монголчуудын хүчийг нэгтгэж Алтан улстай тууштай тэмцэх зорилт тавьж байжээ. Хотула хааны үед Алтан улс, Хамаг Монгол улсын хооронд хэд хэдэн тулалдаан болж байсныг сурвалж бичигт тэмдэглэжээ. 1138 онд Алтан улсын цэргийн жанжин Хушаху Хамаг Монгол руу довтлон 1139 онд Монгол цэрэгт ялагдаад дахин 1140 онд довтолсон ч амжилт олоогүй байна. Дараа нь Ушу жанжин 1147 онд Хамаг Монгол улстай дахин байлдаад ялагджээ.

Энэхүү ялагдлын дараа Алтан улсын хаан Хамаг Монголд буулт хийж эвийн гэрээ байгуулахыг бичгийн түшмэл Сяо Бошоно-д тушаасан байна. Ингээд 1147 онд Хамаг Монгол улс ба Алтан улсын хооронд эвийн гэрээ байгуулж, Алтан улсын тал Хамаг Монгол улсад Алтан улсын 27 цайзыг өгөх, жил бүр тэрэгний үхэр, идэшний хонь, будаа, вандуй зэргээр алба өгөх, Хамаг Монгол улс хаантайг хүлээн зөвшөөрөхөөр заасан байна. Энэхүү гэрээ нь Хамаг Монгол улс Төв Азийн түүхэнд нөлөөтэй, хүчирхэг цэргийн зохион байгуулалттай улс байсныг харуулсан түүхэн нотолгоо мөн. Хамаг Монгол улсын хаад, Мэргэд, Хэрэйд, Найман зэрэг нөлөө бүхий ханлигтай холбоо тогтоож, харин Алтан улсын гар хөл болж байсан Татартай эрс тэмцэж байсан байна. Хамаг Монгол улс, Татарын хооронд үргэлжилсэн 70 жилийн тэмцэл, тулалдаан 1202 онд Чингис хаан Татарыг бүр мөсөн байлдан дагуулснаар дуусгавар болсон түүхтэй.

Төрийн байгуулал. Хамаг Монгол улс бол хаант улс мөн. Хамаг Монгол улсын анхны хаан агаад үндэслэн байгуулагч нь Хабул хаан болно. Хабул хаан нь Батцагаан/Батчахан/-ы 19 дүгээр ач, Бодончарын 8 дугаар үе, Боржигон овгийн хүн, Тумбинай сэцэний ахмад хүү бөлгөө. Монголын нууц товчооны 62 дугаар зүйлд “Хамаг Монголыг Хабул хаан мэдэн авав” хэмээн эл улсын засаглан захирагч, их эрх мэдэлтэн болохыг тодорхойлон дурдсан байдаг. Хамаг Монгол улсыг байгуулсан нь Хабул хааны Монголын түүхэнд байгуулсан хамгийн том гавьяа мөн юм /34.57/.

Хабул хаан өөрийн холбоонд багтах нийт аймгийн хүчийг нэгтгэн зангидаж, аж ахуй, соёлоо хөгжүүлж, гадаад улс, дотоодын аймаг, ханлиг улсуудтай өргөн харилцаа холбоо тогтоож, улсынхаа хүч чадлыг өсгөн нэмэгдүүлж, улс төр, засаг захиргаа, цэргийн шинэтгэл хийж, “Монголын түүхэнд их гавьяа байгуулсан улс төр, цэргийн том зүтгэлтэн байжээ”/34.57/. Иймийн учир түүхийн зарим сурвалж бичиг, ном зохиолд “Шинэчлэгч хаан”, “Олноор хэлэлцэх ардчиллыг тогтоогч” гэх зэргээр /34.57/ түүний авьяас билэг, хүч чадлыг үнэлэн хүндэтгэж байсныг дурдсан байдаг. Ираны их сударч Рашид-ад-Дин “Хабул хаан өөрийн аймгууд ба захирагдсан аймгуудын тэргүүн эзэн нь байсан тул Монгол аймгууд түүнийг нэн алдаршуулан хүндэтгэдэг байсан”/46-57/ хэмээн бичсэн нь Хабул хааны дүр төрхийг харуулам. Хятадын түүхэнд “Хабул хаан бол олондоо онцгой итгэл хүндтэй тул аймаг угсаагаараа түүнийг хүндэлдэг” /34.55-55/ гэж дурджээ. Алтан улсын хаад “Хамаг Монгол улсыг улс гэж зөвшөөрөх” бодлого явуулж байжээ. Хабул хаан XII зууны эхний хагаст нас барсан бөлгөө.

Хабул хаан нас барахдаа Тайчуудын зоригт баатар Сэнгүм Билэгийн Хөвгүүн Амбагайг Хамаг Монголын хаан болгохоор гэрээсэлсэн учир Амбагай Хамаг Монголын хаан болжээ. Монголын нууц товчоонд “Амбагайг Хамаг Монголын хаан болгохоор Хабул хаан хэлсэн” /32.40/ хэмээн бичсэн байдаг.

Амбагай хаан Тайчууд аймгийг Хамаг Монголын тэргүүлэх аймаг болгож, улсынхаа хүч чадлыг нэмэгдүүлэн, Хабул хааны үр садтай эв найртай байх, Алтан улсын довтлолоос сэргийлэх бодлого явуулснаар олон аймгийнхаа итгэлийг хүлээж, Хамаг Монгол улс ихээхэн хүчирхэг улс болж бэхжсэн байна. Амбагай угаас эвдрэлцэхээс эвлэхийг илүү хичээдэг хаан байжээ /34.59/. Тэрбээр Монголчуудын хүчийг нэгтгэх, Алтан улстай эв найртай байхад их анхаарал тавьж, засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтад зарим нэг өөрчлөлт хийсэн ажээ. Амбагай хааныг Татарчууд гэнэдүүлэн барьж Алтан улсын хаанд хүргүүлэхэд, түүнийг модон илжиг²⁰ унуулан, төмөр хадаасаар хадаж зовоон тарчлаах зэрлэг аргаар цаазалжээ.

Хамаг Монгол улсын гурав дахь хаан нь Хотула²¹ мөн. Амбагай хаан Хабул хааны хал үзэж, хашир суусан бөгөөд эе эвийг хичээж чаддаг хүүхдүүдийнх нь нэгэнд хаан ширээг эгүүлж өгөх нь Хамаг Монголын эрх ашигт нийцнэ /34.60/ хэмээн үзжээ. Чингээд Хабул хааны хүү Хотулаг хаан болгохоор гэрээсэлжээ. Энэ нь Хамаг Монгол улсын эрх ашиг, эе эвийг амин хувийн эрх ашгаас дээгүүрт тавьсан ухаалаг бодлого, үзэл санааг илэрхийлсэн захиас байсан буй заа. Ингээд Хотулаг Монгол, Тайчуудын ноёдын хуралдайгаар Хамаг Монгол улсын хаанаар өргөмжилжээ. Энэ тухай Монголын нууц товчоонд “Хамаг Монгол, Тайчууд нар Онон мөрний Хорхунагийн хөндий гэдэг газар цугларч хэлэлцээд Хотулаг хаан ширээнд өргөмжлөв” /32.57/ гэж бичсэн байдаг. Хотула хааны үед Хамаг Монгол улсын бүрэлдэхүүнд Дарилгин 16, Нирун 16, Жалайр 10 аймаг, Тайчуудын олон аймаг бүхий холбоо хийгээд Нирун аймгаас салбарласан Нирун хиад, Хиад боржигин аймгууд багтах болж газар нутаг нь өргөжиж, хүн ам нь нэлээд нэмэгдсэн байна. Хамаг Монгол улс, Зүрчидийн Алтан улстай эн сацууд зэрэгцэн оршиж байсан нь Хамаг Монгол улс хүчтэй болохын илэрхийлэл болно. Хотула хаан төдий л удаан төр барьсангүй нас баржээ. Залгамжлах халаагаа захиж үлдээгээгүй ажээ.

Хамаг Монгол улсын хаад

№	Хааны нэр	Төр барьсан он	Овог аймаг	Цол
1.	Тумбинайн Хабул	1130-ХII зууны тэргүүн хагас	Боржигин	Хаан
2.	Сэнгүм Билэгийн Амбагай	ХII зууны тэргүүн хагас	Тайчууд	Хаан
3.	Хабулын Хотула		Боржигин	Хаан
4.	Есүхэй		Боржигин	Баатар хан
5.	Есүхэйн Чингис	1189-1206	Боржигин	Хаан

Хамаг Монгол улсын хаанд өргөмжлөх ёс нь Хүннү болон түүнээс хойшхи эртний улсуудын хаанд өргөмжлөх ёсны уламжлалыг өвлөн авч хуралдайгаар болон үе угсаа залгамжлах хоёр хэлбэрээр өргөмжлөх ёсыг мөрдөж байжээ. Амбагай үе залгамжилж хаан болсон бол Хабул, Хотула нар ноёдын хуралдайгаар хаанаар өргөмжлөгдөж байсан байна. Хабул, Амбагай, Хотула, Тэмүжин нар “хаан” цолтой байжээ. Хамаг Монголын хаад нь улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нэр хүнд, авьяас билэгтэй, улсынхаа эрх ашгийг хувийнхаасаа дээгүүр тавьдаг, эрдэм ухаантайгаараа шалгарч тодорсон, улсаа тэргүүлэх чадвар бүхий сурвалжтанууд байсан болой.

Хамаг Монголын хаад нь зарлиг шийдвэр гаргах, засаг захиргааны хуваарь, хил хязгаар, цэргийн зохион байгуулалт, түшмэдийн зэрэг дэвийг тогтоох, төрийн түшмэдийг томилох, дайн байлдаан хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, гэмт хэрэг мөнийг тодорхойлох, ял шийтгэл оногдуулах зэрэг эрхтэй байсныг сурвалж бичиг, зохиол бүтээлүүд дэх баримтууд нотлон харуулдаг бөлгөө. Хамаг Монгол улс эртний улсуудын уламжлалыг даган улсаа зүүн, төвийн/голын/, баруун хэмээх гурван хэсэг/гар/-т хуваасан байна. Хабул хаан улсаа төв, баруун, зүүн хэсэгт хувааж, тус бүрийг нэгэн сурвалжтанаар захируулжээ. Хотула хааны үед Хамаг Монгол улс мөн л төв, баруун, зүүн гэсэн гурван хэсэгт хуваагдсан байлаа. Баруун хэсгийг Хотула хаан өөрөө, Зүүн хэсгийг Аригчинэ, төв хэсгийг Хадан тайш захирч байжээ. Энэхүү хуваарь нь захиргаа, цэргийн зохион байгуулалтад зохицож, баруун гарын цэрэг, зүүн гарын цэрэг, төвийн цэрэг гэж байсан аж /5.176/ Нэгэн хэсэгт хичнээн аймаг байсан нь тодорхойгүй боловч Хамаг Монгол улсад наад зах нь 50 орчим аймаг байсан бололтой. Аймгууд нь гурван хэсэгт хуваагдан харьяалагдахын хамт тус бүр өөрийн газар нутаг, өрх иргэд, захирах ноён, цэрэг, түшмэл бүхий бие даасан зохион байгуулалттай байсан аж.

Хамаг Монгол улсад “Хуралдай” хэмээх язгууртны хуралдаан байжээ. Хуралдайд хаан, тайш, сэцэд, гурван гарын захирагч зэрэг төр, цэргийн ноёд оролцож хаанд өргөмжлөх, байлдах, найрамдах асуудал хэлэлцдэг байв. Хуралдай нь хаанд зөвлөх эрхтэй төрийн дээд байгууллага байсан аж. Хуралдай нь төрийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэхэд нөлөөтэй байсан ажээ. Хамаг Монгол улсад төрийн албыг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн түшмэдүүд бий болж, тэдгээрийн албан тушаал, цол зэрэг, албанд томилох горим бүрэлдсэн байна. Хааны дараа орох том албан тушаал нь улсын тайш²² байжээ. Улсын тайш нь төвийн хэсэг /гар/-ийн толгойлогч бөгөөд цэргийн ерөнхий захирагч байсан аж. Улсын “тайш”-ийн албан тушаалыг анх Амбагай хаан тогтоож хааны дараах эрх мэдэлтэн болгожээ. Амбагай хаан өөрийн дунд хүү Хадааныг улсын тайшаар томилж, цэргийн хэргийг голлон эрхлэх үүрэг оногдуулсан байна.

Дараа нь Есүхэй²³ хан улсын тайшаар өөрийн ах Нэгүнийг томилон ажиллуулж байжээ.

Тайшийн дараах албан тушаалд сул гарын захирагч ноён орно. Хабул хааны үеийн зүүн хэсэг /гар/-ийн захирагч Аригчинэ, Амбагай хааны үеийн Хадаан нар эл эрх мэдлийн албан тушаалтнууд байсан аж. Улсын хэсэг /гар/ захирагчид нь хаанаас олгосон газар нутаг, хүн амыг харъяалж, өөрийн хэсгийн цэргийг удирдан аймгийн ноёдыг захирч байжээ. Улсын хэсгийн захирагч ноёд нь бүгд хаанд захирагдахын хамт түүнд нөлөөлөх төрийн дээд албан тушаалтнууд болно. Тийм ч учраас хэсгийн захирагчаар хамгийн туршлагатай, мэдлэг чадвартай, нэр хүндтэй язгууртныг ажиллуулж байсан аж.

Доктор Д.Гонгор XI–XII зууны үеийн Монголын нийгмийн байгуулал, Монгол орны дотоод хөгжлийн үйл явцыг судлаад туурвисан “Халх товчоон” зохиолын II ботьдоо Хамаг Монгол хант улсын хааны ордны зохион байгуулалт, түүний албаны бүтэц, тэнд албан тушаал эрхлэгч түшмэдийн тухай тодорхой өгүүлсэн байдаг. Үүнийг төрийн түүхийн үүднээс нягтлан үзбээс Хамаг Монгол улсын хаан нь ажиллаж албан үүргээ гүйцэтгэх орд өргөөтэй, тэнд алба хаах олон тушаалын түшмэл, үйлчлэгчидтэй, үйл ажиллагаа нь цэгцтэй явагдах нарийн дэг горимтой байсан ажээ. Хааны орд нь нүүдлийн соёл иргэншлийн зүй тогтол, онцлогийг илэрхийлэн нутгийхаа төв хэсэгт, бэлчээр, ус жигдэрсэн газарт байрлаж, хаан эндээс улсаа удирдаж, бодлогоо хэрэгжүүлдэг байсан байна. Монголын нууц товчоонд тэмдэглэснээр хааны орд өргөөг “а`урук ордо” /Монголын нууц товчоо: §136, 198, 233, 253, 257, 271/ гэдэг байжээ. Хааны ордны дотоод ёс горим эгэл хөдөөх байдалтай боловч XII зууны дунд үеэс нарийсч ордны чэрби, хорчи, засуулч, тамгач, бичээч, буурч, агтач, хоньч, тэрэгч зэрэг цэрэг, захиргаа, аж ахуйн үүрэг гүйцэтгэгч албан тушаалтан ажилладаг болж, тэдний хэрэг үйлийг хааны шадар цэргийн ерөнхий даамал чэрби эрхлэн хариуцах болжээ /18.37/. Энэ нь төрийн байгууллагын үүсгэл, ордны аппаратын үндэс суурь болж, хаан, хийгээд төрийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан юм.

Чэрби, тамгач, бичээч зэрэг нь ордны гол түшмэд болно. Хамаг Монгол улсын аймаг нь өмнөх түүхэн урт хугацаанд аймаг үүсэж боловсорсон уламжлалд тулгуурлан, тухайн үеийнхээ нөхцөлд нийцсэн зохион байгуулалтын хэлбэр, тус улсын дотоод бүтцийн гол нэгж байсан байна. Чингэхдээ аймаг нь удам угсаа, газар нутгийн онцлогийг илэрхийлэн хаанд захирагдсан нийгэм-төрийн зохион байгуулалтын харьцангуй тогтвортой нэгж байснаараа онцлог юм. Ийм нэгж болох аймаг нь нутаг дэвсгэр-засаг захиргааны хуваарьт үндэслэсэн төрийн байгууламжийн суурь болох эхлэл болсон бөлгөө. Аймгуудыг /ахлагч/ зонхилогч ноён захирах бөгөөд тэр нь төрийн түшмэдийн тогтолцооны бүрэлдэхүүнд багтан орж, харъяат иргэдээ засаглан, газар нутгаа эзэмшиж, цэрэг эрсийг татан захирч, аж ахуй, бэлчээр усыг зохицуулан, хаан төрийнхөө бодлогыг өөрийн аймагтаа хэрэгжүүлэх үүрэгтэй байсан ажгуу.

Хамаг Монгол улс байнгын ба орон нутгийн цэрэг байгуулан, улсынхаа хил хязгаарыг хамгаалж, бусад улс, аймгийг байлдан эзэлж, эсэргүүцэл тэмцлийг дарахад ашиглаж байсан аж. Доктор Х.Пэрлээ “Ханлиг улс бүр газар нутаг, мал сүрэг зэрэг баялгаа гаднын довтолгоон эрсдэлээс хамгаалах отрядтай. Түүнийг анхандаа “турхаг”, дараа нь “нөхөр” гэх болжээ” /18.37/ гэж бичсэн байдаг. Үүнээс үзэхүл Хамаг Монгол улс эл жишгийг даган өөрийн байнгын цэрэг бий болгож байсан аж. Цэрэг нь төрөл байдлаараа аймгийн цэрэг, хэсэг /гар/-ын цэрэг, хааны ордны цэрэг гэж гурван төрөлд хуваагдаж байсан гэж үзэж болох. Аймаг, хэсэг /гар/, хааны цэрэг нь жирийн үед өөрийн аймаг, хэсэг, ордыг хамгаалах зориулалттай бөгөөд тооны хувьд хязгаарлагдмал цөөн байсан аж. Харин дайн байлдааны үед цэрэгт татах дайчилгаа явуулж, тэдгээрийг аймаг, хэсэг тус бүрээр зохион байгуулан их цэргийг бүрэлдүүлж байв. Их цэргийн зохион байгуулалтыг улсын тайш хийж, байлдааны бэлтгэлийг хангана. Улсын их цэргийг хаан удирдана.

§2. Татарын холбоо

Татар бол Монгол нутагт оршиж байсан эртний аймгийн нэгэн бөлгөө. Татарыг зүүн Дунхугаас гаралтай хэмээн үздэг. Татар²⁴ долоон түмэн өрхтэй /46/ байсан гэж Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо бичсэн байдаг. Татар хэмээх нэр эрт үед Хятад сурвалжид эхлэн гарч “дада”, “датань”, “тантань” гэх мэт нэрээр тэмдэглэгдсээр байсан ажээ. 492-493 онд зохиогдсон “Сун шу”-ийн 95-р бүлэгт “Жүй-Жүйн” /Жужаны/ нэг нэр нь датань, бас тантань гэнэ. Мөн “Хүннүгийн тусгай нэг аймаг амой” гэж бичжээ /50/. Ийнхүү нэрлэсэн нь 414-429 онд төр барьж байсан Жужан улсын хаан Датаны нэртэй холбоотой бөгөөд түүний албат иргэдийг Датааныхан хэмээн нэрийдэж байснаас үүдэн улмаар аймаг улсын нэр болон хувирсан байна /34.63/. Үүнээс хойш 300 гаруй жилийн дараа 732 онд Түрэгийн Культегиний хөшөөний Орхон бичээсэнд “Татар”, Хятад бичээсэнд нь “дадан” гэж бичигдсэн нь бий. Эл үеэс хойш бараг 260-аад жилийн турш Хятад сурвалж бичигт хар Татар, цагаан Татар, буйругуд, алухай, айргууд, баруун, өмнөд, зүүн Татар, есөн Татар гэх мэтээр Татарчуудыг нэрлэн бичиж байжээ. X зууны эхнээс XII зууны дунд үе хүртэл Татарыг Хятад сурвалжуудад Зу-бу²⁵ аймгийн холбоо, Зу-бу улс хэмээн тэмдэглэх болжээ. Тухайлбал, Хятан, Алтан, Ляо улсуудын үеийн Хятадын сурвалжид “Зу-бу-го” /Зу-бу улс/, “Зу-бу-го, да-ван-фу” /Зу-бу улсын вангийн орд/ гэх мэтээр тэмдэглэсэн байдаг.

Түүхийн урт хугацаанд XII зуунаас өмнөх Татарчууд хүчирхэг байж бусад аймгуудыг эзлэн захирч асан цаг үед гэрхүү харъяанд байсан аймгууд нь Татар нэрийн дор аж төрж байжээ. Жишээлбэл хэрлэн голоос урагших Алтайн уулнаас зүүн тийшхи олон монгол, түрэг аймгуудыг Зу-бу хэмээн нэрлэж байсан удаатай.

Түүхэнд тэмдэглэгдсэн Шивэй, Дадан, Зу-бу гэх ерөнхий нэрээр нэрлэгдэж авсан олон аймгууд нь өөр хоорондоо ялгаатай байсан аж. Тухайлбал «шивэй», «дадан» гэсэн ерөнхий нэрийн дор явсан аймгуудад язгуурын Монголчууд оролцдог бол «Зу-бу» гэх нэрийн доорхи аймгуудад тэд /Монголчууд/ оролцдоггүй байжээ /44.294-298/. Сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдээс үзэхэд «гучин Татар, есөн Татар, хар тэрэгт дадан /Татар/ нь шивэй олон аймгийн хэсэг нь байсан аж. Татар, шивэй хоёр бол нэг угсаатан мөн бөлгөө. XII зууны үед Татарууд бүгдээрээ Буйр нуур хавьд нутагладаг болсон бөгөөд үүнээс хойш Татарын үндсэн нутаг нь Буйр нуур болжээ.

Түүх сударт Дадан улс гэж олонтаа дурдсан байх ба түүнийг тэргүүн хан цолтой Нор-бюрук, Ажэ зэрэг ноёд захирч байсныг тэмдэглэсэн байдаг. Энэ нь XII зууны эхэн, дунд үед Татарчууд нь хан тэргүүтэй аймгийн холбоо байсныг харуулна.

XII зууны эцсээр Татарууд хэдэн том аймагт хуваагдах болсон байна. “Монголын нууц товчоо”-нд цагаан Татар, алчи Татар, дутауд Татар, алухай Татар, айуриут Татар, буйруут Татар гэсэн 6 Татарын тухай тэмдэглэсэн /33.153/ байх аж. Харин “Судрын чуулган”-д баркуй Татар, камаши Татар, Аиучи Татар, терат /тариат/ Татар, тутукулиут Татар, куйн /ойн/ Татар, цагаан Татар, алчи Татар хэмээх 8 Татар байсныг тэмдэглэжээ. Эл хоёр сурвалжид тэмдэглэгдсэн 14 нэрийн 4 нь давхардсаныг хасвал 10 Татар үлдэх агаад үүнээс цагаан Татар нь эрт цагт есөн Татарын тоонд ордоггүй байжээ. Тийм учраас есөн Татар гэдэг байжээ. XII зууны эцэс болоход Татараас цагаан, алчи, дутаут, алухай дөрвөн Татарын нэр түүхэнд үлдсэн байна /34.64/. Татарын холбоо нь том ханлиг бөгөөд түүнд 70000 өрх харьяалагдаж байжээ /46.33/ Татар аймгуудын дотроос хамгийн нэр хүндтэй аймаг нь Тутукулиут аймаг бөгөөд эл аймаг нь ноёлох аймаг болон товойн гарч бусад аймгууддаа нөлөөлөн дагуулах үүрэгтэй байжээ. Хятад сурвалжид дадан улс гэж олонтаа дурдсан байснаа Ляо улсын үед “Татар улс” гэж бичих болсон байна. Есөн Татар аймгууд нэгдэж Татарын холбоо /ханлиг/ болсон бөгөөд ялангуяа дайн байлдааны үед эл холбоо нь мэдрэгдэм хүчтэй болдог байсан аж. Гэвч Татарын холбоо нь Хамаг Монгол, Хэрэйд, Найман шиг нэгдмэл, хүчтэй ханлиг болж чадаагүй ажээ.

XII зууны эцэс XIII зууны эхээр Татаруудын үндсэн нутаг нь Хөлөн, Буйр хоёр нуур хавийн мал адуулан өсгөхөд нэн тохиромжтой, сайхан бэлчээр бүхий газар нутаг болсон байна. Татарын холбооны газар нутаг нь өвс, ургамал, ус бэлчээр сайтай, тариа тарихад тохиромжтой, ан гөрөөс, загас сэлтээр элбэг, наймааны замын уулзвар замд оршдог, Хятад улстай шууд хил залган хиллэдэг гэх мэт олон давуу талтай байсан ажээ. Татарчуудын эдийн засгийн үндэс нь бэлчээрийн мал аж ахуй байсан аж. Мөн тариа тарьж, ан агнаж, гар үйлдвэр эрхлэн Хятадын Алтан, Тан улсууд болон Монгол аймаг, ханлигуудтай худалдаа арилжаа хийдэг байжээ.

XII зууны эцэст Татарын холбоо /ханлиг/-г бүрэлдүүлдэг аймаг бүр харьцангуй бие даасан байдалтайгаар өөр өөрийн газар нутаг дээрээ оршин тогтнож байсан ажгуу. Аймгийг зонхилогч захирна. Зонхилогч нь аймгаа удирдаж, газар нутаг, нүүдэл суудал, аж ахуйн ба худалдаа арилжаа, соёлын хэргээ зохицуулан гадаад байдал, харилцаа холбоогоо бэхжүүлэх үйл ажиллагаа явуулж байв.

Татарын холбоо, түүний аймгуудын гадаад байдал төдий л тогтвортой байж чадаагүй байна. Энэ нь Татарууд Хятан, Алтан улсуудын түрэмгийлэл, довтолгоонд өртөж, тэдний хараат болж, Хамаг Монголтой харилцах харилцаа хүндэрч байнгын дайны нөхцөлтэй байсантай холбоотой байв. 1015 онд есөн Татараас Хятан улсад алба төлж, 1125 онд Хар Хятаны Елюй Дашид²⁶ цагаан Татарууд дэмжлэг үзүүлэн, XII зууны эхэн хагаст “Дадан улс”-аас Алтан улсад хоёр удаа хониор алба хүргэсэн зэрэг нь Татарууд эл хоёр улсын хараанд байсныг нотолж байна.

1135-1136 оноос эхлэн Хамаг Монгол, Алтан хоёр улсын харилцсан цагаас /60.162-166/ Татарууд Монголчуудтай эвдрэлцэж эхэлсэн ажгуу. Татарууд, Хабул хааны ахмад хүү Охинбархагийг, мөн 1162 онд Хамаг Монгол улсын хаан Амбагайг өөр өөр он цагт баривчлан авч, Алтан улсын хаанд хүргүүлэн цаазлуулсан нь Хамаг Монгол, Татарын эвдрэлцлийг дайсагналд хүргэж, үүний улмаас олон удаа хоорондоо дайтсан ажээ. Жишээлбэл Хабул хааны хүү Хадаанбаатар, Татарын Матар /Мэнэн/ гэдэг ноёнтой хоёр удаа хүчтэй тулалдсан байна. Үүний нэг нь Сангдан гэдэг газар болжээ. Тэгээд Монгол Татарын тулалдаан 9 удаад хүрсэн гэж Рашид-ад-Дин бичжээ /46.39/.

Мөн Хамаг Монгол улсын Сайн-Тэгин Хадаанбаатарын төлөө Татаруудтай олон удаа байлдсан байдаг /46. 41-42/. Татарчуудаас Хамаг Монголчуудтай хийсэн тулалдааныг Котол-Барха, Жили-Буха, Тэмүжин-Үгэ, Хори-буха нар удирдаж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Хамаг Монгол, Татарын хоорондын олон жилийн сөргөлдөөн, тулалдаан нь зөвхөн өшөө атаархлын учир шалтгаантай төдийгүй газар нутаг, худалдааны замын төлөөх бодлогыг илэрхийлсэн улс төр, эдийн засгийн шалтгаантай байжээ. Татарын холбооны дотор хамгийн нөлөө бүхий нэр хүндтэй аймгууд нь Тутукулиут, Алчи, Цагаан, Куйн, Терат, Бакуй гэсэн 6 аймаг байсан хэмээн “Судрын чуулган” зохиолд бичсэн бөлгөө /46.67/. Аймгийг зонхилогч захирна. Аймаг бүрд цэргийн жанжин, цэргийн зоригтой удирдагчид байсан байна. Мөн аймаг бүр нөхөр цэрэг буюу шилдэг цэрэгтэй байжээ.

§3. Хэрэйдийн хант улс

Хэрэйд²⁷ аймгууд нь эртний Хятан улсын үеэс түүхийн тайзнаа гарч ирж, Монгол нутагт оршин тогтнож байсан түүхтэй. X-XI зуунд Хятан улсын үеийн Зу-бу гурван аймгийн дотор Хэрэйд аймаг байсан нь газар зүйн талаар гарцаагүй тохирдог

байна. Учир нь Хятан нар өнөөгийн Монголчуудын шууд өвөг дээдэс болох Монгол аймгуудыг “Зү-бу” гэдэг ерөнхий нэрээр нэрлэдэг байжээ. Эл үед Зү-бу гэсэн ерөнхий нэрийн дор 20 гаруй аймаг оршиж байсан аж. “Хятан нар Зү-бу нарыг дотор нь умард Зү-бу, баруун Зү-бу хэмээн зааглан ялгадаг байв. Умарт Зү-бу гэдэгт Хэрэйд тэргүүтэй аймгуудыг ... багтаан оруулж агсан гэмээр байна” /33.376/ гэж 2003 онд хэвлэгдсэн “Монгол улсын түүх”-ийн тэргүүн ботид бичжээ.

XI-XII зууны эхэнд Хэрэйд аймгууд хүчтэй болж, хоорондоо нэгдэн Хэрэйдийн ханлигийг байгуулжээ. Хэрэйдийн ханлигт Хэрэйд, Джиркин, Конкаит, Сакант, Тумаут, Албату, Киркун хэмээх аймгууд багтаж байсан байна. Түүхэн сурвалж бичигт “1089 оны 5 дугаар сард Зү-бу-гийн Маркус /Могус/ аймгуудын толгойлогчоор томилогдсон” /7.82/ хэмээн бичсэнээс үзвэл Хэрэйдийн ханлиг үүсэж, толгойлогч нь Маркус болсон бололтой. “Хэрэйдийн түүхэнд нэр нь үлдсэн хамгийн эртний хан бол Маркус болно” /6.180/ гэж Монгол улсын түүхийн тэргүүн ботид бичсэн нь үүний нотолгоо мөн байж болох юм. Хэрэйдийн тэргүүн нь “Буюрук” цолтой байжээ. XI-XII зууны эхэн үеийн Хэрэйдийн ханлиг нь Яг-ябган /Заг завхан/. Туул, Сэлэнгэ, элсэн говийн хоорондох нутагт оршиж байжээ. Тус ханлиг баруун талаараа Наймантай, хойд талаараа Мэргэдтэй, зүүн талаараа Монголчуудтай, өмнөд талаараа тангудын Ся улстай хил залгаж байсан болой. Хэрэйдийн ханлигийн бүрэлдэхүүнд Хэрэйд, Жиркин, Конкайд, Сакаид, Тумауд, Албат, Тункайд, Хиркун гэсэн 8 аймаг орж байжээ. Чухамдаа эдгээр аймгууд нь Хэрэйдийн ханлигийг бүрэлдүүлж байсан байна.

XII зууны эхэнд Маркус²⁸ төр барьж байх үед Хэрэйд, Татарууд хоорондоо зөрчил сөргөлдөөнтэй байжээ. Алтан улсын хараат байсан Татарууд Маркус хааныг гэнэдүүлэн барьж Алтан улсад хүргүүлэн модон илжигт хадуулж үхүүлсэн /46.90/ байна.

Маркус Куржакиз буюруг, Гүр хан гэсэн хоёр хүүтэй байсан боловч эл цагт ханлигийн төрийг бариагүй агаад харин Сарык хан төрийг барьж байжээ. Сарык хааны үед Хэрэйдүүд Татаруудад 4 удаа бут цохигдож улмаар хүч нь сулран Татарын мэдэлд орсон ажээ. Гэвч Сарык хан цэргийн хүчээ хуримтлуулаад Татарыг довтлон ялж, Татарын ноёрхлоос өөрийн ханлигаа чөлөөлсөн байна.

XII зууны эхэн хагасын эцсээр Хэрэйдийн ханлигийг Маркус ханы ууган хүү Куржакуз толгойлох болжээ. Куржакуз буюруг хаан ханлигийнхаа газар нутгийг хүн амын нь хамт өөртөө болон дүү, хүүхэд нартаа хуваан эзэмшүүлсэн байна. Үүнд: өөртөө Хар балгасан /орду балагасун/ дүү Гүрхан, ахмад хүү Тоорилд яг-ябган /заг завхан/ хүү Юла Магус, Тай-Тимура нарт Каргас-Буругус газрыг эзэмшүүлэхээр зааж өгсөн ажээ. Куржакуз ханы энэ арга хэмжээ Хэрэйд ханлиг бутрах, хан ширээний тэмцэл гарахад нөлөөлснийг дараа дараагийн үйл явдлууд нотлон харуулсан байдаг бөлгөө.

Куржакузын нас барсны дараа хүү Тай–Тимур, Бука-тамир нар Хэрэйдийн хаан ширээг эзэлсэн боловч үнэн хэрэг дээрээ хааны удмын бус Элжидай төрийн хэргийг захиран мэдэх болжээ.

Үүнд ихэд дургүйцэн Куржакузын ахмад хүү Тоорил²⁹ хүч хэрэглэн, эцгийн суурийг эзэлжээ /46.9/. Ийнхүү XII зууны дунд үед Тоорил Хэрэйдийн ханлигийн хаан болжээ. Тоорилыг хан болсныг түүний авга ах Гүр хан тэргүүтэй ноёд эсэргүүцэн тэмцсэнд Хамаг Монголын Есүхэй баатар Тоорил ханд туслан хоёул “Туулын хар шугуйд анд бололцож, Гүр ханыг довтлон ялжээ. Тоорилыг хан ширээнд нь эгүүлэн залсан болой”/46.91/ Хэрэйдийн ханлигийн түүхэнд түүний төрийг Маркус, Сарык, Куржакуз, Тоорил нар хан, буюруг, ван цолтойгоор барин 111 жил хаанчилж байсан байна.

XII зууны дунд үед Тоорил ханы зуслан нь Талан-Гусэр, Дабан, Наур, өвөлжөө нь Үтегин мөрөн, Орон-Куркин, Тош, Варау, Ширэ, Кулусун, Өткү-Кулан, Джалаур-Кулан байсан аж. Хятан улсын сүүлч, Алтан улсын эхэн үед Тоорил ханы зуны ордон нь Далан-Даваа гэдэг газар, өвлийн орд нь Онгийн голд байсан ажээ. Харин XII зууны эцсээр Хэрэйдийн хан Тоорилын орд өргөө Туулын хар шугуйд байсан нь “Монголын нууц товчоо”-нд бичсэнээс тодорхой байна.

Хэрэйдийн ханлиг нь түрүү феодалын хаант улс бөгөөд Монголын нэгдсэн улс байгуулагдахын өмнөх үеийн хүчирхэг хаант улсуудын нэгэн байжээ. Чингэхдээ Хэрэйд улсын гадаад, дотоод байдал, хөгжлийн явц нь тухайн үеийн түүхэн нөхцөл, Монгол ханлиг, аймгуудын хөгжлийн түвшин, хандлага, гадаад улс орнуудын бодлого, үйл ажиллагаатай ихээхэн холбоотой байв. Хэрэйдийн ханлигийн гадаад, дотоод байдал төдий л тогтвортой бус байсан бөгөөд бараг байнга шахам гаднын довтолгоон, өдөөн хатгалгад өртөж, хан ширээний төлөө тэмцэл, хямралд автагдаж байсан ажээ.

Хэрэйд нь Сарык, Тоорил ханы үед Хамаг Монгол улс, Монголчуудтай сайн харилцаатай байж, үүнээ анд бололцох, харилцан туслалцах зэргээр баталгаажуулж байсан байна. Сарык хан Монголчуудыг “дүүс” маань хэмээн үзэж Монгол, Хэрэйд хоёр хоорондоо гэрлэхгүй, найрамдан явахыг сануулсан байдгийг Монголын түүхэнд тэмдэглэн бичсэн нь бий.

Ер нь түүхэнд Амбагай хан, Есүхэй баатартай, Амбагайн хүү Хадаан тайш, Ван ханы авга Гүр хантай, Тоорил ван Есүхэйн хүү Тэмүүжинтэй сайн харилцаа, андын холбоотой байсан аж.

Хэрэйдийн ханлиг, Татарчуудыг ялсан хэдий ч Тангудын Ся, Хар Хятан улс, хөрш Найманы хант улсын уулга довтолгоонд эрсдэж, хүч чадал нь буурсаар байсан ажээ. Дотоодын сөргөлдөөн ч зогссонгүй. Тоорил хан түүний дүү Эрх Хар хоёрын эрх мэдлийн төлөө тэмцэл ужгирч үргэлжилсээр Хэрэйдийн ханлигийг улам доройтуулсан байна.

Хэрэйдийн Тоорил хан урьдын сайн харилцаа, андын үүргээ умартан, Хамаг Монголын хан Тэмүүжинтэй эрх мэдлийн төлөө сөргөлдөж, дайтах ажиллагаа явуулсан нь Хэрэйдийн ханлигийг мөхөхөд хүргэжээ. Хэрэйдийн ханлиг 1203 онд мөхсөн бөлгөө. Хэрэйдийн ханлигт хан цолыг зөвхөн төрийн тэргүүн төдийгүй ханы хүү хэрэглэж байсан нь Маркусын хүү Гүр хан цолтой байсан баримтаар нотлогдож байна. Мөн зарим өндөр нэр төртэй язгууртан “тайш” албан тушаалтан байжээ. Жишээлбэл, Амбагай ханы хүү Хадаан, Куржакуз ханы хүү Тай-Тимур нар тайш байжээ. Хэрэйдийн ван ханы хоёр хүндтэй ноён нь Ала-Буха, Тайр нар байв.

Хэрэйдийн холбоонд багтдаг аймгууд нь өөрийн газар нутаг, харьяат иргэдтэй байсан агаад аймаг бүрийг зонхилогч захирдаг байсан гэх боловч тодорхой мэдээлэл, баримт хомс байна. Хэрэйд ханлиг баруун ба зүүн жигүүрийн цэрэгтэй байсан байна. Тоорил ханы үед баруун жигүүрийн анги нь Тулсүтан, Джалсутанд, зүүн жигүүрийн цэрэг нь Илат, Тарат /Тариат/, Айджиэ, Күтүкэн /Өтүкэн/, Урут, Укрут, Ийлет, Тертитэд оршдог байсныг “Судрын чуулган” зохиолд тэмдэглэжээ.

Хэрэйд улсын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй байсан аж. Жилийн дөрвөн улиралд нүүдэллэн мал сүргээ өсгөн үржүүлж, ашиг шимийг нь ашиглан амьдарна. Мөн ан агнаж, гар урлал эрхлэн, худалдаа арилжаа хийнэ. Хэрэйд аймаг кристос шашин шүтдэг байсан гэж XIII зууны үед нэгэн түүхч “Сирийн түүх” номондоо бичжээ.

§4. Найманы хант улс

Монгол нутагт оршин тогтнож байсан томоохон ханлигийн нэг нь Найман болно. “Найман”³⁰ гэдэг үг нь 8 аймаг гэсэн тооноос үүсэлтэй болой. Үүнээс үүдэн Найман аймаг нь Найманы ханлигийг бүрдүүлж, Найманы холбоо, Найманы ханлиг хэмээн түүхнээ нэрлэгдэх болжээ. Найманы ханлиг нь XII зууны эхэн үед байгуулагдсан байна. Найман аймаг нь “секиз-огуз” гэсэн Түрэг үгээр илэрхийлэгдэн түүхнээ тэмдэглэгдсэн байдаг. Энэ нь Монголоор бол “Найман огуз” юм.

Хятан улсын үед Монгол аймгуудыг “Зү-бу” /Зүньбу/ гэдэг ерөнхий нэрээр нэрлэж, түүнд 20 гаруй аймаг багтаж байсны дотор Найманы аймаг байсан бололтой. Түүхээс үзэхэд Хятан нар Зү-бу нарыг дотор нь умард Зү-бу, баруун Зү-бу хэмээн зааглаад умард Зү-бу-д Хэрэйд тэргүүтэй аймгуудыг, баруун Зү-бу-д Найман зэрэг аймгуудыг багтаан оруулж агсан /33.375/ байна. Зү-бу нар Хангайн нуруу, түүнээс баруун тийших Монгол нутагт нутаглаж байсан нь үүнийг улам үнэмшилтэй болгож буй юм. Түүхийн дурсгалт судалгаанаас ажиглахуйд “Сэлэнгийн чулуу” хэмээн нэрлэгдсэн Уйгурын хөшөөний бичээсэнд “Сегиз-Огуз” нэр дурдагдсан байдаг. Энэ нь 750-аад он юм.

Эл хөшөөний бичээсэнд Уйгурын Моюун-чур хаан сегиз-огузын бослогын эсрэг тэмцэн, тэднийг Бюкегюк /Бүхэг/ гэдэг газарт дарсан тухай тэмдэглэжээ. Монгол улсын түүхийн тулгуур бүтээлд X зууны 20-иод оноос тэд Хятаны Зү-бу гэж нэрлэгдсэн аймгуудад багтаж байгаад XI зууны эхнээс “Найман” гэдэг Монгол нэрээр түүхэнд бичигдэх болсоныг өгүүлсэн байдаг /34.73/. Түүхийн мэдээллээс үзэхэд Найман нар VIII зууны үеэс Хангай-Алтайн уулсын завсарт нутаглаж байжээ. Дараа нь Найман нар XII зууны үед Алтай, Элүй Сирас, Кок-Иртыш /Хөх эрчис/, Кара-Ирдыш /Хар эрчис/, Каракорум /Хар хорум/, Алтайн уулс, Хэмчичүүдийн орчан голд нутаглаж байсан аж /46.96/. Найманы хааны өргөө нь Жажиз-Нуурт, өвөлжөө нь Адари-Эбкэ уул, Бакарас-Олом, Ачирик нуур /Ачит нуур/, Ала-Этрин /Алтайд-Идэр гол/-д байжээ /46.96/. Ерөнхийд нь хэлэх юм бол Найманы нутгийн баруун тал нь Зайсан нуур, зүүн зах нь Хар хорум байсан аж. Найманы ханлиг нь хаант улс бөгөөд дотроо 8 аймагт хуваагдаж байжээ. Найманы ханлигийг хан удирдана. Хан нь аймгуудыг нэгтгэн удирдах, улсын ба аймгийн газар нутгийг тогтоох, цэрэг бүрдүүлэн захирах, байлдаан тулалдааныг толгойлох, газар нутаг, хил хязгаар, хүн амаа хамгаалах, аж ахуй, соёлоо хөгжүүлэх арга хэмжээ авах, гэрээ хэлэлцээр байгуулах зэрэг эрх үүрэг хүлээж байсан ажээ.

XI-XII зууны үед Найманы ханлигийн тэргүүн нь “хан” цол хэрэглэж байв. Найманы ханлигийн тэргүүнээр Буюруг хан, Баку хан, Даян /Таян/ хан, Кушлук хан ажиллаж байсан аж.

XII зууны дунд үед Найманы ханлигийг Наркыш-Даян толгойлж байсан аж. Наркыш-Даяны дараа түүний хүү Инанч-Билгэ Баку хан цолтойгоор Найманы ханлигийг тэргүүлсэн байна. XII зууны хоёрдугаар хагаст дотоод зөрчил хурцдаж, нэгдэлгүй болж буй үед Инанч-Билгийн хүү /Бай-Бука/ Даян /Таян/ хан, Буюруг хоёр төрийн эрх мэдлийг харилцан булаацалдаж эцэст нь Найманыг хоёр хэсэг болгон салгаж, нэг нэгээр нь захирах болсон байна. Үүнд: Даян /Таян/ хан нь тал газарт нь нутаглаж, эртний Уйгурын Орду бал /хар Балгасан/ төвтэй умард хэсгийг, Буюруг хан уулархаг газарт нь нутаглаж, Алтан Хар-Эрчис ба Өрнүүн хөндийг захирах болж /46.139/, хоорондын харилцаа холбоо нь бүрмөсөн тасарсан байна. Даян хан шинээр сэргээн байгуулагдсан Хамаг Монгол улсад 1204 онд бут цохиулах хүртэл төр барьсан болой. Найманы ханлиг, Хятадын Ляо улс, Алтан улс, Хэрэйдийн ханлиг, Хамаг Монгол улс, Хиргис улс, Уйгур улс, Дундат Азийн улсуудтай харилцаж худалдаа арилжаа хийж байсан байна. Ялангуяа Уйгур, Дундат Азийн худалдаачидтай худалдааны өргөн харилцаатай байжээ. XII зууны эхэн үед Алтан улсын хилд халдаж, аюул, хохирол учруулж байсан нүүдэлчин аймгийн тоонд Найман нар орж байжээ.

Иймээс Алтан улс Наймантай болгоомжтой харилцаж аль болохоор өөртөө татах бодлого явуулан зарим үед амжилт олж байсан байна.

Инанч Билгэ ханы үед Найманы ханлиг Алтан улстай улс төрийн холбоотой болж, ахмад хүү Бай-Бука нь “Ай ван” /ханхүү/ хэмээх Хятад цолтой байсан /46.139 нь үүнийг нотолж байна. Хятадын Ляо улс хүчирхэгжсэнээр Найманы байдалд нөлөөлөх болжээ. Энэхүү нөлөөнд автагдах явдал ч гарч байв. Үүний жишээ нь 1048, 1095 онд Найманы ханлиг нь Ляо улсад дагаар орсон явдал ч гарчээ.

XII зууны II хагаст Хиргис нарыг Найманы Инанч-Билгийн удирдсан цэрэг ялснаар ихээхэн хүчирхэг болж байжээ. Найман нь Хэрэйдийн ханлигтай нилээд зөрчилдөж байсан аж. Найманы ноён Көкэсу-Сапрак Хэрэйдэд цэрэглэн орж, Тоорилын ах дүү нарын эд хөрөнгийг уулгалан дээрэмдсэн байна. Хэрэйдийн дотор хан ширээ булаацалдсан Тоорилын дүү Эрх Хар-д Найман нар тусалж, Тоорилыг хөөж, газар орныг нь эзлэн аваад Эрх Хар-д өгч байжээ.

Түүхэн сурвалж бичгээс үзэхэд Найман аймгууд олон сайн цэрэгтэй байжээ /35.5/. Ханлигийн хан үлэмж цэргийг захирч байсан нь хоёр хантай болоход бас л хоёр хаан хуваагдсан байна /5.190/. Найманы аймгууд Монголын нутгийн баруун захын өргөн уудам нутагт, зарим нь уулархаг газарт, зарим нь тал газарт нутаглан мал маллан нүүдэллэж амьдарч байжээ.

Найманы ханлигт бичиг, соёл хөгжин байжээ. Монгол аймаг дотроос хамгийн түрүүнд бичиг үсэгтэй болж соёлжсон нь Найман аймаг юм /34.75/. Чингис хаан Монгол аймгуудыг нэгтгэх үед хамгийн соёлжсон бичиг үсэгтэй аймаг нь Найман аймаг хэмээн сурвалжид тэмдэглэжээ /34.75/.

§5. Бусад холбоо, аймгууд

XII зууны үед Монгол нутаг дээр Хамаг Монгол, Татар, Хэрэйд, Найманы ханлиг улсууд оршин байснаас гадна эдгээр улсуудын захиргаанд ороогүй тусгаар аймаг, ханлигууд олон байсан байна. Тэдгээрийн дотор хэд хэдэн аймгаас бүрэлдсэн аймгийн холбоод, мөн холбоонд нэгдэж байгаад задарсан аймгууд, бас ганц нэгээрээ биеэ даан оршиж буй аймгууд ч байсан бөлгөө. Эдгээрийн талаар товч өгүүлэе.

Мэргэдийн холбоо. Гурван Мэргэд³¹ аймгийн нэр анх 1096 онд “Мэйлизи” нэрээр түүхнээ тэмдэглэгдсэн байна. Гурван Мэргэд нь Хятан улсын харъяанд байсан Зү-бу аймгийн тоонд багтаж байсан бололтой. Учир юун хэмээбээс 1223 онд Хятаны Елюй Даши Жэнь-Жэу хотод /Одоогийн Чин толгой/ Зү-бу 18 аймгийн тэргүүнийг хуралдуулахад Мэргэдийн тэргүүн оролцсон байдаг /5.123/ байна.

Мэргэд аймгуудын холбоо Орхон мөрний адаг, Сэлэнгэ мөрний дунд хавиар оршиж байжээ. Тухайлбал, Орхон голын адгаар Буур нуурт /Одоогийн Алтанбулаг, Сүхбаатар хотуудын хооронд/ Удуйд-Мэргэд, Орхон, Сэлэнгийн бэлчир Талхун арлаар, Увас-Мэргэд, Сэлэнгийн Каражи хээрээр /Орхон Сэлэнгийн бэлчирээс доош/

хаад Мэргэд тус тус төвлөн нутаглаж байжээ /32.105.111/. Эдгээр Мэргэдийг түүхэнд Гурван Мэргэд /холбоо/ хэмээн үздэг бөлгөө. Рашид-ад-Диний “Судрын чуулган”-нд “Мэргэд улс” байсан хэмээн тэмдэглэсэн нь нягтлууштай асуудал мөн юм. “Хаад” гэсэн нь олон хаан гэсний илэрхийлэл тул Мэргэдүүд хэд хэдэн ханлиг байгуулж яваад хожим задарч улмаар “түүний захиргааны хуваарийн нэр нь Гурван Мэргэд болон үлдсэн байж” /34.69/ болох юм. Мэргэд аймаг нь салбар аймгуудтай байсан аж.

Хамгийн нөлөө бүхий Удуйд аймаг нь Уйкур, Мудан, Джиюн, Тудаклит гэсэн дөрвөн салбар жижиг аймагтай байжээ /46.76/. Удуйд Мэргэд нь хүн ам олонтой, дайчин эрэлхэг цэрэгтэй байсан учир бусад хоёр Мэргэдээ дагуулан тэргүүлж байсан аж. Удуйд Мэргэд нь уйкур, мудан, джиюн, Тудаклит дөрвөн салбартай. Энэ цаг үед удуйд Мэргэдийг Тудур-Билгэ чигин толгойлж бүх цэргээ баруун жигүүр, зүүн жигүүр, төв жигүүр гэсэн гурван ангид хувааж байжээ. Мөн Тудур-Билгэ чигин, түүний хүү Тогтоа бэхи нар өөр өөртөө хишигтэн цэрэгтэй байсан байна. Эдгээр нь удуйд Мэргэд сайн зохион байгуулалттай, торгон ба улсын цэрэгтэй байсныг харуулна. Энэ талаар Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо нилээд тодорхой өгүүлсэн байдаг бөлгөө. Энэ үед Мэргэдийн холбооны тэргүүн хэмээх бүх Мэргэд аймгийг удирдах толгойлогчийн тухай тодорхой баримт эс олдном. Гэсэн ч “Мэргэдийн тэргүүн Тудур-Билгэ, Амбагай ханы хүү Хадаан тайштай анд явсан байна” гэж түүхэнд бичсэнээс үзвэл бүх Мэргэдийг /холбоо/ Удуйд Мэргэдийн тэргүүн толгойлж байсан бололтой.

Нэгэнт удуйд Мэргэд аймаг бүх Мэргэд аймгаа дагуулж, манлайлж байсан болохоор түүний тэргүүн нь нийт Мэргэдийг /холбоо/ удирдаж байсан гэх үндэслэлтэй буюу.

Харин Чингис хааны үед Удуйд Мэргэдийг Тогтоа бэхи толгойлж байсан аж. Мэргэд аймаг бүр тэргүүлэгчтэй байжээ. Аймгийн тэргүүн нь аймгийнхаа газар нутгийг хамгаалж, нүүдэл суудал, бэлчээр усыг зохицуулан, харъяатаа засан аж ахуйгаа хөгжүүлэх, дэг журмыг сахиулах, цэргээ зохион байгуулж захирах, байлдааныг удирдах эрх, үүрэгтэй байсан байна. Аймгийн тэргүүн нь “чигин”, “бэхи” гэсэн цол хэрэглэж байжээ. Жишээлбэл Удуйд Мэргэд аймгийн тэргүүн Тудур-Билгэ “чигин”, түүнийг залгамжлагч, дараа нь тэргүүлэгч болсон Тогтоа “бэхи” цолтой байжээ. “Монголын нууц товчоо”-ны 111-р зүйлд тэмдэглэснээс үзвэл Удуйд Мэргэдийг Тогтоа бэхи, Увас Мэргэдийг Дайр-Үсүн, хаад Мэргэдийг хаатай Дармала нар тэргүүлж /32.61/, тус бүр цэрэг бүрдүүлэн захирч байжээ. Мэргэд аймгууд /холбоо/ Монгол аймгууд /Хамаг Монгол/ эрт үеэс сайн хөршүүд байж, эв найртай явж ирсэн уламжлалтай болой. Гэвч энэ харилцаа XII зууны дунд үеэс хямарч, түүгээр ч үл барам бүр хоорондоо дайтахад хүрсэн байна. XII зууны хоёрдугаар хагасын эхэнд Хамаг Монгол улс, Мэргэд аймгуудтай гурван жилийн зайтайгаар хоёр удаа байлдсан байна.

Эхний дайныг Мэргэдээс Тудур-Билгэ, Хамаг Монголоос Хадаан тайш нар удирдаж, Мэргэд буюу Тудур-Билгэ ялагджээ. Дараагийн дайныг Хамаг Монголын Хадаан тайш, Мэргэдийн Тогтоа бэхи нар удирдан Хамаг Монголын ялалтаар төгсжээ. Гурван Мэргэд XIII зууны эхэн хүртэл тусгаар, бие даасан байдлаа хадгалан оршин тогтнож байсан бөлгөө.

Баядын холбоо. /Баягуд/ аймаг нь 606 оноос “Ба-е-гу” гэсэн нэрээр түүхнээ тэмдэглэгдэж тодорсон байна. Баяд³² аймаг нь 706 онд Орхон-Түрэгийн бичээсэнд “Иир-Байрку” хэмээн бичигдсэн байдаг. “Монголын нууц товчоо”-нд “малиг баяд” /32.32/ гэж гардаг билээ. “Судрын чуулган”-д бичсэнээр Баяд аймаг нь хэд хэдэн салбартай байснаас нилээд нэрд гарсан нь Жидай буюу Жийдийн баяд, нөгөө нь Кэхэр буюу Хээрийн баяд байсан аж. Түүхэн сурвалжаас үзэхэд Сэлэнгэ мөрний сав дагуу /Одоогийн Хиагт, Бүрэн хан уул хавиар/ нутагладаг баядуудыг Хээрийн баядууд, Сэлэнгийн нэгэн цутгалан Жид голоор нутаглагсдыг Жийдийн баяд гэж нэрлэж байжээ.

Мөн Буйр нуураас баруун хойшхи Баяд-дуклад, Буйр нуураас баруун урдуур “баяд” горлос нутаглаж, бас чаншиуд-баяд, баяд-хиад гэх аймгууд байсан ажээ.

ҮІ-ҮІІІ зуунд баядууд Хөлөн, Буйр нуур орчмоор нутаглаж байсан байдаг. ҮІІІ зууны эхэнд Баядууд есөн аймагтай байсан мэдээ бийг Монголын түүхийн тулгуур зохиолд тэмдэглэсэн нь бий /34.71/. Ийм олон аймгууд байсан нөхцөлд тэдгээрийг нэгтгэсэн баядын холбоо байсан ч байж болох юм.

ҮІІІ-Х зуунд баяд нь олон салбартай, хүн ам олонтой байсан ч нэгдмэл хүч хараахан болж чадаагүй бололтой.

Х-ХІІ зуунд “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”-нд баядын эртний нутаг нь Сэлэнгэ, Туул голоос Эргүнэ мөрөн, Цагаан Хэрэм хүртэл байсан тухай дурджээ. Баяд нь Чингис хаанаас Тайчуудтай байлдахад цэргийнх нь нэг хүрээ болж байснаас гадна Чингис хааны өвгөөс бэр буулгаж авах эрхтэй байжээ. Энэ аймагт цэргийн ноён Буха, түүний Хүргэн Хунга, Мянгатын ноён Үнгүз хааны хоолыг шалгагч Бакаул, Буурч Борохул ноён, Чингисийн хуурай эцэг хэмээгддэг Сорхон шар гэх мэт нэрд гарсан эрэлхэг хүмүүс байжээ.

Онгудын холбоо. Монгол аймгуудын дотроос нилээд олон хүн ам бүхий томоохон аймаг нь Онгуд³³ байжээ. Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо “Онгуд улс” хэмээн бичсэн нь үндэслэл бүхий буй заа. Ийнхүү улс хэмээсэн нь тэр цаг үед хэд хэдэн Онгуд аймгууд нэгдэн Онгудын холбоо /ханлиг улс/-г бүрэлдүүлж, улс болж оршиж байсныг үгүйсгэх юун. Онгуд нь цагаан Татаруудын нэгэн хэсэг аймаг байсан ажээ. Хятад сурвалжид тэднийг “**шато**” буюу “Цагаан Татар” хэмээн нэрлэсэн байдаг. /33.379/

Онгуд аймгууд Хятадын цагаан хэрмийн араар нутаглаж байсан газар зүйн түүхэн онцлогтой юм. Энэ нь өмнө талаараа хил залгадаг Хятад ба хойт талаараа хиллэдэг Монгол аймгуудтай харилцах харилцаанд шууд болон шууд бусаар нөлөөлж байжээ. Ongуд аймгууд байнга хөршийн сайн харилцаатай байх, худалдаа арилжаа хийх, харилцан тохиролцох шаардлагын үүднээс Хятадтай харилцаж байсан нь яваандаа Хятадаас хараат байдалд оруулжээ. 941 онд Ongудууд шахалтанд автагдан Хятадад дагаж орохыг завдаж байсан нь цаашид гүнзгийрсээр Хятадын хараат болсон байж болох. Ongудууд Цагаан хэрмийн хэсэг буюу ар тал, өөрөөр хэлбэл Хятадын хилийг хамгаалж байх албыг Алтан улсад хаах үүрэг хүлээж байсан аж. Энэ нь Монгол ханлиг, аймгуудад таалагдахгүй байсан нь илэрхий. Хятадын хилийг ямар хүчээр манан хамгаалах явдал анхаарал татах нь зүйн хэрэг. “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” дахь баримтыг үзвэл эл үед Ongудын өрхийн тоо 4000-5000 байжээ /46.99/. Энэ бол тэр үедээ бага бус тоо байсан аж. “Судрын чуулган”-д өгүүлснээр Хятадын Алтан улсын хаад “Монголчууд, Хэрэйд, Найман болон тэр орчмын нүүдэлчдээс улсаа хамгаалахын тулд хэрэм байгуулсан бөгөөд түүнийг нь Монголоор “Утху“, түргээр “Буркур” гэдэг байв. Энэ хэрэм нь Тангуд, Төвдийн нутгаас эхлээд Хар ус мөрний дагуу явж, ... Зөрчидийн тэнгисийн эрэг хүрдэг байжээ. Өөрөөр хэлбэл “Хэрмийн нэг үзүүр нь гаталж боломгүй Их Хар мөрөнд, нөгөө нь “Зүрчидийн хэмээх далайд тулсан байдаг”/46.99/ Үүнийг хамгаалах үүргийг Ongуд аймагт хариуцуулсан байна”. “Судрын чуулган”-д “Ongуд аймгийг өөрийнхөө цэрэг, чин үнэнч боолоо гэж үздэг Хятадын эзэд нь Уткух хэрмийн хаалгыг хамгаалж байхыг тэдэнд даалгасан, тэд ч байнга хамгаалсаар байв” /46.99/ хэмээн бичсэн байдаг билээ.

XII зууны үед Ongуд аймгийг тэргүүлэгч ноён захирч байв. Энэ үед ноён Бинуй Ongудыг тэргүүлж байжээ. XII зууны хоёрдугаар хагаст Ongудын тэргүүн нь Алакуш-тэгин ноён болжээ. Ongудууд хэдийгээр Алтан улсын хараат байсан ч гэсэн Монгол аймгуудтай харилцаа холбоотой байсан аж. Найманы хан Ongудын эзний охиныг хатан болгон буулгаж, ургийн холбоо байгуулан, Байтарак /Одоогийн Байдраг гол/ голын бэлчирт хуримлаж байсан нь түүхэнд тэмдэглэгджээ /34.70/ Түүхээс үзвэл Чингис хааны овгоос ч Ongуд аймагт бэр өгдөг, мөн тэднээс ч бэр буулгадаг ёс тогтсон байна. Ийнхүү ургийн холбоо тогтоосноос хойш Монгол, Ongуд аймгууд дотно харилцаатай болсон аж. XII зууны эцэс, XIII зууны эхээр Ongуд аймаг Наймантай дотно холбоотой байсан нь “Найманы хан Ongудыг холбоотон “баруун гар” гэж үзэж байсан”/46.99/-аас тодорхой байна. Ongудууд голдуу мал аж ахуй эрхэлж, тариа тарьж, гар үйлдвэр, худалдаа арилжаа хийн аж төрж байсан байна.

Ойрадын холбоо. Енисей мөрний эх /Секиз хэмээн Найман мөрөн/-ээр нутагшин сууж байсан Ойрад аймгуудын холбоо юм.

Энэхүү холбоонд ямар ямар нэртэй аймгууд орж байсныг дурдсан мэдээлэл түүхэнд тэмдэглэгдэж үлдээгүй боловч үүнд холбогдох зарим баримт Рашид-ад-Дины “Судрын чуулган”-д дурдагдсан байна. Эл зохиолд дурдсанаар Енисей мөрний дээд хавиас эх авсан голууд урсах замдаа нийлсээр “Кем” гэдэг том гол болж Амар мөрөнд цутгадаг ажээ. Эдгээр голууд нь Хөх гол, Ойн гол, Хар-усун, Санди-тун, Укри /үхэрт/ гол, Акар /Ахар/ гол, Журчэ гол, Цагаан гол болно. Иймээс эдгээр голоор нэрлэсэн Найман аймаг байж, улмаар тэдгээр аймгууд нэгдэж Ойрад аймгуудын холбоог бүрэлдүүлж байсан болохыг үгүйсгэх юун. Үүнийг Ойрадын “эдгээр аймаг тус бүр эрт үеэс хэдэн салаа болон салбарлан олон тоотой байсан. Салаа тус бүр ... ийнхүү хуваарилагдсан тусгай нэртэй байсан /46.80/” хэмээн “Судрын чуулган”-д дурдсантай холбон үзэж болох юм. Тэгээд ч “Судрын чуулган”-нд дурдсанчлан аймаг тус тусдаа нэртэй, нутагладаг газартай, харъяалдаг хүн амтай байсан байна. Ойрад³⁴ аймгууд Монгол аймгаас багахан ялгаа бүхий Монгол хэлээр ярьдаг нүүдэлчин аймгууд байсан аж. Аймгийг “толгойлогч” хэмээх ноён захирна.

Ойрад аймгууд эхний үедээ жинхэнэ ойн иргэд байж, ан агнан загас барьж амьдарч байжээ. Түүхийн урт нугачааны явцад Ойрадууд Монгол аймагтай холбоо харилцаа тогтоож, тэдний нөлөөгөөр аажмаар ой тайгаас гарч мал маллаж амьдрахад шилжих болжээ. Малчин аймаг болохын тулд тодорхой цаг хугацааг туулсан нь мэдээж. Энэхүү хугацаанд мал маллаж амьдрах болсон нь баруун зүг Алтайн уулс руу нүүх гол түлхэц болжээ. Ойрадууд баруун Алтайд суурьшин нутагшиж, талын Монгол аймгуудын нүүдлийн амьдралын жишигт шилжин, жилийн дөрвөн улиралд бэлчээр, усны сайныг даган мал маллаж амьдрах болсноор амьдралынх нь хэв маягт өөрчлөлт орж, жинхэнэ малчин аймгууд болсон ажээ. XII зууны сүүл үед Ойрад аймгийн толгойлогч нь Хутага бэхи байжээ. XIII зууны эхэн үеэс Ойрад аймгууд “Дөрвөн Ойрад” хэмээн нэрлэгдэж түүхнээ тодорсон байна.

Чингис хаан Монгол аймаг, угсаатныг нэгтгэх үйл явцад Ойрадыг төдий л их эсэргүүцэлгүйгээр өөртөө нэгтгэсэн бөлгөө. Чингис хаан ч тэдэнтэй эвийг нь олон харилцаж их улсдаа нэгтгэсэн байна. Ойрадууд ч хүчтэй эсэргүүцэл үл үзүүлэн дагаж орсныг түүхэнд дурджээ. Чингис хаан, Ойрадуудад хүндэтгэлтэй хандаж, худ ургийн хэмжээнд хүртэл харилцаагаа бэхжүүлсэн байна. Жишээлбээс, Хутага бэхийн охин Огул-Каймыг Мөнх хааны гэргий, Хутага бэхийн хүү Торэлчи Чингисийн Цэцээхэн охиныг гэргий болгон цаашид ч удам дамжин худ ургийн барилдлагаа үргэлжлүүлсэн байна. Ойрадуудад Чингис хаан итгэж, бас түүнд ч Ойрадууд итгэж байсан илрэл нь Ойрадын баатар Хар-Хару Чингисийн есөн өрлөгийн нэгэн, цэргийн нэрт жанжин болж нэгдсэн Монгол улсад эр зориг, хүч чадал, эрдэм ухаанаа зориулан үнэнчээр зүтгэсэн явдал мөн бөлгөө.

Хонгирадын холбоо. Хонгирад³⁵ аймаг анх Хятад улсын түүхэнд “Уан-ги-ла” /Унгира/ гэж тэмдэглэгдэн түүхнээ гарч иржээ. Тэр цагт Хонгирад нь дөрвөн салбар овогтой байжээ. Хонгирад аймгийн үүсэл нь Хятан улсын үеийн Зү-бу хэмээх 18 аймгийг нэгтгэсэн их аймагтай холбоотой юм. Энэхүү 18 аймгийн нэг нь Хонгирад байсан юм. 1124 онд Жен Жэү /Чин толгой/ хотод Зү-бу 18 аймгийн тэргүүнийг Зү-бу-ийн толгойлогч Елюй Даши удирдан хуралдуулахад Хонгирадын тэргүүлэгч ирж оролцож байсан түүхтэй. Хонгирад аймгууд нь хүний нэрээр нэрлэгдэж байв. Жишээлбэл, “Алтан сав”-наас гурван хөвгүүн төрсөн хэмээсэн домогт гардгийн нэгдэх хөвгүүн нь Журлук-мэргэн бөгөөд Хонгирадад хамрагдаж байгаа аймгуудын өвөг нь аж. Хоёрдугаар хөвгүүн нь Кубай Ширэ бөгөөд Ихирас, Олхунуд гэсэн хоёр хүүтэй. Эл хоёр хөвгүүнээс салбарлагсад мөн эдний нэрээр нэрлэгдсэн Ихирас, Олхонуд хэмээх хоёр аймгийг үүсгэжээ. Мөн гуравдугаар хөвгүүн Түсүбү-Даудын хоёр хөвгүүн хар нүдэн, Кинклиуд ба тэдгээрээс салбарлагсад нь харнууд ба Хунхлиуд гэсэн аймгийг үүсгэсэн байна. Ийнхүү үүссэн эдгээр аймгуудаас Хонгирадын холбоо бүрэлдсэн бололтой. Хонгирадын холбоо нь ханлиг улсын түвшинд хүрч хөгжөөгүй ч гэсэн нэр сүртэй ул мөртэй аймгууд байж, Монгол аймаг, ханлигуудын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулсан түүхтэй болно. Хонгирадууд XII зууны эхэнд Цагаан хэрэмээс хойш нутаглаж байгаад XII зууны сүүлээр /1170-1200 онд/ Халх гол хавьд нүүдэллэн ирж суурьшжээ. Хонгирад аймаг нь язгуур удам сайтай, төлөв түвшин аймаг байсан байна. Энэ тухай “Монголын нууц товчоо”-нд Хонгирад өөрсдийгөө бусдын нутгийг булаан тэмцэлдээгүй, хацар гоо хатадтай, өнгө сайн охидтой гэж сайрхдаг байжээ” /32.41/

Хонгирад аймаг нь Чингисийн удам, Чингисийн улс төрийг байгуулах үйл ажилд хүчин зүтгэж, дотно холбоо, ураг барилдах нарийн жимээр холбогдож, түүхэн зохих замыг туулсан болой. Хамаг Монголын хан Есүхэй баатар, Хонгирадын толгойлогч Дай сэцэн нар худ ургууд болж, хүү Тэмүүжин нь охин Бөртэ нар хуримлах сүй тавьсан болон хожимхон нь Тэмүүжин Бөртэ үжинтэй гэр бүл болж, үр хүүхдүүд төрүүлсэн зэрэг нь эл холбоо, харилцааны үндэс болсон аж. Тэмүүжин Хамаг Монголыг сэргээх, Монгол туургатныг нэгтгэх үйл ажиллагааг дэмжин тусалж үүнд Хонгирадууд идэвхитэй оролцсон ажээ. Тэмүжиний удам, Хонгирадын удам олон үеийг дамжиж худ урагийн холбоотой байсан ажээ. Хонгирадууд мал аж ахуйг голлон эрхэлдэг нүүдэлчин аймгууд байсан байна.

Баргын холбоо. Барга³⁶ /Баргуд/-ын холбоонд хори /кори/ тулас, тумат /түмэд/ аймгуудаас бүрдэнэ. Барга аймаг нь Монголын төв нутгаас хол, хязгаар нутагт оршино. Эл аймгийн холбооны үндсэн нутаг нь “Баргужин-Төхөм” түүний хавь орчмын газар болно. Барга аймаг тус бүрийг толгойлогч ноён захирна. Барга аймгууд нь харилцан ойр төстэй ба энэхүү Баргужин Төхөм нь Сэлэнгийн солгой этгээдэд оршино.

Баргын холбооны аймгууд нь Ойрад, ойн урианхад болон булгачин, хэрэмчин аймгуудтай залган хөршилдөг байжээ.

Барга аймгаас Түмэд аймаг салбарлан гарчээ. Эл аймаг секиз /Найман мөрөн/ орчимд нутаглаж, Хиргис аймгуудтай айл хөрш орших болсон байна. Барга аймаг Монголын Элжигин аймагтай гарлын холбоотой төдийгүй, нэг адил тамга хэрэглэдэг байжээ. Түүх судлаачид Элжигин аймаг нь Барга аймгуудаас салбарлан үүссэн /33.380/ хэмээн үздэг.

Барга аймаг нь Элжигин аймагтай ургийн холбоотой байжээ. Хабул ханы хүү Бартанбаатар Барга аймагтай ургийн холбоотой болж авааль хатан Сунигул Фүжигээ /32.72/ Баргаас гэргий болгон буулгасан байдаг бөлгөө. Энэ тухай “Судрын чуулган”, “Монголын нууц товчоо”-нд дурдсан байдаг. “Судрын чуулган”-д “Баргут аймаг Элжигин аймагтай найрамдалтай байсан, одоо ч байна.” Баргут, Элжигин аймаг “бие биенээсээ хүүхэн авч, өгөлцөж байдаг” /46.83/ Энд мөн Чингис хааны өвөг эцэг Хабулын Барданбаатарын их хатан Сунигул Баргуд аймгийн хүн байсан хэмээн /46.197/ дурдсан нь бий. Барга аймгийн аж ахуйн тухай мэдээ сурвалж бичиг, зохиолд маш хомс тусгагдсан агаад тодорхой мэдээ байхгүй болой. Харин Баргын холбооны аймгуудын “нийгмийн хөгжил нь ойн урианхадаас арай доогуур, булгачин, хэрэмчин аймгуудаас арай дээгүүр шатанд байсан” /34.72/ хэмээн түүхэнд тэмдэглэсэн байна.

Ойн Урианхай аймаг. Маш эртний түүхтэй аймгийн нэг нь Урианхай мөн. X-XII зууны үеийн Монголын аймгуудын түүхэнд хоёр төрлийн Урианхай³⁷ байсан хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Үүнд: *нэгдүгээрт* Бурхан Халдун хавийн буюу талын Урианхай, *хоёрдугаарт* Байгалнуур, Баргужин Төхөм хавиар нутагтай ойн Урианхай болно. Харин ойн Урианхай нь түүхэнд хожим мэдэгдэн тэмдэглэгдсэн ажээ. X зууны эхэнд Хятад сурвалжид баруун хойд Урианхай хэмээн тэмдэглэсэн нь ойн Урианхай байжээ. “Судрын чуулган”-д ойн Урианхайчууд XII-XIII зууны үед Баргужин Төхөмд нутаглаж байсан /34.156 / гэж тэмдэглэсэн байна. Ойн Урианхай хэмээн нэрлэгддэг энэхүү ойн аймаг нь хори, түмэд, боргужин аймагтай хөршлөн оршино. Урианхайчууд бол мөргөлийг үнэнхүү биширч түүнд бүхнээ даатгадаг байжээ.

Урианхай аймаг өөрийн төрх амьдралаараа амь зуусаар Монголын нэгдсэн улсын бүрэлдэхүүнд орсон бөлгөө. Эл аймаг нэгдсэн Монгол улсын түүхэнд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулж, энэхүү аугаа их төрд зүтгэх үнэнч зүтгэлтнийг төрүүлсэн бөлгөө.

Урианхай аймгийн бахархал нь Чингисийн хишигтэн цэргийн ноён Зэлмэ-Ухэ, түүний хүү зүүн гарын цэргийн ноён Есү-Буха-Тайши, мянгатын захирагч, баруун түмний ноён, Чингисийн хорчин нарын дарга Есүн-Буха-Тархи /их багш, эрдэмтэн/, Чингис хааны есөн өрлөгийн нэгэн, цэргийн алдар суут жанжин Сүбээдэй баатар, мянганы ноён Хараун-Джубан, Буурч Төмөр-Буха зэрэг олон нэрт хүмүүс байжээ.

Монголын нэгдсэн улсын их төрийг гүнээ хүндэтгэн, энэ их төрд үнэнчээр зүтгэсний илрэл нь Чингис хааны “их ясыг тавьсан Бурхан Халдун гэдэг дархалсан газар /хориг/-ыг өөрсдийнхөө /Урианхайчууд/ мянгатуудаар хамгаалж байсан” /46.116/ явдал мөн. Урианхайчууд Чингисийн үеэс хойшид ч түүнийг залгамжлагчдад үнэнчээр алба хашсан түүхтэй. Үүний жишээ нь Сүбээдэй баатарын хүү мянгатын ноён Хөхчү /Күкүджи/, Мөнх хааны цэргийн ерөнхийлөн захирагч, Хубилай хааны цэргийн жанжин Урианхайдай, олон улсын элч Чаурхай Илаган зэрэг алдартнууд мөн юм.

Ойн аймгууд. Монголын нэгдсэн улс байгуулагдахын өмнөх үед Ойн иргэдэд Урасуд, Тэлэгүд, Куштем аймгуудыг хамаарагдаж байв. Уугуул утгаараа ойн иргэд нь Монгол нутагт оршиж байсан Монголчуудын өвөрмөц хэсэг, амьдралын хэв маяг нь жинхэнэ малчин Монголчуудаас ялгагдах өвөрмөц онцлог бүхий ард түмэн болно. Ойн иргэд нь XII зууны үед нэгдүгээрт, жинхэнэ ой тайгад байнга оршин суудаг, хоёрдугаарт, ой тайга завсардсан нутагт оршин суудаг, эсвэл хожим тэнд очиж идээшил олсон иргэд хэмээн хоёр төрөлд хуваагдаж байжээ.

Дээр дурдсан Урасуд, Тэлэгүм, Куштем аймгууд нь Монгол маягт хамаарах амьдралын хэв маягтай боловч зөвхөн ой тайга, сүрлэг уулс, цаст өндөрлөгт нүүдэллэн, гэрт биш урц овоохойд амьдардаг нүүдэлчин ард түмэн юм. “Судрын чуулган”-д “ойд нутагладаг”, “Монгол эм сайн мэддэг, Монгол аргаар сайн эмчилдэг” /46.84/ учир ойн иргэд хэмээн нэрлэдэг гэж тэмдэглэжээ. Ойн аймгууд нь ойр ойрхон олон өрхөөрөө амьдардаг. Хооронд нь ялгахад хэцүү. Тэгээд ч ойн иргэдийн нутагладаг нутаг нь хиргисчүүд, баргудууд, монголчуудын нутгийн хооронд нь зайчлан орших газар байдаг учир тэдгээр аймгуудтай хүйн холбоотой байдаг онцлогтой. “Судрын чуулган”-д “Урасуд, Куштем, Теленгуд аймгийн нутаг нь хиргисүүдийн нөгөө талд нэг сарын газар оршдог байв” /46.84/ гэж дурдсан байдаг. Ер нь ойн нэг аймаг нөгөөгөөсөө нэг сар, хоёр сар, эсхүл арав хоног явахаар хол байдаг /46.84/ байсан ажээ.

Ойн аймгуудын амьдрал нь жинхэнэ ой тайгад амьдрагчид ба тал хээр нутагт амьдардаг хүмүүсийн хоорондын яах аргагүй нарийн увидас холбоог зөвхөн өөртөө агуулж, аж төрж амьдарсаар Монголын нэгдсэн улсын бүрэлдэхүүнд орсон түүхтэй.

Монголын түүхэн зохиолд дурдсанаар Чингис хаан Монгол туургатныг нэгтгэх явцдаа өөрийн ахмад хүү Зүчийн үйл ажиллагаагаар ойн иргэдийг өөртөө нэгтгэн авсан ажээ. Монголын түүхийн тулгуур зохиолд ойн иргэдэд булгачин, хэрэмчин аймгууд болон **Хилга** мөрөн нутагт амьдардаг загасчин, гөрөөчин иргэдийг хамааруулсан байдаг нь үндэслэлтэй болой.

Булгачин, хэрэмчин аймгууд нь Багужин төхөм орчмоор нутаглаж, Хиргисчүүдтэй хил залган нутагладаг учир ойн аймагтай хүйн холбоотой болох үндэслэлтэй байсан бөлгөө.

Жалайрын холбоо. Жалайрын³⁸ холбоо нь ихээхэн газар нутаг, олон хүн ам бүхий арван аймгаас бүрдсэн томоохон холбоо байжээ. Тус холбооны бүрэлдэхүүнд Джат, Тукараун, Кунхсауд, Кумсаут, Уят, Нилкан, Куркин, Тулангит, Тури, Шанкут гэсэн аймгууд багтаж байв /46.59/. Аймаг бүр захирагч ноёноор толгойлуулсан бэлчээр нутаг, хүн ам бүхий харьцангуй бие даасан нэгж байсан аж.

Жалайр аймгийн нэг хэсэг нь Ононд нутаглаж байгаад Хятадын довтолгоонд өртөгдөн сүйрч, үлдсэн нь зугатан гарч Дутум Мэнэний хоёрдугаар хүү Хайду-хан, түүний хүүхэд, садангийн олзны хүмүүст тооцогдон өвгөөс өвөгт өвлөгдсөөр эцсийн дүнд аймгаараа Чингисийн харьяат болсон ажээ. Жалайрын холбооныхон Чингис, түүний удмынханд үйлчилж, аян байлдаанд нь оролцон, хүчээ өгч ирсэн түүхтэй болой. Тийм ч учраас Жалайр³⁸ аймгаас “цэргийн ноёд, нэр хүндтэй хүмүүс олноор гарсан” /46.59/ ажээ.

Чингис хааны үед Жалайрын бүх аймгаас хамгийн алдартай төр, цэргийн нэрт зүтгэлтэн нь Джат угсааны Мухулай байсан ажээ. Тэрээр Чингис хааны зүүн гарын бүх цэргийг захирч, Го Ван хэмээн цоллогдож, бас удмыг нь Го ван хэмээн нэрлэдэг байжээ. Жалайр аймгийн удмаас Иран дахь түмтийн ноён Жаукур, Умук, мянганы ноён Олхун, Бартас, Тайсун улсын элч ноён Булаудур, гүржийг захирагч Хорчин-Бугун, Хулагу хааны нэрт зүтгэлтэн Илгай их ноён, Кинжатугийн их ноён Ахбота, Чингис хааны бараа бологч Хадан ноён, Өгөдэй хааны цэргийн хүндтэй ноён Илүхэ, Мөнх хааны заргачдын ахлагч их ноён Мунхасар гэх мэтийн нэр төртэй олон арван хүмүүс гарч Монгол улсад зүтгэж байсан байна.

Эдгээрээс үзэхүл Жалайр аймгууд хүчирхэг ханлиг улсын хэмжээнд хүрч хөгжин хараахан чадаагүй ч гэсэн аймгуудын холбооны зохион байгуулалтад орж, Хамаг Монгол улсыг сэргээх, нэгдсэн их улсыг байгуулахад хүчин зүтгэсээр Монголын нэгдсэн улсын бүрэлдэхүүнд орсон түүхтэй.



ДЭД АНГИЙН ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. *“Монголчуудын нийгмийн байгуулал”* /Нүүдлийн феодализм/-Оросын академич Б.Я.Владимирцовын /1884-1931/ бичсэн алдарт зохиол. IX-XII зууны монгол, ханлигуудын гарвал шинж төрх, нийгмийн байгуулал, амьдралын хэв маягийг дагнан судалж бичсэн судалгааны ховорхон бүтээл. “Монголчуудын нийгмийн байгуулал” зохиолд монгол аймгуудын гарвал угсаа, үүсэл, хувьсал, нутагшилт, эрхэлж байсан аж ахуй, зан заншил, аймгуудын хоорондын харилцаа, гүйцэтгэсэн үүрэг ролийг өгүүлж, олон шинэ санаа, дүгнэлтүүд дэвшүүлэн тавьсан байдаг. Монгол аймгуудыг эрхлэх аж ахуй, соёлын байдлаар нь талын аймгууд, ойн аймгууд гэсэн хоёр бүлэгт хуваан, тус бүрийн нь хөгжлийн төвшин, цаашид төлөвших төрх төлөвийг тодорхойлсон нь их үнэ цэнэтэй бөлгөө. Эл зохиол монгол аймгууд, тэдгээрийн холбоо, ханлигуудын судалгаанд томоохон байр эзэлдэг юм.

2 *“Монгол”*- Монгол угсаатны бүх аймаг улсыг төлөөлсөн ерөнхий нэр. Монгол угсаатныг Хүннүгийн үеэс үүсэлтэй гэж үздэг. Хүннүгийн сурвалжит “Хуянь” овог бол Монголын “Хиан” овог мөн /50.216/. Гэтэл Хиан нь дарилгин монголын өвөг бөлгөө. Хиан аймгаас монгол аймгууд үүсэж, монгол гэсэн нэрээр нэрлэгдэх болсон гэдэг. Тоба улсын үед “Му-Гу-Люй”, Хятад сурвалжид “Мэн-Гу-Ла”, “Мын-у”, “Мон-ва”, “Мон-Гу-Ли”, “Мэн-гэ”, “Ман-гузы”, “Ман-Гу”, “Мэн-Гу” гэх зэргээр тэмдэглэгдсэн үгийг “Монгол” гэж үзээд Хятадын түүхчид зохиолдоо “Монголын түүх” гэж нэрлэсэн байдаг. Юан гүрний үед нэрлэгдсэн “Мэн-гу” гэсэн тэрхүү Хятад үсэг өөрчлөгдөхгүй өдий хүрчээ. “Судрын чуулган”-д “Монгол” гэдэг тэдгээрийн овгийн нэр, “Монгол” гэдэг үг анх Мун-гу гэгдэж байсан.

Өөрөөр хэлбэл Персээр “формандэ” гэсэн үг. Харин хиан /Киян/ гэдэг нь уулнаас доош урсагч түргэн, ширүүн хүчтэй “том урсгал” гэсэн утгатай хэмээн Рашид-ад-Дин бичсэн байдаг /46.112/.

3. *“Монгол аймаг”*- IX-XII зуунд Монгол нутагт оршиж байсан бүх монгол аймгуудыг багтаасан ерөнхий нэр. Монголын нууц товчоо, Рашид-ад-Дины “Судрын чуулган” зэрэг түүхэн сурвалжид дурдсаныг болгоовоос эл үед 100 гаруй монгол аймаг оршиж байжээ /18.27/. Тэд нь аймаг, аймгуудын холбоо, ханлигийн хэлбэрээр оршиж, Монгол маягаар /нүүдэллэж/ амьдарч, монгол хэл аялгаар ярьж, монгол зан заншлаа баримталж, монгол соёлоо дэлгэрүүлж байсан нийтлэг шинжтэй байсан болой.

4. *“Монгол ханлиг”*- XII зууны эцэст Монгол нутагт оршиж байсан ханаар толгойлуулсан монгол жижиг улсуудыг нийтэд нь монгол ханлиг гэж нэрлэдэг.

Монгол ханлигт “Хамаг Монгол”, “Хэрэйд”, “Найман”-ы хант улсууд багтана. Европынхоор бол “вант улс” гэдэгтэй жишиг нэг болно.

Монгол ханлиг нь нийгмийн харилцаа, төрт ёсны хөгжлийн хувьд аймгийн ердийн холбоо бус түүний дараагийн шатны нийгмийн зохион байгуулалтын хэлбэр, түүрүү феодализмын хант улсууд мөн юм.

5. "Бөртэ-Чино"- Дарилгин монголчуудын нөлөө бүхий удирдагч хүний нэр. Бөртэ-Чино нь 758 онд төрсөн түүхт хүн мөн.

Бөртэ нь Чинос ястны ахлагч, монгол овогтон аймгийн ахмад удирдагч нь байжээ /20.7/. Доктор Ч.Далайн мөшгөснөөр Бөртэ-Чино шороо нохой жил буюу 758 онд, Бодончар төмөр морин жил буюу 970 онд төрсөнөөс үзэхэд Бөртэ-Чино төрснөөс Бодончар хүртэл 212 жил болсон нь тодорхой байна /20.8/. Бөртэ-Чино Өөлдийн Гоо маралтай ханилан сууж олон хүүхэд төрүүлсний ахмад нь Батцагаан юм. Бөртэ-Чино Онон мөрний эхэн, Бурхан Халдунаас Онон, Хэрлэн, Туул гурван голын урсгалын дагуу нутаглаж байсан аж.

6. "Язгуур Монгол"- VIII, IX зуунаас монгол аймгуудыг жинхэнэ монгол аймгууд ба монголжуу монгол аймгууд хэмээн ялган нэрлэх болжээ. Үүний жинхэнэ монгол аймаг нь язгуурын монголчуудаас бүрдэж байжээ. Язгуурын монголд "Дарилгин" ба "Нирун"-наас салбарлан үүссэн төв Монголчууд багтана. Нирун монголд нь хиад, тайчууд, Жадран аймгийн монголчууд харьяалагдаж, голдуу Бурхан Халдан уулаар Онон мөрний эх ба адгаар нутаглаж байжээ. "Дарилгин" Монголд нь голдуу Урианхай, Хонгирад, Баядууд багтаж Бурхан Халдуны хавиар нутаглаж, өмнө талаараа Хятадтай хил залгаж байсан байна.

7. "Батцагаан"- Бөртэ-Чино-ын 29 настай байхад 970 онд төрсөн, түүний ахмад хүү Монголын нууц товчоонд Бөртэ-Чино-ын Бурхан Халдунд нутаглаж байхад Батачи хаан төрсөн ажгуу гэж өгүүлжээ /32.5/. Тэрбээр Бөртэ-Чино-ыг нас барсны дараагаар Монголыг хан цолтойгоор захирч байсан. Бөртэ-Чино-ын дараа түүний хүү Батцагаан гол Монголыг захирсан зонхилогч болж, бас "хан" хэмээх цолтой байжээ гэж бичсэн байдаг. Батцагааныг түүх сурвалж ном, зохиолд бас "Батачи" гэж бичсэн байдаг билээ. Гэхдээ энэ нь нэг л хүний нэр билээ. Батцагааны дараах Монгол аймгуудын зонхилогчид нь түүний шууд угсааны язгууртнууд байсан ажгуу.

8. "Боржигидай мэргэн"- Монгол аймгийн зонхилогч, Харчиугийн хөвгүүн. Харчиугийн хүү Боржигидай мэргэн нь баян чинээлэг, мэргэн харваач хүн байв. Боржигидай мэргэн нь алс холын ойн иргэн, хори Түмэдийн Монголжингоо гэдэг гэргийтэй байсан бөгөөд Торголжин баян гэдэг хүү төрүүлсэн бөлгөө. Боржигидай мэргэн, Монголжин гоо хатан хоёр бол Боржигон овгийн өвөг дээдсийн үлгэрийн биш үнэн дүр мөн /20.8/. Боржигидай мэргэн Бурхан Халдан уулын өврөөр нутаглаж байжээ. Боржигидай мэргэнээс монгол овог аймгийн дотор тодорхой шинэ үе эхэлсэн түүхтэй ажгуу. Тэрээр язгуурын монгол Дарлигин аймгийн хиан ястны ахлагч юм.

Эл гэр бүл нь тухайн үеийн язгууртны ураг барилдах ёсонд ихэд нийцэж, төв монголыг бусад монголтой холбоход чухал үүрэг гүйцэтгэсэн болой.

9. “Добу мэргэн”- Боржигдай мэргэний хүү Торголжин баяны хатан Борогчингоогоос төрсөн. Өөрөөр хэлбэл Боржигдай мэргэний ач хүү. Добу мэргэн нь удам дагасан язгууртан, сайн харваач /мэргэн/ хүн байжээ. Добу мэргэн нь Бөртэ-Чино-ын аравдахь үеийн ач, Чингис хааны арван нэгдэх үеийн дээд өвөг болно. /20.9/ Добу мэргэн нь язгуурын баян чинээлэг, нэр хүндтэй, зохион байгуулах авьяас билэгтэй агаад Дарилгин монгол аймгийг захирч Бурхан Халдун уулын хавиар нутаглаж байжээ.

Түүнийг нас барсны дараагаар Язгуур монголын ханы суурь Дарилгин монголоос Нирун Монголд шилжсэн түүхтэй.

10. “Дарилгин Монгол”- Монголчуудын эртний хуланц дээдэс болох Нохос, Хиан хоёр овгоос төрж үржигсэд нь дарилгинчууд болно. Дарилгинчууд нь Бөртэ-Чино-ны залгамж удам Добу мэргэний хатан Алунгоогоос төрсөн Бэлгэнүтэй, Бүгүнүтэй нарын үр удам юм. Дарилгин Монгол нь X-XII зууны үед Хамаг Монголын бүрэлдэхүүний нэг гол хэсэг аж. Энэ үед Дарилгин гэх ерөнхий нэрийн дор 18 аймаг багтаж, тус тусынхаа нутаг дэвсгэрт оршин тогтнож байжээ. Рашид-ад-Дины бичсэнээр эдгээр 18 аймагт Нукуз, Урианхан, Хонгирад, Ихирэс, Олхонуд, Куралос, Илжигин, Үүшин /хушин/, Сүлдеун, Илдуркин, Баяуд, Кингит аймгууд багтаж байжээ. Эдгээр 18 аймаг нь Бөртэ-Чино-ын удам болно. Үүний дээр Бэлгэнүдэй, Бүгүнүтэй хоёрын удмын Бөгөнүд, Бэлгэнүд, Харнууд гэх зэрэг овог аймаг нэмэгдэж байв. Эдгээрийг нийтэд нь Дарилгин монгол, Дарилгин Монгол аймгууд хэмээн нэрлэж байсан болой.

11. “Нирун монгол”- Добу мэргэний бэлбэсэн гэргий Алунгоогийн гурван хөвгүүнээс гарсан бүх аймгуудыг “Нирун”, “Нирун монгол аймаг” хэмээнэ. “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган”, “Монгол нирун улс” тулгуур зохиолуудад Алунгоогийн тооноор нэвтэрч ирсэн гэрлээс жирэмсэлж нирунаас гарсан хөвгүүдийн удмыг нирунчууд гэнэ хэмээн домогоос үндэслэн өгүүлсэн байдаг. Алунгоо Хори Түмэдийн Ариг усун гэдэг газар Хорилдай мэргэний гэрт төрсөн үзэсгэлэн төгс бүсгүй бөгөөд Добу мэргэнийг нас барсны дараа дахин дээрхи гурван хүүг төрүүлсэн ажгуу. Тухайлбал эдгээр гурван хөвгүүн нь Буха Хатиги, Бухату Салжи, Бодончар мунхаг гурваас Нирун монгол үүссэн байна. Алунгоогийн эдгээр гурван хөвгүүний нэрээр Хатигин, Салжиуд, Боржигон гурван овог үүссэн түүхтэй. Хотула хааны үед Нирун 10 аймаг байжээ /34.60/.

12. “Талын малчин аймаг”- X-XII зууны Монгол аймгуудын дийлэнх аймгийг ингэж нэрлэж байв. Мал аж ахуйг эрхэлж амьдарна. Монгол газар орны хангай, тал хээр, говийн уудам нутгаар нүүдэллэн мал сүргээ маллаж, өрх гэр, айл саахалтаар

эсгий гэрт амьдарч, малынхаа мах, арьс, шир, үс, ноос, ашиг шим, сүү саалийг ашиглан, арилжаа худалдаа хийж аж төрнө. Үүнийхээ зэрэгцээгээр гар урлал хөгжүүлж, бага зэргийн тариа тарьж, ан гөрөө хийн аж ахуйдаа тус нэмэр болгоно.

Талын аймгууд нь нийтдээ малчин аймгууд бөгөөд тэдгээрийн хөгжил, соёлын түвшин ойн аймгуудаасаа өндөр байсан ажээ. Малчин аймгууд өөр хоорондоо болон бусад улс орны иргэдтэй өргөн харилцаатай байхыг эрмэлзэж байжээ.

13. “Ойн аймаг”- Монгол нутгийн ой тайга, цаст уулсаар нутаглаж, ан гөрөө, цаа буга өсгөж, зэрлэг хонь, ямаа агнаж аж төрдөг аймгууд. Ийм маягаар амьдардаг бүх аймгуудыг нийтэд нь “ойн аймаг” гэж нэрлэдэг. Ойн аймгууд гэсэн ерөнхий нэрийн дор урасуд, куштейм, тэлэгүд, булгачин, хэрэмчин зэрэг аймгууд оршин амьдарч байжээ. Ойн аймгууд нь талын аймгуудаас цөөн, хөгжлийн түвшингөөр доогуур боловч талын аймаг /малчин/-уудаас амьдрах хэв маягаараа ихээхэн ялгаа, онцлогтой. Ойн аймгуудын амьдрах гол салбар нь ан гөрөө. Төрөл бүрийн ан агнаж, махыг нь идэн, арьс үсийг нь ашиглан, мөн арилжаа солилцоондоо хэрэглэхийн хамт, цаа буга, ор буга, уулын үхэр /сарлаг/, уулын хонь /аргаль/, бор гөрөөс барьж сүү сааль, арьс, махыг нь хэрэглэж байжээ. Тэд урц овоохойд амьдарч, удам угсаагаа бэлтгэдэг өвөрмөц онцлогтой.

14. “Аймгуудын холбоо”- Хэд хэдэн аймгуудын нэгдэл. Бас Монгол угсаатан аймгуудын оршин тогтнох зохион байгуулалтын хэлбэр. Түүний гол агуулга нь удам угсаа, амьдрах зорилго, эрхлэх аж ахуй, аж төрөх горим, зан заншил, хэл, соёлоор адилдуу аймгууд нэгдэж нэгэн холбоо болоход оршино. Үүнийг аймгийн холбоо хэмээнэ. Аймгийн холбоо нь өөрт нь нэгтгэгдсэн бүх аймгийн эрх ашгийг хамгаалж, нэгэн ерөнхий удирдлагад захирагдаж, дотоод, гадаад эрх ашигтаа нэгэн чигийн бодлогод захирагдана. Жишээлбээс Татарын холбоо нь хөгжлийн түвшингийнхээ хувьд ханлиг улсын өмнөх шат болно.

15. “Бодончар”- Чингис хааны дээд өвөг Алунгоогийн таван хүүхдийн хамгийн бага нь Бодончар юм. Өөрөөр хэлбэл Алунгоогийн нуруунаас гарсан гуравдахь хүү болно. Алунгоог нас барсны дараа хөрөнгө, малаа хуваахдаа эхний дөрөв нь бүгдийг хуваан авч харин Бодончарт хувь эс өгөв /32.34/. Үүний дараа Бодончар Онон мөрний Балжийн аралд хүрч суурьшжээ. Ах Бугу Хатачи нь дүүгээ эрсээс Бодончартай уулзаад дагуулж буцжээ. Тэд замдаа Түнхэлэг горхинд хэсэг иргэн буйг хараад ах нартаа очоод зөвлөлдөж эргэн ирж дагуулан авчээ.

Эд нарын дотор байсан Жарчиуд Урианхай жирэмсэн эмэгтэйтэй Бодончар ханилан суужээ. Чингээд хүү төрөхөд түүнд Жад /харь/ иргэний хөвгүүн гэсэн утгаар Жажирдай гэсэн нэр өгчээ. Ингэж Бодончар Хиад яснаасаа салаагүй харин ах нараасаа салж Боржигон овогтонг үүсгэсэн түүхтэй.

Жажирдайн хөвгүүн Түгүдэй, Түгүдэйн хөвгүүн Бури Булчиру, Бури Булчируйн хөвгүүн Хар Хадаан, Хар Хадааны хөвгүүн Жамуха бөгөөд тэд нийлж Жадаран овогтой болжээ /32.35/. Бодончараас үндэслэн 16 овог салбарлан гарсан түүхтэй /20.14/.

16. “Да-Мэн-гу”- Хамаг Монгол улсыг Хятадын судар түүхэнд тэмдэглэсэн нэр. “Да-Мэн-гу” нь монголчилбол “Их Монгол” гэсэн үг. “Да-Мэн-Гу”-г Тайваны эрдэмтэн Хаганчулуу “Олонхийн гол улс” гэж орчуулсан байдаг. Хамаг Монголын суурь XII зууны эхэн хагаст /Байшинхор, Тумбинай сэцэний үе/ тавигдаж Хабул хааны үед улс болон байгуулагдсан хэмээн түүхэнд үздэг /20.38/

17. “Тумбинай Сэцэн”- Байшинхор догшины ганц хөвгүүн, Хабул хааны эцэг, Чингис хааны өвөг, боржигон овгийн хүн. Тумбинай сэцэн нь Боржигон овгийн нэр хүндтэй язгууртан, Хамаг Монголчуудын нэгэн удирдагч байж, алдар цуу, үлгэр жишээг дараа дараачийн үедээ өвлүүлэн үлдээсэн язгуурын хүн байв. Тумбинайн ургаас эзэнт улсын хаад эрхэмсэг эзэнтнүүд гарсан бөгөөд тэдний хүн бүр нь эрэлхэгийн билэг тэмдэг аз жаргалын голомт болж үлдсэн түүхтэй /16.178/. Тумбинайн сэцэн Байшинхор догшиныг залгамжлан Хамаг Монголыг бүрэлдүүлэх үндэс суурийг тавилцаж, Хамаг Монгол улсыг байгуулах үйлсэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн гавъяатан болно.

18. “Хабул”- Хамаг Монгол улсын анхны хаан. Нирун-хиад овгийн хүн. Хабул хаан /1101-1137/ бол Батцагааны 19 дүгээр ач, Бодончарын 8 дугаар үе, Тумбинай сэцэний ууган хөвгүүн, Чингис хааны элэнцэг болно. Хамаг Монгол улсыг байгуулсан нь Хабул хааны монголын түүхэнд байгуулсан хамгийн том гавьяа мөн.

Тэрбээр монголын түүхэнд нэн их гавьяа байгуулсан улс төр, цэргийн нэрт зүтгэлтэн болно. Хабул хааныг “шинэчлэгч хаан”, “олноор хэлэлцэх ардчилалыг тогтоосон хаан” гэх зэргээр үнэлсэн байдаг /20-47/ бөлгөө.

19. “Амбагай”- Хамаг Монгол улсын хоёрдахь хаан, Тайчуудын Сэнгүн Билгэ-гийн хөвгүүн, Хамаг Монголын анхны хаан Хабултай нэг ясан төрөл. Хабул хааны гэрээсийн дагуу Хамаг Монголын хаанаар өргөмжлөгдсөн. Хаан суумагцаа Тайчууд аймгийг Хамаг Монголын тэргүүлэх аймаг болгосон. Энэ үеэс улсын гол хүч нь тайчууд болжээ /20.48/. Амбагай нь улсынхаа эв нэгдлийг хангах, гаднын хүчнээс Хамаг Монголыг хамгаалах, нэр хүндтэй хаан бүхий хүчирхэг улс байхын төлөө тууштай тэмцэж байсан ажгуу. Амбагай хааны үед Хамаг Монгол улс хүчтэй болсон түүхтэй. “Амбагай угаас эвдрэлцэхээс эвлэхийг илүү хичээдэг хаан байжээ. Ялангуяа монголчууд бүгдээрээ хүчээ нэгтгэсэн цагт л Алтан улсыг ялан дийлнэ. Тэгэхгүй цагт үргэлж хүч дутаж байх болно. Татарын ард иргэд ч үүнийг ойлгон дэмжих учиртай гэж тэрээр үздэг байжээ” /34.69/ гэж Монголын түүхийн тулгуур зохиолд тэмдэглэсэн байдаг.

20. “Модон илжигэнд хадах”- Ялтан гэх хүнийг “модон илжигэнд” төмөр хадаасаар хадаж, тарчлаан зовоож алдаг Хятадын Алтан улсын цаазаар авах ял.

“Модон илжигэнд хадах” гэдэг нь тусгай бэлтгэсэн хавтгай модон дээр наран өөд, дээш харуулж хэвтүүлээд, дөрвөн мөчийг нь хадаасаар доод модонд нь хадаж тэлээд амьдаар нь тарчилгаан зовоож, цангаан хатааж алахыг хэлнэ /20.29.51/. Татарчууд, Хамаг Монголын хаад язгууртныг баривчилж аваад Алтан улсад хүргүүлэхэд тус улсын хаан нь модон илжигэнд хадаж түүнийг цаазлан хороодог байжээ. Татарчууд Хамаг Монголын хаан Амбагай, Хабул хааны ууган хүү Охин бархаг, дунд хүү Хаданбаатар нарыг барин авч, Алтан улсад хүргүүлсэнийг Алтан улсын хаад дээрх аргаар цаазлан хороосон нь түүхнээ тэмдэглэгдсэн байдаг /46.68.69/. Хятадын Алтан улс Хамаг Монголын язгууртнуудыг эл аргаар цаазлан хороож байсан нь өс хонзонтой шууд холбоотой байжээ. Энэ нь *Нэгд*, Хятадын хааны элчийг Хабул хаан доромжилж хороосноос Хятадууд өс хонзон санаж байсантай. *Хоёрт*, Алтан улсын хааны энэхүү өс хонзон авах бодлыг Татарчууд сайн мэдэж, өөрсдийн бодлоо биелүүлэхэд ашиглах болсонтой. *Гуравт*, Хабул хааны гэргийн ах Хонгирад аймгийн Сайн Тегин өвдөхөд Татарын бөө Чархил Нүдүйг урьж ирүүлсэн боловч Сайн Тегин нас баржээ.

Үүнд хороссон түүний ах дүү нар бөөг гэрт нь очиж алснаас Татарчууд өс санаж ирсэнтэй тус тус холбоотой байжээ. Гэвч гурван талын энэхүү өс хонзон санах бодол санаа, хийсэн үйлдэл нь сайн юманд хүргэсэнгүй, харин ч олон удаа дайтах шалтаг болж, асар их хохирол учруулсаар эцэст нь Чингис хаан бүх Татар аймаг, Алтан улсыг устган эрхшээлдээ оруулснаар дуусгавар болсон /46.69/ түүхтэй.

21. “Хотула”- Хамаг Монголын гуравдахь хаан. Хотулаг Хамаг Монгол, тайчууд нар Онон мөрний Хорхунагийн хөндийд хуран цугларч Хотулаг Хамаг Монголын хаанд өргөмжилжээ. Д.Оссон “Монголын түүх” зохиолдоо “Хотулагийн дуу хоолой нь аянга ниргэх адил сүртэй бадриун, хоёр гар нь баавгайн савар шиг том, хоёр сумыг ташраар нь нэг сум шиг хуруугаараа хугалдаг, өвлийн хүйтэнд том модны дэргэд нүцгэн биеэр унтаж хэвтэхэд бүх биеэс нь хөлс чийхран уур савсаг, цуцлын гал бие дээр нь унаж байсан ч үл тооно. Нэг өдөрт хонины бүтэн мах иднэ. Айраг уух нь ёроолгүй ходоодтой адил” /46. /хэмээн Рашид-ад-Дины бичсэнээс үзэхэд ер бишийн бие бялдар, хүч чадалтай хүн байсан нь анхаарал татахуйц бөлгөө. Хотула нь эр зориг, авхаалж самбаатай, улсынхаа төлөө үнэнхүү хүч сэтгэлээ зориулсан хаан байсан аж.

22. “Улсын тайш”- Амбагай хааны засаг захиргааны зохион байгуулалтад хийсэн өөрчлөлтөөр бий болсон төрийн өндөр албан тушаал “Улсын тайш” гэдэг нь хааны дараа орох албан тушаал юм. Улсын тайш болсон хүн Хамаг Монгол улсын цэргийн хэргийг эрхэлж байжээ. Амбагай хаан улсын тайшаар өөрийн дунд хүү Хадааныг томилон ажиллуулж байв. Амбагай хан нас барахынхаа өмнө хааны орыг Хабулын дунд /дөрөвдэх/ хүү Хотулад залгамжуулж, миний дунд хүү Хадаан тайш хоёрдахь хүү нь болж яваарай хэмээн захиж байсан нь түүхнээ тэмдэглэгджээ /20.50/.

23. **“Есүхэй”**- Хабулын төрсөн ач. Барданбаатарын 3 дугаар хөвгүүн. Багаасаа нум сум харван, морь унаж сурсан. Байлдаж тоглох дуртай, шувууны анд хорхойтой байжээ. Юунаас ч айдаггүй зоригтой. Мэргэдийн их Чилэдүгийн авааль эхнэр Өэлүн Үжинийг булаан авч эхнэрээ болгосон түүхтэй. Есүхэй Тэмүүжин, Хасар, Хачиун, Тэмүгэ дөрвөн хүү, Тэмүлэн нэртэй нэг охинтой. Бас өөр нэг эхнэртэй байсан нь Сочигил хатан юм. Түүнээс Бэхтэр, Бэлгүтэй хоёр хөвгүүн төрсөн аж. Есүхэй нь Хамаг Монголын Хотула хааны хамтран зүтгэгч, түүнд ихэд үнэлэгдсэн ухаалаг эр зоригтой хүн. Алтан улс, Татарын эсрэг мятрашгүй тэмцэгч, олон удаа ялалт байгуулсан баатар эр.

Иймд Есүхэй баатар гэж алдаршсан аж. Хотула хааныг нас барсны дараа Хамаг Монголыг толгойлсон. Судлаачид, Есүхэйг Хамаг Монголын өргөмжлөгдөөгүй хаан байсан гэж үздэг /5.176/. Түүний гэргий Өэлүн Үжин Монголын түүхэн дэх ухаант монгол эмэгтэйн жинхэнэ дүр мөн /20.61/. Тэрбээр 4 хүү, нэг охины эх. Өөрийн хүүхэд ба бусад өргөмөл хүүхдүүдийг өргөн өсгөж төрийн зүтгэлтнүүд болгон хүмүүжүүлсэн алдарт эх хүн. Өэлүн Үжин эв найртай, зориг баатарлаг, тэсвэр тэвчээр, шулуун шударга байхын үлгэр жишээг үзүүлж Хамаг Монгол улсыг байгуулахад их гавъяа байгуулсан түүхтэй.

24. **“Татар”**- Монгол нутагт оршиж байсан эртний аймгуудаас үүдэл бүхий XII зууны эцсийн Монгол-Татар аймгуудын ерөнхий нэр. “Монголын нууц товчоо”-нд 6, “Судрын чуулган”-нд 8 Татар аймаг байсныг дурдсан нь бий. Эдгээр 14 аймгийн нэрийн 4 нь давхардаж байгааг хасвал 10 аймгийн нэр үлддэг боловч түүнд цагаан Татар ордоггүй байжээ. Чингэвэл XII зууны эцсээр Монгол нутагт 9 Татар аймаг оршиж байжээ.

Татар аймгийг нийтэд нь Татар аймаг гэх боловч тэрхүү нэрийн дор орших 9 Татар аймаг нь тус бүр нэртэй, оршин буй нутаг дэвсгэртэй, өөрийн гэсэн зохион байгуулалтын бүтэцтэй байжээ. X-XII зуунд Татар аймаг, Хамаг Монгол аймгуудтай сөргөлдөж ирсэн түүхтэй боловч олон олон Татар хүн их Монгол улсыг байгуулан бэхжүүлэхэд зүтгэсэн болой. Чингисийн өрлөг, их заргач Шихихутуг, Чингисийн хатан Есүгэн, Есүй, буурч Кули, Цэргийн ноён Дурбэй, мянганы ноён Денгиз зэрэг алдартнууд нь Татар овогтнууд байсан аж.

25. **“Зү-бу”**- XII зуунаас өмнө хүчирхэг байсан Татарчуудад харъяалагдан захирагдаж байсан ойн аймгууд Татар гэсэн нэрийн дор аж төрж “Зү-бу” хэмээн нэрлэгдэж байсан юм. Өөрөөр хэлбэл XII зуунаас өмнө монгол нутагт оршиж байсан монгол, түрэг, Татар аймгуудыг нийтэд нь “Зү-бу” гэж нэрлэж байжээ. Зү-бу гэх нэр X зууны эхнээс сурвалж бичигт тэмдэглэгдсэнийг бодохул энэ үеэс Зү-бу гэх нэр гарч ирсэн бололтой. Зү-бу бүгд 20 гаруй аймаг байсан гэх бөгөөд дотроо “Умард Зү-бу”, “Баруун Зү-бу” хэмээн хуваагдаж байжээ.

26. **“Елюй Даши”**- Хятан гүрэн мөхсөний дараа хэсэг хятанчуудыг толгойлон баруун зүг нүүдэллэсэн, хаан угсааны язгууртан хүн. Тэрээр Иран хүртэлх орныг байлдан эзэлж хүчирхэг улсыг байгуулсан аж. Энэ улсыг Хятадын түүхэнд Баруун Ляо улс, Араб Иран сударт Хар Хятан /Кидан/ гэж нэрлэдэг байжээ. Елюй Дашийн байгуулсан улс гүрэн болж хөгжиж, Амударьяа, Эрчис мөрний хооронд XIII зууны эхэн хүртэл оршин тогтнож байжээ. Хар Хятан улс нь Дорнод Туркестан, Дундод Азийн түүхэнд өөрийн ул мөрийг үлдээсэн түүхтэй.

27. **“Хэрэйд”**- XII зууны Монголын нэгэн ханлигийн нэр. Зү-бу аймгийн дотор Хэрэйд аймаг багтаж байсан гэж үздэг. Судлаачид “Умард Зү-бу-д Хэрэйд тэргүүтэй аймгууд багтаж байсан” /33-376/ хэмээн өгүүлсэн байдаг.

XI-XII зууны эхэнд хүчирхэгжин, хоорондоо нэгдэж, Хэрэйдийн ханлигийг байгуулсан. Хэрэйдийн ханлигт Хэрэйд, Джиркин, Конкант, Сакант, Тумаут, Албату, Киркун зэрэг аймгууд нэгдэж байжээ. Хэрэйд нь Яг ябган, Туул, Сэлэнгэ, Элсэн говийн хоорондох нутагт оршиж, Найман, Хамаг Монгол, Тангудын Ся улстай хиллэж байсан аж. Хүчтэй, соёлтой, нөлөөтэй ханлиг байсан түүхтэй.

28. **“Маркус”**- Хэрэйд ханлигийн анхны хаан. 1089 онд ханаар өргөмжлөгдсөн. Ван хааны өвөг эцэг, Түүнийг Буюрук хан гэж нэрлэдэг байсан /46.89-90/ хэмээн Рашид-ад-Дин бичсэн байдаг. Байнга тэрсэлддэг байсан Татарын тэргүүн Нор-Буюрук хан аятай боломжийг ашиглан Маркусыг барин авч Алтан улсад хүргүүлсэнд модон илжигэнд хадаж тарчлаан алжээ. Маркусын хатан Хүтугтай Хэрикчи, Татарын эзэн Нор-Буюрукт “100 хонь, 10 гүү, зүүн ундыр бэлэглэе” хэмээн хэлүүлээд ирмэгц нь ундырт нуусан хэдэн зуун баатар цэргээ гарган Татарын хааныг дагалдагсдынх нь хамт хядаж нөхрийнхөө өшөөг авч байсан түүхтэй. Ундыр гэдэг нь ширээр хийж тэргэн дээр ачсан маш том хөхүүр /айраг хадгалах сав/ бөгөөд нэгэнд нь таван зуун литр айраг багтдаг аж. Үүнд айраг бус цэргээ хийж нуун авч ирсэн хэрэг байжээ.

29. **“Тоорил”**- Хэрэйд аймгийн толгойлогч. 1196 онд Алтан улсын хаанаас “ван” цол хүртэж, түүнээс хойш Ван хан хэмээн алдаршжээ. Хурчухус Буюругийн зургаан хөвгүүний нэг. Долоон настайдаа Мэргэдэд баригдан будаа нүдэж, 13 настайдаа дахин баригдаж тэмээ хариулж амьдарч явжээ.

Хожим нь Тай-төмөр, Бух-төмөр хэмээх хоёр дүүгээ хороож хаан суудлыг булаан авчээ. Тоорил, Есүхэй баатартай нөхөрлөж үеийн үед анд байхаар тангараг тавьж байсан. Тэмүжинтэй түүнийг нөхөрлөн, харилцан бие биедээ тусалж байгаад 1200 оны өвлөөс түүнээс салсан. Тэмүжинд удаа дараа ялагдсаар 1203 онд нас барсанаар Хэрэйд мөхжээ.

Тэмүжин эцгийн анд болон ахмад, язгууртан хүний хувьд үргэлж хүндэтгэхийг эрмэлзэж, өөрийнхөө тал руу татах гэсэн боловч эс зөвшөөрсөн ажгуу.

30. “Найман”- ХI-ХII зуунд оршиж байсан Монголын нэгэн ханлиг. Монгол нутагт оршиж байсан баруун Зү-бу-д “Найман” хэмээх аймаг багтаж байсантай гарал үүсэл нь холбоотой. Найманы ханлиг Хангай-Алтайн уулсын завсарт нутаглаж байжээ. Найманы ханлиг нь 8 аймгаас бүрдэж байсан аж. ХII зууны дунд үед Найманы ханлигийг Наркыш-Таян, дараа нь түүний хүү Инанч Билгэ, ХII зууны эцсээс Таян хан толгойлж байжээ. Найманы ханлиг монголын томоохон, хүчирхэг, нилээд соёлжсон ханлиг байж, Монголын түүхэнд өөрийн байр сууриа эзэлж үлдээсэн түүхтэй. Найманы ханлиг Хэрэйд, Хамаг Монгол улстай хүчтэй өрсөлдөж олон удаа тулалдсаны эцэст ялагдан 1204 онд мөхсөн. Найманы Таян хан нас барсны дараа хүү Хүчүлүг нь эцгийн орыг залгасан боловч мөн л ялагдаж Хар Хятан улсад зугтан гарсан бөлгөө.

31. “Мэргэд”- Зү-бу 18 аймгийн бүрэлдэхүүнд байсан аймаг. ХII зуунд Гурван Мэргэд аймаг байсан нь Удуйд-Мэргэд, Увас Мэргэд, Хаад Мэргэд юм. Эдгээр Мэргэдийг түүхэнд Гурван Мэргэд /холбоо/ хэмээн нэрлэж ирсэн түүхтэй. Бас эл Гурван Мэргэд аймаг дотроо салбар аймгуудтай байсан аж. Жишээлбэл, Улдуйд Мэргэдийг Тудур-Билгэ Чигин, Тогтоа бэхи нар толгойлж, уйкур, Мудан, Джинон, Тудаклит гэсэн 4 салбар аймагтай байжээ.

“Монголын нууц товчоо”-нд Удуйд Мэргэдийг Тогта бэхи, Увас Мэргэдийг Дайр-үсун, Хаад Мэргэдийг Дармала тэргүүлж байсан хэмээн /32.63/ бичсэн байдаг бөлгөө.

32. “Баяд”- ХII зууны монгол аймаг Орхон-Түрэгийн бичээсэнд “Ийр Баийрку” хэмээн тэмдэглэжээ. “Судрын чуулган”-д Жидай буюу Жийдийн баяд, Кэхэр буюу хээрийн баяд гэсэн хоёр том баяд аймаг байсныг дурдсан байдаг. Баяд аймгийг “баягуд”, “баяуд” гэж дуудаж ирсэн аж. Дээрхи хоёр аймгаас гадна дуклад баяд, горлос баяд, чаншиуд баяд, хиад баяд гэсэн аймгууд, ер нь нийтдээ есөн баяд аймаг байжээ /34.71/.

33. “Онгуд”- Монгол аймгийн нэгэн. Онгудууд их содон, зөвхөн монголчуудтай адил. Дөрвөн мянган чингэлэг тэргэн гэртэй /46.99/ гэж Рашид-ад-Дин бичсэн байдаг. Онгуд аймаг Хятадын Их Цагаан хэрмийн араар нутаглаж байсан, газар зүйн онцлог нь Хятад ба Монголын харилцаанд шууд холбогдохоос аргагүйд хүргэж байсан түүхэн хувь заяатай, энэ онцлог нь Онгудуудыг Цагаан хэрмийн ар талын улс, аймгуудын довтолгооноос Хятадыг хамгаалах үүрэг хүлээхэд хүргэсэн ажгуу. Түүхийн хугацаанд Онгуд, монгол аймгууд жирийн харилцаатай байж, бие биеэ хүндэтгэн дэмжиж байсан түүхтэй.

34. “Ойрад”- Енисей мөрний дээд хавиас эх авч амар мөрөнд цутгадаг Кэм голын дагуу нутагладаг аймаг юм. Эдгээр нь Хөх гол, Ойн гол, Хар усан, Санди-тун, Укри, Акар, Жүрчэ, Цагаан голоор нутагладаг 8 аймаг бөгөөд тэдгээрийг бүхэлд нь

“Ойрад” аймаг хэмээн нэрлэнэ. Эдгээр аймгууд түүхийн урт хугацааны явцад малчин аймгууд болсон ажгуу. XII зууны сүүл үед Ойрад аймгийг Хутга бэхи толгойлж, XIII зууны эхэн үеэс Ойрад аймгууд “Дөрвөн Ойрад” хэмээн нэрлэгдэх болсон ажгуу.

35. “Хонгирад”- XII зууны эцсийн Монгол аймаг. “Унгира” гэж нэрлэгдсэн Хонгирад аймаг дөрвөн салбартай. Хонгирад аймаг нь Зү-бу 18 аймгийн нэгэн болно. Журлук мэргэн Хонгирад аймгийн өвөг болно. Хонгирад язгуур удам сайтай, төлөв түвшин “бусдын нутгийг булаан тэмцэлддэггүй, хацар гоо хатадтай, өнгө сайт охидтой аймаг байжээ” /32.41/. Хонгирад аймаг Онгуд аймагтай ураг барилдах нарийн жимээр холбогдож, Монголын нэгдсэн улсыг байгуулах үйл хэрэгт хүчин зүтгэл гаргасан түүхэн үүрэг гүйцэтгэсэн аймаг болой.

36. “Барга”- XII зууны монгол аймаг. Барга нь хори /кори/ тулас, тумат /түмэд/ гэсэн хоёр үндсэн аймагтай байжээ.

Үндсэн нутаг нь Баргужин тохом, түүний хавь орчмын гзар нутаг болно. Барга аймгаас илжигин /Элжигэн/ аймаг салбарлан үүссэн түүхтэй. Барга аймаг Хамаг Монголтой ургийн холбоотой. Юун хэмээвээс Хабул хааны хүү Бартанбаатар барга аймгийн Сунигул фужитэй ханилан суусан бөлгөө /46.197/.

37. “Урианхай”- Монгол аймгийн нэг. X-XII зуунд Монголд хоёр төрлийн Урианхай байсан ажээ. Энэ нь Бурхан халдун хавийн буюу талын Урианхай, Баргужин тохом хавиар нутагтай Ойн Урианхай болно. Урианхай аймгууд өөрийн хэмээсэн жирийн амьдралаараа амьдарсаар Монголын нэгдсэн улсын бүрэлдэхүүнд орж, энэ аугаа их улсын түүхэнд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулсан, төрд зүтгэх үнэнч зүтгэлтэн олныг төрүүлсэн түүхтэй. Чингисийн цэргийн нэрт жанжин Зэлмэ, цэргийн жанжин Есү-Буха-Тайши, мянгатын захирагч Есун-Буха-Тархи, өрлөг жанжин Сүбээдэй баатар, Буурч Төмөр-Буха зэрэг алдарт хүмүүс энэ аймгаас төрсөн түүхтэй ажгуу. “Бурхан Халдун” дахь Чингис хаан түүнийг залгамжлагчдын их хоригийг хүндэтгэн хамгаалах нэр хүндтэй үүргийг Урианхайчууд гүйцэтгэж байсан түүхтэй бөлгөө.

38. “Жалайр”- XII зууны эцсээр монгол нутагт оршиж байсан Монгол аймгийн нэр. Жалайрыг “Залайр” гэж дуудах нь бий. Жалайр нь 10 том салбартай, салбар бүр нь олон хүнтэй байжээ. Жалайрыг Монголын “хэтэрхий үнэнч” аймаг хэмээдэг. Уйгурчуудын эзэн Гүр хан буурынх нь тэжээлд шар тос хийн өгдөг үнэнч байсан болохоор нь тэднийг “белагэ” гэж нэрлэдэг байсан гэдэг /46.59/.

Жалайрчууд Монголын нэгдсэн улсыг байгуулахад их гавьяа байгуулж, их хаан Чингис, Өгөдэй, Мөнх хаан, Хубилай хаан болон Цагаадай, Хулагу зэрэг Чингисийн удмынханы төр, цэргийн их үйлсэд үе угсаагаараа үнэнч зүтгэж, дотроосоо олон сайд, жанжин, түшмэд, захирагч зэрэг алдартныг төрүүлсэн түүхтэй.

ДЭД АНГИЙН ОН ЦАГИЙН ТҮҮХЭН ХЭЛХЭЭС

706 он	Орхон Түрэгийн бичээсэнд “Ийр Баййрку” гэсэн нэрээр Баяд аймаг бичигдсэн
732 он	Культегины хөшөөний бичээсэнд “Татар”, Хятад бичээсэнд “дадан” гэж бичигджээ
750 он	“Сегиз-Огуз” гэсэн нэрээр Найман аймаг, “Сэлэнгийн чулуу” хэмээх Уйгурын хөшөөний бичээсэнд тэмдэглэсэн.
758 он	Дарилгин монголчуудын удирдагч Бөртэ-Чино төрсөн
ҮII-ҮIII зуун	Монгол гэдэг нэр түүхэнд тэмдэглэгдсэн
770 он	Батцагаан /Батачи/ төрсөн
ҮIII-IX зуун	Гурван голын монголчуудын дунд аймгуудын холбоо байгуулагдсан
IX-X зуун	Хэрэйд аймгууд хүчтэй болж Хэрэйдийн ханлигийг байгуулсан
X зуун	Хятад сурвалжид Зү-бу хэмээн Монгол, Түрэг, Татар аймгуудыг ерөнхийлөн нэрлэжээ.
X зуун	Бодончар мунхаг Монгол аймгуудын дийлэнхийг захирсан
1005 он	Есөн Татараас Хятан улсад алба өргөсөн.
1035 он	Монгол аймгуудын удирдагч Хайду төрсөн
1052 он	Монгол аймгуудын удирдагч Байшинхор төрсөн
1069 он	Хамаг Монголыг үүсгэн байгуулагч Түмбинэй сэцэн төрсөн
1089 он	Маркус Хэрэйдийн толгойлогч болсон
1096 он	Мэргэд аймаг “Мэнлизи” нэрээр түүхнээ тэмдэглэгдсэн
1124 он	Цагаан Татар түүхнээ тэмдэглэгдэн гарч иржээ
1101-1137 он	Хабул хан Хамаг Монголыг захирсан
1124 он	Хятан Елюй Дашид Цагаан Татар тусалж байсан
1133-1135 он	Хамаг Монголын хаан Хабул, Алтан улсын хаан Баян Үжимэй нарын уулзалт болсон
1135-1136 он	Хамаг Монгол ба Татар аймгууд хоорондоо эвдрэлцэж эхэлсэн
1135 оны эцэс	Алтан улсын цэрэг Монгол руу довтолж их хохирол учруулсан
1138-1139 он	Алтан улсын цэргийн жанжин Хушаху Хамаг Монгол руу довтолж ялагдсан
XII зууны эх	Хонгирад нар цагаан хэрэмийн араар нутаглаж байсан
1140 он	Алтан улсын Ушу жанжин Хамаг Монгол улстай байлдаж ялагдсан
1147 он	Алтан улсын Ушу жанжин Хамаг Монгол руу довтолж бут цохигджээ.
1147 он	Хамаг Монгол ба Алтан улсын хооронд эвийн гэрээ байгуулагдсан
1148 он	Хамаг Монголын Хабул хаан нас барсан

ХII зууны эх	Найманы ханлиг байгуулагдсан
ХII зууны тэргүүн хагас	Амбагай хаан Хамаг Монголын төрийг барьсан
ХII зууны эх	Хэрэйд Татарын сөргөлдөөн эхэлсэн.
ХII зуун эхний хагасын эцэс	Маркус хааны ууган хүү Куржакуз Хэрэйдийн хан болжээ.
ХII зууны үе	Тудур-Билгэ чигин Удуйд Мэргэдийн толгойлогч байв
ХII зууны дунд үе	Тоорил Хэрэйдийн хан болсон
ХII зуун	Онгуд аймгийг ноён Бинуй толгойлж байсан
ХII зууны эцэс	Алакуш тегин Онгуд аймгийн тэргүүн байсан
ХII зууны эцэс,	
ХIII зууны эх	Онгуд, Найман аймаг холбоотон байсан
1150 он	Хамаг Монгол ба Алтан улсын харилцаа эрс хурцадсан
ХII зууны дунд үе	Тоорил хан, Есүхэй баатар хоёр Туулын хар шугуйд анд бололцсон
ХII зууны II хагас	Найманы ханлиг хоёр хэсэгт хуваагдаж тус бүрдээ хантай болсон.
ХII зууны II хагас	Найманы цэрэг Хиргистэй байлдаж ялсан.
ХII зууны II хагас	Хамаг Монгол Мэргэд аймгууд 3 түмийн хугацаатай 2 удаа байлдаж Хамаг Монголын ялалтаар төгссөн.
1161 он	Дай Сэцэний Бөртэ-Үжин төрсөн
1162 он	Амбагай хаан нас барсан
1162 он	Тэмүжин төрсөн
1164 он	Хасар төрсөн
1166 он	Чингисийн дүү Хачиун төрсөн
1168 он	Тэмүгэ Отчигин төрсөн
1169 он	Өүлэн Үжинээс Тэмүлэн охин төрсөн
1170 он	Есүхэй баатар нас барсан
1171 он	Тайчууд Өүлэн үжинг хүүхдүүдийнх нь хамт орхин одсон
1172 он	Тэмүжин Жамуха нар анд бололцсон
1177 он	Тэмүжин Тайчуудад баригдсан
1178 он	Тэмүжин Бөртэ Үжинтэй гэрлэсэн
1179 он	Чингисийн ахмад хүү Зүчи төрсөн
1181 он	Жамуха Тэмүжингээс салж явсан

- 1183 он** Чингисийн хүү Цагаадай төрсөн
- 1186 он** Чингисийн хүү Өгэдэй төрсөн
- 1189 он** Тэмүжин Чингис цолтойгоор Хамаг Монголын хаанд өргөмжлөгдсөн
- 1190 он** Тэмүжин Жамуха нарын хооронд 13 хүрээний байлдаан болсон
- X-XII зуун** Талын Урианхай, Ойн Урианхай гэсэн 2 төрлийн Урианхай оршиж байсан
- XII зууны сүүл** Хутуга бэхи Ойрад аймгийн тэргүүн байв
- XII зууны сүүл** Хонгирадууд Цагаан хэрэмийн араас нүүдэллэн Халх голд ирж нутагласан
- X-XIII зууны эх** Урасуд, Куштем, Тэлэгүд гэсэн ойн аймгууд оршиж байсан
- XIII зууны эх** Ойрадууд түүхнээ “дөрвөн Ойрад” хэмээгдэх болов
- 1193 он** Чингисийн 4 дүгээр хөвгүүн Тулуй төрсөн
- 1194 он** Монголын Хатигин, Салжиуд аймаг Алтан улсад халдсан
- 1196 он** Тэмүжин, Тоорил хааны хамт Татарчуудтай байлдсан
- 1197 он** Чингис хаан Жүрхэн аймгийг эрхшээлдээ оруулсан
- 1198 он** Тэмүжин, Мэргэдийн Тогтоа бэхитэй байлдаж ялсан
- 1199 он** Тоорил ванд Тэмүжин цэргийн тусламж үзүүлсэн
- 1200 он** Чингис Ван хантай хамтран Тайчууддй ялсан
- 1201 он** Хонгирад, Икрис, Горлос аймгийн тэргүүн нар Жамухыг гүр хаанд өргөмжилсөн.
- 1202 он** Чингис “Далан нөмрөг” гэдэг газар Татарчуудтай байлдаж ялсан
- 1203 он** Чингис Ван хантай “Муу өндөр” гэдэг газар дайтсан
- 1203 он** Чингис журмын нөхдийнхээ хамт Балжиуд нуурын дэргэд үүрд хамтран тэмцэхээр тангараг өргөсөн
- 1204 он** Чингис хаан Найманы ханлигийн цэрэгтэй “Наху Хун”-д байлдаж ялсан
- 1205 он** Тангуд улсыг анх удаа дайлсан.

ДЭД АНГИЙН НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Амар.А. Монголын товч түүх УБ.,1992
2. Бат-Очир.Ч. Монгол улсын эртнээс уламжилж ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг. УБ.,1928
3. Баяр. Монголын нууц товчоо. Гурван боть. Хөх хот. 1980,
4. Баярсайхан. Б. Хууль зүйн тайлбар толь. (Монгол Улсын төр, эрх зүйн түүх) УБ., 2003
5. Бира.Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ.,2001
6. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.,1966
7. БНМАУ-ын түүх. Нэгэн боть, нэмж засварласан III хэвлэл. УБ.,1984
8. БНМАУ-ын түүхийн дээж бичиг УБ.,1968
9. Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997
10. Бор.Ж. Монгол улсын төрийн гадаад бодлого, дипломатын уламжлалын зарим асуудал. УБ.,1988
11. Бөртэ-Чино. Бээжин 1981, 1983.
12. Булаг. Монгол үсэг бичгийн товч түүх. Хөх хот. 1983
13. Гаадамба.Ш. Монголын нууц товчооны нууцаас. УБ.,1990
14. Гангийн урсгал. Хөх хот. 1980.
15. Галдан туслагч Эрдэнийн эрх. УБ.,1960
16. Гао Вэнь дэ. X-XIII зууны үе дэх монголын мал аж ахуйн эдийн засгийн хөгжил. Хөх хот. 1991
17. Гомбосүрэн.Ц. Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү. УБ.,1995
18. Гонгор.Д. Халх товчоон. I боть. УБ.,1970
19. Гонгор.Д. Халх товчоон. II боть. УБ.,1978
20. Гэрэлбадрах.Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. /МЭӨ III-XIX зуун/ УБ.,2002
21. Далай.Ч. Монголын түүх. Хамаг Монгол улс. /1101-1206/. УБ.,1996
22. Дамдинсүрэн.Ц. Монголын нууц товчоо. 1990
23. Дашням.И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. УБ.,199...
24. Дэндэв.Л. Монголын товч түүх. 1934
25. Дэндэв.Л. Монголын эрт эдүүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. УБ.,1936
26. Жамбалдорж Болор толь. Бээжин. 1987
27. Жүгдэр.Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ.,1987

28. Ишжамц.Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ.,1974
29. Ишжамц.Н. Монголд байсан эртний аймгуудын удам угсааны хамаарлын асуудалд. “Этнографийн цуврал” II боть. 1965
30. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
31. Лею Женсо. Чингис хааны эзэнт улс байгуулагдахаас өмнөх Монголын нийгмийн байгууламж. Хөх хот. 1986
32. Ломи. Монгол боржигин овгийн түүх. Хөх хот. 1983.
33. Монголын нууц товчоо./Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар/ УБ.,2003
34. Монгол улсын түүх. Тэргүүн боть. УБ.,2003
35. Монгол улсын түүх. Дэд боть. УБ.,2003
36. Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр. УБ.,1992
37. Монголын археологийн эмхэтгэл. УБ.,1962
38. Монгол нутаг дахь соёлын дурсгал: УБ.,1999
39. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. /МЭӨ III-МЭ XX зуун/ Тэргүүн боть. УБ.,1995
40. Монгол улсын соёлын түүх. Нэгдүгээр боть. УБ.,1995
41. Нацагдорж.Ш. Монголын феодализмын түүхэн замнал.УБ.,1978
42. Нацагдорж.Ш. Чингис хааны цадиг. УБ.,1992
43. Нацагдорж.Ш. Цагаан түүхийн тухай хэдэн үг. УБ.,1958
44. Нямбуу.Х. Монголын угсаатны зүй. УБ.,1992
45. Пэрлээ.Х. Хятан гүрний үеийн гурван голын монголчууд. УБ.,1960
46. Пэрлээ.Х. Монголын хувьсгалын өмнөх түүх бичлэгийн асуудал. УБ.,1978
47. Рашид-ад-Дин. Судрын чуулган. I боть. I дэвтэр. УБ., 2002
48. Рене Груссе. Азийн нүүдэлчин үндэстний түүх. Хөх хот. 1999
49. Саган-Сэцэн. Эрдэнийн товч. УБ.,1961
50. Сайшаал Чингис хааны товчоон I боть. УБ.,2003
51. Сүхбаатар.Г. Монголчуудын эртний өвөг. УБ.,1980
52. Сүхбаатар.Г. Монгол Нирун улс. 330-550. УБ.,1992
53. Сурбадрах. Монголын үндэстний язгуур үүсэл. Бээжин.1988
54. Хаганчулуу. Хабул хааны гавъяа зүтгэлийг магадлах нь. Тайбэй. 1979.
55. Хасдорж.Ч. Монгол гэдэг нэрийн тухай.УБ.,1959
56. Цэвээндорж.Д, Баяр.Д. Монголын археологи. УБ.,2002
57. Цэвээн.Ж. Дархад, Урианхай, Дөрвөд, Хотон, Баяд, Өөлд, Мянгад, Захчин, Торгууд, Хошууд, Цахар, Дарьганга, Хасаг, Хамниганы гарал, үүсэл байдлын тухай. УБ.,1932
58. “Чингис хаан Монгол аймгуудыг нэгтгэсэн нь” Хөх хот. 1989.

Орос хэлээр

59. Билэгт.Л. Тюрки и Монголии. S.A.T. ХҮШ. F-19. УБ.,1998
60. Бичурин.Н.Я. Записки о Монголии сочиненные монахам Иахинфым.
Т. 1-2. СПб. 1828.
61. Васильев.В.П. “История древности части средней Азии”. Полное описание Монголо-Татар “Мэн-да-бей-лу” труды ТВОРАО ч-4. 1857.
62. Владиморцов.Б.Я. Общественный строй Монголов. Монгольский ночевой феодализм. Л.,1931
63. Гаспин.В.С. Материалы по истории древних кочевых народов. М.,1978
64. Грумм-Гржимайло.Г.Е. Западная Монголия и Урянхайский край. Т.1. Л. 1936
65. Дорж Банзаров. О происхождении имени Монгол. М.,1955
66. Дорж Банзаров История Монгольской народной республики. М.,1983.
67. Евтюхова.Л.А. Южный Сибирь в древности СБП. По следам древних культур. М.,1954
68. Евтюхова.Л.А. О племенах центральной Монголии в IX веке. СА. №2 1957
69. История Монгольской Народной республики. М.,1954.
70. Кара Дорж. Книги монгольских кочевников. М.,1972
71. Киселев.С.В. Археологическая поездка в Монголию. Краткие сообщения Ин-та материальной Культуры. XXI.1947
72. Кычанов.Е.И. Монголия в XI-первой половине XII в.
73. Киселев.С.В. Древняя история Южной Сибири. М., 1951
74. Кононков.П.Ф, Кононкова С.Н. Земледелие в Монголии. М.,1966
75. Кюннер.А.В. Китайская известия о народах Южной Сибири, Центральной Азии и Дальнего Востока. М.,1961
76. Майский.П.Н. Монголия наугануне революции. М.,1959.
77. Мункуев.Н.Ц. Монголия наугануне революции. М.,1959.
78. Мэн-Гу-Ю-Шу-Цзи. Заметки о Монгольских кочевьях. М.,1965
79. Новосельцев.Л.П, Пашуто.В.Т, Черепнин.Л.В. Пути развития феодализма. М.,1972
80. Позднеев.А.М. Монголы и Монголия. Т.1. М-Л. 1952.
81. Рашид-ад-Динь Сборник летописей. Т.1.К1.1952
82. Роль кочевых народов в цивилизации Центральной Азии. 1974
83. Якубовский.А.Ю. Из истории изучения Монголов периода XI-XII вв. Очерки и истории русского востоковедения. М.,1953

*Дорно дахины хэлээр**А.Хятад хэлээр*

84. Бан Тун-Лин “Чжинго-ши” /Хятадын түүх/ Бээжин.1934
85. Ван Говэй “Да да као” /Татарын судалгаа/ Шанхай.1940.
86. “Вэй шу /Умард Вэй улсын түүх/”
87. Ван Говэй “Мэн-Гу као” /Монголын судалгаа/ ҮИ боть.
88. “Дай-Ляо Гүрини судури /манжаар/”
89. Гуан-Тан-Цзи-Лин. Бээжин.1921.
90. Ли-Ю-дан /Ляо улсын эх адгийн хэрэг/
91. “Ляо-ши” /Ляо улсын түүх/ Бээжин. 1958
92. “Мэн-дабэй-лу” /Монгол Татарын бүрэн тэмдэглэл/. Шанхай.1927
93. Оссон,Д. Монголын түүх. Шанхай.1962
94. “Сынь Тан шу” /Тан улсын шинэ түүх/ Бээжин.1958
95. “Сун-ши” /Сун улсын түүх/ Бээжин.1957.
96. Ту-Цзи. Мэн-у-эр ши-ци /Монголын түүхэн тэмдэглэл/ Бээжин.1990
97. Ци-дан-Го-ци /Киданы түүхийн тэмдэглэл/
98. “Цзю-Тан-шу” /Тан улсын хуучин түүх/ Бээжин.1958
99. “Цзинь-ши” /Алтан улсын түүх/
100. Чингис хааны цадиг. Бээжин.
101. “Юань-ши” /Юан улсын судар/ Бээжин.1935

Б. Япон хэлээр

102. Вада Сщй “Тоа ши Кэнкю” /Моокохэн/ /Дорнод Азийн түүхийн судалгаа. Монголын бүлэг/ Токио. 1959
103. Ивамура Шинобу “Монгору шякай кэйзайши но кэнкю” / Монголын нийгэм эдийн засгийн түүхийн судалгаа/ Киото. 1968
104. Мора Масао “Юбоку Кокка-но сэйрицу то хатгэн” /Нүүдэлчин улсын үүсэл хөгжил/
105. Яцай Ватари мокосо кэнкю /Монголын түүхийн судалгаа/. Токио.1970

Өрнө дахины хэлээр

106. Ala ad-Din Ata-Malik Juvaini. The History of the World Conqueror. Translated by J.A.Boyle. Manchester,1958.vol.1
107. Alizade A.A.(ed.) Rashid al-Din, Jami'al-tawarikh vol.3. Baku,1957
108. Andersen P. Passeges from Antiquity to Feudalism.London,1974
109. Dawson C. (ed.) The Mongol Mission. London and New York, 1955

110. Grigor of Akanc. "History of the Nations of the Archers" (the Mongols).
Cambridge, Massachusetts, 1954.
111. D.Osson. Histoire des Mongols. Paris,1824. 4 боть
112. Howorth H.History of the Mongols from the 9-th to 19-th century. Tomus I-III.
London,1905-6. Долоон боть.
113. Hambly G (ed.) Central Asia. London,1969
114. The Religions of Mongolia. London,1980.
115. Karimi B. (ed.) Rashid al-Din, Jami'al-tawarikh, 2 vols.Tehran,1970
116. Romaskevich A.A., Khetagurov L.A. and Alizade A.A. (eds.) Rashid ad-Din,
Jami'al-tawarikh vol. 18 part 1. Moscow,1965.
117. Ronay G. The Tartar Khan's Englishman. London,1978
118. The History of the Mongol Conquests. London,1971
119. The Mongols in History. London,1971
120. History of the Mongols. London, 1972
121. "History of the Nation of the Archers" (the Mongols). 1954. Eberhard W.
"Conquerors and Rulers"
122. Phillips E.D. The Mongols. London, 1969
123. Quatremure E. (ed. And tr.) Rachid Eldin, Histoire des Mongols de la Perse.
Paris,1836
124. Reischauer E.O., Fairbank J.K. East Asia, The Great tradition. Boston, 1960





ГУТГААР АНГИ

**МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ТӨР,
ЭРХ ЗҮЙ
(1206-1227)**

ГУТГААР АНГИ
МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ
(1206-1227)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

**Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийн сурвалж бичиг,
судалгааны зохиол**

Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхэнд холбогдох сурвалж, судалгааны зохиол бүтээл нэн арвин агаад дэлхийн олон улс орны хэдэн зуун мянган эрдэмтэд судлаачдын хамтын оюунаар бүтээгдэж, хэмжээ агуулгын хувьд асар баялаг, маш өргөн бөгөөд олон талтай байгаа нь үнэхээр бахархууштай бөлгөө.

Эл үеийн Монголын төр, хууль цааз дэлхий дахины анхааралд орж, тив дэлхийн улс орнуудыг улс төрч, эрдэмтэд судлаачдын оюун ухаан, хүч чадлыг сориход хүргэсэн нь Монгол үндэстний хүчирхэг улс байгуулагдаж, түүнийг дэлхийн хэмжээний аугаа их Чингис хаан толгойлж байсантай холбоотойг хүлцэн зөвшөөрөхөөс аргагүй буюу өндөр соёл иргэншилтэй олон улс орнууд тухайлбал Орос, Хятад, Энэтхэг, Америк, Япон, Солонгос, Иран, Англи, Франц, Унгар, Армян зэрэг улсуудын суут хүмүүс судлаачид, Чингисийн унаган Монголын сор нь болсон нэрт эрдэмтдээс Чингис судлалаар туурвисан бүтээлүүд өгүүлэн буй үеийн судалгааны зохиолын үндсэн цөм болж ирсэн ба цаашид ч болсоор байх нь баттай болой. Монголын нэгдсэн улсад холбогдох судалгааны эдгээр зохиолын дийлэнх нь суурь шинжтэй шинжлэх ухааны үнэ цэнэт бүтээлүүд байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Монголын нэгдсэн төр, эрх зүй түүнийг судлахад 1240 онд зохион дуусгасан “Монголын нууц товчоо”, мөн “Алтан дэвтэр”, 1260 онд бичсэн Ираны алдарт түүхч М.Жувейний “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”, XIII зууны тэргүүн хагаст Монгол хэлээр зохиосон “Богд баатар биеэр дайсан тэмдэглэл”, 1300-1311 онд туурвисан Рашид-ад-Дины “Судрын чуулган” 3 боть зохиол, “Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” тэргүүн зэргийн ач холбогдолтой болой. Дурдан буй зохиолууд нь эх сурвалжийн шинжтэй, Монголын нэгдсэн улс оршин тогтнож байсан цаг хугацаанд хамгийн ойр, халуун сэргэг баримт мэдээллийг агуулж байснаараа түүхэн чухал ач холбогдолтой болой.

Эдгээр зохиолуудыг цаашид явагдсан бүх судалгааны бүтээлд эх сурвалж болгон ашигласан байна. Дээрхи зохиолуудыг туурвигчид нь Чингис хаантай хамтран зүтгэж байсан, түүний болон залгамжлагчид, үр ач нарынх нь төрд сайд, түшмэдээр ажиллаж байсан, Монголын нэгдсэн улс, монгол гүрний ард иргэдийн аж төрөх ёс горим, зан

заншлыг сайн мэддэг хүмүүс байсны хувьд тэдний бичиж үлдээсэн зүйл нь тухайн үеийн үнэн байдлыг тусгасан хэмээн үзэх бүрэн үндэслэлтэй бөлгөө.

Дээрхи зохиолуудад Монголын нэгдсэн улсыг байгуулах нөхцөл, үйл явц, төрийн тогтолцоо, эзэн хааны удам угсаа, гадаад дотоод бодлого, үйл ажиллагаа, хууль цаазын тухай бүрэн цэгцтэй баримт, материалууд бичигдсэн нь эл улсын төр, эрх зүйн түүхийг судлахад анхдагч сурвалж болох учир холбогдолтойд тэдгээрийн жинхэнэ үнэ цэнэ оршимуй. “Монголын нууц товчоо”-нд VIII-XIII зууны дунд үе хүртэлх 600 шахам жилийн, “Судрын чуулган”-нд XIY зууны эхэн хүртэлх 800 гаруй жилийн түүхэн хэрэг явдал, баримт мэдээллийг багтаасан ажгуу. “Монголын нууц товчоо”-нд удам угсаа, боржигон овог, Алтан ургийн түүх, Чингис хааны бага, залуу нас, Монголын нэгдсэн улс, Монгол гүрнийг байгуулахад түүний оролцож байсан үйл явдал, эзэнт улсын төр, хаад, ноёд, төр, цэргийн зүтгэлтнүүд, тэдгээрийн үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Оросын академич Б.Я.Владмирцов “Хэрэв дундат эртний үед нэг ч улс түмэн түүхчдийн анхаарлыг Монгол шиг татсангүй гэж хэлж болох аваас ганц нүүдэлчин түмэн бодит амьдралыг “нууц товчоо”-ны адилаар тэгж уран нарийн дүрслэн харуулсан дурсгалт бичиг үлдээгээгүй гэдгийг тэмдэглэвэл зохино” /112.8./ гэж бичсэн нь эл алдарт сурвалжийн ач холбогдлыг яруу сайхнаар тодорхойлсон хэрэг юм. Чухам иймээс доктор Г.Сүхбаатар “Монголын нууц товчоон XIII зуун түүнээс өмнөх монголын түүхийн мэдээг агуулсан нэгэн ёсны архив мөн” /80.6/ гэж тун онож хэлжээ хэмээсэн нь бий.

Ираны түүхч, Ата-Малик Жувейны “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” гэх томоохон зохиолыг 1250 онд Иран дахь Монгол сайд Аргуны бараа бологчийн тоонд багтаж Монгол ноёдын чуулганд оролцохоор Хархорум хотод ирэх үеэрээ бичиж эхлэн Хулагу хааны дэргэд байхдаа бичиж дуусгасан түүхтэй. Жувейни энэ зохиолдоо Чингис хаанаас Мөнх хаан хүртэлх үеийн түүхийг нэлээд тодорхой бичсэн байдаг. Үүнээс гадна Зүчи, Бат, Цагаадай, Тулуй нарын намтрыг өгүүлж, Туркстан, Иран, Багдарын хүндэтгэн хийсэн дайн, лалын шашинт орнуудын аж байдал, амьдралыг бичсэн байна. Энэ зохиолын эх нь Орос, Англи, Иран, Францын номын санд хадгалагдаж байдаг бөлгөө. Ираны Рашид-ад-ДинХамадани /1247-1318/-ы перс хэлээр бичсэн “Судрын чуулган” /Жами-ат-таварих/ хэмээх “агуулга, зохиомжоороо онцгой зохиол”-д монгол түрэг аймгуудын үүсэл салаа салбар, тархац, Добу баянаас Чингисийн өвөг дээдэс, Чингис хаан, Өгөдэй, Гүюг, Мөнх, Хубилай эдгээрээс Хасан хаан /1294-1304/-ы үеийн түүхэн хэрэг явдал, баримт, мэдээллийг дэлгэн бичсэн нь үнэхээр анхаарал татахуйц бөлгөө.

“Шэн-ву цзинь-чжэн” гэдэг нэрээр хятад хэлээр уламжлагдаж ирсэн “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” зохиолыг Францын эрдэмтэн П.Пеллиот, Л.Амбис

нар монгол сурвалжуудтай харьцуулан олон жил явуулсан судалгааныхаа дүнд XIII зууны эхэн хагаст монгол хэлээр зохиосон зохиол гэж /12.27/ үзсэн байдаг. Монгол эх нь олдоогүй боловч XII зууны II хагаст хятадаар орчуулан хэвлүүлсэн нь эдүгээ бидэнд уламжлан ирсэн байна. Францын дээрхи хоёр эрдэмтэн энэ зохиолыг франц хэлээр орчуулан хэвлүүлсэн нь ихэд нэрд гарсан бөлгөө. Энэхүү зохиолыг Палладий Кафаров орос хэлнээ орчуулж хэвлүүлсэн бол хятадагч Ч.Дандаа “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл” нэртэйгээр 1920 онд монголчилсны дээр Өвөрмонголд шинээр орчуулан хэвлүүлжээ. Энэ зохиолд “Нууц товчоо”-нд гардаг үйл явдал бараг хэвээр өгүүлэгдэхийн хамт өөр сурвалжид байхгүй шинэ чухал мэдээ ч байдаг ажгуу. Ялангуяа Чингис хааны намтар, үйл ажиллагаа, түүний явуулсан аян дайны тухай ихээхэн баримт агуулж байдгаараа онцлог юм.

“Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх” хэмээх Хубилай хаан /1260-1294/ монгол эрдэмтэд захиалга өгч бичүүлсэн байж болох алдарт зохиол нь Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг судлах эх сурвалжийн хэмжээний бүтээлд өмнөд хөрш Хятадын улсуудын төрийн түүх, шастир монголын нэгдсэн улсуудтай хил залгасан улсуудын төрийн түүх шастир монгол гүрний харьяа улсуудын түүх тулгуур зохиолууд хамаарагдана. Учир нь болбоос эдгээр улсуудын төрийн түүхийн судар, ном, зохиолд эл үеийн монгол улсын төр, хууль цааз, хаад ноёд, зан заншил, гадаад, дотоод бодлого, үйл ажиллагааны тухай үлэмж баримт, материал бичигдсэн байдаг нь монголын төр, эрх зүйн түүхийг судлахад чухал ач холбогдолтой бөлгөө. Ийм сурвалж бичгүүдийн дотроос “Суй-шу” /Сүй улсын түүх/, “Сун ши” /Сун улсын түүх/, “Тангуд улсын түүх”, Тан-шу /Тан улсын түүх/, “Цзинь ши” /Алтан улсын түүх/, “Цинь-шу” /Цинь улсын түүх/, “Ляо-ши” /Ляо улсын түүх/, “Мин ши” /Мин улсын түүх/, “Дундат Азийн түүхийн тойм” /Ираны түүх/, /Сирийн түүх/, /Энэтхэгийн түүх/, “Корё-Са” /Персийн түүх/, “Эрт үеэс төмрийг хүртэлх үеийн түүх”, “Монгол-татарын түүх”, “Хейза ши люе” /Хар татарын хэргийн тэмдэглэл/, “Монголын тухай Армяны эх сурвалжууд”, “Дай Юань ши” /Их Юан улсын түүх/ зэргийг дурдан хэлж болох юм.

Хэдийгээр ХҮИ зууны эхээр хэвлэгдсэн ч гэсэн XIII зууны монголын төр, эрх зүйн түүхэнд хамаарах нэгэн чухал сурвалж бол эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан “Алтан товч” хэмээх шастир болно. Энэхүү шастирыг Лувсанданзан гүүш зохиосон тул Лувсанданзаны “Алтан товч” гэж түүхэнд алдаршсан болой. Лувсанданзаны “Алтан товч”-д монголын 400 жилийн түүхэн баримт, материалыг өгүүлсэн байдгийн дийлэнх нь Чингис, түүнийг залгамжилсан хаадад холбогдох ажгуу. Энэхүү “Алтан товч”-д “Монголын нууц товчоо”-н дахь материалын гуравны хоёр нь тэр чигээрээ багтан орсоноос гадна урьд нь мэдэгдээгүй байсан чухал мэдээллүүд бичигдсэн нь судалгааны чухал үнэ цэнэтэй юм.

Үүнийх нь хувьд Лувсанданзаны Алтан товчийг Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийн сурвалжид хамааруулдаг бөлгөө. Эл Алтан товчоос гадна хураангуй “Алтан товч”, Мэргэн гэгээний “Алтан товч” зэрэг хэд хэдэн зүйл “Алтан товч” байдаг ч эхээрээ уламжлагдан үлдсэн нь үгүй болой. Эдгээрийн дотроос Урадын мэргэн гэгээний 1765 онд бичсэн “Алтан товч”-д Чингис хааны өвөг дээдсийн оршин амьдарч байсан цаг үе, төрсөн, нас барсан он цагийг илүү тодорхой өгүүлсэн ажээ /57.14/.

Энэ зохиолыг Оросын Буриадын эрдэмтэн П.Б.Балданжанов судалж хэвлүүлсэн нь нэн сайшаалтай болой. Дээр дурдсан сурвалж бичгүүдээс гадна ХҮП зуунд зохиогдсон түүхэн тулгар зохиолууд Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг судлахад нэн чухал бөлгөө. Зарим тулгар бүтээлийг дурдвас ХҮП зууны эхэнд зохиосон “Шар тууж”, 1863 онд зохиосон Саган Сэцэний “Эрдэнийн товч”, 1774-1775 онд Рашпунцагийн бичсэн “Дай улсын Болор эрхи”, 1835-1836 онд Жамбалдоржийн зохиосон “Болор толь” болон Цахарын Гомбожавын бүтээсэн “Гангын урсгал”, Жамбын бичиглэсэн “Асрагч нэртийн түүх”, Ломигийн үзэглэсэн “Монгол Боржигин овгийн түүх”, Галдан туслагчийн бийрлэсэн “Эрдэнийн эрхи”, Инжинашийн туурвисан “Хөх судар” зэрэг болно. Дээрхи тулгар зохиолууд нь XIII-XIV зууны төрийн түүхэнд холбогдох баялаг материал, монгол төрийн бодлого, монгол төрийн ёс жаяг, өв уламжлалыг агуулдагийн хувьд их үнэтэй болой.

XIII зууны үеийн монголын төр, эрх зүйн түүхийн судалгаанд эх сурвалжийн шинжтэйгээр хэрэглэж болох бүтээлүүдэд монгол гүрэнд аялж, Чингис, түүнийг залгамжлагч нартай уулзан явсан элч төлөөлөгчдийн бичиж үлдээсэн аян замын тэмдэглэлүүдийг хамааруулж болох билээ. Эдгээр тэмдэглэлүүд нь улсын түүх, судалгааны зохиолуудад биш ч гэсэн Монголын эзэнт гүрний хаад, сайд, жанжин, түшмэдүүдтэй уулзаж ярилцсан, монголчуудын амьдрал, орон сууц, эрхэлдэг аж ахуй, зан заншил, мэдлэг оюун, шашин мөргөл, төрийн бодлого, аян байлдаан, хууль цаазын тухай жинхэнэ үнэн мэдээллийг нүдээрээ үзэж сэтгэлээрээ мэдэрсэн амьдралын жишээн дээр тулгуурлан тэмдэглэн үлдээсэн учир судалгаанд бодит баримт, нотолгоо болох гүн учир холбогдолтой болой. Жишээлэн дурдвас Их лам Чан Чунь бомбын “Баруун газар зорчсон тэмдэглэл” түүхэн үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Чан Чунь Чингис хааны урилгаар түүнтэй уулзахын тулд 1219 оны 12-р сарын 18-нд хятадын шандуны Лай чжоу нутгаас гарч Бээжингээр дамжин, Монголын нэгдсэн улсын нутгаар нэвт аялж, улмаар 1221 оны 11-р сарын 18-нд Хорезмын шинэ нийслэл Самарканд хүрч, тэндээсээ цааш аялан 1222 оны 4-р сарын 5-нд Чингис хааны явуулын ордонд морилж их хаантай уулзаж, эл орд ба Самарканд хотод 2 жил шахам байж байгаад буцан аялж уугуул нутагтаа иржээ. Чан Чунь бомбо замын тэмдэглэлдээ Чингис хааны дүр төрх, хаан ёс, эрдэм ухаан, үзэл санаа авьяас билэг, улсыг жолоодох

бодлого, аян байлдааны тухай монголчуудын амьдрал, зан заншил, ёс горимын тухай, төрийн түшмэд, цэргийн жанжин нарын тухай өгүүлсэн зүйлүүд бодит байдлаараа эх баримт нотолгоо болох ач холбогдолтой юм.

Монголын нийслэл Хар хорумд 1246 онд өрнөдөөс ирсэн анхны элч жуулчин Пано Карпины “Монголчуудын түүх”, мөн дараахан нь 1248 онд ирсэн Гильом де Рубруккийн “Дорно этгээдэд зөрчсөн минь” хэмээх замын тэмдэглэлүүд чухал ач холбогдолтой болно. Ромын пап лам, Францын IX Людовик хааны эдгээр элч жуулчид ирэх, буцах болон Монголд байх хугацаандаа монгол улс, монголын газар нутаг, хүн ам, монголын төр, хууль цааз, ард түмний аж амьдрал, эрхлэх аж ахуй, зан заншил зэргийг нэлээд нарийн ажиглан судалж, түүнээ аян замын тэмдэглэлүүддээ бичиглэн үлдээсэн бөлгөө. Дээрхи элч жуулчдын замын тэмдэглэлүүдэд Хархорум хот, төрийн Их Хуралдай, хаад, ноёд түшмэдийн тухай, тэдгээрийн орд өргөө, эрдэм ухаан, зэрэг дэв, хувцас хэрэглэл, хоорондын харилцаа, төрийн ёс ёслолын тухай ард иргэдийн эрхлэх аж ахуй, зан заншил, улсын бодлого, хууль цаазын талаар нэлээд тодорхой өгүүлсэн нь их үнэ цэнэтэй юм. Эл үеийн монголын төр, хууль цаазыг судлахад Италийн жуулчин Марко Пологийн Монгол, Хятад оронд 17 жил байсан хугацаандаа үзсэн мэдсэн, судалсан зүйлээ өгүүлэн бичсэн “Замын тэмдэглэл” нь томоохон үүрэг гүйцэтгэсэн бөлгөө.

Монголын нэгдсэн төр, эрх зүйн түүхийг судлах сурвалжид археологийн олдвор, түүнийг дүгнэн цэгнэсэн бүтээл, тайлан, эд өлгийн зүйлс онцгой биет байдлаараа шууд холбогдоно. Монголын нэгдсэн улсын үеийн хот сууринг хаадын ноёд, язгууртны бунхан булшийг малтан судалсан, тэдгээртэй холбоотой хөшөө дурсгал, түүхт газар, нутаг, зэр Зэбсг, угсаатан зүйн хувцас хэрэглэл, шашин мөргөлийн тайлга, туг сүлд, төрийн тамга, дуулал зэргийн олдвор, зүйлс нь эл үеийн төр, эрх зүйн түүхийн судалгааны биет материал, нотлох эд өлгийн сурвалж мөн юм.

Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг судлахад монгол улсын түүхийн тулгуур зохиолууд нэгэн төрөл чухал эх сурвалж болно. Үүнд А.Амарын “Монголын товч түүх” /1934,1992/, Ч.Баг-Очирын “Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг” /1928/, Ж.Цэвээний “Монголын түүх” /гурван боть. 1956/, “БНМАУ-ын түүх” /нэгэн боть.1954/, “БНМАУ-ын түүх” /тэргүүн боть.1966/, “Монгол улсын түүх” /дэд боть. 2003/ гэсэн Монгол улсын түүхийн тулгуур зохиолууд хамаарагдана.

Эдгээр зохиолууд нь Монгол улсын түүхийг бүхэлд нь багтааж, шинжлэх ухааны байгууллага, мэргэжлийн өндөр түвшин бүхий эрдэмтэдийн хүчээр түүхийн шинжлэх ухааны түвшинд боловсрогдон бичигдсэнээрээ онцлог болой. Нэгэн ёсондоо төрийн албан ёсны түүх мөн.

Монгол улсын өөр өөр цаг үед зохиогдсон эдгээр түүхүүдэд монголын нэгдсэн улсын төрийн түүх, төрийн байгуулал, хууль цаазын түүх системтэйгээр бичигдсэн байдаг тул монголын төр, эрх зүйн түүхийг судлахад шинжлэх ухааны ихээхэн ач холбогдол үзүүлж эх сурвалж болдог юм.

Монголын нэгдсэн төр, эрх зүйн түүхийг судлахад хамгийн өргөн ашиглах зохиол нь шинжлэх ухаан, судалгааны бүтээлүүд болой. Дэлхийн хэмжээний аугаа хүн, монгол гүрний нэгдсэн улс, Монгол гүрний тухай тив тивийн олон арав, зуун нэр цуутай эрдэмтэд судлаачдын туурвисан бүтээлүүд энэ үеийн улс төр шинжлэх ухааны зохиолуудын дотор нэн том байр суурь эзэлж байна.

Үнэхээрийн дурдууштай зүйл бол хамгийн өндөр соёл иргэншилтэй улсуудын төрийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийн нэгэн мянга гаруй бүтээл байдгийг дэлхий дахины анхааралд зарласныг бодолцох хэрэгтэй буй зээ. Энэ бол аугаа их Чингис хаантай холбоотой агаад эл их хааны тухай бүтээл. Ер нь Чингис судлал, Чингисийг бизнесийн ертөнцөд нэвтрүүлэх гэсэн тэмүүлэл даян дэлхийг бүрнээ бүрхсэн гэвэл үл хилсдэх биз ээ.

Чингээд Монгол их гүрэн, Эзэн богд Чингисийн тухай хамгийн гол хэмээсэн зарим зохиолын тухай өгүүлэе. Монголын нэгдсэн улс, их хаан Чингисийн өлгий нутгийн орчин үеийн түүхч, гүн ухаантан, эрдэмтэд судлаачдын шинжлэх ухааны зохиолууд том байр суурь эзэлж байна.

Монгол улсын нэрт “ясны” түүхч академич Чулууны Далайн “Их Монгол улс /1206-1260/”, Ш.Нацагдоржийн “Монголын феодализмын түүхэн замнал” /1987/, “Чингис хааны цагид” /1991/, “Чингис хааны түүхэн роль” /1962/, Н.Ишжамцын “Монголын нэгдсэн улс байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь” /1974/, “Чингис хаан” /1999/, Д.Гонгорын “Халх товчоон” /II боть, 1976/, их эрдэмтэн гүн ухаантан Ч.Жүгдэрийн “Монголд феодализм бүрэлдэн тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ” /1986/, “Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг”, М.Санждорж “Монголын төрийн түүхээс” /1998/, Н.Ням-Осор “XIII зууны монголын нийгэм-эдийн засгийн амьдралд Чингис хааны “Их засаг” хуулийн гүйцэтгэсэн түүхэн үүрэг” /1990/ хэмээн судалгааны ажлын үр дүнг илтгэн харуулсан шинжлэх ухааны томоохон бүтээлүүд монголын төр, эрх зүйн түүхийг судлахад нэгэн гол оргил нь болж ирэв.

Дурдан буй зохиолууд Монголын нэгдсэн улс байгуулахын онол, нийгэм, улс төрийн үндэслэл, урьдач нөхцөл, байгуулсан үйл явц, Монголын нэгдсэн улсын төр, эзэн хаан, төрийн байгууллага, засаг захиргааны хуваарь, төрийн түшмэдийн зэрэг дэв, төрийн гадаад, дотоод бодлогын тухай шинжлэх ухааны баримт, нотолгоо, үнэлэлт дүгнэлт, түүхэн үйлдэл, үйл явцыг бичиглэсэн нь Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг боловсруулахад шинжлэх ухааны их ач холбогдолтой бөлгөө.

Монгол гүрэн, Чингис хаан, Монголын байлдан дагууллын тухай дагнан бичсэн гадаадын эрдэмтэдийн зохиолууд бүхэлдээ монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг боловсруулахад нэгэн зүйлийн томоохон эх сурвалж болж байгаа нь бахархуштай юм. Энд хамгийн түрүүнд монголоор орчуулагдан хэвлэгдсэн зарим бүтээлийг дурдах нь зүйтэй болов уу. Хятадын Жо Яотаны “Чингис хааны түүх шастир”, Хятад улсын өөртөө засах Өвөрмонголын Сайшаалын¹ “Чингис хааны товчоон. Дээд, доод дэвтэр” /2004/, Намжилын “Чингисийн Их засаг ба билэг” /1990/, Я.Оссоны² “Монголын түүх” /1824/ Английн Ж.Саундерсийн³ “Монголын байлдан дагуулал” /1992/, Гарольд Лемпийн⁴ “Дэлхийн эзэн Чингис хаан” /2003/, Оросын В.Я.Владимирцовын⁵ “Чингис хаан” /1922/, Е.И.Кычановын “Ертөнцийг эзэгнэн дагуулсан Тэмүжиний үйл амьдрал” /монголоор. 2000/, Францын рене Груссын⁶ “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” /монголоор. 2003/, Америкийн Г.В.Варнадскийн “Чингисийн үеийн монголчууд ба Орос улс” /монголоор. 2004/, Ж.Вернадскийн “Их засгийн судалгаа ба түүний агуулга” /монгол хэлээр. 1995/, Японы Окада Хидэхирогийн “Чингис хаан” /1986/, Солонгосын Кэминон Рэгийн “Мянган жилийн түүхэн хүн” /1999/, Энэтхэгийн Ж.Неругийн “Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл” /1987/, Вьетнамын Мишэл Хоунгийн “Эзэн хаан Чингис” /2000/ зэрэг олон зохиолыг дурдаж болох бөлгөө. Дээр дурдсан зохиолуудыг агуулга, зохиомж, ашигласан эх сурвалжаас үзэхэд Өрнөдийн улсуудад гарсан зохиолууд өрнөд, барууны орнууд дахь эх сурвалжийг ашигласан бол, дорно дахинд гарсан зохиолууд дорно дахины орнууд дахь эх сурвалжийг ашигласан онцлогтой байгаа нь харагддаг. Үүнээс гадна Монгол хэлээр орчуулан хэвлэгдээгүй зохиолууд өрнөдөд ч, дорно дахинд ч олон бий, ялангуяа Орос, Хятад, Япон хэлээр олон зохиол хэвлэгдсэн ажгуу. Эдгээр зохиолуудаас заримыг нь нэрлэн дурдах нь зүйтэй биз ээ.

Орос хэлээр хэвлэгдсэн В.В.Бартольддын “Чингис хааны эзэнт гүрэн байгуулагдсан нь” /1900/, Н.В.Бичурины “Эхний 4 хааны гэр бүлийн түүх” /1892/, М.Бутаятовын “Хорезмшахын улс” /1986/, Караа Доржийн “Монголын нүүдэлчдийн ном” /1972/, М.И.Иванины “Чингис хаан ба Төмөр хааны үед Монгол-татар ба дундат Азийн ард түмнүүдийн явуулсан байлдан дагуулал ба цэргийн урлагийн тухай” /1875/, Н.Ц.Мункуевын “Монголын анхны хаадын тухай хятад эх сурвалж” /1965/, С.А.Тиквинскийн “Ази ба Европод явуулсан татар монголчуудын байлдан дагуулал” /1970/ зэрэг Оросын эрдэмтэдийн бүтээлүүд Чингис хаан, түүний төрийн түүхийг боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Хятад хэлээр хэвлэгдсэн Бархаусены “Монголын нэгдсэн улсын түүх” /1940/, Дадасбуд Боруугийн “Чингис хаан” /1923/, Дин Шиян Биний “Чингис хааны дуулал” /1973/, Жэү-Чин Жийгийн “Чингис хаан” 1955, Фэн Чэн Жиюний “Чингис хааны

намтар” /1934/, “Монголын эзэнт улсын түүх” /1989/, Пүй Юань Аньны “Чингис хааны намтар” /1955/, “Чингис хаан” /1985/, Тогтохын “Алтан улсын түүх” /1975/, Ян Наны “Дэлхийг байлдан дагуулагч” /1997/ зэрэг зохиолууд нь Монголын нэгдсэн улсын төрийн түүхийг боловсруулахад холбогдох үлэмж баримт, материалыг агуулж байгаа болно. Ер нь Чингис хааны тухай хятадын эрдэмтэд, судлаачид хамгийн олон зохиол буюу 20 шахам бүтээл бичиж хэвлүүлсэн байна.

Япон хэлээр хэвлэгдсэн зохиолууд ч цөөн биш бөлгөө. Үүнээс онцолж Вамацу Хирошийн “Монгол Их засаг” /1973/, “Их Монголын эзэнт улс” /1967/, Ивамура Шинобу, Кафуджи Такэшийн “Их Монголын эзэнт улс”, Кобаяши Такаширогийн “Чингис хаан” /1965/, Хонда Минобугийн “Монголын түүхийн судалгаа” /1970/, Кэзифужийн Такэкийн “Чингис хаан, тал нутаг дахь дэлхийн хаант улс” /1972/, Ооба Яхайн “Чингис хааны бүрэн намтар” /1944/, Накажимогийн “Чингис хааны үнэн тэмдэглэл” /Монголын нууц товчоо/ 1906, Окушике Ширугийн “Чингис хаан” /1940/, Осаке Широкийн “Чингис хаан” /1940/, Саке Шигайтакийн “Чингис хаан” /1915/, Уймаймото Сэтайзугийн “Чингис хаан” /1943/, Чиоку Ротайрын “Чингис хааны байлдааны түүх” /1939/, Сагуул Тоорийн “Монголын эзэнт улс ба Төмөрийн улс” /1987/, Эгами Намиогийн “Морьтон үндэстний улс” /1967/ зэрэг зохиолуудыг дурдаж болно. Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг судлахад төр, эрх зүй судлаач үндэсний эрдэмтэдийн судалгааны зохиол бүтээлүүд их чухал ач холбогдолтой нь маргашгүй. Учир нь эл бүтээлүүд хууль зүйн үүднээс Монголын нэгдсэн улс, Их Чингис хаан, төрийн байгууламж, гадаад, дотоод бодлого, хууль цаазыг судалсан судалгааны дүнг агуулж байдаг ажгуу. Монголын хууль зүйн мэргэжилтнүүд энэ чиглэлийн судалгааг 1950-иад оны эцсээс эхэлсэн онцлогтой ч бага бус бүтээлүүд гаргаж, чамламгүй үр дүнд хүрсэн юм. Эдгээр бүтээлийг агуулга ач холбогдлоор нь хоёр үндсэн хэсэгт ангилж болно. Нэг дэх хэсэгт бие даасан эрдэм шинжилгээний зохиол, хоёрдахь хэсэгт ном, эмхэтгэл, сэтгүүл дэх судалгааны шинжтэй хэсэг, бүлэг, хийгээд өгүүллүүд хамаарагдана хэмээн үзмой.

Бие даасан эрдэм шинжилгээний зохиол, номд И.Дашнямын “Чингисийн хаант улсын төр, хууль цааз” /1995/, Г.Баярхүүгийн “Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь” /1997/, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын “Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал” /1997/, Х.Сэлэнгийн “ХІІІ зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл” /2004/, И.Дашням, Б.Шаравнямбуу, Х.Сэлэнгэ нарын “Эзэн богд Чингисийн Их засаг” /1995/ зэрэг зохиол номыг дурдаж болох юм. Эдгээр бүтээлүүд Монголын нэгдсэн улс байгуулагдсан үе шат, үйл явц, ач холбогдол, Чингис хааны эрх хэмжээ, үүрэг роль, нэгдсэн улсын төрийн байгууллагын тогтолцоо, засаг захиргааны хуваарь, түшмэдийн

ёс, цэргийн зохион байгуулалт, нэгдсэн улсын эрх зүйн эх сурвалж, тогтолцоо, Их засаг хуулийн судалгаа, түүний бүтэц, агуулга, залгамжлагдах шинж зэрэг хууль зүйн шинжтэй өргөн асуудлыг агуулснаараа Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийн судалгааны нэгэн чухал сурвалж болох үндэслэлтэй ажгуу.

Ном, эмхэтгэл, сэтгүүл дэх судалгааны шинжтэй өгүүлүүдэд С.Жалан-Аажавын “Их засаг” хуулийн тухай /Халх журам бол монголын хуучны дурсгалт бичиг мөн. УБ.,1958/, “Их засаг” хууль /Арван буянт номын цагаан түүхийн тухай. УБ.,1998/, Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд “Монголын нууц товчоонд үлдсэн хууль цаазын уламжлал”, “Чингисийн Их засаг” “Монгол хууль” УБ.,1997, Д.Дашцэдэн “Нууц товчооны хууль цаазын зарим асуудал” /Дорно дахины судлал. Сэтгүүл. 1990. №2/, И.Дашням “Чингис хааны дүр төрх, зан чанар, суу билэг” /МУИС. Эрдэм шинжилгээний бичиг. №112/, “Монголын нууц товчоо, Монголын төр, хууль эрхэм нандин өв мөн” /Зууны мэдээ. 2004.06 сар/, “Чингисийн төрийг үзэх үзэл” /Ардын эрх. 1996.07.18/ зэрэг өгүүлүүдийг хамааруулж болох юм.

Дээр дурдсан Чингис хаан “Их засаг” хуулийн бүтэц агуулга, Монголын нууц товчоон дахь хууль цаазад холбогдох үндэслэл, заалтууд, Чингис хааны төр, хууль цаазын үзэл баримтлал, хувийн дүр төрх, эрдэм ухааныг нарийвчлан авч үзсэн нь Монголын нэгдсэн улсын эрх зүйн тогтолцоог судлахад чухал ач холбогдолтой болой. Эцэст нь дурдваас Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн түүхийг судлахад Монголын нэгдсэн улсын түүхтэй холбогдох арвин баялаг хөшөө дурсгал, бичээс, хот суурингууд болон тэдгээрийг судалсан түүх-археологийн шинжилгээний дүнг нарийвчлан нягталж ашиглах нэн чухал болой. Үүнд 1922 оноос эхэлсэн /ялангуяа С.Ц.Киселев, Х.Пэрлээ нарын/ Хар-Хорумыг малтсан дүн, Сүүлийн үед Япон-Монголын эрдэмтэдийн их хоригийг малтан шинжилсэн, Франц-Монголын эрдэмтэдийн Хар-Хорумыг малтан судалсан дүн бол төр, эрх зүйн түүхийн судалгаанд их үнэ цэнэтэй болой.





МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ИХ ХААН ЧИНГИС
(1162-1227)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь, түүний дотоод, гадаад бодлого

§1. Монголын нэгдсэн улс байгуулагдахын урьдач нөхцөл

Хятан улс мөхсөнөөс хойш Монгол нутагт оршиж байсан 80 гаруй том, жижиг аймгуудыг нэгтгэж нэгэн нэгдмэл улсыг байгуулах нь түүхэн бодит нөхцөл, цаг хугацаа шаардах, хоорондоо учир шалтгаан, уялдаа холбоо бүхий нарийн үйл явц байжээ. Энэ нарийн үйл явцад л тэрхүү урьдач нөхцөл боловсрон бүрэлдэх ёстой байсан аж.

Тэгвэл ийм урьдач нөхцөл 60 шахам жилийн туршид боловсорсоор, улмаар XII зууны эцэс, XIII зууны эхэн болж ирэхэд нэгэнтээ бүрэлдэн бий болсон байна. Монголын түүхийн тулгуур бүтээлүүд хийгээд томоохон судлаачдын зохиолуудаас эл дүгнэлтэд хэрхэн хүрснийг олж харж болно. 1966 онд “БНМАУ-ын түүх” тэргүүн ботид “Монголын бүх газар нутаг нэгдэж Монгол угсаатны нэгэн нэгдмэл улсын хүрээнд багтах түүхэн хэрэг явдал феодалиж байсан язгууртнуудын хооронд урт удаан хугацаагаар үргэлжилсэн өрсөлдөөн тэмцэлдээний явцад сая гүйцэлдсэн” /12.209/ хэмээсэн бол 2003 онд хэвлэгдсэн Монгол улсын түүхийн дэд ботид “Монголын бүх газар нутаг нэгдэж, Монгол угсаатны нэгэн нэгдмэл улсын хүрээнд багтах түүхэн хэрэг явдал бол Монголын улс, аймгийн язгууртнуудын хооронд урт удаан хугацаагаар үргэлжилсэн өрсөлдөөн тэмцэлдээний явцад сая гүйцэлдсэн” /57.85/ гэж дүгнэн бичжээ. Өөр хоёр дүгнэлтийг иш татая.

Академич Ч.Далай “XII зууны 80-аад он болоход Монголчууд нийлж нэгдсэн улс байгуулах үйл явц чухамдаа түргэсэж /24.32/ ирсэн” хэмээн дүгнэлт хийсэн байхад доктор Н.Ишжамц XII зууны эцэс болж ирэхэд нийгмийн шинэ харилцаа “... цаг мөч улирах тутам янз бүрийн аймагт дэлгэрч улмаар ахиц олон урагшлан хөгжсөөр байлаа” /24.32/ хэмээн үзсэн байна. Дээрхи дүгнэлтүүдийг харьцуулан үзэхэд нэг талаас XII зууны эцэс болж ирэхэд нэгдсэн улс байгуулж болох урьдач нөхцөл бүрэлдэж байсныг, нөгөө талаас тэр нөхцлийг чухам ямар элементүүд бүрдүүлж байсныг дурдсан нь ажиглагдах бөлгөө.

Эдгээрээс үүдэн Монголын угсаатны нэгдсэн улсыг байгуулахад зайлшгүй шаардлагатай нөхцлүүд хэрхэн бүрэлдсэнийг тодорхойлох нь чухал. Тийм нөхцлийг дотоод, гадаад гэсэн хоёр хэсэгт хувааж болно. Дотоод нөхцөлд, Нэгдүгээрт, Нийгмийн дотоодод эдийн засгийн шинэ харилцаа бүрэлдэн бий болсон явдал мөн. Олон аймгуудын хөгжлийн явцад тэдгээрийн язгууртнууд мал сүргээ өмчилж тоо толгойг нь өсгөн нэмэгдүүлэх, худалдаа арилжаа хийх, ангийн арьс, үсийг нь ашиг олох хэрэгсэл болгох, бусад аймаг, улсад довтлон мал, эд хөрөнгийг нь олзлон хөрөнгө

зоорио арвижуулах, олзлогдогсдыг зарц барлаг болгон ажиллуулах замаар ихээхэн өмч хөрөнгө хуримтлуулсан ажээ. Язгууртнууд төдийгүй нүүдэлч малчдын дотор ялгарал явагдаж, үлэмж мал, хөрөнгөтэй чинээлэг хэсгийнх нь давхраа шинээр төрөн, улам бүр бэхжсээр байв. Ийм өмч хөрөнгийн өсөлт, бүрэлдэлт нь эдгээртэй холбогдсон эдийн засгийн шинэ харилцааг бий болгож, тэр нь амьдралын бүх хүрээнд нөлөөлж, улмаар нийгмийн хөгжлийг урагш ахиулах шийдвэрлэх хүчин зүйл болгоход хүргэжээ.

Эдийн засгийн харилцаанд гарсан нэн томоохон өөрчлөлтийн нэг нь нүүдэлчдийн хүрээгээр нүүх нүүдэл бүрмөсөн халагдаж айл, өрхөөр нүүх нүүдэлд эргэлт буцалтгүй шилжсэн үйл явдал болжээ. Рашид-ад-Дин “Хуучин цагт ямар нэгэн аймаг аль нэгэн газар дугуйлан тойрч буугаад тойргийн төвд ахлах этгээд нь оршвоос түүнийг хүрээ хэмээнэ. Одоо цагт дайны цэрэг ойртоход тийнхүү хүрээлэн зогсож дундаа гаднын этгээд оруулахыг хориглодог” гэж хүрээ гэдгийг тодорхойлсон байдаг. “Ийнхүү овог нийтийн өмчид тулгуурласан хүрээ, хувийн өмчид тулгуурласан айл хэмээх нийгмийн зохион байгуулалтын хоёр хэлбэр, аж ахуйг хөтлөх хоёр арга зэрэгцэн хосолж хуучин нь шинэдээ сууриа тавьж өгсөн нь XI-XII зууны үеийн Монголын нийгэм эдийн засгийн тун онцлог өвөрмөц шинжийн нэгэн болно... Айл алхаа бүрдээ хүчийг олж XIII зууны эхэн болоход үндсэндээ хүрээг давамгайлж ялсан байна” /20.79/ гэж доктор Д.Гонгор “Халх товчоон” хэмээх түүхэн том судалгааны зохиолдоо бичжээ.

Энэ бол язгууртан ба чинээлэг хүмүүсийн эзэмшиж буй хувийн өмч нийгэмд давамгайлж, өмчийн шинэ харилцааны үндэс, цөм болж байгааг харуулам.

Өөр нэг баримтыг дурдвал, Туркестаны худалдаачин Хасан 1202 оны үеэр үлэмж хэмжээний хонь тууж явсан. Мөн Эргэнэ мөрний хүмүүсийн булга, хэрэм худалдан авч байсан, Онгуд аймгийн ноён Алхуш Тихитхури мянган ирэг худалдаж байсан баримтууд түүхэн сурвалж бичиг, зохиолуудад тэмдэглэгдсэн нь зүй ёсоор анхаарал татахуй. Эдгээр баримтууд нь Монголчууд худалдаа арилжаанд татагдан орж, мөн гаднын худалдаачид Монголд худалдаа хийж, худалдааны нээлттэй байдалд шилжиж байсны нотолгоо мөн юм.

Хоёрдугаарт. Улс төрийн хүрээнд аймгуудын хөгжлийн хэлбэр, төвшинд чанарын өөрчлөлт гарсан явдал орно. Энэ нь өнгөрсөн хугацаанд явагдсан үйл явцаар аймгуудын дотоод хөгжлийн үр дүнд зохион байгуулалтын эхний шинэ хэлбэр болох аймгуудын холбоо, дараагийн хэлбэр болох ханлиг /хант/ улс үүсэн бий болсон нь дээд шат болох нэгдсэн улс үүсэх туршлага хуримтлуулж, улмаар урьдач нөхцөл нь болжээ. XII зууны эцэс болоход аймгуудын арав шахам холбоо үүсэн бий болсоны зарим нь ханлиг, улсуудын түвшинд хүрч хөгжиж байв. Алтай, Хангайн уулсын хооронд оршин тогтнож байсан Найманы ханлиг хамгийн том улс төрийн нэгдэл байлаа. Дараа нь Хэрэйдийн вант улс, бас гурван голын Хамаг Монгол улс орж байсан бөлгөө.

Эдгээр хант улсууд нь биеэ даасан улсын түвшинд хүрч байсны хувьд Монголын нэгдсэн улс байгуулах төрийн урьдач нөхцлийн дээд түвшин нь болсон гэж үзвээс зохилтой.

Гуравдугаарт. улс төрийн бүлгүүдийн хоорондын тэмцэл өрнөлтийнхөө дээд шатанд шилжин орсон явдал гол нөхцлийн нэгэн нь болсон аж. “Талын язгууртнууд” хэмээн нэрлэгдсэн үндэсний язгууртнууд “урт дурын хүн” /57.84/ хэмээн томъёологдсон чинээлэг нүүдэлч малчид, жирийн нүүдэлчин малчид зэрэг бүлгүүд өөр өөрсдийнхөө эрх ашгийн төлөө болон өөр хоорондоо сөргөлдөн тэмцэлдэх явдал дээд хэмжээндээ хүрчээ. “Урт дурын хүмүүс нь X зууны үеэс монголын нийгэмд зохих байр сууриа эзлэн гарч ирсэн байдалтай... Урт дурын хүмүүс монголын тархай бутархай байдлыг эцэс болгож, нэгэн хаантай нэгдмэл улс байгуулахын төлөө зорьж байсан аж” /57.84/ Хамгийн шийдвэрлэх тэмцэл нүүдэлч малчин ардын тэмцэл байв.

Тэд малын тоо толгойг дарах, харъяат эзнээ орхин нүүх, ганц нэгээрээ төдийгүй бүхэл бүтэн овог угсаагаараа хамтран тэмцэх, захирагдахаас татгалзах, орхин одох, дайсанд барьж өгөх, шууд барьж алах, тэмцлийг няцаан дарж чадахгүйгээс гарт нь өртөх явдал хүртэл гарч тэмцэл ширүүсэж байжээ. Ийм нөхцөлд язгууртнууд хүчээ нэгтгэж хүчтэй төр засаг байгуулахаас аргагүйд хүрсэн ажгуу. “Монголын нууц товчоо”-нд “хар хэрээ халтар нугасыг барих болов, харц ард хан эзэндээ халдах болов”, ”Хан эзэндээ халдсан харц ардыг хотлоор нь хүйс тэмтрэн устгах”, “босгоноос булгаж зайлсан боолын борвийг огтлох”, “үүднээс зайлсан боолын элгийг эмтлэх” гэх зэргээр бичсэн байдаг нь язгууртан ба нүүдэлчин ардын тэмцэл хэрхэн хурцдаж байсны дүр зургийг илэрхийлнэ.

Дөрөвдүгээрт. аймаг, ханлиг, язгууртан ихсүүдийн хоорондын газар нутаг, харъяат иргэд, өмч хөрөнгөө булаалдах, эрх мэдэл, зэрэг тушаал олж авах, олз ашиг олохын төлөөх сөргөлдөөнд бүх аймаг, хүн ам хамрагдаж нийгмийн дэг журам, амгалан тайван байдал алдагдахад хүрсэн нь нэгдсэн улс байгуулах бас нэгэн нөхцөл байжээ. “Монголын нууц товчоо”-нд

“Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлон булаацалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв” /51.226/ гэж өгүүлсэнээс үзбээс XII зууны эцэс болж ирэхэд Монгол нутагт мөргөлдөөн, сөргөлдөөн, тэмцэл, довтолгоон, тулалдаан нийтийг

хамарч, түүний явцад өмч хөрөнгө, мал сүрэг үлэмж их үрэгдэж, хүн ам үгүйрч, бас сүйрэн устаж, амар тайван байдал алдагдахад хүрч байжээ. Рашид-ад-Дин, аймаг тус бүр өөр өөрийн эзэн ноёнттой байж, цагийн ихэнхийг тэд бие биетэйгээ байлдан тулалдаж, хоорондоо эвдрэлцэн бие бие харилцан дээрэмдэж байсан /72.158/ хэмээн өгүүлсэн нь аймаг хоорондын тэмцэл ихэд хурц байсныг нотолно. Ийнхүү бүх аймаг, ханлиг, хүн амын бүх бүлэг, тухайлбал язгууртнууд, урт дурынхан, харц ард, нүүдэлч малчид, гар урчууд, худалдаачид бүгд залхаж, тайван амьдралыг хүсэх болжээ. Тэд бүгд хүчтэй төр улсад багтаж, тайван нөхцөлд аж ахуйгаа эрхлэхийг хүсэж байсан нь нэгдсэн улс байгуулахын нийгмийн томоохон нөхцөл мөн байв.

Монголын нэгдсэн улс байгуулахын дотоод нөхцлийн зэрэгцээгээр гадаад урьдач нөхцөл бүрдсэнийг тэмдэглэвэл зохино. Үүнд нэгэн чухал гадаад нөхцөл нь Монгол аймаг, ханлиг, хүн ам, газар нутаг харийн улс орны өнгөлзлөг түрэмгийлэлд байнга өртөж байсан учир тэдгээрээс хамгаалах зайлшгүй шаардлага бол нэгдсэн улс байгуулахын гадаад урьдач нөхцөл мөн байв. Өмнөд хөршийн Зүрчидийн Алтан улс болон Тангуд, Хар Хятан, Ляо улсуудын довтолгоонд монголчууд байнга өртөж байв.

Гаднын довтолгоог сөрөн зогсож, газар нутаг, хүн ам, мал хөрөнгөө хамгаалахын тулд монголчууд хүчээ нэгтгэх, хүчирхэг улс байгуулж, дээвэр дор нь нэгдэн нягтрах шаардлага нийгмийн хэрэгцээ болж тавигджээ. Эл шаардлагыг бүх аймаг, улс, хүн амын бүх давхраа гүнзгий мэдэрч, бүрнээ ойлгож байжээ.

Монголын нэгдсэн улс байгуулахын бас нэгэн чухал гадаад нөхцөл нь дэлхий дахины соёл иргэншлийн хөгжлийн хандлагатай холбоотой байв. Ази, Европын ууган соёл иргэншилтэй улсууд ялангуяа Хятад, Энэтхэгийн улсуудад феодалт ёс, феодалын харилцаа аль эрт ялан төлөвшиж, хөгжлийнхөө хандлагаар дэлхий дахиныг дагуулан түрүүлж байв. Хөгжлийн энэхүү хандлага нь дэлхийн ард түмний салшгүй хэсэг болсон нүүдлийн соёл иргэншилтэй монголчууд, тэдний түрүү үеийн феодалын харилцаанд нөлөөлөхгүй байхын аргагүй байжээ. Энэ хандлага, мэдрэмж нь нүүдэлчин монголчуудад нөлөөлж, нийгмийн хөгжлийн илүү түвшин рүү тэмүүлэхэд хүргэх хүчин зүйл болж үйлчилжээ. Дэлхийн улсуудад “феодалт ёсны харилцаа хөгжсөн бодит байдал, түүний үр дагавар нь монголчуудад туршлага болон нөлөөлөх нь зайлшгүй бөгөөд зүй тогтолт шинжтэй байжээ” /26.33/ Дээр дурдсан нөхцлүүд бүгд нийлж монголын нэгдсэн улсыг байгуулахын урьдач цогцолбор нөхцлийг бүрэлдүүлсэн болой.

§2. Монголын нэгдсэн улсыг байгуулсан үе шат, үйл явц

Монголын нэгдсэн улсыг байгуулах урьдач нөхцөл бүрэлдсэн ч түүнийг ажил хэрэг болгон, бүх аймаг, ханлигийг нэгтгэж нэгэн их улсад багтаах нь тийм ч амар

хялбар биш агаад зохих цаг хугацаа, үзэл баримтлал, хүч нөөц, эр зориг, эрэмгий үйл ажиллагаа шаардсан нийгмийн аугаа том үйл явдал байсан ажгуу. Монгол оронд нэгдсэн улс байгуулах нь монголчуудад төдийгүй дэлхий дахины ач холбогдолтой бөгөөд ялангуяа төв азийн соёл иргэншилд асар их нөлөө үзүүлэх учир шалтгаантай байсан бөлгөө.

Дээрхи бодит үндэслэл, нөхцөл байдлын улмаас Монголын нэгдсэн улсыг байгуулах үйл явц нилээд удаан хугацаагаар буюу 27 жил үргэлжилж, хоёр том шатыг дамжин явагдсан байна.

Хамаг Монгол улсыг сэргээх нь Монголын нэгдсэн улс байгуулахын эхний шат болно. Хамаг Монголыг сэргээхийн учир юун хэмээвээс тус улс нь монгол орны гол зангилаа, улсын бүх газар нутгийн төвд оршдог, нийгэм эдийн засаг, улс төр, соёл, гарал удам, зан заншлын илүү өндөр түвшин, уламжлалтай бусад аймаг, угсаатныг хойноосоо дагуулж, тэдний төлөө хариуцлага хүлээх чадвартай, нэгдсэн улс байгуулах гол цөм болох ирээдүйтэй байсан бөлгөө. Хамаг Монгол улсыг сэргээж гол цөм болгохгүйгээр Монголын нэгдсэн улсыг байгуулах боломж үнэн хэрэгтээ үгүй байжээ.

Гэтэл энэ үед Хамаг Монгол улс бутран сарнисан байсан юм. Хотула ханы дараа тус улс улам бүр доройтсоор байв. Үлэмж нөлөө бүхий Есүхэй баатар нас барсан нь байдлыг ихээхэн хүндрүүлжээ. Түүний захиргаанд байсан овог, аймгууд салан одож, тайчууд аймагт дагаж оржээ. Их баатрын шадар нөхрүүд Есүхэйн гэр бүлийг орхин одсон байна. Гэвч хамаг монголд өөрийн манлайлан дагуулагчаа бэлтгэх, тодруулах, дэмжин туслах их үйлс үүрлэж, цаг улирах тусам улам бүр дотогшсоор байсан ажгуу. Энэ хугацаанд эцгээсээ 9 настайдаа өнчрөн үлдсэн Тэмүжин хүү Өүлэн эхийнхээ сургаал ивгээлийг хичээнгүйлэн дагаж, аймаг юугаан хүндэтгэн, алсын бодлоготой, холч ухаантай, зориг төгс, бэрхшээлийг даван туулж чадах тэсвэр хатуужилтай язгуурын хүмүүн болон өсөн өндийж үеийнхэн дотроосоо улам бүр товойн тодорсоор байсан аж. Тэмүжин ядуу зүдүүгийн зовлон, хүч чадал үл хүрэхийн гамшгийг амсаж, хүүхдээ тэжээж өсгөхийн төлөө эхийнхээ яаж зовж, зүдэрч байгааг гүнээ мэдэрч, тайчуудын эсрэг зориг тэвчээртэй тэмцэх явцдаа улам бүр хатуужин, өөртөө үнэнч найз нөхөдтэй болж, хамаг монголын төлөө эцгийнхээ явуулж байсан үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд бие сэтгэлээ тууштай бэлтгэж байлаа. Эцгийгээ нас барсныг хараад уйлан хайлах агшинд Хонхотны Чирха өвгөний “усны загас мэт юунд уяран гасална вэ чи? Улс төрөө байгуулья гэж учиртай үгээ хэлэлцсэн биш бил үү”/51.44/ гэж хэлсэнийг ухааран сэтгэлийн өчгөө өргөсөн нь хамаг монголыг сэргээхэд гүйцэтгэх үүргийнх нь тангарга болсон буй заа. Тэмүжин өсөн хүмүүжиж, хатуужин төлөвшсөн нь Хамаг Монголыг сэргээсний нэгэн хүчин зүйл байсан аж.

Түүнийг улс төрийн амьдралд бэлтгэхэд Өүэлэн эх, Хуагчин эмээ, Хонхотны Чирха, Мэнлиг эцгээс⁷ авахуулаад багын найз Борочи, үеийн язгууртан Жамух, эцгийнх нь анд Тоорил ван зэрэг хүмүүс ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Тэмүжин “Бага ахуй наснаасаа өнчрөл, зовлон зүдүүр, хоосрол ядуурал, атаархал, хонзогнолын гай гамшгийг амсаж, бутран сарнисан овог аймгуудын сөргөлдөөн, хүн амын ядуурал, аж ахуйн доройтол, гаднын хүчний өнгөлзлөг, дээрэм тонуул зэргийг бие сэтгэлээрээ мэдэрч, энэ бүхнийг даван туулж, дэвшил хөгжилд хүрэхэд монголчуудын хүчийг нэгтгэн хүчирхэг улс байгуулах нь зүйтэй юм байна гэсэн нэгэн үзүүрт бодлогод очсон ажээ”/26.39-40/

Тэмүжин өсөн төлөвшиж эрийн цээнд хүрч, найз нөхөдтэйгээ хамтарч “Хагацсан улсаа хамтатгах, бутарсанаа цуглуулах” /51.54-55/ зорилго тавьж нэгэн чигийг барьснаар хамаг монголыг сэргээх үйл явц эхэлжээ. Хамаг Монголыг сэргээх арга тактикаа ч боловсруулсан байна. Хамаг Монголыг сэргээхийн тулд юуны өмнө эцгийн ба өөрийн анд нарын хүчинд тулгуурлахаар шийдвэрлэжээ. Эцгийн анд Хэрэйдийн ханлиг улсын Тоорил ванг Туулын хар Шугуйд нутаглаж байхад нь дүү нарынхаа хамт зочилж “Эцгийн хуучин анд та миний эцгийн адил буюу гэж би гэргий аваад өмсгөл хар булган дахыг чамд авчрав”/51.54/ гээд хамаг монголыг сэргээхэд туслахыг хүссэн санаагаа илэрхийлэхэд Ван ихэд баясаж “хар булган дахны чинь хариуд хагацсан улсыг тань хамтатган өгье. Булган дахны чинь хариуд бутарсан улсыг чинь цуглуулж өгье. Бөөр нь бөгсөнд байг. Цэр нь цээжинд байг” /51.54,55/ хэмээн хамтран ажиллахаар шийдвэрлэсэн байна. Дараа нь Тэмүжин, Жамуха анддаа хандаж “Өст мэргэд өрийг минь өвтгөв. Өврийг минь хоослов. Өмөг түшиг болох өндөр төрлийн та өшөөг минь авч өгнө үү”/51.62/ гэхэд Жамуха “Эл өшөөг нэхэж эдгээр мэргэд аймгийг эвдэн мохоож, эхнэр Бөртийг чинь эгүүлж авчирья” /51.63/ хэмээн хариу өчжээ.

Тэмүжин Хамаг Монголыг сэргээх үйлсийг удирдах болж, түүнийг нь ч дайчин нөхөд, төрийн зүтгэлтнүүд, ураг төрлийнхөн нь дэмжин хүрээлжээ.

Хамаг Монголын аймгуудыг нэгтгэх үйл явц Тоорил ван, Жамуха сэцэн хоёртой хүч хамтран гурван мэргэд аймгийн цэргийг 1179 онд бут цохин ялсан “Буур хээрийн тулалдаан”⁸-аар эхэлжээ. Энэ тулалдааны дараагаар Жамуха, Тэмүжин хоёр салсан хэдий ч Тэмүжиний байр суурь бэхжиж, өөртөө үнэнч сайн нөхөд, чадварлаг баатрууд, цэрэг дайчдаар хүчин чадлаа нэмэгдүүлсэн байна. Дүү Хасар, Бэлгүтэй, Сорхон Шар, түүний хүү Чулуун, Нахугийн Боорчи, Жарчиудайн Зэлмэ, дархадын Хадаан, Далдурхан, Мэнгэтийн Үнгүр, Барулас аймгийн Хубилай, Мангад аймгийн Жатай, Доголху, Урианхан Сүбээдэй, Бааран аймгийн Хорчи, Хөхөчөс зэрэг эрэлхэг дайчид нийлж Тэмүжиний нөхөд цэргийн цөм нь болжээ.

Жалайр, Дархад, Баяуд, Барулас, Мангуд, Арулад, Урианхай, Бэсүд, Сүлдүс, Олхонуд, Горлос, Дүрвэд, Ихирэс, Ноёхон, Оронар, Баарин зэрэг хорь гаруй аймгийн нөлөө бүхий ноёд толгойлогчид Тэмүжинийг дэмжигчид болж даган орж ирснээр түүний хүч чадал, нэр нөлөө ихээхэн нэмэгджээ.

Тэмүжин хамаг Монголчуудыг нэгтгэх үйл ажиллагааг жолоодож, довтолгоон хийх, тулалдах тэмцлийг явуулахын хамт нэгтгэх үйлсэд дэмжлэг үзүүлэх, хүчин зүтгэх, дагаж орох ажлыг амжилттай зохион байгуулснаар хамаг Монголын харьяатуудын олонхи нь түүний мэдэлд төвлөрч ирсэн ажээ. Тэмүжин ч өөрийгөө хамаг монголчуудын жинхэнэ удирдагч гэдгээ харуулж чадсан байна. Хамаг Монголыг сэргээх нөхцөл ч нэгэнт бүрджээ. Ийм нөхцөлд Онон, Хэрлэнгийн эхэнд орших Цэнхэрийн голын хар зүрхний Хөх нуур хэмээх газар Хотула хааны гуравдахь хүү Алтан, Отчигин, Есүхэй баатрын ах Нэгүн тайжийн хөвгүүн Хучир, Зүрхэн аймгийн толгойлогч охин Бархлагийн ач хүү Сача Бэхи тэргүүтэй язгуурын монголын нөлөө бүхий ноёдын онц хуралдаан шарагчин гахай жил буюу 1189 онд болж, Тэмүжинд “Чингис хаан” гэсэн цол хайрлаж, хамаг Монголын хаанд өргөмжилжээ.

“Боржигон овгийн хууль ёсны залгамжлагч 28 настай Есүхэйн Тэмүжин 10 гаруй жилийн уян хатан, ухаалаг, эр зоригт тэмцлээрээ эцгийнхээ захирч байсан ханлигийн түмэн олны итгэл дэмжлэгийг хүлээн хамаг монголыг сэргээн байгуулж, тэргүүн нь болжээ”. Тэмүжиний хаанд өргөмжлөгдсөн нь Хабул, Хотула нарынхтай нэгэн адил байсан боловч ялгаварлагдах зүйл нь “Чингис” /51.122/ гэдэг цолтой болсонд оршино /57.88,89/ хэмээн Монгол улсын түүхэнд тэмдэглэсэн болой. Тэмүжин хамаг монголын хаан болмогцоо улсаа бэхжүүлэн нэр хүндийг нь өргөх, түүнийг монголын нөлөө бүхий төв болгох, улмаар бүх монгол туургатныг нэгтгэх онол, арга тактик боловсруулахад яаравчлан орж, бүх үйл ажиллагаагаа чиглүүлжээ. Чингис хаан өөрийн өргөө, албыг бий болгон, Боорчийн хүү Үгэлэн Чэрби, Хачиун-Тохураун, ах дүү Жэтэй, Доголху нарыг ордны түшмэл, хамгаалагчид болгов. Өнчүр, Сүйхэтү Чэрби, Хадаан-Далдурхан нарыг буурч /тогооч/, Дэгэйг хоньчин, Хүчүгүрийг тэрэгчнээр томилж, гэр доторхи гэргий, хүүхэд, зарц нарыг Додой Чэрбиэр захируулав. Бэлгүтэй, Харалдай-Тохураун нарыг агтчин, Хуту, Маричи, Мулхалху гурвыг адуучин, Архай Хасар, Тахар, Сүхэхай, Чаурхан дөрвийг холбоочин, газарчин, Боорчи, Зэлмэ хоёрыг хамгийг захирах бүх хэргийг мэдэгчээр томилон ажиллуулжээ. Ийнхүү хааны орд өргөө, албан хэрэг, үйл ажиллагааг зохион байгуулалттай, ёс журамтай, өргөл хүндэтгэлтэй болгосон нь хамаг монгол улс оршин ахуйг илтгэн харуулж, цаашид хүчирхэгжин хөгжихийн эс үндэс болсон байна. Хамаг Монгол улс сэргээн байгуулагдсанаар Монголын нэгдсэн улсыг байгуулах эхний шат дуусгавар болжээ. Монголын нэгдсэн улсыг байгуулах үйл явцын хоёр дахь шат нь монгол туургатныг нэгтгэх явдал байжээ.

Чингис хаан Монгол туургатныг нэгтгэхдээ *нэгдүгээрт*, эе эвийг хичээж, нэгдсэн улс байгуулахын утга учрыг ойлгуулах, энэ үйлсэд оролцох, идэвх сонирхол төрүүлэх, нэгдэж, дагаж орохыг хөхүүлэн дэмжих бодлого, үйл ажиллагаа явуулах, *хоёрдугаарт*, эсэргүүцэгч овог, аймгийн толгойлогч, язгууртны эсрэг шургуу тэмцэх, цэрэг Зэвсгийн хүч хэрэглэх хоёр аргыг хослуулсан ажээ. Тэмүжин нэгдэх аргыг хэрэглэх явцдаа цэргийн жанжин, эрэлхэг зоригт баатруудаа бэлтгэж, цэргийн Зэвсэг, байлдах арга техникээ сайжруулан амжилт олсны үр дүнд нэр хүнд, сүр хүч нь нэмэгдэж, олон овог, аймгийн төлөөлөгчид, тухайлбал Уруд, Мангуд, Хонгирад, Жадран, Хатигин, Салжиуд, Тайчууд аймгууд Чингис хаанд дагаж орсон ажээ. Чингис хаан, түүний 19 сайн анд нөхөд Балжиуд нуурын дэргэд цугларан үүрд хамт амьдран тэмцэнэ гэж тангарга өргөжээ. Үүнийг түүхэнд “Балжиуд нуурын тангараг”⁹ хэмээн нэрлэгдсэн энэ үйл явдал Чингисийн зорилго, хүч чадал, эв нэгдлийг улам нягтруулсан болой. Чингис хаан өөрийн эсрэг сөрж зогссон нөлөө бүхий аймаг, ханлигийн толгойлогчдын эсрэг Зэвсэгт тэмцэл явуулахад зайлшгүй хүрчээ. Үүний улмаас Жамуха эцэн, Тоорил ван, наймны Таян хан, түүний хүү Сэнгум, Татарын Мэнгүжин сүүлт зэрэг толгойлогчид, тэдгээрийн цэрэгтэй олон удаа ширүүн тулалдаан хийсэн ажээ. Энэ нь 1190 оны орчим Тэмүжин, Жамуха нарын хоорондын тулалдаан Туулын хар шугуйн Далан Балжуд гэдэг газарт явагдаж, түүхэнд “13 хүрээний тулалдаан”¹⁰ гэж нэрлэгдсэн их байлдаанаар эхэлжээ. Эл тулалдаанд Чингисийн цэрэг ялагдсан ч дараа нь 1201 онд Онон, Хэрлэнгийн хооронд оршдог “Хүйтэний тулалдаан”-д Жамухын цэрэг сэхэшгүй болтлоо бут цохиулсан байна. Тэмүжиний цэрэг, ван хааны цэрэгтэй хамтран 1196 оны орчим Улз голын Нарту шүтээн, Хусту шүтээн гэдэг газар Мэгүжин сүүлт тэргүүтэй Татарын цэргийг бут цохисон нь түүхэнд “Улз голын дайн”¹¹ гэж нэрлэгдэн тэмдэглэгджээ. Мөн 1200 оны өвөл Татарын холбооны цэргийг “Буйр нуурын тулалдаанаар”¹², 1202 оны намар цагаан татар тэргүүтэй татарын цэргийн үлдэгдэл хүчийг “Далан нөмөргийн”¹³ тулалдаан, 1202 онд “Хүйтэн уулын тулалдаанаар”¹⁴ Жамуха түүний холбоотны цэргийг тус тус бут цохин ялалт байгуулсан ажгуу. Чингис хаан 1203 оны намар түүхэнд “Муу өндөрийн тулалдаан”¹⁵ гэж нэрлэгдсэн сүрт тулалдаанаар /3 өдөр, 3 шөнийн үргэлжилсэн/ Ван хан, түүний хүү Сэнгүмийн цэргийг ялсан ажээ. Чингис хааны цэрэг 1204 оны эхээр Наху гүний Цухал хөндий гэдэг газар¹⁶ Найманы Даян хаан, түүний хүү Хүчүлүгийн цэргийг бут цохин ялалт байгуулжээ. Чингис хаан 1185-1206 оны хооронд их бага 32 удаагийн дайн тулалдааныг удирдаж, монгол угсаатны нийт 81 том жижиг аймгийг нэгтгэжээ /57.95- 96/.

Ийнхүү 1206 оны эхэн болоход монгол угсаатны ихэнх аймаг Чингис хааны мэдэлд орж, Монголын нэгдсэн улсыг байгуулах үйл явцын хоёрдахь шат үндсэндээ дуусгавар болжээ. “Монголын нууц товчоо”-нд “Тэгээд эсгий туургатан улс энх шударга болов” /51.178/ хэмээн тэмдэглэсэн нь үүний нотолгоо мөн.

Монгол туургатныг нэгтгэхэд Чингис, тэр үеийн улс төрийн язгуурын хүмүүний дотроос шалгаран тодорч, жинхэнэ хүчтэй удирдагч болохоо харуулж, Хамаг монгол улсыг монгол туургатныг нэгтгэхэд гол мөхлөг болгож чадсан аж. Хамаг Монгол улс нь бусад ханлиг улсуудаа бодвол шинэхэн байгуулагдсан, хүч чадал, эв нэгдэлтэй, өөрийн хаан Чингистээ бат итгэж, нягт хүрээлэн, монгол угсаатныг нэгтгэх үйл явцыг гол төлөв өөрийн нутаг дээрээ идэвхтэй зохион байгуулсан зэрэг түүхэн давуу тал, өндөр үүрэг хариуцлага хүлээж, түүнээ амжилттай дааж чадсан болой. Францын эрдэмтэн Рене Груссегийн бичсэнчлэн “Хянганы нуруунаас Алтайн их уулс хүртэлх умард монголын нүүдэлчид эсгий гэртэй бүхэнээ цөм нэгэн тугийн дор нэгдэн нэгдсэн аугаа хүчин болон хувирсан” /74.180/ бөлгөө. Монголын нэгдсэн улс байгуулах үйл явц өрнөсөн энэ жилүүдэд гаднын хүчин болох Алтан улсын хүч суларсан, хар Хятан улс дундыг сахиж байсан зэрэг гадаад нөхцөл байдал зохих нөлөө үзүүлсэн байна.

Энэ тухай академич Ш.Нацагдорж “Алтан улс ихээхэн сулран доройтож байсан цаг тул Монголын дотор улс төрийн хүчирхэг шинэ нэгдэл бүрэлдэн тогтох явдлыг саатуулан зогсоож чадахгүй байжээ” /62.108/ гэж тодорхойлон бичсэн байдаг.

1189 оноос хойшхи 16 жилийн хугацаанд Монгол туургатныг нэгтгэж чадсан нь түүхэн том үйл явдал мөн. Үүнийг Чингис хааны үүрэг рольтой холбож үзэхээс аргагүй болой. Чингис хаан нэгдсэн улс байгуулах үзэл бодлогод үнэнч байж, хүч чадал, эр зоригтой цэрэг бүрдүүлж, өөрийн нөхөд хэмээх эрдэм чадалтай дайчдыг гол цөм болгон, энгийн элэг нэгт хүмүүсийг өөртөө татаж, тэдний итгэл хүндэтгэлийг хүлээн, сөргөлдөгч талынхаа сул тал, дотоод зөрчлийг ухаалгаар ашиглаж, эцэг эх, ахас ихсийнхээ сургаал сургамжийг хичээнгүйлж болгоон, шинэ шинэ арга ухааныг зориглон хэрэглэсэн нь түүний ялалт байгуулах бодит хүчин зүйл болсон ажээ.

§3. Монголын нэгдсэн улс байгуулсныг тунхагласан нь

“Монголын нууц товчоо”-нд 1206 онд Ноёдын Их Хуралдай¹⁷ “барс жил Онон мөрний эхэнд хуралдаж есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүжинд “Чингис хаан” цолыг өргөв” /52.178/ хэмээн Монголын нэгдсэн улс байгуулагдсаныг албан ёсоор тунхагласан ажгуу. Их Хуралдайд алтан ургийнхан, Чингис хааны эх, хүүхдүүд, хатад, цэргийн жанжин, хамтран зүтгэгчид, эрэлхэг баатрууд, язгууртан ноёд нар ихэд билэгшээн, нэн хүндэтгэлтэйгээр оролцжээ. Эл их ёслолын хуралдаан монголчуудын анхаарлыг гүнээ татаж, түүн лүгээ монгол угсаатан бүх овог, аймаг, хүн ард нүдээрээ үзэхийг чин санаанаасаа хүсэж байсан аж. Энэ тухай “Юан улсын мандсан төрийн хөх судар”-т “Онон мөрний эхэнд уул давшин, далай нүүх чуулганаа очих их, бага улс аймгууд нэг нь ч хоцролгүй хамтаар нүүн очив” /36.1146, 1147/ хэмээн тэмдэглэн бичсэн байдаг бөлгөө.

Үнэхээр монголын нэгдсэн улсыг байгуулахаар Их Хуралдай чуулж монгол нутагт хүчирхэг нэгдмэл улс байгууллаа хэмээн тунхагласан нь аугаа их түүхэн үйл явдал байсан ажээ. Их Хуралдай дээр тэмдэглэснийг монголын нэгдсэн улсын хаанаар тунхагласан ёслолын үйл явц өрнүүн хүндэтгэл, ёс журам, учир холбогдлыг агуулсан асар их сүр хүч ач холбогдолтой байсан болой.

Их Хуралдай чуулж Монголын нэгдсэн улсыг тунхаглан, Тэмүжинийг Чингис хаанд өргөмжилсөн түүхэн үйл явдлыг олон орны эрдэмтэд судлан бичсэний дотроос Ираны төрийн зүтгэлтэн Рашид-ад-Дин, Монголын дундат үеийн их номч Инжнаши, ХХ зууны монголын нэрт эрдэмтэн академич Ш.Нацагдорж, Ч.Далай, Хятадын алдарт судлаач Сайшаал нарын бичсэн зүйлс илүү их анхаарал татдаг билээ.

Рашид-ад-Дин 1206 оны хавар цагийн эхэнд Чингис хаан есөн хөлт цагаан тугаа босго гэж айлдаад, сүр жавхлан төгөлдөр Их Хуралдай хуруулав. Энэ хуралдай түүний Чингис хаан гэсэн аугаа их цолыг баталсан бөгөөд түүнийг санаачлагч нь Хонхтой аймгийн Мэнлиг эцгийн хөвгүүн Тэв тэнгэр гэгдсэн Хөхчү байсан билээ.

Чин гэдэг нь бат бэх, Чингиз гэдэг нь түүний олонтаа утгаараа Гүр хаан гэдэгтэй адил ажгуу... Өөрөөр хэлбэл, аугаа их хүчтэн, эзэнтэн гэсэн үг ажгуу” /72.297/ хэмээн айлдсан бөлгөө. Үүнээс үзэхүл Их Хуралдайг сүр жавхлан, нэр төртэй чуулсан нь тодорхой авч хэрхэн чуулсан үйл явцыг бичсэн нь арай хомс болой. Харин үүнийг мэдэхийг хүссэн нь их ажгуу.

Их сударч Инжнаши “Тайцзу /Чингис/ гол тэнгэрийн хөвгүүний өргөөнд ирж, тэнгэр газарт хүж, зул өргөн ёслол мөргөөд, өөрийн өвөг дээдсийн хаадад хүж зул асаан ёслол мөргөж, төрсөн эх Өүлэн хатны зүг хүж, зул өргөн ёслол мөргөж, гараа угаан, амаа зайлан, дээлийн тоосоо гөвж, сайхан үнэрээр ариулсаад Сорхон Шар, Дай сэцэн хоёулыг түшиж 3 давхар өндөрт тэнгэрийн хөвгүүний хаан сууриндаа сууж хагаан болов” /36. 1148, 1149/ гэж хаанд өргөмжлөхийн өмнө гүйцэтгэсэн ёс ёслолын тухай өгүүлжээ. Үнэндээ ийм ёс гүйцэтгэсэн байхад болохгүй гэх зүйл үгүй бөлгөө. Үүнээс ч илүү утга төгс, сүр жавхлантай байсныг ч бас үгүйсгэх юун.

Хятадын эрдэмтэн Сайшаал “Чингис хаан” хэмээх судалгааны томоохон бүтээлдээ нэгдсэн улсыг тунхаглаж, Тэмүжинг хаанд өргөмжилсөн их ёслолыг аль болох бодит үнэнд ойртуулан зураглан дүрслэхийг хичээсэн нь харагдана. Тэрбээр Хуралдай чуулах төрийн ордон нь Алтан Хөвөөтэй хөх хөлд рөгөөр чимэглэсэн цас шиг цагаан өнгөтэй том Монгол гэрийн хэлбэртэй ордон болох бөгөөд тооныг нь тулсан бат дөрвөн тулгуурыг нь шижир алтаар чимсэн байлаа.

Их ордны үүдний гадна нэгэн талд нь Монголын төрийн далбаа “есөн хөлт цагаан туг”-ийг өндөрт мандуулж, нөгөө талд нь Чингисийн дайчин үйл явдлын бэлэг дэмбэрэл болсон “дөрвөн хөлт хар сүлд”-ийг мандуулжээ.

Их ордны өмнө байдаг өргөн уудам их талбайд нь цэрэг жагсаал, найр наадам хийдэг байна /75.348/ гэж бичжээ. Академич Ч.Далай хаанд өргөмжилсөн ёслолын тухай нилээд дэлгэрэнгүй өгүүлсэн нь үнэн бодит байдалд улам илүү ойртуулсан нь ажиглагднам. Ч.Далай Тэмүжинг цагаан эсгий дээр суулган дамнан суудалд нь залж суулгаад, дараа нь төрөл садан, түшмэд сайд нар өмнө нь сөгдөн 9 удаа мөргөж, алтан зарлигийг нь ёсчлон гүйцэтгэхээ тангаргалаж байжээ. Тамгын сайд Тататунгаа хаш тамгыг харагсадад үзүүлж “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” хэмээсэн тамгын бичгийг уншиж сонсоод Чингис хаанд хоёр гараараа өргөн барьжээ /24. 54,55/ гэх зэргээр бичсэн байдаг. Энэ мэтээр сурвалж бичиг, ном судар, зохиол бүтээлүүдэд тэмдэглэгдсэн болон өгүүлсэн зүйлсийг нягтлан болгоож, харьцуулан үзбээс Тэмүжинг Чингис хаанд өргөмжилсөн Их Хуралдайн ёслолын талаар дараах зураглал гарч байна.

Тэмүжинг Монголын нэгдсэн улсын хаанд өргөмжилсөн Их Хуралдайн ёслол монгол түмний анхаарлыг ихэд татаж түүнд алтан ураг, өрлөг жанжин, сайд ноёд, анд нөхөд, ард нийтээр өргөн оролцсон түүхэн аугаа үйл явдал болжээ. Онон мөрний их хөндийд зочдын байрлах асар өргөө, гэр, майхнууд нарийн дэс дарааллаар байршин баригджээ. Эхний эгнээнд алтан ургийнхны гоёмсог орд өргөөг эгнүүлэн зэрэгцүүлж, дараагийн эгнээнүүдэд өрлөг жанжин, их баатар, сайд ноёдын асар өргөө гавьяа, тушаал, зэрэглэлийн дэс дарааллаар сүртэйе байрлажээ. Түүний дараа дагалдсан түшмэл, албатуудын гэр, асарыг байрлуулсан болой. Ер нь Орхоны хөндий тэр аяараа зочид гийчид, овог аймгийн төлөөлөгчид, сонирхсон олон түмний гэр майхан, унаа хөсгөөр дүүрэн багширч, ёстой л уул нүүж байгаа мэт давалгаалан харагдаж байсан буй заа. Их хааны ордон өргөө нь өндөр тавцан дээр баригдсан алтан хөвөөтэй хөх хөлдрөгөөр чимэглэсэн цас шиг цагаан өнгөтэй, Монгол гэр хэлбэртэй ордон байсан агаад тооныг нь тулсан бат дөрвөн тулгуур/багана/-ыг шижир алтаар бүрэн чимжээ. Ордны үүдний гадна нэгэн талд нь есөн хөлт цагаан туг, нөгөө талд нь дөрвөн хөлт хар тугийг өндөр сүр жавхлантайяа байрлуулжээ. Хааны их ордны голд өндөр сүрлэг тавцан дээр цагаан морины бүтэн арьсаар бүрхэн хийсэн хааны залрах их суудлыг засаж, дэргэд нь Бөртэ хатны гоёмсог суудлыг байрлуулсан ажгуу. ... Их ордны баруун талд хааны хөвгүүд, төрөл төрөгсөд, жанжин сайд, түшмэд, ноёд, ордны зүүн талд Бөртэ хатныг залан Өүлэн эх бусад хатад, охид, эмэгтэйчүүд дэс дараалан суудлаа эзэлжээ. Их хааныг өргөмжлөх ёслол болох агшин ирэхүйд Тэмүжин тэнгэр газар, өвөг дээдэс, төрсөн эх Өүлэн хатанд хандаж хүж зул өргөн мөргөж, хүндэтгэл илэрхийлэв. Дараа нь рашаанаар гараа угааж, амаа зайлан, хувцсаа /тоосоо/ гөвж биеэ ариусгах ариун ёс үйлджээ. Үүний дараах агшинд ордны өмнөх уужим талбайд монгол цагаан эсгий дэвсэж дээр нь Тэмүжинг суулгаад алтан ургийн ба өрлөг жанжин нар хүндэтгэлтэйе

өргөн ордон лугаа морилж, их суудалд нь очихуйяа, хамгийн ахмад зүтгэлтэн Сорхон Шар¹⁸, Дай сэцэн¹⁹ нар өргөн түшиж эрхэм суудалд нь залан суулгажээ.

Тэмүжинг суудалдаа залармагц ордны баруун, зүүн талд байраа эзэлсэн хан хөвгүүд, төрөл төрөгсөд, олон сайд, жанжин, ноёд түшмэд, хатад, зочид гийчид бүгд Тэмүжинд 9 удаа мөргөн улсын хаан төрийн тэргүүн болохыг хүлээн соёрхох ёсон үйлджээ. Ихэс дээдсүүд Тэмүжинг хаан суудалтай нь мөрнөөсөө дээш өргөн ордны их талбайг нэгэн удаа тойрон эргээхүйд тэрхүү талбайд хуран цугларагсад цөм сөгдөн мөргөж, гүнээ хүндэтгэсэн ажгуу. Тэмүжин өргөөндөө залармагц ордны бичгийн багш, тамгын сайд, номч мэргэн Тататунгаа Тэмүжинд Чингис цол өргөж их улсын их хаанд өргөмжилснийг зарлан тунхаглаж, цагаан хаш чулуун дээр сийлсэн төрийн хаш тамгыг дээш нь хүндэтгэлтэйе өргөн “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын Далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай” гэсэн тамганы доторхи үгийг сүртэйе уншин сонсоод, хоёр гараараа Чингис хаанд гүнээ хүндэтгэн барьжээ. Чингис хаан, төрийн хаш тамгыг хоёр гараараа гүнээ сүсэглэн гардан авах эл агшинд сүр жавхлант хөгжмийн эгшиг дуурсаж, ордны дотно, гаднын зочид “Чингис, Чингис” хэмээн уриа цуурайтуулан их хаандаа баяр бахархал дэвшүүлжээ. Хаан эзэн, төрийн тамгаа гардан авсны дараа Их Хуралдайн ёслолд оролцсон хан хөвгүүд, хатад ноёд, сайд, жанжин, түшмэд нар Чингис хаан, хатан Бөртэ Үжинд²⁰ талархал илэрхийлж, авчирсан эрхэмсэг бэлэг сэлтээ гардуулсан аж. Чингис хаан маш сүрлэг, баяр баясгалан төгс байж, хуран цугларсан хүмүүсийг дээд, доод гэж ялгалгүйгээр сэтгэл хуваалцан эрхэмсэг бөгөөд энгийнээр ярилцаж олон иргэдийнхээ санаа бодлыг сонсон, Их Хуралдайд хүрэлцэн ирсэн бүх зочдыг ихэд хүндэтгэн элбэг дэлбэг, сэтгэл ариунаар дайлжээ. Ордны өмнөх их талбайд олныг хамарсан төрийн их найр, наадам хийж дээдэс, доодосгүй сэтгэл өөдрөг баяр баясгалантай оролцжээ. Тэмүжинг Чингис хаанд өргөмжилсөн төрийн Хуралдайн их ёслол ийм зураглалаар явагдсан байх үндэслэл буй. Тэмүжинг Монголын нэгдсэн улсын хаанд өргөмжилсөн ноёдын Хуралдайн ёслол өмнөх уламжлалд түшсэн бөгөөд нэгдсэн улсын сүр хүч, нэр төрийг илэрхийлж, цааш цаашид шинэ агуулга, хэлбэрээр баяжин хөгжих Монгол төрийн эрхэм ёсон байсан ажгуу. 1206 оны ноёдын Их Хуралдайн хэлэлцсэн хамгийн гол асуудал нь Тэмүжинг Чингис хаанд өргөмжилж, Монголын нэгдсэн улс байгуулсаныг тунхаглах явдал байсан бөгөөд тус Хуралдай эл асуудлаа амжилттай шийдвэрлэжээ. Энэ тухай академич Ч.Далай “Их Хуралдайгаар хамгийн түрүүнд хэлэлцэх гол асуудал бол Их Монгол улсыг байгуулан дэлхий дахинд зарлан тунхаглах, Их Монгол улсын төрийн хэргийг мэргэн жолоодох их хааныг олж сонгох ажил байжээ” /24.55/ гэж их л онож бичсэн байдаг билээ. Их Хуралдайгаар хэлэлцсэн бусад асуудлын талаар дараагийн бүлэгт өгүүлэхийг болгооно уу.

Чингис хаан Монгол угсаатныг нэгтгэж бүрэн дуусгах, улсын хил хязгаарыг чандлан тогтвортой болгохын тулд нэгдээгүй байсан баруун зүгийн монгол угсаатан аймгийг нэгтгэх арга хэмжээ авсан байна. Энэ зорилгоор Хубилай²¹ жанжныг Харлагуудад илгээхэд Харлагийн Арслан хан байлдаан хийлгүйгээр их улсад даган орж нэгдэв. Чингис хаан түүнийг ихэд соёрхон охиноо хатан болгон өгч ураг барилджээ.

Чингис хааны илгээсэн Сүбээдэй²², Мэргэдийн Тогтоагийн Худу, Чулуун нарын цэргийг Чүй мөрний орчимд, Зэб жанжны тэргүүлсэн цэрэг, найманы Хүчүлүг ханы цэргийг Сариг гүн хэмээх газарт тус тус гүйцэн тулалдаж сөнөөжээ.

1207 онд Зүчи жанжин, баруун гарын цэргийг авч ойн иргэдийг дайлаар очиход Ойрадын Худуга Бэхи²³ түмэн ойрдоо захирч дагаар оров. Зүчи жанжин Шишгэд голд хүрч Ойрд, Буриад, Барга, Урасуд, Кабканас, Ханхас, Туба аймгийг дагуулжээ. Тэгээд цааш Хиргисийн нутагт ороход Хиргисийн ноёд Эди, Инал, Алдизэр, Өлэбэг-Тегин Зүчийг даган орж бэлэг сэлт барин угтжээ. Зүчи жанжин Шибир, Хэсдин, Баяд, Тухас, Тэнлиг, Таолс, Тас зэрэг Баягидаас нааших ойн иргэнийг эзэлж дагуулаад Хиргисийн түмт мянганы ноёд, ойн иргэний ноёдыг дагуулан ирэхэд тэд их хаанд цагаан шонхрууд, цагаан морьд, хар булгануудаа бэлэглэн уулзалдсан аж.

Чингис хаан ихэд баясан угтаж, Худуга бэхийн хөвгүүн Иналчид Чичэхэн охиноо, ах Төрэлчид нь Зүчийн охин Олуйханыг, Алага-бэхи охиныг Онгуудад гэргий болгон соёрхож, Зүчид ойн иргэнийг захирахыг зарлиглажээ. Үүний дараа Чингис хаан Борохул, Дөрбэй, Хорчи ноёдыг Хори Түмдэд явуулж эрхшээлдээ оруулжээ. Үүгээр Монгол туургатныг нэгтгэх үйл ажиллагаа бүрэн дууссан байна. Ийнхүү Алтайн сүрлэг уулсаас Их Хянганы нуруу хүртэл, Түмэн газрын цагаан хэрмээс умард зүгийн Байгаль далай хүртэлх уудам нутгийг эзэмдсэн Монголын нэгдсэн улс байгуулагдсан байна. Энэ улсыг түүхэнд “Монголын нэгдсэн улс”, “Феодалын нэгдсэн улс”, “Их Монгол улс”, “Монголын төвлөрсөн улс”, “Монголын тулгар улс” хэмээн янз бүрээр бичин тэмдэглэсэн нь өөр өөрийн өвөрмөц тайлбар бүхий ажээ.

XIII зууны эхээр Монгол аймаг, ханлигуудыг нэгтгэж нэгэн хүчирхэг улсыг байгуулсан нь дүр төрх, шинж байдлаараа Монгол түмэн нэгдсэн улс байжээ.

Иймээс Монголын нэгдсэн улс хэмээн нэрлэх нь улс төр, хууль зүйн утгаараа тухайн бодит байдалд илүү нийцэж түүнийг бүрнээ тусган илэрхийлсэн бөлгөө.

Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь Монголын нийгмийн хөгжлийг Ази Европын олон улс орны соёл иргэншлийн ололт, жишээгээр түргэсгэн, шинэ түвшинд гаргаж, монголчуудын дотоод хямрал, бутралыг эцэс болгон, үндэсний сэргэн мандалт, тусгаар тогтнолын баталгааг хангасан түүхэн ач холбогдолтой байжээ. Энэ тухай “Монголын нэгдсэн улс тогтнон мандсан нь нийт Монголын ард түмний түүхэнд чухал ач холбогдолтой, түүхэн дэвшилт үзэгдэл мөн байлаа.

Монгол улс байгуулагдсанаар монголын нийгмийн дэвшил хөгжилд ихээхэн саад тотгор болж байсан овог, аймгуудын хоорондын удаан хугацааны тасралтгүй дайн дажин намдаж, салангид тасархай байдал эцэс болж, улмаар Монгол аймгууд нэгэн угсааны ард түмэн болон бүрэлдэх нөхцлийг буй болгожээ” /57.103/ хэмээн 2003 онд хэвлэгдсэн Монгол улсын түүхэнд бичжээ.

Монголын нэгдсэн улс байгуулагдсанаар Монголчуудын сэргэн мандалтын шинэ үе эхэлж, монгол оронд цоо шинэ улс төр, нийгэм, эдийн засаг, хууль зүйн тогтолцоо бүрэлдэн тогтоход хүргэсэн ажээ. Монголын нэгдсэн улс байгуулагдсан нь дэлхийн хүчний харьцааны тэнцвэрт ихээхэн өөрчлөлт оруулсан төдийгүй өрнө, дорнын хооронд соёл иргэншлийн шинэ харилцаа хөгжиж, түүний ололт амжилт харилцан нэвтрэхэд ихээхэн нөлөө үзүүлж, Төв Азийн нүүдэлчин ард түмний түүхэнд гүйцэтгэх үүрэг ролийг үлэмж өргөн мандуулсан болой.

§4. Монголын нэгдсэн улсын дотоод бодлого

Монголын Нэгдсэн улсын хэмжээнд явуулах дотоод бодлого цоо шинээр боловсрогдон хэрэгжсэн ажээ. Чингис хаан Монголчуудын улс төр, аж ахуй, соёлын өмнөх уламжлал хийгээд өөрийн засаглалын үеийн өвгөд өтгөс, алтан ургийнхан, сайд жанжин, ноёд түшмэд, эрдэмт хүмүүсийн сургаал, зөвлөгөө, тухайн үеийнхээ түүхэн нөхцөл байдал, их улсынхаа ирээдүйн төлөв төрхийг тунгааж, бодон бодон ихээхэн цэгцтэй дотоод бодлого боловсруулж, түүнээ хэрэгжүүлэхэд бүх үйл ажиллагаагаа чиглүүлсэн ажээ. Чингис хаан Монгол улсад нийгэм, эдийн засаг, төр, хууль цаазын цоо шинэ тогтолцоо бүрэлдүүлэн тогтоох явдлыг дотоод улс төрийн бодлогынхоо гол зорилт болгожээ. Эл зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор Монгол оронд тогтоох төрийнхөө хэлбэрийг тодорхойлж, засаг захиргаа-нутаг дэвсгэрийн шинэ хуваарийг бий болгож, төрийн байгууллагын шинэ тогтолцоо, түшмэдийн шинэ ёсыг бүрэлдүүлж, нэгдмэл хууль цаазыг батлан, нарийн чанд хууль ёс, дэг журмыг тогтоосон байна.

Эдгээр арга хэмжээ нь Монголын нэгдсэн улс төр хүчтэй, тогтвортой байх нөхцлийг хангахын баталгаа байсан бөлгөө. Энэ талаар төрийн байгуулал, эрх зүй гэсэн бүлгүүдэд тодорхой өгүүлэх болно. Нэгдсэн төрийн бодлогоор Монголын бүх газар нутаг улсын өмчид байсан бөгөөд түүний дээд өмчлөгч нь Чингис хаан байжээ. Их хаан улсын газар нутгийг 3 төрөл зүйл дээр хуваан эзэмшүүлэх бодлого явуулсан байна. Мянгат бүрт газар нутаг хуваарилан эзэмшүүлсэн нь мянгатын нутаг хэмээн нэрлэгдсэн аж. Монголын нууц товчоонд дурдсанаар шинээр 95 мянгат байгуулж, тус бүрд нь нутаг хуваарилан олгосон байдаг. Мянгатын ноёд нь мянганы газар нутгийг мэдэж, бэлчээр, нутгийг эзэмшиж өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн хэлбэрээр хуваарилан эзэмшүүлж байсан байна.

Мянгатын иргэд уул мянганы нутаг бэлчээрийг эрхэлж буй нүүдлийн мал аж ахуйн онцлогоос шалтгаалан “нийтээрээ ашиглан” эзэмшиж байв.

Монголын нэгдсэн улсад зарим язгуурын хүмүүс “дархалсан нутаг” эзэмшиж байсан аж. Чингис хаан төрд их гавъяа байгуулсан Сорхон Шар, Хорчи, Ильжигэдэй ноён зэрэг язгууртнуудад тухайлсан газар нутгийг үе удмаар нь эзэмшүүлэхээр дархлан олгосон байдаг. Үүнийг түүхэнд “дархалсан нутаг” хэмээн нэрлэсэн аж. Энэ нь эл үеийн газар эзэмшлийн бие даасан нэгэн хэлбэр байжээ. “Дархалсан нутаг”²⁴ эзэмшиж байгаа ноёд нь уул газар нутгийг оршин суугч иргэдийн хамтаар харъяалан мэдэж, эзэмших, ашиглах, иргэдэд хуваарилан ашиглуулах бүрэн эрхтэй байжээ.

Эдгээр дархалсан газар нутгийн эзэд нь уул газраа үе улиран эзэмшиж, тэрхүү газарт оршин суугчид нь улсын алба үүргээс чөлөөлөгдөж, зөвхөн эзэн ноёндоо алба татвар төлдөг байсан аж. Чингис хаан алтан ургийн зарим язгууртнуудад тодорхой өрх иргэн, газар нутгийг зарлиглан олгосон нь түүхнээ “соёрхлын газар”²⁵ хэмээн нэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл эзэн хаан зарим ноёд язгууртанд тодорхой газар нутгийг соёрхон олгож эзэмшүүлж байжээ. “Монголын нууц товчоо”-нд дурдсанаас үзэхэд Чингис хаан Өүэлэн эх, Отчигин хоёрт нэг түмэн иргэн /түмэн өрх/, Зүчид есөн мянга, Цагаадайд найман мянга, Өгөдөйд таван мянга, Тулуйд таван мянга, Хавт Хасарт дөрвөн мянга, Алчидайд хоёр мянга, Бэлгүтэйд мянга таван зуун иргэн /өрх/, Шихихутугт суурьшмал нутгийн иргэдийг соёрхон өгчээ /51.210, 211/. Мөн тулалдаанд амь үрэгдсэн цэргийн жанжин Хуйлдар эцэн, Борохул жанжин нарын эхнэр, хөвгүүдэд 100 өрх иргэд соёрхон олгосон байдаг /51.210/. Соёрхлын газар бол дээрхи язгууртнуудад үүрд эзэмшил болгон олгосон газар бөгөөд түүн дээр оршин суугчид нь зөвхөн эзэндээ захирагдаж, алба татвар төлөх үүрэгтэй байсан байна.

Монголын нэгдсэн улсын газрын харилцаа, газрын өмчлөл, эзэмшил, ашиглалтын байдлыг судлан үзэхэд хэд хэдэн язгуур онцлог илэрдэг бөлгөө. Үүнд:

Нэгдүгээрт, эл үеийн Монгол орон дахь газар эзэмшил нь нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг малчин түмний амьдралын хэв маягийн шинж байдлаар тодорхойлогдож, газрыг малын бэлчээрийн хэлбэрээр эзэмшин, ашиглах бодит шаардлагатай амин холбоотой байжээ. Энэ нь Европ, Азийн улс оронд зөвхөн тариа, ногоо тариалах “хирчээс газар” /тодорхой бага хэмжээний газар/ авч өмчлөн эзэмшихээс зарчмын ялгаатай байв. Малын бэлчээр нь мал сүрэг жилийн дөрвөн улиралд бэлчээрлэн, өвс ургамал идэж, хужир шүү долоож, усны тунгалагийг уун, цасны сайхныг идэж, тал хээр, уул тайга дамжин сүрэглэн явдаг учир ихээхэн хэмжээтэй нутгийг эзэлдэг онцлогтой байжээ. Тийм учраас хувийн хатуу өмч хэмээн тооцож нарийвчлан өмчлөх шаардлага бага, харин “нийтээрээ эзэмших, ашиглах” хэрэгцээ зайлшгүй хэрэгтэй байсан аж.

Хоёрдугаарт, Газрыг өмчлөгч нь хаан байсан аж. Эзэн хаан түмтийн нутгийн хил хязгаарыг тогтоож, мянгат бүхэнд нутаг хуваарилан олгож, энэ утгаараа газрыг улсын нэрийн өмнөөс дээд эзэмшигч нь болж байв. Мянгатын ноёд хаанаас тогтоон олгосон нутгийг өмчлөн захирна. Тэгэхдээ тэд дундад зууны үеийн газрын эзэд шиг төвлөрсөн тодорхой газар өмчлөгч бус харин мянгатын ихээхэн газар нутгийг мэдэн захирч, малчин нүүдэлчин иргэдийн мал сүргээ маллахад нь зориулан бэлчээр нутгийг хуваарилан олгох, өвөлжөө, хаваржаа, намаржаа, зусах газрыг зааж өгөх зэргээр өргөн утгаар нь эзэмшиж байсан онцлогтой.

Гуравдугаарт, Чингис хаан хэдийгээр алтан ургийн ноёд, зарим язгууртанд “дархалсан”, “соёрхсон” газар нутаг, өрх, иргэн зарлиглан олгож, үүрд эзэмшүүлж байсан боловч тэдгээр ноёд нь бүгд мянгатын ноёд байсан онцлог бий. Тэд нэг талаас мянганы ноён, нөгөө талаас дархалсан, соёрхсон газар эзэмшигчийн хувиар газар нутагтай харилцаж, мөн л нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд зориулан эл газар нутгаа ашиглаж, эзэмшиж байжээ.

Дөрөвдүгээрт, Мянгатын ноёд, дархалсан, соёрхсон газар эзэмшигчийн өмчийн эзэн эрхийг төрийн хуулиар баталгаажуулсан нь зохион байгуулалт-хууль зүйн шинжтэй байсан ажээ. Энэ нь хуваарилан олгосон газар нутгийг бусдад дур зоргоор шилжүүлэх, хуваарилан олгосон нутгаа дур мэдэн орхиж явах, эзэн ноёноо хаяж нүүхийг хуулиар хориглож байснаар тодорхойлогдоно. Мянгатын ноёны эрх “мянгатын газар нутгийг хариуцан мэдэж захиран баримтлах, сонгон нутаглах, хуваарилан зохицуулах, мянганыхаа хил заагт болсон нутгийн хэрэг явдлыг таслан барагдуулах эрхээр илэрч байсан” /20.248/ нь газар өмчлөгчийн бус харин мянгатыг захирагч ноёны эрх үүрэг зонхилж байсныг харуулж байна.

Тавдугаарт, мянгатын газар нутгийг эзэмших, ашиглах нь зөвхөн бэлчээр нутгийг хамрах төдийгүй уг нутагт мал сүргээ маллах, оршин буй уул, ус, ургамал, ой модыг ашиглах, ан амьтдыг агнах, тэдгээрийг үржүүлэх, өсгөх, хайрлах, хамгаалах, хадлан бэлтгэх, тариа тарих болон шүтэж бишрэх, тахиж хүндэтгэх зэргийг мөн адил хамарч байсан учир суурьшмал оронд газрыг өмчилж байснаас ихээхэн ялгаатай байсан ажээ.

Зургаадугаарт, газар нутгийг өмчилж, эзэмшиж, ашиглах нь мал сүргийг өмчлөх, түүнийг маллах, амьдралын гол хэрэгсэл байлгах үйл ажиллагаатай амин холбоотой агаад хоорондоо салшгүй нэгдмэл бөгөөд нэг юмны хоёр тал байсан ажгуу. Мал сүрэг байхгүй бол бэлчээр нутаг байхгүй. Бэлчээр нутаг байхгүй бол мал сүрэг байхгүй хэмээхэд дээрхи амин холбооны утга учир оршино. Чингэхээр газар, мал сүрэг хамтдаа Монгол орны эдийн засаг, үйлдвэрлэлийн хэрэгслийн агуулга, шинж чанарыг тодорхойлж байжээ.

Энэ тухай Монгол улсын түүхийн тулгар зохиолд “Газар бэлчээрийг үйлдвэрлэлийн гол хэрэгсэл хэмээн үзэх боловч нүүдэлчдийн гол амь зуулга болж байсан малыг үйлдвэрлэлийн чухал хэрэгсэлд мөн оруулан тооцох нь зүйтэй бөгөөд Монголын нөхцөлд харъяат ардаас татвар авах эрх мэдэл нь гагцхүү малын бэлчээрийг эзэмшин мэдэх явдалд орших төдийгүй, харин тэр нь түүний өмчлөлд байсан олон тооны мал сүрэгтэй бас хосолсноор сая хүчин төгөлдөр болж байжээ” /57.100/ гэж тодорхойлон бичжээ. Нэгэнт газар бэлчээр нь улсын хааны өмчлөлд байсан учир газрын рент, улсын татвар хоёр харилцан нийлж нэгэн зүйл болж байжээ /57.100/. Эдгээр нь газар, мал сүрэгтэй харилцах, тэдгээрийг өмчлөх, эзэмших, ашиглах, алба гувчуур оноох, авах, нийгмийн давхраа, бүлгийг тогтоон тодорхойлох үндэслэл болж тэдгээрийн оршин ахуйн бодит үндэслэл болж байсан ажгуу.

Монгол орны газрын харилцааны түүхэн асуудлыг хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор О.Амархүү нэлээд үндэслэлтэй судлан шинжлээд “Монголд эртнээс нааш газар улсын өмч байсан ... газрын харилцааны төрийн ерөнхий удирдлага нь эзэн ханад байсан... Монголын төрийн хөгжлийн түүхэн бүх үеийн туршид газрыг байгалийн бусад баялгийнх нтэ хамт зөвхөн төр /хаан/ өмчилж, нүүдэлчин ардууд, ноёд, язгууртнууд эзэмшин ашиглаж ирсэн нь уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц хэлбэр гэж үзэх үндэслэлтэй” /4.55-69/ гэж бичсэн нь зохистой дүгнэлт мөн.

Газар, мал сүргийн өмчлөлтэй холбоотойгоор нийгэмд өвөрмөц давхраа, бүлгүүд бүрэлдэн бий болсон байна. Эл үед “Монголын нийгэм нь феодал, язгууртны, малчин ардын гэсэн үндсэн хоёр давхраанаас бүрэлдэж байжээ /57.98/. Язгууртны давхраанд Чингис тэргүүтэй боржигон овгийн төрөл, төрөгсөд, түмт, мянгат, зуутын ноёд багтаж байв. Язгууртны давхраанд мянгатын ноёдууд томоохон байр эзэлж байжээ. Мянгатын ноёд нь дотроо зэрэг дэв, нийгэмд эзлэх байр, эрх мэдлээрээ харилцан адилгүй байжээ. Зарим мянгатын ноёд есөн удаагийн ялаас хэлтрэх, их хаанд дуртай цагтаа бараалхах, дархалсан тусгай нутаг эзэмших, дайн, авын олзоо хэнтэй ч хуваалцахгүй авах зэрэг дархан эрхтэй байхад үлдсэн нь зөвхөн мянгатаа захирахаас өөр эрхгүй байсан аж.

Малчин ардын давхраанд түмт, мянгат, зуутад бүртгэгдсэн бүх иргэд, боржигон овгийн ноёд, язгууртны харъяат иргэд багтаж байсан аж. Улсын буюу мянгатын иргэд “цэрэгт мордох, хааны санд алба төлөх, сүрэг малыг нь адуулах, ав хөмрөгөд оролцох, төрийн Их Хуралдайн бүх зардлыг хариуцан гаргах, олон замын уургын улаа, элчин харилцааг дамжуулан залгуулах зэрэг /57.98/” улсын чанартай алба үүргийг дагнан гүйцэтгэж байсан бол ноёдын харъяат иргэд нь аравтлах системд хамаарагддаггүй, улсын алба үүргийг гүйцэтгэдэггүй бөгөөд гагцхүү эзэн дээдэстээ үйлчилдэг байсан ажээ. Монголын нууц товчоонд дурдагдсан “эсгийн туургатан” нь хээр талын малчид, “хавтсан үүдтэн” нь суурьшмал иргэд байсан боловч “харъяатан” иргэдэд зөвхөн

дайны олзны хүмүүс, боол, шивэгчин, гэрийн зарц хамаарна гэж үзэж болохгүй харин мал хөрөнгөтэй иргэд бас багтаж байсан ажээ.

Газар нутаг, малын өмчлөл, хүн амын давхрааг бүрэлдүүлэх, тэдэнтэй харилцах харилцаа нь Чингис хаан, түүний төрөөс явуулах дотоод бодлогын гол үндэслэл болж байсан ажгуу.

Монголын нэгдсэн улсын төр, улсын нутаг дэвсгэрийн хилийг тогтоож, түмт, мянгатуудад нутаг хуваарилан олгож, улмаар тэдэнд өөрийн нутаг дэвсгэр дээрх газар шороо, бэлчээр, ус, ургамал, амьтдыг ашиглах, хамгаалах эрх үүрэг оногдуулж, өөрийн бодлогоороо хүчтэй зохицуулалт хийж байжээ. Бэлчээрийг зөв зохистой хуваарилах, ашиглахад өмнөх уламжлал, заншлаа зүй зохистой ашигласан байна. Төрийнхөө бодлогоор аравтуудад ихээхэн өндөр үүрэг хариуцлага хүлээлгэж байжээ. Нүүдэл суудал зохицуулах, ан ав хийх, мал сүргээ маллах, зуд бэрхшээлийг давах, үр хүүхдээ өсгөх, өтгөс өвгөдөө асрах, эзэд ноёддоо үйлчлэх, аж амьдралаа төвхнүүлэх, арилжаа хийх, гар үйлдвэрлэл явуулах, алба гувчуур төлөх, байгаль орчин тойрноо хамгаалах, хүндэтгэн хайрлах бүхий л үйл эцсийн эцэст чухамдаа аравт дээр явагдаж байлаа.

Амьтны үр, төлийг устгах, ургамлын үндсийг таслах, газар шороог сэндчих, нүхлэх, ус булгийг бохирдуулах, ан амьтныг түйвээх зэргийг төрөөс хориглон хамгаалж байжээ. Мал сүргээ өсгөхийг тусалж дэмжихийн хамт хайрлан хамгаалахыг чухалчилж байв. Малыг цохиж нүдэх, ялангуяа морины толгой, нүдрүү цохих, хулгайлахыг гэмт үйлдэл хэмээн үзэж байсан аж. Нэгдсэн улсын үед адуун сүргийг үржүүлэх, хамгаалах, хайрлан хүндэтгэхэд ихээхэн анхаарал тавьж байв. Учир нь адуун сүрэг айл өрх бүрийн гол уналга, цэрэг байлдааны үндсэн унаа, мэдээлэл харилцааны хамгийн хурдан “хөлөг” болж байсан бөлгөө.

Нэгдсэн улсын төр, ан ав хийх, гэрийн үйлдвэрлэл явуулах, гар урлал эрхлэх, арилжаа худалдаа хийхийг дэмжих бодлого баримталж байсан аж. Өрх, иргэдээс малаа маллахын зэрэгцээгээр ан хийх нь тэдний аж ахуйн нэгэн салаа салбар, аж төрж амьдрахын чухал хүчин зүйл байсан байна. Ан хийж махыг нь идэн, үс, арьсыг нь хувцас хунар, дэр дэвсгэр хийж, арилжаа худалдаанд хэрэглэдэг байсан бөгөөд энэ нь тэдний хэвийн амьдралд ихээхэн тус нэмэр болж, мал сүргээ өсгөн үржүүлэхэд нь багагүй нөлөөлдөг байжээ. Тийм ч учраас ан хийх явдал иргэдийн аж амьдралд зайлшгүй хэрэгтэй байсан болой.

Нүүдэлчин малчдын амьдралын хэв маягтай холбоотойгоор гэр, ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэтгэн дэмжих нь төрийн бодлогын салшгүй хэсэг байжээ. Ийм үйлдвэрлэлийн гол зорилго нь гэр сууцныхаа хана, тооно, унь, үүд хаалга, багана, өрх, дээвэр, туурга, эсгий дэвсгэр, оосор бүслүүр, малын эмээл хазаар, ногт, чөдөр, тохош, бурантаг, буйл, хом, уурга, зэл, аргамжаа, тэрэг тэргэнцэр, гэрийн авдар, шүүгээ,

ор, дэвсгэр, тулга, хайч, аяга, таваг, сав суулга, тогоо, шанага, хөхүүр, шүүр, хүний дээл, тэрлэг, цамц, хантааз, цув, өмд, малгай, гутал, ороолт мэт хувцас хунар, сүү саалиар тараг, айраг, өрөм, тос, ааруул, эзгий, хурууд, бяслаг, ангийн тор, хавх, сааль, цохиур, хутга гэх мэтийг үйлдэн хийж хэрэглэх явдал байсан аж. Гэр ахуйн үйлдвэрлэл нь айл өрх бүрийг хамран, байнга тасралтгүй явагдаж нүүдэлчин түмний өдөр тутмын амьдралын зайлшгүй хэрэгцээг хангаж, хэвийн аж төрж амьдрах нөхцлийг бүрдүүлж байсан болой. Жишээлбэл “Монголчууд хоол ундны оронд айргийг тун их хэрэглэж түүнийг идээний дээж гэж эрхэмлэдэг заншилтай байжээ. Нэг ч найр хурим айраггүй өнгөрөх ёсгүй байжээ” /57.329/.

Монголд гар урлалыг хөгжүүлэхэд төрийн бодлого чиглэгдэж байжээ. Хаад ноёдын ордон өргөөг барих, цэргийн зэр Зэвсэг, хэрэглэл сэлтийг үйлдвэрлэх, ихэс дээдэс, язгууртан ноёд иргэдийн гоёл чимэглэлийн зүйлсийг хийх нь гар урлалын салбарын гол зорилт байжээ.

Гар урлалын оргил нь гэр орд буюу “Алтан тэрэм”, “гэр тэрэг” байсан бололтой, “Алтан тэрэм” нь хэдэн зуу, мянган хүн багтах, гоёмсогоор засаж чимэглэсэн асар том эсгий гэр байжээ. Харин гэр-тэрэг бол тусгай том тавцан бүхий тэргэн дээр буулгадаггүйгээр барьж бэхэлсэн замд явах ба суурин газарт байж байхад тохиромжтой асар том гэр, гоёмсог, тохилог “гэр-сууц” болно. Хаад, ноёд “орд-гэр-тэрэг” хэмээн тэргэн дээр бэхэлсэн асар том гэр хэрэглэж байжээ. Нэрт жуулчин П.Карпини, Г.Рубрук нарын тэмдэглэлд бичсэнээр зарим Орд-Гэр-Тэрэг нь өргөөшөө 30 фут, дугуйн хоорондох зай нь 20 фут бөгөөд дээр нь байгаа гэр нь хоёр хажуугаараа 5 фут үхэр тэргэнээсээ илүү гарч түүнд 22 үхэр хөллөдөг байсан ажээ /18.91/.

Төрийн бэлгэдэл, ёс... ёслолын хэрэгсэл, ихэс дээдэс, ноёд язгууртны хэрэглэдэг гоёл чимэглэлийн зүйлс нь Монголчуудын гар урлалын ховор нандин бүтээлүүд байсан аж. Монголын нэгдсэн улсын төрийн хаш тамга, есөн хөхөлт цагаан туг, дөрвөн хөхөлт хар туг, их гэрэгэ, их хааны Хуралдайн ордон, орд-гэр-тэрэг, хүндэтгэлийн суудал, хаан, хатны малгай, өмсгөл, ихэс дээдсийн малгай хувцас, зэрэглэлийн бэлэг тэмдэг, зүүлт, бөгж, аяга, алтан, мөнгөн эд хэрэглэл, ёс ёслолын гоёл чимэглэл эл бүхэн Монгол дархад, алтан гартнуудын эрхэм хосгүй бүтээлүүд байсан бөлгөө. Хар хорум хот зэрэг археологийн малтлагаас олдсон “хээ цохиж чимэглэсэн хүрэл сав, мөнгөн сав суулга, морины хэрэгсэл, хүрэл толь зэрэг нь Монголын дархчуудын ур чадварыг гэрчилнэ” /57.335/

Монголын нэгдсэн улсад цэргийн Зэвсэг, техник үйлдвэрлэл нь төрийн дотоод бодлогын нэг гол чиглэл болж байжээ. Цэргийн Зэвсэг техникийг сонгох, түүнийг үйлдвэрлэх, хэрэглэх нь хааны бодлогоор тодорхойлогдсон нарийн үйл ажиллагаа байжээ.

Үүнд цэргийн жанжнууд, монгол дарханууд, гар урчууд, эзлэгдсэн орны дархан, гар урчууд, мэргэжсэн эрдэм ухаан, ур чадвартай хүмүүсийг өргөн оролцуулж байсан аж. Нум, сум, дуут сум, жад, сэлэм, хөө хуяг, дуулга, шийдэм бороохой, сүх, дэгээ, хөвчит нум, харвах, шидэх оньс, дүүгүүр, дарь, шатаах хэрэгсэл, чулуун сум, чулуу шидэх машин, гал харвах нумт буу, хана нэвтлэх буу, хөвөх тулам зэргийг байнгын хүн хүч, цаг хугацаа, үйл ажиллагаа зарцуулан үйлдвэрлэж байжээ. Цэргийн зэр Зэбсэг үйлдвэрлэх нь ур ухаан, эрдэм чадал, эр зориг, эрмүүн үйл ажиллагаа шаардаж улам бүр өргөжин, улам өндөр зохион байгуулалттай болж байсан ажгуу. Монголын нэгдсэн улсад эе эвийг хичээх, өндөр дэг журамтай байх, их хаанаа тойрон нягтрах, эзэнт төрөө дээдлэн хүндэтгэх нь төрийн бодлогын бас нэгэн чухал үндэс байсан бөлгөө. Монгол туургатныг нэгэн нэгдмэл цул хүчин болгон хувиргаж, Монгол үндэстнийг бүрэлдүүлсэн нь нэгдсэн улсын аугаа том амжилт мөн байжээ. Монгол угсаатны зан заншлыг тэднийг нэгдэж нягтрах дотоод сэтгэлийн нандин хүчин зүйлс болгож, нэгэн чигт хөхүүлэн дэмжжээ. Эх нутаг, газар шороо, уул ус, ой тайга, мал сүрэг, амьтан ургамлаа хайрлан бахархах, тахин шүтэх нь угсаа дээд, доод ялгалгүй бүх л монгол хүмүүний нийтлэг заншил болон зангилагдсан ажгуу.

Эл заншлаас гажих нь монгол туургатан хүн бүрийн аж төрөх амьдрах эрхэм хүслэн, утга учирт эрс харшилна хэмээн итгэх итгэлийг бүрдүүлсэн болой.

Чингис хаан бөө мөргөлийг Монгол туургатны шашин хэвээр нь байлган өөрөөсөө эхлэн бишрэн шүтэж байсан нь Монгол угсаатан бүрэлдэхэд ихээхэн нөлөөлсөн буйзаа. Мөнх тэнгэр хэмээх аугаа хүчин монголчуудыг “ивээж” удам угсаа, хүч чадал, амь нас, аж амьдрал “олгож” байсанд итгэсэн их сүсэг бишрэл монгол түмэнд нийтлэг хүчин зүйл болон үйлчилсэн ажээ. Чингис хаанаас Бурхан Халдун уулыг тахиж, түүнд сүсэглэн мөргөж, гуйж тангаргалаж байсан үйлдэл, их хааныг мөнх тэнгэрээс илгээсэн түүний элч хэмээн сүсэглэж байсан бишрэл болон монгол түмэнд түгэж домогшсон нь монгол угсаатны бүрэлдэхэд мөн л их нөлөө үзүүлсэн нь магад.

Академич Ш.Нацагдорж “Чингисийн шашны хувьд баримталж байсан байр суурь нь Дундад эртний хаадын шашин бүрд адил бус хандаж нэгийг дотночлон, нөгөөг хавчин гадуурхах бодлого явуулж, улсын доторхи янз бүрийн шүтлэгтэй ард түмнийг хооронд нь хямралдуулж байсан ухвар мөчид явдалтай жишээлэн үзэхэд ихээхэн холч ухаалаг бодлого байжээ” /62.193/ хэмээн онож бичсэн байна.

Чингисийн төрийн бодлогоор бүх шашныг адил хэмжээнд хүндэтгэж, ямарч шүтлэгтэнтэй ялгаварлахгүй харилцаж байсан явдал эе эвийг хангах, нэгдсэн улсыг бэхжүүлэх, нэр хүндийг нь өргөхөд томоохон хүчин зүйл болон үйлчилжээ. Монголын нэгдсэн улс дотоод бодлогынхоо хүрээнд алба гувчуур авах, олз ашиг олох, иргэд, цэрэг эрсээ асрах, төр, цэргийн албанд дайчлах ажлыг зохион явуулсан бөлгөө.

Монгол оронд татвар авах эрх мэдэл нь бэлчээр нутаг, мал сүрэг хоёр иргэний өмч болон хосолж байсан нөхцөлд тохирч, татварыг малаар авах, харъяат иргэдийг албанд биеэр ажиллуулах, төр ба эзэн ноёнд мал, ангийн ашиг, бүтээгдэхүүнийг гувчуурлан авах явдлаар хэрэгжиж байжээ. Чингис хааны үед “Монголын нууц товчоо”-нд “Бидний хэмлэсэн хэм” хэмээн тогтоосон татварын хэм хэмжээ байсан боловч татварыг малаар тогтмол авах тодорхой тоо хэмжээг заагаагүй бөлгөө. Гэвч цэргийн албанд явах хэн боловч 1-5 морь авч ирэх, зохих хэмжээний малыг цэргийн хүнсэнд нийлүүлэх үүрэгтэй байсан байна. Энэ нь гол төлөв цэрэг, байлдааны нөхцөлд амьдарч байсан Монголчуудад нэгэн төрлийн малаараа алба төлөх хэлбэр байсан байж болох юм.

Мянгатын иргэд мянганы ноёд, язгууртанд, ихэс дээдэс, ноёдын албатууд өөрийн эзэнд биеэрээ ажиллаж, бүтээгдэхүүн өгч /нүүлгэх, малыг нь маллах, үс ноосыг нь авах, идэш тэжээлийг хийх, сүү саалийг нь боловсруулах гэх мэт/ алба төлж байжээ.

Мянгатын иргэд төрийн Их Хуралдайн зардлыг /Хуралдайн ордон босгох, хүнснийх нь хэрэгцээнд зориулж мал, мах, айраг, сүү, тос, ааруул, өрөм, сархад нийлүүлэх гэх мэт/ гаргаж байсан нь нэгэн төрлийн алба байсан аж. Байлдан эзэлсэн улс орныхоо иргэдээс олзолсон урчуудыг монголд хүчлэн авчирч, гар урлал, орд барилгад ажиллуулах, алт, мөнгө, эрдэнэсийн чулуу, гоёл чимэглэлийн зүйлс, үнэт эдлэл хэрэглэлийг хураан авч монголд аваачин төрийн санд нийлүүлж, ихэс дээдэст хуваарилан олгож байсан бөгөөд үүнийг хүчлэн авсан бас нэгэн төрлийн алба татаас хэмээн үзэж болох юм. Чингис хаан “асрах сан” байгуулж түүнд хуримтлагдсан эд хөрөнгө, баялагаас өтгөс дээдэс, дайнд тахир дутуу болсон хүмүүс, өнчин нялхаст олгож байжээ. Цэргийн жанжин хан хөвгүүд, түмт мянгатын ноёд аян байлдаанд ялж олсон олз бүрээсээ Их хаанд хувь хүртээх үүрэгтэй байж түүнээ заавал биеэрээ хүлээлгэн өгч байсныг хаан өөрийн болон, төрийн санд нийлүүлэн зарж байв. Үүнийг тухайн нөхцөлдөө өмчийг бүрдүүлэх, хуваарилах нэгэн зүйл хэлбэр байсан гэж үзэж болохуй. Монголын нэгдсэн улсын хаан шуудан өртөөний талаар тууштай бодлого явуулжээ. Олон үеийн турш говь нутгийн овог, аймгууд аливаа хэл мэдээг морьтой элчээс нэг хотноос нөгөөд дамжуулдаг байсан уламжлалд түшиглэн өртөөний бодлого боловсруулж хэрэгжүүлжээ. Чингис хаан юуны өмнө цэрэг, байлдааны үйл ажиллагаанд зориулан байнгын дамжуулан өнгөрөөх өртөөг байгуулсан байна. Английн түүхч Гарольд Лэмбэ “Дэлхийн эзэн Чингис хаан” номондоо Чингис хааны байгуулсан өртөөний тухай нэлээд тодорхой өгүүлсэн болой.

Их хаан баруун чиглэлд аян дайн явуулах явцдаа аян байлдааны газраас Хар хорин хүртэлх замд нэг суурь нь /агуулах, гэрүүд/ 100 орчим миль зайтайгаар орших өртөөнүүдийг байгуулсан байна.

Чингисийн Хар хорин хүртэл байгуулсан бүх өртөө буудлуудад 300000 агт морь, 10000 гаруй гэр, байр сав байрлуулсан байжээ /17.136,137/. “Хаан арван өртөө явах зайтай газраас өгүүлсэн мэдээг өдөр шөнө хоёр давхисан морьтноор дамжуулан үтэр түргэн хүлээж авдаг байсан байна” /17.137/. Ганцхан өдрийн дотор 200 юм уу, 250 миль газрыг, бас шөнө нь мөн төдий хэрийн газрыг онцгой шаардлагын улмаас туулсан хүмүүс эдгээр өртөө буудлууд дээр тааралддаг байсан хэмээн арай хэтрүүлэн бичсэн нь бий. Өртөөгөөр хааны буухиа элч мэдээ хүргэгч, цэргийн жанжин, ноёд, худалдаачид, лам, татвар, албаны эд зүйлс хүргэгчид, урчууд зэрэг хүмүүс тасралтгүй зорчдог байжээ. Буухиа элч нар өртөөн дээр ирмэгц эмээл, хазаартай бэлэн зогсож байгаа морийг сэлгээ морины хамт шууд аван давхих бөгөөд дараагийн өртөөний хүмүүс хонхны дуу сонсмогц солих морийг нь бэлтгээд зогсож байдаг байжээ. Буухиа элчийн аян зам туулах хурд үнэхээр гайхамшигтай байв /17.137/ гэж Гарольд Дэмбэ бичжээ. Өртөөний замаар тэмээн жингийн цуваа тасралтгүй хөвөрнө. Худалдаачид бөс бараа, эд агуурсаа ачин байнга аялна.

Монгол соёлыг дэлгэрүүлэх, Ази, Европын соёлыг харилцан нэвтрүүлэх, төрийн бичиг үсэгтэй болох, Монголчуудын мэдлэг ухааныг дээшлүүлэх, утга зохиолыг хөгжүүлэх, үүндээ бусад орны эрдэмтэн мэргэдийн хүч оюуныг зохистой ашиглах нь нэгдсэн улсын дотоод бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан ажгуу.

Чингис хаан Хятадын гүн ухаантан Елюй Чуцайг²⁶ төрийн сайдаар, Уйгурын Тататунгааг²⁷ төрийн бичгийн сайдаар, Чингайг²⁸ их сайдаар, Ха-Лай-И-Ха-Чи Пэй Луг²⁹ хан хөвгүүдийн бичгийн багшаар, Ле-Зун-Луг³⁰ хааны шадар бараа бологч эмчээр ажиллуулж, Хятадын гүн ухаантан Чанчунь бомботай³¹ уулзан эрдэм ухааны тухай зөвлөлдөж, хөвгүүд, шадар хүмүүстээ ном заалгаж байсан ажээ.

Их хаан өрнө дорнын эрдэм ухаантай хүмүүсийг төрдөө ажиллуулж, эрдэм ном заалгуулж байсны дээр өөрийн үндэсний эрдэмтэй ухаантай хүмүүсийг түшиглэж, тэдний сургаал зөвлөгөөг гүнээ анхаарч, өөрөө ч эрдэм ухаанд шамдан суралцаж байсан бөлгөө. Тийм учраас Чингисийн үед *ардын язгуур мэдлэг ухаан* /мал аж ахуйг эрхлэх, малаас гарах ашиг шимийг боловсруулах, нүүдэл суурьшилыг зохицуулах, ургамал, амьтныг танин мэдэх, аж амьдралаа жолоодох, аятай амьдралыг бүрдүүлэх, гэрийн үйлдвэрлэл явуулах гэх мэт/, *аж ахуйн эд хэрэгсэл, цэргийн Зэбсэг хийх мэдлэг ухаан, ур чадвар* /гэр ахуйн эд хэрэгсэл хийх, цагаан идээ боловсруулах, малын хэрэглэл үйлдвэрлэх, цэргийн зэр, Зэвсэг, техник зохиох, хийх, цэргийн урлаг боловсруулах гэх мэт/, *байгалийг хамгаалах, ан амьтныг үржүүлэх, агнах мэдлэг ухаан, эрдэс бодис олзворлох, ашиглах мэдлэг ухаан* /төмрийн орд газар олох, төмрийг хайлуулах, боловсруулах, нүүрс ашиглах, төмөр, зэс, алт, мөнгө, эрдэнийн чулууг олох, эдлэл хэрэгсэл, гоёл чимэглэлийн зүйлс хийх, гэх мэт/, *газар зүйн мэдлэг ухаан* /нутаг

ус, малын бэлчээрийг танин мэдэх, нэр алдар оноох, байгалийн үзэгдлийг шинжих, тайлах гэх мэт/, *ардын эмнэлэгийн мэдлэг ухаан* /төрөл бүрийн ургамлыг танин мэдэж эмнэлэгт хэрэглэх, Монгол эм хийх, ашиглах, мал, ангийн зарим эд эсийг эмчлэхэд ашиглах, бариа төөнүүр хэрэглэх гэх мэт/, *түүхэн мэдлэг ухаан* /овог, удам угсаагаа мэдэх, элэнц хуланц, эцэг өвгөд, аймаг, улсынхаа туулсан үүх түүхийг мэдэх гэх мэт/, *ардын үлгэр, домог, зохиол бүтээлийн тухай мэдлэг ухаан* /үлгэр, домог, аман зохиол дэлгэрэх, түүнийг дэмжих, шүлэг яруу найраг зохиогч төрөх, ном бүтээл туурвих гэх мэт./ /Чингисээс есөн өрлөгөө магтсан, есөн өрлөгөөс их хаандаа өргөсөн магтаалын шүлгүүд, өнчин хөвгүүний цэцэлсэн шастир, Чингисийг нас барахад Сөнөдийн яруу найрагч баатар жанжин Гилгүдэйн утга төгс яруу шүлэг, ардын дуу, бүжиг, хаант улсын төрийн дуулал, Монголын нууц товчоо, Их хааны тухай өргөн өгүүлсэн “Судрын чуулган” хэмээх алдарт бүтээлүүд зэрэг нь Монголын нэгдсэн улсын үеийн Соёлын үнэт сан хөмрөг мөн болой/, *төр, хууль цаазын мэдлэг ухаан* /”Их засаг” хууль, “Алтан дэвтэр”, Их хааны билэг сургаал, Чингисийн түмт, мянгатууд байгуулсан төрийн их заргач, түшээ түшмэдийг баталсан, газар нутаг хуваарилан олгосон, иргэн хүмүүний эрх үүргийг тогтоосон алдарт зарлигууд, төрийн нэгдмэл тогтолцоо бүрэлдсэн үйл явц гэх мэт/ дэлгэрсэн нь түүний төрийн бодлогын бодит үр дүн мөн байсан бөлгөө.

Монголын нэгдсэн улс, төрийн бичигтэй байсан нь түүний дотоод бодлогын нэг гол үр дүн мөн. Чингис хаан их бичгийн хүн Тататунгаагаар уйгур бичгийн үндсэн дээр Монгол бичиг зохиолгож улмаар улсын бичгийг буй болгосон ажээ. Чингэхдээ Чингис хаан эртний Монгол бичгийн хэлийг тэмдэглэж байсан уйгаржин үсгийг тэр хэвээр нь авч нийт Монгол улсын албан хэрэгцээнд авч хэрэглэсэн байна. Энэ тухай “Уйгур бичгийг авч хэрэглэсэн нь туйлын том дэвшил байв... Нүүдэлчид биеэ даасан өөрийн бичигтэй болох хэмээн өөрсдөө бичиг зохиох буюу бусдаас уламжлан авахыг олон үеийн турш оролдсоор ирсэн боловч гагцхүү монголчуудын оролдлого нь бусдаас илүү амжилттай бүтсэн” хэмээн Английн нэрт Монголч эрдэмтэн О.Латимор бичсэн байдаг бөлгөө.

§5. Монголын нэгдсэн улсын гадаад бодлого

Чингис хаан Монголын нэгдсэн улс, улсын хил хязгаарын аюулгүй байдлыг хангах, хөрш улс орны зүгээс учрах аюул, өнгөлзлөгийг арилгах, дорно, өрнийн улс орнуудын улс төр, эдийн засаг, соёлын харилцаа холбоог хөгжүүлэх, худалдаа, арилжааг өргөжүүлэх гадаад бодлого явуулжээ.

Чингис хаан юуны өмнө хөрш улс орны өнгөлзлөг, довтолгоон, дайсагналыг тас цохин арилгаж, улсынхаа аюулгүй байдлыг хангахад ихээхэн анхаарал тавьжээ. Учир юун хэмээбээс Монгол нутаг, хүн ам, хөрш улс орны довтолгоон, өнгөлзлөг, яс

хаях ажиллагаанд олон арван жилийн турш байнга өртөгдөж, асар их хохирол үзэж ирсэн тул үүнээс бүрмөсөн ангижрах нь зайлшгүй чухал болж, нэгдсэн улсын өмнө тулгарсан зорилт болон тавигджээ.

Тангудыг байлдан эзэлсэн нь. Монголын хөрш Тангуд улсыг Хятадын судар түүхэнд “Ся” /Ся улс/, “Да Ся”/Их Ся/ нэрлэн бичиж иржээ. Хожим нь Алтан улсаас салбарласан зүүн Ся улсаас ялгахын учир “Си Ся” /Баруун Ся/ хэмээн нэрлэсэн аж.

Тангуд улс³² 1032 онд байгуулагдаж 1227 онд мөхсөн түүхтэй. Газр нутаг нь одоогийн ӨМӨЗО-ны Ордос, Алашаа, Эзэнээ болон Нинся, Ганьсу мужийн ихэнхийг хамарч байсан аж.

Тус улс нь дорно, өрнийг холбосон торгоны замын гол зангилаа болж байснаараа олон улсын анхаарлыг ихэд татаж байжээ.

Монголчууд Тангуд улсыг “Хашин улс”, иргэдийг нь “Хашин иргэн”, хааныг нь “Хашин хаан” буюу “Илахуй Бурхан” хэмээн нэрлэж ирсэн ажгуу.

Тангуд улс монголчуудтай ихээхэн холбоотой. Ялангуяа өөртэйгээ хиллэдэг Монголын Хэрэйд, Найманы ханлигтай өргөн харилцаатай байжээ.

Чингис хаан Тангудыг байлдан эзлэх нь Зүрчидийн Алтан улстай байлдахад бэлтгэл, түшиц газар болох, түүний нөөц хүчийг ашиглах, тус улс ба Алтан улсын холбоог таслах, Хэрэйдийн Гүр хан Тоорил вангийн хүү Сэнгүлийг нутагтаа орогнуулж монгол угсаатныг нэгтгэхэд саад учруулсаныг харгалзан үзэх, Чингис хааныг баруун зүгт дайн хийхэд холбоотон болж цэргийн хүчээр туслах үүргээ биелүүлээгүй, Алтан улстай Чингисийн эсрэг холбоо байгуулан дайны бэлтгэл хийсэн зэргээс улбаалсан их учир шалтгаантай байжээ.

Чингис хааны цэрэг Тангудын нутагт 5 удаа нэвтрэн орж байлджээ. 1205 онд Елюй Аха жанжинаар удирдуулсан цэрэг Баруун Тангудын хилээр цөмрөн байлдахад Тангудын хаан тодорхой хэмжээний алба төлөхөөр амалсан байна. Энэ амлалтыг 1206 онд шинэ хаан Ань Цюнь /1206-1211/ биелүүлээгүй ажээ. Үүний учир улаагчин туулай жил буюу 1207 оны намар Чингис хааны цэрэг хоёр дахь удаагаа Тангуд улсад довтолжээ. Монгол цэрэг Алашаа, Хулан уулын орчмоор довтолж, цэрэг дайны ихээхэн мэдээ цуглуулаад 1208 оны зуны эхээр нутаг буцсан аж.

Чингис хаан мэдээ сэлтийг нягтлан шалгаад Сэцдийн зөвлөгөөнөөр нухацтай хэлэлцэн, Тангудыг цэргийн их хүчээр дайлах нь чухал гэсэн шийдвэр гаргасны дагуу дайны эрчимтэй бэлтгэл хийж улмаар 1209 оны намар Чингис хааны толгойлсон их цэрэг Тангуд улсад довтлон оржээ. Энэ дайнаар Чингисийн цэрэг эхлээд Тангудын Гао Лингуны цэргийг бут цохин олзолж, дараа нь том боомт Улахай хотыг эзэлж, захирагч Сиби овогтыг олзлон, эцэст нь Веймин гүний удирдсан 50000 цэргийг ялж, гүнийг өөрийг нь барьж авчээ.

Энэ тухай “Монгол улсын түүх”-д “Чингис хаан хоёрхон сарын дотор өөрийн цэрэгт нэг их хохирол хүлээхгүйгээр том ялалтыг Тангуд улсын нутагт байгуулав” /57.110/ хэмээн бичжээ. Дайнд ялагдсан Тангудын Ань-Цюнь хаан Алтан улстай хэзээ ч холбоотон болохгүй. Харин Алтан улсыг дайлбал бид туслана хэмээн Чингис хаанд амласан байна.

Тангуд улс, амласнаа үл биелүүлэн, Чингис хаанаас амийг нь өршөөн явуулсан Вэйгийн гүнээр удирдуулан Монголын нэгдсэн улсын эсрэг дайтах ажлыг зохион байгуулсан байна. Иймээс Чингис хаан 1218 оны хавар Тангуд улсыг дөрөв дэх удаа дайлав. Тангуд улс Хорезмыг байлдахад цэрэг гаргана гэсэн амлалтаасаа няцсан нь их хааны бодлогыг өөрчилжээ. Чингисийн цэрэг маш богино хугацаанд Тангудын нийслэл Яргай хотыг эзлэн хүчтэй цохилт өгсөн байна.

Гэвч дайн үүгээр зогссонгүй. Чингис хааныг Дундад Азийн байлдаанаас буцаж ирж явах үеэр Тангуд улсын хаан Ли-Дэ ван /1223-1226/ Монгол нутгийг Эзэний голын зүгээс довтолсон байна. Чингис хаан нөхцөл байдлыг анхааран үзээд Мухулай жанжны хүү Бороор үлэмжхэн цэргийг удирдуулж, Тангудын хамгийн зүүн захын Инчжоу хотыг эзлүүлэхээр явуулжээ. Борын цэрэг 1224 оны 5-р сард Инчжоу хотыг эзлэн, Тангудын цэргийг бут цохиход Ли-Дэ ван найрамдахыг гуйсан байна. Чингис хаан түүний гуйлтыг зөвшөөрч цэргээ татжээ. Энэ нь Тангудтай хийсэн тав дахь байлдаан байв.

Тангуд улс Монголтой байлдахаар бэлтгэж, хэрэм боомтоо бэлтгэн, Алтан улсаас цэрэг, Зэвсгийн тусламж авахаар хэлэлцээ хийж, 1225 оны 10 дугаар сард гарын үсэг зурж, 11 дүгээр сард илэрхий зарлажээ.

Чингис хаан үүнийг мэдмэгц 1225 оны 11 дүгээр сарын эхээр 10 түмэн цэргийн хүчээр Тангуд улсыг дайлхаар хөдөлсөн байна. Энэ дайнд Өгөөдэй, Тулуй, Сүбээдэй, Боорчи жанжин, эрдэмтэн зөвлөх Елюй Чуцай нар оролцсон байдаг. Монголын цэрэг 1226 оны 3 дугаар сард Эзний голын зүгээс байлдааны ажиллагааг эхэлж, Тангуд улсын умард талын Ганчжоу, Сучжоу, Силян хотуудыг дараа дараалан хүчтэй цохилтоор эзлэн авчээ. Үүний дараа Тангудын олон олон хот боомтыг эзлэн авсан байна. Мөн Алтан, Тангуд хоёр улсын хилийн заагт орших хэд хэдэн хотыг байлдан эзэлжээ.

Тангуд улсын сүүлчийн хаан Ли сянь Монголын цэргийн довтолгооныг няцааж чадахгүй болмогц өөрийн биеэр Чингис хаанд очин бууж өгчээ. Ийнхүү Чингис хаан түүний цэрэг 1205-1227 он хүртэл 5 удаа Тангуд улсын цэрэгтэй байлдаж тус улсыг бүр мөсөн мөхөөсөн ажээ. Тангуд улс мөхөж, газар нутаг нь монголчуудад эзлэгдсэн ажгуу.

Алтан улсыг байлдсан нь. Зүрчид угсаатны Алтан /Цзинь/ улс /1115-1234/³³-ын нутаг нь өмнүүрээ Шар мөрөн, зүүнээрээ Сунгари мөрөн, баруун талаараа Хянганы нуруунд тулж, умард хил нь монголын их говьтой зах нийлж байжээ.

Зүрчид буюу Манж нь эхлээд түрэг, Монголын захиргаанд байснаа Х зуунаас Хятад гүрний харьяанд орж байсан түүхтэй. Зүрчидийн баатар Агуда, Зүрчид аймгуудаа нэгтгэн босч 1114 онд Хятадны төрийг унаган, Зүрчид угсааны Алтан улсыг байгуулж, 1115 онд өөрийгөө хаанд өргөмжилжээ. Агуда хаан умард Хятадын Янжин хотоор нийслэлээ хийж, 1153 онд уг хотыг Чжунду /Одоогийн Бээжин/ хот гэж нэрлэсэн байна. Зүрчидийн Алтан улс Чингисийн өмнөх хаад ба өөрийнх нь эсрэг чиглэсэн ихээхэн халгаатай бодлогыг удаан хугацаагаар явуулж, монголчууд руу байнга довтолж, хор хохирол учруулан Монголын нэгдсэн улсын аюулгүй байдалд аюул занал тарьж, Алтан ургийн хануудыг зэрлэгээр хороон, Монгол аймгуудыг хооронд нь сөргөлдүүлэн хямралдуулж байжээ.

Энэ нь Чингис хаанаас Алтан улстай дайтах гол шалтгаан болсон аж. Энэ тухай Оросын нэрт эрдэмтэн В.Я.Владимирцов, Чингис хаан Хятад /Алтан/ улсын эзэн хаантай дайтах онцгой шалтгаан байсан юм. Учир нь Цзинь түүний шадар ноёд чухамхүү умард хилээ хамгаалан бататгах зорилгоо баримтлахдаа тал нутгийн чөлөөт хөвгүүдийг эрхшээлдээ оруулахыг хичээсэн. Ингэхдээ нүүдэлчин аймгуудыг бие биетэй нь дайсагнуулан үймээн самуун ямагт эхлүүлж байв. Тэд Татаруудын гараар XII зуунд монголчуудын өвөг төрлийн эзэн ноёдыг хөнөөсөн бөгөөд ингэхдээ тэдний ураг төрлийн сурвалжит хүмүүсийг Алтан улсын нийслэлд аваачин “модон илжиг”-т хадаж алдаг байж /112.42/ хэмээн бичжээ. Үүний хамт монголчуудыг довтлох, хооронд нь сөргөлдүүлэх замаар олз ашиг олох, худалдааны торгоны замыг хаах, хил хязгаарыг нь зөрчиж, хүн мал, эд хөрөнгөнд нь үлэмж хохирол учруулж байсан нь хоёр улсын дайтах үндсэн шалтгаан болсон ажээ. Чингис хаан, Зүрчидийн Алтан улстай байлдах стратеги, тактикийг нилээд удаан хугацаагаар ул суурьтай боловсруулж, дайны улс төр, цэрэг байлдааны болон эдийн засаг, зохион байгуулалтын зэрэг бүх талын бэлтгэлийг сайтай хийжээ. Чингис хаан Алтан улсад элч зарж, мөн Алтан улсын элчийг нутагтаа хүлээн авч, дайнтай холбогдох мэдээ мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн ажээ. Мөн Хятадын өмнөт Сүн улстай хамтран Алтан улсын ноёрхлын эсрэг тэмцэхээр санаа бодлоо нэгтгэсэн байна. Чингис хаан Хятадын өмнөд Сүн улс, Алтан улсын ноёрхлыг эцэс болгож, Хятадын умард, өмнөдийг нэгтгэх бодлого явуулж байсныг анхааралдаа авсан байна. Чингис хаан 1211 оны 2 дугаар сар гэхэд Алтан улстай дайтах дайны бэлтгэлээ хангасан гэж үзээд 1211 оны 3 дугаар сард Хэрлэн голын хөвөөн дээр онц Их Хуралдайг хуралдуулж, Зүрчидийн Алтан улстай дайтах асуудлыг хэлэлцүүлж, дайтах төлөвлөгөөгөө танилцуулжээ. Их Хуралдай, Монгол улс Алтан улстай байлдахыг зөвшөөрсөн ажээ. Үүний дараа Чингис хаан Бурхан Халдун ууланд гарч бүсээ тайлан, хүзүүндээ өлгөөд сөгдөж, тэнгэрт залбиран, Мөнх тэнгэр ивээж, Алтан улсад хөнөөгдсөн өвөг дээдсийнхээ ариун сүнс болон өөрийгөө дэмжин тэтгэхийг сүсэглэн гуйж бөөгийн ёсон үйлджээ.

Чингис хаан, Зүрчидийн Алтан улсыг дайлан байлдах үйл ажиллагаа нэгдүгээрт, 1211-1217 онд Чингис хаан биеэр дайлсан дайн, хоёрдугаарт, 1217-1223 онд Мухулай жанжнаар удирдан хийсэн дайн гэсэн хоёр шаттайгаар явуулжээ.

Чингис хаан 1221 оны намар Зүчи, Цагаадай, Өгэдэй, Тулуй дөрвөн хөвгүүнээ дагуулан, их цэргээ агсаж, гурван жигүүрээр Алтан улс руу нэвтэрчээ. Төв ба зүүн жигүүрийн цэрэг Долоон нуурын чиглэлээр, баруун жигүүрийн цэрэг Чуулгат хаалганы чиглэлээр довтолж, Зэб жанжин толгойн сэргийлэх ангийн цэргийг удирдан явжээ.

Энэ дайн Монгол улсын цэргийн ихэнхи хүчийг хамарч, цар хүрээ, байлдааны үйл ажиллагаагаараа үлэмж том байсан аж. Түүхэн сурвалжаас үзэхэд эл дайнд 120000 орчим морин цэрэг оролцсоны 70000 орчим нь төвийн ба зүүн жигүүрийн, 40000 орчим нь баруун жигүүрийн цэрэг байжээ. Бас 20000-25000 цэрэг Тэмүгэ Отчигиноор толгойлуулан эх нутаг, орд өргөөгөө хамгаалж байжээ /57.114; 62.131-132/.

Төвийн ба Зүүн жигүүрийн цэргийг Чингис биеэр удирдан, цэргийн ерөнхий жанжнаар Мухулай явж, бүрэлдэхүүнд нь Хасар, Тулуй нар орсон аж. Баруун жигүүрийн цэргийг гурван хан хөвгүүн Зүчи, Цагаадай, Өгэдэй жанжнууд захирч, Боорчи зөвлөх жанжнаар нь явсан байна. Төвийн ба Зүүн жигүүрийн цэрэг Алтан улсын умард хилийн дагуух хэд хэдэн боомт хот, түүний дотор Ушабу /Цагаан балгасун/ цайзыг эзэлж чухал уулзвар Ехулин /Үнэгэн даваа/ боомтод тулж очжээ. Энд хоёр талын ихээхэн хүч оролцсон ширүүн тулалдаан болжээ. Сар шахам үргэлжилсэн тулалдааны эцэст Чингис хааны удирдсан Монголын цэргийн гол хүчин Алтан улсын Ху Шаху жанжнаар 300000 хүнтэй удирдуулсан их цэргийг цохиж том ялалт байгуулсан байна. Үүний дараа Чингис хаан их цэргээ түр амрааж, хоол хүнс, байлдааны бэлтгэлээ базаах ажил зохион байгуулсан байна.

Баруун жигүүрийн цэрэг Онгуд аймгийн нутгаар дайрч тэднийг холбоотноо болгон хүчээ нэмэгдүүлж, Юньной, Дуншэн, Учжоу, Сүвэй зэрэг олон боомт хотыг эзэлсээр Алтан улсын баруун нийслэл Датуньд дөхөж очжээ. Энд тус жигүүрийн цэрэг бага зэрэг ухран түр амсхийн цэрэг дайны бэлтгэл хийсэн байна.

1212 онд Монгол цэрэг Шуандэ Чжоу /Өнөөгийн Хэбэй мужийн Шуан хуа хот/-г эзлэн улмаар боомтуудад тулж байлджээ. 1212 оны намар Хятан угсааны эрэлхэг жанжин Елюй Люгэ цэргээ авч Монголын талд орж тулалдсан нь дайны явцад багагүй ач тус болжээ. 1213 онд Чингис хаан Алтан улстай хийх дайнаа бүх чиглэлээр өргөжүүлж, сар шахамын хугацаанд Шуандэ, Дэсинь хотыг эзэлж, улмаар Датунь хотыг бүслэн байлджээ. Тус цайз хотыг дайрах төлөвлөгөөг боловсруулан, дайтах ажиллагааг Тулуй удирдан шаргуу тулалдсаны дүнд эзлэн авчээ.

Мөн Зэб жанжин, Цагаан хэрмийн гол нэгэн хаалга Чавчаал боомтыг дайрч эзлэн авсан байна.

Монгол цэрэг дайнаа Хятадын умард нутгаар үргэлжлүүлэн Чжунду /Бээжин/-г гурван удаа бүслэн байлдаж, 1214 онд Шар хээр гэдэг газар бусад замын цэрэгтэйгээ нийлжээ /171.114/ хэмээн Юан улсын сударт бичсэн байдаг.

Энэ үед Монгол цэрэг 862 том жижиг хот, бэхлэлт, цайз, боомт, хэрмийг эзлэн умард Хятадын бараг бүх нутгийг эрхшээлдээ оруулаад байсан аж. Алтан улс нийслэл хотоо тогтоон барьж чадахгүйд хүрчээ. Яг ийм үеэр Чингис Алтан улсын хаанд “Чи хараат болж алба өргөн хаан цолоо бууруулж ван болго” /170.114/ гэсэн шаардлага тавиад хэрэв эл шаардлагыг биелүүлбэл манай цэрэг Цагаан хэрмийн ард ухран гарна хэмээн мэдэгджээ. Энэ хооронд Шар Хээрт хааны сэцдийн нууц хуралдаан болж, Алтан улстай байлдсан гурван жилийн дайны дүнг хэлэлцэн, амжилт, хохирлоо илэн далангүй ярилцаад “Алтан улсыг үргэлжлүүлэн байлдая” гэсэн санал гарчээ.

Үүнийг сайтар болгоон тунгаасны эцэст Чингис хаан хэрэв Алтан улсын хаан эвийн хэлэлцээр байгуулахыг зөвшөөрвөл бид дайныг зогсоож болох юм гэсэн шийдвэр гаргажээ. Ийн байтал Алтан улсын хаан, Вангинь цэхийг элчээр ирүүлж, дайнаа зогсоон эвсэхийг гуйгаад Вэй Шуу вангийн охин Чийхивэй гүнжийг инж, дагалт хөвгүүд, охид тус бүр 500, агт морь 3000, алт эд барааг Чингис хаанд хүргэжээ /62.134/. Үүнд нь итгэсэн Чингис хаан 1214 оны хавар байлдааныг зогсоож, Чжунду хотыг орхин Цагаан хэрмээс хойш ухарч, Загасан нуур хүрч зусжээ.

Алтан улсын хаан “гагц Чжунду хотоо сахин үлдэх” Чингис хааны шаардлагыг хүлээн авалгүй цэрэг, байлдааны бэлтгэлийг шаргуу хийж, Чжунду хотыг хамгаалах, Лиюүдүнгийн хориглолтыг чангатгах арга хэмжээ аваад өөрөө нийслэл хотоо орхин өмнө зүгийн Нанжин хотоор нийслэлэн суусан ажгуу.

Эл байдлыг Чингис хаан цэгнэн үзээд Чжунду хотыг бүр мөсөн байлдан эзлэх үүргийг цэргийн жанжинууддаа өгчээ. Шимо Мянган жанжин, Салжиудын Самух баатар, Елүй ахай, Елүй Тоху нарын удирдсан цэрэг Мулташийн хаалгаар дайрч Жинжэү, Жинсү хотыг дараа дараагаар эзэлж, улмаар Чжунду хотод шахан байлдаж эзлэн авчээ. Ийнхүү Алтан улсын нийслэл Чжунду хот Монгол улсын цэрэгт эзлэгдэн тус хотыг гурав дахь удаа дайлсан байлдан дууссан байна.

Чингис хаан Алтан улсыг дайлах байлдааныг үргэлжлүүлж, эзлэн авсан Хятад нутгийг захирах онц эрхийг төрийн сайд, Хөлөг баатар Мухулайд олгоод 1215 оны эцсээр Монгол нутаг уруугаа буцжээ. Алтан улсыг дайлж ялалт байгуулсан нь тус улсын эрхшээлээс Монголчуудыг ангижруулж, Монгол улсын тусгаар тогтнолыг хамгаалсан чухал ач холбогдолтой байжээ.

Дундад Азид байлдсан нь. Монголын нэгдсэн улсаас Хорезм улсын эсрэг байлдсан нь баруун зүг, түүний дотор дундат Азид явуулсан аян дайны эхлэл болсон ажгуу.

Хорезм улс³⁴ бол баруун Туркестаны нутаг Амударьяа мөрний адгаар оршин байсан эртний соёл бүхий Дундаг Азийн нэгэн том улс байсан бөлгөө.

Хорезм улсыг Монголын түүхэнд Сартуул улс, ард иргэдийг нь сартуул иргэн хэмээн нэрлэж ирсэн түүх буй. Тэр үедээ Хорезм улс нь Дундаг Ази, Иран, Афганистаны нутаг дэвсгэрийг бүхэлд нь эзэмшсэн хүчирхэг улс байсан аж. Ялангуяа шах Мухаммед /1200-1220/-ийн үед баруун Ляо улс, эзэмшилд нь багтаж байсан Бухар, Самарканд, Отрар хотуудыг эзлэн хүч цуутай лалын шашинт улс болж, хаан нь өөрийгөө бүх лалын шашинтны их эзэн хэмээн өргөмжилж, хятад дорно дахиныг лалын ариун дайнаар эзлэн авч, лалын мөргөлтний ноёрхол тогтоохоо зарлажээ.

Эл санаархалдаа хөтлөгдсөн Хорезмын Шах Мухаммед Монголын нэгдсэн улсыг тандах, тусгай элч төлөөлөгч явуулж судлуулах, худалдаачид илгээж мэдээлэл цуглуулах, “найрамдлын харилцаа тогтооё”, “харилцан ашигтай худалдаа хийе” гэсэн далдуур санаатай хуурамч санал дэвшүүлэх, монголчуудын байлдах арга, ухааныг газарт нь очиж үзэх зэргээр Чингис хаан, Монгол улсын эсрэг хорлолтой бодлого явуулж байв. Шах Мухаммед, Монгол цэрэг Чжүндуг эзлэх үеэр 1215 онд Баха-ал-Дин Ражи тэргүүтэй төлөөлөгчдийг явуулж Монгол цэргүүд тус хотыг яаж эзэлж, хэрмийг хэрхэн нурааж давсан тухай зэрэг цэргийн холбогдолтой элдэв мэдээ сэлт цуглуулж /57.119/ байжээ.

Чингис хаан 1218 оны хавар Махмуд, Али Хадша, Юсуф Кахна гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй элчийг Шах Мухаммедэд илгээж, үнэт бэлэг сэлт өгүүлэн эвийн харилцаа тогтоох санал тавьж “Мухаммед шах чамайг би хүүгээ гэж үзнэ” гэж хэлүүлсэнд шах “намайг дорд үзлээ” хэмээн уурлажээ /170.141/. Чингис хаан дээрхи гурван элчтэй зэрэгцүүлэн 1218 онд Хорезм улсад 500 тэмээтэй 450 хүний бүрэлдэхүүнтэй Монголын худалдааны ангийг илгээсэн боловч Отрар хотын даргын хуурамч танилцуулгыг үндэслэн Шах Мухаммедын тушаалаар бүх худалдаачдыг баривчлан цаазалж, ганц хөтөч нь амьд үлдэн монгол нутагт ирж Чингис хаанд болсон хэрэг явдлыг илтгэжээ. Чингис хаан эл хэрэг явдлыг сонсоод гурван өдөр, гурван шөнө гашуудал үйлдэж, мөнх тэнгэрт цацал өргөн, Бурхан Халдунд гарч залбиран мөргөсөн байна. Энэ тухай Араб худалдаачин Ибн-аль-Асирын тэмдэглэлд нилээд тодорхой өгүүлсэн байдаг ажгуу.

Чингис хаан болсон хэргийн нарийн учрыг олохоор Шах Мухаммедэд дахин лалын мөргөлчин Вахра, хоёр монгол элчийг илгээж /152.428-429/ түүндээ “чи энэ орны худалдаачны мууг үзэхгүй хэмээн над итгүүлж байсан. Чи үгэндээ хүрсэнгүй. Ийм үнэнч биш байх нь хаан хүнд жигшүүртэй. Хэрэв би чиний буруугаар худалдаачид алагдаагүй гэж үзэх ёстой бол чи тэр хотын даргаа надад залхаан цээрлүүлэхээр тавьж өг, хэрэв өгөхгүй бол байлдахад бэлтгэнэ” /62.141/ гэж өгүүлжээ.

Шах Мухаммед хоёр монголыг нь хөнөөж, ахлагч Вакраг хөөн явуулсан байна.

Энэ бүхэн нь Чингис хааныг Хорезмд дайн зарлахад хүргэсэн ажаамуй. 1219 онд Чингис хаан өөрийн биеэр их цэргээ авч Хорезм улсыг байлдахаар хөдөлжээ.

Чингис хаан, Дундат Азид хийх аян дайнаа Хорезмоос эхэлсэн хэдий ч уг дайны цар хүрээ, стратегийн зорилго нь ихэд өргөн, алсын хараа төгс байжээ. Чингисийн Дундат Азид хийсэн дайныг дэлхийн түүх судлаач нэрт эрдэмтэд судлан бичсэн нь аргагүй анхаарал татахуйц билээ. Хятадын ӨМӨЗО-ны нэрт эрдэмтэн Сайшаал “Чингис хааны Дундад Азид хийсэн энэ дайныг ерөнхийд нь гурван их байлдаан болгон хувааж болох юм. *Нэгдүгээрх нь* Мухаммед Султаны гол хүчийг устгасан “Хэ Жүн” /Амударьяа, Сырдарьяа мөрний хоорондох нутаг/ бөгөөд одоогийн Узбекистан, өмнөд Казакстан, Таджикстан, Киргистаны нутагт явуулсан тулалдаан болно. *Хоёрдугаарх нь* Мухаммедын хөвгүүн Желал-ад-Дин Султан лугаа байлдсан “Шин” /Өмнөд Азийн Илд мөрөн/ мөрний тулалдаан буюу өмнөд оронд хийсэн тулалдаан юм. Энэ хоёр тулалдааныг Чингис хаан өөрөө шууд удирджээ. *Гуравдугаарх нь* Мухаммед Султаны үлдэгдлийг нэхэж Оросын холбоот цэрэгтэй хийсэн “Каспийн тэнгис хавийн тулалдаан буюу умард оронд хийсэн тулалдаан болно. Энэ их тулалдааныг Чингисийн хошууч жанжин Зэб, Сүбээдэйн удирдлагаар хийжээ” хэмээн бичсэн байдаг бөлгөө /76.95-96/. Энэ нь Чингис хааны Дундад Азид хийсэн аян дайны нутаг дэвсгэр, улс орны хамаарлыг нилээд ончтой тодорхойлсон болой. Мөн эл тулалдааныг “Туркестан-Афганистан ба Персийн тулалдаан” гэж нэрлэсэн нь байдаг билээ.

Чингис хаан Их Хуралдайд 1218 онд хуралдуулж, Хорезмтай дайтах асуудлыг хэлэлцүүлсэнд дайтахыг зөвшөөрч, их цэргийг Чингис хаан биеэр удирдах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргажээ. Чингис эл Хуралдайд ихээхэн ач холбогдол өгч байжээ. Энэ тухай В.Я.Владимирцов “Чингисийн хуралдуулсан Хуралдай нь өөрийн төлөвлөгөөгөө алтан ураг, язгууртан нараараа зөвшөөрүүлэхийн тулд хийсэн биш, харин хамгийн амжилттай аргаар нэгэн агуу их төлөвлөгөөг зохиохын хамт ирээдүйн байлдааны жолоодогч нараа биеэрээ сургахын тулд хийсэн хуралдаан байсан юм” хэмээн бичсэн байдаг. Чингис хаан энэ шийдвэрийн дагуу дайтах бэлтгэлийг нухацтай хийгээд Чингис хаан өөрөө 80000 орчим шилдэг Монгол цэрэг, арын алба, цоохор 60000 цэрэг, Зэб, Сүбээдэй, Тогочарын удирдсан тусгай ангийн 15000 цэрэг нийт 155000 цэрэгтэйгээр байлдааныг эхлүүлжээ.

Чингис хаан Хорезм явах замдаа өөртөө саад болж буй хүчнийг бут цохин замаа засах арга хэмжээ авсан байна. Үүнд 1219 онд Зэб жанжнаар удирдуулсан хөнгөн морьт цэргийн хүчээр Хар хятаны эзэн Хүчүлэгийн хүчийг бут цохин Монгол улсад нэгтгэсэн байна. Мөн Сүбээдэй жанжнаар удирдуулсан морин цэргээр мэргэдийн үлдэгдэл хүчийг бут цохиулжээ.

Чингис хааны цэргийн гол хүч 1219 оны зун Эрчис мөрөн хүрч тэнд цэрэг, байлдааны бэлтгэлээ цэгцлэн, Сэцдийн зөвлөлийн хуралдаан хийж, Хорезмыг байлдах зам, чиглэл, байлдах тактикийг хэлэлцэн шийдвэрлэжээ. Их цэргийг 4 жигүүр болгон хувааж, дөрвөн чиглэлээр довтлохоор зохион байгуулсан байна. Үүнд нэгдүгээр жигүүрийг Цагаадай, Өгөдэй удирдаж Отрар хотыг байлдан эзлэх, Зүчийн удирдлагаар хоёрдахь жигүүр Амударьяа мөрний дээд урсгалаар давших, Алаг Чэрби, Таха нарын удирдсан гуравдахь жигүүр Бенакет, Ходжент хотын чиглэлээр хөдлөх, Чингис, Тулуй хоёрын удирдсан дөрөвдэх жигүүр Бухар хотыг дайлахаар тус тус хуваарилан үүнийхээ дагуу байлдааныг явуулжээ.

Цагаадай, Өгөдэйн удирдсан нэгдүгээр жигүүрийн цэрэг Отрар хотыг 1219 оны 9 дүгээр сард бүслэв /34.83/. Нүсэр бэхлэлт, сайн хамгаалалт бүхий Дундат Азийн худалдаа арилжаа, олон улсын харилцааны чухал зангилаа Хорезмын үүд хаалга болсон тус хотыг эзлэх нь ихээхэн ач холбогдолтой байсан ажгуу. Отрар хотын дарга Инальчик Монголын хоёр удаагийн элч төлөөлөгчид, энгийн дөрвөн зуун тавин худалдаачдыг харгислан хөнөөсөн гэмтэн бөгөөд түүнийг баривчлан гэсгээх нь монгол цэргийн үүрэг байсан аж. Отрар хотын дарга хамгаалалтыг удирдан “буруу номтон зэрлэгчүүдэд бууж өгвөл Аллах бурхан өршөөхгүй”, “эзэн Мухаммедын ариун дайныг хийе” гэх мэтээр тасралтгүй ятган ухуулж байжээ. Отрар хотын цэрэг, ард иргэд хотоо хамгаалан Монгол цэрэгтэй таван сар тулалджээ. Цагаадай, Өгөдэй жанжнууд хотыг эзлэх төлөвлөгөөг нухацтай боловсруулж, хэнийг ч оруулж, гаргахгүйгээр бүслэн, хотыг дайрах ажлыг чадварлаг удирдаж байсан аж. Гэвч хот хоол хүнсний нөөцөө дуусгаж, ихэд сульдан доройтож, хүч чадлаа барсаар эцэстээ монгол цэрэгтэй тулалдах чадваргүй болжээ. Иймээс хотыг хамгаалж байсан Харц, Хас нар монгол цэрэгт бууж өгөх санал тавьсан ч хотын дарга эс зөвшөөрчээ.

Гэсэн ч тэд шилдэг морин цэргээ авч шөнөөр хотын Суфи гэх гол хаалгаар гарч зугтсан боловч монгол цэрэгт гүйцэгдэн устгагдсан байна. Монгол цэрэг нээгдсэн хаалгаар нэвтрэн орж ширүүн тулалдаан хийж Отрар хотыг эзлэн авчээ. Хотын дарга Инальчук хоёр түмэн цэрэгтэйгээр дотоод бэхлэлтдээ орж хоёрхон цэрэгтэй болтлоо сар шахам ширүүн тулалдаж эцэстээ монгол цэрэгт баригдан Чингис хаанд хүргэгдэн цаазлуулжээ. Монгол цэрэг Отрар хотыг эвдэн сүйтгэж, урчуудыг нь олзлон, бусад хүмүүсийг нь устган хядсан байна. Ингэж монгол цэрэг Отрарын 40000 цэргийг ялж хотыг нь эзлэх байлдаан 1220 оны хаврын хугаст дууссан болой. Эл үед Монгол цэрэг Хорезм улсын бүх нутагт байлдааны ажиллагаа явуулж байжээ. Зүчи жанжны удирдсан их цэргийн хоёрдугаар жигүүр Шихун мөрний хөвөөгөөр орших Сохнаг, Узкент, Баржиг-Кент, Ашинес зэрэг хотуудыг байлдан эзэлж, 1220 оны хаврын сүүлчээр Жант хотод тулж иржээ.

Зүчийн цэрэг Жант хотруу нэвтрэн ороход нь эсэргүүцээгүй тул бүгдийг нь өршөөж, даргаар нь Сартуул хүн Али Хожог томилон захируулжээ. Дараа нь Зүчи байлдааныг цааш үргэлжлүүлж Шихун мөрний адагт орших Яньжи-Кент хотыг эзэлжээ. Алаг, Сүйхэту, Тахай нарын захирсан гуравдахь жигүүрийн цэрэг Шихун мөрний эх өөд байлдааны ажиллагаа явуулж Панакт, Хозент хотыг довтлон турк Малик, түүхэнд төмөр жанжин хэмээн алдаршсан Төмөр Мелигийн цэргүүдийг бут цохиж эзлэн авчээ.

Дээрхи байлдааны үр дүн нь Сайшаалын бичсэнчлэн “Хозент хотоос Янжи-Кент хүртэл Шихун мөрний дагуу бүх нутаг нь бүгд монгол цэргийн гарт орсноос анх удаагийн их дайлалтын шийдвэрлэгч амжилт гарчээ” /76.101/

Чингис хааны захирсан гол их цэрэг Бухар, Самаркандыг эзлэх аян дайнаа 1219 оны өвөл Зарнут хотоос эхэлжээ. Энэ хотын иргэд Чингисийн бие элч мусульман шашинт Хажибын “Би мусульман болохоор барахгүй бас ч мусульманы хөвгүүн эзэн тэнгэрт өршөөгдөхийн тулд эдүгээ Чингис хааны зарлигаар та нарыг мөхлийн далай, цусан голоос аврахаар энд элчлэн ирсэн билээ. Энд Чингис хаан биеэрээ хэдэн мянган байлдагчийг дагуулан ирээд байна. ... та нар хэрвээ бага ч гэсэн эсэргүүцвээс нүд ирмэхийн зуур хот чинь үнсэн товрог болж, хээр талыг цусан далай болгох болно. Хэрэв та нар үнэнч итгэлийг болгоон сонсдог юм бол та нарын амь нас, эд хөрөнгөнд чинь үл халдах баталгаатай” /34.16 бүлэг/ хэмээн уриалсныг иргэд хүлээн авчээ. Хотын дарга Чингис хаанд элч, бэлэг сэлт хүргүүлэн бас өөрийн биеэр их хаанд бараалхан бууж өгснөө өчсөн байна. Чингис хаан хотын дарга, элчийг хүлээн аваад зөөлөн үг, өршөөлийн царайгаар тэднийг тайтгаруулж, үхэх ялаас хэлтрүүлжээ. Дараа нь хотын иргэдийг гарган ирж идэрчүүдийг цэрэгт татаж... Бухарын байлдаанд оролцуулахаар бэлтгэсэн бөгөөд бусды нь гэр гэрт нь буцаажээ” /76.102/. Ингээд Зарнут хотын иргэд хотоо “Хутулууг балга” /Буянт хот/ хэмээн нэрлэсэн нь түүхэнд тэмдэглэгдсэн байна.

Дараа нь Чингис хааны цэрэг Бухар хотыг чиглэн давшиж замд тааралдсан “Нуур хот” хүрэхэд тус хотын иргэд амуу хүнс өргөж бууж өгсөн учир өршөөн хор хохиролгүй үлдээн цааш хөдөлсөн ажээ.

1220 оны 3 дугаар сард Чингис хааны цэрэг Бухар хотод тулж очжээ. “Бухар” гэдэг нь Зороястрын шашин /гал шүтэгчид/-ийнхний хэлээр “Эрдэм шинжилгээний төв” гээн утгатай агаад тухайн үедээ шашны эрдэмтэд цуглардаг газар, лалын тоорцогон оройт дуган бүхий тайван сайхан хот байжээ. Чингис хааны цэрэг хотыг тойрон хэдэн өдөр үргэлжилсэн ширүүн дайралт хиймэгц Султан хааны хотыг хамгаалж байсан хоёр түмэн цэрэг шөнө дөлөөр хотыг орхин гарч зугатсан байна. Монгол цэрэг тэднийг Охос мөрөн /Амударья/-ний хөвөөнд гүйцэн тулалдаж бут цохижээ. Хотын иргэд Монгол цэрэгт хотын хаалгыг нээж өгсөн учир хохирол, сүйтгэл бага гарсан байна.

Арабын түүхэнд Бухар хотыг эзэлсэн явдлыг Бухар хотын эмгэнэлт хэрэг хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэ нь эсэргүүцэл үзүүлэлгүй бууж өгвөл хот, бэхлэлтийг эвдэхгүй, хүн ардыг алж талахгүй гэсэн амлалтаа Чингис хааны цэрэг зөрчиж, дэлхийн соёл иргэншлийн нэгэн төв үзэсгэлэнт Бухарыг эвдлэн сүйтгэж, сүм дуганыг шатааж, сүсэгтэн олныг доромжилсон ажиллагаа /57.126/ -тай холбоотой. Гэхдээ энэ нь болгоон үзвэл зохих өөр нэгэн учир шалтгаантайг нэрт түүхч Сайшаал “Чингис хааны товчоон” номынхоо дэд дэвтэрт бичжээ. Тэрбээр “Энэ үед нэгэн санамсаргүй явдал тохиолдов.

Султан хааны цэрэг Бухар хотоос дутаан гарах үед дөрвөн зуун морьт цэрэг гарч чадалгүй үлдэж, тэд дотор цайздаа ухран ороод үхэн хатан эсэргүүцэж байв. Монгол цэрэг дотор цайз өөд довтоллоо. Бас суугуул ардын дотроос идэр чийрэг эрсийг нь сонгож дотор цайзын сувгийг бөглүүлж, дараа нь их буугаар буудав. Арван хоёр өдөр ширүүн тулалдаад цайзыг бас эзэлж чадсангүй ба монгол цэрэг ба суугуул иргэд цөөн бус үрэгджээ. Дотор цайзын дайсан ч өөрсдийн амь насныхаа төлөө үхэн хатан байлдаж байсан бөгөөд шөнө бас дайралт хийж байв. Ийм байдалд Чингис хаан зарлиг буулгаж, бүх хотын тойрогт гал тавиулжээ. Хотын олонхи гэр байшин нь модоор барьсан тул хэдхэн өдрийн дотор ихэнх нь бүр үнсэн товрог болов /76.105-106/. Ираны эрдэмтэн Жувейни мөн ийм утгатай зүйлийг бичсэн нь бий. Сайшаал эрдэмтэн цааш нь “хотын ба дотор цайзын эсэргүүцэл нь устгагдсан бөгөөд хотын хэрэм болон гадар бэхлэлт нь тэгш тал адил талхлагджээ. Энэ үед суугуул ардыг эр эм, хөгшин залуу гэсэнгүй цөмийг Мусулла талбайд авчирч, тэднийг үхлээс хэлтрүүлэв”/76.106/ гэж өгүүлжээ. Өөр нэг анхаарал татахуйц мэдээллийг Жувени “1310 онд хэвлүүлсэн Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” номынхоо нэгдүгээр ботид /16-р бүлэгт/ бичсэн байдаг. Энд Чингис хаан Самарканд хотыг эзэлсний дараа Бухар хотыг Тагуша, Ялавач түшмэлээр захируулж, сэргээн босгох ажил өрнүүлснээр тус “хот нь өдрөөс өдөрт хөгжсөн бөгөөд оргилдоо ч хүрсэн юм. Ингээд Бухарын нутаг орон нь нэр төртэй угсаатны гэр хүрээлэн нь болж, эрхэм язгууртан ба энгийн иргэдийн цугларах газар болсон байна” гэж бичсэн байдаг ажгуу. Үүнээс үзэхүл Бухар хот богино хугацаанд сэргээн босгогдсон бололтой.

Чингис хааны удирдсан гол цэрэг Самаркандыг эзлэхээр хөдөлж 1220 оны 3 дугаар сард тус хотыг бүслэн авчээ.

Зүчи, Цагаадай, Өгөдэй, Алаг нарын удирдсан гурван жигүүрийн цэрэг Чингисийн гол цэрэгтэй ирж нийлсэнээр их цэргийн хүч ихэд өсөн нэмэгдсэн аж. Эл үед Согда гол /Одоогийн Зорнышань гол/-ын сав газар оршдог “Ертөнцийн диваажин” хэмээн алдаршсан Хорезмын шинэ нийслэл Самаркандыг Шах Мухаммедын хүү Тугай ханаар удирдуулсан 50000 цэрэг хамгаалж байжээ.

Самаркандын дайнд Султаны тал 20 том заан хэрэглэж /72.209/ байсан бол Монгол цэрэг “Чөдөр оньс” хэмээх чулуу харвах буугаа өмнөөс нь тавьж байсан аж /57.127/. Монгол цэрэг таван өдөр ширүүн тулалдсаны эцэст Самаркандыг хамгаалж байсан Султаны цэргийг бут цохисон байна. Самаркандын төлөөлөгч-иргэд Чингис хаантай уулзан түүний бодлогыг ойлгон буцаж ирээд лалын мөргөлчдийн наманчлалын цагаар хотын хаалгыг нээж өгсөн нь монгол цэрэгт их тус нэмэр болсон гэдэг. Самарканд хотыг эзлэн авч хотын хэрмийг газартай нь тэгшлэн, гурван түмэн гар урчуудыг олзолж, хорин түмэн динар /алтан зоос/-ын татвар авчээ /76.109/. Монгол цэрэг тулалдаанаас зайлж зугтаасан Алб-Ар Ханы удирдсан мянга гаруй цэргийг хойноос нь хөөн цохисон байна.

Чингис хаан Самарканд хотоо орхиод Тирмузийн гармаар Амударьяа мөрнийг гатлан зугтаасан Хорезмын Шах Мухаммедын цэргийг цохихоор Зэб, Сүбээдэй, Тугочар нараар тус бүр түмэн цэргийг удирдуулан араас нь явуулжээ.

Бухар, Самарканд болон Шахун мөрний хөвөөн дагуу орших олон хот тосгодыг байлдан дагуулсан нь Хэ жүн орны их дайллалдаан шийдвэрлэх чанартай ялалт болжээ /76.109/. Чингис хаан, Самаркандын байлдааны дараа, Зүчи, Цагаадай, Өгөдэйн удирдсан жигүүрийн цэргийг 1220 оны 7 дугаар сард Ургенч хотыг дайлахаар давшуулаад өөрөө гол цэргээ авч Хорасан муж /Одоогийн Туркмен улсын өмнөд хэсэг, Иран улсын хойт хэсэг, Афганистаны баруун хойт хэсгийг хамардаг/-ын газар нутгийг эзлэхээр морджээ.

1220 оны өвлийн эхээр Ургенчийн байлдаан эхэлжээ. Ургенч бол Амударьяа мөрний адагт оршдог Хорезм улсын анхны нийслэл, том хот юм. Монгол цэрэг Ургенчийн Хумар ноёны удирдсан хамгаалалтын цэргийг хотоос нь өдөөн гаргаж их цэргийнхээ бүслэлтэд оруулан цохилт өгөх замаар байлдаанаа эхэлжээ. Монгол цэргийн дотор Зүчи, Цагаадай хоёрын хооронд зөрчил гарсан учир Чингис хаан эл жигүүрийг ерөнхийлөн удирдах жанжнаар Өгөдэйг томилсон аж. Өгөдэй жанжин удирдлагыг гартаа авч цэрэг, морио цэгцлэн Ургенчийн эсрэг шинээр дайралт хийн 1221 оны 5 дугаар сард Ургенч хотыг эзлэн авчээ. Ургенчийн байлдаан 7 сар гаруй үргэлжилж ихээхэн хохирол сүйтгэл учруулсан байна. Ираны түүхч Жувейни “XIII зууны эхэн үед байсан арабын түүхч Ибн-ал-Асир Монголчууд Ургенч хотыг эзлэхдээ голын далан боомтыг эвдэж усаар авахуулж юу ч үгүй болтол сүйтгэсэн ба бас гар урчууд үзэсгэлэнт охидоос бусад иргэдийг хядаж алсан” гэж бичсэнийг дурдсан байдаг /34.150-152/ “Тэр үед Ургенч хотыг Монголын 50000 цэрэг дайран байлдсан хэмээх бөгөөд тэрхүү цэргийн хүн тус бүр хорин дөрвөн хүнийг өөрийн гараар алах тушаал авчээ /109.153/ гэсэн байхад өөр нэг зохиолд “Хотыг эзлэх байлдаанд оролцсон цэрэг эр бүрд 25 хүнийг боол болгон өгсөн” гэж бичсэн байна.

Сайшаал, Жувейни зэрэг Персийн түүхчдийн тэмдэглэлийг үзвэл Монгол цэрэг хотын гадна хөөн аваачиж арван түм гаруй уран дархчууд ба эмс хүүхнийг боол, зарц болгохоор олзлон аваад үлдсэн хүмүүсийг нь цэрэг бүрт 24 хүнийг хуваан өгч цөмийг алуулжээ”. Энэ үед монгол цэрэг түмэн хүнтэй байлаа гэдэг. Ийм бол нийт алсан хүний тоо зуун хорин түм болно /76.110/. Үндсэн эх сурвалж нэг авч өөр өөрөөр тайлбарлаж бичсэн нь дээрхи ишлэлүүдээс тодорхой харагдана. Ямар боловч Ургенчийн дайн монгол цэрэг ба хотын иргэдэд их хохирол учруулсан, үлэмжхэн сүйтгэлтэй дайн байсан нь эргэлзээгүй. Чингис хааны Дундат Азид хийсэн аян байлдааны төгсгөл нь Хорезмын Шах Мухаммедийн цэргийн үлдэгдэл болон түүний хүү Желал-ад-Диний Монгол цэргийн эсрэг байлдахаар цуглуулсан хүчийг бут цохиход чиглэгджээ.

Чингис хаан, Самаркандыг хамгаалахаа зогсоож, арван түмэн цэргээ авч зугтаасан Шах Мухаммедын араас Зэб, Сүбээдэйн их цэргийг нэхэн байлдуулсан аж. Монгол цэрэг Панжаб, Балаг, Нишапур, Раян хотыг дайран Ирак хүрч, Харун цайзыг өнгөрөн, Каспийн тэнгисийн зүүн өмнө өнцөгт орших Мазандаран хот орох зэргээр Султаныг тасралтгүй мөрдөн хөөсөн ажгуу. Бараг жил шахмын хугацаанд айн эмээн, зовон зүдэрч эцэстээ цээжний хальсны үрэвсэл өвчинд нэрвэгдэн, зугтан очсон Мазандарын хотын ойролцоо нэгэн бяцхан зэлүүд арал дээр Султан 1221 оны 1 дүгээр сарын 1-нд нас эцэслэснийг түүхэнд тэмдэглэжээ. Үхэхээсээ өмнө Султан хөвгүүн Жалалдин-мөнх Бирдигээр хаан ширээг залгамжлуулахаар шийдвэрлэсэн бөлгөө.

Тэр өдрөөс хойш Хорезм улсын Султан нь Желал-ад-Дин болжээ /76.115/

Желал-ад-Дин хоёр дүүгийхээ хамт Султан эцгээ оршуулаад, Монгол цэрэгтэй байлдахаар өөрийн байрлал руугаа буцсан хэмээн түүхнээ тэмдэглэсэн байдаг.

Чингис хаан, Афганистаны нутагт дайны бэлтгэл хийж Желал-ад-Дины цуглуулаад байгаа цэргийн хүчинд цохилт өгүүлэхээр 30000 цэрэг удирдуулан Шихихутугийг явуулжээ. Желал-ад-Дины цэрэг Перван хотын орчимд Шихихутугийн цэргийг ялж, олон тооны цэргийг нь олзлон авсан байна. Энэ бол Хорезм улсын нутагт Монгол цэргийн амссан анхны том ялагдал байжээ /57.128/. Желал-ад-Дин олзолж авсан монгол цэргийг маш их тамлаж, ихэнхийг амьдаар нь газар булсан гэдэг /57.129/.

Чингис хаан олзлогдон тарчлагдаж алагдсан Монгол цэргүүдийнхээ төлөө гашуудал үйлдээд, их цэргээ удирдан Желал-ад-Динтай тулан байлдахаар эрслэн хөдөлжээ. Эл түрэлтийг Желал-ад-Дин тэсч чадалгүй Афганистанаас Энэтхэг рүү зугтаасан байна.

Чингис хаан нэхэн хөөх зам зуураа Гурзив, Андраба, Бамдака, Таликан, Герот, Фирузкук, Парван, Кабул, Кезин хотуудыг эзлэн улмаар 1221 оны намар Энэтхэгийн Инд мөрний эрэгт Желал-ад-Дины цэргийг шахан байлдаж ялжээ. Энэ тулалдаан нь түүхэнд “Шин мөрний тулалдаан” хэмээн алдаршсан болой.

Ялагдсан Желал-ад-Дин Их мөрний эргийн 20 фут өндөр хадан цохион дээр гарч нэг гартаа Хорезм улсын тугийг, нөгөө гартаа илд бамбайгаа барьсаар мөрний давалгаалсан их ус руу үсрэн орж, улмаар нөгөө эрэгт нь гарч зориг баатарлагаа харуулжээ. Үүнийг анхааралтай харж байсан Чингис хаан “Эцэг хүн ийм хүүтэй байгууштай” /62.147/ хэмээн айлдсан гэдэг. Эл явдал 1221 оны 2 дугаар сарын 25-нд болсон /62.147/ ажаамуй.

Их сэтгэгч К.Маркс “Желал-ад-Дин бол хуурай газрын барс, мөрөн голын гүмбэр матар шиг эр” байж хэмээн магтсан байдаг. Хожим нь Желал-ад-Дин жанжин Чингис хаан нас барсныг сонсоод ихэд гашуудан “Надтай тэнцэх сайн эр нас баржээ. Цаашид би хэнтэй тэмцэн байлдах билээ” /140.209/ гэж түүхэнд тэмдэглэгдсэн нь домог болон үлдсэн ажгуу. Чингис хааны их аян дайн үндсэндээ үүгээр дуусгавар болсон хэдий ч Хорезмын цэргийн үлдэгдэл, дайталгүй үлдсэн, бослого үймээн гаргасан, захирагдахаас татгалзсан хот цайзыг цэгцлэх зорилгоор хэсэг бусад тулалдаанууд явуулсан байна. Тухайлбал, Жалайрын Бала ноён тэргүүтэй цэргийг Желал-ад-Диныг нэхүүлэхээр умард Энэтхэгт, Дөрбэйний Дүрбэй тэргүүтэй цэргийг Индус, Багдадын хооронд орших Абту балгасыг дайлуулахаар, Өгөдэйн цэргийг Газнин, урвасан Бала хотыг, Илжигэдэй ноёны цэргийг Ели балгасыг эзлүүлэхээр тус тус явуулж бага хэмжээний байлдааны үйл ажиллагаа явуулжээ.

Чингис хаан 1222 оны зунаас байршлаа сэлгэн, нутаг буцах бэлтгэлээ хийж эхэлсэн ажээ. Дайлан дагуулсан гол гол газар орон, хот балгасуудын дарга нарыг томилж, захиа даалгавар өгсөн байна. Бухар, Самарканд, Ургенч, Утан, Кашгар, Кушиндэрил зэрэг гол нутгийг тайш Елүй Ахайгаар захируулж, Махамад Ялавачийн хүү Машахудаар хавсруулжээ /76.123/.

Чингис хаан Дундад Азийн үзэсгэлэнт бэлчээр нутагт агт морьд, цэрэг, иргэд, бараа бологсдоо амрааж, Хорезмын нутагт таран байлдсан цэрэг эрсээ цуглуулжээ. Их хаан энд Их Хуралдайг чулуулж, Хорезм улсыг байлдан эзэлсэн дүнгээ гарган, эзэлсэн газар орныг хэрхэн захирах, Монгол орон лугаа буцах зэрэг асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэжээ.

Чингис хаан 1222 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр явуулын ордондоо Хятадын бомбын шашны бясалгагч Чан Чунь арштай уулзжээ.

Их бясалгагч Чан Чунь арш 1219 оны 12 дугаар сарын 18-нд Хятадын Шандуны Лай Ипсоу нутгаас арав гаруй шавь нараа дагуулан бүтэн 2 жил 4 сар шахам аялан, уртын урт замыг туулж, сэтгэл итгэлийн их тэнхээ, тэсвэр тэвчээр гарган Чингис хаантай биеэрээ ирж уулзсан нь олон олныг бодогдуулах түүхэн үйл явдал байсан ажаамуй. Чингис хаан их арштай улс орон, өөрийнхөө бодлого, зорилго, зорилтынхоо тухай, хүний хувьд өөрийнхөө тухай илэн далангүй санал бодлоо солилцож, улсынхаа

төрийн бодлого, тогтолцооны тухай, төрийн тэргүүн, түшээдийн тухай илэн далангүй ярилцаж, алтан ургийнхан, хан хөвгүүд, шадар сайд түшмэддээ эрдэм заалган зөвлөгөө өгүүлж, төрийг авч явах арга ухааны утга учрыг дэлгэрэнгүй яриулсан агаад энэ нь цаашид гүн гүнзгий нөлөөлөх учиртайг мэдрүүлж ухамсарлуулсан болой.

Чан Чунь арш Самарканд хотод өвлийг өнгөрүүлэхдээ тус хотод 100000 хүн ард амьдран сууж, тариа ногоо тарьж, арилжаа худалдаа эрхлэн, шашин мөргөлөө үйлдэж хэвийн амьдарч байсан тухай аян замын тэмдэглэлдээ бичсэн нь дайн ба түүний дараах амьдралын бодит үнэнийг танин мэдэхэд чухал ач холбогдолтойг тэмдэглэх юун.

Чингис хаан Дундат Азид байлдан явуулсан үйл ажиллагаа нь хэдийгээр зөвхөн Дундат Азид хэмээн нэрлэсэн ч гэсэн түүний явцад Нэгдсэн улсын төрийн бодлогод бага зэрэг өөрчлөлт орсон болой. Энэ нь Дундат Ази, Европ хооронд цэрэг дайны холбоо тогтохоос сэрэмжлэн болгоомжилоход чиглэж байсан аж. Чингис хаан энэ чигт Зэб³⁵, Сүбээдэйн цэргийн үйл ажиллагааг зангидан чиглүүлэх бодлого явуулжээ.

Үүнтэй холбоотойгоор Зэб, Сүбээдэйн их цэргийг илгээсэн байна. Зэб Сүбээдэйн цэрэг Грузи /Одоогийн Грузин/ Азербайджан, Зажира оронд ажиглалт хийж, холбоо тогтоон, монгол цэрэгтэй байлдахаар бэлтгэж буйг таслан зогсоож, Грузруу довтолж түмэн цэргийг нь ялан сөнөөжээ. Улмаар 1222 оны өвөл Хэ Лин нуруу /Одоогийн Кунс нуруу/-г даван Асу аймгийн холбоот /Месжи, Саргис, Кабчиг зэрэг аймгууд багтдаг/ цэргийг сарниулан мохоож, 1223 оны 5 дугаар сард Бүзү голын хөвөөнд Кибчагийн цэргийг бут цохисон аж. 1223 оны 5 дугаар сард оросын өмнөт хэсгийн вант улсуудын байгуулсан холбоот цэргийн хүчинтэй Днепр мөрний орчимд тааралджээ. Монгол цэргийг удирдаж байсан жанжин Зэб, Сүбээдэй нар холбоот цэргийн удирдлагад 10 элч илгээж Оростой байлдах зорилго бидэнд байхгүй бөгөөд хүчин хамтран ажиллах сонирхолтой байгаагаар илэрхийлсэн аж. Гэтэл Оросын вангууд 10 элчийг нь алж, монгол цэрэгтэй байлдахаар Калх голд цугларчээ. Ийнхүү аргагүй байдалд орсон Зэб, Сүбээдэйн удирдсан Монгол цэрэг Калх голын хөвөөнд Оросын холбоот /Вангуудын нэгдсэн цэрэг/ цэргийн түрүүч Галичийн ван Метиславын цэрэгтэй 5 дугаар сарын 30-ны орчим тулалдан ялалт байгуулсан байна. Дараа нь Киевийн вангийн цэрэг, Владимир гүнт улсын цэргийг байлдан ялж, Өмнөт Оросын нутаг Крымийн хойг, Днепр мөрний адаг орчмын газар орныг эзлэн авч, Ижил мөрнийг даган, Болгар луу нэвтрэн 1223 оны сүүлч, 1224 оны эхээр Болгарын цэргийг цохиж монголын хараат улс болгожээ. Зэб, Сүбээдэй нар аян дайнаа дуусгаад Сахашни хотоор дамжин буцсан боловч замдаа Зэб жанжин Ханлины нутагт өвчнөөр нас барж, Сүбээдэй жанжин цэргээ авч нутаг буцаж Чингис хааны их цэрэгтэй 1224 онд нийлсэн болой.

Зэб, Сүбээдэйн байлдааны үйл ажиллагааг “Монголчууд Хорезмыг дайлах явцад санамсаргүй тохиолдсон дайлалт гэж европынхон үздэг байна”/76.128/

Энэ нь оргүй ч бус ортой аж. Учир нь Зэб, Сүбээдэйн 3 түмэн цэргийн хийсэн байлдааны ажиллагаа нь Хорезмын ба Европын хооронд цэргийн холбоо буй болохоос сэргийлэх, Чингис хаанд хэрхэн хандаж, ямар байр суурь баримталж байгаа болон цэргийн хир зэрэг хүчтэйг тандах зорилготой байсан болой. Харин Зэб Сүбээдэйн байлдааны амжилт нь санасанаас хэд дахин илүү байж “дэлхий дахины түүхэн дэх гайхамшигт явдал” /76.128/ болсон гэж түүхнээ тэмдэглэгдсэн ажээ.

Чингис хаан бүх жигүүрийн цэрэг цугларч, Сүбээдэй жанжныг буцаж ирсэний дараа 1224 оны зун Эрчис мөрний үзэсгэлэнт эрэгт дайны ялалтаа дүгнэн тэмдэглэж их найр хурим хийсэн ажээ. Чингис хаан ахмад хүү Зүчийг Хорезмын захирагчаар томилон, их цэргээ авч Монгол нутаг руу шуудран буцав. Их хаан 1225 оны 2 дугаар сарын сүүлчээр Туулын хөвөөнд буй ордондоо морилон ирсэн ажгуу.

Чингис хааны удирдсан Монгол цэргийн Дундад Ази, өрнө зүгт хийсэн таван жилийн /1219-1224/ аян дайн ялалтаар дуусч, Монголын цэрэг Дундад Ази, Афганистан, Пакистан, Умард Энэтхэг, Иран, Ирак, Азербайджан, Гүрж, Армян, Өмнөт оросын тал нутгийг үндсэнд нь байлдан дагуулав.

Ингэж Их Монгол улсаар төвлөсөн Монгол гүрэн үүсэж Хятадаас гадна Дундад Ази, Иран, Орост хэд хэдэн бие даасан шинжтэй хаант улс тогтох үүд хаалга нээгджээ. /57.134/

§6. Монголын нэгдсэн улсын гадаад харилцаа

Монгол оронд гадаад харилцаа бүр Монгол нутагт оршин тогтнож байсан эртний улсуудын үеэс эхлэн үүссэн уламжлалтай. Монголын нэгдсэн улс байгуулагдахын өмнөх үед Монгол аймгууд дор дороо биеэ дааж харь орнуудтай харилцаж байснаас гадна мөн өөр хоорондоо харилцаж байжээ. Аймгуудын холбоо, ханлигуудын өөр хоорондын харилцааны хөгжлийн явцад Монголын гадаад харилцааны эх загвар үүсэн бий болжээ /57.297/. Феодалын харилцаа гүнзгийрэн хөгжих тутам аймгууд ба аймгуудын холбоо өөр хоорондын харилцаа улам бүр өргөжин хөгжсөөр байжээ. Монголын нэгдсэн улс байгуулагдахын өмнөх үед анд бололцох ёс дэлгэрч улмаар улс төр, цэргийн холбоо, эвслийн шинжтэй болон хувирч байв. Үүний бодит жишээ нь Тэмүжин ба Тоорил, Тэмүжин ба Жамух нарын хооронд байгуулсан андын холбоо мөн юм. Анд бологсод болзон уулзаж, бие биедээ билэг харилцан барилцаж, эрхий хурууныхаа цусыг харилцан амсаж, андгай тангарга өргөдөг байжээ. Энэхүү тангарга нь хоёр этгээдийн хоорондын нэг ёсны ам гэрээ байжээ. Тангаргаар хүч хавсран дайсантай тэмцэх, бие биедээ үнэнч шударга байх, харилцан эрх мэдэл тэгш байх, хэрүүл маргааныг учран хэлэлцэж эвээр шийдвэрлэх зэргээр тохиролцдог байсан аж.

Ардын дипломат ёсонд анд бололцохоос гадна ам гэрээ хэлэлцээр байгуулах явдал ихээхэн дэлгэрч байжээ. Аймгуудын зонхилгогч, аймгийн холбооны тэргүүлэгчид,

цэргийн жанжин, ноёд язгууртнууд ам гэрээ хэлэлцээр байгуулж, түүндээ үнэнч байхыг эрхэмлэдэг, хэрэв түүнээ зөрчвөл итгэл үл үзүүлэх, зэмлэх, санаа сэтгэлийн дарамт, ганцаардалд оруулах зэргээр шийтгэдэг байсан аж. Энэ нь ан авд явах, олз ашгаа хуваах, хамтарч тэмцэх, байлдаан тулалдаан хийх, эсвэл холбоо байгуулах, харилцан бие биедээ туслах, аян жин тээх, цэрэг Зэбсэг нийлүүлэх, худалдаа арилжаа явуулах зэрэгт хэрэглэгддэг байсан ажээ. Монгол аймаг, ханлигуудын түүхэнд элч нар их чухал үүрэг гүйцэтгэж иржээ. Аймгийн зонхилогч, холбооны тэргүүлэгч нар өөрийгөө төлөөлсөн элч томилон өөр хоорондоо илгээж, түүгээрээ дамжуулан холбоо барьж, мэдээлэл солилцон, санаа бодлоо ойлголцож байсан аж. Монголын нэгдсэн улс байгуулахын өмнө ч, байгуулсны дараа ч элч хэмээх харилцаа холбооны тусгай албаны хүмүүс бий болж дотоод төдийгүй гадаад харилцаанд их үүрэг гүйцэтгэж байжээ. Бичиг үсэг хэрэглээгүй байсан цагт элчид үг цээжлүүлэн хэлүүлэх, толгой холбон шүлэглэж уран хошиноор ёгтлох мэтээр гуйлт, хүсэлт, санаа бодлоо илэрхийлэх нь нэн ойлгомжтой байдаг байсан ажгуу. Элч нарыг хүндэтгэх, аль болохоор дэмжин туслах, хоол ундаар хангах, унаа хэрэглүүлэх, аян замд саад учруулахгүй, амь насанд нь хор хүргэхгүй байхыг хичээдэг заншил уламжлан хэвшсэн бөлгөө. Энэ бүхэн нь Монгол улсаас гадаад улсуудтай харилцах харилцаанд суурь дэвсгэр болж, гадаад харилцаа хөгжихөд ихээхэн нөлөөлсөн ажээ. Чингис хаан цэргийн хүчиндээ түшиглэхийн хамт улс орноо хамгаалах, газар нутгаа өргөтгөх, олон улс оронтой харилцаа холбоо тогтоох, гадаад худалдааг хөгжүүлэхэд дипломат бодлого, ёс горим, арга, ухааныг аль болох оновчтой хэрэглэх зорилт тавьж байжээ. Монгол улсын дипломатын үйл ажиллагаа нь гадаад улс орнуудад тусгай тэмдэг “гэрэгэ” /пайз/ бүхий элч нарыг илгээх, бусад улсын элч нарыг хүлээн авах, гадаад орнуудтай бичиг захидлаар харилцах, гэрээ хэлэлцээр хийх, эвсэл холбоо байгуулах, бусад улс орныг улс төр, цэрэг, эдийн засгийн талаар туршин тагнах зэрэг олон төрлөөр тогтвортой явагдаж байсан аж. Үүнтэй зэрэгцэн монголын гадаад хэргийн зохион байгуулалт, арга ажиллагаа, дипломатын өвөрмөц арга барил, ёс дэг, хэв заншил үүсэн бий болжээ /34.300/.

Гадаадтай харилцах дээд эрхийг хаан барьж, дипломат харилцааны хэргийг гагцхүү хааны нэрийн өмнөөс явуулж байв. Хааны дэргэд гадаад харилцааны албан хэргийг хариуцан хөтөлдөг тусгай ноён, бичээч нар ажиллаж, явуулах бичиг, захидлыг хүлээн авах, уул орных нь хэл бичгээр зохион үйлдэж, төгсгөлд нь уйгаржин үсгээр гарын үсэг зурж хааны тамгыг дарж гүйцэтгэдэг горимтой байжээ. Гадаад харилцааны гол чухал асуудал-дайтах, найрамдах асуудлыг Хуралдайгаар хэлэлцүүлэн шийдвэрлэдэг нь маш ач холбогдолтой байсан болой.

Жишээлбэл, Чингис хаан Тангуд, Алтан, Хорезмтай хийх дайны асуудлыг Их Хуралдайгаар хэлэлцүүлж байсныг өмнө дурдсан билээ.

Их Монгол улсын үед гадаад улсуудад зарагдан явдаг тусгай мэргэжсэн элч нарын үүрэг, хариуцлага үлэмж өндөр болж төлөвшжээ. Элчин харилцааг хөгжүүлэхэд их гүрний хэмжээнд байгуулсан өртөө чухал үүрэг гүйцэтгэж байсныг сурвалж бүтээлүүдэд тэмдэглэсэн байдаг. Өртөөний аль ч сууринд унаа хөсөг, улаач, хоол хүнс, сууц үргэлж бэлэн байж, маш түргэн шуурхай үйлчилдэг хатуу журам тогтсон байна.



Элч нарт онцгой эрх үүргийг нь баталсан алт, мөнгө, хүрэл болон модон “гэрэгэ”-г тэдний хэргим, тушаалыг харгалзан олгодог байжээ. Алтан “гэрэгэ” нь өргөөшөө алга, уртаашаа хагас тохойн чинээ /18.145/ хэмжээтэй бөгөөд түүн дээр хааны зарлиг бичээстэй байна. Алтан “гэрэгэ”-тэй элч нь юу дуртайгаа тушаах эрхтэй агаад тэрхүү тушаасан бүхнийг ямарч саадгүй биелүүлнэ /18.145/.

Хааны Алтан “гэрэгэ”-тэй элч нь хааны онцгой эрх бүхий бие төлөөлөгч учир хамгийн өндөр хэмжээнд хүлээн авч үйлчилнэ. Хааны элчийг хүндэтгэн өнгөрүүлэх, эрхэм суудалд суулгах, харуул гаргаж хамгаалах, хэнгэрэг дэлдэн, хөгжим дуугарган, далбаа барьж угтан авах журамтай. Энэ тухай 1221 онд Бээжин хотод их хааны төлөөний сайд Мухулайтай уулзсан Өмнөд Сүн улсын элч Жао Хун өөрийн тэмдэглэлдээ тодорхой бичсэн байдаг бөлгөө. Монголын нэгдсэн улсын гадаад харилцааны бодлого нь улсынхаа туурга тусгаар байдлыг олон улс оронд ойлгуулах, улсаа олон улсын тавцанд гаргаж, нэр хүндийг нь өргөн мандуулах, сүр хүчтэй, тогтвортой, ирээдүйтэй агаад түүний хаан нь эрдэм ухаан, авьяас чадвар, эрэлхэг зориг, холч бодлого, эрч хүчтэйг харуулах, энэ улстай эв найртай байхгүй бол болохгүй юм байна гэдгийг хүндэтгэн мэдрүүлэхэд оршиж байсан ажгуу. Монгол улсын хаан нь Тэнгэрээс заяатай, түүний газарт илгээсэн элч, тэнгэрлэг, “Их хаан” болохыг тунхаглан зарлаж, эрдэм чадал, сүр хүчийг нь өргөн мандуулж байсан нь зөвхөн хааны тухай бас зөвхөн түүнд зориулагдсан бус мөн монгол улсын хүч чадал, нэр хүнд, дэлхийн хэмжээний улс болохыг илэрхийлсэн утга санааг агуулж байжээ. Эл бодлого нь Тэмүүжинг Монгол улсын хаанд өргөмжлөхдөө “Чингис” буюу “Далай” хаан гэсэн өвөрмөц содон нэр, цол хайрласнаар /52.132/ эхэлсэн болой. Чингис хаанд өргөмжлөгдөх агшинд түүнд өргөн гардуулсан “Их Монгол улсын далай хааны тамга” /76.105/ гэсэн төрийн тамга үүний нэгэн нотолгоо мөн. Монголын нэгдсэн улс бол жирийн бус харин “Их” улс мөн гэсэн утга энд бүрнээ бууна. Далай хааны тамганд сийлэгдсэн бичгийн “мөнх тэнгэрийн хүчин дор” хэмээх нь тэнгэрээс заяасан дэлхийн улс, “Их Монгол улсын далай хааны зарлиг” гэсэн нь энэ их улсын хүчирхэг хаан, түүний зарлиг шийдвэр, “Ил болгон дор хүрвээс биширтүгэй аюутугай” гэсэн нь их хааны зарлиг шийдвэрийг сонссон бүхэн үг дуугүй бишрэн сүрдэж дагах хүч чадалтайг илэрхийлнэ.

Энэ л бодлого, утга санааны үүднээс Монгол улс, түүний их хаан дэлхийн улс, тэдгээрийн хаад, эзэдтэй харилцах ёстой байсан ажгуу. Монгол улсын төр, их хааны сүр хүч, нэр төрийг илтгэж илэрхийлсэн дээрх үгс гадаад улс оронд явуулах бичиг, айлтгал, элч төлөөлөгчийн гэрээг, гэрээ хэлэлцээр, төрийн ёслолын үг зэрэгт бичигдсэн, хэлэгдсэн байх хатуу ёс үйлчилж байсан байна. Эдгээр нь бүхэлдээ улс нь тусгаар Их Монгол улс, төр нь хүчирхэг нэгдмэл хаант төр, төрийн тэргүүн нь хэмжээгүй эрх мэдэл, нэр хүнд, хүчин чадал төгс их хаан болохын цогцолсон илэрхийлэл, албан ёсны баталгаа мөн байсныг ажаамуй.

Монгол улс XIII зууны эхэнд хөрш зэргэлдээ улс орнуудтай сайн харилцаа тогтоох, эв найртай байхыг ихэд эрхэмлэж байсан байна. Тухайлбал Тангуд улс /Баруун Ся улс/, Зүрчидийн Алтан улс, Хятадын Сун улс, Зүүн Ся улс, Ляо улс, Солонгос улс, Хар Хятан /Баруун Ляо/ улс, Хорезмын улс, Уйгурын улстай харилцах өргөн бодлого явуулж байжээ. Монгол улс Тангуд улстай харилцах харилцаанд ихэд анхаарч, хүчээ нэгтгэн хамтран ажиллах, харилцан туслалцах, эв найртай байх бодлого явуулж байв.

Тангуд улс монголын Хэрэйд, Найман аймгуудтай өргөн харилцаатай байж, мал аж ахуй, газар тариалан хосолж, гар урлал, худалдаа нилээд хөгжсөн нь хоёр улсын харилцааны үндэс суурь болж байв. Харин Тангуд улс Монгол улстай харилцахдаа сөргөлдөх байр суурь баримталж ирсэн нь эерэг бус нөхцөл байдлыг бий болгож байсан аж. Жишээлбээс, Хэрэйд, Наймны дайнд ялагдсан ноёд, язгууртныг нутагтаа орогнуулах, цэргийн тусламж үзүүлэх амлалтаасаа няцаж буцах, байгуулсан гэрээ хэлэлцээгээ зөрчих, худалдааны замыг хаах зохисгүй үйлдлийг Тангуд улс удаа дараалан хийж байжээ. Энэ нь ч хоёр улсын хооронд хэд хэдэн удаа дайн байлдаан болоход хүргэсэн байна.

Чингис хаан, 1205 оноос эхлэн Тангуд улсыг тандаж цэргийг Елүй ахайгаар толгойлуулан илгээж зарим цайз газрыг нь эзэлж байсан боловч цааш нь лавшруулалгүйгээр буцаан татаж “Тангуд улсаас Монголд өргөл өгөх гэрээ байгуулсан” /76.15/ ажээ. Чингис хааны энэ алхам нь Тангудтай дайтах бус харин эв найртай байж, Монгол улсыг хүлээн зөвшөөрч байгаагаар илэрхийлж, өргөл өргөж байхыг тохироход чиглэж байсан нь Чингис хааны гадаад бодлогын нэгэн тактик байжээ.

Чингис хаан 1209 оны намар Тангуд улсад дахин довтолж ялан дийлсэн ч гадаад бодлогынхоо үүднээс Тангуд улс Монгол улсын тогтнолыг хүлээн зөвшөөрч, Тангуд улсаар хууль ёсоор баталгаажуулах зорилго агуулж байсан нь илт байна. Яагаад хэмэвээс Чингис хан Тангуд улсыг байлдан эзэлсэн авч “Тангудын эзэн хаан Ли Ань Чуань Монгол улсад хандаж дагаар орж /буун өгч/ баруун гар чинь болж хүчээ өгье хэмээн Чага нэртэй охиноо Чингист авчирч өгсөн” /51,221/ тухай гэрээнд үндэслэсэн нь хууль зүйд нийцэж байсан бололтой.

Дараагийн шатанд /1218 онд/ Чингис хаан Тангуд улсад дөрөв дэх удаагаа довтолсон нь гадаад харилцааны дипломат бодлоготой холбоотой байсан ажээ. Учир юун хэмээвээс Тангуд улсын хаанаас Монгол улсад өргөл барьж, эв найртай харьцана гэж амласан үүргийг хаан орыг залгамжилсан шинэ хаан Ли Чуань Шиэй биелүүлээгүй, биелүүлэх үйл ажиллагаа явуулаагүй учир хоёр улсын харилцаа тасарсан ажээ. Энэ нь Монгол улсын гадаад худалдаа арилжаанд сөрөг нөлөө үзүүлсэн байна. Өөр нэгэн шалтгаан нь Монгол улсын элч төлөөлөгч, худалдаачдын аян жинг сүйтгэн хөнөөсний учир Хорезмтой хийсэн дайнд цэргийн хүчээр туслахаар хүлээсэн үүргээ үл тоомсорлон биелүүлээгүй явдал байсан ажээ. Энэ тухай Монголын нууц товчоонд Чингис хаан Тангуд Улсын хаанд элч илгээж “Баруун гар чинь больё хэмээсэн биш үү. Сартуул улсад алтан аргамжаагаа таслуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил” /51.224,225/ гэж хэлүүлсэнд Тангуд улсын хаан “Хүч хүрэхгүй болбоос хаан юунд болов” /51.230/ гэж хариу өчөөд цэргээ явуулаагүй байна.

Тангудын хаан Ли-Дэ-Вангийн үед /1223-1226/ Монгол, Тангуд улсын харилцаа ихэд хурцадсан түүхтэй. Ли-Дэ-Вангийн цэрэг 1224 оны 5 дугаар сард Монголын нутагт Эзэний голын чиглэлээр нэвтрэн орж довтолсон учир Чингис хаан Их жанжин Мухулайн хүү жанжин Бороор удирдуулсан цэрэг явуулж няцаалт өгүүлжээ. Тангудын хаан Чингис хаанд элч зарж, найрамдах санал тавихад Чингис хаан өөрийн нэг хүүг барьцаа болговол найрамдъя гэсэн хариу өгч Тангудын тал энэ байдлыг зөвшөөрсөн тул Монголын тал цэргээ татсан байна. Үүний дараа Чингис хаан Ли-Дэ ванд элч зарж хүүгээ барьцаа болгон ирүүлэхгүй байгааг асуулгаж, анхааруулж байжээ. Гэвч Тангуд улс Монголтой байлдахаар дахин бэлтгэж, Алтан улсаас цэрэг Зэбсгийн тусламж авахаар хэлэлцээ хийж, энэ тухай Алтан улсын хаан Айзун, Жэн Дэ-гийн анхдугаар оны /1224/ өвлийн 10 дугаар сар, шороон морин өдөр Ся улс элч томилон ирүүлж, эвсэн найрамдахыг зорив хэмээн Алтан улсын түүхэнд тэмдэглэсэн байдаг /76.192/. Чухам үүний үндсэн дээр Алтан улсын Тангуд улсад цэрэг, Зэбсгийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээрт 1225 оны 10 дугаар сард хоёр тал гарын үсэг зуржээ /57.135/.

Чингис хаан, барьцааны хүүгээ ирүүлээгүй, Алтан улсаас цэрэг, Зэбсгийн тусламж авахаар хэлэлцээр байгуулсан зэргийг “Тангуд урвасан” /76.192/ гэдгийг харуулж, хоёр улсын харилцаа туйлдаа хүртэл хурцадсаныг харгалзан 1226 онд Тангуд улсын цэрэгтэй байлдаж эцсийн цохилт өгч ялалт байгуулснаар хоёр улсын харилцаа төгссөн ажгуу.

Түүхээс үзэхүл Монголын нэгдсэн улс, Чингис хаан, хятадын Алтан, Сүн улстай харицлах харилцаанд их анхаарал тавьж байсан аж. Алтан улс нь “Дундат улсын умард орныг эзлэж байсан нэгэн феодалын хаант улс болно” /76.20/ Тус улс нь Монгол улсын өмнөд хөрш, худалдааны их түнш байсан аж.

Хятадын нэрт эрдэмтэн Сайшаалын нотолсноор Алтан улс нь “нэг талаар олон тооны их цэргийг “гурван жил бүр” /хэрэг дээрээ жил бүр/ Монгол оронд илгээж, алан хядах, талхин дээрэмдэх зэрэг харгис үйл ажиллагаагаа Монголын ард түмэнд тулгаж байсан” /76.22/ байна. Нөгөө талаар “Монголын аймгуудыг хагаралдуулж, хооронд нь алалдуулж байв”. Мөн монголтой хийх “Худалдаа арилжааг хавчин боогдуулж, ... өргөн хэрэглээний эд таваар, хүнс хэрэглэгдэхүүнээр ихээхэн гачигдуулж байв” /62.128/

1206 онд Монголын нэгдсэн улсыг байгуулсны дараа ч Монгол улс Алтан улсын хааны удаа дараагийн довтолгооныг няцаан дарж байв.

Чингис хаан хэдийгээр Алтан улсыг хаан албатаа хэмээн үздэг ч түүнийг үл тоон урьдын өшөө хорслоо ч гол бус хэмээн үзэж гагцхүү Алтан улсын зүгээс явуулах довтолгооныг зогсоох, цэрэг Зэбсгийн талаар харилцан бие биедээ туслах, худалдааны өргөн харилцаа тогтоохыг эрмэлзэж байжээ. Гэвч Алтан улс Монголын талаар ямагт дайсагнах бодлого баримталж байв. Ийм нөхцөлд Чингис хаан эв найртай байх, эс болбоос довтлон байлдах хоёрыг хосолж хэрэглэх бодлого явуулжээ. Алтан улстай харилцах Монгол улсын гадаад харилцаа ч үүнд чиглэгдэж байсан ажээ.

Чингис хаан, Алтан улсад элч зарж Их Монголын нэгдсэн улсын хаанд өргөмжлөгдсөнөө мэдэгдэн, ихээхэн хэмжээний билэг хүргүүлснийг Чжэнду хотод Алтан улсын хааны ойр төрлийн Вэй Ван Юнь Чжи хааны нэрийн өмнөөс хүлээн авч байжээ.

Энэ нь Монголчууд өөрийн бие даасан нэгдмэл улс байгуулснаа мэдэгдэж найртай харилцаатай байхыг хүссэн Чингис хааны Алтан улстай харилцах бодлогын анхны том илрэл байсан ажгуу. Алтан улсын хаан Чжан Цзун 1208 онд нас барж, оронд нь Вэй Ван Юнь Чжи хаан ор суусан байна. Алтан улсын шинэ хаан 1208 онд хаан ор суусан сүржин зарлиг бичгийг онцгой элч зарж Чингис хаанд ирүүлжээ /57.112/. Чингис хаан Алтан хааны элчийг Хэрлэн мөрний эхэнд түр өргөөндөө хүлээн авч зарлиг бичигтэй нь танилцжээ. Эл зарлиг бичигт “Тэнгэрийн хөвгүүн миний энэхүү зарлиг бичгийг Чингис чи сөгдөн хүлээж авах ёстой” /57.113/ хэмээн тушаажээ.

Чингис хаан ”Би юунд түүний өмнө сөгдөн бөхөлзөх билээ” хэмээн Юан улсын судрын Чингисийн шастирт тэмдэглэснээс үзэхэд Монгол, Алтан хоёр улс эрх тэгш байдлаар, биеэ даасан улсуудын хувиар харилцах бодлого баримталж байсан нь тодорхой байна. Чингис хаан Алтан улсын түрэмгийлэлээс хамгаалах, дээрэнгүй, тэгш биш харилцааг өөрчлөх, тус улсын хүчин чадлыг бууруулж, Монгол улсын хүч чадлыг нэмэгдүүлэх тусгай бодлого явуулжээ.

Тухайлбал, Тангудын нутгийг түшиц газар болгох, Алтан улстай хүч хавсран тэмцэх, Алтан улсын бүрэлдэхүүнд байдаг хятанчуудтай холбоо тогтоож, Алтан улсын ноёрхлын эсрэг хамтран тэмцэх, Алтан улсын хойт хилийг хамгаалж байсан

Онгуд аймгийг талдаа татаж бүрэлдэхүүндээ оруулах зэрэгт анхаарлаа хандуулсан байна. Алтан улсын ноёрхолд дургүйцсэн хятанчууд 1212 онд Елюй-Люге ноёны удирдлагаар Алтан улсын хааны эсрэг үймээн гаргаж, улмаар түүнийг хятан нарын хаанаар өргөмжилөн Монголд дагаар орсон нь Чингис хааны дипломат болон гадаад харилцааны үйл ажиллагааны нэгэн чухал ололт мөн байв.

Чингис хаан, монголчуудын үйлсийг дэмжиж байсан Ongud нартай холбоо барьж талдаа татахаар дипломат арга ухаан зарсан түүхтэй. Үүний үр дүнд 1211 оны 5 дугаар сард Ongud аймгийн эзэн АлгушТеген Чингисийн үйлсийг дэмжин Монгол улсад дагаар орсон байна. Чингис, Тегентэй ургийн холбоо байгуулан, ахмад хүүд нь өөрийн охин Алуха бэхийг гэргий болгон өгчээ. Мөн Ongудын ноён Алахуш-Дигитхур Чингисийг дэмжин үнэтэй мэдээлэл өгч байгаад баригдаж цаазлагдсан. Алахуш-Дигитхурын гэргий, хүүхдийг хүлээн авч соёрхол үзүүлэв. Удалгүй Ongудаас Монголчуудтай хамтран ажилласны учир Ongud ноён Нэгүдэйд Тулуйн охиныг гэргий болгон өгч, ургийн холбоо тогтоожээ. Энэ мэтээр Чингис хаан Ongud нарыг талдаа бүрэн татсан нь Алтан улсын хойт хамгаалалтыг эзэнгүйдүүлж, Алтан улсын ноёрхлын эсрэг тэмцэхэд ихээхэн үнэтэй хувь нэмэр болсон ажгуу.

Чингис хаан Алтан улс руу 1213 онд аян дайн хийх явцад өөрийг нь давшуулахгүйн тулд найрамдах элч болгон явуулсан хятан угсаатны Ши Мо Мянгантай хэлэлцээр хийж, Алтан улсын эсрэг хамтран тэмцэх санал тавьж, сэтгэл санаагийг нь сэргээн тэтгэсэнд монгол хэл сайн мэддэг Ши Мо Мянган, монгол угсаатныхаа талд орон Чингисийн албанд зүтгэхээр зориг шулууджээ /62.113/. Чингис хаан түүнд их итгэл үзүүлэн монгол цэргийн жанжин болгон цэрэг захируулсан байна. Ши Мо Мянган жанжин монгол цэрэг захиран Чжэн-Жүндүгийн төлөө тулалдаанд оролцож, баатар зоригоор шалгарч том гавьяа байгуулсан ажээ.

Чингис хаан, Алтан улстай удаан хугацаагаар хийсэн дайны явцад ч гэсэн нухацтай тайван хандаж, ардын дипломат арга ухааныг хэрэглэж байсан бөлгөө. Чингис хаан 1214 онд Цагаан хэрмийг давж ихээхэн амжилт олон, Алтан улсын нийслэл Чжэндү хотыг бүслэн хүнд байдалд оруулсан үедээ Алтан улсын хаанд элч зарж “Алтан улсын эзэн чи хараат болж алба өргө. Хаан цолоо бууруулж ван болго” /170.114/ гэсэн шаардлага тавьжээ. Энэ нь миний улс хүчирхэг том улс, харин Алтан улс бол ялагдаж байгаа бөгөөд манай улстай эн зэрэгцэхгүй, улс биш болсон хэмээн үзэж тайван, хохирол багатайгаар буулгаж авах гэсэн санааг илэрхийлж байсан болой. Чингээд Монголын их хаан эл шаардлагыг биелүүлбэл цагаан хэрмийн ард ухран гарна гэж мэдэгджээ.

Алтан улсын хаан Чингис хааны шаардлага, болзлыг ноёдынхоо хамт хэдэн өдөр хэлэлцсэний эцэст Чингис хаанд элч зарж, хариу бичиг хүргүүлжээ.

Энэхүү бичигт “эвийн гэрээ байгуулья. Дайнаа зогсооё. Өөрийн гүнжийг, алт, мөнгө, хоргой торго болон 500 охид, хөвгүүд, 300 сайн агт морины хамт өргөл билэг болгон барив” /76.42, 62.134/ гэж өгүүлжээ. Чингис хаан бичгийг хүлээж аваад Алтан улсын хаанд хариу элч зарж, “Чиний улсын Хэбэй, Шаньдун муж минийх болов. Мөнх тэнгэр чамайг ивээсэнгүй. Чи гагцхүү Чжэнду хотоо сахих болов” /76.41/ гэж хэлүүлжээ. Чингис хаан 1215 онд их цэргээ аван нутаг буцаж, хятадыг захирах эрхийг Мухулай жанжинд олгосон болой.

Харин Чингисийн их цэрэг нутаг буцсаны дараа Алтан улсын хаан хүлээсэн үүргээ үл биелүүлж, улсын нийслэлээ өмнө зүгийн Нанжин хотод шилжүүлэн, Монголтой дахин байлдахаар бэлтгэж эхэлсэн ажээ. Чингис хаан энэ мэдээг хүлээн аваад ихэд харамсаж, Алтан улсын хаан хэлэлцээг арга бааш болгон ашиглаад, хүчээ өмнө зүг төвлөрүүлэн байлдах гэсэн хэрэг хэмээн үзэж, Хятадыг дайлах, Чжэндүг бүслэн хааж, эзлэн авахыг Хятадыг захирах Мухулай жанжинд даалгажээ.

Алтан улсын хаан дахин найрамдлын гэрээ байгуулах санал тавьсан ч Чингис хаан хүлээж аваагүй байна. Чингис хаан Өмнөд Хятадын Сүн улстай холбоо тогтоож харилцах нь чухал юм гэсэн дүгнэлтэд хүрсэн болой. Чингис хаан Өмнөд Сүн улстай 1214 оноос элчин харилцаа тогтоож эхэлсэн байна. Монголын нууц товчоонд тэмдэглэсэнээс үзэхэд Чингис хаан нохой жил буюу 1214 онд Жубган тэргүүтэй олон элчийг Сүн улсын Жүэ хаанд явуулж хоёр улсын хооронд эвийн гэрээ байгуулах санал тавьжээ.

1221 онд Сүн улсын элч Жао Хун Бээжин хотод ирж Чингис хааны төлөөний сайд Мухулайтай уулзаж хэлэлцээр хийж байжээ. Дээрхи дипломат үйл ажиллагааны үр дүнд Сүн ба Их Монгол улсын хооронд цэргийн холбоо тогтож, цэрэг Зэбсгийн туслалцааг харилцан бие биедээ үзүүлэх болсон байна. Эл холбоо нь Алтан улсыг ганцаардуулах, Сүн, Монгол хоёр улс хавсарсан хүчээр Алтан улсын цэрэгт цохилт өгөх бололцоог нээж өгсөнөөрөө ихээхэн ач холбогдолтой байжээ. “Алтан улсын эсрэг Монгол, Сүн улсын хооронд цэргийн холбоо бий болсон нь Чингисийн дипломатын нэг том амжилт болсон бөгөөд тэр нь Алтан улсыг Сүн улстай хавсайдан цохиход их тус нэмэр болжээ”/57.304/. Сүн улс, Алтан улстай олон удаа тулалдаан хийж, удаан хугацаагаар дайны нөхцөлд оршиж байсан учир хүчирхэг Монгол улстай холбоо тогтоох сонирхолтой байсан аж. Монгол улс ч удаа дараа итгэл эвдэж, байгуулсан гэрээ хэлэлцээр, амлалтаа биелүүлээгүй Алтан улстай удаан хугацаагаар зууралдах сонирхолгүй байсан байна. Сүн улс ба Монголын холбоо харилцаа нь Алтан улсын цэргийг бүр мөсөн бут цохиж, тус улсыг мөхөөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Их Монгол улс Гуулин улс буюу Солонгос улстай харилцаа холбоо тогтоож эхэлсэн байна. Гуулин улс, Алтан улсад жил бүр өргөл барьдаг харилцаатай байсан учир Алтан улсыг ганцаардуулахын тулд энэхүү холбоог таслах бодлого баримталж байв.

1211-1217 онд Алтан улсыг дайлах үед Жиншань тэргүүтэй Хятаны үлдэгдэл есөн түмэн хүн Гуулин улсад зугтан гарч, Жияндүн хотыг нь эзлэн тус орныг түйвээсэн байна /76.55/. Иймээс Чингис хаан 1218 оны 12 дугаар сард Хажин, Жалайрын Хачигуун Тохорхунаар манлайлуулж, Жалайрын Хорчи, Хятаны Лёохэ, Зүүн Ся улсын Ванчин Зиюа нараар захируулсан 10 түмэн цэргийг Гуулин улс руу илгээж, Хятаны оргодлуудыг дайлуулжээ. Гуулинд монгол цэрэг, гуулин улсын жанжин Жуу Чүнтэй хамтран байлдаж, 1219 оны хавар болоход Жиньшагийн удирдсан оргодол Хятанчуудыг бүр мөсөн бут цохиод, монгол цэрэг тус улсаас гарч явжээ. Гуулин улсын эзэн Ван Цэ монгол цэрэгт ихэд талархаж, түшмэл Шу-Ли /Батлан хамгаалах сайд/ монгол цэргийн захирагч Жуу Чүн, Жалайрдай нартай журмын ах дүү бололцжээ. Гуулин улс нь Монгол улсад жил бүр өргөл барьж байхаар тогтжээ /76.55/. Чингэж Монгол, Гуулин улсын харилцаа Чингис хааны үеэс эхэлсэн ажээ.

Чингис дорно дахин төдийгүй өрнө дахин, баруун зүгийн орнуудтай харилцаа холбоо тогтоох, худалдаа арилжаа хийх, газар тариалан, гар үйлдвэрлэл, бичиг соёлоос суралцах, хамтран ажиллахад ихээхэн анхаарал тавьж байжээ.

Юуны өмнө Монголтой хөрш зэргэлдээ орших Хар Хятан, Уйгурын улстай харилцаа тогтооход анхаарлаа хандуулсан байна. Хятан үндэстний байгуулсан Ляо улс 1125 онд Алтан улсад мөхөөгдөж, тус улсад харъяалагджээ. Харин Хятан хааны угсааны Елүй Даши баруун тийш нүүж байгуулсан Хар Хятан буюу Баруун Ляо улс Монгол улсын баруун хилийн залгаа оршиж байжээ. Найманы хүү Хүчүлүг Хар Хятаны Гүр хааны ивээлд орж, улмаар Хорезмын шахтай холбоо тогтоон, Гүр хааныг сөнөөн Хар Хятаны эзэн болжээ. Ийм нөхцөлд Чингис Хар Хятаны лалын шашинт хүмүүстэй харилцах, тэднээс лалын шашныг гадуурхан, хавчиж байгаа Хүчүлүгийн төрийг түлхэн унагах арга сүвэгчилж байгааг дэмжих, цэргийн тусламж үзүүлэх бодлого явуулсан байна. Чингис хаан 1218 онд Зэб жанжинаар захируулсан 2 түмэн элч цэргийг илгээж, Хар Хятанг аль болохоор талдаа татах, шашин шүтлэгийг нь хүндэтгэх, ард иргэдийг нь айлган сүрдүүлэхгүй, тонож дээрэмдэхгүй байх, тэднийг элэгсэгээр элбэн тохинуулах даалгавар өгчээ. Энэ нь Чингис хаан Хар Хятан, түүний ард түмэнд зориулсан дипломат арга ухаан байсан бөлгөө. Үүний зэрэгцээгээр Хар Хятаны ард түмнийг дарангуйлж байсан Хүчүлүгт цохилт өгөх үүрэг өгсөн байна.

Чингис хааны энэхүү дипломат тактик, арга ухаан амжилтад хүрчээ. Зэб жанжин Хятанчүүд дуртай шашнаа шүтэж болно. Хүчүлүгийн дарлалаас ангижирахад бид туслана.

Аж ахуйгаа чөлөөтэй эрхэлж, худалдаа арилжаа хийж болно гэх зэргээр ухуулга хийж, Чингис хааны арга ухааныг хэрэгжүүлсэн нь Хятанчуудын дэмжлэгийг олж, Хүчүлүгийг түшиг тулгуургүй болгожээ /62.13/. Нэгэнт Хятанчуудын дэмжлэгийг авч чадахгүй болсон Хүчүлүгийн цэрэг бут цохигдож, өөрөө алагджээ.

Ийнхүү Хар Хятан Монголчуудын талд орсоноор Дорнот Туркстан, Дундад Азийн зарим нутаг Монгол улсад хамаарагдаж, Монгол улсын хил хязгаар нь Хорезм улстай шууд залгах болжээ /62.133/. Чингис хааны гадаад харилцаанд Уйгур улс чухал байр эзэлж байв. Уйгур нь IX зуунаас суурин амьдралд шилжиж, бичиг үсэг, утга зохиол хөгжсөн, Түрэг-Монголын бусад ард түмэнд соёл иргэншлийг түгээсэн, монголчуудтай нэн ойр дотно ард түмэн байжээ. Тэнгэр уулын зүүн хойд хэсэгт орших Бешбалык идүүд хэмээх сайд, ноёд төвлөрөн суудаг хант улсыг Барчук гэдэг ухаалаг хэрсүү ноён толгойлж, Чингис хааныг ихэд дэмжин байсан аж. Уйгурын эзэнтэн Идикут Чингис хаанд элч зарахаар бэлтгэж байжээ. Чингис энэ мэдээллийг авмагцаа Идикут, Алп Упук ба Дурбай хоёр хүнийг элч болгон Барчук ноёнд илгээсэн байна /72.298/. Тэднийг хүрэлцэн очиход Уйгурын Идикут ихэд баярлаж, ёс төртэй хүлээн авч, тэдэнд элэгтэй байгаагаа элдвээр илэрхийлж байлаа. Чингээд Чингис хаанд Варгуш Иш айгучи ба Алгин-Төмөр-Түтүк хоёр хүнийг элчээр хамт явуулав. Идикут “Дэлхийг байлдан дагуулагч, хорвоо ертөнцийг эзэмдэгч таны эрэлхэг хүчин, цог жавхлан, хурц догшин, хатуу ширүүний тухай би ирэгсэд ба одогсодоос дуулсаар байна. . .

Ингээд бүх Уйгур орноо өргөн бариад, өөрөө би Чингис хааны хөвгүүн нь, боол нь больё” /72.298-299/ гэж хэлүүлжээ. Үүний дараа Идихүт өөрийнхөө нөхөр цэргээс Арслан үгэ, Жарух уга, Болд тегин, Инал-хай-сүнчи нарыг элчээр зарж мэдээлэл хүргүүлжээ. Чингис хаан их тааламжтай байгаагаа илэрхийлэн “Хэрэв Идикут бидэнд чармайн зүтгэе гэж чин зүрхнээсээ бодож байгаа бол . . . сан хөмрөгтөө бэлэн байгаагаа аваад өөрөө ирж алба барьтугай” /72.299/ гэжээ. Чингис энэ хэргээр Алп-Унуга, Дарьбай нарыг Идикутэд дахин элчээр заржээ /72.299/. Идикут элчийн үгийг сонсоод өөрийн биеэр 1211 онд Монголд ирж Чингис хаанд бараалхсан байна. Ийнхүү дипломат ажиллагааны үр дүнд Уйгурын хант улс монголд дагаж орсоноор Монгол улс торгоны замыг хяналтандаа байлгаж байх бололцоотой болжээ /74.211/.

Чингис хаан, Хорезмын их гүрэнтэй гадаад харилцаагаа хөгжүүлэхийг ихэд эрмэлзэж байв. Хоёр их гүрэн улс төрийн эрх мэдлийн төлөө төдийгүй, Дундад Азийн олон улсын худалдааны онц эрхийг булаацалдан өрсөлдөж байжээ. Чингис хаан, Хорезмын эсрэг дайн эхлэхэд тус орны хаан Мухаммедыг бодоход дипломатын талаар илүү хожоотой бодлого явуулж чаджээ /57.305/.

1215 онд Хорезмын шах Мухаммед айл хөршийн найрамдалт харилцаа тогтоох, харилцан худалдаа хийх санал тавьж, Чингис хаанд Бех Ад-Дин тэргүүтэй төлөөлөгчдийг томилон явуулжээ /104.423/. Энэ нь Чингисийн Дундад Азитай худалдааны харилцаа тогтоох гэсэн эрмэлзэлтэй яв цав нийцсэн байна. Тийм учраас Хорезмын элчийг хүндэтгэн хүлээн авч, харилцан худалдаалах явдлыг дуртайяа зөвшөөрч байгаагаа мэдэгджээ /62.139/.

Чингис хаан, Хорезмын Шахын элчийн хариуд Монголд амьдарч байсан Мухаммедын өөрийн нь харьяат Хорезмын Махмуд, Бухарын Али-Ходжа, Отрарын Юсуф Канка гэдэг гурван хүнийг элчээр илгээж, Султанд ихээхэн үнэтэй билэг хүргүүлжээ. Султан эдгээр элчийг 1218 онд хүлээн авчээ /74.216/. Үүнээс хойш хэсэг хугацаа өнгөрсөний дараа Чингис хаан тавьсан саналаа хэрэгжүүлэх зорилгоор алт, мөнгө, хятад торго, хоргой, ноосон эдлэл, булга, халиу, минжний арьс тэргүүтнийг ачсан 400 гаруй хүнээс бүрэлдсэн худалдааны хөсгийг Хорезм руу хөдөлгөжээ.

Хөсгийн даамлаар Монголд амьдардаг лал хүмүүс болох Отрарын Омар Ходжа, Морагийн Гаммаль, Бухарын Фахрадинизаки нарыг томилсон байна. Мөн тэднийг дагалдуулан өөрийн бие төлөөлөгч Ухуна гэдэг хүнийг Чингис хаан илгээжээ.

Түүнээс гадна шадар ноёд болон цэргийн жанжинууд, бусад дээд зиндааныхаа тус бүр нэг хүнд мөнгө өгөн хөсгийн хамт явуулж, Хорезмын үнэт эдлэлүүдээс авчрахыг Чингис хаан хүссэн байна. Дорнот Ази, лалын ертөнц хоёрын хоорондын худалдаа наймааны ажлыг өргөтгөхийг Чингис хаан ихэд эрмэлзэж байсан нь эндээс харагддаг /74.217/. Чингис хаан Мухаммедад бичсэн захидалдаа танай орноос манай улсад худалдаачид ирэв. Бид тэр ёсоор өөрийн худалдаачдыг томилон явуулж, танай орноос зүйл бүрийн гайхамшигт эдлэл, бараа авахыг хүсэж байна. Манай хоёр орны хооронд айл хөршийн найрамдалт харилцаа тогтоно гэдэгт итгэнэ гэх зэргээр бичжээ /34. 79/.

Гэвч худалдаачдын их хөсөг Хорезмын Отрар хотод ирэхэд хотын Султаны амбан Инальчук Кадыр хөсөгт халдан бараа таваарыг булаан дээрэмдсэн төдийгүй элч Ухуна болон бүх худалдаачдыг алжээ. Худалдаачдаас оргож ирсэн нэгэн хүн Монголд ирж Чингис хаанд айлтгахад Чингис маш их хилэгнэж, харамсан уйлж байжээ.

Үүний дараа Чингис хан Бахра хэмээх турк угсааны хүнийг, хоёр монгол хүний хамт элч болгон Мухаммедад илгээж “Чи энэ орны худалдаачны мууг үзэхгүй гэж над итгүүлэн байсан. Чи үгэндээ хүрсэнгүй. Ийм үнэнч биш байх нь хаан хүнд жигшүүртэй. Хэрэв би чиний буруугаар худалдаачид алагдаагүй гэж үзэх ёстой бол чиний тэр хотын даргыг надад залхаан цээрлүүлэхээр тавьж өг. Хэрэв өгөхгүй бол байлдахад бэлтгэ” /135.130/ гэж бичжээ. Гэвч Хорезмын шах Мухаммед гурван элчийн хоёр монголыг нь алаад, ахлагч Бахрагийн сахлыг тайрч гэдрэг хөөн явуулжээ.

Хорезмын шах Мухаммедын дипломат харилцаанд харш ёс бус энэхүү удаа дараагийн үйлдэл, үйл ажиллагаа нь Монгол, Хорезм хоёр улсын харилцааг эрс хурцатган, амь өрссөн ширүүн дайн үүсэхэд хүргэж, улмаар энэхүү дайн нь Хорезм улсыг мөхөөсөн түүхтэй бөлгөө. Монголын нэгдсэн улсыг байгуулж, бэхжүүлэхэд “дан ганц цэрэг зэвсгийн хүч бат, дипломат алтан аргамжийн бодлого дутахгүй үүрэг гүйцэтгэсэн билээ” /84.51/. Үүнийг Монголын Нэгдсэн улсын гадаад харилцаа, түүний хөгжсөн үйл явц нотлон харуулж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Монголын нэгдсэн улсын төрийн байгуулал

§1. Төрийн хэлбэр ба улсын хаан

Чингисийн байгуулсан Монголын нэгдсэн улс нь төрийн удирдлагын хэлбэр, шинж байдлаараа хэмжээгүй эрхт хаант улс байв. Ч.Жүгдэр "Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ" хэмээх бүтээлдээ монголын төрийн өмнөх уламжлал дээр сүндэрлэн боссон монголын нэгдсэн тулгар төр юуны өмнө ойр төрөл овог, аймгуудийг хураасан хэмжээгүй эрхт хаант улс байлаа /32.98/ гэж XIII зууны эхээр бүрэлдэн тогтсон монгол угсаатны их улсын төрийн удирдлагын хэлбэрийг тодорхойлон бичжээ. Хүн төрөлхтний соёл иргэншлийн дундат үеийн феодалт ёсон бүхий хаант засагт улсад угсаа залгамжлах замаар өргөмжлөгдсөн хаан төрийг тэргүүлэн, төрийн дээд эрх мэдлийг гартаа төвлөрүүлж, улсаа жолоодон захирах шийдвэрийг эцэслэн гаргадаг их эрх мэдэлтэй байх нь нийтлэг шинжтэй байсан бөлгөө.

Өөрөөр хэлбэл, засгийн бүх эрх мэдэл нэг хүн буюу хаанд төвлөрч, тэр нь төрийн байгуулалт, хууль цаазаа тогтоон, улсын дотоод гадаад бодлогоо гардан барьж, цэрэг армийг удирдах, шүүн таслах хэргийг шийдвэрлэх талаар дээд эрх эдэлж байсан ажээ. Энэ үүднээс үзвээс Монголын нэгдсэн улсын хааны хувьд нилээд онцлог буй бөлгөө. Монголын нэгдсэн улсын хаан нь Монголын язгууртны Их Хуралдайгаар сонгогдон өргөмжлөгдсөн далай их хаан болно. Монголын нэгдсэн улсын их хаан тэр үеийнхээ язгууртнуудын өрсөлдөөн дундаас ялгаран шалгарч, тодорсон тэнгэрлэг агаад авьяаслаг аугаа хүн байсан ажгуу.

Чингис хааны эцэг Бодончарын угсааны Есүхэй хэмээх ер бусын хүч чадалтай баатар эр байжээ. Есүхэй, түүний хатан Өүлэн хоёрын дундаас заяасан ууган хөвгүүн нь 1162 оны зун Онон мөрний Дэлүүн болдог хэмээх газар хорвоод мэндэлсэн Тэмүүжин ажгуу.

Тэмүжиний төрсөн он, сар, өдрийг тогтоох талаар олон эрдэмтэд, ялангуяа Монгол, Хятад эрдэмтэд ихээхэн хичээл зүтгэл гарган үр дүнд хүрсэн нь тодорхой харагднам.

Манай ахмад эрдэмтэн Ш.Нацагдорж, Н.Ишжамц, Х.Пэрлээ, Ч.Далай нар Тэмүжний төрсөн он 1162 он болохыг олон баримтаар нотлон санал нэгтэй тогтоожээ. Ч.Далай "Юан улсын судар"-т "Хорин хоёр он, улаагчин гахай жил /1227/, намрын долоон сар, шарагчин үхэр өдөр хаан тэнгэрт халив. Нас сүүдэр жаран зургаа" хэмээн Юан улсын судар. 1 дүгээр бүлэг."Тайц-зу" Чингисийн шастирт бичжээ. Үүнээс үзвэл 1162 онд төрсөн болох нь илэрхий байна" /24.39 / хэмээн өгүүлсэн нь Чингис

хааны төрсөн оныг түүхэн баримтаар нотлон тогтоосон хамгийн сүүлийн нотолгоо болно. Харин Чингис хааны төрсөн сар, өдрийг 4 дүгээр сарын 16-ны өдөр хэмээн Ш.Нацагдорж, Ч.Далай нар тогтоож, Өвөр Монголын эрдэмтэн Сайшаал дэмжсэн байдаг билээ.

Чингис 28 настайдаа Хамаг Монголын ханлигийн хаан, 45 насандаа Их Монгол улсын эзэн хаанаар өргөмжлөгдөн Монгол туургатны нэгдсэн улсын төрийг 21 жил толгойлжээ. Чингис хаан Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулж тэргүүлснээс хойш тэр үеийн нийгмийн амьдралын бүх хүрээнд дорвитой шинэтгэл хийж, Монголын нэрийг дэлхийн тавцанд гарган алдаршуулснаараа өөрөө ч давхар алдаршиж, ард түмнийхээ сэтгэл зүрхэнд үүрд мөнх үлдсэн болой.

Чингис хаан насан өөд болсныг сурвалж бичигт нэлээд тодорхой тэмдэглэжээ. “Монголын нууц товчоо”-ны 265 дугаар зүйлд “Нохой жил /1226/- ийн намар Чингис хаан тангуд иргэнтэй байлдахаар мордов” 268 дугаар зүйлд “Тангуд улсыг сөнөөн дараад гахай жил /1227/ долоон сарын 12-нд тэнгэрт халив” гэж тодорхой бичжээ. Бас Лувсанданзаны “Алтан товч”-д Чингис хааныг “улаагчин гахай жилийн долоон сарын 12-нд тэнгэр болов” /43.144/ гэжээ. Чингис хаан нас барсан өдрийг “Сүн улсын түүх” /Сунши/, “Юаний түүхийн шинэ эмхэтгэл” /Юан ши Си Бянь/-д 8 дугаар сарын 15, “Юан ши бэн мо” судар, Алтан улсын түүх, Д.Оссоны “Монголын түүх” номонд 8 дугаар сарын 18-нд гэж бичсэнийг доктор Ч.Далай” Монголын түүх, Их Монгол улс” номныхоо 114-р талд дурдаад улмаар сүүлчийн баримтыг нь дэмжиж байгаагаа нотолжээ.

“Монголын нууц товчоо”-ны 202-р зүйлд “Эсгий туургатан улс энх шударга болж, барс жил /1206/ Онон мөрний эхэнд хуралдаж есөн хөлт цагаан тугаа мандуулаад Тэмүүжинд Чингис хаан /Далай хаан/ цолыг өргөв /51.178/ хэмээн шастирлан тэмдэглэсэн нь бидний үед уламжлагдан үлдсэн ховор баримт юм. Тэмүүжин 1206 онд Их Хуралдайгаар Монголын нэгдсэн улсын хаанд өргөмжлөгдөхдөө “Чингис” хэмээх цолыг хүртсэнээс хойш Монголдоо төдийгүй дэлхий дахинаа нэрд гарсан Тэмүүжин хэмээн эцэг, эхээс хайрласан нэрээр бус Чингис гэсэн цолоороо нэршин алдаршсан бөлгөө. Монголын иргэний болон төрийн түүхэнд Чингис хаан гэсэн холбоо үг дэлгэрч улмаар нийт даяарт хоногшин дотношсон билээ.

Чингис хаан бие хүний хувьд ямар дүр төрх, оюун ухаан, зан чанар, авьяас чадавхитай хүн байсныг дүрслэн гаргахыг олон орны Чингис судлаач эрдэмтэд хичээсээр ирснийг тэдгээрийн бүтээлүүд харуулж байна. Өгүүлбээс “Монголын нууц товчоо”-нд Хонгирадын Дайсэцэн Тэмүжинг хараад “Энэ хөвгүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хөвгүүн байна” /51.38/, “Монгол-Татарын бүрэн тэмдэглэл”-д Тэмүжиний “биеийн байдал хүдэр том, магнай өргөн, сахал урт,

төрсөн байдал нь агуу сүрлэг, ер бусын” /172.32/, Марко Пологийн өдрийн тэмдэглэлд Тэмүжиний “төрсөн байдал маш чийрэг хүдэр, билэг ухаан хурц, сэргэлэн, үг хэл гарамгай сайн, эрэлхэг баатарлаг” /48.33/ гэх зэргээр Чингисийн үеийн амьдралыг бичиглэсэн сурвалж бичгүүдэд өгүүлсэн байх нь ихэд анхаарал татахуй. Нэн ховор баримтыг Английн профессор Ж.Саундерс “Монголын байлдан дагуулал” номныхоо “Чингис хаан” гэсэн 4 дүгээр бүлэгт иш татан дурдаж, дүгнэлт хийжээ. Энэ эрдэмтэн ”Чингис хаан бие бялдраар ямар байсныг Персийн түүхч Жузжаны бидэнд бүдэг бичиж үлдээсэн болой. Тэрээр “өндөр нуруутай, тэнхээлэг хүч чадалтай, бууралтсан шингэн үстэй, мууран нүдтэй, маш зоримог, юмыг нүдээр үзэж учрыг олохыг хичээдэг, тархины ер бусын чадалтай, юмыг тусган ойлгохдоо онцгой, харахад аймаар сүртэй, юу ч хийхээс буцахгүй. Яг бодсоноороо шийддэг, дайсныг ялж гардаг, аймшиггүй эрчимтэй, өөдрөг сэтгэлтэй, догшин ширүүн хүн байлаа гэж тэмдэглэсэн байдаг. Бие болон сэтгэлийн иймэрхүү дүрслэл бол айх сүрдэхийн аргагүй хослол байлаа” /78.72/ гэж бичжээ. Ж.Саундерсын, зохиолоос нь иш татсан Жузжани 1226 онд Энэтхэгт очиж Дели хотноо хааны ордонд дээд тушаалын алба хааж байсан нэгэн аж. Тэрээр Чингисийн дүр төрхийг эцэг А.Мостерийн ”Монголын зарим зураг төрхийн тухай” өгүүлэлээс уншиж мэдсэн гэдэг байна. Жузжани нь Чингис, түүний үйл ажиллагааг сонирхон судалдаг хүн байсан агаад 1260 онд нас барсан байна. Энэ бүхнээс үзэхэд Чингисийн хаанчлалын үед амьдарч, түүний тухай бодит баримт мэдээг хүлээн авах бололцоо бүхий хүн байсны хувьд Жузжаны бичсэн зүйл үнэнд ойр байж болох юм.

Академич Ш.Нацагдорж, хөргийг нь ажиглан харахад “дэлгэмэл царайтай, өргөн магнайтай, усгал бөгөөд ухаалаг нүдтэй, шингэн сахалтай, том бие бялдартай хүн байсан нь мэдэгдэж байна” /62.274/ хэмээн бичсэн нь бий.

Эрдэмтэн Сайшаал “Тэмүжин бол өргөн тэнэгэр магнайтай, улаан, цагаан ялгарсан хээнцэр дөрвөлжин царайтай, өтгөн хар хөмсөгтэй, өндрөвтөр тэгш хамартай, хоёр нүд нь хар, бор өнгө ялгарч харагдсан, хоёр чих нь халбигар, их биеийн байдал ханагар өргөн цээжтэй, хавтгай дөрвөлжин мөртэй, хатан ширүүн гартай, хатуу чийрэг том сүрлэг биетэй, сүр жавхлан төгс” /76.93/ хүн байсан хэмээн бичсэн байдаг.

Дээрх тодорхойлолтуудыг харьцуулан үзэхэд Чингис хаанд хамгийн ойр хугацаанд бичсэн бүтээлүүд дэх ишлэлүүд, Хубилай хаанаас зуруулсан Чингисийн хөргөөс үүдэлтэй ишлэлүүд гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваагддаг нь ажиглагдаж байгаа ч аль алиных нь зохист элементүүдийг нэгтгэх замаар шинжлэх ухааны аргуудыг хэрэглэн үзвээс Чингис хаан өндөрдүү нуруу, ханхар цээж, хүдэр чийрэг биетэй, өргөн магнай, улаавтар хээнцэр дөрвөлжин царайтай, онигордуу хурц хар нүдтэй, өтгөн харавтар хөмсөг, өндрөвтөр тэгш хамартай, халбигардуу өргөн чихтэй, тэгш дөрвөлжин мөртэй, бадриун чийрэг гартай, бодлогошронгуй хурц ухаан, эр зориогтой байдал царайд нь илэрхийлэгдсэн ханагар сүрлэг эр хүн байсан болов уу.

Чингис хувийн зан чанарын хувьд шулуун шударга, зорьсон үйл, гаргасан шийдвэрийнхээ төлөө тууштай зогсдог, элдэв урвалт шарвалтыг эрс цээрлэдэг хүн байжээ. Монголын нэрт түүхч А.Амар “Чингис хаан болвоос тэр цагийн байдлаар жишиж үзэхэд төрхөөс үнэнч шударга, элдэвт урваж шарвадаггүй, хөлвөрөлтгүй бат оршин, санаа тогтвортой, нэгэн чигийг баримталсан хүн байсан ба үнэнч шудрага ёсыг хүндэтгэн эрхэмлэж байсан” /2.173/ хэмээн бичсэн нь үнэний хувьтай буй зээ.

Чингис бол Монголын нэгдсэн улсын хэмжээгүй эрхтэй хаан болно. Төрийн онолын үүднээс хааны хэмжээгүй эрх нь тэрхүү хэмжээгүй эрхийг бүрдүүлэгч элементүүдийн материаллаг ба зохион байгуулалтын баталгаагаар хангагдсан нийлбэр байдаг. Ийм хэмжээгүй эрх эртний Вавилон, Египет, Ром, Энэтхэг, Хятадад сонгодог байдлаараа хэрэгжчихсэн байсан нөхцөлд Чингис хаан XIII зууны эхэн үеийн нүүдэлчин Монголд хэмжээгүй эрхт хаант засгийг байгуулсан. Гэтэл суурьшмал улсын хаан, нүүдэлчдийн улсын хааны хэмжээгүй эрх мэдэл хоёр ялгаатай болой. Иймээс Чингис хааны хэмжээгүй эрх мэдлээ өөрөө бүрдүүлэн төлөвшүүлж хэрэглэхэд хүрсэн онцлогтой. Их Монголын нэгдсэн улсад Чингис хааны эрх хэмжээ бүрэлдэн төлөвшсөн нь юуны өмнө хоёр гол хүчин зүйлтэй холбоотой байсан бололтой. Үүний нэгдэх нь, монголын төр ёсны хөгжлийн өмнөх үеийн уламжлал, хөгжлийн янз бүрийн түвшин, аж ахуй, зан заншил, ашиг сонирхлын өөр өөрийн онцлог бүхий аймаг, ханлигуудыг хураан нэгтгэсэн нэгэн нэгдмэл хүчирхэг улсыг байгуулах монгол угсаатны нийтлэг зорилго, үйл ажиллагаанаас урган тавигдаж, түүнийг удирдахад шаардлагатай эрх мэдлийг эдлэх хэрэгцээгээр тодорхойлогдож байв. Хоёрдахь нь хааны төрийг үзэх үзэл, хаант улсын зорилго, төрийн зохион байгуулалтын тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн бүтэц, эрх мэдлийн хуваарилалт, улсын дотоод, гадаад бодлогын чиглэл, багтаамжаас хамаарч, чухамдаа эдгээрийн агуулга онцлогийг тусган илэрхийлж байсан ажээ. Хаант улсын уудам нутаг дэвсгэр, өвөрмөц эрс тэс уур амьсгал, хүн амын эрхлэн амьдардаг нүүдлийн мал аж ахуй, аж төрж амьдрах арга, хэрэгсэл, зан заншил, хүмүүсийн бие махбод, сэтгэхүйн онцлог зэрэг бусад хүчин зүйлүүд ч нөлөөлжээ.

Дурдан буй хүчин зүйлүүд болон “Их засаг”-ийн заалт, сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн баримт, дүгнэлт зэргийг харьцуулан нягтлаад Чингис хааны хэмжээгүй эрх мэдлийн агуулга, онцлогийг дараах байдлаар тодорхойлмой.

Чингис хаан хууль батлах, зарлиг гаргах, тэдгээрийн биелэлтэд дээд хяналт тавих эрхтэй байжээ. “Монголын нууц товчоо”-нд “Надтай зөвлөж, Шихихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилсүгэй” /51.178/ гэсний агуулгыг задлан дүгнэлт хийж үзвэл төрийн хууль цааз, боловсруулах, батлуулах эрх их заргачид, батлах эрх хаанд байж,

нэгэнт баталсны дараа түүнийг заавал биелүүлэх бөгөөд хэн ч өөрчлөх, зөрчих эрхгүйгээр тогтоосон нь тов тодорхой байна. Чингис хаан улсын хуулийг өөрийг нь залгамжлагчид үг дуугүй чандлан биелүүлэхийг тунхагласан нь хаан хуулийг гаргах, биелүүлэх, хяналт тавихад дээд эрх эдэлж байсны бас нэгэн илэрхийлэл болой.

Чингис хаан хэмжээгүй эрх эдэлж байсныг нотлох баримт бол улсын ван, төрийн сайд, түмт, мянгатын захирагч ноёдыг томилж, улсын засаг захиргааны хуваарийг тогтоож, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, улсын засаг захиргааны хуваарийг тогтоосон хааны үйл ажиллагаа мөн юм. Чингис хаан цэрэг армийг толгойлон захирч, цэргийн жанжнуудыг томилон удирдаж, байлдааны төлөвлөгөөг баглах, цэрэг хөдөлгөх, дайн зарлах, байлдаан явуулах, дайныг зогсоох, найрамдах асуудлыг шийдвэрлэх эрхийг чөлөөтэй эдэлж байв.

Чингисийн зарлигаар хишигтэн цэргийг түмэн хүнтэйгээр байгуулж, түүнийг дотор нь хэвтүүл, торгууд, хорчин болгон хувааж, тус бүрийнх нь эдлэх эрх, гүйцэтгэх үүргийг тогтоон төвхнүүлсэн бөлгөө.

Чингис хаан бусад улс орнууд, тэдгээрийн хаадтай харилцах, элч төлөөлөгч илгээх, тэдний элчийг хүлээн авах эрх эдэлж, Азийн Тангуд, Алтан улс, Сүн улс, Солонгос, Уйгур, Хар Хятан улс, Дундат азийн Хорезмын улстай харилцах, элч төлөөлөгч солилцох, гэрээ хэлэлцээр байгуулах өргөн үйл ажиллагаа явуулсан бөлгөө. Чингис хаан улсын хэмжээнд шүүхийн дээд эрх эдэлж, улсын заргачийг томилох, ял оногдуулах, ялаас чөлөөлөх, өршөөл, уучлал үзүүлэх онцгой эрхтэй байсан бөлгөө. Улсын газрын дээд эзэн өмчлөгч нь байж, түүнийг алтан ургийнхан, шадар сайд, түшмэд, түмт, мянгатын захирагчид хуваарилан олгож, эзэмшүүлэх, үе угсаа дамжин эзэмшүүлэх газар олгох эрх эдэлж, үүнээ ч хэрэгжүүлсэн ажгуу.

Чингис хаан улсын дотоод бодлогын асуудал, тухайлбал алба татвар тогтоох, өртөө байгуулах, худалдаа арилжааг хөгжүүлэх, мал сүргийг өсгөн үржүүлэх, хамгаалах, ард иргэдээ өмгөөлөх, өтгөс нялхсаа асрамжлах, байгаль, ан амьтнаа хайрлах, уул ус, газар тэнгэрээ тахих зэрэг өргөн эрхтэй байсан бөлгөө.

Их эрдэмтэн Сайшаал, Чингис хааны эрх мэдлийн хүрээг “Тэр нь /хаан/ улс төр, аж ахуй, цэрэг дайны талаар бүр хамгийн дээд онцгой эрхтэй бөгөөд дайн байлдааныг зарлах ба зогсоох, олзолсон ард иргэд ба эд ашгийг шийдвэрлэх, сайд, түшмэдийг томилох, жич хаан орыг залгамжлах мэт том чухал асуудлыг шийдвэрлэх /зарлиг буулгах/ онц эрхтэй ... мөн аливаа үндэстний хаадтай адил халдашгүй эрхтэй байжээ”/76.360-361/ хэмээн нэлээд дэлгэмэл байдлаар тодорхойлсон байдаг билээ.

Хууль тогтоох, гүйцэтгэн захирах, шүүн таслах, цэрэг арми удирдах, улсын гадаад бодлогыг боловсруулан явуулах талаар Чингис хаан нээлттэй өргөн эрх эдэлж, монгол орондоо төдийгүй дэлхий дахинаа ихэд алдаршсан билээ.

Чингис хаан хэмжээгүй эрх мэдлээ өөрийнхөө орны нөхцөлд бодитой эдэлж, Монгол улсынхаа төлөө хийж бүтээсэн ажил үйлээрээ хайр хүндэтгэл, итгэл бишрэл хүлээж, монголчуудын сэтгэл зүрхнээ “Эзэн богд их Чингис хаан” хэмээн хоногшин үлдсэн бөлгөө.

Их хаан, алтан урагтай хүйн холбоотой. Монголын нэгдсэн улсын төрийн амьдрал, түүний бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх үйлсэд Чингисийн алтан ургийнхан онцгой байр эзэлж байсныг тэмдэглэн өгүүлэхээс аргагүй буюу. ”Алтан урагт”-т хааны гол хатад, хан хөвгүүд, хааны дүү нар, авга болон бусад гол гол хамаатан садангууд орно. Алтан ургийн гишүүдийн дотор Өүлэн эх, хатан Бөртэ, хаан хөвгүүд -Зүчи, Цагаадай, Өгөдэй, Тулуй³⁶, өргөмөл хүү Шихихутуг, дүү нар Хасар³⁷, Тэмүгэ отчигин³⁸, Бэлгүдэй³⁹, хатан Хулан, Есүй, Есүгэн, ач Илжигдэй нар ихээхэн рольтой байжээ.

Алтан ургийн гишүүд Их Хуралдайд их эрх ямбатай оролцоно. Тэд хааныг сонгох, байлдах, найрамдах, улсын бодлогын асуудлыг хэлэлцэхэд буурь суурьтай, уужим ухаантай оролцож, чөлөөтэй үгээ солилцож, санал бодлоо илэн далангүй илэрхийлнэ. Алтан ургийн гишүүдийн санал хуралдайн шийдвэрт жинтэй нөлөөлж байсан аж.

Алтан ургийн гишүүдээс есөн өрлөг, цэргийн жанжин, мянганы ноёноор олон хүн томилогдож төрийн дээд албан тушаал хашин, төрийн өмнө ихээхэн гавьяа байгуулсан байдаг. Зүчи, Цагаадай, Өгөөдэй, Хасар, Тулуй, Шихихутуг, Бэлгүтэй нар цэргийн гарамгай жанжнуудаар тодрон, хаант улсын цэрэг арми үүсэн хөгжихөд бодитой хувь нэмэр оруулан, олон том тулалдаануудад оролцон баатарлаг гавьяа байгуулж шилдэг жанжинууд болохоо харуулсан аж. Тэд бүгдээрээ улс төрийн зүтгэлтнүүд, хааны зөвлөгчид, мянгатын захирагчид байв. Хаант төрийн нүд, чих болсон улсын заргач Шихихутуг их хааны итгэлт түшээ, төрийн бодлогын ”Алтан хүн” байсан болой.

Алтан ургийн гишүүдээс олон хүн төр, цэргийн чадварлаг зүтгэлтнүүд болж, төрийн бодлого, цэргийн стратеги, тактик боловсруулах, тэдгээрийг төр цэргийн амьдралд хэрэгжүүлэх үйлсэд багагүй үүрэг гүйцэтгэж байжээ. Тэд Чингисийн 88 гавьяатанд багтах төдийгүй зарим нь их хааны итгэлийг хүлээсэн шадар хүн болж зүтгэсэн ажгуу.

Чингис, алтан ургийнханд ихэд итгэж, тэднийг шууд хүлээн авдаг, тэд ч хаантай чөлөөтэй харилцдаг байсан агаад тэдний зөвлөгөө, хэлсэн үг, санал гомдлыг ихээхэн анхааран гүн хүндэтгэлтэйгээр сонсож хүлээж авдаг байсан ажээ. Ялангуяа Өүлэн эх, Бөртэ үжиний үгэнд маш болгоомжтойгоор хандаж, санаа бодолдоо гүнээ шингээдэг байсан ажгуу. Ээжийнхээ ачлал, амьдралын ухааныг сэтгэлээрээ хүндэтгэн мэдэрч, зөвлөсөн хэлснийг нь биелүүлдэг байжээ.

Өүлэн эх хүүхдүүдийнхээ эвтэй найртай байж, улс орноо нэгдмэлээр хөгжүүлэхэд хүчийг нь нэгтгэхийн төлөө тууштай зогсож байсан ажаамуй.

Бөртэ Үжин уужуу тайван байдал, чин халуун сэтгэл, холч цэлмэг ухаанаараа дүү нарыг нь ямар ч нөхцөлд хамгаалж өмгөөлөн ахтай нь нэгэн цул хүч байлгах бодлоороо их хаанд насан туршид нь эерэг сайхнаар нөлөөлсөн түүхтэй. Бөртэ хатан их хааныг баруун зүг байлдаанд явахад нь зоригийг нь засаж, байнга холбоотой байж, дайнаа дуусмагц эх орондоо үтэр ирэхийг зөвлөж байсан нь нууц товчоонд тэмдэглэгдэн үлдсэн нь бий.

Чингисийн бусад хатад ч мөн л иймэрхүү ухаант байдлаар Чингист хандаж байжээ. Есүй хатан их хаанд Хорезм руу аян дайнд мордохынх нь өмнө “Төрсөн бие төлбөрөх түмэн амьтны хуулийг төгс санаасай. Уул мэт бие чинь нурж одвол улс олон монголыг чинь хэн захирах юм бэ?” /51.225/ гэхэд их хаан ухааран болгоож, өөрийн залгамжлагчаар Өгөдэйг хэлэлцэн тодруулсан удаатай. Чингисийн алтан ургийн тухай мэдээлэл мөхөс, бичигдсэн зүйлс бага тал бий. Гэвч эрдэмтэн, судлаачид энэ чиглэлээр судалгаа явуулж, дүгнэлт, санал дэвшүүлэхэд нэлээд анхаарч ирснийг тэмдэглэлтэй. Тухайлбал, Ч.Далай ”Алтан ургийнхан төрд нэн дээгүүр эрхтэй. Чингисийн хамгийн итгэлт хүмүүс ... Чингис хааны алтан ургийн баг бүрдүүлсэн нь хэдийгээр төвлөрсөн төрд чухал хэрэгтэй байсан боловч олон аймаг, угсаатнаас бүрэлдсэн Их Монгол Улсын бат нэгдэлд сайн нөлөө болоогүйг тэмдэглэвэл зохино” /24.57/ хэмээн сонирхолтой дүгнэлт хийсэн байдаг. Өвөг дээдсийн уламжлал, Чингисийн үеийн амьдрал, ёс заншил, төрийн үзлийн логик, засаг төрийн байгууллагын тогтолцооны төрх төлвийг шинжин үзэхүйд алтан ургийнхны онцлог, үүрэг ролийн талаар хэд хэдэн зүйл хэлж болмоор санагдана. Чингисийн алтан ураг хэмээх нь Есүхэй баатрын удам, түүний хүү Чингисийн ураг, садан хамаатныг нэгтгэн илэрхийлэх бөгөөд Монголын их хааныг тодруулан өргөмжлөх гол үүр болж байжээ.

Их хааны мөхлөг учир нэг талаар хаантай өөртэй нь амин холбоотой, нөгөө талаар алтан ургийг хамгаалан өргөх нь хааны үүрэг болж байсан аж. Хаан бас алтан урийнхны нэгдлийг хангах, нийгэмд онцгой эрх, ямба, байр суурь эзэлж, өндөр хариуцлага хүлээхэд анхаарч, соёрхох үүрэгтэй байсан нь эргэлзээгүй. Энэ үүднээс Чингис хаан алтан ургийнханд өмч, газар, иргэд захируулж, төрийн өндөр албан тушаал, цэргийн жанжинд томилж, хариуцлагатай үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлж байсан нь олонтой. Алтан ургийн гишүүд өөр хоорондоо зарим талаар зөрчил, маргаантай байсан хэдий ч их хааны төр, түүний бодлогын төлөө тэмцэж, удам ургаа хамгаалан зүтгэж байсан аж. Тэд монголын нэгдсэн улсын төрийн бодлого боловсруулах, төрийн үүрэг зорилтыг ханган хэрэгжүүлэхэд их хааны шадарлан зүтгэх хүч болж, хаант төрийн үйлсэд бие сэтгэлээ зориулан хувь нэмрээ оруулсан болой.

Алтан ургийнхан төрийн амьдралд өндөр байр суурь эзэлж, өөрсдийн сүр хүч, нэр төр, нөлөө хүрээгээрээ хаант төр бэхжихэд бодитой нөлөө үзүүлж байсан нь эргэлзээгүй буюу тэд өөрсдийнхөө дотроос ирээдүйн их хаан, төр, цэргийн зүтгэлтнүүдийг бэлтгэн бойжуулсан ажгуу. Алтан ургийн үзэл санаа, уламжлал, их хааныг залгамжлагчдын үед ч, Хубилай хааны үед ч, цаашилбал монгол төрийн түүхэнд ч нөлөөлж байсан бөлгөө.

§2. Их Хуралдай

Монголын нэгдсэн улсын төрийн байгууллагын бүтцэд “Хуралдай” хэмээх ноёдын чуулган чухал байр эзэлж байв.”Хуралдай нь хуран чуулах гэсэн утгатай “кури” гэсэн үгнээс үүссэн” /20.193/ хэмээн доктор Д.Гонгор”Халх товчоон” зохиолдоо бичсэн байдаг.

Хуралдай бол Монголын нэгдсэн улсын хаад, ноёдын хуран чуулах гол хэлбэр-Төрийн чуулган байжээ. Түүнд хаан, хан хөвгүүд, хааны хатад, түмтийн захирагч, сайд, ноёд, цэргийн жанжин тэргүүтэй хаант улсын ихэс дээдэс оролцоно. Ялангуяа хааныг өргөмжлөх Их Хуралдайд хаан, хааны хатад, хааны хүүхдүүд тэдгээрийн хатад, хааны ач зээ нар, садан хамаатнууд өргөн бүрэлдэхүүнээрээ оролцдог байжээ. Хуралдай нь олон түмтээс сонгогдсон төлөөлөгчдөөс бус хааны алтан ураг, ноёд түшмэдээс бүрэлддэг язгууртны хурал байсан аж. Хуралдай нь Чингисийн үед үүссэн бус, харин монголын эртний улсуудын үед үүссэн төрт ёсны уламжлалаас залгамжлан авсан шинжтэй болой. Эртний Хүннү улсад ноёдын чуулган /Хуралдай/ анх үүссэн тухай баримтыг доктор Г.Сүхбаатар”Монголчуудын эртний өвөг” номондоо өгүүлсэн байдгийг өмнө дурдсан билээ. Тэрээр ”Хүннү улсад наана хэлэхэд МЭӨ 1 дүгээр зууны үеэр ноёдын чуулга байсан нь үнэнтэй” гэж бичсэн бөлгөө.

Эртний монгол овог, аймаг дор бүрнээ ургийн цуглаантай байжээ. Энэ нь ”эе” гэж нэрлэгдэнэ.”Эе”-ийн тухай Д.Гонгор ”Халх товчоон” хэмээх зохиолдоо нэлээд дэлгэрэнгүй авч үзэж, тайлбар сэлт хийсэн нь судалгааны ихээхэн ач холбогдолтой төдийгүй энэ талаарх ойлголтыг тодруулах гол үндэслэл болж байна. ”Эе”-д зөвхөн тэр овог, аймгийн гишүүд оролцон санасан бодсоноо ил хэлж, ургийн хэмжээний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. ”Эе” нь овог ургийн хүмүүс ордог, бас овог ургийн дотоод асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг, гаргасан шийдвэр нь эцсийн болдог учир овог аймгийн удирдлагын гол хэлбэр болж байсан ажээ.

“Эе” нь хэлэлцдэг асуудал, явагдах дэг журам, хүндэтгэн итгэх ёсон бүхий овог аймгийн ардчиллын хэлбэр болно. ”Овог аймгийн нийтийн эрх ашгийг илэрхийлж, гол төлөв амьдралын шаардлагаар тавигдсан хэрэгцээг хангах, гадны довтолгооноос хамгаалах, анд нөхөд бололцох, цусан өшөө авах ургийн дотоод хэрэг явдлыг зохицуулах зэргийг хэлэлцдэг”/20.192/ байжээ.

”Эе”нь ургийн доторхи хэрэг явдлыг мах цусны холбооны эрх ашгийг илэрхийлэн хэлэлцэн шийдвэрлэдэг агаад түүний нууцыг оролцогч гишүүн бүр чанд хадгалах үүрэгтэй. ”Эе”-ийн нууцыг задруулбал дахин түүнд оролцох эрхийг нь хасдаг байна. Монголын нууц товчоонд үүн лүгээ холбогдох баримтууд нэгэнтээ бус тааралддаг. Нууц товчооны 154 дүгээр зүйлд ”Бид ургаараа их зөвлөлдөөн хийснийг Бэлгүтэй гаргаж хэлээд бидний цэргүүдэд маш их хохирлыг учруулав. Үүнээс хойш их эе зөвлөлдөөнд Бэлгүтэйг бүү оруул. Зөвлөлдөөн хийж байхад Бэлгүтэй гаднах үйлийг захирч, хэрүүл ба хулгай худлын заргыг шүүж байтугай“ /51.114/ хэмээн Чингис хаан зарлиг буулгасныг өгүүлсэн байдаг бөлгөө. Овог аймгийн ”эе” сүүлдээ ханлиг улс байгуулагдах цагт улсаар хийх хуралдаан болж ургийн доторхи бус ханлиг улсын хэмжээний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хэлбэрээр өргөжиж, бүрэлдэхүүн, агуулга нь аажмаар өөрчлөгдсөн байна. Урьдынх шиг овог аймгийн гишүүд бус аймгийн холбоо, ханлиг улсын хаад, ноёд мэт язгууртны төлөөлөгчид оролцож, хэрэг явдлыг хэлэлцэн шийдвэрлэдэг болжээ. Хуралдаан дээр хааныг сонгож, дайн байлдааны хэргийг хэлэлцэж, ав хомрого явуулах удирдагчдыг томилж байжээ.

Ийм байдлаар овог аймгийн ”эе“ яван явсаар улсын төрийн зохион байгуулалтын нэгэн хэлбэр болж ”Хуралдай” хэмээн алдаршжээ. XII зууны эцэс XIII зууны эхэн үеийн монгол аймаг, ханлиг улсуудад Хуралдайг ихээхэн хүндэтгэн хэрэглэх ёс дэлгэрсэн нь нууц товчооны баримтаас тодорхой харагдана. Монголын нэгдсэн улс байгуулагдсан үеэс Хуралдай нь төрийн чуулган буюу Их Хуралдай хэмээн нэрлэгдэх болжээ.

1206 оны намар Онон мөрний эхэн дэх Чингисийн их ордонд болсон Хуралдай Монголын нэгдсэн улсын түүхэнд хамгийн анхны төрийн том чуулган байсан аж. Ч.Далай”Монголын түүхэнд болсон олон чухал Хуралдай дотроос хамгийн өргөн цар хүрээтэй онцгой ач холбогдолтой болсон нь 1206 оны тэрхүү түүхт Их Хуралдай мөн” /24.55/ гэж бичээд тус Их Хуралдайн ажиллагааг монгол их эрдэмтэн Инжнаши, Өвөр монголын эрдэмтэн Сайшаалын бичсэн зүйлүүдтэй харьцуулах, түүнээс иш татах замаар нэлээд дэлгэрэнгүй тайлбарлан өгүүлсэн нь бий болой. Энэ тухай өмнө өгүүлсэн билээ. Их Хуралдайг чуулах ордон нь эрдэмтэн Инжнашийн”Юан улсын мандсан төрийн хөх судар“ хэмээх зохиолд бичсэнээр 1000 цэргээр хамгаалуулсан 18 алд өндөр, 81 алд уудам, дунд нь эзэн хаан суух 22 хан мөнгөн тулгуурт, оройдоо алд өндөр алтан ганжиртай ордон байжээ. /36.1140-1146/. Эрдэмтэн Сайшаал ”Чингис хааны товчоон“ номондоо Их Хуралдайг чуулсан ордон нь алтан хөвөөтэй хөх хөлдрөгөөр чимэглэсэн цас шиг цагаан өнгөтэй том монгол гэрийн хэлбэртэй бөгөөд тооныг нь тулсан бат дөрвөн тулгуурыг шижир алтаар чимж, үүдний гадна нэгэн талд нь есөн хөхөлт цагаан туг, нөгөө талд нь дөрвөн хөхөлт хар сүлд мандуулсан байв” гэж бичсэн байна. /76.382-385/

Эдгээр баримт Их Хуралдай хуран чуулсан хааны ордны дүр төрхийг мэдэхэд тус болох бөлгөө. 1206 оны Их Хуралдайг хурах бэлтгэл ажлыг барс жилийн хавраас намрын эхэн сар хүртэл базаасан учир өндөр зохион байгуулалт, нарийн дэг журамтай, цог жавхлан, баяр баясгалантай болсон ажээ. Их Хуралдайгаар хамгийн түрүүнд хэлэлцсэн асуудал нь Тэмүүжинг хаанд сонгон өргөмжилж, Их Монгол улсыг хаант засгийн хэлбэртэйгээр байгуулсныг дэлхий дахинд зарлан тунхагласан явдал юм.

Мөн үүнээс хойш Тэмүүжинг Чингис хаан хэмээн дуудтугай гэсэн албан ёсны шийдвэрийг Их Хуралдай гаргажээ /24.55/. Их Хуралдай дээр чингисийн тамгын сайд "цагаан хаш чулуун дээр сийлсэн төрийн тамгыг хурагсдад нээн үзүүлж, тамганы үгийг уншин сонсоод Чингис хаанд хоёр гараараа өргөн барьсан /24.55/ нь Монголын нэгдсэн улсын бүрэн эрхт байдал төрийн тусгаар тогтнолын билэгдэл болж монгол угсаатны нэгдсэн улс байгуулагдсаны эрхэм нэгэн шинж болсон ажгуу. "Монголын нууц товчоо"-нд Чингисийг Монголын нэгдсэн хаанд өргөмжилсөн талаархи мэдээлэл түүхэн сурвалж болох ач холбогдолтой.

Их Хуралдайн талаар гадаад, дотоодын эрдэмтэд, судлаачдын бүтээлд ч бичиж тэмдэглэсэн нь арвин байдаг. Ялангуяа Жувейни, Рашид-ад-Дин, Хэбрэус, Плано Карпини, Инжнаши, Ш.Нацагдорж, Ч.Далай, Сайшаал, И.Дашням нарын бүтээлд тодорхой бичсэн байдаг.

Их хаанд өргөмжлөх Хуралдайгаас бусад Хуралдайд Чингисийн алтан ургийнхнаас гадна бусад сайд, жанжин, түшмэд, язгууртнууд оролцож, аян дайн хийх, түүнийг явуулах төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам, цэрэг толгойлох жанжнууд, гэрээ хэлэлцээр байгуулах болон дотоод, гадаад бусад асуудал хэлэлцдэг байжээ.

1206 оны Хуралдайгаар цэрэг дайны асуудал ба улсын ванг томилох, 1211 оны Хуралдайгаар Зүрчидийн Алтан улстай байлдах, 1218 оны Хуралдайгаар Хорезмын хаант улстай байлдах тухай асуудал, 1210, 1218 оны Хуралдайгаар "Их засаг"-т нэмэлт оруулах талаар 1224 оны Хуралдайгаар Хорезмын улстай хийсэн дайны дүнгийн тухай хэлэлцэж байжээ. Хуралдайн бүрэн эрхийн тухай тодорхой баримт хэлэхэд хэцүү боловч хоёр зүйлийг онцлон дурдаж болох байна. Хуралдайн тухай сурвалж бичиг, зохиол бүтээлүүдэд бичиж тэмдэглэсэн зүйлүүдийг шинжлэн нягтлахуйд нэг дүгнэлт гарч байна. Энэ бол төрийн тэргүүн-их хаанд тодруулан өргөмжлөх эрх гагцхүү Хуралдайд байсан явдал юм. Хуралдайгаар хаанд тодруулан өргөмжлөх ёсыг үйлдэж цол олгон, нийт даяар зарлан тунхаглаж байгаа нь албан ёсны үйл ажиллагаа болж түүнээс хойш их хааныг ёс төр бүхий улсын эзэн хаан хэмээн бүх нийтээрээ бишрэн хүндэтгэх болж байгаа нь ажиглагдаж байна.

Ийнхүү нэг ёсондоо Хуралдай хааныг ёсчлон баталж, нийтэд тунхаглан мэдэгдэж байгаа нь хамгийн хүндэтгэлтэй эрх, хүндэтгэлтэй шийдвэр гэж хэлж болмой.

Өөр нэг зүйл бол Хуралдай хаанд зөвлөх эрхтэй байсан байна. Чингэхлээр нэг талаар улсын бодлогын шинжтэй асуудлыг Хуралдайд оруулж буй төрийн зүтгэлтнүүд хааны ургийнхан, сайд, жанжин, түшмэдүүд тал бүрээс нь тунгаан хэлэлцэж аль болох бодит үндэслэлтэй санал дүгнэлт дэвшүүлж байхыг эрмэлзэж байсан нь хаанд ухааран болгоох оюун билэг хайрлаж, дараа нь түүнээ үндэслэн хамгийн зөв шийдвэр гаргах хүчин зүйл болж нөлөөлж байсан байж мэдэх. Энэ утгаар Хуралдай нь их хаанаас төрийн бодлого боловсруулах, төрөө засаж, иргэнээ хашихад нэн мэргэн зөвлөгөө болж байсан болов уу. Нөгөө талаар амьдралын туршлагатай ахмад хүмүүс, эрдэм ном бүхий чадавхи сайтай мэргэдийг төрийн хэргийг жолоодоход оролцуулах нэгэн хэлбэр болгон Хуралдайд ашиглаж, түүнд их анхаарал тавьж хүндэтгэж байсан хэрэг буй заа.

§3. Сэцдийн зөвлөл

Монголын нэгдсэн улсын төрийн зохион байгуулалтад “Сэцдийн зөвлөл” орно. Сэцдийн зөвлөл нь сонгуулийн бус байгууллага байв. Сэцдийн зөвлөл нь хааны саналаараа томилсон тодорхой хэсэг, зэрэг цол бүхий хүмүүсээс бүрэлдэж байжээ. Сэцдийн зөвлөлийн тухай монголын түүхийн тулгуур зохиолуудад зохих байр эзлүүлэн дурдсанаас гадна Ш.Нацагдорж, Ч. Жүгдэр, Н.Ишжамц, Сайшаал, Ч.Далай зэрэг монгол улсын дундад үеийн түүх, улс төр, сэтгэлгээ судлаач нэртэй эрдэмтэд өөрсдийн зохиолуудад бичиж, дүгнэлт хийсэн нь анхаарал татна. Ш.Нацагдорж “Чингис хаан тулгамдсан асуудалд “Сэцдийн зөвлөлд” хандан тэдний зөвлөлгөөнөөс сонсдог байж” /62.175/ гэж бичсэн байхад Ч.Жүгдэр “Чингис хааны дэргэд сэцдийн зөвлөл гэж байсан бөгөөд хаан аливаа ажил явуулахдаа тэдний зөвлөлгөөг анхааран сонсдог байжээ” /32.100/ хэмээн өгүүлсэн байна.

Мөн ийм утгатай зүйлийг БНМАУ-ын түүхийн нэг дүгээр ботийн 2 дугаар бүлгийн “Монгол улсын төрийн байгууламж” гэсэн 4 дүгээр зүйлд бичсэн байдаг /12.221/. Хамгийн дэлгэрэнгүй баримтыг Ч.Далай “Монголын түүх, Их Монгол улс 1206-1260” зохиолдоо бичжээ. Энд сэцдийн зөвлөл гэдэг нь Чингисийн дөрвөн хошууч, дөрвөн хүлэг, хоёр манлай, есөн өрлөг, 88-н гавьяатнаас бүрддэг.. сэцдийн зөвлөлөөр өөрийн төлөвлөсөн зүйл хэр зэрэг оновчтой зөв болохыг, онож бодоогүй орхигдсон юу байгааг бататган хэлэлцүүлж санал бодлыг нь сонсдог байна” /24.59/ хэмээн өгүүлсэн баймой.

Эдгээр баримт дүгнэлтүүд хийгээд түүний сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн бусад мэдээ сэлтээс ургуулан дараах зүйлийг өгүүлмүй. Чингис хааны дэргэд ажиллаж байсан сэцдийн зөвлөл хэмээх байгууллага нь байнгын ажиллагаатай байгаагүй хэдий ч төрийн бодлогыг боловсруулах, түүний хүрээнд төрийн гадаад, дотоод

бодлогын тулгуур юм уу, эгзэгтэй нарийн асуудлыг шийдвэрлэх, биелүүлэх арга замыг тодорхойлоход нөлөө бүхий үүрэг гүйцэтгэж байжээ. Сэцдийн зөвлөлд алтан ургийнхан бүхлээрээ ордоггүй байсан бололтой. Гэвч төрийн бодлогод мэргэшсэн, улс төр, цэргийн амьдралд хатуужсан дадлага туршлагатай ноёд, түшмэд, цэргийн жанжин, ухаантан мэргэд бүрэлдэхүүнд нь ордгоос сэцдийн зөвлөл нь асуудалд үлэмж буурьтай суурьтай, анхааралтай хандаж, бүх талаас нь жинхэнэ ёсоор тунгаан хэлэлцэж, хамгийн оночтой гэж хэлж болох санал, дүгнэлт гаргах, бололцоотой байсан аж. Сэцдийн зөвлөлд хэлэлцэх асуудлыг хаан тогтоож өгнө. Зөвлөл нь хааны тогтоосон асуудлыг нэг бүрчилэн нягт нямбай хэлэлцээд зохих санал, дүгнэлт гаргадаг байжээ. Хаан, Сэцдийн зөвлөлийн гаргасан санал дүгнэлтийг уг асуудлаар эцсийн шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ. Иймээс сэцдийн зөвлөл нь хаанд зөвлөх эрхтэй байжээ. Хаанаас хэлэлцүүлэхээр оруулсан асуудлыг нягтлан хэлэлцэж, хамгийн бодитой гэсэн санал, дүгнэлт гаргах нь зөвлөлийн үндсэн үүрэг байсан ажгуу.

Сэцдийн зөвлөл нь их дайны явцад ч гэсэн шуурхай ажиллах бололцоотой байсны учир байлдааны явц, дүнгийн талаар хэлэлцэж, түүнд нь Чингисийн хөвгүүд, ач зээ нар, цэргийн жанжин, ордны түшмэдүүд оролцож байсан ажээ. Жишээлвээс Чингис хаан 1214 онд Алтан улсын Шар хээр гэдэг газар Сэцдийн зөвлөлийг зарлан хуралдуулж, Алтан улстай байлдсан 3 жилийн дүнг гаргаж, цаашид үргэлжлүүлэн байлдах эсэх асуудлыг хэлэлцүүлж байсан ажээ. Чингис хаан 1219 оны эцэс Эрчис мөрний хөвөөнд их цэрэг байлдааны бэлтгэлээ хийж байсан үед Сэцдийн зөвлөлийг зарлан хуралдуулж Хорезмыг байлдах зам, чиглэл, байлдах хүч, удирдах жанжин байлдах тактикийг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Дараа нь 1224 оны зун Чингис хаан Сэцдийн зөвлөлийг хуралдуулж, Дундаг Азид явуулсан дайны дүнг хэлэлцүүлж, ахмад хүү Зүчийг Хорезмын захирагчаар томилсон байдаг билээ.

Сэцдийн зөвлөл нь Их Хуралдайгаас ялгагдах хэд хэдэн онцлогтой. Хуралдайд алтан ургийнхан голлон оролцож уламжлал болон тогтсон тодорхой асуудлыг хэлэлцэн харьцангуй цөөн тоотой хуран чуулахын хамт тусгайлан боловсруулсан дэг журам, ёс төр гүйцэтгэн явуулдаг байсан ажээ. Тэгвэл сэцдийн зөвлөл бүрэлдэхүүний хувьд онцлог, жилийн аль ч улирал, сард хааны саналаар цугларч хуралдах бололцоотой бөгөөд тусгайлан гүйцэтгэх ёс шаардахгүй, харин нэлээд ажил хэргийн шинжтэй байснаараа онцлог юм. Хааны санал шаардлагын дагуу хэдийд ч цугларан ажиллаж болох учраас хаанаас бодлого боловсруулах, шийдвэр гаргахад тухай бүр тус дөхөм үзүүлэх бололцоо бүхий байсан аж. Энэ утгаар нь сэцдийн зөвлөлийг нэг талаар хааны байнгын үйл ажиллагаанд тус нөлөө үзүүлэх чадвараар Хуралдайгаас илүү, нөгөө талаар хаанаас төрийнхөө бодлогыг боловсруулж явуулахад олон түмэн, ноёд түшмэдийн санаа бодлыг тусгаж, зөв шийдэлд хүрэхэд тусалдаг ажил хэргийн ач холбогдолтой байгууллага байсан хэмээн үзэж болмой.

§4. Засаг захиргааны хуваарь

Монголын нэгдсэн улсын засаг захиргааны хуваарь Хүннү улсын үеэс уламжлан аравтын тогтолцоонд үндэслэж байв.

Аравтын тогтолцоо нь улсыг түмтүүдэд, түмтүүд нь мянгатуудад, мянгатууд нь зуутуудад, зуутууд нь аравтуудад, аравтууд нь арван өрхөд хуваагдах замаар бүрэлдсэн нарийн тогтолцоо юм. Энэ нь түмт нь арван мянгатаас, мянгат нь арван зуугаас, зуут нь арван аравтаас аравт нь арван өрхөөс бүрэлдэнэ гэсэн хэрэг болой.

Аравтын тогтолцоо нь монгол улсын нэгдмэл шинж, төрийн удирдлагын хэлбэр, цэргийн зохион байгуулалт, хүн ам, газар нутаг, уур амьсгал, эрхлэх аж ахуйн онцлог, төрөөс иргэнийг засах, иргэнээс төртэй харьцах, түүнд захирагдах арга хэрэгсэлтэй гүн холбоотой байв. Чухамдаа өрх, иргэн, хүн амыг аравтлах замаар /арван өрх, арван арван, арван зуут, арван мянган болгох/ төвлөрсөн нэг захиргаанд оруулан улмаар эл зохион байгуулалтаар төрийн үүрэг, удирдлагыг хэрэгжүүлэх, хүн замыг захиран засах нь энэ үеийн монгол орны онцлог, хүн амын сэтгэл зүй, төр ёсны байдал, нүүдлийн мал аж ахуй эрхлэх хэв шинжид нийцсэн хамгийн энгийн агаад монголчууд нийтээрээ хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр байжээ. Аравтын тогтолцооны дагуу хаант улсад хичнээн түмт, мянгат, зуут, аравтууд байгуулагдсан талаар хөдөлгөөнгүй тогтоогдсон баримт байхгүй боловч Монголын нууц товчоо зэрэг түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэнээс үзэхэд гол гурван түмтээс гадна хэд хэдэн түмт оршин наад зах нь 100 гаруй мянгат, 1000 гаруй зуут 10000 гаруй аравт байсан нь тодорхой байдаг билээ. Аравтын тогтолцооны үндсэн дээр монголын нэгдсэн улсын засаг захиргааны хуваарь бүрэлдэж, төрийн орон нутгийн удирдлагын бүтэц төлөвшин тогтжээ. Аравтын тогтолцооны дагуу хаан улсын засаг захирааны нэгжид түмт, мянгат, зуут, аравтын ноёдууд төр, цэргийн удирдлагыг хэрэгжүүлж байв. Аравтын тогтолцоо нь Монголын нэгдсэн улсын засаг захиргааны бүтэц, цэргийн зохион байгуулалтын үндэс болж байсан ажгуу.

Чингис хаан аравтын тогтолцоог уламжлан авч хэрэглэхдээ”олон талаар өөрчилж улам нарийн зохион байгуулалтад оруулжээ” /24.60/

Аравтын тогтолцоо нь монголын нэгдсэн улсын төвлөрсөн нэгдмэл байдлыг ханган, түүний дотоод, гадаад бодлого хэрэгжихэд үлэмж ашигтайгаар нөлөөлөх учир тохиолтой байв. Тийм учраас аравтын тогтолцоо өөрөө засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтын хосолсон шинжийг агуулж байжээ. Доктор Д.Гонгор ”Аравтын систем нь тайван цагт иргэний засаг засаглалын, дайны үед тогтоосон хэмжээний цэрэг дайчлан мордуулах үүрэг бүхий цэрэг захиргааны байгуулалтыг хосолжээ” /20.187/ хэмээн бичсэн байна. Аравтын тогтолцоо нь засаг захиргааны төдийгүй цэргийн зохион байгуулалтад чухал үүрэг гүйцэтгэн цэргийг аравт, зуут, мянган цэргээр зохион байгуулан захирч байв.

Аравтын тогтолцооны гол бүтэц болох түмт, мянгат, зуут, аравтыг тус бүрт нь тодруулан авч үзье.

Түмэн. Монголын нэгдсэн улсын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хамгийн том хуваарь нь Түмэн байв. Түүхийн сурвалж бичиг, зохиол, бүтээлүүдэд эртний улсууд болон монгол аймгуудын холбоод бүх нутаг, хүн амаа гурван хэсэг, гар, тойрог, түмэнд хувааж байсныг тэмдэглэсэн байдаг. Г.Сүхбаатар "Монголчуудын эртний өвөг", Хүннү Судлаач Ц.Доржсүрэн "Умард хүннү" гэсэн судалгааны зохиолуудад Хүннү улсад түмэн хэмээх засаг захиргааны хуваарь байсныг нотлон өгүүлсэн байдаг. "БНМАУ-ын түүх" гурвалсан ботийн тэргүүнд нь Хүннү улсын шаньюй "Модун бүх улсаа зүүн, баруун, төв гэж гурван хэсэг хуваасан" /12.84/ хэмээн бичжээ. Ингэхлээр Чингис хаан улсаа 3 түмэнд хуваасан нь Хүннү зэрэг монголын эртний өтгөс, элэнцээс өөрийн бүх улс нутгаа зүүн, баруун ба төв хэмээн гурван хэсэгт хуваан захирч байснаас үүсэл уламжлал бүхий бөлгөө /20.247/.

Монголын нууц товчоонд "Боорчи баруун гарын алтай орчмын түмнийг мэдэж захиртугай", "Мухулай ван зүүн гарын Хираун-Жидуны хавийн түмнийг мэдтүгэй", "Наяа төвийн түмнийг захирах ноён болтугай" /51.178/ хэмээн Чингис хаан 3 түмэн, түүний ноёдыг томилон зарлиг буулгасныг тэмдэглэсэн байдаг билээ.

Чингис хаан түмэнг байгуулан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн албан ёсны хуваарь болгосон нь өмнөх уламжлалыг төдийгүй нэгдсэн улс байгуулж, бэхжүүлэх үеийн түүхэн бодит нөхцөлийг нарийн тооцож харгалзсан хэрэг байжээ. Ч.Далайн дүгнэснээр "Өргөн уудам нутаг дэвсгэртэй, мал аж ахуй эрхлэн тархай бутархай суурьшдаг улсын ард иргэдийг авсаархан удирдаж чаддаг байгуулал бол Түмтийн систем үнэхээр мөн байсан" /24.62/ байж болох бөлгөө.

Рашид-ад-Дин, Д.Гонгор, Ч.Далай зэрэг эрдэмтэн мэргэдийн судалгаа, Монголын нууц товчооны материалаас үзэхэд 10, түүнээс ч илүү түмэн байсан байж болох мэт боловч түүхэнд гурван гол түмний тухай тодорхой тэмдэглэж бусад түмний талаар бага бичжээ. Энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн албан ёсны хуваарь болох гол гурван түмнийг онцлон авч өгүүлээд харин түүнд багтах бага түмнийг төдий л анхаараагүйтэй холбоотой байж болох юм.

Монголын нэгдсэн улсын төрийн түүхэнд түмэн нь их, бага гэсэн хоёр янз байжээ. Их түмэн нь гурав байв. Энэ нь төвийн түмэн, Зүүн түмэн, баруун түмэн болно. Төвийн түмэнд Хэрлэн, Онон, Туул гурван голын сав нутаг, түүн дээр оршин амьдардаг хүн ам харьяалагдана. Төвийн түмнийг Их хаан өөрөө хамаарч Наяа ноён захирч байсан бололтой.

Зүүн түмэн нь монгол орны зүүн хэсгийг харьяалан захирч, дорнод хил нь Их Хянганы нурууг давж байв. Түүнийг "Хиаун Жидун" түмэн гэж нэрлэж байв.

Эл түмэнд 62 мянган өрх-иргэн захирагдаж байсан хэмээнэ. Зүүн түмнийг төрийн нэрт зүтгэлтэн улсын ван Мухулай захирч байжээ.

“Алитан дэрэлэгүн” түмэн хэмээн нэрлэгддэг баруун түмэн Алтайн уулсын сав газар нутгийг харъяалдаг бөгөөд хил нь Алтайн нурууг давж байжээ. Рашид-ад-Дины өгүүлсэнээр баруун түмэнд хорин найман мянган өрх-иргэн захирагдаж байв. Баруун түмнийг төр, цэргийн өргөн мэдлэг, туршлагатай их сайд Боорчи захирч байсан түүхтэй.

Их гурван түмний хүрээнд бага түмэн оршиж байжээ. Монголын нууц товчоонд “Гурван мянган баарины дээр Тахай Ашиг хоёрын хамт Адарганы чинос, Тоолис, Тэлэнгүд аймгийг нийлүүлж түмэн иргэн болгоод Хоорчи захирч, Эрчис мөрний дагуу ойн иргэнд хүртэлх нутгийг эзэмшин нутаглаж, бас ойн түмэн иргэнийг даргалж мэдтүгэй” /51.182/ гэж Чингис зарлиг болсон нь бага түмэн байсны нэгэн жишээ болой.

Монголын нэгдсэн улсад түмтийн тогтолцоо бий болсон нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Уламжлалт ёсыг баримтлан түмэнг байгуулсан хэдий ч төвлөрсөн нэгдмэл улс, түүний аж ахуй, цэргийн байгуулалтын хэв шинж, үүрэг зорилгыг хангах хэмжээнд хүртэл түмэнг зохион байгуулан бэхжүүлсэн нь гол онцлог болно. Энэ талаар Ш.Нацагдорж “Их түмэн нь феодалын эзэмшлын шинжийг гүйцэд агуулсан төвлөн удирдах засаг захиргааны гол нэгж байжээ.” /62.98 / гэж бичсэн байдаг.

Түмэн нь тооны илэрхийлэл мэт боловч түмэн иргэнийг захирна гэсэн утгыг илэрхийлсэн нэр бус, харин тооны илэрхийллээр нь төрд 10000 буюу түмэн цэрэг гаргаж өгч чадах чадвартай нэгж мөн гэж эрдэмтэд судлаачид бичсэн байдаг. Өгүүлбээс Ч.Жүгдэр “Түмэнг” хаандаа арван мянган цэрэг гаргаж өгөх чадвартай” /32.98/ цэрэг захиргааны хамгийн том нэгж хэмээн тодорхойлсон нь бий.

Түмний дотоод зохион байгуулалт нь аравтлах системд үндэслэнэ. Түмэн нь мянгатуудад, мянгат нь зуутуудад, зуутууд нь аравтуудад хуваагдаж шаталсан зохион байгуулалттай байжээ. Энэ зохион байгуулалт нь нийт хүн ам ба цэргийн хүчин хоёрын холбоог бий болгох, төр, иргэнийг засах үйл ажиллагааг энэхүү шаталсан зохион байгуулалтаар явуулж, тэдгээрийг нэгэн хэмжээгүй эрхт хаан төвлөрүүлэн захирч байхыг хангахад нийцэн тохирч байв.

Мянгат. Монголын нэгдсэн улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарийн үлдсэн нэгж нь мянгат байжээ. Төрийн шинэтгэлийн хүрээнд мянганы системийг тогтоож, түүний зохион байгуулалт, бүтцийг шинээр бий болгосон нь Чингис хаанаас төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх бодлогийн салшгүй хэсэг байв.

Феодалын түрүү үеийн шинжтэй Хүннү улсын үед анх бий болсон мянгат нь тухайн үеийн түүхэн нөхцлөөр тодорхойлогдон тус улсын үүслийн нэгэн чухал шинжийг илэрхийлж байсан бөлгөө.

Монголын нэгдсэн улсад тогтоосон мянганы систем өмнөх уламжлалаа өвлөн авсан хэдий ч XIII зууны үеийн нийгмийн харилцааны хөгжлийн хандлагыг тусган илэрхийлсэн өвөрмөц үүрэг, нарийн бүтэцтэй байснаараа онцлог юм.

Мянганы системийн байр суурь, гүйцэтгэж байсан үүргийг сурвалж бичиг, эрдэмтдийн зохиол бүтээлүүдэд нэлээд тодорхой тэмдэглэн бичиж иржээ.

Д.Гонгор Монголын нэгдсэн улсад мянганы систем тогтоосны ач холбогдлыг газар нутгийн хуваарилалт, иргэний харьяалалтай холбож нэлээд үндэслэлтэй дүгнэлт хийсэн байдаг. Тэрээр "XIII зууны эхэнд бүх улсын иргэдийг аравтын тогтолцоотой болгон байгуулсны дотор газар нутгийн хуваарийн хамгийн гол нь мянгатууд байлаа.

Мянгатыг зохион байгуулсан нь ураг төрлийн шүтэлцээ барилдлагаанд тулгуурласан овог аймгийн хуучин байгууллыг халж, газар нутгийн хуваарьт түшиглэсэн шинэ харьяаллыг бий болгов. Чингиснээр хуучин овгийн гишүүд, мянгатын захиргааны иргэд, эзэн хааны хамжлага албат болон хувирч, хамаг монгол тэргүүтэн улс ханлигийн газар нутаг мянгатын ноёны мэдэлд шилжиж улс буюу хааны хувийн өмчид тооцогдох болов. Ийнхүү мянгатын нутгийн шинэ тогтолцоо үүсэн бүрэлдэв" /20.245/ гэж бичжээ.

Алив улсад төрийн тогтолцоо бүрэлдэхдээ улсын нийт иргэдийг ямар гол зохион байгуулалтаар харьяалж, тэдгээрийг засан захирах ямар байгууллагыг хэрхэн бий болгохоо томъёолон тодорхойлдог зүй тогтолтой. Чингэвэл Монголын нэгдсэн улсад нийт иргэдийн харьяалах гол зохион байгуулалт нь мянгат байжээ. Улсын иргэдийг мянгатуудад хуваан харьяалуулж, мянган бүхэнд зохих газар нутаг хуваарилан, түүнийг иргэддээ ашиглуулах эрхийг мянганы ноёд олгох нь Монголын нэгдсэн улсын мянганы системийн гол баримтлал байсан аж. Үүнд мянгат нь тус улсын засаг захиргааны үндсэн нэгж байсан гол үндэслэл оршино. Ч.Далай "Мянгатын систем бол дан ганц цэргийн зохион байгуулалт биш засаг захиргааны үндсэн нэгж болж байсан" /24.61/ хэмээн мянганы шинж чанар үүргийг засаг захиргааны үндсэн нэгж болох талаас нь тодорхойлжээ. Ш.Нацагдорж энэхүү мянганы системийг "Засаг захиргааны бүтцийн үндэс ... төрийн нэгдсэн систем" /61.181/ хэмээн төрийн зохион байгуулалт, тогтолцоонд мянгат гол үндэс болох шинжийг нь тодорхойлон бичжээ.

Чингис хаанд өргөмжлөгдмөгцөө 95 мянганыг байгуулж тэдгээрийг захирах ноёдоор Мэнлиг Боорчи, Мухулай, Хорчи, Илугай, Хунан, Хубилай, Зэлмэ, Түгэ, Дэгэй, Толун, Үнгүр, Чүлггэдэй, Борохул, Шихихутуг, Хүчү, Хөхөчү, Хоргасун, Үсүн, Хуйлдар, Шүлүгэй, Жидай, Тахай, Цагаан гуа, алаг Сорхон Шар, Булу гун, Хорачар, Хөхөчос, Сүйхэту, Наяа, Жунсо, Хучугур, Бала, Оронартай, Дайр, Мугэл, Бужир, Мунгүүр, Долоодой, Бөгэн, Худус, Марал, Жибгэ, Юрухан, Хөхө, Зэб, Удутай, Бала-чэрби, Хэтэ, Субээдэй, Мөнх Халжа, Хурчухус, Гэүги, Бадай, Хишиглиг, Хэтэй,

Чаурхай, Хонгиран, Тогоонтөмөр, Мэгэту, Хадаан, Мороха, Дори-бөхө, Идухадай, Ширахул, Даун, Дамачи, Хауран, Алчи, Тобсаха, Тунхудай, Тобухай, Түйтхэр, Сачуур, Жидэр, Олар, Хингиадай, Буха, Хурил, Ашиг, Хадай, Чигу, Алчи, Буту, Хирэс, Алхушдигид нарыг томилжээ. Монголын нууц товчоонд 95 мянганы ноёны нэрийг бараг бүгдийг нь заан дурдаад “Чингис хааны томилсноор мянгатын ноёд ерэн таван хүн болов” /51.178/ хэмээн өгүүлжээ.

Мянганы ноёныг томилохдоо овог, аймгийн ахлагчдыг тавих зарчмыг баримтлаагүй байна. Харин нэгдсэн хаант улс байгуулахад шадарлан зүтгэж, авъяас чанараараа тодорч, хүч чадлаа харуулсан бөгөөд төрийнхөө төлөө үнэнчээр ажиллах итгэл бүхий жирийн хүмүүс, анд нөхдөө томилж, үе залгамжлах эрх олгожээ. Энэ нь монголын нууц товчоонд “Улс төрийг байгуулалцсан урьдын гавъяат нөхдөө угсаатан ноёд болгож, мятралгүй зүтгэсэн миний хайрт нөхдийг мянганы ноёд өргөмжилж, соёрхлын үгийг хэлье” /51.178/ хэмээн Чингис хаан зарлиг болгосноос тодорхой байна.

Мухулай, Боорчи, Зэлмэ, Борохул, Шихихутуг, Наяа, Зэб, Сүбээдэй зэрэг Чингисийн төрийн зүтгэлтэн цэргийн жанжнууд бүгд мянгат захирч байжээ.

Чингис хаан мянганы систем байгуулах талаар баримталсан зарчим, бодлогоо хэрэгжүүлснээр засаг захиргаа-цэргийн зохион байгуулалтын хосолмол шинж бүхий мянганы системийг тогтоож, улмаар тэр нь төвлөрсөн нэгдмэл улсын зохион байгуулалтын цөм болжээ. Мянганы систем нь тэр үеийнхээ нийгмийн нөхцөл, төрийн бодлого, монголчуудын амьдарч аж төрөх хэлбэр, эрхлэх бэлчээрийн мал аж ахуй, уудам нутаг дэвсгэр зэргээр нөхцөлдсөн хэд хэдэн онцлог шинжтэй ажээ. Үүнд:

Мянганы систем нь овог, аймгийн байгууллын шинжээс бүрмөсөн ангижирч монгол угсаатны нэгдсэн улс тогтон бэхжихэд зохион байгуулалтын үндсэн бүтэц болж үйлчилжээ. Иргэний харъяалал, газар нутаг эзэмшил, мал аж ахуй эрхлэлт, алба татвар төлөлт, засаг захиргааны бүтэц, цэргийн байгуулалт нь мянгатад төвлөрч төлөвшсөн байна.

Мянгат бүр төрөөс тогтоон олгосон нутаг дэвсгэртэй. Энэ нутаг дэвсгэрийн эзэн нь мянганы ноён байжээ. Мянганы ноён мянганы нутаг дэвсгэрийг хуваарилах, зохицуулах, хамгаалах эрхтэй.

Мянганы ноёд, иргэд-малчид энэ нутаг дээр малаа чөлөөтэй бэлчээрлүүлэн ашиглах, ан гөрөө хийх, ус ургамлыг хамгаалах, уул овоогоо тахин бишрэх зэргээр жилийн дөрвөн улиралд зохицсон нүүдэл суудал хийж аж төрж амьдарна. Мянганы ноён харъяат мянгат, түүний нутгийг үе улиран захирч эзэмших боловч эрх мэдлийн байдал нь ихээхэн онцлогтой байв. Мянганы газар нутгийг эзэмших, ашиглах байдлыг суурьшмал орны хүн ам, газрыг байшин сууцаа барьж, ногоо, жимс тарих, мал тэжээх зэрэг жинхэнэ амьдралын гол хэрэгсэл болгон өмчилдөг нарийн горимтой адилтган үзэж болохгүй.

Ийм нарийн горимыг нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын амьдралд хэрэглэх боломжгүй төдийгүй хэрэглэх хэрэгцээ, шаардлага байхгүй байв. Тийм учраас монголд газрыг мянгатын системээр дамжуулан эзэмших арга замыг сонгон тогтоожээ. Мянганы ноён газрыг яг өөрийн хувийн өмч мэт үзэж худалдах эрхгүй. Мянгатын нутаг нь улсын газар гэж тооцогдоно.

Мянгатын дотор газар бэлчээрийг эдлэн ашиглах зохион байгуулалтад хот айл гол хэлбэр болж төлөвшсөн хэмээн үзэж болно. Хот айлд хуулиар тогтоосон хил хязгаар бүхий газар нутаг эдлэх зураг, цэс байхгүй боловч тодорхой нутаг бэлчээрийг хуваарилан авч эдэлбэрлэн чөлөөтэй ашиглах заншил хууль мэт болон хэвшсэн байна. Эл хуваарь хот айлаар нь хэрэгцээгээр нь хуваарилах зарчимд тулгуурлаж байжээ. Чухамдаа энэ нь газар нутгийг хот айлаар эзэмшин эдэлбэрлэх үндэслэл болж, түүний үндсэн хэлбэр нь өвөлжөө, хаваржаа, намаржаа, бууц хэмээн хэлбэршиж байжээ. Хот айлын газар нутагт хот айлын бууц /гэр, хашаа, хороо байрлаж мал сүрэг хотлох газар/ бэлчээр, ус түүн дээрх ургамал, амьтад хамаарагдаж, тэрхүү хот айлын өрх, иргэдийн дундын ашиглалтад байжээ. Хот айлаар газрыг эдэлбэрлэн ашиглах нь бэлчээр шүтдэг нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдрах иргэдийн түүхэн онцлогт тохирч байжээ. Доктор Н.Жагваралын судлан тогтоосноор хот тус бүрт олгосон газар нь тогтоосон хил заагтай, хилийн ихэнх нь уулын нуруу, хамраар тогтоогддог, хэрэв нэгэн амыг хэд ч хотонд өгөх болж, нутгийн хил нь тал газраар гарах бол чулуугаар овоо шав тавьдаг байжээ. Д.Гонгор "хот айл нь монголын малчдын нүүдлийн аргаар газар эдэлбэрлэхийн тодорхой хэлбэр, түүний төлөвлөсөн цогцолбор мөн" /20.299/ гэж бичжээ.

Мянган нь өөрийн нутаг дэвсгэр дээр оршин амьдарч буй иргэнийг харъяалан захирна. Эдгээр нь мянганы харъяат иргэд бөгөөд мянганы ноёны шийдвэрийг биелүүлэн, түүнд захирагдана. Түүний шийдвэрээр алба татвар төлж, цэргийн албанд явж, ав хомрогод оролцоно. Хуралдайн зардал, цэргийн хоол, хүнс, уналга гаргах, өртөө улаа хийх зэргээр бүх төрлийн албанд дайчлагдана. Мянганы иргэн, түүний хил хязгаараас гадагш нэвтрэн гарч болохгүй бөгөөд бусад мянганы нутагт нутаглах хэрэгцээ гарвал зөвшөөрөл авах ёсон тогтжээ.

Мянган бүр хааны зарлигийн дагуу өөрийн харъяалан захирч буй иргэдийн дотроос мянган цэрэг гаргах үүрэгтэй.

Ийм байдлаар нэг талаас мянганы ноён мянгатын нутаг дэвсгэрийн эзэн болж, түүн дээр оршин сууж буй иргэдийг захирч байхад нөгөө талаас мянганы иргэд мянганы ноёнд захирагдан, улсын иргэний шинжтэй алба үүрэг гүйцэтгэж байсан ажгуу. Энэ бүхэн нь мянганы систем засаг захиргааны өвөрмөц нэгж болж, хаант улсын төрийн байгуулалтад томоохон байр эзэлж байсныг харуулна.

Мянгат нь засаг захиргааны хэрэг шийдвэрлэх, хүн амыг засан захирах ажиллагааг зохицуулан удирдах, тэрчлэн цэрэгт татан зохион байгуулахад ихээхэн үүрэгтэй байснаараа онцлог болно.

Мянгат нь засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтад хосолмол шинжтэй үүрэг гүйцэтгэж байсан нь бодит зүйл мөн. Энэ хос үүргийг хооронд нь хэт зааглан холдуулах юм уу аль нэгийг нь салган авч дөвийлгөн үзэх шаардлагагүй болой.

Мянган нь дотроо гадаад мянган ба дотоод мянган гэж хуваагдана.

Дотоод мянганд Чингис хааны өөрийн нь захирч байсан гол мянган, түүний эх Өүлэн, дүү Бэлгүдэй, Отчигин, хүү Зүчи, Цагаадай, Өгөөдэй, Тулуйн мянган орно. Хишигтэн цэрэг нь дотоод мянганд хамаарагдана. Дотоод мянган нь гадаад мянганаас дээгүүр эрх эдэлнэ. “Гадаад мянган нь дотоод мянганаас хэрэг дээрээ хувь дор, гадаад мянганы ноён Чингис хааны нөгөө онцгой эрхтэй хишигтний зэрэгт хүрэхгүй тийм доогуур байжээ” /62.282-283/

Чингис хаан “гадаад мянганы ноёдоос миний хишигтний ерийн хүмүүс эрхэм бөгөөд ... гадаад мянганы ноёнд миний хишигтэнтэй тэнцэж хэрэлдвэл мянганы ноёныг шийтгэе” /51.199/ гэж зарлиг буулгасан байдаг нь үүний хууль зүйн үндэслэл мөн.

Мянгатууд гурван үндсэн шатыг дамжин хөгжжээ. Эхний шат нь 1189 онд эхэлж Хамаг монголын хаант улсыг сэргээн байгуулаад бий болгосон мянгатуудаас бүрдэж байв. Хоёр дахь шат нь 1206 онд нэгдсэн улсыг тунхаглаад шинээр байгуулсан 95 мянгатыг хамарч байжээ. Мянгатын гол үндсэн хэсэг нь энэ үед бий болон тогтжээ. Гурав дахь шат нь монгол улсыг байгуулсны дараа шинээр байгуулсан мянгатууд болно. Эдгээр мянгатуудыг түүхэнд олсон зөөснөөрөө байгуулсан мянгат хэмээн нэрлэж иржээ.

Ийм гурван төрлийн мянгат байсны дотор шинээр байгуулсан мянгатын тоо 95 байсан нь нууц товчоонд тов тодорхой тэмдэглэгдсэн бөлгөө. Харин бусад хичнээн мянгат байсан нь тодорхой бус. Мөн бүгд хэдэн мянгат байсныг түүх шастир, зохиол бүтээлд төдийлөн дурдсангүй. Харин Өвөрмонголын нэрт түүхч Сайшаал “Чингис хааны товчоон” хэмээх алдарт хоёр боть зохиолын дээд ботид “Монголын бүх орон нутгийг нэгтгэж, ерэн таван “мянган”-г хааны зарлигаар /хуулиар/ байгуулжээ. Сүүлдээ нэг зуун хорин есөн мянган болсон” /76.368/ гэж бичсэн байна. Үүнээс үзвэл Монголд наад зах нь 129 мянган байсан аж. Мянганы тоог тодорхой болгох нь хичнээн зуут, аравт байсныг болон тэдгээрт хичнээн ноён, дарга ажиллаж байсныг тогтоох үндэслэл болох ач холбогдолтой ажгуу.

Мянгат бол нүүдлийн мал аж ахуйг хөгжүүлэн, малын тоо толгойг олшруулах, адуун сүргийг улсын ивээлд авах, малчин өрх, айлын аж ахуйг дэмжих, нүүдэллэн аж төрөхийг хот айлын системд оруулах, газар бэлчээрийг хуваарьтайгаар ашиглан, аж ахуйгаа хамгийн энгийн, үр ашигтайгаар хөтлөн явуулж, бие биедээ хамжин туслах заншил төрхийг нэвтрүүлэх нийгмийн чухал үүрэг гүйцэтгэж байсан ажгуу.

Монголын нэгдсэн улсын засаг захиргааны хуваарийн доод шат нь зуут, аравт болой. Зуут, аравтын тухай мэдээлэл түүхэнд маш ховор тэмдэглэгдсэн байдаг. Зуут, аравт нь мянган бүрт байдаг дотоод нэгж юм. Учир нь болбоос мянган бүр дотроо арван зуут болж хуваарилагдана. Зуут бүр нь дотроо бас арван аравтад хуваагдана.

Өөрөөр хэлбэл нэг мянган арван зуутаас, нэг зуут арван аравтаас бүрдэж байсан байна. Мянганы ноёноос газар нутаг хуваарилан ашиглуулах, цэрэгт татах, гувчуур авах, ав хомрогод оролцуулах, мал сүргийг өсгөн үржүүлэх, өтгөс, хүүхдийг асрах, байгалийн гамшигтай тэмцэх, иргэнийг засаглан захирах бүх үйл ажиллагаа зуут, арван бүхнээр дамжин хэрэгжиж байсан бөлгөө.

§5. Түшмэдийн тогтолцоо

Монголын нэгдсэн улсын төрийн түшмэдийн тогтолцоо нь хаан, улсын ван, төрийн сайд, зөвлөгч, ордны түшмэдүүд, түмт, мянгатын захирагч, тэдгээрийн дор ажиллагч түшмэдүүд, зуутын ноён, аравны дарга нараас бүрдэж байсан ажгуу.

Монгол угсаатны нэгдсэн улс тогтож, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт бүрэлдэн бий болохтой нэгэн зэргээр түшмэдийн тогтолцоо бүрдэж төрд алба хаших төрийн түшмэдийн албан тушаал, цол, зэрэг, эрх, үүрэг, ажиллах ёс горим үүсэн төлөвшсэн амой. Монголын нэгдсэн улсын төрийн түшмэдийн тушаал, зэрэг, дэв, эрх, мэдэл, эрэмбэ дарааллын тухай Ш.Нацагдорж бусад эрдэмтэд, судлаачдаас арай илүү тодорхой судалсан ажгуу. Тэрээр “Төрийн дээд эрхийг Чингис хаан барьж, түүний дараа Ерөнхий сайд буюу улсын ван, төрийн заргач, шадар сайдууд, төрийн зайран орно. Эдгээрийн дараа Монголын төрийг байгуулахад хүчин зүтгэж, онцгой гавъяа байгуулсан Чингис хааны шадар есөн өрлөгүүд ба дархадууд ордог байв” /62.175/ хэмээн бичжээ. Нэгдсэн улсын түшмэдийн тогтолцооны хамгийн дээд хэсэгт улсын ван, түмнийг захирагчид, төрийн сайдууд багтаж байв.

Чингис хаан төрийн байгууллагын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээнийхээ эхэнд Мухулайд улс гүрний го ван /улсын ван-Тайши/ цол өгч /51.180-181/ зүүн түмний захирагч, мянганы ноён, цэргийн жанжнаар томилжээ.

Чингисийн есөн өрлөг хэмээх их баатар сайдын хамгийн их нь Го Мухулай⁴⁰ байжээ. Тэрээр бас Сэцэн хэмээх цолтой бөлгөө. Мухулай бол Чингис хааны хамтран зүтгэгч, төрийн түшээ, билгүүн их зөвлөгч, эр зориг, туршлага төгс цэргийн жанжин, төрийн бодлогын баримтлал, тактик боловсруулагч ухаан саруул, холч бодлоготон бөгөөд үүнийхээ хувьд Чингисийн төрийн амьдралд хамгийн их нэр, нөлөө бүхий улсын хэмжээний хоёрдахь өндөр албан тушаалтан болой.

Чингисийн төрийн зүтгэлтний дотор ч тэр, албан тушаалтны дунд ч тэр Арулад аймгийн Наху Баяны хүү Боорчи⁴¹ хүндтэй байр эзэлж байв.

Тэрээр бага наснаасаа Чингистэй хамтран зүтгэж, их нэгдсэн улс байгуулах цагт төрийн их сайд, эзэн хааны шадар зөвлөгч, баруун түмний захирагч, есөн өрлөгийн нэгэн болж төрийн өндөрлөгт гарсан ажээ. Чингис хаан түүнийг ямагт хүндэлж, үг зөвлөгөөг нь нухацтай сонсдог, ёс төр гүйцэтгэх, их үйлсийг ярилцах, зөвлөх бүхэнд хамгийн эхэнд нь дуудаж хүндэтгэн болгоодог байжээ. Боорчи бол гүн ухаантай, эелдэг даруу, эвсэг нөхөрсөг, уужим сэтгэлтэй, эрэлхэг зоригтой, тэсвэр хатуужилтай, төрийн зүтгэлтэн байсан бөлгөө.

Чингис хаан “Боорчи, Мухулай хоёр зөв явдлыг минь зөвшөөрөн тэтгэж, буруу явдлыг минь буцаан зогсоож, энэ их сууринд хүргэв” /51.181/ гэж өгүүлсэн нь эл хоёр түшээ Чингисийн хувийн болон төрийн амьдралд томоохон үүрэг гүйцэтгэсэн төдийгүй өөрсдөө ч төрөлхийн ухаалаг, хурц мэлмийтэй, төр, цэргийн өргөн мэдлэгтэй, амьдралын явцад хатуужин туршлагажсан авъяас билэгт төрийн зүтгэлтэн, Чингисийн итгэлт андууд байжээ.

Төвийн түмнийг их хаан өөрөө хамаарч байсан ч түүнийг захирагч нь Наяа ноён⁴² байжээ. Наяа нь Чингис хааны үнэнч, итгэлт шадар хүн, цэргийн нэртэй жанжин, сайн зохион байгуулагч, төрийн зүтгэлтэн байсан ажгуу.

Төрийн сайдын нэг нь төрийн заргач /шүүгч/ Шихихутуг⁴³ мөн. Монголын нууц товчоонд Шихихутугийг бүх улсын доторхи хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх естойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай гэж бүх улсын дээд заргач /шүүгч/ болгов” /51.180/ хэмээн бичжээ. Ийнхүү Шихихутуг төрийн хууль цааз барьж, түүний бодлогыг боловсруулагч, шударга үнэнийг тогтоогч, заргын хэргийг таслагч, тохирсон ял зэм хүлээлгэгч, газар нутаг, өрх гэр хуваарилан, төрийн их сайд-улсын заргач байсан болой. Чингис хаан Шихихутугийг “Хэлэлцсэн үгийг минь гадагш үл өгүүлэгч битүү лонх”, “мэсийг минь хурцатгагч чулуун билүү”, “бууц нутгийг минь засагч” /43.94 -95/ хэмээн тодорхойлсон нь эл тушаалд тохирох төрийн түшээгийн шинж бүрдмэл байсны илэрхийлэл буюу. Шихихутуг бол Чингисийн эх Өүлэн хатны асран хүмүүжүүлсэн өргөмөл хүү, нигүүлсэнгүй агаад шударга үнэний талд хатуу зогсогч, буурь суурьтай, уужуу талбиун, ухаан саруул, туршлага арвин, эрх мэдэлдээ үл эрдэгч даруу, үнэнч, их хааны гарын түшмэл, есөн өрлөг сайдын нэгэн байжээ. Тэрээр бас авъяас билэгт цэргийн жанжин байсан бөлгөө.

Д.Гонгор “Шихихутуг бол XIII зууны үеийн монголын төрийн зүтгэлтний дотроос хамгийн өргөн боловсролтой бөгөөд улсын ерөнхий заргач, шүүгчээр томилогдон ажиллаж байжээ. Монголын тулгар төрийн анхны төрийн гол хууль-Их засаг зохиоход оролцсон бололтой” /20.154-155/ гэж бичсэн байдаг.

Чингис хааны төрд цэргийн хэргийг эрхэлсэн сайдын тушаал байжээ. Чингис хаан цэргийн хэргийг эрхэлсэн сайдаар өөрийн бие хамгаалах ажлын удирдагч Барулас овгийн Хубилайг томилон ажиллуулжээ.

Хубилай⁴⁴ нь 88 гавъяатны найм дахь гавъяатан, мянганы ноён, цэргийн нэрт жанжны нэг байв. Монголын нууц товчоонд өгүүлснээр Чингис хаан “Хубилай чи, цэргийн үйл бүгдийг ерөнхийлөн захирч бай” /51.188/ хэмээн зарлиглажээ. Ч.Далай Чингис хаан “Хубилайгаар улсын батлан хамгаалалтын ажлыг эрхлүүлжээ” /24.57/ гэж бичсэн нь бий. Сайшаал, Дөрвөн хошууч /нохос/-ийн тэргүүнд явдаг Хубилайгаар “цэргийн үйл бүгдийг ахлах” дарга болгов хэмээн тайлбарласан байдаг /76.352/

Чингис хаан төрийн бэхи хэмээх тушаалд Үсүн өвгөнийг томилжээ. Төрийн бэхи нь “Одод тэнгэрийг шинжиж, он жил, сар, өдрийг тодорхойлон, цаг улирлын тооны бичиг зохиож, наран саран хиртэхийг урьдан мэдэж хаанд айлтгах” /24.57/ үүрэгтэй байжээ.

“Монголын нууц товчоо”-нд дурдснаас үзэхэд Чингис хаан “Монголын төр ёсонд бэхи ноёныг өргөмжлөх заншил бий. Ахмад үеийн хүнээ бэхи болгодог заншилтай тул баарин овгийн Үсүн өвгөнийг бэхи болгоё. Бэхи өргөмжлөгдөөд цагаан дээл өмсөж, цагаан морь унаж, дээд сууринд сууж, он сарыг олж сонгож байтугай” /51.192/ хэмээн зарлиг буулгасан нь тэмдэглэгдсэн байдаг.

Чингис хаан шашны хэрэгт их анхаарал тавьж төрийн зайран хэмээх тушаал бий болгожээ. Чингээд төрийн зайранд Хөхчүг тохоон тавьж их эрх дарх олгосон ажээ. Төрийн зайран нь шашны хэргийг ерөнхийлөн хамаарахдаа бөөгийн шүтлэгийн ёс заншлыг сахих, хаан, түүний төрийг дэмжих, ийнхүү дэмжих, итгэх, хүндэтгэх итгэл үнэмшлийг олон түмэнд төрүүлэх үүрэгтэй. Зайран Хөхчү бол Хорчи, Усүн нарын нэгэн адил хүчит бөө, шашны тэргүүн бөгөөд тэнгэртэй шууд харьцаж хүмүүсийн дотоод санаа сэтгэлийг мэдэн хаанд мэдээлж байх үүрэгтэй байжээ. Зайран нь шашин төдийгүй улс төрийн амьдрал, хүмүүсийн итгэл сэтгэлд их нөлөөтэй байсан аж.


Чингис хаан Тодойг мал аж ахуйн сайдаар, Тататунгааг тамгын бөгөөд бичгийн сайдаар тус тус томилон ажиллуулжээ. Улсын ван, төрийн сайдууд нь өөрийн эрхэлсэн ажлыг хааны өмнө хариуцаж, мөн хааны өмнө хариуцлага хүлээж байсан аж.

Чингис хаан яамгүй, яамны аппаратгүй төрийн тогтолцоо бий болгосон бөлгөө. Төрийн хэргийг гүйцэтгэн явуулах, хууль, зарлигийг зохион байгуулан хэрэгжүүлэх үүргийг төрийн сайдууд шууд өөртөө хүлээн, үүнийгээ газар дээр нь мянгат, зуутын захирагчдаар биелүүлж байсан бөлгөө. Иймээс нэгдсэн улсын төрийн сайдуудын үүрэг, хариуцлага нэн өндөр байсан ажгуу.

Төрийн амьдрал, түшмэдийн ёсонд Чингис хааны хэлбэршүүлж бий болгосон “есөн өрлөг” өвөрмөц байр эзэлж байсан ажээ. “Өрлөг” гэдэг нь хааны хамгийн итгэлтэй шадар хүн гэсэн утгатай ажгуу. “Өрлөг” хэмээх үг нь “өр дотны”, “өр зүрхний” гэдгээс үүссэн хэмээх тул тэдгээр өрлөгүүд бол монголын хааны шадар дотно нөхөд болох нь зайлшгүй” /20.152/, “Чингис хаан есөн жанжин /өрлөг/-тэй” /118.608/ байв.

/бүдүүвч/

МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО



ТӨРИЙН САЙДУУД



Төрийн орон нутгийн байгууллага



“Чухамдаа есөн хүн байсан эсэхийн тухай гэвэл... есөн орон тоо, хэргэм тушаал үнэхээр байсан бөгөөд харин тэгэхдээ орон шийдэхэд нэмэн оруулах зэргээр бүрэлдэхүүн нь өөрчлөгдөж байсан бололтой” /20.152/. Есөн өрлөг гэдгийг саган Сэцэний “Эрдэнийн товч”-д “тэргүүлэн хүчээ өгөгсөд”, Лу. Алтан товчид “дотоод есөн сайд” гэх зэргээр нэрлэсэн байдгийг санах нь зүйтэй.

Монголын нууц товчоо, Алтан товч, Эрдэнийн товч, Чингис хааны цадиг, Чингис судлаачдын бүтээлээс үзэхүйл есөн өрлөгт Арлаудын Боорчи, Жалайрын Мухулай, Урианхайн Зэлмэ⁴⁵, Бесудийн Зэб, Сүлдүсний Сорхон Шар, Ойрадын Хар хиру, Хуучины Борохул⁴⁶, Татарын Шихихутуг, Жарчиу Урианхайн Сүбээдэй нар орж байжээ. Эдгээрээс Борохул нас барахад түүний оронд Зүрчидийн чуу Мэргэнийг томилжээ.

Тунгаан болгоовоос есөн өрлөгт хэд хэдэн онцлог бий бөлгөө.

Есөн өрлөг бол түүхэн бие хүмүүс мөн. Монгол угсаатны нэгдсэн улсыг байгуулах үйлсийг толгойлж, Их Монгол улсын хаан болсон Чингис лүгээ шадарлан нөхөрлөж, үнэнчээр зүтгэснээ амь бие, үйл хэргээрээ нотлон харуулж, цаглашгүй гавьяа байгуулсан их улсын цаашдын хувь заяаны төлөө бие сэтгэлээ зориулах итгэл бүхий хүмүүсээс есөн өрлөг бүрдэж байжээ. Тэд бүгдээрээ тухайн үедээ бодитойгоор амьдарч байсан бөгөөд эр зориг гаргаж, баатарлаг үйлс бүтээсэн гавьяат хүмүүс юм.

Есөн өрлөг нь олон овог, аймгийн хүмүүс, тухайлбал Арлауд, Жалайр, Үшин, Тайчууд, Бэсүд, Урианхай, Татар, Ойрад, Жарчауд, Зүрчид аймгийн харьяатууд болой. Гэсэн ч тэд Чингисийн үйл хэргийг дэмжин, монголчуудыг нэгтгэж, их монгол улс байгуулан төвхнүүлэх зорилгод захирагдсан нэгэн үзүүрт сэтгэлтнүүд байсан ажгуу.

Өрлөгийн тоо ес байсан нь есийн тоог эрхэмлэж ирсэн монголчуудын зан үйл, билэгшээлтэй холбоотой буюу. Есөн өрлөг нь төрийн амьдрал, түшмэдийн хүрээлэлд хамгийн нөлөө бүхий өндөр тушаал хүлээн, эрх дарх эдэлж, их хааны бодлого, шийдвэрийг эрхэмлэн биелүүлдэг, улс төр, цэргийн авьяас билэгт зүтгэлтнүүд байв.

Мухулай улсын ван, /ерөнхий сайд/ түмний ноён, Боорчи баруун түмний ноён, Шихихутуг улсын заргачийн алба хашиж байлаа.

Есөн өрлөгүүд бүгдээрээ мянгат захирч бас есөн хөлт цагаан туг тэргүүлэн есөн их билэгийг эрхлэн хариуцаж байв. Есөн өрлөгийн дотроос хааны дөрвөн хөлөгт Боорчи, Мухулай, Борохул, дөрвөн нохост Хубилай, Зэлмэ, Зэб, Сүбээдэй нар багтаж байжээ. Есөн удаа алдаа эндэгдэл гаргасан ч зэм шийтгэл хүлээлгүй уучлагдаж байх эрхийг Боорчи, Мухулай, Борохул, Шихихутуг, Зэлмэ, Сорхоншар өрлөгт олгосон байдаг. Есөн өрлөгүүд нь хаант төрийн хамгийн гол албан тушаалын сууринд сууж, улс орны баруун, зүүн жигүүрүүдийг захиран, төр, цэргийн бодлогын стратеги, тактик боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд хаан зөвлөх, хаанаас хамгийн их итгэл хүлээлгэн өгдөг үүрэг даалгаварыг нэр төртэйгээр биелүүлдэг зориг төгс баатарлаг хүмүүс байжээ

Есөн өрлөгүүд нь энэ бүхнээрээ хаант төрийн түшмэдийн дотор өндөр дээд зиндааг үүсгэж, төрийн хамгийн гол тушаалын албыг хашин, түүнээ гүйцэтгэхэд шаардагдах их эрх мэдэл эдэлж, өмч хөрөнгө эзэмшиж, иргэд харьяатыг захирч байсан ажээ.

Чингис хаан, Монголын нэгдсэн улс байгуулмагцаа төрийн зүтгэлтэн, төрийн түшмэдийн тогтолцооны ноён нуруу, үндсэн бүрэлдэхүүн болсон 88 гавъяатныг шалгаруулан тогтоож, зарлигаар баталсан түүхтэй. Эдгээр гавъяатны дотор үнэмлэхүй олонхи нь мянганыг захирагч ноёд байгаа хэдий ч тэд төрд байгуулсан гавъяагаараа шалгаргасад байсан ажгуу.

ЧИНГИСИЙН НАЯН НАЙМАН ГАВЪЯАТНЫ НЭРС

1. Мэнлиг-Хонхтон овогтон, Чараха өвгөний хөвгүүн, мянганы ноён
2. Боорчи-Арулад овогтон, Наху баяны хөвгүүн, мянганы ноён, есөн өрлөгийн нэгэн, баруун түмний захирагч, Чингисийн дөрвөн хөлгийн нэг
3. Мухулай-Жалайр овогтон, Толэнгэтү баяны хөвгүүн, улсын ван, есөн өрлөгийн нэгэн, зүүн түмний захирагч, мянганы ноён, Чингисийн дөрвөн хөлгийн нэг
4. Наяа-Баарин овогтон, Ширгүгэтү өвгөний хөвгүүн, төвийн түмний захирагч
5. Сорхон Шар-Сүлдүс овогтон, мянганы ноён, есөн өрлөгийн нэгэн
6. Хорчи-Баарин овогтон, мянганы ноён
7. Зэлмэ-Урианхай овогтон, Жарчигудай өвгөний хөвгүүн, есөн өрлөгийн нэгэн, мянганы ноён, Чингисийн дөрвөн хошуучийн нэг
8. Зэб-Бэсүүд овогтон, мянганы ноён, есөн өрлөгийн нэгэн
9. Сүбээдэй-Жүрчид овогтон, есөн өрлөгийн нэгэн, мянганы ноён, цэргийн гарамгай жанжин, Чингисийн дөрвөн хошуучийн нэг
10. Илүгэй-Алчидайн ураг, Алчидайн нь Чингисийн дүү Хачигуны хөвгүүн, Чингисийн ураг, мянганы ноён, Өгэдэйн хоёр зөвлөгчийн нэг.
11. Зүрчидай-Орогуд⁴⁷ овогтон, мянганы ноён
12. Хунан-энигэс овогтон, хааны гурван зөвлөгчийн нэг, зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг, мянганы ноён
13. Хубилай-Барулас овогтон, Чингисийн есөн өрлөг, дөрвөн хошуучийн нэг, мянганы ноён
14. Түгэ-Жалайр овогтон, Тэлэнгэтү баяны ач буюу Чулуун хайчийн хүү, мянганы ноён
15. Тахи-Бэсүүд овогтон, зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг, мянганы ноён, Өгэдэйн хоёр зөвлөгчийн нэг
16. Толун-Хонгирад овогтон, Черби, мянганы ноён
17. Өнгүр-Хиюд овогтон, Бартан баатрын ахмад хөвгүүн, Манхату Хиюны хүү, мянганы ноён

18. Чүлгүдэй-Сүлдүс овогтон, мянганы ноён
19. Борохул-Өнчин /Өгүшин/ овогтон, Өэлүн эхийн тэжээн өсгөсөн дөрвөн хөвгүүний нэг, Чингисийн есөн өрлөг, дөрвөн хүлгийн нэг, мянганы ноён
20. Шихихутуг-Татаар овогтон, Өэлүн эхийн тэжээн өсгөсөн дөрвөн хөвгүүний нэг, бүх улсын их заргач, мянганы ноён
21. Хөхөчү-Мэргид овогтон, Өэлүн эхийн тэжээн өсгөсөн дөрвөн хөвгүүний нэг, Отчигин, Өэлүн эхийн дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
22. Хөгэчү-Бэсүд овогтон, Өэлүн эхийн тэжээн өсгөсөн дөрвөн хөвгүүний нэг, Отчигин, Өэлүн эхийн дөрвөн зөвлөгчийн нэг
23. Хоргосун-Өэлүн эх, Отчигиний дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
24. Үсүн-Хэрэйд овогтон, мянганы ноён
25. Хуйлдар⁴⁸-Мангуд овогтон, сэцэн, мянганы ноён
26. Шилухай-Жэгүрэйд овогтон, мянганы ноён
27. Жэтэй-Мангуд овогтон, мянганы ноён, Тулуйн хоёр зөвлөгчийн нэг
28. Тахай-Сүлдүс овогтон, мянганы ноён
29. Цагаан гуа-Нэхүс овогтон, наян найман гавъяатанд нэхэн өргөмжлөгдсөн. Дараа нь хүү Нарийн Тогорил нь хашсан, мянганы ноён
30. Алаг-Баарин овогтон. Ширгүчэтү өвгөний хөвгүүн, Түмний ноён Нягийн ах, мянганы ноён
31. Булуган-Барулас овогтон, мянганы ноён
32. Харачар-Барулас овогтон, Саху сэцний хөвгүүн, Цагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
33. Хөхөчөс-Баарин овогтон, Хаанд зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг, Цагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
34. Сүйхэтү-Хонхотан овогтон, Черби, мянганы ноён
35. Жонсой-Ноёгин овогтон, Өэлүн, Отчигины дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
36. Хүчүгүр-Бэсүд овогтон, мянганы ноён
37. Бала Оронардай-Оронар овогтон, мянганы ноён
38. Дайр-Хэрэйд овогтон, Дайр баатар хэмээн алдаршсан, Дундад Азид Чингисийн дайнд хошуучлагч байсан, мянганы ноён
39. Мүгэ-Хонгирад овогтон, Цагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг, мянганы ноён
40. Бужир-Чэрби, мянганы ноён
41. Мөнгүр-Сагашууд овогтон, Зүчийн гурван зөвлөгчийн нэг, мянганы ноён
42. Долоодай-Мянганы ноён
43. Бөгэн-Ургуд овогтон, мянганы ноён

44. Хотос-Барулас овогтон, мянганы ноён
45. Марал-мянганы ноён
46. Жибгэ-Жалайр овогтон, Тэлэгэтү баяны хүү, Хасарын зөвлөгч, мянганы ноён
47. Юрухан-Жалайр овогтон, мянганы ноён, Үнэгэн давааны байлдаанд нас барсан
48. Хөхэ-Татар овогтон, мянганы ноён
49. Удутай-Мянганы ноён
50. Бала Чэрби-Жалайр овогтон, Сэцэн Домогийн хөвгүүн, Архай Хасарын дүү, Тулуйн хоёр зөвлөгчийн нэг, мянганы ноён
51. Хэтэ-Мянганы ноён, Зүчийн гурван зөвлөгчийн нэг
52. Мөнх Халжа-Мангууд овогтон, Хуйлдарын хөвгүүн, мянганы ноён
53. Хорчахус-Мянганы ноён
54. Хөхи-Хиюд овогтон, занги, мянганы ноён
55. Бадай-Оронар овогтон, “Муу өндрийн байлдаан”-д Чингист мэдээ хүргэсэн, мянганы ноён
56. Хишилиг-Оронар овогтон, мянганы ноён
57. Хэтэй-Орогууд овогтон, Жүрчидэйн хөвгүүн, мянганы ноён
58. Чаурхай-Урианхан овогтон, Жарчигудай өвгөний хөвгүүн, Зэлмэ жанжны дүү, мянганы ноён
59. Онгиран-Мянганы ноён
60. Тохун-Өгүшин овогтон, Борохул жанжны хөвгүүн
61. Төмөр-Сонид овогтон, Хар хорум хотын захирагч, мянганы ноён
62. Мэгэтү-Хияд овогтон, мянганы ноён
63. Хадаан-Дархад овогтон, мянганы ноён
64. Мороха-Мянганы ноён
65. Дори Буха-Мянганы ноён
66. Идугадай-Мянганы ноён, Цагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг
67. Шархул-Хэрэйд овогтон, Есөн Буха-ийн дээдэс, мянганы ноён
68. Дагун-Мянганы ноён
69. Тамачи-Мянганы ноён
70. Хууран-Мянганы ноён
71. Алчи-Мянганы ноён
72. Тобсаха-Дөрбэн овогтон, мянганы ноён
73. Тонхудай-1203 онд Балжуна нуурын тангаргатад байлцсан тул гавъяатнаар тодорсон. Тохувадай гэсэн нэрийг монголчуудаас авч, ахынхаа барьцаанд Монголд үлдэж, Чингисийн итгэлийг хүлээн хэвтүүл болжээ. Мянганы ноён
74. Тобуха-Хэрэйд овогтон, Шархулын ах, мянганы ноён

75. Ажинай-Хонгирад овогтон, мянганы ноён
76. Дүйтгэр-Мянганы ноён
77. Сэцэгүр-Горлос овогтон, мянганы ноён
78. Жэдэр-Өгөдэй жанжныг даган Кипчаг, Ханлин, Сартул улсад дайтаж явсан гавьяатан, мянганы ноён
79. Улар хүргэн-Мянганы ноён
80. Хингиядай-Олхонуд овогтон, мянганы ноён
81. Буха хүргэн-Жалайр овогтон, Хүмүн гуагийн хүргэн, Мухулайн дүү, мянганы ноён
82. Хорил-Тайчууд овогтон, “Хорил жанжин” хэмээн алдаршсан, мянганы ноён
83. Ашиг хүргэн-Мянганы ноён
84. Хадай хүргэн-Ойрадын Худуга бэхийн хөвгүүн, Ян Ан гүнж хорийн хүргэн мянганы ноён
85. Чихү хүргэн-Хонгирад овогтон. Алчи ноёны хөвгүүн. Алчи ноён нь Дай Сэцэний хөвгүүн, Чингисийн Бөртэ хатны дүү, мянганы ноён
86. Алчи хүргэн-төрийн нагац цолтон, мянганы ноён
87. Буту хүргэн-Ихирэс овогтон, хааны охин дүү Тэмүлэний нөхөр, мянганы ноён
88. Алахуш Дигид Хури хүргэн-Онгуд овогтон, мянганы ноён

Наян найман гавьяатан нь Сэцдийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах, хаанаас оногдуулсан төр, цэргийн хариуцлагатай даалгаврыг ямар ч нөхцөлд хүчээ дайчлан үг дуугүй биелүүлэх, бүх хүч чадал, авьяас билгээ зориулан, амь биеэ үл хайрлан зүтгэх хатуужилтай хүмүүс байсан учир хааны түшиглэх гол хүчин мөн ажгуу. Гавьяатан өөрөө амь эрсэдвэл үр хүүхэд нь залгамжлан авч эл хүндэт үүргийг хэрэгжүүлнэ.

Наян найман гавьяатныг тодруулж, төрийн бодлогоо хэрэгжүүлэх гол хүчин болгож байсанд монголын нэгдсэн улс хүчирхэг нэгдмэл том гүрэн болохын нэгэн нууц байсан ч байж болохыг үл үгүйсгэх бөлгөө.

1206 онд Монголын нэгдсэн улсыг байгуулсны дараа чэрбийг уламжлуулан үлдээж, төрийн түшмэдийн тогтолцоонд тодорхой байр эзлүүлэн бэхжүүлсэн байна. Чэрби нь түшмэл гэсэн утгад нийцэх агаад хааны ордонд болон хишигтэн цэрэгт алба хаагч түшмэлүүд ажгуу. Тодой, Доголху, Буха зэргийг тус бүр хишигтэн цэргийн нэгэн ээлжийн захирагчаар томиллов. Өчлэл чэрби далан турхаг захирах болов. Эдгээр нь цэргийн хэргийг эрхлэх чэрби нар байжээ. Үүнээс гадна ордны хэргийг эрхлэх чэрби нар байсан аж. Хааны ордны чэрби нар нь ордны албаны үйл ажиллагааг эрхлэн явуулж, ордонд ёс журмыг сахиулах, албаны өдөр тутмын асуудлыг зохицуулах үүрэгтэй. Монголын нууц товчоонд дурдсанаас үзэхэд хааны ордонд 6 чэрби ажиллаж байжээ.

Хаанд үйлчлэх адуучин, үхэрчин, хоньчин, тэмээчин, тэрэгчин, газарчин, буурчи, үйлчлэгч нарын ажил хэргийг чэрби нар зохицуулж байжээ.

Чэрби нар бол төрийн түшмэлийн хэсэг, хаанд итгэгдсэн бөгөөд хаан, түүний ордныг хамгаалах, хааны өдөр тутмын албыг залгуулах үйл ажиллагааг эрхлэн хариуцаж байснаараа онцлог бөлгөө.

Хаант улсын төрийн түшмэлийн ёсонд дархлал олгон хүндэтгэж, төрд хүчий нь авах ёсон өвөрмөц байр эзэлж байсан аж. Монголын эртний улсууд болох Жужан /Нирун/, Түрэг улсын үеэс уламжилсан дархлан ёсыг Чингис хаан төрийн хүчийг хангах нэгэн арга болгон хэрэглэж дархадын язгуурыг бий болгожээ. Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн баримтаас үзэхэд Чингис хаан Сүлдүсний Сорхон Шар, агтчин Уркуд, Килингуд овгын Бадай, Хишилэг, Хорчи нарыг дархад болгож, уугуул овог аймгаа хураан цуглуулж захирах, газар нутгаа ургийн урагт хүртэл эзэмших, дайны ба ангийн олзоо хувьдаа ашиглах дархан эрх олгож байжээ.

Монголын нууц товчоонд бичигдсэн баримтыг түшвээс Чингис хаан зарлиг буулган Сорхон Шард “нутаг, дархалж, мэргэдийн газар, Сэлэнгээр ургийн урагт хүртэл нутаг орон эзэмших” /51.134/ Сорхон Шар, Бадай, Хишиглэг нарт “олон дайсанд довтолж олз юм олбол олсоноо бүрэн авах, аян ав хийж ан гөрөөс албал олсноо бүрэн авах” /51.194/ Хорчид⁴⁹ Түмэдийн “30 охиныг авах” /51.210/ дархан эрх олгож, ”Бадай, Хишилэг хоёрыг дархадын ноёд болгожээ” /124.34/.

Эдгээр дархад нь бүгд мянгат захирагч, нутаг газар, харъяат иргэдээ засан, өмч хөрөнгөө аривжуулж, дархалсан эрхээ эдлэн нэгэн өвөрмөц язгуурыг бүрдүүлж дараа үедээ уламжлагдсан болой.

Төрийн түшмэдийн хүрээнд түмт, мянгат, зуут, аравтын ноёд чухал байр эзэлж байжээ. Тэд тооны хувьд ч төрийн түшмэдийн дийлэнх олонхийг бүрэлдүүлж байв.

Хамгийн бага хэмжээнд авч үзэхэд 15300 гаруй хүн түмт, мянгат, зуут, аравтын ноёноор ажиллаж байсан ажгуу.

Төрийн албаны түшмэдийн тогтолцоонд засаг захиргааны нэгжийг удирдах ноёдыг томилох, захирах, захирагдах, дэвшүүлэх, огцруулах ёс горим тогтон үйлчилжээ.

Түмт, мянганы ноёныг их хаан, зуутын ноён, арваны ноёныг мянганы ноён томилж байв. Аравны ноён өөрийн зуутын ноёнд, зуутын ноёд мянганыхаа ноёнд, мянгатын ноёд түмтийнхээ ноёнд шууд захирагдаж, гаргасан шийдвэр, өгсөн үүргийг нь хатуу чанд биелүүлэх ёсон тогтож хэвшжээ.

Чингис хаан, түмт, мянгат, зуутын ноёдод жилийн эхэн ба адаг хоёрт төрийн бодлого, хууль цаазын талаар зарлиг, айлтгал буулган, заавар, зөвлөгөө өгч, хууль цааз хэрхэн биелж байгаа талаар ярилцдаг журмыг тогтоожээ.

Энэ нь түмт, мянгат, зуутын ноёдоос харьяат иргэнээ засан захирахад удирдлага болгох учир холбогдолтой байжээ. Зуутын ноёд аравтын ноёдоо энэхүү зарлиг, зөвлөгөөний дагуу сурган захирах үүрэгтэй байв.

Түмт, мянгат, зуут, арваны ноёныг сонгон шалгаруулж томилох, албан тушаалаас нь өөрчлөх, огцруулах хуулийн үндэслэлийг тогтоож мөрдсөн нь төрийн удирдах албан тушаалтнаар авч ажилуулах гол болзол болсон байна. Энэ тухай Чингисийн Их засаг хуульд "арваныг захирч чадсан хүнд мянгат, түмтийг захируулж болно. Өөрийн аравныг захирч чадаагүй аливаа ноёныг гэмтэн болгож, арваны дотор хэн чадахыг нь сонгож ноён тавина. Түмт, мянгат, зуутын ноёд үүн лүгээ нэгэн адил" хэмээн заажээ.

Нэг талаас аравт, зуут, мянгатын ноёд үүргээ сайн биелүүлж, мэдлэг, дадлага чадвартайгаа батлан харуулж чадсан нөхцөлд уг ноёноор тогтвортой ажиллах буюу дээд шатныхаа нэгжийн ноёноор дэвшин ажиллах болзлыг хангасанд үзэх, нөгөө талаас үүргээ биелүүлж чадахгүй, чадах чадваргүйгээ харуулбал уг дуугүй огцруулж, дахин албан тушаалд авч ажилуулахгүй байх нь хаант улсын төрийн албаны бодлого байж, хуулиар баталгаажин хэрэгжиж байсан ажээ. Чингис хаан, аравт, зуутын ноёд өөрөөр хэлбэл, төрийн доод шатны байгууллагын ноёдод их анхаарал тавьж байжээ. Үнэндээ аравт, зуутын ноёдууд цэрэг, иргэнээ шууд биечлэн засаж, төрийнхөө бодлогыг ойлгох, биелүүлэхийн учир холбогдлыг таниулан мэдүүлэх, хэрэгжүүлэхэд нь туслах явдлыг өөрийн хатуу үүрэг хэмээн үзэж аравт, зуутын гишүүн бүхэнтэй байнга ажилладаг байжээ. Тэд өрх, хүн бүрийн байдлыг нарийн мэдэж, хүүхэд бүхнийг мал маллах, морь унах, сум харвах эрдэмд сурган, тэсвэр хатуужил суулгахаас аваад нутаг, ус, нүүдэл суурьшил, цэрэгт цугларах, хүнс унаа бэлтгэх, гэрлэж хуримлах, татвар төлөх, зуд бэрхшээлийг давах, ан ав хийх, дэг журмыг сахиулах хүртлэх ажлыг зохицуулан зохион байгуулж, төрийн төлөөлөгчийн үүргээ чандлан биелүүлэх үүрэгтэй байв.

Төрөөс түмт, мянгат, зуут, аравтын ноёд хатуу шаардлага тавьж, тэд ч мөн төрийнхөө өмнө өндөр үүрэг, хариуцлага хүлээж байжээ. Жишээлбээс, аравны ноён захирч байгаа цэргээ аян, байлдааны өмнө гутлаа хэрхэн тохируулж, яаж ороосноос эхлээд ямар бэлтгэл, зориг сэтгэлтэй байгааг хүртэл биечлэн шалгаж дутагдалтай зүйлийг нь засуулах үүрэгтэй. Хэрэв аравны дотроос аль нэг хүн хулгай хийсэн бол тэрхүү арваны ноёныг шийтгэнэ хэмээн хуульд заасан байдаг бөлгөө.

Энэ бол өрх, иргэний харьяалсан албан тушаалтны үүрэг хариуцлага нь эцсийн эцэст тэдний төлөө үнэнч шударга үйлчилсэн үр дүнгээр хэмжигдэнэ хэмээсэн Чингис хааны үзэл баримтлал, билэг сургаалын биелэл байсан болой.

Чингис хаан түшмэдийн ёс, орон тоог бий болгон тэдгээрт томилох зарчим журмыг тогтоон тодорхой хүмүүсийг ажиллуулснаар төрийн алба цэгцэрч, хаанд үнэнч зүтгэн, түүний үүрэг зорилтыг хэрэгжүүлэх гол хүчин бүрэлдэн төлөвшжээ.

Чингис хаан төрийн албыг бүрэлдүүлэн төвхнүүлэхэд эрдэм ухаан, авъяас чадвар, билэг арга сайтай, сэтгэл оюун уужим, бодох сэтгэх нь саруул, тушлага хатуужилтай хүмүүсийн хүч чадлыг дээдлэн ашиглах бодлого баримталсан нь амжилт олох нэгэн чухал хүчин зүйл болсон ажээ. Чингис хаан сэцдийн зөвлөл бий болгож, есөн их өрлөг сайд томилон, наян найман гавъяатныг тодруулж ажиллуулсан нь чухамдаа энэхүү бодлогын илэрхийлэл юм. Ахмад буурлууд, улс төр, цэргийн зүтгэлтнүүд, эрдэм чадалтай хүмүүсийн сургаал зөвлөгөө, санал дүгнэлтийг байнга сонсож, тунгаан болгоож байсан нь төрийн алба хаших хүч төлөвшихөд ихээхэн чухал хүчин зүйл болж нөлөөлжээ. Хэрэйдийн хаант улсын тэргүүн Тоорил ван, Хонгирад аймгийн хамгийн нөлөө бүхий сурвалжтан Дай сэцэн, Тэмүүжин эхийн зөвлөгч Мэнлиг эцэг, есөн өрлөгийн хамгийн ахмад нь болох Сорхон Шар, Мангут овогтоны Хуйлдар Сэцэн, Найманы хант улсын бичгийн сайд Тататунгаа, Хятадын гүн ухаантан Чан Чунь, Хятадын эрдэмтэн Елюй Чу Цай нарын мэдлэг зөвлөгөөг Чингис ихэд болгоон түшмэдийн ёсыг төлөвшүүлэх арга ухаандаа шингээж байсан бөлгөө.

Чингис хаан төрийн албаа явуулахад бичиг хэрэглэж “уйгар бичгийн үндсэн дээр монгол бичиг зохиолгож улмаар улсын бичиг болгожээ”. Уйгар бичгийг авч хэрэглэсэн нь том дэвшил байсан бөлгөө. Английн эрдэмтэн Ж.Ж.Саундерс “монгол хэлийг бичгийн хэл болгосон нь Чингисийн нэг чухал гавъяа байв” /78.180/ гэж дүгнээд тэр цагаас хойш монголын албан хэрэг бичгээр үйлдэгдэх болсныг тэмдэглэжээ.

Чингис хаан” заргыг шийтгэж түүнийгээ хөх дэвтэрт бичиж тэмдэглэгтүн... Шихихутугийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” /51.180/ хэмээн зарлигласныг “Нууц товчоо”-нд дурджээ. Персийн түүхч Жувейни “Чингис хаан монгол хүүхдийг уйгар бичигт сургах хийгээд эдгээр засаг ба хууль дүрмийг хуйлмал цаасан дээр бичиж тэмдэглэхийг зарлиг болгожээ” /34.25/ хэмээн “Ертөнцийн байлдан дагуулагчийн түүх” номондоо бичжээ. Ийнхүү Монголын нэгдсэн улсад уйгаржин бичгийг төрийн албан хэрэгт өргөн хэрэглэж, энэ бичгээр төрийн хэргийг хөтөлж байжээ.

Монголын нэгдсэн улсын төрийн албан хэргийн баталгаа нь төрийн тамга байсан бөлгөө. Хаант төрд алтан тамга, хөх тамга гэсэн хоёр тамга байжээ. Чингис хаан төрийн тамгаа хашаар хийлгэсэн нь Лигдэн хааныг өөд болох хүртэл уламжлагдан хэрэглэгдсэн түүхтэй. Үүнээс гадна төрийн элчийг итгэмжлэн батлах учиртай алт, мөнгө, хүрэл пайзыг хэрэглэж байжээ. Энэ тухай дээр өгүүлсэн билээ.

§6. Цэргийн зохион байгуулалт, стратеги тактик

Монголын нэгдсэн улсын төрийн байгууллагын тогтолцоонд цэргийн байгуулалт өвөрмөц байр эзэлж байжээ.

XIII зууны үеийн монгол улсын цэргийн байгуулалт, үйл ажиллагааны тухай өгүүлсэн сурвалж бичиг, бүтээлүүдийг судлан шинжихүйд Чингис хаан цэргийн шинэтгэл хийж, сайн зохион байгуулагдсан хүчирхэг арми байгуулсан нь тодорхой байна.

Чингис хаан цэргийн жанжнуудынхаа хамт хаант улсын цэргийн номлол, стратеги, тактик, цэргийн зохион байгуулалт, цэргийн сахилгын үндсийг боловсруулж хэрэгжүүлсэн аж. Чингис хааны цэргийн номлолын гол агуулга нь Цэргийн зохион байгуулалт, хүч чадлыг бэхжүүлэх явдал улс орон нэгдэлтэй, хүчирхэг байж, өөрийгөө хамгаалах чадвартай байхын баталгаа; Өмнөх үеийн уламжлал, өөрийн үеийн улс орны өвөрмөц нөхцөл, онцлогт нийцсэн өндөр зохион байгуулалт, сахилга бүхий арми төрийн дотоод, гадаад үүргийг хэрэгжүүлэх хэрэгсэл; Цэргийн стратеги, тактик сайн эзэмшсэн зориг, туршлага төгс жанжнууд цэрэг, армийн тархи ноён нуруу; Цэрэг, арми ба ар тал нэгдмэл байх; Эр зоригтой бөгөөд үйл хэрэгтээ үнэнч, байлдааны арга техник эзэмшсэн, хатуу сахилгатай цэргүүдэд армийн хүч орших; Цэрэг, армийг шилмэл Зэбсэг хэрэгсэл, хүнс, хувцас, уналга холбоогоор хангах; Цэргийн ноён бүр өөрийн цэргийн сэтгэл зүй, цэргийн ба хувийн бэлтгэлийг бүрнээ хариуцахад оршиж байсан ажгуу. Чингис хаан цэргийн номлол боловсруулж, шинэтгэл хийхдээ овгийн цэргийн уламжлал, эртний улсуудын цэргийн байгуулалтын туршлага, сургамжийг ашиглахын хамт шинэ зарчим, зохион байгуулалт нэвтрүүлэхэд их анхаарал тавьсан байна.

Эртний уламжлалт аравтын системийг цэргийн зохион байгуулалтын үндэс болгож үүний үндсэн дээр аравт, зуут, мянгат, түмт бүрээр цэрэгт татан байршуулж, удирдлагын өвөрмөц шинэ тогтолцоо бий болгон захирах ноёдоор хамгийн шилдэг хүмүүсийг томилж байв.

Улсын цэргийг бүхэлд нь их хаан удирдана. Хааны дараа төрийн тусгай сайд ажиллаж, улсын цэргийн хэргийг эрхлэн явуулна. Цэргийн хэргийг эрхэлсэн төрийн сайдаар зоригт жанжин Хубилай ажиллаж байжээ.

Үүнээс гадна цэргийн бодлогын асуудлыг хариуцсан тусгай газар хааны дэргэд ажиллаж байсан аж. Энэ газрыг “Илдэч” хэмээн нэрлэдэг байсан байна.

Чингис хаан 12 хүнээс бүрэлдсэн “Илдэч” хэмээх цэргийн бодлогын газрыг байгуулж ажиллуулжээ. Тус газар нь цэрэг дайчлах, дайны төлөвлөгөө боловсруулах, дайнд илгээх, цэргийн захирагч, жанжнуудыг томилох, дайсны байдлыг тагнах, мэдээлэл цуглуулж шинжлэх, цэргийн хангамжийн ажлыг зохицуулан зохион байгуулах үүрэгтэй байсан аж. Монголын нэгдсэн улсын цэрэг нь гүйцэтгэх үндсэн үүргээсээ шалтгаалан хишигтэн буюу шадар цэрэг, их цэрэг буюу байнгын цэрэг гэсэн хоёр төрөлд хуваагдаж байв.

“Түр их улсыг хамтатгаж, ганц жолоондоо оруулсан тул одоо надад мянган шадар хишигтэнг ялгаж өг.

Хэвтүүл, хорчин, торгуудын хамт бүгд түмэн хүн болгон өгтүгэй” /51.135/ хэмээн Чингис хаан зарлиг буулгасныг Монголын нууц товчоонд тэмдэглэжээ.

Доктор Д.Гонгорын судалгаагаар хишигтэн цэрэг бол шилж сонгогдсон, сайн бэлтгэгдсэн, хатуу сахилга бүхий “онцгой маягийн шадар цэрэг” /20.187/ болмуй. Тэр нь хоёр үндсэн үүрэгтэй. Хаан, түүний бие, орд өргөө, хатад, гэр бүлийг хамгаалж, ордны үйлчилгээг хариуцан гүйцэтгэх нь нэгдэх үүрэг болно. Ан ав, аян байлдааны үед хаанд шууд захирагдаж, байлдах болбоос хааныг хамгаалан шийдвэрлэх цохилт өгөх гол цөм болж тулалдах нь хоёр дахь үндсэн үүрэг болой.

Хишигтэн цэрэг⁵⁰ Чингис хааны сүр хүчийн илэрхийлэл, халдашгүй байдлын баталгаа, цэрэг армийн үлгэр дууриал болж, нэн өндөр үүрэг хариуцлага хүлээж байсныг тэмдэглэлтэй. Тийм учраас хишигтэн цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагааг тодорхойлсон хууль гаргаж, түүнийг биелүүлэхэд хаан өөрөө үлэмж анхаарал тавьж байсан аж. “Монголын нууц товчоо”, ”Алтан товч” хэмээх сурвалж бичигт хишигтэн цэргийн талаар нэлээд тодорхой зүйл тэмдэглэгдсэн нь улсын цэргийн байгуулалтыг судлахад гол хэрэглэгдхүүн болох ач холбогдолтой болой.

Хишигтэн нь торгууд⁵¹, хэвтүүл, хорчин гэсэн 3 хэсэгт хуваагдана. Хишигтэн цэргийн тоо нэгэн түм буюу 10000, үүнээс торгууд 8000, хэвтүүл, хорчин 2000 болно. Хорчин нь 400 байжээ. Эдгээр нь гүйцэтгэх үндсэн үүргээрээ ялгаатай. Хэвтүүл шөнийн хамгаалалт, торгууд өдрийн хамгаалалт, хорчин буурч үйлчилгээний ажлыг тус тус хариуцан гүйцэтгэнэ. Хишигтэн нь дөрвөн ээлж болж ажилладаг журамтай байжээ.

Хишигтэн цэрэгт алба хаах нь нарийн дэгтэй. Чингис хааны зарлиг болгосноор хишигтэн цэрэгт мянганы ноёдын хөвгүүд нэг дүү, арван нөхөр, зуутын ноёдын хөвгүүд нэг дүү, таван нөхөр, аравны ноёд нэг дүү, гурван нөхөр сонгон авч, уналга морь бусад зүйлийн хамт авчирч алба хаана. Чингэхдээ хишигтэн цэрэгт эрэлхэг зоригтой, бие бялдраар чийрэг, цэргийн эрдэмд шалгарсан, үүрэгтээ үнэнч шилмэл залуучуудыг сонгон авч алба хаалгана. Хишигтэн цэргийн бүх хэрэгцээт зүйлийг тухайн мянгат нь гаргах хуультай. Хэвтүүлийг Их-Нэурин, Хорчины ээлжүүдийг Зэлмийн хөвгүүн Есөнтэй, Түгээгийн хөвгүүн Бүхэдэйтэй, Хорч-худаг, Лаблах нараар, торгуудын ээлжүүдийг Боорчийн ураг Өэлэн чэрби, Мухулайн ураг Бухар, Илугайн ураг Алчидай, Долой чэрби, Доголху чэрби, Жорчидайн ураг Чанай, Алчийн ураг Ахудай нараар захируулж байсан байна. Ээлжийн ахлагчид харьяат хишигтэнээ жагсааж, ээлж хишигт оруулаад гурав хоноод солилцуулдаг байсан аж. Хишигтэн цэрэг ээлжээ таслахыг хориглоно. Өдрийн цагт хишиг бүхий хорчин торгуудууд ажиллана. Шөнийн цагт хэвтүүлийн цэрэг хааны ордныг хамгаална,

Хааны хишигтэн цэрэг нь ёс журмыг чанд сахидаг, төрийн нууцыг хамгаалж чаддаг, сайн бэлтгэл сургуультай, хүмүүс байсан аж.

Мөн тусгай халамжид байж зөвхөн хаанд захирагдана. Чингис хаанаас өөр хэн ч зэмлэл шийтгэл хүлээлгэх эрхгүй байв. Шаардлагатай үед цэрэг захирна. Тэдний дотроос хариуцлагатай албан тушаалд томилдог байв.

Хишигтэн цэргийн дотроос хэвтүүлүүд ордны үйлчлэгчид, хоньчин, тэмээчин, үхэрчин нарыг захиран мэдэж, ордны тэрэг өргөө, гэрийг хариуцан хамгаална. Мөн туг, Зэвсэг, хэрэгслийг хадгалан, тахилгын идээ, ундыг тарааж өгөх үүрэг гүйцэтгэнэ. Хэвтүүлээд алтан ургийнхны орд өргөө буух нутгийг сонгох, зөөж буулгах, ан ав хийхэд оролцох үүрэг гүйцэтгэнэ. Хишигтэн цэрэг нь цэргийн аян, байлдааны үед хааныг хамгаалж явна. Хэрэв хаан байлдаанд биечлэн орвол хишигтэн цэрэг мөн орж хааныг хамгаалан байлдаана.

Хишигтэн цэрэг бол Монголын нэгдсэн улсын цэргийн гол цөм, Чингис хаанд үнэнч зүтгэх шаардлагатай шилмэл цэрэг байв. Цэргийн байгуулалт, сахилга, журам бэхжих, цэрэг байлдаанд амжилт олох, чадварлаг захирагч, жанжнууд төрүүлэхэд хишигтэн цэрэг чухал роль гүйцэтгэж байжээ. Ч.Далай хишигтэн цэрэг нь “Чингисийн төрийн гол тулгуур ... дайн байлдааны үед монгол цэргийг манлайлах гол мөхлөг болж” /24.82/ байсан хэмээн нухацтай тэмдэглэсэн нь их л дүйсэн дүгнэлт мөн болой.

Монголын нэгдсэн улсын цэргийн үндсэн төрөл нь байнгын цэрэг мөн. Нэрт эрдэмтэн Сайшаал нэгдсэн улсын байнгын цэргийг “төмөр морьт цэрэг” гэж нэрлэн 1178-1189, 1189-1204, 1204-1206, 1206 оноос хойш гэсэн 4 үе шатыг дамжин зохион байгуулагдсан болохыг тодорхойлсон байдаг /76.371-374/. Монголын нууц товчоонд бичиглэснээр ийм цэргийн тоо 1206 онд арван түм, Рашид-ад-Дины тооцоолсноор гол цэрэг /1000/, баруун гарын цэрэг 3 түм 8000, зүүн гарын цэрэг 5 түм, Чингисийн дүү нарын цэрэг 2 түм бүгд нийлээд 12 түм 9000 хүнтэй байжээ. Эл цэрэг нь байнгын цэргийн гол мөхлөг юм. Түүнийг бүхэлд нь Чингисийн отгон хөвгүүн Тулуй мэдэж байсан ажээ. Байлдааны үед их цэрэг нь шинэ зохион байгуулалт, журам бүхий байнгын цэрэг бөгөөд Чингис хааны байлдан дагууллын үндсэн хүч болж иржээ. Их цэргийг аравтлан захирах, цэрэг бэлтгэх, цэргийн сургууль хийх, байлдааны үйл ажиллагаа явуулах, байлдааны олзыг хуваарилах, цэргийг Зэбсэг хэрэгсэл, хүнс хоолоор хангах нь тус бүрдээ нарийн зохион байгуулалт, дэг горимтой байсан аж. Монголын нэгдсэн улсын их цэрэг аравт, зуут, мянгат, түмтээр зохион байгуулагдаж, тус бүрийг түүний ноён захирна. Ж. Саундерс “Монголын байлдан дагуулал” номондоо Чингисийн “арми цэрэг нь аравтын нэгжүүдэд, тухайлбал 10000 хүнтэй дивиз нь мянгатын бригад, зуутын цэргүүд, аравтын салаа болон хуваагдаж байв” /78.73/ хэмээн орчин үеийн цэргийн зохион байгуулалттай харьцуулан бичжээ.

Монгол их цэрэг нь хатуу сахилга бүхий шинэ маягийн морин цэрэг болж бэхжсэн байна. Монгол цэргийн тоо хэд байсныг батлах дорвитой баримт ховор боловч хэд хэдэн сурвалж бичиг, тулгуур бүтээлүүдэд зарим тоог дурдсан байх нь анхаарал татна. Ч.Далай Ираны нэрт түүхч Рашид-Ад-Дины “Судрын чуулган” хэмээх бүтээлээс иш татан Чингис хааны цэрэг 129000. Зүүн жигүүрийн цэрэг 23800, баруун жигүүрийн цэрэг 62000 байсныг “Юан төрийн түүх” сурвалжаас иш татан тус тус дурдан бичжээ /24.67/. Үүнээс үзэхэд хэрэв зүүн, баруун жигүүрээс гадна төвийн жигүүрийн цэрэг, Чингис хааны биеэр удирддаг шилмэл байсныг тооцох нь зүйн хэрэг юм. Ш.Нацагдорж “Монголын цэргийн тоо чухам хэд байсан нь асар тодорхойгүй боловч ихэнх эрдэмтэд монгол цэргийг 129000 байсан бололтой гэж үзэж байна” /62.244/ гэж бичжээ.

Ч.Жүгдэр “XIII зууны үед төрөл бүрийн дайнд оролцож байсан монголын цэргийн тоо 100-400 мянгад хүрч байжээ” /32.149/ хэмээн А.А.Стрековын бичсэн “Цэргийн урлагийн түүх” хэмээх номноос иш татан өгүүлсэн байна. Английн түүхч Гарольд Дэмбэ Хорезмын эсрэг аян дайнд мордохын өмнө монголын их цэрэг 230000 хүнтэй байсныг дурджээ /17.170/. Эдгээр баримтаас үзэхэд Чингис хааны байнгын монгол цэргийн тоо 129000 хэмээсэн нь үндэстэй байж болох дундаж тоо аж.

Монгол морин цэрэг нь хөнгөн ба хүнд морьт цэрэг хэмээн хуваагдана. Хөнгөн морьт цэрэг нь хөдөлгөөнт, гавшгай шинжтэй бөгөөд гол төлөв нум, сум, дэгээт төмөр зэргээр зэвсэглэн дайрах, давших, сэтлэх, тойрох, хөөн нэхэх хэлбэрээр байлдаанд оролцоно.

Хүнд морьт цэрэг нь хориглох, тогтож тулалдах байлдаанд оролцох бөгөөд жад, сэлэм, бамбай, хөө, хуяг сэлтээр зэвсэглэнэ. Монгол цэргийн гол зэвсэг нь нум, сум, жад, сэлэм, сүх, шийдэм, бороохой, хуяг, дуулга байна. Нум сум нь барагцаалбал 60 кг хүнд, 180-270 метрийн тусгалтай байв. Цэрэг бүхэн жирийн ба хуяг дуулга нэвтрэх ган хушуу хоёр нум сум авч явна. Байлдааны үед хэрэм, цайз эвдлэхэд хэрэглэх чөдөр, оньс, хөвчит нум, харвах буу, дүүгүүр чулуу, шатаах хэрэгсэл, харвах чулуун сум зэргийг хэрэглэнэ. Е.Д. Филипс “Чулуун сум, чулуу шидэх машин, дарь хэрэглэх чулуу, төмөр харвах галт буу буюу эртний их буу, ойроос гал харвах нумт буу зэрэг Зэвсэгтэй байжээ” /2,4/ хэмээн бичжээ. Жишээлбэл, 1220 онд Нишапур хотыг эзлэн авах тулалдаанд өөрөө харвах буу 3000, дүүгүүр 300, хана нэвтрэх буу 1000, шатаах бодис, шидэх оньс 1700, хана давахад хэрэглэх шат 4000, харвах чулуун сум 2500-г хэрэглэж байжээ гэсэн баримт бий. Цэрэг бүр хэд хэдэн хөтөлгөө морьтой явна. Хүнсэнд зориулсан хоёр арьс ширэн, ус нэвтэрдэггүй ууттай явах бөгөөд түүний 1-д нь айраг, сүү, ус зэрэг ундааны зүйл, нөгөөд борц,ааруул,тос,гурил,бяслаг мэт хуурай зүйлс хийнэ.

Цэргийн аяны үед цэргийг дотор нь манлай цэрэг, хоёр гар цэрэг, гол бие цэрэг, хоёр хөл цэрэг, гэзэг цэрэг зэргээр ялгана. Эдгээр нь тус бүрдээ гүйцэтгэх тодорхой үүрэг, онцлогтой. Жишээлбэл, манлай цэрэг гавшгай хөдөлгөөн хийж, дайсны жагсаалыг эвдлэх байлдаан явуулах, дайсны хоёр жигүүрээс халдах, араас нь тойрч цохилт өгөх үйл ажиллагаа явуулна. Цэргийг давшуулахдаа төв, баруун жигүүр болгон хувааж, төв жигүүрээ хаан, бусад жигүүрийг хан хөвгүүн, цэргийн жанжнууд удирдана. Цэргийн ангийн өмнө хошууч анги явуулж, ард хайгуул, халхавч ангиар хамгаалуулна. Цэргийн жигүүр ангиуд тогтсон дохио тэмдгээр мэдээлэл солилцох морьт холбоочин ажиллуулна.

Цэргийг байнгын дасгал сургуультай байлгах бодлого баримтлаж, довтлох давших, харвах, цавчилдах, жадлах, хана хэрэм давах, нэвтрэх, морин дээрээс шүүрэх, татаж унагах зэрэг сургууль хийж, зааж сургана. Дайн тулалдаан бүхнийг зохион байгуулалттай, бэлтгэлтэй, хатуу сахилгатайгаар явуулах нь гол зарчим байжээ.

Дайн тулалдаан явуулахын өмнө эхлээд эсрэг талаа нарийн судалж, дүгнэлт хийнэ. Үүний тул тагнах, турших элч төлөөлөгч илгээх, мэдээлэл цуглуулах ажиллагаа явуулна. Дараа нь дайны төлөвлөгөө боловсруулна. Түүнд цэргийн туршлагатай жанжинууд оролцоно. Дайны төлөвлөгөөг хуралдаанаар хэлэлцэж батална.

Бэлтгэл ажлыг хангаж дуусмагц цөмрөн орох гэж буй тал, улс оронд дайтахаа мэдэгдэж, шаардлага тавина. Тэгээд шаардлага эс биелүүлбэл дайны ажиллагааг эхэлнэ. Чингис хаан Тангад, Алтан, Ляо улс, Дундад Ази, Европын орнуудад чухам энэ л зарчмыг баримтлан дайны ажиллагаа, байлдаан, тулалдаан явуулсан ажээ.

Чингис хааны цэрэг, арми дайн тулалдаан явуулахдаа шалган туршсан шилмэл аргууд хэрэглэж, түүнээ дайтах явцад олсон туршлагаараа баяжуулан улам сайжруулж байжээ.

Улсын цэрэг, дайныг давших хэлбэрээр голлон явуулна. Чингэхдээ хөдлөх, эс хөдлөхийн хооронд явж дайны хүчтэй ба дорой талыг олж мэдэх, ташуурын далайлтаар бутрах, хэнгэргийн дуунаар бөөгнөрөх, маш хүчтэй цохилт өгөх, дайсны жагсаалыг зориуд сарниулах, олон талаас нь сэхээ өгөлгүй харвах, дайсныг тойрон бүслэх, бөөн жагсаалаар урагшилж "чонын алхаа" хийх, хуурамчаар зугтаан дайсны цэргийг бүгсэн цэрэг дээр авч ирэх, эсвэл зугтааж холдуулаад гэнэт эргэн байлдах, дайсны цэргийг цөөн цөөнөөр нь таслан цохих, дайсанд гэнэтийн цохилт өгөх, дайсныг дундаа оруулж бүслэн цохих, хоёр хажуугаас нь хавчин дайтах, цайзад ус оруулах, хэрмийн доогуур нүхлэх, дээгүүр нь шат тавьж давах, айлган сүрдүүлэх зэрэг аргуудыг чадварлаг хэрэглэж байжээ. Монголын нэгдсэн улсад цэргийн урлагийг сайтар эзэмшсэн жанжнуудаар удирдуулсан нарийн зохион байгуулалттай хүчирхэг арми бүрэлдэн бий болж, дотоод ба гадаадад цэрэг, байлдааны үйл ажиллагаа явуулж амжилт олсон нь монголчуудыг ихэд алдаршуулжээ.

Монголчуудаас тулалдааны талбарт байгуулсан ялалт нь армийн сайн зохион байгуулалт, цэргийн чанд сахилга, цэргийн урлагийг гарамгай эзэмшсэн жанжнуудын авьяас билэгт орших бөлгөө. Монголчууд "сахилга бат болон дайтах аргаараа тэр үеийнхнээсээ хол давж гарсан байв. Монголын цэрэг нум сум харвахдаа гайхамшигтай авьяаслаг бөгөөд цэргийн техник хэрэгсэлээр сайн хангагдаж, бүслэлтийн болон хана, хэрэм эвдэгч, чулуу харвагч машинуудыг өргөн ашиглаж байжээ" /24.11,64/.

Монгол цэргийн сахилга хатуу чанд, цэргийн жанжин, захирагч ноёдын тушаалыг үг дуугүй биелүүлэх нь хөдөлшгүй хууль болно. Зориг шантарч, аймхай хулчгар байхыг үл тэвчинэ. Тушаал үл биелүүлсэнийг шууд цаазаар авна. Хатуу сахилга цэрэг армийг бэхжүүлж, дайнд ялалт авчрах чухал нөхцөл хэмээх номлолыг жанжнаас жирийн цэрэг хүртэлх бүх хүн хүлээн зөвшөөрч байжээ. Цэргийн жанжин, захирах ноёны зөвшөөрөлгүйгээр булааж дээрэмдэх, аравтаасаа салах, эргүүлд гараад унтвал шууд цаазаар авах шийтгэл ногдуулна. Цэргийн жанжин, захирагчид байлдаанд орохын өмнө цэргийнхээ Зэвсэг хэрэгсэл, гутал хувцсыг заавал шалгаж үзэх үүрэгтэй. Нэг цэрэг морио алуулбаас нөгөө цэрэг хөтөлгөө мориноосоо заавал өгөх, шарх олбол аварч амь гаргах, цэргийн сургуулийг үнэн сэтгэлээсээ хийх зэрэг нь цэргийн хувьд хатуу хууль байжээ. Монгол улсын цэрэг нь цоо шинэ онол, стратегийн дагуу нүүдлийн соёл иргэншлийн өвөрмөц нөхцөлд зөвхөн өөрийн сэтгэхүйн хүчээр төрөлхийн сэргэлэн авхаалжтай шинж, жинхэнэ монгол цэргийн урлагийг өндөр түвшинд эзэмшсэн, шилдэг зэр зэвсэг, техник хэрэгсэлээр хангагдсан, хүнд, хөнгөн морин цэрэг, хошууч цоож, тагнуулын хэсэг барилга байгууламж, зэр зэвсгийн анги арын аж ахуй бүхий сайн зохион байгуулагдсан арми байсан бөлгөө.

Арми нь Чингис тэргүүтэй монгол цэргийн жанжнуудын босгосон агуу их хүч, улсын бүрэн бүтэн байдлын баталгаа, аян байлдаанд ялахын бат үндэс болж байсан ажгуу. Чингис хаан өөрөө Монгол үндэстний их улсыг байгуулж, дэлхийн хэмжээний эзэнт гүрэн болгох үйл явцад цэргийн онолч стратегич, цэргийн нэрт зүтгэлтэн, гарамгай жанжин, Монголын нэгдсэн их цэргийг үндэслэн байгуулагч, Монгол аймаг ханлигийг нэгтгэн нэгэн цул хүч болгон дэлхийн талыг эзэлсэн өрнө, дорнын их дайныг манлайлан удирдагч байсан ажгуу.

Ж.Неру "Хэмжээ далайц, урлагаараа, гэнэт довтлох чадвар, хөдөлгөөний байдлаараа, стратеги, тактикийг хэрхэн хэрэглэсэнээрээ монголчуудын явуулсан дайны хэмжээ, далайц нь түүхэнд ижилсэх юм байхгүй" /65.314/ гэж бичсэн Я.Гарттай санаа нийлж байгаагаа тэмдэглэсэн байдаг.

"Чингис хаан бол хэрэв дэлхийд хамгийн их жанжин биш гэхэд хамгийн гайхамшигтайн нэг байсан нь эргэлзээгүй юм" /32.167/ гэж дурдсаныг доктор Ч.Жүгдэр онцлон тэмдэглэжээ.

Японы Отахи Мацуо, Чингис хааны биед цэрэг дайны авьяас билэг төгөлдөр байсан /67.6/ хэмээн бичжээ. Чингис хаан өөрөө цэргийн гарамгай жанжин болон төлөвшсөн төдийгүй мөн өөрийн армийн өдий төдий шилдэг жанжнуудыг төрүүлэн бэлтгэжээ. Ж.Неру “Зөвхөн өөрөө цэргийн их жанжин байгаад зогсоогүй цэргийн гайхамшигт олон жанжнуудыг хүмүүжүүлжээ” /65.351/ гэж Чингисийн цэргийн их жанжин суу билэг, үүрэг ролийг үнэлсэн байдаг.

Монголын нэгдсэн улсын цэрэг армид авьяас чадвар, эрэлхэг зориг, цэргийн урлагийг чадамгай эзэмшсэн алдарт жанжнууд тодрон төрж, яруу алдраа дуурсган үлдээсэн бөлгөө.

Тэдний дотор Чингисийн дүү Хасар, Тулуй, Чингисийн хүү Зүчи, Цагаадай, Өгөөдэй, Түмний ноён Мухулай, Боорчи, Наяа, эрэлхэг жанжин Хубилай, Сүбээдэй, Зэб, Зэлмэ, Хархируу, Борохул, Зүрчидай, Чулуун нар ихэд нэрд гар байсан ажгуу.

Чингисийн цэргийн жанжинуудын дотор “Дөрвөн хөлөг”⁵², “Дөрвөн хушуу, нохос”⁵³, “Хоёр манлай”⁵⁴ хэмээн алдаршин нэршигдсэн эрэлхэг баатрууд ихээхэн чухал рольтой байжээ. Тангадын Линг-Жоугийн, Хятадын цавчаал боомтын, Хорезмын Отрар, Бухарын, Оросын Калка голын сүрлэг том тулалдаанууд Монголын нэгдсэн улсын цэрэг армийн хүч чадал, цэргийн урлагийн өндөр төвшинг харуулсан ажээ.

§7.Төрийн бэлгэдэл

Монголын нэгдсэн улс тусгаар тогтнол, бүрэн эрх, гадаад, дотоод бодлого, хүчирхэг шинж чанараа илэрхийлсэн төрийн бэлгэдэлтэй байжээ.

Монголын нэгдсэн улсад цагаан, хар, алаг сүлд-туг байжээ. Цагаан сүлд-туг нь цагаан сар, хар сүлд-туг нь хар, алаг сүлд-туг нь цагаан хар зүсмийн адууны дэл сүүлээр манжлага хийснээс ийнхүү гурван янз сүлд-туг болон алдаршжээ.

Цагаан сүлд-туг нь нэгэн төв том, найман жижиг цагаан тугаас бүрдсэн бөгөөд түүнийг есөн хөлт цагаан туг гэнэ. Их цагаан сүлд-тугийг тойруулан байрлуулах найман жижиг тугийг хөл гэж нэрлэнэ.

Төрийн ёслол, хурим, том үйл явдлын үеэр цагаан сүлд-тугийг ихэд хүндэтгэн зална.

Хар сүлд-тугийг цэргийн дайчин үйл явдал, дайны үед бэлэгдэн залж байжээ. Хар сүлд-тугийг “дөрвөн хөлт хар сүлд” хэмээн нэрлэх ёсон бий. Чингисийг нэгдсэн монгол улсын их хаанаар өргөмжлөх төрийн ёслол үйлдэх үед цагаан сүлд-туг, хар сүлд-тугийг хоёуланг ёс төгөлдөр залдаг байсныг нэрт эрдэмтэн Сайшаал “Чингис хааны товчоон” номондоо бичсэн байдаг бөлгөө.

Алаг сүлд-тугийг дайны болон энх цагийн аль ч үед хэрэглэдэг байсан боловч ихээхэн ховор тохиож байсан аж.

Монголын нэгдсэн улсын үед төрийн сүлд тугийг хүндэтгэн биширч, төр улс

амгалан тайван, сүр хүчтэй байваас өргөн олон иргэд амар жимэр, аз хийморьтой байхыг бэлгэдэн сүлд-тугийн тайлга тахилгыг шашин шүтлэг, зан үйлийн горимыг баримтлан, төрийн хэмжээнд үйлддэг ёс тогтжээ. Тухайлбал, ”Есөн хөлт цагаан тугийн тайлга”, ”хараа ихт хар тугийн тайлга”, ”алаг тугийн тайлга” хийдэг байжээ.

Ялангуяа хар тугийн тайлгад ихэд анхаарч, монголоо нэгтгэн нэгэн хүчирхэг улс байгуулж, дайснаа дарж монголчуудын хийморь, заяа дэлгэрсэнд зориулан уг тайлгыг үйлдэж байв. Чингис хаан 1206 онд хар тугийн том тайлга хийсэн байдаг. Мөн хар тугийн тайлгыг өшөөт дайсантай байлдах, улс оронд муу муухай ёс гарч, хулгай дээрэм буй болоход хар тугийн тайлга тахиж, түүнийг арилгах үйл үйлддэг байжээ.

Улсын гол нэгэн тахилга нь есөн хөлт цагаан тугийн тахилга байв. Есөн хөлт цагаан тугийн тахилгыг их тахилга, бага тахилга хэмээн хуваана. Бага тахилгыг жилд нэг, их тахилгыг” хоёр жилд нэг удаа үйлдэнэ. 1206 онд Чингисийн есөн өрлөг их цагаан тугийг хааны ордны өмнө аваачиж байрлуулан анхны том тахилга үйлдэж байсан түүхтэй.

Сүлд-тугийн тахилга нь хаант төрийн нэр хүндийг өргөн, түүнийг бишрэн хүндэтгэх итгэл үнэмшлийг лавшруулж, улс гүрний амгалан тайван байдлыг хангахад нөлөөлөх чухал зүйл байв.

Монголын нэгдсэн улсын төрийн бэлэгдлийн нэгэн нь төрийн дуулал байжээ. Төрийн дууллын үгэнд:

Эзэн төрийн энхээр

Эелэж хамт жаргая

Хааны их буянаар

Хамаг улсыг хамтатгая

Хаан эцгийн буянаар

Харгис мууг арилгая

Богд эзний буянаар


Бүхэн улс амаръя гэж өгүүлэн, их төр, эзэн хаанаа түшин, улс гэрээ төвхнүүлж, ард олноороо амар сайхан жаргах хүслийг бэлэгдэн илэрхийлсэн бөлгөө.



ЦАГААН СҮЛД ТУГ



ХАР СҮЛД ТУГ



ТӨРИЙН ХАШ ТАМГА

Ч.Далай төрийн дууллын үгийн агуулгыг нягтлан шинжээд Монголын нэгдсэн улсын төрийн дуулал нь "эсэн мэнд амьдрах, аж төрөхөд төрийн роль, эзэн хааны ач холбогдлыг ихэд товойлгож, улмаар зол жаргалтай амьдрахын хүслийг голлон илэрхийлж байжээ" /24.101/ хэмээн бичжээ.

Чингисийн хаант төрийн хууль ёсны дээд баталгаа, улсын тусгаар тогтнолын эрхэм бэлгэ тэмдгийн нэгэн нь Төрийн тамга болно. Хаант улсад төрийн алтан тамга, хөх тамга гэсэн хоёр янз байжээ. Төрийн их тамга нь алтан тамга юм. Төрийн тамгыг хаш чулуун дээр сийлэн хийсэн бөгөөд бичиг бүхий байв.

Тамганы дотор "Мөнх тэнгэрийн хүчин дор хүрвээс биширтүгэй, аюутугай" хэмээн бичсэн болой. Улсын тусгаар тогтнол, эзэн хааны эрх мэдэл, нэр сүрийн нэгэн том бэлгэдэл нь хааны орд байжээ. Чингис, Монгол улсын эзэн хааны хувиар их ордыг байгуулан түүний зохион байгуулалт, бүтэц, дэгийг тогтоосон юм. Чингэхдээ монголын ханлиг улс бүр ордтой байсан өмнөх уламжлалаа өвлөн ашигласан байна.

Хааны их орд хэмээх нь түүний жирийн нэгэн өргөө, гэр, орон байр гэсэн утга бүхий бус харин их хаан, төрийн дээд удирдлага төвлөрөн байрлаж, улсаа жолоодох үйл ажиллагааг явуулах, хаан, түүний хатан, гэр бүл амьдран аж төрж бүрэн баталгаатай, хамгаалалт, хангамжтай байхыг хангасан тодорхой нутаг дэвсгэрт байрлан зохион байгуулагдсан өвөрмөц бүтэц бүхий засаг захиргааны төв болно.


Монголын нэгдсэн улсын сүлд туг, тамга, дуулал, ордны тухай эрдэмтэн зохиолч Ц.Дамдинсүрэн, Х.Пэрлээ, доктор Д.Гонгор, Ч.Жүгдэр, Ч.Далай нар судлан нягталж бичсэн байдаг бөлгөө. Доктор Д.Гонгор "Орд хэмээхэд нэг талаар хаад эздийн орон суурин, нөгөө талаар түүний эрх захирамжийн төв гэсэн утга агуулагдаж байна. Жишээ нь: Чингис хааны их орд гэхэд түүний гол орон тэргэн, улс-хүмүүс, төв захиргааг хэлдэг байсан" /20.194/ гэж бичжээ. Хааны ордны бүтэц, зохион байгуулалт нь нүүдэллэн амьдрах монголчуудын амьдралын хэв маяг, төрх онцлогтой салшгүй холбоотой. Үүнээс үүдэн Чингис хаан хэд хэдэн их ордтой байснаас гадна ордны байршил, зохион байгуулалт, бүтцийг нүсэр бус, хөнгөн байдлаар тогтоон төвхнүүлсэн аж. Чингис ордоо эхлээд бусдаас ялгаварлан "аурук" хэмээн нэрлэжээ. "Аурук" гэсэн үгийг Ц.Дамдинсүрэн "агуу, аварга гэсэн утгатай" хэмээн тайлсан байдаг бөлгөө.

Чингис хаан дөрвөн их ордтой байв. Энэ нь Хэрлэн мөрний Шилгэнцэгийн орд, Сайр хээрийн Халиутын орд, Туул голын Хар шугуйн орд, Сэлэнгэ мөрний эхэн дэх Идэр голын орд болно. Чингис хааны их орд нь засаг захиргааны төв байв. Их ордонд Их Хуралдай хуралдаж, төрийн ёслол, том арга хэмжээ явагдана. Ордонд алтан ургийнхан, өрлөг сайдууд зөвлөлдөнө. Их хааны зарлиг, айлтгал буулгана. Төрийн дотоод, гадаад бодлогын асуудлыг шийдвэрлэнэ. Ордод чэрби нар болон бичээч, үйлчлэгчид байнга ажиллана. Хаанд бараалхах, үүрэг айлтгал авах, ажил

төрөл зөвлөлдөх, зарлиг шийдвэрийн биелэлтийг танилцуулах зорилгоор сайд, ноёд, түмэдүүд үргэлж орж гарна. Элч төлөөлөгч ч ирнэ. Хааны ордыг Хишигтэн цэрэг хамгаалж, түүний үйлчилгээний үйл ажиллагааг зохион байгуулж зохицуулна. Хааны ордод орох, хаанд бараалхах нь нарийн тодорхой тогтоосон ёс горимтой байжээ.

Хааны орд нь тодорхой газар нутаг эзлэн оршиж байв. Тэрхүү газар нутаг нь хааны өргөө гэр замнах газар, мал сүргийн бэлчээрийн газар, оршуулгын газар буюу "их хориг", ан агнуурын газраас бүрэлдэж байсан ажгуу.

МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН



Зургийг “Монгол Улсын түүх” номын тэргүүн ботиос ашиглав.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Монголын нэгдсэн улсын эрх зүй

§1. Эрх зүйн үүсэл хөгжил

Монголчууд нэгдэж, өргөн уудам нутаг дэвсгэртэй, нэгэн их хаанд захирагдсан, төвлөрсөн хүчирхэг нэгдсэн улсыг байгуулсанаар соёл иргэншлийн хөгжлийнхөө шинэ үед дэвшин оржээ. Ийнхүү шинэ үед дэвшин орсон нь Монголын нэгдсэн улсад үндэсний эрх зүйн тогтолцоо үүсэх нийгмийн зорилт болж улмаар тэр нь улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санааны бодит нөхцлөөр тодорхойлогдож байв.

Гүн ухаантан, түүхч, эдийн засагч, хуульч эрдэмтэн судлаачид Монголын нэгдсэн улсын шинж төлөвийг цэгнэн үзэж тодорхойлон бичсэн байх нь цөөн бус. "Чингисийн үндэслэн байгуулсан монголын феодалын нэгдсэн улсын төр нь нэг талаар феодалын түрүү үеийн харилцааны хөгжилд гарсан бүх ололт амжилтын үр дүн болж гарч ирсэн бөгөөд нөгөө талаар монголд феодализм бүрэн ялж, түрүү феодалын үеэс хөгжсөн феодализмд дэвшин орох хэрэгцээ шаардлагын улмаас буй болсон юм" /32.97/. "Их монгол улс байгуулагдсан явдал монголын нийгмийн урагшлах хөгжлийн үр дүн мөн бөгөөд тэр үеэс монголчуудын хоёрдугаар их сэргэн мандалтын үе эхэлсэн гэж үзэлтэй"/24.56/. Чингисийн эзэнт улс "урьд хожид байгаагүй тийм холимог соёлыг бадраан хөгжүүлсэн болой" /78.81/. XIII зуунаас монголын" нийгмийн тогтолцоо нь бэлчээрийн газар эзэмшлийн хамжлагат...нийгэм эдийн засгийн үндэс нь улс орны нийт газрыг эзэн хаан буюу төр өмчилж ноёд хууль цаазын дагуу өв залгамжлан хувьдаа эзэмшдэг явдал" /61.28/ болжээ. Нийгэмд ноёрхох дээд байрыг талын язгууртнууд, дараах байрыг урт дурын хүмүүс эзлэн хүн амын үндсэн хэсэг болох жирийн хүмүүс-иргэдийн эдийн засаг, иргэншлийн байдалд зарчмын өөрчлөлт оржээ.

Дээрх дүгнэлтүүдийг өөрийн судалгааны үзүүлэлтүүдтэй харьцуулан шинжвээс Монгол орон дэлхий дахины соёл иргэншлийн дундад үед эргэлтгүй шилжин орж нэг талаас Европын феодализмын хэв шинжийг бүрдүүлдэг үндсэн элементүүд давтагдан илэрч, нөгөө талаас ийнхүү давтагдан илрэхдээ монгол орон, түүний эдийн засаг, хүн ам, нийгмийн бүтэц, төрийн байгууллагын өвөрмөц онцлогийг шингээсэн буюу төсөөтэйгээр илэрхийлсэн хэв шинж бүхий элементүүд бүрэлдэн төлөвшжээ. XIII зууны эхэн үеийн Европт феодалын рентийн хоёр хэлбэр, тухайлбал албадан хөдөлмөрийн ба бүтээгдэхүүний рентүүд хүчтэй илэрч байсан бол Монголын нэгдсэн улсад энэ нь иргэд харъяат эзнээсээ хөлс авахгүй түүнд ажиллах болон бүтээгдэхүүн өгч барих хэлбэрээр илэрч байв.

Эл үед Европын феодализмын эдийн засагт газрыг хувьд өмчлөх ёсонд тулгуурласан натурал аж ахуй байсан бол монголд байгалийн нөхцөл, эрхшээлд

зохицсон нүүдлийн мал аж ахуй ноёрхож, зөвхөн түүнд үйлчлэх зориулалт бүхий гар үйлдвэр дагалдан хөгжиж, хүн амын хэрэгцээ, аж төрж амьдрах өвөрмөц нөхцлийг хангахад чиглэгдэж байлаа. Монголд газрыг /хааны/ өмч гэсэн ёсон ноёрхож, бэлчээрийн хэлбэрээр голлон ашиглаж байв.

Европын орнуудад төрийн сонгодог засаглал нь хаант засаг байсан бол монголд хэмжээгүй эрхт хаант төр тогтож, хаант засаглалын хэв шинжид хамаарах төсөөтэй ба ялгаатай зүйлсийн аль аль нь илэрч байсан бөлгөө. "Европын улсууд тэр үеийн монгол хоёрын аль алинд нь хүн амын гол анги бүлэг нь эзэн-харъяатын харилцаанд байсан" /78.81/ болой. Монголын алтан ургынхан, түмт, мянгатын ноёд, тэдгээрийн үр хүүхэд, сайд, ноёд, цэргийн жанжнууд европын феодал ангитай ижил байр сууринд байсан боол, мянганы иргэд, ноёдын харъяат иргэд хамжлагын тариачидтай төстэй байр суурь эзэлж байжээ. Энэ бүхнээс дүгнэлт хийвээс XIII зууны эхээр тогтсон Монголын нэгдсэн улсад өөрийн өвөрмөц онцлог бүхий феодалын ёсон тогтож, чингэхдээ түүний шинж чанар, эдийн засаг, улс төр, нийгмийн төрх төлвийг илэрхийлсэн элементүүдээс бүрэлдэж байсан нь илт байна. Энэ бүхэн нь Монголын нэгдсэн улсын үндэсний эрх зүй үүсэн хөгжих нөхцөл болохын хамт мөн түүний шинж чанар, агуулгыг тодорхойлох гол хүчин зүйл болсон ажээ. Чухамхүү дээрхи нөхцлөөр тодорхойлогдон Монголын нэгдсэн улсад үндэсний өвөрмөц онцлог шинж бүхий эрх зүйн тогтолцоо үүсэн хөгжсөн ажгуу. Дээр дурдсан зүй тогтол, бодит шаардлага, нөхцөл байдлын үндсэн дээр монгол оронд үүсэн бүрэлдсэн нийгмийн харилцаа тус орны эдийн засаг, улс төр, нийгмийн байгууллын агуулга, онцлогийг эрх зүйн хэм хэмжээгээр бататган бэхжүүлэх үйл явц монголын нэгдсэн улс байгуулагдан хөгжих явцтай зэрэгцэн явагджээ. Монголын нэгдсэн улсад өөрийн хэмээсэн эрх зүйн тогтолцоо үүсэхдээ нэг талаас Монголын нэгдсэн улсын төрийн үүрэг зорилго, нөгөө талаас төрийн өөрийнх нь үйл ажиллагааны онцгой хэлбэр, түүний үр дүн болж үүсэн бүрэлдсэн байна.

Чингэхдээ монголын анхны төр улсын үеэс, тухайлбал Хүннү, Сяньби, Нирун зэрэг эртний улсуудын үед үүсэн хөгжсөн эрх зүйн уламжлалыг өвлөн шингээж байсныг тэмдэглэлтэй. Монголын нэгдсэн улсын эрх зүй үүсэн бүрэлдэхдээ эх сурвалжийн хоёр үндсэн хэлбэрээр илэрч байсан бөлгөө. Үүний нэгдэх нь төрөөс зөвшөөрөн дэмжиж буй заншлын эрх, хэм хэмжээ, хоёрдахь нь төрөөс батлан гаргасан хууль, эрх зүйн актууд болно.

Төр ёс, монголчуудын аж байдал, амьдралын амин салбар болох мал аж ахуйг эрхлэн хөтлөх, зохион байгуулалт, арга ажиллагаа, хүмүүсийн өөр хооронд болон хүн ба байгаль орчны харьцаанд олон үеийн турш уламжлан хэрэглэгдэж зайлшгүй сахин мөрдөх горим болж хэвшсэн зан заншил нь тийнхүү заавал мөрдөн сахих хэм хэмжээ болж, тэр нь нийгмийн амьдралын зохион байгуулалт, хэвийн нөхцлийг хангахад бодит ач холбогдол үзүүлж байсан нь заншлын эрхийн гол шинж мөн.

Ялангуяа мал маллах, малтай харьцах, бэлчээр нутаг ашиглах, уул овоо, ус ургамал, ан амьтныг хайрлан хамгаалах, бишрэн хүндэтгэх, байгалийн бэрхшээлийг танин мэдэж, гэтлэн давахад бие биеэндээ туслах, харилцан арилжаа, солилцоо хийх, малынхаа ашиг шимийг ашиглах, гэр ахуйн ба малын хэрэглэгдэхүүнийг үйлдвэрлэх чиглэлээр заншлын олон төрлийн арга хэмжээнүүд үйлчилж байсан нь нийгмийн харилцаа ямар чиг хандлагаар төлөвших, түүний зохицуулалт хэрхэн бүрэлдэхэд ихээхэн үүрэгтэй байсан бөлгөө. Аж байдал, амьдралын зохион байгуулалт, арга ажиллагаа төдийгүй нийгмийн зохион байгуулалтын салбар ч заншлын хэм хэмжээ уламжлагдан ашиглагдах шинжээ мэдэгдэхүйц хадгалж байв. Тухайлбал улсын хааныг сонгох, хүндэтгэн бишрэх, хуралдайг зарлах, хуралдуулах, төрийн бэхи ажиллуулах, улсын нутаг, хүн амыг аравтлах системээр хуваах, цэрэг байлдааны үйл ажиллагаа явуулахад олон төрлийн заншлын хэм хэмжээ уламжлан мөрдөгдөж байсан ажгуу.

Заншлын эрх, түүний хэм хэмжээнүүд нь монголчуудын төр, нийгэм, аж ахуйн амьдрал өөрийн хэмээсэн дэг горимоор хэвийн явагдах, хүмүүс өөр хоорондоо харилцахад аж байдал, ахуйн нөхцлөөрөө эв найртай, амьдралдаа ашиг тустай, холбогдох зан үйл болж үйлчилсэн байна. Чингиснээр монголчуудын аж төрж амьдрах арга ажиллагааг түүхэн уламжлал, заншлын дагуу хэвийн явуулах, төрийн бодлоготой нийцэж, түүний дэмжлэгийг хүлээсэн болой. Үүний зэрэгцээгээр төрөөс заншлын хэм хэмжээнээс зарим хэм хэмжээг нь төрийн хууль цаазад багтаан хуульчлан бэхжүүлж заавал биелүүлэх, хэрэв эс биелүүлбэл төрөөс цээрлэл үзүүлж биелүүлдэг болгох бодлого явуулсан бөгөөд энэ нь янз бүрийн ястан, овог, аймгуудын иргэдийг нэг л монгол үндэстэн болгон төлөвшүүлэх төрийн бодлоготой холбоотой.

Заншлын хэм хэмжээний заримыг нь эрх зүйн хэм хэмжээгээр бэхжүүлэх болсон нь нийгмийн харилцааны хөгжлийн хандлага тогтвортой байх, монгол үндэстний хэв шинжийг нийтлэгжүүлэх, түүний бүрэлдэн тогтох үйл явцыг хангах учир холбогдолтой байжээ.

Хууль цаазаар бэхжүүлсэн заншлын хэм хэмжээний гол нь хүн амаас газар нутаг, уул хад, ус ургамал, амьтан малтай харьцах, тэдгээрийг хамгаалах, ашиглах, хүмүүсийн гэр бүл, аж байдлын харилцааг шинэ нөхцөлд нийцүүлэн төлөвшүүлж, үр ашигтай хэмээсэн зан үйлийг нэвтрүүлэн хэвшүүлэхэд чиглэж байсан бөлгөө.

Монголын нэгдсэн улсад шинээр бүрэлдэн бий болсон эрх зүйн хэм хэмжээнүүд энэ үеийн нийгмийн хэм хэмжээний тогтолцоонд тодорхойлогч байр эзэлж байсанд түүний нэг гол шинж оршино. Учир нь эрх зүйн хэм хэмжээ тус оронд бүрэлдсэн нийгмийн харилцааны гол чиглэл, хэсгийг хамран зохицуулж, улс орны нийгэм, төрийн зохион байгуулалт, эдийн засаг, аж ахуй, төр, түүний харьяатын харилцаа, улсын дотоод гадаад амьдралын эрх зүйн үндсийг бүрдүүлж байсан болой.

Монголын нэгдсэн улсын эрх зүйн хэлбэршин илэрч байсан гадаад гол хэлбэрүүд нь хааны баталсан хууль, гаргасан зарлиг, засаг, дүрэм, түмт, мянгат, зуут, аравны ноёдын шийдвэрүүд байсан ажгуу. Өөрөөр хэлбэл нэгдсэн улсын эрх зүй эдгээрт хэлбэршин бэхжиж, заавал биелүүлэх зан үйл болон үйлчилж байсан хэмээн хэлж болно.

Монголын нэгдсэн улсын эрх зүйн шинж чанар нь түүний зохицуулж байсан нийгмийн харилцааны чиглэл, төрөл, агуулгаар тодорхойлогдож байв. Нэгдсэн улсад бүрэлдэж, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан харилцааны агуулга өргөн агаад олон чиглэл төрөлтэй байсан ажгуу.

Судалгааны дүнд үндэслэн нэгдсэн улсын эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байсан харилцааг орчин үеийн шинжлэх ухааны ололтыг ашиглан *нэгдүгээрт*, төрийн байгуулал, төрийн байгууллагын зохион байгуулалт үйл ажиллагаатай холбогдсон харилцаа, *хоёрдугаарт*, өмч хөрөнгө, аж ахуй, аж байдал, зан заншилтай холбогдсон харилцаа, *гуравдугаарт*, эрүүгийн бодлого, гэмт хэрэг, ял шийтгэл, түүнийг хэрэглэхтэй холбогдсон харилцаа хэмээн гурван бүлэг болгон ангилж болох юм. Үүний чиглэл бүр нь дотроо олон төрөлтэй байжээ.

Монголын нэгдсэн улсын төрийн хэлбэр, улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц, үйл ажиллагаа, төрийн түшмэдийн эрх, үүрэг, ажиллах журам хийгээд төрийн гадаад бодлоготой холбогдсон харилцаа эл үеийн эрх зүйн харилцааны дотор томоохон байр эзэлж байжээ. Ийм чиглэлийн харилцааны дийлэнх нь шинээр бүрэлдэж бий болсныг тэмдэглэлтэй.

Хааны эрх, түүний ордны үйлчилгээ, хатан болон гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, улсын цэрэг, армийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцаа эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах харилцааны өвөрмөц хэсэг байсан нь тодорхой байна.

Монголын нэгдсэн улсын үед эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах шаардлагатай харилцааны хүрээнд газар нутаг, ус ургамал, ан амьтад, тэдгээрийг эдлэх, ашиглах, хамгаалах, мал сүрэг өмч хөрөнгө эзэмших, өв залгамжлах, аж ахуй эрхэлж аж амьдралаа хөтлөн явуулах, арилжаа солилцоо хийх, алба татвар авах, төлөхтэй холбогдсон харилцаа бүрэлдэн төлөвшиж өөрийн байр сууриа эзлэн, зохих хэмжээгээр бэхжигдсэн болой. Хүмүүсийн хоорондын эд хөрөнгийн бус олон зүйл харилцаа хийгээд гэр бүлийн харилцаа, зан заншлын харилцаа ч эрх зүйн хэм хэмжээний зохицуулагдах зүйл болж ирсэн ажгуу.

Монголын нэгдсэн улсад төрийн хууль цаазыг зөрчвөл гэмт хэрэг хэмээн үзэхтэй холбогдсон бодлого боловсорч, эрүүгийн эрх зүйн харилцаа үүсэн бий болжээ. Үүнтэй холбогдсон эрүүгийн бодлого, гэмт хэрэг, ял, түүнийг оногдуулах,

эдлүүлэхтэй холбогдсон харилцаа эл үеийн эрх зүйн харилцааны хүрээнд онцгой байр эзэлж бүрэлдэн бий болжээ. Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийгэм, аж ахуй, хүн ам, өмч хөрөнгө, зан заншил, ёс журмыг эрүүгийн бодлого явуулж хамгаалах нь түүний оршин тогтнож бэхжин хөгжихийн нэгэн тулгуур үндэс байсан ажээ.

Ийнхүү XIII зууны эхэнд монгол оронд бүрэлдэн хөгжсөн эрх зүйн харилцаа нийгэм, төрийн амьдралын олон талыг хамарсан өргөн агуулгатай байсан нь Монголын нэгдсэн улсын эрх зүйн бүтэц, агуулга, үйлчлэх хүрээ, цаг хугацаанд нөлөөлөх гол хүчин зүйл мөн.

Монголын нэгдсэн улсын үед боловсорсон эрх зүйн харилцааг зохицуулсан эх үндсэн сурвалж нь "Их засаг"⁵⁵ хэмээн алдаршсан төрийн хууль болно. 2003 онд хэвлэгдсэн "Монголын түүх" зохиолд "Монгол улсын төрийн цааз хууль "Их засаг" байжээ. Энэ хуульд овгийн байгууллын үеийн зарим үлдэгдэл байсан боловч бүхэлдээ монгол төрийн жинхэнэ хууль мөн ажээ... "Их засаг"-т хаанд өргөмжлөх ёс, олон улстай харилцах журам, улсын Их Хуралдай, ард иргэний албан үүрэг, дархлах ёс, эр цэрэг, ав хомрог, санхүү, алба гувчуур, эрүү, иргэний хууль, гэр бүл, өвлөх эрхийн тухай тус тус дурджээ... Засаг хууль нь нийгмийн харилцааг хуулиар бататган бэхжүүлж, овгийн байгууллын үлдэгдэлд мэдэгдэм цохилт өгснөөр тэр үедээ дэвшилттэй зүйл болжээ. Чухам "засаг хууль"-ийн гол ач холбогдол оршино" /57.102/ гэж тодорхойлон бичсэн байна. Монголын нэгдсэн улсын түүхийг олон жилийн турш судалсан академич Ш.Нацагдорж "Их засаг бол" хааны хэн ч халдашгүй дархан эрх мэдэл, "Чингис" гэдэг цолыг бусад хаанд зүүхийг хориглосон зүйл, их хааныг хаан ширээнээ өргөмжлөх ёс журам, ёслол, Их Хуралдайг зарлан хуралдуулах, гадаад улстай харилцах ёс, ард иргэдийн үүрэг, эр цэрэг, авд мордох, санхүү, алба татварын ёс, эрүүгийн эрх, гэр бүл, өв хөрөнгө залгамжлах ёс тэргүүтнийг заасан" /61.53/ хууль байсан байна гэж өгүүлсэн бол академич Ч.Далай "Их Хуралдай хурах, хаан өргөмжлөх ёс, олон улстай харилцах журам, ард иргэний албан үүрэг, дархлах ёс, эр цэрэг татах, ан хоморго хийх, алба гувчуур татах, эрүү, иргэний хууль, гэр бүл, өвлөх эрх зэрэг маш олон асуудлыг хуульчилсан байна" /24.63/ гэж нотолсон байна.

Хуульч эрдэмтэн судлаач О.Амархүү Их засаг хуулийн нэг онцлог бол монголчуудын байгаль, дэлхий, газар нутаг, уул усаа хайрлан хамгаалж, хүндэтгэн дээдэлж, шүтэн бишэрсээр иргэн уламжлалт зан заншлын олон хэм хэмжээнээс нэлээд хэдий ч хуульчлан бататгаажуулж, зөрчсөн тохиолдолд зэмлэл, шийтгэл үзүүлж байх эрх зүйн үндэслэлийг анхлан тогтоосон талаар суурь судалгааг анх хийснийг тэмдэглэвэл зохино /4.25-31/. Хятад улсын эрдэмтэн Вэнду Жиень Чингис хаан хууль цаазтай байсныг нотолж 1206 онд бичиглэсэн хуультай болсон /76.423/ гэж үзсэн бол Өвөрмонголын их эрдэмтэн Сайшаал Чингис хаан "үсэг бичгээр анх удаа тэмдэглэсэн

хууль цаазын бичиг “Их засаг”-ийг байгуулан /батлан/ бүх улсын заргач /шүүгч/ түшмэлийг томилжээ” /76.422/ хэмээн бичсэн байдаг. Ийм байдлаар Чингис хааны түүх Их монгол улсыг судлаач үеийн эрдэмтэд судлаачид “Их засаг” нь Монголын Чингисийн хаант улсын бичмэл гол хууль мөн гэдэгтэй санал нэгддэг бөлгөө.

Монголын түүхийн тулгуур зохиолууд болон дэлхийн янз бүрийн улс орны эрдэмтэд, судлаачид, жуулчид, элч төлөөлөгчдийн бүтээл, тэмдэглэлүүдэд дурдагдан үлдсэн “Их засаг”-ийн заалтуудын агуулгыг нэгтгэн дүгнэж үзвээс уг хууль нь Монголын нэгдсэн төрийн хэлбэр, дэглэм, хааны хэмжээгүй эрх мэдэл, хаанд өргөмжлөх ёс, төрийн байгууллагууд, тэдгээрийн зохион байгуулалт, эрх үүрэг, ажиллах журам, төрийн түшмэдийн зэрэг, эрх ямба, үүрэг хариуцлага, төрийн удирдах, удирдуулах ёсон, гадаад, дотоод бодлого, засаг захиргааны хуваарь, газар нутаг, байгаль хамгаалал, өмч хөрөнгө, өв залгамжлал, эзэн харьяатын ёс, алба татвар, ёс заншил, эрүүгийн бодлого, ял ногдуулах, эдлүүлэх зарчим, журмыг тодорхойлон тогтоосон улсын гол хууль байжээ хэмээн хэлж болох ажгуу. Энэ утгаар нь “Их засаг”-ийг нийгмийн нэгэн төрлийн харилцааг бус харин эрх зүйн хэм хэмжээгээр зайлшгүй зохицуулагдах шаардлага бүхий янз бүрийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг агуулсан хууль байсан гэж үзвэл зохилтой. Чингэхдээ Чингис хаанаас нэг л удаа зарлиглан тогтоочихсон хэмээн гэж үзэж болохгүй. Чингис хаанаас янз бүрийн цаг үед түүний дотор их хаанд өргөмжлөгдөхийн өмнө болон Их засгийг тунхагласанаас хойш гарсан хууль зарлигуудыг багтаан оруулсан байх ажаамуй. Чингис хаан 1210, 1218, 1225 оны орчим Их засагт нэмэлт өөрчлөлт оруулж байсан нь түүхээ тэмдэглэгдэж байдаг бөлгөө. Ингэхлээр “Их засаг” нь янз бүрийн үед гарсан хуульчилсан заалтуудыг эмхэтгэн хэвлүүлсэн нь болой. 1304-1356 онд амьдарч байсан нэрт жуулчин Ибн-Батута “Чингис хаан” Ал-Ясак” гэж нэрлэгдсэн хуулийн эмхэтгэл гаргасан” /16.112/ гэж дурдсан нь байдаг.

“Их засаг”-ийн зориулалт, үйлчилж байсан орон зай, цаг хугацаа анхаарал татах асуудал мөн болой. Монголын нэгдсэн улсын гол хууль болсон “Их засаг”-ийг Чингис хаан эхэлж тунхаглан зарлахдаа энэ хууль нь өөрийн толгойлсон Монгол улсын хэмжээнд үйлчилж түүнд зориулагдсан болохыг илэрхийлсэн байдаг бөлгөө.

Монгол угсаатны нэгдсэн улсын төрийн бодлогын илэрхийлэл болж, тус улсын төрийн байгууллага, их хаан, түүний ургийнхан, ноёд, түшмэд, жанжин, цэрэг, иргэд бүх нийтээр “Их засаг”-ийг сахин мөрдөх үүрэгтэй байсан аж. Чингис хааны тунхагласан засаг, зарлигуудыг багтааж байсны хувьд “Их засаг” хэмээх хууль нь Монголын нэгдсэн улсын эрх зүйн гол эх сурвалж болон үйлчилж байжээ. Чингис хаан 1206 онд “хөх бичгээр бичиж дэвтэрлэсэн” улсын энэ хуулийг хэн ч өөрчилж үл болно. Хэрэв өөрчилбөл гэмтэн болохыг зарлиглаж тунхагласан болой.

Монголын нууц товчооны 203 дугаар зүйлд “Их засаг”-ийг ”ургийн урагт хүртэл хэн ч бүү өөрчилтүгэй” гэж Чингис хаан зарлиг буулгаснаас үзвэл энэхүү хууль Чингис хааны үед төдийгүй өөрийгөө залгамжлагчдын үед ч сахин мөрдөгдөх хүчин чадалтай байхаар тогтоосон нь тодорхой байна. Амьдрал дээр ч энэ байдлаар хэрэгжин байсныг сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн байдаг бөлгөө.

Чингисийн залгамжлагч Өгөдэй, Гүюг, Мөнх хааны үед “Их засаг” хууль нарийн чанд мөрдөгдөж байсан нь үүний бодит баримт мөн билээ.

Чингис хааны тогтоосон хууль цаазыг Монголын нэгдсэн улсад төдийгүй түүний залгамжлагчид, үр ач нарынх нь толгойлсон улсуудад хүндлэн мөрдөж байсныг тэмдэглэвэл зохино. 1283 онд насан өөд болсон Ираны их түүхч Ага-Малик Жувейнийн тэмдэглэснээр ”Их засаг”-ийн хувь Чингисийн удмын бүх улс хааны ордонд хадгалагдаж байсан /16.8/ ажээ Энэ мэт түүхэн баримтуудаас үзэхэд Чингисийн тогтоосон ”Их засаг” монголын нэгдсэн улсад үйлчлэх зориулалттай хэдий ч Чингис ба түүний залгамжлагчдын байгуулан толгойлсон эзэнт гүрний хэмжээнд хүндлэн сахих хууль болон хэрэгжиж байсан нь түүхэн үнэн бөлгөө.

Төгсгөлд нь тэмдэглэн хэлэх нэгэн зүйл буй. Юун хэмээхүл Монголын нэгдсэн улсад ”Их засаг”-аас өөр хууль байгаагүй мэтээр ойлгож үл болмой. Үүнтэй холбогдуулан их эрдэмтэн В.А.Рязановскийн ”бусад бага Яса буюу овог аймгуудын Ясагаас ялгагдан бүх монгол аймгуудад ерөнхий хууль болохийн хувьд ийнхүү нэрлэгджээ /32.6/ гэж тайлсныг болгоон үзэхэд илүүдэх юун. Чингисийн зарлаг, дүрэм хэмжээ, түмт, мянгат, зуутын захирагчдийн шийдвэр ч эрх зүйн сурвалж болно.

Монголын нэгдсэн улсын бичмэл хууль “Их засаг” Чингис ба түүний залгамжлагчдыг ихэд алдаршуулж, Ази, Европын орноор дэлгэрч, монгол гүрний хувь заяанд томоохон роль гүйцэтгэсэн бөлгөө. Тийм ч учраас ”Их засаг” монголын төдийгүй дэлхий дахины хууль цаазын түүхнээ мөнхрөн үлдэх “гавьяа”-г олж монголчуудын бүтээсэн хүн төрөлхтний соёл иргэншлийн хэмжээний алдарт ”бүтээл” болж, тив тивийн судлаачдын анхаарлыг татаж ирсэн, одоо ч татсаар байна. “Их засаг”-ийн бүтэц, агуулгыг судлан нэвээс эл үеийн монголын хууль цаазын бүтэц, агуулга түүхнээ ил тодорхой болно. Гагцхүү түүнийг бүрэн эхээр нь олох буюу сэргээн босгох замаар бүтээвээс”дэлхий дахины хууль цаазын түүхэнд”хувь хандиваа оруулж ”алтан үсэг”-ээр нэрээ бичүүлэн хөшөө дурсгалаа монгол оронд босгуулах тавилан буй биз ээ. Тийм эрдэмтэн төрөх нь лавтай. Бар Хэбрэус хэмээн нэрлэгдсэн нэрт эрдэмтэн Абул Фаражийн /1225-1286/ өгүүлсэнчлэн”Монголчууд бусад олон хуулиудтай байсан боловч бид өөр хэлэх юм байхгүй тул бүхэл бүтэн эмхэтгэлээс /энэ бол Их засаг И.Д/ хэдхэнийг толилуулж байна.” /16.13/ хэмээсэн шиг бид ч өөрсдийн мэдсэн судалсан хэмжээнд л “Их засаг” хуулийг ойлгож бичиж байгаа бөлгөө.

Чингисийн “Их засаг” хуулийг судлах нь дэлхийн үйлс болой. Түүн лүгээ дэлхий даяар анхаарлаа хандуулах цаг ирмүй. “Их засаг” хууль судлал дэлхийг бүрхэн хөгжих болтугай хэмээн монгол хүн бүр чин сэтгэлээсээ бодож явдаг нь нууц биш ээ.

§2. “Их засаг” хэмээх нэрийн тухайд өгүүлэх нь

Монголын нэгдсэн улсын эрх зүйн гол эх сурвалжийн нэрийн асуудлыг авч үзэхэд юуны өмнө “Их засаг”-ийн тухай өгүүлэх хэрэгтэй бизээ. Энэхүү холбоо хоёр үгийн “Их” гэдэг нь “Засаг”⁵⁶ хэмээх үгийн тодотгол болох нь илэрхий. Тэгээд ч “Их” гэдэг үгийг нэлээд хожуу хэрэглэсэн байдаг бөлгөө.

“Их засаг” гэсэн нэрийн талаар сонирхолтой өгүүллийг МУИС-д ажилладаг эх бичиг үсэг судлаач, ном ч хичээнгүй багш Ш.Чоймаа бичиж эзэн богд Чингисийн “Их засаг” хэмээх эрдэм шинжилгээний бүтээлд хэвлүүлжээ. Ш.Чоймаа “Засаг” гэдэг үгийг хэл шинжлэлийн үүднээс тайлахад анхаарлаа хандуулсан нь сонирхолтой болой.

“Засаг” хэмээх үгийн язгуур нь ЗАСА /засах/ ажээ. Засан тохинуулах гэсэн язгуур утгатай ЗАСА гэсэн үгийг үндсэн үйл үгээс нэр үг бүтээдэг “г” дагавар залгаж ЗАСАГ хэмээх үг буй болжээ. Засаг хэмээх үгийн “г” дагаврыг БИЧ+Г=БИЧИГ, ЗУР+Г=ЗУРАГ гэсэн үгсийн бүтсэн ёстой адилтган харж үзвэл /36.8/ зохилтой.

“Засаг” хэмээх үгийн гарвалыг авч үзэх нь чухал. Хэл шинжлэлийн үүднээс монгол хэл нь уг гарлаараа Алтайн овгийн хэлэнд багтдаг. Алтайн овгийн хэлэнд монгол хэлнээс гадна түрэг /Түрк/ манж хэл багтна Тэгвэл Алтай овгийн эдгээр хэлүүдэд “Засаг” гэдэг үг адилхан байдаг ажээ “ЗАСА” /засах/ гэдэг үгийг түргээр /ЙАСА/-/яса/, манжаар ДАСА гэх бөгөөд алтайн хэлэнд З, й, д, авиа хоорондоо сэлгэдэг авиа зүйн үзэгдэл түгээмэл юм, Өөрөөр хэлбэл монгол, манж, түрэг хэлэнд байгаа ЗАСА, ЙАСА, ДАСА гэсэн гурван эхний гийгүүлэгч авиа сэлгэсэн болохоос бус нэг язгуур үг юм /36.10/. Үүний хамт ЗАСАХ гэдэг үгийг баруун монголын дөрвөд, торгууд, захчин, урианхай, өөлд, баяд, хотон ястны аялгуунд ЯСАХ /йасах/ гэж хэлдгийг анхаарах нь зүйн хэрэг болов уу, Мөн засаг гэдэг үгийг түрэг ба баруун монголын аялгуунд ЯСАК /йасак/, манжаар ДАСАК буюу ЗАСАГ гэдгийг ч анхаарах нь зүйн хэрэг бизээ. Ингэхлээр “ЗАСАГ”, “ЯСА”, “ЯСАК”, “ДАСАК”, “ЙАСА” гэх зэргээр янз бүрийн орны судлаачдын бүтээлд бичигдсэн үгс бүгд алтай овгийн язгуур нэг үгийн гарвалд тулгуурласан шинжлэх ухааны үндэс буйг тэмдэглэвэл зохино.

Одоо “ЗАСАГ” хэмээх утга санааг авч үзсүгэй. “Засаг” гэдэг үгийн хууль зүйн утгын гол илэрхийлэл нь XIII зууны түүхэн цаг үедээ цааз, дүрэм, журам, хэв ёс гэсэн утга санааг илэрхийлж байсан нь эрдэм судлалын ажлын үр дүнгээс харагдаж байна. Ш.Чоймаа эртний түрэг хэлний толь бичигт “ЙАСА” гэдэг нь а/ хориглох, б/ тогтоол цаазын бичиг, журам, в/ торгууль, ял шийтгэл, г/ алба барьцаа, д/ цэрэг дайны журам гэсэн утгатай гэж бичжээ /36.9/.

М.Д.Рязановский”Яса” үг нь хориг, дүрэм, хууль гэсэн утгатай /44.6/ хэмээн тайлбарласан байна. Судалгааны үр дүнгээс урган гарсан нэгэн сонирхолтой дүгнэлт бол монголын дундад үеийн монгол хэлний санд йаса гэдэг үгийн санаа бараг тэр утгаараа уламжлагдан үлдсэн явдал болой.

Судлаачид ”засаг” гэдэг үг хэдий үеэс хэрхэн түгэж хэрэглэгдсэнийг ихэд анхаарсан нь зүйн хэрэг. Үүнийг гэрчлэн харуулахын тулд Монголын нууц товчоог шинжлэн үзэж, тольдон харуулахаас өөр арга юун. Монголын нууц товчооны үгийн санд цааз хууль хэмээх үг тохиолдоно. Энэ нь XIII зууны эхэнд цааз, хууль гэдэг үгийн төдий л хэрэглэдэггүй байсныг гэрчилж буй хэрэг юм.

Нууц товчоонд ”засаг” гэдэг үг нэлээд тааралддаг байна. Академич Ц.Дамдинсүрэн Монголын нууц товчоог орчин цагийн монгол хэлнээ буулгахдаа засаг хэмээх үгийг хууль цааз гэсэн утгаар хөрвүүлсэн болой. Жишээлбэл, ”Чингис хаан засаг өгүүлэрүүн” гэснийг “ Чингис хаан цааз тогтоон зарласан нь” /199-р зүйл /, “... засаг давагсад” гэснийг “цааз хууль зөрчигчид...”-г /199-р зүйл/ гэх зэргээр буулгасан ажээ. Ц.Дамдинсүрэн гуай ийм хөрвүүлэл нь нэг талаар засаг хэмээх үг хууль цааз гэдэгтэй адил утгатайг ухан харуулж, нөгөө талаар орчин цагийн хүмүүсийн хэллэг, зөв ойлгохын учир холбогдлыг илэрхийлсэн хэрэг буйзаа.

XIV зуунд ч засаг хэмээх үг хэрэглэгдэж байсныг түүхэн баримт нотолж байна. Сажа бандид Гунгаажалцангийн зохиосон ”Субашид” хэмээх яруу найргийн XIV зууны Соном авгайн орчуулгад ”аль хүн засгийг хөндвөөс” гэснийг XIII зууны үед гэвш Лувсанчүлтэм ”аль хүн цааз ёсноос этгээд явбал” гэж орчуулсныг Ш.Чоймаа дурдаад ”Засаг хөндөх” /хууль зөрчих / гэдэг хэллэг XIV зуунд тогтвортой хэрэглэгдэж байсан аж гэсэн дүгнэлт хийсэн байна. Энэ нь бас засаг хэмээх үг хууль гэсэн үгтэй адил утгатайг харуулж байна.

XIII зууны Чингисийн билэг сургаалаас “Оюун түлхүүр хэмээх сургаал”-д засаг цаазыг номын ёсоор барьж, олон амьтныг жаргаланд зохиож” хэмээн бичсэн бол “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир”-т ...Бор дарсны зориг буюу Богд эзний маань засаг үгүй буюу. Хар архины дур буюу хаан эзний маань цааз үгүй буюу” гэж өгүүлсэн байдаг. Энэ бүхэн нь нэг талаар “засаг” гэдэг үг ”цааз” гэсэн үгтэй хоршин хэрэглэгдэж байсныг гэрчилнэ. Ингэхлээр XIII зуунд монгол хэлэнд хууль гэдэг үг нэвтрээгүй байсан бөгөөд харин түүнийг засаг гэдэг үгээр илэрхийлж байжээ. Ийнхүү Чингис хааны гаргасан хууль цааз “засаг” хэмээн нэрлэгдэж, үүнээс үүдэн Чингисийн засаг гэсэн нэр уламжлагдан алдаршсан байж болохыг ажаамуй.

Үүний зэрэгцээгээр ”засаг” гэдэг үгийн толь бичигт хэрхэн тайлсныг авч үзэх нь эл үгийн утгыг ойлгоход багагүй ач тустай болой. Ингэхлээр XIII зуунд монгол хэлэнд хууль гэдэг үг нэвтрээгүй байсан бөгөөд харин түүнийг засаг гэдэг үгээр илэрхийлж

байдаг байжээ. Ийнхүү Чингис хааны гаргасан хууль "засаг" хэмээн нэрлэгдэж, үүнээс үүдэн Чингисийн засаг гэсэн нэр уламжлагдан алдаршсан байж болох талтай.

XIV зуунаас хойшхи үед "засаг" хэмээх үгийн утга аажмаар шилжирч өөр буюу хэд хэдэн утга санааг илэрхийлэх болсон нь ажиглагднам. Түүгээр ч үл барам "засаг" гэдэг үг орос хэлэнд нэвтрэн оржээ. Оросын нэвтэрхий толь, бусад томоохон толь бичигт "ясак, ясачный налог, ясачные книги, ясаул" гэх мэт үгс тэмдэглэгдсэн байна. Орос хэлний дөрвөн боть толь бичигт "ясакист, Натуральная податъ, которой облагались нерусские народы поволжья и Сибирий и Дальнего востока в россий" хэмээн /36.815/ тайлбарлажээ,

Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нарын Орос Монгол толь бичигт "ясак" гэдэг үгийг "эд агуурсны алба, татвар" гэж тайлсан байна. Түрэг, хятад хэлэнд засаг гэдгийг мөн алба татвар гэсэн утгатай хэмээн тайлсан байдаг ажээ. "Мукаддина" хэмээх XIV зууны үед арабаар бичсэн араб, перс, түрэг, монгол хэлний тольд "засаг" гэдэг монгол үгийг "татвар" гэж орчуулжээ. Эдгээрээс үзэхэд "засаг" гэсэн үг нь алба, татвар гэсэн утга санаагаар илэрч байжээ хэмээн үзэж болно.

XVIII зуунд "засаг" хэмээх үгийн утга нилээд шилжирч иржээ. Манжийн захиргааны үед "засаг" хэмээх үг төрийн байгууламж, төрийн засаглал, засаглах эрх мэдэл, засаг захиргааны гол нэгж болсон хошууны ноёны эрх хэмжээг илэрхийлсэн утга санаатай болж ирсэн байна. "Хошууны засаг ноён" хэмээсэн төрийн албан тушаалтан нь хошууны захирагч, хошууг захирах эрх мэдэлтэн гэсэн утгыг илэрхийлж байв.

Орчин цагийн монгол хэлэнд "засаг" гэсэн үг нь "власть" гэсэн орос үг, түүний орчуулга "засаг, засаг захиргаа" "эрх мэдэл" гэсэн утгаар хэрэглэгдэж байна, Орос хэл дээр гарч ихэд алдаршсан С.И.Ожеговын "орос хэлний толь бичиг" /Словарь русского языка /-г "улс төрийн ноёрхол, төрийн удирдлага, төрийн байгууллагууд" гэсэн утгатайг бичсэн нь бий. Дээр дурдсан зүйлүүдийг харьцуулан үзээд хэд хэдэн дүгнэлт хийж болох юм.

Үүнд: *Нэгдүгээрт*, "засаг" хэмээх үг орчин цагт хууль гэсэн утгаар хэрэглэгдэхгүй болсон; *Хоёрдугаарт*, хууль цааз гэсэн үг XVIII зуунаас монгол хэлнээ идэвхтэй нэвтэрснээр "засаг" гэсэн үгний хууль гэсэн утга шилжирч, төрийн байгууллага, түүний эрх мэдлийг илэрхийлэх утгатай болсон; *Гуравдугаарт*, Чингисийн үед хуулийг засаг хэмээн нэрлэж байсан байж болох талтай. Ингэж үзвээс Чингис хааны засаг "хууль" хэмээн нэрлэхэд болохгүй гэх юмгүй.

Үүний хамт бүр өөрөөр үздэг эрдэмтэн судлаачид бас бий. Хятадын эрдэмтэн Сайшаал, Монгол улсын нэрт түүхч Л.Дэндэв нар "их засаг" хэмээн нэрлээгүй болой. Харин "Их засгийн хууль" хэмээсэн нь бий. Л.Дэндэв 1936 онд хэвлүүлсэн "Монгол эрт эдүүгээгийн хууль цаазны түүхийн сэдэв, дэвтэр" номын "Монголын Чингис

хааны бүлэг”-г Чингис хаанаас ”Урьд эдүгээгийн хуулийг хянан хэлэлцэж цаг тухайн байдалд нийцүүлэн тогтоосон хууль их засгийн хууль” /58.9/ хэмээжээ.

Ийнхүү Монголын нэгдсэн улсын ”Их засаг” гэлгүй ”Их засгийн хууль” хэмээн нэрлэж агуулга, ач холбогдлыг нь судлан бичсэн бөлгөө. Энэ нь түүхэн үндэслэлтэй болохыг дурдвал зохино. Ираны нэрт түүхч А.Жувейни, Чингис хаант засаг ба зарлиг дүрмийг хуйлмал цаасан дээр бичиж, тэмдэглэхийг зарлиг болгожээ. Тэгээд энэхүү хуйлмал бичгийг ”Засгийн их дэвтэр” гэж нэрлэн, хааны ойр ураг төрлийнхний санд хадгалагддаг байв /34.25/ хэмээн бичиж үлдээжээ. Ингэхлээр энэхүү засгийн дэвтэр хэмээх нь засгийн /хуулийн/ эмхтгэл дэвтэр байж болох юм. ”Их засгийн хууль” гэх нь Чингисийн төрийн хууль гэсэнтэй утга дүйх учиртай бизээ.

Бас Их засгийн хэмээсэн төвлөрсөн хүчирхэг төрийн нийт даяар мөрдөх нэгдмэл хууль гэсэн утга санааг илэрхийлсэн ч байж болох талтай. Дүгнэж хэлвээс Монголын нэгдсэн улсын гол хуулийн нэрийн тухай асуудалд Монгол төдийгүй дэлхий дахин анхаарч ирсэн болохыг тэмдэглэмээр байна. ”Их засаг”, ”Их засгийн хууль” гэсний алианаар нь ч нэрлэж болохыг үгүйсгэх юун.

Ямраар ч нэрлэсэн гэсэн Их монгол улсын төрийн гол хуулийг хэлж түүний агуулгын шинж онцлогийг авч үзэх учиртай бөлгөө. Гэхдээ дотоод, гадаад олон эрдэмтэн мэргэд Чингис ба түүний залгамжлагчдын хаанчлалын үед үйлчилж байсан гол хуулийг ”Их засаг” хэмээн нэрлэн алдаршуулж, олон арав, зуун бүтээлд бичиж үлдээсэн болой. Жишээлбэл: Америкийн проф, Жорж Вернадский ”Яса” гэдэг нь монголын аугаа их эзэн Чингис хааны зарлигдсан хууль тушаалын эмхтгэлийн нэр юм /16.7/ гэж тайлбарласан бол проф. В.А.Рязановский ”Их засаг бол Чингис хааны баталсан бичгийн хэлбэртэй хуульчилсан дурсгал мөн” /144.6/ гэж бичжээ.

Иймээс дэлхий дахинаа алдаршсан энэ нэрээр нь ”Чингисийн Их засаг” гэж нэрлэхэд болохгүй гэх зүйлгүй бөгөөд харин ч монголын хууль цаазны үнэ цэнийг дэлхийн улс орон, ард түмэнд танилцуулахад ач тус үзүүлэх учиртай бизээ хэмээн үзнэм.

§3. Их засаг хууль батлагдсан цаг хугацааны тухай

Чингис хааны ”Их засаг” хэмээн алдршсан монголын нэгдсэн улсын хууль хэдийд батлагдан гарсан бэ? гэдэг асуудал үе үеийн эрдэмтэд судлаачдын анхаарлыг ихэд татаж иржээ. Зуун зуун дахь судлаачдын бүтээлүүдийг харьцуулан үзэхүйц Чингис хаан улсын нэгдсэн хууль ”Их засаг” батлагдсан цаг хугацааны талаар олон зүйл санал дүгнэлтүүд гарч, түүхэн ба судалгааны баримт дүгнэлтүүдээр нотлон өгүүлэхийг хичээсэн нь илт ажиглагддаг. Энэ тухай сурвалж бичиг, зохиол, бүтээлүүдэд өгүүлэгдсэн зарим баримт дүгнэлтийг иш татаж харьцуулан авч үзье.

Монголын нууц товчоонд” ...Гүр иргэний хувь хувилгасны жаргу /зарга/ жаргулагсны /заргалсны/ хөх дэвтэр бичигт бичиж дэвтэрлэн ургийн ураг хүртэл Шихихутугийн надтай эетэж ёсолж, хөх бичиг цагаан цалсун дор /цаас/ дэвтэрлэснийг бүү юүтгэтүгэй /бүү өөрчилтүгэй/ юүтгэхүн /өөрчилсэн/ аран алдалтан /хүн гэмтэн/ болтугай” /51.202-203-р зүйл/ хэмээн зарлиглажээ. Монголын нэгдсэн улс Чингис хааны үеийн бодит үйл явдалд тулгуурлан 1240 онд туурвисан ”Монголын нууц товчоо” хэмээх алдарт бүтээл дэх энэ баримт ”Их засаг” хэдийд гарсныг нотлоход холбогдох хамгийн эрхэм үнэ цэнэтэй бөлгөө. Учир юун хэмээхүл ”Монголын нууц товчоо” бол *нэгдүгээрт*, Монголын нэгдсэн улсыг байгуулалцаж явсан хүмүүсийн бичиж туурвисан, *хоёрдугаарт*, Монголын нэгдсэн улсын төр хууль цаазны түүхэнд холбогдох эхний бөгөөд хамгийн халуун сэргэг материалд тулгуурласан, *гуравдугаарт*, хаант улсын төр, хууль цаазны тогтолцоог бүрэлдүүлэх бодлого авч явуулсан арга хэмжээг тодорхой өгүүлсэн бүтээл мөн. Иймээс бид нууц товчоон дэх баримтыг нотолгооны учир холбогдлоороо анхдагч ач холбогдолтой хэмээн үзэж байгаа болой. Нууц товчооноос иш татсан дээрх баримт нь нийт иргэний нутаг ус, мал хөрөнгө, эзэн харъяатын хуваарилал, захирах захирагдах ёсон, төр, хууль цаазны тогтолцоо, шинэтгэлийн бодлогыг тодорхойлж тогтоосон хааны зарлиг шийдвэрийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гол агуулга нь хууль гарган хэрэг маргаан шийдвэрлэж хөтлөх явдлыг цагаан цаасан дээр бичиж дэвтэрлэн хүндтэйгээр хадгалах, улс удмаараа сахин биелүүлэх ёс журмыг тогтоосонд оршино

Чухамдаа монголын нэгдсэн улсыг тунхаглаж, төрийн шинэ тогтолцоог тогтоон, төрийн гол албан тушаалтнуудыг томилсон тэрхүү үйл явдалтай нэгэн зэргээр хааны гаргасан зарлигуудыг нэгтгэн дэвтэрлэж, улс даяар мөрдөхөөр тогтоох нь зайлшгүй төдийгүй төрийн тогтолцоог бүрэлдүүлэх бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан болов уу. Энэ нь ”...Чингис хааны ”Их засаг” хэмээн алдаршсан улсын хууль цаазны үндсэн суурь” /37,13/ байсан байж болох бус уу.

Баримт ийм ахул ”нууц товчоо”-ноос 70-аас 200 жилийн хойно гарсан бүтээлүүд дэх баримтыг анхдагч ач холбогдолтойд тооцон, мөн анхдагч нотолгоо болгож үзэх нь үнэнд хэр нийцэх бол.

Тэгэхдээ энэ нь тийнхүү бичсэн бүтээлүүдийн ач холбогдлыг үгүйсгэх бус харин баримтын учир шалтгааныг нь тайлж зөв ойлгох нь чухал болой.

Жорж Вернадский ”Рашид-ад-Дин, Макризи нар “Засаг” батлагдсан цаг хугацааг Хэрэйд, Найман, Мэргэдийг ялсны дараа хийсэн Их Хуралдайтай холбон үзжээ. Энэ нь нэлээд үндэслэлтэй юм” гээд ”энд Тэмүүжин их эзэн хаанаар өргөмжлөгдөж, Чингис гэж нэрлэгдсэн Хуралдайг хэлж байна” /6,8/ хэмээн тайлбарласан байна.

Оросын нэрт эрдэмтэд С.Д.Дылыков 1965 онд хэвлүүлсэн ”Халха Джирум” номынхоо оршилд Рашид-ад-Дин, Макризи нарын мэдээлж байгаагаар Чингис хааны

Яса нь 1206 онд монголын феодалуудын Их Хуралдайгаар батлагдсан байна /117.3-4/ хэмээн дурджээ.

Мөн 1966 онд хэвлэгдсэн "БНМАУ-ын түүх"-ийн тэргүүн ботид "Рашид-ад-Дин, Макризи нарын мэдээнээс үзэхэд засаг хуулийг 1206 оны Их Хуралдайн үед эмхэтгэсэн бололтой" /12.396/ гэж бичсэн байна.

Дээр дурдсан ишлэлүүдийг харьцуулан үзэхэд нэг талаас агуулгын хувьд хоорондоо адил, нөгөө талаас тухайн дүгнэлтийг гаргасан эх сурвалжийн хувьд зөвхөн Рашид-ад-Дин, Макризи нарын бичсэн мэдээ баримтыг үндэс болгон дүгнэлт гаргасан нь тодорхой байна.

Тэгвэл Рашид-ад-Дин, Макризи нарын бичсэн зүйлийг иш татъя. 1310 он буюу Монголын нууц товчоо гарснаас хойш 70 жилийн дараа Рашид-ад-Дин "Судрын чуулган" хэмээх бүтээлдээ "Чингис хаан ван ханыг ялсны дараа хаан ширээнд суухаар Их Хуралдайг хуралдуулж хатуу чанд хууль гаргасан" /73.135/ гэж бичжээ. Үүнээс үзэхэд Чингис хаан Хэрэйдийн Ван ханыг ялсны дараа хууль гаргасан нь тодорхой байна. Түүхэн баримтаас үзэхэд Чингис хааны цэрэг 1203 онд Ван хааны цэргийг дийлж том ялалт хийсэн байдаг бөлгөө.

Чингис хааны намтар түүхийг судлан ажиглахууд томоохон тулалдаанд орохын өмнө ба хойно Хуралдай хуралдуулж хууль гаргадаг нь жирийн хэрэг байжээ. Монголын нууц товчооны баримтаас үзэхэд нохой жил буюу 1202 онд Чингис хаан Татарчуудтай "Далан нэмүргэ" гэдэг газар байлдахын өмнө засаг тогтоосон байдаг бөлгөө /51.153/. Мөн Найманы хант улсын цэрэгтэй байлдах төлөвлөгөө боловсруулахдаа хуралдай хуралдуулж байжээ /12.210/. Монголын нууц товчоонд дурдсанаас үзэхэд Чингис хаан Ван ханы цэргийг ялсны дараа Найманы цэрэгтэй байлдахын өмнө Халх голын Ор нугын" Хэлтгий хад" гэдэг газар буугаад цэргээ цуглуулж бүртгэн аравт, зуут, мянгатад хуваарилан тэдгээрийг захирах Чэrbийг томилж, хишигтэн цэргийг байгуулан хэвтүүл, торгууд, хорчиныг бүрдүүлэх зарчим, түүний гүйцэтгэх үүргийг тодорхой зааж зарлигласан байдаг /51.152-153/. Ингэхлээр Чингис хаан Татар, Хэрэйд, Найманы хаант улсын цэрэгтэй байлдахын өмнө ба хойно Хуралдайг хуралдуулж засаг гаргаж байсан нь тодорхой байна. Хэрэйдийн Ван ханы цэргийг ялсны дараа ч бас Хуралдай хуралдуулж, засаг зарлигласан байж болох юм.

Ингээд үзэхээр Рашид-ад-Дин бичсэн зүйл нэгдүгээрт, "Их засаг"-ийг 1206 онд батлагдсан гэж шууд бичээгүй: хоёрдугаарт, 1206 онд батлагдсан гэсэн шууд тулгуур нотолгоо болгоход учир дутагдалтай /16.11/ юм.

Одоо Маркизийн бичсэнийг өгүүлье. Тэрээр "Чингис хаан Ван ханыг ялж, дээд эрхийг олж авсны дараагаар зарим гол хууль, дүрэм, зарим ял шийтгэлийг тогтоон бүгдийг нь ном болгон бичиж, түүнийгээ засаг гэж нэрлэв" хэмээн бичжээ.

/106.2/ Маркизийн бичсэн зүйл бидэнд нэлээд оновчтой тодорхой мэдээлэл өгч байгаа боловч "Их засаг"-ийг 1206 онд гаргасан гэж шууд бичээгүйг анхаарахгүй өнгөрч болохгүй. Өөр нэг хэлбэл зохих зүйл бол Рашид-ад-Дин, Макризи нарын аль аль нь Ван ханы цэргийг ялсны дараа "Их засаг"-ийг гаргасан гэснээрээ адил байна. Энэ нь уг мэдээлэлийн эх сурвалж нэг байсантай холбоотой байж болох юм. Макризи нь Рашид-ад-Дины мэдээллийг ашиглаж, өөрийн олсон баримтаараа баяжуулан өгүүлсэн байж болох талтай. Эсвэл хоёул Монголын нууц товчоо, Алтан дэвтэр мэт сурвалж бичгийн доторхи баримтад түшиглэсэн ч байж болно.

Дүгнэж үзвээс, Рашид-ад-Дин, Макризи нарын бүтээлүүдээс бидний иш татаж авч үзсэн баримтууд Чингисийн хаант улсын "Их засаг" Хэрэйдийн хант улсын цэргийг ялсны дараа гарсныг өгүүлж байгаагаараа түүнийг 1206 онд Их Хуралдайгаар "засаг" хуулийг тунхаглан батлахад хоёрдогч шинжтэй нотолгоо гэх нь түүхэн үнэнд илүү нийцнэ гэж үзнэм. Энэ нь Монголын нууц товчооны баримтын учир холбогдлыг эзэлбээс зохих байр суурин дээр тавьж буй хэрэг болой. Хамаг Монголын улсын үед, тэрчлэн Хэрэйд, Найман, Мэргэдийн цэрэг байлдахаас өмнө Чингис хууль гарган зарлиглаж байсан, тэр нь Их засаг бус, төрийн засаг байсан нь бас тодорхой байна. Харин засгийн /хуулинд/ "Их засаг" гарахад эмхэтгэгдэн орсон байх нь бодитой бөлгөө. Ийнхүү Чингисийн "Их засаг"-ийг Монголын нууц товчоон дахь баримтыг үндэс болгон 1206 онд Монголын нэгдсэн улсыг тунхаглах үеэр хааны зарлиг, засгуудыг эмхэтгэн үүсгэж зарласан гэвэл зохих болой. Монголын нууц товчооны баримтыг Чингисийн хаант улс даяар мөрдөх хуульчилсан, дурсгалын батлагдан гарсан цаг хугацааг гэрчлэх, анхдагч нотолгоо болгож байгаа нь дэлхий дахинаа "Их засаг" хэмээн алдаршсан тэрхүү агуу их дурсгалт бичиг Монгол туургатны нэгдсэн улсыг тунхагласан тэр он, цаг, өдөр "төрөн" гарч харин түүнийг Макризи, Рашид-ад-Дин зэрэг нэрт судлаачид давхар нотолж байна хэмээн нэг мөр болгон үзвэл таашаалтайг өчмүй.

§4. "Их засаг"-ийн судлагдсан байдал

Чингис хааны "Их засаг" хэмээн нэрд гарсан Монголын нэгдсэн улсын эрх зүйн үндсэн эх сурвалжийг судлах явдал дэлхий дахины үе үеийн судлаачдын анхаарлын төвд ямагт байж ирсэн ба одоо ч байсаар байгаа билээ.

Нүүдэлчин ард түмний соёл иргэншлийн гайхамшигт "бүтээл" болж дэлхийн соёл иргэншлийн өв санд "алтан" мөр үлдээсэн "Их засаг"-ийг судлах нь эрдэмтэд судлаачдын авьяас билэгийг сорих их увдистай нь маргашгүй бөлгөө.

"Их засаг"-ийг судлах хэд хэдэн учир шалтгаантай. *Нэгдүгээрт*, Дэлхийн улс гүрнүүдийн нийгэм, улс төр судлалын хүрээнд XIII зууны эхэнд Ази, Европын

ихэнхийг эзэлсэн асар том хүчирхэг гүрний үеийг судлах “Чингис” судлал тодорхой байр суурь эзэлж, олон орны эрдэмтэн мэргэдийн судалгааны чухал сэдэв болж иржээ. Чингис хааны талаархи судалгааг түүний хуулийн бодлого, тогтоон мөрдөж агсан хуультай нь холбохгүйгээр явуулах боломжгүй буй зээ. Иймээс “Их засаг”-ийг судлах нь Чингис судлалын нэг гол зорилт болон тавигдсан болой. *Хоёрдугаарт*, Чингис хааны толгойлсон Монгол угсаатны нэгдсэн улс бүрэлдэн тогтож, дэлхийд алдраа цуурайтуулсан хүчирхэг улс болж хөгжихөд хууль цааз, түүний гол илэрхийлэл болсон “Их засаг” томоохон роль гүйцэтгэсэн нь уг хуулийг судлах нэгэн үндэслэл болсон ажгуу. *Гуравдугаарт*, дэлхий дахины хууль цааз судлалын түүхэнд “Их засаг” судлал жинтэй байр эзэлж байна. “Их засаг” бол эртний Вавилон улсын Хаммурапи, Энэтхэг улсын Манугийн хууль, Оросын 12 таблицын хууль зэрэг бүхэл бүтэн улс орон, соёл иргэншил бүрэлдэн төлөвшихөд түүхэн дорвитой үүрэг гүйцэтгэсэн хуулиудтай эн зэрэгцэхүйц ач холбогдолтой юм. Иймд “Их засаг”-ийг дэлхий дахины хууль цаазын түүхэнд гүйцэтгэсэн үүргийнх нь талаас судлах явдал шаардлагатай нь зүйн хэрэг. *Дөрөвдүгээрт*, Монголын эрх зүйн түүхэнд “Их засаг” гандан бууршгүй түүхэн уламжлалыг залгамжилсан төдийгүй өөрийнхөө цаг үеийн түүхэн нөхцөл, төрт ёс, аж амьдрал, зан заншил, горим үйлийг тусган шингээж тэгснээрээ монголын соёл иргэншлийн ололт амжилтын тодорхой үнэ цэнийг агуулж байсан ажээ.

”Их засаг” дараа дараагийнхаа үеийн хуулийн охь нь болсон байна. “Их засаг”-ийг судлахгүйгээр Монголын эрх зүйн түүх, уламжлалыг танин мэдэх боломжгүй хэмээн хэлж болох буюу. *Тавдугаарт*, “Их засаг” бүрэн бүтнээрээ уламжлагдан үлдэж чадаагүй билээ. Түүнийг эрэн сурвалжлах, хайж олох асуудал эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татаж, эл чиглэлээр судалгаа явуулах эрмэлзлэл, тэмүүллийг төрүүлэх нэгэн учир шалтгаан болжээ. Энэ бүхнээс үүдэн “Их засаг”-ийг сонирхох, мэдэх, судлах гэсэн эрмэлзэл түүний үйлчилж байсан цаг үеэс эхэлж олон арав, зуун жилийг туулж иржээ. Дэлхийн янз бүрийн улс орны олон арван судлаачид өөрсдийн бүтээлийг Их засагтай ямар нэг байдлаар холбож ирсэн нь судалгаанаас илт харагдаж байна. ”Их засаг”-ийн судлагдаж ирсэн үйл явц түүний тухай ямар нэг хэмжээгээр өгүүлсэн 500 орчим сурвалж бичиг ном, бүтээлүүд байдаг гэсэн нь бүрэн хэмжээний тоо биш ажээ. Эдгээрийн нэлээдийнх нь агуулга, учир холбогдлыг иш үндэс болгон ”Их засаг”-ийн судлагдсан байдлыг хамгийн гол бүтээлүүдэд тулгуурлан авч үзэж болох юм. XIII-XIV зууныг ”Их засаг”-ийг судлахад өвөрмөц үе гэж үзвэл зохино. Эл үед ”Их засаг”-ийн тухай бичсэн хүмүүс ”Их засаг” гарч үйлчилж байсан тэр цагийн үйл явдал, амьдралыг биеэр үзэж туулсан, эсвэл сайн мэддэг хамгийн халуун сэргэг мэдээлэлд тулгуурлаж байснаараа онцлог болой. Тэдний зарим нь төрийн зүтгэлтэн алтан ургийхны үр садын ордонд алба хашиж байсан хүмүүс, шадар туслагчид, үр

хүүхэд, хаадын элч, төлөөлөгчид байсан бөлгөө. Эл үеийн бүтээлүүдийг шинжин ажиглахуйд хоёр үндсэн хандлага байсан нь илт байна. Энэ нь *нэгд* Монгол гүрний нийгэм, төр, аж ахуй, цэрэг, иргэний амьдралын тухай өгүүлэх явцад "Их засаг"-ийн тухай тэмдэглэн бичсэн зүйлс, *хоёрт* Монгол нутгаар аялан жуулчилж явсан хүмүүс үзсэн мэдсэнээ дурдсан замын тэмдэглэлүүд бичиж үлдээсэн баримт, материалууд бидний үед уламжлагдан ирснээр тодорхойлогдоно. XIII зууны үеийн бүтээлүүдээс Монголын нэгдсэн улсын хууль цаазад холбогдох хамгийн өргөн агаад шинэ сэргэг мэдээлэл агуулсан бүтээл бол "Монголын нууц товчоо" болой. Олон арван судлаач шинжээч, эрдэмтэн мэргэдийн бичсэнчлэн Чингисийн хаант төрийн нэрт зүтгэлтэн, улсын заргач, 82 сүүдэр зооглосон Шихихутуг өрлөг 1240 онд бичиж дүүргэсэн "Монголын нууц товчоо"-ны 282 дугаар зүйлийн 190 орчим зүйл нь хууль цаазад холбогдох ямар нэгэн мэдээлэл агуулж байдгаас түүн дэх хууль зүйн асуудлыг судлахад анхаарч ирсэн ажээ. Доктор Х.Пэрлээ Монголын нууц товчоог шинжлэн үзээд "Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл" гэсэн чамбай өгүүлэл бичиж "Монгол судлал" сэтгүүлд 1962 онд хэвлүүлсэн нь энэхүү алдарт бүтээл дэх хууль цаазад холбогдох зүйлийг тусган авч үзсэн анхны томоохон оролдлого бөлгөө. Зохиогч эл бүтээлдээ хааны өргөмжлөл, эрх мэдэл, цэрэг, байлдаан, өртөө, татвар, соёрхол, андын болзоо, захирах захирагдах ёсон, гэр бүл, ял шийтгэлийн тухай олон зүйлийг хууль цаазад холбогдуулан авч үзэж, зохих баримтаар нотлон тайлбарласан байна.

Эрдэмтэн Д.Дашцэдэн 1990 онд "Нууц товчооны хууль цаазын зарим зүйл" өгүүлэл бүтээн ШУА-ийн "Дорно дахины судлал" сэтгүүлд хэвлүүлсэн ажгуу. Эл өгүүлэлд нууц товчоон дахь баримтаас хууль цаазад холбогдох зүйлийг нь ялган авч судлан, төр, захиргаа, эрүү, иргэн, гэр бүлийн холбогдолтой зүйлс хэмээн ангилж тус бүрээр нь тайлбарласан болой./27.41-50/ Дээр дурдсан эрдэмтдийн болон бидний явуулсан судалгаанаас үзэхэд Монголын нууц товчоо нь нэг талаар Монголын нэгдсэн улсын хууль цаазад сурвалж болохынхоо хувьд баялаг баримт агуулсан түүхэн сурвалж бичиг, нөгөө талаар ийм сурвалж болохынхоо хувьд эрдэмтэн мэргэдийн анхаарлыг татаж, хууль зүйн үүднээс судлагдсаар ирсэн ба цаашид улам гүнзгий судлах шаардлагатайг илтгэн харуулж байгаа болой. Бидний үзэж байгаагаар монголын нууц товчоонд байгаа хууль цаазын шинжтэй зүйлүүд нь монгол туургатны нэгдсэн улсын нийгэм, төрийн байгуулалт, дотоод гадаад бодлого, ял шийтгэл зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан өргөн агуулгатай нь уг сурвалж бичиг энэ үеийн Монголын хууль цаазыг судлахад жинтэй холбогдох дорвитой сурвалж мөнийг харуулж байна.

Онцлон хэлбээс "Монголын нууц товчоо" өөрөө "Их засаг"-ийн судалгааны дорвитой бүтээл байж болох.

“Нууц товчоо”-г зохиогчид ҮШ зуунаас 1240 хүртэлх хугацааны Монголын төр, хууль цаазын асар их материалыг цуглуулан боловсруулж, 1240 оны гурван сард Хэрлэний хөдөө арлын Долоон болдог, Шилхинцэг хоёрын завсар хаан орд бууж байхад бичиж дуусгасан байх нь бас л үнэмшилтэй бөлгөө.

“Монголын нууц товчоо”-г зохиогчид XII-XIII зууны Монгол улсыг байгуулах, Нэгдсэн улсыг тунхаглахад оролцож, Чингисийн батүүний залгамжлагчдын үедамьдарч явсан монгол хүмүүс байсан нь тодорхой байна. Монголын нууц товчоог хууль зүйн үүднээс хичээн гүнзгий судалбаас Монголын нэгдсэн улсын эрх зүйг судлахад төдий чинээ ач холбогдол өгөх учиртай болой. Монголын нэгдсэн улсын эрх зүйг судлахад үнэтэй баримт, мэдээлэл уламжлуулсан хүмүүсийн дотор Персийн түүхч Ата Малик Жувейни, Рашид-ад-Дин нар томоохон байр эзэлнэ. А.Жувейни “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” хэмээх алдарт бүтээлдээ Монголын нэгдсэн улсын хууль цаазын тухай, түүний зарим заалтуудын агуулга, ач холбогдлыг тайлбарлан өгүүлжээ. Чингис хаан улсын нэгдмэл эрх зүйг үүсгэн тунхаглаж, түүнийг хуйлмал цаасан дээр бичин, хааны алтан ургийн санд хадгалан хөдлөшгүй бат мөрдөж байсныг тэр үеийн түүхэн баримтад тулгуурлан нотолсон нь Монголын нэгдсэн улсын эрх зүйг судлахад түүхэн үнэ цэнэтэй материал болж эрдэмтэд, судлаачдын анхаарлыг татаж ирсэн болой.

Рашид-ад-Дин “Судрын чуулган” хэмээх бүтээлдээ Чингисийн хаант улсын хуулийн талаар ховор мэдээлэл үлдээж, хэд хэдэн үндэслэл, саналыг дэвшүүлжээ. Тэрээр Монголын нэгдсэн улсад бие даасан бичмэл хууль цаазын тухай дурсгалт бичиг байсныг нотолж /140.135,197/, уг хуульд хамаарах цэргийг удирдах, аравт, зуут, мянгатын ноёдыг шилж сонгох, иргэнийг захирах зэрэг заалтуудын талаар өгүүлсэн байна. Монголын нэгдсэн улсын хуулийг судалж, өөрийн хэмээсэн дүгнэлт, баримт үлдээсэн эрдэмтний нэг нь Египетийн түүхч Макризи болой.

Тэрээр Багдадын номын санд хадгалагдаж байсан Чингисийн хаант улсын хуулийн зүйл ангиудыг ашиглан гэмт хэрэг, ял шийтгэлийн тухай нэлээд тодорхой өгүүлэхийн зэрэгцээгээр нэгдсэн хууль гаргасан цаг хугацаа, дагаж мөрдөх журмын талаар тайлбарлан өгүүлжээ.

А.Жувейни, Рашид-ад-Дин, Макризи нар тухайн үедээ Чингис хаан, түүний удам угсаа үр ач нарын намтар, толгойлсон төр улсын үйл ажиллагаа, амьдрал тэмцлийн талаар туурвиж шастирлах явцад Чингисийн үеийн хуулийн талаар хэсэгчлэн өгүүлсэн зүйлс нь нэг талаар Чингисийн хаант улсын хуулийг судлахад үнэтэй баримт болон мөнхрөн үлдэж, нөгөө талаар үе үеийн судлаачдаас Чингисийн хуулийг судлахад чухал “хэрэглэгдэхүүн” болсон учир Монголын судлаач хойч үеийнхэндээ алтан үсгээр бичигдэх гавъяатнууд бөлгөө. Чингисийн хаант улсын хууль, түүний гол илэрхийлэл болж алдаршсан “Их засаг”-ийг судлахад холбогдох үнэт баримт,

дүгнэлтүүд Юан улсын хууль цаазын бичиг, Сирийн Абул Фаражийн “Сирийн түүхэн тэмдэглэл”, Армянний Магакийн “Монголчуудын түүх” зэрэг бүтээлүүдэд бичигдсэн нь бий. Эдгээр бүтээлүүдэд Хуралдай, их хаан, элч төлөөлөгч, цэргийн байгуулалт, үйл ажиллагаа, өртөө улаа, өмч хөрөнгө, алба татвар, ял шийтгэлийн талаар өгүүлэн бичсэн нь “Их засаг”-ийн агуулгыг тодорхойлоход зүй ёсоор холбогдох болой.

Хятадын элч Чан Чунь бомбын “Баруун зүгт зорчсон бичиг”, “Италийн жуулчин Плато Карпиний “Монголчуудын түүх”, Гильен де Рубрукийн “Дорно этгээдэд зорчсон минь”, Марко Пологийн Замын тэмдэглэл хэмээх элч, жуулчдын бүтээлүүдэд Монголын нэгдсэн улсын хууль цаазад холбогдох зүйлс, тэдгээрийн хэрэгжиж байсан үйл явцын тухай бичиж тэмдэглэсэн нь “Их засаг”-ийг судлахад хамаарах чухал хэрэглэгдэхүүнд зүй ёсоор хамаарна.

Ялангуяа “Монголчуудын түүх”-д их хаан, түүний шадар ноёдын эрх ямба, хааны ордны зохион байгуулалт, цэргийн үйл ажиллагаа, гэр бүлийн харилцааны ёс журам, гэмт хэрэг, ял шийтгэлийн тухай /28.13.78/ бичиж тэмдэглэсэн зүйлүүд Монголын нэгдсэн улсын хуулийн шинж агуулгыг тодорхойлоход зүй ёсоор холбогдоно. Гильен де Рубрукийн “Дорно этгээдэд зорчсон минь” тэмдэглэлд хоёр хүний хоорондын маргааныг шийдвэрлэх горимыг өгүүлж хүний амь бүрэлгэсэн, бусдын эхнэртэй нөхцсөн, ихээр хулгай хийсэн, өөрийгөө элч гэж мэхэлсэн үйлдлийг гэмт хэрэг хэмээн үзэж цаазаар аваачих ёс журамтайг /18.114-117/ бичсэн нь мөн л эл үеийн хууль цаазын агуулгыг тодорхойлоход учир холбогдолтой болой.

XIII-XIV зууны Чингисийн “Их засаг”-ийн тухай өгүүлсэн сурвалж бичиг, ном бүтээлүүдийг шинжин үзэж, судлагдсан байдлыг нь ажиглахуйд тэдгээр нь бүхэлдээ хамгийн шинэ сэргэг баримт, материалыг агуулж байсны хувьд “Их засаг” хуулийг сэргээн бүтээхэд тулгуур үүрэг гүйцэтгэх учир холбогдолтой нь илт байна.

Чухамдаа эдгээр бүтээлүүдийг шинжлэн судалж Монголын нэгдсэн улсын хуулийн /Их засаг/ “араг ясыг” босгож тавьсан хэмээн хэлж болох бизээ.

XIV зууны эцэс XV зуунаас XIX зууны эцэс хүртэл түүхийн нилээд урт хугацаанд Монголын нэгдсэн улсын хуулийн талаар тодорхой зүйлүүд бичих нь багассан хэдий ч зохих ёсоор холбогдуулан үзэж судалбал зохих бага бус бүтээлүүд буйг тэмдэглэвэл зохино. Тэдгээрийн дотроос Гүүш Лувсанданзангийн туурвисан “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан “Алтан товч” хэмээх шастир, XII-XIV зууны үеийн Монгол улсын түүхийг уран зохиолын хэлбэрээр өгүүлсэн, алдарт эрдэмтэн Инжинашийн бүтээсэн “Хөх судар”, Ираны түүхч Мирахаундын бүтээл, Туркийн Д.Оссоны “Монголчуудын түүх”, Оросын Н.Н.Березины “Зүчийн улсын дотоод байгууламжийн найраглал” бүтээлүүдийг онцлон нэрлэж болно. Дээрх бүтээлүүдэд хааны өргөмжлөл, нэр төр, эрх мэдэл, элч төлөөлөгч, цэргийн байгуулалт,

ав хоморго, өртөө, улаа, өмч хөрөнгө, гэр бүлийн ёс журам, гэмт хэрэг, ял шийтгэлийн тухай хэсэг, бусгаар өгүүлсэн байх нь Монголын нэгдсэн улсын хуулийг судлах, "Их засаг"-ийн агуулгыг тодорхойлоход холбогдох баримт материалууд бий болой. "Их засаг"-ийн шинж, бүтэц, агуулгыг судлах чиглэлээр ажилласан судлаачид Мирхаун, Березины бүтээлүүдээс иш татсан байх нь хэдэндээ тааралддаг бөлгөө.

XX зуунд Монголын нэгдсэн улсын хууль цааз судлалын талаар томоохон ахиц гарсан хэмээн хэлж болно. Хэрвээ өмнө нь Чингисийн төрийн хууль цаазын тухай хэсэгчилсэн зүйл бичигдэж байсан бол энэхүү зууны гучаад оны эхэн үеэс Монголын нэгдсэн улсын хууль цааз, ялангуяа "Их засаг" хуулийн талаар янз бүрийн орны эрдэмтэн мэргэд дагнасан шинжтэй судалгаа явуулахад шилжсэн нь эл чиглэлээр дорвитой бүтээлүүд гаргахад хүргэсэн томоохон хүчин зүйл болсон ажгуу. Энд юуны өмнө профессор Рязановскийн тухай дурдвал зохино.

Тэрээр "Монголын эрх зүй", "Чингис хааны Их засаг"-ийг онцлон үзэж, дагнан судалсан дүнгээ гарган тавьсан бөлгөө. Ялангуяа "Чингис хааны Их засаг" бүтээлдээ Их засаг үүсэн бий болсныг дурдаад Макризийн бүтээлээс 2,6, Мирахаундын бүтээлээс 2, Ибн Батуты, Вартан, Магакийн бүтээлээс тус бүр нэг, бусад янз бүрийн сурвалжуудаас 29 зүйлийг "Их засаг"-т хамааруулан шинжилж тайлбар хийжээ. Зохиогч дээрх бүтээлүүдээс гадна Монголын нэгдсэн улсын хуулийн тухай чухал баримт мэдээллүүдийг тодорхойлон өгүүлсэн А. Жувейни, Рашид-ад-Дин, Марко Поло, Плано Карпини, Гельен Де Рубрук, П.Березин нарын зохиол, тэмдэглэл, Юан улсын судар мэт сурвалж бичиг, Хятадын түүх, хууль цаазын дурсгалуудыг өргөн ашигласан нь "Их засаг"-ийн тухай түүний судалгаа нилээд гүн гүнзгий шинжилгээ, олон сурвалж бүтээл ашигласны дүнд тулгуурласаныг гэрчилнэ. Бас Дорно дахины орнууд, түүний дотор Хятад, Монгол, Египет, Дундад Азийн орнууд дахь сурвалж бичиг, зохиол бүтээлүүдийг өргөн ашигласанаараа онцлог болох нь илт ажиглагдана. В.А.Рязановский өөрийнхөө судалгаагаар Чингисийн "Их засаг"-т хамаарах заалтуудыг янз бүрийн бүтээлүүдээс ялган авч жагсаан дурдаад улмаар тэдгээрийнхээ агуулга, онцлогийг судлан дүгнэсэн болой.

Иймээс түүний энэ бүтээлийг Монголын нэгдсэн улсын хуулийн талаар зориуд дагнан хийсэн судалгааны анхны бүтээл хэмээн хэлж болох үндэслэлтэй.

В.А.Рязановскийн аргыг өвлөн ашиглаж, "Их засаг"-ийн талаар судалгаа явуулан дорвитой бүтээл туурвисан судлаач бол Хятадын эрдэмтэн Х.Намжил юм. Тэрбээр "Чингис хааны засаг ба билэг" хэмээх бүтээлдээ Чингисийн "Их засаг"-ийн буй болсон түүхэн явц, шинж, онцлог, залгамж холбооны тухай өгүүлэхийн хамт түүнд хамаарна хэмээн үзсэн заалтуудыг түүвэрлэн авч тайлбарлсан бөлгөө. "Монголын нууц товчоо"-оос 9, Жувейний "Ертөнцийг төвшитгөгчийн түүх"-ээс 9, Рашид-

ад-Дины”Судрын чуулган”-аас 5, Плато Карпин, Гильен Де Рубруккийн ”Монголд жуулчилсан тэмдэглэл”-ээс 20, Макризийн бүтээлээс 25, бусад янз бүрийн 4 сурвалж бүтээлүүдээс 13, бүгд 81 зурвас хэсгийг ”Их засаг”-т хамаарах заалтууд хэмээн бичиж, тайлбар зүүлт хийсэн нь арга зүйн хувьд В.А.Рязановскийн бүтээлтэй төстэй боловч арга зүйн хувьд түүнээс ялгагдах онцлогтой аж. Х.Намжил нь Жувейни, Рашид-ад-Дин, Макриз, Плато Карпини, Гильом Рубруккийн бүтээлийг В.А.Рязановскийтэй адил судалсан боловч түүний судлаагүй ”Монголын нууц товчоо”, ”Монгол-Татарын тэмдэглэл”, ”Хар Татарын тухай хэргийн товчоон”, ”Юан улсын түүх” зэргийг судлан ашигласан байдаг. Харин Ибн Батуты, Вартана, Магаки, Мирхаунд, П.Березин нарын бүтээлээс иш татаагүйг бодохул тэдгээрийг ашиглаагүй бололтой.

Эл хоёр эрдэмтний бүтээл ”Их засаг” судлалд жинтэй хувь нэмэр оруулсаны зэрэгцээгээр бие биенийхээ байгаа зүйлээр байхгүйг нь нөхөх ач холбогдолтой ажгуу. ”Их засаг”-ийг судалж, түүний бүтэц агуулгыг тодорхойлох судалгаанд энэхүү бүтээлүүд үлэмж мэдээлэл өгч буй төдийгүй ”Их засаг”-ийн заалт хэмээн түүвэрлэн авсан зүйлүүд, тэдгээрийн талаар хийсэн тайлбарууд нь түүхэн үнэ цэнэтэйг тэмдэглүүштэй.

”Их засаг”-ийг дагнан судлахад үнэтэй хувь нэмэр оруулсан хүний нэг нь проф. Жорж Вернадский бөлгөө. Тэрээр”Их засаг”-ийн талаар нэлээд дагнасан судалгаа явуулсан дүнгээ”Чингис хааны их Яса /засаг/- ийн судалгаа, түүний агуулга” нэртэйгээр хэвлүүлжээ. Ж.Вернадскийн шинжилгээний ажил В.А.Рязановский, Х.Намжил нарын судалгааны ажлаас зарчмын онцлогтойг анхаарууштай юм.

Тэрбээр өөрөөсөө өмнөх үеийн судлаачдын бичсэн англи хэл дээрх бүтээлүүдийг шимтэн судлаж, түүнийхээ үр дүнд тулгуурлан бүтээлээ туурвижээ. Ялангуяа А.Жувейни, Раш-Ад-Дин, Макриз, Ибн Батуты, Абул Фаражи, Мирхаунд, Вардан, Магахи, Д.Оссон, Потис де Ла Пройкс, И.Н.Березин, В.А.Рязановский нарын бүтээлүүд хийгээд Юан улсын судрыг судалсан аж. Гол онцлог нь Монголын нэгдсэн улсын гол хууль”, ”Их засаг”-ийг 7 бүлгээс бүрдэнэ хэмээн тогтоож, бүлэг тус бүрийн агуулгыг зохиомжлон тодорхойлж ”Их засаг” хуулийг тодорхой бүтцэд оруулан бичсэнд оршино. Чингэхдээ хуулийн заалтын хэлбэрээр бус хүүрнэн өгүүлэх, иш татах, тайлбарлах маягаар бүтээсэн болой. ”Их засаг” хууль ямар бүтэцтэй ямар хууль байсныг томъёолж тодорхойлсон нь энэ бүтээлийн гол онцлог оршино.

Ж.Вернадскийн аргатай төстэй байдлаар Монголын нэгдсэн улсын гол хуулийн бүтэц, агуулгыг сэргээн”босгосон” судлаач бий. Энэ нь Хятадын нэрт эрдэмтэн Сайшаал юм. Тэрбээр ”Их засаг” хуулийг 7 бүлэг, 54 зурвас /зүйл/-тайгаар бүтээн ”босгожээ”. Сайшаалын ”Сэргээн тогтоосон хууль нь агуулга, хэллэгийн хувьд нэлээд ойлгомжтойн дээр бүлэг, зүйлүүд болгон хэлбэршүүлэн бичсэнээр бие даан нэгдсэн хуулийн маягт ойртон очсон онцлогтой байна.

Чингисийн “Их засаг” хуулийг судалсан зарим судлаачид “Их засаг”-т холбогдох заалтуудыг сурвалж бичиг, зохиол бүтээлүүдээс түүвэрлэн авч, зориулалтынх нь дагуу бүлэглэн, ангилан бичиж тайлбарласан байх нь эл үеийн хууль цааз судлалын нэгэн өвөрмөц чиглэл мөн болой. Энэ чиглэлийн судлаачдад юуны өмнө монголын эрдэмтэд, судлаачид орж байна. Тухайлбал Л.Дэндэв, С.Жалан-Аажав, Ч.Жүгдэр, И.Дашням нарыг дурдаж болно. Эдгээр судлаачид “Их засаг”-т хамаарна хэмээсэн заалтуудыг орчин үеийн эрх зүйн онолыг үндэслэн а/ засаг захиргааны, б/ иргэний, в/ эрүүгийн эрх зүйд холбогдох зүйлүүд гэсэн 3 хэсэгт ангилан авч үзжээ. Л.Дэндэв “Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр” бүтээлийн “Монголын Чингис хааны бүлэг”-т 46, С.Жалан-Аажав 1958 онд “Халх журам бол Монголын хууль цаазын эртний дурсгалт бичиг” номынхоо “Халх журмын өмнөх монгол хууль цаазын ерөнхий байдал” бүлэгт 32, Ч.Жүгдэр 1987 онд хэвлүүлсэн “Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ” бүтээлийнхээ “хууль цаазын зүйл” бүлэгт 9 хэсэг заалтуудыг “Их засаг”-т холбогдуулан авч үзэж тайлбарласан ажгуу. Доктор И.Дашням Чингисийн хаант улсын төр, хууль цааз бүтээлдээ Их Засаг хуулийн баталсан, үйлчилсэн цаг хугацаа агуулга, ач холбогдлын нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Монгол улсын эдгээр эрдэмтэн, судлаачид “Их засаг”-ийн бүтэц, агуулгыг бүхэлд нь сэргээн тогтоогоогүй хэдий ч уг хуульд холбогдох заалтуудыг түүвэрлэн авч үзэн ангилах, тайлбарлах, дүгнэлт гаргах зэргээр шинжилсэнээрээ Монголын нэгдсэн улсын хууль цаазыг дагнан судлах үйлсэд чухал хувь нэмэр оруулсан хэмээн үзэх бөлгөө.

Чингисийн “Их засаг” хуулийн талаар ерөнхий судалгаа явуулах, “Их засаг”-ийн агуулга, шинж чанар, онцлог, ач холбогдлыг судлан тодорхолох чиглэлээр ажиллаж, өөрсдийн бүтээлүүддээ үнэтэй санал, дүгнэлтүүд дэвшүүлсэн эрдэмтэн мэргэд Монголд төдийгүй бусад янз бүрийн улс оронд цөөн бус буй бөлгөө.

Ийм эрдэмтдийн тоонд юуны өмнө Монголын А.Амар, Д.Гонгор, Х.Пэрлээ, Н.Ишжамц, Ш.Нацагдорж, Ч.Далай, Ш.Бира, Э.Авирмэд, Г.Совд, Ж.Авхиа, О.Амархүү, Д.Дашцэдэн, Д.Лүндээжанцан, Ж.Болдбаатар, Х.Сэлэнгэ, Г.Баярхүү, Х.Нямбуу, Оросын В.В.Бартольд, С.Д.Дылыков, Е.И.Кычанов, В.Г.Владимирцов, Японы Ш.Озова, Мураками, Янай, Казуфужи, Такайши, Америкийн Маккенз, Дюмо, Листер, Морис, Зособо, Английн Зольф Фокс, Пауль Зачановский, Ж.Саундерс, Х.Ламба, Францын Морис Першерон, Германы Грасс, Тайваны Ли Ци Фин нарын зэрэг хүмүүсийн нэрийг дурдаж болно. Түүний Хятад, Орос, Японы эрдэмтэд болон Энэтхэг, Иран, Армян, Сологос, Унгарын эрдэмтдийн олон бүтээл бий.

Монголчуудын хууль цаазын “охь” болсон Чингисийн “Их засаг” хуулийн судлалд өөр өөрийн хэмээсэн ул мөрөө үлдээж үнэ цэнэтэй эрхэм чухаг бүтээлээ уламжлуулсан

эрдэмтэн мэргэдийнхээ нэр алдар, өв санг монгол түмэн үеийн ед үүрд хүндэтгэн эрхэмлэж байх нь эргэлзээгүй бөлгөө. Тэдний бүтээлүүд монголын соёл иргэншлийн оюуны өв санд "эрдэнэ сувд" болон мөнхрөх тавилантай ажгуу.

"Их засаг"-ийг судлах, түүнийг сэргээн босгох буюу судалгааг гүнзгийрүүлэх, эсвэл эх хувийг нь хүн төрөлхтний өмнө нээн олох үйлс ариун агаад нээлттэй бөлгөө. Энэ чиглэлийн судалгаанд Турк, Иран, Ирак, Египет, Энэтхэг, Армяны эрдэмтэд хүчтэй оролцож, Чингисийн "Их засаг"-ийг эрэн сурвалжлах, судлах ажлыг НҮБ-ын хөтөлбөрийн хүрээнд өрнүүлбээс томоохон ахиц аяндаа гарна даа хэмээн бодож явдагаа эл ялдамд өчье. Сайн үйлс дэлгэрэх тавилантай билээ.

§ 5. "Их засаг" хуулийн бүтэц

"Их засаг" хэмээн алдаршсан Монголын нэгдсэн улсын хуулийн бүтэц, агуулгыг тогтоон томъёолох асуудалд эрдэмтэд, судлаачид багагүй анхаарал тавьж иржээ. Учир нь "Их засаг" бол монголын нэгдсэн улсад үйлчилж байсан болон шинээр тогтоосон цаазын заалтуудыг багтаасан бөгөөд "хуйлмал хуудас"-д дэвтэрлэн хадгалж, төрийн хэргийг хэлэлцэн шийдвэрлэх үед уншин болгоож баримталдаг улсын хэмжээний хууль байсан бөлгөө.

"Их засаг" хэмээх төрийн нэгдмэл хууль бүрэн эхээрээ бидний үед уламжлагдан үлдээгүйгээс үүдэн түүний бүтэц, агуулгыг тогтоон томъёолох нь хууль судлалын нэг чухал зорилт болж, цөөн бус эрдэмтэд авьяас билгээ сорьж иржээ.

"Их засаг"-ийн бүтцийг томъёолж агуулгыг нь тогтооход гурван үндсэн хандлага гарч ирсэнийг судалгааны дүн харуулж байна. Энэ нь: *Нэгдүгээрт*, "Их засаг"-ийг нэгэн бүхэл хууль, түүнийг илэрхийлсэн хэсэг, бүлэг, зүйлийн хэлбэрт оруулан нэг тодорхой бүтэц, бүрэлдүүлэн болгон авч үзсэнээр илэрч байна. Ийм хандлага гаргасан эрдэмтэд юуны түрүүнд Хятадын Сайшаал, Америкын Ж.Вернадский нарыг оруулж болно. Ж.Вернадский "Их засаг"-ийн бүтцийг олон улсын хууль, төрийн хууль, эрүүгийн хууль, хувийн өмч буюу хувийн эрхийн хууль, худалдааны хууль, шүүн таслах ажиллагаа, хуулийг хянах, хэрэгжүүлэх гэсэн 7 хэсэгтэйгээр тогтоож /5.15-33/ хэсэг тус бүрээ тодорхой зүйлд оруулахгүйгээр авч үзжээ. Тэгэхдээ зарим хэсгийг нь жижиг жижиг бүлгүүдэд хуваан өгүүлсэн байна, Тухайлбал, "төрийн хууль" хэмээх хэсгийг хааны дээд эрх, үндэстэн, тусгай үүргийн журам, тусгай эрх, цэргийн журам, ан авлах журам, дотоод захиргаа, захиргааны тушаалууд, санхүүгийн удирдлага, татвар гэсэн жижиг бүлгүүд болгожээ. Мөн "эрүүгийн хууль" гэсэн хэсгийг гэмт хэргийн төрөл, ял шийтгэлийн төрөл хэмээн хоёр бүлэг болгосон ажгуу. Хэсэг, бүлгийн агуулгыг авч үзэхдээ тоочих бус хэн гэдэг хүний ямар ямар бүтээлд юу гэж тэмдэглэгдснийг иш татан нотлох арга хэрэглэсэн онцлогтой. Ж.Вернадскийн

бүтээлийг уншиж үзэхэд "Ийм л хууль байсан байж болох юм шүү" гэсэн төсөөлөл сэтгэлд бууж ирдэг билээ. "Их засаг"-ийн бүтэц агуулгийг тогтооход Ж.Вернадскийн томъёолон гаргасан бүтэц чухал ач холбогдолтой нь эргэлзээгүй болой.

Өвөр монголын өөртөө засах орны эрдэмтэн Сайшаал "Их засаг"-ийг "Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль товчоон" хэмээн нэрлээд бүтцийг нь 4 хэсэгтэйгээр тогтоожээ. Хэсэгүүдээ: хаан төрийн хууль, цэрэг дайны хууль, ард иргэдийн хууль, тусгай хууль хэмээн нэрлэсэн байна. Үүнээс тусгай хуулиа дотор нь олон улсын харилцааны хууль, аж ахуйн хууль, арилжаа худалдааны хууль, зам нэвтрэх ба өртөөний хууль, шашин суртлын хууль, ургийн хууль, эрүүгийн хууль гэсэн долоон бүлэгт ангилжээ. Зохиогч хэсэг, бүлгүүдийг зурвасаас /зүйл/ бүрдэхээр тогтоожээ. Сайшаалын томъёолон тогтоосон хуулийн бүтцийг авч үзэхэд "Их засаг"-ийн бүтцийн тухай нэгэн өвөрмөц төсөөлөл сэтгэлд бүрэлдэж ирдгийг тэмдэглэлтэй.

Хоёрдугаарт, "Их засаг"-ийн бүтцийг тодорхойлон тогтоохдоо эрх зүйн тогтолцооны орчин үеийн онолын үүднээс "Их засаг"-т хамаарах заалтуудийг эрх зүйн тодорхой салбарт хуваарилан оруулж авч үзсэн нь өөр нэг хандлага болно. Л. Дэндэв, Ч.Жүгдэр, С.Жалан-Аажав нар энэхүү хандлагын гол төлөөлөгчид мөн. Эдгээр эрдэмтэд "Их засаг"-т хамаарна гэж үзсэн заалтуудаа а/ төр, захиргаа, б/ иргэн, в/ эрүүгийн гэсэн гурван гол салбарт хуваан ангилж авч үзсэн байна. МУИС-ийн хуульч судлаачид "Эзэн богд Чингисийн их засаг"-т холбогдох заалтуудыг мөн тийм гурван чиглэлд хуваан ангилж авч үзсэн байна. Чингэхдээ хуулийн заалтыг байгаагаар нь бичиж, зарим тайлбар хийсэн байдаг. Ийм байдлаар "Их засаг"-ийн заалтуудыг ангилж авч үзсэн нь "Их засаг"-ийн бүтцийг тодорхойлон тогтоочих гэсэн бус, харин түүний агуулгыг тодорхойлох, ойлгоход хамаарах арга зүйн учир шалтгаантай бөгөөд хуулийн агуулгыг тогтооход чухал ач холбогдолтой болой.

Гуравдугаарт, "Их засаг"-ийн бүтэц агуулгыг тодорхойлоход гарч ирсэн гурав дахь хандлага нь тодорхой хэсэг, бүлэгт оруулахгүйгээр тухайн сурвалж бичиг, зохиол бүтээлд тэмдэглэн дурдсан хуулийн заалтуудыг иш татаж дарааллаар нь жагсаан бичиж тайлбар зүүлт хийснээр илэрч байна. Ийм байдлаар Их засгийн агуулга, ач холбогдлыг тодорхойлон гаргах гэсэн хандлага Оросын нэрт эрдэмтэн В.Я.Рязановский, Хятадын Өвөр монголын өөртөө засах орны эрдэмтэн Х.Намжил нарын бүтээлүүдэд илрэлээ олжээ. В.Рязановский "Чингис хааны их засаг" гэсэн бүтээлдээ эрдэмтдийн бүтээлүүдээс "Их засаг" холбогдох заалтуудыг иш татан жагсаан бичиж, тайлбар, дүгнэлтүүд хийсэн бөлгөө. В.Рязановскийн сурвалжлан олж, нэгэн бүтээлд нотлон өгүүлж, дүгнэлт хийсэн "Их засаг"-т холбогдох заалтууд Монголын нэгдсэн улсын хууль цаазын агуулгыг тогтоон тодорхойлоход эрдэм шинжилгээ, арга зүйн чухал ач холбогдолтой бөгөөд өөрөөсөө хойши судлаачдад асар их нөлөө үзүүлсэн ажгуу.

Х.Намжил “Чингис хааны засаг ба билэг” хэмээх зохиолдоо Монголын түүхэнд хамаарах сурвалж бичгийн шинжтэй бүтээлүүдэд дурдан тэмдэглэсэн “Их засаг”-т хамаарах заалтуудыг иш татан бичсэн нь “Их засаг” хуулийн агуулгыг тогтоон тодорхойлоход мөн л чухал ач холбогдолтойг тэмдэглүүштэй.

Дээрх гурван хандлага чиглэлээр явагдаж ирсэн ажлын үр дүн нь Чингисийн “Их засаг” хуулийн агуулга, ач холбогдлыг нээн харуулахад суурь үүрэг гүйцэтгэх ач холбогдолтой юм. Энэ нь ямар ч арга хэлбэрээр Чингисийн үеийн хууль цаазыг судлахад дээрх судалгааны ажлын үр дүнг үндсэн хэрэглэгдэхүүн, харьцуулан жиших гол хэмжүүр болгон үзэж судалгаа, шинжилгээний ажил явуулна гэсэн хэрэг болой. Судлаачидын дотроос доктор Д.Дашцэдэн арай өөрөөр бичихдээ “Их засаг” хууль нь бүтцийн хувьд дараах хэсгийг өөртөө багтаасан гэж үзэж болно. Үүнд: а/ оршил, б/ улсын хаан өргөмжлөх ёс, төрийн байгуулал, цэргийн анги, в/ эрүүгийн хуулийн холбогдолтой заалтууд, г/ алба татвар, д/ олон улсын харилцаа, е/ шашин суртахуун, ё/ гэр бүл, иргэний хуулийн холбогдолтой заалтууд, ж/ мал аж ахуйн талаарх заалтууд болохыг дурджээ /59.121/.

“Их засаг”-ийн бүтэц, агуулгыг тодорхойлох асуудалд хандахдаа арга зүйн хувьд анхаарах хэд хэдэн зүйл бий. *Нэгд*, Монголын нэгдсэн улсын хуульд хамаарах заалтуудыг түүвэрлэн авч боловсруулахдаа дорно дахины орнуудад хууль цаазаа бүтээж ирсэн уламжлалыг харгалзан зохих дэс дараалалд оруулж тайлах чиг баримтлах. *Хоёрд*, Тус хаант улсын хуульд хамаарах заалтуудыг зохицуулсан харилцааных нь шинж байдлаар төрөлжүүлэн ангилж байршуулбал ойлгомжийн хувьд илүү сайн болох. *Гуравд*, аль болох шинжлэх ухааны үндэслэлтэй байх шаардлагыг иш үндэс болгон эрх зүйн тогтолцооны орчин үеийн онолын сэтгэлгээний үүднээс хандах. *Дөрөвт*, орчин үеийн гол хуулиудийн бүтэц агуулгатай жишиж үзэн агуулга, ач холбогдол, уламжлагдах шинжийг нь тодорхойлон гаргах. *Тавд*, заалт бүрийн хууль зүйн утгыг түүхэн тухайн цаг үеийн нөхцөлд нийцүүлэн үнэн бодитой тайлах зэрэгт анхаарах нь чухал юм. Ийм арга зүйгээр хандахдаа “Их засаг” хуулийн тухай мэдээлэл, баримт, заалтуудыг агуулсан түүхэн сурвалж бичиг, судар, шасдир, ном зохиол, туурвил бүтээлүүдийг аль болохоор бүрэн судалж ашиглавал эл үеийн хууль цаазын агуулга, ач хобогдол төдий чинээ үндэслэлтэй, гүн гүнзгий боловсрогдох учиртай.

Бид Чингисийн “Их засаг” хууль, түүний илэрхийлэл болсон “Их засаг”-ийн бүтэц агуулгыг тодорхойлох асуудалд хандахдаа уг цааз төчнөөн хэсэг, бүлэг, зүйлээс бүрдсэн, тийм хэмжээтэй хууль байсан хэмээн тогтоох гол зорилго тавиагүй юм. Нэгэнт “Их засаг”-ийн жинхэнэ эх олдоогүй болохоор түүний бүтцийг ямарч хэлбэрээр тогтоолоо гэхэд тэр нь “зохиомол” бүтэц байх болно гэдэгт мартаж үл болох буй заа.

Энэхүү бүтээлд "Их засаг"-ийн агуулга, түүний хууль зүйн утгыг аль болохоор тодорхой харуулах чиглэл баримталж, үүний үндсэн дээр "Их засаг" нь ямар харилцааг зохицуулсан, ямар хүрээ агуулгатай ямар шинж чанар, ач холбогдолтой, ямар хууль байсныг тодорхойлон гаргах зорилт тавив. Чингэхдээ монголын нууц товчоо, Алтан товч, Хөх судар, Юан улсын судар, Монгол-Татарын тэмдэглэл зэрэг Монгол сурвалж бичигүүд болон өрнө дорнын ба үндэсний олон арван эрдэмтэд, судлаачдын судалгаа, шинжилгээний бүтээлүүдийг харьцуулан судалсан дүнд тулгуурласан бөлгөө. Ингээд "Их засаг"-ийн агуулгыг авч үзье.

§ 6. "Их засаг" хуулийн агуулга, уламжлагдах шинж

Түүхэн сурвалжууд болон эрдэмтэд, судлаачдын зохиол бүтээлүүдэд тэмдэглэн дурдсан Их засагт хамаарах заалтуудыг түүвэрлэн авч, нэгтгэн шинжиж үзвээс тооны хувьд цөөн бус, агуулга хүрээний талаар өргөн бөгөөд баялаг болох нь илэрхий мэдрэгднэм. Агуулга багтаамж нь нийгэм, төрийн амьдралын бүх үндсэн хүрээг хамарсан агаад монголын унаган төрх, өвөрмөц онцлог, төрийн бодлого, нийгмийн зохион байгуулалт, амьдралын хэв маяг, зан заншил, иргэний ёс, аж байдлыг гүнзгий тусгасан шинжтэй ажгуу. Монголын нэгдсэн улсын дүр төрх, шинж төлөв төрийн цааздаа тусаж байх нь зайлшгүй төдийгүй Монгол улс дэлхийд алдаршсан хүчирхэг гүрэн болж мандан хөгжсөний нэгэн үндэс, шалтгаан нь энэхүү хууль, түүний хэрэгжсэн үр дүнд оршиж байсан байж болох нь бүрэн магадлалтай буюу. Ямар боловч "Их засаг" хууль Чингисийн хаант улсын төр оршин тогтнохын нэгэн гол үндэс, хүчирхэгжин мандаж, төрийн дотоод, гадаад бодлого биелэн хэрэгжих чухал хэрэгсэл, монгол үндэстэн бүрэлдэж, нийтлэг маягийн эдийн засаг, аж ахуй, хэл, бичиг үсэг, удам угсаа, зан заншил бүхий соёл иргэншил тогтон төлөвших хууль зүйн нөхцөл болж үйлчилсэн нь түүхэн үнэн болой.

Иймээс Монголын нэгдсэн улсын хууль "Их засаг"-ийн заалтуудыг тогтоосон хэм хэмжээнийх нь агуулга, хүрээг үндэс болгон төрөлжүүлэн ангилж үзэх нь зүйтэй болов уу.

Эл ялдамд их засгийн заалтууд ямар дэг журам, зан үйлийг тогтоосон, тэр нь хууль зүйн ямар агуулга, учир утгатай бөгөөд нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлсөн, хууль цаазын цаашдын зохицуулалтанд ямар байдлаар уламжлагдах шинж төлөв агуулж байсныг тайлан тайлбарлахыг хичээсэн болой.

"Их засаг"-г хамаарах заалтуудын агуулгыг нэгтгэн дүгнэж үзвэл тогтоомжийнхоо утгаучир, зохицуулсан зүйлийнхээ зориулалтаар үлэмж баялаг юм. Тухайлбал, монголын нэгдсэн улсын бүрэн эрхт байдал, их хаан, түүний эрх мэдэл, засаг захиргааны хуваарь, төрийн байгууллагын тогтолцоо, түүний байгууллагуудын эрх, үүрэг, түшмэдийн ёс, улсын санхүү, алба татвар, цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, аж ахуй эрхлэн

хөтлөх, газар нутаг, ус ургамал, ан эзэмших, ашиглах, хамгаалах журам, гэр бүл, зан заншил, эрүүгийн бодлого, гэмт хэргийн төрөл, ял шийтгэлийн хэлбэр, хэмжээ зэрэг олон асуудлыг багтаасан нь үнэнхүү гайхамшигтай юм.

Орчин цагийн ёс, олон түмэнд ойлгомжтой болгох зорилгын үүднээс дээр дурдсан “Их засаг”-ийн агуулгыг авч үзэх нь ч чухал. Түүнээс бус ром-германы маягт хуультай адилтгаж, мөн энэ үүднээс агуулгыг нь шаардаж үл болмой. Харин XIII зууны эхэн үеийн нөхцөлд нь л авч үзэхийг хичээсэн болно.

Хуулийн зохих заалтуудыг дурдахын хамт ямар сурвалж, хэний бүтээлд хэрхэн тэмдэглэснийг өгүүлэн утга учрыг нь тайлах, орчин үед сургамжтай хэмээсэн зүйлийн тухай санаа бодлоо илэрхийлэн гаргахыг эрмэлзэх нь зүйтэй болов уу.

XIII зууны эхээр бүрэлдэн тогтсон Монголын нэгдсэн улс ямар улс болох, ямар байр суурь эзлэх, гадаад, дотооддоо ямар бодлого баримтлах, бусад улс оронтой хэрхэн харилцах, улсынхаа бүрэн бүтэн байдал, монгол үндэстнээ яаж хамгаалахыг хуульчлан тогтоосон нь “Их засаг”-ийн агуулгын ноён оргил нь мөн болой.

Чингис хаан, ”Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг ил болгон дээр дор хүрвээс биширтүгэй, аюутугай” хэмээн зарлиг буулгаж улмаар энэхүү зарлиг нь төрийн тамган дээр сийлэгдсэн нь монголын нэгдсэн бие даасан, ямар ч улсаас хараат бус хүчирхэг улс бөгөөд, түүний тэнгэрээс заяасан сүр хүч, их эрх мэдэлтэйг хуульчлан тунхагласан хэрэг мөн юм. Энэ нь монголчуудын байгуулсан улс бол монгол угсаатны эх дэлхийн хамгийн хүчирхэг улс бөгөөд түүнийг ямарч улс орон хүндэтгэн биширч, бодлого, саналыг нь анхааран үзэж, найрсаг харилцаатай байх утга санааг илэрхийлж байв. Чингис хаан гадаад бодлого, дайн явуулах, найрамдал, эвлэрэл тогтоох зэрэг улсын бүрэн эрхт байдалд хамаарах асуудлыг Их Хуралдайгаар хэлэлцэх журмыг хатуу баримталж байсан нь улсынхаа бүрэн эрх, халдашгүй байдлыг ариун дархан эрх, ашиг сонирхол хэмээн өндөрт тавьж, түүнд маш гүн итгэл, бишрэлтэй хандаж байсныг харуулна. Чингис хаан алив улс оронтой харилцахдаа Монгол улс биеэ даасан хүчирхэг улс мөн болох үүднээс харилцаж, мөн ийм улс гэдгийг хүлээн зөвшөөрч харилцан бие биедээ итгэл, хүндэтгэл үзүүлж байх зарчмыг удирдлага болгож байсан болой.

Монгол улсаас гадаад улс оронтой харилцахдаа төрийн бүрэн эрхт Элч илгээж улсыхаа сүр хүч, бодлого, саналыг ойлгуулах нь хамгийн гол хэлбэр байсан аж. Тийм учраас алив улсын тэргүүнтэй харилцах бодлого, саналаа илэрхийлэх, дайн зарлахад заавал хааны элч илгээж хариуг нь харгалзан үзэж байжээ.

Монгол улсын бүрэн эрхт байдлыг илэрхийлэн хангахдаа төрийн тэргүүн их хааныг дээдлэн биширч, түүний гарвал угсаа, нэр төрийг хүндэтгэн хамгаалахтай гүнээ холбон үзэж үүндээ шашин, ёс суртахууны зан үйлийг эрхэмлэн ашиглаж

байсан бөлгөө. “Тэнгэрээс соёрхон Чингис хааны зарлиг эргэлзээгүй” /98.34/ хэмээсэн пайзын үгс, “Мөнх тэнгэрийн ивээлээр улс орныг тохинуулж байхад үзэх нүд, сонсох чих болж яв” хэмээн Шихихутугт хандан буулгасан Чингис хааны зарлиг /51.203-р зүйл/, Чингисийг “Их хамаг олны эзэн”, “Хөх тэнгэрээс заяагаар төрсөн хүлэг богд эзэн” гэх зэргээр соёрхсон өргөмжлөл нь улсын бүрэн эрхт байдлын илэрхийлэл болсон хаан хүний халдашгүй байдал, бүрэн эрхийг баталгаажуулсан хэрэг болой. Чингис хааныг дээдлэн хүндэтгэх нь монгол улсын бүрэн эрхт байдлыг зөвшөөрч буйн илэрхийлэл, улсын иргэд хаанаа бишрэн итгэх нь бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрч буйн баталгаа хэмээн үзэж байжээ.

Ж.Вернадский “Чингис хааны их Яса /засаг/-ийн судалгаа, түүний агуулга” бүтээлдээ “Төрийн дээд эрх хаан хүнд төвлөрч, хаан цол нь төрийн дээд эрхийн баталгаа болно” /16.17/, “Чингис хаан олон улсын харилцаанд хандахдаа өөрийгөө бурхан тэнгэрээр хамгаалуулан удирдуулдаг гэж үздэг байв” /16.15/ хэмээн бичээд тавьсан шаардлага биелүүлээгүй бол юу тохиолдохыг бурхан тэнгэр зааж өгнө гэсэн итгэл, бишрэлээр авсан арга хэмжээгээ зөвтгөн үзэж байсныг тайлбарласан байдаг.

Өөрөөр хэлбэл, төрөөс /хаанаас/ авсан онцгой арга хэмжээ, түүний дотор дайн зарлах, цээрлэл үзүүлэх зэрэг үйлдлүүд ч тэнгэр бурхнаас зааж өгч буй зайлшгүй зүйл хэмээн хаант төр, эзэн хаанд итгэх нь хууль мэт хүчтэй, ёс суртахууны хувьд бишрэн хүндэтгэх учиртай байсан аж.

Улсын бүрэн эрхт байдал, хааны хэмжээгүй эрх мэдлийн илэрхийлэл нь их хаанаа сонгон өргөмжлөх, түүнд хүндэтгэл бишрэл үзүүлэхэд илэрмүй. Чингисийн хаант улсын хуулийн бүтэц, агуулгыг сэргээн тогтоосон Сайшаал “Хуралдайгаар орыг залгамжлахад эрх биш ... алтан ургийн Хуралдайгаар сонгох хэрэгтэй”, Ж.Вернадский “Хуралдайгаар шинэ хааныг сонгоход бүх анхаарлаа хандуулдаг.. Хууль ёсоор сонгогдоогүй хэн боловч өөрийгөө хаан хэмээн өргөмжилж болохгүй” /16.17/ гэж бичжээ. Монголын нууц товчоонд өгүүлснээр 1206 онд Онон мөрний эхэнд чуулсан Их Хуралдайгаар Тэмүжинийг Чингис хаан цолтойгоор монголын нэгдсэн улсын их хаанд өргөмжилсөн байдаг нь тодорхой баримт болой. Хуралдайгаар хааныг сонгодог талаар А.Жувейни, Рашид-Ад-Дин, Хэбрэус, Плано Карпини, Д.Гонгор, Ш.Нацагдорж, Ч.Далай зэрэг олон эрдэмтэд бичсэн байдаг бөлгөө. А.Жувейни хаанд өргөмжлөгдөгсөд хаан хэмээх цолыг эрхэмлэн хүндэтгэж албан бичигт гагцхүү тэр цолыг бичиж, бусдыг бол бичдэггүй журамтай байсныг тэмдэглэсэн байна.

Хааныг Их Хуралдайгаар сонгох нь улсыг жолоодож, төрийг тэргүүлэх их хааны хэмжээгүй эрх мэдэл улсын бүрэн эрхт байдлын хууль зүйн баталгаа байсан ажгуу.

Чингисийн хаант улсад их хааныг өргөмжлөн хүндлэх ёс, улс төр, зан заншлын хэм хэмжээгээр гол төлөв бэхжигдэн төрийн амьдралд сахигдаж, олон түмний итгэл

бишрэл, хүндэтгэл, соёрхолыг хүлээсэн зан үйл болон мөрдөгдсөн авай. Улсын их хаанд өргөмжлөх ёс, зан үйл, ёслолын үйлдлийн тухай 2 дугаар бүлэгт өгүүлсэн билээ.

Төрийн тэргүүн-их хааныг өргөмжлөх улс төр, зан заншлын хэм хэмжээ нь өмнөх үеийн монголын төрийн уламжлалт ёсыг өвлөн залгамжлахын хамт өөрөөсөө хойшхи үеийн төрийн ёсонд эерэг гүн нөлөө үзүүлсэн төдийгүй орчин үеийн төрийн ёсонд төрийн тэргүүнээ, төрийн өндөрлөгийн дээд албан тушаалтнаа сонгох, шинэ аргаар баяжуулан хэрэглэж болох ач холбогдолтой болмой.

Улсын бүрэн эрхт байдал, төрийн тэргүүн хааны өндөр дээд эрх төрийн хуулийг батлах, биелүүлэх зан үйлд тод илэрч байсан бөлгөө. Төрийн нэгдмэл хуультай байж, түүнийг их хаан батлан, улс орон, ард иргэд нийтээрээ хүндэтгэн биелүүлэх, эс биелүүлвээс гэмтэн болох нь улсын бүрэн эрхт байдал, туурга нэгт улс оршин тогтнохын нэгэн үндэс байсан болой. 1206 оны Их Хуралдай дээр улс орон нэгдмэл хуультай байхыг тунхаглаж, төрийн хуульч, улсын дээд заргачийн орон тоог бий болгон хааны хууль зарлигийг эмхэтгэн дэвтэрлэж, түүнийг ”ургийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” /51.180/ хэмээн тогтоосон болой. Аравны даргаас эхлээд түмтийн захирагч, шадар сайд хүртэлх бүх албан тушаалтнаас төрийн хууль зарлигийг хатуу чанд биелүүлэхийг шаардаж байжээ. Чингис хаан “Миний зарлигийг аман дээрээ даган алсдаа зөрчиж, уснаа унагасан чулуу, өвснөө гээсэн зүү мэт хөсөрдүүлэгсэд болбоос нийтийг захирч үл чадмой” хэмээн зарлиг буулгасан нь хуулийг нэг мөр ойлгон, зүрх сэтгэлээрээ чанд сахиж, тэгснээрээ төр хүчтэй байх гүн ухааны учир шалтгаантай ажгуу. Хууль цааз биелүүлэхийг шаардах төдийгүй түүний тухай тайлбарлан таниулах, учирлан зөвлөх ажлыг зориуд явуулж, харьяат иргэдээ хуулийн дагуу удирдан засах нь Монголын нэгдсэн улсын төрийн бодлогод чухал байр суурь эзэлж байжээ.

Рашид-Ад-Дин ”Судрын чуулган” хэмээх бүтээлдээ ”Түмтийн ноёд, мянгатын ноёд хийгээд зуутын ноёд он бүрийн эхэн ба эцэст хүрэлцэн ирж Чингис хааны билэгийг хичээнгүйлэн сонсоод буцваас цэрэг анги ноёлж чадна. Хэрэв орд харшдаа саатаж билэг сургаалыг эс сонсвоос цээл уснаа шидсэн чулуу, хулснаа харвасан сум мэтээр мөр сураггүй орших болой. Ийм хүн удирдагч болбоос зохихгүй” /140.355/ хэмээн бичсэн байдаг. А.В.Рязановский ”Түмт, мянгат, зуутын ноёд жилийн эхэн, адаг хоёрт хаанд бараалхаж түүнээс юу сургахыг сонсч хариад цэрэг иргэдээ захирна” хэмээн” Монголын эрх зүй” номондоо өгүүлжээ /143.16-17/.

Монголын хууль цаазын эрт эдүүгээгийн түүхд”Алив ноёд жилийн эхэн ба адагт ирж чингис хааны соёрхох сургахыг сонсч эргэж хариад цэрэг ард юугаан асарч чадна. Соёрхох сургахыг үл сонсон гэртээ суугсад бол зэгсэнд харвасан сум, усанд орхисон чулуу мэт сураггүй болно”, гэж өгүүлсэн нь бий. Янз бүрийн цаг үед янз бүрийн эрдэмтдийн бичсэн зүйлс хэлбэрийн хувьд л зөрүүтэй ч агуулгын хувьд

нэгэн адил болмой. Тухайлбал, Хаант төрөөс их хаан тэргүүлэн жил бүрийн эх, адаг хоёрт төрийн засаглах гол албан тушаалтнуудыг цугларуулан цааз, сургаал буулган, үүрэг зөвлөгөөн айлдаж тэр нь хуулийг биелүүлэхэд улс төр, хууль зүйн чухал үүрэг гүйцэтгэж байсныг илтгэн харуулна.

Чингис хаан хуулийг гуйвалтгүй биелүүлэхийг шаардан түүнийг найдвартай хамгаалахыг зарлиглаж байсан нь өөрийн үед ч, залгажлагчдынх нь үед ч хэрэгжиж байсаныг тэмдэглэвэл зохилтой. Жишээлбээс Италийн жуулчин Марко Поло “монголчууд хааныхаа” зарлиг “тушаалыг ертөнцөд хосгүй сайн дагаж гүйцэтгэдэг” /48.72/ гэж тэмдэглэсэн байдаг. Ибн Батутыгийн тэмдэглэсэнээр Чингисийн залгажлагчид Чингисийн цусны биш ноёдоос дурдсан хугацаанд их засгийг зөрчсөн эсэхийг мэдэхээр дээд албаны хүмүүстэй жил бүр цуглаж хэлэлцэн ямар нэг ноёны гэм буруутай байдал илэрвэл албан тушаалаас нь халж байсныг Ж.Вернадский бичсэн байдаг /16.31/. Монголын нэгдсэн улсад нийт хүн ам аль нэг аравт, зуут, мянгат, түмтэд харьяалагдан аж төрж амьдрах иргэдийн харьяаллын тогтолцоог бий болгож хуулиар бэхжүүлсэн ажгуу. Энэ тухай хуулийн тодорхой заалтууд байсаныг өгүүлсэн бүтээлүүд бий.

А.Жувейни “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” номонд “Хүн ард харьяалагдан бүхий зуут, мянгат, аравтдаа байваас зохимой. Бусад нэгжид шилжиж үл болно. Өөр газарт очоод өмчлөгдөн хоргодож үл болно. Энэ зарчмыг зөрчин шилжигсэдийг цэрэг, ардын өмнө цаазаар автугай” /60.128/ хэмээн бичсэн байдаг. Мөн ийм утгатай зүйлийг Япон, эртнээс хятад улсын эрдэмтэд бичсэн нь бий. Харьяаллын ийм тогтолцоо нь улсын иргэдийг засах, цэрэг, иргэний амьдралыг явуулах зохион байгуулалтыг хангаж байжээ. Үүний үндсэн дээр цэрэгт татах, цэргийг зохион байгуулах, байлдах ажиллагаа явуулах, цэргийн хэрэглэл, морь, унаа, хоол хүнс дайчлан гаргуулах, алба авах, авд явах, нүүдэл суудал хийх, байгалийн бэрхшээлээс гарах зэрэг ажил хэрэг зохион байгуулагдан явагдаж байжээ.

Улс, иргэнийг засах дотоод нарийн дэг журмыг хуулиар тогтоосон нь хаан “Их засаг” хуулийн агуулгын нэгэн онцлог, гол чиглэл болой.

Түмт, мянгат, зуут, аравтын захирагчийн тушаал, шийдвэрийг харьяат иргэд нь заавал биелүүлэх үүрэгтэй. Гэхдээ ийнхүү тушаал, шийдвэр гаргах нь жинхэнэ үнэнд нийцсэн бодитой байх үндэслэлийг хуулиар тогтоожээ. Тушаал буулгахад заавал гурван хүн нотолсон байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, гурван хүн адил нотолгоо гаргасан нөхцөлд тушаалаа буулгаж байхыг хуулиар тогтоосон байна. Энэ тухай Сайшаал “Зарлиг захиа буулгахад заавал гурван хүний хэлсэн нь адил байх хэрэгтэй. Тийм болвоос сая биелүүлж болно. 3 хүн хэмээхийн нэгэнд нь өөрийн бие тооцогдмой. Өөрийнхийг бусдын хэлсэн лүгээ ялангуяа мэргэдийн яриа лугаа адилтгах хэрэгтэй. Эс тэгвээс зарлиг буулгаж үл болно” гэж хуульд заасныг тэмдэглэжээ.

Л.Дэндэв “Их засаг”-ийн нэгэн зүйлд “Гурван хүн ам авалцан зөвшөөрсөн хэргийг хаана ч өгүүлж болмой. Тийм бус бол батлан итгэж болохгүй”, “Өөрийн ба бусдын үгсийг учир мэдэх хүмүүсийн үг лүгээ харьцуулан үз. Хэрэв нийлбэл бусдад хэлж болно. Эс нийлбэл хэлж болохгүй” хэмээн заасан гэж бичсэн бөлгөө.

Дотоод засаглалын журамд татвар, өртөөний тухай хуулийн заалт томоохон байр эзэлнэ. Чингисийн хаант улсын засаг захиргааны зардалд татварын тогтвортой систем тогтоох шаардлага гарсан нь зүйн хэрэг. Тийм учраас Монголын нэгдсэн улсын хуульд татварын талаар нэлээд боловсронгуй журам тогтоосон аж.

А.Жувейни “Монголын эзэмшилд улс орнууд, хүн амыг нэгтгэсний дараа тооллого явуулж, аравт, зуут, мянгатаар бүлэглэн зэвсэгт хүчнээ өөрчлөн байгуулдаг байв. Мөнгөөр тооцохгүй өртөө шуудангийн татвар, алба болон мал, цэргийн хүнсэн татварыг тусгай журмаар тогтоов”, Бар Хэбрэус “Монголын бүх үндэстнүүд жил бүр хонь, үхэр, үнэт эрдэнэ, агт морьд, цагаан идээ, бөс бараатайгаа ирж ноёддоо хандив өргөнө” гэж бичснийг Ж.Вернадский “Чингисийн хааны их Яса /засаг/-ийн судалгаа, түүний агуулга” бүтээлдээ тэмдэглэжээ /16.25/. Албан татвар нь эзэлсэн орны ард иргэдээс хураах татвар, өөрийн харъяат иргэдээс хураах татвар хэмээн хуваагдаж байв. Монголын нууц товчоон дахь баримтаас үзэхэд Тангуд улсын хаан Хашин “Хамаг Тайчууд улс өндөр дэрсний нөмөрт өсгөсөн олон тэмээгээ өргөл болгон тусалъя. Өөрийн гараар нэхсэн өрмөг бөс эдээ бэлэг болгон өгье” /51.222/ хэмээн өчсөн нь бий. Бас “Тангуд иргэнээс тэмээ татварлан тууж барагдахгүй олон тэмээ авчирч өгөв” /51.222/ гэж өгүүлсэн байдаг. Цэрэг татах үед цэргийн хэрэглэх унаа, хоол, хүнс, хэрэглэгдэхүүнийг тухайн аравт, зуут, мянгатаас татварлан гаргуулдаг журмыг хуулиар тогтоосон болой. Монголын нууц товчоонд тэмдэглэгдэн үлдсэн заалтаас үзэхэд Чингис хаан хишигтэн цэргийг бүрдүүлэх журмыг тогтоосны дотор миний шадар цэрэг “хэрэглэх юмаа харъяат мянганы дотроос татан авагтун”, “уг газраасаа уналга морь бэлтгэж иртүгэй” /51.196/ хэмээн зарлигласан нь ёсчлон биелэгдэж хишигтэн цэрэг эмхлэн байгуулагдсан болой.

Их засагт”... хэн нэгэн цэрэгт юу дутагдвал даруй нийлүүлэн өгтүгэй” /27.12/ гэсэн заалт байсныг ”Монголын хууль цаазын эрт эдүгээгийн түүх” номонд өгүүлсэн байдаг. А.Жувейни “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх” номондоо “Хэзээ ч гэсэн хамаагүй дайсантай тулалдах буюу урвагчийг дарах үүрэг бууж ирвэл 18 зэвсгээс туг, далбаа, зүү, хадаас, татлага, дээс, морь, унаа, хийгээд илжиг, тэмээ зэрэг хүлэмжид хэрэглэх юмыг тэднүүсээс татварлан авна. Хүн бүр харьяалагдан бүхий аравт буюу зуугаас хуваарилан даатгасан хувь юугаан хангаж өгөх ёстой” хэмээн бичснийг Өвөр монголын эрдэмтэн Намжил “Чингис хааны засаг ба билэг” бүтээлдээ дурджээ /60.129/.

“Чингис хаан зарлиг буулган бадарчин, заргач, эмч, эрдэмтэн, лам санваартан, даяанч, шарил ариутгагч нарыг татвараас чөлөөлж байжээ.

Жорж Вернадский ”Хүн амын давхаргын тодорхой бүлэг хүмүүс татвараас чөлөөлөгдөж байв. Тийм хүмүүсийг шашны чиглэлээр сүм хийдэд холбоотойгоор нь, мөн зохион бүтээгч, төмрийн дархчууд, гар урчууд зэрэг татвараас чөлөөлөгдөх хүмүүсийг өөрийн нь үнэт зүйлээр баталгаажуулдаг байжээ” /16.19/ гэж бичсэн нь бий. Сайшаал шашны хэргэмтэн, шавь, эмч сурагчаас бусад ард иргэн гааль, гувчуур тушаах үүрэгтэй байсныг дурдсан байдаг. Мөн Чингис хааны үед цэргийн алба, өртөөний алба болон энгийн гааль гувчуур хэмээх татвар авч байсан тухай В.А.Рязановскийн бүтээлд тэмдэглэгдснийг өгүүлсэн байна. Энэ бүхнээс үзэхэд албан татварын бодлого түүний төрөл хэлбэр хэмжээ хууль цаазад өөрийн зохих байр суурь эзэлж байсан нь илт байна. Татварыг мөнгөн хэлбэрээр авах журам байгаагүй ч эд хөрөнгө, мал уналга хүнсэн бүтээгдэхүүнээр ба биеэр авах журам тогтон хэрэгжиж байжээ. Өртөөний алба бол ард иргэдийн эд хөрөнгө, мал, бүтээгдэхүүнээ нийлүүлэн биеэр ажиллах явдлыг хосолсон өвөрмөц алба бөлгөө. Өртөөний алба нь Монголчуудын нүүдэлчин маягийн амьдрал, хүн амын тоо, байршил, аж байдал, газар нутгийн өргөн уудам байдал, эрхлэх аж ахуй, нэгдсэн төрийн бодлого зэргийг тусгасан өвөрмөц онцлогтой. Зориулалтын хувьд мэдээ шуудан хүргэх, төр, цэргийн элч төлөөлөгч зорчин явагчдад уналга, орон байр, хоол хүнс, хүн хүчээр үйлчлэхэд чиглэгдэж байжээ. Өртөөний албаны талаар Сайшаалын “Чингис хааны товчоон” бүтээлд дурдсанчлан нилээд тодорхой заалт Чингисийн хаант улсын хууль цаазад хуульчлан бэхжигдсэн ажгуу. Уг бүтээлийн “Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль товчоон” хэмээх бүлгийн “Зам нэвтрэх ба өртөөний хууль” гэсэн хэсгийн 41-р зурваст “Өртөө бүрд нэвтрэх зохих тооны хүн, унаа, жич идэш, зууш зэрэг хэрэглэх зүйл ба зардал хангалт зэргийг нь тохируулж хуваадаг. Тухайлбал, нэгэн замын өртөө нь хоёр түмнээс хангагдана. Түмэн нь мөн өрх бүрээс алба татварлана. Энэхүү өртөөгөө жил бүр байгуулж, дутах зүйлийг нь эргэж нөхдөг байчухуй. 42-р зурваст “Өртөө бүгдэд сар бүр түшмэл ирж нэг удаа цагдана.

Тэдний захиран хамаарч буй байдлыг байцаан үзэж аливаа алба чимгийг хаагдуулсныг залгуулан ялламой” хэмээн өгүүлжээ. Дээрх баримтуудаас үзэхүл өртөөний алба нь хүн амаас өөрийн эд хөрөнгө, мал, хоол хүнсээ гарган, биеэрээ ажиллан үйлчилж хаадаг алба болон үүсэж, төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэх болсон ажгуу. Албан хүчээр ажил хийлгүүлэх нь зөвхөн өртөө төдийгүй өөр бусад хэлбэртэй ч байжээ. Монголын цэргүүд аян дайнаас буцаж ирээд өөрийн ноёддоо зарим төрлийн ажлыг хийж өгөх үүрэгтэй байсныг Ж.Вернадский тэмдэглэсэн байна. Цэргийн алба хаах нь Чингисийн улсын төрийн нэгэн гол алба байжээ.

Эр хүмүүн бүхэн цэргийн алба хаах үүрэгтэйг хаант улсын хуулиар бэхжүүлсэн болой. Тухайлбал, ”Эр хүмүүс 20 нас хүрвээс цөм цэргийн алба хаах үүрэгтэй”/58.13/ ”Эрэгтэйчүүд байлдан одохуйд эрчүүдийн хийх ажлыг бүтээх үүргийг эмэгтэйчүүд хүлээсүгэй” /58.12/ гэх зэргээр хуульд заажээ. Сайшаалын бичсэнээр 15-60 насны эрчүүд цэргийн алба хаах үүрэгтэй байсан ажгуу.

Албан татвар, цэрэг, өртөөний албаны тухай Чингисийн бодлого түүнийг залгамжлагчдын үед улам гүнзгийрэн боловсорч хөгжсөн бөлгөө.

Цэргийн үйл ажиллагааны тухай хууль эрх зүйн тогтолцоонд томоохон байр суурь эзэлнэ. Цэргийн зохион байгуулалтаас гадна цэргийн сахилга, цэргийн сургууль, аян байлдаан явуулах журам, байлдаанд оролцох горим, цэрэг хүний эрх, үүрэг, цэргийн хангамж, үйлчилгээний тухай заасан хуулийн заалтууд нэлээд өргөн томъёологджээ. Энэ нь цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагааны тухай журмыг хуулиар тогтоон мөрдүүлэх шаардлага хаант улсын төрийн бодлого, цэргийн аян дайны явц сургамжаас үүдэн хурцаар тавигдсантай холбоотой.

Цэргийн үйл ажиллагааны тухай хуулийг хааны хишигтэн цэргийн ба их цэргийн үйл ажиллагааны тухай цааз хэмээн хоёр хэсэгт хувааж болмой.

Бидний хийсэн судалгаанаас үзэхэд хишигтэн цэргийн үйл ажиллагааны тухай заалт цэргийн хуулийн дотор тодорхойлогч рольтой байсан нь харагдаж байна. Тийм учраас хишигтэн цэргийн тухай хууль нэлээд дэлгэрэнгүй байдлаараа ”Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдэн үлджээ.

“Монголын нууц товчоо”-нд байгаа хишигтэн цэргийн үйл ажиллагааны тухай заалтуудын агуулгыг нэгтгэн дүгнэж хэлвээс: хааны өргөөний өдрийн хамгаалалт, үйлчилгээг хорчин торгууд, буурчид, шөнийн хамгаалалтын үүргийг хэвтүүлүүд хариуцан гүйцэтгэнэ. Хорчин, торгууд, буурч нар шингэх үес хэвтүүлд ээлжээ өгөөд ордны хүрээнээс гарч тус тусын байранд хоноод өглөө ордныхон цайгаа уумагц хэвтүүлд мэдэгдэн орж ирэн өдрийн ажлын үүргээ гүйцэтгэнэ. Хишигтэн цэргүүд 4 ээлжээр ажиллана. Нар шингэсний хойно ордны хойгуур, урдуур хэн хүн явж үл болно. Хэрэв хүн явбал хэвтүүл түүнийг барьж хонон өглөө нь байцаана.

Ордонд орохыг завдвал хэвтүүлүүд түүнийг мөрийг мөлт цохиж, толгойг нь цавчих эрхтэй. Хэн хүн хэвтүүлийн тоог асууж болохгүй. Асуусан хүн гарвал унасан морь, тохсон эмээл, хэрэглэсэн хазаар, өмссөн хувцсаа хэвтүүлд өгнө. Хишигтэн цэрэг ээлжээ таслахыг хатуу хориглоно. Хэрэв ээлжээ тасалвал цэргээс халж цөлөх хүртэл дэс дараалсан арга хэмжээ авна. Хишигтэн ээлжээ гүйцэтгэж байгаа үедээ юуны ч нөлөөнд авталгүйгээр зөвхөн үүрэг биелүүлэх үүрэгтэй. Цэргийн тухай заалтын дотор цэргийг захирах, цэргийн аян дайнд явах журам, цэрэг ба цэргийн захирагчдын хоорондын харьцааны тухай зүйлүүд өвөрмөц байр эзэлж байсан аж.

Аравт, зуут, мянгат, түмтийн ноёд бүхэн өөрсдийн цэргийг ямагт эмх журамтай, дайнд мордох бэлтгэлтэй байлгах үүрэгтэй. Дээдсийн зарлиг буумагц өдөр шөнө ялгалгүйгээр даруй цэргээ авч болзсон цаг газарт бэлэн байна. Цэргийн ноёд аян замд нарийн тооцоотой явж цэргүүдийг өлсгөж цангаахгүй, адуу малыг тураалгүйгээр цэргээ захиран удирдана. Цэргийн ба заншлын хэм хэмжээний агуулгаас үзэхэд цэргийн сахилга, ур чадварын үндэс нь бүр өрх бүлд буй хүүхэд ахуй цагаас эхэлж байсан нь илт байна. Багачууд хүүхдийг 5-6 настайгаас нь морь унаж, нум сум хийн харваж, хулгана зурам намнаж чаддаг, тэсвэр тэвчээртэй, зориг хатуужилтай болгон бэлтгэх үүргийг өрх гэр, эцэг эх хүлээж, аравтын ноёд зохицуулан хянаж байжээ.

Цэргийн сургууль хийж тэсвэр тэвчээр суулгах, байлдах ур чадвар эзэмшүүлэх чухал арга бол их ав зохион байгуулах явдал гэж их хаан ба цэргийн жанжнууд санал нэгтэй үзэж байжээ. Их хаан ав хийх журмыг хуулиар зохицуулж байв. Их хаан ав хийх хугацааг өвлийн эхээр тогтоож хуарангын цэргийн ангиудаар авын бэлтгэл хийлгэж улмаар баруун зүүн голын цэргийг жагсаан байршуулж ерөнхий захирагч удирдана. Тэгээд 2-3 сарын турш их хүрээний зохион байгуулалтаар явж, аажмаар хүрээгээ хумин өмнөх ан араатнаа бүслэх, үргээх, хөөх, харвах, цавчих зэргээр дотогш шахаж тэр явцад зориг тэвчээр, өндөр ур ухаан суулгах ажиллагаа явуулна. Шилдэг сайныг нь тогтоон сайшааж, хянамгай бус байдал гаргах, зөрчил үйлдэх аваас буруушаан, алдаа гаргавал зэмлэн шийтгэж байх журмыг хуулиар тогтоожээ. Авын журмын тухай нилээд тодорхой мэдээг Жувейни, Мирхаунд, Ж.Вернадский нар тэмдэглэсэн мэдээ анхдагч ач холбогдолтой болой. Ж.Вернадский бичсэнээр “Чингис хаан ан авыг цэргийн хамгийн шилдэг сургууль гэж үзэж байлаа /16.22/.

Цэрэг захирагч ноёд аян дайнд мордохоос өмнө цэрэг бүрийн зэр зэвсэг, замд хэрэглэх зүйлс зүү, утас, зэрэг бүхий л бэлтгэлийг шалган зааварлаж байх үүрэгтэй.

Цэргүүд цэргийн сахилгыг чанд сахих үүрэгтэй. Цэргийн ноёдын тушаалыг цэрэг бүхэн үг дуугүй биелүүлэх, цэрэг нь нэг газраас нөгөөд зөвшөөрөлгүй нүүж үл болно. Аян байлдаан, ан авын талбараас цэрэг хүн дур мэдэн явж болохгүй.

Аравтаас цэрэг нь оргосон байвал арваны даргыг шийтгэнэ хэмээн “Их засаг” хуульд заасан байна. Байлдааны үйл ажиллагааны журмын тухай заалтууд цэргийн тухай хуулийн агуулгын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болой. Цэрэг хүн байлдааны явцад эр зориг, хатуужил тэсвэртэй байж, чадварлаг овсгоотойгоор тулалдан тэмцэлдэх үүрэгтэй. Байлдааны талбар дээр шархдагсдаа орхиж болохгүй. Байлдан явагсад цэргийн тугийг буухаас өмнө байлдааны талбараас явж үл болно. Хэрэв дайлагдан ухарвал эхний довтолсон байрандаа буцаж ирэх үүрэгтэй. Дайсны цэргийг гүйцэд ялахаас өмнө олз ашиг хайж болохгүй. Байлдааны явцад нум сум, ачаа, боодол, уналага хөсгөө унагавал дагалдан явагсад нь мориноосоо бууж уг зүйлийг авч өгөх үүрэгтэй.

Байлдааны талбар дээр цэргийн уналга, эд юмс, олз ашгийг хулгайлж болохгүй. Дайн дууссан хойно олзоо хуваавал зохино. Дур мэдэн олзны юмсыг шатаах, олзлогсдыг дэврээн зүй бусаар харьцах, тонон дээрэмдэх, алах, хүчирхийлэх явдал гаргаж болохгүй гэх зэргээр хуульчлан заасан байдаг бөлгөө.

Цэргийн үйл ажиллагааны тухай хууль нь цэргийн сахилгыг нарийн болгон, үүрэг, хариуцлагыг нь чандлан тэгшилж, цэрэг эрсийн эр зориг, тэсвэр хатуужлыг тогтоон төлөвшүүлэхэд чиглэгдсэн байна. Цэргийн үйл ажиллагааны тухай хууль нь цэрэг, цэргийн захиргааны хууль цаазны үндэс болж, цэрэг армиас хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Иймээс ”Чингис хааны эзэнт улсын үүсэн тогтсон гол нөхцөл нь түүний хууль цаазад цэрэг, цэргийн захиргаа маш чухал үүрэг гүйцэтгэж байсан явдал болно. Цэргийн засаг захиргааны гол ноён нуруу нь болжээ /16.20-21/.

Монголын нэгдсэн улсын хууль цаазын агуулгын нэгэн гол чиглэл нь аж ахуй, иргэн, аж байдлын шинжтэй заалтуудад илрэлээ олж байсан ажгуу.

Монголчуудын амь зуух гол аж ахуй нь бэлчээрийг шүтдэг мал аж ахуй байсан учир түүнийг маллах, арчлах, хамгаалах, ашиглах, эзэмшихтэй холбогдсон төрийн бодлого, зохицуулалт хууль цаазад нилээд тодорхой тусгагдсан болой. Мал маллах арга ажиллагаа олон зуун жилийн өмнөөс уламжлан өвлөсөн заншил, аж ахуйн хэм хэмжээний үндсэн дээр явагдаж байсан нь тодорхой. Малыг жилийн дөрвөн улирлын байдалд нийцүүлэн ”Хаваржаа”, ”Намаржаа”, ”Өвөлжөө”, ”Зуслан” хэмээн хэлбэршсэн ус ургамлын ашиг шимтэйг даган сэлгэн нүүдлэх хэлбэрээр маллаж байжээ. Бэлчээрийг өдөр тутамд хуваарилан малаа идээшлүүлэх, хариулах, малд тарга хүч авахуулах, услах, хужирлах, ноослох, өвчнийг нь эмчлэх, тэжээх, нүүдэл суурьшил хийх, байгалийн үзэгдлээс хамгаалах ажиллагаа заншлын хэм хэмжээний үндсэн дээр явагдаж байсан агаад түүний агуулга нь маш өргөн олон талтай байсан бөлгөө. Мал маллах арга ажиллагаанаас гадна малын ашиг шимийг ашиглах хэмээх өргөн ойлголтын хүрээнд малын ноос үс, хялгасыг авах, ашиглах, мах, арьс, шир, сүүг хэрэглэх, түүгээр хүнсний зүйл /аарц, ааруул, тос, бяслаг, тараг, айраг, борц гэх мэт/ хийх, гэр ахуйн зүйлс /эсгий гэрийн бүрээс, ширдэг, дэвсгэр, гутал гэх зэрэг/, хүний хувцас хунар /дээл, өмд, дах,дэгтий, гутал гэх зэрэг/ хийж гэрийн шинжтэй үйлдвэрлэл явуулах, гэдгээрийн технологийг сурах, эзэмших, үйл ажиллагаа мөн л зан заншлын хэм хэмжээний үндсэн дээр явагдаж байсан ажээ.

Монголчуудын амьдрах арга болсон эдгээр чиглэл нь өөр хоорондоо салшгүй холбоотойгоор нэг талаас аж төрөх хэрэгсэл, нөгөө талаас амьдрах орчин ахуй болж жил, улирал бүр тасралтгүй явагдаж байснаараа онцлог юм. Энэ нь төрийн бодлого, үйл ажиллагаанаас гадна бус, харин түүний ивээл хүрээнд явагдаж байсан боловч эдгээр

зан үйлийн ихэнх нь олон үеийн турш улам бүр сайжирсаар зайлшгүй мөрдөгдөх хэм хэмжээ болсны учир тухайн төрийн хуулиар бэхжүүлэх шаардлаггүй байсан хэмээн хэлж болох таатай бөлгөө. Гэвч үүний хамт мал аж ахуйн талаар Чингисийн “Их засаг” хуульд тусгагдсан бидний үед уламжлагдан үлдсэн заалтууд байгааг дурдах нь зүйтэй. Монголын таван хошуу мал сүргийн дотроос хонь, ямаа, үхэр, тэмээн сүрэг иргэдийн өдөр тутмын хэрэгцээг хангаж хоол хүнс, сааль сүү, ачлага уналгын голдуу үүрэг гүйцэтгэж байсан бол адуун сүрэг, ялангуяа агт морьд цэргийн гол уналга, өртөө шуудан, зам харилцааны үндсэн хүч болж байсан аж. Үүнтэй холбоотойгоор дайн байлдаанд унаж байсан агт морьдыг ус бэлчээрт тавин таргалуулж уналгад хэрэглэхгүй байх, морины толгой, нүдийг занчиж цохиж үл болох, морьдыг хулгайлахыг хатуу цээрлэхийг хуулиар тогтоосон ажгуу. Мөн хонин сүргийг арчлан хамгаалахад ч анхаарал тавьж байсныг харуулах хууль зүйн баримт байна. Хонь хулгайлахыг цаазлан хориглож байжээ. Бог малыг гаргаж /алж/ хоолонд бэлтгэхдээ зөвхөн өрцлөн голыг нь таслан алж байхаар хуульчилсан болой.

Монголчууд мал сүргээ эрхлэн маллаж аж төрөхдөө малынхаа бэлчээр нутаг, газар шороо, ургамал амьтадтай зүй зохистой харьцаж, аль болох ая зүйтэй ашиглах, хамгаалах явдлыг төрийн хуулийн бодлого болгон явуулж байжээ.

Монголын бүх газар нутгийг эзэн хааны /төрийн/ өмч хэмээн үзэхдээ монгол улсын тусгаар тогтнолын нэгэн үндсэн агуулга, түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах төрийн бодлого, нийт иргэдийн хүсэл зориг, шашин, ёс суртахуунтай нягт холбож байсан нь илт байна. Бүх газар шороо, уул, ус, тэнгэр эрхэс, өвс, ургамалаа эрхэмлэн дээдэлж хамгаалах, зохистой ашиглах нь бурханаас заяатай агаад төрийн их хаанд бурхан тэнгэрээс олгосон ариун үйлс болно хэмээн үзэж байжээ. Ийм учраас энэ талаарх хуулийн заалтууд нь шашин, ёс суртахууны ба заншлын шинжийг үлэмж хэмжээгээр агуулж байснаараа онцлог. Мөн газар нутаг хэмээхийг түүн дээр оршин амьдардаг айл өрх, хүн ам, ургамал, амьтадтай нь хамтатган ойлгож байсан нь нүүдэлчин маягийн амьдралын онцлогтой холбоотой.

Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн хууль зүйн шинжтэй баримтаас үзэхэд газар нутгийг гурван үндсэн хэлбэрээр эзэмшүүлэн ашиглаж байжээ. Чингис хаан улсын заргач Шихихутугт “бидний ба дүү нар, хөвгүүдэд эсгий туургатны дотроос эзлэх хувийг олгож, хавтсан үүдэтний дотроос харьяалах ардыг хувааж өг”/51.180/, “нийт улсын өмчийг хувааж заргыг шийтгэ” /51.180/ хэмээн зарлиг буулгасны дагуу Өүлэн эх, бага дүү Отчигин, Зүчи, Цагаадай, Өгөөдэй, Тулуй, дүү Хасар, Ачидай, Бэлгүүтэй тодорхой өрх иргэнийг /51.210-211/ нутаг усны нь хамт соёрхон өгч эзэмшүүлжээ. Чингис хааны зарлигаар мянгат бүхэнд газар нутаг хуваарилан хэрхэн эзэмших, захицуулах эрхийг мянгатын ноёнд олгосон байна. Мөн Сорхон

Шар, Хорчи ноён зэрэг үнэнч зүтгэж үйлс бүтээсэн ноёдод газар нутаг, өрх иргэнийг зарлиглан эзэмшүүлжээ. Ийнхүү газар нутаг, өрх иргэнийг эзэмшүүлсэн нь нэг талаас дундад зууны үед хамжилгын систем тогтохуйн илрэл байсан боловч нөгөө талаас суурьшмал оронд газрыг сонгодог хэлбэрээр эзэмшүүлдэг нь нүүдлийн иргэншилт улс оронд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байхын илэрхийлэл байсан болой. Чингис мянгатын ба Чингисийн эх, дүү, хүүхэд, ноёд дээдэст хуваарилагдан очсон өрх иргэд, өөрийн дураар нутаг усаа, эзэн ноёноо орхин явах эрхгүйг хуульчлан тогтоосон юм. Ийм байдлаар Чингис хааны хуулиар монголын онцлогт нийцсэн газар эзэмшлийн тогтолцоог бий болгосон байна. Чингэхдээ өмнө өгүүлсэнчлэн монгол дахь газар эзэмшил нь өөрийнхөө жинхэнэ агуулгаар нутгийг бэлчээрийн хэлбэрээр нийтээр эдэлж, нутагласан нутаг бүхэндээ түүн дээр байдаг уул, ус, ургамал, амьтадыг дээдлэн ашиглах, хамгаалах, ёс заншлыг хэвшүүлэх, хуулиар баталгаажуулах нь төрийн хууль цаазын бэлчээрийг онцгой эрхэмлэж, бэлчээрийн тухай тусгай хуультай байхад хүргэсэн ажаамуй.

Бэлчээрийг эвдэх, ногоорсон хойно нь газрыг нүхлэх /ургах, үржих, үр, үндсийг нь таслах, хөрсийг нь эвдлэхээс хамгаалах зорилготой/, гал алдаж бэлчээрийг шатаах, гол, булгийн усанд биеэрээ орох, хувцсаа угаах, ахуйн усанд гараа дүрэхийг хуулиар хоргилсон нь газар усаа дээдлэн бишрэх, хамгаалан ариун байлгах зорилготой байсан ажгуу.

Газар шороо, бэлчээр, ой мод, ан амьтандаа ийнхүү хандан харьцаж ирсэн монголчуудын зан заншлын хийгээд хууль цаазны хэм хэмжээг орчин цагийн эрх зүйн болон төрийн онолын асуудалтай уялдуулан дагнасан суурь судалгааг хуульч эрдэмтэн О.Амархүү нэлээд ул үндэстэй судалж, зохих дүгнэлтүүд хийсэн “Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз /Уламжлал, шинэчлэлийн асуудал/” бүтээл туурвисан нь хууль зүйн шинжлэх ухааны тэр дотроо байгаль орчны эрх зүйн түүхэн хөгжилд дорвитой хувь нэмэр болсон билээ.

Петис де Крейкс “эртний монгол, түүний зэргэлдээ орнуудын сударт бичсэнээр тэнгэрийн дуу цахилгаан нь монголчуудад үргэлж гамшиг тарьдагаас тэнгэрийн дуу сонсмогцоо гол, цөөрөм рүү үсрэн орж живдэг учир тэд дуу, цахилгаантай борооноос айдаг, Тэмүүжин энэ ер бусын аюулаас болж юугаар ч сольж болшгүй хамгийн шилдэг цэргүүдээ алдаж байсан учраас ямар нэгэн шалтгаар усанд орох, хувцсаа угаах гэсэн хэнийг ч болов хатуу шийтгэхээр зааж тэнгэрийн дуу цахилгаантай үед урсгал усанд хувцсаа угаахыг хориглож байв” хэмээн бичсэнийг хэд хэдэн бүтээлд иш татан тайлбарласан байдаг нь /16.24/ Монголын тухайн үеийн түүхэн уламжлал, зан заншил, хууль тогтоосон бодит байдалд төдий л нийцмээр үндэслэл биш юм. Харин монголчууд дуу цахилгаантай бороотой харьцах, түүнийг бишрэн хүндэтгэх мөртлөө

түүнээс ба цахилгаан, аянга буух үзэгдлээс бие хүн, мал хөрөнгө, гэр орноо хамгаалах арга ухааныг бүр эртнээс сурч эзэмшсэн уламжлалтай бөлгөө.

Монголчууд мал сүргээ маллан, газар, ус, өвс ургамлаа шүтэн амьдрахдаа өөрсдийн амьдралын байнгын нэгэн орчин болох ан амьтдыг ашиглах, хамгаалах харилцааг заншлын ба төрийн хуулийн хэм хэмжээгээр зохицуулахад хаант төр анхаарал тавьж, зохих түвшинд хуулиар бэхжүүлж байжээ.

Ан амьтанг бишрэн хайрлан хамгаалах, ан авыг амьдрах, аж төрөх хэрэгсэл болгон ашиглах нь монголчуудын хувьд нэн эртнээс уламжлалтай юм. Ан амьтны амгалан тайван байдлыг алдагдуулж үргээх, хөөх, утга учиргүй алах хөнөөхийг ихэд цээрлэх, хүн байгальд нөлөөлөх байдлаар нь амьтан бүхэнд ялгавартай хандах, бишрэх, шүтэх, ан агнахад эрхэс тэнгэр, нутаг, уул усандаа хүндэтгэл үзүүлж нигүүлсэнгүй сүсэг, зан үйл нэвтрүүлэх зэрэг нь эртнээс өвлөсөн заншлын хэм хэмжээний үндсэн дээр явагдаж байв. Анд явах, ирэхдээ ямар зан үйл гүйцэтгэх, яаж ямар аргаар агнах, хэрхэн төхөөрөх, өвчих, мөчлөх, дээш өргөх, чанах, айл хөршид амсуулах, хуваах, зооглох мэт үйлдэл бүр өөрийн горим, зан үйлтэй байжээ.

Ангийн мах, арьс, үсийг хэрхэн ашиглах нь ч нарийн ёс дэгтэй. Тэдгээрийн гол агуулга нь анг үс, мах гүйцсэн ашигтай үед нь агнах, үр төлөө гаргаж буй үед агнахыг цээрлэх, үржлийн ба төлөөрөө байгаа анг агнахгүй байх, анг үржүүлэх, хамгаалахад чиглэж иржээ. Ан амьтныг агнах, гөрөөс, тарвага, гахай гэх мэтийг хүнс, хувцас хунар, гэр ахуйдаа хэрэглэж байсан нь мал аж ахуйтай харьцуулбал туслах, дагалдах шинжтэй байжээ. Иймээс хувиараа ан агнах нь голдуу заншлын зан үйлд тулгуурлан байв. Харин ав хийх, түүнд оролцох нь төрөөс тогтоосон журмаар зохицуулагдаж байсан бөгөөд түүний тухай өмнө өгүүлсэн билээ. Иргэдийн хоорондын харилцааг зохицуулсан шинжтэй цаазууд хаант улсын хууль цаазад мэдрэгдэхүйц байр суурь эзэлж өөрийн гэсэн онцлог шинжтэй байсан нь судалгааны дүнгээс харагднам.

Энэ нь юуны өмнө болзох, анд бололцох, гэрээслэл тавих, өв өвлөх, арилжаа худалдаа хийх, гэр бүл бололцох, бие биедээ тусламж дэмжлэг үзүүлэх, иргэд хоорондын маргаан мэтгэлцээнийг шийдвэрлэх зэрэгт илэрч байжээ.

Монголын нууц товчоонд буй баримтаас үзэхэд /51.96,108,116,117-р зүйл/ Есүхэй ба Тоорил, Тэмүжин, Жамуха нар болзоо тавьж, анд бололцсон мэдээлэл үлдсэн нь иргэний цаазын агуулгатай болно. Учир нь анд бололцох ба болзоо тавихад хоёр тал тодорхой үүрэг хүлээж, тангараглан нотлох, анд бололцсоноо илэрхийлсэн эд мөрийн зүйл солилцох журам бүхий байжээ. Тухайлбал Тэмүжин, Жамуха хоёр анд бололцохдоо эхний удаад Тэмүжин нь цутгамал шагай ба арц модон годил /болцуу/-ыг Жамухад өгөөд оронд нь Жамуха гурын шагай ба бярууны хоёр эврийг нааж хийсэн дуут сумыг Тэмүжинд өгч бэлэгдсэн /51.70/.

Эрийн цээнд хүрч эрэлхэг эрс болсныхоо дараа”Аливаа хүн харилцан анд нөхөр бололцвол амь биедээ арч болж аль алиндаа түшиг болж, амраглан ханилах ёстой” хэмээн анд бололцохын үүрэг, учир утгыг илэрхийлэн нотлоод Тэмүжин нь Жамухад алтан бүсээ бүслүүлж, эвэрт ишгэн цагаан морио унуулан анд болохоо баталцгаан найр хийж нэгэн хөнжилд хамтдаа хоносон байна. Энэ тухай Монголын нууц товчоонд ”Хорхунаг Жибурын хөндийд Хулдгар хуны өвөрт Саглагар модны дор сайхан хурим үйлдэж сайтар бүжиглэн жаргаж, санаа сэтгэл нэгдэж сайн нөхөд болоод шөнө нь нэг хөнжилд хонох бөлгөө” /51.71/ хэмээн бичсэн нь бий болой. Болзоо тавихад хоёр талын аль аль нь хатуу үүрэг хүлээж, түүнээ харилцан тангарагладаг ёсон байсан нь басхүү хууль зүйн агуулгатай асан ажгуу. Энэ нь болзоогоо зөрчиж, тангарагаа няцваас нөгөө тал нь торгууль оногдуулж шийтгэдэг байснаар илэрч байна.

Энэ тухай Монголын нууц товчоонд Жамух болзоо тавьсан Тэмүжин, Тоорил нарт хандаж”Бороо тохиолдовч болзооноос хождохгүй, хур тохиолдовч хурлаас саатахгүй гэж монгол үгээр хэлэлцэж”за” гэж андгайлсан биш бил үү?” гэвэл Тоорил ван “тогтсон болзооноос гурван өдөр хожимдсоны учир торгож буруушаахыг Жамух дүү минь мэд” /51.56-66/ хэмээн өгүүлсэн байна.

Гэрээслэл нь иргэдийн хоорондын харилцааны нэг гол хэлбэр байсныг Монголын нэгдсэн улсын хуулийн эх сурвалж дахь баримтууд нотолж байна. Монголын нууц товчоонд татвар эмээс төрсөн хүүхэд эцгийн нь гэрээсэлснээр хөрөнгө хуваах үед хувь авах эрхтэйг заасан нь үүний нэг жишээ мөн. Мөн ахмад хүүхэд дүү нараасаа илүү хувь авах, отгон хөвгүүн эцгийн гэр хогшлыг залгамжлах, хөвгүүдийн ахмадыг тэдгээрийн эхийн дэс дарааллаар тогтоох хэм хэмжээ хэрэглэгдэж байсан байна. Энэ нь заншлын ба хуулийн хэм хэмжээг хослон агуулж цаашид монголчуудаас үр хүүхэддээ хөрөнгө хувь хуваах, тэдгээрийн эзлэх байр суурийг тодорхойлоход уламжлагдан хэрэглэгдсэн болой.

Монголын нэгдсэн улсын хуульд өв хөрөнгийг залгамжлах, эзэмшүүлэх тухай тодорхой заалтууд байсныг эрдэмтэд өөрсдийн бүтээлүүддээ өгүүлсэн байна. Сайшаал”Өв хөрөнгийг залгамжлах тухай хууль” хэмээн гарчиглаад хэд хэдэн заалтыг тодорхойлон өгүүлжээ. Түүний агуулга нь аливаа хүний өмч хөрөнгийг зарцуулахад хөндлөнгөөс үл оролцох, түүнд халдахгүй байх, нас барсан хүний хөрөнгийг хүүхдүүдэд нь залгамжлуулах, хэрэв үр хүүхэдгүй бол түүний шавь буюу зарцад нь өгөх, байлдааны талбарт амь үрэгдэгсэдийг үүрч гарч ирвээс мал хөрөнгийг нь уг үүрч гарч ирсэн хүнд өгөхөөр тогтоосноор тодорхойлогдоно. Ийм агуулгатай зүйлс “Монголын нууц товчоо”, Жувейны “Ертөнцийг байлдан дагуулагчдын түүх” мэт түүхэн сурвалж бичигт тэмдэглэсэн байдгаас үзвэл олон судлаачид эл баримтуудыг иш үндэс болгож иржээ.

Монголчуудын дунд өв залгамжлах хэмээх ойлголт суурьшмал орныхонтой харьцуулбал ихээхэн өвөрмөц агаад өргөн агуулга, учир шалтгаантай юм. Энэ нь эцэг дээдсийнхээ бэлчээр нутаг, өвөлжөө, хаваржаа, намаржааг бишрэн хүндэтгэж үе дамжин эзэмших, түүн дээр орших уул, ус, ургадаг ургамал, амьдардаг амьтдыг шүтэн хамгаалж, дээдлэн ашиглах, эцэг эх нь нас барах үедээ хамгийн хайртай мал, эдлэл чимэглэл (ээмэг, бөгж, гаанс, хөөрөг, эмээл, хазаар, авдар сав, хувцас хэрэглэл, орон гэр гэх мэт) -ийн зүйлсээ биеэр ба гэрээслэлээр өгөх, отгон хүү нь эцгийнхээ гал голомтыг сахин үлдэж, нандигнан хамгаалаад дараагийн залгамжлагчиддаа өвлүүлэн үлдээх, удам угсаагаа хүндэтгэн хамгаалж, үр хүүхдэдээ мэдрүүлэн цааш цаашид үргэлжлүүлэх зэргээр илэрч байсан бөлгөө. Үүнд үеэс үед уламжлагдан үлдсэн заншлын хэм хэмжээ ихээхэн нөлөөтэй байсан хэдий ч бүхэлдээ хууль цаазын агуулгыг хадгалж, зарим нь бүр хуулийн заалтаар хуульчлан бэхжигдэж байсан онцлогтой.

Монголын нэгдсэн улсын үед худалдах, худалдан авах, солилцоо хийх, зээлэх, зээлдүүлэх, жин тээх зэрэгтэй холбогдсон гэрээ, хэлцлүүд ба худалдааны тухай хуулийн заалт, тэдгээрийн хэрэгжиж байсан үйл явцад хууль зүйн агуулга, шинж төлөв илэрхийлэгдэж байсан нь судлагаанаас тодорхой байна. Худалдааны тухай хуулийн заалтууд үйлчилж байсныг Макриси, В.А.Рязановский, Л.Дэндэв С.Жалан-Аажав, Сайшаал зэрэг эртэмтэд бүтээлүүддээ дурдсан байдаг.

Харин эдгээрийн агуулга нь адил бөгөөд тухайлбал худалдаа хийгээд гуравдахь удаагаа алдахыг цээрлэн хориглож байсан шинжтэй байна. Өөрийн бодит үнэ өртгөө алдаж худалдаа хийх нь иргэдийн амьдралд хортой, худалдаа арилжаа хийж сурахад муу нөлөө үзүүлэх учир үүнээс хамгаалж дээрх хуулийн заалтыг гаргасан байж болох юм. Энэ тухай Макризийн бүтээлд "Худалдааны эд барааг гурвантаа зээлж, арилжаа худалдаа ирэхэд гурвантаа хоосрогчдыг үхүүлтүгэй" хэмээн анх бичсэн нь цаашдын бүх бүтээлүүдэд эх үндэс болсон бололтой.

Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн баримтаас үзэхэд хонь, морь, алт мөнгөн эдлэл худалдах, худалдан авах, эд зүйлсийн зэрэг солилцоо, бие биедээ зээлэх үйл ажилгаа явагдаж байсан байна. Нүүдэлчин маягийн амьдралын практикт худалдаа, солилцоо, зээлийн өвөрмөц арга хэлбэр амьдралаар шалгагдан хэрэглэгдэж, ихэнхдээ заншлын хэм хэмжээг мөрдөх явдал өргөн дэлгэр байсныг тэмдэглэвэл зохино. Морь, тэмээ, үхэр, хонио солилцон худалдаалцах, эд өлгийн, гэр ахуйн зүйлсийг мал, түүний ашиг шимийн бүтээгдэхүүнээр солилцон худалдах, худалдан авах явдал иргэд хоорондын харилцаанд нэлээд дэлгэрсэн байж болно. Мөн мал, малын мах, хүнс, тэжээлийн зүйлсээ харилцан бие биедээ зээлэх, зээлдүүлэх, малын хэрэглэгдэхүүнээ харилцан бие биедээ хэрэглүүлэх буюу солилцон хэрэглэх заншил дэлгэрсэн нь илт. Эдгээрийг хэрэгжүүлэхэд хоёр тал харилцан тохирох, өгч авалцах

зүйлийнхээ тоо, хэмжээ, хугацаа, чанарыг тогтоох, бие биенийхээ хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох хэлцлүүд явагдаж түүнээ мөрдөж байсан нь хууль зүйн агуулгатай байсан хэмээн үзэж болох юм.

Үүний зэрэгцээгээр иргэд хоорондын харилцаанд заншлын хэм хэмжээг хуулийн заалтаар бэхжүүлэн заавал биелүүлэх шинжтэйгээр мөрдүүлэх явдал дэлгэрсэн нь нэгдсэн улсын хууль цаазын нэгэн онцлог мөн. Түүхэн сурвалж бичиг, эрдэмтдийн бүтээлүүдэд энэ тухай нилээд хэдэн заалтыг дурдсан байна. Тухайлбал ямарч хүн замд явж байгаад хоол идэж буй явдалтай тохиолдвол мориноосоо бууж, эзэн хүний зөвшөөрлийг хүлээлгүйгээр идэх, ингэж идэхийг үл хориглох, зочин хүн хань нөхдөөсөө илүү идэх, зочилж буй айлынхаа гал тогоо, идээтэй тавган дээгүүр алхахгүй байх, зориуд худал хэлэх, ид шид гаргах, хүмүүстэй хамт хоол идэж байгаад хахах, тогоотой хоол, гал голомт руу хутга, мэс дүрэх, бусдын үйл хөдлөлийг далдуур тагнах, зодолдож маргалдаж буй хүмүүсийн хооронд хөндлөнгөөс оролцохыг хориглох хуулийн заалтууд гаргаж байсан нь хүмүүсийн хоорондын харилцаанд хүнлэг, хүндэтгэлтэй, төлөв зан үйлийг нэвтрүүлж, үндэсний иргэнших ёс, бүрэлдүүлэхэд нөлөөлөх зорилго агуулж байсан байж болох бөлгөө.

Мөн аж байдлын шинжтэй зарим үйлдэл, тухайлбал хүмүүсийн аж амьдралд хор хохирол учруулах үйлдлийг цээрлэн хуулиар хориглож байв. Үүнд: хулгай хийх, дээрэмдэх, архи уух, завхайрахыг хориглосон заалт нэгдсэн улсын хуульд байсныг эрдэмтэн мэргэд бүтээлүүддээ дурдсан байна. Жишээлбэлээс, Рашид-Ад-Дин "Судрын чуулган" бүтээлдээ "илээр садарлан явалдах", бусдын юмыг "булаан дээрэмдэх", "галд хутга дүрэх"-ийг хориглож тэдгээрийг үйлдэгсэд гэмтэн болох тухай өгүүлжээ. Жуулчин Вильгельм Рубрук, түүхч Маккризи нар хулгай хийх, садарлах, худал хэлэх, иш шид гаргахыг хориглосон хуулийн заалт байсныг бичсэн байдаг бөлгөө. Чингисийн Их засагт холбогдох хуулийн заалтуудыг нэгтгэн дэвтэрлэж "Чингисийн Их засаг ба билэг" хэмээн нэрлэж хэвлүүлсэн Хятадын эрдэмтэн Намжилын бүтээлд энэ бүхнийг эх бүтээлээс нь иш татан дурдсаныг болгоон тунгаавал зохих юм.

Сайн зан үйл төлөвшүүлж, муу зан үйл хийхээс сэргийлэхэд төр анхаарч байсны илрэл болгож заншлын зарим хэм хэмжээг төрийн хуулиар хуульчлан баталгаажуулсан байж болох юм, Ялангуяа энэ нь архи хэрэглэх, түүний хор холбогдлыг олон түмэнд ойлгуулах, архи уухад хүрвэл баримтлах ёс, зан үйлийг тогтоон төлөвшүүлэхэд нилээд тодорхой илэрч байжээ. Чингис хаан "Архинд автвас сохор дүлий мэт, дотроо ухаангүй, гаднаас аргагүй, ажил цөм саарна. Архи хэтэрвээс сайн мууг үл ялгана. Эзэн хаан архинд автвас төр гүрнээ алдана. Сайд түшмэд архинд автвас хүнд ялд унана. Миний сургаалийг эс дагагсадыг түрүү хоёр удаа зэмлэн донгод, гуравдахь удаагаа бол хорчирт цөл, дахин эс дагавал гянданд хорь" гэж зарлигласан байдаг.

Чингисийн есөн өрлөгүүдээс архины учир холбогдлын тухай хэлсэн үгс анхаарал татахгүй байхын аргагүй. Жишээлбээс, Го Мухулай ”Барилдсан үгсийг маань байлгадаг бишүү...Улигт муу ундаа дарсыг тэвчье”, Боорчи ”Аманд орохдоо алтан шумуул мэт. Амнаас гарахдаа арслан заан мэт... Оюун билгийг умартуулдаг биш үү”, Зэлмэ ”Бор дарсны зориг буюу Богд эзний маань засаг үгүй буюу”, ”Хар архийг тэвчье л. Хаан эзнийхээ өмнө үнэхээр зүтгэе л”, ”Амрагаас алгасуулдаг биш үү. Алив муу сэтгэлийг төрүүлдэг биш үү” хэмээн санаагаа тодорхойлсон байдаг. Мөн олны төлөөлөгч болох өнчин хөвгүүн ”Балай их ууваас өвчин биш үү, ...Учиртай сайхан ууваас жаргал биш үү” гэж ишэлсэн болой. Ингэж архины уух, түүнд автахын хор холбогдлыг улс орны эрх ашгийн үүднээс, хувь хүний амьдралын утга учрын үүднээс, хүний ёс суртахууны үүднээс тайлбарлан гаргаж, архинд автвал ёс суртахууны ба гэгсгээн цээрлүүлэх арга хэмжээ авч хэвшүүлэх зорилт тавьж байсан нь тухайн үедээ төдийгүй орчин үед ч ихэд анхаарч үзүүштэй бөлгөө. Монголын нэгдсэн улсын төр архи уухад эерэг ёс заншил барамтлах зан үйл нэвтрүүлэхэд багагүй анхаарч, үүнээ хууль цааздаа тусгаж байжээ.

Энэ нь хэрэв архи уухгүй байж чадахгүй бол сард 3 удаа ууж байхыг зөвшөөрч харин түүнээс хэтэрвэл гэмтэн хэмээн үзэх хуулийн заалтад илэрч байв. Ахас, ихэсийн дэргэд архи үл хэрэглэх, архийг найр хурим, бэлэг дэмбэрлийн бэлэгдэл, хүндэтгэлт идээний охь болгон зөв хэрэглэх ёсон Чингисийн хааны үед ч дэлгэрч байсан нь тэр үеийн зохиол бүтээлүүдээс тодорхой харагднам.

Монголын нэгдсэн улсын хуульд гэр бүлийн хууль өвөрмөц байр эзэлнэ. Энэ үеийн гэр бүлийн хууль нь өрх гэр төв төвшин, өнөр амгалан байваас улс орон бат бэх, тулгар хүчирхэг байна гэсэн үндэслэлд тулгуурлаж байжээ.

Чингис хаан өрхөө засаж байж төрөө засна хэмээн сургасан нь гүн ухааны гүнзгий утга учиртай бөлгөө.

Гэр бүлийн хуулийн агуулга нь гэрлэлтийн ёс журмыг уламжлалт зан заншилд үндэслэн тогтоон хэвшүүлэх, гэрлэгсэд гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүмүүсийн харилцааг бие биеэ хүндэтгэж, энэрэн туслах, удам судраа хайрлан хамгаалахад чиглүүлэх, тэдгээрээс нийгмийн өмнө хүлээх үүргийг өндөржүүлэх, гэр бүлийг бат суурьтай байлгаж, төрийн өмнө өндөр хариуцлага хүлээлгэдэг ёсыг төлөвшүүлэхэд чиглэгдэж байв.

“Их засаг” хууль судлаачдаас бичсэн зүйлүүдэд гэр бүлийн тухай заалт нэлээд элбэг тааралддаг. Ялангуяа энэ үеийн анхдагч сурвалж бичиг болох Монголын нууц товчоо болон Рашид-ад-Дин, Макриз, В.А.Рязановский, Ж.Вернадский, Ч.Далай, Л.Дэндэв, С.Жалан-Аажав, Сайшаал, И.Дашням зэрэг эрдэмтдийн бүтээлүүдийг шиншин үзэхэд гэр бүлийн харилцаанд холбогдох өвөрмөц баримт байдгийг

тэмдэглэсэн болой. Тэдгээрийн гол утга санааг нэгтгэн дүгнэж үзвээс гэрлэх, сүй тавих, уг сүйг тавьсан хөвгүүн эхнэр болох эмэгтэйн гэрт очиж ямар хүн болохоо харуулах сорилт туулах, гэр бүлд эцэг хүн тэргүүлэгч байр суурь эзлэх, гэр бүлийн бусад гишүүд тус тусын үүрэг хариуцлагатай байх, үр хүүхэддээ насны дэс дарааллаар өрх иргэн хувааж захируулах, нэг эр олон эхнэртэй байх, охиноо нас гүйцмэгц сүлдэнд үзүүлэх, хүүхэд үрчлэн авах, хаан хатан охидоо ноёд ихэст эхнэр болгон өгөх зэрэг ёс журмыг тогтоон хэвшүүлэхэд чиглэгдсэн байна.

Хамаг монголын тэргүүн Есүхэй Хонгирад аймгийн толгойлогч Дай Сэцэнийд очиж 9 настай хүү Тэмүүжиндээ гэргий болгохоор охин Бөртэг нь гуйхад Дай сэцэн өгүүлрүүн "Олон гуйлгаж очвол эрхэмлэгдэх, цөөн удаа гуйлгаж өгвөл доромжлогдох гэдэг боловч охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөхгүй тул охиноо өгье. Чи хөвгүүнээ хүргэн болгож манай гэрт үлдээ" /51.46/ гэхэд нь хөтөлж явсан морио бэлэглээд хөвгүүнээ үлдээн буцжээ.

Хөвгүүнтэй айл түүндээ эхнэр гуйхдаа арав орчим настай байхад нь эхнэр болох охины гэрт нь очиж бэлэг сэлт өгөн, ёс журам гүйцэтгэн гуйж зөвшөөрлийг олмогц хөвгүүнээ гэрт нь үлдээдэг заншил нэлээд өмнөөс уламжлагдсан буюу. Энэ нь хүргэн болох хүн эхнэр болох охинд ажил төрөл, авьяас билэг, зан төрхөө мэдүүлж дасах, харилцан суралцах, нэр төрөө хадгалан төлөвших нарийн үйл явцыг хамардаг гүн учир утгатай ёсон байсан ажээ.

Гэрлэх ёслолыг хурим хэмээн нэрлэж, нарийн ёс журам үйлддэг байсан авч ихэнхдээ заншлийн хэм хэмжээг мөрдөнө. Монголын нууц товчооны 168-р зүйлд "Багалзуур идэх" тухай өгүүлснийг Монголын нэрт эрдэмтэн академич Ц.Дамдинсүрэн "багалзуур ид" гэх нь эр, эм болох хурим хийх гэсэн үг биз /51.124-125/ хэмээн тайлбарласан байна. Судалгаанаас үзэхүл "Багалзуур идэх" гэдэг нь хуримлах ёсны нэгэн хэсэг бөгөөд эр, эм бологсдын үйлдвэл зохих зан үйлийн нэг аж.

Хүзүү багалзуурын яс маш бат хэлхээтэй байдаг тул үүгээр эр, эмийн бат холбоог бэлэгдсэн /51.124/ байж болох талтай. "Багалзуур идэх"-ийн гол агуулга нь эр, эм бологсод гэрлэсэн анхныхаа 3 хоногт хонины хүзүү, багалзуур идэж, гэрлэлтээ насан үүрдийн бат холбоотой байхыг батлан бэлгэддэгт оршмой.

Гэрлэлтийн харилцаанд мөрдөж байсан нэгэн өвөрмөц ёс бол инж өгөх явдал аж. Чингис хаан Ибага хатанд хандаж "Чиний эцэг Жаха-Хамбу чамд имж болгож Ашиг-Төмөр, Алчиг хоёр тогоочийн хамт хоёр зуун хүнийг өгсөн билээ" /51.184/ гэснээс үзэхэд охиноо өгсөн эцэг болгон харъяат иргэд, мал, хөрөнгө, эд адгуурс өгдөг ёсон байсан нь илэрхий болой. Гэр бүлийн гишүүдийн эзлэх байр суурь, эрх, үүрэг, тэдгээрийн хоорондын харилцаа, өмч хөрөнгийн асуудал гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээний нэгэн чухал хэсэг байсан ажээ.

Монголын нууц товчоо болон бусад сурвалжаас үзэхэд заншлын шинжтэй хэм хэмжээний зэрэгцээгээр хуулиар бэхжүүлэн тогтоосон хэм хэмжээ бага бус үүрэг гүйцэтгэж байсан нь харагдана.

Энэ талаарх хэм хэмжээний агуулгыг нягтлан үзэхэд нэгэн гэр бүлийн хүүхдүүдийг ахмад хүүхэд нь ахлах, ахмадаас нь эхлэн доошлох тутам багасах замаар өрх, иргэд, өмч хөрөнгө хуваарилан, олгох, хүүхэд нь эцгийнхээ, дүү нь ахынхаа сургаалыг сонсож дагах, отгон хүү нь эцгийнхээ гал голомтыг хадгалан өвлөх, хойт, урд гэрийн болон татвар эмийн хүүхдэд адил хувь хөрөнгө олгох, өргөмөл хүүхдэд өмч хөрөнгө хуваах, эцэг эх, ах дүү нар бие биеэ хүндэтгэн тусалж дэмжихэд чиглэгдэж байсан ажгуу.

Чингис хаан өөрийн хүүхдүүд, дүү нартаа өмч, иргэн хувааж өгсөн тухай Монголын нууц товчоон дахь баримтуудыг өмнө нь өгүүлсэн билээ.

Гэр бүлийн гишүүдийн ажил эрхлэх хуваарыг тогтоон мөрдүүлж байсан нь Монголын амьдралын онцлогтой холбоотой. Эрчүүд нь адуу мал маллах, гаргах, нүүдэл суурьшил хийхээс эхлээд ан ав эрхлэх, цэрэгт явж дайн тулалдаанд оролцох зэрэг бие физиологийн онцлогтоо тохирсон ажил эрхлэх үүрэгтэй байжээ.

Гэтэл эмс эхнэрүүд нь гэр зуурын ажлыг эрхлэн хувцас хунар оёх, сааль сүү хийх, хоол ундаа бэлтгэх, үр хүүхдээ асрахад хүч чадлаа зориулдаг байсан аж. Харин нөхөр нь аян байлдаанд явсан үед эр нөхрийнхөө эрхлэн хийдэг байсан бүх ажлыг эхнэр нь хариуцан хийж байх үүргийг хуулиар оногдуулсан байна.

Гэр бүлийн гишүүдийн дотор хүүхдийн гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн төлөө тавих анхаарал их л өвөрмөц байсан ажгуу. Хүүхдийг гэр бүлийн аз жаргал хэмээн үзэж ихэд хүндэтгэн анхаарахдаа амьдралынхаа жирийн нөхцөлтэй холбон нялхаас нь өлчир, тэсвэр тэвчээртэй, зориг шийдмэг, чадалдаа тохирсон ажил хийх дадал дүй олгоход анхаарч байсан нь ажиглагдана.

Гэрээ цэвэрлэх, үнсээ гаргах, аргал түлээ оруулахаас эхлээд хурга, ишиг хариулах, унага, тугал татах, мал саах, цагаан идээ бэлтгэх, мал хариулах, эмнэг сургах, нум сум агсаж тарвага, зурам намнах хүртэлх ажилд нас, бие, хүйс, чадлынхаа онцлогоор зүтгэж суралцахад нь хүүхдийн гүйцэтгэх үүргийн гол агуулга байсан болой.

Хүүхдэд эцэг эх, ах, эгч нарынхаа сургаалийг сонсох, тэднийгээ дагаж ажил хийж, худал хэлэхгүй, хулгай хийхгүй байхыг бүр багаас нь хэвшүүлэх ёс хатуу үйлчилж байжээ.

Эдгээртэй холбогдон хоёр сурвалжид бичигдэн үлдсэн зүйлийг иш татан дурдъя. Рашид-Ад-Диний "Судрын чуулган"-д "Эрчүүд ав хоморго, дайн тулалдаанд явахад гэргий нь зочин ирвээс цэвэр цэмцгэр дэг журмыг үзүүлэн, тансаг идээ бэлтгэж, зочин гийчнийг хүндэлвээс эр нөхрийн нэрийг уулын оргил адил өндөрт өргөмүй. Сайн эрийг сайн ханиар нь мэдмой. Тэнэг мулгуу ухаан бодол, ёс заншил муутай эхнэртэй бол нөхөр нь тэнэг болмой" /51.120/ хэмээн бичжээ.

Мөн Сайшаал “Чингис хааны товчоон” номондоо “Хөвгүүд нь эцгийн сургаалыг үл авсан, дүү нар нь ахмадын ятгалыг үл сонссон, эр нь гэргийгээ сэжиглэн, гэргий нь эрээ эсэргүүцсэн, хүүхэд багачуул нь ахас, ихэсийнхээ сургаалыг үл дагасан” явдлыг Чингис хаан муу зүйл хэмээн хориглон зарлиглаж түүнээс сэрэмжлэхийг анхааруулж байсныг өгүүлжээ.

“Их засаг” хуульд өв залгамжлах, тэтгэвэр, тусламж үзүүлэх заалтууд байсан нь судалгаанаас харагдаж байна.

Өв залгамжлах тухай заалтууд “Их засаг” хуульд байсныг Жувейни, Рязановский, Дэндэв Сайшаал нарын бүтээлүүд, “Эзэн богд Чингисийн Их засаг”, “Чингисийн төр хууль цааз”-д өгүүлсэн нь байдаг. Сайшаал “Их түшмэд, ноёд, иргэд буюу ард иргэд үхсэн хойно түүний эд хөрөнгө хэдий байсан ч болтугай хөндлөнгөөс ингэ, тэг гэж үл болох бөгөөд хэн ч энэ эд хөрөнгөд халдаж болохгүй. Үхэгсдэд залгамжлах үр хөвгүүн үгүй болбоос эд хөрөнгийг нь түүний шавь буюу зарцад өгч болохоос биш улсын санд огт оруулж болохгүй” / / хэмээн бичжээ. Монголчуудын гэр бүлийн ёсонд хамгийн отгон хөвгүүнийг “галын эзэн, эцгийн голомтыг залга” хэмээн үзэж эцгийн нь амьдарч байсан гэр орныг өгч, эхтэй нь хамт өмч хөрөнгө хуваарилан олгож байсан нь өв хөрөнгө залгамжлалд хамаарах өвөрмөц ёсон болой.

Монголын нэгдсэн улсын хууль-“Их засаг” хуульд эрүүгийн бодлого, ял шийтгэлийн асуудал онцгой байр эзэлж байсан гэж хэлж болно. Энэ нь тус улсын монгол угсаатныг нэгтгэсэн хүчирхэг бөгөөд нарийн дэг журам, зохион байгуулалт бүхий нэгдмэл улсын зохион байгуулалттай байж, дэлхийн их гүрэн болох бодлого явуулж хэрэгжүүлсэнтэй холбоотой.

Жорж Вернадский “Засагт орсон эрүүгийн хууль цааз нь төр хийгээд нийгэмд тайван ёс журмыг сахиулах гол хэрэгсэл болсон” /16.26/ хэмээн тодорхойлоод түүнийг Армяны түүхч Магакийн “хүн бүр гэр бүлийн ёсыг бүү зөрч. Бүү хулгайл.

Гэрчлэхээс бүү татгалз. Бүү худал хэл, алив гэмт явдалд алах ял онооно” /16.26/ гэж эрүүгийн хуулийн агуулгыг томъёолсонтой холбон тайлбарлажээ.

Түүхэн сурвалж бичиг эрдэмтдийн судалгааны бүтээлүүдэд Монголын нэгдсэн улсын хууль дахь эрүүгийн талаар тэмдэглэгдсэн заалтуудын агуулгыг нягтлан судалсан дүн нь өнөө үеийн эрүүгийн бодлогын зорилт, онцлог, гэмт хэргийн төрөл, гэмт хэргийг илрүүлэн тогтоох, ял шийтгэл оноох, тэдгээрийг эдлүүлэх үйл явцын тухай өгүүлэх бололцоо олгож байгаа болой.

“Их засаг” хуулийг судлаач бүр өөр өөрсдийн бүтээлүүдэд эрүүгийн цаазад холбогдох заалтуудыг иш татан дурдсан тайлбар хийсэн нь зүй ёсоор анхаарал татаж байна. Жишээлбэл, В.А.Рязановский 14, Л.Дэндэв 13, С.Жалан-Аажав 10, Сайшаал 27 заалтыг нэг бүрчлэн дурдаж дүгнэлт, тайлбар хийсэн байх юм. Ж.Вернадский

“эрүүгийн хууль” гэсэн тусгай бүлэг гаргаж түүндээ гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй дүгнэлт тайлбар хийж байсан нь гэмт халдлагаас хамгаалах зорилготой байсан нь судалгаанаас илт байна” /98.50/ гэсэн дүгнэлт хийжээ. Эл бүтээлд Монголын тулгар төр, тусгаар тогтнолыг хамгаалах, Монгол улс нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, монголчуудын зан заншил, удам угсаа, шашны ёс мөргөлийг бэхжүүлэх, их улсын хуулийг дээдлэхэд эрүүгийн бодлого чиглэж байсныг дурдсан нь анхаарал татнам.

Онолын үүднээс ч, практикийн хувьд ч Монголын нэгдсэн улс, Чингис хааны эрүүгийн бодлого нь Монголчуудын нэгдмэл байдлыг хангах, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, нийгэм, төрийн байгуулага, хаан, төрийн түшмэдүүд хийгээд иргэний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төр, зан заншил, байгалийн баялагийг гэмт халдлагаас хамгаалахад чиглэж байсан нь эргэлзээгүй болой.

Энэ талаас нь хэлбээс Монголын нэгдсэн улсын эрүүгийн бодлого, хууль цааз нь тус улс хүчирхэгжин бэхжих нэгэн гол хүчин зүйл болж, түүний амьдралд томоохон үүрэг гүйцэтгэсэн хэмээн хэлж болох үндэслэлтэй болой,

Монголын нэгдсэн улсын эрүүгийн бодлогын шинж төрх нь гэмт хэрэг, түүнийг төрөлжүүлэн ангилахад тод илэрч байв. Гэмт хэргийг ойлгох, түүнийг ангилахад В.Я.Рязановский, Ж.Вернадский нар томоохон алхам хийсэн ажгуу. Ж.Вернадский Их засаг дахь гэмт хэргийг а/ шашин ёс суртахуун, тогтсон заншлын эсрэг гэмт хэрэг; б/ хаан болон төрийн эсрэг гэмт хэрэг; в/ хувь хүний амьдрал, ашиг сонирхолын эсрэг гэмт хэрэг гэсэн гурван төрөлд ангилж тус бүрд нь ямар гэмт хэрэг багтаж байсныг дурджээ. Нэгдэх төрөлд шашин шүтэх эрх чөлөөнд хөндлөнгөөс оролцох, албан ёсны мэдүүлэгт санаатай худал хэлэх, ус голомт бохирдуулах. зохих журмыг зөрчин мал нядлах, гэр бүлийн ёс зөрчих хэргийг хамааруулсан болно. Хоёрдахь төрөлд хааны зарлигийг зөрчих, хаан төрийн түшмэдийг доромжлох, хуулийг үл биелүүлэх, цэргийн сахилгыг зөрчих хэргийг оруулж дурджээ. Гурав дахь төрөлд өмчлөх эрхийг зөрчих, бусдын амь насыг бүрэлгэх, адуу, мал хулгайлах мэт хэргүүд орно хэмээн тайлбарлажээ.

Эзэн богд Чингисийн ”Их засаг” хэмээх номонд а/ төр захиргааны эсрэг гэмт хэрэг, б/ цэргийн гэмт хэрэг, в/ иргэний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, г/ зан заншил, бөөгийн ёсны эсрэг гэмт хэрэг, д/ аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг хэмээн ангилж тус бүрд нь ямар гэмт хэргүүд хамаарахыг дурдан түүнд оногдуулах ял шийтгэлийг хууль зүйн үүднээс нягтлан боловсруулж өгүүлсэн байдаг.

Түүхэн сурвалж бичиг, эрдэмтэн мэргэдийн бүтээлүүдэд тэмдэглэгдсэн буюу нягтлан боловсруулж бичсэн бөгөөд гэмт хэрэгт хамаарах заалт тайлбаруудыг харьцуулан үзвээс хоёр зүйлийн дүгнэлт гарч болох байна.

Чингисийн толгойлсон Монголын хаант төрд ямар үйлдлийг гэмт хэрэг гэж үзэж байсан нь анхаарал татах зүйл мөн хэмээн санагдана. Баримтуудыг түшихүйд хаан, түүний алтан ургийнхан болон түшмэд, иргэдийн амь бие, нэр төрийн эсрэг үйлдэл, төрийн байгууллага, албан тушаалты үйл ажиллагааны журам зөрчсөн үйлдэл, цэргийн сахилга, байлдааны үед баримтлах дэг журмыг зөрчсөн үйлдэл, мал хөрөнгө, эд зүйлс хулгайлсан үйлдэл, нутаг бэлчээр, ус мэтийг сүйтгэсэн, бохирдуулсан үйлдэл, ашиггүй худалдаа арилжаа хийж удаа дараа алдагдал хохиролд оруулсан үйлдэл, зарим зан заншлын хэм хэмжээг эвдсэн, шашны ёс үйлийг зөрчсөн үйлдэл нь засаг, төр, нийгмийн байгуулал, иргэд болон олон түмэн, тэдгээрийн амьдрал, ахуй, зан заншилд хор хохирол учруулсан аваас гэмт хэрэг хэмээн үзэж, тэдгээрийг хуулиараа тогтоосон байна.

Тодорхой үйлдлийг гэмт хэрэг гэж хуульчлан тодорхойлж, уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд оноох ялын хэлбэр, хэмжээг тогтоодог нь засаглал хэрэгжиж буйн нэгэн гол шинж байдаг. Монголын нэгдсэн улсад ч мөн ийм ёс үйлчлэх явдал зайлшгүй байсан нь эргэлзээгүй.

Чингэхдээ гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулах нь дур зоргоороо бус, тухайн түүхэн нөхцөл, төрийн бодлого, амьдралын бодит шаардлагыг илэрхийлэн төрөөс батлан тогтоосон хууль журмын ёсоор явагдаж байсан бөлгөө.

Дээрх дүгнэлтүүдийг нотлох зорилгын үүднээс ямар гэмт хэрэгт, ямар шийтгэл оногдуулаж байсныг дурдъя.

Төрийн тэргүүн, их хааны махбод, эрх мэдэл, нэр төр халдашгүй дархан агаад түүний эсрэг үйлдэл гаргаваас төрийн эсрэг хэрэгт тооцож хатуу цээрлэл хүлээлгэнэ.

“Хаан батөр улсаас зөрчигсөдийг алах ялаар шийтгэх”, “Хаадын сонгуульгүйгээр өөрийн эрх сүлд түшиглэн хаан суусан бол түүнийг өчүүхэн ч хайр найргүй цаазлах”, “Алтан ургийхан ”Их засаг”-ийг зөрчвөөс хүнд хөнгөний байдлаар гяндлах ба цөлөх”, “Ноёдууд хаанаас өөр хүнд хэрэг учир мэдүүлвэл алах”, “Хааны зөвшөөрөлгүйгээр зарлиг шийдвэргүйгээр дайны олз хуваарилбал тушаал бууруулах”, “Төр, цэргийн нууцыг задруулбал шийдэмдэж шитгэх”, “Хуурамч элч буюу өөрийгөө элчин сайд, төлөөлөгч хэмээн хууран мэхэлбэл цаазлах”, “Хааны бие, гэр өргөө, хатад, хүүхдийг хамгаалах үүрэг хүлээхээс татгалзах, үл биелүүлэх аваас цөлөх, цаазлах хүртэл шийтгэх” зэргээр нэгдсэн улсын хуульд буй заалтууд нь хаант засаглал, түүний тэргүүн хааны бие махбод, удам угсаа, эрх мэдэл, нэр төрийг гэмт халдлагаас хамгаалсан шинжтэй байсан болой.

Захиргааны журам зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн үйлдэл мөн бөлгөө.

Хаант улсын хууль цаазад холбогдуулах заалтуудыг ажиглахуйд ийм төрлийн үйлдэл, түүнийг үйлдэгсдэд оногдуулах шийтгэл “Өөрийн арваныг үл захирах,

ноёныг алж гэмт болгох”, ”Хөрөнгө мөнгө эрхэлдэг түшмэдэд тэрхүү албан мөнгө хөрөнгөнөөс авч хэрэглэвэл алах”, ”Хэрэг зөвлөх чуулган чуулахаас их ван, сайд, түшмэдүүд саатан хоцорвол мөнгөөр яллах”, ”Хөдөөний захирагч нар дур зоргоор ард иргэдээс алба авах,ажилд зарах, албан сан эд агуурсыг түшмэдүүд дураар авч хэрэглэвэл ял хэлэлцэх”, “Өөрийн албан тушаалыг бусдад дураар шилжүүлэх аваас гэмт хэрэгтэн болох”, ”Хүн өөрийн харъяаны мянгат, зуут,арванаас дур мэдэн гарч явбаас алах” зэрэг заалтууд орж байсан ажээ.

Монголын нэгдсэн улсын үеийн гэмт хэргийн төрөлд цэргийн гэмт хэрэг орно.

Энэ нь цэргийн зохион байгуулалт үйл ажилгааний журмыг нарийн зохицуулж түүнийг зөрчигсдөд хүлээлгэх харицлага нэлээд тодорхой байсантай холбоотой.

Цэргийн албанд татах журмыг зөрчих, цэргийн албанаас зайлсхийх, цэргийн удирдлагын шийдвэрийг үл биелүүлэх, цэргийн нууц задруулах, байлдах журам зөрчих, урвах, байлдааны талбараас зугтах, цэргийн эд хөрөнгийг хулгайлах, устгах, олзны хөрөнгийг дур мэдэн авах, өгөх үйлдлүүд цэргийн гэмт хэрэгт багтаж байсан ажгуу.

Хишигтэн цэрэгт мянгат, зуут аравтаас татах зарлиг журмыг зөрчвөл чангалан шийтгэх, цэрэгт орвол зохих хүн бултаж зайлсхийвэл цөлөх, хишигтэн хүн ээлжээ анхны удаа тасалбал 3 бэрээ, хоёр дахь удаа тасалбал 7 бэрээ, гуравдах удаа тасалбал 37 бэрээ занчаж, цөлөх ялд унагах хуультайг /15.198-199/ Монголын нууц товчоонд тэмдэглэн бичсэн бөлгөө.

П.Карпини, В.Рубрук нарийн бичсэн ”Монголд жуулчилсан тэмдэглэл” номонд бичсэнээр цэргийн захирагч аян дайнд мордохоос өмнө цэрэг, анги, зэр зэвсэг юугаа өөрийн биеэр шалган үзэх үүрэгтэй. Ингэж үзээгүй буюу дутуу үзэснээс зөрчил гарвал захирагчийг яллах хуультай байжээ.

Хаант улсын хууль цаазад цэрэг хүн байлдааны даалгаврыг үл биелүүлэх, байлдааны талбар дээр нөхдийнхөө унаа морийг хулгайлах, урван тэрслэх, байлдааны талбараас зугтах, оргох, байлдаж, байгаад ухрахад эхний довтолсон байрандаа ирэхгүй байх, цэргийн олзлогдсон хүнд түүнийг барьсан хүнээс зөвшөөрөл авалгүйгээр хоол, хувцас өгөх аваас гэмт хэрэг үйлдсэн хэмээн цаазлах хүртэл ял оногдуулахаар заасан байна. Зарим гэмт хэргийг хүндрүүлэн үзэж хатуу шийтгэл оногдуулах журам байсан ажгуу. Жишээлбээс, Байлдаан хийж байхад нэгэн аравтаас олон хүн оргож боссон бол тэдгээрийг бүгдийг нь цаазлана. Бүх цэрэг ухраагүй байхад оргож зугтсан хүн гарвал цаазлах хуультай. Аравтын дотроос олон хүн дайсан руу баатарлагаар дайрч орсон байвал түүнээс үлдсэн бүх хүнийг ална. Аравтын цэргээс нэг буюу хэд хэдэн хүн олзлогдоход үлдсэн хүмүүс нь тэд нарыг олж очиж туслаж, тэтгээгүй бол мөн бүгдийг нь цаазлана.

Энэ бүхнээс үзэхэд эдгээр нь бүлэг гэмт хэрэгт багтаж байжээ. Цэргийн гэмт хэрэгт, хуульчлан бэхжүүлсэн заншлын шинжтэй заалтыг зөрчин үйлдэл гэмт хэрэгт орж байсан нь сонирхол татна. Тухайлбал, цэргийн ноёны босгон дээр гишгэсэн, байлдан дайрах буюу ухрах үед байлдаж явсан цэргийн унагасан боодол баглаа, нум сум, ачааг араас дагаж явсан хүн нь мориноос бууж авч өгөөгүй бол гэмт хэрэг үйлдсэн хэмээн цаазлах ял оногдуулдаг байсан аж.

Байлдааны ажиллагаа дуусаж дайснаа бүрэн ялсны дараа олз ашгаа хуваах ажил явуулахыг хуулиар зөвшөөрнө. Хэрэв үүнийг зөрчвөл цэргийн цааз зөрчсөн хэмээн ял ононо. Хэрэв байлдааны цагт бие үрэгдэгсдийг үүрэн гаргах, шархдагсдаа туслах, хүний амийг аврах аваас урамшуулан шагнах санкц байсныг тэмдэглэвэл зохино.

Хэдийгээр баримт материалаар ховор боловч гэмт хэргийн төрөлд өмчийн эсрэг гэмт хэргийг хамааруулан өгүүлэхийг хичээмүй. Учир юун хэмээвээс бэлчээр, нутаг, мал хөрөнгө, эд зүйлсийг хамгаалах нь нэг талаар өргөн хүрээтэй бөгөөд заншлын хэм хэмжээгээр зохицуулагдсан зүйл ихтэй, нөгөө талаар улсын бодлого хууль цаазаар хамгаалагдах шаардлага төрийн түвшинд тавигдаж эхэлсэн нь хаанаас батлан гаргах хууль зарлигт зүй ёсоор тусгалаа олсон байна.

Монголын нэгдсэн улсын хуульд бусдын малыг хулгайлан авах үйлдлийг ноцтой гэмт хэрэг хэмээн үзэж түүнийг үйлдсэн этгээдэд хүндрүүлэн үзэж хатуу шийтгэл оногдуулах ялын бодлого илэрлээ олсон ажгуу. “Эрдэмтэн Сайшаал” Чингис хааны товчоон” номондоо хулгай хийсэн этгээдийг цаазлан хороож гэргий ба мал хөрөнгийг хурааж аван хулгайд мал алдаж хохирогсдод өгнө хэмээн өгүүлжээ./76.435/ Үүнээс үзвэл хулгай хийх нь онц жигшүүртэй гэмт хэрэг бөгөөд хэрэв хулгай хийвэл өөрийг нь цаазлахаар зогсохгүй гэр оронд нь халдааж, эд хөрөнгийн нь хураан авах төдийгүй эхнэрийг нь ч мөн хурааж давхар давхар зэмлэл хүлээлгэж байжээ. Мөн хулгайн хэргийг том ба жижиг хэрэг хэмээн ангилж, түүний хэмжээ хохиролд нийцүүлэн ял шийтгэл оногдуулах бодлого баримталж байсан ажгуу.

Том хулгайлагчид үхэх ял оногдуулна. Гэвч нэг хонь хулгайлсан гэх мэт хэрэгт бол газар дээр нь тогтоон шийдвэрлэж шийдэмдэж шийтгэнэ гэж П.Карпини, В.Рубрук нар “Монголд жуулчилсан тэмдэглэл” номондоо бичсэнээс үзэхэд жижгээр хулгай хийгсдийг шийдэмдэн шийтгэж байсныг харуулна. Хулгайн хэргийг ихэд цээрлэж хэрэв үйлдвээс зөвхөн хулгайлсан юмыг нь төлүүлэх төдийгүй хэд дахин өсгөн нэмэгдүүлж торгох, түүнийг эд төлөхүйд хүүхдийг нь авах буюу өөрийг нь чангалан хатуу шийтгэх, хэрэг үйлдэгчийн амьдралд хохирол үзүүлж жигшүүлэх бодлого явуулж байжээ. Монголын нэгдсэн улсын хуульд “Хулгайлагдсан морь, хэн нэгэн хүнээс олдвоос уул эзэнд нь адил зүсмийн есөн морь өг. Хэрэв торгуулийн морьдыг өгөх хөрөнгөгүй бол оронд нь үр хүүхдийг нь ав. Үр хүүхэдгүй бол хонь

адил ал” гэсэн заалт байсан хэмээн С.Жалан-Аажав бичсэн байдаг. Бас боол хүн бусдын эд хөрөнгийг хулгайлбал тэрхүү боол ба уг боолын эзнийг алах ялаар шийтгэ гэсэн заалт Их засагт байжээ.

Өмчийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, булаах, хадгалуулсан эд юмыг нь үрэх, олзны зүйлийг дур мэдэн хувааж өгөх, эд хөрөнгийг шатааж, олсон эд зүйлээ нуух хэргийг хамруулж болох авай. Ямар нэг хүн бусдын эд зүйлийг булаан дээрэмдэх буюу булааж авбал уг этгээдийг хайргүй цаазлах, бусдын хадгалуулсан эд зүйлийг 3 удаа үрвэл гэмт хэрэг хэмээн үзэж шийтгэх, олсон эд зүйлсийг хувьд авахаар нуух, байлдааны явцад олж авсан хувцас, эд зүйлс, зэр зэбсгийг эзэнд нь эргүүлж үл өгөх хэрэг үйлдвэл цаазаар авах шийтгэл оногдуулах хуулийн заалт байсныг Сайшаал “Чингис хааны товчоон” номондоо дурдсан байна.

“Хар татарын тухай хэргийн товч” хэмээх бүтээлд өвс ногоорсон хойно газрыг нүхлэх, гал алдах, бэлчээрийг шатаах хэрэгт цаазлах ял оногдуулах хуультай байсныг дурдсанаас үзэхэд ил 2 зүйл хэрэг хүнд гэмт хэрэгт хамаарагдаж байсан нь ийм бөлгөө.

Хэдийгээр их газар нутаг, байгалийн нөөц баялаг, ургамал ан амьтдыг хамгаалах, ашиглахтай холбогдсон гэмт хэрэг ял шийтгэлийн тухай заалт харьцангуй цөөн боловч тэмдэглэгдэн үлдсэн заалтууд нь жинтэй агаад түүхэн нөхцөлд төрөөс цаг зуурын төдийгүй алс хэтийн хандлагыг баримжаалсан нухацтай бодлогыг явуулж байсныг харуулах бөлгөө. Бэлчээр нутагт түймэр тавих, ус, булаг шандыг бохирдуулах, эдгээртэй холбогдсон зан заншлийг зөрчихийг цээрлэж хууль цаазын хамгаалалтанд авч байсан нь төрийн холч бодлогын илэрхийлэл болой.

Гэр бүлийн холбогдол бүхий зан заншлийн эсрэг гэмт хэрэг, гэмт хэргийн нэгэн өвөрмөц төрөл байсан ажгуу. Гэр бүлийн эсрэг гэмт хэрэг нь олон эхнэртэй байх, сүй тавих, сүлдэд үзүүлэх ёс мөрдөгдөж байсныг тусгаж байсан нь эргэлзээгүй. Макризи, В И Рязанюский, П Карпиний, Л Дэндэв С Жалан-Аажав нарын бүтээлүүдэд алив хүн бусадтай явалдваас гэрлэсэн эсэхийг харгалзахгүйгээр ял оногдуулах заалт байсныг дурдсан байна. Энэ нь гэр бүлийн харилцаанаас гадуур эр эмийн харилцаа явагдахыг ихэд цээрлэж ялангуяа хүн амын нэгийн дорд хэсэгт эл ёс зөрчигдөхөөс хамгаалах зорилготой байсан. Зарим судлаачид “Нэгэнт олон эхнэртэй байхыг зөвшөөрч байхад олон эхнэр тэжээх чадваргүй эрчүүд эцэг эх нь охиныхоо төлөө сүй тавихгүйгээр эрд гаргадаггүй учраас эрд гарч чадахгүй байгаа эмэгтэйчүүдэд дээрх заалт үйлчилж байсан бололтой” /98.48/ хэмээн бичсэн нь анхаарах зүйл болой. Үүний зэрэгцээгээр эцэг нь нас барахад түүний эхнэрүүдийг хөвгүүд нь эхнэр болгож авах буюу бусдад эхнэр болгож өгөх, эх буюу дүү нь нас барвал бэргэн ба дүү бэрээ эхнэр болгох ёс журам зөрчихийг цээрлэн байсныг тэмдэглэвэл зохино.

Зан заншлийн эсрэг гэмт хэрэгт ус, үнс рүү шээх, хоол идэхдээ хахах, цэргийн дарга ба ноён хүний үүдний босгон дээр гишгэх, галд хутга дүрэх, тогоон дотроос хутгаар мах авах, галын хажууд сүхээр түлээ хагалах, газар дээр сүү бусад идээний зүйл асгах, адгуустай явалдах, худал хэлэх, ов мэх гаргах, хоёр хүний хэрүүл маргаанд хөндлөнгөөс оролцох, бог малыг өрцлөхөөс өөрөөр нядлах, бусдын үйлдлийг далдуур тагнах, худал гэрчлэх сэлтийг оруулан ёс заншил, заншлын горимыг зөрчиж ёс суртахууны хэмийг алдсаных нь төлөө цаазлах зэрэг ял шийтгэлийг оногдуулж байв.

Монголын нэгдсэн улсын эрүүгийн хууль, түүнийг зөрчиж ял шийтгэл оногдуулж байсан баримт сэлтийг дүгнэн үзвээс энэ үед ял шийтгэлийн дор дурдсан хэлбэрүүдийг хэрэглэж байсан хэмээн хэлж болох байна. Үүнд: а/ цаазаар аваачих, б/ эрхтэнг нь хагаслах⁵⁷, в/ гяндлах, г/ цөлөх, д/ бэрээдэх, е/ торгох, ё/ эд хөрөнгө хураах, ж/тушаал эвдэх хэмээн найман төрөлд ангилж болох бөлгөө.

Монголын нэгдсэн улсын хууль судлаачид эрүүгийн ял шийтгэлийн хэлбэрүүдийн талаар янз бүрийн дүгнэлт хийсэн байна. Ж.Вернадскийн бүтээлийг судлахад түүнд эрүүгийн ял шийтгэлийн зургаан хэлбэр дурдагджээ. Уг бүтээлд: “Алах ялыг хуулинд бүхэлд нь гол байр эзлүүлжээ.... бараг бүх төрлийн гэмт хэрэгт алах ял оногдуулахаар заажээ. Дараагийн ял гэвэл хорьж тусгаарлах, цөлөх, цол бууруулах, зодох, торгох ял болно” /16.29/ хэмээн өгүүлжээ. Сайшаал Чингис хааны товчоон хэмээх зохиолынхоо “Чингис хааны үндсэн хууль, товчоон” бүлэгт алах, торгох, хөрөнгө хураах, ташуурдах ялын хэлбэрүүд байсныг дурдсан байна.

Эзэн богд Чингисийн “Их засаг” хэмээх 1995 оны номонд судлаач Х.Сэлэнгэ 51 гэмт хэрэгт оногдуулж байсан ялыг судлан үзээд “цаазаар авах, гяндлах, цөлөх, ташуурдах /шийдэмдэх/, торгох, хөрөнгө хураах” гэсэн 6 төрлийн ялын хэлбэр байсан /98.56/ гэж бичжээ.

В.А.Рязановский “Их засаг” - ийн эрүүгийн ялын хэлбэрүүд дотор цаазаар авах ял давамгайлж байсныг өгүүсэн байдаг. Чингисийн “Их засаг” хуулиас бидний үед уламжлан ирсэн заалтуудад цаазлах ял оногдуулах тухай бичсэн зүйл цөөн бус байгаа боловч энэ нь хоёр талтай болов уу хэмээн үзүүштэй. Эрх зүйн түүхэнд “цаазлах” хэмээх үг хоёр утгаар хэрэглэгдэж байжээ. Үүний нэгдэх нь хориглох гэсэн утгатай. Алив хэрэг, хор холбогдолтой үйлдэл хийхийг тэвчин өнгөрүүлэхийг даалгах нь “хориглох” хэмээхүйн гол утга санаа байжээ. Тэрхүү үйлдэл хийлгүй тэвчиж өнгөрүүлвээс өөрийн болон бусдын үйлдэлд ач тус болж тэгснээрээ нийгэмд эсрэг үйл гүйцэтгэх учиртай аж. Гэрийн босгон дээр гишгэх, хоол идэхдээ хахах, худал хэлэх, ов мэх гаргах, бусадтай явалдахыг хориглосон нь алив хүний ёс суртахууны үүргийг дээшлүүлж төлөвшүүлэх гол зорилготой агаад түүнийг тэвчих нь тийм хүнд зүйл бус учир сахих үйл гүйцэтгэх магадлал ихтэй байсан бизээ.

Орчин үеийн хууль цаазад ч хориглосон хэм хэмжээг хэдий чинээ зөв сонгож, аль болох оновчтой байрлуулваас сахин тэвчих үндэслэл нь төдий чинээ суурь дэвсгэртэй болж тэгснээрээ нийгэмд гүйцэтгэх роль нь өсөн дээшлэх магадлал арвин болох бөлгөө.

“Цаазлах”⁵⁸ хэмээх үгийн нөгөө утга санаа нь цаазаар аваачих буюу амийг нь авах гэсэн агуулгыг илэрхийлж байжээ. Монголын нууц товчоонд цаазаар аваачихыг “махируулах” хэмээн томъёолсон бөлгөө. Монголын нэгдсэн улсад цаазаар аваачихыг эрүүгийн ялын дээд хэлбэр болгон үзэж, төрийнхөө бодлогыг илэрхийлэн анхаарал болгоомжтой хэрэглэж байсныг тэмдэглэх нь буюу. Монголын нууц товчоонд дурдагдсан баримтыг шинжиж үзэхүйд цаазаар аваачихыг гүйцэтгэх 3 арга байжээ. Нууц товчооны 140-р зүйлд Хутугт Монхорын хөвгүүн Бүрибөхийг агдлан барьж цээж бөгснөөс нь угзран татаж нуруугий нь хугалан /51.88/ амийг авсан баримт бий. Мөн 245-р зүйлд Мэнлигийн хөвгүүн Тэвтэнгэрийн нурууг хугалж амийг нь авсан тухай өгүүлжээ. Нурууг хугалах нь цус үл гарч, хоромхон зуур амь алдах учиртай тул монголчууд аль эртнээс гарцаагүй тохиолдолд хэрэглэж байсан цаазын ховор арга ажгуу. Цусгүй цаазлах аргын өөр нэг хэлбэр “цагаан эсгийгээр” амыг нь бүтээж алах арга бөгөөд үүнийг Чингис хаан язгуурын хүн Жамухад өөрийнх нь хүсэлтийн дагуу хэрэглэсэн байдаг билээ.

Цаазаар аваачих бусад хэлбэр нь юмаар цохиж амийг нь авах, цавчин амийг нь хороох аргууд бөгөөд сүүлчийнх нь илүү албан ёсны арга байжээ.

Монголын нэгдсэн улсын хуульд бидний үе хүртэл уламжлагдан үлдсэн заалтуудад “цаазлах” тухай үг нилээд байгаагаас үүдэн эл үеийн хууль цаазын нийт хэм хэмжээний ихэнхийг эрүүгийн хэм хэмжээ, ял шийтгэлийн дийлэнхийг цаазлах ял байсан хэмээн дүгнэлт хийх нь тийм ч бодит бус шинжтэй. Судалгаанаас үзвэл нийт хэм хэмжээний системд тогтоосон, үүрэг болгосон, зөвшөөрсөн хэм хэмжээ дийлэнх хувийг эзэлж тэдгээр нь хаант улсын төр, цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, иргэний өмч, гэр бүл, аж ахуйн харилцаа зэрэг нийгмийн олон янзын хүрээнд мөрдөх зан үйлийг хамран байсан нь илт бөлгөө. Ингэхлээр хаант улсын эрх зүйн хэм хэмжээний системд сахих /хориглосон/ хэм хэмжээ, зонхилж байсан хэмээн үзвэл үнэнд илүү ойртох болов уу хэмээн бодном.

Их засагт хамаарах заалтуудын эрүүгийн ялын хэлбэрүүдийг шинжиж үзэхэд хууль бусаар хаан суудалд суух, улсыг төлөөлсөн хуурамч элч, төлөөлөгч болох, улсаас урвах, байлдааны талбараас зугтаах, мөн талбараас нөхдийн унааг хулгайлах, хүний амь бүрэлгэх, адгуус амьтадтай явалдах, мал хулгайлаад зохих тооны малыг төлж чадаагүй, байлдааны олзыг хулгайлах, малын бэлчээрийг шатаах зэрэг хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд цаазаар аваачих ял оногдуулж байсан нь нилээд бодит үндэслэлтэй ажээ.

Монголын нэгдсэн улсын эрүүгийн бодлогод хүний эрхтэнг хагаслах ял орж ирсэн нь сонирхол татахгүй байх аргагүй. Учир нь монголын өмнөх үеийн эрүүгийн бодлогод гэмт хэрэг үйлдсний төлөө хүний аль нэг эрхтэнг нь хүчээр тасдаж хаядаг ял байхгүй байсан бөлгөө. Харин дундад зууны Европод хүнд гэмт хэрэг үйлдэгсдэд хуруу, гар, чих, хамар зэрэг эрхтнийг нь тайрч зэрэмдэг болгодог ялын бодлого үйлчилж байсан түүхтэй. Ингэхлээр эрхтэн хагаслах ялыг баруун зүгийн улс орнуудын амьдралаас улбаалан авч хэрэглэсэн байж болох юм. Монголын нууц товчооны 280-р зүйлд алба татвар төлөөгүй буюу дутуу төлсөн хүний уруул, хамрыг огтлон тайрч байх тухай заасан байна. Хааны зарлигт ийнхүү заасан нь амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байсныг дурдсан баримт олддоогүй. Өөр сурвалж бичиг судалгааны бүтээлд энэ талаар бичсэн зүйл үгүй бөлгөө. Энэ бүхнээс үзэхэд эрхтэн хагаслах ял түгээмэл бус бөгөөд гол төлөв алба, татвар төлөөгүй ноцтой тохиолдолд хааяа нэг хэрэглэгдэж байсан болов уу гэж санагднам.

Цөлөх ялыг ховор хэрэглэж байсан болов уу, “Далд газар” аваачих хэмээн томъёолсон цөлөх ялыг алтан ургийнхан 3 дахь удаа хууль зөрчих, хишигтэн цэрэг 3 дахь удаагаа ээлжээ тасалбал цөлөх ял оноож байхаар Монголын нууц товчоонд заасан нь гол баримт юм.

Мөн гяндлах /хорих/ ял ч түгээмэл хэлбэр бус. Ж. Вернадский Чингисийн эвийн гишүүд хуулийг 3 дахь удаагаа зөрчиж цөлөх ял эдэлсэн боловч “засрахгүй бол засрах хүртэл шороонд хийнэ” /16.30/ гэж бичжээ. Нэгдсэн улсын хуульд гяндлах ялтай заалт ховор тохиолддог.

Энэ нь төрийн бодлогын хувьд нэг талаас хорих ялыг түгээмэл бөгөөд урт хугцаагаар хэрэглэх материалын хэрэгцээ, сонирхол бага, нөгөө талаас Монгол орны нөхцөлд хорих ялыг хэрэглэх нь үр ашиг багатай байсныг харгалзан үзсэн ч байж болох юм.

Харин бэрээдэх, тушаал бууруулах, торгох ялыг түгээмэл хэрэглэж байсан бололтой. Ялангуяа бэрээдэх шийтгэлийг бусдаас илүү их хэрэглэж байсан нь баримтаас илэрхий харагднам.

Нэгдсэн улсад хишигтэн цэрэг ээлжээ нэг удаа тасалбал 3, хоёр удаа тасалбал 7, гурав дахь удаагаа тасалбал 37 удаа бэрээдэх, дайн балдааны үед нууцыг задруулбал 100 удаа бэрээдэх, хулгайлсан эд нь чухал бус бол бэрээдэх ял оногдуулна хэмээн хууль цаазад заасан байна. Ж.Вернадский “Ямар нэг ноёдын гэм буруутай байдал илэрвэл, тушаалаас нь халах хэрэгтэй болдог байна” /16.31/, “Цэргийн нэгтгэлийн удирдагч анги нэгтгэлээ удирдах чадваргүй болсон тухайд зэрэг бууруулж шийтгэнэ.” /16.28/ гэж бичсэн нь төрийн албан тушаалтныг халах, тушаал бууруулах явдал түгээмэл байсны илрэл болно.

Монголын нууц товчоонд Чингис хааны зарлиг шийдвэрийг биелүүлэхгүй, байлдааны явцад олзоо хуваасан цэргийн жанжнуудыг цэрэг захиран командлах тушаалаас нь огцруулсан баримт бий бөлгөө. Цэргийн үйл ажиллагаа, захирах захирагдах журам, аж ахуйн горим журам зөрчсөн олон үйлдэлд торгуулийн шийтгэлийг хэрэглэж байжээ. Сайшаал “Чингис хааны товчоон”-ны 50-р зурваст “морь хулгайлсныг үнэ ёсоор төлүүлэхээс гадна бас мөнгөөр торгоно” гэж бичсэн байна. Санаатай бусаар хүн алах, бага хэмжээгээр мал хөрөнгө хулгайлах хэрэг үйлдэгсдэд торгуулийн ял оногдуулж байжээ.

Монголын нэгдсэн улсын ялын бодлогод торгох ял нэн онцлог байр эзэлж, монголчуудын аж амьдралын өвөрмөц шинж, ялын нөлөөлөх чадвар, үндэсний хандлагыг илэрхийлж байжээ. Торгох ял нь монголчуудын амьдралын гол хэрэгслийг /барьж авсан/ аваад амьдралд нь шууд хохирол учруулан нөлөөлөх учир ач холбогдолтой байсан ажгуу. Үүнийг нэгэн баримтаар жишээлэн авч үзье. Сайшаал Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль, товчоон”-ны нэгэн зүйлд “Хулгайлагдсан морь хэн нэгнээс олдвоос уул эзэнд нь адил зүсмийн 9 морь өг” хэмээн Чингисийн хаан улсын хуульд заасныг өгүүлжээ. Үүнээс үзэхүл : Нэгд, торуульд өгөх зүйл нь монголчуудын амьдрал, аж ахуйд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэдэг мал байсан. Хоёрд, торгохдоо хулгайлсан нэг малыг есөн мал болгон өсгөн авахаар тогтоосон нь хулгайн хэрэг үйлдэхэд учрах хор уршиг нь мэдэгдэхүйц өндөр байх хуулийн бодлого байсныг харуулна.

Монголын нэгдсэн улсын хууль цаазад зарим ял зөвхөн нэмэгдэл ялын хувиар үйлчлэхийг тодорхойлон заасан байдаг бөлгөө. Хөрөнгө хураах ял чухам ийм нэмэгдэл ял байсан ажгуу.

Сайшаалын бичсэн “Ерөнхий хууль буюу Чингис хааны үндсэн хууль, товчоон”-ны 51-р зурваст “Хулгайлагчдыг алах бөгөөд түүний гэргий, мал хөрөнгийг нь хураана”, 52-р зурваст “Боол хүн бусдын юмыг хулгайлбал тэрхүү боол ба боолын эзнийг алах ялаар шийтгэж тэдний гэргий ба мал хөрөнгийг хураан авмой” /76.435/ хэмээн заажээ. Ийнхүү цаазаар аваачих үндсэн ялыг оногдуулахын хамт хөрөнгийг нь хурааж тэр нь нэмэгдэл ял болон үйлчилж байжээ.

Монголын нэгдсэн улсын ялын бодлого, ялын төрөл, хэлбэр, ял оногдуулах, эдлүүлэх зарчим журам нь их тулгар улсын тусгаар тогтнол, нийгэм эдийн засаг, улс төрийн тогтолцоо, иргэн ба төрийн хоорондын харьцаа, шинж төлвийг тусган илэрхийлж их монгол улсын оршин тогтноход нэгэн чухал нөхцөл болсон ажгуу гэхэд эргэлзэх нэгэн үгүй буй заа.

Монгол оронд хэмжээгүй эрхт хаан хүний эрх хэмжээ бүрэлдэн төлөвшиж, Их Хурилдай, Сэцэдийн зөвлөлийг төрийн зохион байгуулалтад өвөрмөц байр эзлүүлэн,

яамгүй төрийн сайдыг томилон ажиллуулж, аравтлах системийг засаг захиргаа, цэргийн байгуулалтын үндэс болгон хүчирхэг арми, нэр хүндтэй төрийн түшмэдийн тогтолцоог бүрэлдүүлэн тогтоосон нь хаант улсын төрийн байгууллагын гол агуулга мөн.

“Их засаг” бол монголын соёл иргэншлийн түүхэнд эргэлт гаргасан үед үйлчилсэн нүүдлийн маягийн амьдралын хэв шинжтэй, дэлхийн хэмжээний ач холбогдол бүхий хууль зүйн чухал дурсгалт бичиг мөн.

Тэр нь Монголын нэгдсэн улсын амьдралд асар чухал роль гүйцэтгэж тус улс оршин тогтож, мандан хөгжихийн хууль зүйн үндэс болсон ажгуу.

“Их засаг” нь өөрөөсөө өмнөх хууль цаазын өв уламжлалыг шингээн монгол угсаатны нэгдсэн улсын нийгэм төрийн байгуулал, төрийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааг явуулах журам, монголчуудын иргэн, аж байдал, гэр бүлийн харилцаа, эрүүгийн бодлого, гэмт хэргийн төрөл, ялын хэлбэр, ял оногдуулах, эдлүүлэх горимыг хуульчлан тогтоосон өргөн баялаг агуулгатай алдарт хууль байжээ хэмээн тодорхойлон хэлж болно.

Чингисийн “Их засаг” нь Монгол хуулийн цаашдын дэвшил хөгжилд түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн, түүний бодлого, чиглэл, зарим заалтуудын агуулга, хэм хэмжээнүүд нь уламжлагдан хадгалагдаж ирсэн ба одоо ч хадгалагдсаар байна.

“Их засаг” -ийн өв сан арвин баялаг. Түүнд Монгол орны онцлог, аж амьдралыг өвөрмөц хэв шинж, монголчуудын сэтгэн ухаарах чадавхи, унаган дүр төрх, хүсэл тэмүүлэл гүнзгий шингээстэй агаад сонирхол татам болой. Түүний уламжлалаас суралцах ажил үйлс, аж амьдралдаа болгоон тунгаах зүйлс үлэмжхэн байдгийг мэдвээс буян болох буй заа.



ГУТГААР АНГИЙН ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. *“Сайшаал”*- 1930 онд Өвөрмонголын чуулганы мянганы хошууны 14-р сумын Сартугуд Баянбуу овогт малчин Рашдонровын гэрт төрсөн. Тэрбээр монгол хэл, түүх угсаатны зүй, ялангуяа Чингис хааны талаар 1970-1981 онд өргөн судалгаа явуулж 1981-1984 онд “Чингис хааны товчоон” хоёр боть зохиол туурвисныг 1985 оны 11-р сард Ардын хэвлэлийн хороо хэвлэжээ. Энэхүү хоёр боть зохиол Чингис хааны амьдрал үйл ажиллагаа, Монголын нэгдсэн улсын түүхийг судлахад чухал ач холбогдолтой тулгуур материал, түүхэн баримтуудыг агуулж буйн хувьд их үнэ цэнэтэй агаад өдгөө үедээ Хятад, Өвөрмонголд төдийгүй бусад улс оронд ч ихэд алдаршаад байгаа бөлгөө. Зохиогч бүтээлээ бэлтгэхдээ хятад, орос, япон, монгол хэлээр бичигдсэн Чингисийн холбогдолтой олон ном, материал, түүхэн баримтыг ашигласан нь энэ алдарт ном “мэндлэх” бодит хүчин зүйл болж, Чингисийн удам гарвалаас эхлээд Чингис хааны насан өөд болох хүртэлх бүх түүхийг багтаасан нэг ёсондоо Чингис хааны түүх болой. 10 бүлэг, 71 хэсэг, 292 зурвас, дагалдвар 150 зураг бүхий энэ хоёр боть алдарт зохиолыг 2003 онд Батжаргал монгол бичгээр хөрвүүлэн хэвлүүлсэн бөлгөө.

2. *“Доссон(D’ohsson)”*- Армяны дорно дахин судлаач, түүхч, 1780 онд Константинополь хотод төрсөн. Шведийн гадаад яаманд түшмэлээр ажиллаж байсан. “Монголын түүх” хэмээх алдарт 4 боть номоо франц хэлээр 1824-1852 онд бичиж хэвлүүлсэн байдаг. Эл номонд дундат зууны үед Ази, Европод оршин амьдарч байсан монголчуудын түүхийг маш нарийн бичсэн учир монголчуудын түүхийг судлахад нэгэн бүтэн үе болсон үлэмж ач холбогдолтой юм. Зохиогч өөрөө турк, араб, перс болон өрнө дахины олон хэл мэддэг агаад энэ нь мөн олон хэлээр бичигдсэн материалыг ул суурьтай ашиглахад нь нөлөөлжээ. Зохиогч 1855 онд Берлинд нас барсан ажээ. Энэ зохиолын эхний хоёр боть 1824 онд, дөрвөн ботиороо 1858 онд хэвлэгдсэн болой.

3. *“Ж.Саундерс”*- Английн Кентерберийн Их сургуулийн профессор, монгол судлаач нэрт эрдэмтэн. Тэрбээр Монголын түүх уламжлалын талаар бүрэн судалгаа хийж, өрнө, дорно дахинд Чингисийн амьдрал, үйл ажиллагаа, монголчуудын өвөг дээдсийн тухай бичсэн нэрт эрдэмтэд, судлаачдын суурь зохиолуудыг толгой дараалан уншиж, судалж “Монголчуудын байлдан дагуулал” гэсэн алдарт зохиол бичиж, түүндээ монгол нутагт оршин тогтнож байсан Монголын эзэнт гүрнээс харь оронд явуулсан аян дайны тухай өгүүлсэн бөлгөө. Зохиогч, монголчуудын байлдан дагууллыг Хүннүгийн үе, Түрэгийн үе, Монголын их эзэнт улсын үе гэсэн гурван үед хуваан үзэж, тус бүрд явагдсан байлдаан, түүний үйл явц, шинж чанар, онцлогийг тодорхойлсон нь үнэнхүү их ач холбогдолтой болой. Маш сайн бичигдсэн, ховорхон зохиолын тоонд орох том бүтээл мөн.

4. *“Гарольд Лемн”*- Америкийн түүхч, Чингис хааны амьдрал, үйл ажиллагааг их хүч, цаг зарж гүнзгий судалсан нэрт хүний нэгэн. Түүний бичсэн “Дэлхийн эзэн Чингис хаан” хэмээх томоохон зохиол нь 1928 онд Лондон хотноо хэвлэгдсэн ажгуу. Энэ зохиолд Есүхэй баатраас эхлээд Чингис хааны түүх, амьдрал тэмцэл, байлдан дагуулал, түүхэнд эзлэх байр суурь, их хааны эрдэм ухаан, авьяас билэг, үйл хэрэг, үзэл бодлыг хар, цагаан аль аль өнцгөөс нь харж шударгаар өгүүлсэн байдаг нь гайхалтай. Тэрээр ховор эх сурвалжуудыг хэрэглэснээс гадна “Понс Д’обон, Томас де Спалат, Леон Каэн, Деметриус Булгавр, генерал Перси Сайнс, Стенли Лейн Пул, Пети де ла Круа нарын бүтээлд тулгуурлан” /17.6/ барууны томоохон бүтээлүүдийн ололтыг ашигласан нь чухаг болой.

5. *“В.Я.Владимирцов”*- Оросын хятад, монгол судлаач нэрт эрдэмтэн. Монгол судлаач эрдэмтний хувьд монголчуудад ихээхэн ойр дотно бөгөөд мөн тэдний түүх амьдралд гүнзгий нэвтрэн орж, мөн тэдний сэтгэлд шингэсэн “Чингис хаан”, “Монголчуудын нийгмийн байгуулал” хэмээх алдарт зохиолуудыг туурвисан. Владимирцовын зохиолууд дэлхий дахинаа алдаршиж монголын түүх ба Чингис судлалд түүхэн том амжилт авчирсан юм. Эдгээр нь эрдэм шинжилгээний их үнэт зохиолууд болой.

6. *“Рене Гресс”*- Францын дорно дахиныг судлаач эрдэмтэн. Францын академийн гишүүн. 1885 онд төрж 1952 онд нас барсан. Дорныг судлагч их эрдэмтэн “Азийн түүх” /4 боть/, “Алс дорнотын түүх”, “Хятадын түүх”, “Армяны түүх” хэмээх томоохон зохиолуудыг туурвижээ. Р.Гресс дорнын улсуудаас Монгол улсын түүхийг судлахад илүү их анхаарал тавьж хэд хэдэн томоохон зохиол бичсэн, нэрд гарсан монгол судлаач болно. Тэрээр “Талын эзэнт гүрэн”, “Монголын эзэнт гүрэн” гэсэн зохиолууд бичжээ. “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” гэсэн зохиол нь Ч.Баатрын орчуулгаар монгол хэлээр 2003 онд хэвлэгдсэн бөлгөө. “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” зохиол нь Чингис ба Чингис хааны их авьяас чадвар, онолын гүнзгий мэдлэг, дэлхийн хэмжээний их хүн, аугаа хаан, гарамгай жанжин, нигүүлсэнгүй хүмүүнлэг үзэлтэн, түүхнээ эерэгээр үзүүлсэн нөлөөтэй талыг бодитой баримтаар нотлон гаргаж тавьсанаараа онцгой бүтээл хэмээн үзвээс зохилтой ажгуу.

7. *“Мэнлиг эцэг”*- Хонхатны Чарха өвгөний хөвгүүн, Есүхэй баатрын шадар хүн. Гэргий, хүүхдүүдийг минь харин хамгаалж явахыг гуйсан Есүхэйн гэрээсийн дагуу “Өүлэн Үжинд бараа болж, хүүхдүүдэд нь түшиг болж явсан ачтан хүн. 1190 онд Мэнлиг эцэг долоон хүүхдээ дагуулан ирж Тэмүжинтэй нэгджээ. Тэрбээр Тэмүжинд ухаан санаа их зааж, зөвлөдөг байсан аж. Тэмүжин ч түүний үг, зөвлөгөөг эцгийнхээ юм шигээр хүлээн авдаг байж. 1206 онд Чингис хаан Мэнлигийн гавьяат үйлсийг “төрөхөд төрөлцсөн, өсгөхөд өсгөлцсөн, Өлзий хутагт чиний тус ивээл чинь хичнээн

их ажгуу” гэж үнэлээд мянганы ноён болгож “суудлын эхэн талд суулгаж, он сар / бүрийд/ саатаж, өглөг соёрхол өгч, ургийн ураг хүртэл үүрд мялааж атугай” /51.180/ гэж зарлигласан болой.

8. “Буур хээрийн тулалдаан”- Тэмүжин, Хэрэйдийн хан Тоорил ван, Жамух сэцэн нартай хүч хавсран 1179 оны намрын дунд сард Мэргэдийн цэрэгтэй байлдсан тулалдаан. Тэмүжин, Тоорил, Жамух нарын цэрэг Онон мөрний эхэн дэх “Будаан Буурчи” гэдэг газар нийлж, өвсөн салаар их голыг гатлан “Буур хээр” гэдэг газарт Мэргэдийн гол хүчийг гурван талаас нь дайран цохиж, “Бөртэ” үжинийг чөлөөлөн ялалт байгуулжээ.

Энэ тухай “Монголын нууц товчоо”-ны 109-113-р зүйлд тодорхой бичсэн байдаг бөлгөө. Тэмүжин, Тоорил, Жамуха нарын цэрэг мэргэдийн их хүчийг бут цохисон энэ байлдааныг түүхэнд “Буур хээрийн тулалдаан” гэж нэрлэсэн нь энэ буюу.

9. “Балжид нуурын тангараг”- Уруд, Мангуд, Хонгирад, Жадран, Хатигин, Салжиуд, Тайчууд аймгууд дагаж орсны дараа Чингис, түүний 19 анд нөхөд Балжиуд нуурын дэргэд цугларан их улсыг байгуулж мандуулахын төлөө үүрд хамтран тэмцэнэ хэмээн тангараг өргөжээ. Үүнийг түүхэнд “Балжиуд нуурын тангараг” хэмээн алдаршсан түүхтэй. Энэ нь Чингисийн зорилго, хүчийг мятрашгүй болгож, түүний талынханы эв нэгдэл, хүч чадлыг асар их нягтруулан нэмэгдүүлсэн гэдэг.

10. “Арван гурван хүрээний тулалдаан”- Тэмүжин, Жамуха нарын хоёр тал тус бүр 13 хүрээгээр цэргээ зохион байгуулан Туул голын хар шугуйн Далан Балжид гэдэг газар хийсэн байлдаан. Энэ байлдааныг түүхэнд “Арван гурван хүрээний тулалдаан” гэдэг бөгөөд тулалдаанд Жамухын цэрэг ялж, Чингисийн цэрэг ялагдсан ажгуу.

11. “Улз голын дайн”- 1196 оны орчим Тэмүжин, Тоорил хан нар хүч хавсран, Татарын Мэгүжин-сүүлт, Алтан хааны Вангин Чинсан нарын хооронд явагдаж буй дайнд Чинсаны талд орж тулалдсан байлдаан. Тэмүжин, Тоорил нарын цэрэг Улз голын Хусуту Шитүэн, Нарату гэдэг газар Татарын Мэгүжин-сүүлтийн цэрэгтэй байлдаж ялжээ. Энэ ялалтыг Алтан хааны Ванчин Чинсан үнэлж, Хэрэйдийн Тоорилд “ван” цол шагнасан бөгөөд түүнээс хойш Тоорилыг ван гэж нэрийдэх болсон гэдэг. Энэ дайн нь түүхнээ “Улз голын дайн” гэж тэмдэглэгдсэн байдаг бөлгөө.

12. “Буйр нуурын орчмын тулалдаан”- 1200 оны өвөл Тэмүжин, Ван Тоорилын цэрэгтэй хамтран Буйр нуурын орчим Татарын холбоотны цэрэгтэй тулалдаж ялалт байгуулжээ. Үүнийг түүхэнд “Буйр нуурын орчмын тулалдаан” хэмээн тэмдэглэжээ.

13. “Далан нөмрөгийн тулалдаан”- Хар нохой жил буюу 1202 оны намар Тэмүжин эцсийн удаа буюу гурав дахь удаагаа татарыг дайлж “далан нөмрөг” гэдэг газар Цагаан татар тэргүүтэй татарын цэргийн үлдэгдэл хүчийг бут цохисон эл байлдааныг түүхэнд “далан нөмрөгийн тулалдаан” гэж нэрлэж иржээ.

Олон татар эрчүүдийг байлдах явцад устгаж, үлдэгдэл хэсгийг нь тэрэгнээс чирж алан, эмс, охидыг нь боол шивэгчин болгон, боржигон, татар хоёрын хоорондын үе уламжлагдсан ургийн хонзон, Есүхэй баатрыг хорлон алуулсан өшөөг авсан харгис үйлдэлтэй тулалдаан хэмээн түүхэнд үздэг /24. 49/.

14. “Хүйтний тулалдаан”- 1202 онд нэг талаас Тэмүжин, Ван хан, нөгөө талаас Жамуха түүний холбоотны хүч “хүйтэн” гэдэг газар тулалдсан байлдааныг түүхэнд ийн нэрлэж ирсэн ажгуу. Энэхүү байлдаанд Тэмүжин, Ван хан ялалт байгуулж, монголыг нэгтгэх гэсэн Тэмүжиний үйл ажиллагааг тасалдуулах гэсэн сөрөг хүчний тэмцэлд цохилт өгсөн ач холбогдолтой.

“Хүйтэн” гэдэг газар чухам хаана байгааг судлаачид янз бүрээр тайлбарлаж ирсэн бөгөөд түүний дотроос Х.Пэрлээгийн Онон, хэрлэнгийн хооронд буй “Хүйтэн шуусыг” мөн хэмээн хэлснийг үнэнд дөхөж очсон бололтой гэж академич Ч.Далай онцлон тэмдэглэсэн байдаг. /24. 49,50/

15. “Муу өндөрийн тулалдаан”- 1203 оны хавар Тэмүжин, Тоорил вангийн цэрэгтэй байлдсан хамгийн их хүч шаардсан, цар хүрээ өргөнтэй, үр дагавар ихтэй тулалдаан байжээ. “Муу өндөр” хэмээх газар нь хаана байдаг тухай эрдэмтэд өдгөө хүртэл маргалдсаар иржээ. Нэгэн хэсэг эрдэмтэд Өвөрмонголын Хишигтэн хошуунд байдаг “Муу өндөр” мөн гэжээ. Бас зарим эрдэмтэд “Улаан бутан”-г хэлж буй гэнэ.

Миний бодлоор бол Халхын гол, Нөмрөгийн гол хоёрын хооронд “Муу өндөр” гэдэг газар байдаг бөгөөд тэр нь дээрх “Муу өндөр” мөн бололтой гэж Х.Пэрлээ доктор бичсэн нь ортой мэт байна хэмээн академич Ч.Далай амбугай өчсөн бөлгөө /24.50/. Энэ байлдаан нь Тэмүжинээс Ван хантай хийсэн их ялалт, нэр хүнд явчирсан шийдвэрлэх тулалдаан байжээ.

16. “Нахуу гүний тулалдаан”- Тэмүжин, Найманы Таян хан нарын хооронд болсон сүрт байлдааныг түүхнээ “Нахуу гүний тулалдаан” хэмээн нэрлэж иржээ. 1204 оны хавар болж хэд хэдэн өдөр шөнө үргэлжлэн явагдсан энэ тулалдаанд Тэмүжин, Таян хааны цэргийг ялан, бүх албатыг нь хураан мэдэлдээ авсанаар дуусчээ. Найманыг байлдан эзэлсэнээр Монголын нэгдэл үндсэндээ хангагдсан ажээ /24.51/.

17. “1206 оны Их Хуралдай”- 1206 он буюу Барс жил Онон мөрний хөвөөнөө чуулж, Монголын нэгдсэн улс байгуулсныг тунхаглан, Чингисийг их хаанд өргөмжилсөн алтан ургийнхан, ноёд язгууртны их хуралдаан.

Эл хуралдааныг “Их Хуралдай”, төрийн чуулган гэж нэрлэж ирсэн авч “Их Хуралдай” гэх нь илүү оноосон нэр болно. “Их Хуралдай” нь Монголын нэгдсэн улс, Монгол гүрний төрийн зохион байгуулалтын оргил болж, Монгол төрийн дээд ёсон төлөвшин хөгжихөд энгүүн их үүрэг гүйцэтгэж, цааш цаашид монгол төрийн амьдралд эрхэм нандин өв уламжлал болж уламжлагдсан бөлгөө.

18. **“Сорхон Шар”**- Тайчуудын цэрэгт баригдаж хорлогдох аюулд нэрвэгдсэн Тэмүжиний амь насыг аварч, тэлээ хурга чанан, хөхүүр айраг, нэг нум, хоёр сум өгч, хулагч гүүгээ унуулан гэр лүү нь явуулж тусалсан ачтан буурал. Тэмүжинийг Сорхон Шарын гэрт очиход хүү Чимбай, Чулуун хоёр нь “Болжмор харцаганд хөөгдөж бутны ёроолд хоргодоход бут түүнийг хамгаалан авардаг биш үү хэмээн” эцгээ буруушаан дөнгийг нь эвдэн галд түлж, Тэмүжинг унгаст хар тэргэнд нуув. Чулуун, Чимбай хоёрын охин дүү Хадаан Тэмүжинд хоол унд өгч асрав /51.51/ Сорхон Шар 1202 онд Чингис хааны цэрэг Тайчуудыг байлдаж ялсны дараа Тэмүжинд ирж нийлсэн байдаг. Тэмүжингээс Сорхон Шар түүний хөвгүүд, охинтой нөхөрлөсөн холбоо насан туршид нь хадаглагдсан ажгуу. 1206 онд Монголын нэгдсэн улсыг байгуулах үеэр Чингис Сорхон Шарын төрд байгуулсан гавъяаг үнэлж “дархан” цол хүртээн, олон удаагийн ослоос хэтрүүлэх, дайнд олсон олз, агнасан аваа өөрөө авах онцгой эрх олгон, Сэлэнгэд нутаг заан өгч дархалжээ /52.219.145-146/. Сорхон Шар нь Чингисийн есөн өрлөгийн нэгэн, мөн 88 гавьяатад дээгүүрт ордог итгэлт хүн болой. Тэрбээр гэр орноороо Чингист зүтгэж, үнэнчээ харуулсан гавьяатан ажгуу.

19. **“Дай сэцэн”**- Чингис хааны хадам эцэг. Хонгирад аймгийн нөлөө бүхий, буурь суурьтай, холч хараатай, ухаалаг баян хүн. Бөртэ хатны хайртай эцэг. Тэрбээр хүргэн Тэмүжингээ ихэд хүндэтгэн, ямагт үнэнчээр хандаж, худ ургийн ариун холбоо ямар байхыг өөрийн биеэр үлгэрлэн харуулсан жинхэнэ эр хүмүүн байсан ажаамуй. Нэгэн удаа Хонгирад аймаг, Татартай хамтран хуйвалдаан зохион байгуулж байгааг мэдээд Чингисдээ хэл хүргэн сэрэмжүүлсэн байдаг.

Дай сэцэний хүү, Бөртэ хатны дүү Алчи ноён Чингисийн 88 гавьяатны нэгэн байжээ.

20. **“Бөртэ”**- Хонгирад аймгийн тэргүүн Дай сэцэний охин. 1161 онд төрсөн. Тэрбээр, үзэсгэлэн төгс, ухаалаг, хүмүүнлэг, чин сэтгэлтэй, нөхөртөө үнэнч монгол эмэгтэй байсан аж. Чингис хааны насан туршийн үнэнч хань, төрийн дөрвөн хатны манлай, дотно зөвлөгч нь байв. Бөртэ хатнаас төрийн багана болсон Зүчи, Цагаадай, Өгөдэй, Тулуй хүү, Тэмүүлэн хэмээх охин төрсөн нь бүгд төрийн зүтгэлтэн, нэрт жанжнууд болон өсөн төлөвшиж, Их Монгол улсыг байгуулан бэхжүүлэхэд үнэнхүү их үүрэг гүйцэтгэн түүхнээ мөнхөрсөн гавьяатай болой.

21. **“Хубилай”**- Барулас овогтон. 1180 оноос Жамухаас салж Тэмүжинтэй нэгдэн “илдэч”-ээр /бие хамгаалагчаар/ ажилласан. Наймантай байлдахад хошуучлан байлдаж онцгой гавъяа байгуулсан. Монголын нэгдсэн улсыг байгуулахад их үйлс бүтээсний учир есөн өрлөгийн нэг болж, цэргийн хэргийн сайд, мянганы ноёноор томилогдож, 88 гавьяатны тоонд багтан оржээ. Цэргийн нэрт жанжны нэг. 1209 оны орчим нас барсан.

22. *“Сүбээдэй”*- Жарчиуд Урианхай овогтон. 1176 онд төрсөн. Хабулын хоёр дахь хүү, дээд өвөг нь Нарчи гэдэг хүн байжээ. 1189 онд Зэлмийн хамт Тэмүжинд нийлжээ.

Чингисийг биеэр дайлах болгонд Сүбээдэй хамт явж, байлдааны тэргүүн эгнээнд тулалдаж явсан эрэлхэг зоригт баатар. Өрнөд, өмнө зүг рүү хийсэн их аянд цэргийн толгойлох жанжнаар ажиллаж, асар их гавьяа, нэр сүрийг олж, Их Монгол улсын гурван Далай хаанд шударгаар зүтгэж гандан бууршгүй гавьяа байгуулсан их жанжин, цэргийн нэрт зүтгэлтэн болой.

Чингисийн есөн өрлөг, дөрвөн нохос, 88 гавьяатны нэгэн. 1248 онд 73 насандаа насан өөд болжээ.

23. *“Худуга бэхи”*- Ойрад түмний тэргүүн. 1207 онд Зүчи жанжныг ойн иргэдийг дайлах үед түмэн ойрдоо захирч, бусад ноёдынхоо хамт угтан золгож, Монголын нэгдсэн улсад даган орж нэгдсэн.

Мянгатын ноёдоо дагуулан, цагаан шонхорууд, цагаан морьд, хар бугануудаа бэлэглэн их хаанд бараалхахад Чингис хаан ихэд талархаж, Худуга бэхийн хөвгүүн Иналчид Чичэхэн охиноо, ах Төрэлчид нь Зүчийн охин Олуйханыг гэргий болгон өгсөн түүхтэй.

24. *“Дархалсан нутаг”*- Чингис хаанаас Монголын нэгдсэн улсыг байгуулахад их гавьяа байгуулсан зарим язгууртнуудад олгосон газар нутаг, эл үеийн газар эзэмшлийн нэгэн хэлбэр. Чингис хаан, Сорхон Шар, Хорчи, Илжигдэй ноён нарт тодорхой газар нутгийг дархлан олгосон байдаг бөлгөө. “Дархалсан нутаг”-ийг эзэмшигчид нь уул газар нутгийг түүн дээр оршин амьдарч байгаа иргэдийнх нь хамт харъяалан мэдэж, эзэмших, ашиглах бүрэн эрхтэй байжээ. Дархалсан газар нутгийн эзэд нь уул газар нутгаа үе улираан эзэмшиж, оршин амьдрагчид нь улсын алба үүргээс чөлөөлөгдөн, зөвхөн ноёндоо зүтгэн алба гувчуур төлөх үүрэгтэй байсан болой.

25. *“Соёрхлын газар”*- Чингис хаанаас алтан ургийнхандаа зарлиглан олгосон газар нутаг-өрх иргэд. Их хаанаас Өүлэн эх, Отчигин ноён, Зүчи, Цагаадай, Өгөдэй, Тулуй, Хасар, Алчидай, Бэлгүтэй, Шихихутуг, Хуйлдар сэцэн, Борохул жанжны эхнэр, хөвгүүдэд тодорхой газар нутаг, өрх иргэнийг соёрхон олгож, үүрд эзэмшүүлэн өгсөн нь “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэн байдаг бөлгөө. Соёрхон олгосон газар нутаг дээр оршин амьдардаг өрх иргэд зөвхөн эзэндээ үйлчлэн алба гувчуур төлөх үүрэгтэй. “Соёрхлын газар” нь Монголын нэгдсэн улсын газар эзэмшлийн нэгэн өвөрмөц хэлбэр байсан болой.

26. *“Елюй Чуцай”*- Хятадын гүн ухаантан, хятан омгийн хүн. 1190 онд Бээжингийн баруун үзэсгэлэнт ууланд Дунданы Ван Елюй Абужингийн ахмад хүү болон төрсөн.

Багаасаа ном эрдэмд суралцаж, 17 настайдаа хятад хэл бичгийг маш сайн мэддэг болжээ. Эрдэм номоороо шалгарч Алтан улсын хааны ордны бичгийн түшмэл болсон. Монгол цэрэг Алтан улс, түүний нийслэл Чжэндуг эзлэх үед монголчуудад олзлогдон, Монголын нэгдсэн улсын төрд зүтгэхээр сэтгэл шулуудаж, хүчин зүтгэсэн түшмэл. Номд мэргэн, одон орон, ардын эмчилгээнд мэргэшсэн, монгол цэрэг, нутгийн иргэдийг эмчлэгч, ядууст туслагч нигүүлсэнгүй үзэлтэн, төрийн жинхэнэ түшээ хүн байсан ажгуу. 1219 онд Чингис хаан баруун зүг аян дайн хийхэд түүнийг дагалдан Дундат Азид очиж ордны түшмэлээр нь ажиллаж байжээ.

Энэ үеийн амьдрал, үзсэн харсан, хийсэн бүтээсэн зүйлийнхээ тухай “Баруун газар зорчсон шастир” /Си-ни Лу/ тэмдэглэл бичсэн нь Чингис судлалд нэгэн чухал хэрэглэгдэхүүн болдог бөлгөө. Елюй Чуцай, Чингисийг хүндэтгэж, ихэд тоон хайрладаг хүн байсан бөгөөд төр, улс, цэрэг армийг удирдахад нь оюунлиг ухаанаар тусалж, их нэр төр, сүр хүчийг олохыг нь хичээнгүйлэн дэмжиж байсан аж. Чингисийн шулуун шударга занг ихэд үнэлдэг байжээ. Чингисийг нас барсны дараа Елюй Чуцай Өгэдэй хааны төрийн сайлаар ажиллаж байсан бөлгөө. Елюй Чуцайн гэрийг үзэхэд алт, мөнгө, эрдэнэс бус хөгжмийн зэмсэг, ном, гар бичмэлүүд, зураг, янз бүрийн бичээс бүхий самбар, чулуунуудаас өөр юу ч гараагүй гэдэг.

27. “Тататунгаа”- Уйгар хүн. Найманы хант улсын Таян хааны тамгын түшмэл байж, хатуу хас чулуугаар сийлсэн төрийн тамгыг хариуцан барьж байсан. 1204 онд Найманы хант улсыг мөхөхөд монгол цэрэгт баригдан, монголын нэгдсэн улсын төрд зүтгэх болжээ. Төрийн ёс, үсэг бичиг сайн мэддэг. Тататунгаа 1206 оноос Чингис хааны төрийн сайд, хааны тамга баригч болж их төрд зүтгэсэн ажгуу. Тататунгаа Өгэдэй хааны үед мөн түүний ордны сайдаар ажиллаж байсан бөлгөө. Тататунгаа Чингисийн хүүхдүүдэд бичиг үсэг зааж сурган, монголын нэгдсэн улс бичиг үсэгтэй болоход түүхэн үүрэг гүйцэтгэсэн буянтай хүн билээ.

28. “Чингай”- Чингисийн төрийн сайд. Чингис хааныг баруун зүг аян дайн хийх үед Хангай Алтайн уулсын хооронд орших хааны ордонд төрийн сайдаар, бас Өгөдэйн үед түүний төрийн сайдаар ажиллаж байсан нэрд гарсан төрийн зүтгэлтэн. Бичиг үсэг төгс мэддэг, эрдэм ухаанаар арвин, төрийн хичээнгүй сайд байжээ.

29. “Ха-Лай-И-Ха Пэйлу”- Уйгур түшмэл. Уйгур улс Монголын нэгдсэн улсад дагаар орох үеэс Монголын төрд хүчин зүтгэсэн бичгийн хүн. Чингис хаан, бичиг эрдэмтэй уйгур түшмэлийг дотночлон хүндэтгэж, хан хөвгүүдийнхээ бичгийн багшаар томилон ажиллуулж байжээ. Тэрбээр Тататунгаагийн хамт Монгол үндэсний бичиг зохиох, хэрэглэхэд хувь нэмрээ оруулсан гавьяатай хүн.

30. “Ле-зун-Лу”- Чингисийн шадар бараа бологч, эмч. Хятад үндэстэн. Бичиг үсэг, эрдэм ном сайтай, монгол хэл мэддэг, нигүүлсэнгүй үзэлтэй хүн.

Чингисийг хүндэтгэн биширч, түүнд үнэнчээр зүтгэхээ тангараглан дэргэд нь байхыг зөвшөөрсөн ажээ. Тэрээр Чингисийн бараа бологч, эмчлэгч эмчээр нь ажиллаж байсан соёлтой нэгэн байсан болой.

31. “Чан-Чунь бомбо”- Хятадын гүн ухаантан. 1148 онд Шандунь мужад төрсөн. Багаасаа хуврага болж, бомбын ёсонд гүнзгий нэвтэрсэн, эрдэмт хүн. Түүний эрдэм ухааныг сонсоод ихэд биширсэн Чингис хаан, Чан-Чуныг өөртэйгээ уулзахыг 2 удаа урьсан байдаг. Чан-Чунь 1218 оны 12-р сарын 18-нд Хятадын шандунь нутгаас гарч Хятад, Монголын нутгийг нэвтрэн, дундаг Азиар 2 жил 4 сар шахам аялан 1222 оны 4-р сарын 5-нд Чингистэй биеэрээ уулзан, олон удаа ярилцаж санал бодлоо солилцсон байдаг. Чингис хаан суурин соёл иргэншил, эртний соёлтой Хятад улсын төрийн зохион байгуулалт, төр жолоодох, иргэнийг захирах арга ухааныг ихэд сонирхон яриулсан байдаг бөлгөө.

32. “Тангуд улс”- 1032 онд байгуулагдсан. Газар нутаг нь одоогийн Өвөрмонголын Ордос, Алаша, Эзэнээ болон Нинся, Ганьсу сужийн ихэнхийг хамарч байжээ. Тус улс нь дорно-өрнийг холбосон торгоны замын гол зангилаа болж байсан. Монголтой хиллэн оршдог, хаант улс. Тангудыг Хятадын шастир түүхэнд “Ся” /Ся-улс/, “Да ся” /Их Ся/ улс хэмээн нэрлэж байсан. Хожим нь Алтан улсаас салбарлан байгуулагдсан “Ся” улсаас ялгахын учир “Си-Ся” /Баруун Ся/ гэж бас нэрлэж байсан түүхтэй. Монголчууд Тангуд улсыг “Хашин улс”, иргэдийг нь “хашин иргэн”, хааныг нь “Хашин хаан” буюу “Илухай Бурхан” хэмээн нэрлэж байсан ажгуу. Тангуд улс 1227 онд Чингис хааны цэрэгт эзлэгдэн мөхсөн ажээ.

33. “Алтан улс”- Зүрчид угсаатны хаант улс. Алтан улс 1115 онд байгуулагдан, өмнүүрээ Шар мөрөн, зүүнээрээ Сунгари мөрөн, баруунаараа Хянганы нуруунд тулж, умард тал нь Монголын их говьтой зах нийлж байжээ. Алтан улс, Умард Хятадын Янжин хотоор нийслэлээ хийж, үг хотоо 1153 онд Чжэнду /Бээжин/ гэж нэрлэсэн түүхтэй. Алтан улс Монголын нэгдсэн улсын их цэрэгт удаа дараа ялагдсаар 1134 онд бүр мөсөн мөхжээ.

34. “Хорезмын улс”- Амударьяа мөрний адгаар байсан эртний соёл бүхий Дундад Азийн нэгэн том улс.

1200 онд Хорезмын хаан болсон шах Мухаммед, баруун Ляо улс, Узбекистан, Казакстан, Таджикстан, Киргистан, Бухар, Самарканд, Отрар хотуудыг эзлэн Лалын шашины хүчирхэг эзэнт гүрнийг байгуулж, нэр, нөлөө нь ихэд өссөн ажгуу. Хорезм улс нь Афганистан, Иран, Дундад Азийн нутаг дувсгэр, хүн амыг бүхэлд нь харьяалан захирсан асар том эзэнт улс байжээ. Чингис хаанаас 1218-1224 онд Хорезм улстай байлдсан дайны эцэст Хорезм улс сэхэшгүй болтлоо ялагдаж мөхсөн түүхтэй. Энэ дайныг түүхэнд “Дундад Азид хийсэн дайн”, “Туркестан-Афганистан ба Персийн

тулалдаан”, “Каспийн тэнгис хавийн буюу умард орны тулалдаан” гэх мэтээр нэрлэж байжээ.

35. “Зэб”- Бэсүд овогтой. Өвөг дээдэс нь Бэсүдэй. Нэр нь Зургаадай. Анхандаа Тайчуудын Агучу баатрын цэрэг байхдаа нэгэн байлдаанд Тэмүжиний унаж явсан ам цагаан хул морины хүзүүг харван шархдуулжээ. Байлдаан дууссаны дараа хэн шархдуулсныг асууваас нэгэн эр сөхрөн байж “Уулан ээрээс би харвасан билээ. Одоо хаанд алагдваас алгын чинээ газар өмхийрч хоцоръё” хэмээн өчөөд, хаанд хандан

Цээлийн усыг тасалж

Цэгээн чулууг

Цууртал довтолж өгье

Хүр хэмээсэн газарт Хөх гүрийг хэмхлэж

Халд хэмээсэнд

Хар гүрийг

Хамхартал довтолж өгье хэмээн соёрхон хэлжээ.

Чингис хаан ухварлан үзээд “Алсан, дайсагнаснаа үл далдлан /үнэн/ мөнөөр заан /хэлэх/ буюу нөхөрлөж болох хүн буюу. Зургаадай нэрт ажгуу. Мөн Зэблэх хун цагаан хулын минь аман хүзүүг харвасны тул Зэб гэж нэрлэж Зэб болгоё чамайг гэж Зэб хэмээн нэрийдэж, дэргэд минь бай” /51.93/ хэмээн зарлиг буулгажээ. Зэб ийнхүү Чингистэй нөхөрлөж, түүний төлөө үнэнчээр зүтгэн Чингисийн есөн өрлөг, 88 гавьяатанд багтаж, дөрвөн нохосын нэгнээр алдаршин, цэргийн алдар цуут жанжин болж, төрд их гавьяа байгуулсан ажгуу. Зэб жанжин 1255 онд нас баржээ.

36. “Тулуй”- Чингис хааны дөрөвдүгээр хөвгүүн. Түүнийг их ноён, өрлөг буюу аугаа их ноён хэмээн цоллодог. Тэрээр энэ нэрээрээ алдаршсан бөгөөд Чингис түүнийг “нөхөр” гэж дууддаг байв. Зүрх зориг, захирамжлах, шүүн хэлэлцэх талаараа түүнтэй зэрэгцэхүйц хүн байсангүй гэж Рашид-ад-Дин бичсэн байдаг /73.117/. Бичиг үсэг, эрдэм ухаантай, эцэг эх, ах нараа хүндэтгэх ёсыг төгс сахидаг, төрийг засах, цэрэг захирах ухааныг гарамгай эзэмшсэн, цэргийн алдарт жанжин байсан ажгуу. Чингисийн дэргэд үргэлж байж, хаан эцэгтээ үнэнчээр зүтгэдэг, их хаан байх бүрэн чадвартай эрхэм хүн байсныг бүгд хүлээн зөвшөөрдөг байжээ. Их хааны эрдэм ухаан, авъяас билэг, арга туршлагаас хамгийн ихийг сурсан нь Тулуй байв. Чингис хаан чухал, чухал бус бүх ажил хэргээ түүнтэй зөвлөдөг, түүнд бүрэн итгэдэг байжээ.

Тулуй монголын нэгдсэн улсыг байгуулан хөгжүүлэхэд хосгүй хувь нэмэр оруулсан түүхтэй. Тулуйн удмаас Монголын их хаан Мөнх, Аригбөх, Хубилай, Ираны хаан Хулагу /Үлэхү/ тодорсон бөлгөө. Мөнхөөс эхлэн Монголын их хааны суурийг Тулуйн үр хүүхдүүд 380 гаруй жил /1251-1634/ залгамжилсан. Тулуй 1233 оны орчим нас баржээ.

37. **“Хасар”**-Есүхэйн хөвгүүн, Чингисийн дүү. Алтан ургийн нөлөө бүхий гишүүн, удирдан жолоодох, цэрэг захирах чадвартай, бичиг үсэг мэддэг, авхаалжтай сэргэлэн, хурц ухаантай, цэргийн урлагт суралцсан алдарт жанжин бөлгөө. Их хаанаас дөрвөн мянган өрх иргэнийг соёрхон авч захирсан, өөрийн гэсэн үзэл бодол, итгэл үнэмшилтэй, монголын нэгдсэн улсын төлөө бүх хүч чадал авьяас билгээ зориулсан, шударга шулуун төрийн зүтгэлтэн байсан ажгуу. Хасар бол биеэр том, хүч чадал ихтэй, мэргэн харваач, байлдахдаа гарамгай эр зоригт баатар байсан бөгөөд “хүчит хасар” хэмээн алдаршсан ажээ. “Монголын нууц товчоо”-нд “Турван бухаар зүтгүүлэвч гулзайхгүй хүчтэй, гунжин үхрийг идэвч цадахгүй ходоодтой, хэдэн алд биедээ хэлхээ хуяг өмссөн ... урдах сумаа шүүрч ухасхийн харвахад уулын цаадах хүмүүс ч уул суманд оногдож ундуй сундуй үхэцгээнэ ... их дэлж харвал есөн зуун мод газар харвадаг, татуу дэлж харвал таван зуун алд газар харвадаг хүчит Хасар” /51.160.161/ хэмээн шүлэглэн магтсан нь Хасар чухам хэн болохыг яруу тод харуулам.

38. **“Отчигин”**- Чингис хааны дүү. Түүнийг их ван гэж дууддаг байжээ. Отчигины орд Халх голын хөвөөнд байсан гэж түүхнээ бичсэн байдаг. Есүхэйн отгон хүүгийн хувьд гал голомтоо сахин үлдэж, өөрийн Өүлэн эхтэй хамт амьдарч, Их хаанаас хуваарилан олгосон нэгэн түмэн өрх иргэнээ харьяалан амьдарч байжээ. Хааны алтан ургийн томоохон төлөөлөгч, бичиг боловсролтой, хичээнгүй нямбай зүтгэлтэн бөлгөө. Отчигин ноён дөрвөн зөвлөгчтэй байсан нь дөрвүүлээ мянганы ноён байв.

39. **“Бэлгүтэй”**- Чингис хааны эцэг нэг, эх ондоотой дүү. Есүхэйн Сочигэрэл хатны хүү. Чингис хаанаас 1500 өрх иргэнийг соёрхон авсан, алтан ургийн гишүүн. Монголын нэгдсэн улсыг байгуулахад их гавьяа байгуулсан. Цэргийн нэрт жанжин, Чингис хаан Бэлгүтэйг хүндэлж, хамгийн чухал зүйлдээ түүний тусламжийг авдаг байсан бөлгөө. Чингис хаан Бөртэ үжинийг гэрээс нь залахад Бэлгүтэй хамт явсан. Ван хаанаас тусламж гуйхад Бэлгүтэй мөн хамт явж байсан. Чингис Боорчийг шадарлан нөхөрлөө гэж санал тавихдаа Бэлгүтэйг илгээж байсан нь түүхэнд тэмдэглэгдсэн ажгуу.

40. **“Мухулай”**- Хятадаар “Го-Сян” /төрийн ван/ гэсэн утгатай. 1170 онд төрсөн Чингис хаан түүнийг Хариун, Жидүн гэдэг газар үлдээхэд Хятадууд ийм хоч өгсөн гэж Рашид-ад-Дин тэмдэглэсэн байдаг /46.60/. Энэ нэрийг Чингис хаан төрийн байгууллаа тогтоохдоо Жалайрын Мухулайд “гоо ван” гэсэн тушаал, цол олгосноор албан ёсны агуулгатай болсон ажээ. Энэ тухай Монголын нууц товчоонд “Мухулайд улсын ван цол өгөв” /32.132/ гэж бичсэн бөлгөө. Ингэснээр Ван цолтой улсын хэмжээний албан тушаал болж, хэрэглэгдсэн байна. Улсын ван нь хааны дараах /орлогч/ албан тушаал бий. Чингис хаан, Мухулайн орлогч нь байсан хүү Бэголыг ван гэж нэрлэсэн /46.60/ байдгаас үзвэл улсын ванг улсын эзний орлогч нь гэж үзэж байсан байж болох. Мухулай

нь зүүн түмэн түүний 62 мянган өрх иргэнийг захирч байв. Тэрээр Монголын нэгдсэн улсын төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин, Чингисийн есөн өрлөгийн нэгэн, 88 гавъяатанд дээгүүр ордог их хааны хамгийн нэр хүндтэй, шадар хүн байсан ажгуу. Чингис хааны нэн хүнд даалгаваруудыг Мухулай ямагт амжилттай биелүүлж байжээ. Мухулай Их хааны Хятад дахь төлөөний сайдаар ажиллаж байгаад 1223 онд нас барсан ажгуу.

41. “Боорчи”- Тэмүжиний анхны анд, Наху баяны хүү. Арулад удмын хүн, Тэмүжин 8 шарга морио эрж явах үед тааралдсанаас хойш түүнтэй насан туршдаа нөхөрлөж, Чингисийн үнэнч нөхөр, мэргэн зөвлөгч нь байсан бөлгөө. Боорчи бол Чингисийн төрд их гавьяа байгуулж, есөн өрлөг, 88 гавъяатны нэгэн болж, Баруун түмний захирагчаар ажиллаж байжээ. Монголын нэгдсэн улсын төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн сүрлэг жанжин хүн. Тэрбээр Чингис хаантай үргэлж шахам хамт байж, олон удаагийн байлдаан, тулалдаанд цэргийн жанжинаар томилогдон үүргээ ямагт нэр төртэй биелүүлж хатуужин боловсорсон гавьяат хүн болой. Иймээс Чингис хаан 1206 онд Монголын нэгдсэн улс байгуулагдах үед “Боорчи, Мухулай хоёр зөв явдлыг минь зүтгүүлж, бурууг минь больтол ятгаж, энэ оронд хүргэв. Эдүгээ бүхний дээр сууринд сууж, есөн эндэгдэлд бүү эндүүлтүгэй Боорчи баруун гарын Алтай дэрлэн /нутаглах/ түмнийг мэдтүгэй” /51.181/ хэмээн зарлиг буулгасан байдаг бөлгөө.

42. “Наяа”- Нүцгэн Баарины ширээт өвгөний хүү. Тайчуудын иргэн. Хулан хатныг Чингис хаанд ариун нандинаар нь хүргэн ирж итгэлийг олсон. Монголын нэгдсэн улсын төвийн түмний ноён. Цэргийн нэрт жанжин. Төрийн 88 гавъяатны нэг.

Ах Алаг нь төрийн 88 гавъяатны нэгэн байжээ. Наяа ноён Чингис хаанд үнэнч зүтгэж, Монголын нэгдсэн улсыг байгуулж бэхжүүлэхэд их хувь нэмэр оруулсан гавьяатай хүн.

43. “Шихихутуг”- Татар овогтон. Өүлэн эхийн өргөж өсгөсөн Чингисийн зургаадах дүү. Эрдэм номтой, бичиг үсэг мэддэг, шулуун шударга, хичээнгүй нягт, нэр хүнд төгс, төрийн алдарт түшээ, нэрт зүтгэлтэн хүн байсан ажгуу. Шихихутуг улсын заргач /шүүгчээр/ олон жил ажиллаж, нэрд гарч, төрд их үйлс бүтээсэн гавьяатан хүн болой. Тэрбээр мянганы ноён, төрийн 88 гавьяатан, Чингисийн есөн өрлөгийн нэгэн. “Шихихутуг бол XIII зууны үеийн монголын төрийн зүтгэлтний дотроос хамгийн өргөн боловсролтой бөгөөд ... монголын тулгар төрийн анхны гол хууль “Их Засаг”-ийг зохиоход оролцсон бололтой” /20.154-155/. Төрийн хуулийг боловсруулдаг, сайн мэддэг төдийгүй, хэрэгтнийг байцаан, гэм буруугий нь тогтоож, ял шийтгэл оногдуулдаг их туршлагатай, нигүүлсэнгүй түшээ байсан ажээ. Түүнийг “Их засаг” хуулийг бүтээж, “Монголын нууц товчоо”-г бичилцсэн хүний нэгэн хэмээн үздэг бөлгөө. Шихихутуг Чингис, Өгөдэй хааны төрд зүтгэсээр 83 насандаа өөд болсон гэдэг.

44. “Хубилай”- Барулас овогтон. Монголын нэгдсэн улсын төрийн цэргийн хэргийг эрхэлсэн сайд. Чингис хаан “Хубилай чи цэргийн үйл бүгдийг ерөнхийлөн захирч бай” /51.188/ хэмээн зарлиг буулгасан байдаг. Тэрээр цэргийн эрдэмд гаргуунгүй, байлдахад хошуучлан орж, маш эрхэлхэг хүчтэй тулалддаг зориг төгс баатар, цэргийн нэрт жанжин, Хубилай мянганы ноён, төрийн 88 гавьяатан ба Чингисийн дөрвөн хошуучийн нэгэн. Монголын төрд их гавьяа байгуулсан, эзэн Чингисийн хамгийн итгэлт, сүр хүчтэй жанжин байсан бөлгөө.

45. “Зэлмэ”- Урианхайн Жарчиуд овогтон. Эцэг Жарчиудай нь нутагтаа ихэд алдаршсан дархан /төмөрчин/ хүн байжээ. Бурхан халдун уулын өврөөр нутагладаг байснаас Тэмүжиний удам судрыг сайн мэдэж, Есүхэй баатар, түүний гэр бүлийг хүндэтгэдэг байсан ажээ. Тэмүжин, Бөртэ үжинийг хатан болгон авч Хэрлэн мөрний эх Бүрчи эрэг гэдэг газар гэрлэж байхад нь Жарчиудай дархан Зэлмэ хөвгүүнээ дагуулан ирж, Тэмүжинд нэгдэн анд бололцжээ. Зэлмэ насан өөд болтлоо Чингистэй дотно анд байж үнэнчээр нөхөрлөсөн ажээ. Тэмүжинг Тайчуудтай байлдах үед хүнд шархдахад нь Зэлмэ шархны цусыг нь амаараа шарж зогсоон, тараг олж өгөн асарч биеийг нь тэнхрүүлж байсан удаатай. Хэрэйд, Наймантай байлдахад онцгой сайн тулалдаж, Монголын нэгдсэн улсыг байгуулахад их гавьяа байгуулсан. Зэлмэ нь Чингисийн есөн өрлөгийн нэг, цэргийн гарамгай жанжин, мянганы ноён байжээ. Тэрээр бас Чингисийн “дөрвөн ноход” хэмээн алдаршсан хүчит дөрвөн баатрын нэг болой. Чингис хаан, Зэлмийн гавьяат үйлсийг үнэлж: Зэлмийн тус нь олон буй за.

Төрөхөд /минь/ төрөлцсөн

Өсөхөд /минь/ өсөлцсөн

Булган хөнжил язгуурт

Өлзий хутагт Зэлмэ

Есөн эндэл эндэхэд

Яланд бүү ортугай хэмээн зарлигласан байдаг бөлгөө /51.182/.

46. “Борохул”- Өнчин /Өгүшин/ овгийн хүн. Өүлэн эхийн өргөн авч өсгөн хүмүүжүүлсэн хүү. Чингис хааны өргөмөл дүү. Боорчи, Мухулай нартай эн зэрэгцэхүйц алдар гавьяатай, эрэлхэг зоригт баатар, цэргийн нэрт жанжин. Мянганы ноён, төрийн 88 гавьяатны нэгэн. Чингисийн есөн өрлөг, дөрвөн хүлэгийн сүр хүчит баатар. Монголын нэгдсэн улсыг байгуулан бэхжүүлэх үйлсэд онцгой гавьяа байгуулсан төр, цэргийн зүтгэлтэн байсан болой.

47. “Зүрчидай”- Начин баатрын ахмад хөвгүүн. Ургагайн зургаадугаар үе. Ургуд овогтон. Жамухын харьяат байгаад 13 хүрээний тулалдааны дараа Тэмүжинтэй нэгдсэн. Хэрэйдийг дайлахад хошуучлан байлдаж онцгой гавьяа байгуулсан, мэргэн харваач, эрэлхэг баатар, Чингисийн 88 гавьяатны нэг. Чингис хаан “чамайг би өндөр

уулын нөмөр мэт санаж явах бөлгөө” /52.208,137/ хэмээн Зүрчидайн их итгэл, гавъяат үйлсийг нь үнэлээд өөрийн хайртай хатан Ибаха бэхийг өгсөн бөлгөө. Чингис хаан Ибагад хандаж, чамайг

Уудам цээжийг чинь голоогүй

Үзэсгэлэн тал муу эс хэмээв би

Өвөр түрүүд орсон

Зэрэгтээ

Зэрэглэн буулгасан чамайг

Зүрчидайд соёрхохдоо

Их төрийг санаж

Зүрчидайн

Хатгалдах өдөр

Халх болсныг

Дайсан хүмүүнд

Далдлагч болсныг

Хагацсан улсыг хамтатгасны

Бугарсан улсыг

Бүрэн болгосны тусынх нь төрийн үйлсийг санаж чамайг өгөв гэж хэлсэн байдаг.

Үүнээс үзэхүл Чингис хаан Ибага бэхийг Зүрчидайд соёрхсон нь төрийн ёсон байсан ажгуу.

48. “Хуйлдар сэцэн”- Мангуд овогтоны Начин баатрын хоёрдугаар хөвгүүн. Мангудайн 6 дугаар үе. Жамухаас салж Зүрчидайн хамт Тэмүжинд ирж нэгдсэн. Тэмүжин Хуйлдараас “ах чинь Жамухын тэнд байх атал чи ганцаар ямар учраас энд үлдэх болов” хэмээн асуухад тэрбээр нэгэн сум авч хугалаад “энэ биеэ эцэслэтэл хаанд эс үйлчилбээс энэ сум мэт болтугай” гэхэд үнэнч шударгыг нь үнэлэн “Сэцэн” цол өгч, өөртөө нэгтгэжээ.

Хуйлдар Сэцэн Монголын нэгдсэн улсыг байгуулахын төлөө үнэнч, шударгаар зүтгэж, Ван хантай дайтсан “Муу өндөр”-ийн тулалдаанд эрэлхэг гавьяа байгуулж хүзүүндээ хүнд шарх олж үүнийхээ сэдрэлээс насан өөд болсон ажгуу. Түүний хүү Мөнххалзан 88 гавъяатад багтан орсон бөлгөө.

49. “Хорчи”-Чингис Хорчийг “Өчүүхэн балчир цагаас өдий болтол минь Өлзийт нөхөр болж, нойтонд хамт норж, хүйтэнд хамт хөрч хүчээ өргөв чи” /51.182/ гэж үнэлж, Эрчис мөрний дагуу ойн иргэнд хүртэлх нутгийг эзэмшүүлэн олгож, мянганы ноён болгосон бөлгөө. Хорчи цэргийн жанжин, Чингис хаанд үнэнчээр зүтгэж, Монголын нэгдсэн улсыг байгуулахад их гавьяа байгуулсан ажгуу.

50. *“Хишигтэн”*- Хишиг хайр гэсэн үг биш, харин хонь малын хишиг хариулах дэс дараа-ээлжийг хэлэхийн нэгэн адил утгатай ээлжийн цэрэг гэсэн үг болно /20.188/. Иймээс Чингисийн хишигтэн цэрэг гэдэг нь Чингис, түүний орд өргөөг өдөр шөнө ялгалгүй 24 цагийн турш ээлжлэн хамгаалах цэрэг гэсэн агуулгатай бөлгөө. Зарим хүмүүс бусад орны жишгээр хааны торгон цэрэг хэмээн бичсэн нь бий. Хишигтэн цэрэг хэвтүүл, торгууд, хорчин гэсэн зохион байгуулалтаар 3 хэсэг болж, Чингис түүний орд өргөөг 24 цагийн турш ээлжлэн хамгаалах үндсэн үүрэгтэй байжээ.

51. *“Торгууд”*- “Турхаг” хэмээх монгол үгтэй холбоотой. Монгол хэлнээ турхаг хэмээх нь бие томтон, их хүчтэн гэсэн утгатай байсан нь тураг биетэн, тураг морин, тураг шувуун, тураг гөрөөсөн гэх мэт том биет, их хүчит гэсэн утгатай. Үүнээс үүдээд “Турхаг” хэмээхийг том биетэй гээд үүнээс “Торгууд” гэдэг нэр үүссэн гэж тайлсан нь бий /20.188/. Иймээс “Торгууд” цэрэг бол том бие бялдартай, хүч чадал ихтэй, шилмэл цэрэг байсан байж болох юм. “Монголын нууц товчоо”-нд Чингис хаан “Эдүгээ надад хишигтэн тургийг мянгат мянгатаас ялгаж оруулагтун. ... хишигтэнг оруулахдаа түмт, мянгат, зуутын ноёдын хөвүүд, эгэл хүний хөвүүдийг оруулахад эрдэмтэй, шил сайтайг нь бидний дэргэд явах /энэ/ мэтийн /хүмүүсийг/ оруултугай” /51.224.147/ гэж зарлигласнаас үзэхэд торгууд /турхаг/ нь эрдэм ухаантай, бие бялдар том хүч сайтай хүмүүсээс бүрдэнэ гэж үзэж байсан харагднам.

52. *“Дөрвөн хөлөг”*- Боорчи, Мухулай, Борохул, Чулуун нарыг ийн нэрийдэж байсан ажгуу. Байлдаанд зориглон орж биеэрээ үлгэрлэн их хүч, ид хавыг үзүүлэн тулалдаж дайснаа дархан ялдаг хүчит жанжнууд болой. Чингис хааны “Амь биеийг нь аварсан хөлөг, аюул бэрхээс нь тусалсан анд, атаатан дайсны нь дарсан байлдагч, алтан төрийг босгосон тулгуур нь” /176-391/ түүний дөрвөн хөлөг байсан ажгуу. Чингис хаан өндөр хэргим, өв тэгш алдар, өршөөл хайрыг энэ дөрвөн хөлөгтөө шагнан үзүүлж байжээ. Тэд бүгдээрээ мянганы ноён, төрийн гавъяатнууд байсан ажгуу.

53. *“Дөрвөн хошууч /сайн нохос”*- Хубилай, Зэлмэ, Зэб, Сүбээдэй дөрвөн баатар жанжныг дөрвөн хошууч /сайн нохос/ гэж нэрлэж байжээ. Дөрвөн хошууч нь алив байлдаанд цэргийн жанжинаар ажиллаж, өөрсдөө шууд хошуучлан дагуулж, шаргуу довтлон, маш хүчтэй цохилт өгдөг эр зоригт, хүчирхэг баатрууд, ямагт ялдаг алдартнууд байв. Дөрвөн хошууч нь бүгд мянганы ноён, есөн өрлөгийн жанжин, төрийн гавьяатан, Монголын төрд үнэнчээрээ шалгарсан төр, цэргийн зүтгэлтнүүд байсан аж. “Монголын нууц товчоо”-нд тэднийг “Ширмэн төмөр малгайтай, шивээ хурц хэлтэй, Ган төмөр зүрхтэй, гадас цүүцэн хошуутай ... шүүдрээр унд хийж, шүлсээр хоол хийж, салхиар унаа хийж, саадгаар нөхөр хийж явдаг Зэб, Хубилай тэргүүтэй, Зэлмэ, Сүбээдэй дараатай, Тэмүжин андын дөрвөн нохос/д” гэж тодорхойлсон байдаг бөлгөө.

54. *“Хоёр манлай”*- Зүрчидай, Хуйлдар нарыг хоёр манлай баатар хэмээн өргөмжилж байжээ. Хоёр манлай нь дөрвөн хошууч, дөрвөн хөлөгтэй эн зэрэгцэхүйц алдартан, цэргийн их жанжин, хүчит баатрууд байсан бөлгөө. Байдаанд хамгийн түрүүнд манлайлан орж, авьяас чадвар, хүч чадал түрэн тулалддаг эрэлхэг зоригт баатрууд юм. Уруд, Мангудууд байлдаан бүхэнд оройлон орж ямагт ялдаг эр зоригтнууд байж ихэд алдаршсан нь Зүрчидай, Хуйлдар нарын авьяас чадвар, эр зоригтой холбоотой байсан болой.

55. *“Их засаг”*- Монголын төрийн бичмэл хууль. 1206 онд Их Хуралдайгаар батлагдаж, 1210, 1218, 1225 онд нэмэлт өөрчлөлт орсон. “Их засаг” хууль Чингис, түүнийг залгамжлагчид, үр, ач нарынх нь толгойлсон бүх улс, хаадын ордонд хадгалагдаж байсан аж. “Их засаг” нь “Их хууль” гэсэн нэр мөн. “Их засаг” нь бичмэл хууль бөгөөд бүрэн эхээрээ өдгөө хүртэл олдоогүй байгаа бөлгөө. Харин “Их засаг”-т холбогдох заалтууд тэр үеийн сурвалж бичиг, түүх шастирт нилээд хэмжээгээр тэмдэглэгдэн үлдсэн нь бий. Их засаг бол төрөлжсөн, системчлэгдсэн хууль биш. Харин нүүдлийн соёл иргэншилтэй улс орны онцлогт тохирсон бөгөөд төрөөс гаргасан бүх хуулийн заалтуудыг зохих дэс дарааллын дагуу жагсаан оруулж багтаасан улсын хэмжээнээ дагаж мөрдөж буй бүх заалтуудын “эмхэтгэл” болно. “Их засаг” нь Ази маягийн нүүдлийн соёл иргэншилт улсын хууль, монголчуудын оюун ухааны хосгүй бүтээл, дэлхийн их өв соёлын салшгүй хэсэг болно.

56. *“Засаг”*- Засан тохинуулах гэсэн язгуур утгатай “ЗАСА” гэсэн үгийг үндсэн үйл үгээс нэр үг бүтээдэг “Г” дагавар залгаж “Засаг” хэмээх үг буй болжээ. Монгол хэл багтдаг Алтай овгийн хэлэнд “Засаг” гэдэг үгийг түрэгээр “ЙАСА” /Яса/, манжаар “Даса” гэдэг. Засаг, Яса /йаса/-к даса-к эдгээр үг нь бүгд Алтай овгийн язгуур нэг үг болно. XIII зууны үед монгол хэлний үгийн санд “Хууль” гэдэг байгаагүй, харин “засаг” гэсэн үг байжээ. “Засаг” гэдэг үг нь хууль гэсэн утгыг илэрхийлж байсан учир “Засаг”-ийг “хууль” хэмээн ойлгож болно. Харин хууль гэдэг үг хожуу үүссэн түүхтэй. Иймээс “Засаг” гэсэн нь “хууль”, “Их засаг” гэвэл “Их хууль” гэсэнтэй дүйнэ. Зарим зохиолд “Засгийн засаг” гэсэн байх бөгөөд энэ нь “Засгийн /төрийн/ хууль” гэсэн санааг илэрхийлмүй.

57. *“Эрхтэн хагаслах”*- Монголын эзэнт гүрэнд хэрэглэж байсан ялын хэлбэр. Суурьшмал соёл иргэншилтэй, хаант засагтай эрт, дундаг үеийн улсуудад эрхтэн хагаслах ялыг нилээд түгээмэл хэрэглэж байсан түүхтэй. Гэмт хэрэгтэн хүний нүдийг сохлох, хамар, чихийг нь огтлох, гар, хөл, хурууг нь тайрах мэтээр бие мах бодид нь хохирол учруулж, насан туршид нь эрэмдэг зэрэмдэг болгодгийн хувьд энэхүү ял нэн харгис шинжтэй болой. Монголын нууц товчоо-нд тэмдэглэснээр эзэн ноёноосоо орговол борвьийг нь огтлох, эзлэгдсэн орны иргэд алба, татвараа төлөхгүй бол дээд

уруулыг нь огтолж байх ялтай байжээ. Үүнээс үзэхүл ийм 2 төрлийн ял байсан бололтой. Гэвч ийм ялыг хэрэглэж байсан тухай баримт ямар ч зохиолд тэмдэглэгдсэн нь олдоогүй бөгөөд ялын энэ хэлбэрүүд Монголын ял шийтгэлийн уламжлалт хэлбэр биш, харин ч монголчуудын заншил, сэтгэл зүйд огт таалагдахгүй байсан байж болох бөлгөө.

58. “Цаазлах”- Энэ үг нь “хориглох”, “алах” гэсэн 2 утгаар хэрэглэгдэж байжээ. Иймээс эл хоёр үгийн утгыг хольж хутгаж ойлгож байсан нь ажиглагддаг. Жишээлбээс хоол идэж байгаад хахах, цэргийн ноёны гэрийн босгон дээр гишгэх, гэр ахуйн усанд гараа дүрэх, тогооноос хутгаар мах гаргах, гал руу хутгаар дүрэх, үнсэн дээр шээхийг цаазлах /хориглох/-оор “Их засаг” хуульд заасан байдаг. Өөрөөр хэлбэл ийм үйлдэл хийхийг хуулиар хориглосон байна. Харин ийм үйлдэл хийвэл алаад бай гэсэн үг арай биш буй зээ. Нөгөө утга нь хүнд гэмт хэрэг үйлдвэл цаазлан алах /амийг нь авах, цаазаар авах, цаазаар аваачих/ гэсэн хэрэг болой. Цаазаар авах нь юмаар цохиж алах, сэлмээр цавчиж алах, нурууг нь хугалж алах, ам хамрыг нь бүтээж алах гэсэн хэд хэдэн хэлбэрээр гүйцэтгэгддэг байжээ. Чингэхдээ язгууртан хүнийг цус гаргалгүйгээр нурууг нь хугалж, эсвэл эсгийгээр бүтээж цаазалдаг /алдаг/ байсан бол жирийн хүнийг цохиж, цавчиж цаазалдаг /алдаг/ байсан ажгуу.



ГУТГААР АНГИЙН ТҮҮХЭН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

- 1162 он Тэмүжин, Онон мөрний хөвөө, Дэлүүн болдог гэдэг газар төрсөн.
- 1168 он Тэмүжиний отгон дүү Тэмүгэ отчигин төрсөн.
- 1169 он Тэмүжиний охин дүү Тэмүлэн төрсөн.
- 1170 он Тэмүжиний эцэг Есүхэй баатар Татар аймагт хорлогдон нас барсан.
- 1172 он Тэмүжин, Жамух нар анд бололцсон.
- 1178 он Тэмүжин Бөртэ Үжинтэй харимлаж, гэр бүл болсон
- 1179 он Буур хээрийн байлдаан болж Мэргэдийг ялсан.
- 1179 он Тэмүжиний ахмад хөвгүүн Зүчи төрсөн.
- 1186 он Тэмүжиний хүү Өгөдэй төрсөн.
- 1189 он Тэмүжинг Хамаг монгол улсын хаанд өргөмжилж “Чингис хаан” цол олгов.
- 1196 он Тэмүжин, эцгийн анд Тоорил вангийн хүсэлтийг хүлээн авч тусламж үзүүлсэн.
- 1197 он Тэмүжиний талынхан Зүрхэн аймгийг өөртөө дагуулсан
- 1198 он Тэмүжин, Тоорил ван нар хүч хавсран Алтан улсад тусалж, Татар аймагтай байлджээ.
- 1199 он Тоорил, Тэмүжин нар тохиролцож Найманы ханлигтай байлдав.
- 1201 он Монголын зарим аймгуудын тэргүүн нар нэгдэж, Жамухыг Гүр хаанд өргөмжлөв.
- 1202 он Тэмүжин “Далан нөмрөг” гэдэг газар, Татар аймагтай байлдаж, Татарыг бүрмөсөн мөхөөв.
- 1202 он Тэмүжин “Хүйтэн” хэмээх газар Жамух сэцэний цэрэгтэй байлдаж ялжээ.
- 1203 он Чингис хаан Ван хааны цэрэгтэй “Муу өндөр” гэдэг газар байлдав.
- 1203 он Чингис хаан өөрийн шадар хүмүүстэйгээ “Балжид” нуурын хөвөөнд уулзаж үнэнчээр зүтгэн тэмцэхээр тангараг өргөцөөсөн нь түүхнээ “Балжид нуурын тангараг” гэж алдаршжээ.
- 1203 он Чингис хааны цэрэг Ван хааны цэрэгтэй байлдан ялж, Хэрэйдийг мөхөөжээ.
- 1204 он Чингис хаан Найманы хаант улстай байлдаж ялалт байгуулан Найманыг мөхөөсөн.
- 1205 он Елюй Аха жанжнаар удирдуулсан Чингис хааны цэрэг Тангудыг дайлсан.
- 1206 он Монголчуудын Их Хуралдай чуулж, Чингисийг улсын их хаанд өргөмжилж, Монголын нэгдсэн улс байгуулсныг тунхаглажээ.
- 1206 он 95 мянгатыг байгуулж, их улсыг байгуулахад хүчин зүтгэсэн төрийн 88 гавъяатыг тодруулан тогтоосон.
- 1206 он Жалайрын Мухулайг зүүн түмний ноёнд томилж, улсын ван цол олгосон.
- 1206 он Татарын Шихихутугийг улсын заргач /шүүгч/-аар томилж алдарт “Их засаг” хуулийг тогтоосон.

- 1207 он Зүчи жанжин, баруун гарын цэргийг авч, Ойн иргэдийг дайлахад Ойрадын Худуга бэхи Чингис хаанд дагаж орсон.
- 1207 он Чингис хааны цэрэг хоёрдахь удаагаа Тангудтай байлдаад 1208 онд нутаг буцсан.
- 1208 он Алтан улсын шинэ хаан Вэй Ван Юнь Чжи, Чингис хаанд онцгой элч ирүүлж, өөртөө захирагдахыг мэдэгджээ.
- 1209 он Чингис хааны цэрэг удаа дараагийн амлалтаа биелүүлээгүй учир Тангуд улсад гурав дахь удаагаа довтолж, ялалт байгуулжээ.
- 1210 он Их Хуралдайгаар “Их засаг” хуульд нэмэлт оруулсан.
- 1211 он Онгуд аймгийн эзэн Алгуш Тегин Монголын нэгдсэн улсад дагаар орсон. Тегин ахмад хүүд Чингис хаан Алуха бэхээ хатан болгон өгч, ургийн холбоо тогтоожээ.
- 1211 он Уйгурын хант улс Монголын нэгдсэн улсад дагаж орсон.
- 1211 он Монголын нэгдсэн улсын Их Хуралдай Хэрлэн голын хөвөөнөө хуралдаж, Зүрчидийн Алтан улстай байлдахыг зөвшөөрсөн.
- 1212 он Хятан нарын хаан Елюй Люге Монголын нэгдсэн улсад дагаар орсон. 1212-
- 1214 он Чингис хааны цэрэг Алтан улстай байлдан, ялалт байгуулж Чжүндү /Бээжин/ хотыг эзэлсэн.
- 1213 он Хятан угсаатны ноён Шимо-Мянган Чингис хаанд даган орж, Монголын төлөө хүчин зүтгэх болжээ.
- 1214 он Чингис хаан, Жубган тэргүүтэй төлөөлөгчдийг өмнөд Сүн улсад илгээж эвийн гэрээ байгуулах санал тавьжээ.
- 1214 он Сэцдийн зөвлөл хуралдаж, Алтан улстай байлдсан гурван жилийн дүнг гаргасан.
- 1215 он Хорезмын шах Мухаммедийн Баха-ад-Дин Ражи тэргүүтэй төлөөлөгчдийг Чингис хаан хүлээн авч уулзсан.
- 1215 он Мухулай жанжин Хятадыг захирах Чингис хааны төлөөний сайдаар томилогдсон.
- 1218 он Чингис хааны цэрэг Тангуд улсыг дөрөв дэх удаагаа дайлж, түүний нийслэл Яргай хотыг эзэлсэн.
- 1218 он Их Хуралдай чуулж, “Их засаг” хуульд нэмэлт оруулсан.
- 1218 он Чингис хаан, Махмуд, Али-Хадша, Юсу Кахна нарын бүрэлдэхүүнтэй элчийг Хорезмын Шах Мухамедад илгээсэн.
- 1218 он Чингис хаан Хорезм улсад 500 тэмээтэй, 450 хүний бүрэлдэхүүнтэй худалдааны ангийг илгээсэн Энэ ангийн худалдаачдыг Отрар хотын дарга баривчилж цаазалсан.

- 1218 он Их Хуралдайг хуралдуулж, Хорезмтай байлдах асуудлыг хэлэлцүүлсэн.
Хуралдай их цэргийг Чингис хаан биеэр удирдаж, дайлаар явахыг зөвшөөрчээ.
- 1218 он Зэб жанжнаар удирдуулсан морьт цэрэг Хар хятаны эзэн Хүчүлэгийн цэргийг бут цохисон.
- 1219 он Эрчис мөрний хөвөөнд Сэцдийн зөвлөл хуралдаж, Хорезмтай байлдах зам чиглэлийг тогтоожээ.
- 1219 он Чингис хаанаас Солонгост Жалайрын хачигун Тохорхунаар толгойлуулан илгээсэн 10 түмэн цэрэг, оргодол хятанчуудыг бут цохисонд талархсан солонгосчууд монголчуудтай эвийн харилцаа тогтоож жил бүр алба барих болжээ.
- 1220 он Чингис хааны цэрэг Хорезмын Отрар, Бухар, Самарканд зэрэг хотыг эзэлсэн.
- 1221 он Өмнөт Сүн улсын элч Жао Хун Бээжин хотод Чингис хааны төлөөний сайд Мухулайтай уулзсан.
- 1221 он Чингис хааны цэрэг Инд мөрний эрэгт Желал-ад-Диний цэргийг бут цохисон.
- 1222 он Чингис хаан, Хятадын шашны бясалгагч лам Чан Чунь бомботай уулзсан.
- 1223 он Сүбээдэй, Зэб жанжны цэрэг Грузин, Азербайджан, Болгарыг эзэлж, Оросын вангуудын цэргийг бут цохижээ.
- 1224 он Эрчис мөрний үзэсгэлэнт эрэгт Сэцдийн зөвлөл хуралдсан.
Чингис хаан, дайны ялалтаа тэмдэглэж их хурим хийсэн.
Зүчийг Хорезмын захирагчаар томилжээ.
- 1224 он Алтан улсын хаан Айзун Чингис хаанд тусгай элч ирүүлж дайныг зогсоож найрамдал байгуулахыг гуйсан.
- 1225 он Чингис хаан баруун зүгт хийсэн байлдаанаа дуусгаад,
Туулын хөвөөнд эх орондоо морилон иржээ.
- 1225 он Тангуд улсад Алтан улс цэрэг, Зэбсгийн тусламж үзүүлэх тухай хэлэлцээр байгуулсан.
- 1226 он Гэрээ хэлэлцээгээ удаа дараа зөрчсөний учир Чингис хаан Тангуд улстай цэрэглэн байлдаж, эцсийн цохилт өгөн бүрмөсөн мөхөөжээ.
- 1227 он 8-р сар Их Чингис хаан таалал төгсчээ.

ГУТГААР АНГИЙН НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. “Алтан ордны тайллага” Бээжин 1983
2. Амар.А. Монголын товч түүх. УБ.,1934, 1992
3. Амархүү.О. Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз /Уламжлал шинэчлэлийн асуудал. УБ.,2000
4. Багана.Б. Богдбаатар. Биеэр дайлсан тэмдэглэл. Хөх хот. 1979
5. Базарсүрэн.Ж. Чингис хааны зэр Зэбсэг. УБ.,2000
6. Бат-Очир.Ч. Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг. УБ.,1928
7. Баянчулуун Б. Аж ахуйн тэмдэглэл. УБ.,1934
8. Баярхүү.Г. Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь. УБ.,1997
9. Баяр.Б. Чингисийн үзэл ертөнцийн язгууртай болохын учир. УБ.,1998
10. Баярсайхан.Б. Хууль зүйн товч тайлбар толь. УБ.,2000
11. Бира.Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ.,2001
12. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.,1966.
13. Болдбаатар.Ж, Лүндээжанцан.Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997
14. Бөртэ Чино. Бээжин.1981
15. Вернадский.Г.В. Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс. УБ.,1994
16. Вернадский.Г.В. Чингис хааны их засгийн судалгаа, түүний агуулга. УБ.,1992
17. Гарольд Дэмб. Дэлхийн эзэн Чингис хаан. УБ.,2003
18. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.,1998
19. Гомбосүрэн.Ц. Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү. УБ.,1995
20. Гонгор.А. Халх товчоон II боть. УБ.,1978
21. Гэрэлбадрах.Ж. Монголын нутаг дэвсгэр хил хязгаарын түүх /МЭӨ II-XIX зуун/ УБ.,2002
22. Далай.Ч. Эзэн Чингисийн гэрээслэл ба эдүгээ миний бодол. Чингисийн түг. УБ.,1990
23. Далай.Ч. Монголын бөөгийн мөргөлийн товч түүх УБ.,1958
24. Далай.Ч. Монголын түүх. Их Монгол улс. /1206-1260/. УБ.,1994
25. Дамдинсүрэн.Ц. Монголын уран зохиолын зуун бүлэг оршвой. УБ.,1973
26. Дашням.И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. УБ.,1997
27. Дашцэдэн.Д. Нууц товчооны хууль цаазын зарим асуудал. “Дорно дахины судлал”. 1990. №2

28. Дорж Банзаров. Монголын бөө мөргөл ба хар шүтлэг
29. Дорнотив. Чингис хааны цэргийн эрдэм. Хөх хот. 1990
30. Жалан-Аажав.С. Халх журам бол Монголын хууль цаазын дурсгалт бичиг мөн. УБ.,1958
31. Жалан-Аажав.С. Арван буянт номын цагаан түүх. УБ.,1998
32. Жүгдэр.Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ.,1987
33. Жүгдэр.Ч. Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг. УБ.,1990
34. Жувейни.А. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх. Хөх хот. 1980
35. Кимэнон Рэ. Мянган жилийн түүхэн хүн. УБ.,1999
36. Инжинаш. Хөх судар. Хөх хот.1991
37. Ишжамц.Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ.,1978
38. Ишжамц.Н. Чингис хаан хятадын эрдэмтэн Чань Чунь бомбыг урьж уулзсан нь. УБ.,1993
39. Кычанов.Е.И. Ертөнцийг эзэгнэн дагуулсан Тэмүжиний үйл амьдрал. УБ.,2000
40. Лааган.Б. Монгол хаадын хураангуй товчоон. УБ.,1998
41. Лиу Жинь Сүвэ. Хаадын үндэсний хураангуй Алтан товч. Хөх хот. 1980
42. Лүндэндорж.Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ.,2002
43. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
44. Лхаашид.Д. Монголын хаад, зүтгэлтнүүдийн жолоодохуйн урлаг. УБ.,1999
45. Лю Жэнсо. Монгол үндэстний товч түүх. Хөх хот.
46. Майдар.Д. Чингис хаан ба Монголын их гүрэн. УБ.,1969
47. Монголын соёлын түүх. Тэргүүн боть. УБ.,1999
48. Марко Поло. Замын тэмдэглэл. УБ.,1975
49. Мишел Хаонг. Эзэн хаан Чингис. УБ.,2000
50. Монголын эрт эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр. /хөрвүүлсэн Б.Баярсайхан/ УБ.,2002
51. Монголын нууц товчоо. УБ.,1990
52. Монголын нууц товчоо. УБ.,2004
53. Монгол ба Тангуд. Хөх хот.1990
54. Монголын хаад болон хятадын түүх. Тайбэй.1992
55. Монголын эртний цагийн цааз хуулийн түүхэнд холбогдох хэрэглэгдэхүүн. УБ.,1936
56. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил /МЭӨ III-МЭ XIX/. УБ.,1995
57. Монгол улсын түүх. Дэд боть. УБ.,2003

58. Монголын ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. УБ.,1974
59. Монгол хууль. УБ.,1997
60. Намжил.Х. Чингис хааны засаг ба билэг. Хөх хот.1990
61. Нацагдорж.Ш.Монголын феодализмын түүхэн замнал. УБ.,1978
62. Нацагдорж.Ш Чингис хааны цадиг. УБ.,1991
63. Нацагдорж.Ш. Чингис хааны түүхэн роль. УБ.,1962
64. Нарангэрэл.С. Монголын эрх зүйн түүхэн тойм. Монголын эрх зүйн хөгжлийн: он дараалал, үндсэн үе шат, Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. УБ.,2001
65. Неру.Ж. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. Уб.,1987.
66. Окада Хидэхиро. Чингис хаан. Токио.1986
67. Отахи Мацуэ. Хубилай хаан. Хөх хот.1984
68. Пэрлээ.Х. Нууц товчоонд үлдсэн хууль цаазын зарим зүйл. “Монгол судлал”. УБ.,1962.
69. Ням-Осор.Н. XIII зууны Монголын нийгэм-эдийн засгийн амьдралд Чингис хааны “Их засаг” хуулийн гүйцэтгэсэн түүхэн үүрэг. УБ.,1999
70. Пэрлээ.Х. Монголын эрт, дундат үеийн хот суурины товчоон. УБ.,1961
71. Пүрэвжав.С. Монголын шашны хураангуй түүх. УБ.1978
72. Рашид-ад-Дин Судрын чуулган. I боть. УБ.,2002
73. Рашид-ад-Дин Судрын чуулган. II боть. УБ.,2002
74. Рене Груссе. Орчлонг эзэгнэгч Чингис хаан. УБ.,2003
75. Сайшаал. Чингис хааны товчоон. Тэргүүн дэвтэр. УБ.,2003
76. Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. УБ.,2004
77. Санждорж.М. Монгол төрийн түүхээс /XIII-XIX зуун/ УБ.,1998
78. Саундерс.Ж.Ж. Монголын байлдан дагуулал. УБ.,1992
79. Суут богд Чингис хааны үнэн гавъяа. Б.Даш-Ендонгийн орчуулга. Софи.2003
80. Сүхбаатар.Г, Жамсран.Л. БНМАУ-ын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр. УБ.,1968
81. Сэлэнгэ.Х. XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. УБ.,2004
82. Тогтох. Эсгий туургатны түүх. /дээд, доод дэвтэр/ Хөх хот. 1992
83. Төрийн минь сүлд өршөө. /Эмхэтгэсэн Д.Самданмөнх, С.Цэрэндамба/ УБ.,2004
84. Үлэмжийн Их Чингис хаан /Чингис хааны 800 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын материал/ УБ.,2002
85. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг дуурсгах тухай Монгол түүхийн эрдэм шинжилгээний ярилцах хурлын түүвэр. Хөх хот.1962
86. Чингис хааны тухай товч тайлбар толь. УБ.,1992
87. Чингис хааны цэргийн арга ухаан. УБ.,1993

88. Чингис богдын дурсгалын түүвэр. Бээжин.1925
89. Чингисийн цадиг. Бээжин.1927
90. Чингис эзний алтан ургийн түүх. Гангын урсгал нэрт бичиг оршивой. Санкт-Петербург.1960
91. Чжоу Яотин. Чингис хааны түүх шастир. УБ.,2002
92. Чулуунбаатар.Л. Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл. УБ.,2002
93. Шагдар.Х. Чингисийн байлдааны цадиг. /1179-1206/ УБ.,1993
94. Шагдар.Х. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх. /XIII зуун/ УБ.,2000
95. Шаралдай.Х. Чингис хааны онгон шүтээний тайллага, тахилга. УБ.,2001
96. Шаравнямбуу. Цэдэнжапов. Богд Чингис хаан. УБ.,1991
97. Уолкер.С.С. Чингис хаан. УБ.,2001
98. Эзэнбогд Чингисийн Их засаг. УБ.,1995
99. Эрдэнийн товч. Хөх хот.1984

Орос хэлээр

100. Абрамзон.С.М. Киргизы-народы средней Азии и Казахстана
101. Армянские источники о Монголах. М.,1562, М.,1963
102. Ахмедов.Б.А. Государство кочевых узбеков. М.,1965
103. Бартольд.В.В. Чингиз-хан. Энциклоп слов. 1903,
104. Бартольд.В.В. Туркстан в эпоху Монгольского нашествия. Ч.II. Исследование СПб.1900
105. Бартольд.В.В. Образование Империи Чингис-хана. ЗВО-РАО
106. Березин.Н.Н. Очерк внутреннего устройства улуса Дэжучева. СПб.1892
107. Бира.Ш. О золотой книге Ш.Дамдина. УБ.,1964.
108. Бичурин.Н.Я. История первых четырех ханов из дома. 1892
109. Бутаятов.М. Государство Хорезмшаха. М.,1986
110. Ванан.Ю.В. Феодалная Корея в XIII-XV веках. М.,1962
111. Владимирцов.Б.Я. Чингиз-хан. Берлин.1922
112. Владимирцов.Б.Я. Общественный строй Монголов-Монгольской кочевьей феодализм. 1934
113. Греков.Б.Д., Якубовский А.Ю. Золотая Орда и ее падение М.,1998
114. Грумм-Гржимэйло.Г.Е. Западная Монголия и Урянхайский край. Т.П.Л.1926
115. Гумилев.Л.Н. Древняя русь и Великая степь.М.,1989
116. Дылылков С.Д. Халха джирум. М.,1965
117. Доржи Банзаров. История Монгольской Народной Республики. М.,1983.
118. Иванин. М.И. О военном искусстве и завоеваниях Монголо-татар и среднеазиатских народов при Чингис хане и Тамерлане. СПб.1875

119. История стран Азии и Африки в средние века. Ч I. 1987
120. Ишжамц.Н Культура Монголии XIII-XIV вв.УБ.,1974
121. Кара дорж. Книги Монгольских кочевников. М.,1972
122. Кафоров. П. Старинное Монгольское предание о Чингис хане. 1866
123. Котовуч.В.Л. Из поучения Чингис хана. Восток-III. 1923.
124. Кычанов.Ё.И. Татаро-Монголы в Азии и Европе. М.,1977
125. Кычанов.Е.И. Жизнь Темучжина, думавшего покорить мир. М.,1973
126. Кычанов.Е.И. Очерки истории Тангутского государства. М.,1968
127. Кычанов.Е.И. Очерки истории Калмыцкой АССР. Т.I. М.,1967
128. Магакия. История Монголов. 1891
129. Майдар.Д. Архитектура и градостроительство Монголии. М.,1971
130. Майский.И.М. Чингис хан /Вопросы истории/. 1962. N25
131. Мэн-гу-ю-му-цзи. Записки о монгольских кочевьях
132. Мункуев.Н.Ц. К вопросу об экономическом положении Монголии и Китая в XI-XIV вв КСИНЭ N76. М.,1965
133. Мункуев.Н.Ц. Китайские источники о первых Монгольских ханах. М.,1965
134. Насонов.А.Б. Монголы и русь, история Татарской политики На руси. СПб.1873
135. Оссон.Д. История Монголов от Чингиз хана до Тамерлена. Иркутск.1937
136. Попов.П.С. Яса Чингис хана у уложение Монгольской династии 380 ХҮП. СПб. 1907.
137. Патканов.К.П. История Монголов о армянских источниках СПб. 1873
138. Патканов.К.П. История Монголов, Инока Магакия XIII века. СПб.1871
139. Пэн Дая, Сюй Тин. Краткие Сведения о черных татарах. Проблемы Востоковедения 1960. №5
140. Рашид-ад-Дин Сборник летописей.Т.1. КН.1.2. М.Л.1952
141. Рашид-ад-Дин История Монголов.Ч III. СПб.1988
142. Рене Грუსь Чингис хан. М.,2000
143. Рязановский.В.А. Монгольское право. Харбин. 1931.
144. Рязановский.В.А. Великая Яса Чингис-хана. Харбин. 1933
145. Тихвинкий.С.А. Татар-монгольские завоевания в Азии и Европе. М.,1970
146. Улымжиев.Д.Б. Ням-Осор.Н. О великой Ясе Чингис-хана. Улан-Удэ.1999
147. Чимиддоржиев.Ш.Б. Буряд-Монголы: История современности. Улан-Удэ.2000
148. Якубовский.А.Ю. Из истории изучения Монголов периода XI-XII вв. Очерки по истории русского востоковедения. М.,1953.

*Дорно дахины хэлээр**А.Хятад хэлээр*

149. Бак Тунлин. “Чжинго-или /Хятадын түүх/” Бээжин.1934
150. Бархаусен. “Чингис хааны хаант улсын түүх” Жунхуа.1940
151. Ван Говэй “Мэн-Гу-као /Монголын судалгаа/” ҮИ боть
152. Ван Чжи-лай. “Чжун-Я шиган /Дундат азийн түүхийн тойм/”. Чанша.1986
153. Дадасборуу. Чингис хаан. Шанхай.1923
154. Дэк Чжичэн. “Чжун-Хуа-эр-цянь нянь-ши /Хятадын 2000 жилийн түүх/” Бээжин.1958
155. Дин Шиян Бинь. Чингис хааны дуулал. Тайван.1973
156. Даоссон. Монголын түүх. Шан Эү.1936
157. Елүй Чуцай. Баруун зүг зорчсон тэмдэглэл. Жунхуа.1981
158. Жэү Чин Жий. Чингис хаан. Шанхай. 1955
159. Жоу Зүн Эү, Жагсэцэн. “Хятадаар шинэчлэн тайлбарласан”
/Монголын нууц товчоо/ Тайван 1960-1961
160. Ли Хи Чэн. “Чанчунь аршийн баруун зүг зорчсон тэмдэглэл” 1926
161. “Мэн-Шу ди-го ши /Монголын эзэнт улсын түүх/” Бээжин 1989
162. “Мэн Гулаи-ши /Монголын нууц товчоо/” Хөх хот.1980
163. Фэн Чэн Жиюнь. Чингис хааны намтар. Шан Эү.1934
164. Пүй Юань Ань. Чингис хааны намтар. Шанхай. 1955.
165. Си ся-шу-ши /Баруун тангуудын хэргийн тэмдэглэл/ Бээжин.1935
166. Тогтох. Алтан улсын түүх. Жунхуа. 1975
167. “Цинь-Ши /Алтан улсын түүх/” Шанхай Бээжин. 1958
168. “Чжунго-Мин Цзу Ши” /Хятадын үндэсний түүх/ Бээжин.1990
169. Ши вэй. Чингис хаан. Сянган. 1985
170. “Юан Чао Ши /Юан төрийн түүх/” Бээжин.1986
171. Чжао Хун “Мэн-да бэй лу” /Монгол-татарын бүрэн тэмдэглэл/
172. “Чжун-Я ши гань /Дундат азийн түүхийн тойм/” Хунань.1958
173. Юй Юань-ань “Чжэн Цзи-сы хань чжуань /Чингис хааны намтар/”. Шанхай.1955
174. Ян На “Шицзэ-чжэнфуижэ /Дэлхийг байлдан дагуулагч/” Бээжин.1997

Б.Япон хэлээр

175. Кэзифүжи Такэки. Чингис хаан-тал нутаг дахь дэлхийн хаант улс.
Токио.1972
176. Кобаяши Такаширо. Чингис хаан. Токио.1979
177. Накажимо “Чингис хааны үнэн тэмдэглэл” /Монголын нууц товчоо/ 1906
178. Ооба Яхай. Чингис хааны бүрэн намтар. Токио. 1944.

179. Оқушикэ Ширу. Чингис хаан. Токио. 1940
180. Осаке Широ. Чингис хаан. Токио. 1941
181. Оохама Киеичиро. Чингис хаан хийгээд Азийн үндэстэн. Токио. 1933
182. Сакеэ Шигайтаке. Чингис хаан. Токио. 1915
183. Уймаймото Сэтайзу. Чингис хаан. Мүгдэн. 1943
184. Чиюку Ротайру. Чингис хааны байлдааны түүх. Токио. 1939.

Өрнө дахины хэлээр

185. The Yuan Dynasty and the Uighurt os Turfan in the 13 th century. In Rossabi8 China among Equals. 1983, 243-80.
186. Ayalon J. L'ethnogenese des Qaraunas. Turcica 1. 1969, 65-94.
187. Bezzola G.A. Die Mongolen in abendlendischer Sicht (1220-1270) 6 Berne and Munich, 1974.
188. Boule J.A. (tr.) 'Ata Malik Juvainni, The History of the Word Conqueror, 2 vols. Manchester, 1958.
189. The thirteenth-century Mongol's conception of the after life: the evidence of their finery practices. Mongolian Studeis 1. 1974, 5-14. Reprinted on Boyle, The Mongol World Empire.
190. The Mongol World Empire 1206-13706 London., 1977. – Bretschneider. E. Mediaval Researches from Eastern Asiatic Sources, 2 vols. London, 1888.
191. The role of the Sino-Mongolian Frontier zone on the rise of Chiggis-Qan. In Schwarz H.G. (ed.) Studeis on Mongolia: Proceeding of the First North American Conference on Mongolian Studeis. Bellingham., Washington, 1979. 63-76.
192. Papal Envoys to the Great Khans. London, 1971.
193. Some remarks on the ideological foundations of the Chinggis Khan's empire. Papers in Far Eastern History. 7. 1973. 21-36.
194. Fennel J.L.I. The Crisis of Medieval Russia 1200-1304. London, 1983.
195. Fox R. Genghis Khan. London, 1936
196. Halperin C.J. Russia in the Mongol Empire in comparative. Harvard Journal of Asiatic Studeis 43/1. 1983. 239-61
197. Hambus L. Chengis-Khan. Paris, 1973.
198. Hambly G. (ed.) Central Asia. London, 1969
199. "The Sino-Mongolian Inscription of 1240". HJAS. 23. 1960-1961.
200. "History of Civilizations Central Asia" UNESCO Publishing. T.I. 1992. t. IV. "The historical, social and economic sitting". Тэргүүн дэвтэр 1998. "The achievements" дэд дэвтэр. 2000.

ДӨТГӨӨР АНГИ
ЧИНГИСИЙН ДАРААХ ҮЕИЙН ИХ МОНГОЛ УЛСЫН
ТӨР, ЭРХ ЗҮЙ /1227-1260/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Чингисийн дараах үеийн Их Монгол улсын төр, эрх зүйн
түүхийн сурвалж бичиг, судалгааны зохиолын тойм

Чингис хааныг тэнгэрт хальсны дараа түүнийг залгамжилсан Өгөдэй, Гүюг, Мөнх хааны үеийн Их Монгол улсын төр, эрх зүйн түүх нь 1227-1260 он буюу 30 гаруй жилийг хамарсан өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой бөлгөө. Эзэн хаан Их Чингисийн байгуулсан Их Монгол улсыг бэхжүүлэн хөгжүүлэх, түүний дотоод, гадаад бодлогыг залгамжлан үргэлжлүүлж, нийгэм, улс төр, эдийн засаг, хууль цаазын амьдралд эл үеийн шинэ нөхцөл байдалд нийцсэн өөрчлөлт шинэчлэл хийх явдал Чингисийн дараах үеийн хаадын өмнө тулгарсан зорилт болж тавигджээ.

Иймээс Чингисийн дараах хаадын үеийн төр, эрх зүйн түүхийн асуудал сурвалж бичиг, судалгаа шинжилгээний зохиол, бүтээлүүдэд тусгалаа олж, судлаачдын анхаарлыг ихэд татаж ирсэн ба одоо ч татсаар байна. Алдарт “Монголын нууц товчоо”-нд Чингисийн дараах үеийн хаадын удам гарвал, өсөн төлөвшсөн, монголын нэгдсэн улсыг байгуулж бэхжүүлэхэд оролцсон үйл ажиллагаа, гүйцэтгэсэн үүрэг, хаанд өргөмжилсөн үйл явц, явуулсан гадаад, дотоод бодлогын тухай өгүүлсэн байдаг нь эх сурвалжийн шинжтэй болой. “Нууц товчоо”-ны XII бүлэгт Чингис хааны хүү Өгөдэй их хаан болоод явуулсан дотоод, гадаад бодлого, улсынхаа талаар авсан арга хэмжээний тухай нилээд дэлгэрэнгүй бичсэн байдаг. Зохиолын XII бүлгийн 281-р зүйлд Өгөдэй эцгийнхээ сууринд сууснаас хойш бүтээсэн дөрвөн зөв үйл ба дөрвөн буруу үйлийг тоочин бичсэн нь /31.253-254/ нэн ховор чухаг баримт мөн. “Монголын нууц товчоо” нь Өгөдэй хааны үеийн Их Монгол улсын төр, эрх зүйн анхдагч сурвалж бичиг мөн болой. “Монголын нууц товчоо”-той хүйн холбоотой бөгөөд түүнээс ихээхэн баримтыг нь шингээсний дээр бас түүнд байхгүй олон баримтыг багтаасан “Хаадын үндэсний хураангуй алтан товч”, 1628-1634 онд Монголын түүхч лам Лувсанданзангийн бичсэн “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч” Лу “Алтан товч” хэмээн алдаршсан зохиолууд Чингисийн дараах хаадын төр, эрх зүйд холбогдох их баримт, материалыг агуулсны хувьд эх сурвалж болох ач холбогдолтой юм.

Лувсанданзангийн “Алтан товч”-д Өгөдэй, Гүюг, Мөнх нар их хаанд өргөмжлөгдөн, түүхэн үүргээ гүйцэтгэсэнийг бичсэн /28.149-150/ байдаг бөлгөө. Чингисийн дараах хаадын үеийн монголын төр, эрх зүйн түүхэнд хамаарах сурвалж

201. Sh.Bira. "The Mongols and their state in the twelfth and thirteenth century"- "History of Civilizations of Central Asia". IV боть, тэргүүн дэвтэр, UNESCO,1998.
202. B.Ahmedov revised by D.Sinor. "Central Asia under the rule of Chinggis khan successors". "History of Civilizations of Central Asia". IV боть, тэргүүн дэвтэр. UNESCO, 1998.
203. "Word book". Encyclopedia. A Scott Fetzer company. Chicago, London, Sydney, Toronto,1995. боть 13, 719-724-р тал.
204. The Rise of Chingis Khan and his Conquest of North China. Baltimore,1950.
205. The Mongols in Syria, 1260-1300. In Edbury P.W. /ed./ Crusade and Settlement. Cardiff, 1985.231-5.
206. The `Great Yasa of Chingis Khan` and Mongol law in the Ilkhanate. Bulletin of the School of Oriental and African Students 49/1. 1986. 163-76.
207. Mostaert A. and Cleaves F.W. Les Lettres de 1289 et 1305 des ilkhans Argun et Oljeitu a Philippe le Bel. Cambridge, Mass.,1962.
208. Mostaert A. "Les letters de 1289 et 1305 des Il khan Ardun Oljeitu a Philippe le Bel". Cambridge, Massachusett,1962.
209. Histore des Campagnes de gengis khan, Cheng-wu tsin-tscheng-Lon, trad, et annot, par P.Pelliot, L.Hambis. t.1. Leiden,1951.





бичигт Персийн түүхч Жувейни “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх”, Рашид-ад-Дины “Судрын чуулган” чухал байр суурь эзэлнэ. Судрын чуулганы I ботид Өгөдэй, Тулуй, Гүюг хан нар Тангуд, Хятад, Дундаг Ази руу хийсэн аян дайнд оролцож хатуужин төлөвшсөн тухай /48.357-365/, II ботид Өгөдэй, Гүюг, Мөнх хааны гарвал хаанд өргөмжилсөн явц, түүний явуулсан бодлого, үйл ажиллагааны тухай /49.92, 128-168/ бичсэн байдаг бөлгөө.

Их Монгол улсаар аялж байсан элч-жуулчин Плано Карпины “Монголчуудын түүх”, Гильом де Рубруккийн “Дорно этгээдэд зорчсон минь”, Марко Пологийн “Замын тэмдэглэл” гэх зэрэг бүтээлүүдэд Өгөдэй, Гүюг, Мөнх хааны болон тэдгээрийн төр, улс, иргэний амьдрал, хууль цаазын тухай бичсэн зүйлс бодитой, баримттай учир төр, эрх зүйн түүх судлалд нотолгоо болох чухал ач холбогдолтой болно.

XVI-XIX зууны Монголын түүхийн тулгуур зарим зохиолууд Монголын төр, эрх зүйн түүхийн нэгэн төрлийн чухал сурвалж мөн. Эдгээр тулгуур зохиол, тухайлбал “Монголын хаадын үндэсний их шар тууж” товчоор “Шар тууж”-д Өгөдэй, Гүюг, Мөнх хааны хаан ширээнд суусан болон явуулсан бодлого, насан өөд болсон он цагийн тухай бичсэн бол 1362 онд Сэцэн хун тайж Саган Сэцэний бичиж дуусгасан “Хаад үндэсний эрдэнийн товч” /Эрдэнийн товч/-д Чингисийг залгамжилсан хаадын тухай бичсэн бөлгөө.

Мөн Монголын түүхч Жамбын 1677 онд зохиосон “Асрагч нэртийн түүх”, 1725 онд Гомбожавын бичсэн “Чингис эзний алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршив” /Гангын урсгал/, 1734 онд Ширээт гүүш Дармагийн туурвисан “Алтан ургийн тод түүх”, 1775 онд тайш Рашпунцагийн бичиж хэвлүүлсэн “Монгол улсын их Юан хэмээх улсын мандсан түүх” /Болор эрх/, 1841 онд гарсан түүхч Галдан туслагчийн “Эрдэнийн эрх”, Инжинашийн бүтээсэн “Хөх судар” зэрэг зохиолуудад Чингисийн дараах хаадын амьдрал, үйл ажиллагааны тухай хэсэгчлэн өгүүлсэн байдаг билээ.

Чингисийн дараах үеийн Монголын төр, эрх зүйн түүхийн эх сурвалжид Монголын түүхийн тулгуур зохиолууд хамаарагдана.

Үүнтэй холбогдуулж, А.Амарын “Монголын товч түүх” /1934/, “БНМАУ-ын түүх” нэгэн боть /1954/, “БНМАУ-ын түүх” тэргүүн боть /1966/, “Монгол улсын түүх” дэд боть /2003/-ыг онцлон дурдвал зохино. Монголын эрдэмтдийн бичин туурвиж, хамтын оюун ухаанаар шүүн тунгаасан бөгөөд олон арван жилийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд бүтээгдсэн эдгээр зохиолуудад Чингисийн дараах хаадын үеийн монгол улсын түүхийг тусгай анги болгон боловсруулан зохиосны дотор энэ үеийн төр, эрх зүйн түүхийн олон талт асуудал томоохон байр эзэлж ирсэн болой. Тухайлбал Өгөдэй, Гүюг, Мөнхийн хаанд өргөмжлөгдсөн үйл явц, Монгол улсын дотоод, гадаад бодлого, монголын төрийн бүтэц, зохион байгуулалт, түшмэдийн ёс,

хууль цаазын асуудлыг түүхийн шинжлэх ухааны үүднээс нэлээд тодорхой бичсэн нь эл үеийн төр, эрх зүйн түүхийн үнэт зүйлс, баримт, материалууд болно. Чингисийн дараах хаадын үеийн монгол улсын төр, эрх зүйн түүхийг судлахад XIII, XIV зууны Монголын түүхийг олон жилийн туршид дагнан судалж бичсэн зохиолууд, тухайлбал академич Ч.Далайн “Монголын түүх” /1206-1260/, доктор Д.Гонгорын “Халх товчоон” /1978/, М.Санждоржийн Монгол төрийн түүхээс XIII-XIX зуун /1998/, Ш.Нацагдоржийн “Монголын феодализмын түүхэн замнал” /1978/ зохиолуудыг онцлон дурдвал зохилтой. Дээрхи зохиолуудад Чингис хааны дараагийн хаад Өгөдэй, Гүюг, Мөнх нарыг хаанд өргөмжилсөн үйл явдал, эл үеийн төрийн байгуулалт, түшмэдийн ёс, төрийн дотоод, гадаад бодлого, хууль цаазад хийсэн шинэчлэлт, өөрчлөлтийг шинжлэх ухааны үүднээс өгүүлэн бичсэн нь эл үеийн төр, эрх зүйн түүхийн судалгааны чухал хэрэглэгдэхүүн мөн болой.

Өрнө, дорнын улсуудын сурвалж бичиг, эрдэмтэд судлаачдын бүтээлүүд Чингисийн дараах хаадын үеийн монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны зохиолд томоохон байр эзэлж байна.

XIII зууны үеийн монголын төр, эрх зүйн түүхэнд холбогдох эх сурвалжууд орос, Хятад, япон, Солонгос, араб, перс, франц, түвд, армян, турк, гүрж зэрэг хэл дээр бичигдсэн байдаг. Эдгээр нь тооны хувьд ч, чанарын хувьд ч үлэмж арвин болой. Ялангуяа Хятад сурвалж бичиг олон буйн дотор “Юан ши” буюу Юан улсын судар онцгой байр эзэлнэ. 1369-1370 оны үед Хятадын Мин улсын 13 түүхчдийн зохиосон 210 бүлэг бүхий Юан улсын сударт Чингис ба түүний дараах үеийн хаад, хатад, сайд, түшмэд, жанжинуудын намтар, энэ төрийн түүх, гадаад, дотоод бодлого, аж ахуй, эдийн засаг, соёлын холбогдолтой ихээхэн баримт мэдээ буй бөлгөө.

“Юан улсын судар”-ыг 1644 онд Манж, Монгол хэлээр хураангуйлан орчуулсан байдаг. Мөн дуу зохиолыг Монголын Чимидийн Дэмчигдорж /1863-1932/ Хятад хэлнээс монгол хэлээр орчуулсан нь нэн чухал ач холбогдолтой болно.

Оросын Хятад, монгол судлаач нэрт эрдэмтэн Н.Я.Бичурин 1829 онд “Юан улсын судар”-ийн эхний 4 бүлгийг орчуулж “Чингисийн удмын эхний дөрвөн хаадын намтар” нэртэйгээр хэвлүүлсэн ажгуу. Энэ номонд Чингис, Өгөдэй, Гүюг, Мөнх хааны тухай дэлгэрэнгүй өгүүлсэн нь эрхэм чухал өв, нэн ач холбогдолтой сурвалж болно. Оросын эрдэмтэн Н.Я.Бичурин, Н.Ц.Мунхуев, Монголын эрдэмтэн Ч.Далай, Н.Ишжамц нар “Юан улсын судар”-ыг судлах, орчуулах, суурь зохиол бичих талаар үлэмж их хувь нэмэр оруулсан ажгуу.

Оросын эрдэмтэн Н.Я.Бичурины “Чингисийн удмын эхний 4 хаант түүх” /1829/, В.В.Григорьевын “Эртнээс Төмөр хүртэлх үеийн монголчуудын түүх” /1834/, Н.Н.Беризины “Зүчийн улсын дотоод зохион байгууллын тухай найруулал” /1882/,

В.В.Бартольддын “Монголын довтолгооны үеийн Туркестан” /1898-1890/, Н.П.Козьмины “Түрэг, монголын феодализмын тухай” /1934/, Б.Д.Грекев, А.Ю.Якубовский нарын “Алтан ордон, түүний уналт” /1950/, Н.Ц.Мункуевын “XIII-XIV зууны үеийн Монгол ба Хятадын эдийн засгийн байдлын тухай асуудалд” /1965/, С.Л.Тихвинскийн “Татар-Монголчууд Ази, Европод” /1970/, Л.Н.Гумилевын “Түүх үнэнийг шаардаж байна” /1968/ зэрэг зохиолууд Чингисийн дараах үеийн хаадын монголын төр, эрх зүйн түүхийн судлалд чухал хувь нэмэр оруулсан бүтээлүүд болно.

Өрнөдийн судлаачид, тухайлбал Английн Ховорсын “Монголчуудын түүх” /1876/, Жон-ф Бадделийн “Орос, Монгол, Хятад” /1919/, Ж.Ж.Саундерсын “Монголын байлдан дагуулал” /1992/, Америкийн Х.Дэмбийн “Бүх дэлхийг эзэгнэгч Чингис хаан” /1927/, Францын Рене Груссийн “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” /2004/, “Монгол гүрэн” /1941/, Армяны Д.Оссоны “Чингис хаанаас Төмөр хүртэлх үеийн Монголчуудын түүх” /1937/, Унгарын Кара Доржийн “Нүүдэлчин монголчуудын ном” /1972/, Хятадын Пэн-Дая Сютины “Хар татарын хэргийн тэмдэглэл”, Ван говэйн “Монголын судалгаа” /1940/, Кэ Шао мины “Юан улсын шинэ түүх” /1928/, Хань, Жулинь нарын “Юан төрийн түүх” /Юан Чао Ши/ хэмээх 2 боть /1986/, Японы Янай Ватарын “Монголчуудын түүхийн судалгаа” /1970/, Ивамүра Шинобын “Монголын нийгэм, эдийн засгийн судалгаа” /1968/, Сагуул Тоорын “Монголын эзэнт улс ба Төмөрийн улс” /1987/ зэрэг өрнө, дорнын эрдэмтэд, судлаачдын зохиолууд Чингисийн дараах хаадын үеийн монголын төр, эрх зүйд холбогдох баялаг баримт, материал, мэдээлэл агуулж байгаа нь эл судлалд ихээхэн чухал ач холбогдолтой болой. Чингисийн дараах үеийн хаадын Монгол улсын төр, эрх зүйн түүхийн судлалд археологийн шинжилгээ, судалгааны үр дүн, энэ талаар хэвлэгдсэн судалгааны бүтээлүүд чухал үүрэг гүйцэтгэсэн ба цаашид ч улам гүнзгийрүүлэн судлах шаардлагатай бөлгөө.

1948-1949 онд С.В.Киселев, Х.Пэрлээ нараас Хархорум хотын туурийг малтан шинжилж “Эртний Монголын хотууд”, “Монгол хот суурины товчоон” зохиолууд бичсэн нь эл үеийн судлалд үнэ цэнэтэй хэрэглэгдэхүүн болж байна. 1961 оноос Монгол-Германы хамтарсан хээрийн шинжилгээний ангиас Хэрлэн мөрний Хөдөө арлыг шинжилсэн дүн, Монгол-Японы шинжилгээний ангиас 1990-1992 онд Хэнтий, Төв аймагт явуулсан судалгаа, “Гурван гол” хөтөлбөрийн дагуу Хэнтий ханы өвөр, Ононгийн дунд хэсэг, Хэрлэнгийн Хөдөө аралд явуулсан шинжилгээний ажил 1990-ээд оны сүүлчээр Монгол-Францын эрдэмтэдийн Хар-Хорумд хийсэн археологийн шинжилгээний дүн зэрэг нь Чингисийн дараах хаадын Монгол улсын төр, эрх зүйн түүхийг судлахад ихээхэн чухал ач холбогдолтой болой.

Чингисийн дараах үеийн Их Монгол улсын хаад болох Өгөдэй, Гүюг, Мөнх хааны намтар түүх, түүхэнд гүйцэтгэсэн роль, энэ үеийн Монгол улсын төрийн

байгуулал, төрийн гадаад, дотоод бодлого, нийгэм эдийн засаг, аж ахуйн амьдрал, хууль цааз, түүний хэрэгжиж байсан асуудлыг гүнзгийрүүлэн судлах явдал чухал шаардлагатай байгаа билээ.

Энэ талаар томоохон судалгаа явуулах, суурь бүтээлүүд туурвих хэрэгцээ үгүйсгэгдэж байгааг анхаарвал зохих юм.





МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ИХ ХААН ӨГӨДЭЙ
(1187-1241)

ХОЁРДУГААР БҮЛЭГ
Өгөдэйн хаанчлалын үеийн
Их Монгол улсын төр, эрх зүй /1227-1241/

§1. Өгөдэй хаанд өргөмжлөгдөж төр барьсан нь

Их хаан Чингис таалал төгссөнөөс хойш Монгол улсын их хаанд өргөмжлөх бэлтгэл ажил явагджээ. Их хаан Чингис насан өөд болсон нь Монголын төрийн бодлого, ард түмний сэтгэл зүйд ихээхэн нөлөөлсөн аж. Иймээс хааны орыг яаран өргөмжлөх нь гадаад улс орон, ялангуяа Хятадтай байлдааны ажиллагаа дуусаагүй байгаа, бүрэн бут цохигдоогүй үлдэгдэл хүчин эзлэгдсэн орнуудад буй, тэдгээрийг захирах захиргаа төвхнөж чадаагүй байгаа болон дотоодод ард түмэн үлэмж цочирдсон зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байсан буй заа. Шинэ хааныг хаана ямар ордонд өргөмжлөх, тэнд ямар ямар бэлтгэл ажлыг хийх, үүнд алтан ургийнхны санаа бодлыг хэрхэн нэгтгэх, бусад орнуудад байгаа ноёд язгууртанд хаанд өргөмжлөх төрийн ёслолд оролцох бололцоо олгох, ард олны анхаарлыг энэхүү ёслолд хандуулах зэрэгт зохих цаг хугацаа шаардагдсан нь эл үеийн бодит байдал мөн байв. Энэ бүх ажилд хоёр жил шахам хугацаа зарцуулжээ. Түүнээс биш хаанаа сонгохгүй л байгаад байсан хэрэг бус. Учир юун хэмээвээс шинэ хааныг сонготол төрийн хэргийг Чингисийн хүү Тулуй мэдэж явуулах, их хаанаар Өгөдэйг өргөмжлөх нь эзэн богд Чингисийн захиас, гэрээсээр нэгэнт тогтоогдсон байсан бөлгөө.

Их Монгол улсын шинэ хаанд өргөмжлөх бэлтгэл ажлыг нэрт жанжин Чингис хааны отгон хүү Тулуй удирдаж, түүнд алтан ургийнхан, төр, цэргийн зүтгэлтнүүд, төрийн сайдууд, мянгатын ноёдууд идэвхтэй оролцжээ. Чингис хаан, Тулуйг отгон хүүгийн хувьд дэргэдээ байлгахыг ямагт хичээж, бичиг үсэг, эрдэм номд сургах, цэргийн жанжны авьяас чадвар, цэргийн урлаг эзэмшүүлэхэд ихээхэн анхааран бололцоо олгож, сургаал, ивээлээ харамгүй хайрлан, томоохон байлдаанд нэгэн гар болон явдаг байсан бөлгөө. Энэ тухай Рашид-ад-Дин “Тулуй хан ихэнхдээ эцгийн дэргэд байнга л байдаг байв. Чингис хаан чухал чухал бүх ажил хэргээ түүнтэй зөвлөлдөн ярилцдаг байв. Тэрбээр Тулуйг нөхрөө гэж үздэг байлаа. Чингис хааны өргөө гэр, ордон /хөрөнгө/, сан хөмрөг /ам бүл/, ноёд нөхөд, хувийн ба торгон цэрэг цөм л түүний захиргаанд байдаг ажгуу. Учир нь Монгол, Түрэгийн аль эрт дивангарын үеэс тогтсон заншлаар бол тэд том хөвгүүдээ өрх тусгаарлан гаргаж, хөрөнгө мал, хонин сүрэг тасдаж өгөөд үлдсэн нь отгон хөвүүнд харьяалагддаг бөгөөд түүнийгээ “Отчигин” буюу гал голомтын эзэн, ам бүлийн үндэс нь гэдгийг заан тогтоодог байв” /49.121/ гэж бичжээ. Их хаан баруун ба дорно зүгт явуулсан том аян дайнуудад ялангуяа Тангуд, Алтан, Хорезмын улсыг дайлахад отгон хүү Тулуйгаа хамт авч яван, бас өөртэйгөө хамт байлгаж, гол гол цэргээ

захирах жанжнаар ажиллуулж байсан бөлгөө. Рашид-ад-Дины хэлсэнчлэн “Тулуй дайнд явахдаа ч их аз хийморьтой байлаа. Хан хөвгүүдийн нэг нь ч түүний чинээ улс, хотыг эрхшээлдээ оруулж байсангүй билээ” /49.122/. Иймээс Тулуй эцэг хааныхаа төрх, төлөв, зан ааш, холч ухаан, хүнийг өөртөө татах, хүндэтгэх, хүмүүнлэг хандах, цэрэг удирдах, иргэнийг засах эрдмээс ихийг сурч, хатуужин боловсорсон цэргийн нэрт жанжин, улс төрийн хийгүй бодлоготон, авъяаслаг зохион байгуулагч, асар их нэр хүнд олсон эцэгтээ үнэнхүү итгэгдсэн хүү нь байсан болой.

Шинэ хааныг сонгогтол монгол орныг Тулуй захирч, төрийн хэргийг шийдвэрлэж байв. Тэрбээр бас Монгол улсын 120 мянган шилдэг морьт цэргийн 100 мянгыг нь захирч байлаа. Тийм болохоор Тулуйн нэр төр өндөр, сүр хүч их байжээ /36.139/.

Энэ ч чанараараа Тулуй Их Монгол улсын хаанд Өгөдэй ахыгаа өргөмжлөх бэлтгэл ажлыг гялалзтал зохион байгуулж, Их хаанд өргөмжлөх бүхий л үйл явцыг биечлэн удирдаж, олны итгэл хүндэтгэлийг хүлээн, эцгийнхээ захиасыг нэр төртэй биелүүлснийг болгоон ажаамуй. Их Монгол улсын шинэ хааныг өргөмжлөх Монголын төрийн Их Хуралдайг 1229 оны намар хийхээр товлон тогтоосон бөгөөд энэ л товлосон хугацаандаа Их Хуралдай чуулжээ. Их Хуралдайд Алтан ургийнхан түүний дотор том ах Зүчийн¹ хүүхдүүд, ах Цагаадай², Өгөдэй³, тэдгээрийн үр хүүхдүүд зэрэг ихэс дээдэс, ноёд язгууртны нийт хүрээлэл бүрэн хамрагдаж, гол хэмээсэн хүмүүс бүгд хүрэлцэн ирсэн нь эл Хуралдайг хүсэн хүлээж, түүнд асар их ач холбогдол өгч байсныг харуулнам. Их Хуралдай хоёр үе шаттайгаар явагджээ.

Эхний шат болох гурван өдөр уламжлал ёсоор найр хурим болж, эрийн гурван наадам хийжээ. Чингэхдээ зөвхөн наадаад л өнгөрсөн бус. Олон жил уулзалдаагүй хүмүүс учран золгож, бие биесээ ихэд хүндэтгэн, бусдыгаа үгүйлж байснаа илчилж, сэтгэлээ онгойтол хөөрөлцөж байв. Хол ойроос ирсэн ахан дүүс, ураг садныхан, ноёд жанжин нар өөр хоорондоо уулзан нутаг орон, аян дайн, гэр орныхныхоо сонин сайхныг хүүрнэн ярилцаж байжээ. Залуус нь бие биесээ нүдээрээ харж, сэтгэлээрээ танилцан ойртож дотноссон байна.

Их Хуралдайн хоёр дахь шат дөрөв дэх өдрөөсөө эхэлж, Их Монгол улсын хааныг сонгох түүхэн хариуцлагатай үйл ажиллагаа явагджээ. Тулуй хаан их хааныг сонгох Хуралдайн үйл ажиллагааг эхнээс нь дуустал даргалжээ /39.139/.

Түүх шастирт “Их Хуралдай хурж байх явцад алтан ургийн ихэс дээдэс, ноёд түшмэдийн ихэнх нь Тулуйн амыг харж, түүний араас хуйлран дагах нь мэдэгдэхүйц ажиглагдаж байлаа”/39.139/ хэмээн тэмдэглэсэн байдаг. Сэтгэлдээ нэгийг бодсон эрдэмтэн сайд Елюй Чуцай, Тулуйд “Чингис хааны гэрээсэлсэн ёсоор ах Өгөдэйгээр тань их хааны суурийг залгамжлуулбал шударгыг сахиж, хожмын хойно хэл ам бага болох биз ээ. Тунгаан соёрхогтун” /39.139/ хэмээн сануулсан байдаг бөлгөө.

Чингис хааны орыг залгамжлах их хааныг сонгох Хуралдай эхэлмэгц түүнийг даргалагч Тулуй хаан Өгөдэй ахыг хаан эцгийн гэрээсэлсэн ёсоор Монголын хааны сууринд өргөмжлөх нь зүйтэй гэж хэлээд Чингисийн гэрээсийг уншиж сонсгожээ. Чингис хаан гуравдахь хүү Өгөдэйгээр хаан ширээг залгамжлуулах тухай хоёр удаа гэрээслэж байсан нь түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Эхний удаад Хорезмын эзэнт улс руу хийх туйлын их хүнд бөгөөд хариуцлагатай аян дайны өмнөхөн Есүй хатан,

Хаан минь !

Өндөр давааг давж өргөн мөрнийг гэтэлж

Урт аянд морилохдоо улс иргэнээ захирахыг

Урьтал болгож сэтгэнэ.

Төрсөн бие түлбэрэх түмэн амьтны хуулийг

Төгс ухаандаа санаасай.

Уул мэт бие чинь нурж одвол

Улс орон Монголыг чинь хэн захирах юм бэ?

Тулгуур мэт бие чинь туйвж одвол

Туг, сүлдийг чинь хэн өргөх юм бэ?

Төрсөн дөрвөн хүүгээс чинь төр барих нь хэн бэ?

Хан хөвгүүд, дүү нар, харц олон ард ба

Хатад бид бүхэнд хариу айлдах эсэхийг

Хааны зарлиг мэдтүгэй /31.225/ хэмээн сануулсныг Чингис хаан ухааран мэдэрч сайшаагаад, хан хөвгүүдтэйгээ зөвлөлдөн, саналыг нь сонсож гуравдахь хүү Өгөдэй намайг залгамжилна хэмээн гэрээсэлсэн байдаг /50.219-222/.

Дараагийн удаад Чингис хаан Тангуд улсыг дайлаар ялж яваад нас барахынхаа өмнөхөн 1227 оны зун, энд байлдаж явсан хүү Өгөдэй, Тулуй нараа дуудан ирүүлж “Миний насны эцэс нэгэнт тулсан мэт. Би та нарын төлөө энэхүү өмнө, умар, дорно хааш хаашаа бүр нэг жил явах өргөн уудам нутаг орон бүхий их улсыг анх цогцлон байгуулав. Та нар дайснаас сэргийлж, иргэдийг илүүц хураан олны сэтгэлийг нэгэн сэтгэл болгож чадвал төрийн суурийг удаан эдэлж чадна. Намайг үхсэн хойно та нар Өгөдэйг эзнээр өргөмжлөх хэрэгтэй.

Одоо та нар буцаж тус тусын хэргээ эрхлэх болно. Би ийм их алдар хүндийг эдэлсэн тул харамсах зүйл үгүй. Миний сүг, сүнс эх нутагтаа буцах болтугай! Цагаадай хэдийгээр дэргэд байхгүй боловч миний гэрээсийг зөрчиж, самуурал гаргахгүй байх аа” гэж гэрээсэлж байжээ /45.200, 50.285/.

Чингис хааны гэрээсийг уншсаны дараа Өгөдэй босч Тулуй “өдөр ч шөнө ч ажлын ба ажлын бус цагаар эцгийн дэргэд байж, дэг жаяг, яс хуулийг сонсож тахин мэдсэн хүн билээ” /49.16/

Их хаан түүнд хаант улсаа, хаан ширээгээ шилжүүлж, хаан ширээ залгамжлагчаа болгох бодолтой байсан юм шүү /49.12/. Иймээс дүү Тулуйг хаан сууринд суулгавал болохгүй зүйл үгүй хэмээн хариу хэлжээ. Дараа нь “хан хөвгүүд нь нэгэн санаагаар өгүүлрүүн, Чингис хааны зарлигийн хүчин дор бурхны ивээлээр чи бол оюун билгээ хаанчлахад зориулах болно. Учир нь эрхшээлийг үл дагагсадын тэргүүн нар ч амь амьдрал зүтгэхэд бэлэн байхаар чиний ойрын ба холынхон, түрэгүүд, тазикууд бүгд чиний тушаалд захирагдах, дагах учиртай” /49.16/ гэжээ. Мөн олон ноёд дараалан босч “Эцэг хаан тэнгэр халихын өмнө их хааны сууринд Өгөдэй таныг суулгахаар гэрээслэн үлдээсэн тул тэрхүү гэрээс зарлигийг зөрчиж зүрхлэх хүн бидний дунд нэгээхэн ч үгүй. Тулуйн санал зүйтэй ажгуу” /36.140/ хэмээн өчицгөөв.

Хан хөвгүүд дахин саналаа нэгтгэж, “Чингис хаан бүх хөвгүүд ах нарын чинь дотроос чамд л энэ аугаа их хэргийг даатгаж, түүнийг манлайлах эрхийг чамд л үлдээсэн шүү дээ. Түүний шулуухан тушаал халдашгүй тогтоолыг яахин хувиргаж, өөрчилж болохсон билээ” /49.16/ гэж айлтгажээ. Ийм байдлаар их хааныг залгамжлах асуудлыг хан хөвгүүд, алтан ургийнхан, ихэс дээдэс, ноёд жанжин нар нухацтай ярилцаж, зөвлөлдсөний дараа Өгөдэй “эцгийн тааллыг дагах, авга нар, ахсын зааврыг дагах нь чухал гэж үзээд зөвшөөрлөө өгчээ” /49.16/. Чингээд 1229 оны үхэр жил, намар цагаар Чингисийн гуравдахь хүү Өгөдэйг Их Монгол улсын хаанд өргөмжилжээ. Хаанд өргөмжлөх ажиллагаа Хэрлэнгийн Хөдөө аралд тусгайлан бэлтгэж зассан их өргөөнд явагдсан байна. Хаанд өргөмжлөх цаг мөч болохуйд Өгөдэй монгол заншлаар бүсээ хүзүүндээ өлгөн, малгайгаа гартаа барьж, цээжиндээ гараа тавин алтан ургийнхан, сайд, ноёдын өөдөөс ёс гүйцэтгэв. Дараа нь Өгөдэйг баруун гараас Цагаадай, зүүн гараас нь Тулуй хан, бүсэлхийнээс нь Отчигин ноён түшин хаан ширээнээ залав.

Ингээд Тулуй хан Өгөдөйд алд хадаг аягатай сүү өргөн барихад хааны өргөөний гадна дотно байсан бүх хүмүүс есөнтөө өвдөг нугалан сөгдөн /49.16-17/ мөргөж ёслол гүйцэтгэв.

Өгөдэй хаан Хуралдайд оролцсон сайд, бараа бологсдоо дагуулж, өргөөнөөс гараад наран өөд гурван удаа сөхрөн мөргөжээ. Өгөдэй буцаж өргөөндөө орж ирээд их суудалдаа заларч, сайд, ноёдоо баруун гартаа, хатад, гүнж нараа зүүн гартаа зэрэгцүүлэн зогсоож “Эцэг их хаан Чингисийн байгуулсан улсыг бүү зовооё, Хөлийг нь хөсөр, гарыг нь газар тавиулж жаргуулая. Хаан эцгийн бэлэн суурийг эзлээд иргэнийг нь үл зовоохыг эрхэм болгоцгооё” /36.140-141/ хэмээн давтан хэлж тангарагласан байна. Ийнхүү Өгөдэй, Их Монгол улсын хоёрдугаар далай хаан болсон ажгуу. Өгөдэй их хаанд өргөмжлөгдсөнийхээ дараа төрөл төрөгсөд, гадны аймгийнхан, цэргүүд, хүн бүрт билэг хүртээж найр хурим хийжээ. Тэгээд дараагийн гурван өдөр монгол заншил, жаягийнхаа дагуу Чингис хааны сүнсний төлөө хүмүүсийг хооллон буян хийж, их тахилга⁴ үйлдсэнийг Судрын чуулганд бичсэн байна.

Өгөдэй, Их Монгол улсын далай хаанаар өргөмжлөгдсөн нь монголчуудын язгуур эрх ашигт нийцсэн агаад Чингис хааны бодлогыг тууштай үргэлжлүүлж, Монгол улсыг улам хүчирхэг гүрэн болгон хөгжүүлэх итгэл өгсөн асар том үйл явдал, Өгөдэйд оногдсон маш өндөр хариуцлага байсан бөлгөө.

Хаан эцгийн гэрээсийг биелүүлж, Өгөдэйг Их Монгол улсын хаанд өргөмжлөхөд түүний дүү Тулуй хан чин үнэнчээр зүтгэж шударга үүрэг гүйцэтгэсэн болой.

Тулуй хан эцгээсээ хойш ахас, төрөл төрөгсдөө ихэд асрамжлан үзэж, янз бүрийн тус ихэд хүргэсэн учир цөм баярлацгааж байлаа. Тулуй ханыг алтан ургийнхан “Их ноён” , “Өрлөг ноён”, “Аугаа их ноён” гэж цоллодог байв. Тэрбээр энэ цолоороо алдаршсан аж. Зүрх ба зориг, захирамжлах, шүүн хэлэлцэх талаараа түүнтэй зэрэгцэхүйц хүн байсангүй /49.117/ хэмээн Рашид-ад-Дин бичсэн байдаг.

Тулуй хан, Өгөдэй ахыгаа их хаанд өргөмжлөгдсөний дараа ихэнхдээ түүний дэргэд байж, түүнийг бүх талаар дэмжин тусалж, саналаа сэтгэл харамгүй хэлж зөвлөж байсан бөгөөд Өгөдэй хаан ч Тулуйг ихэд итгэн хүндэтгэн хайрлаж байжээ.

Өгөдэй хаан, Их Монгол улсын төрийг 12 жил барьж, хаан эцгийнхээ гэрээслэлийг нэр төртэй биелүүлж байгаад 1241 онд насан өөд болсон бөлгөө.

§2. Өгөдэйн хаанчлалын үеийн

Их Монгол улсын төрийн байгуулал

Хамаг Монгол улсын төрийн зохион байгуулалтад тулгуурлан эцэг Чингисээс тогтоосон Монголын нэгдсэн улсын төрийн байгуулал, засаг захиргааны зохион байгуулалтыг Монгол гүрний нөхцөлд нийцүүлэн боловсронгуй болгож зохих шинэчлэлт хийх явдал зүй ёсоор шаардагдсан байна. Энэ нь Монгол улс, хөгжлийн түвшингээр харилцан адилгүй монгол угсааны олон аймаг, ханлигуудыг нэгтгэн улс байгуулсан болохоор тэрхүү олон аймгуудын нийтлэг дүр төрхөд тохируулсан бөгөөд эзлэн авсан олон улс орныг захирах бодлогыг тусгасан, тэдгээрийн туршлага сургамжийг харгалзсан тийм төрийн байгуулалтай байх шаардлагатай амин холбоотой байжээ. Үүнээс гадна Чингис хааны үед олон жилээр сунжирсан дайн явуулснаас дотоод байдлаа засан тохижуулах, засаг захиргааны зохион байгуулалтыг гүйцэт боловсруулж, зохих өөрчлөлт хийж чадаагүй, эдийн засаг соёлоо өөд татаж хөгжүүлэх, ард түмнийхээ аж амьдралыг сайжруулах, суурьшмал амьдралын туршлагыг хэрэглэх ажлыг нухацтай хийж амжаагүй зэрэг нь Өгөдэй хаанд бүр ч их хариуцлага оногдуулж, дээрх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах зорилт тулгаран тавигдсан ажээ. Монголын түүхэнд тэмдэглэсэнээр “Их Монгол улс /Чингисийн/ үндсэндээ гурван түмний хяналтад байж, мянгатын журам гүйцэд хэрэгжээгүй, төрийн зохион байгууламж эгэл бүдүүн, хааны шадар тушаалтны тоо ч цөөн, тэдний гүйцэтгэх үүрэг

ч төдий л нарийн биш байжээ” /36.141/. Энэ тухай Юан улсын сударт Чингис “умард газраас мандаад олон аймгуудыг бүгдийг олсон боловч хээр суух тул хот, дүүргийн хууль ч үгүй бөгөөд улсын зан суртал нь шулуун зузаан тул олон хэргийг будлиангүй, гагцхүү түмт, цэргийн ноёд аймгийг захирч, заргач түшмэл эрүү засна. Тушаалд хэрэглэх нь нэгэн хоёр эрхэм сурвалжит тэргүүлсэн сайдаас өнгөрөхгүй бүлгээ” /Юан. Суд. 85-р бүлэг/ хэмээн бичжээ. Дээр дурдсан бодит байдлыг Өгөдэй хаан ухааран ойлгож, ахин дахин нягтлан болгоож, шадар сайд, түшмэл ноёд, ахас эхэсүүдтэйгээ зөвлөлдсөний эцэст нэгэн үзүүрт сэтгэлд хүрч, шинэчлэлийн чанартай нилээд арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Тэхдээ Чингис хааны төрийн уламжлал, ёс заншлыг хатуу сахиж, төрийн байгууллаар тогтоосон бүтцийг эвдэлгүйгээр түүний зохион байгуулалт, ажиллах журмыг сайжруулах, боловсронгуй болгох, эл үеийнхээ нөхцөлд нийцсэн шинэ бүтэц, орон тоог бий болгох, зардлыг нь нэмэгдүүлэх, төрийн түшмэдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд Өгөдэй хаан өөрийн бодлого, үйл ажиллагааг бүрнээ чиглүүлсэн ажээ.

Өгөдэйн үеийн Их Монгол улс нь хэмжээгүй эрхт хаант засагтай улс байв. Хэмжээгүй эрхт хаант ёсыг залгамжлан авсан нь уламжлалаа дагахын хамт Тангуд, Алтан, Сүн улс, Уйгур, Хорезм зэрэг хөрш зэргэлдээ буюу ойр харилцаатай байсан улсуудын хэмжээгүй эрхт хаант засгийн нөлөө ч байсан байж болох юм.

Өгөдэй Их Монгол улсын “Далай” цолтой эзэн хааны хувьд хэмжээгүй эрх эдэлж, төрийн дээд бүх эрх мэдлийг өөртөө төвлөрүүлж байв. Рашид-ад-Дины бичсэнээр Өгөдэй гэдэг нь “Өөдөө, дээшээ” гэсэн утгаар өгөгдсөн өргөмжлөгдсөн нэр аж. Харин “Далай” гэдэг нь “тэнгис, далай шиг хаан” гэсэн өргөн утгыг илэрхийлнэ хэмээн үздэг. Өгөдэй гэдэг үг нь “өргөмжлөл” гэсэн утгатай ажгуу /49.4/. Өгөдэй хаан, эцэг Чингис хаанаас “хаан гэдэг нь улсын нүүр царай, өнгө зүс мөн тул сүртэй ч байх, хийморлог ч байх, эрх дархтай ч байх, уужим ухаалаг ч байх, бас тэгээд авьяас билэгтэй байх ёстой” /80.19-20/ гэж сургасныг улсаа жолоодох, хэмжээгүй эрх мэдлээ хэрэглэхэд ямагт санаж байжээ. Чухам үүнд Өгөдэй ихэд санаа зовж, сэтгэлдээ үргэлж тээж явсан нь их хаанд өргөмжлөх үед “Эцэг хааны байгуулсан энэ агуу их улсын төрийн хэргийн жолоог сулруулах, цаашилбал алдах бий гэхээс яс янгинах юм” /81.19-20/ гэж хэлснээс тодорхой харагдах бөлгөө.

Өгөдэй хаан хэмжээгүй эрхт хаан, улсын эзэн, төрийн тэргүүний хувьд хууль батлах, засаг захиргааны хуваарийг тогтоох, төрийн байгууллагуудыг байгуулах, төрийн сайд, жанжин, түмт, мянгатын захирагчийг томилох, Их Хуралдайг хуралдуулах, олон улсад элч төлөөлөгч томилох, гэрээ хэлэлцээр байгуулах, шүүн таслах дээд эрх эдлэх, улсын өртөө бий болгох, гааль, татвар, түрээсийн төрөл, хэмжээг тогтоох, аж ахуй, эдийн засаг, худалдаа арилжаа, соёл, гэгээрлийн тодорхой бодлого явуулах, арга

хэмжээ авах, газар бэлчээр олгох, цэрэг, иргэдийг халамжлах, тусламж тэтгэлэг олгох, улсын цэргийг ерөнхийлөн захирах, цэргийн стратеги, тактикийг тодорхойлох, дайны олз ашгийг хуваарилах талаар хэмжээгүй эрх эдэлж байжээ.

Өгөдэй хааны их орд нь Хархорум хотод байрладаг хамгийн том бөгөөд үзэсгэлэн төгс “Түмэн амгалан” орд байжээ. Энэ ордод далай хаан төрийн хэргээ явуулж, элч төлөөлөгчдийг хүлээн авч, Их Хуралдайг чулуулдаг байсан аж. Өгөдэй хаан Хархорумын умардад орших шар ордондоо зусаж, Хөх нуурын /Хөх ус/ дэргэд намарждаг байлаа гэж сурвалжид тэмдэглэсэн нь бий. Их хаан нийт 6 ордтой байсан бөгөөд жилийн дөрвөн улирлыг эдгээр ордуудад өнгөрөөдөг байжээ /36.157/

Өгөдэй бол “ихэмсэг, ухаантай, авъяаслаг, эрэгцүүлэн тунгаан боддог, хатуу чанд төрх, намбатай, уужуу тайван, шулуун шудрагаараа тодрон гарсан” /49.4/ байдлаараа их Чингис хааныг залгамжилж, эцгийнхээ “хаан хүн иргэд, албатынхаа сэтгэлд бүрэн нийцэж, хүнд мэндийг тэднээс аяндаа олбол тэр жинхэнэ хаан байна” /81.19-20/ гэсэн захиас, гэрээсийг ягштал биелүүлсэн болой.. “Өгөдэй хаан угаас уур уцааргүй, налгар тайван, холын гүйлгээ ухаантай, илүү дутуу үггүй, бусдыг тоож сонсоод эргэцүүлж боддог, эрдэмтэн хүнийг дээдэлдэг, түүх судар унших дуртай бас тэгээд удам угсааныхаа түүх намтрыг их мэддэг, үлгэр сонсох дуртай, ядуу доодсыг өрөвдөн хайрладаг, хувийн аминцар үзэл байхгүй. Юмны эвийг аятайхан олдог, цэргийн хэргийн өндөр мэдлэгтэй, улсыг удирдах увидастай” /17.162/ зан чанараараа ард олны итгэлийг хүлээж, улмаар тэр нь хааныхаа үүргийг биелүүлэхэд нь эерэг хүчин зүйл нөлөөлж байжээ.

Өгөдэйн үед, өргөн хүрээнд өөрчлөлт, шинэчлэл явагдаж, төрийн нэр хүнд өсөн, улсын гадаад харилцаа өргөжиж, эдийн засаг, мал аж ахуй, соёл сэргэн хөгжиж, гаднаас довтлох аюул үгүй, амар тайван болсон бөлгөө.

Өгөдэй хаан, Монгол гүрний орд, туг, тамгыг эрхэмлэн хүндэтгэж, ёс төртэйгээр байрлуулан залж, ариунаар хамгаалж байсан бөгөөд үүнээ улс орон цаг ямагт хөгжин, дэвжиж байхын баталгаа хэмээн ихэд бэлэгшээдэг байжээ.

Өгөдэйн Их Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал нь төрийн бэлэгдэлд илэрхийлэгдэж байсан ажгуу. Өгөдэй хаан Монгол төрийн уламжлал ёсоор төрийн хамгийн дээд хууль ёсны баталгаа болгон Хас тамгыг хэрэглэж байв. Хаш чулуугаар сийлж үйлдсэн хас тамганы хэлбэр, доторхи үгн түүний сийлбэрийг Өгөдэй хаан гүйцэд боловсруулж, Их Хуралдайгаар хэлэлцүүлэн батлуулж эл тамгаа “Хасбуу” хэмээн нэрлэжээ /17.140/.

Өгөдэй хаан эцэг Чингис хааны сүлд тахих тахилгыг бий болгож, түүнд зориулан найман цагаан гэр барьжээ. Гол дунд нь байрлуулсан есөн хөлт сүрлэг том цагаан тугийн зүүн талд дөрөв, баруун талд дөрөв бүгд 8 цагаан гэр барьж, ес дэх билэг

дэмбэрэл нь цагаан туг өөрөө болдог ажээ. Тахилгыг Чингисийн нас барсан өдрөөр жил бүр үйлддэг болсон байна.

Өгөдэй хаан, эцэг Чингисээс залгамжлан авсан догшин хар сүлд, төрийн есөн хөлт цагаан тугийг 1236 онд Хар Хорум дахь хааны өргөөнд байрлуулан залжээ /17.139/. Догшин хар сүлд, есөн хөлт тугийг манаж хүндэт харуул зогсдог журам тогтоосон байна.

Өгөдэй, Их Монгол улсын төрийг 12 жилийн турш барьж, эзэн хааныхаа нэр төрийг хүндэтгэн хадгалж, хаан байх ариун үүргээ шударга сайнаар биелүүлсэн ажгуу. Тэрбээр “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэнчлэн, хаан эцгээсээ хойш дөрвөн их зүйлийг бүтээснээ, *Нэгдүгээрт*, Зүрчид иргэнд аялж, зүрчид иргэнийг мохоов би. *Хоёрдугаарт*, бидний элч хурдлан явуулж, харилцах ба элдэв зөөлгөх өртөө замыг тавиулав. *Гуравдугаарт*, усгүй газар худаг малтуулж, гаргуулаад улс иргэдийг ус, өвсөнд хүргүүлэв.

Дөрөвдүгээрт, зүг зүгийн суурин иргэдэд ахлагч, тамгачийг тавьж улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж амар түвшин болгов /31.253/ хэмээн хэлсэн байдаг бөлгөө.

Үүний хамт мөн дөрвөн буруу үйл хийснээ дурдсан нь “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгджээ. Энэ бол Өгөдэй хааны төлөв шударга, чин үнэнчийн илэрхийлэл болой.

Өгөдэй хаан 1241 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн үүрээр тэнгэр хальж гэнэт насан өөд болжээ. Өгөдэй хаан бол хаанчлалынхаа турш Чингис хааны гэрээслэл, “Их засаг” хуульд үнэнч байж, Монголын эзэнт улсын төрийг бэхжүүлэх, эдийн засаг, аж ахуй соёлыг өөд татах, монголчуудын аж амьдралыг сайжруулахын төлөө амь бие хайрлахгүй зүтгэсэн их хаан байсан бөлгөө.

Өгөдэй хааны үед төрийн Их Хуралдай тогтмол чуулж, улс орны амьдралд, төрт ёсны төлөвшилтөд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Өгөдэй хаан Их Хуралдайн бүтэц, бүрэлдэхүүнийг сайжруулахын тулд түүнд оролцох хүмүүсийг тодорхой болгон тусгайлан тогтоосон байна. Их Хуралдайгаар хэлэлцэх асуудлыг өргөжүүлж, улс орны амьдралын чухал асуудлыг хэлэлцдэг болгожээ. Дайн зарлах, найрамдал, гэрээ хэлэлцээр байгуулах, их хаанд өргөмжлөх уламжлалт асуудлаас гадна хууль батлах, албан татвар тогтоох, улсын өртөө байгуулах, хааны элчид онцгой эрх олгох зэрэг асуудлыг хэлэлцдэг болгожээ. Их Хуралдайг чуулах горим дэглэмийг нарийсгаж, түүнийг хааны товлосон газар, орд, өргөөнд хийх, албан ёсоор зарласан Их Хуралдайд оролцохоор хаанаас тогтоосон ихэс, язгууртнууд заавал биечлэн ирж оролцох, хэрэв оролцоогүй бол зэм ял оногдуулахыг журамлан тогтоож мөрджээ. Үүний үр дүнд Хуралдайн нэр хүнд, үүрэг роль өсөж, ажил хэрэгч чанар дээшилсэн байна. Өгөдэйн хаанчлалын хугацаанд Их Хуралдай 5 удаа хуран чуулжээ. Үүний анхны Их Хуралдай 1229 оны намар чуулж, Монголын нэгдсэн улсын их хаанд

өргөмжлөх асуудлыг хэлэлцэн Чингисийн гурав дахь хүү Өгөдэйг Их Монгол ын далай хаанаар өргөмжилжээ. Өгөдэйн хаанчлалын үеийн хоёрдахь Их Хуралдай 1231 оны 5 дугаар сард Өвөрмонголын “Ерэн есөн булаг” хэмээх газарт болж Зүрчидийн Алтан улстай байлдах тухай хэлэлцэж, тус улстай хэрхэн яаж байлдах талаар нухацтай ярилцаад гурван замаар яаравчлан довтолж цохилт өгөх шийдвэр гаргажээ. Өгөдэйн үеийн гурав дахь Хуралдай 1232 онд болж уургын улааг халж, улсын өртөө байгуулах тухай асуудал хэлэлцээд улсын нэгдсэн өртөөг Монгол гүрний хэмжээнд байгуулах түүхэн шийдвэр гаргажээ. Өгөдэйн хаанчлалын үед дөрөв дэх Их Хуралдай 1234 оны 5 дугаар сард “Даландаваа” гэдэг газар чуулж, аравтын дотроос дураар гарч явахыг хориглох тухай хуулийг хэлэлцэн баталсан байна.

Өгөдэйн хаанчлалын үеийн тав дахь Их Хуралдай 1235 онд Хархорум хотод чуулжээ. Энэхүү Хуралдайгаар Алтан улсыг байлдан эзэлсэн дүн ба Өрнө зүгт аян дайн явуулах тухай хэлэлцэн өрнө зүгт дайны үйл ажиллагааг явуулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргажээ.

Өгөдэй хаан “Сэцдийн зөвлөл”-ийг уламжлал ёсоор ажиллуулж, гүйцэтгэх үүргийг нь тодорхой болгожээ. Сэцэдийн зөвлөлийг Их Хуралдайн завсар чөлөөгөөр хуралдуулж, хойшлуулшгүй тулгамдсан чухал асуудлыг хэлэлцэн, хамтын саналаар шийдвэр гаргадаг байжээ. Жишээлбээс, 1232 онд Сэцэдийн зөвлөл “Уургын улааг халж, улсын өртөө байгуулах асуудал”-ыг хэлэлцэж, өртөө байгуулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргаж байсан байна.

Өгөдэй хаан “үхэрчин”, “агтчин” /адуучин/, “хоньчин” гэсэн албан тушаал бий болгосон нь мал сүргийн эдгээр төрлүүдийг өсгөн үржүүлэх, ашиглах явдал төрийн түвшинд хүрч энэ талаархи бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан төрийн тусгай түшмэлүүд бий болгож ажиллуулж байсныг харуулж байна. Мянгат бүхэнд “нутагчин” хэмээх орон албан тушаалтан бий болгосон нь бэлчээр нутгийг олгох, ашиглах, хяналт тавих асуудлыг дагнан хариуцаж байжээ. Өгөдэй хаан, Чанай, Уйгуртай нарыг нутагчдын ажлыг хариуцах түшмэдээр томилон ажиллуулсан байна.

Өгөдэйн хаанчлалын үед төрийн байгууллагын бүтцэд зарим өөрчлөлт оруулан, аравтын тогтолцоог гүйцэд тогтоон төлөвшүүлж, захирах ноёд, түшмэдийн эдлэх эрх хариуцах үүргийг тодорхой болгосон байна.

Өгөдэй хаан, хааны ордны аппаратыг бэхжүүлж, үүрэг ролийг нь дээшлүүлсэн бөлгөө. Хааны ордонд 6 чэрби ажиллуулж байв. Улсын гадаад, дотоод бүх үйлийг эдгээр чэрбиуд даргална. Орд, өргөөнүүдийг хишигтэн цэргээр байнга харгалзан хамгаалуулна. Хааны ордонд сайд, түшмэл, бичээч, хишигтэн, гэрийн хөвгүүд, эмс, охид, сөнчин, буурчин, агтач, хоньчин, үхэрчин гэх зэрэг олон тооны хүмүүс ажиллаж тус бүр тодорхой ажлыг хариуцан гүйцэтгэж байв.

Өгөдэй, хааны ордны сайд зөвлөхөөр Тулуй хан, Тататунгаа, Елюй-Чуцай, Чингай ноён, заргачаар Шихихутуг, цэргийн жанжинаар Сүбээдэй, Хятад дахь хааны төлөөний сайдаар Бор жанжин, Хорезм дахь хааны төлөөний сайдаар Махмуд Ялавич, Тангудыг захирах хааны төлөөний сайдаар хан хөвүүн Хүдэрийг, ордны эмчээр Чжао Хун, түшмэдээр Булхадар, Уйгур, Хадаг, Булгат, Бал, зурхайч, бэхээр Хөх цөс зэрэг тухайн үедээ нэрд гарсан эрдэм номтой хүмүүсийг томилон ажиллуулж байсан бөгөөд эдгээр нь ордны аппаратыг бэхжүүлж, үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чухал роль гүйцэтгэжээ.

Өгөдэй хаан, Алтан улсыг эзлэн авсны дараа, түүний төрийн зохион байгуулалтаас санаа авч, 1234 онд “Чжүн шүшэн”⁵ хэмээх нэртэй, засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам байгуулж, ерөнхий сайдаар нь Елюй Чуцайг томилжээ. Энэ тухай Юан Улсын судрын 85 дугаар бүлэгт тэмдэглэн бичсэн байдаг. Гэхдээ энэ нь зөвхөн умард Хятадыг захирахад зориулагдаж байсан аж. Өгөдэй хаан энэ яамыг байгуулахдаа Хятад орныг зөвхөн Хятад аргаар захирч болох баримтлалыг харгалзан байгуулсан байж болох юм. Энэхүү ерөнхийлөн шийтгэх яам нь төрийн захиргааны төв байгууллага мэтээр харагдах боловч үнэн хэрэг дээрээ төрийн захиргааны дээд байгууллага /Засгийн газар/-ын үүргийг гүйцэтгэж байсан байна. 1218 оноос Их Монгол улсын төрийн албанд зүтгэсэн Елюй Чуцай ноён Өгөдэйг хаан ширээнд суусны дараа “Морин дээр байгуулсан улсыг морин дээрээс удирдаж болохгүй” /9.246/ гэж зөвлөснийг бодон тунгаагаад Хятад орныг Хятадын аргаар нь удирдах ёстой юм байна гэж тооцоод эл яамыг Хятадыг захирахаар зориуд байгуулсан байж болох талтай.

Өгөдэй хаан ордны харуул, хамгаалалтыг сайжруулж, үүрэг хариуцлагыг нь өндөржүүлэн, харъяалал, зохион байгуулалтад өөрчлөлт оруулжээ. Энэ тухай “Монголын нууц товчоо”-нд “Чингис хаан эцгийн алтан амийг сахиж байсан хэвтүүл, хорчин, торгууд, хаан эцгийн шадар явсан түмэн Хишигтнийг Цагаадай, Тулуй хоёр Өгөдэй хаанд өгөв” /31.269/ гэж бичсэн байдаг. Хишигтэн нь урьдын адил хэвтүүл хэмээх шөнийн манаа, торгууд хэмээх өдрийн харуул, хорчин хэмээх шадар цэргээс бүрдэж байв. Өгөдэй хаан Хишигтэнийг “Өтгөс хэвтүүл”, “Их турхагууд”, “Өтгөс баатар”, “Ихэс хорчин” /14.190/ гэж тус нэрлэсэн байна. Хишигтэн нь 2000 хорчин, 1000 хэвтүүл, 7000 торгуудаас бүрдэж байв. Хишигтэн цэргийг өөрийн мэдэлд аваад, захирагч, ахлагчдыг нь томилж, гүйцэтгэх үүргийг нь нарийн тодорхой болгон тогтоосон байна. Үүнд: Бүх хэвтүүлийн захирагчаар мянганы ноён Хаданыг томилжээ. Хэвтүүлүүд нь дөрвөн ээлж болон хуваагдаж ордныг хамгаална. Дөрвөн ээлж тус бүрийн ахлагчаар Хадаан-Булхадар, Амал-чанар, Хадай-Хори-чар, Ялбас-Хараудар хавсарч нэг ээлж болон ордны дэвсгэрийн заасан хэсэгт манааны үүрэг

гүйцэтгэхээр шийдвэрлэжээ. Хэвтүүлүүд хааны бие болон ордыг тойрон хамгаалж, үүдийг сахин харгалзана. Орд гэрт орох, гарах бүх асуудлыг Хонхордай, Ширхан хоёр эрхлэн хэвтүүлтэй хамтран гүйцэтгэнэ.

Хорчины захирагчаар Есүнтэй, Бүхэдэй, Хар худаг, Лабалха нарыг томилжээ. Тэд дөрвүүл нум, сум агссан торгуудаа дөрвөн ээлж болгон ээлж бүрийн хорчиноо захирна /31.278/ Бүх хорчины захирагчаар Илжигэдэйг томилсон байна.

Торгуудууд хааны дэргэд байж, өдрийн цагаар хааны шадар цэргийн үүрэг гүйцэтгэн хааны бие, орд өргөөг хамгаалахаас гадна хаан байлдаанд орвол түүний биеийг хамгаалан тулалдах үүрэгтэй. Хорчин торгууд нар өдөр дараалан ээлжлэн манаж, наран шингэмэгц хэвтүүлд үүргээ шилжүүлж өгнө.

Хишигтэн нь түмт, мянгат, зуут, аравтын ноёдын хүүхдийн дотроос сонгогдсон шилдэг эрчүүдээс бүрэлдэж, хааны туг, зэр зэвсэг, аяга савыг хариуцан, ундаа, айраг цагаа, мах шүүсийг мэдэж, орд өргөөг манан хамгаалж, ордны гадна, дотны бүх үйлдлийг зохицуулан, орд өргөө байрлах газрыг сонгож, бүх нүүдэл, суудлыг эрхлэн гүйцэтгэнэ. Хишигтэн зөвхөн их хаанд захирагдана. Иймээс хишигтэнг “өмч түмэн хишигтэн” хэмээн нэрлэх явдал ч байжээ. Хишигтэн нь өндөр эрх мэдэл эдэлж, хатуу сахилга, дэг журамтай байж, аливаа болзошгүй аюулаас хааны бие, орд өргөө, хатад, үрс, засгийн аппаратыг цаг мөч алгасалгүй, өдөр шөнө ялгалгүй хамгаалж байсан ажээ.

Өгөдэй хаан болмогцоо Их Монгол улсын цэргийн нэгдсэн удирдлагыг бий болгосон байна. Тулуй өөрийн мэдэлд байсан 100000 морьт цэрэг ба их хааны хишигтэн цэргийг Өгөдэй хаанд ёс төртэйгээр хүлээлгэн өгчээ.

Далай хаан улсын бүх цэргийг өөрөө ерөнхийлөн захирч, аян дайн байлдааныг удирдах цэргийг толгойлох жанжин, захирах жанжнуудыг томилж байв. Жишээлбэл, Дундад Азид Шах Мухаммедын үлдэгдэл хүчнийг цохих цэргийн жанжнаар Чурмаган ноёныг, Алтан улстай байлдах байлдааны цэргийн жанжнаар Тулуй хан, Зэв, хөвүүн Хүдэр, Сүбээдэй баатрыг томилж, өөрөө Алтан улстай хийх дайныг биечлэн толгойлж удирджээ. Мөн Солонгост явуулсан байлдааны жанжнаар Сартаг баатрыг, Өрнөдөд хийх аян дайныг толгойлон удирдах жанжнаар Зүчийн ахмад хүү Батыг⁶, байлдааныг удирдах ерөнхий жанжнаар Сүбээдэй баатрыг тус тус томилсон байдаг бөлгөө.

Өгөдэй хаан улсын нийт цэргээ хишигтэн цэрэг, улсын их цэрэг хэмээсэн хоёр төрөлд хувааж, аравтлах системийг нийт цэргийн зохион байгуулалтын үндэс болгон бэхжүүлсэн байна. Сурвалж бичигт хишигтэн цэргийг улсын “гол хүч”, шилмэл “цэргийн анги” хэмээн нэрлэж байсныг тэмдэглэсэн байдаг /36.144/. Хишигтэн цэрэг түмт, мянгат, зуут, аравтын ноёдын хөвгүүдийн дотроос шалгарч шилэгдсэн хүмүүсээс голлон бүрэлдсэн, цэргийн эрдэм, аргад илүү бэлтгэгдсэн, эр зоригтой, байлдах ур чадварыг гарамгай эзэмшсэн, хааныг хамгаалж, ямагт хаантай хамт явдаг,

хаан байлдвал түүнийг хамгаалан тулалддаг, зэвсэг сайтай, жирийн цэргээс илүү эрх ямба эдэлдэг, зөвхөн хаанд захирагддаг, түүнд үнэнчээр зүтгэдэг, хатуу сахилга, дэг журамтай зэрэг олон давуу талтай учраас “гол хүч” хэмээсэн байж болох юм. Цэрэг нь мянгат, зуут, аравтаараа зохион байгуулагдаж, ноёд тус бүр өөрийн цэргээ бүрдүүлж захирдаг байжээ.

Цэргийн албыг 20 наснаас 70 хүртэлх насны эрчүүд хааж байх Чингисийн зарлиг хүчин төгөлдөр үйлчилж байсан аж. Өгөдэй хааны үед Монгол цэргийн тоо чухамд хэд байсныг тэмдэглэн бичсэн нь ховор.

Гэвч түүхэн сурвалжид “Их Монгол улсын хүйс болсон Монгол орныг Тулуй захирч байснаас гадна 120000 шилдэг морьт цэргийн 100000 нь түүний гарт байсан” /36.139/ гэж тэмдэглэгдсэнээс үзэхүл Өгөдэй хааны үед Монгол улс ямарч гэсэн 120000 шилмэл морьт цэрэгтэй байсан нь тодорхой байна. Энэ бол монгол улсын цэргийн гол хэсэг, найдвартай хүч мөн. Үүнээс гадна аян байлдаан хийх цагт дагаж орогсдоос цэргийн хүч бэлтгэх, гэрээгээр цэргийн хүч авч дайнд хэрэглэх явдал нилээд гарч байсныг тэмдэглэлтэй.

Тухайлбал, Алтан улстай байлдах үед Цайчжоу хотыг бүслэн байлдахад Сүн⁷ улстай байгуулсан гэрээний дагуу тус улсын жанжин Хуны удирдсан 200000 цэрэг Монгол цэрэгтэй хавсарч байлдсанаас /36.159/ үзэхэд энэ байлдаанд лав л 300000 орчим цэрэг оролцсон байх магадлал байгаа болой. Өгөдэй хаан, Монгол цэргийн удирдлагыг Чингис хааны үеийн шалгарсан баатар ахмад жанжнууд, шинээр төрж хатуужин өсөж буй залуу жанжнуудаар хослуулан бэхжүүлж, шилдэг залуу жанжнуудыг төрүүлэх бодлого явуулж, амжилтад хүрсэн ажгуу. Энэ үед ахмад туршлагатай жанжин Сүбээдэй, Цагаадай, Тулуй, Зэлмэ, Отчигин, Шихихутуг зэрэг алдартнууд чухал үүрэг гүйцэтгэж байсны зэрэгцээгээр Зүчийн ахмад хүү Бат, Мухулайн ахмад хүү Бор, Өгөдэйн ахмад хүү Гүюг⁸, Цагаадайн ач хүү Бури⁹, Тулуйн хүү Хубилай¹⁰, Мөнх, бусад хан хөвгүүд Хүдэн, Хүчү зэрэг залуу жанжнууд тодрон гарч цэргийн удирдлагыг бэхжүүлж байсан аж. Өгөдэйн хаанчлалын үеийн төрийн орон нутгийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаанд зарим талын шинэчлэл хийжээ. Юуны өмнө Их Монгол улсыг түмт, мянгат, зуут, аравтын системд бүрэн оруулжээ. Энэ үед гадаад мянган буюу олсон зөөснөөрөө байгуулсан мянгатууд, 1206 оноос хойш байгуулсан мянгатууд зүгшрэн тэгширч, бусад мянгантайгаа бараг адил болжээ /36.143/. Иймээс мянгатуудыг ялгаварлан үзэх шаардлагагүй болсон байна. Мянгат бүхэнд бэлчээр нутаг олгож, албат ард, бэлчээр нутгийг мал сүрэгтэй нь хамт мянгат бүхэнд хуулиар эзэмшүүлж, энэхүү мянгатаасаа дураар гарч орох явдлыг бас хуулиар хориглож, хэрэв зөрчвөл хатуу цээрлүүлж шийтгэхээр тогтоосон байна. Энэ нь засаг захиргааны гол хуваарь болох мянгат жинхэнэ ёсоор засаг төрийн үйл ажиллагааны гол нэгж болж, түүнд иргэнийг захирах эрх мэдэл төвлөрч, захирах, засах ажиллагаа явуулах бололцоо бүрэлдэн, мянгатын ажил хэрэг тэгшрэхэд хүргэсэн байна.

Үүний үндсэн дээр хуулийг хэрэгжүүлэх, хаан, түмт, мянгатын зарлиг, шийдвэрийг биелүүлэх, бэлчээр нутгийг эзэмшүүлэх, ашиглуулах, ав хомрого хийх, малаа өсгөж үржүүлэх, худаг ус гаргах, худалдаа арилжаа явуулах, иргэнийг асрах, гааль татвар хураах, өртөөний алба хаах, алба гувчуур төлөх бүх ажил мянган дээр явагдах болсон байна. Үүнийг дагаад зуут, аравтын ажил цэгцрэх болжээ.

§3. Өгөдэйн хаанчлалын төрийн дотоод бодлого

Өгөдэй хаан “Хөлийг нь хөсөр, гарыг нь газар тавиулж жаргуулья” хэмээн их хаанд өргөмжлөхөд өргөсөн тангаргаа ямагт санаж улсынхаа дотоод бодлогын талаар шинэчлэлийн шинжтэй олон олон чухал зорилтууд тавьж хэрэгжүүлжээ. Тухайлбал, Засаг захиргааны зохион байгуулалтыг гүйцэд боловсруулах, хууль эрхэмжийг тогтоож, төрийн хуулийг чангатгах, эдийн засгаа өөд татах, төрийн аппаратын гүйцэтгэх үүргийг нарийсгах, цөл говьд худаг байгуулж бэлчээр, нутгийг өргөтгөх, мянгатад бэлчээр, нутаг олгох ажлыг гүйцээн явуулах, ард олныг халамжлан, татвар түрээсийг хөнгөлж, ядуусын сан байгуулж тэтгэх, цэргийн нэгдсэн удирдлагыг бий болгох, уургын улааг халж, улсын нэгдсэн өртөөг байгуулах, гааль гувчуурын бодлогыг улсын эдийн засгийг хөгжүүлэх түлхэц болгох, гар урлал, үйлдвэрийг төрөөс хөхүүлэн дэмжих, худалдаа арилжааг чөлөөтэй болгох, өргөжүүлэх, ан агнуурыг амьдралын чухал хэрэгцээ болгох, хот байгуулалтыг бий болгож хөгжүүлэх нь Өгөдэй хааны дотоод бодлогын үндсэн гол зорилтууд байсан ажээ.

Олон жилийн сунжирсан дайн явуулснаас засаг төрийн зохион байгуулалтыг төдий л гүйцэд боловсруулан хэрэгжүүлж чадаагүй, төрийн аппарат, түшмэдийн гүйцэтгэх үүрэг нарийвчлан тогтоогдож хэвшээгүй, төрийн хууль тогтоомж, дэг ёс бүрэн боловсрогдож, нийтийн хүртээл болоогүй, цэргийн нэгдсэн удирдлага тогтоогүй байсныг Өгөдэй хаан нягтлан тунгааж нилээд цэгцтэй арга хэмжээнүүд авч хэрэгжүүлжээ. Энэ тухай төрийн байгуулалт, цэргийн зохион байгуулалт, эрх зүй гэсэн дараагийн зүйлүүдэд өгүүлэх болно. Өгөдэй хаан, газар нутгийн харьяалал, нутаг бэлчээр, байгаль орчныг мэдрэх, хүндэтгэж бишрэх, ашиглах, хамгаалах талаар нилээд нухацтай бодлого явуулжээ. Зарим эрдэмтэд монгол дахь газар нутгийн харьяалал нь эзэн ноёны нэрийн доорхи харьяалал байсан гэдэг /36.143/. Тэгвэл ийм харьяалал нь Өгөдэйн үед шинэ газар нутгийн харьяалал болсон байна /9.246/. Үнэхээр Монголын “бэлчээр нутаг”¹⁶ гэдэг нь их өргөн агуулгатай бөгөөд жишиж хэлбээс дэлхий нийтэд хэрэглэдэг “экологи” гэсэнтэй дүйцэхүйц утга санааг илэрхийлнэ хэмээн хэлж болно. Учир юун гэвэл бэлчээр нутаг гэдэг ойлголтод тэрхүү бэлчээр нутагт буй газар, уул толгод, тал говь, гүвээ даваа, ой мод, бут сөөг, өвс ургамал, жимс сонгино, гол мөрөн, булаг шанд, ус хужир, агаар салхи, ан амьтан, хүн, мал бүгд хамаарагдах бөлгөө.

Монголын бэлчээр нутаг нь хэмжээний хувьд уудам, том бөгөөд ус, өвс, ногооны шимийг даган нүүдэллэн амьдрахад зохицсон, жилийн дөрвөн улиралд буудаллах өвөлжөө, хаваржаа, намаржаа, зусланг багтаасан байдгаараа суурьшмал орны тариа, ногоо тарьж амьдрах газраас эрс ялгаатайгаараа онцлог болой.

Иймээс Өгөдэй хаан, мянгатад бэлчээр нутаг олгох эцэг Чингисийн бодлогыг үргэлжлүүлж, түүнийг гүйцээн явуулж, мянгатын ноёдод эзэмших нутаг хуваарилан олгох ажлыг дуусгажээ. Энэ тухай “Монголын нууц товчоо” нд “Улс иргэнд нутаг усыг хуваан өгье. Нутгийг хувааж сонгож нутаглахад мянгат бүрээс нутагчиныг ялгавал зохино” \31.252\ гэж бичжээ. Ийнхүү бэлчээр нутаг хуваан олгох ажлыг мянгат бүрээс тусгай албан ёсны нутагчныг томилон гаргуулж гүйцэтгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл мянгат бүрт “нутагчин” хэмээх газар олгох ажил эрхэлсэн тусгай албан тушаалтныг бий болгож, түүгээр дамжуулан бэлчээр нутгийг хуваарилан олгуулж дуусгажээ. Доктор Гонгор “Бүх мянгатын нутаг усыг батлан тогтоож, нийтээр журамлуулах ажлыг Өгөдэй хааны үед гүйцэтгэсэн”-ийг Халх товчоон зохиолдоо тэмдэглэсэн /14.246/ байна. Үүний үр дүнд мянгат тус бүр тодорхой хил зааг бүхий эзэмшил нутагтай байжээ. Европын элч В. Рубрук “Ямар нэгэн ноёд өөрийн харьяат хүн өрхийн олон цөөнөөр түүний бэлчээр нутгийн хил хязгаарыг мэдэх ба мөн өвөл, хавар, зун, намарт хаана мал сүргээ адуулахыг мэдмүй” /79.91/ гэж аян замын тэмдэглэлдээ бичсэн бол Плано Карпини “Хаанаас зааж өгөөгүй нутагт хэн ч зоргоороо нутаглаж үл чадмуй. Хаан бээр хан хөвгүүдэд, хан хөвгүүд түмний ноёдод, түмний ноёд мянганы ноёдод, мянганы ноёд зууны ноёдод нутаглах нутгийг нь тус тус дам дамаа дэглэн зааж өгнө” /79.45/ гэж бичсэн байна. “БНМАУ-ын түүх” хэмээх зохиолд “феодалын газар нутгийн харьяалал нь нүүдлийн мал аж ахуйн нөхцөл байдлаас болж шууд үйлдвэрлэгчдийг нэгэн тогтмол газар байнга бэхлэн хадах хэлбэрээр бус, харин феодалууд харьяалах ардын малын бэлчээрийг захиран мэдэж, нүүдэл суудлыг нь зохицуулан удирдаж, ардууд тус тусын мянгат, зуут, аравтын хуваарьт нутгаас эзэн ноёны зөвшөөрөлгүй шилжин явах эрхгүй байснаар илэрч байжээ” /9.247/ гэж бичжээ. Эдгээр баримтууд нь эл үед бэлчээр нутгийг хувиарлан олгох, түүнийг ашиглах, эзэмшихэд шинэчлэл явагдаж байсныг нотолно.

Бэлчээр нутгийг хуваарилан олгосон төдийгүй түүний ашигт чанарыг дээшлүүлэх, ашиглах даацыг нэмэгдүүлэхэд багагүй анхаарал тавьж байжээ. Тангууд, Хорезмын улсад аян дайн хийх явцад говь цөл газар мал маллах, худаг малтаж ус гаргаж байсан туршлагыг харгалзан Өгөдэй хаан монголын говь тал газар худаг малтуулж, хүн малын ундаа бий болгон, тэнд малчдыг нутаглуулах бодлого явуулжээ. Чингээд Өгөдэй хаан “Цөл говь нутагт гөрөөснөөс өөр амьтангүй байна. Ард иргэд уужим суухыг хүсэж байна.

Чингай, Уйгуртай тэргүүтэй нутагчдыг явуулж говь цөлд худаг малтуулж хашуульа “ /31.252/ хэмээн зарлиг буулгаж олон олон худаг малтаж, ус гаргаж хүн, малыг усаар ханган малчдыг тэнд нутаглуулсан нь тухайн үедээ яахын аргагүй шинэ зүйл, том амжилт байсан юм. Иймээс Өгөдэй хаан сууринд суугаад эцгээсээ хойш үйлдсэн сайн дөрвөн үйлийн нэг нь “Усгүй газарт худаг малтуулж гаргуулаад улс иргэнийг ус өвсөн хүрэлцээтэй болгосон “ /31.253/ явдал мөн гэж өгүүлсэн бөлгөө.

Их Монгол улсын аж ахуй, түүний дотроос мал аж ахуй улам бүр сэргэн хөгжсөн нь Өгөдэй хааны үе ажээ /36.150/. Өгөдэй хааны үед мал сүрэг нь жилээс жилд өсөн үржиж, малын удам, сайн чанарыг дээшлүүлэхэд их анхаарал тавьж байсан байна.

Өгөдэй хаанаас мал аж ахуйн талаар явуулсан бодлого, авсан арга хэмжээ нь түүний эдийн засгийн шинэчлэлийн зорилттой салшгүй холбоотой байжээ. Энэ нь Монгол орон мал аж ахуйн орон, хүн ардын эрхлэх үндсэн аж ахуй нь мөн мал аж ахуй байсантай холбоотой. Ямаа-янгир, тэмээ-хавтгай, адуу-тахь гэх мэтээр монголын таван хошуу малын, түүний дотор ямаа, тэмээ, адууны өвөг удам улам бүр нутагшин хөгжсөөр байв. Армяны Д.Оссон монголд “Тэрийн малаас тэмээ, үхэр, хонь, ямаа арвин байх ба адуу хамгийн олон”, Плано Карпини, Рубрук нар монголчууд “тэмээ, үхэр, хонь, ямаа, адуугаар тун баян” гэх мэтээр өөрийн зохиол, аян замын тэмдэглэлдээ дурдсан байдаг. Эдгээр нь монголчууд таван хошуу малаар баян бөгөөд амьдралын гол хэрэгсэл байсныг харуулна.

Өгөдэй хаан, таван хошуу малын амьдралын хамгийн гол, чухал үүрэг гүйцэтгэдэг сүргийг нь тооны хувьд өсгөх, удам, чанарын хувьд хайрлах, ашиг шимийг нь зохистой ашиглах, бие мах бодийг нь хамгаалах, эрхэмлэж бишрэхэд илүү анхаарч, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан байна. Үүнтэй холбоотойгоор бод малын дотроос адуу, тэмээн сүргийг онцгойлон үзэж, эл сүргүүдийг улсын мэдэлд шууд авч өсгөж байсан ажээ. Энэ нь адуу бол өртөө цэргийн үндсэн уналга, тэмээ нь жин тээх, худалдаа арилжааны бараа тээвэрлэх, нүүдэл суудал хийх, өртөө улаагаар зорчиход асар их хүнд ачаа тээдэг байсантай шууд холбоотой байв. Сурвалж бичигт тэмдэглэсэнээр монгол оронд нэг моринд 6-7 хонь дүйцэх жишигтэй байсан учир 100 адуутай хүн 600-700 толгой хоньтой гэсэн үг” /64.150/. Монголчууд адууг уналганд хэрэглэхдээ даага байхаас нь сургаж гурван жил дараалан дасгасаар хэрэгцээндээ бүрэн чөлөөтэй хэрэглэдэг болгодог байв.

Морийг эрхэмлэн хайрлаж, сайн морио гагцхүү ан гөрөө хийх, ав хомрогод оролцох, цэргийн дайн байлдаанд унах заншилтай байжээ. 300-500 адууг нэг суурь болгон тогтоож улсын хяналтад авч байжээ /36.151/. Үүний зэрэгцээгээр адууг тэргэнд хөллөх, гүүний сүүгээр айраг хийж ундаалах, арьс ширээр нь гутал хувцас, сав суулга хийх, дэл сүүлээр нь дээс, аргамж томох, махыг нь идэх зэргээр ахуйн хэрэгцээндээ өргөн хэрэглэнэ.

Иймээс адууг өсгөх, сайн маллах, хайрлаж хамгаалах явдал төрийн бодлогын түвшинд хүрч байсан болой. Тиймийн учир “хээр талын нүүдлийн аж ахуйг хүлэг морины хүч дэмжлэггүйгээр эрхэлж үл чадах нь тодорхой билээ” хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг /36.151/

Өгөдэй хаан, мөн үхэр, хонь, ямаан сүргийг өсгөхөд ч анхаарч байжээ. Үхрийг гэр өргөөг нүүлгэхэд тэргэнд хөллөж амьдрал ахуйдаа өргөн хэрэглэж байв. Хаад ноёдын нэг том өргөөг нүүлгэхэд 22 шар хөллөж байсныг монголд ирж байсан элч нарын замын тэмдэглэлд дурдсан нь бий. Үхрийн мах, үс, арьсыг мөн л өргөн хэрэглэж байсан бөлгөө.

Малыг дээдлэн хайрлах нь Өгөдэй хааны бодлого, малд хандах хандлагын бодит илэрхийлэл байсан ажгуу. Тэрбээр малыг зодож болохгүй, малыг зовоож алж болохгүй, малыг үргээж болохгүй, морийг гамнан уна, малыг зохистой идээшлүүлж, ус, хужиараар хангах, говийн үржил шимтэй нутгийг малын бэлчээрт ашиглахыг номлож, түүнээ биелүүлэхийг шаардаж байсан байна.

Өгөдэй хаан, гар урлал, үйлдвэрийг хөгжүүлэн дэмжих бодлого явуулжээ. Юуны өмнө цэргийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зэвсэг, техникийг үйлдвэрийн аргаар хийж байсан аж. Цэргийн сэлэм жад, хөө хуяг, нум, сум, харвагч оньс, дарь зэрэг зэр зэвсгийг эл үйлдвэрт хийж байжээ. Хархорум хотод ширэм хайлуулж, төмөр боловсруулах үйлдвэр байгуулан ажиллуулж байв.

Гэр ахуйн хэрэгсэл хийх үйлдвэр байгуулсан нь аж ахуйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн аж. Орд-гэрэг тэрэг, гэр тэрэг хийж их хаан, хан хөвгүүд, хатад ноёд, ихэс дээдсийн хэрэгцээг хангаж байв. Мөн гэр ахуйн хэрэгсэл, тухайлбал гэрийн тооно, унь, хана, хаалга, дээвэр, туурга, оосор бүч, авдар шүүгээ, сав суулга, хувцас хунар зэргийг хийж байжээ. Элч-жуулчин Рубрук, “Монголын гэр тэрэг нүүж явахыг урьдаас нь харахад асар том хот өмнөөс ирж нүүж яваа мэт харагддаг” гэж /13.107/ бичсэн байдаг.

Өгөдэй хаан, гар урлалыг барууны туршлагаар нилээд өндөр түвшинд хөгжүүлэх зорилго тавьж байсан байна. Гар урлалын олон үйлдвэр байгуулж, гадаад, дотоодын олон гар урчуудыг ажиллуулж байжээ. Хорезм, Алтан улстай хийсэн дайнд олон хотуудын гар урчууд, уран дархчуудыг олзлон авчирсан нь гар урлалын үйлдвэрийн мэргэжсэн ажилчид болж, хөгжин өргөжихөд нь их үүрэг гүйцэтгэсэн байна. Тэд алт, мөнгө, сувд, гууль, зэс, төмөр, эрдэнийн чулуу, шавар, мод, яс, арьс, шир зэргээр янз бүрийн гоёл чимэглэлийн зүйлс, уран хийцтэй эд хогшил, бэлэг, дурсгалын хэрэглэгдэхүүн хийж байжээ.

Өгөдэй хаан, ан авыг аж ахуйн хэлбэрийн хувьд төдийгүй цэрэг, стратегийн их ач холбогдлыг нь бас харгалзан үзэж тэтгэн дэмжиж байжээ.

Түүхэн сурвалж бичиг, тухайлбал “Монголын нууц товчоо”, Рашид-ад-Диний “Судрын чуулган”, “Юан Ши” судар, Плано-Карпини¹¹, Гельом де Рубрук¹², Пэн Дая¹³, Сюй Тин нарын тэмдэглэл зэрэг эл үеийн бүтээлүүдэд ан, ав хоморгын тухай заавал бичсэн байдаг нь ан агнуур монголчуудын амьдралд ихээхэн үүрэг гүйцэтгэж байсныг харуулж буй баримтууд мөн юм. Тэгэхдээ ан амьтныг бүлэг, сүргээр нь хүйс тэмтрэх, байсан нутгаас нь айлган үргээхийг цээрлэж, харин байршуулан өсгөх, зөвхөн хэрэгцээндээ тохируулан агнах, агнасан ангийнхаа мах, арьс, үсийг зөв зохистой ашиглах, хэрэглэхийг ихэд чухалчилж байсан ажээ. Ангийн махыг тэгш хуваан авах, айл аймгийнхандаа ангийн мах хүртээх, дайралдсан хүнд ангийн махнаас амсуулах заншилтай байв. Өгөдэй хаан ав хоморгыг цэргийн сургуулилт гэж үзэн олон цэрэг эрс, ноёд, жанжнуудыг оролцуулан нарийн зохион байгуулалт, дэг журамтай хийх зорилго тавьж хэрэгжүүлж байжээ. Ав хоморго нь олон мянган хүнийг оролцуулан хэдэн сарын турш үргэлжилдэг байсан аж. Пэн Дая, Сюй Тин нарын тэмдэглэлээс үзэхэд их ав хомрого жил бүрийн 9 дүгээр сараас дараа жилийн 2 дугаар сар хүртэл үргэлжилдэг байжээ /91.135-140/. Ав хомрогын онцлог нь олон сараар үргэлжилдэг, эр зориг, эрч хүч, тэсвэр тэвчээр, хатуужил, авхаалж самбаа, хурц хараа, цэцэн тусгал, хөнгөн шаламгай, цэвэрч нямбай, эвсэг нөхөрсөг, элэгсэг нигүүлсэнгүй байдлыг шаарддаг болон ангийн “олз, омгийг бүх оролцогчдод тэгш хуваадаг” /36.6,140/ дэг журмаар илэрдэг байна. Ан агнуурыг хугацаатай, ёс төртэй, хэр хэмжээтэй агнадаг нь агнуурын өөрийнх нь эрхэмсэг соёл байжээ. Үүний зэрэгцээгээр энгийн ард иргэд, айл саахалт, өрх гэрийн эрчүүд хувиараа ан агнаж амьдрал ахуйнхаа нэгэн төрөл хэрэгцээг хангаж, махыг нь идэж, арьс үсийг нь арилжаалахын хамт үр төлд нь үл халдах, хээлтэй анг үл агнах, аль болохоор үржин өсөх нөхцлийг нь чөлөөтэй байлгах, ангийн олзноосоо айлынхандаа амсуулах, багачууд хүүхдэд ан агнах арга ухааныг зааж өгөх заншлыг хатуу дагаж байсан ажээ.

Өгөдэй хааны дотоод бодлогынхоо хүрээнд уургын улааг халж, улсын нэгдсэн өртөөг өргөтгөн байгуулжээ. Их хаан улсын нэгдсэн өртөө байгуулах асуудлыг Төрийн Их Хуралдай болон Сэцдийн зөвлөлөөр хэлэлцүүлэн Цагаадай, Бат, Шихихутуг, Елюй Чуцай, Булхадар, Уйгурдай, Хөхцөс, Хадаг, Булгат, Бал зэрэг хан хөвгүүд, эрдэмтэн мэргэд, ноёдын саналыг авчээ. Өгөдэй хаан Цагаадай ахдаа элч зарж “Элч нарыг одоогийн байдлаар явуулахад элч нар удаан явах ба ард олонд зовлон чирэгдэл үлэмж их байна. Одоо бид байнга журам болгож зүг зүгийн мянгатаас замчин, улаачин гаргаж, суурь суурьд өртөө тавьж, элчийг ард олны дундуур хамаагүй уургын улаа унаж хэсүүчлэн давхихгүй гагцхүү өртөө замаар явах болгоё. ... Эдгээр хэлсэн зүйлсийг зохимжтой гэж зөвших эсэхийг Цагаадай шийдтүгэй” /31.252/ гэж хэлүүлсэнд Цагаадай тал талаас нь нягтлан үзээд “тэр ёсоор хийтүгэй” гэж зөвшөөрөөд хариу элч

зарж “Би эндээс угтуулан өртөө замыг байгуулсугай. Бас эндээ Батад элч илгээе. Бат угтуулан өртөө зам байгуулж холботугай... Бүгдийн хооронд өртөө зам тавья гэдэг зөвөөс зөв” хэмээн хэлүүлжээ /31.252/.

Эдгээрийн үндсэн дээр Монгол гүрний хэмжээнд улсын өртөө байгуулах ажлыг зохион байгуулсан байна. Монгол орны дотоодод 37 суурь өртөөг¹⁴ Хятадын нутагт Бээжингээс Монголын хил хүртэл, Цагаадай, Батын улс тус тусдаа салбар өртөөдийг угтуулан байгуулжээ. Ингээд Өгөдэй хааны үед бүрэн бус тоогоор 1500 өртөө байгуулсан аж /36.148/. Суурь өртөө бүрд өртөөний сууц, улаач, улааны морь шүүсний хонь, саалийн гүү, хөллөх үхэр, ачих тэрэг зэргийг бэлтгэсэн байна. Өртөөнүүдийг бага, дунд, том өртөө гэж ангилан, том өртөөнд 1000, дунд зэргийн өртөөнд 500, бага өртөөнд 100 шахам улаач ажиллаж байжээ. /36.149/

Нэгдсэн өртөөг байгуулсан нь эдийн засаг, зам харилцааны чиглэлээр хийсэн нэн томоохон шинэтгэл болж, улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Иймээс их гүрний нэгдсэн өртөөг байгуулсныг Өгөдэй хаан эцгийгээ залгамжилсанаас хойш хийж бүтээсэн дөрвөн сайн үйлсийн нэгэнд оруулсан нь “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэсэн бөлгөө. Энэ тухай Өгөдэй, хаан эцгийнхээ их сууринд сууж, хаан эцгээс хойш үйлдсэн сайн хэргийн ...хоёрдугаар нь “Бидний хооронд элч явуулж харилцах ба элдэв хэргийг зөөлгөх өртөө замыг тавиулсан” /36.281, 253/ явдал болов хэмээн дурджээ.

Өгөдэй хааны гааль, гувчуурын бодлого нь улс орны эдийн засгийн хөгжилд томоохон түлхэц болжээ. Тэрбээр улс орны хэмжээнд үйлчлэх албан татварын нэгдсэн тогтолцоо бий болгож, түүндээ ард олноос авах гувчуурын хэмжээ, малын татвар, газар тариалангаас авах гувчуур, гаалийн татвар, газрын татвар зэргийг хамааруулсан байна. Өгөдэй хаан зуун толгой мал бүхий арван толгой малаар татвар авах, монголд ирж суурьшсан гадаадын иргэдийн эзэмшил газар, худалдаа, мяндсан эдлэлээс гаалийн татвар авахаар шийдвэрлэж, тэдгээрийн тоо хэмжээг тогтоосон байна.

Татварын нэгдсэн тогтолцоо бий болгосон нь улсын сан хөмрөгийг арвижуулж, эдийн засаг, аж ахуй хөгжихөд тогтвортой хөрөнгийн эх үүсвэр бүрэлдүүлэх бололцоог олгосон үлэмж ач холбогдолтой байжээ.

Монголын түүхэнд өгүүлснээр Өгөдэй хаан, Их Монгол ын хаадын дотроос хот барьж байгуулах талаар хамгийн их ажил хийсэн нь бөгөөд Монгол улсын Нийслэл Хар Хорум¹⁵ хотыг барьж гүйцэтгэн /36.156/ гавьяат үйлс бүтээсэн болой. 1220 онд Хархорумыг Их Монгол улсын нийслэл болгоно гэж тогтоосон боловч түүнийг барьж байгуулах ажил арай хожуу эхэлжээ. Сурвалж бичигт бичсэнээс үзвэл 1235 оноос Орхон голын хөвөөнд хот байгуулж “Хархорум” хэмээн нэрлэжээ. Хархорум хотын тухай Европын элч жуулчин Марко Поло, Плато Карпини, Гильом де Рубрук, Хятадын

Пен-Дая, Ажао-Хун нар нилээд дэлгэрэнгүй бичиж, өөрсдийн замын тэмдэглэлдээ үлдээсэн болой. Өгөдэй хаан Хархорум болон бусад хотуудыг барихад эзлэгдсэн орнуудаас олзлогдсон гар урчууд, уран барилгачдыг өргөнөөр дайчлан оролцуулсан байна. Хотыг барих ажлыг Хятадын уран барилгач Лю Мин, Монголын нэрд гарсан, авъяаслаг зохион байгуулагч Отчигин ноён нар удирдан гүйцэтгэжээ.

Хархорум хотод Монгол хааны “Түмэн амгалан” хэмээх сүрлэг ордон баригдаж, түүний төв дунд том асар байх бөгөөд хоёр жигүүр нь хоёр эгнээ баганатай аж. Ордон нь өмнө зүг хандсан гурван хаалгатай, гол хаалганы дотор талд мөнгөн модыг босгожээ. Хааны суудлыг харагдахуйц өндөрт зассан, түүнд хүрэх хоёр шаттай. Ордны өрнө этгээдэд эрчүүдийн, зүүн этгээдэд бүсгүйчүүдийн суудал, баруун хажуугийн баганын өмнө этгээдэдийн өндөрлөг тавцан дээр хан хөвгүүд, хааны дүү нарын суудал, зүүн хажуугийн баганы өмнө тавцан дээр хатад, охидын суудал зассан байна. Их хатны суудлыг хааны дэргэд арай доохно засжээ. Орхон голоос суваг татаж оруулсан хиймэл нуур хийсэн байна. Хиймэл мөнгөн модны иш, навч бүгдийг мөнгөөр хийж, дээр нь мөнгөн бишгүүр үлээж буй христосын шашны охин тэнгэрийг цутган зоожээ. Мөн мөнгөн модны дөрвөн талд дөрвөн арслангийн толгой хийн тавьж, тус тусын дор мөнгөн сав тавьжээ. Найр хурим болох үеэр мөнгөн бишгүүр дуугарч, дөрвөн арслангийн амнаас архи, дарс, бал бурам, айраг гоожин доорхи саванд орох бөгөөд найрлагч хан, сурвалжтанууд зооглодог /13.185-186/ ажээ.

Хархорум нь Их Монгол улсын засаг захиргаа, худалдаа, соёлын төв, дорно дахины хамгийн их хөл хөгжөөнтэй, олон улсын харилцааны зангилаа хот байжээ. /36.156/. Хархорумаас гадна түүний өмнөдөд, нэг өдрийн зайд “Сурин” хотыг 1237 онд Персийн дархчууд барьжээ. Мөн Хөшөө нуурын дэргэд 1238 онд “Тосох” хотыг барьж байгуулжээ. Энэ хотод 1000 хүний суудалтай, сувдан хана, алтан дээвэртэй “Угтах Орд” байжээ.

Мөн Умардын шар орд, Хөшөө нуурын орд, Онгийн орд зэрэг 6 үзэсгэлэнт орд барьж байгуулсан байна. Үүнээс гадна Чингай, Годан зэрэг ноёд, язгууртнууд өөр өөрсдийн ордыг барьж байгуулж байсан аж.

Монгол оронд эрдэм ухааныг дэлгэрүүлэх, соёл, боловсролыг хөгжүүлэх, ард олныг соён гэгээрүүлэх талаар Өгөдэй хааны явуулсан үйл ажиллагаа нь түүний дотоод бодлогын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байжээ. Энэ талаар Өгөдэйн явуулсан бодлогод Хятад, Тангуд, Хорезм, Уйгур, Хар Хятан, Энэтхэг улс, Орос, Баруун европын вант улс, хот улсуудын соёлын төвшин, туршлага, үлгэр жишээ, сургамж, эзлэгдсэн орнуудын соёлыг монголчуудаас мэдэрсэн мэдрэмж энэ бүхэн ихээхэн нөлөөлснийг тэмдэглэвэл зохилтой. Эдгээр нь бүхэлдээ Монголд соёл дэлгэрэхэд том түлхэц болжээ.

Өгөдэйн үед барьж байгуулсан Хархорум, Сурин, Тосох хот, үзэсгэлэнт 6 ордын өнгө үзэмж, гоёмсог сүрлэг байдал, уран барилга, хээ угалз, зураг дүрс, гоёл чимэглэл, арслангийн баримал, мөнгөн мод, мөнгөн бишгүүр, усан оргилуур, хиймэл нуур зэрэг нь Ази, Европын гайхамшигт урлаг, уран барилга, монголын уламжлалтай хослон дэлгэрч байсны бодит биелэл мөн юм. Монголын гэр-орд, гэр-өргөө, монгол гэрийн урлал нь эл үеийн уран барилгад нэвтрэн нөлөөлсөн нь ч бодитой зүйл мөн.

Өгөдэй хаан, түүний хүүхдүүд их эрдэмтэн Елюй-Чуцай, Тататунгаа Ираны алдарт эрдэмтэн Ифтихар-ад-Дин, Исламын нэрд гарсан тэнгэрийн зурхайч Насир-ад-Дин Түч зэрэг дөрвөн эрдэмтэн, Түвдийн эрдэмтэн лам Гунгаажанцан, Оросын алдарт уран дарханч Кузьма, Францын алт мөнгөний дарханч Вилгельм Бушье зэрэг хүмүүсийн их авъяас, чадварыг ашиглаж, тэднээс суралцах ажлыг зохион байгуулж байжээ. Ийм оюунлаг, авъяаслаг хүмүүс Ази, Европын соёлыг Монголд нэвтрүүлж дэлгэрүүлэх ариун үйлсийг бүтээгчид байсан бөлгөө.

Өгөдэй хаан бичгийн боловсрол, эрдэм мэдлэг урьд урьдынхаас илүү ихэд шаардагдах болсныг анзааран, хаан эцэг Чингисээс өөрийн хүүхэд, ач, зээ нар, шадар ноёд, түшмэддээ эрдэмтэн мэргэдээр бичиг үсэг заалгаж, лекц яриа хийлгэдэг байсан уламжлалыг үргэлжлүүлсэн байна. Өгөдэй хаан ордны бичгийн сайд Тататунгаагаар бичиг заалгах, “монгол сургууль байгуулах ажлыг нэн чухалчилж, Хархорумд монгол сургууль байгуулжээ. Мөн хаадын бичиг хэргийн нууц архивын газар, номын сан байгуулсан байна. 1237 онд бичгийн мэргэд шалгаруулах ажил зохион байгуулж байжээ” /17.209/. Чингисийн дүү Хасар энэхүү сургуульд орж, бичиг үсэг заалган, улс төр, хууль цааз, уран зохиолын ном унших, цэргийн эрдэм сонирхон судлах болсон хэмээн Монгол мэргэн гэгээний Алтан товчид тэмдэглэснийг доктор Ч.Далай дурдсан байдаг.

Хятадын Хэнань мужийн нэгэн сүмээс Өгөдэй хааны 1240 оны зарлигийг Хятад, монгол бичгээр цохиж сийлсэн чулуун хөшөө олдсон нь эл үеийн бичиг соёлын түүхэн дурсгал мөн.

Өгөдэй хааны урилгаар Ираны эрдэмтэн Ифтихар-ад-Дин Хархорумд ирж Тулуйн хүү Мөнхөд эрдэм ном зааж байсан бөгөөд тэрээр сайн сурч, ялангуяа тооны ухаан, геометрийн өргөн мэдлэг олж эзэмшсэн байна. Далай хаан, Хархорумд Исламын мэргэдээр одон орны оргил байгуулахаар бэлтгэж байжээ. Өгөдэйн хүү Годан, Түвдийн эрдэмтэн лам Гунгаажанцанг урьж бурхны шашны ном заалган, зарим судар номыг орчуулуулж байсан байна. Өгөдэй хааны үед монголчуудын гол шүтлэг урьдын адил бөө мөргөл хэвээр байжээ. Өгөдэй хаан өглөө босоод наран зүг харж, тэнгэр газар хоёрт шүтэн залбирдаг байжээ. Эзэн хааны нэр хүндийг өргөж, тэнгэрээс заяатай болгох, улсын гал голомтыг ариун байлгах, улсын туг сүлдийг тахиж тайх, хийморь сэргээх, уул ус овоо тахих, мэрэг төлөг үйлдэх, тэнгэр бурханаас аз заяа хийморь гуйж сөхрөн мөргөх зэргээр бөө мөргөлийг хэрэглэж байсан ажээ.

Өгөдэй эцгийн бодлогыг уламжлан бүх шашныг адил тэгш үзэх, монголд аль ч шашин нэвтрэн дэлгэрэхийг дэмжих бодлого явуулсан байна. Шашныг адил тэгшээр үзсэнээр лал, христос, бомбын шашны урсгал орж ирж, сүм хийдүүд байгуулагдан, мөргөл ёслол үйлдэж байсан ажээ.

§4. Өгөдэй хааны гадаад бодлого, гадаад харилцаа

Өгөдэй хаан, эцэг хааныхаа гадаад бодлого, гадаад харилцааг өөрийнхөө үеийн шинэ нөхцөл байдалд нийцүүлэн, мөн шинэ агуулгаар баяжуулан үргэлжлүүлсэн болой.

Өгөдэй хаан, Дундат Азийн үлдэгдэл хүчийг бут цохиж, Хорезм гүрний нутгийг Монгол гүрний эзэмшилд бүрэн оруулах, Алтан улсыг бүрмөсөн эзлэн авах, Өмнөд Сүн улсыг байлдан эзлэх, Солонгос дахь үймээнийг дарж, Солонгос улстай найрамдал тогтоох, өрнө зүгт дайныг үргэлжлүүлэн ялалт байгуулах, эзлэгдсэн улс орнуудыг захирах бодлогыг тус тус явуулсан байна.

Өгөдэй хаан сууринд суумагцаа өрнө зүгт зогсоосон дайны ажиллагааг сэргээж, Дундат Ази дахь үлдэгдэл хүчнийг бут цохихоор 1230 онд Чурмаган ноёноор удирдуулсан цэрэг хөдөлгөжээ. Хорезмын шах Желал-Ад-Дин Мухаммед шахын гүрнийг дахин сэргээхийг санаархаж, цэргийн хүч цуглуулан Монгол цэрэгтэй гурван удаа байлдсан боловч удаа дараалан ялагдаж, 1231 онд эцсийн удаа цохигдож, үнэнч нөхдийнхөө хамт зугтаж яваад нутгийнхаа хүмүүст хорлогдон алагдсан байна. Ингээд Хорезмын нутаг бүхэлдээ Монгол гүрний мэдэлд бүрэн оржээ. Хожим Хорезмын нутаг дэвсгэр дээр Цагаадайн улс буюу Дундат Ази дахь Монголын хаант улс тогтсон бөлгөө.

1231 оны 5 дугаар сард Өгөдэй хаан Өвөрмонголын “Ерэн есөн булаг” хэмээх газарт Их Хуралдай хуруулж, Алтан улстай хэрхэн байлдах тухай асуудлыг хэлэлцүүлж, 3 замаар довтлох шийдвэр гаргажээ. Алтан улсын хаан Айцзун /1223-1233/ умард нийслэл Чжунду /Бээжин/-г орхин Бяньцзинь хотод голлон суурьшиж, бэхлэлт хийн монгол цэрэгтэй байлдахаар бэлтгэж байв. Бас Цзюнь-Чжоу, Гүйдэ, Цайцжжоу хот зэрэг чухал байрыг эзэлж, дайтахад бэлтгэсэн байна. Өгөдэй хаан Алтан улсыг бүрэн эзлэн авахын тулд Өмнөд Сүн улстай хамтран Алтан улстай байлдахаар хэлэлцээр байгуулж, Алтан улсыг эзэлсэний дараа гол муж Хэнаныг нь Сүн улсад эгүүлэн өгөхөөр тохиролцсон байна.

Монгол улс ба Сүн улсын цэрэг хамтран Алтан улсын цэрэгтэй байлдаж Алтан улсын гол бэхлэлттэй хот болох Бяньцзин хотыг 1233 оны эцсээр эзлэн авчээ. Айцзун хаан найрамдах хэлэлцээр хийх гэсэн боловч тус хотод очсон 30 элчийг нь алсан /36.160/ учир монголчууд хэлэлцээр хийхээс татгалзаж, байлдааныг цааш нь үргэлжлүүлсэн байна. Алтан улсын хаан Айцзун Цайчжоу хотод зугтан очиж 100000 цэргээр хамгаалсан боловч Монгол цэрэг, Сүн улсын цэрэгтэй хамтран тус хотыг

бүслэн байлдаж, 1234 оны хавар бүрмөсөн эзлэн авчээ. Ийнхүү Алтан улс 1234 онд бүрмөсөн мөхөж, Айцзун хаан нь амиа хорлосон ажээ. Ийнхүү Алтан улстай Монголын хаад 20 гаруй жил байлдан ихээхэн хохирол хүлээсний эцэст бүрмөсөн эзлэн авсан түүхтэй ажгуу.

Алтан улсыг мөхсөний дараа Өмнөд Сүн улс, Монголоос холбоогоо таслан Их Монгол улсыг сөрөн зогсож, Алтан улсын зарим хот, эзэмшлийг эзлэн авчээ. Сүн улсын хаанд зарсан Монголын элчийг ч алсан байна. Иймд Өгөдэй хаан Сүн улстай байлдаж эхэлсэн байна. Хан хөвүүн Хүдэр Ганьсү, Шанша мужийн зарим хот тосгод, Сычуань мужийн хэд хэдэн хотыг эзлэн авчээ. Хан хөвүүн Хүчийн толгойлсон цэрэг Хэбэй мужийн зарим чухал боомтыг эзлэв. Өгөдэй хаан Сүн улстай дайтах ажиллагаагаа түр зогсоожээ. Энэ нь өрнөдийг довтлохтой холбоотой байжээ.

Өгөдэй хааны үед Солонгос, Монголын харилцаа хурцдаж, хоорондоо дайтахад хүрчээ. Өгөдэй хаан, 6 жилийн өмнө Солонгост илгээсэн Чингис хааны элч Жугуйг буцах замд нь Солонгосчууд харван алсныг шалтаглан 1231 онд монгол цэргийг умард Солонгосын нутгаар Солонгос руу дайлаар оруулжээ. Монголчууд 70 даргачийг хамгаалах цэргийн хамт Солонгосын гол төв газруудад томилон суулгасныг Солонгосчууд эсэргүүцэн бослого гаргаж бүх монгол даргачийг нь алсан ажээ.

Үүний улмаас Монгол цэрэг Солонгосын цэрэгтэй 1231, 1232, 1235 онуудад байлдаж ялалт байгуулжээ.

Өгөдэй хаан 1235 онд Хархорум хотод Их Хуралдайг зарлан хуралдуулж, Алтан улсыг байлдан эзэлж, Чингисийн гэрээсийг биелүүлсэн дүн ба өрнөдөд явуулах дайны тухай хэлэлцүүлэв. Их Хуралдайгаар өрнөдийг довтлох дайныг эхлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Өрнө зүгт хийх дайны ажиллагааг ерөнхийлөн удирдахыг Зүчийн хүү Батад хариуцуулж, цэргийг удирдах ерөнхий жанжнаар Сүбээдэй баатрыг томилжээ. Мөн Өгөдэйн ахмад хүү Гүюг, Цагаадайн ач хүү Бури, Байдар, Тулуйн хүү Мөнх нарыг цэрэг захируулан явуулсан байна. Монгол цэрэг 1236 онд Болгаруудыг бут цохиод, 1238 онд Оросын Рязаны вант улсын Рязано хотыг, дараа нь Москва, Ростов, Ярослав, Дмитрийн вант улсын 14 хот болон Владимир хотыг эзлэн авч /65.210/, Батын удирдсан монгол цэрэг 1238 онд Смоленск, Черниговийн вант улсуудыг эзлэв. Хотоо хамгаалан 49 хоног бүслэгдэн тулалдсан Калуга мужийн Казельск хотыг бас эзэлсэн ажээ. 1239 оны эцсээр монгол цэрэг Переяславль, Чернигов хот, улмаар Крым, Кавказын чанадыг эзлэн авчээ /65.212/. Монгол цэрэг 1240 оны эцсээр Киевийг, 1241 оны эхээр Оросын баруун зүгт давшиж Галиц, Владимир, Боловскийн газар нутгийг эзэлсэн байна /65.213/.

Монгол цэрэг Оросын гол хотуудыг байлдан эзэлснээр Баруун Европод нэвтрэн орох зам нээгдэж, давшилтаа Европ руу чиглүүлжээ. Чингээд Монгол цэрэг Польш,

Молдав, Силезийг довтолж улмаар Унгарт нэвтрэн орсон байна. Бат жанжин Баруун европт нэвтрэх гол зангилаа болж, монгол цэрэгт цохигдоод зугтан ирсэн бүхнийг орогнуулж байсан учир Унгарыг эзлэх явдлыг чухалчлан үзэж, Унгарын цэргийн гол хүчийг Тисса гол дээр бут цохижээ. Бат Сүбээдэйн цэрэг Унгарын хаан Гү Белаг хөөсөөр Австрийн Вена хотод нэвтрэв. Монгол цэрэг Словакийг туулж, Дорнод Чехийг эзэлж, Адриатын тэнгист хүрээд байтал Өгөдэй хаан нас барсан мэдээг аваад Төв Европод хийх дайнаа зогсоож 1241 оны 12 дугаар сарын эцсээр цэргээ авч нутаг буцжээ /36.168/.

Өгөдэй хааны гадаад бодлогод дорно, өрнөдөд явуулсан аян дайн томоохон байр эзэлж байсан ажээ. Үүнийг дээр дурдсан байлдаан, аян дайны ажиллагаа нотолж байна. Өгөдэй хаан эцэг Чингисийн гэрээслэлийн дагуу Тангуд, Алтан улс, Хорезм гүрнийг бүрэн эзэлж, Орос, баруун Европын олон улс орон, вант улс, хотуудыг дайлаар авч Их Монгол гүрний харъяалах нутаг дэвсгэрийг үлэмж өргөтгөсөн байна. Энэ нь Чингисийн гэрээслэлийг бүрэн биелүүлж, Их Монгол гүрнийг тогтвортой, эрч хүчтэй болгож, монголчуудын нэрийг дорно, өрнө дахинаа тод томруун гаргасан түүхэн ул мөртэй болой.

Өгөдэй хааны байлдан дагууллын үйл ажиллагаа өөрийн гэсэн зорилго, зорилт, учир шалтгаантай байсан хэдий ч өрнө, дорнын олон улс орны энгийн хүн ардыг алан хядаж, хот байгууламжийг нь үнсэн товрог болгон, аж ахуй, соёлын асар их үнэ цэнэт зүйлсийг нь устгаж, нөхөж үл болох үлэмж их гарз, хохирол учруулсныг үгүйсгэх учиргүй бөлгөө. Түүх ч үүнийг мартаж юун.

Өгөдэй хааны хаанчлалын үед гадаад бодлогод нь өөрчлөлт орж, Их Монгол улсад эзлэгдсэн улс орнуудын талаар явуулах бодлого, тэдгээртэй харилцах харилцааг цоо шинэ түвшинд гаргах шаардлага тавигджээ. Эл үед Тангуд улс, Хятадын Сүн улс, Шах Мухаммедын Иран гүрэн, Орос, Чех, Польш, Унгар улсууд монголчуудад бүрэн эзлэгдсэн нь Чингис хааны үеэс илүү их өргөн нутаг дэвсгэр, олон улс орныг хамрах болжээ. Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо “Өгөдэйн төр барьж байсан үед Монголын ихэс дээдсийн нэг хэсэг нь суурин амьдрал, хот балгас, тариаланг байлдааны явцад ямар нэг хэмжээгээр бусниулан, эзлэгдсэн орнуудыг баримтлан захирах нарийн төвөгтэй ажлаас бэрхшээж шинэ шинэ газар орнуудад довтолгоон хийхийг сонирхож, нөгөө хэсэг нь байлдан дагууллыг үргэлжлүүлэхийн хамт эзэлсэн орныг цаашид удаан хугацаагаар баримтлан захирч эдийн засгийн ашиг олохыг чухалчилж байсан” /80.12-13/ хэмээн бичжээ.

Өгөдэй хаан, эцэг Чингис хааны гэрээслэл, мэргэн Тататунгаа, Елюй Чуцай нарын сургаал зөвлөгөөг Алтан ургийнхан, Сэцдийн гишүүд, хан хөвгүүд, цэрэг, төрийн зүтгэлтнүүдийн санал, дүгнэлт сэлтийг харгалзан, сайтар тунгаан бодсоны

эцэст эзлэгдсэн орнуудыг захирах, тэдэнтэй харилцах цэгцтэй бодлого боловсруулжээ. “Монголын нууц товчоо”, Рашид-ад-Диний “Судрын чуулган”, Ч.Далайн “Их Монгол улс” /1206-1260/, “Монгол Солонгосын эртний түүхэн харилцаа”, А.Амарын “Монголын түүх”, “БНМАУ-ын түүх”, “Монгол улсын түүх”, К.Д.Оссоны “Чингис хаанаас Төмөр хан хүртэлх монголчуудын түүх”, М.Санждоржийн “Монгол төрийн түүхээс”, элч, жуулчдын тэмдэглэл зэрэг түүхэн сурвалж бичиг, зохиол бүтээлүүдийг судлан үзэхүл Өгөдэй хаанаас эзлэгдсэн орнуудад хандаж явуулах Их Монгол улсын төрийн бодлого нь нэгдүгээрт, эзлэгдсэн орнуудын газар зүйн байршил, хөгжлийн түвшин, эрхлэх аж ахуй, зан заншлын онцлог, шашин шүтлэгийн байдал, ирээдүйн төрх, төлөвийг харгалзах, хоёрдугаарт, орон тус бүрийг өөрийн бодлогын үүднээс захирах, засаг захиргааны түр тогтолцоо бий болгох, гурвдугаарт, эзлэгдсэн орнуудыг захирахад өөрийгөө дэмжих эрдэм чадалтай хүмүүс, төр шашны зүтгэлтэн, язгууртан ноёд, худалдаачдыг аль болох оролцуулах, дөрөвдүгээрт, эзлэгдсэн орон тус бүрийн захирах захиргааг хан хөвгүүд, хааны угсааны ноёд, төр цэргийн зүтгэлтэн, жанжин нараар толгойлуулах, тавдугаарт, эзлэгдсэн орнуудаас олз ашиг олох, өргөл барьц авах, билэг сэлт хүртэх, зургаадугаарт, түрээс алба, татвар хураах, долоодугаарт, улс хоорондын ба дотоодын худалдаа арилжааг хөхүүлэн дэмжих, наймдугаарт, олон төрлийн шашин, соён гэгээрүүлэх ажил, элчин жуулчин солилцох явдлыг дэмжин тэтгэх, есдүгээрт, эзлэгдсэн улс орны эдийн засаг, аж ахуй, суурьшмал амьдралыг сэргээн өөд татахыг дэмжихэд чиглэгдэж байсан байна. Тийм ч байхаас өөр аргагүй агаад үнэхээр тийм ч байсан ажээ.

Өгөдэй хаан, эзлэгдсэн орнуудад колончлон захирах хатуу төвлөрсөн засаг захиргаа байгуулж, хот сууринг нь нураан, ард иргэдийг нь хядаж, тариа, ногооны талбайг нь бэлчээр болгон хувиргахаас болгоомжилж, өөрийн төлөөний сайд, захирах хүнийг томилон ажиллуулж, түүний аппаратыг бий болгож, өөрсдийн хэрэглэх зүйлийг татварлан авч байх нь илүү ашигтай гэж үзсэн байна /36.166/.

Өгөдэй хаан, Хорезм буюу Дундад Ази дахь монголын амбан захирагчаар Махмуд Ялавачийг, Тангудын захирагчаар өөрийн хан хөвүүн Хүдэнг, Орос дахь захирагчаар Зүчийн ахмад хүү Батыг, Хятадын Алтан улсын харъяатын захирагчаар Мухулайн ахмад хүү Борыг тус тус томилжээ. Эзлэгдсэн орнуудыг захирагчид нь хааны төлөөний сайд маягаар ажиллаж байв. Захирагч бүр өөрийн орд өргөө, хатад эмс, зөвлөгч түшмэл, бараа бологч, үйлчлэгчид, хамгаалах цэрэгтэй байсан аж. Захирагчид нь Өгөдэй хааны бодлогыг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй байлаа.

Өгөдэй хаан, түүний жанжнууд дайн, байлдаан хийж эзэлж авсан орны хаад ноёд, ихэс дээдэс, хот, суурин, иргэдээс их хэмжээний алт, мөнгө, эрдэнийн чулуу, гоёл чимэглэл, эд агуурс, үнэт зүйлсийг хураан, бууж өгсөн улс, хотуудаас их хэмжээний

өглөг барьц авч гар урчууд, дархчууд, уран барилгачдыг олзлон монгол лугаа авчирч ажиллуулж байсан ажээ. Энэ бол эзлэгдсэн орнуудаас дээрэмдэж, хүч хэрэглэж олсон асар их баялаг бөгөөд түүнийг монголын хаад, ноёд, цэргийн жанжин, захирагчид, түшмэд, цэргүүд хуваан авсан нь эргэлзээгүй буйзээ. Харин олзолж аваачсан гар урчууд, уран дархчууд, барилгачид нь Хар Хорум зэрэг хот суурингууд, орд өргөө, сүм дуганууд барьж, тэдгээрийн гоёл чимэглэлийг хийж, тариа, ногоо тарьж байсан болой.

Өгөдэй хаан эзлэгдсэн орнуудын ардуудаас татварлах алба гувчуурын төрөл, тоо хэмжээг дорно, өрнийн хэмээн ялгаж, хоёр янзаар тогтоожээ. Үүнд: Хятадын хүн амаас өрхөөр бодож, баруун зүгийн орнуудаас эрийн тоогоор бодож алба гувчуур авах журмыг тогтоосон байна. “Юан улсын судар”-ын 2-3 дугаар дэвтэрт Хятадын иргэдээс сайн чанарын тарианы му /6,44 га/ тутмаас гурван жин, дунд чанарын тарианы му тутмаас хоёр жин хагас, дорд чанарын тарианы му тутмаас хоёр жин тариа тус тус хурааж, ус оруулсан сайн чанарыг тарианы му тутмаас таван жин тариа авахаар тогтоож мөрдсөн байна. Худалдааны зүйлээс гааль хураахдаа орлогын 30 хувийн нэгийг авах, дарсны худалдаанаас 40 жин тутмаас нэг лан хураахаар тус тус тогтоосон байна.

Өгөдэй хаан Дундад Азид албан татварын хэмжээг бүх тарианы ургацын 9/10 хувийг хүртэл авч байхаар тогтоожээ. Өгөдэй хаан худалдааны /торгоны/ замыг бүрэн хяналтандаа аван сэргээж, өрнө-дорнын худалдааг чөлөөтэй болгон, монголд ирэх худалдаачдыг бүх талаар хөхүүлэн дэмжиж байжээ. Хятад, Дундад Азийн худалдаачид, ялангуяа лалын худалдаачид Монгол оронд олноор ирж байсан аж. Монголчууд хаад ноёд, лалын худалдаачидтай хувь нийлүүлж худалдаа хийх, худалдааны гүйлгээнд хөрөнгө мөнгө оруулах, лалын худалдаачдаар дамжуулж мөнгө хүүлэх үйл ажиллагаа явуулж байсан байна. Лалын нөлөө бүхий худалдаачин Абдурхманыг 1240 онд эзлэгдсэн орнуудын олон мужаас гааль гувчуур хураах хааны түшмэлээр томилж ажиллуулжээ. Өгөдэй хаан суурьшсан ард түмнээс хураах гааль, гувчуурын үнэ 140 түмэн лан /лан-37,301 грамм/ мөнгө байсныг Абдурхман 220 түмэн лан хүртэл нэмэгдүүлж байжээ./36.168/

Өгөдэйн хаанчлалын үеийн Их Монгол улсын гадаад харилцаа, дотоод, гадаад бодлоготойгоо салшгүй холбоотой байсан ажгуу. Өгөдэй хааны гадаад харилцаа нь Их Монгол улсыг дэлхийн тайзнаа гаргах, гадаад орноор Их Монгол улсыг хүлээн зөвшөөрүүлэх, олон улстай Их Монгол улсын сүр хүчийг харуулан харилцах, найрамдал, харилцан туслалцах холбоо тогтоох, гадаад худалдаа, арилжаа хөгжүүлэх нь эл үеийн гадаад харилцааны үндсэн зорилт байсан болой.

Өгөдэй хааны үед Хархорум төвтэй Их Монгол улсад олон улсын харилцаа улам хөгжсөн байна. Эл үед Өгөдэй хаан өөрийнхөө олон улсын харилцаанд улс хоорондын хэргийг “хүчээр түрээ барих”, “зэвсгийн хүчээр, дайны аргаар шийдвэрлэх” бодлогоо

бусад орнуудад тулган хүлээлгэхийг оролдож, гадаадын олон улс оронтой элчин төлөөлөгчид солилцох үйл ажиллагаа явуулжээ. Гадаад харилцаа хөгжихөд Хархорум Монгол улсын нийслэл болж, олон улс орноос элч төлөөлөгчид, аянчин, жуулчин, худалдаачид, лам, хувраг, гар урчууд, уран дархчид хүрэлцэн ирдэг, урт богино хугацаагаар оршин суудаг томоохон төв болсон нь чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Гадаадтай харилцах дээд эрхийг Өгөдэй хаан өөрөө барьж байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор дипломат харилцааны бүх хэргийг их хааны нэрийн өмнөөс явуулж байжээ.

Өгөдэй хааны дэргэд гадаад харилцааны албан хэргийг хөтөлдөг, баримт бичгийг боловсруулдаг, орчуулдаг, бэлтгэдэг, гарын үсэг зуруулж, баталгаажуулдаг, бичиг хэргийн алба ажиллаж байсан аж.

Өгөдэй хаан эцгийнхээ гадаад харилцааны уламжлалыг залган авч дайн зарлах, найрамдал, гэрээ хэлэлцээр байгуулах асуудалд ихэд хүндэтгэлтэй, болгоомжтой хандаж, төрийн Их Хуралдайгаар хэлэлцүүлэн хамтын ухаан, оюун бодлыг шингээн шийдвэрлүүлж байсан байна. Тэрбээр Алтан улс ба өрнөдөд явуулах дайны асуудлыг Их Хуралдайгаар хэлэлцүүлж дайны зорилго, оролцох хүч, довтлох чиглэл, толгойлох болон ерөнхий жанжины асуудлыг шийдвэрлүүлж байсан ажээ.

Монголд гадаадын элч төлөөлөгчид олноор ирэх болсныг харгалзан, тэднийг хүлээн авч үйлчлэх, ажил үйлсэд нь тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой тусгай яамыг Хархорумд байгуулсан байна. Энэ яам Монголд ирсэн элч, төлөөлөгчдийг хүлээн авах, сууц, үйлчилгээгээр хангах, тэдний халдашгүй эрхийг хамгаалах, зам зуурт нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх үүрэгтэй байж, түүнээ гүйцэтгэн биелүүлдэг байсан аж.

Гадаад орны элч, төлөөлөгчдийг хүлээн авах нь Их Монгол улс, эзэн хааны сүр хүчийг илэрхийлэн харуулсан нарийн ёс журамтай байсан байна.

Тэднийг хаанд бараалхахын өмнө хааны өргөөний бараа бологч түшмэл, элч нартай уулзаж хэрэг зориг, хаанаас ирсэн, хэн хэн гэдгийг мэдэж авдаг байсан ба өргөөнд хүрэлцэн ирэхэд нь тосон угтаж, нэгжин үзээд хоёр галын хоорондуур оруулж ариутгана. Дараа нь ордонд оруулан хаан, шадар хүмүүсийн өмнө алдар нэр, хэрэг зориг, хаанаас ирсэнийг нь өндөр дуугаар сонсгон дууддаг. Элч нар өргөөний үүдний зүүн талаар босгонд хүрэлгүйгээр орох ёстой. Элч нар хаанд бараалхахдаа зүүн өвдгөөрөө сөгдөж мэндэлнэ. Хаан гадаадын элчтэй шууд өөрөө ярилцалгүй гуравдахь этгээдээр дамжуулан ярилцдаг ёстой байжээ. Харин элч нар нь хаантай юу дуртайгаа чөлөөтэй ярилцах давуу талтай байв.

Өгөдэй хаан Хятадын Алтан, Сүн улстай харилцах харилцаанд ихээхэн анхаарал тавьж байжээ. Алтан улсын хаан умард нийслэл Чжэндү /Бээжин/ хотоо орхин Бяньцзанд төвлөрснөөс хойш Их Монгол улс найрамдах санал тавьсан 30 элчийг Алтан улсад илгээсэн боловч хариу эс өгөн бүгдийг нь алсан ажээ /36.158/.

Тэгээд монголчуудыг довтлон ороход Айцзун элч зарж Өгөдэй хаанд найрамдах санал тавьсан ч эс зөвшөөрчээ. Энэ бол Өгөдэй хаан дипломат аргаар Алтан улстай хэлэлцэж, дайны бус аргаар асуудлаа шийдвэрлэхийг уйгагүй хичээж байсныг харуулна.

Өгөдэй хаан Алтан улсыг ялахын тулд түүний холбоотон Өмнөд Сүн улстай харилцаж, Алтан улстай хамтран байлдах аргыг дипломатын замаар олохоор шаргуу ажилласан байдаг. Ийм дипломат ажиллагааны үр дүнд Өмнөд Сүн улстай Алтан улсыг хамтран байлдах хэлэлцээр байгуулж, Алтан улсыг мөхөөсний дараа түүний эзэмшил агсан гол муж Хэнанийг Сүн улсын мэдэлд эгүүлж өгөхөөр тохиролцжээ /36.158/. Ингээд Сүн, Монгол улс хоёр Алтан улстай хамтран байлдаж 1234 онд Алтан улсыг мөхөөсөн ажгуу.

Их Монгол улс, Солонгос /гуулин/ улс хоёрын хооронд дипломат харилцаа тогтож, хоёр улсын харилцаанд ихээхэн эерэг нөлөө үзүүлж байжээ. Ийм харилцаа Чингис хааны үеэс эхэлж Өгөдэй хааны үед уламжлагдан цааш хөгжжээ. 1231-1232 онд Солонгос улсын Вангаас Өгөдэй хаанд 2 удаа айлтгал бичиг илгээж, харилцан найрамдалтай байхаа илэрхийлснийг Өгөдэй хаан анхааралтай судлан үзэж харилцан найртай байх, Солонгос улс Их Монголд алба өргөж байхыг анхааруулж хариу элч илгээж байсан байна. “XIII зууны үед Монголын эмэгтэй элч Солонгост очиж байсан нь Монгол-Солонгосын гадаад харилцааны түүхэнд чухал үйл явдал байжээ” /36.160/. Монгол, Солонгосын харилцаа дараа дараачийн үед үргэлжлэн хөгжсөн түүхтэй.

Алтан улсыг мөхсөний дараа Монгол, Сүн улсын харилцаа ээдрээтэй байсан хэдий ч цаашид үргэлжлэн явагджээ. Сүн улс 1234 оноос Монголыг сөрөн зогсож холбоогоо таслан, дайны бэлтгэл хийж, зарим нэг довтолгоон явуулах болсон байна. Байдал хурцадсан үед Өгөдэй хаан Сүн улсын элч нарыг ихэд хүндэтгэн хүлээн авч байжээ. Тэрбээр “Цзоу Шэнь Чжи-гийн толгойлон ирж байсан олон элчийн нэгний бүрэлдэхүүнд орж 1235-1236 онуудад Монголд хүрэлцэн ирж байсан Сюй-Тинийг Сүн улсын хааны бас элч гэж хүндлэн тусгай алтан тэрэм барьж өгч байжээ” /36.307/. Байдал хурцадсан үед Өгөдэй хаан эл байдлын учрыг мэдэх, харилцаагаа сэргээх зорилгоор өөрийн элчийг Сүн улсын хаанд илгээсэн боловч эл элчийг алжээ. Энэ үед Монгол улс Өрнөдөд аян дайн хийж байсан учир Сүн улстай харилцаагаа илт хурцатгахгүйг хичээн уян хатан бодлого явуулж байжээ.

Өгөдэй хааны өрнөдөд явуулсан дайн байлдааны ялалт, олон улс, вант улсуудыг эзлэн өөрийн түшмэг болгосон нь өрнө дахин ба Монгол улсын харилцаанд өөрчлөлт гарахад хүргэсэн ажгуу. Ялангуяа монголчуудын эзлэн авсан улс орнуудын хаан, оргодол, зугтмал хүчийг өөрийн улсад орогнуулж, Монголын эсрэг бодлого явуулж байсан өрнөдийн орнуудын гадаад бодлогод шууд нөлөөлжээ. “Монгол цэргийн сүр хүчнээс Франц, Англи, Испани хүртэл айж болгоомжилж эхэлсэн байна.

Ромын Их хамба лам хүртэл Монгол цэргээс айн сүрдэж, өдөр бүр мөргөл залбирал үйлдэж байсан гэдэг. Данийн ван Галиций монголчуудаас өршөөл гуйхаар шийдэж байжээ” /36.162/

Өгөдэйн хаанчлалын үед Дундаг Азид Цагаадайн улс, Орост Батын улс байгуулагдан, Өгөдэй хаан тэдэнтэй зузаан холбоо тогтоож, монголчуудын улс төрийн гол төв нь Хар Хорум хот болж чаджээ. Энэ нь Өгөдэй хааны холч хараатай, ухаалаг бодлогын том үр дүн мөн байсан бөлгөө.

§5. Өгөдэйн хаанчлалын үеийн Их Монгол улсын эрх зүй

Өгөдэй хааны үед Их Монгол улсын эрх зүйн эх сурвалжийн гол төрөл болох эрх зүйн бичигдэл актуудын эзлэх хувийн жин үлэмж нэмэгдэж, эрх зүйн агуулга өргөжин гүнзгийрч, гүйцэтгэх үүрэг роль нь ихээхэн дээшилсэн байна. Эрх зүйн хэм хэмжээгээр зайлшгүй тохируулагдах нийгмийн харилцааны шинэ төрлүүд бий болсоор байсан нь бас эрх зүйн шинэ актуудыг батлан гаргахад хүргэж байсан ажээ. Жишээлбээс, засаг захиргааны хуваарь, ордны аппарат, цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, түшмэдийн систем, бэлчээр нутаг олгох, мал аж ахуйг өсгөн үржүүлэх, эдийн засгийг өөд татах, албан татварын тогтолцоо бий болгох, улсын өртөө байгуулах зэрэг нь өөрт тохирсон эрх зүйн зохицуулалтыг зайлшгүй шаардсан ажгуу.

Өгөдэй Их Монгол улсын хаанд өргөмжлөгдмөгцөө “Анхныхаа хуулийг гаргав. Үүнд: Чингис хааны гаргасан зарлигууд нь урьдын адил хүчин төгөлдөр байх бөгөөд тэднийг өөрчилж хувиргахаас хамгаална. Бидний хаан ширээнд суух хүртэлх хугацаанд гарсан гэмт хэрэг, буруутай явдлыг өдөгсөд нь хэн болохыг үл харгалзан цөмтэй нь бид ял хэлэлцэхгүй болгож өршөөе.

Одооноос эхлэн хэн нэгэн нь хуучин ба шинэ хууль жаяг дэглэмд таарахгүй үйлдэл үйлдэх буюу гаргасан бол түүндээ тохирохуйц шийтгэл хүлээх болно” /80.17-18/ гэж алдарт Рашид-ад-Дин “Судрын чуулган” хэмээх зохиолдоо бичсэн байдаг. Үүнээс үзэхүл дээрх хууль нь *нэгдүгээрт*, Чингис хааны үед гарсан хуулиудыг Өгөдэй хаан уламжлан авч хүчин төгөлдөр хэмээн үзэж нийт улс даяар сахиж мөрдөх, *хоёрдугаарт*, эдгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй хэвээр нь үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, *гуравдугаарт*, хаан ширээнд суух хүртэлх хугацаанд гэмт хэрэг, буруу үйлдэл хийсэн хүмүүсийг ял зэмээс хэлтрүүлэн өршөөх, *дөрөвдүгээрт*, энэ цагаас өмнөх ба хойшхи үеийн хуулийг зөрчвөл зохих шийтгэл хүртээнэ гэдгийг хуульчилсан гүнзгий агуулгатай байжээ.

Өгөдэй хааны хууль цаазын бодлого ийн буюу.

Өгөдэйн үеэс Их Чингис хааны Их засаг хууль, эл үеийн бусад хуулийг нарийн чанд сахин биелүүлэх нь Их засаг хуулийг “ургийн урагт хүртэл үүрд хэн

ч бүү өөрчилтүгэй” /31.180/ гэсэн Чингис хааны зарлиглан тогтоосон хуульд бүрнээ нийцсэн хэрэг байсан болой.

Иймээс Өгөдэйн хаанчлалын үеийн эрх зүйн тулгуур эх сурвалж нь “Их засаг” хууль байсан болой. Эзэн Чингисийн тогтоосон бусад хууль, зарлигууд Өгөдэй хааны үед хүчин төгөлдөр үйлчилж, эл үеийн эрх зүйн эх сурвалжид томоохон байр эзэлж байжээ. Өгөдэйн хаанчлалын үед далай хааны батлан тогтоосон хууль зарлигууд мөн энэ үеийн эрх зүйн эх сурвалжид өөрийн зохих байр сууриа эзэлж чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. “Монголын нууц товчоо”, Рашид-ад-Диний “Судрын чуулган” болон монголын түүхэн эх сурвалжийг судалваас Өгөдэй хаан өөрийнхөө хаанчлах хугацаанд наад зах нь 10 гаруй хууль батлан гаргасан нь тодорхой байна. Өгөдэй хааны хуулиуд Монгол улсын нийгмийн амьдралын өргөн хүрээг хамарч, хуулийг хүндлэх, ёсчлон биелүүлэх нь их хаан, төрийн сайд, түшмэд, цэргийн жанжин, ихэс дээдэс, ноёд язгууртан, жирийн иргэн хүн бүрийн хуулиар тогтоосон үүрэг байжээ. Энэ бүхэн нь Өгөдэйн үед хуулийг нарийн чанд сахих явдлыг Чингис хааны гэрээслэл, Өгөдэй хааны төрийн бодлого зорилтыг биелүүлэх, улс орныг хөгжүүлэх хамгийн чухал хүчин зүйлийн нэг нь мөн гэж үзэж, хууль ёсыг сахихын төлөө хатуу зогсож байсныг харуулнам.

Өгөдэй хаан Их засаг хуулийг гүйцэд бичүүлж дуусгаад эцсийн хувилбараар нь хэвлэн хэрэгжүүлжээ /36.141/. Ийнхүү Их засаг хуулийг бүрэн эхээр нь хэвлүүлж, түүнээ мөрдсөн нь Өгөдэй хааны үед тохиожээ. Өгөдэй Их засаг хуулийг сайн мэддэг, үнэ цэнэ, ач холбогдлыг нь бүрнээ ойлгодог, ихэд бишрэн хүндэтгэдэг байсны илрэл нь Их засаг хуулийг бичүүлэх, хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, нийтэд хүртээмжтэй болгож, мөрдөх нөхцлийг нь бүрдүүлсэн үйл ажиллагаа байсан болов уу.

Өөр нэгэн ихэд үнэлвэл зохих Өгөдэй хааны гавьяа бол Чингисийн нэртэй холбогдсон зарим дурдатгал, сургаал, хэлсэн үг, гэрээс зэрэг монгол хүний үе уламжлан санаж дурсаж, сахин хэрэгжүүлж явах учиртай зүйлсийг удирдан эмхлүүлж гаргасан нь өнөө үед “Чингисийн билэг сургаал”¹⁶ хэмээн нэрлэгдэж, үнэ цэнэтэй хэвээр байгаа үйл явдал мөн. Өгөдэй хаан ийм үйлсийг бүтээхдээ Их Монгол улсын хууль, зарлиг улс гүрний хэмжээнд нэг мөр ойлгогдон хэрэгжих, тийнхүү хэрэгжихдээ олон үеэр хэвшин хэрэглэгдсээр заавал биелэгдэх шинжтэй болсон заншлын хэм хэмжээ, сургаал, билэгтэй хослох, бодит хэрэгцээ шаардлага, ирээдүйн төрх төлөвийг холчоор харж байж бүтээсэн болохыг тэмдэглэлтэй. Чингисийн билэг сургаал нь Их Монгол улсад Их засаг хууль, эрх зүйн бусад хэм хэмжээ хэрэгжихэд их үүрэг гүйцэтгэж, бас түүний хэрэгжих нэн чухал хүчин болж үйлчилсэн болой.

“Хуулийг дээдэлж, заалтыг нь чанд мөрдөх явдал засаг төр тогтвортой байхын гол үндэс болно” гэж Чингис, Өгөдэй нар байнга сургаж байжээ /36.142/ Өгөдэй хааны үед хууль гаргаж, Их Хуралдайн горим, дэглэмийг улам чангатган нарийсгаж,

албан ёсоор оролцох ихэс, дээдсийг тусгайлан тогтоогоод, хэрэв албан ёсоор зарласан Их Хуралдайд оролцоогүй бол тэр хүнийг цаазлан алах хүртэл яллахаар хуульчлан тогтоосон байна /36.145/. Энэ нь Их Хуралдайн ирцийг хангалттай бүрдүүлэх, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцогчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, идэвхитэй оролцуулах, аль болох олон хүний бодлыг тусгахад чиглэгдэж байсан аж. Албан ёсоор зарласан Хуралдайд оролцохоор нэр заагдсан ноёд заавал оролцох үүрэгтэй бөгөөд хэрэв эл үүргээ биелүүлэхгүй бол ял хүлээх ёстой болсон нь нилээд хатуу горим байжээ.

Өгөдэй хаан 1236 онд төрийн сүлд, туг, тамга, Чингис хааны сүлд тахих тахилгын тухай хууль гаргаж ихэд билэгшээн хэрэгжүүлж байв. Эл хуулиар Догшин хар сүлд, есөн хөхөлт цагаан тугийг хааны их өргөөнд байршуулан манах харуултай болгохыг тогтоож, төрийн тамгаа “Хасбу” хэмээн нэрлэжээ. Мөн Чингисийн нас эцэслэсэн өдрөөр тахилга хийх ёсыг тогтоожээ.

Өгөдэй хаан 1234 оны 5 дугаар сард Их Хуралдайгаар иргэдийн харъяаллын тухай хууль хэлэлцүүлж батлуулсан байна. Энэ хуулийн гол агуулга нь “Аравтын дотроос дураар гарч орох явдлыг хатуу цээрлүүлэн шийтгэнэ” /Юан улсын судар 3-р бүлэг/ гэж тогтоосонд оршиж байв. Энэ нь засаг захиргааны анхан шатны нэгж болох аравт нь харъяалан захирах тодорхой тооны иргэдтэй байж, түүнээ захиран засах хууль зүйн үндсийг нь тогтоож өгсөн ач холбогдолтой байжээ. Энэ заалт, засаг хуульд мянгат, зуут, аравтад бүртгэлтэй хэн атугай ч дур зоргоороо өөр эзэнд шилжихийг хатуу хориглоно” гэсэн хуулийн заалтыг улам тодорхой болгож, хэрэв зөрчвөл шийтгэж болохыг нарийвчлан тогтоосон ажээ.

Иргэний харъяаллын асуудал нь бэлчээр нутгийг олгохтой амин холбоотой байсан ажгуу. Өгөдэй хаан олон мянгатад бэлчээр нутаг хуваан олгох тухай хууль гаргаж “улс иргэнд нутаг усыг хувааж өгье. Нутгийг хувааж, сонгож нутаглахад мянгат бүрээс нутагчныг ялгаж гарвал зохино” /31.279/ хэмээн заажээ. Энэ нь мянгат бүхэнд нутаг хувааж олгох хууль зүйн үндэслэл болж улмаар үүний дагуу мянгат бүхэнд бэлчээр нутаг олгогджээ. Нутаг бэлчээр олгох заалтын хууль зүйн агуулга нь уул нутаг бэлчээр нь таван хошуу мал сүргийг жилийн дөрвөн улиралд маллаж болохоор уужуу агаад хаваржаа, өвөлжөө, зуслан бүхий уул тал, ус хужир, өвс ургамал, бут сөөг сайтай нутаг, түүн дээр суудаг хүн ам, ан амьтныг хамарна гэсэн утгыг илэрхийлнэ.

Түмт, мянгат, зуут, аравт нь нутаг бэлчээр, хүн амыг тодорхой тоо хэмжээнд хамтад нь багтаан эзэмшиж байгаагаараа жинхэнэ засаг захиргааны хуваарь болж төлөвшин тогтох болсон байна.

Өгөдэй хаан хууль гаргаж, цэргийн нэгдсэн удирдлагыг тогтоон эцэг Чингисийн үеийн хишигтэн цэргийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг

боловсронгуй болгосон байна. Хуульд хишигтэн цэргийг хэвтүүл, хорчин, торгууд хэмээн 3 хувааж, тус бүрийн бүрэлдэхүүн, удирдлага, үүргийн талаархи уламжлалыг хадгалахын хамт нилээд тодорхой журамласан заалтуудыг шинээр оруулж, зарим заалтад нь нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Хишигтэн цэрэг нь орд гэрт орох, гарах бүх зүйлийг эрхлэн мэдэх, орд гэрийг асарч мэдэх, хаан дайнд эс мордвол өөр тусгай анги, цэрэгт мордохгүй байх, нүүж буух нутгийг сонгох, орд гэрийг тойрон байж үүд хаалгыг сахин харгалзах, ээлжийн ахлагчид хишигтнээ бүртгэн жагсаахгүйгээр манаанд орохыг цээрлэх, ээлжийн ахлагчид ээлж солигдохдоо зарлигийг хишигтэндээ заавал сонсгож байх, зарлиг сонссон бөгөөтөл хишигтэн ээлж тасалбал зарлиг ёсоор шийтгэх заалтуудыг хуульд нэмэлт, өөрчлөлт болгон оруулжээ. Энэ тухай “Монголын нууц товчоо”-ны 278 дугаар зүйлд нилээд дэлгэрэнгүй дурдсан нь бий /31.250-251/ Хишигтэний өтгөс ахлагчдад гар хүрэхийг хуулиар хориглосон байна. Энэ тухай “Монголын нууц товчоо”-нд “Миний хишигтэнд гар, хөл хүрвэл нударгын оронд нударгаар, бэрээний оронд бэрээгээр цохиж хариулна. ... Гаднах мянганы ноёд миний хишигтэнтэй хэрэлдвэл мянганы ноёдыг шийтгэнэ” /31.145/ гэж бичсэн бөлгөө. Хишигтэн цэргийн эрх үүргийг нарийсган тогтоож, эдлэх онцгой эрх ямбыг нь өргөтгөн, бие махбодийн нь халдашгүй дархан байдлыг хуульчилж, өндөр хүнд, хариуцлагатай байх, хамгаалалтын үүргээ яв цав биелүүлэх нь онцгой байх, үүргээ эс биелүүлбэл оногдуулах ял нь хатуу байх зэргийг чандлан журамласан нь энэ хуулийн нэмэлт өөрчлөлтийн гол онцлог болой.

Өгөдэй хаан 1229 онд Монгол гүрний хэмжээнд улсын нэгдсэн өртөө байгуулах тухай Их Хуралдайгаар хэлэлцүүлж, өртөөний нэгдсэн хуулийг батлан гаргасан ажгуу. Энэ хуульд Монгол гүрэнд уургын улааг халж, нэгдсэн өртөө байгуулсныг тунхаглан зарлаж, өртөөний зохион байгуулалт, ажиллах журмыг хуульчлан тогтоожээ. Энэ тухай “Монголын нууц товчоо”-нд “... зүг зүгийн мянгатаас замчин улаачин гаргаж, суурь суурьд өртөө тавьж, элч нарт ард олны дундуур хамаагүй уургын улаа унаж хэсүүлэн давхихгүй гагцхүү өртөө замаар явах болгоё” /31.252/ гэж бичсэн байна. 1229 оны өртөөний хуулиар өртөөний суурь тутамд байлгах улаач, улааны морь, шүүсний хонь, саалийн гүү, хөглөх үхэр, ачих тэрэг зэргийн тоо хэмжээг тогтоож, эдгээрийг бэлтгэх үүргийг мянгат бүрд оногдуулсан байна. Ийнхүү анхны энэ хууль Монгол гүрэнд улсын нэгдсэн өртөө байгуулах хууль зүйн үндэс болсон аж.

Өгөдэй хаан, 1232-1233 онд өртөөгөөр явах журмын тухай хууль ба хэд хэдэн зарлиг гаргажээ. Эдгээр хууль ба зарлигууд нь 1229 оны өртөөний хуульд шинээр нэмэлт, өөрчлөлт оруулсан шинжтэй юм. Дээрхи хууль, зарлигуудад өртөөгөөр явагсад заавал пайз тэмдэг, зар бичигтэй явах, пайз бичиггүй явахыг цаазлах, өртөөгөөр явагчид тогтоосон хэмжээтэй хүнс шүүс хэрэглэх, хэрэв тоо хэмжээг хэтрүүлбэл

цээрлүүлэн шийтгэх, пайз тэмдэг, зар бичиггүй бол өртөө, улаа хэрэглэх эрх үл эдлэх, хүнс шүүсэнд зориулж улаач, унаа, шүүсний хонь татварлан хураах, саалийн үнээ, хөтлөх үхэр, ачих тэргийг албадан гаргуулахыг заажээ.

Өгөдэй хааны үед ийм байдлаар өртөөний зохион байгуулалт, бүрэлдэхүүн бааз суурь, өртөө хэрэглэх, өртөөгөөр зорчих дэг журам хууль, зарлигаар хуульчлан тогтоогдож, түүнийг үндэслэн улсын өртөөг байгуулан хэрэглэж байсан аж.

Өгөдэйн хаанчлалын үеийн хууль, зарлигийн дотор алба, татварын талаарх хууль, зарлиг томоохон байр эзэлнэ. Өгөдэй хаан 1229 онд хааны санд хураах улсын нэгдсэн алба гувчуурын хууль батлан гаргаж, авах гувчуурын хэмжээг тогтоожээ. Авах алба, татвар, гувчуур нь малын татвар, өртөөний татвар, гаалийн татвар, тариалангийн газраас авах гувчуур, гэх мэтийн төрлүүдтэй байжээ. Цаашид 1230 онд давсны татварын хууль, 1233 онд татварын нэмэлт хууль, 1234 онд худалдааны гаалийн хууль, 1236 онд мяндас эдлэлийн татварын хуулийг тус тус батлан гаргажээ. Дээр дурдсан хууль тогтоомжуудын заалтаас үзэхэд алба, татвар, гувчуурын төрлүүд нэмэгдэж, авах тоо хэмжээ нь тодорхой тогтоогдон, хураан авах журам нь нарийсч, зөрчвөл хүлээлгэх ял шийтгэл нь чангарсан байна. Давсны татвар, мяндас эдлэлийн татвар, худалдааны татвар болон алба, гувчуурын шинэ төрлүүд бий болсон байна.

Монгол улсын үндсэн нутаг дэвсгэрт төрийн алба татварыг мянгатын иргэд / зуут, аравт/ төлдөг бол гувчуурыг эзэн ноёндоо харьяат иргэд нь төлж байв. Үүнийг малаар, мах, сүү, айраг, тос, өрөм, ааруул, бяслаг, архи цагаа, ангийн мах, арьсаар төлдөг байжээ. Мөн нүүлгэх, суулгах, жин тээх, ан үргээх, идэш, цагаан идээ бэлтгэх, гэрийн хэрэглэл, малын хэрэгсэл хийх, малыг нь маллах, хариулах, төллүүлэх, малыг нь ноослох, эсгий хошлон хийх, гэр оронд нь үйлчлэх, эмнэг хангалыг нь сургах зэргээр биеэр үнэ хөлсгүй ажиллах буюу гувчуур өгнө. Өгөдэй хааны хаанчлалын үед гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэгт холбогдогсдыг байцаах, яллах, ял оногдуулах, ялтан хэрэгтнийг хадгалах төрийн үйл ажиллагаа нэгэн цогц болон явагдаж байжээ. Дээрхи ажиллагаа нь бүхэлдээ улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа, хууль, зарлиг, шийдвэрийг биелүүлэх, хэрэгжих гол хүчин зүйл, хүн ардын амь нас, эд хөрөнгийг халдлагаас хамгаалах хууль зүйн үндэслэл, журам болж үйлчилж байсан хэмээн үзэж болно. Шүүн таслах дээд эрхийг Өгөдэй хаан эдэлж, ял шийтгэл оногдуулах, ялаас хэлтрүүлэх, өршөөх нь мөн л түүний онцгой эрх байсан байна. Хаан Өгөдэй улсын заргач /шүүгч/-ийг томилох, байцааж шийтгэх эрхийг захирагч ноёнд олгох бүрэн эрхтэй байв. Өгөдэй хаан улсын заргачаар Шихихутугийг томилон ажиллуулжээ. Шүүхэд шударга зарчмыг тууштай нэвтрүүлэхийг түүнээс шаардаж байжээ. Улсын заргач нь шүүн таслах ажиллагааны зарчим, бодлого, журмыг боловсруулах, хааны нэрийн өмнөөс шүүн таслах ажиллагаа явуулах, гэмт хэрэгт

холбогдогсдыг шүүн байцаах, нотлох, гэрчлэх баримтуудыг тогтоох, ял оногдуулж сонсгох бүрэн эрхтэй байв.

Өгөдэйн үеийн хууль, зарлигууд, ял шийтгэл оногдуулж байсан үйл ажиллагааг судлан үзэхүл дараах үйлдлүүдийг гэмт хэрэг гэж үзэн ял оногдуулж байсан байна.

Үүнд: Хааны амь нас, бие махбодь, нэр төрд халдсан гэмт хэрэг, улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын эсрэг гэмт хэрэг, цэргийн гэмт хэрэг, засаг захиргааны эсрэг гэмт хэрэг, аж ахуйн гэмт хэрэг, эд хөрөнгө, мал сүргийн гэмт хэрэг, байгаль хамгаалал, зан заншлын эсрэг гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг, алба татварын гэмт хэрэг, өртөөний журам зөрчсөн гэмт хэрэг зэрэг гэмт хэргийн төрлүүд байсныг дурдаж болно.

Өгөдэй хааны хаанчлалын үед Их Монгол улсад дараах ялыг хэрэглэж байсан нь сурвалж бичиг, зохиол бүтээлүүдэд дурдагдан тэмдэглэгдсэн байна. Үүнд:

1. Бэрээдэх
2. Нударгалах
3. Торгох
4. Жанчих
5. Хол газар, нүдний далд цөлөх
6. Гянданд хорих
7. Алах /цаазлах/ гэсэн ялууд байжээ.

Чухам ямар үйлдлүүд хийснийг шийтгэх, ямар үйлдэлд ямар ял шийтгэл оногдуулах, мөн ялыг ямар хэлбэр, аргаар гүйцэтгэхийг хүртэл сурвалж бичгүүдэд өгүүлэн тэмдэглэсэн байна.

Төрийн Их Хуралдайд оролцох жагсаалтад орсон ноёд хааны албан ёсоор зарласан Их Хуралдайд заавал оролцох үүрэгтэй.

Хэрэв үүргээ эс биелүүлэн Их Хуралдайд оролцоогүй бол цаазлан алах хүртэл яллах хатуу журам тогтоожээ. Их Хуралдайд оролцох жагсаалтад орсон нь уг Хуралдайдаа оролцоогүй бол гэмт хэрэг болж цаазлах хүртэл ял оногдох болж байна. Энэ нь Хуралдайн журам нарийн агаад хатуу болсныг харуулж байна.

“Монголын нууц товчоо”-нд хишигтэн ээлжийн манаач цагаас хожимдвол 3 удаа бэрээдэж занчих, хоёрдахь удаа цагаас хожимдвол 7 удаа бэрээдэж жанчих, өвчний шалтгаангүй ээлжийн ахлагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдахь удаа ээлжээ тасалбал 37 удаа бэрээдэн жанчаад хол газар, нүдний далд цөлөхөөр хуульд заасан байна. /36.250,251/. Дээрхи заалтаас үзэхэд хишигтэн цэрэг ээлжээ 3 удаа тасалбал оногдуулах ял нь үндсэн ба нэмэгдэл ял гэсэн хоёр хэлбэртэй байна.

Хишигтэн ээлжээ 1 ба 2 удаа тасалбал 3 ба 7 удаа бэрээдэж жанчих нь үндсэн ял байна. Харин ээлжээ 3 удаа тасалбал үндсэн ял нь цөлөх ял, нэмэгдэл ял нь бэрээдэж

жанчих ял байжээ. “Ахлагч гэсэн төдийгөөр бидэнд мэдэгдэхгүйгээр хишигтэнд гар, хөл хүрвэл /зодвол/ нударгын оронд нударгаар, бэрээний оронд бэрээгээр цохиж” /31.251/ шийтгэхээр “Монголын нууц товчоо”-нд бичсэн байна. Энэ нь ээлжийн ахлагч гэдгээрээ дарамтлан өөрийн хишигтэнг бэрээдэх юм уу нударгалж зодсон үйлдлийг хэрэг гэж үзэж, бэрээдэн жанчих юм уу нударгалан хариу шийтгэл үзүүлэхийг зөвшөөрч байсныг харуулж байна. “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэнээр хишигтэн цэргийн ээлжийн ахлагчид харьяат хишигтэнээ жагсаалгүйгээр манаанд оруулах, ээлж солигдоход зарлигийг хишигтэндээ уншиж сонсгоогүй, манаж буй хишигтэн нараа ахлагч гэсэн байдлаар дур мэдэн шийтгэвэл ахлагчийн буруутай үйлдэл хэмээн үзэж түүнийг шийтгэхээр тогтоосон байдаг.

Цааш нь “гаднах мянганы ноёд миний хишигтэнтэй хэрэлдвэл мянганы ноёныг шийтгэнэ”/31.251; 36.145/. Монголын нууц товчоонд дурдсанчлан “хэвтүүлийн завсраар явах”, “хэвтүүлийн тоог асуух”, “хэвтүүлийн байрны дэргэд суух, хэвтүүлийг их хаанаас ангид дайнд явуулах”, “хишигтэн үүргээ эс биелүүлэх”, “пайз тэмдэг, зар бичиггүй өртөөгөөр явах”, “тогтоосон хүнс, шүүсний хэмжээг хэтрүүлэн хэрэглэх”, “малыг зодох”, “малыг зовоож алах”, “малыг үргээх” зэрэг үйлдлүүдийг гэмт хэрэг хэмээн тогтоож, тэдгээрийг үйлдэгсдэд ял шийтгэл ногдуулахаар заасан байдаг бөлгөө. Тэгэхдээ чухам ямар ял шийтгэл оногдуулахыг тодорхой нэрлэж заагаагүй ажээ. “Таалийн хууль зөрчсөн буюу хахууль авсан хүнийг 2 жил хүртэл гянданд хорих ял оногдуулж байжээ” /36.154/. Өгөдэй хааны тогтоосон хууль, зарлигуудыг судлан үзэхэд эрүүгийнх нь бодлогод ял шийтгэлийг хүндрүүлэх, хөнгөрүүлэх үндэслэл нийгмийн хор хохирлын хэмжээ, хэргийг ямар аргаар /харгис хэрцгий, зовоох, тарчлаах гэх мэт/ үйлдсэнийг харгалзах явдал байсан нь ажиглагдаж байна. Зарим зөв, ашигтай үйлдэлд урамшууллын санкц /урамшуулах/ хэрэглэж байжээ. Жишээлбэл, хишигтэн цэргийн тухай хуульд хэвтүүлийн тоог асуусан хүнийг хэвтүүл барьтугай. Хэвтүүлийн тоог асууж баригдсан хүний тэр өдрийн унаж явсан эмээл хазаартай морийг хувцасны хамт тэрхүү барьсан хэвтүүл автугай /31.248/ гэж “Монголын нууц товчоо”-нд 278 дугаар зүйлд заасныг энд дурдаж болно. Өгөдэй хааны үед шүүн таслах ажиллагааг явуулахдаа Чингис хааны тогтоосон хаана хэрэг үйлдсэн байна тэр газарт нь явуулж байх зарчмыг хатуу баримталж байжээ. Нэгэн зүйл баримтыг өгүүлье. Хан хөвүүн Мангай болон ноён Алчидай, Хонхордай, Жанги тэргүүтэн ноёд Өгөдэй хаанд өчрүүн “Чингис хаан эцгийн чинь зарлиг билээ.

Хээрийн үйлийг хээр шийтгэж, гэрийн үйлийг гэрт шийтгэх, хаан одоо Гүюгт хилэгнэж байна. Энэ бол хээрийн хэрэг мөн. Хаан соёрхвол энэ хэргийг Батад тушааж илгээвэл болох уу?” /31.247/ гэхэд Өгөдэй зөвшөөрч байжээ.



ӨГӨДЭЙ ХААНЫ БАЙГУУЛСАН ХАРХОРУМ ХОТ



МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ИХ ХААН ГҮЮГ
(1206-1248)

ГУРАВДУГААР БҮЛЭГ**Гүюгийн хаанчлалын үеийн Их Монгол улсын төр,
эрх зүй /1246-1251/****§1. Гүюг хаанд өргөмжлөгдөж төр барьсан нь**

Өгөдэй хаан гэнэт нас барсны дараа Монгол гүрний дотор хаан ширээ булаацалдсан тэмцэл, хямрал явагджээ. Өгөдэй амьд сэрүүн байхдаа ахмад хүү Гүюгээ хаан сууринд суулгах дургүй байсан байна. “Учир нь Гүюг, Бат хаантай эе эвдэрч, өөрийн эцэгтээ ч төдий л сайнгүй, зарим талаар нэлээд зөрчилтэй байсан ажээ” /36.168/ Өгөдэй хаан гуравдахь хүү Хүчүг хаан ширээ залгамжлуулах хүсэлтэй байсан боловч дайнд үрэгдсэн учир түүний хүү Ширэмүнийг ширээ залгах хан хөвүүн болгосон байна. Гэтэл Өгөдэй хаан гэнэт нас барсан эл үед хараахан нялх байсан тул хаанд өргөмжлөх бололцоогүй байжээ. Ийнхүү хаан ширээ булаацалдах тэмцэл эдгээр шалтгааны улмаас улам ширүүссэн ажээ.

Энэхүү нөхцөл байдалд Өгөдэй хааны их хатан Туракина¹⁷, хэсэг ноёд түшмэдийг “Далан даваа” гэдэг газар хуралдуулан шинэ хаан өргөмжлөх асуудлыг хэлэлцүүлжээ. Тэрхүү хуралдаан чухам хэнийг хаанд өргөмжлөх тухай тодорхой шийдвэр гаргалгүй, Туракина хатанд төр хамааруулахаар тогтсон байна. Ийнхүү Их Монгол улсын төрийг барих эрх Туракина хатанд шилжжээ. Энэ тухай Рашид-ад-Дин “Дөргөнэ /Туракина/ хатан башир арга хэрэглэж, заль гарган төрлийнхэнтэй зөвлөлдөлдөггүй дураараа загнан улсын засгийн эрхийг булаан авчээ” /49.129/. Тэрбээр янз бүрийн бэлэг өглөгөөр урхидан, төрөл, төрөгсөд, ноёдын сэтгэлийг өөртөө татсан учир тэд ч түүний талыг барьж захиргаанд нь оржээ /49.129/ хэмээн бичсэн байдаг билээ /9.261; 36.169/ хэмээн Монгол улсын тулгуур түүхэн бүтээлүүдэд ч мөн ийм байдлаар бичсэн нь бий.

Эдгээр баримт нь арга заль хэрэглэн, хаан ширээний хямралыг гүнзгийрүүлэн, дундаас хувийн ашиг хонжоо олох замаар Туракина хатан хэсэг зуур төр барьсан ажгуу.

Туракина хэмээх Наймалжин хатан бол мэргэд гаралтай, мэргэд аймгийн ноён Тагтоо бэхийн их хөвүүн Ходын эхнэр байжээ. Чингис хаан Мэргэдийг дагуулан ялны дараа Туракинаг Өгөдөйд хатан болгон өгчээ. Ингэж Туракина Өгөдэй хааны их хатан болсон ажгуу.

“Туракина хатан, төрөлхийн эрмэг зантай, чадварлаг хүн учир бусад хатны дотроос Өгөдөйд ихэд эрхэмлэгдэж, улмаар төрийн хэргийг шүүрэн авсан” /48.259/ аж.

Тэрбээр сэргэлэн, бусдыг өөртөө татах увидастай /25.31/, “нэг их сайхан хүүхэн байгаагүй ч төрөлхийн нэн их захирамтгай араншинтай байжээ” /49.5/ гэх зэргээр түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн болой.

Туракина хатан бол Их Монгол улсад хааны үүрэг гүйцэтгэж байсан анхны хатан юм.

Эл хатан хааны үүрэг гүйцэтгэгчээр 4 жил 6 сар ажиллаж, төрийг барьжээ. Туракина хатнаас төр барьсан энэхүү хугацаанд явуулсан бодлого, үйл ажиллагаа нь санаатай ч санамсаргүй аль ч байдлаараа хаант улсын байдал хүндрэлд орж, төрд хямрал нүүрлэж, хан хөвгүүд талцан эвдрэхэд хүргэсэн байна. Туракина төр барьж байгаад “Өгөөдэй хааны ах дүү, үр сад, хуучин түшмэд, Чингисийн угсааны ноёд, сурвалжтан нарын олонхи ихэд дургүйцжээ” /36.169/

Ялангуяа Өгөөдэйн хоёрдугаар хүү Годан¹⁸, төрийн сайд Чинсан Чингай, нэрт түшмэд Мухамед Ялавич, Чингис хааны отгон дүү Отчигин ноён, мөн Зүчийн үр садууд илүү дургүйцэж байсан байна.

Туракина хатан Өгөөдэйн ордны сайд Чингай Чинсанг албанаас нь халж, түшмэд Мухамед Ялавачийг хань нөхдийнх нь хамт барьж авахаар заналхийлж байснаас хатантантай эвдрэлцсэн ихэс дээдэс цөм, Хөх нуурын газрыг захирч байсан Годаныг тойрон бөөгнөрөх болжээ. Годан ч тэднийг зүйл зүйлээр дэмжиж хаацайлж байв. Туракина хатан Чингай, Ялавич нарыг гаргаж өгөхийг хэд хэдэн удаа шаардсан ч Годан ноён гаргаж өгөөгүй байна. Харин “Харцаганы савраас амь дүйж байгаа болжмор шувуу бутын төгөлд хоргодож байж аюулт дайсныхаа довтолгооноос амиа авардаг шүү дээ. Үүнчлэн тэд, манайхаас аврал эрж бидний хамгаалалтад ирсэн учир тэднийг эндээс явуулах нь энэрэнгүй сэтгэлд хэрхэвч нийцэхгүй билээ. Удахгүй Хуралдай болно. Тэднийг би тийш нь дагуулаад очно. Тэдний бурууг манай төрлүүд, ноёдууд байж байгаад шалган шүүнэ. Тэгээд ногдвол зохих ял цаазаараа шийтгэгдэх болно” /49.131/ гэж хариу өгчээ. Түүнээс хойш хэд хэдэн удаа элч нар ирсэн боловч Годан энэ л үгээ хэлсээр байжээ.

Туракина хатан өөрийн үйл ажиллагаанд лалын шашинтан Фатима гэдэг эмэгтэйг татан оролцуулж, тэр нь хатны алба, амины хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэх болсон явдал Отчигин тэргүүтэй ноёдын дургүйцлийг бүр ч их хүргэж, Туракинаг сөрөн зогсож, их хаанд өргөмжлөх үйл явцыг түргэтгэхийг хичээх болсон байна. Туракина ч Чингисийн отгон дүү Отчигин ноёныг Фатимагаар хорлуулан егүүтгэж амжжээ.

Өгөөдэй хааны хүү Гүюг эхийгээ төр барихыг илт эсэргүүцэж байсан боловч өөр хэн хүнд хаан ширээ залгамжлуулахыг хүсэхгүй байжээ. Мөн Цагаадайн хүү Баттай ч тэмцэлдэж байсан байна. Гүюг Отчигиныг эсэргүүцэх нэрийдлээр цэрэг удирдан нутагтаа орж ирсэн байна. Гүюгийн уг санаа нь хаан ширээг шууд эзлэн авахаар шийдсэн байжээ.

Гэтэл Отчигин авга ах нь нас барсан учир өвөг эцгийн талаас хаанд өрсөлдөх хүн байхгүй болж, зам нь бүр шулууджээ.

Гүюгийн үйл ажиллагаа идэвхижсэн хийгээд Туракина хатны 4 жил гаруй хугацаанд явуулсан бодлогын үр дагавар нь улс орон даяар хааны үүрэг гүйцэтгэгч

хатанд дургүйцэх явдал эрс нэмэгдэж, нөлөө бүхий ноёд түшмэдийн ихэнх нь шинэ хаан өргөмжлөх хүсэл эрмэлзэлтэй болсон байна. Ширэмүн¹⁹ насанд хүрээгүй учир яах ч аргагүй хүнд байдалд орсон Туракина хатан аргагүйн эрхээр хүү Гүюгээ дэмжиж, түүнийг хаан ширээнд өргөмжлөх нь зүйтэй юм гэсэн шийдэлд хүрчээ.

Өгөдэйн Гүюг, аян дайнаас өөрийн ордондоо эгэж ирээд төдөлгүй хааны ордон руу явжээ. Хааны ордноос улсын ойрын ба алсын мужууд, бүх өнцөг хязгаар тийш элч довтолгон хан хөвгүүд, ноёд, нарыг Их Хуралдайд урин залсан байна. 1245 оны морин жилийн хаврын улирал ирж байхад баруун, зүүн жигүүрийн бүх хан хөвгүүд ба ноёдууд нь захирагдагсад ба талынхантайгаа хүрэлцэн иржээ. Хуралдайд ирэгсдийн тухай Рашид-ад-Дин “Судрын чуулган”-ы 2 дугаар ботид нилээд дэлгэрэнгүй бичсэн байдаг бөлгөө. Түүний бичсэнээр “Сорхог тайш Бэхи, түүний хөвгүүд их гоёмсог тансаг хувцасласан, цог жавхлантайгаар хүрэлцэн ирсэн байна. Дорно зүгээс Отчигин ноёны хөвгүүд Илжигэдэй ба бусад авга ба үеэл ахан дүүсийн хамт, Цагаадайн ордноос Хар /Хулагу/, Иису, Бури, Есөнмөнх²⁰ Байдар, Есөн-Буха болон Цагаадайн бусад хөвгүүд ба ач нар, Зүчийн улсын ордноос Бат, Орда, Шэйбан, Бэрх, Бэрхчир, Тангуд ба Туга, Төмөр дүү нараа явуулсан байна. Хан хөвгүүдийн хамтаар аль аль талынхаа нөлөө бүхий ноёд, мөн Хятадаас ноёд, албан тушаалтнууд, Туркестан ба Мавернахраас Масуд бэхи болон түүний зөвшөөрөлтэйгээр тэдгээр орнуудын түшмэдүүд, Хоросанаас Аргун ноён ба түүний хамт тэр нутгийн Ирак, Лура, Ширван ба Азербайджаны түшмэдүүд, нөлөө бүхий хүмүүс, Румээс Султан Рукн-ад-Дин, Гуржистанаас хоёр Давууд, Хлебаас тэндхийн эзэмдэгчийн дүү, Мосулаас султан Бадр-ад-Дин Лулугийн элчин, Багдадаас дээд шүүгч Факр-ад-Дин, Франкуудын элчин, Фарс-ба Керманаас мөн Аламутын эзэн, Ала-ад-Дингайн Мухташамууд, Кухистанаас Шихаб-ад-Дин ба Шали-ад-Дин нар тус тус хүрэлцэн ирсэн ажгуу” /49.134/.

Ромын пап ламын илгээсэн католик шашинт, гэлэн Плано Карпини тэргүүтэй хүмүүс байлцжээ. “Хуралдайд гадна, дотноос ирсэн зөвхөн элч төлөөлөгч нар 4000 гарч байжээ” /36.170-171/.

Хуралдайд олон хүн цуглан ирж, тэдэнд “зориулан хоёр мянга орчим асар /49.171/, хэдэн мянган гэр барьж, их хэмжээний хоол хүнс бэлтгэсэн боловч суух газар олдохгүй, идэш уушны зүйл хүрэлцэхгүй үнэ ихтэй байв” хэмээн түүхэн сурвалжид тэмдэглэснээс үзэхэд оролцогч сонирхогчид нэн олон байсныг харуулах бөлгөө.

Их Хуралдай 1246 оны зун, Өгөдэй хааны зуслан Тамирын Шар Ордод²¹ чуулжээ. Шар ордны газар 2000 гаруй хүн багтах том цагаан асар босгож, Ромын папын элч Плано Карпинигийн ажигласнаар “асарыг алтан хадаасаар заадаслаж хадсан алтадмал багана дээр барьсан байх бөгөөд дотуур дээвэр, хөшиг нь цул хоргой байсан” /40.71/ ажээ. Шар орд нь Плано Карпинигийн өгүүлснээр “уулын хөндийд орших нэгэн

сайхан тал дундуур урссан голын хөвөөн дээр байсан бөгөөд алтаар бүрмэл модон баганатай, торгон дотортой, элдэв бөс даавуугаар зүйж хучсан тийм ордон” байжээ.

Гадуур нь янз бүрийн дүрс зургаар чимэглэсэн модон хашаа барьсан байжээ.

Тэр хашаа хоёр том хаалгатай байсны нэгээр эзэн хаан, нөгөөгөөр бусад хүмүүс орж гарч байжээ /13.217-218; 36.171/. Их Хуралдайд оролцогч ихэс, дээдэс, ноёд түшмэд, жанжин нар өдөр бүр өөр өөр хувцас өмсөж гоёмсоглож байсан ажээ. Цөм анхны өдөр цагаан торго, маргааш нь улаан торго, нөгөөдөр нь хөх торгон хувцас өмсөх зэргээр хувцсаа сольцгоож байсан нь энэ ёслолын Хуралдайд ихэд хүндэтгэн, өөрсдийн нэр төрийн илэрхийлэл хэмээн үзэж байсантай холбоотой буюу.

Их Хуралдайгаар хэлэлцэх үндсэн асуудал нь хаан ширээнд өргөмжлөх их хааны тухай асуудал байсан бөлгөө. Хан хөвгүүд, ноёд ихэс дээдэс зөвлөлдөж ярилцаад “Чингис хаан, хаан суулгаарай гэж айлдсан Годан өөд болсон, хааны гэрээсэлсэн угсаа залгамжлагч Ширэмүн нь эрийн цээнд хүрээгүй болохоор хааны ууган хөвүүн Гүюгийг л тохоон тавих нь дээр болно” /49.134/ хэмээн ярилцаж мөн ийм нэгдмэл шийдэлд хүрчээ. Энэ асуудлыг Их Хуралдай нухацтай хэлэлцсэн байна. Олон ч хан хөвгүүд, ноёд, түшмэд үг хэлж, санал бодлоо илэрхийлжээ. Тэд бүгд үгээ ярьж хэлэлцээний дараа түүнийг хаан ширээнд залахаар тогтсон байна /49.134/.

Харин Гүюг тогтсон заншил ёсоор татгалзан, өөр хүнрүү заан, өөрөө өвчтэй, бие муутай гэж шалтаглан маргаж байсан аж. Түүнийг олон удаа, ихэд гуйсны эцэст нэгэн зүйл болзол тавьжээ. Тэрхүү болзлоор “Миний дараа хаант улс нь миний овгийнхон байхыг баталсан нөхцөлд би зөвшөөрнө” /49.134/ гэж өчсөн байдаг. Хаанд өргөмжилж байгаа хүмүүс Гүюгийн саналыг зөвшөөрч, бичгээр андгай тангараг өргөсөн болой.

Тэрхүү тангарагийн бичигт “Чиний овгоос өөхөнд ч, өвсөнд ч ороогоод байхад нохой ч, мал ч идэхгүй хэсэгхэн мах ч үлдээд байсан цагт бид хаан зэргийг хэнд ч өгөхгүй” /49.134/ хэмээн андгайлжээ. Ийнхүү Гүюг их хаанд өргөмжлөхийг зөвшөөрсөн байна.

Үүний дараа хаанд өргөмжлөх ёслолын ажиллагаа явагджээ. Эхлээд бөө буулгаж, хан хөвгүүд бүгд малгайгаа авч, бүсээ тайлан босож Гүюгт хүндэтгэл үзүүлэн дуугүй зогсов. Есөнмөнх, Урт²² хоёр Гүюгийн зүүн, баруун суганаас сугадаж, их хааны сууринд суулгаад “хаан” хэмээн дуудаж гурван удаа сөхрөн мөргөв. Дараа нь Их Хуралдайд оролцогсод цөмөөр есөн удаа сөгдөн мөргөжээ. Мөн асарын гадна байсан ноёд, сайд, элч, харуул болон бусад эгэл жирийн ард цөмөөрөө наран зүг харж гурав мөргөсөн байна. Дараа нь Гүюг Хуралдайд оролцсон ихэс дээдсээ дагуулан асраас гадаа гарч, ард иргэдтэйгээ хамт наран өөд харж “Мөнх тэнгэрийн хүчин” хэмээн хэлж гурван удаа мөргөсөн байна.

Ингэж Гүюг Их Монгол улсын гурав дахь хаанаар өргөмжлөгдсөн байна. Гүюгийг хаан сууринд суусанд зориулан сүр жавхлантай марш хөгжим үлээж,

нүсэр их хурим найр хийж долоон өдөр, долоон шөнө найрлажээ /17.176/. Найр дууссаны дараа Гүюг хатад, хан хөвгүүд, түмт, мянгат, зуут, аравтын ноёдод ихээхэн бэлэг барьсан /49.135/ ажгуу. Гүюгийн хаанд суусан байдлыг ажиглахад Тэмүжин, Өгөдэй нарын үеийнхээс нилээд өөр бөгөөд түүхэн баримт бичигт тодорхой тэмдэглэгдэж үлдсэн нь тухайн үеийн монгол гүрэнд хаан өргөмжлөх журам горим нь сүр дуулиан ихтэй байсныг харуулж байна /36.172/. Гаднын орон, тухайлбал Хятад, Солонгос, Франц, Ирак, Исмайл болон оросын Суздаль муж, Туркестан, Азербайджан, Мавероннахр, Гуржистаны төлөөлөгчид, Ромын папын элч нар оролцсон нь үүний нотолгоо болой. Их Монгол улсын түмт, мянгат, зуутын ноёд Хуралдайд ирсэн нь тэдэнд бэлэг өргөсөн гэсэн Рашид-ад-Дин мэргэний бичсэнээс илэрхий байна.

Гүюг бол эцэг Өгөдэйн ажлын арга барилыг эзэмшсэн, алтан ургийн нэр төрийг ихэд хамгаалдаг, монгол түмнээ хайрлах сэтгэл өндөр, шударга сахисан, хаан ширээний төлөө тэмцэл хурцатгахаас ихэд болгоомжилдог /17.177/ хаан байсан байна. Тэрбээр өрнөдөд аянд явж байхдаа байлдаан тулалдаанд удаа дараа оролцож, цэргийн жанжин болтлоо хатуужин, алтан ургийн хүрээнд өсөн төлөвшсөн боловсролтой хаан байсан ажгуу. Ромын папын элч Плато Карпини “Монголчуудын түүх” хэмээх замын тэмдэглэлдээ Гүюгийг хааны ширээ залгамжлах Их Хуралдай, ёслолын ажиллагааг биечлэн ажиглаж, их хаан болон ихэс, дээдэс, иргэдтэй уулзаж, тэр үеийн Монгол орны улс төр, нийгмийн амьдралыг нүдээрээ үзэж танилцаж байсан мэдлэг, соёлтой хүний хувьд үнэтэй мэдээллүүд үлдээснийг нягтлан судлах нь их чухал ач холбогдолтойг болгоон ажаамуу.

“Тэрбээр дунд зэргийн нуруутай, маш хэрсүү ухаалаг бөгөөд хэтэрхий зальжин байртай, буурьтай бөгөөд ихэмсэг зантай ажгуу. Түүнийг хий хоосон инээвхийлэх буюу ямар нэгэн гэнэхэн дэмий явдал гаргахыг хэн ч үзээгүй гэж түүнтэй салшгүй хамт байсан христос шашинтнууд бидэнд ярьсан билээ” хэмээн Плато Карпини бичсэн байдаг бөлгөө /13.76/. Гүюг хаан бол алсын хараатай, сүрхий эцэн мэргэн бодлоготой, чанга нямбай зан чанартай хүн байсан аж /36.173/.

Гүюг хаан, 1248 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр баруун зүгт аян дайнд явж байх үедээ 42 насандаа Дорнод Туркестаны нутагт таалал төгссөн бөлгөө. Гүюг хааныг түүний орд нь байсан Имилдь аваачиж оршуулжээ.

Доктор Ч.Далайн дүгнэн бичсэнээр Гүюг хаан “хаанчлалын хугацаа нь богино ч гэсэн хаан эцгийн зассан улсыг тэр хэвээр нь хадгалж, хууль дүрэм чангатгаж, төрийг нь тогтвортой болгож чадсан” /17.181/ бөгөөд өвөг эцгийнхээ гэрээсийг чамбай биелүүлсэн их хаан байжээ.

§2. Гүюгийн хаанчлалын үеийн

Их Монгол улсын төрийн байгуулал

Гүюгийн хаанчлалын үеийн Их Монгол улс нь хэмжээгүй эрхт хаант засаглалтай байв. Их хааны хэмжээгүй эрх мэдэл Чингис, Өгөдэй хаанаас уламжлагдан Гүюгт шилжин ирж, эзэнт гүрнийг захирах, өвөг эцэг ба өөрийн эцгийн гэрээслэлийг биелүүлж, монгол улсаа хямралгүй, тогтвортой байлгаж хөгжүүлэхэд нэн чухал байсан аж. Иймээс тэрээр хэмжээгүй эрх мэдлээ хэнтэй ч хуваалцахгүй, хэнд ч ашиглуулахгүй байх хатуу чиг шугам баримталсан байна. Хааны эрх мэдлийг булаацалдах, хаантай сөргөлдөхийн эсрэг тууштай зогсож, эцэг хааныхаа дараа өөрийгөө хаанд өргөмжлөгдөх хүртэл хугацаанд гарсан төрийн эрх мэдлийн хямрал, гажуудал, дур зоргоор аашлах явдлын хор уршгийг арилгахад ихээхэн анхаарал тавьж, зарим шийдвэртэй арга хэмжээ авсан ажээ.

Гүюг хаан болмогцоо төрийн эрх мэдэл булаацалдах хэрэгт идэвхтэй оролцогсдыг цээрлүүлэн шийтгэсэн байна. Юуны өмнө төрийн эрхийг түр барьж байсан Туракина хатны үед өндөр зиндаанд хүрч, хатны зөвлөгчөөр нь ажиллаж байсан Фатимаг шүүн цаазалжээ.

Фатима нь Хорезмын эсрэг аян дайны явцад тус хотын Мешхедээс олзлогдон Монголд ирсэн нэгэн ховч, хутган үймүүлэгч, яс хаягч, хорлон бусниулагч, зальт эмэгтэй. Фатима, хатан Туракинагийн “нууцыг нь хадгалж чаддаг, итгэгдсэн дотно хүн нь байв” /49.130/ Туракина хатан, улсынхаа чухал томоохон ажилд тавигдаад байсан түшмэд, ноёдуудыг халж солин, тэдний оронд мэдлэггүй хүмүүсийг томилдог болсон нь төрийг бусниулсан хэрэг байжээ. Туракина хатан Өгөдэй хааны хамгийн хүндтэй, мэдлэг чадвартай сайдууд болох Чингай, Ялавич нарыг албан тушаалаас нь халж, амь насыг нь хөнөөхөөр зэхэж байсан болой. Хаан орыг залгамжлах эрх бүхий Өгөдэй хааны хүү Годанд Фатима хор өгч алсан хэмээн үздэг бөлгөө. Хан хүү Годан өвчин нь улам хүндэрсэн учир ах Гүюг хаандаа элч заран “өвчин хүндэрсэн нь Фатима хараал хийснээс /илбэнээс/” боллоо. Хэрэв ямар нэгэн явдал тохиолдвол тэр л хариуцна шүү” /49.32/ гэж хэлүүлсэн нь түүхнээ тэмдэглэгдсэн байдаг бөлгөө.

2003 онд хэвлэгдсэн “Монголын түүх” хэмээх 5 боть номын дэд ботид Гүюг хаан эх Туракина хатны хүч нөлөөг хязгаарлаж дарахаар Фатимаг барьж аваачин “Годанг хорлон алсаны учир хороов” гэж зарлажээ /36.172/ хэмээн бичсэнийг тунгаан ажаамуй.

Иймээс Гүюг хаан Туракина хатны эрх мэдлийг хязгаарлаж, зөвлөгч Фатима, түүний хань хамсаатнуудыг хааны ордноос зайлуулжээ. Мөн Чингайг төрийн сайдаар эгүүлэн томилж, Махмуд Ялавичийг Хятадыг захирах сайдаар ажиллуулжээ. Үүний дараа Гүюг хаан, хаан эцэг болон өөрийнхөө бодлогыг тууштай хэрэгжүүлж чадах

мэдлэг боловсролтой, туршлагатай, чадварлаг түшмэдүүдийг төрд ажиллуулах шийдвэртэй арга хэмжээ авчээ. Олон чадварлаг түшмэдүүдийг төрийн албандаа томилж ажиллуулсан байна.

Гүюг хаан алтан ургийнхны нэгдлийг хангах, “Өгөдэйн үр садаас Монголын цаашдын хаадыг өргөмжлүүлж байх”, Их Хуралдайн шийдвэр, алтан ургийнхны тангаргыг биелүүлэх нь монгол төр тогтвортой, хүчирхэг байхын үндэс хэмээн үзэж, ихээхэн анхаарал тавьж байжээ.

Тэрбээр хааны эрх мэдлийг булаалдаж, хямрал үүсгэхийг оролдсон хэмээн авга ах Отчигин ноёныг шүүн цаазалжээ. Энэ тухай Рашид-ад-Дин “Отчигин ноёнд тохиолдсон явдлыг шалган шүүх ажилд орлоо. Үүнийг маш нарийн чанд явуулах ёстой байв. Түүнийг сайтар байцаасан байна. Гэхдээ үүнийг хэн бүхэн хийж болохгүй байсан учир тэр нь ойр төрлийн хүн болох учир билээ. Үүнийг Мөнх хан, Орда хоёр шүүсэн бөгөөд өөр хэнийг ч оролцуулсангүй билээ. Ингэж шүүснийхээ дараа Отчигинийг хэдэн цэргийн ноёд нь цаазалжээ” /49.135/ гэж бичсэнээс үзвэл Отчигин ноёныг их нарийн бодлого, арга хэрэглэн төрийн хэргээс салгасан төдийгүй амь насыг нь хороосон ажгуу. Үүний дараа Туракинагийн байр суурь суларч, эрх мэдэл нь хязгаарлагдсан ч бас нэр, нөлөөтэй байж Гүюгийн бодлогод оролцсоор байжээ.

Энэ тухай “Судрын чуулган”-нд “Гүюг эх дээр ирсэн ч төрийн хэргийг удирдахад огт орсонгүй хаан ширээ ... батжитал нь Туракина хатан урьдын адил удирдсаар л байлаа” /49.132/ гэж бичсэн байдаг. Гэвч хоёр гурван сарын дараа Туракина хатан нас барж, Гүюг хаан төрийн эрхийг дангаар барих болсон байна. Их Монгол улсын хаан ширээний түүхэнд Гүюг, Мөнх хааны үед Өгөдэй, Цагаадайн үр ач нар ба Зүчи, Тулуйн үр ач нар гэсэн хоёр тал болж, хаан ширээг булаалдан ил, далд аргаар тэмцэлдэж байсан бөлгөө. Гүюг хаан хаан ширээний төлөө тэмцэлдэх вий хэмээн ихэд болгоомжилж, үүний тулд дараа дараагийн хаадыг зөвхөн Өгөдэйн удмаас тодруулж байхыг Их Хуралдайгаар зөвшөөрүүлж байсан ажээ.

Гүюг хаан, Цагаадайг залгамжилсан түүний ах Хар Огул Цагаадайн өөрийн нь хан хүү Есөн Мөнхийг төрийн хэрэгт оролцуулдаггүйг нь буруушааж, хар Огулийг өөрчилж, Есөн Мөнхийг Цагаадайн ор суулгасан байна. Энэ тухай Рашид-ад-Дин, “Цагаадайг залгамжилсан Хар Огул нь Цагаадайн хөвүүн Есөн Мөнхийг төрийн хэрэгт оролцуулдаггүй байлаа. Түүнтэй нөхөрлөдөг байсан Гүюг хаан хэлсэн нь; Хөвүүн нь амьд байхад ач нь залгамжлагч байж яаж болдог юм бэ? гэжээ. Ингээд Есөн Мөнхийг Цагаадайн ор суулгаад, энэ хэрэгт түүний төрийг нь бэхжүүлсэн байна” /49.135/ гэж бичжээ. Үнэний хувь ч ийм байсан болов уу.

Гүюг хаан ширээнд суухад нь элдвээр саад хийж, захирсан орноо Монголоос тусгаар байлгах бодлого явуулж байсан Зүчийн хүү Батын эсрэг зогсож түүнтэй

тулалдаж, цохилт өгөхөөр далд бодлого баримтлан баруун зүг их цэргээ авч хөдөлсөн боловч зам зуураа нас барж зорьсондоо хүрч чадаагүй ажгуу.

Гүюг хаан хэмжээгүй эрхт хааныхаа хувьд хууль, зарлиг гаргах, төрийн ордноо бэхжүүлэх, төрийн сайд түшмэдүүдийг шинэчлэх, томилох, засаг захиргааны бүтцэд зарим нэг өөрчлөлт хийх, их цэргээ удирдаж зохион байгуулалт, зэр зэвсгээ сайжруулж, аян дайны бэлтгэл хийх, гадаад, дотоод харилцаагаа хөгжүүлэх, эдийн засгийн хүч чадлаа нэмэгдүүлэх зэрэгт анхаарлаа төвлөрүүлсэн ажээ.

Гүюг хаан, эзэн хааны эрх мэдлийг сэргээж, хаан ширээ, эрх мэдлийн төлөөх тэмцэл, сөргөлдөөнийг зогсоож, төрөө тогтвортой болгосон нь төрийн байгуулалтдаа олсон томоохон амжилт мөн байжээ.

Энэ талаар академич Ч.Далай “хаанчлалын хугацаа нь богино ч гэсэн хаан эцгийн зассан улсыг тэр хэвээр нь хадгалж, хууль дүрэм чангатгаж, төрийг нь тогтвортой байлгаж чадсан байна”/17.181/ хэмээн Гүюг хаан түүхэн үүргээ хэрхэн биелүүлснийг дүгнэн бичжээ. Гүюг хааны үед хааны нэр хүнд өндөр, сүр хүч ихтэй байжээ.

Тэрбээр Их Монгол улсын өөрөөсөө өмнөх төрийн байгууллын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагааны дэг журмыг хэвээр нь үлдээж, уламжлалыг нь хадгалан хамгаалахыг ихэд хичээсэн ажээ. Төрийн чуулган хэмээн алдаршсан Их Хуралдай өмнөх уламжлал, жаягаараа ажилласан байна. Гүюг хааныг Их Монгол улсын хаанд өргөмжилсөн 1246 оны Их Хуралдай сүр жавхлантай, хамгийн олон элч төлөөлөгч, зочид, ард иргэд оролцсон өргөн бүрэлдэхүүнтэй байсан болой. Түүнээс өөр Их Хуралдай чуулаагүй бөгөөд чуулах цаг хугацаа ч хомс байсан бололтой.

Гүюг хааны сайд, зөвлөгчид түмт, ордны аппаратын хариуцлагыг дээшлүүлж, хамгийн нэр хүндтэй, чадварлаг ноёд түшмэдээр бэхжүүлсэн байна. Тэрбээр Чингайг баруун гарын чинсан буюу их сайдаар, их ноён Илжигэдэйг өрнийн орны ард иргэдээс гааль гувчуур авах ноёноор, Махмуд Ялавичийг Хятадыг захирах даргач/сайд/-аар, Масуд бегийг Туркестан, Мавдененхакхрыз Хорассан, Ирак, Азербайджан, Ширван, Лур, Керман, Гүржийг захирах ноён/сайд/-оор тус тус томилжээ. Мөн бусад ноёдыг төрийн түшмэлээр шинээр томилсноор төрийн аппаратын чадвар дээшилсэн байна.

Энэ тухай Рашид-ад-Дин Өгөдэй хаан “Чинхайг хайрлан Визарь-сайдын тушаал соёрхсон ажгуу. Бүх түшмэл нь эргэж буцацгаасан байна”/49.136/ хэмээн тэмдэглэсэн байна. Өгөдэй хаан, Дирбекрийн хэрэг захиргааг Илжигэдэйд шилжүүлээд “тэдгээр нутгийн захирагч-хакимууд нь албан татварын талаар түүний өмнө хариуцах ёстой болгосон төдийгүй энэ нутгийн хэрэгт хэн ч хутгалдах ёсгүй”/49.136/ гэж зарлигласан нь төлөөний сайд, түшмэдийн үндсэн үүрэг нь тэр улс орны хэргийг Их Монгол улсын нэрийн өмнөөс хаант төрийнхөө бодлогыг баримтлан шийтгэж, хаан төрийн санхүүд татварын орлогыг бүрэн оруулах хатуу хариуцлага хүлээж, тийнхүү тухайн нутгийг

захирах онцгой эрх эдэлж байв. Эзлэгдсэн улс орон, газар нутгийг захирах нэгдмэл бодлогын үндсийг ийнхүү чандлан тогтоосноор Их Монгол улсын төрийн нэр хүнд хүчин чадлыг өсгөсөн байна.

Гүүгийн үед хааны төв аппарат нилээд бэхжих хандлагатай болж, шилмэл сайд, түшмэдийг ажиллуулж, ордны дэг журмыг чангатгасан байна. Туракина хатны үед ажлаасаа халагдсан сайд түшмэдийг эгүүлэн ажилд нь авч, төрийн түшмэдийг томилоход хахуульдах, зүй бус аргаар өөртөө татах, атгаг санаа, өс хонзон өвөрлөхийг таслан зогсоож, зөвхөн мэдлэг чадвар, шударга үнэнч байдал, дадлага туршлагыг нь харгалзах чанд бодлого явуулжээ. Өсөж хөгжиж яваа, үнэнч, зориг тэвчээртэй хүмүүсийг шинээр түшмэл болгосон байна. Ахмад туршлагатай ханхүү Годан, Чинхай чинсан, Их жанжин Сүбээдэй, ханхүү Орда, Илжигэдэй ноён, Аригун ноён, Цагаан ноён, Бэрх ноён, түшмэл Хадаг, Бала зэрэг олон олон чадварлаг сайд, ноёд, түшмэдүүд Гүүг хаанд хүчээ өгөн төрд зүтгэж явсан ажгуу.

Гүүг хаан түмт, мянгат, зуут, аравтын тогтолцоог хэвээр нь хадгалж, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нь өөрчлөлт хийж амжаагүй ч гэсэн эцгийнхээ үеийн түвшингээс бууруулахгүйгээр ажил хэргээ авч явах шаардлага тавьж байсан ажээ.

Гүүг хаан цэргийнхээ удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад анхаарлаа хандуулж, зарим нэг арга хэмжээ авчээ. Учир нь болбоос Чингис, Өгөдэй хааны үеийн цэргийн их жанжин, зүтгэлтэн, хүлэг баатрууд насан өөд болох буюу өндөр насалсан учир цэргийн удирдлагаас аргагүйн эрхээр чөлөөлөгдөхөд хүрч дараа дараачийн жанжин баатрууд, цэргийн ноёдыг тодруулах, бэлтгэх, хатуужуулан төлөвшүүлэх шаардлага тулгарсан бөлгөө. Өгөдэй ч, мөн Гүүг ч их цэргийг ерөнхийлөн удирдах үүргийг өөртөө авч, өмнөт Сүн улсыг дайлах байлдааныг толгойлох, захирах жанжинаар Сүбээдэй баатар, Цагаан ноёнг, баруун зүгт Исмайлыг дайлах байлдааны гол цэргийн жанжинаар Илжигэдэй ноёныг томилж, цэрэг татлага явуулж мянгат, зуут, аравтын цэргээр бэлтгэл сургууль хийлгэсэн нь их цэргийг ерөнхийд нь зүгшрүүлэхэд чиглэсэн байна. Цэрэг татлагыг хүн малын тооллогын дүнг харгалзан явуулсан нь өмнө гарч байгаагүй үйл хэрэг байсан бөлгөө.

§3. Гүүгийн хаанчлалын төрийн дотоод, гадаад бодлого

Гүүг хаан эцэг Өгөдэйн дотоод бодлогыг үргэлжүүлж, хаан ширээний төлөөх зөрчил сөргөлдөөнийг зогсоож, улсаа амар тайван байлгах, хууль ёс дэглэмийг нарийн чанд сахих, цэрэгт татахыг цэгцлэх, өртөө улааны горим журмыг чангатгах, улсын сан хөмрөгийг арвижуулах, албан татварыг журамлах, мал сүргээ өсгөх, ард түмнийхээ аж амьдралыг төвхнүүлэхийг хичээсэн байна. Гүүг, Туракина хатны төр барьж байх үед өртөөний журам зөрчигдөж, эмх замбараагүй байдал үүсэж, пайз, бичгийг дур

зоргоор олгох явдал газар авсныг анхааран, энэ бүхнийг цэгцлэх арга хэмжээ авчээ. Юуны өмнө Туракина хатны үед олгосон пайз, тэмдгийг хүчингүй болгож, хэн хүнд пайз бичиг дураар олгохыг зогсоосон байна. Рашид-ад-Диний “Судрын чуулган”-д бичсэнээс үзэхэд *нэгдүгээрт*, Туракина хатны үеийн пайз тэмдгийг хүчингүй болгох, *хоёрдугаарт*, Өгөдэй хааны пайз, тэмдгийг хүчин төгөлдөрөөр хэрэглэх, *гуравдугаарт*, шинээр пайз тэмдэг олгох үйл ажиллагаа зэрэгцэн явагдсан байна. Энэ нь Гүюг хаанаас өртөө улаагаар зорчих асуудлыг цэгцэлсэн томоохон арга хэмжээ болж ард олны дэмжлэгийг хүлээж байв. Цагаадайг нас барсны дараа “Хан хөвгүүд бүр л мужуудаар мөнгө төлүүлэх бичиг бичих, аливаа хүнд пайз өлгөх зэрэг байж таарахгүй үйлдэл хийж байсны нь төлөө тэднийг шийтгэжээ. Энэ бол хуулинд ч, заншилд ч таарахгүй байсан болохоор тэднийг сайтар ичээсэнд сэтгэл нь зовсондоо эгцлэн харж чадахгүй, толгойгоо гудайлган доош харж байлаа. Тэгээд тэд пайз, зарлиг өгсөн хүмүүсээсээ түүнийгээ буцааж аваад өмнө нь тавьсан байна“ /49.135/ гэх мэтээр Рашид-ад-Дин бичиж байсныг болгоон ажаамуй,

Гүюг хаан 1247 оны өвөл хүн амын тооллого явуулсан байна /49.172/. Энэ нь албан татварыг журамлах, цэрэг татахыг цэгцлэх зорилготой байжээ. Үнэхээр ч тооллогын дүн нь цэрэгт татвал зохих эрчүүдийг бүртгэх, албан татвар төлөх ёстой өрх айлын тоог гаргаж данслахад үндсэн хэрэглэгдэхүүн болсон байна. Судлаач их эрдэмтний нотолсныг үндэс болговол “Гүюг хааны үеийн хүн амын тооллогын байдлаас үзэхэд тэр үед монголчууд хоёр сая орчим хүн амтай байжээ /17.177/. Энэ тоо “орчим“ гэдэг үгээр яг зөв тоо биш болохыг илэрхийлсэн боловч нийт хүн амын ерөнхийлсөн тоо байсан буйзаа. Олон жилийн дайн байлдаанд амь эрсэдсэн болон эзлэгдсэн орныг захирахаар үлдсэн монголчуудыг харгалзаж үзэх юм бол монголчууд энэ тооноос үлэмж олон байх байсан нь эргэлзээгүй. Гэсэн ч тэр үед хүн амын тооллого явуулсан хийгээд түүний үр дүн нь монголчуудын түүхэнд, монгол угсаатныг цаашид үржүүлэн өсгөх, удам угсаагаа хамгаалан тэмцэхэд үлэмжийн их ач холбогдолтойг тунгаан болгооход илүүдэх юун бөлгөө.

Гүюг хааны явуулсан дотоод бодлогын гол үр дүнг цэгнэн хэлэх юм бол эзэн хаант ёсыг сэргээн тогтоож, хаан ширээний төлөө сөргөлдөөнийг эцэс болгон, төрийн төв аппаратыг шинэчлэн бэхжүүлж, цэргийн зохион байгуулалт, сургууль бэлтгэлийг сайжруулан, өртөө улаа, албан татварыг цэгцлэн журам горимыг нь нарийсгаж, хууль ёсыг төвшитгөсөн явдал мөн болой. Гуравхан жил шахам төр барьж, байлдаан хийх, түүний бэлтгэлийг хангахад хирэндээ ихээхэн цаг зарж байсантай харьцуулан үзэхүл Гүюг хааны дотоод бодлогын үр дүн, ач холбогдолыг чамлах бус, харин чанга атгасан нь хавьгүй дээр буюу. Гадаад бодлогын хувьд Гүюг хаан эцгийн бодлогыг баримталж, бусад улс орныг байлдан дагуулах бодлогыг үргэлжлүүлжээ /9.172/.

Тэрбээр өмнө зүгт умард Хятадын Алтан улсыг эзэлж дуусган, Өмнөд Хятадын Сүн улсыг байлдах бодлого явуулжээ. Их цэргээ бэлтгэн засаад Хятадыг эзлэн авах аян дайныг сэргээж цэрэг нэмэн хөдөлгөсөн байна. Рашид-ад-Диний өгүүлснийг үзбээс “Сүбээдэй баатар, Цагаан ноёныг тоо томшгүй цэрэгтэйгээр Хятад нутаг ба Манжийн орчим тийш хөдөлгөсөн байна /49.135/. Гүюг хаан Хятадыг байлдах толгойлогч жанжнаар Сүбээдэй баатрыг, цэргийн ерөнхий жанжинаар Цагаан ноёныг томилж “Умард Хятадыг эцсийн удаа бүрэн гартаа оруулж, айл өрхөд нь татвар, түрээс оногдуулж, цаашлан өмнөд Сүн улсыг довтлон байлдахыг...тушааж, тодорхой хэмжээний монгол цэрэг өгч мордуулжээ” /49.177-178/. Харин хичнээн тооны цэрэг хөдөлгөсөн нь түүхэнд тэмдэглэгдсэнгүй.

Энд нэгэн зүйлийг нэмэн өгүүлэх нь зүйтэй болов уу. Их Монгол улсын түүхэнд Умард, Өмнөд Хятадыг дайлах аян дайн олон жилээр сунжирч, Чингис, Өгөдэй, Гүюг хааны төдийгүй Мөнх хааны үеийг ч дамжин үргэлжилсээр Хубилайн үед сая дууссан ажгуу. Гүюг хаан Хятадыг довтлох байлдааныг сэргээн үргэлжлүүлж ихээхэн цэрэг илгээж, ихэд анхаарсан үр дүнгээ үзэж чадахгүй насан өөд болсон бөлгөө.

Гүюг хаан 1247 оны намар Илжигэдэй ноёноор толгойлуулсан Монгол цэргийг өрнө зүгт хөдөлгөж, Исмайлын улсыг байлдан дагуулахыг даалгасан байна. Чингэхдээ Гүюг хаан Илжигэдэйн цэргийг тэргүүн анги болгоод, түүний хүчийг нэмэгдүүлэхэд ихэд анхаарч 100 монгол айл тутмаас нэг эр, Ираны нутагт байгаа Таджик цэргийн арван хүн тутмаас хоёр хүн авч /49.135/ хүчийг нь зузаатгах арга хэмжээ авчээ.

Гүюг өөрөө 1248 оны өвлийн сүүл сард цэргийн гол хүчээ аван “тэнгэрийн байдал дулаарах тийшээ хандлаа Имилийн цаг агаар миний биед таардаг, тэндхийн ус рашаан ч миний өвчинг эдгээх сайн нөлөөтэй” /49.137/ хэмээн хэлээд баруун зүгт морджээ. Гүюг хаан баруун зүгт их цэргээ толгойлон мордохдоо эхлээд замдаа өөрийн өрсөлдөгч Батыг гэнэдүүлэн цохиж эрхэндээ оруулах /36.173/, дараа нь Исмайлд Илжигэдэйн цэрэгтэй нийлж байлдах хоёр санаа агуулж байсан бололтой. Үүнийг ч түүхэн баримт нотолдог юм. Тулуйн хатан Сорхугтани Гүюгийг баруун зүг хөдөлмөгц Бат хаантай уулзах хүнийг нууцаар явуулж “Гүюг хаан их цэрэгтэйгээр тэр хязгаар тийш чинь хөдөллөө. Бэлэн байгаарай” /49.137/ гэж хэлүүлжээ. Бат хаан эл хэлийг хүлээн аваад “Захирсан нутгийнхаа хязгаарыг бэхлэн цэрэг зэвсэг бэлдэж, Гүюгийг тосон байлдахаар зэхэж байжээ” /36.173/. Академич Ч.Далай “Гүюг хаан баруун зүг хөдөлсний гол учир бие сувилуулахад биш Батын эсрэг дайнд мордох гэсэн нь нэн ойлгомжтой юм” /17.178/ хэмээн өгүүлжээ. Эдгээр нь түүхэн баримт мөн болой.

Гүюг хааны гадаад бодлогод шүтэж байсан шашин, алив шашинд түүний хандаж байсан хандлага, үзэл баримтлал нөлөөлж байсан нь лавтай. Гүюг хаан өөрөө “Хэзээ ямагт христосын шашин санваартны сургаалийг зөвшөөрдөг байв...

Гүюг хааны захиргааны үед христос шашны үйлс нь дэгжиж дэвшин дээшилж байхад лалын сүсэгтний нэг нь ч түүнийг эсэргүүцэн дуугарах сачийгүй байлаа“ /49.136/ гэж Рашид-ад-Дан өгүүлсэн баймуу.

Судалгаанаас үзбээс Гүюг өвөг эцгийн шүтэж, монголчуудын дунд гүн нэвтэрсэн бөө мөргөлөөс хөндий байж, түүнийг хүндэтгээгүй гэж хэлбэл үнэнд үл нийцэх авай. Тэрбээр алтан үеийнхний ихэс дээдсийг гүнээ хүндэтгэн тэднээс суралцахын хамт Их Монгол улсын төрийн шашинд хандах бодлогыг уламжлан үргэлжлүүлж, аль ч шашинд адилхан хандаж дэмжих, аль ч шашинтан ард олныг үл ялгаварлах, шашны их дээдэс, лам, эрдэмтэдтэй хүндэтгэн харилцах, шашныг төрийн бодлого, эзлэгдсэн орны ард иргэдийг захирахад ашиглахыг эрмэлзэн байсан ажгуу. Лалын шашинг ч Гүюг анхаарахгүй байсангүй. Ираныг захирах, Исламыг эзлэхэд ч лалын шашны хүч нөлөө чухал гэж үзэж байсан нь илт ажиглагддаг бөлгөө. Чухамхүү Гүюг хаан аливаа шашинд хандах уламжлалт бодлогын үүднээс бөө мөргөл, лал, христос, бурхны шашныг дэмжиж, тэдгээрийг бие биеийнх нь эсрэг тавих, ялгаварлан үзэх, аль нэгд нь давуу байдал олгох арга үйл ажиллагаа явуулаагүй нь үнэнд нийцэх болой. Тийм ч үйл ажиллагаа явуулах хэрэгцээ, шаардлага, цаг хугацааг Гүюг хааны хаанчилсан маш богинохон цаг үе нэгэнтэй олгоогүйг түүх мэдэх ажаамуй.

Гүюг хаан Их Монгол улсын төрийн уламжлалт гадаад харилцааг үргэлжлүүлж явуулсан ажгуу. Өмнөх үеийн гадаад харилцаанаас ялгагдах онцлог хэмээвэл, *нэгд*, Их Монгол улсын нэр хүнд, сүр хүчин дэлхийн анхааралд бүрнээ орсон, *хоёрт*, Их Монгол улс дэлхийн олон улс орнуудтай харилцаа тогтоож, элч төлөөлөгч харилцан солилцдог байсан, гуравт, Ази, Европын том, жижиг олон улс орон, хот улс, вант улс, газар нутаг монголчуудад эзлэгдэж, тэдгээртэй байнга харилцах шаардлага тулгарсныг тус тус харгалзан үзэх болсон явдал болно.

Гүюгийг Их Монгол улсын хаанд өргөмжлөх төрийн ёслолд гадаадын 4000 гаруй элч төлөөлөгч оролцсон үйл явдал дээрхи дүгнэлтийн нотолгоо болохын хамт Гүюг хааны явуулах гадаад бодлогод ихээхэн нөлөө үзүүлжээ.

Монголчуудын байлдан дагуулал, түүний хэн ч төсөөлшгүй огцом дараа дараалсан ялалтууд нь Европын соёлт орнуудыг цочрол, гайхшралд оруулж, хүчээ нэгтгэн, монголчуудын эсрэг тэмцэх, үүнд дипломат бодлогыг хүчтэй хэрэглэхэд хүргэсэн байна. Үүний тодорхой илрэл нь 1245 онд Ромын пап IY Иннокентий Лион хотод онцгой хэргээр хуралдуулдаг учиртай “Ертөнц дахины чуулган”-ыг хуралдуулж, Монгол-Татарын довтолгооноос өрнө дахиныг хамгаалах зорилгоор загалмайтны аян дайныг монголчуудын эсрэг явуулах асуудал хэлэлцсэн явдал мөн.

Чуулганаас Оросын ван Даннил Романович Голицкийд хандаж тусламж гуйхаар тогтож байжээ /36.306/.

Энэхүү чуулганы үйл явц, үзэл санаа, шийдэл нь өрнөдийн улс орнуудын ч, Монгол улсын ч гадаад бодлого, гадаад харилцаанд үлэмж нөлөө үзүүлж, шинэ чиглэл хандлага, шинэ арга хэлбэр үүсэн гарч хэрэгжихэд хүргэжээ.

Гүюг хаан Европ дахинд явагдаж буй үйл явдлыг цэгнэн үзэж өрнөдөд явуулах аян дайныг түргэвчлэх, Хятадыг бүрэн эзлэхийг яаравчлах, дипломат харилцааг өргөжүүлэх, шашны элчин харилцааг дэмжих бодлого явуулжээ.

Ромын пап IY Иннокентий 1245 онд Ромын католик шашны зүтгэлтэн ПIANO Карпинийг өөрийн элчээр Монголд явуулж Гүюг хаанд бичиг илгээжээ.

1246 онд Гүюг хаан Ромын папын элч ПIANO Карпинийг Хар Хорумд хүлээн авч уулзан ярилцаж, улмаар папын илгээсэн бичигтэй сайтар танилцаж судалсан байна. ПIANO Карпини Монголд 4 сар байхдаа Гүюг хаанд бараалхан яриа, хэлэлцээр хийж, Монгол улс, түүний амьдралтай танилцаж, ихээхэн мэдээ, мэдээлэл цуглуулсан аж. Энэ нь Ромын пап, тэрчлэн Европод Монголын тухай бодит мэдээлэл өгөхөд их тус нэмэр болсон ажгуу.

ПIANO Карпинийн тэмдэглэлд Папын бичгийн агуулгын талаар “Христийн шашныг дагаж христос шашинтан болохыг сургамжилж байна. Үүнээс өөрөөр ивээлгүй бөлгөө... Христос шашинтан нарыг, ялангуяа Папын харъяат бөгөөд ямар ч гаж буруугүйн дээр, гэм тавих санаагүй Мажор, Мерав, Польш хүмүүсийг бөөн бөөнөөр нь алж байгаад гайхаж байгааг мэдүүлэх ... Үүнд тэнгэр бурхан аймшигтай хилэгнэж байгаа тул цаашид энэ явдлаа бүрмөсөн огоорч, нүглээ наманчлах” /13.61/-ыг Пап сануулсан хэмээн бичжээ.

Гүюг хаан Ромын папын бичигт Монгол улс христос шашинтны ертөнцөд ноёрхлоо тогтоон, дэлхий дахины улс байгуулахын төлөө тэмцэж байгааг ойлгож, Монголын хааныг христос шашинд орохыг шаардаж, монголчууд христосын шүтлэгтэн улс орон, ард түмнийг эзлэн авсан явдлыг буруушаасныг мэдэж, энэ талаар зөвлөх сайд, түшмэдүүдтэйгээ нухацтай зөвлөлдөж хариу жуух бичгийг боловсруулжээ.

ПIANO Карпинийн замын тэмдэглэлд 1246 оны 11 дүгээр сарын 11-нд биднийг дуудан уулзаж, бичгийн сайд Чингай, хадаг Бала нар болон олон бичээч нар ирж жуух бичгийг дуустал тэд ямар нэгэн үг ташаарсан эсэхийг мэдэх гэж хэсэг хэсгээр нь орчуулж өг хэмээн албадаж билээ. Захидлын хоёр эх бэлэн болмогц ямар нэг үг үсэг гээгдүүлж орхигдуулсан байхаас болгоомжилж, тэд бүгдээр дахин дахин уншуулж, бас “бүгдийг сайн ойлгохын тулд нягтлан үзтүгэй. Та нар бүгдийг ойлгож авахгүй бөгөөс ийм алс хол газар ирсний ашиг тус гарахгүй болно”/13.75/ гэж хэлсэн бөлгөө хэмээн бичсэнээс үзэхэд Гүюг хаан Ромын папын бичиг, тэдэнд хариу өгөхөд их анхаарч ач холбогдол өгч байсныг харуулнам. Ромын папын элч ПIANO Карпинид ч Гүюг хаан, түүний захиргаа хүндэтгэн хүлээн авч, Монголд байх хугацаанд нь элдэв

хориг саад тавилгүй, үүргээ биелүүлэх нөхцөл бололцоог хангаж сайтар үйлчилсэн ажээ. Түүнийг буцахад нь хааны эх өөртөө бараалхуулж “хүн бүрт хөвөн дотортой, үнэгэн дээл нэжгээд, бас магнаг торго өгч” /13.78/ хүндэтгэл үзүүлсэн авай.

Плано Карпини Гүюг хаанаас Ромын папад илгээсэн жуух бичгийг хүлээн аваад 1246 оны 11 дүгээр сарын 13-нд Монголоос мордож 1247 оны 11 дүгээр сард Лион хотноо буцаж ирсэн байна.

Плано Карпини нутагтаа ирсэний дараа Ромын папад Гүюг хааны жуух бичгийг гардуулж өгчээ. Энэхүү жуух бичиг Перс эхээрээ Ватиканы гарт хадгалагдан үлдсэнийг 1920 онд Польшийн лам Кирилл Каралевский олж олны хүртээл болгон улмаар Массэ Пеллио нар орчуулан хэвлэсэн, түүнийг нь Монгол улсын түүхийг бичихэд ашигласнаа зохиогчид нь тайлбарласан байдаг бөлгөө /36.308/.

Гүюг хаан эл жуух бичигт өгүүлсэн зүйлийн гол агуулга нь “Мөнх тэнгэрийн хүчин дор наран ургахуй зүгээс наран шингэх хүртэл бүх газар орон бидний ивээлд орсон .. одоо та нар иргэн чинь болж, эд арга бүхнээ өгье хэмээн өгүүлбээс зохино” гээд эцэст нь “энэ үеэс эхлэн бид та нарыг ивээл дороо орсон хэмээн үзсүгэй. Хэрэв та нар тэнгэрийн бошгыг үл даган, миний зарлигийг зөрчвөөс дайсан чинь болно. ... юу болохыг гагцхүү тэнгэр мэдтүгэй” /36.308/ хэмээснээс харахад Гүюг хаан Ромын пап, түүний улсыг Их Монгол улсын эрхшээлд орсон гэж үзэж байгаагаа илэрхийлэн, түүнийгээ зөвшөөрөхийг папаас шаардаж, хэрэв эс зөвшөөрвөл байлдан эзлэх болно гэдгийг анхааруулсан нь тодорхой байна. Гүюгийн жуух бичгийн агуулгыг сайтар ойлгож мэдэрсэн Плано Карпини Ромын папад Гүюгийн жуух бичгийг гардуулаад өөрийн санаа бодлоо шууд илтгэн “Хэрэв зарлигийг нь биелүүлэхгүй бол Гүюг хаан өрнө зүгийн улс түмэн, христос шашинтны бүх хаант улс, Ромын их гүрэн, католик шашны эсрэг аян дайнд мордохоор бэлтгэж байна” /13.50-56/ гэж хэлсэн ажээ.

Ийнхүү Их Монгол улс ба Ромын папын хооронд элчин харилцаа Гүюг хааны үед тогтож эхэлсэн байна. Ийм харилцаа нь Европын орнууд болон Их Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтооход нөлөөлсөн юм.

Гүюг хааны үед Монгол ба Ойрхи дорнодын орнуудын харилцаа өргөжжээ. Үргэлжийн довтолгоон, байлдаан хийх нь багасч, эзлэгдсэн газар нутгийг төвхнүүлэхэд их анхаарах болсны улмаас Гүюг хаан Ойрхи дорнодын талаар явуулах дипломат бодлогоо идэвхижүүлсэн байна.

1242 оны Монгол-Киликийн хэлэлцээрийн дагуу Монгол улс Киликтэй биеэ даасан улсын хувиар харилцаж, бие биедээ харилцан туслалцаж байжээ.

Мөн Килик, Армян, Монголын харилцаа хоорондоо уялдан холбоотойгоор өргөжсөн байна. Армянаас Монголд хэд хэдэн удаа, элч зарж яриа хэлэлцээр хийж байжээ. 1246-1247 онд Армяны ван II Гетумийн хүү Сибатт Спарпет Хархорумд Гүюг

хаантай хэлэлцээ хийсэн байна. Гүюг хаан Армяны элчийг ихэд хүндэтгэн түүнд Алтан гэрэгэ олгож, монгол гүнжээ өгсөн ажээ. Чухамдаа энэхүү хэлэлцээрийн үр дүнд хожимхон нь Монгол, Армяны хооронд гэрээ байгуулагдсан ажээ.

Монгол улсаас Килик, Армяны вант улстай тогтоосон харилцаа холбоо явуулсан дипломат үйл ажиллагаа нь Ойрхи Дорнод дахь өөрийн өрсөлдөгч улсуудын эсрэг холбоотон болгож ашиглах, худалдааны их замыг чөлөөтэй байлгахад чиглэж байжээ.

§4. Гүюгийн хаанчлалын үеийн Их Монгол улсын эрх зүй

Гүюг хаан Чингис хааны үед баталсан Их засаг хуулийг хатуу мөрдөж эрх зүйн бүх эх сурвалжийнхаа үндэс болгон хэрэглэсэн ажээ. Мөн Чингис, Өгөдэй хаадын баталсан хууль, зарлигуудыг хэвээр нь дагаж мөрдөхийг Гүюг хаан зарлигласан байна. Гүюг хаан өөрийгөө хаанд өргөмжлөх үеэр “Эцгийнхээ гаргасан бүх хуулийг хүчин төгөлдөр гэдгийг батлан хэлээд хааны улаан тамгатай зарлиг бүхнийг түүнд илтгэлгүйгээр шууд үсгээ зурж бай” /49.135/ гэж тушаажээ. Гүюг өмнөх хаадынхаа хууль зарлигийг хэвээр нь сахин биелүүлэхийн хамт “хаан эцгийн зассан улсыг тэр хэвээр нь хадгалж, хууль дүрмээ чангатгасан” /17.181/ хаан байсан бөлгөө. Гүюг хаан Монгол улсад хууль зөрчигдөж, дур зоргоороо авирлах, эрдэм ухаантай түшмэдийг хавчих, халах, хахууль шан өгөх, талцах, яс хаялцах, атгач санаа агуулах, хардаж сэрдэх, шударга ёсыг огоорон амин хувиа хичээх, алба тушаалын төлөө ил, далд тэмцэлдэх явдал дэлгэрч буйг анхааралдаа авч шийдвэртэй арга хэмжээ авч таслан зогсоосон нь үүний баримт мөн болой. Хуулиа биелүүлэх, хууль ёсоо дээдлэх нь Гүюгийн төрийн бодлогын нэн чухал зарчим байсан ажгуу.

Гүюг хаан хаант төрийг барьсан харьцангуй богинохон хугацаандаа хэд хэдэн хууль, зарлиг гаргажээ.

Төрийн өндөр тушаалын албанаас хууль бусаар халагдсан түшмэдүүдийг эгүүлэн хуучин албанд нь томилох, хууль бусаар төрийн өндөр алба тушаалыг эзэлж, төрийн ажлыг хуурмагжуулсан сайд түшмэд, тэдний хань хамсаатныг цээрлүүлэн шийтгэх тухай зарлигууд гаргаж, хэрэгжүүлсэн нь төрийн албаны нэр хүндийг дээшлүүлж, хууль ёсыг хангасан хэрэг байв.

Гүюг хаан зарлигууд гаргаж, хамгийн эрдэм ухаантай, үнэнч шударга, ажил хэрэгч хүмүүсийг сайд түшмэдээр томилж, чин хатуу үүрэг хариуцлага хүлээлгэсэн нь төрийн албыг цэвэршүүлж чадваржуулсан арга хэмжээ байсан юм. Гүюг хаан бас эзлэгдсэн орнуудын захиргааг бэхжүүлэх, тэдгээрээс хаант төрийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зарлигууд гарган шинэ төлөөний эрх ямба эдлүүлсэн нь нэн ач холбогдолтой байжээ. Гүюг хааны зарлигласнаар Илжигэдэй ноён төрийн албан

татварын бодлогыг барьж, хааны өмнө хариуцаж байв. Төлөөний сайд нь эзлэгдсэн орны алба, татварын асуудлыг хааны өмнө хариуцаж байхад тэдгээр орны захиргаа, ноёд, түшмэдүүд нь алба татварын талаар чухамхүү түүний өмнө хариуцах ёстой /49.136/ байсан ажээ. Төрийн сайд түшмэдийн хариуцлагын тогтолцоог ийнхүү зарлигаар тогтоосон нь Гүюг хааны төрийн сайд, түшмэдүүддээ өндөр хариуцлага хүлээлгэж, тэр чанараараа хууль ёс нарийн чанд сахигдахыг бодолцсон хэрэг байсан бөлгөө. Рашид-ад-Дин Гүюг хаан хууль ёс зөрчихтэй хэрхэн хатуу, зоригтой тэмцэж байсныг сайтар ажиглаад “Сорхогтуни бэхи түүний хөвгүүд нь нүүр бардам, тайван дээрэлхүү байдалтай байлаа. Учир нь тэнд яс зас хуулийг зөрчсөн гэж зэмлэх зүйл огт байсангүй. Гүюг хаан бусдад хандаж хэлсэн үгэндээ тэднийг магтан бусдад үлгэр дууриал болгоод, бусадтай нь харилцахдаа үл тоомсорлох янзтай байв” гэж /49.135/ тэмдэглэн бичсэн ажгуу. Үүнээс үзвэл Гүюг хаан хууль ёсыг сахихын учир холбогдлыг сайтар ойлгож, хуулийг чандлан биелүүлж буй хүмүүсийг сайшаан урамшуулж, түүнээс суралцахыг бусдад уриалж, харин хуулийг зөрчсөн этгээд ямагт хүний нүд рүү эгц харж чадалгүй дальдчиж, цэрвэж, гишгэх газаргүй мэт гөлөлзөж байдгийн үнэн дүр төрх буйзээ.

Гүюг хаан зарлиг гаргаж хүн амын тооллого явуулсан нь алсын хараатай бөгөөд хуулийг гаргах нь үндэслэлтэй байхыг сануулсан хэрэг мөн байжээ. Энэ зарлигийн агуулгын талаар нэгэнт дээр өгүүлсэн билээ. Гэхдээ тооллогын үр дүн нь эзэнт гүрний хүн ам, айл өрхийн тоог төрийн бодлого, арга хэмжээгээр тодорхойлон гаргаж улмаар тэр нь алба татвар, цэрэг дайчилгаа, ард түмний амьдралд хандсан хууль, зарлиг, шийдвэр гаргахад зөвхөн Гүюг хааны үед төдийгүй дараагийн хаадын үед ч бодит үндэслэл болж байсан ажгуу.

Гүюг хаан цэргийн зохион байгуулалтыг шинэчлэх, цэрэг албанд татах талаар зарлиг гаргасан бөлгөө. Тэрбээр өмнөд, өрнийн орнуудад байлдах цэргийн жанжинуудыг томилж, цэргийн тоог нь цэрэг дайчилгаа явуулж нэмэгдүүлэх тоо хэмжээг нь тогтоосон байна.

Мөн өртөөний тухай хууль гаргаж, өртөөгөөр зорчих пайз тэмдэг, түүнийг олгох, хэрэглэх журмыг зохицуулж, өртөөний үйл ажиллагааг журамласан ажээ.

Ер нь Гүюг хаанаас дотоод, гадаад бодлогын талаар авсан арга хэмжээнүүд түүний хууль, зарлигуудаар тогтоогдон хэрэгжиж байсныг тэмдэглэлтэй.

Энэ талаархи баримт, үр дүн, өмнөх зүйл /3§/-д тодорхой өгүүлснийг болгоон үзэхийг хүсмүй. Эх сурвалжууд дахь баримтуудыг судлан үзэхүл нэг талаар Чингис, Өгөдэйн үеийн хууль цаазыг хүчинтэйд үзэн тэр чигээр нь мөрдсөн, нөгөө талаар Гүюг хаан өөрөө шинэ хууль цаазууд тогтоож хэрэглэсэн нь Гүюгийн хаанчлалын үед бичмэл цааз хангалттай байсан болох нь тодорхой байна.

Ромын папын элч христос шашинт, Португаль улсын ламтан Пласано-Карпинийгийн Монголд аялж, Гүюг хаанд хэд хэдэн удаа биечлэн бараалхаж, эл цагийн монголчуудын амьдралыг нүдээр үзэж, ажиглаж, түүхнээ бичиглэн үлдээсэн “Монголчуудын түүх” хэмээх аян замын тэмдэглэлийг уншихуйд монголчууд хуулиа хэрхэн ойлгож, сахин биелүүлж, хууль цаазын заалтууд монголчуудын зан заншилтай хавсран бие биенээ нөхөх, дэмжих, хүч нэмэх замаар хэрэгжин байсныг мэдэрч болно. Пласано Карпинийгийн бичсэнээр асар өргөөндөө хүмүүс суудлаа эзлэх, мэнд ус мэдэх, босох, гарах хоорондоо харилцах, үг хэлэх, архиа хундагалан амтлах, айраг цагаа уух, идээ зооглохоос эхлээд өртөөгөөр зорчих, элч төлөөлөгчийг хүлээн авах, ёс ёслол гүйцэтгэх, бичиг захидал боловсруулах, бичиж бэлтгэх, илгээх, зарлиг шийдвэр сонсгох, дайтах, найрамдах, гэрээ хэлэлцээр хийх, хурал хурах, чуулган чуулах, хаанд өргөмжлөх, хаад, ихэс, дээдсээ хүндэтгэх хүртэл бүгд нарийн ёс жаягаар явагддаг байсан ажээ.

Дайн байлдааны үед гурав ба түүнээс олон хүн аравтын цэргээс оргон зугтвал тэднийг цөмийг цаазлах, аравгаараа цөм зугтвал бусад зуут байсан ч бүгдийг цаазлах, цэрэг нийтээрээ ухраагүй байхад зугтвал цаазлах, хоёр ба түүнээс илүү хүн зориглон дайрахад аравтынхан нь эс дагалдваас тэднийг цаазлах, нэг ба хэдэн хүн нь олзлогдоход тэр аравтынхан нь эс чөлөөлбөл цаазлах, дайсан бүрэн дарагдаагүй байхад ашиг завшаан эрж хайвал цаазлах хууль Гүюг хааны үед үйлчилж байжээ. /13.39/ Энэ нь Гүюг хааны үед цэргийн цааз хатуу, нарийн чанд байсныг харуулах бөлгөө.

Тухайн үеийн нийгмийн шаардлагаар Монгол үндэстнийг бүрэлдүүлэх, үндэсний нийтлэг зан заншил, ёс жаяг, төлөвшил хүмүүжлийг бий болгох, төрийг хүндэтгэх, хууль цаазыг чандлан мөрдөх, нэгдмэл ёсон тогтоох зорилгоор хориглосон шинжтэй эрх зүйн хэмжээнүүд тогтоон, түүнийг нийтээрээ биелүүлэн хэвшүүлэх, хэрэв эс биелүүлбэл төрийн албадлага хэрэглэж ял шийтгэл үзүүлэх замаар заавал биелүүлэх Их Монгол улсын төрийн бодлого Гүюг хааны үед ч уламжлагдан хэрэгжиж байжээ. Тухайлбал, гал руу хутгаар чичих, хутгыг галд дүрэх, хутгаар тогооноос мах гаргах, ташуураар газар тулах, шувууны ангаахай, дэгдээхэйг барих, алах, хазаараар морио ороолгох, ясыг ясаар нь ташиж хугалах, сүү, унд, хоолыг газар руу асгах, гэр дотор шээх, хоол идэж байхдаа хахаад гаргаж чадахгүйд хүрэх, удирдагчийн гэрийн босгон дээр гишгэхийг хуулиар хориглож, хэрэв хоригийг зөрчвөл цаазлах хатуу ялтай байсныг Пласано Карпини нилээд дэлгэрэнгүй өгүүлсэнийг анхаарахгүй байж хэрхэн болох бөлгөө. /13.18/ Гэрлэлт, гэр бүлийн харилцааны талаар ч сонирхол татахуйц хэм хэмжээнүүд үйлчилж байсан аж. Олон эхнэртэй байхыг хуулиар зөвшөөрч, эцэг нь нас барвал эхнэртэй нь гэрлэх, ах ба дүү нь бие барвал гэргийтэй нь суух /13.13-16/ ёсыг тогтоож, эхнэр, нөхөртэй хүн бусадтай завхайрвал эхнэр, нөхрийг хоёуланг нь алах /13.24/ цаазтай байжээ.

Тэрчлэн хулгай, дээрэм хийх, орд өргөө рүү дураараа нэвтрэн орох, алба татвар эс төлөх аваас ял зааж хэрэглэж /13.24, 45/ байсан байна. Үүнээс гадна энэхүү бүлгийн дээрхи зүйлүүдэд өгүүлсэн төрд тэрслэх, цэрэг хөдөлгөн босох, улсаас урвах, төрийн залгамжлах ёсыг алдагдуулах, төрийн зүтгэлтнүүдийг сөргөлдүүлэх, хооронд нь яс хаях, өдөөн хатгах, хавчин гадуурхах, өш хонзон авах, амь насыг нь хохироох, эд хөрөнгийг хулгайлах үйлдлийг нэн хүнд хэрэг хэмээн яллаж байсан бөлгөө.

Эх сурвалжуудад буй мэдээллүүд, Гүюг хааны авсан арга хэмжээ, гаргасан хууль зарлигийг судлан үзэхүйд ялын дараах хэлбэрүүдийг хэрэглэж байсан байна. Энэ нь цаазаар авах, туйвандах, эрх тушаалыг нь эвдэх, ташуурдах, жанчих, боол, шивэгчин болгох, сануулан анхааруулах, эд хөрөнгө, газар нутгийг нь хураах, торгох ялууд болно. Эдгээр ялуудаас цаазаар авах /алах/, жанчих, ялуудыг нилээд түгээмэл хэрэглэж байжээ. Плано Карпини “Монголчуудын түүх”-д дурдсанаар ял оногдуулбал зохих 40 шахам гэмт үйлдлийн нилээд илүүд нь цаазаар авахаар ял оногдуулж байсан аж. Энэ нь цаазаар авах ялыг түгээмэл хэрэглэж байсныг харуулна. Төрд тэрслэх, цэрэг хөдөлгөн босгох, амь насыг нь санаатайгаар бүрэлгэх, улсаас урвах, цэрэг байлдааны журам зөрчих аваас цаазаар авах ялыг чандлан хэрэглэж байсан нь зүйн хэрэг юм. Төрд тэрсэлсэн, цэрэг хөдөлгөн боссон Фатима эм, Отчигин ноён, тэдгээрийн хамсаатнууд захирагч түшмэл Абд-Ар-Рахманыг цаазаар авсан, хууль бусаар эрх мэдэл олж Цагаадайг залгамжилсан Хар Огулын эрх мэдлийг эвдэж Цагаадайг залгамжлахаас болиулсан зэрэг тодорхой баримтуудыг Рашид-ад-Диний “Судрын чуулган”-д өгүүлсэн нь бий бөлгөө.

Цаазаар авах ялыг гүйцэтгэхдээ сурвалжит хүнийг бол хортой ундаа, хор өгөх хэлбэрээр, амийг нь авах бусад тохиолдолд цавчих, харвах, усанд хаяж живүүлэх хэлбэрээр гүйцэтгэж байсан ажээ. Хулгай, дээрэм хийхийг ихэд сэжиглэн шууд цаазалж байсан бол алба, татвараа төлөөгүй хүнийг боол, шивэгчин болгож зарцлах, дайн байлдаан хийх гэж буйг задруулбал 100 удаа туйвандах /13.25/ хэлбэрээр ял эдлүүлж байсан ажгуу.





Гүег хааны тамгын бичиг. Энэ тамгыг Гүюг хаанаас Европын Пап ламд 1246 онд илгээсэн захидал дээр дарсан байна. Энэхүү захидлыг 1920 онд эрдэмтэн лам Кирилл Каралевский Ватиканы нууц архиваас олж гэрэл зургыг нь авснаар судалгааны ажил эхэлсэн байна.

1923 онд Францын монголч эрдэмтэн П.Пеллио уг тамганы бичгийг “Монголчууд ба католик шашны төр” бүтээлдээ нийтлүүлснээр эрдэм шинжилгээний эргэлтэнд оржээ.

Тамганы хэмжээ: 14,5x14,7 см.

Бичиг нь: “Мөнх тэнгэрийн хүчин дүр их монгол улсын далай хааны зарлиг эл булха иргэн дүр хүрвээс биширтүгэй, аюутугай.” хэмээжээ.



МОНГОЛЫН НЭГДСЭН УЛСЫН ИХ ХААН МӨНХ
(1208-1259)

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мөнхийн хаанчлалын үеийн Их Монгол улсын төр, эрх зүй

/1251-1259/

§1. Мөнх хаанд өргөмжлөгдөж төр, барьсан нь

Гүюг хааны нас барсны дараа Их Монгол улсын хаанд хэнийг өргөмжлөх талаар нилээд ширүүн маргаан тэмцэл өрнөжээ. Хаан ширээний төлөө хан хөвгүүд, ихэс дээдсийн дотор хоёр том бүлэглэл гарч тэмцэлдсэн байна. Эл бүлэглэлийн хүрээнд Өгөдэй, Цагаадайн үр ач нар нэг бүлэг, Зүчи, Тулуйн үр ач нар өөр нэг бүлэг болж, өөр өөрсдийнхөө талаас хаан өргөмжлөхийн төлөө тэмцэл явуулжээ. “Бат тэргүүтэй Чингисийн ахмад хүү Зүчийн үр ач нар өөрсдөө хаан ширээнд суух гэлгүй, Тулуйн үр ач нарыг дэмжиж байсан нь учиртай юм. Тэд хэдийгээр хаан ширээнд суухаас буцахгүй байсан боловч, “Алтан ураг”-ийн хан хөвгүүдийн зүгээс гүйцэд дэмжлэг олохгүй байж магад хэмээн болгоомжлон, харин тэдэнтэй талцаж байсан Тулуйн угсааны ноёныг хаан ширээнд суулгах гэж тэмцжээ” /36.173/ хэмээсэн нь илүү түүхэн үндэслэлтэй буюу. Түүхэн удам угсааг түшихүйд эзэн богд Чингисийн хүүхдүүд бүгд насан элээчихсэн болохлоор мөн тэдгээрийн хүүхдүүд дотроос хамгийн боломжтой нь нас, эрдэм ухаан, хүч нөлөөгөө даган, аль хатуужин тодорсон нь хаанд өргөмжлөгдөх нь зүйн хэрэг байсан ажгуу. Чингисийн хан хөвгүүдийн дотроос Өгөдэйн ахмад хөвүүн Гүюг хаан ширээ залгамжилсан билээ. Харин түүний хүүхдүүдийн дотор хаан ширээ залгах хүн тодрох боломжгүй байжээ. Зүчийн ахмад хүү Орд дэмжин Зүчийг залгамжлуулсан Бат ширээнд суух боломжтой нэгэн байсан боловч болгоомжлон өөрөө татгалзаж байжээ. Түүний дүү нараас хаан болох хүн бэлтгэгдээгүй байв. Чингисийн хоёрдахь хүү Цагаадайн хүүхдүүд дотроос хаан болох боломжтой хөвгүүд тодрох бололцоогүй байжээ. Чингис хааны отгон хүү Тулуйн хүүхдүүд бусад ах нарынхаа хүүхдүүдээс илүү хааны төлөө бэлтгэгдсэн нь гэр бүлийнх нь нөлөөтэй амин холбоотой байжээ. Тулуй ханы мэдлэг, чадвар, зан чанар, их хатагтай Сорхугтани²³ хүүхдээ сурган өсгөсөн их хичээл зүтгэл, гэр бүлийн шударга шинж байдал нь Гүюг, Мөнх, Хубилай, Хүлэгү, Аригбөх, Муха нарыг төр барьж түших төвшинд хүртэл өсгөн бэлтгэсэн нь их л гавьяатай үйлс мөн болой. Иймээс Тулуйн удмаас их хаан тодрох бололцоо, боломж илүү байж, бусад хан хөвгүүд, ихэс дээдэс нь дэмжиж байсныг үгүйсгэхийн аргагүй буй заа.

Гүюг хаан нас барсны дараах өвөрмөц нөхцөлд эл байдлыг нарийвчлан харгалзаж Чингисийн хөвгүүдийн ач нарын хамгийн ахмад нь болохын хувьд Бат хан юуны өмнө төрийн амар төвшин байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор Гүюгийг нас барсанд гүнээ харамсаж байгаагаа илэрхийлээд “Төрийн хэргийг Чингай ба Гүюгийн их хатан Огул Хаймишийн зөвлөгөөгөөр өмнөх үндсэн дээр явуултугай.

Тэднийг тоомсорлохгүй байж болохгүй баймой. Учир нь би бээр настай ба хөл өвчтэй, тэнхээ муутай болсны улмаас байрнаасаа хөдөлж чадахгүй болсон учир дүү та нар минь бүгд тэнд амь зууж байдаг болохоороо юу хэрэгтэй байна, түүнийгээ хийтүгэй” /49.138/ хэмээн айлтгасан нь эл үеийн улс төрийн амьдралд ихэд нөлөөлсөн аж. Хан хөвгүүд ч үүнийг хүлээн авсан байна.

Чингээд “Огул Хаймиш Бат болон Алтан ургийн олон ноёдын зөвшөөрснөөр төрийн хэргийг түр хамаарч” /36.174/, Огул Хаймиш 1251 оны 7 дугаар сарын 1 хүртэл 3 жил, 3 сар орчим төр барьжээ.

Хаймиш хатан²⁴ бол Ойрадын Хутуга бэхийн охин агаад багаасаа сайн хүмүүжил олж төлөвшсөн эмэгтэй байжээ. Тэрбээр хэрсүүд, ухаалаг, юмны учрыг олохыг хичээдэг, алив асуудалд хүлээцтэй ханддаг зан чанартай нь түүний эерэг давуу шинж бөгөөд энэ нь түр төр барьж, хааны үүргийг гүйцэтгэхэд нөлөөлжээ. Огул Хаймиш хатан шударга ёсыг ихэд сахидаг, хувийн муу санаа өвөрлөдөггүй, үнэн хэргийн төлөө зүтгэдэг байжээ. Хадам эх Туракина хатны авир занг таашаадаггүй байлаа. Олон сайд ноёдыг хэлмэгдүүлснийг буруутгаж, эхийнхээ хийсэн буруу үйлийг засахыг эр нөхөр Гүюг хаанд хэлж зөвлөдөг байжээ. Тэр ч байтугай Гүюг хаан суухад чи бие султай, төрийн их албыг хашиж давахгүй /17.182/ хэмээн зөвлөж байжээ.

Хаймиш хатан төр барьсан жилүүд нь хаан ширээний төлөө ил, далд тэмцэл явагдаж байсан хэцүү он жилүүд байсан билээ. Огул Хаймиш их хаанд өргөмжлөх асуудлыг шийдвэрлэх, улс орны нэгдмэл тогтвортой байдлыг хангах, хан хөвгүүд, их дээдсийн зөрчил зөрөлдөөнийг харилцан ойлголцуулж, нэгдмэл санаанд хүргэхийг хичээсэн боловч төдий л амжилт олж чадаагүй ажээ. Алтан ургийнхан Зүчи, Тулуйнхан ба Өгөдэй, Цагаадайнхан гэсэн хоёр талцалд хуваагдаж, хаан ширээний төлөө тэмцэлдсэн нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж, улс орны дотоод, гадаад байдалд ч нөлөөлөх болжээ. Төрийг түр барьж байсан Огул Хаймиш, түүний зөвлөгч Чингай Чинсаны үйл ажиллагаанд энэ нөлөөлөл тусаж ажил хэрэгт нь их бэрхшээл учруулж байсан болов уу. Гүюгийг хаанд суух үед түүний удмаас өөр хүнийг хаанд өргөмжлөхгүй гэсэн алтан ургийнхны тангараг ч үл хэрэгсэгдэн үлдсэн ажгуу. Огул Хаймиш хатны нэр нөлөө суларч хүү Хаджи, Нагур нь эхийгээ үл тоон эрх мэдлийг нь өөрсөддөө шилжүүлэн авч, дураар аашлах болжээ. “Нэгэн нутагт гурван захирагчтай боллоо.... Хан хөвгүүд нь өөрсдийнхөө дураар үнэмлэх бичиг ба тушаал гаргаж байдаг боллоо“ /49.138/ хэмээн түүхэн сурвалжид тэмдэглэсэн нь үүний нэгэн зүйл баримт болой. Нийгэмд эмх замбараагүй байдал ч үүсэх болжээ. “Судрын чуулган“-нд энэ тухай “Эх ба хөвгүүд хоорондын маргаантай зөрүүд, эсрэг тэсрэг санаа, шийдвэрээс болоод үйл хэрэг эмх замбараагүй боллоо. Чингай ноён ч юу хийхээ мэдэхээ болилоо. Түүний үг зөвлөгөөг сонсдог хүн ч үгүй боллоо“ /49.138/ гэж бичсэн байх юм.

Огул Хаймиш “Өгөдэйн угсаанаас ялангуяа Ширэмүнийг хаан суулгах гэж их зүтгэсэн байна. Гэвч санасандаа хүрч чадаагүй ажээ” /36.174/. Нөхцөл байдал ийм байгааг болон Өгөдэйн угсааны ноёдын дунд ноцтой хагарал гарсныг ашиглан Зүчийн үр ач нар Тулуйн хөвгүүдийн нэгийг хаан суулгахаар” /36.173/ үйл ажиллагаа эрчимжүүлсэн байна.

Бат хан бусад хөвгүүд, ихэс, ноёдод илч зарж, өөрийн ордондоо Их Хуралдай хуралдуулж, “цөм сайн хүн гэж зөвшөөрсөн авьяаслаг хэн нэгнийгээ сэнтийд суулгая” /49.145/ гэсэн санал тавьсан боловч Цагаадай, Өгөдэй, Гүюгийнхний удам угсааныхан “Чингис хааны их гол гэр ба нийслэл нь энд Онон, Хэрлэнд байхад бид Хипчагийн хээр тал тийш явах алба биш” /49.146/ гээд эс зөвшөөрч, төлөөний хүмүүсээ явуулжээ. Харин Сорхугтани бэхи Мөнхийг баруун зүг явуулж Баттай уулзуулжээ.

Бат хан “Орчин үед хаан байвал зохих таарах хүн нь Мөнх байна. Чингис хааны овгийн хан хөвгүүдээс зөвөөр эргэцүүлэн бодож, яруу тодоор сэтгэн хэлж чадсанаараа төр ба цэргийг дагуулж чадахаар өөр ямар хүн байна? Зөвхөн Чингис хааны бага хөвүүн, түүний аугаа их гал голомтын эзэн, манай хайрт авга ах Тулуй хааны хөвүүн ганц Мөнх хаан л байна. Яс-Засхуулийн дагуу монголчуудын заншлын ёсоор эцгийн ор, бага хөвүүнд нь ногддог нь мэдээж билээ. Ийм учраас хаан байх урьдач нөхцөл нь Мөнх ханд байна” /49.146/ гэж үзэж байлаа. “Хан хөвгүүдээс /зөвхөн ганц/ Мөнх хан л Чингис хааны Яс Зас хууль зарлигийг нүдээрээ үзэж, чихээрээ сонссон билээ. Улс, цэрэг, хан хөвгүүд бидний буян бол түүнийг хаан суулгахад л байна” /49.147/ гэж хэлж байжээ.

Батын ордонд болсон ноёдын хуралд оролцогсод Мөнхийг хаан ширээнд суулгахаар тогтжээ /36.174/. Хурал дуусмагц Бат хан Бэрх²⁵ ноёнд цэрэг өгч Хэрлэнд илгээж Мөнхийг хаан ширээнд өргөмжлүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг өгчээ. Бэрх ноён хаанд өргөмжлөх Их Хуралдайг зарласан боловч Өгөдэй, Цагаадайн угсааны ноёд, Гүюгийн хөвгүүд ирэхгүй байсаар хоёр жил болжээ /36.175/.

Энэ хугацаанд Өгөдэй, Цагаадайн угсааны ноёд Батад удаа дараа элч зарж “Хааны засаг бидэнд оногдвол зохино. Та яагаад өөр хүн соёрхов” /36.175/ хэмээн асуулгасаар байжээ. Бат хан хариуд нь “Бид төрөл, төрөгсөдтэйгээ хэлэлцэн байж энэ буянт үйлсийг шийдсэн юм. Тэгээд энэ тухай яриаг үүгээр төгсгөсөн билээ. Иймээс үүнийг өөрчлөх ямар ч боломжгүй юм. Хэрэв энэ үйлс бүтэж Мөнхөөс өөр хэн нэгнийг “эзэнтэн” гэж зарлавал хаант төрд гэм учирна. Энэ учраас түүнийг зааварлах боломжгүй болох бий. Хэрэв хан хөвгүүд үүнийг шүүн сэтгэж ирээдүйн тухай угтуулан бодвол энэ нь хан хөвгүүд, ач нарын нь хувьд санаа тавьсан хэрэг гэдэг нь тодорхой болно. Учир нь дорноос өрнө хүртэл үргэлжилсэн ийм уудам орны хэрэг явдал хүүхдүүдийн хүч гэнхээгээр хэрэгждэггүй ажгуу” гэж хариу өгсөн байдаг бөлгөө. Энэ бүхэнд хаан ширээнд ор суулгах асуудал хичнээн нарийн, хичнээн олон янзын тактик хэрэглэх явдал шаарддагийг илтгэн илэрхийллгүй.

Монгол нутагт байсан Бэрх ноён “Бид Мөнхийг хаан ширээнд суулгах гэсээр хоёр жил өнгөрлөө. Гэтэл Өгөдэй хаан, Гүюг хаан хоёрын үр сад болон Цагаадын хөвүүн Есөнмөнх нар хүрэлцэн ирсэнгүй” /49.149/ гэж Бат ханд мэдэгджээ. Бат “Чи түүнийг /Мөнх/ хаан ширээнд нь суулгачих. Яс-Засхуулийг зөрчсөн хэн боловч толгойгүй болно” /49.149/ гэсэн хариу өгсөн байна.

Сөргөлдөн буй хоёр талцлын хоорондоо уйгагүй ажиллагаа, харилцан тохирох гэсэн эрмэлзлэлийн үр дүнд Их Монгол улсын хаанд өргөмжлөх асуудлыг төрийн Их Хуралдайгаар хэлэлцэн тохироонд эцсийн дүнд хүрсэн ажгуу. Их Хуралдай хуралдуулж, түүнд оролцон, өөрсдийн байр суурь, хүсэл зорилгоо биелүүлэхийн төлөө тэмцэхээс өөр аргагүй болохыг сөргөлдөгч талын аль аль нь мэдэрсэн ажгуу. Энэ бол маш чухал зорилт. Үүнийг хэрэгжүүлэх нь нэн нарийн арга ухааныг шаардах нь зайлшгүй бөлгөө. Нэгэнт цаг үе нь ирсэн болохлоор Их Хуралдайг хуралдуулахыг аль аль тал нь зөвшөөрөхөд хүрсэн ажгуу. Энд нэгэн баримтыг иш татан дурдсугай. Өгөдэй, Гүюгийн талынхан Огул Хаймиш түүний хөвгүүд Хожа, Нагуу ба Есөнмөнхөд “Чингис хааны өрхийнхний ихэнх /хан хөвгүүд/ цугларчихлаа. Харин Хуралдай чуулах ажил та нараас болоод одоо болтол саатлаа. /Үүнээс/ зайлсхийх, татгалзах боломж байхгүй. Хэрэв та нэгдмэл бөгөөд нэгэн санаатай байх тухай боддог бол улсын үйл хэргийг /нийтийн/ зөвшин тогтсоноор зохион явуулъя гэж та Хуралдайд ирэх хэрэгтэй” /49.148/ хэмээн өгүүлсэн нь Их хаан өргөмжлөх Хуралдайд заавал оролцох шаардлагатайн нотолгоо мөн болой.

Сөргөлдөгч талууд ийм л санаа бодол, хүсэл эрмэлзэлтэйгээр 1251 оны 7 дугаар сарын 1-ны орчимд /1251 оны 6 дугаар сарын 21-нээс 7 дугаар сарын 20-ны хооронд болсон Их Хуралдайд хүрэлцэн ирсэн ажгуу. Рашид-ад-Дины судлан бичсэнчлэн хан хөвгүүд, ахлах ноёд, тухайлбал ахмад ноёд Бэрх, Хархалун, зүүн жигүүрийн хан хөвүүн Зүчи, Хасарын хөвгүүд, Есөнмөнх ба Хачиуны хөвүүн Илжигэдэй, Оточи ноёны хөвүүн ба Тачар, Тэку ноёны хөвгүүд, Чингис хааны бүх ач нар, баруун жигүүрийн хан хөвгүүдээс Цагаадын удмын Хар Хулагу, хааны хөвгүүдээс Хадан, түүний ач нараас Годаны хөвүүн Мунхату, Мөнх хааны дүү Хубилай, Үлэхү, Муха, Аригбөх болон Мөнхсар тэргүүлж олон ноёд хүрэлцэн иржээ.

Их Монгол улсын хаанд өргөмжлөх төрийн Их Хуралдайг Батын зөвлөснөөр түүний дүү Бэрх ноён ерөнхийд нь удирдан, уламжлалт ёсыг даган Хэрлэнгийн хөдөө аралд хуралдуулжээ. Хуралдааны үйл ажиллагааг Бэрх ноёны санал болгосноор Гүюгийн хүү Хубилай удирдсан аж. Хуралдайг Хубилай хаан нээж хан хөвгүүд, хүндтэй ахмад ноёд, овгуудын толгойлогчид, цэрэг эрс малгайгаа авч бүсээ мөрөндөө тохоод есөнтөө өвдөг сөхрөн мөргөж, Их Монгол улсын хаанд Тулуй ханы хүү Мөнхийг²⁶ өргөмжилсөн болой. “Хуралдайд оролцогсод ёслолын хурим хийж, бүтэн

долоо хоног цэнгэх зуур өдөр бүр 2000 тэрэг архи, айраг, 3000 хонь, 300 үхэр, адуу гаргаж, идэш уушиндаа хэрэглэжээ” /36.175/

Мөнхийг хаанд өргөмжлөх Их Хуралдай тайван бус нөхцөлд явагдсан байна. Үүнтэй холбоотойгоор амар тайван байхыг Хуралдайд оролцогсод ихэд хүсэмжилж байжээ. Их хаан ч санаа тавьж ор суусан өдрөө “энэ буянтай өдөр ганц ч бодгаль хэрүүл маргаанд орж хэрхэвч үл болно. Нэгэнт янз бүрийн зэрэг дэвийн хүмүүс хувь тавилангаас зүй ёсоор жаргалтай хангалуун байхыг шаарддагчлан бүгд л хангалуун зугаацаж байтугай. Ямар ч амьтан эрдэс хувьгүй хоцрох ёсгүй, гэрийн ачлага уналгыг, нэг ч амьтныг унаж эцээхгүй, ачиж ядраахгүй, ан хийхгүй, тушиж чөдөрлөхгүй байлгах... амьтдын цусыг урсгахгүй .. газрын хөрсийг ч гадас шаах, морины тахаар цохиж зовоохгүй, урсгал усыг бохир зүйлээр бузарлахгүй бай” /49.150/ хэмээн зарлиглажээ.

Гэтэл Мөнхийг хаан ор суухыг эсэргүүцсэн Өгөдэйн талынхан Ширэмүн, Нагу нарын удирдаж, тэдний дагалдсан 77 ноёд оролцсон бүлэглэл цэргийн хүч хэрэглэн хааныг устгахаар боссон байна. Үүнийг мэдсэн Мөнх хаан өөрийн дүү Хүлэгү²⁷, жанжин Мөнхсар²⁸ нарт 3000 цэрэг өгч угтуулан хөдөлгөжээ. Хүлэгү, Мөнхсар нар шуурхай хөдөлж, Ширэмүн, Нагу нарыг дагалдагсдын нь хамт баривчлан Мөнх хаанд хүргэсэн байна. Энэ үйл явдлын тухай Рашид-ад-Дин нилээд тодорхой үгүүлсэн нь эл хэрэгт түүхийн цаг хугацаагаараа хамгийн ойрын баримт мөн болой.

Мөнх энэхүү явдалд оролцогсдыг байцаан нягтлаад “урвахаар бодож, хан хөвгүүдийг тухиран дуулгаваргүй /болгосоноороо/ тэднийг ийм ялт хэрэгт оруулаад хоригдож байгаа тэдгээр ноёдод илдэн шийтгэл ноогдуулсугай” /49.155/ гэсэн зарлиг буулгажээ.

Зарлигийг ёсоор болгож 77 түшмэлийг цаазаар аваачсан байна.

Мөнх хаан хан хөвгүүдийг байцаахад тэд “бид энэ хэргийн талаар мэдэх юм алга” /49.154/ гэж өчицгөөн хэргээ хүлээхгүй байжээ. Өгөдэйн ач хүү Ширмүүнийг Нагун ба Чугантай хамт Хятад руу томилон явуулж, Хожад Хар Хорумын ойролцоо Сэлэнгийн ай савд нутаг олгосон байна /49.158/. Гүүгийн хатан Огул Хаймиш, Онгон шүтэгчдийн төлөөлөгч Иду кутныг цаазалж түүний ордны түшмэд Чингай, Хадаг, Илжигэдэй нарыг баривчлан хатуу ялласан байна.

Цагаадайн хөвүүн Есөнмөнх, Бури нарыг Бат ханд хүргүүлж цаазлуулжээ. Ер нь Цагаадайн үр нарын ихэнхийг Бат хан хөнөөснийг түүхнээ тэмдэглэсэн байдаг бөлгөө.

Мөнх хаан Илжигэдэй ноён, Том Бубал, Жихи, Хулжай, Сархан, Бяцхан Бубал, Туган Ийсүр зэрэг олон ноёдыг Өгөдэй, Гүүг, Огул Хаймишийн талд үйлчилсэн хэмээн үзэж бүгдийг нь дөнгөлж, гянданд хорих /49.154/ тушаал буулгаж гүйцэтгүүлжээ.

Мөнх хааны эдгээр ажиллагаагаар төр хямралаас гарч Тулуйн угсааныхан төрийг барих болж, Өгөөдэй, Цагаадайн угсааныхан төрийн хэргээс зайлуулагдсан байна. Үүнд Зүчийн хүү Бат хан их үүрэг гүйцэтгэжээ. Тэрбээр Мөнхийг дэмжин хаанд өргөмжлүүлж чадсанаар өөрийн байр сууриа бэхжүүлж, Их Монгол улсын хаанаас дэмжлэг хүлээх эрх нь баталгаажсан ажээ. Мөнх хаан Их Монгол улсын төрийг хямралаас гаргаж, хатуу захиргаа тогтоожээ /36.176/

Мөнх хаан бол Тулуйн ууган хөвүүн бөгөөд түүний их хатан Сорхогтунигаас төрсөн бөлгөө. Мөнхийг өсгөж, хааны зэрэгт хүртэл бэлтгэхэд эл хатан эх нь маш том агаад хариуцлагатай үүрэг гүйцэтгэж бүхнээ түүнд зориулсан аж. Үүнтэй холбогдуулан Рашид-ад-Дины “Сорхогтуни бэхи хүүхдүүд” асрамжлах тэтгэх ба нөхрийнхөө цэргүүдийн хэрэгсэл, бэлтгэл нөөцийн талаар санаа тавихдаа яаж ч хуурч мэхлэхийн аргагүй тийм хяналт тогтоосон байна. Хаан бүх ажил хэргийнхээ талаар түүнтэй зөвлөж, шийдвэр тушаалд нь /ямар нэгэн/ өөрчлөлт хийдэггүй байв. Түүний хараат бүх хүмүүс /тусгай/ ивээл, хүндэтгэлтэйгээрээ ялгарч байсан бөгөөд гарсан үймээн, будлианд тэдний дотроос эртний Яс-Засхууль, хууч домгийг зөрчсөн нэг ч тохиолдол гарч байсангүй... Ийм байдалтай байлгадаг нь туйлын их авьяас, төгс ухаан, үйл явдлын эцсийг нэвт харж чаддагийн л үр дүн, ач билээ” /49.44-145/ хэмээн үгүүлснийг болгоон тунгаагтун.

Мөнх Их Монгол улсын эзэн хаанаар өргөмжлөгдөн арав шахам жил ажилласан түүхийг сурвалж бичгүүдэд хэрхэн дүгнэгдсэнийг босгон үзэхүйд *нэгд*, Мөнх нь Их Монгол улсын сүүлчийн хаан буюу дөрөвдэх хаан байж Монгол улсын төлөө зүтгэсэн хүчтэй хаан байсан, *хоёрт*, Мөнх өмнөх хаадынхаа дотоод, гадаад бодлого, хаант төрийн үйл ажиллагааг залгамжлан үргэлжлүүлсэн, *гуравт*, тухайн улсын түүхэн нөхцөлд нийцүүлэн бодлогын шинжтэй шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр засаг төр нилээд хүчирхэг болж, улс орны эдийн засаг хөгжсөн, *тавд*, Монгол гүрний харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээг урьд өмнө байгаагүй хэмжээнд хүргэж, гадаад харилцааг ихэд өргөтгөсөн эерэг үйлсийг бүтээжээ. Тэгвэл хаан ширээний төлөө тэмцлийн явцад илт нэг талыг баримталсан, Бат хааны хатуу чанга бодлогыг хэт даган түүнд дулдуйдсан, Өгөөдэй, Цагаадайн угсааныхныг шахан хавчиж, үүнийг дагалдсан ноёдод энэрэнгүй бус хандсанаар олон эрдэмт хүний амь насыг хохироож хэлмэгдүүлсэн, гадаад орнуудыг эзлэн авах дайнаар тэдний соёл, иргэншилд халдаж, хүн ардыг нь хүйс тэмтэрсэн харгис үйл ажиллагаа явуулж, нөхөж үл барам асар их гарз хохирол учруулсан нь Мөнх хааны үйл ажиллагааны эерэг бус үр дагавар мөн болой.

Мөнх хаан 1259 оны 8 дугаар сард Сүн улсыг байлдан дагуулахаар явж байгаад тэнгэрт хальж бурхан болжээ. Мөнхийн хүү Шилт ихэнх монгол цэргээ авч, эцэг

хааныхаа шарилыг хамгаалан эх нутагтаа буцжээ. Мөнх хааны шарилыг нутагт нь авч ирээд уй гашуудал хийж, эмгэнэл гүйцэтгээд, Бурхан Халдунд орших Их Хориг гэдэг хаадын шарил тавих газар Чингис, Тулуй нартай зэрэгцүүлэн оршуулжээ хэмээн Юан улсын судрын оршуулгын бичигт тэмдэглэжээ /36.182/

Мөнх хаан нас барснаар 54 жилийн турш оршин тогтносон Их Монгол улс үгүй болж, түүний аугаа их түүх дууссан авай. Энэ түүх бол монголчууд дэлхийн эзэнт улс байгуулж, дэлхий дахины соёл иргэншилд асар том орон зайг эзлэн үүрд мөнхрөн үлдсэний түүх болой. Энэ л аугаа их түүхээр монголчууд дэлхийн тайзнаа алдаршиж, “Чингисийн монгол”, “Чингисийн их гүрэн” хэмээх алдрыг олсон бөлгөө. Түүх биднийг өршөөн соёрхох болтугай.

§2. Мөнхийн хаанчлалын үеийн

Их Монгол улсын төрийн байгуулал

Мөнх хаан өвөг эцэг, эцэг Гүюгийн үеийн Монгол улсын төрийн байгууллыг бэхжүүлэх, түүний тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулах, шинэ нөхцөлд тохирсон шинэчлэлийн шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх бодлого явуулсан ажгуу.

Мөнх хаан ордны өргөөндөө заларч, хааны албан үүргээ гүйцэтгэв. “Хааны ордонг бүхэлд нь алтан саатай цэмбээр доторложээ. Ордны голд орших жижиг тулганд харгана болон тэнд маш өндөр ургадаг агийн үндэс, түүнчлэн аргалын гал түлсэн байв.

Эзэн хаан бээр далайн нохойн арьстай, /далайн хавны арьсан дээл хэмээсэн тайлбартай/ төсөө бүхий толбодсон, маш гялалзсан арьсан дээл өмсөж, сэнтий дээр заларч байв. Тэр бол шантгар хамартай, дунд зэргийн нуруутай, дөчин тав орчим насны хүн байв” /13.162/ хэмээн нүдээрээ харсан Гильом де Рубрукийн тэмдэглэсэн нь Мөнх хааны тухай бодит амьдрал, үнэн баримт мөн болой. Их Монгол улсын сүүлчийн их хаан Мөнх ийм л эрхэм дээдэс байсан ажгуу. Мөнх хаан их улсыг захирч, ноёд түшмэдийг атгандаа оруулж, эрх мэдэл хөөцөлдөн, салан тусгаарлах гэсэн оролдлогуудыг тас цохин, өрсөлдөөн тэмцлийг хатуу ширүүн дарж, нэр сүрээ өргөн өсгөхийг хичээж байжээ. Мөнх хааны нэр хүнд өндөр байсан ажгуу. Манай улсад Мөнх хааны үеэс уламжлагдаж ирсэн дурсгалын зүйлс цөөнгүй байдаг бөлгөө. Хөвсгөл аймгийн Арбулаг сумын нутаг дахь Дэлгэр мөрөнд байсан гэрэлт хөшөө, түүн дээр сийлсэн уйгаржин монгол ба Хятад үсгээр сийлсэн бичээс бол дурсгалт зүйлсийн хамгийн алдартай нь болой. Мөнхийн хаанчлалын үед Монгол улсад хэмжээгүй эрхт хаант засаг уламжлагдан оршин тогтнож байсан бөлгөө. Хаант засгийн Чингисийн үеийн тогтолцоо үндсэндээ хэвээр хадгалагдаж байсан ч гэсэн төрийн байгуулал нь урьдах туршлага, сургамжийг харгалзан боловсронгуй болон хөгжсөн байна.

Түр төр барьж байсан Огул Хаймишийн үеийн төрийн хямралыг даван туулж, эмх журамгүй байдал, түшмэд ноёдын дураараа аашлахыг таслан зогсоож, төрийн бүх эрх мэдлийг Мөнх хаан өөртөө төвлөрүүлж, хэмжээгүй эрхт хааныхаа байр суурин дээр баттай зогсож чаджээ. Үүнд, Эзэн хаан Чингисийн бие эрхэс, түүний үйл хэрэг, Их засаг хуулийг үзэж харж сургаал, номлолыг нь хүртэж байсан явдал хийгээд, Өгөдэй, Гүюг хаан Чингис хааны үйлсийг хэрхэн залгамжилж яаж төр барьж, ухаан зарж байсныг мэдэрсэн мэдрэмж зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн болохыг анхаарах нь зүйн хэрэг буй заа.

Мөнх хаан төрийнхөө бодлогыг тодорхойлох, хууль цааз тогтоох, зарлиг шийдвэр гаргах, газар нутаг олгох, алба тагвар ноогдуулах, сайд түшмэдийг томилох, огцруулах, дайн байлдаан явуулах, гэрээ хэлэлцээр байгуулах, гэмтэнийг гэгсгээн цээрлүүлэх зэрэг онцгой эрх эдэлж байсан бөлгөө. Мөнх хааны эрх мэдэл хэнтэй ч хуваагдашгүй, бас хязгаарлагдашгүй, хэмжээлшгүй, онцгой шинжтэй байсан бөгөөд энэ нь түүний хатуу засаглал тогтооход нь их хэрэгтэй байсан бизээ. Хаанд өргөмжлөгдөх үеийн хямралт нөхцөл байдал ч чингэхийг шаардсан байж болох.

Мөнх хаан Их Хуралдайн сүр хүчийг өргөж, төрийн бодлогын нэн гол асуудлыг шийдвэрлэхэд хамтын оюун ухаан, бодол санааг төрийн дээд шийдэлд шингээх, төрийн их ноёдыг хатуужуулан туршлагажуулах, сурган бэлтгэх, хариуцлага хүлээх чадвар олгоход чиглүүлж чадсан амой. Мөнхийг эзэн хаанд өргөмжилсөн Их Хуралдайн үйл явц, түүн дээр ба дараа нь Мөнх хааны гаргасан зарлиг шийдвэр нь төрийн эл их чуулганы үүрэг ролийг ихэд өргөсөн байна. Энэ Хуралдай алтан ургийнхны бүх төлөөллийг хамарч, ширүүн тэмцэлдээний явцад болж зоригтой шийдвэр гаргасан их л сүр дуулиантай болсон ажгуу.

Мөнх хаан өөрийн биеэр удирдаж нэгэн чухал Хуралдайг явуулсан түүхтэй. Энэ бол Өмнөд Хятадын сүн улсад дайлаар мордох асуудлыг хэлэлцсэн 1256 оны 12 дугаар сарын Их Хуралдай юм. Их Хуралдай 1256 оны 12 дугаар сарын 19-нөөс 1257 оны 1 дүгээр сарын 16-ны хооронд хуралдсан гэж судлаачид үздэг /17.195/ Сурвалж бичигт хаана, ямар нэртэй газар Их Хуралдай чуулсныг тодорхой бичиж тэмдэглээгүй ажээ. Рашид-ад-Дин “Судрын чуулган” зохиолдоо “Могулистаны дунд нь байдаг ... газар Мөнх хаан Хуралдай зохион байгуулав. Энэ нь Хотула хаан ямар нэгэн ялалт байгуулаад нөхөдтэйгээ нэгэн модны дор бүжиглэсээр байгаад газрыг нь хотойлгон цөмөлсөн чухам тэр газар юмсанж” /49.165/ гэсэн бүрэг бараг төдий бичсэн нь бий. Хуралдай чуулахын өмнө хүрэлцэн ирж чадахгүй зарим ноёд, ихэс дээдэст элч зарж саналыг нь авчээ. Хуралдай 20 гаруй хоног хуралдан асуудлыг нухацтай, маргаантай, ажил хэрэгч байдлаар хэлэлцсэн байна. Сүн улстай байлдах нь зүйтэй гэсэн шийдэлд бүх ноёд санал нэгджээ. Харин энэ байлдаан харь нутагт, цаг агаар,

байгалийн хүнд нөхцөлд хүн амын ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан, сайтар хийгдсэн бэхлэлт, хамгаалалт ихтэй оронд явуулах учир зохион байгуулалт, бэлтгэлийг маш сайн хангах, хамгийн шилдэг туршлагатай жанжнуудаар удирдуулах санал хүчтэй тавигдсан ажээ.

Сүн улсад хийх байлдааныг Тогачур, Хубилай, Урианхайдай жанжинуудаар удирдуулж, Их хаан биеэр цэрэг авч дайлахгүй гэж олон ноёд санал гаргахад, отгон дүү Аригбөх, түүний хүү Ёлондаш нар их хааныг энэ удаа биеэр цэрэг удирдаж явахыг шууд эсэргүүцэж байжээ /17.195/. Санал зөрөлдсөн ийм нөхцөлд Бат хааны санал ихээхэн нөлөөлсөн бололтой. Тэрбээр “биеэр цэрэг авч дайлан нэр төрөө мандуулах нь зүйтэй” /36.180/ гэсэн хариу ирүүлсэн ажээ. Энэ нь Их Хуралдай дээр Мөнх хаан “миний өвөг эцэг их үйлсийг бүтээж, нэр төрөө мөнх алдаршуулсан билээ. Би өвөг эцгийнхээ адил их үйлсийг заавал бүтээнэ. Өмнөд Сүн улс гэрээгээ эвдэж, миний элчийг баривчлан хорьж, ёс журмыг зөрчив. Иймээс цэрэг гаргаж дайлах болно” хэмээн хэлснээс тодорхой байна. Их Хуралдайгаар удаанаар маргалдан хэлэлцсэний эцэст Их хаан Мөнх биеэр цэрэг авч дайлахыг зөвшөөрсөн ажээ. Рашид-ад-Диний бичсэнээр бол Мөнх “хаан ширээнд заларсан буянт жилээс хойш зургаа дахь жилд буюу загас жилд /1255 оны хоёрдугаар сарын 10-наас гуравдугаар сарын 11/ Хятадын эзэнтэн Жукан /Жунга/-тай тэмцэх шийдвэрээ төгс гаргажээ” /49.167/. Иймээс энэ Их Хуралдай төрийн амьдралд томоохон үйл явдал түүхнээ үлдсэн бөлгөө.

Мөнх хааны үед “Сэцдийн зөвлөл” ажиллаж байсан нь түүхнээ тэмдэглэгдээгүй байна. Харин алтан ургийнхан, ихэс дээдэс, эрдэмтэн мэргэд, сайд ноёдтой уулзаж зөвлөлдөж, тэдгээрийн санаа бодлыг төрийн хэргийг шийдэхэд харгалзан үзэж байсан түүхэн баримт бишгүй байх ажгуу.

Мөнх хаан төрийн байгуулалтад өөрчлөлт хийхдээ Сэцдийн зөвлөлийг хуралдуулж Монгол улсынхаа төрийн зүтгэлтэн, алтан ургийн гишүүд, сайд ноёд, түмт, мянган захирагчид, эрдэм ухааны санал бодлыг сонсож ойлголцсон ажгуу. Чингис хааны хамгийн ахмад ач болох Бат хан өөрийн эх болон дүү нар, бичгийн сайд, зөвлөх, цэргийн жанжнуудтайгаа холбоо барьж санааг нь авах, биечлэн уулзаж зөвлөлдөх арга явуулга хийжээ. Энэ тухай академич Ч.Далай “Их Монгол улсын түүх” зохиолдоо нилээд тодорхой өгүүлсэн байдаг бөлгөө.

Мөнх хаан, ордны аппаратыг өөрчилж, шинэ чадварлаг ноёд түшмэдээр бэхжүүлэх, орон нутгийн ба эзлэгдсэн орныг захирагчдыг өөрчлөх арга хэмжээг иж бүрэн шинжтэйгээр авч хэрэгжүүлжээ. Мөнх хаан Бэрх ноёныг “гүрч” /Гүр улсын их хүн. Чингис хааны үед улсын гоо ван Мухулай энэ албан тушаалд ажиллаж байсан/-ээр, Мөнхсарыг их заргач, цэргийн хэргийг эрхэлсэн сайдаар, Аландарийг дэд сайд зөвлөхөөр томилж, Булганг их бичээч болгон, улсын бичиг хэрэг, улсын

дотоод бодлого, эдийн засгийн хэргийг хариуцуулжээ. Плано Карпини намайг Мөнх хааны ордонд бараалхах үед “хааны ордны их Чэрби гол түшмэл” /40.239/ байсан хэмээн бичсэн байдаг. Хасарын ачинцар Хонхор Тавхайгаар Хархорумын орд харш, сан хөмрөгийн асуудлыг эрхлүүлсэн байна. Кашмирын хувраг Намуг улсын багшаар өргөмжилж, шашны асуудлыг ерөнхийлөн эрхлүүлсэн болой. Мөн Ахдуч, Алагбух хоёрыг сан тахилга, эм эмнэлэгийн хэргийг эрхэлсэн түшмэлээр томилсон болой.

Мөнх хаан их гүрнээ зүүн, баруун гар хэмээсэн хоёр хэсэгт хувааж, зүүн гарын захирагчаар Дүү Хубилайг, баруун гарын захирагчаар Хулагу /зарим номд Хүлэгү гэж бичсэн байдаг/-г томилсон байна. Их гүрний зүүн гар нь Хятадаар, баруун гар нь Иранаар төвлөрч байсан ажээ. Мөнх хаан, эзлэгдсэн улс орнуудыг захирахад ихэд анхаарч, Монгол улсын хааны төлөөний сайдуудыг шинэчлэн томилж, тэдгээрийн эрх үүрэг, явуулах бодлогыг тогтоон соёрхсон байна. Аргуныг Ираныг захирах төлөөний сайдаар, Мухаммед Ялавачийг Хятадыг захирах төлөөний сайдаар, Масуд бэгийг Туркестан, Маверен нахр, Уйгур, Ферган, Хорезмыг захирах сайдаар, Али мелигийг Исфакхан ба Нашачурыг захирах сайдаар тус тус томилон ажиллуулсан болой.

Мөнх хааны ордонд хааны албаны ажил хэрэгт үйлчлэх түшмэлүүд /Чэрбүүд/ элчүүд, зайран, бэхи, хаан ба ордныг хамгаалагчид, хэлмэрч, бичээчүүд, няравууд, үйлчлэгчид ажиллаж байжээ. Ийм тушаал бүхий хүмүүс ажиллагчийг Гильом де Рубрук жуулчин аян замын тэмдэглэл “Дорно этгээдэд зорчсон минь” номондоо өгүүлсэн байдаг бөлгөө /13.162-165/. Рашид-ад-Диний “Судрын чуулган”-д дурдсанаас үзвэл өмнө нь Өгөдэй, Гүюг хаанд алба хашиж байсан Эмир Имад-аль-Мулк, Эмир, Фахр-аль-Мулкийг пайз олгогч, захиргаадах эрх бүхий хүмүүс ба худалдаачдын хоорондын зарга зальхай, маргааныг таслагч, жуулчлагч, бараа таваарыг үнэлэгч, мөнгө хураагч түшмэлээр томилжээ /49.164/. Мөнх хаан төрийн төлөөний сайд, ордны түшмэлээр хааны удмынхан, монгол ноёд, бичиг соёлын хүмүүс төдийгүй олон улс орны эрдэм номтой зүтгэлтнүүд, янз бүрийн шашин шүтдэг мөргөлтнүүд хамтран алба хааж байсан ажгуу. Мөнхийн төрийн сайд, түшмэлийн албанд Иран, Уйгур, Хятад, Монгол угсааны хүмүүс, бөөгийн мөргөл, бурхны шашин, лалын шашин, христос, несториан, саррицин шүтлэгтнүүд ажиллаж байсан нь ихээхэн онцлогтой болой. Жишээлбээс Хятадыг захирах төлөөний сайд Мухамед Ялавич Иран лалын шашинтан, төрийн сайд Булган монгол бурхны шашинтан байжээ. Мөнх хааны ордны түшмэл нестор ёсны христос шашинтан, ордны үйлчлэгч Мажор /уйгур/ хүн байсан тухай жуулчин Гильом де Рубрук замын тэмдэглэлдээ бичсэн байдаг /13.159/ бөлгөө.

Мөнх хаан орон нутгийн засаг захиргааны хуваарь, түүний удирдлагад өөрчлөлт оруулаагүй болой. Өвөг эцэг Чингисийн үеийн мянгат, зуут, аравтын тогтолцоо хэвээр байж, тэдгээрийг мянгат, зуутын ноён, аравны дарга захирч байсан аж.

Мөнх хаан хамгаалах цэрэг /хишигтэн/-тэй байхын хамт их цэргийг бэхжүүлэх, түүний удирдлагыг бэлтгэх, цэргийн жанжнуудаа тодруулах талаар нилээд арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Мөнх хаан улсын цэргийн бодлого, удирдлагыг өөртөө төвлөрүүлж, цэргийн хэргийг дагнан эрхэлсэн сайдыг ажиллуулж байсан аж.

Мөнх хааны үед улсын цэргийн тоо хэд байсан нь тодорхойгүй боловч Хятад, Иранд аян дайн хийхэд явсан Монгол цэргийн тооны тухайн мэдээлэл Рашид-ад-Диний “Судрын чуулган”-д тэмдэглэгдсэн болой. Мөнх хаан Хятадыг дайлах байлдаанд 60 мянган цэргийг өөрөө удирдаж, өөр замаар Тогучур жанжны 30 мянган цэргийг, Сүбээдэй баатарын хөвгүүн арван түмэн цэргийг удирдан явсан ажгуу /49.166/. Үүнээс үзэхүл Хятадыг /Сүн улсыг/ дайлах дайнд 140 мянгаас доошгүй цэрэг оролцсон нь тодорхой байна.

Баруун зүгт аян дайнд явсан Хулагу /Хүлэгү-үлэх/ жанжин цэргийг удирдан явсан байдаг. Үүнээс гадна Монгол нутаг, Хархорум хотоо сахин үлдсэн Тогоонтөмөр жанжин өөрийн цэрэгтэй байжээ. Эдгээр баримтууд нь Мөнх хааны үед их цэргийн тоо бага бус байсныг харуулах бөлгөө.

§3. Мөнх хааны дотоод бодлого

Мөнх хааны үед үндсэн монгол орны эдийн засаг хөгжиж, малын тоо, толгой нэмэгдэн өсчээ /17.192/. Малын тоо толгойг өсгөх, бэлчээр нутгийг усжуулах, хүн ардыг суурьшуулах, малын бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах, малын үүлдэр угсааг сайжруулах бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд багагүй анхаарал тавьсан байна. Мал сүргийн дотроос адуу, тэмээг өсгөхөд ихэд анхаарч, монгол адууг төрийн хяналтад авч, адуун сүргийн асуудлыг эрхлэх төрийн тусгай байгууллыг байгуулан ажиллуулжээ. Энэ нь тэмээн сүрэг жин тээх, нүүдэл суурьшил хийх, худалдаа арилжааны барааг тээвэрлэх, адуу нь мал сүргийг хариулах, айл өрх, хүмүүсийн уналгыг хангах, цэргийн морь уналга болгоход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байсантай холбоотой ажгуу.

Монголчууд тэмээ, үхэр, хонь, ямаа, адуу зэрэг маш их малтай. Бүхэл дэлхийд байхгүй тийм олон ачлаганы малтай байсан /13.15/ хэмээн Плано Карпини монголд аялсан замын тэмдэглэлдээ бичсэн болой. Мал аж ахуйгаа дэмжихийн хамт ан гөрөө хийх, тариа ногоо тарих, малын бүтээгдэхүүнээ үйлдвэрлэх, гар үйлдвэр, алт, мөнгө, төмрийн дархан хөгжүүлэх бодлого явуулжээ. Монгол улс эзлэгдсэн орны иргэдийн аж амьдралыг хөнгөвчлөх, улсын сан хөмрөгийг арвижуулах, өрийн дарамтыг багасгахад ч анхаарч, зарим нэг арга хэмжээ авчээ. Гильом де Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь” тэмдэглэлдээ “Монголчууд бэлчээр нутаг, уулсын дунд амьдран сууна. Тэд эрэлхэг зоригтой ... Морь шиг өтгөн сүүлтэй, нуруу хэвлий нь үс, хялгас элбэгтэй, маш их бяр чадал бүхий үхэр /сарлаг/ өсгөнө.

Үхэр нь том гэр тэргүүдийг чирнэ” /13.150/. Хүн ард нь хана, дээвэр, үүдийг эсгийгээр хулдсан гэрт сууна. Гэр нь дээрээ агаар нэвтэрч, нар тусаж, тэнгэр харагдах тооно /цонх/-той байна. Гэрүүд нь том, дунд зэрэг, жирийн гэр гэх мэтээр ялгагдана. Ямар гэртэй байх нь эзнийх нь чинээлэг ба чинээлэг бус байдлаас шалтгаална. Гэрийн олонхи нь амархан буулгаж, хурааж, ачиж, барьж болдог авсаархан байдаг ажгуу. Хаана ч нүүдэллэсэн орон гэртэйгээ, тэр ч байтугай дайн тулаанд явсан ч орон гэрээ заавал авч явдаг байжээ. Эрэгтэй нь тэр эмэгтэй нь тэр, нэг л янзаар оёсон дээл өмсөнө /13.14-15/.

Гэрийн хана, унь, тооно, багана, үүд, дээвэр, туурга болон дээл хувцсаа өөрсдөө хийнэ. Бас гэрийн доторхи авдар сав, ширдэг, шүүгээ, хөхүүр, тулам, цагаан идээ /айраг, ааруул, өрөм, тос, бяслаг гэх мэт/ малын хэрэглэгдэхүүн /эмээл, тохош, хазаар, ногт, чөдөр, ташуур, буйл, цулбуур, ховоо гэх мэт/, зэргийг айл өрх бүр өөрсдөө хийнэ. Монголчууд айргийг их хийж, өргөн хэрэглэдэг байжээ. Элч-жуулчин Гильом де Рубрук Хархорум хотод их тахилгын баяр ёслолын өдөр “Айраг ачсан 500 тэрэг, 90 морь байхыг би тоолсон билээ. Бурхны элч Петр ба Павловын баярын үеэр бас ингэсэн болой” /13.212/ гэж дурдсан байдаг нь түүхэн баримт мөн буюу. Бат хаан өргөөнийхөө орчим өдрийн газрын зайтай 30 хүн бүрэнээр 100 гүү бариулж, өөрөөр хэлбэл өдөр бүр 3000 гүүний саам авчруулан уудаг байсныг /40.111/ Плано Карпини замын тэмдэглэлдээ бичсэн байдаг бөлгөө. Мөн “Зунд нь зөвхөн айраг ууна. Айргаа ямагт гэрийн баруун талд хаалганыхаа тус газар байрлуулна ... Эрэгтэй, эмэгтэйгүй цөм тойрон сууж айргаа амтархан ууцгаана” /40.109/ гэж бичсэн нь айраг бол монголчуудын цагаан идээний хосгүй бүтээгдэхүүн, эрхэмсэг сайхан ундаа байсан ажгуу.

Мөнх хаан “дархан” хэмээн ерөнхийлөн нэрлэдэг алт, мөнгө, төмрийн дархан, уран барилгачид, орд өргөө, сүм дуган баригчид, гар урчуудыг дэмжиж, цэргийн зэвсгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ихэд ухаан зарж байсан ажгуу. Аялан жуулчдын тухайн үеийнхээ амьдрал, үзсэн харснаа дүрслэн бичиж үлдээснийг сөхвөөс арвин баримт буй бөлгөө. Хархорумд олон үндэстэн, ястан, хэлтэн янз бүрийн хүмүүс олзлогдон ирж, ажиллаж амьдарч, Их Монгол улсад хүчин зүтгэж, тэднийг төрөөс халамжлан үзэж байсан нь анхаарал татахуй. Мажараас олзлогдсон Лотаринг мужийн /францын нэгэн муж/ Метца хотын Пакета эмэгтэй, түүний нөхөр байшин баригч орос барилгачин, Парис хотын Вильгельм, нэрт алтны дархан Бушье, Английн Базиль ажиллаж байжээ. Парисын Вильгельм Бушье хааны ордны үүдэнд мөнгөн мод урлан бүтээсэн ажгуу.

Энэ нь бусад модноос хамгийн түрүүн гөлөглөдөг, бургас маягийн гоёмсог мод агаад тахилгын ёсонд хүндэтгэн тахидаг байжээ.

Түүний дөрвөн цоргоос нь дарс, айраг, шар айраг, балын ундаа гоожин урсах бөгөөд модны бүх навч, мөчир, жимсийг цөмийг нь мөнгөөр хийсэн нь ховор урлал, алт, мөнгөн дарханы дээд бүтээлийн илэрхийлэл байсан болой.

Мөнх хааны үед цэргийн зэвсгийн үйлдвэрүүд ажиллаж байжээ. Хэлэгү /Хулагу/ баруун зүг дайлаар явахынхаа өмнө 1500 гаруй Хятад дархчуудыг ажиллуулан, цэргийн зэвсэг хийлгэсэн /36.182/, Хархорумд дархны газар ажиллаж байсан баримт түүхнээ тэмдэглэгдсэн байдаг.

Эзлэгдсэн орнуудаас олзолсон гар урчуудыг Хархорумд ажиллуулж орд өргөө, сүм дуган бариулж, алт мөнгөн эдлэл, цэргийн зэр зэвсэг хийлгүүлж, жимс ногоо тариулж, зарц шивэгчнээр ажиллуулж байжээ.

Мөнх хаан дотоод бодлогодоо худалдаа арилжааг хөхүүлэн дэмжих, худалдааны үйл ажиллагаан дахь дутагдал, зөрчлийг арилгах, худалдааг ард иргэдийн амьдралыг сайжруулахад чиглүүлэхэд анхаарлаа хандуулж байсан аж. Мөнх хаан дэлхийн аль ч улс оронтой худалдаа хийх, улсуудын хооронд ба хүмүүсийн хооронд худалдаа арилжааг өрнүүлэх, Монгол улсын нүүдэлчин ард түмэнд өргөн худалдаа арилжаа хийх бололцоо олгох, Монгол оронд гадаадын худалдаачид чөлөөтэй зорчих, бололцоог бүрдүүлэхэд их анхаарал тавьж байсан бөлгөө. Мөнх хаан, худалдааны хүмүүс, өртөө улаа, унаа хөсөг, уургын улааг өөрийн дураар хэрэглэж байсныг хориглон зогсоож, хуульчилсан нь шударга ёсыг тогтоосон хэрэг байв. Чингэхдээ Мөнх хаан худалдаачдын гарт байж байгаад хүчингүй болсон тэмдэгтийн үнийг улсын сангаас төлөхөөр тогтоосон нь хэдэн зуун мянган алт, мөнгөн зоос болсон ажгуу. Энэ нь худалдааны ажлыг улсын хэмжээнд саатуулалгүй явуулах хэвийн нөхцлийг хангасан болой. Худалдаа арилжааг чөлөөтэй болгон явуулах болсон нь худалдаачид өөрт буй бүх бололцоог дайчлан ашиглах, ашиг орлогоо хуримтлуулах, эрхээ чөлөөтэй эдлэх бололцоог бүрдүүлсэн их ач холбогдолтой байжээ.

Мөнх хааны явуулсан дотоод бодлогод алба татварын асуудал жинтэй байр суурь эзэлж байсан ажгуу. Албан татварт дур зоргоороо хандах, шударга бус пайз тараах, алба татах тэмдэгт олгохыг таслан зогсоож, эзлэгдсэн оронд зөвхөн эзэн хааны төлөөний сайдын зөвшөөрөлтэйгээр алба татвар төлөх хатуу журмыг тогтоожээ. Өөр ямар ч албан тушаалтнаас алба татвар тогтоохыг чандлан хориглосон байна.

Мөнх хаан Монгол улсын хязгаарын дотор алба татвар төлөх журмыг цэгцэлж, шинэ журам тогтоосон бөлгөө. Тухайлбал, эзлэгдсэн орны муж, хязгаарын эрх баригчдаас алба татах эрхийн пайз олгох, дур зоргоор зарлиг гаргахыг хатуу хориглосон байна /8.269/. Жинхэнэ монгол нутаг ба бусад нүүдлийн мал аж ахуйт орны 100 мал тутмаас жил бүр нэгэн толгой мал татах, 100 хүрэхгүй малтай айлыг алба өгөхөөс хэлтрүүлж, урьдын албаны дутууг нөхүүлэн төлүүлэхийг хэрэгсэхгүй болгох зарлиг

гарган мөрдүүлжээ /80.142/. Мөнх хаан Хятад, Туркестаны нутагт жил бүр баян хүнээс 10, ядуу хүнээс 1 алтан зоос, Хоросанд баян хүнээс 7 алтан зоос, ядуу хүнээс 1 алтан зоосыг татаж байх хууль гаргахын хамт 100 хүрэхгүй малтай айлыг алба төлөхөөс хэлтрүүлж, улмаар урьдын албаны дутууг нөхүүлэн төлөхийг хэрэгсэхгүй болгосон /81.142/ нь албан татварын бодлогод эргэлт гаргасан үйл явдал хэмээн үзэхээс өөр аргагүй буй зээ. Энэ тухай академич Ч.Далай “энэ нь монгол орныхоо хүн ардын амьдралыг өөд татаж, ядуу амьдралтай малчин ардыг малтай хогшилтой болгох гэсэн арга хэмжээ мөн юм” /17.191/ гэсэн нь түүний судалгааны их ажлын нэгэн том цацал мөн болой. Монгол улсын их хаан Мөнх алба татвар хураагчдаас элдэв заль хэрэглэж, хээл хахууль авах зэргийг цаазлан хориглосон /81.140/ нь түүний төрийг эрүүлжүүлэх гэсэн бодлогын илэрхийлэл мөн юм. Энэ нь “Хатуу ширүүнээр мөрдөн нэхэмжилж, өнгөрсөн өрийн төлөө битгий маргалд учир нь бид улсын санг нэмэгдүүлэх гэсэн биш, харъяат нарын аж байдлыг хөнгөвчлөх гэсэн нь буй” /17.142/ хэмээсэн Мөнх хааны бодлогын утга учир байсан буй зээ. Тэр үеийн төрийн мэргэн зүтгэлтэн, төрийн сайд, их сэтгэгч Рашид-ад-Дины энд өгүүлснийг мэргэн оюундаа тунгаахад нэг их алдахгүй буюу хэмээн бодном. Мөнх хаан өөрийн цаг үедээ монголд эзлэгдсэн ард иргэдийн амьдрал маш хүнд, татварын дарамтад бүрэн автагдсан, монголын ноёрхогчид хэт дураараа аашилж татвараар дарангуйлсныг ийнхүү мэдэрсэн нь Монгол улсын их хааны нэгэн чухал шинж байсан бизээ.

Үүний зэрэгцээгээр Монгол улсын ихэс дээдэс, жирийн иргэд худалдаа арилжааг өөрсдийн амьдралын хэвийн нөхцлийн маш чухал хэсэг гэдгийг ухамсарлан ойлгож, түүний төлөө сэтгэл оюун, хүч чадлаа зориулж байсныг мартажгүй нь хэрэгтэй болов уу. Улсын иргэд үүний төлөө тэмцдэг нь төрийн алтан бодлогын амин сүнс байдгийг мартаж хэрэггүй гэдгийг түүх өөрөө гэрчилдэг бөлгөө.

Мөнх хааны үед ард олон өөрсдийнхөө амьдралын төлөө амиа хайрлахгүй тэмцэж байсан нь албан татвараас улбаатай болохыг Мөнх хаан ойлгон мэдэрч байсан нь төрийн зүтгэлтэн, улсын их хааны алтан мэдрэмжтэй холбоотой байсныг хэлэхэд болохгүй нь юун бөлгөө. Үүний хамт Мөнх хаан улсын албан татвар улсын онцгой давхарга, цөөн бүлэг хүмүүст үйлчилж, монгол улсын болон эзлэгдсэн орны ард түмэнд их хохирол учруулж, ард түмний аж амьдралыг доройтуулж байсныг мэдэрч, алба татварын тогтолцоонд өөрчлөлт, шинэчлэлт хийсэн нь түүний гавьяат үйлс мөн болой.

Мөнх хааны шашны талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа уламжлалт шинжтэй байсан бөлгөө. Мөнх өөрөө бөөгийн мөргөлтөн байсан ч гэсэн бүх шашинд хандахдаа адил тэгш байх зарчмыг хэлбэрэлтгүй баримталж байсан ажгуу. Тэрээр өөрөө бөө мөргөлийг шүтэж “бөө удган бэлгэдэх, төлөгдөх ёсыг даанч итгэдэг” /Юан улсын судар 3-р бүлэг/ байсан ч гэсэн бүх шашныг хүндэтгэн, адил тэгшээр хандаж

байсан бөлгөө. Тэр үед Монголын нийслэл Хархорумд загалмайтны, лалын, буддын зэрэг олон шашин дэлгэрч, түүнийг Мөнх хаан дэмжиж байсан ажээ. “Мөнх хаан тэдний аль нэгийг алагчлахгүй, цөмийг нэгэн адил дэмжин итгэл үзүүлж байжээ” /17.192/. Мөнх хаан бурханы, лалын, христосын шашныг адил түвшинд тавьж дэмжиж байсан нь түүний шашны талаар баримталж байсан бодлогын цөм байсан болой.

Монгол улсын нийслэл Хархорум хотод буддын шашинтан, лалын шашинтан, христосын шашинтан, бөөгийн шашинтан, протестаны шашинтан амьдарч, өөр өөрсдийн сүм дуганаа барин, өргөл номоо уншиж байсныг Мөнх хаан ойлгож, тэдэнд адил тэгш хандах бодлого баримталж байсан нь Мөнх хааны төрийн бодлогын салшгүй хэсэг болж байсан нь лавтай. Энэ тухай Рашид-ад-Диний Судрын чуулган, Монголын түүхийн тулгуур зохиолууд болон Мөнх хааны үед монголд ирсэн жуулчдын замын тэмдэглэлд тодорхой өгүүлсэн бөгөөд үүнийг улам лавшруулан судлах шаардлагатай бөлгөө.

Түүхийн баримтыг түшвээс христосын нэгэн сүмийн үйл ажиллагаа, бурханы шашны зүтгэлтэн сүм хийд, ёс ёслол, сүсэг бишрэлийн тухай, тэдгээрийн сүм хийд, мөргөлийн үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй бичиж үлдээсэн нь түүхэн чухал баримт мөн болно. Юан улсын сударт Мөнх хааны тухай өгүүлэхдээ, Хархорумд загалмайтны, лалын, буддын шашинтны нэлээд хэдэн сүм хийд, олон лам нар байдаг тухай өгүүлсэн байдаг. Мөнх хаан “эдгээр шашныг алагчлахгүй, цөмийг нь нэгэн адил дэмжин, цөмд нь итгэн бишрэл үзүүлж байжээ” /17.192/. Аль ч шашныг дэмжиж, тэдгээртэй адил тэгш харилцаж, дэмжиж байсан нь Чингис хааны төрийн бодлогын алтан уламжлалыг өвлөн авч, ажил хэрэг дээр нь биелүүлж байсны нотолгоо мөн ажгуу.

§4. Мөнхийн гадаад бодлого, гадаад харилцаа

Мөнх хаан өвөг эцэг Чингис, авга ах Өгөдэй, Гүюг нарын гадаад бодлогыг үргэлжүүлж, Их Монгол улсын нэр хүндийг өргөх, их гүрний газар нутгийг өргөтгөх, улсынхаа бие даасан байдал, бүрэн эрхт байдлыг ханган хамгаалахад гадаад бодлогоо чиглүүлсэн ажгуу. Алтан ургийн өмнөх хаадын явуулж байсан Хятадын өмнөт Сүн улсыг байлдан дагуулах, баруун зүгт өөрийн ноёрхлыг бүрэн тогтоож, түүнийг эсэргүүцэгчдийг дарах, гадаад улс орнуудтой харилцаа холбоогоо бэхжүүлэх нь Мөнх хааны төрийн бодлогын төвд байсан болой.

Мөнх хаан 1252 онд өөрийн дүү Хубилайд их цэрэг удирдуулан явуулж 1254 оны эхээр Өмнөд Хятадыг Дали-Юньнань-ыг байлдан дагуулж, улмаар Өмнөд Хятадын нутгаар байлдааны ажиллагааг үргэлжлүүлсэн байна. Энэ дайны ялалт том үйл явдал болж, Юньнань Хятадын бүрэлдэхүүнд бүрмөсөн багтан орж, бүх Хятадыг байлдан дагуулах үүдийг нээжээ. 1256 онд Монгол улсын Их Хуралдай чуулж, Хятад улсад байлдааны үйл ажиллагааг явуулах эсэх тухай асуудлыг хэлэлцүүлжээ.

Хятадыг байлдан эзлэх бодлого их Чингис хааны гэрээс учир заавал биелүүлэх ёстой гэсэн нэрийн дор авч үзэж, Хуралдайд оролцогсод их ширүүнээр маргалдан хэлэлцжээ. Их Хуралдай Хятадад аян дайн хийж, түүнийг Мөнх хаан биеэр удирдах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргажээ. Чингисийн ач нарын ахмад нь болох Бат хаан Мөнх хаан өөрийн биеэр дайныг удирдах нь зүйтэй бөгөөд энэ нь өвөг эцэг Чингисээс уламжилсан эрхэм хүндэт нэр төр, алдар гавъяа байгуулах нэн гол бололцоо мөн гэж үзсэн байна. Их Хуралдайд оролцсон Ихирэс аймгийн дархан, Чингис хааны хүргэн “Нанхиад улс бидэнд ойрхон, тэгээд биднийг дайсагнаж байдаг. Бид яагаад үүнийг анхаардаггүй аажуурсаар байдаг билээ”/49.165/ хэмээхүйд Мөнх хаан “Манай ихэс ахас, урьдын эзэнтнүүд тус бүр л ямар нэгэн үйлдэл үйлдэж, ямар нэгэн улс муж эзлэн, хүмүүсийн дунд нэрээ тодруулж чадаж байсан билээ. Би ч бас Нанхиадад очихын тулд дайлаар мордоно” /49.165/ гэсэн шийдвэр гаргажээ. Үүнийг хан хөвгүүд ярилцаад “Бид нэгэнт үгээ төгс хэлсэн болохоор түүнийг эсэргүүцэх бодол байхгүй бөгөөд ийнхүү эсэргүүцвэл буруу явдал болох билээ”/49.165/ хэмээн айлдацгаажээ. Их Хуралдай, эзэн хааны цэрэг, морьдоо сонгон, илд зэвсгээ үйлдэж, усан завь хийлгэн, газарчнаа олж, хүнс тэжээлээ базаан Сүн улстай хэрхэн байлдахыг ноёд жанжнаараа судлуулж сэтгэл санаагаа шулуутгасан ажгуу.

Ийм нүсэр бэлтгэл хийсний дараа төрийн туг, сүлд, догшин хар тугаа тахиж, аян дайнд явахад бэлэн болжээ. Мөнх хаан Хархорумын ордны толгойлогчоор дүү Аригбөхийг томилон, хамгаалах цэргийн хамт үлдээгээд 1257 оны өвөл Хархорумаас хөдөлсөн бөлгөө /36.180-181/. Байлдааны үйл ажиллагааг, тухайлбаас баруун замын цэргийг удирдан Мөнх хааныг дагалдан Хадан, Тутугай, Мөгэ, Асудай, зүүн замын их цэргийг удирдсан Тогучар³⁰ жанжныг дагалдан Есүигэ, Хурц, Бужгар, Мөнх, Цагаан жанжнууд, Хятад цэргийг удирдан Ван Анго, Ху Цзинь, Тянь Богжун, Сун Янь жанжнууд толгойлон эхлүүлж байлдан тулалдсан ажээ. Мөнх хааны толгойлсон Их цэрэг өмнөд Сүн улсын гол нутаг Шу-г довтолж тэндхийн 20 гаруй боомт хотыг, тухайлбал хамгийн том бэхлэлт хот Чэндэ Фу, Чунцин Фу, Куйгжоу боомт хотыг эзлэн авчээ. Гэвч Монголын цэрэг асар их эсэргүүцэл, эх нутгаа хамгаалах гэсэн Хятадын иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч их хэмжээний хохирол амссан болой.

1259 оны эхээр Мөнх хаан Хятадын Сычуаны нутагт цэргийн жанжинуудын зөвлөгөөн хийлгэж, Хятадад хийсэн аян байлдааны явц, үр дүнг хэлэлцүүлсэн ажгуу. Байлдааны явц, үр дүн Хятадын ард түмний эсэргүүцэл, тэмцлийн талаар нухацтай хэлэлцсэн эл зөвлөгөөнөөс өмнөд Хятадад байлдааны үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах шийдвэр гаргажээ. Байлдаан цаашид үргэлжилсэн ч Мөнх хааны бие муудан, өвчин нь хүндэрсэнээс 1259 оны 8-р сард нас барсан учир Хятад дахь байлдааны ажиллагаа завсарласан ажгуу.

Мөнх хаанаас баруун зүгт хийсэн байлдаан Хулагу/Хүлэгү/ их жанжны удирдлагаар явагдаж ихээхэн амжилт олжээ. Энэ дайн Чингис хаан, түүнийг залгамжлагчдаас баруун зүгт хийсэн гурав дахь их дайн байсан ажгуу. Хүлэгүгийн удирдсан Монгол цэрэг Ираны сүүлчийн гал голомт болж байсан Исмайлитын улсыг эзэлж, монголчуудын ноёрхлыг нутаг дахь үр ач нар, Иран /Перс/-ны захирагч Аргун ноёны дэмжлэгийг авч, Ираныг дайлан цааш давшсаар Ирак, Багдадыг эзлэн, Египет, Сирид цөмрөн орж байлджээ. Үүгээр Монгол цэрэг Арабын улс орныг шатлан дайлах дайнаа дуусгаж, Их Монгол улсын сүүлчийн хаан Мөнхийн зарлигийг биелүүлсэн ажгуу.

Мөнх хааны аян байлдаанаар Монгол эзэнт гүрний /Их Монгол улсын/ газар нутаг ихээхэн өргөжиж, умард, өмнөд Хятад, Орос, Дундад Ази, Иран, баруун Ирак, Сири улс хүртэлх Ази, Европын өргөн уудам нутгийг хамарсан хүчирхэг улс болсон бөлгөө.

Мөнх хаан гадаад харилцаандаа Монгол гүрэн, түүний хааныг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, аугаа энэ их улсад захирагдаж байхыг шаардаж, харьцангуй нээлттэй бодлого баримталж байсан ажгуу.

Өрнө, дорнын улс орнуудтай харилцаж, тэдгээрийн элч төлөөлөгчдийг чөлөөтэй хүлээн авч, улс орноо танилцуулж байсан ажээ. Гильом де Рубрук Францын IX Людовик хааны элчээр Монголд ирж Мөнх хаантай уулзаж, түүний захиаг гардуулж байсан түүхтэй. Тэрээр 1253 оны 5-р сард Константинополиос монгол руу мордож 1253 оны 12-р сард Хархорумд ирж Мөнх хаантай уулзан, улмаар түүний ивгээлээр 6 сар гаруй хугацаагаар монголд байж монголчуудын амьдралтай танилцсан бөлгөө. Мөнх хаан элчээр дамжуулан Ромын пап, Францын IX Людовик хаантай харилцаж байсан ажгуу.

Мөнх хаан ба түүний төлөөлөгчид Багдадын хааны элч, Туркийн Султаны элч, Энэтхэгийн нэгэн султаны элч, Иерусалимын элч, Армяны элч нартай уулзаж, улс орныхоо бодлого, аж байдлыг танилцуулж, мөн Мөнх хааны элч нар Ромын пап, Францын хаан IX Людовик, Армяны хаан, Никейн хаан, Вестаци нарт элч илгээж, захидал бичиг хүргүүлж байсан нь түүхнээ тэмдэглэгдэн үлдсэн байдаг /13.211-219/.

Мөнх хаан олон улс, үндэстний зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг төрийн түшмэд, багш төлөөний сайдаар ажиллуулж байсан аж. Жишээлбээс Ираны Мухамед Ялавич Хятадад төлөөний сайдаар, Уйгур гаралтай Аргун Иранд төлөөний сайдаар, Кашмарын хуврага Наму төрийн багшаар, Эмир Имад аль-Мулк хааны пайз олгогч түшмэлээр ажиллаж байсан болой. Мөн эзлэгдсэн улс орнуудын захиргаанд тэр улс үндэстнийх нь нөлөө бүхий хүмүүсийг түшмэд, зөвлөхүүдээр ажиллуулж байсан ажгуу. Ираны алдарт эрдэмтэн Ифтихар-ад-Дин Хархорумд уригдан ирж Мөнхөд эрдэм ном зааж сургасан бөгөөд тэрээр энэ багшийнхаа ачаар тооны ухаан, геометрийн өргөн мэдлэг олж авсан байдаг бөлгөө /17.214/. Ираны эзэн Хулуга эл орны лалын нэрд гарсан тэнгэрийн зурхайч Насир-ад-Дин Түчтэй хамт ажиллаж байжээ.

Мөнх хаан гадаад харилцаандаа гадаад худалдаа, арилжааг өргөтгөх, эзлэгдсэн орнуудтай өргөн худалдаа хийх, эрдэмтэн мэргэд, дархчууд, гар урчууд, янз бүрийн шашинтан, тэдний төлөөлөгчид, аялан жуулчдыг аль болохоор татан оролцуулах, тэднээр дамжуулан эзэнт улс, аж ахуй, соёл, зан заншлаа сурталчлахад багагүй анхаарал тавьж байжээ. Эзлэгдсэн улс орнуудаас алба, татвар авахын зэрэгцээгээр худалдаа арилжааны шугамаар хүнсний өргөн бүтээгдэхүүн, тухайлбал чихэр, жимс, дарс, цай, гурил, будаа, бөс бараа, гэр ахуйн сав суулга, гоёл чимэглэлийн зүйлсийг монголд өргөнөөр оруулж ирж байсан аж. Янз бүрийн улс орон, жишээлбээс Перс, Турк, Армян, Гурж, Орос, Хятад худалдаачид, гар урчууд, уран дархчид, олон төрлийн шашинтнууд монголд амьдарч, ажиллаж байсан аж.

§5. Мөнхийн хаанчлалын үеийн Их Монгол улсын эрх зүй

Монголын нэгдсэн улс, үүнээс өргөжин тэлсэн Их Монгол улсад Чингис хааны үүсгэн бий болгосон үндэсний эрх зүйн тогтолцоо улам гүнзгийрэн хөгжсөн аж. Мөнх хааны үеийн Их Монгол улсад эрх зүйн хэд хэдэн төрлийн эх сурвалж үйлчилж байжээ. Тухайлбал а) Их засаг хууль, б) Мөнх хааны тогтоосон хууль, зарлиг, төрийн сайд, түмт, мянгатын ноёдын гаргасан шийдвэрүүд, в) Эзлэгдсэн оронд мөрдөж байсан хууль, зарлиг, шийдвэрүүд, г) Шашны хэм хэмжээ, д) Заншлын эрхийн хэм хэмжээнүүд үйлчилж байжээ. Монгол улсад монгол эх сурвалжууд ба заншлын хэм хэмжээнүүд, эзлэгдсэн улс орнуудад “Их засаг ” ба тухайн орны актууд, лалын шашинт орнуудад өөрийн нь хууль цааз ба лалын шашны судар, хэм хэмжээнүүд голлон үйлчилж байсан ажээ. Үүнээс Их Монгол улсын хэмжээнд үйлчилж байсан эрх зүйн эх сурвалж, шинж чанар, агуулгыг авч үзмүй.

Мөнх Их Монгол улсын хаан болоод Чингис хааны баталсан Их засаг хуулийг өөрийнхөө өмнөх хаадын уламжлалыг даган ёсчлон биелүүлж байжээ. Их засаг хуулийг “намайг залгамжлагчдын үед ч нарийн чанад сахин биелүүлж байхыг” зарлигласан эзэн Чингисийн зарлиг Мөнх хааны үед ч хатуу мөрдөгдөж байсан ажгуу.

Мөнхийг их хаанд өргөмжлөх үеэр Чингисийн хамгийн ахмад ач Зүчийн ууган хүү Бат хаан “Яс зас хуулийг зөрчсөн хэн боловч толгойгүй болно” /49.149/ хэмээн зарлиг буулгасан нь Мөнх хаан “Их засаг ”-ийг чандлан биелүүлэхээс өөр аргагүй бөгөөд ингэж ч сахиж байсан нь тодорхой байна. Өгөдэй хаан Мөнхийг “номын ухаантайгаас гадна цэрэг, захиргааны хатуу бодлоготой хүн болгон” /36.175/ төлөвшүүлсэн нь Мөнх хаанаас “Их засаг ”-ийг сахин биелүүлэхэд нөлөөлсөн болов уу.

Мөнх хааны гаргасан зарлигууд, тухайлбал баруун, зүүн түмт байгуулж, түүний эрх үүрэг, харъяалах газар нутаг, хүн ам, захирах ноёныг томилсон тухай зарлиг, улсын ван, улсын заргач, төрийн бичгийн сайд, улсын багш, цэргийн жанжин, муж

захирагч ноёд, бусад олон янзын түшмэдийг томилж, тэдгээрийн гүйцэтгэх үүргийг заасан зарлигууд нь Их Монгол улсын төрийн зохион байгуулалтыг төвхнүүлэн бэхжүүлэх, төрийн түшмэдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, үйл ажиллагааных нь үр дүнг сайжруулахад чиглэгдсэн ажээ. Энэ ч хэмжээгээр төрийн үйл ажиллагаа нь идэвхижсэн ажгуу.

Мөнх хаан хууль ёсны зөрчил гажуудлыг арилгах, хууль цааз биелүүлэх үйл ажиллагааг чангатгах бодлого явуулж, зарим тодорхой арга хэмжээнүүд авсан аж. Мөнх хаан “Их засаг”, Чингисийн гэрээсийг зөрчиж, алтан ургийнхныг эв нэгдэлгүй бутаргах явуулга хийж, хуйвалдаан, урвалт үйлдсэн ноёд, язгууртнуудад “илдэн шийтгэл ноогдуултугай” /49.155/ гэсэн зарлиг буулгаж, 70 гаруй ноёд, түшмэдийг ялласан байдаг.

Мөнх хаан энэ арга хэмжээнд Өгөдэй, Цагаадайн талынхан болон их төрийн туршлагатай, эрдэм мэдлэгтэй олон сайд түшмэдүүд хамрагдсан байдаг билээ. Их түшмэл Илжигэдэй, Цагаадайн хүү Есөнмөнх, Бури жанжин, Хадаг ноён зэрэг хүмүүс цаазлагдаж, бичгийн сайд Чингай, Гүюг хааны хүү Хурц зэрэг алдар цуут ноёд язгууртнууд хатуу шийтгүүлсэн нь их л харамсалтай байсан ажгуу.

Мөнх хаан төрийн албан хэрэг хөтлөлт, хадгалалт, хамгаалалтыг журам, цэгцтэй болгож, үүнийг хариуцсан төрийн түшмэлээр Булган ноёныг томилон зарлиг, айлдлыг бичиж, хувилж байх /49.164/-ыг хариуцуулсан байна. Мөн Мөнхсар ноёныг улсын заргач /шүүгч/ болгон хэрэг маргалдаан, зарга зайлхааг шударгаар шүүж шалгах /49.164/ үүрэг ноогдуулж, шударга ёсны үндсийг бэхжүүлэхийг зарлиглан даалгасан ажээ.

Мөнх хаан худалдааны үйл ажиллагаа, ард олонд ногдуулах алба, татварын оноолт, хураалтад хууль ёс ихэд зөрчигдөн, асар их дарамт учруулж, аж амьдралыг доройтуулж байсныг зогсоох тухай зарлиг гаргаж зохион байгуулалт, хууль зүйн нилээд тодорхой арга хэмжээ авсан байдаг бөлгөө.

Мөнх хаан энэ талаар нилээд олон зарлиг гаргажээ.

Мөнх хаан Гүюг хааныг нас барснаас хойш “хан хөвгүүд, охид тоогүйгээр пайз зарлиг олгосныг хүчингүй болгож, ... Чингис хаан, Өгөдэй хаан, Гүюг хаан, хан хөвгүүдээс авсан бүгдийг хурааж авах” /49.161/ тухай, хан хөвгүүдийн хааны төлөөний хүнээс зөвшөөрөл авалгүйгээр хошууны ажилтай холбоо бүхий тушаал бичихгүй, өгөхгүй байх, их элчүүд нь арван дөрвөөс илүү унаа хэрэглэхгүй байх, нэг өртөөнөөс нөгөө өртөө хүртэл явж байх замдаа хүн амаас морь үл дайчлах, худалдаачид үйл ажиллагаандаа өртөөний улаа хэрэглэхээс татгалзах, татвар хураагчид, бичигчид нь тал тохой татаж, хээл хахууль авдаггүй байх, зуун толгойгоос доош малтай малчид татвар үл төлөх, хаана ч, хэнээс ч болов төлөгдөөгүй дутуу үлдсэнийг хүн амаас гаргуулан авахгүй байх, бүх улсууд дахь хоригдлууд саатуулагчид нарыг суллах, ямар нэгэн газар орны хүмүүст холбогдох зарлиг, шийдвэрийг тэр улс орных нь

хэл ба бичгээр гаргаж байх тухай зарлигуудыг тус тус батлан гаргаж хэрэгжүүлж байжээ /49.161-164/. Мөнх хаан мөн зөрчил, хэрэг гаргагсдын ажил үйлсийн тухай эзэнтний ариун сонорт яаралтай хүргэж бай гэсэн зарлиг гаргажээ. Тэгээд Мөнх хаан зарлигийг хүн ардад хүргэх, зөрчил, хохирлыг газар дээр нь засаж залруулах үүрэгтэй элч төлөөлөгчдийг бүх муж орон нутагт томилон явуулж гүйцэтгүүлсэн байна. Түмт, муж захирагчид ч хүн ам, мал хөрөнгийн тооллого явуулах, пайз бичгийг хураах, зарим өрийг хүчингүй болгох, төрөөс тогтоосон хүмүүс өртөөгөөр зорчих, өртөөгөөр явагсад нь төрийн нэрлэн заасан албан тушаалтнаас авсан пайз бичигтэй явах, заасан хэмжээнд орон байр уналга, хоол хүнс, улаач нарыг хэрэглэх, тогтоосон хэмжээнээс илүү зардал гаргахгүй, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байхаар тогтоосон нь бүгд тогтоосон, журамласан шинжтэй байжээ.

Хаанаас алба, татварын талаар хууль, зарлиг гаргасан нь чухал үр дүн үзүүлсэн аж. Алба, татварын хэмжээг хөрөнгө чинээний байдалд /баян хүн, ядуу хүн/ нийцүүлэн тогтоох, суурьшмал иргэдаас алба татварыг зоосоор /динарь/, малчин өрхөөс малаар авахаар тогтоосон бөлгөө. Мөн Иран, Туркстан, Хятад орон, бас мужуудад ч ялгавартай байхаар тогтоогоод алба татвар хураагчид элдэв заль мэх хэрэглэх, хээл хахууль авахыг хориглосон байна.

Мөнх хаан худалдаа арилжааны талаар зарлиг гаргаж түүндээ худалдааг хөхүүлэн дэмжихийн хамт түүнийг өртөөний үйл ажиллагаатай хутгахгүйг чухалчилж байсан ажээ. Худалдаа арилжааны үйл ажиллагааг зөвхөн худалдаачид эрхлэн явуулж, үүндээ өртөө, уургын улааг дур мэдэн ашиглахыг шууд цаазлан хоригложээ. Худалдааг чөлөөтэй, ашигтай, хэвийн явуулах, гадаадын худалдаачид Монгол оронд өргөнөөр ирэх нөхцлийг бүрдүүлэх, худалдаачид бүх зорчих зардлыг өөрсдөө хариуцаж байхаар тогтоосон нь худалдааны тухай зарлигийн гол агуулга байсан байна.

Эдгээрээс үзэхүл Мөнх хааны худалдаа, алба, татвар, өртөөний талаархи хууль, зарлиг нь аж ахуй, сан хөмрөгийн эрх зүйн эх сурвалж, эрх зүйн шинж чанар, агуулгын салшгүй хэсэг болох нь тодорхой болой.

Дээрхи чиглэлээр гаргасан цаазын бүтэц агуулга, хэлбэр, хэмжээний тухай Мөнх хааны төрийн дотоод бодлогод тодорхой өгүүлсэн учир тэндээс уншин тунгааж болохыг болгоон ажаамуй.

Мөнх хааны үеийн төрийн бүтэц, зохион байгуулалт, түшмэдийн ёс, дотоод бодлого, аж ахуйн шинжтэй хууль, зарлиг, тэдгээрийн агуулга товчдоо ийм байна.

Мөнх хааны үеийн эрх зүйн агуулгад Монголчуудын эрхлэх аж ахуй, зан заншил, гэр бүл, удам угсаа, эд хөрөнгө, өв залгамжлалын талаархи хэм хэмжээ томоохон байр эзэлж байсан ажгуу. Энэ чиглэлээр Мөнх хаан хуульчилсан акт бага гаргасан бөгөөд харин заншлын хэм хэмжээ, түүний уламжлал нэлээд өргөн хэрэглэгдэж байсан онцлогтой болой.

Мал аж ахуй эрхлэх нь монголчуудын амьдралын үндэс болохоор мал маллах, малтай харьцах, малын бүтээгдэхүүн хийх, ашиглах, мал сүргийг хамгаалах малын түүхий эдийг ашиглахтай холбогдсон олон төрөл зүйлийн заншлын хэм хэмжээ үйлчилж байсан ажээ. Мал маллаж байгаа өрх иргэд, хүмүүс малаа заавал өөрсдийн тамгаар тамгалж, улмаар тэрхүү тамга нь малаа бэлчээрлүүлэх, мал нийлбэл, бас сураггүй болбол түүнийг олох, эзэнд нь өгөх үндэслэл болно.

Монгол эмэгтэйчүүдийн хийх ажил гэвэл тэрэг хөтлөх, гэрийг тэрэгнээс буулгах буюу ачих, үнээ саах, тос хайлах, хурууд хийх, арьс нэхийгээр оёдол хийх ба нэхий дээлийг шөрмөсөн утсаар оёно. Бас оймс, гутал, дээл хувцас оёно. Мөн эсгий хийж, эсгийгээр гэрээ бүрнэ. Эрэгтэйчүүд нь нум сум, дөрөө, хазаар, эмээл хийх ба гэрийн мод, тэрэг тэргүүтнийг хийхээс гадна адуу манаж, гүү саах, хөхүүр хийж айраг эсгэх, тэмээ хариулах, ачих зэрэг ажил хийнэ. Хонь ямааг хариулах, саах ажлыг эрэгтэй эмэгтэйгүй хамтран хийнэ, нэхий элдэнэ гэх зэргээр ажил үүрэгтэй байсныг тэр үед Монголд ирж байсан жуулчид тэмдэглэсэн нь олонтоо тааралддаг /29.91/ болой.

Мал, мах, малын түүхий эдийг биет байдлаар нь солилцох, хоорондоо арилжаалах, бие биедээ зээлдэх, зээлсэн зүйлээ эгүүлж өгөх, худалдаачдаас бөс бараа, эд агуурс, сав суулга, гоёл чимэглэлийн зүйл худалдан авах зэрэгт харилцан тохиролцох, өмнө нь баримталж байсан заншлын хэм хэмжээг сахин мөрдөж байсан аж.

Гэрлэлт, гэр бүлийн харилцаанд заншлын хэм хэмжээг даган сахиж байсан байна. Эрэгтэй хүн эхнэр болох хүнээ худалдан авна. Хоёр үеийн цусан төрөлтөн хоорондоо гэрлэн суухыг цээрлэдэг. Бас эрэгтэй хүн угсаа ижил биш эхийн эгч, дүү нартай ураглаж болно. Түүнчлэн хүү нь өөрийн төрсөн эхээс бусад эцгийнхээ үлдээсэн эхнэрүүдтэй сууж тэднийг асарч тэжээх үүрэгтэй байжээ /29.115-116/. Иргэдийн хоорондын харилцаанд хэрүүл, зарга хийж 2 хүний хооронд дундуур нь орох, нэг нэгнийгээ алах, хулгай хийх, худал хэлэх, бусдын эхнэртэй явах, илбэдэх, өвчилсөн хүн дээр орох мэтийг хориглосон зан үйл мөрдөгдөж байсныг /29.117/ Гильом де Рубрук бичсэнийг болгоох нь зүйтэй буй зээ.

Мөнх хааны төрийн ял шийтгэлийн бодлого эл үеийн гэмт хэрэг, түүнийг илрүүлэх, шалган байцаах, гэмт этгээдэд ял шийтгэл оногдуулах, үүнээ эдлүүлэх ажиллагаанд илрэлээ олж, эрх зүйн хэм хэмжээгээр тодорхой заагдсан байжээ. Үймээн самуун гаргах, хааны зарлиг тушаалд үл захирагдах, пайз, бичгийг дур мэдэн тараах, хууль бусаар алба татвах хураах, өртөө улааг хэрэглэх өртөөнөөс хэрэглэх зүйлээ тогтоосноос хэтрүүлэх, алба татвар төлөхөөс зайлсхийх, албыг нэгэн жилд нь төлөөгүй байх, татвар хураагч, бичигчид тал тохой татах, хээл хахууль авах зэрэг үйлдлийг гэмт хэрэг мөн гэж тогтоосон болой. Мөнх хаан гэмт хэрэг үйлдэгчдийг илрүүлэх, байцаах, яллах талаар зарим тодорхой журам тогтоосон нь эх сурвалжид тэмдэглэгдсэн байна.

Хэрэгтнийг байцааж шийтгэж байсан баримтыг ч дурдсан нь бий. Рашид-ад-Диний Судрын чуулганд “Мөнх хаан Илжигэдэй ноён, Том Буха, Жихи, Хулжай, Сархан, бяцхан Буба, Туган, Ийсур зэрэг ... ноёдыг цөмийг нь саатуул. Шүүгч Мөнхсар ноён бусад ноёдтой хамтран нэгжин байцааж эхэл” хэмээн тушаав /49.154/. “Энэ хэргийг хэдэн өдөр шүүжээ. Байцаалт маш нарийнаар явагдсаар эцсийн эцэст тэдгээр хүмүүсийн үг нь зөрж, тэдний тэрсэлж байсан нь ямар ч эргэлзэх зүйлгүй болтол үргэлжлэв. Тэд цөм хэргээ хүлээж гэмт хэрэг өдүүлснийхээ бурууг хүлээв” /49.154/. Мөнх хаан “урвагчдыг дөнгөлөөд гяндангийн цайзанд хорь” гэж тушаалаа /49.154/.

Цааш нь Мөнх хаан “Хоригдогсдод илдэн шийтгэл ноогдуулсугай” “Ийм хүмүүс нь 77 байв. Тэднийг бүгдийг нь цаазалсны дотор Илжигэдэйн хоёр хөвгүүнийг аманд нь чулуу чихэж алсан байна” /49.155/ Бат хааны зарлигаар Бури, Хадаг нарыг үхэл рүү нь явуулжээ /49.156/. Мөнх хаан “хатан Огул Каймишийг баривчилж, заргач шүүгч Мөнхсарын ордонд ирүүлж нүцгэлээд шүүхээр байцаасан байна. Тэгээд шүүгч асууж гүйцээд эсгийд ороон усанд хаяжээ”/49.157/.

Эдгээр баримтууд нь Мөнх хааны үед шалган шүүх процесс хэрхэн явагдаж, ямар ял шийтгэл оногдуулж байсныг нотлон харуулж байна. Дээрхээс үндэслэн, *Нэгдүгээрт*, Мөнх хааны үед гэмт хэрэг гэж юу болохыг тогтоосон тодорхой ойлголт загвар байсан. *Хоёрдугаарт*, гэмт хэрэгт холбогдсон хүнийг байцаах нэлээд хатуу ажиллагаа явагдаж байсан. *Гуравдугаарт*, гэмт хэрэгтэнд ял оногдуулах чанга үйлдэл хийгддэг байсан. *Дөрөвдүгээрт*, оногдуулсан ялыг ямар ч болзолгүйгээр гүйцэтгэх дэглэм, түүнийг хангах шорон, гяндан үйлчилж байжээ хэмээн үзэж болох нь нотлогдож байна. Энэ нь Чингис, түүний залгамжлагчид, хан хөвгүүд, тэдгээрийн үр ач нарын хоорондын тэмцэл, сөргөлдөөн, эрх мэдэл, албан тушаалын төлөө тэмцэлтэй холбоотой байсан байж болох. Тэд их Чингис хааны гэрээсийг хүндэтгэж, эв нэгдэлтэй, их улсад зүтгэх нэгэн үзүүрт сэтгэлтэй, хүчирхэг, бат бэх байсан бол ийм байдалд хүрч, Их Монгол улс мөхөхгүй байх учир холбогдолтой байсан байхыг ч үгүйсгэх юун.


Мөнхийн үеийн Монгол улсын эрх зүйн шинж чанар нь төрийн ял шийтгэлийн төрөл, хэлбэр, ялыг эдлүүлж байсан арга ажиллагаанд илэрч байсан нь тодорхой байна. Эх сурвалжуудыг судлан үзбээс, тус улсад ялын дараах хэлбэрийг хэрэглэж байсан ажээ. Үүнд цаазлах /алах/ ял онцгой ял байсан ажгуу. Баримтыг түшихүйд цаазлах ялыг цавчих, газарт булах, эсгийд ороож усанд хаях, аманд нь чулуу чихэж алах аргаар гүйцэтгэж байсан байна. Сурвалж материалд хүн алсан, бусдын эхнэртэй явсан, их хэмжээгээр хулгай хийсэн, элч төлөөлөгч биш атлаа өөрийгөө элч төлөөлөгч гэж худал хэлсэн хүнийг цаазалж /алж/ байсан байна /49.116/. Хаанд халдсан, тэрсэлсэн хүнийг цаазалж хороож байсан тухай дээр өгүүлсэн билээ. Төрийн эсрэг хуйвалдаанд оролцсон л бол хэн ч байсан цаазаар авахыг Мөнх хаан, зарлигласан

байна /49.158/. Дайсан дарагдаагүй байхад ашиг завшааныг эрж хайгчдыг шууд алж цаазлана /49.54/. Хатгалдан дайралдан байх үед оргон зугтах, нийтээрээ ухраагүй байхад оргон дутаавал алдаг байжээ /40.54/.

Мөнх хааны үед цаазлах /алах/ ялаас гадна гянданд хорих ял хэрэглэж байжээ. Гэмт хэрэгтэнг баривчилж дөнгөлөх, хоёр гарыг нь нойтон ширээр ороож оёх, нүцгэлээд байцаах бөгөөд цайзад хорих /49.156-157/ арга хэрэглэж байсан бөгөөд гянданд хорьдог байсан. Мөн шийдэмдэх /зодох/ ял байсан аж. Нэг хонь хулгайбал ийм хэрэг хийлгэхгүйн тулд 100 хүртэл шийдэмдэж байжээ /13.116/. Бас тусгай газар нутаг суулгах /нэг ёсондоо цөлж буй юм/ ял оногдуулдаг байв. Ийм ялыг хааны удам, ханхүү, төрийн дээд ихэст хэрэглэдэг байсан бололтой. Жишээлбэл ханхүү Ширэмүн хаанд бараалан уулзан гуйсны учир амийг нь өршөөж Сэлэнгийн ай савд нутаг заан суулгасан нь /49.158/ одооны ойлгомжоор цөллөг байсан бололтой. Дээрхи ялуудаас гадна хөрөнгийг нь хураах, албан тушаалаас нь огцруулах ял оногдуулж байжээ. Жишээлбэл, төрийн сайд Чингайг Мөнх хаан албан тушаалаас нь зарлигаар огцруулсан байдаг бөлгөө. Эцэст нь тэмдэглэбээс Мөнх хааны үед хууль цааз чанга байж, эрх зүйг зохистой сахин, төрийн хатуу ял шийтгэлийг хэрэглэж байсан болой.



МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРЭН



ДӨТГӨӨР АНГИЙН ТАЙЛБАР, ЗҮҮЛТ

1. **“Зүчи”**- Чингис хааны их хатан Бөртэ үжинээс 1179 онд төрсөн Чингисийн ахмад хөвгүүн. Тэрээр их хаанаас 9000 өрх иргэнийг соёрхон хүртэж, Их Монгол улсынхаа төлөө зүрх сэтгэл, авьяас билгээ зориулан зүтгэсэн төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин байжээ. Тэрээр Алтан улсыг эзлэх /1211-1215/, Дундат Азийн улсууд, Дешт-И-Калбчакийг байлдан дагуулах их дайн /1219-1221/ -д цэргийн жанжинаар томилогдон оролцож их гавъяа байгуулсан болой. Чингис хаан 1225 онд Эрчис мөрнөөс Уралын нуруу хүртэлх их газар, түүнээс баруун тийш орших уудам нутгийг Зүчид соёрхон олгосон нь түүхэнд “Зүчийн улс”, “Алтан ордны улс” хэмээн нэрлэгдэх улсууд үүсэхэд хүргэсэн болой. Зүчи 1227 онд 45 настайдаа насан өөд болжээ. Чингис хаан ахмад хүү Зүчийгээ нас барсанд ихэд гашуудан харамсаж, түүнд зориулан сүрлэг бунхан бариулсан ажгуу. Эл бунханг Бат хаан, түүнийг залгамжлагчид олон үе дамжуулан тахиж байсан түүхтэй.

2. **“Цагаадай”**- Чингис хааны хоёрдахь хүү. 1183 онд төрсөн. Шулуун шударга, эрэлхэг зоригтой, дайчин шаламгай цэргийн жанжин байв. Тэрээр ухаантай, авьяаслаг бөгөөд бусдад хүндэтгэх сүжиг төрүүлдэг ... яс хууль, билэгдэл ба жаяг, хант ёсыг сахихыг ихэд хичээнгүйлдэг /49.105/ хүн байв хэмээн Рашид-ад-Дин бичсэн байдаг. Харин догшин ширүүн зан авиртай ба ах Зүчитэйгээ үргэлж зөрчилдөж маргалддаг байжээ. 1211 онд Хятадын Алтан улстай байлдсан дайн, 1218 онд Хорезмыг дайлахад цэргийн жанжинаар оролцож, их гавъяа байгуулан эрэлхэг зоригтой жанжин болохоо харуулсан. Өгөдэйтэй дотно харилцаатай байж, ажил хэргээ зөвлөлддөг байжээ. Өгөдэй хаанаас баруун зүгт хийсэн дайныг дэмжин, Чингисийн хөвгүүдийн ахмад болгоныг нь дайнд оруулах санал гаргаж байсан бөгөөд энэ санал нь ч хэрэгжсэн байдаг. 1236 онд Өгөдэй хаан Цагаадай ахдаа Хар Хятаны хуучин нутаг ба баруун Уйгурын нутгийг өгч захируулжээ. Цагаадайн харьяалж байсан газар нь зүүн тийшээ Иль голд тулж, баруун тийшээ Сырдарьяа мөрний эхээс цааш гарч, өмнөөрөө Аму мөрөн хүрч, хойшоогоо Чүү мөрний саваар Сибирьт тулж байжээ. Энд Цагаадай улсаа толгойлж, “Цагаадайн хаант улс” хэмээн нэрлэгдэх болжээ. Цагаадай 1242 онд нас барсан болой.

3. **“Өгөдэй”**- Чингис хааны гуравдахь хүү. 1186 онд Бөртэ хатнаас төрсөн бөлгөө. Тэрээр “ихэмсэг, ухаантай, авьяаслаг, эргэцүүлэн тунгаан боддог, хатуу чанд төрх намбатай, уужуу тайван, шулуун шударгаараа тодрон нэрд гарч байсан боловч жаргал цэнгэлд дуртай бөгөөд сархад хүртдэг байв” /49.4/ хэмээн “Судрын чуулган” зохиолд тэмдэглэсэн байдаг. Өгөдэй өрнөд, өмнөд зүгт хийсэн олон тулалдаанд цэрэг удирдан ялалт байгуулж байсан цэргийн авьяас билэгт жанжин болой.

Өгөдэй 1229 онд Хэрлэнгийн хөдөө аралд болсон төрийн Хуралдайгаар Их Монгол улсын хаанд өргөмжлөгдсөн. 12 жил төр барьсан бөлгөө. Өгөдэй их хаан болоод эцэг Чингисийнхээ гэрээсийг нэр төртэй биелүүлж, “Их засаг” хуулийг нь ягштал сахин мөрдөж байсан юм. “Монголын нууц товчоо”-нд Өгөдэй хаан төр барьсан хугацаандаа дөрвөн сайн үйлс бүтээж, бас дөрвөн муу үйл хийснийг тэмдэглэн бичсэн байдаг билээ. Өгөдэй хаан 1241 онд нас барсан болой.

4. **“Чингисийн тахилга”**- Өгөдэй хаанаас бий болгосон эцэг Чингис хааны сүлд тахих тахилга. Энэхүү тахилгын гол хэрэглэгдэхүүн нь голд нь байрлуулсан есөн хөлт цагаан туг, түүний зүүн талд барьсан 4 цагаан гэр, баруун талд нь байрлуулсан дөрвөн цагаан гэр мөн аж. Тахилгыг Чингис хааны нас эцэслэсэн өдөр хийж, түүнд алтан ургийнхан, сайд, ноёд оролцон сүрлэг том цагаан тугийн хөлүүдэд шүтэн залбирч мөргөн, ихэд хүндэтгэж, хувь заяагаа даатгах их ёслол үйлдэнэ. “Тэд эцэг хааны адил тэнгэр эцэг таны тааллаар газар эх-эдүүгээ түвшин явж байна” /36.146/ хэмээн амандаа үглэн залбирдаг байжээ.

5. **“Чжэншүшэн”**- Өгөдэйн хаант улсын засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам. Энэ яам нь зөвхөн умард Хятадыг захирах үүрэгтэй байсан бөгөөд яамны ерөнхий сайдаар Елюй Чуцайг томилон ажиллуулж байжээ. Өгөдэй хаан энэ яамыг Хятад орныг зөвхөн хятад аргаар захирч болох баримтлалыг үндэслэн, Елюй Чуцайн саналыг харгалзан байгуулсан байж болох. “Чжэн Шү-шэн” хэмээх яамны уламжлалыг Юан улсын үед авч хэрэглэн, ийм нэртэй төрийн захиргааны дээд байгууллагыг байгуулсан ажгуу.

6. **“Бат хаан”**- Чингисийн ахмад хөвгүүн Зүчийн хоёрдахь хүү. 1209 онд төрсөн. “Алтан Ордон”-ы улсын хаан. 1236 онд баруун зүгт хийсэн байлдааныг толгойлон удирдаж, түүндээ Сүбээдэй жанжин, Чингис хааны хүүхдүүдийн ач нарыг оролцуулан агуу том ялалт хийсэн цэргийн гарамгай жанжин. Гүюг монгол улсын их хаан болсон үеэс “Алтан орд”-ыг монголын төвлөрсөн төрөөс тусгаар байлгах бие даасан бодлого явуулж байсан. Харин Гүюг хааныг нас барсны дараа Тулуй хааны хүү Мөнх жанжинг Монгол улсын хаан болохыг зохион байгуулсан гол хан хүү байжээ. Тэрээр “Алтан ордон”-ы улсыг бэхжүүлэн хөгжүүлж, ихээхэн хүчирхэг болгосон аж. Бат зоригтой, шулуун шударга, цэргийн эрдмийг гарамгай эзэмшсэн, улс төрийн том зүтгэлтэн байсан ажгуу.

7. **“Сүн улс”**- Хятадын Өмнөд хэсэгт оршин тогтнож байсан феодалын ёст их газар нутаг, олон хүн ам бүхий хүчирхэг хаант улс. Чингис хаан Тангуд, Алтан улсыг байлдан эзэлсний дараа Их Монгол улс Сүн улстай шууд хөршлөн орших болсон нь хоёр улсыг харилцан бие биенээсээ шууд хамааралтай болгосон ажээ /17.170/. Алтан улстай байлдах үед Чингис хааны холбоотноор орж тулалдан, Алтан улсыг мөхөөхөд тусалсан түүхтэй.

8. **“Гүюг”**- Ханхүү. 1206 онд Өгөдэйн их хатан Туракинаас төрсөн. Өгөдэйн ахмад хүү. 20 орчим наснаасаа цэрэг, байлдааны ажилд идэвхийлэн оролцож, цэргийн эрдэмд шамдан суралцаж хатуужин өссөн нэртэй жанжин болой. Гүюг Алтан улс, Өмнөд Сүн улс, Өрнө зүгийн Исмайл улсыг байлдан дагуулахад ихэвхтэй зүтгэж гавъяа байгуулсан ханхүү бөлгөө. Тэрээр 1246 онд Монгол улсын хаанд өргөмжлөгдөн 3 жил шахам Монгол улсыг тэргүүлж байсан ажгуу. Чингис хаан Монголын нэгдсэн улсыг тунхаглах жил төрсөн хэмээн түүнийг ихэд хайрладаг байжээ. Гүюг дунд зэргийн нуруутай, маш хэрсүү, ухаалаг, буурьтай бөгөөд ихэмсэг зантай хүн байсан гэж Плано Карпини бичсэн байдаг /40.74/. Тэрээр хаан эцгийн зассан улсыг тэр хэвээр нь хадгалж, төрөө тогтвортой байлгаж чадсан хаан бөлгөө. Гүюг хаан 1248 онд нас баржээ.

9. **“Бури”**- Цагаадайн ахмад хүү Мутучины хоёрдахь хүү. Түүний нэрийг Хятад сурвалжид “Бури”, Монгол зохиолд “Бор” гэж нэрлэсэн байдаг. Бури маш зоригтой, шазруун зантай хүн байв. Тэрээр цэргийн эрдэмд сайн бөгөөд Чингисийн ач Гүюг, Мөнх нартай хамт Өгөдэй хаанаас өрнө зүгт хийсэн их дайнд цэрэг удирдан оролцож гавъяа байгуулсан. Гүюгийг хаанд өргөнмжилсөн Их Хуралдайд оролцож байсан аж. Бури Бат хаантай тэрсэлдэж байсан ба Мөнх хаан болоод төрд тэрсэлсэн хэмээн баривчилж Бат хаанд хүргүүлжээ. Бат хаан Бурийг цаазласан ажгуу.

10. **“Хубилай”**- Тулуй хааны хоёрдахь хүү. Хубилайг 1215 онд Мөнхийн их хатан Сорхугтани бэхи төрүүлсэн бөлгөө. Тэрээр Өрнө, Дорно зүгт хийсэн Өгөдэй, Гүюг, Мөнх хаадаас явуулсан дайнд оролцож хатуужсан цэргийн жанжин байжээ. Өөрийн ах Мөнхийг их хаан болохыг идэвхтэй дэмжин хаанд өргөмжилсөн Их Хуралдайд нь удирдан явуулсан болой. Цэргийн төдийгүй зохион байгуулах чадвартай, мэдлэгтэй, зоригтой, эрэмгий, шаламгай, хурц мэдрэмжтэй, төрийн зүтгэлтэн ажгуу. Мөнх хаан 1252 онд Хятадын Сүн улстай байлахаар их цэрэг хөдөлгөж, Хубилай жанжинаар удирдуулсан бөгөөд Хубилай ч энэ үүрэг даалгаварыг нь сайн биелүүлсэн байдаг. Хубилай цаашид Хятадыг бүхэлд нь байлдан дагуулах ажлыг удирдаж явуулсан түүхтэй.

11. **“Плано Карпини”**- 1182-1251 онд амьдарч байсан Итали гаралтай агаад Баруун Европоос Монгол газар ирсэн анхны төлөөлөгч, элч. Түүнийг Италиар Плано де Пиано Карпини, францаар Жан де Плано Карпино хэмээн дууддаг байжээ.

Тэрээр Ромын сүм хийдийн илгээлтээр Герман, Италид элчээр явж байсан ажгуу. Ромын пап /далай/ лам, францын IX Людовик хааны элчээр 1246 онд Хархорумд ирж, Гүюг хаантай уулзан Пап болон Францын хааны бичиг захиаг гардуулж байсан бөлгөө. Монголд байсан хугацаандаа улс орон, газар нутгийн байдалтай нилээд сайн танилцсан. 1247 оны 2-р сард нутагтаа буцаж очжээ. Плано Карпини аялан явсан тухайгаа “Монголчуудын түүх” хэмээх замын тэмдэглэл бичсэн нь дэлхийд алдаршсан бөлгөө.

12. *“Гильом де Рубрук”*- Ромын пап, францын IX Людовик хааны элчээр монголд ирж байсан европын лам хүн. Тэрээр 1253 оны 5-р сард Константинополь хотоос гарч аялсаар 1254 оны 4-р сард Монголын нийслэл Хархорум хотод хүрэлцэн ирээд, Мөнх хаантай уулзан, пап болон хааны илтгээлт бичгийг гардуулж өгсөн ажээ. Тэрээр Мөнхийг хаанд өргөмжилсөн Их Хуралдайд оролцсон нь нэн сонирхолтой. Эл элч Монголд 4 сар гаруй байхдаа монголчуудын амьдралтай танилцаж, Монголын хаантай хэд хэдэн удаа уулзаж байжээ. Рубрук, Мөнх хаанаас францын IX Людовик хаанд илгээсэн захидал бичгийг аваад нутаг буцан Людовик хаанд өгсөн болой. Рубрук 1253-1255 онд хийсэн аялалын тайланг гаргаж IX Людовик хаанд өргөн барьсан ажээ. Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь” гэсэн замын тэмдэглэл бичсэн нь анх 1600 онд хэвлэгджээ. Рубрукийн ном Европ, Азийн олон оронд хэвлэгдсэн болой.

13. *“Пэн-Дая”*- Хятадын Сүн улсаас Монголд 1235-1236 онд Сюй Тиний хамт ирж байсан элч. Энэ элч Монголд байсан хугацаанд үзсэн, харсан, сонссон, судалсан зүйлээ тэмдэглэл маягаар “Хар татарын тэмдэглэл” /Хэй-да-ши-люе/ нэртэйгээр бичиж хэвлүүлсэн байдаг. Энэхүү тэмдэглэлд Монгол улс, түүний нийгэм, төрийн байгуулал, хүн ардын аж байдал, газар нутаг, түүх соёл, зан заншлын тухай ихээхэн мэдээллийг бичиж үлдээснээрээ түүхэн их үнэ цэнэтэй бөлгөө.

14. *“Суурь өртөө”*- Өгөдэй хааны зарлигаар Монгол улсын хэмжээнд байгуулсан нэгдсэн өртөөний ерөнхий нэр. Өгөдэй хааны эцэг Чингисээс хойш бүтээсэн дөрвөн сайн үйлсийн нэгэн. Хятадын нутгаас эхлэн Монголын нэгдсэн улсын нутгийг дайруулан, Бат, Цагаадын нутаг хүртэл бүгд 1500 орчим суурь өртөө байгуулсан түүхтэй. Үүнийг бүхэлд нь бас Улсын нэгдсэн өртөө хэмээн нэрлэх нь бий. Энэ нь түүхэнд тэмдэглүүштэй маш нүсэр том бөгөөд асар их ач холбогдол бүхий ажил байсан болой.

15. *“Хархорум”*- Их Монгол улсын нийслэл. Чингис хаан амьд сэрүүн байхдаа 1220 онд “Хар Хорум”-ыг Монгол улсын нийслэл болгох гэж тогтоосон боловч түүнийг барьж байгуулах ажил 1230-аад оны дунд хүртэл үргэлжилж, улмаар Өгөдэй барьж дуусгуулсан байна.

Өгөдэй хаан Орхон голын хөвөөнд 1235 оноос энэ хотоо барьж дуусгаад “Хархорум” гэж уламжлан нэрлэж, улсынхаа нийслэл болгожээ. Хархорум хот Өгөдэй хааны үед жинхэнэ ёсоор цэцэглэн хөгжсөн бөлгөө. Хотыг барихад газар газрын уран барилгачид оролцож, Лю-Мин гэдэг Хятад уран барилгач ерөнхийлөн удирдаж бариулжээ. Монголоос Отчигин ноён их үүрэгтэйгээр оролцсон байдаг. Энэ үеэс Хархорум хот Их Монгол улсын засаг захиргаа, худалдаа, соёлын төв, олон улсын харилцааны хот болжээ /36.156/. Хотын дотор Өгөдэй хааны Түмэн амгалан орд болон бусад олон гоёмсог орд харш, сүм хийд, барилга байгууламж, мөнгөн мод,

түүхэн дурсгалт зүйлс байсан ажээ. Хотод олон үндэстний гар урчууд, барилгачид, алт, мөнгө, төмрийн дархчууд, худалдаачид тусгай хорооллууд байгуулан амьдарч, аж төрж байжээ. Мөн Хархорумын ойролцоо 6 үзэсгэлэнт орд баригдсан байдаг бөлгөө.

16. “Чингисийн билэг сургаал”- Их Чингис хаанаас өөрийн хүүхэд, дүү, үр ач нар болон сайд, ноёд, түшмэдүүддээ хандан сургамжлан хэлсэн үгийг бүхэлд нь “Чингисийн билэг” хэмээн нэрлэдэг байжээ. Рашид-ад-Дин “Судрын чуулган” хэмээх зохиолдоо билэг сургаалаас гучаад зүйлийг перс хэлнээ орчуулан дурдсан байдаг бөлгөө. “Монголын нууц товчоо”-нд ч билэг сургаалаас орсон зүйл багагүй бий. Чингис хаан “Цэцэн сайн түшмэл улсын эрдэнэ, Цэцэн хатан гэрийн эрдэнэ. Хүн хэдий сайн төрөвч эс сургавал цэцэн үл болох, хүндлэгдэх, хөнгөлөгдөх хоёр өөрийн биеээс болно” хэмээн сургасан байдаг. Билэг сургаал нь эрх зүйн бус, харин заншил, ёс суртахууны шинжтэй байдгаараа онцлог. Хүн ардыг ухааруулах, сэрэмжлүүлэх, сургамж авч хэвшил болгох үндсийг өөртөө агуулж, төлөвшин хөгжихөд их үүрэг гүйцэтгэдэгт билэг сургаалын ач холбогдол оршино.

17. “Туракина”- Өгөдэй хааны их хатан. Жинэхэн нэр нь Наймалжин. Мэргэд гаралтай мэргэд аймгийн Тогтоа бэхийн их хөвгүүн Ходын эхнэр болж явсан. Эрмэг зантай, чадварлаг, сэргэлэн, бусдыг өөртөө татаж чаддаг, хүнийг захирах гэсэн араншинтай хатан байжээ. Гүюгийг хаан болохын өмнө их хааны үүрэг гүйцэтгэгчээр 4 жил 6 сар ажиллаж, Монголын төрийн түүхэнд ул мөрөө үлдээсэн эмэгтэй зүтгэлтэн байжээ. Хатан Туракина түүхэнд эерэг, сөрөг үүргийн аль алиныг гүйцэтгэж, эцэст нь Гүюг хаан болсоны дараа хорлогдон нас барсан болой.

18. “Годан”- Өгөдэй хааны хоёрдахь хүү. Зарим сурвалж бичиг, зохиолд Хадаан хэмээн бичсэн байдаг. Дөргөнэ хатан төрүүлсэн ээж нь мөн билээ. Өгөдэй хаан Годаныг өөрийнхөө ор суух хаанд бэлтгэж, зохих мэдлэг боловсрол олгон, ихэд анхаарч байсан боловч энэ хүсэл нь биелэгдээгүй болой. Өгөдэй хааныг нас барсны дараа эх Дөргөнэ төрийн эрх барихыг илт эсэргүүцсэний учир ихэд хавчигдаж байжээ. Годан Монгол гүрний нэг чухал муж болох Хөх нуурын газрын захирагч байсан аж. Тэрээр өвөг эцгийн итгэлт хүн Мухамед Ялавич, Чингай Чинсан нарыг өмгөөлөлдөө аван хамгаалж байсан түүхтэй. Годан бол жинхэнэ монгол сэтгэлгээтэй, монгол улсын төлөө зүтгэх чин сэтгэлтэй, мэдлэг боловсролтой хан хөвүүн байжээ. Тэрээр хорлогдон нас барсан болой.

19. “Ширэмүн”- Өгөдэй хааны ач хүү. Өгөдэй хаан өөрийгөө ахмад хүү Гүюгээр залгамжлуулах дургүй байжээ. Учир нь Гүюг, Бат хаан хоёр үргэлж зөрчилддөг байсан байна. Харин гуравдугаар хүү Хүчүгээр өөрийгөө залгамжлуулахаар бодож байсан боловч энэ хүү нь дайнд үрэгдсэн ажээ. Ингээд Хүчүгийн ахмад хүү Ширэмүнийг ханхүү болгожээ. Өгөдэй нас барахад ханхүү дэндүү балчир байснаас хааны үүргийг

их хатан Туракина түр гүйцэтгэх болжээ. Дараа нь Гүюг хаан ор сууж, улмаар түүнийг нас барахад насанд хүрсэн ч гэсэн Тулуйн хүү Мөнхийг хаанд өргөмжилжээ. Эл үед Ширэмүн хуйвалдаанд оролцсоны учир баривчлагдан Хархорумын ойролцоо оршдог “Шар хорго” гэдэг газар цөлөгдөв. Ширэмүн ханхүү бол ухаантай, авъяастай, зоригтой хүн байсан гэдэг.

20. “Есөнмөнх”- Чингисийн хүү Цагаадайн тавдугаар хөвгүүн. Гүюгийг Монгол улсын хаанд өргөмжлөх Их Хуралдайд өрнө зүгээс ирж оролцож байсан. Цэргийн жанжин, авъяаслаг, сэргэлэн хүн байжээ. Гүюгийн үед Есөнмөнх Цагаадайн улсын ханаар өргөмжлөгдсөн. Харин Мөнх хаан Хар Хулагуд зарлиг буулгаж Есөнмөнхийг устга гэсэн боловч биелүүлж амжаагүй учир Хар Хулагугийн эхнэр Ургана хатан очиж Есөнмөнхийг хороогоод өөрөө хан болсон түүхтэй.

21. “Шар ордон”- Өгөдэй хааны зуслан орд. Их хаан энэ ордондоо зусдаг байжээ. Энэхүү ордыг “Шар ордон” буюу “Алтан ордон” хэмээн нэрлэдэг байсан түүхтэй. Шар ордны баганыг шижир алтаар шарж, дээврийг нь алтан хадаасаар хадсан байснаас шар ордон хэмээн нэрлэж байсан аж. Тамир голын хөвөөн дээр баригдсан учир “Тамирын шар ордон” хэмээн бас нэрлэдэг байсан. 2000 гаруй хүн өлхөн багтах энэ ордонд Гүюгийг Монгол улсын их хаанд өргөмжилсөн төрийн Хуралдай чуулжээ.

22. “Илжигэдэй”- Өгөдэй, Гүюг хааны төрийн сайдаар ажиллаж байсан асар их нэр хүнд, эрдэм ухаан, бичгийн соёлтой төрийн түшээ, цэргийн жанжин.

23. “Сорхугтани бэхи”- Чингис хааны хүү Тулуйн хатан. Ухаалаг, сэргэлэн, ажил хэргийг зохион байгуулах их авъяастай, нөхрөө ба хүүхдүүдээ өсгөн төлөвшүүлэхэд их анхаарал тавьдаг хатан болой. Гүюг хааныг нас барсны дараа, түүний талынхны хагарлыг ашиглан хүү Мөнхөө хаан болгуулахаар Бат хаантай нууц тохиролцож зорилгодоо хүрч, Мөнх нь хаан болсон бөлгөө. Ухаантай хатан төдийгүй сайн ээж байсан болой. Сорхугтани хатан Мөнх, Хубилай, Хүлэгү, Аригбөх гэсэн 4 хүү төрүүлсэн нь бүгдээрээ цэргийн жанжин, улсын хаан болж байсан түүхтэй. Мөнх, Аригбөх нь Монгол улсын хаан, Хүлэгү нь Иран улсын хаан, Хубилай Юан улсын хаан байсан бөлгөө. Тулуй хаан Сорхугтанид их итгэл өгч, ажил хэргээ түүнтэй зөвлөлддөг байсан гэдэг.

24. “Огул Хаймиш”- Гүюгийн их хатан Ойрадын Хутуга бэхийн охин. Хаймиш хатан багаасаа сайн хүмүүжил олсон, ухаалаг хэрсүүд, алив асуудалд хүлээцтэй ханддаг, шударга ёсыг ихэд хүндэтгэдэг, хувийн муу санаа өвөрлөдөггүй, үнэн хэргийн төлөө эрч хүчтэй зүтгэдэг, удирдан зохион байгуулах чадвар бүхий хатан байсан аж. Зүчийн ахмад хүү Бат болон алтан ургийн олон ноёдын зөвшөөрснөөр их хаан орыг түр эзэлж, хааны үүргийг 3 жил 3 сар гүйцэтгэсэн төрийн зүтгэлтэн Монгол хатан бөлгөө.

25. **“Бэрх ноён”**- Чингис хааны ууган хөвгүүн Зүчийн гуравдахь хүү. Бат хааныг нас барсны дараа 1254, 1255 оны орчим “Алтан ордон”-ы улсын хаан болсон төрийн зүтгэлтэн, цэргийн жанжин, нэр хүндтэй, нөлөө бүхий хүн байв. Тэрээр Мөнхийг Их Монгол улсын хаанд өргөмжилсөн Их Хуралдайг зохион байгуулж, түүнийг хааны сэнтийд залсан түүхтэй. Бэрх ноён Мөнх хааны үед гүрч /улсын ван, ерөнхий сайд/, Батыг нас барсны дараа Алтан ордны улсын хаан, Их Монгол улсын төрийн зүтгэлтэн болж хүчин зүтгэжээ. Бэрх ноён 1265, 1266 оны орчим нас барсан ажгуу.

26. **“Мөнх”**- Тулуй ханы ууган хүү. Бага залуугаасаа эцэг өвгийг дагаж Алтан улс, Хорезмын улсыг дайлахад оролцож гавьяа байгуулсан цэргийн жанжин болой. Мөнх 1251 онд Монголын их хаанд өргөмжлөгдөн 10 шахам жил төр барьжээ. Мөнх хаан 1258 онд их цэргээ удирдан Өмнөд Хятадыг дайлахаар мордож их амжилтанд хүрсэн боловч 1259 онд өвчний улмаас насан өөд болжээ. Их Монгол улсын сүүлчийн хаан Мөнх төрийн нэрт зүтгэлтэн, цэргийн авьяаслаг жанжин, ухаалаг сэргэлэн хүн байсан болой.

27. **“Хулагу /Хүлэгү”**- Тулуй ханы гуравдахь хүү. Сорхугтаниас төрсөн бөлгөө. Хулагу бол төр, цэргийн зүтгэлтэн, мэдлэг авьяастай, сэргэлэн хүн байсан ажээ. Мөнх хаан болмогцоо баруун зүгт хийх дайныг Хүлэгү жанжнаар удирдуулжээ. Хүлэгүгийн удирдсан цэрэг Исмайлитын улсыг эзлэн, Багдадын Халифт цохилт өгч их хааны зарлигийг биелүүлсэн учир Иран улсын эзэн болж байжээ. Иран улсыг түүхэнд Хулагугийн улс хэмээн бас нэрлэдэг билээ. Хулагу хаан хорлогдон нас барсан бөлгөө.

28. **“Мөнхсар”**- Язгуур угсаат ноён, төр, цэргийн зүтгэлтэн. Бат хаан, Бэрх жанжны итгэлт хүн. Мөнхийг Монгол улсын их хаанд өргөмжлөх төрийн Их Хуралдайг Хэрлэн мөрний Хөдөө аралд Бэрх ноёны хамт зохион байгуулж хийлгэсэн ажгуу. Мөнх хаан болоод Мөнхсарыг улсын заргачаар томилжээ. Төрийн хуйвалдааныг зохион байгуулсан, түүнд оролцсон шалтгаанаар ханхүү тэргүүтэй 77 ноёныг Мөнх хааны зарлигаар Мөнхсар ноён баривчлан байцааж, ял шийтгэл оногдуулсан байдаг. Тэдний ихэнхи нь Өгөдэй, Цагаадайн талынхан байжээ.

29. **“Булган”**- Уйгур гаралтай түшмэл. Бичиг үсэг мэддэг, олон хэлээр ярьдаг, хашир туршлагатай ноён. Мөнх хаан Булган түшмэлийг онцлон үзэж улсын их бичээч болгож, улсын бичиг хэрэг, алба татварын асуудлыг харуицуулсан байдаг бөлгөө. “биднийг ордны их бичээч Булган дуудаж билээ. Булган эхлээд Гэлэнг, дараа нь биднийг нэг нэгээр нь дуудан нягтлан шалгасан” /49.194/ гэж Рубрук тэмдэглэн бичсэн байдаг.

30. **“Тогачур”**- Мөнх хааны их цэргийн жанжин. Олон удаагийн дайн байлдаанд орж, ялалт байгуулсан зоригт баатар. Цэргийн урлагт ихэд мэргэшсэн, алдар цуут жанжин. Мөнх хаан Сүн улсад явуулсан их дайныг удирдах жанжинаар Тогачурыг томилсон нь жирийн зүйл биш, харин түнний авьяас билэгт итгэсэн хэрэг байсан. Тогачур

ДӨТГӨӨР АНГИЙН ТҮҮХЭН ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

- 1227-1229 он Чингис хааны отгон хүү Тулуй хан Их Монгол улсын төрийг түр захирч, хаан ор гүйцэтгэж байсан.
- 1229 он Өгөдэй Их Монгол улсын хаанд өргөмжлөгдсөн.
- 1229 он Өгөдэй хаан Улсын албан татварын нэгдсэн хуулийг батлав.
- 1230 он Өгөдэй хаан давсны татварын хуулийг батлав.
- 1231 он Их Хуралдай “Ерэн есөн булаг” хэмээх газар хуран чуулж Зүрчидийн улстай байлдах тухай хэлэлцсэн.
- 1231 он Өгөдэй хааны томилсон цэргийн жанжин Чурмаган Хорезмын шах Желал-ад-Дин Мухамедийн хүчийг бүрэн бут цохисноор Хорезмын нутаг бүхэлдээ Монгол гүрний мэдэлд оржээ.
- 1231-1232 он Монгол, Солонгос улсын хооронд дипломат харилцаа тогтож, захидлаар харилцан элч солилцсон.
- 1232 он Их Хуралдай чуулж, уургын улааг халж, улсын нэгдсэн Өртөөг байгуулах түүхэн шийдвэр гаргасан.
- 1232-1233 он Өртөөгөөр явах журмын тухай хууль баталсан.
- 1234 он Худалдааны гаалийн хууль батлагдсан.
- 1234 он Монгол улсын цэрэг Алтан улсын цэргийг бүр мөсөн ялснаар Алтан улс мөхжээ.
- 1234 он “Их чуулган “Далан даваа” хэмээх газар хуран чуулж иргэд нь аравтын дотроос дураар гарч явахыг хориглосон хууль баталсан. ““Чжэн-ши-шэн” нэртэй засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яам байгуулсан.
- 1235 он Их Хуралдай чуулж, Алтан улсад байлдсан дүү ба өмнө зүгт дайн хийх асуудлыг хэлэлцсэн.
- 1235 он Өмнөд Сүн улсын элч Пэн-Дая, Сюй Тан нар Монголд ирсэн.
- 1235 он Орхон голын хөвөөнд хот байгуулж дуусган “Хархорум” гэж нэрлэв.
- 1235 он Чингис хааны нас барсан өдрөөр түүний сүлдийг тахиж, цаашид жил бүр хийж байх ёсыг тогтоосон.
- 1231-1235 он Монгол, Солонгос хамтарч Солонгосын зарим нутгийг эзэлсэн цэргийн хүчийг дарж, Солонгосыг чөлөөлсөн.
- 1236 он Өгөдэй хаан Чингис хааны Есөн хөлт цагаан тугийг Хархорум хот, хааны өргөн нь албан ёсоор залж байрлуулсан.
- 1236 он Өгөдэй хаан мяндас эдлэлийн татварын хуулийг батлав.

- 1237 он Өгөдэй хаан Сурин хотыг байгуулсан.
- 1237 он Хархорумд Монгол сургууль, архивын газар, номын сан байгуулсан.
- 1237 он Бичгийн мэргэдийг шалгаруулах уралдааныг анх удаа зохион явуулсан.
- 1236-1241 он Зүчийн хүү Бат, Сүбээдэй жанжин, Өгөдэйн ахмад хүү Гүюг, Цагаадайн ач Бури, Байдар, Тулуйн хүү Мөнх нарын удирдсан цэрэг Болгар, Оросын Рязань, Москва, Ростов, Ярослав, Димитри, Смоленск, Черниговийн вант улсууд, Владимир, Козольск, Переяславль, Чернигов хот, Крым, Казказын газар Киев, Галиц, Болынскийн газар болон Польш, Молдав, Унгар, Австри, Словак, Чехийг байлдан эзэлжээ.
- 1238 он Өгөдэй хаан “Төсөх” хотыг байгуулсан.
- 1241 он Өгөдэй хаан насан өөд болжээ.
- 1241-1246 он Өгөдэй хааны их хатан Туракина Монгол улсын төрийг түр барьсан
- 1246 он Өгөдэй хааны хүү Гүюг Их Монгол улсын хаанд өргөмжлөгдсөн.
- 1246 он Гүюг хаан Ромын папын элч Плано Карпинийг Хархорумд хүлээн авч уулзсан.
- 1246-1247 он Гүюг хаан Армяны ван II Гетумийн хүү Сибатт Спарпетийг Хархорумд хүлээн авч уулзжээ.
- 1247 он Гүюг хаан хүн амын тооллого явуулжээ.
- 1248 он Гүюг хаан Монгол их цэргээ авч баруун зүг рүү аян дайн хийхээр морджээ.
- 1248 оны 5-р сар Гүюг хаан нас барсан.
- 1248-1251 он Огул Хаймиш Монголын төрийг түр барьсан.
- 1251 он Тулуйн хүү Мөнхийг Их Монгол улсын хаанд өргөмжилсөн.
- 1251 он Мөнх хаан төрийн эсрэг хэрэг үйлдсэн гэж 77 ноёдыг цаазалжээ.
- 1252 он Мөнх хаан дүү Хубилайд их цэрэг удирдуулан өгч Өмнөд Хятадыг дайтахаар явуулсан.
- 1252 он Вьетнам Монголын хараат улс болсон.
- 1252 он Хулагу-ын удирдсан Монгол цэрэг Ираныг байлдан эзэлсэн.
- 1255 он Францын IX Людовик хааны элч Гильом де Рубрук Мөнх хаантай Хархорумд уулзсан.

- 1256 он Мөнх хааны удирдсан Их Хуралдай чуулж, Хятадын Сүн улстай байлдах тухай асуудал хэлэлцээд байлдахыг зөвшөөрсөн шийдвэр гаргасан.
- 1253 он Мөнх хаан Өмнөд Сүн улсыг дайлах их дайны жанжнаар Тогачур, Урианхайдай нарыг томилсон.
- 1257 он Мөнх хааны удирдсан их цэрэг Өмнөд Хятадтай байлдахаар Хархорумаас хөдөлсөн.
- 1259 он Их Монгол улсын сүүлчийн хаан Мөнх хаан эл оны 8-р сард насан өөд болжээ.



ДӨТГӨӨР АНГИЙН НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Алтан ордны тайлга. Бээжин.1983
2. Алтаншаа Н. Монголын гурван хаан-Өгөдэй, Гүюг, Мөнх. Хайлаар.1985
3. Амар А. Монголын товч түүх. УБ.,1934, 1992
4. Амархүү.О. Байгаль орчныг хамгаалах монгол занзаншил хууль цааз /Уламжлал шинэчлэлийн асуудал/ УБ.,200
5. Баярхүү Г. Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь. УБ.,1997
6. Баярсайхан Б. Хууль зүйн товч тайлбар толь. УБ.,2000
7. Бира Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ.,2001
8. БНМАУ-ын түүх. Нэгэн боть. УБ.,1954
9. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.,1966
10. Болдбаатар Ж. Лүндэжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997
11. Булаг. Хаадын үндсэн хураангуй алтан товч. Хөх хот. 1958
12. Галдан. Эрдэнийн эрх. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1960
13. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.,1998
14. Гонгор Д. Халх товчоон. II боть. УБ.,1976
15. Гомбожав. Гангын урсгал /Чингисийн алтан ургийн түүх/. 1960
16. Гэрэлбадрах Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. МЭӨ III-МЭ XIX зуун. УБ.,2002
17. Далай Ч. Монголын түүх. 1206-1260. УБ.,1994
18. Далай Ч. Монголын түүх. 1260-1388. УБ.,1992
19. Жамбалдорж. Болор толь. УБ.,1981
20. Жамсран Л. нар. Монголын түүхэн бага нэвтэрхий толь I, II. УБ.,1998
21. Жувейни А. Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Хөх хот. 1980
22. Инжинаш. Хөх судар. Хөх хот.1991
23. Ишжамц. Монголын нэгдсэн төр улс байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ.,1974
24. Ишжамц Н. Монголын төр, ёсны уламжлалын асуудал. УБ.,1986
25. Лааган Б. Монгол хаадын хураангуй товчоон. УБ.,1998
26. Лхагваа Б. Монгол Солонгосын харилцааны уламжлалаас. Сөүл.1996
27. Лиу Жинь Сувэ. Хаадын үндэсний хураангуй Алтан товч. Хөх хот.1980.
28. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
29. Марко Поло. Замын тэмдэглэл. УБ.,1975

30. Монголын эрт, эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр.
Хөрвүүлсэн Б.Баярсайхан. УБ.,2002
31. Монголын нууц товчоо. УБ.,1990
32. Монголын нууц товчоо. УБ.,2004
33. Монголын эртний цагийн цааз хуулийн түүхэнд холбогдох хэрэглэгдэхүүн. УБ.,1936
34. Монголын хаад болон Хатадын түүх. Тайбэй. 1992
35. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил.
(МЭӨ III-МЭ XX зуун). УБ.,1995
36. Монголын улсын түүх. Дэд боть. УБ.,2003
37. Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр. УБ.,1992
38. Монголын соёлын түүх. I боть. УБ.,1999
39. Оссон Д. Монголын түүх. Тэргүүн боть. Бээжин. 1962
40. Плано Карпини “Монголчуудын түүх” 1998
41. Пүрэвжав С. Монголын шашны хураангуй түүх. УБ.,1978
42. Пэрлээ Х. Монголын эрт, дундат үеийн хот, суурины товчоон. УБ.,1861
43. Саган Сэцэн. Эрдэнийн товч. Бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1961
44. Сайшаал. Чингис хааны товчоон. Тэргүүн дэвтэр. УБ.,2003
45. Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. УБ.,2003
46. Санждорж М. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ.,1998
47. Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал. Ж.Гэндэндарамын орчуулга. УБ.,1992
48. Рашид-ад-Дин. Судрын чуулган. I боть. Хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ.,2002
49. Рашид-ад-Дин. Судрын чуулган. II боть. Хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ.,2002
50. Рене Груссе. Орчлонг эзэгнэгч Чингис хаан Ч.Баатарын орчуулга. УБ.,2003
51. Төрийн минь сүлд өршөө /эмхэтгэсэн Д.Самданмөнх, С.Цэдэндамба/. УБ.,2004
52. Чан Чунь бомбо. Баруун газар зорчсон тэмдэглэл.
53. Чингис хааны тухай товч тайлбар толь. УБ.,1992

Орос хэлээр

54. Армянские источники о монголах. М.,1962
55. Ахмедов Б.А. Государство кочевых Узбеков. М.,1965
56. Бартольд В.В. История культурной жизни Туркстана. Л.,1927
57. Бартольд В.В. Туркстан в эпоху монгольского нашествия. Ч.II. Исследование.
СПб. 1900
58. Березин Н.И. Очерк внутреннего устройства улуса Джучева. ТВО.УИИ.
СПб. 1864
59. Березин Н.И. Нашествие Батыя на Россию. ЖМНП. 1855

60. Березин Н.И. Первое нашествие монголов на Россию ЖМНП. 1853
61. Бичурин Иах. История первых четырех ханов из дома Чингисыва. СПб. 1829
62. Бороздин Н.Н. Столица Золотой орды-Старый Крым. Татарская Культура XIII-XIV вв. 1917
63. Ванан Ю.В. Феодалная Корея в XIII-XIV вв. М.,1965
64. Васильев В.П. Записки о монголо-татарах. ТОВРАО. СПб.1859.
65. Греков Б.Д. и Якубовский А.Ю. Золотая Орда /Очерк истории улуса Джучи в период сложения и расцвета в XIII-XIV вв./ 1937
66. Греков Б.Д. и Якубовский А.Ю. Золотая орда и её падение. М.,1998.
67. Далай Ч. Монголия в XIII-XV веках. М.,1983
68. Кара Дорж. Книги монгольских кочевников. М.,1972
69. Киселев С.В. Древняя история Южной Сибири. М.,1951
70. Ледфер. Татарское нашествие. Венгерские связи с международными событиями. Будапешт.1953.
71. Мункуев Н.Ц. Китайский источник о первых монгольских ханах. М.,1965
72. Мункуев Н.Ц. К вопросу об экономическом положении Монголии и Китая в XI-XIX вв. КСИНА. №76. М.,1965
73. Мункуев Н.Ц. Об экономическом положении Монголии и Китая. /Краткие сообщения/ института Народов Азии. 1965,№76
74. Насонов А.Н. Татары и роль /история татарской политики на Руси/ М-Л. 1940
75. Оссон Д. История Монголов от Чингиз-хана до Тимурлена. Иркутск.1937
76. Патканов К. История монголов инока Магакии XIII в. СПб. 1871
77. Патканов К. История монголов по армянским источникам. СПб. 1873-1874
78. Петрушевский И.П. Земледелие и аграрные отношения в Иране XII-XIV веков. МЛ.1960
79. Плано Карпини. История Монголов-Вильгельм Рубрук. Пертешествие в восточные страны. 1911
80. Рашид-ад-Дин Сборник летописей. Т.I, II. М-Л.1946-1960
81. Рашид-ад-Дин Сборник летописей. Т.III. М.,1946
82. Саблуков.Г.С. Очерк внутреннего состояния кипчакского Царства. ИКУ-УП. 1895
83. Тизенчуазен В.Г. Сборник материалов, относящихся к истории Золотой Орды. I, II. Икчеления и сочинений арабских. СПб. 1884
84. Татаро-монголы в Азии и Европе. М.,1977.
85. Тихвинский С.А. Татаро-монгольские завоевания в Азии и Европе. М.,1970

86. Успенский Ф.Н. Византийские историки о Монголах и Египетских мамлюках. Византийский Временник XIX Л., 1926
87. Якубовский А.Ю. Феодализм на востоке. Стоица Золотой орды Сарай Берке. Л., 1932

Дорно дахины хэлээр

А.Хятад хэлээр

88. Ван Говэй. “Мэн-гу као” /монголын судалгаа/ ҮИ боть
89. Кэ Шаоминь. “Синь Юан-ши” /Юан улсын шинэ түүх/ Шанхай. 1928
90. “Мэн-да-бэй-лу” /Монгол татарын бүрэн тэмдэглэл/ Шанхай. 1927
91. Пэн-Дая, Сюитин. “хэйда Ши Люе” /Хар татарын хэргийн тэмдэглэл/
92. “Юан-Чао-ши” /Юан төрийн түүх/ Бээжин. 1986
93. “Юань ши” /Юан улсын судар/ Шанхай-Бээжин. 1935
94. “Юань ши” /Юан улсын судар/ 4 боть. Тайпэй. 1968
95. “Юань ши” /Юаны түүх/ “Хятадын нэвтэрхий түүхийн Юаны хэсэг” Шанхай. 1985

Б.Япон, Солонгос хэлээр

96. Вада Сей. “Тао ши Кэнкюү” /Моокохэн/ /Дорнод Азийн судалгаа. Монголын бүлэг/ Токио. 1959
97. Ивамура Шинобу. “Монгору шякай Кэйзайши но кэнкюү” /Монголын нийгэм, эдийн засгийн түүхийн судалгаа/ Киото. 1968
98. Хонда Минобу. “Мокоши кэнкюү” /Монголын түүхийн судалгаа/ Токио. 1970
99. Сагуул Тоору. “Монголын эзэнт улс ба Төмөрийн улс” Ямакава Шюппиашя. 1987
100. Янай Ватару. “Мокоши кэнкюү” /Монголчуудын түүхийн судалгаа/ Токио. 1970
101. “Коре-са” /Корейн түүх/ Солонгос хэлээр. Пеньян. 1973

Өрнө дахины хэлээр

102. Allsen T.T. Mongol census taking in Rus', 1245-1275. Harvard Ukrainian Studies 5/16 198, 32-53.
103. Reprinted in Boyle, The Mongol World Empire.
104. Chan H. Liu Ping-chung: a Buddhist-Taoist statesman at the court of Khubilai Khan. T'oung-pao 53. 1967. 98-146
105. Cleaves W. “G Chancellery Practice of the Mongols in the Thirteenth and Fourteenth Centuries.. HJAS. Vol. 14. №3-4

106. Cleaves W. "The Sino-Mongolian inscription of 1346". HJAS. Vol. 15. 1952. №1-2. 29-33; 69-71.
107. "The Monks of Khubilai-khan. Emperor of China". translated from Syrian by E.A.Walles Budge.London
108. Humphreys R.S. From Saladin to the Mongols. Albany, 1977.
109. The Mongols, the Turks and the Muslim Polity. In his Islam in History. London,1973. 179-98 and 324-5
110. Langlois J.D.Jr (ed.) China under Mongol Rule. Princeton,1981.
111. Notes on Marco Polo. 3 vols. Paris, 1959-73.
112. Qazwini M.M. (ed.) 'Ata Malik Juwayni, Ta'rikh-i Jahan Gussha. 3 vols. Leiden and London, 1912, 1916, 1937.
113. Ricc A. (tr.) The Travels of Marco Polo. London, 1931.
114. The Mongol armies in Persia. Der Islam 56/1. 1979.81-96.
115. Khubilai Khan and the women in his family. In Bauer W. (ed.) Sino-Mongolica: Festschrift für Hervert Franke. Wiesbaden, 1979, 153-80.





ТАВДУГААР АНГИ

**ЧИНГИС ХААНЫ ТҮҮХЭН ГАВЪЯА,
ДЭЛХИЙ ДАХИНД ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ**

ТАВДУГААР АНГИ
ЧИНГИС ХААНЫ ТҮҮХЭН ГАВЪЯА, ДЭЛХИЙ ДАХИНД
ҮЗҮҮЛСЭН НӨЛӨӨ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Сурвалж бичиг, судалгааны зохиол

Дэлхий ертөнцийн тавцанд нэр цууд гарсан их хаад, ерөнхийлөгчдийн түүхэнд мөнхөрсөн ул мөр, үүрэг ролийг судлан бичих нь шинжлэх ухааны нэн чухал зорилт байсаар ирсэн ба одоо ч байсаар буй бөлгөө. Ийм хүмүүс нь тухайн цаг үедээ, тухайн улс орондоо эерэг ба эерэг бус үйлс бүтээж, сайн муугаар дуудуулж, бичүүлж, нэрд гарч, тодорхой орон зайг эзэлсэн түүхэн бие хүн байдаг ажгуу.

Эртний Египетийн фаронууд, Вавилоны Хаммурап хаан, Ромын Юлий Цезарь, Грекийн Македоны Александр, Энэтхэгийн Ману хаан, Эртний хятадын Хань улсын хаан, Хүннү гүрний хаан Модун Шаньюй, Францын хаан Наполеон Бонапарт, Оросын Петр I хаан, Америкийн анхны ерөнхийлөгч Жорж Вашингтон, Энэтхэгийн анхны ерөнхийлөгч Джавхарлал Неру гээд олон хаад, ерөнхийлөгчдийг нэрлэж болох билээ. Улс, орон бүхэн нэрд гарсан хаад, ерөнхийлөгч, үндэсний баатруудтай байж, түүгээрээ бахархаж, тэднээ судалж, алдаршуулж ирсэн түүхтэй. Ийм алдарт хүмүүсийн нэг хэсэг нь өөрийн улс орондоо нэрд гарсан байхад нөгөө хэсэг нь өөрийн төдийгүй хэд хэдэн оронд, бас зарим нь тив дэлхийн тавцанд алдаршсан байдаг нь хүн төрөлхтөний түүхээс тодорхой харагддаг болой.

Ийм хүмүүсийн нэгэн болох XIII зууны үеийн Монгол үндэстний нэгдсэн улсын их хаан Чингисийн түүхэн гавъяа, түүний өөрийн орондоо болон дэлхийн дорно, өрнөд дахинд үзүүлсэн нөлөөг судлан өгүүлэхдээ түүхэн сурвалж бичиг, судалгааны зохиол, эдийн ба оюуны соёлын өвд тулгуурлах нь зүйн хэрэг. Иймээс энэ тухай өгүүлсүгэй.

Эх сурвалжийг авч үзэхдээ юуны өмнө Монгол үндэстэн, монголчуудын өөрсдийн бүтээсэн хийгээд монголчуудын оролцон бүтээсэн XIII зууны үеийн эх сурвалжийг чухалчилсан болохыг ажаамуй. Үүнд: 1240 онд зохиогдсон “Монголын нууц товчоо”, мөн энэ цаг орчимд бүтээгдсэн “Алтан дэвтэр”, “Их товчоон”, 1260 онд бичигдсэн Атак Малик Жувейний “Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх”, бас л энэ цаг үед хамаарах Египетийн Макризийн “Монголчуудын түүх”, 1300-1310 онд Болд чинсан зэрэг монголын их бичгийн хүмүүсийн оролцоотойгоор туурвисан Рашид-ад-Дины “Судрын чуулган” гурван боть, XIII зууны тэргүүн хагаст зохиогдсон “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, Жужжаны “Насирийнхний хэргэм ямба”, XIY зууны

Петис Кроксын “Их Чингис хааны цадиг” зэргийг анхаарч судалбаас тэдгээр нь Чингис хааны үйл ажиллагаа, түүний үр дүн, эерэг, сөрөг тал, байгуулсан гавьяа зүтгэл, алдар нэр, Их Монгол улсын түүхэн байр суурь, нөлөөг дурьдсан бодит баримт, мэдээллийг агуулж буй учир хамгийн үнэтэй сурвалж бичгүүд болой. Дээрхи сурвалж бичгүүдийн тухай өмнөх ангиудад өгүүлсэн учир зөвхөн энэхүү зүйлд хамаарах зарим зүйлийг тэмдэглэе.

Чингис хааны хурц оюун ухаан, сэргэлэн авхаалжтай шинж, хаан хүний 35 эрдмийг төгс эзэмшсэн чадвар, эрэмгий зориг, холч бодлого, зохион байгуулах авьяас билэгтэй бөгөөд Монголын нэгдсэн улс байгуулах их зорилго тавьж, түүнээ итгэлтэй биелүүлж чадсан шинж чанарыг “Монголын нууц товчоо”-нд тод томруун харуулсан бол Рашид-ад-Дины “Судрын чуулган”-д их хааны удам угсаа, үр хүүхэд, үйл ажиллагаа, гадаад улсуудтай хийсэн аян дайны ялалт, цэргийн их бодлоготон, гарамгай жанжин байсанд холбогдох баримтыг дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг бөлгөө.

Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг ролийг судлахад XIII зуунаас хойш Монгол хүмүүсийн туурвин бүтээсэн сурвалж бичиг, зохиолууд тулгуур болох их ач холбогдолтой болно. “Алтан товч” нэртэй хэдэн зүйл зохиолын дотроос Лувсанданзаны зохиосон “Алтан товч” нэн өргөн баримт мэдээлэлтэй нь юм. Түүнд “Монгол нууц товчоо”-д байдаггүй олон зүйл, шинэ мэдээлэл, орсоны дотор “Өнчин хүүгийн цэцэлсэн шастир” дахь эрдэм ухаан, сургаал билэгийн шинжтэй баримтууд эрхэм нандин өв мөн. Өгүүлэн буй үед гарсан “Шар тууж”, Саган Сэцэний “Эрдэнийн товч”, Жамбын Онгийн голын хөндийд 1677 онд үзэглэж дууссан “Асрагч нэртийн түүх”, Гомбожавын “Гангын урсгал”, “Эрдэнийн толь”, Рашпунцагийн “Болор толь”, Галдан туслагчийн “Эрдэнийн эрх”, Инжнашийн “Хөх судар” мэт зохиолууд бүхэлдээ Их Монгол улсын түүх, эзэн богд Чингисийн намтар үйл хэрэгт холбогдох үлэмж их мэдээллүүд байгааг анхааран судлах аргагүй шаардлага бий билээ.

Их Монгол улстай хөршлөн оршиж байсан болон, аян байлдаанд эзлэгдсэн хараат, харьяат болсон улс орнуудын түүх, судар бичиг, жишээлбээс хятадын Алтан, Сүн улс, Тангуд улс, Уйгур, Хятан, Солонгос улсуудын түүх, Армян, Туркестан зэрэг дундад азийн улсууд, Орос, Иран, Турк зэрэг улс орнуудын түүх сударт тэмдэглэгдсэн Чингис хааны үзэл санаа, бодлого, үйл ажиллагаа, үүрэг ролийн тухай зүйлс мөн л чухал эх сурвалж болох үнэтэй материалууд болно. Эдгээр бүтээлийн нэр, он цаг, ерөнхий агуулга, ач холбогдлын талаар бусад ангиудын сурвалж бичиг, ном зүйд дурьдсаныг тэмдэглэе. Монгол улсын түүх хэмээх ерөнхий нэртэй манай улсын түүхийн тулгуур зохиолуудад Чингис хаан, Их Монгол улсын тухай тусгайлан анги, бүлэг, болгон бичсэн нь бий. Олон эрдэмтэн судлаачдын хамтран боловсруулж бүтээсэн “БНМАУ-ын түүх” нэгэн боть, “БНМАУ-ын түүх” гурван ботийн тэргүүн

боть, “Монгол улсын түүх” таван ботийн дэд боть, А.Амарын зохиосон “Монгол улсын товч түүх”, Ч.Бат-Очирын “Монгол улсын эртнээс уламжлан ирснийг товчлон тэмдэглэсэн бичиг”, Ч.Далайн туурвисан “Монгол улсын түүх. Их Монгол улс. 1206-1260”, М.Санждоржийн “Монгол төрийн түүхээс” Г.Гонгорын “Халх товчоон” нэртэй зохиолуудад Чингис хааны түүх, түүний байгуулсан эзэнт гүрний түүх нэгтгэгдэн боловсрогдсон ажгуу. Үүнийхээ хувьд дээрхи зохиолууд нь энэхүү ангийн тулгуур сурвалж болох ач холбогдолтой.

Монголынүндэснийэрдэмтэнсудлаачдаасолонжилийнсудалгаандаатулгуурлан, Чингис хаан, түүний төр улсын тухай дагнан бичсэн нэгэн сэдэвт зохиолууд, энэхүү ангийн судалгааны нэн үнэтэй туурвилууд болно. Үүнд Ш.Нацагдоржийн “Монголын феодализмын түүхэн замнал”, “Чингис хааны цадиг”, “Чингис хааны түүхэн роль”, Н.Ишжамцын “Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь”, Ч.Далайн “Их Монгол улс”, Ч.Жүгдэрийн “Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ”, “Чингисийн төрийн үзэл, цэргийн эрдэм”, Ж.Болдбаатарын “Түүх зулсан он жилүүдийн ойлго”, И.Дашнямын “Чингисийн хаант улсын төр, хууль цааз”, Н.Лүндэндоржийн “Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага”, Х.Сэлэнгийн “ХШ зууны Монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл” зэрэг философич, түүхч, хуульч эрдэмтдийн эрдэм шинжилгээний зохиолууд дорвитой байр суурь эзэлнэ.

Монгол улсын мөнхийн хөрш Орос, Хятад хоёр Улсын эрдэмтэд, монгол судлаачдын Чингис хаан, Их Монгол улсын талаар тусгайлан явуулсан судалгаа, шинжилгээний ажил, түүний үр дүн болж туурвигдсан зохиол бүтээлүүд арвин бий. Эдгээрийг бүрэн судалж, нэгдсэн дүгнэлт, үнэлэлт гаргах нь Чингисийн үүрэг ролийг тодорхойлоход асар ач холбогдолтой юм.

Оросын эрдэмтэн В.В.Бартольд, Н.Н.Березин, Б.Я.Владимирцов, С.Кафаров, Н.Я. Бичурин, Б.Д.Греков, А.Ю.Якубовский, В.А.Рязановский, С.А.Тихвинский, Н.Ц.Мункуев, Доржи Банзаров, К.Патканов, Ш.Цэдэнжаланов, Г.В.Вернадский, Л.Н.Гумилев, Е.И.Кычанов, А.Дугин зэрэг эрдэмтэд судлаачид Чингис хаан, түүний эзэнт гүрнийг судлахад их хувь нэмэр оруулсан олон арван зохиолыг туурвин бүтээсэн билээ. Түүний дотор В.В.Бартольдын “Монголын довтолгооны үе дэхь Туркестан”, “Туркестаны соёлын амьдралын түүх”, Н.Н.Березины “Зүчийн улсын дотоод зохион байгуулалтын найруулал”, Н.Я.Бичурины “Чингисийн удмаас төрсөн анхны дөрвөн хааны түүх”, Б.Я.Владимирцовын “Чингис хаан”, Е.И.Кычановын “Ертөнцийг эзэгнэн дагуулсан Тэмүжиний амьдрал”, Т.Д.Греков, А.Ю.Якубовский нарын “Алтан орд түүний уналт”, Н.Ц.Мункуевын “Монголын анхны хааны тухай хятад сурвалж”, К.Паткановын “Армянний эх сурвалжууд дахь монголчуудын түүх”, А.Дугины

“Геополитикийн үндсүүд”, Г.В.Вернадскийн “Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс”, В.А.Рязановскийн “Чингис хааны их засаг” зэрэг олон үнэ цэнэтэй зохиолууд бий бөлгөө.

Ренчин Хар Даваагийн “Суут жанжин Чингис хаан, түүний өв”, Г.В.Вернадскийн “Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс” II зохиолд Чингис түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, түүний эзэнт улсын дэлхий дахинд үзүүлсэн нөлөөг шинэлэг үзлийн үүднээс тодорхойлон гаргасан нь их анхаарал татаж байна.

Хятад улсын эрдэмтэд Монголын эзэнт гүрэн, их Чингисийн талаар сурвалж бичиг судалгааны арвин сангайн дээр тус орны эрдэмтэд нэн олон бүтээл туурвисан нь түүхнээ үлдсэн ажээ.

Хятадын улсуудын /Алтан улс, Сүн улс, Мин улс гэх мэт/ түүх, шастираас гадна тус орны эрдэмтэд, судлаач, сэтгэгчдийн бүтээсэн олон арван зохиол бүтээлүүд байдаг билээ. Тэдгээрийн дотор “Монголын эзэнт улсын түүх”, “Чингис хаан”, “Монголын судалгаа”, “Түүхийн судлал”, “Богд баатарын биеэр дайлсан тэмдэглэл”, “Хар татарын хэргийн тэмдэглэл”, “Чингис хааны намтар”, “Монгол-татарын бүрэн тэмдэглэл”, “Юан төрийн түүх”, “Юан улсын түүх”, “Монголын түүхэн тэмдэглэл”, “Алтан ордны тайлга”, “Богд Чингис хааны цадиг” зэрэг суурь зохиол бүтээлүүд байгаа болно. Булагийн “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, Сайшаалын “Чингис хааны товчоон” хоёр боть, Дорнотивийн “Чингисийн цэргийн эрдэм”, Тогтохын “Эсгий туургатны түүх” хоёр дэвтэр, Чжи Яотины “Чингис хаан”, Бархаусены “Чингис хааны хаант улсын түүх”, Ван Говэйн “Монголын судалгаа”, Дадасборугийн “Чингис хаан”, Ян Наны “Дэлхийг байлдан дагуулагч” болон хэд хэдэн зохиогчийн бичсэн “Чингис хааны намтар” зохиолууд гол байр эзэлж буй. Сайшаалын “Чингис хааны товчоо”-нд “Чингис хааныг хэрхэн үнэлэх”, “Чингис хаан бол монгол үндэстний анхдагч агуу их төрийн зүтгэлтэн”, “Чингис хааны улс байгуулсан их гавьяа”, “Чингис хааны дэлхийн соёлд оруулсан хувь нэмэр”, “Чингис хааны түүхэн байр суурь”, “Чингис хаан бол цэрэг дайны шалгарсан бодлоготон”, “Чингис хааны үзэл санаа” гэх зэрэг сэдвүүдээр Хятад Орос, Ираны эрдэмтэдийн зарим зохиолуудыг харьцуулан судалсан баримтуудад тулгуурлан бичсэн нь судалгааны нэн чухал ач холбогдолтой болой.

Чингис хаан, түүний үүрэг, үйл ажиллагааг судлахад Японы эрдэмтэд судлаачдын зохиолууд чухал үүрэг рольтой байна. Тэд олон сайхан зохиол бүтээлүүдийг туурвисан байдаг. Заримыг нь дурьдвал, Вада Сейн “Дорнот азийн түүхийн судалгаа. Монголын бүлэг”, Янай Ватарын “Монголчуудын түүхийн судалгаа”, Эгами Намиогийн “Морьтон үндэстний түүх”, Нака Мичиегийн “Чингис хааны үнэн зөв тэмдэглэл”, Кабаяши Такаширогийн “Чингис хаан”, Вакамацу Хирошийн “Монгол их засаг”, Хонда Минобугийн “Монголын түүхийн судалгаа”, Мураками Масацугийн “Монголын

эзэнт улсын үүсэл, бутрал”, Сагуул Тооругийн “Монголын их эзэнт улс ба Төмөрийн улс”, Сугияма Масаокын “Их Монголын ертөнц”, Сакеэ Шигаитакийн “Чингис хаан”, Окушикэ Ширугийн “Чингис хаан”, Уймаймото Сэтайзугийн “Чингис хаан” Ооба Яхайн “Чингис хааны бүрэн намтар”, Чиюку Ротайрын “Чингис хааны байлдааны түүх” зохиолууд гэх мэт. Япон орон Чингис хааны аян байлдаанд өртөгдөөгүй билээ. Иймээс Японы эрдэмтэд судлаачдын бүтээл нь хөндлөнгийн судалгаа шинжилгээ, дүгнэлт үнэлэлт хийж, Чингисийн үүрэг ролийн судалгаанд хандсан онцлогтой болох нь ажиглагддаг. Энэ талаар цаашид өгүүлэх болно.

Чингис хааны түүхэнд эзлэх байр суурийг тодорхойлох, үүрэг ролийг судлахад Өрнөдийн болон бусад орны судлаачдын зохиолууд их учир холбогдолтой бөлгөө. Тэд Чингис хаан, түүний улсын тухай судалгааг дээр үеэс явуулж, үлэмж амжилт олсны дүнд олон арван жинтэй зохиолууд туурвигдан дэлхий нийтийн хүртээл болж, Чингис хааны судлалд их хувь нэмрийг оруулсан ажээ. Ийм бүтээлүүдийг туурвин бүтээхэд Англи, Франц, Америк, Герман, Итали, Турк, Армян, Чехсловак, Польш, Иран, Сири, Египет, Ирак, Энэтхэг, Солонгос зэрэг олон орны эрдэмтэн судлаачид оролцсон нь гайхамшигтай юм. Эдгээрээс зарим томоохон зохиолуудыг нэрлэх нь зүйтэй болов уу.

ХҮI зууны үеийн Ираны түүхч Хондемирийн “Эрт үеэс Төмөрийг хүртэлх үеийн Монголын түүх”, ХҮIII зууны Хивангийн Хан Абул-Гази Бахадурын бичсэн “Монгол татарын түүх” болон Уэльсийн “Дэлхийн түүхийн программ”, СС.Уолкерийн “Чингис хаан”, Рене Руссийн “Орчлонг эзэгнэнч Чингис хаан”, “Талын гүрнүүд” /1975/, Петис де ла Крайхын “Чингис хааны намтар” /1710/, Гаубилын “Чингисийн намтар” /1739/, Д.Оссоны “Монголчуудын түүх” /1924/, Ховартын “Монголчуудын түүх” /1888/, Фернан Гренарын “Чингис хаан” /1935/, Ф.Краузын “Чингис хаан” /1922/, Ральф Фоксын “Чингис хаан” /1936/, О.Латтиморын “Хятадын дотоод Азийн хил” /1940/, Ж.Саундерсын “Монголын байлдан дагуулал” /1971/, Е.Д.Филлифсын “Монголчууд” /1969/, Е.Х.Паркерын “Татарчуудын 1000 жил” /1924/, Ф.Эрдманны “Ялагдашгүй Чингис хаан” /1862/, Р.К.Дугласын “чингис хааны амьдрал” /1877/, Б.Спулерийн “Монголчуудын түүхэнд эзлэх байр суурь” /1971/, Гарольд Дэмбийн “Чингис хаан ба Алтан орд, Оросын дундат зууны түүхэнд үзүүлсэн нөлөө” /1987/, “Чингис хаан”, Паул Рачневскийн “Чингис хаан” /1983/, Райхолд Нейман-Хоицын “Чингис хаан”, Херберт Франкын “Монголын байлдан дагууллын үеийн Ази ба Европ /дэлхийн түүхийн нэг бүлэг/”, Мишель Хоангийн “Эзэн хаан Чингис”, “Дэлхийн түүх” зохиолын IY боть зэргийг дурьдаж болох юм. Түүнчлэн энэ сэдэвт холбогдох олон зуун эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, түүхэн зураг, түүх дурсгалын зүйлс байдгийг тэмдэглэвэл зохино. Ялангуяа Францын Рене Русс “Орчлогч эзэгнэгч Чингис хаан”, Фернан Гренер “Чингис хаан”, Английн Ж.Саундерс “Монголын байлдан дагуулал”,

Гарольд Дэмбэ “Дэлхийн эзэн Чингис хаан”, Жек Редофордын “Өнөөгийн ертөнцийг үндэслэгч Чингис хаан” хэмээх зохиолдоо Чингис хааны дэлхийн хэмжээний хүн болох түүхэн роль, дэлхийн талыг байлдан дагуулж Монгол гүрний эзэн хаан болсон алдар хүнд, цэргийн гарамгай жанжин, хийгээд түүний хурц оюун ухаан, их эрдэм мэдлэг, авьяас билэг, шударга, нийгүүлсэнгүй шинжийг бодит байдал, баримтад тулгуурлан их л гэгээлэг байдлаар тодорхойлсон нь Чингис судлалд нэн чухал ач холбогдолтой юм. Тэд Чингис хааныг Евразийн номлолыг үндэслэгч гэж үзэн, түүний эзэнт гүрний дорно, өрнө дахин ялангуяа Хятад, Орос, дундад ази, Тав европод үзүүлсэн улс төр, эдийн засаг, соёлын нөлөөг шинжлэн судалж, дүгнэсэн нь эдүгээ цагт асар их үнэ цэнэтэй болно.

Чингис хааны үүрэг роль, үзэл баримтлал, дүр төрх, зан чанар, авьяас билэг, эрдэм чадвар, түүнээс их Монгол улсыг байгуулсан үйл явц, хийсэн аян дайн, дэлхийн улс орнуудад үзүүлсэн нөлөөлөлийн тухай сурвалж бичиг, ном зохиол, баримт материал хангалттай их бий. Эдгээр нь бүхэлдээ энэхүү ангийн сурвалж, судалгааны зохиол, бүтээлүүдийн цөм болж байгаа бөлгөө. Гэхдээ энэ нь энэ талаархи судалгаа, шинжилгээг бүрэн хийчихсэн байна гэх буюу бүрэн хангалттай болчихлоо гэсэн хэрэг биш. Харин улам гүнзгийрүүлэн судлах, улам ихийг бүтээн туурвих шаардлага байгаа гэдгийг тэмдэглэвэл зохимой.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

Чингис хааны үзэл баримтлал, түүхэн гавъяа

§1. Чингис хааны улс төрийн үзэл бүрэлдэн төлөвшсөн нь

Чингис хааны улс төрийн үзэл бүрэлдэн тогтсон нь Монгол үндэстний нэгдсэн улсыг байгуулах нөхцөл бүрэлдсэнтэй амин холбоотой болой. Цаг хугацааны хувьд XII зууны эцэс XIII зууны эхээр ийм нөхцөл бүрэлдсэн бөгөөд түүний явцад тэр үеийн олон язгууртны дотроос нэг нь товойн тодорч, нэгдсэн улс байгуулах үзэл баримтлалыг толгойлон боловсруулж хэрэгжүүлэх нь зайлшгүй байв. Есүхэй баатар, Нэгүн тайж, Даридай Отчигин, Тоорил ван, Жамух сэцэн, Есүхэйн Тэмүжин, Найманы Таян хан, Нэгүн тайжийн хөвгүүн Хучар, Хотула хааны хүү Алтан, Мэргэдийн тэргүүн Тогтоа бэхи, Ван ханы хөвгүүн Сэнгүм, Таян ханы хөвгүүн Хүчүлүг, Жүрхэн аймгийн тэргүүн Сача-бэхи, Онгуд аймгийн эзэн Алгуш-тегин, Татар аймгийн ноён Мэгужин сүүлт зэрэг язгууртнуудын дотроос Тэмүжин шалгаран тодорч монголчуудын хамгийн хүчтэй нөлөө бүхий удирдагч болжээ. Үүнийх нь хувьд түүний өмнө хатуужин боловсорч, ухаан санаагаа тэлэн хөгжүүлж, Монгол угсаатныг нэгтгэж, нэгэн улс болгох, түүнд тохирсон засаглал, хууль цаазын үзэл баримтлалыг боловсруулах үүргийг түүх өөрөө тулган тавьсан ажгуу.

XII зууны далаад оны дунд үеэс Есүхэй баатарын хүү Тэмүжин нас бие тэнцэж улс төрийн тавцан дээр гарч ирсэн явдал тэр үеийн нөлөө бүхий язгууртнуудыг хөдөлгөөнд оруулж, авьяас билгээ дайчлан өрсөлдөх үйл явц эрчимжин, аймаг, ханлигуудын хоорондын харилцаа, үйл ажиллагаа эрс идэвхижсэн байна.

Чухамхүү энэ үеэс Чингисийн улс төрийн үзэл бүрэлдэх үйл явцад шинэ үе эхэлсэн түүхтэй. Чингисийн улс төрийн үзэл бүрэлдэн төлөвших үйл явц гурван үе шатыг дамжин явагдсан байна. Үүнд: 1175-1189 он буюу Хамаг Монгол улсыг сэргээн байгуулах хүртэлх нэгдүгээр үе. 1189-1206 он буюу Монголын нэгдсэн улсыг тунхаглах хүртэлх хоёрдугаар үе. 1206-1227 он буюу Чингис хааны нас барах хүртэлх гуравдугаар үе болно. Эл гурван үе нийтдээ Чингисийн амьдралын хүүхэд ахуй наснаас эхэлж залуу, идэр, ид, өтлөх насыг нь хамран нийтдээ 50 орчим жил үргэлжилсэн бөлгөө.

Энэхүү хугацаанд Чингисийн улс төрийн үзэл бүрэлдэх, төлөвших, шинэ үзэл онол боловсруулах, түүнээ хэрэгжүүлэх, цаашид боловсронгуй болгох дэс дараалсан үйл явц тасралтгүй явагдсан ажээ. Чингэхдээ эдгээр үйл явц нь хий хоосон санаанаас бус нийгмийн бодит амьдрал, түүнд гарсан өөрчлөлт, амьдралын өмнө тулгарсан зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга зам, хэрэгцээ, гарсан үр дүн, сургамж зэрэгтэй холбогдож, улам бүр урагшлан давших амьдралын шаардлыг тусгаж байсан байна.

Чингисийн улс төрийн үзэл бүрэлдэн төлөвшсөн үе шат тус бүрийн гол агуулгыг авч үзье. Өөрөөр хэлбэл Тэмүжин нэртэй хүүхэд ахуй цагаас улс төрийн үзэл нь бүрэлдэж эхэлжээ. Аймаг, ханлиг толгойлж, газар нутаг, харьяат иргэдээ захирч ирсэн эцэг, өвөг эцэг, элэнц, хуланц эцгийнхээ болон эцгийн ба өөрийнхөө анд нарын ахуй нөхцөл, сургаал зэмлэл, бодол санаа, энэ бүхэн түүний үзэл бүрэлдэхэд ихээхэн нөлөөлсөн аж. Ялангуяа Амбагай сэцэн, Хотула хан, Есүхэй баатар, Өүлэн эх, Хуагчин эмгэн, Чирха өвгөн, Мэнлиг эцэг, Даридай отчигин, Сорхон шар, Наху баян зэрэг хүмүүс онцгой рольтой байжээ.

Чингис өөрийн эцгийн удмын Амбагай сэцэн хан татар аймагт баригдаж Алтан улсад хороогдохдоо “Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдогтун” гэсэн гэрээсийг болгоон тунгаахгүй явсан гэж бодвол эндүүрэл болохсон биз. Чингисийн эцэг Есүхэй 9 настай хүү Тэмүжингээ дагуулан олхонуд аймагт очихул Хонгирадын Дай сэцэн тааралдаад”Энэ хөвгүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хөвгүүн байна” /50.38/ хэмээн өгүүлсэн нь Тэмүүжин хүүхэд ахуй цагаасаа эхлэн сэргэлэн жавхаалаг, сэтгэл, нүүрний өнгө талбиун тайван, хүний итгэлийг татах увдистай байсныг харуулах бус уу. Эцгээ татарчуудад хорлогдон насан өөд болсоныг хараад маш ихээр гаслан эмгэнэж байгаа Тэмүүжинд хандаж хонхотаны Чирха өвгөн “Тул загас мэт юунд тулбиран гасална чи. Туурга цэргээ /Тогон цэрэг/ бэхэлье гэж тууштай үгээ хэлэлцсэн биш билүү?” /50.43/ гэхэд уйлахаа зогссон нь түүний ухаан санаа тэрхэн агшинд маш хүчтэй төвлөрч, улс гэрийн тухай бодолд автсан нь илт. Үүний дараахан Чирха өвгөн Өэлүн эх түүний хүүхдүүдийг орхин нүүсэн хүмүүсийг ятгах гэж яваад шархадаад ирсэн Чирха өвгөн “Чиний сайн эцэг чинь насан эцэслэснээс хойш манай аймгийн цэргүүд чамд захирагдахаа больж, тэд чамаас салж явцгааж байна. Би түүнд нь саад болох гэсэн юм. Гэтэл дээд тэнгэрээс тогтоосон миний амьдралын төөрөг тийм л байсан юм байлгүй гэнэт л намайг оночихлоо” /1.236/ гээд нас баржээ. Энэ үгийг сонсож, түүний нас барсныг харсан Тэмүжин маш их уйман уйлжээ. Өэлүн эх өөрийн биеэр туг барьж мордоод, орхиж явсан иргэдийг буцаан авчрах, хүүхдүүдээ өсгөж, гэжээх гэж яаж зовж зүдэрч явааг ойлгон эхээ өрөвдөх, бутрал сарнил, өрсөлдөөн мэтийг ухаарах, эдгээрийн талаар эргэцүүлэн бодох, түүнээс гарах учир шалтгаан, арга замыг сүвэгчлэх хэлбэрээр Тэмүүжиний үзэл санаа бүрэлдэн, улс төрийн үзэл суух үйл явц явагдаж байсан ажээ. Ялангуяа Тэмүүжин Бөртэ Үжинтэй ханилан сууж, Сорхон шар, Боорчи, Мухулай, Зэлмэтэй нөхөрлөж, Тоорил ван, Жамуха нартай анд бололцсон үеэс улс төрийн үзэл бүрэлдэх үйл явцад нь эргэлт гарч шинэ үе эхэлжээ. Тэмүжин эцгийн гэрээсийг биелүүлж, түүний захирсан улсыг сэргээн байгуулахыг зорилгоо болгосон нь энэ үе дэх улс төрийн үзлийнх нь гол баримтлал болсон байна.

Ван ханыг Туулын шугуйд нутаглаж байхад нь Тэмүүжин дүү нарынхаа хамт зочилж, эцгийн хуучин анд та миний эцгийн адил буюу хар булган дахаа бариад харьяат иргэдээ цуглуулахад туслахыг гуйхад Ван хан ихэд баясан “хагацсан улсыг чинь хамтатгаж өгье. Бутарсан улсыг чинь цуглуулж өгье. Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг” /50.61-62/ гэж амалжээ. Тэмүүжин мөн өөрийн анд Жамухад хандаж “Өст мэргид ирж өрий минь өвтгөв... түшиг болох өнөр төрлийн та нар өшөөг авч өгнө үү” гэхэд Жамуха хариуд нь “мэргэд аймгийг эвдэн мөхөөж эхнэр Бөртийг эргүүлж авчирья” /50.63/ гэж хэлжээ. Энэ бүхнээс үзэхэд. Тэмүүжиний үзэл санаанд эцгийн захирч байсан хамаг монгол улсыг сэргээн байгуулах гэсэн бодол боловсорч байсан нь илт байна. Чухамдаа энэ үеэс эхлэн Хамаг монголыг сэргээх зэвсэгт тэмцэл явуулж, өөрийн үеийн улс төр, цэргийн зүтгэлтнүүдтэй ухаан бодлоо уралдуулж, үйл ажиллагааныхаа стратеги, тактик, арга барилыг боловсруулан хэрэгжүүлэх болсон нь Тэмүүжинд улс төрийн хатуужил сууж, үзэл бодол төлөвшихөд их нөлөө үзүүлжээ хэмээн үзэж болно.

Тэмүүжинг 1189 онд Хамаг Монгол улсын хаанд өргөмжилж Чингис цол олгосон цагаас түүний улс төрийн үзэл ялангуяа төрийг үзэх үзэл бодит зүйл болж хэрэгжиж эхлэх болсон аж. Энэ нь Тэмүүжинд асар өндөр хариуцлага ногдож байгааг ухаарч, ихэд хатуужин боловсрохыг хичээх болсонтой холбоотой байсан биз ээ. Энэ үеэс түүний улс төрийн үзэл боловсрон төлөвших хоёр дахь шат эхэлжээ.

Хамаг Монголын толгойлогч болмогцоо нэр сүр, эрх мэдлээ бэхжүүлж, хишигтэн цэрэг байгуулан, ордныхоо сайд, чэрби нарыг томилж, харьяат иргэдээ аравтлах системээр захирах арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ нэг талаар Хамаг Монголын хаадын өмнөх уламжлалыг сэргээж, нөгөө талаар хант төрийг бэхжүүлэх шинэ санаа бодлоор хандсан нь түүний улс төрийн үзлийг ихээхэн гүнзгийрүүлжээ.

Тэмүүжин хамаг монголыг сэргээн байгуулж, түүнийг толгойлох болсоноор үзэл, бодол нь хязгаарлагдсангүй харин ч улам өрнөн хөгжжээ. Бага ахуй наснаасаа өнчрөл, зовлон, зүдгүүр, хоосрол, атаархал, хонзогнолын гай гамшгийг амсаж, бутран сарнисан овог аймаг, ханлигуудын сөргөлдөөн, хүн амын ядуурал, аж ахуйн доройтол, гаднын хүчний өнгөлзлөг, дээрэм тонуул зэргийг бие сэтгэлээрээ мэдэрч, энэ бүхнийг даван туулж, дэвшил хөгжилд хүрэхэд монголчуудын хүчийг нэгтгэн хүчирхэг улс байгуулах нь зүйтэй юм байна гэсэн нэгэн үзүүрт бодлогод тулж очсон ажээ. Энэ нь эл үеийн Чингис хааны улс төрийн үзлийн оргил, зорилго, зорилтын дээд нь болсон байна. Энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд:

Нэгдүгээрт, өөрийн чиг бодлогод үнэнч, ямар ч нөхцөлд бүх хүчээ зориулан зүтгэх бодит хүчнийг төрүүлэн гаргах бодлогоо явуулжээ. Ийм хүчнийг бүрдүүлж чадсан бөгөөд тэр нь түүхэнд “Чингисийн нөхөр” хэмээн нэрлэгдсэн болой. Доктор Ч.Жүгдэр “Нөхөд гэдэг бол ноёндоо жинхэнэ ёсоор үйлчлэх үүрэгтэй чөлөөт байлдагч юм.

Жинхэнэ нөхөр болохын тулд андгай тангараг тавина.....Нөхөд бол эзнийхээ гэрт зарц, дайн ба довтолгооны үед байлдагч, хүрээ ав хийхэд хавсарч болдог байв. Нөхрийн шалгуур эзэндээ үнэнч байх явдалаар илэрч байсан байна” /35.92/ гэж нөхдийн шинж байдлыг дүгнэн бичжээ. Чингисийн “нөхөр”-ийн цөм нь Чингисийн “есөн өрлөг” байсан байж болох. Есөн өрлөгийн нэрийг өмнөх ангид дурьдсан бөлгөө. Эл есөн өрлөг нь Чингис хаанд чин үнэнч, хамгийн шалгарсан улс төрийн зүтгэлтэн, цэргийн гарамгай жанжин, эр зоригт баатар, байлдагчид байж, нэгдсэн улс байгуулахын төлөө бүхнээ зориулсан тэмцэгчид байсан бөлгөө. Эдгээр нөхдийн аль эрдэм, чадалтайг нь төрийн түшээ, цэргийн жанжин дарга болгон сонгох замаар төр, цэргийн зүтгэлтнүүдийг боловсруулан бэлтгэжээ. Ялангуяа Мухулай, Боорчи, Зэв, Зэлмэ, Сүбээдэй, Шихихутаг Хубилай нар тодрон гарч ирсэн нь нэгдмэл улс байгуулахад түүхэн үүрэг гүйцэтгэсэн болой. Мөн түүний дүү Хасар, Бэлгүтэй, хүү Зүчи, Цагаадай, Өгөдэй, Тулуй нар алдарт хүчирхэг үйл хэрэг, ариун бадрангуй үйлсээрээ алтан ургийнхны нэр төр, сүр хүчийг өргөсөн бөлгөө.

Хоёрдугаарт, монголчуудыг нэгтгэх бодлого, үйл явцад саад болж сөрсөн хүчнээс зоригтой ангижирч, зэвсгийн аргыг хослуулах замаар нэгдсэн улс байгуулах үйл ажиллагааг эрс шийдвэртэй, эргэлт буцалтгүй явуулах бодлогод шилжсэн байна. Энэ үед хичнээн хэцүү байлаа ч гэсэн Тоорил, Жамуха, Таян мэт нэр төртэй олон өрсөлдөгчдөөсөө салж, нэгдмэл улс байгуулах эцсийн зорилгодоо захирагдаж чаджээ.

Гуравдугаарт, өөрийн улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө Монгол угсаатныг нэгтгэж, байнгын шахам дажин хямралыг даван туулах, аж төрөл, амьдрал ахуйгаа тайван нөхцөлд явуулж, хэвийн амьдралыг эрмэлзсэн хүн амын бүх давхаргын хүсэл сонирхолтой үзэл бодлоо нягт холбох арга, тактикийг уран чадмаг хэрэглэхэд үйл ажлаа чиглүүлж чаджээ. Энэ бүхнийг хангах бодлого, ухааныг боловсруулахад эрдэм чадал дадлага туршлагатай хүмүүсийг оролцуулах, авъяас чадвар, оюун билгийг нь тунгаан харгалзах, тэдгээрийг зангидан чиглүүлэх үүргийг Тэмүүжин шууд өөртөө хүлээн авсан байна. Дурдан буй цаг үед Тэмүжин улс төрийн хатуужил олж, зан чанарын хувьд төлөвшин үлэмж их зориг тэвчээр гарган, ухаан бодлоо саруулсгахад маш их анхаарал, хүч чармайлт тавьжээ. Чухам эл үед монголын нэгдсэн улсын төр, хууль цаазын тогтолцооны онолын үндсийг боловсруулсан билээ.

Энэ талаар дараагийн зүйлд өгүүлэмз.

Чингис хаан, энэ үзэл бодлоо хэрэгжүүлэхийн төлөө тэмцэх явцад олон хүнд эсэргүүцэл, хуйвалдаан, довтолгоо, тулалдаан, бэрхшээл зовлонг даван туулж, түүнийхээ хэрээр өөрөө хатуужин төлөвшжээ. Тэрээр Монгол угсаатныг нэгтгэхэд хэрэйд, найманы ханлиг, мэргэд татаарын холбоо, тайчууд, Жүрхэн аймаг тэдгээрийг удирдаж байсан хүмүүсийн эсэргүүцэл, довтоллыг удаа дараа няцаахын хамт олон

удаа зэвсэг агсан тулалдаж ялалт байгуулсаны үр дүнд Монголын үндэстний их улсыг байгуулсан ажгуу. Энэ тухай “Монгол улсын түүх”-д Тэмүүжин 1185-1206 оны хооронд их,бага 32 удаагийн дотоодын дайн тулалдааныг өнгөрүүлж /54.52/ хатуужсан гэж бичсэн байдаг билээ. Монголчуудыг нэгтгэх үйл явцад хатуужих төдийгүй улс төрийн бодлого, төрийг засах ухаан, цэргийн жанжны урлагт суралцаж 20 гаруй жилийн амьдралаа өнгөрүүлсэн нь бие хүний хувьд бага бус хугацаа болно.

Чингис хаан монгол угсаатны нэгдсэн улсын хаан болсон үеээс туулсан амьдрал, хатуужсан сургамж, сурсан эрдэм, ухаарсан бодол сэтгэхүйдээ тулгуурлан улс төрийн үзлээ шинэ түвшинд гарган хөгжүүлж, монголын хэмжээгүй эрхт хаант улсын төр, хууль цааз, цэргийн номлол, сургаалыг боловсруулан хэрэгжүүлсэн түүхэн гавьяаг эдлэх зүй ёсны эрхийг суут авьяас билгээрээ олж авсан хэмээн лавтайяа хэлж болно. Энэ тухай дараа өгүүлнэ.

Чингис хаан бүх Монгол аймаг ханлигуудыг нэгтгэж, Монголын үндэстний их улс /Монголын нэгдсэн улс/-ыг байгуулсаны дараа түүний улс төрийн үзэл тус улсын гадаад бодлого, хөрш улс орнуудын бодлоготой холбогдон цаашид гүнзгийрэн хөгжсөн байна. Энэ нь Тангуд, Алтан улсад довтолж, хар Хятан, Уйгурын улсыг эрхшээлдээ оруулсан үеэс эхэлсэн болой. Энэхүү үеэс Чингисийн улс төрийн үзэл төлөвших гурав дахь үе шат эхэлсэн байна.

Монголын нэгдсэн лус байгуулагдмагцаа өөрийгөө хөрш улсуудаар хүлээн зөвшөөрүүлэх, заримыг нь хараат болгож алба авах, торгоны замыг нэлттэй байлгаж чөлөөт худалдаа арилжаа хөгжүүлэх бодлого явуулсан нь төдий л үр дүнд хүрээгүй учир дэлхийн хэмжээнд хамаарах улс төрийн бодлого явуулах үзэл баритлах боловсруулж хэрэгжүүлэхэд хүргэжээ. Үүнтэй уялдан “Тэнгэрт нэг бурхан, газарт нэг хаан байх ёстой” гэсэн Чингисийн үзэл боловсорсон байж болох. Чингис хаан Хятадын Алтан улсын шинэ хаан “даяарт зарлиг тарааж сөгдөн хүлээтүгэй” гэснийг сонсоод Алтан улсын элчтэй уулзан “танай улсын хаан хэн бэ?” гэхэд элч “Вэй Шу ван болой” хэмээхэд “Дундат орны хаан нь тэнгэрээс заяасан хүн хэмээн би боддог бөлгөө. Харин ийм хөдөөх амьтан бас байх ажгуу.

Түүнд хэрхэн сөгдөх вэ?” /71.27/ гэж хэлсэн байдаг. Үүнээс үзэхүл Чингис хаан өөрийгөө тэнгэрээс заяасан хаан, түүний бүх үйл ажиллагааг тэнгэрээс тэтгэн дэмждэг агаад эл Алтан улсын хаанаас ч өөрийгөө дээрд хэмээн үзэж, өмнө нь сөгдөхийг огтхон ч хүсэхгүй байсан нь түүний улс төрийн үзлийн нэгэн илэрхийлэл байсан биз.

Тангуд, Алтан, Уйгур, Хар Хятан улс, Дундат Ази, Афганистаны нутаг дэвсгэрийг бүхэлд нь эзэмшсэн Хорезмын улс, Оросын вант улсууд, Ирак, Болгари, Унгар улсад тэнгэрээс заяасан газар дээрхи ганц хаан гэсэн Чингисийн үзэл улам лавширч, бүх улс орон миний улстай харилцаж, алба татвар төлж, миний хараа эрхшээлд байх ёстой

хэмээхэд бат итгэж, түүнийг нь бүх сайд жанжин, түшмэд, харьяат иргэд нь дэмжин болгоож, эзлэгдсэн улс орнууд, янз бүрийн шашин санваартнууд ч “ертөнцийн эзэн” хэмээн хүлээн зөвшөөрөхөд хүрсэн ажгуу.

Дээрхи нөхцөл байдлаас урган Чингис хаан бол ертөнцийн их хаан түүний эзэнт улс нь дэлхийн их гүрэн, баримталж буй гүн ухаан, ёс зүй нь шинэ агаад хүчтэй гэсэн үзэл санаа дэлгэрсэн байна. Үүнийг боловсруулагч нь Чингис хаан бөгөөд тэрээр туулсан их амьдралын дадлагадаа тулгуурлахын хамт, өвөг дээдэс, ахмад буурлууд, янз бүрийн улс орон ялангуяа өөрийн төрдөө ажиллаж байсан хятад, зүрчид, түвд, хятан, уйгур, иран гаралтай эрдэм номтой хүмүүс, уулзан учирч бас харилцаж байсан олон улсын хаад, тэдгээрийн элч төлөөлөгчид, ноёд, худалдаачид, жуулчид, зохион бүтээгчид, уран дархчууд, гар урчуудын их мэдлэг, туршлагаас үргэлж суралцаж, үзэл баримтлалаа гүнзгийрүүлсээр байсан бөлгөө. Иймээс ч “Чингис хаан үйл ажиллагаа, зан авираараа, ялалт ололтоороо дэлхий дахинд шинэ ёс зүй, шинэ гүн ухааныг бий болгосон юм” хэмээн философич доктор Б.Даш-Ёндон бичсэн байдаг /78.7/.

Энэ үед Чингис хааны улс төрийн үзэлд Дэлхийн хамгийн хүчирхэг гүрэн Монгол үндэстний их улс ба түүний их хаанд бүх улс орнуудын хаад гүн хүндэтгэлтэй хандаж, үнэнхүү хүчирхэг улс болохыг нь хүлээн зөвшөөрөх, эзлэгдсэн улс орныг захирах хааны төлөөний сайдуудаар дамжуулан тэдгээрээс алба татвар авах, улс орнуудтай эвтэй байх, харилцан бие биенээ хүндэтгэх, өөр хоорондоо өргөн худалдаа арилжаа хийх, эдийн засаг, соёлоо хөгжүүлэх, түүний ололт, үр дүнг бие биедээ аль болохоор нэвтрүүлэх, эрдэм номын мэргэд, худалдаачид, жуулчид, иргэд харилцан чөлөөтэй зорчих, өөрсдийн дуртай шашнаа шүтэх, биесээ хуурч мэхлэхгүй байх зэрэг нь эл үеийн Чингис хааны улс төрийн үзлийн гол агуулга байжээ.

Чингис хааны алив шашныг ялгаварлан гадуурхалгүй адил хэмжээнд үзэх, эзлэгдсэн орны ард түмэн өөрийн дуртай шашнаа шүтэх, аль ч шашныг дэмжиж, санваартан нарыг хүндэтгэх үзэл нь Монгол гүрний нэр төр, хүчин чадлыг өргөх эрхэмсэг соёл байсан бөлгөө.

Чингис хаан өөрийгөө нас барсны дараа Монголын эзэнт гүрэн хэрхэн хөгжих үзэл баримтлалын үндсийг боловсруулсан болой. Чингис хаан “Мөнх тэнгэрийн ивээлээр явснаараа манай амгалан, зугаатай, жаргалтай амьдрал өдгөө болтол үргэлжилж байгаа билээ. Ирээдүйд таван зуу, мянга, арван мянган жилд ч хэрэв нарт хорвоод төрж, хаан төр барих удмынхан минь аль ч улс түмэн хэрэглэхээр Чингис хааны ёс заншил /йусун/, Засаг хуулийг /йасах/ өөрчлөлгүйгээр сахивал тэдний гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, тэд хэзээ ямагт баясгалантай зугаатай байх болно. Орчлонгийн ихэс ч тэдэнд хишгээ хүртээж, дэлхийн хүн ам ч тэндээ наманчлан залбирсаар урт удаан наслан /амьдралын/ сайн сайхан бүхнээр наргин жаргах болно.

Энэ бүхнийг “захиргаа сайтын засаглал нь ч удна” гэдэг араб зүйр үг үгүүлнэ. Хэрэв ... цаазаа хатуу сахихгүй болж, төрийн хэрэг доргиж тасалдаад ирэхэд Чингис хааныг эрээд ч олохгүй” /70.405/ хэмээн сургасан байдаг. Үүнээс үзэхүл Чингис хааныг залгамжлагчдын үед Их Монгол улс, “Их засаг” хуулийг чандлан сахидаг нэгдмэл, хүчирхэг, ёс суртахуунтай, эв нэгдэлтэй байваас зохино хэмээсэн Чингис хааны үзлийн илэрхийлэл болно.

Чингис хаан тухайн цаг үедээ өөрөө хэдийгээр мэдээгүй ч гэсэн Ази-Европыг дамнасан Евразийн соёлыг үндэслэн бүтээгч нь байсан бөлгөө. Энэ нь Чингис хааны улс төрийн үзэл, бүтээсэн соёлын агуу нэгэн гайхамшиг мөн. Чингис хаан амьд ахуйдаа өөрийн хүү Зүчи, Цагаадайд, Өгөөдэй, Тулуй нарт их гүрний нутгаас тодорхой хэмжээний газар, хүн амыг хуваарилан олгож, эзэмшүүлсэн нь ирээдүйд эзлэгдсэн орнуудад Монгол гүрний их хаанд ёс төдий захирагдах бие даасан улсууд бүрэлдэн тогтох /Алтан ордоны улс, Цагаадайн улс, Ил хаант улс/-ын үндэс суурь болсон ажгуу.

Чингис дэлхийн эзэнт гүрнийг байгуулах явцдаа эрхэмлэх суу ухаан, бүхнийг эзэмдэн захирах соёлыг дээд зэргээр үзүүлж, өндөр хариуцлагатай ёс суртахууныг өөрийн үзэл, үлгэр дууриалаараа харуулсан юм. Тэрээр аугаа суу ухаанаараа монголын нэгдсэн улс, дэлхийн талыг хамарсан Монголын их эзэнт гүрэн, дэлхий дахинд хамаарах улс төрийн үзэл, онолыг боловсруулж, их сэтгэгч, онолч улс төрийн агуу зүтгэлтэн болсон билээ.

“Эх газрын хэмжээгүй эрхт эзэн, Монгол цэрэг, аугаа их Тэмүжин Чингис хаан бол Еврази хийгээд Евразийн үзэл номнолын үндсэн гол биет төлөөлөгч мөн. Түүний түүхэн үйл хэрэг, түүний зохиосон хуулиудад нь суун шингэсэн түүний хувь чанар сүүлийн мянган жилийн дэлхий дэлхий дахины түүхийн бүх үйл явцыг үлэмж хэмжээгээр урьдчилан тодорхойлсон юм. Санаанд багтаагүй богино хугацаанд түүний байгуулсан эзэнт гүрэн хуучин ертөнцийн орон зайд улс төрийн зарчмын шинэ зохион байгуулалт буй болох үндэс болсон байна. Чингис хааны өв үлдэц бол нэг ёсондоо тив дэлхийг хамарсан гэрээслэл, эх газрын оюуны тэнхлэг мөн” /78.36/ гэж Оросын авъяаслаг судлаач А.Дугин бичсэн байдаг.

Чингисийн улс төрийн үзлийг Чингисийг залгамжлагчид тууштай баримталж байсан ажээ. Өгөөдэй хаан “Эцэг хааны байгуулсан энэ агуу их улсын төрийн хэргийн түмэн жолоог сулруулж цаашилбал алдах бий гэхээс яс янгинах юм” /54.140/ гэж өчсөн бол Гүюг хаан Ромын пап-д илгээсэн захидалдаа “Мөнх тэнгэрийн хүчин дор наран ургахуй зүгээс наран шингэх хүртэл бүх газар орон бидний ивээлд орсон ... Энэ үеэс та нарыг ивээл дороо орсон хэмээн үзсүгэй” /54.308/ гэж бичсэн байдгийг болгоон үзвэл зохимой.

Их Чингис хааны улс төрийн үзэл аугаа баялаг бөгөөд өргөн хүрээтэй, гүнзгий агуулгатай, төгс утгатай, холч, ирээдүйч чиг хандлагатайгаараа гахамшигтай юм. Түүний гүн ухаан, төр, эрх зүй, ёс суртахууны үзэл баримтлал, хувь хүний нь шинж эдүгээ ч анхаарал татаж, эрдэмтэд, сэтгэгчид, судлаачдыг даллан дуудсаар байна. Чингис хааны үзэл баримтлалыг судлах нь орчин үеийн хамгийн үнэ цэнэтэй эрхэмсэг зүйлийн нэгэн мөнөөс мөн бөлгөө.

§2. Чингис хаан-Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн үзэл онолыг боловсруулан хэрэгжүүлэгч

Чингис хаан-Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн үзэл, онолыг боловсруулсан төдийгүй амьдралд өөрөө гардан хэрэгжүүлсэн түүхэн бие хүн, их сэтгэгч, мэргэн ухаантан байжээ. Түүнийг ингэж хэлэх, ингэж дүгнэх нь өөрийнх нь суу билэг, үйл хэргийн үр дүн болно.

Чингис хаанаас Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн талаар боловсруулсан үзэл, онолын гол агуулга нь монголын нэгдсэн улсын төрийн хэлбэр, хааны хэмжээгүй эрх мэдэл, төрийн байгууллагын ямар тогтолцоог хэрхэн бүрдүүлэх, үүнд их хуралдай, сэцэдийн зөвлөл ямар үүрэг рольтой байх, монгол төрд алба хаах түшмэлийн тогтолцоог хэрхэн бий болгох, тэд ямар эрх үүрэг, хариуцлагатай байх, төрийн дотоод, гадаад бодлогод ямар үндсэн зарчмыг баримтлах, үндэсний эрх зүйн ямар тогтолцоог ямар агуулга, хэлбэртэйгээр тогтоох зэргийг тодорхойлсонд оршино.

Их хаан, Монголын нэгдсэн улсын төр нь аравтын тогтолцоогоор хэрэгжих засаг захиргааны нэг хуваарь дээр байгуулагдсан, нэгдмэл/үл хуваагдах нэг цул механизм/улс байж, түүнийг хэмжээгүй эрхтэй хаан толгойлно хэмээн үзэж байжээ. Үүний үндэслэл нь *нэгд*. Хүннү, Сяньби, Жужаны хэмжээгүй эрхт хаант засаг, хүн амаа аравтлан захирч байсан төрийн байгууламж, *хоёрд*. Хамаг Монгол улсын уламжлал, тухайлбал Амбагай, Хотула, эцэг Есүхэй, Хэрэйдийн Тоорил ван зэрэг төрийн зүтгэлтнүүдийн үзэл бодол, арга туршлага, сургамж, *гуравт*. Хятадын Сүн, Алтан улс, Тангуд мэт улс оронд хэмжээгүй эрхт хаант засаг оршиж байсны нөлөөлөл, *дөрөвт*. Дээрхи хүчин зүйлүүдийг харгалзан Чингисийн өөрийнх нь бодож боловсруулсан цэгц үзэл, байсан хэмээн хэлж болмой. Иймээс засаг захиргаа нутаг дэвсгэрийн аравтын байгууламжид үндэслэсэн нэгдмэл бөгөөд хэмжээгүй эрхт хаант засаг тогтоох нь Чингисийн үзэл онолын ноён нуруу нь байв.

Чингисийн энэхүү үзэл, онол, Чингисийн өөрийнх нь цагт ч, түүнийг залгамжлагчдын үед ч, Их эзэнт гүрэнд ч нарийн чанд бамритлагдаж, монгол улсад эзлэгдсэн бүх улс орон зөвхөн эзэн хаан, түүний толгойлсон Монгол улсад харъяалагдан захирагдаж байв.

Оросын академич В.Я.Владимирцов, “Гүрэн бол нэгэн байх ёстой бөгөөд түүний тэргүүн нь нэгэн эзэн хаан байх ёстой. Миний хаан орыг миний хөвгүүдийн нэг эзэлтүгэй. Миний үг хөдөлшгүй. Түүнийг хэн ч зөрчиж байхгүй гэж Чингис хэлж байжээ” /61.173/ хэмээн бичсэн байдаг. Иймээс үе угсаа залгамжилсан ганц хаан Монгол улсыг захирч байна гэсэн үндэслэл хөдөлбөргүй чанга байжээ.

Чингис энэ л үзэл онолынхоо дагуу Монголын нэгдсэн улсыг байгуулж, их хаанаар нь өргөмжлөгдөн, хаан хүн улсаа яаж тэргүүлэн удирдаж чадахыг амьдралаараа батлан харуулж, бас үүндээ чин үнэнч, сүр хүчтэй байсаар өөрийн залгамжлагчиддаа хүлээлгэн өгсөн түүхтэй. Чингис хэмжээгүй эрхт хааны нэр төр, сүр хүч, эрдэм ухаан, хүн чанар ямар байхыг боловруулан хэрэгжүүлэхэд маш их хүч гаргасан ажгуу.

Тэрээр хэмжээгүй эрхт хааны нэр хүнд, түүнийг бишрэх, итгэх явдал үлэмж өндөр түвшинд байх ёстой гэж үзэж байжээ. Тийм ч учраас ийм үзлээ дорно дахины гүн ухаантай нягт холбож, хааныг бурханлиг /тэнгэрлиг/ болгон, түүнд үнэнхүү итгэн биширч зарлиг сургамжийг нь үг дуугүй дагах ёстойг дотоод итгэл, үнэмшил болгох зарчмыг хатуу баримталж байв. Эл үзлийн гол агуулга нь хаан бол тэнгэрээс /бурхнаас/ газар дээрхи орныг захируулахаар илгээсэн цорын ганц хүн, хаан өөрөө тэнгэрээс заяамал, түүний ажил хэрэг нь тэнгэрээс явуулж буй ажиллагаа гэж итгүүлэхэд оршиж байсан аж. Хаан бол ариун гэгээн, эзэн богд хэмээн өргөмжлөн дээдлэх нь улсыг хүчирхэг, төрийг нэр сүртэй, хааныг жинхэнэ жолоодогч байлгахын язгуур учир болно. Монголын нэгдсэн улсын төрийн тамга хааны элчийн “гэрэгэ”-ний бичээс үүний тод баримт мөн юм. Төрийн тамгын “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй., аюутугай” гэсэн бичээсийн агуулга нь нэгд, хаан бол тэнгэрээс заяамал дээд язгууртай, хоёрд, түүний толгойсон улс нь дэлхийд цуут их хүчирхэг, гуравт, ийм алдар төгс хүчит хааны эрх сүр, нийт даяар хүндлэгдэн, түүнд захирагдаж байх ёстой гэсэн хаант засгийн тухай үзэл онолын нэн чухал илэрхийлэл байжээ.

Чингис хааны нэр төр, эрх мэдэл, сүр хүчийг илэрхийлсэн үг хэллэг “Монголын нууц товчоо”, “Алтан товч”, “Эрдэнийн товч”-д нэлээд тод томруун тэмдэглэгдсэн нь бий. “Эрхт тэнгэрийн хөвгүүн”, “Бадрангуй тэнгэр эзэн богд”, “Төгс аугаа хүчит суут богд эзэн”, “Хан мөнх тэнгэрийн орноос бууж их аугаа хүчин лүгээ цогт төрсөн” /44.88-89/, “Эрдэнийн товч”-д “Хүний арслан тэнгэрлиг богд эзэн” гэх зэргээр Чингис хааныг тэнгэрээс заяамал, суу билэгт, хүч чадалтан болгон нийгмийн хамгийн дээд түвшинд тавьж тэгсэнээрээ төрийн нэр хүнд, хүч чадлыг алдаршуулсан хэрэг байсан болой.

Хаан хүнд эрдэм ухаан төгс байх шинж маш чухал гэж Чингис хаан үзэж байжээ. “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэн баримтаас үзэхэд хаан хүний мэдэж эзэмшвэл зохих 35 эрдэм байсан байна. Эл үзэл, номлолыг хэн боловсруулсан нь

тодорхойгүй боловч Чингис хааныг эдгээр эрдмийг төгс эзэмшсэн хэмээн түүний есөн өрлөг жанжнууд нотолж байгаагаас үзэхэд их хаан өөрөө түүнд гол учир холбогдолтой байсан байж болох. Тэмүжиний итгэмжит нөхөр, есөн өрлөгийн нэг Боорчи Чингис хааныг “хаан хүний гучин таван эрдмээр ямагт хандаж” /50.93/ баймуй. “Хаан хүний гучин таван эрдмийг төгс сураад хас их төр, шажин хоёроо алдалгүй төвшнөө бариад” /44.93/ хэмээн өгүүлснээс үзэхүл хаан хүний сурвал зохих 35 эрдмийн нэр агуулга эл үед ил тод болсон байсныг гэрчилнэ.

Хааны эрдэм төгс байсныг шадар сайд, жанжнуудаас нь магтан хэлсэн үгүүдэд яруу сайханаар тусгасныг тэмдэглэж болох юм. Боорчи “Элдэв эрдэнэсээр цогцолсон сүмбэр уул минь, Энд тэндээс олон мөрөн цугласан анабад далай минь, өдөр шөнө одон гаригаар хүрээлсэн огторгуйн чандмань минь” хэмээн өчсөн бол Гоо ван Мухулай “Асар их хүчин төгс цаст уулын цагаан арслан минь. Арга хүчин хоёрыг тэгш чадагч гарьд хөлөг минь” гэж өгүүлжээ. Мөн Борохул жанжин “Элдэв жаран жигүүр лүгээ төгссөн их хүчит гарьд минь”, Зэлмэ жанжин “Цаглашгүй аугаа хүчин маш төвшин заан” /44.92-98/ гэх мэтээр магтан өгүүлсэн нь Чингис хаан бусдаасаа ялгарахуй тодорхой их эрдэм ухаантай байсныг, нөгөө талаар ер нь хааны ийм эрдэм ухаантай байх ёстойг илтгэн харуулна.

Хэмжээгүй эрхт хаант засгийг тогтоохдоо түүний шийдвэр зөв, бодитой байхад нөлөөлөх механизм байх нь зүйтэй хэмээн Чингис хаан үзэж байсан аж. Түүний боловсруулснаар ийм механизмын зохион байгуулалтын хэлбэр нь “Их Хуралдай” ба “Сэцэдийн зөвлөл” гэж томъёолон, эдгээрийг төрийн зохион байгуулалтын бүтэцдээ оруулахаар тогтоосон байна. Алтан урагийн ноёд, хатагтай нараас бүрэлддэг “Их Хуралдай”-гаар хаанд өргөмжлөх, дайн зарлах, найрамдал байгуулах болон дотоод, гадаад бодлогын том асуудлыг олон хоног нухацтай хэлэлцэн шийдвэр гаргадгийн хувьд Их хааны эрх мэдлээ зөв хэрэгжүүлэх, улсыг ухаантай жолоодох, хамгийн оновчтой шийдэлд хүрэх, улсын ба хааны сүр хүчийг өргөх, эв нэгдлийг хангахад үлэмж нөлөө үзүүлнэ хэмээн их ач холбогдол өгч байжээ. Энэ ёсоор Чингис хаан их хуралдайг байгуулж, хаанчлах хугацаандаа тасралтгүй хуралдуулж, Алтан улс, Хорезмын гүрэнтэй байлдах асуудлыг хэлэлцүүлж байсан ажээ. Энэ үзэл, онол Чингисийг залгамжлагчдын үед ч хатуу мөрдөгдөж, ханхүү Өгөдэй, Гүюг, Мөнхийг их хаанд өргөмжлөх асуудлыг гагцхүү их хуралдайгаар хэлэлцэн шийдвэрлэж байсан бөлгөө. Тэд өрнө зүг, дорно зүгт хийх дайны тухай асуудлыг ч их хуралдайгаар хэлэлцүүлэн шийдэж байсан юм. Мөн их хуралдай “Их засаг”-ийг баталж, бас хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж, түмт, мянгатуудыг байгуулж байсныг санаваас Чингис хаан төрийн зохион байгуулалтын бүтцэд хуралдайн эзлэх байр, гүйцэтгэх үүргийг тодорхойлон тогтооход их анхаарч байсныг харуулам.

“Сэцдийн зөвлөл” бол төрийн зохион байгуулалтын бүтцэд бие даасан байр эзлэнэ хэмээн Чингис хаан үзжээ. Бүрэлдэхүүний хувьд ч, гүйцэтгэх үүргээрээ ч тус зөвлөл нь “Их хуралдай”-гаас ялгагдах ёстойг Чингис хаан тодорхой тогтоосон байдаг. Сэцдийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Чингисийн есөн өрлөг, дөрвөн хөлөг, дөрвөн хошууч, хоёр манлай, чөлөөтэйгээр үгээ шууд хэлдэг дөрвөн “илтгэгч” багтсан төрийн 88 алдартны төлөөлөл ордог бөгөөд эдгээр нь бараг бүгд төрийн сайд, түмтийн захирагч, мянганы ноёдууд байсныг үзэхэд цэвэр төрийн түшээдийн хурлын шинжтэй байсан аж. Чингис хаан зөвлөлийн бүрэлдэхүүнийг ийнхүү тодорхойлохын хамт түүний хуралдааныг их хуралдайн хооронд хийж, төрийн үйл ажиллагааны явцын шинжтэй асуудлыг хэлэлцэж байхаар тогтоосон ажээ. Их хаан сэцдийн зөвлөлийн хуралдааны Хятад ба Өрнөдөд хийсэн дайны явц, үр дүнг хэлэлцүүлж байсан нь үүнийг нотолно.

Чингис хаан, нэгдсэн улсын төрийн зохион байгуулалтын бүтцийг боловсруулахдаа өөрийнхөө бодлого шийдвэрийг төрийн сайдуудаар дамжуулан гүйцэтгэх яамгүй тогтолцоог бүрдүүлэх, бас тэдгээр сайд нь түмтийн захирагч, мянганы ноёны албыг давхар хашихаар тогтоосон байдаг. Энэ нь бүх эрх мэдэл нэгэн хүний гарт төвлөрөх, түүнд сайдууд нь хатуу захирагдаж, хариуцлага хүлээх, төрийн үйл ажиллагаа төвлөрсөн маягаар нарийн чанд дэг журмаар явагдах нөхцлийг бүрдүүлж, нэгдсэн улсын төрийн “тархи, зүрх” нь болно гэж их хаан тооцсон бөлгөө. Энэ нь хааны хэмжээгүй эрх мэдлийг хангах, төрийг хүчтэй төвлөрсөн байлгах, төрийн бодлогыг нэгэн зорилготой нэгдмэл хүчээр хэрэгжүүлнэ хэмээн Чингис хаан үзэж байсантай холбоотой. Яамгүй түшмэдийн тогтолцоо бий болгох нь Чингисийн үзэл, онолын өвөрмөц хэсэг агаад энэ л чигээрээ амьдралд хэрэгжсэн байдаг нь анхаарал татахаас аргагүй бөлгөө.

Чингис хааны боловсруулсан нэгдсэн улсын төрийн үзэл онолын нэн өвөрмөц хэсэг нь аравтын тогтолцоог төвлөрмөл утгаар нь тогтоон, хаант засаг, иргэдийн захирах, захирагдах харилцааг “босоо” тэнхлэгт багтааж, улс гүрнийг төвлөрсөн захиргаанд оруулах тухай асуудал юм. Яг ийм үзлийг Чингис хаан баримталж, үүнийхээ үндэслэлийг ч мөн чанга боловсруулж, түүнээ ч бас амьдралд эргэлт буцалтгүй хэрэгжүүлж чаджээ. Чингис хаан, тархай, бутархай амьдралын түвшин, нөхцөл нь өөр, бодол санаа нь зөрүүтэй олон аймгуудыг нэгтгэн захирах хамгийн оновчтой хэлбэр нь аравтын тогтолцоо гэж үзэх нь аргагүй байсан биз ээ. Аравтын тогтолцоогоор бүх газар нутаг, хүн амыг мянгатуудад хуваарилан захируулж, мянгат бүрээ дотор нь аравт зуут мөн зуутаа арван аравт болгон хуваахаар тогтоосон нь Чингисийн аравтын тогтолцооны зохион байгуулалтын үндэс мөн юм. Ийм хэлбэр өмнө нь байсан ч харин зорилго, агуулгыг нь Чингис хаан цоо шинээр тодорхойлсон байдаг нь их л гүнзгий утгатай аж.

Чингис хаан, ийм тогтолцоог тогтоосноор нэгд, улсын бүх газар нутаг, хүн амыг засаг захиргааны төвлөрсөн хуваарьт оруулах. Ингэснээр харьяалалгүй иргэн, эзэнгүй газар нутаг байхгүй болон, бүгд эзэн хааны өмч, харьяатууд болж, түүнд захирагдах, үүнтэй холбогдуулан арванаа орхих, хуваарилсан газарт үл нутаглах, өөр арваны хүнээс цэрэгт татах, татвар үл хураах, алба үл төлөх хатуу журам тогтооно хэмээн Чингис хаан үзэж байв. Хоёрт, Аравтын тогтолцоог нэгдсэн улсын төрийн зохион байгуулалтын үндэс болгож, түүн дээр арваны дарга зуутын даргад, зуутын дарга мянганы ноёнд, мянганы ноён түмтийн захирагчид, түмтийн захирагч их хаанд шууд захирагдаж байх төвлөрсөн тогтолцоо бий болж төрийн бодлого, үйл ажиллагаа гагцхүү энэ тогтолцоогоор дамжин явагдаж байх ёстой ажээ. Гуравт, Аравтын тогтолцооны гол тулгуур /цөм/-г мянгат болгох. Мянгат нь хаант засгийн үйл ажиллагаа явагдах үндсэн нэгж болж, төр, цэрэг, иргэний үйл ажиллагаа, мянгат дээр төвлөрнө. Мянгат бүр их хаанаас олгосон газар нутагтаан байж, түүнээ өрх иргэдэд хуваарилан эзэмшүүлнэ. Мянганы ноёны хаан томилно гэх зэрэг нь Чингис хааны үзэл мөн юм.

Чингисийн боловсруулсан Монголын нэгдсэн улсын төрийн үзэл онолыг нэгтгэн дүгнэж үзэх юм бол Нэгдүгээрт, хэмжээгүй эрхт хаант засаг тогтоож, түүний эрх мэдлийг хангах зохион байгуулалтын бүтцийг нь тодорхойлсон. Хоёрдугаарт, хаант засгийн бодлогыг хэрэгжүүлэх төрийн түшмэдийн тогтолцоог томъёолсон, Гуравдугаарт, засаг захиргааны хуваарь буюу аравтын тогтолцооны онол, арга зүйн үндсийг боловсруулсан хэмээсэн гурван үндсэн хэсгээс бүрэлдэж буй нь тодорхой байна. Чингэхдээ эл онолоо хэрэгжүүлснээр төвлөрсөн, хүчирхэг, цомхон, няггармал сайн зохион байгуулалт бүхий хариуцлагатай, ёс суртахуунтай төрийг байгуулж чаджээ. Цоо шинэ төр жилээс жилд хүчирхэгжин бэхжжээ. Чингис хааны бодлого, зорилтыг хэрэгжүүлж, Монгол улсыг дэлхийн их гүрэн болгосон ажгуу. Чингисийн байгуулсан энэ төрөөс өөр хүчтэй төр өөр ямар ч улсад байгаагүй болой. Энэ нь энэхүү төрийн үзэл онолыг Чингис хаан, түүний хамтран зүтгэгчид нухацтай боловсруулж, бүх л оюун ухаан, хүч чадлаа дайчлан монголчуудын амьдралд нэвтрүүлсэн нь түүхэн гайхамшиг мөн. Энэ нь Чингис хааны суу билэг, хурц оюун ухаан, дайчин мэлмий, зохион байгуулах их авьяасын үр дүн, түүний хосгүй бүтээл бөлгөө.

Чингис хаан, монголын нэгдсэн улсын эрх зүйн тогтолцооны онолын үндсийг боловсруулсан гэж үзэх үндэслэлтэй. Тэрээр өөрийн суу билэг, оюуны их нөөц төрийн толгойлох зүтгэлтэн, соён гэгээрүүлэгч, сэтгэгч хүнийхээ хувьд төр, засаг /хууль/ хоёрын бие биетэйгээ хамт байхыг шаардах алсын амин холбоог ухааран ойлгож, монголын төр, хуультай байх талаар зөв сэтгэж их зүйлийг бүтээсний учир хамтран зүтгэгч нар нь ч, олон ард нь ч, үе үеийн эрдэмтэд, судлаачид ч “хуульч” хэмээн

үнэлэхийг хүлээн зөвшөөрч ирсэн бөлгөө. Английн Гарольд Дэмб “засаг гэдэг нь Чингисийн өөрийн нь гаргаж ирсэн үзэл” /17.55/ гэсэн байхад Саундерс “Чингис хууль зохиогч иргэний удирдагч байсан нь түүхэнд мэдэгдэж байгаа бөгөөд ... нэр алдар нь цэргийн жанжин гэдгээс ч хавьгүй дээгүүр болой” /77.81/ гэж бичжээ. Америкийн Г.В.Вернадский, Хятадын Сайшаал гэх зэрэг нэр цуутай эрдэмтэд Чингисийг “засагч” /хуульч/ хэмээн цоллосон байдаг. 2003 онд Болгарын Софи хотод Б.Даш-Ёндонгийн орчуулгаар хэвлэгдсэн “Суут Богд Чингис хааны үнэн гавъяа” хэмээх номын оршилд Чингис хааныг “Их хуульч” /78.6/ хүн мөн гэж шууд шууд тодорхойлжээ. Үнэхээр ч их Чингис агуу засагч /хуульч/ мөнөөс мөн бөлгөө. Түүний хууль зүйн сэтгэлгээ нь гайхамшигтай юм. Тэрээр монголын нэгдсэн улсын /төрийн/ сүр хүч, хааны хэмжээгүй эрх мэдлийг хатуу засаг /хууль/, түүнийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэх ажиллагаа хангана хэмээн сэтгэж, энэ чигт анхаарлаа төвлөрүүлж чаджээ.

Чингис нэгд, нэгдсэн улс нь нэгэн нэгдмэл хуультай байна. Хоёрд, энэ хуулийг өмнөх уламжлал, хэв хуультай нь нягт холбоотойгоор гаргана. Түүний зарим үнэт зүйлийг өөртөө шингээсэн байна. Гуравд, нэгдмэл энэ хуулийг улс даяар хатуу сахин биелүүлнэ. Төрийн бодлого, бүх ажил хэрэг энэ хуулийн дагуу, гагцхүү түүний хүрээнд явагдана. Дөрөвд, хууль, түүнийг заавал биелүүлэх ажлыг хариуцсан тусгай бүтцийг төрийн зохион байгуулалтад бий болгоно гэж үзэж байсан ажгуу. Үүнийг Чингис хааны үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж байсан арга хэмжээ бүрнээ нотолдог юм. Чингис хаан Монголын нэгдсэн улсыг байгуулмагц “Их засаг”-ийг баталж, түүнийг ургийн урагт сахин биелүүлж байхыг тунхаглан, улсын заргачийг томилон ажиллуулсан байдаг билээ.

Чингис хаан, Их засаг гэсэн нэгдмэл хульд ийнхүү анхаарал тавьсан нь онолын гүнзгий үндэслэлтэй байжээ. Энэ нь “Их засаг”-ийг монголын нэгдсэн улсын эрх зүйн гол эх сурвалж болгох, улс орны хэмжээнд гарах эрх зүйн бүх акт, тэдгээрт тогтоогдох бүх хэм хэмжээний суурь болгож, зөвхөн түүнийг биелүүлэхэд чиглэгдэнэ хэмээн үзэж байсантай холбоотой болой.

Чингис хаан, энэ үндсэн дээр нэгдсэн улсын эрх зүй тогтолцоо нь хаант засгийн бодлогыг хэрэгжүүлэх хамгийн хүчтэй хэрэгсэл, улс оронд нарийн чанд зохион байгуулалт, дэг журам, сахилга хариуцлага тогтоон үйлчлэх баталгаа, төр хүчтэй, эрчтэй, ёс суртахуунтай байхын чухал нөхцөл хэмээн үзэж байсан ажээ. Тиймийн учир Чингис хаан “Их засаг” хуулийг хатуу чанд сахин биелүүлэхийг үргэлж шаардаж, өөрөө ч энэ хуулиа ямагт хүндэтгэн биелүүлдэг байжээ. “Их засаг” хууль бүх ажил амьдралыг зохицуулж байсны дээр “Их хааны маргаангүй лут нэр хүндийн шахалт шаардлагын ачаар хэлбэрэлтгүй сахин мөрдөгддөг байсан байна” /17.61/ гэж Гарольд Дэмб бичсэн нь буй.

Чингис хаан, өрнө зүгт хийсэн аян дайныг дуусгаад 1224 онд Тэнгэр уулын нэгэн үзэсгэлэнт нугад Их хуралдай чуулуулж, түүнд оролцсон алтан ургийнхан, нэрт жанжнууд, төрийн сайдууд, орон нутгийг захирагчдын өмнө их л хүндэтгэлтэйгээр “Засаг хуулийнхаа ачаар би асар их эрх мэдлийг олж авлаа. Түүний заалт, заалтуудыг үл зөрчин амьдрагтун!” /17.148/ хэмээн маш нухацтай хэлсэн байдаг.

“Их засаг” хууль Монголын нэгдсэн улс, Эзэнт гүрэн байгуулагдан, хөгжих, улс гүрэн хэвийн давшингуй оршин, тогтнох олон түмэн эв нэгдэлтэй, өрнүүн сэтгэлтэй амьдрах, их цэрэг аян байлдаанд ямагт ялан дийлэхийн баталгаа, нэн чухал хүчин зүйл мөн байлаа. Нэгдсэн улсын эрх зүйн тогтолцооны нийгмийн үүрэг, бодит шинж чанар, хүч чадал чухамхүү үүнд илэрч байсан болой.

“Их засаг” хууль Чингисийн хаанчлалын үеэр өөрийгөө дуусгаагүй бөлгөө. Чингисийг залгамжлагчдын үед ч, Юан улсын үед ч, Чингисийн хүүхэд, ач, гуч, дөч нарын үүсгэн байгуулсан улсуудад ч үйлчилсээр байсан бөлгөө. Энэ нь Чингис хааны боловсруулсан Монголын нэгдсэн улсын эрх зүйн онол амьдрах чадвартай бодитой үр дүнтэй байсныг харуулж байгаа юм.

§3. Чингис хаан-Евроазийн соёлыг бүтээсэн суу билэгтэн

Монголчууд бидний оршин амьдардаг газар нутаг нь Төв азид хамаардаг бөлгөө. XIII зууны тэр үед Монголын эзэнт гүрэн чухамдаа Евроазийг бараг бүхэлд нь хамран тогтож байсан түүхтэй. Евроази бол Европ, Ази тивийн нутаг дэвсгэрийн хэсгүүдийг багтаасан манай дэлхийн хамгийн том эх газар мөн. /Европ, Азийн нутаг дахь арлууд хамаарахгүй/. Евроази нь геологийн утгаараа Евроазийн эх газар, арлуудынхаа хамт 53,4 сая км² талбайтай үүнээс арлууд нь 2,75 сая км² талбай эзэлдэг байна /78.3/.

Геологи, газар зүйн Еврази гэдэг ойлголтыг 1883 онд Австрийн геологич эрдэмтэн Э.Зюсс бий болгосон ажгуу. Бас үүнийг үндэслэн бүр XX зууны эхээр Евроазийн тухай нийгэм шинжлэлийн үзэл баримтлал үүсжээ.

Энэ бүхнээс үүдэн орчин үеийн эрдэмтэд судлаачид, XIII зууны Чингисийн байгуулсан нийгэм-улс төр, эдийн засаг, гадаад дотоод бодлогын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэж судалж үзээд Чингисийн байгуулсан эзэнт гүрний үед Евроазийн соёл үүсэн бүрэлдсэн бөгөөд түүнийг үндэслэгч, бүтээгч нь Чингис хаан байжээ гэсэн нэгдмэл дүгнэлтэд хүрсэн ажгуу.

Доктор Б.Даш-Ёндонгийн тодорхойлсноор Монголчуудын соёлыг “цэвэр азийнх гэх аргагүй. Монгол соёлыг Европынхи гэж хэлэх үндэсгүй. Бид Евроазийн соёлтой ажгуу. Энэ нь Чингис хаанаас үүдсэн түүхэн үйл явцын үр дүн юм” /78.3/.

Евразийн түүх, монголчуудыг Евразийн соёлтой болгон үлдээсэн нь уг утгаараа мөн л Евразийн соёлын бүрэлдэхүүн хэсэг нь л мөн болно.

Евроазийн соёл гүн ухааны их үндэслэлтэй болой. “Ази, Европын уялдал найрслаас бүтсэн соёл бидний гол онцлог юм. Монголчуудын нэгдлийн гүн ухааны үзэл энэ соёлын нэгэн илрэл мөн. Тархай бутархай байж, өөр хоорондоо дайсагналцан тэмцэлдэхийг өдөөн өөгшүүлэхгүй, их үйл хэрэг, амьдралын нэгдсэн нийтлэг зорилгын төлөө нэгдэж холбогдон хамтран зүтгэх, тэрхүү хүндэтгэн зөвшөөрөх нь энэхүү нэгдлийн гүн ухааны гол агуулга юм. Нэгдэж нягтарч чадах соёлын агуулга энд оршино” /78.4/

Монголчуудын нэгдсэн улс, Монгол эзэнт гүрнийг Ази, Европ тивийг хамруулан байгуулсан нь Евроазийн их соёлыг бий болгох газар зүй, геологийн хийгээд хүн амын аж амьдрал, соёл заншлын нэгдмэл орчинг бий болгосон ажгуу. Умард хятад, монгол, сибирь, орос, турк, болгар, дундаг ази, герман, словян, мажарын нүүдэлчин ард түмний соёл иргэншлийн хэв маяг нь ийм соёл буюу Евроазийн соёл бий болж дэлгэрэх хөрс суурь нь болсон аж. Өөрөөр хэлбэл монголчууд өөрсдийнхөө талд олон тархай бутархай нүүдэлчин ба хагас нүүдэлчин аймаг болон жижиг улсуудыг бүх аргаар татаж, бас эзлэгдсэн аймаг, улсуудын иргэдээс бүрэлдсэн цэргийн анги, салбаруудыг байгуулсан армийн хүчээ нэмэгдүүлж чадсан байна. Энэ нь Чингис болон түүний нэр цуут жанжнуудын суу билгийн гайхалтай үр дүн мөн аж.

Чингисийн эрхшээл, харъяалалд орсон Умард Хятад, Тангуд, Уйгур, Хар хятан улсууд, Дундаг азийн улсууд, Оросын вант улсууд, зүүн европын ба Ойрхи Дорнодын зарим улсууд хийгээд Чингис түнийг залгамжлагчдын үед байгуулагдсан шинэ улсуудын /Алтан ордны улс, Цагаадайн хаант улс, Иран дахь хаант улс, Юан улс/ ард түмэн Евразийн соёлыг бүтээхэд өөрийн хувь нэмрээ оруулсан юм.

Чингис хаан, түүнийг залгамжлагчдын Евразийн соёлыг бүтээсэн үйл ажиллагааны үр дүн нь дараах гол илэрхийллүүдээр нотлогдож байна хэмээн үзэж боно.

Чингис хаан, Евразийн их гүрнийг байгуулснаар европ, азид оршиж байсан том жижиг бүх улс аймгуудын өөр хооронд тасралтгүй явагдаж байсан сөргөлдөөн, дайсагналыг устгаж, эл хоёр тив цаашид шинэчлэгдэн хөгжих нөхцлийг бүрэлдүүлсэн бөлгөө. Тархай бутархай байдлыг арилган, нэгдэж, хамтран хөгжих бололцоог бий болгосноор тэдгээрийг хөгжлийн зогсонги байдлаас нь гаргаж, хөдөлгөөнд оруулжээ. Ази, Европын улс түмнүүд энх тайван байдалд оршин тогтнож, хөгжих замаа сонгох бололцоотой болсон нь асар том соёл, их боломж мөн байсан аж.

Чингис хаан, Евразийн төр ёсны шинэ соёлыг бий болгосон хэмээн үзэж болно. Эл хоёр тивд улс төрийн өөрчлөлт, дэвшил гарах, төрийн бүтэц зохион байгуулалтдаа өөрчлөлт хийх, улс орныг хамгаалах, хил хязгаараа амар тайван байлгах эрчимтэй, шинэ бодлого явуулах, гадаад бодлого, гадаадтай харилцах ажиллагаандаа их анхаарал

тавих, улс төрийн шинэ нэгдлүүд бий болоход хүргэсэн нь энэхүү соёлын гол агуулга байжээ. Иймээс Чингис хаан төрийн албандаа өөрийн болон эзлэгдсэн орны эрдэм ухаантай хүмүүсийг өргөнөөр ажиллуулж байсан билээ. Евразид хамаарах улс орон төдийгүй Япон, Солонгос, Энэтхэг, Франц, Англи мэт дэлхийн бусад улс орнуудын мэдрэмж, сонор сэрэмж дээшилж, гадаад харилцаагаа сайжруулах, ялангуяа монголын эзэнт гүрэнтэй болгоомжтой хандах болсон нь Монгол гүрэн буйг зөвшөөрч, түүнтэй анхааралтай харилцах нь бодит байдаас урган гарсныг харуулам.

Евроазийн улс орнуудад тайван нөхцөлд аж төрөх, чөлөөтэй худалдаа арилжаа хийх, бие биедээ элч, төлөөлөгч, зочид, жуулчид илгээх, соёл, бичиг үсэг, гар урлалын бүтээл, ололт амжилтаа солилцох, улс хоорондын харилцаанд хамгийн богино хугацаанд хэл, мэдээ авалцах механизм тогтоох, худалдааны замыг үр ашигтай, чөлөөтэй, аюулгүй байлгах нөхцлийг хангах бололцоо бүрдүүлсэн нь Евроазийн соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг болно. Чингис хаан Тангуд, Хятад, Солонгос, Хар Хятан, Уйгур, Хорезмын улсын хаанд өөрийн элчийг удаа дараа илгээж, худалдааны багийг 500 хүнтэйгээр Отрар хот руу явуулж, Бээжингээс Монголоор дамжуулан Зүчи, Цагаадайн улс хүртэл 1500 суурь өртөө байгуулсан зэрэг нь үүний баримт мөн. Венецийн жуулчин Марко-Поло XIII зууны эцсээр юан улсад ирж Хубилайн дэргэд 17 жил алба хааж, Чингис хааныг сайтар мэдэх болсон нэгэн. Тэрээр “Сүүлдээ Чингис хаан, олон тооны хот тосгод улс орныг эзлэн захирсан ба аль ч газрын ард түмэн түүний захиргаан дор байхыг илтэд хүсэх болсон нь тэрбээр хичнээн шударга байж, сайн үйлс бүтээснийг нотлов” гэж бичсэн байдаг. Үнэхээр ч Чингис хаан зөвхөн байлдан тулалдаж байсан бус бас олон улс орныг дипломатын аргаар өөртөө татаж, бусдын түрэмгийллээс хамгаалан, амар тайван орших бололцоог ард түмэнд нь олгож, мөн өөрт нь итгэн дагаж орохыг хүссэн олон улс, хот, тосгодыг эвдрэл сүйтгэлгүй үлдээж, хүн амыг нь авран өмгөөлж байсан бөлгөө. Чингис, Солонгос улсад цэрэг зэвсгийн тусламж үзүүлж бүрэн бүтэн байдлыг нь хамгаалж, Хятадын Өмнөд Сүн улсад Алтан улстай дайтахад нь цэргийн хүчээр тусалж байсан нь түүхнээ тэмдэглэгдсэн байдаг. Чингис хаан дагаж орсон Хар хятан, Уйгур улсыг байгаагаар нь үлдээж, оросын вант улсуудад хамтран ажиллах санал тавьж, Хорезмын гүрний шах /хаан/-д чөлөөтэйгээр явж худалдаа хийх нөхцлийг хамтран бүрдүүлэхийг уриалж байсан зэрэг бодит баримт үйл явдал олон байдгийг түүх гэрчилдэг бөлгөө.

Евроазид хамаарагдах улс орнууд монгол гүрний бодлогын хүрээнд эл эх газар нутагтаа хамааралтай нийтлэг соёлыг бүрэлдүүлж, дорнын, өрнийн /европ/ соёлтой тэнцэхүйц түвшинд хүрсэн нь Чингис хааны үндэслэсэн Евроазийн соёлын үр дүн мөн юм. Евроазийн улс орнууд эдийн засаг, худалдаа арилжаа, соёл урлаг, аялал-жуулчлал, шашин-зан заншлын үйл ажиллагаагаа Евроазийн хүрээнд хөгжүүлж,

бие биетэйгээ улам нягтрах үйл ажиллагаа Чингис хааны үеэс эхэлсэн ажгуу. Чингис хаан Монгол улсыг Хятад, Орос, Европтой шууд холбож, аялал жуулчлал, худалдаа арилжаа, гар урлал, уран дархан, бичиг соёлын харилцаа холбоог чөлөөтэй болгосноор Евроазийн соёл бүрэлдэн төлөвших үүд хаалга нээгдсэн түүхтэй. Чингис түүнийг залгамжлагчдын үед Хархорум хот дэлхийн томоохон хот болж, мөн бусад олон өргөө, суурингууд байгуулагдаж, Франц, Орос, Мажар, Турк, Иран, Хятад зэрэг олон улсын уран дархчуул, гар урчууд, уран барилгачид, худалдаачид, аялан ирж байснаас гадна “торгоны их зам” жинхэнэ утгаараа чөлөөтэй, нээлттэй болж, төрийн хамгаалалтад орж, аюулгүй байдлыг нь бүрэн хангаж байжээ. Хятад-Монгол-Алтан орд-дундат Ази нутгаар дамжин өнгөрдөг Их Монгол улсын морин өртөө, худалдааны замаар төр, цэргийн зүтгэлтэн, хаадын төлөөлөгч, жуулчид, худалдаачид, хувь хүмүүс болон жингийн цуваа тасралтгүй цувж байсныг түүхэнд бичсэн байдаг билээ.

Чингис хаан, Их Монгол улсад харьяалагдаж байсан бүх улс түмэнд дуртай шашнаа шүтэхийг төрийн цазаар баталж, лам санваартан, шүтлэгтэн түмнийг ялгаварлан үзэхийн эсрэг бодлого явуулж, аль ч шашны зүтгэлтэн, лам нарыг албан татвараас чөлөөлж, тэднийг чөлөөтэй байлгаж хүндэтгэх нийгэм-улс төргийн нөхцөл хангаснаар шашны соёлоор дамжин Евроазийн соёл бүрэлдэх нэгэн хүчин зүйл болсон байх юм.

Доктор Б.Даш-Ендон “Монголын их эзэнт гүрний түүх болон Чингис хааны үнэн гавьяаг бүх талаас нь бүрэн дүүрэн судлах гэвэл, Евроазийн тэр тусмаа Дундад Азийн олонхи орнуудын үүх түүхтэй монголчудуудын холбогдлыг нарийвчлан нягтлан үзэх хэрэгтэй болно. Энэ бол чухамдаа Европ, Азийн олонхи улсуудын түүхийн тодорхой үеийн, тодорхой хэсгийг судална гэсэн үг. Ингэж байж Монголын түүх бүрэн гарна, ингэж байж Азийн түүх үнэн зөвөөр бүрэн бичигдэнэ. Ази өөрөө түүхээ үнэн зөвөөр нь мэдэхгүй бол, түүнийгээ олж харахгүй бол хүн төрөлхтний түүх гэдэгт европын түүхийг л ойлгодог барууны номлолд хүлцэнгүй баригдсаар байх болно” /78.11/ гэж тэмдэглэгдснийг санах хэрэгтэй. Ази түүхийг судлахад Их Монгол улсын учир холбогдол их бий. Иймээс Их Монгол улсын түүхийг нарийн нягт судлах, түүнд Евроазийн учир холбогдлыг тодорхой гаргах нь зайлшгүй чухал болой. Энэ нь Чингис хааны Евроазийн соёлын үүсэн бий болоход гүйцэтгэсэн үүргийг тодруулан судлах шаардлагатайг давхар нотолж буй хэрэг мөн.

§4. Чингис хааны түүхэн гавьяа

Чингис хааны түүхэн гавьяаг тодорхойлохын тулд түүний түүхэнд эзлэх байр суурийн тухай асуудлыг хөндөх шаардлагатай юм. Чингис бол дэлхийн талыг хамарсан Монголын Их Эзэнт гүрний хаан, дэлхийн хэмжээний их хүний хувьд XIII зуунаас хүн төрөлхтний анхааралд өртөж, эрдэмтэд, судлаачид, түүхчид, түүний түүхэнд

эзлэх байр суурийг янз бүрийн чиглэл, арга хэлбэрээр тодорхойлон бичиж ирсэн ба одоо ч бичсээр буй. Дэлхий дахинаа Чингис хааны талаар эсрэг тэсрэг хоёр үзэл, хоёр сурталчилгаа явагдаж иржээ. Энэ талаар доктор Даш-Ёндон “Дэлхий дахинаа Чингис хааны тухайд эсрэг тэсрэг хоёр үзэл, хоёр сурталчилгаа буй. Сөрөг тал нь ихэд газар авч давамгайлах байдалтай болсон. Энэ сөрөг тал Чингис хаан, түүнийг залгамжлагчдад эзлэгдэж, ялагдаж байсан угсаа овогтнуудын дундаас гарсан үлгэр, домог, түүхэн өгүүлэл, ном, зохиолуудад голлон тулгуурладаг. Ялагдсан ном болохоор олонхи нь сайнаар хэлэхгүй нь лав. Харин ялагдагсад нь маш олон ажгуу” /78.4/ гэж бичжээ. Чингис хаан бол утга учиргүй дайн хийж, олон улс орныг хүчирхийлэн эзэлж, хүн амыг нь алж хөнөөн, хот суурин, барилга байгууламжийг нь үнсэн товрог болгон устгаж, соёлын асар их үнэт дурсгалыг эвдэн бусниулсан харгис хүн, түүний толгойлсон Монголын Эзэнт гүрэн дайнч, эзэрхэг улс байсан хэмээн нотолж, бичих нь сөрөг үзэл, сурталчилгааны гол утга санаа юм. Үүнээс үүдэн Чингис хаан түүхэнд харгис роль гүйцэтгэсэн хүн хэмээх үзэл бий болж, ялангуяа социализмын орон болох Орос, Хятад, Монголд ХХ зууны эхнээс эцэс хүртэлх хугацаанд нэлээд гүн ул үндэстэй ноёрхож байв. Чингис хааны Өлгий нутаг болох Монгол оронд социалист онол, үзэл ноёрхож байсан цаг үед /1930-аад оны эхнээс 1990-ээд оны эхэн/ Чингис хааны судалгаа, сурталчилгаа хаалттай байсан билээ. 1965 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын түүх” зохиолын 1 дүгээр ботид “Чингис хаан 1211 оноос эхлэн бусдын газар орныг булаан дээрэмдэх дайныг өргөн хэмжээгээр явуулсан бөгөөд чухамхүү тэр үеэс эхлэн Чингисийн үйл ажиллагаа нь эрс харгис шинж чанартай болсон юм. Чингис тэргүүтэй Монголын байлдан дагуулагчдын дээрмийн дайн нь Ази, Европын ард түмэнд цаглашгүй их үхэл гамшиг, эвдрэл сүүдлийг учруулж, түүхийн үнэлж баршгүй хосгүй нандин зүйлийг сүйтгэн, тэдгээр орны хөгжлийг асар ихээр хойш татсан юм” /11-241/ гэж бичсэн нь тэр үед ноёрхож байсан үзэл сурталчилгааны илэрхийлэл мөн. Социализмын онолч К.Маркс монголын байлдан дагуулагчид “явсан газар бүхнээ ээрэм цөл болгож, үржилт нутаг, хүн суусан тосгон сууринг үнсэн товрог болгож хувиргасан” гэж “Оросын дипломатын нууцууд” гэсэн бүтээлдээ бичсэн байдаг.

Оросын эрдэмтэн А.П.Петрушевский “XIII-XIV зууны Иран дахь газар эзэмшил ба газрын харилцаа” зохиолдоо “Алж хядах зохион байгуулалттай системийг дээрээс Чингисийн шууд зарлигаар явуулжээ. Энэхүү систем нь монголын ба тэдэнтэй нийлсэн түрэг нүүдэлчин аймгуудын язгууртан нарын сэтгэл санаанд нийлжээ. Учир нь гэвэл тэр систем зөвхөн эсэргүүцлийг дарж, зөвхөн толгой дараалан дээрэмдэхийг дөхөм болгож, тэр дээрэмдлэгийг язгууртан нарын ашиг тусын тулд илүү зохион байгуулалттай болгосон төдийгүй, аян дайнд дайчлагдсан жирийн нүүдэлчдийг агтлан барьж байхад ч хэрэглэжээ” /121.31-32/ гэж дүгнэн бичжээ.

Иймэрхүү дүгнэлт бичлэг дорнын ба өрнийн орнуудын олон ном, зохиолд дурдагдсан байдаг билээ.

Ялангуяа Чингисийн аян дайнд эзлэгдэн нэрвэгдэж байсан улс орнуудын түүх шастир, ном зохиолд илүү түлхүү бичигдэж ирсэн байна. Энд юуны Чингисийн явуулсан аян дайнд үнэлэлт өгөхдөө харгалзан үзвэл зохих нэгэн үндсэн учир шалтгаан бий. Энэ бол Чингис ямар ч улс, орон, хот сууринтай байлдахдаа эхэлж санаачлага гаргадаггүй, эхлээд эв аргаар зохицон эв найртай амьдрах, өөртөө захирагдаж алба төлөх, эрхшээлдээ сайн дураар орохыг шаарддаг төдийгүй, тийнхүү дайтах нь зөв эсэх, хэрэв дайтвал ямар стратеги, тактикаар байлдахыг Их хуралдай, Сэцдийн зөвлөлөөр хэлэлцэн дүгнэлт гаргуулж түүнийг нь тунгаан болгодог байсан нь “хууль” байжээ. Энэ нь уг аян, байлдааныг гэнэтийн бус аль аль талдаа бодох, бодит ухаалаг шийдвэр гаргах бололцоо олгодог байсныг тооцох нь зүйтэй юм. Чингис хаан, түүний жанжнууд энэ өндөр ёс зүйгээ хатуу мөрдөж байснаар олон улс орон дагаж орж хүн ам, уугуул соёл, хамгаалж байсан түүхтэй. Чингис хаан түүнийг залгамжлагчид Тангуд улс, Алтан улс, Сүн улс, Хорезмын улсад аян дайн хийх үү, хийхгүй юу гэдгээр Монголын нэгдсэн улсын Их Хуралдайгаар заавал хэлэлцүүлж байсан билээ. Энэ талаар академич Ш.Нацагдорж Чингис хаанаас Хятадын Алтан улстай байлдсан Хамаг монгол улсын хаадыг харгислан цаазалж байнга өнгөлзөгч, дээрэмдлэг хийн асар их сүйтгэл учруулахын хамт жил бүр их алба авч эрхшээлдээ оруулж байсан нь дайтахад хүргэж, тус улсын харъяат байдлаас бүр мөсөн чөлөөлөгдөхөөр дайн хийснийг тэмдэглэсэн байдаг. Японы эрдэмтэн Ш.Ивамура, Т.Кацуфути нар “Их Монголын эзэнт улс” бүтээлдээ, Чингис хааны хорезмын гүрэнтэй дайтах болсон нь “Хорезмын улс Чингисийн худалдаачдыг алж элчийг доромжилон буцаасан явдал гол шалтгаан болсон юм Чингис хаан уг нь Хорезмын гүрэнтэй дайтах шаардлагагүй байсан юм” /154.12/ бичсэн байдаг. Үнэндээ Чингис хаан Хорезмын шах Мухамедад 3 удаа элч илгээж худалдааны харилцаа тогтоохыг оролдсон боловч энэ нь түүний санаснаар болоогүй билээ /61.230/.

Чингис хааны дорно, өрнийн улс орнуудад явуулсан аян дайнд одоогийн Хятад, Орос, Иран, Ирак, Турк, Болгар, Армян, Азербайджан, Туркстан, Узбекистан, Таджикстан, Украин, Белорус, Гүрж, Казакстан зэрэг ази, европын олон улс орны нутаг, дэвсгэр дээр оршиж байсан том, жижиг бүх улсууд эзлэгдэж, олон хот суурин, сүм хийдүүд эвдрэн сүйрч мөн олон зуун мянган хүн амь насаа алдсан билээ. Энэ аян дайнд ялсан Монгол улс ч үлэмж их хохирол учирчээ. Аливаа дайн бүр их, бага ямар нэг хэмжээгээр хүний амийг авч, эвдрэл, сүйтгэл, зовлон гуниг учруулдаг уршигтай байдаг. Чингис хааны удирдан дорно, өрнийг улсуудад явуулсан дайн хэмжээ далайцын хувьд асар том дайн байжээ.

Ийм том хэмжээний дайн болохоор учруулсан хохирол нь бас их байсан байж таарна. Энэхүү том аян дайныг Монголын нэгдсэн улсын их хаан Есүхэйн Чингис удирдаж ялалтад хүргэсэн нь дэлхий дахины хэмжээний том үйл явдал мөн. Тэрээр хэдийгээр аян дайн хийж, их гарз хохирол учруулсан нь харамсалтай ч дайныг чадварлаг удирдаж ялалтад хүргэсэн нь эл хувь хүний гоц чадвар, агуу авьяас билэг, гайхамшигт суу билэгийг дэлхий дахинаа нээн үзүүлснийг анхаарах нь зүйтэй болов уу.

Чингис хааны байгуулсан гавьяа, бүтээсэн сайн үйлс нь шүүмжлэгдэх, муучлагдах зүйлээсээ үлэмж их давууг эрэмтэд, судлаачид судлан тодорхойлсон нь Чингис судлалын бие даасан том чиглэл болж улам бүр хүчээ авсаар байна.

Академич Ш.Нацагдорж “Чингис өөрийг нь төрүүлсэн цаг үеийн бүхий л шинжийг агуулсан Чингисийг, түүхчид болон улс төрийн зүтгэлтнүүд, зарим хэсэг нь хараан зүхэж, зарим нь түүнийг шагшин магтаж биширдэг юм. Хэдийгээр ийм олон зүйл санал, дүгнэлт байдаг боловч эцсийн эцэст Чингис бол дахин давтагдашгүй, ер бусын цорын ганц хувь заяатай, түүхэнд тэмдэглэгдсэн суут хүн мөн гэдэг талаар санал нэгддэг байна. Тийнхүү үзбээс Чингис бол төрийн гарамгай зүтгэлтэн, суут жанжин, монгол угсаатны үндэсний баатар мөн” /61.312/ гэж Чингисийн гавьяат үйлсийг эерэг талаас нь дүгнэжээ. Энэтхэгийн төрийн агуу их зүтгэлтэн Джавхарлал Неру “Тухайн үед Монголчууд тооны олноор биш, харин сахилга, зохион байгуулалттай байсныхаа хүчинд тулалдааны талбарт их ялалт хийж байжээ. Бас Чингисийн цэргийн жанжны гайхамшигт урлагийн хүчээр тэд ийнхүү ялалт байгуулж чадсан байна” /32.104-105/ гэж өгүүлсэн байна. Доктор Б.Даш-Ендон “Тэмүжин Монголын тулгар төрийг үндэслэж, Их Монгол улсын эзэн хаан болсоноосоо хойш тэнгэрт халих хүртлээ дайсандаа нэг ч удаа ялагдаж үзээгүй хэмээн ноттой халж болохыг түүх харуулж байна. Энэ ертөнцөд түүнтэй зэрэгцэх сод цуут цэргийн зүтгэлтэн, хаан байсангүй” /78.4/ гэж Чингисийн үүрэг ролийг тодорхойлсон нь бий.

Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг олон орны эрдэмтэд тухайлбал Ираны Рашид-ад-Дин, Египетийн Макриз, Армяны Д.Оссон, Английн Гарольд Дэмбэ, Х.Ховорс, Ж.Саундерс, Жек Редофорд, Германы Краузе, Францын Рене Гуссе, Фернан Гренар, Оросын В.В.Бартольд, Б.Я. Владимирцов, Н.Ренрих, Л.Н.Гумилщв, Буриадын Ш.Р.Цыденжапов, Халимагийн Эрэнджен хара Даван, Монголын Ч.Далай, Ш.Нацагдорж, Н.Ишжамц, М.Санждорж, Хятадын Чжоу Яотин, Сайшаал, Японы Ивамура Шинобу, Вада Сей зэрэг олон нэрт хүмүүс Чингис хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг судлан эерэг үнэлгээ дүгнэлт өгсөн байдаг.

Чингисийн удам, үйл ажиллагаа, хүмүүнлэг чанар, үйл хэргийг түүхэн баримтаар эерэг байдлаар нотлон өгүүлсэн “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” хэмээх зохиолуудын дүгнэлт, үнэлэлтийг ч бид сайтар тунгаан бодох ёстой билээ.

Эдгээр бүтээл дэх баримт, мэдээлэл нь их хааны үед амьдарч байсан бүх цаг хугацаа, ахуй амьдралын халуун тогооны дотор байсан гэгээнтэн мэргэд бичсэний учир хамгийн бодитой, үнэтэйд тооцох магадлал төгс бөлгөө.

Чингээд бид их хаан эзэн богд Чингисийн түүхэнд эзлэх байр, байгуулсан үнэн гавьяаг товч боловч нэгтгэн дүгнэж тодорхойлон гаргах гэгээнлэг зорилго тавьж, зөвхөн энэ л талаар өгүүлэхийг хичээв. Бүгдийг төгс сайн боловсруулан бичихэд авъяас билэг мөхөсдөх, хэдий ч үүнийг цааш цааш нь үргэлжлүүлэн гүйцээхийг хойч үедээ найдах нь баттай хэмээн үзэх үндэслэл буй билээ. Их Чингис хааны үнэн гавьяаг дараах хэдэн үндэслэлээр тодорхойлон үгүүлье. Үүнд:

1. Чингис хаан бол Монгол үндэстний нэгдмэл улсыг үндэслэн байгуулсан их гавьяатай. Тэрээр монгол угсааны аймгуудыг нийтэд нь нэгтгэн нэгэн цул нэгдмэл улсыг байгуулах үйлсийг удирдаж, үүнд амьдралынхаа 20 гаруй жилийг зориулан хатуужиж, Монголчуудын “яс” удирдагчаар товойн тодорч, өөрийгөө монгол овогтондоо бүрнээ нээн харуулж, тэдний итгэлийг хүлээсэн агуу хүн байв. Чингис хаан, Монголын нэгдсэн улсыг өөрийн суу үзэл номнол холч бодлого, хатан зориг, эрдэм ухаан, хүч чадал, эрэмгий үйл ажиллагаагаараа цогцлон байгуулж чадсан нь Монголчуудын түүхнээ тохиосон аугаа том гайхамшигт үйл явдал байсан ажгуу.

Чингис хааны энэ л гавьяагаар монгол аймгууд нэгдэж “Монгол улс” хэмээсэн Төв Азийн хүчирхэг улс болж, түүхнээ мөнхрөх хувь заяаг эдэлсэн бөлгөө. “Нэгдсэн улс байгуулагдсаны үрээр монголчууд Алтан улсын хараат байдлаас бүр мөсөн ангижирч, харийн довтлогчдоос нэг монгол аймгийг нөгөөгий нь эсрэг ашиглан түрэмгийлэх явдлыг эцэс болгожээ. Монгол улс байгуулагдсанаар тус орны өөрийгөө хамгаалах хүчин өсөн нэмэгдэж, энэ үеэс монголчууд дэлхийн түүхийн тавцанд бие даан гарч ирсэн юм” /54-104/ гэж 2003 онд хэвлэгдсэн “Монгол улсын түүх” таван боть зохиолын дэд ботид бичигдсэнийг анхааран болгоовоос зохино.

2. Чингис хаан, Монгол үндэстнийг бүрэлдүүлэн төлөвшүүлсэн ачтан болой. Монгол овогтон 81 аймгийг нэгтгэж, нэгэн угсаа, нэгэн хэл, амьдралын нийтлэг хэв маяг, соёл, зан заншил, ёс суртахуун, газар нутаг бүхий “Монгол” гэсэн нэртэй бүхэл бүтэн үндэстнийг бүрэлдүүлж бий болгосон нь их хааны аугаа том гавьяа мөн. Францын Чингисийг судлаач нэрт эрдэмтэн Фернан Гренар 1935 онд туурвиж дуусгасан “Чингис хаан” хэмээх 10 бүлэг бүхий томоохон зохиолдоо “Чингис хаан бол Монгол ард түмний зэр зэвсэг нь биш, харин монгол ард түмнийг бүтээж бий болгогч нь юм. Чингис хаан, хүч чадлаа бэхжүүлэхийн тулд өвөр хоорондын тэмцэлдээ идэгдэн, хүчээ шавхан барж, жам ёсны нийтлэг мэдрэмжээ алдсан тархай бутархай аймгуудад найдан тулгуурлах аргагүй байсан юм. Тэдгээрийг нэгтгэн захирахын тулд гаргасан шиг тийм их хүч зүтгэлийг Чингис хаан өөр юунд ч, хэзээ ч гаргаагүй билээ.

“Монгол” гэдэг ойлголт монгол хэлээр ярьдаг бүхнийг багтааж байгаагүй учраас тэр юм” /78.12-13/ гэж яруу тод бичсэн байдаг. Монгол үндэстэн бүрэлдсэн нь асар нарийн үйл явц, маш хүчтэй бодлого, үйл ажиллагаа байсан нь тодорхой. Б.Даш-Ёндон “Чингисийн байгуулсан Монголын тулгар төр монголчуудыг нэгдмэл нэгэн үндэстэн болгож, бүрэлдүүлсэн юм. Үндэстэн бол капитализмын бүтээгдэхүүн гэдэг онол явч Монголын нөхцөлд таарахгүй. Хэрэв монголчууд тэр үед үндэстэн болж бүрэлдэж чадаагүй бол тухайн үед мэдэгдэж байсан дэлхий дахины гуравны хоёрыг эзэлж даян дэлхийг хамарсан эзэнт гүрэн байгуулж чадахгүй. Манж-хятадын 200 гаруй жилийн эзэгнэл, дарлалыг тэсэж давж чадахгүй” /78.12/ гэж тодорхойлсонтой санал нэг байна. Монгол үндэстэн бол Чингис хааны аугаа том бүтээл, түүний монголчуудад үлдээж өвлүүлсэн юугаар ч үл сольж болох хамгийн үнэт эрдэнэ мөн.

3. Чингис хаан, Монголын нэгдсэн улсыг дэлхийн их гүрэн болгож, бас өөрөө ч дэлхий дахинаа алдаршсан түүхэн хувь хүн “Монголын тулгар төрийг төдийгүй, дэлхийн талыг хамарсан Монголын их эзэнт гүрнийг байгуулснаараа тэрээр дэлхий дахины ач холбогдолтой төр улсын агуу их зүтгэлтэн болсон юм. Чингис хаан бол дэлхий дахины хэмжээний том хүн мөн. Тэрээр их хуульч, сайн сэтгэл зүйч, өвөрмөц маягийн бодлоготон, түмэн олондоо ойр дотно байдаг монгол төрийн уугуул зүтгэлтэн, үлэмжийн их зохион байгуулагч байжээ. Цааш цаашдаа ч хүн төрөлхтөн түүнийг үүнээс доогуур үнэлэх аргагүй юм” /78.5-6/. Чингис хаан, Ази, Европын олон улс орныг байлдан дагуулж их ялалтад хүрсэн нь “эзлэн ноёрхсон” гэх утгаар нь бус “яагаад ямагт ялалт байгуулаад байв” гэдэг талаас нь авч үзбээс аугаа их авьяас билэг, тэсвэр тэвчээр, ур чадвар, ухаан бодол, хүч чадал зарж байж, тэр олон орны өөрөөсөө илт олон цэрэгтэй, олон олон алдар түүхтэй хаад, сүр хүчит жанжинуудтай халз тулалдаж ялсан тэр их чадвар Чингист байжээ гэдгийг харуулж байгаа нь жинхэнэ бодит үнэн мөн юм. Чухам энэ нь XIII зууны 40-өөд оны Ираны /Перс/-ны түүхч Жувейний “Дэлхийг байлдан дагуулагчийн түүх” алдарт зохиолд “Бүгдийг тольдогч тэнгэрээс Чингис хааныг олноос оройлсон оюун чадвартай, үзэл санааны хурц сэргэлэн, эрх хүчний хязгааргүй талаар дэлхий дахины олон хаан, ван нарын манлай болгожээ...”

Бусад улсыг дайлан дагуулах арга бодлого, дайсан цэргийг устгах ба харьяат нараа дэвшүүлэх арга зэрэг нь бас ч бүр түүний өөрийнх нь сэрж ухсан үр дүн мөн бөгөөд оюун чадварынх нь цараа болох юм. Үнэнийг хэлэхэд тэрхүү арга бодлогодоо чадамгай, дайснаа ажихдаа сахиус мэт гэдэг алдартай Александр хэрэв Чингис хааны үед амьд мэнд байсан бол арга сүвэгчилж, бодлого хэрэглэх талаар Чингис хааны сурагч нь болох бөгөөд хот балгасыг довтлох зүйл бүрийн уран аргын талаар Чингис хааныг үг дуугүйгээр дагаж хийвэл дээр гэдгийгээ тэр лав олж мэдэх байсан байх”

/75.349-350/ гэж бичсэн нь Чингис хааны эзэнт гүрнийг байгуулсан “авьяас билэг, суу чадвар” үнэхээр аугаа болохын нэгэн нотолгоо биз ээ. Чухамхүү Чингис хааны ухаан бодол, авьяас чадвар л умарт Хятад, Тангуд, Түвд, Иран, Дундат Ази, Орос, Европын олон орныг харьяалан захирсан Монголын эзэнт гүрэн тогтоход хүргэжээ гэж энэ л онцлогоос харвал ингэж л хэлэх хэрэгтэй болов уу. Энэ бол Чингис хаан гэдэг хувь хүний, тэр л аугаа их авьяас билэг мөн гэж шууд утгаар нь хэлж болоход хамаг учир оршино хэмээн түүх сануулсаар л байна хэмээн бодогдном. Бодит баримтыг түших юм бол Чингисийн өөрийнх нь бөгөөд түүнд ялагдсан Тангуд, Алтан, Сүн улс, Хорезмын эзэнт гүрэн, дундат Ази, Оросын вант улсууд, европын хаант улсуудын хаад, цэргийн жанжинууд бол тэр л үеийнхээ алдар цуутай, авьяас билэгтэй хувь хүмүүс шүүдээ.

Тэхлээр тэдэнтэй өрсөлдөж, тэднийг ялна гэдэг тийм ч амар хялбар биш, агуу их гүн утга учиртай гэдэг нь ойлгомжтой. Тэхдээ Чингис тэднийг ялсан нь түүхэн үнэн болохоор түүний тэр л их суу билэгийг хүлээн зөвшөөрөх нь бас л гарцаагүй болов уу.

4. Чингис хаан, Монголын нэгдсэн улсын төр, эрх зүйн үзэл, онолыг боловсруулан хэрэглэсэн суу ухаантан болно. Хамаг Монголыг сэргээн босгож, Монголын нэгдсэн улсыг байгуулах үзэл баримтлалыг Чингис хаан тэргүүлэн боловсруулсныг түүх гэрчилж байна. Түүнийг хэн ч судлаагүй нотлоогүй боловч тэрээр хамтран зүтгэгчдийнхээ хамтаар эл үзэл баримтлалаа боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлсэн нь үнэнхүү түүний оюун ухааны их авьяас билгийн үр дүн мөн юм. Үүний бодит үр дүн нь Хамаг Монгол, Монголын нэгдсэн улс байгуулагдан оршин тогтнож байсан түүхэн үнэн өөрөө мөн. Тэр оюун ухааны хурц чадвартай, юмыг олон өнцгөөс нь сэтгэж чаддаг, бас хэрэгтэй бол бие сэтгэлээ барьж чаддаг, эрдэмтэн мэргэдээс үндэс угсаа харгалзахгүйгээр байнга суралцахыг хичээнгүйлэн зүтгэдэг, монгол улсын бие даасан байдлыг ясан махан утгаараа ямагт хамгаалан тэмцдэг, эх орноо, хүн ардаа барс мэт өмөөрдөг, үзэл бодолдоо ямагт үнэнч, шулуун шударга, эрс шийдэмгий зан чанар, бодол санаа нь дээрхи үзэл баримтлалыг боловсруулах хөрс суурь болсон ажгуу. Чингис хааны төр, эрх зүйн үзэл онолын цөм агуулга нь Монгол улс ямар ч улсаас хараат бус бие даасан улс байх, хэмжээгүй эрхт хаант засаг тогтох, Засгийн газар, Яамгүйгээр зөвхөн төрийн сайд, түшмэдээр дамжуулан төрийнхөө удирдлагыг /гүйцэтгэх засаглалыг/ хэрэгжүүлэх, шударга шүүх, хууль цаазтай байх, аравтлах тогтолцоонд үндэслэсэн төрийн байгууламжийг бий болгох, бүх ард нийтэд эрх тэгш байх, дуртай шашнаа сонгон шүтэх эрх олгох, гадаад улс орнуудтай худалдаа арилжааг чөлөөтэй хийх, бас өөр хоорондоо өргөн дэлгэр харилцах, бие биенээ үэннхүү хүндэтгэхэд оршиж байжээ. Эл үзэл онолын агуулгыг тодорхойлогч үзэл баримтлал нь бэлчээрийн мал сүргээ даган нүүдэллэж амьдардаг монгол маягт тохирч түүнд зохицсон байснаараа онцлог болой.

Энэ бол монгол соёлын эрхэмсэг нэгэн хэсэг мөн. Тэр их соёлыг Чингис хаан бүтээж, залгамжлагчид нь хөгжүүлсэн юм. Чингис хааны боловсруулсан эл үзэл, онолын тухай 2 дахь зүйлд өгүүлсэн билээ.

5. Чингисийн гавьяат үйлсэд түүний дэлхий дахинаа алдаршсан цэргийн жанжин, Монголын нэгдсэн улсын цэргийн урлагийг үндэслэн бий болгосон явдал орох нь лавтай. Монголын нэгдсэн улс байгуулагдаж улмаар дэлхийн их гүрэн болсон хийгээд Ази, Европыг дамнасан их аян дайнд ялсны гол нууц нь Монгол цэргийн их урлаг, монгол цэргийн жанжин, монгол цэргүүдийн өөрийн хэмээсэн агуу урлаг, байлдах өндөр ур чадвар, тулалдах хатан зориг, арга ухаанд оршиж байсан хэмээн үзэх үндэслэл бүрэн буй. Үүний нотолгоо болгохын үүднээс хэд хэдэн ишлэлийг тунгаан үзье. Оросын эрдэмтэн Б.Я. Владимирцов “Чингис бол зөвхөн туршлагатай мэргэн жолоодогч, дайн тулалдааны зоригтой авьяаслаг удирдагч төдийгүй, мөн гайхамшигтай стратегич, арми ба түүний салбар ангиудын дайны үйл ажиллагаа болон маневруудын удирдагч болохоо харуулсан юм” гэсэн дүгнэлт хийсэн бол Английн эрдэмтэн Ж.Саундерс “Тухайн үеийн анхны том жанжин байсны хувьд Чингис хааны авьяас чадал нь зөвхөн гайхамшигтай нээлтүүд төдийгүй тэр үед ч байсан практик амьдралыг өөрийн болгон өөрчилж сайжруулахад ер бусын авьяас чадлаа харуулснаар тодорсон ажээ” хэмээн өгүүлсэн нь бий. Хятадын их түүхч Сайшаал “Чингис хаан бол Монгол үндэстний түүхэн дэх шалгарсан гарамгай цэрэг дайны зүтгэлтэн болно. Чингис хаантай адил их түншвээ ер байгаагүй”/ 276-277/ гэж бичжээ. Энэтхэгийн улс төрийн нэрт зүтгэлтэн Джавхралал Неру “Чингис бол түүхэнд гарсан цэргийн суут ухаантай, жолоодогч эргэлзээгүй мөн. Түүний дэргэд Македоны Александр, Юлий Цезарь юу ч бишээ” хэмээн Чингис хааныг үнэлсэн байдаг билээ.

Чингисийн байлдааны тухай бичсэн ном зохиолуудыг судалсан дүнгээс үзэхэд Чингис хаан өөрөө жинхэнэ Монгол эр зориг, түүний баатарлаг үйлс нь үнэхээр гайхамшигтай юм. Тэрээр Монгол цэргийн нэр цуут армийг, гардан үүндээ монгол цэргүүдийг сургаж, ялагдашгүй их хүчирхэг армийг төрүүлсэн их хүн мөнөөс мөн. Нүүдлийн соёл иргэншилтэй улс орон тэр тусмаа төв азийн нүүдэлчин Монгол үндэстний эрэлхэг зориг, авьяас билэг, байлдах өндөр ур чадвар, эх орон, ард түмнээ дээдэлсэн ариун нандин сэтгэл зүй, ёс суртахууныг шингээсэн, монголоос өөр улс оронд байхгүй тийм гайхамшигт чадавхитай армийг төрүүлж, тулалдаан бүхэнд ялж нэр цуугаа мандуулсан алдар төгс цэрэг эрсийг бэлтгэж, түүнээ биет байдлаараа үлгэрлэн харуулсан аугаа хүн бол Чингис өөрөө байсан бөлгөө. Тиймээс академич Ш.Нацагдорж “Чингисийн гавьяа бол нүүдэлчдийн цэргийн эрдэм боловсролыг төгс төгөлдөрийн туйл болгон дээд шатанд гаргаж баяжуулан, цэргийн ухааныг жинхэнэ ёсоор бүрэлдүүлэн бий болгосонд оршино” /61.213/ бичсэн байдаг билээ.

Хятадын Мин улсын сүүлч Чин улсын эхэн үеийн их эрдэмтэн Гү Зо Юу “Би Монголын цэрэг хэрэглэх аргыг шинжиж үзэв. Монголын цэрэг улирч хувирах урагшлан довтолох нь гайхалтай, гэнэт үзэгдэж гэнэдүүлэн дайрахдаа чадамгай. Цэргүүдийн сэтгэл ганц хүн мэт.

... Иймээс Монголын дайны арга бодлого нь эрт өнгөрсөн лугаа харьцуулбал хамгийн дээдэд очно” /61.213/ гэж бичсэн нь жирийн нэгэн илэрхийлэл бус сайтар судалсан мэргэн оюуны үр шим байж таарна. Итгэл, үнэмшил олохын үүднээс их түүхч Монгол судлаач Г.В.Вернадскийн “Чингисийн үеийн монголчууд ба Орос улс” хэмээх зохиолоос нэгэн багц дүгнэлтийг иш татъя. Тэрээр “XIII зууны монгол арми бол тэр үеийн дэлхий дахины хамгийн шилдэг арми байсан нь ямар ч эргэлзээгүй. Энэ морьт арми нь бас хэрэм боомт эвдэх, инженерийн ангитай байжээ” /61.214/. Түүхийн үүднээс авч үзэхэд монголчуудын цэргийн эрдэм эртний өргөмжлөлтэй бөгөөд Чингис хааны үед энэхүү уламжлалыг туйлд нь хүртэл төгс боловсронгуй болгожээ. Энэ үүднээс үзвэл Чингис хааны цэргийн байлдаан, аян дайн явуулах үйл ажиллагаа монголчуудын тэр тусмаа гагхүү Чингис тэргүүтэй монгол цэргийн жанжин, монгол цэргийн байлдах ур чадвар, зэвсэг техник, нэгдмэл зорилго, сэтгэл зүйн тэвчээр, зориг, үнэнч шударга чанартай цогц холбоотой болой.

Монгол авъяас билэг монгол сэтгэхүйгээр өөрсдөө бүтээн хийсэн зэр зэвсэг, бас тэдэнд өөрсдөд нь буй байлдаж сурсан их чадвар, арга барил, цэргийн жанжинуудынх нь суу билэг монголчууд ямагт ялан дийлэхийн үндэс нь болж байсан аж. Монголчуудаас дээгүүр орох, зэвсэг техник тэднээс илүү тулалдан байлдах чадвар, нэгдмэл хатуу, сахилга, эсрэг талд нь байгаагүй аж. Монголчууд өөрсдийн энэ л урлаг, аргаараа байлдаж ялж байв. Энэ бол нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудын аугаа их соёл байсан нь гайхамшигтай. Английн Чингис судлаач Гарольд Дэмбэ “Европын он дарааллын түүхийн орчин үеийн нэгэн хүн /энэ хүн нь Томас де Спалат аж/ дэлхийн нэг ч ард түмэн, ялангуяа задгай газарт байлдан тулалдахдаа эрэлхэг зоригийнхоо ачаар юм уу, дайн хийх ур чадварынхаа хүчээр монголчууд шиг дайсныг ялан дийлэх чадваргүй байсан юм” /17.175/ гэж бичсэн байх юм.

Ромын пап, Францын IX Людовик хааны элч, жуулчин санваартан “1238-1242 оны аймшигт довтолгооны дараа харь хэлтэн байлдан дагуулагчдаас христчүүдийг өршөөн нигүүлсэхийг гуйж үгэндээ оруулахаар монголын хаан руу иргэн Плано Карпини “Нэг ч вант улс, нэг ч муж нутаг монголчуудын довтолгоог тэсэн тогтоох чадваргүй байсан” /17.179/ хэмээн нүдээр үзэж бичсэн хүний үгийг эрхбиш анхаарах нь зүйтэй биз. Тэхлээр хятадын Алтан улс, Сүн улс, Тангуд улсын цэргийн их жанжнууд, Хорезмын эзэнт гүрний хаан /шах/ Мухаммед, түүний хүү эрэлхэг жанжин Желал-ад Дин, Бухар, Отрар, Самарканд, Ургенч хотын баатрууд, оросын вант

улсуудын холбооны ван, жанжнууд, Болгар, Польш, Иракийн хийгээд, Дундат азийн орнуудын цэргийн их жанжин, үндэсний гвардын армийн цэргүүдтэй тулалдан ямагт ялж байсан Монголын арми, Чингис, Мухулай, Боорчи, Зэлмэ, Зэв, Сүбээдэй, Зүчи, Тулуй тэргүүтэй цэргийн жанжнуудын суу авьяас чадварыг тухайн үедээ ямар ч улс орон, төр цэргийн зүтгэлтнүүд хүлээн зөвшөөрч байсан бөлгөө.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

Чингис хаан, Монголын эзэнт гүрний

дэлхий дахинд үзүүлсэн нөлөө

Чингис, Өгөдэй, Гүюг, Мөнх хаад, тэдгээрийн хаанчлалын үеийн Монгол гүрний оршин тогтнож байсан түүх, түүний дэлхий дахинд хэрхэн нөлөөлсөн асуудал янз бүрийн улс орны судлаачдын анхаарлыг олон зууны турш татаж ирсэн ба одоо ч татсаар л байна. Ази, Европын уугуул улсууд тухайлбал одоогийн Хятад, Энэтхэг, Солонгос, Орос, Иран, Ирак, Австри, Унгар, Турк, Болгар, Афганистан, Казакстан, Туркестан, Таджикстан, Гүрж, Азербайджан, Украин, Белорусс, Польш, Чех улсуудад XIII зууны Монголын их эзэнт гүрэн ямар нэг хэмжээгээр нөлөө үзүүлсэн нь түүхэн үнэн болно.

Энэ бол бүхэлдээ Монголын их эзэнт гүрэн дээрхи улсуудын түүхэнд, товчлон үзбээс Ази, Европын түүхэнд эерэг ба сөрөг нөлөө үзүүлсэн тухай асуудал мөн. Энэ бол маш өргөн хүрээ, олон улс орныг хамарсан, түүх нийгэм, төрт ёс, хууль цааз, аж ахуй, соёл, шашны зэрэг олон талын асуудлыг хөндсөн үлэмж эмзэг нарийн асуудал юм. Монгол гүрний явуулсан аян байлдааны тухай түүнийг толгойлон удирдсан их Чингисийн тухай ном бүтээл, түүх шастир, он дараалсан бичиг, яруу найраг, үлгэр туульсд тусгагдсан нь олноос олон байдаг боловч Чингис хаан, түүний үзүүлсэн эерэг нөлөөлөл, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн тухай өгүүлсэн нь харьцангуй бага, шинжлэх ухааны үүднээс судлан шинжилсэн нь бүр ч хомс ажгуу.

Чингис хаан, Монголын эзэнт гүрний үзүүлсэн нөлөөний тухай дорвитой судалгаа хийх шаардлагатайг түүх сануулж, бас шаардаж байна. Энэ нь Монгол гүрний төдийгүй тус гүрний эрхшээлд байсан улсуудын төрийн түүх судлал болон Ази, Европын төрт ёсны түүхийг бүтээхэд нөлөөлсөөр байгааг харгалзан үзэх шаардлагатайг харуулж байна.

XIII зууны сүүлчээр Монголын их хаан Хубилайн дэргэд 17 жил алба хааж байсан Венецийн жуулчин Марко Поло “Сүүлдээ Чингис хаан олон тооны хот тосгод, улс орныг эзлэн захирсан ба аль ч газрын ард түмэн түүний захиргааны дор байхыг илтэд хүсэх болсон нь тэрбээр хичнээн шударга байж сайн үйл бүтээснийг нотлов” /78.6/ гэж бичсэн бол Америкийн эрдэмтэн Г.В.Вернадский “Монголчуудын дарлал” Оросын газар нутгийг тал газрын төвтэй, эх газрын Азийн алс хязгаартай нягт холбож өгсөн юм /14.18/ гэж дүгнэсэн байдаг. Францын түүхч Фернан Гренар Чингис хааны байлдан дагуулалт “Хятадыг нэгтгэж, Оросыг байгуулсан юм” /78.16/ хэмээн тодорхойлсон нь бий. Английн нэрт түүхч Гарольд Дэмбэ “Дотоодын хямрал зөрчилдөө идэгдэж гүйцээд байсан Оросын вант улсуудаас Их Иваны эзэнт гүрэн бий

болж, Монголчуудын эрхшээл анх удаа хятад орон нэгдсэн төр улс болсон” /17.163/ гэж тодорхойлжээ. Монголын эрдэмтэн Б.Даш-Ёндонгийн тодорхойлсноор Чингис хаан Монголын их эзэнт гүрнийг байгуулж дэлхийн талыг эзлэхдээ суу ухааныг дээд зэргээр үзүүлж, хүнд байвал зохих шилдэг ёс суртахууныг хувийн дууриаллаараа харуулж байсан /78.6/ ажгуу.

Ийм байдлаар Чингис хаан, Монголын эзэнт гүрний дэлхий дахинаа үзүүлсэн эерэг нөлөөллийн талаар эрдэмтэд, судлаачид дүгнэлт, саналаа хэлж, эрс шуудаар хөндөн тавьсан нь олон бөлгөө. Энэ бүхэн нь Чингис хаан, монголын Эзэнт гүрний нөлөөллийн асуудалд анхаарлаа хандуулж, дорвитой судалгаа шинжилгээ явуулж, бодитой чиглэл, дүгнэлт гаргах цаг болжээ гэдгийг анхааруулж байгаа хэрэг мөн. Үнэхээр ч энэ асуудлыг монгол орон төдийгүй олон орны эрдэмтэд ялангуяа Хятад, Орос, Иран, Турк, Украин, Беларусь, дундад Азийн орнуудын эрдэмтэд хамтран сайтар судлах шаардлагатай хэмээн үзнэм.

Судалгааны дүн дээр үндэслэн Чингис хаан болон Монголын эзэнт гүрэн дэлхий дахины амьдралд хэрхэн нөлөөлснийг юуны өмнө дор дурдсан байдлаар өгүүлж болох юм. Чингэхдээ цаг хугацааны хувьд 1211-1260 онд Чингис ба түүнийг залгамжлагчдын толгойлсон Монголын их эзэнт гүрний үеэр зааглан авч үзвэл зохистой бөлгөө. Энэ нь Чингис, түүнийг залгамжлагчдын хаанчлалын жилүүдийг хамарч байна.

Түүнээс цааших үеийг Монголын Юан гүрэн, түүний дараа Дундад Ази, Орос, Иранд тогтож байсан Монголын хаадын угсааны хүмүүсийн толгойлсон улсуудын үеийг хамруулан хоёрдугаар ботид дэлгэрэнгүй өгүүлэх болно.

Чингис хааны 1211 оноос эхлэн насан өөд болтлоо гадагш аян дайн хийж, түүнийг нь Өгөдэй, Гүюг, Мөнх хаад үргэлжлүүлж Ази, Дундад Ази, Европын олон улс орныг дагуулан авах буюу эзлэн авснаар хоёр тивийн нутгийг дамнасан асар том Монгол гүрэн /эзэнт улс/ үүсэж, 50 шахам жил, оршин тогтнож байсан бөлгөө.

Чингис, түүний дараах хаадын аян дайн, Монгол их гүрэн тэр үед Ази, Европын нутагт оршиж байсан улс орнуудыг хэн ч бодож төсөөлж байгаагүй тийм түргэн хөдөлгөөнд оруулсан бөгөөд энэ нь тэдгээрийн амьдралын хэв маяг, оршин тогтнохуйн хэмжээ хязгаар, нөхцөлд байдалд эрс өөрчлөлт гаргаж, маш хүчтэй нөлөө үзүүлсэн нь дэлхий дахиныг гайхшруулсан түүхтэй. Хоромхон зуурын хугацаанд Хятадын Сүн улс, Зүрчидийн Алтан улс, Тангудын Ся улс, Хорезмын эзэнт гүрэн, Дорнод Европын Орос улс, Болгари, Унгар, Гүрж, Турк зэрэг тухайн үедээ том бөгөөд хүчирхэг гэгдэж байсан улсууд монголчуудад ялагдав. Чингис, түүнийг залгамжлагчдын аян дайны явцад Дундад Ази, Дорнод, Төв Европын олон арван жижиг вант улс монголчуудын эрхшээлд оржээ. Зөвхөн Орос гэхэд л 61 жижиг вант улс Монголчуудын харъяанд орсон байх жишээтэй.

Чингис хааны үед Монголын хүн ам 650-700 мянга байсан хэдий ч 130000 цэрэгтэй байсан аж. Монголчууд харьцангуй бага хүчээр дайсантайгаа тулалдан ялан дийлж байсан нь гайхалтай. Тэд өөрөөсөө 15, 30, 50 дахин илүү олон цэрэгтэй байлдан ялж байсан ажгуу.

Гэтэл тэр үед Хойд, Өмнөд Хятад 80 сая, Хорезмын гүрэн 20 сая, Дорнод Европын Орос улс 8 сая хүнтэй байлаа. Ийм нөхцөлд Монголчууд бага хүчээр олон дйасантай тулалдахаас өөр арга байгаагүй ажээ. Хорезмын гүрэн 330000 цэрэгтэй байхад монголын цэрэг тэр хэмжээнд хүрэх бодит бололцоо байгаагүй. Гүржийн 80000 цэрэгтэй Монголын 20-22 мянган цэрэг халз байлдан ялж байсныг Л.Гумелив судлан бичжээ /104.24-25/. Сүбээдэй, Зэв жанжны 30 мянган цэрэг Оросын вангуудын нэгдсэн хүч болох 80 мянган цэргийг ялж, Европын олон орны цэргийн давуу хүчийг бут цохиж байсан нь түүхэнд тэмдэглэгдсэн байна.

Өөрийнхөө орны нутаг дэвсгэр, байгаль цаг уур, нүүдлийн амьдралын нөхцлөөс гарч, харь орны нутаг дэвсгэрт, тэдгээрийн цэрэгтэй тулалдаж дийлж байсан ялалт, жинхэнэ монгол цэргийн сэтгэл зүй, тэсвэр тэвчээр, эр зориг, байлдах өндөр ур чадвар, жанжуудынх нь гайхамшигт цэргийн урлаг, монголын цэргийн зохион байгуулалт, хатуу сахилга, зэр зэвсэг, уналага хөсөг, эх орноосоо алс хол атлаа их цэргээ хоол, хүнс, уналагаар чөлөөтэй хангаж байсан ар талын ажиллагаа зэрэг нь дэлхийн улс орнуудыг алмайралд оруулж, монголчуудаас ихэд хоцорсоноо мэдэрч, улс бүрийн төрийн удирдлагын сэтгэхүйд шууд нөлөөлжээ. Тэдний яаж ч чадахгүй байтал нийгэм, төрийн амьдрал нь орвонгоороо өөрчлөгдөж улс орон нь Монголын их эзэнт гүрний эрхшээлд оржээ. Ази, Европ тивийн улс орнуудын харж ажигласаар байтал энэ бүх үйл явц тэдний нүүрэн дээр нь илт хурдацтай явагдаж, түүхэн хатуу сургамж, ул мөрөө үлдээн өнгөрсөн ажгуу. Дайн бол дайн. Дайн сүйтгэл учруулаад өнгөрнө. Харин тэр дайн цаашид ямар нөлөө үзүүлсэн бэ? гэдэг нь ертөнцийн анхаарлыг татаж ирсэн зүй тогтолтой. Тэгвэл Чингисийн явуулсан дайны нөлөө, өвөрмөц агаад асар их юм.

Чингис хаан, Монголын эзэнт гүрэн, Ази, Европын улс орнуудын нийгмийн зохион байгуулалт, улс төрийн амьдралд ирээдүй рүү нь чиглэсэн гүнзгий нөлөө үзүүлжээ. Азид гэхэд Хойд, Өмнөд Хятадад оршиж байсан Сүн, Алтан, Тангуд улсууд үргэлж хоорондоо байлдан тулалдаж, олон хүн амыг хядаж, эд хөрөнгийг нь булаан дээрэмдэж, хот сууринг нь сүйтгэж байлаа. Эл улсуудад төрийн хямрал удтал үргэлжилж, нийгмийн зохион байгуулалт илт хоцрогдсоноос хөгжил нь зогсонги байдалд орсон байв. Төв Ази, Хойд, Өмнөд Хятад бие биенээсээ тасархай байсны дээр, тархай бутархай, том, жижиг улс аймгууд оршиж, үргэлж хоорондоо сөргөлдөн тэмцэлдэж байсан ажээ. Энэ бүхнийг Монголын эзэнт гүрэн таслан зогсоож, байнгын дажин хямралыг эцэс болгон, тэдгээрийг нэгдэн нийлж, хөгжлийнхөө ирээдүйд

хамтран зүтгэх зам руу нь түлхэн оруулжээ. Юан улсын түүх Тайцугийн шастирт Чингис хаан “Дайчин улсыг мөхөөж, баруун Ся улсыг тэгшитгэсэн” /75.227/ хэмээн Өмнөд, Хойд хятад нэгэн захиргаанд орсныг тэмдэглэсэн байдаг. Хятадын эрдэмтэн Сайшаал, Чингис бол “Дундат улсыг нэгтгэхэд ... баларшгүй мөрөө үлдээсэн дэлхийн чанартай түүхэн хүн болно” /75.302/ хэмээн Чингисийн Хятадад үзүүлсэн их нөлөөг дүгнэсэн нь бий.

Нанжины Их сургуулийн багш Чиү Сү Сэн “Юан улсын түүхийн тухай яриа” хэмээх томоохон бүтээлдээ “Чингис хаан Тангудыг устган, Алтан улсыг дайлж, бүх Дундат улсыг нэгтгэх үйлсэд хувь нэмрээ оруулсан юм” /75.346-347/ гэж бичжээ. Францын түүхч Фернан Гренар “Чингис хааны байлдан дагуулалт хятадыг нэгтгэсэн юм” /133.299/ гэж шууд бичсэн байдаг бөлгөө. Монголын их гүрэн Өмнөд, Хойд хятад нэгдэх нөхцлийг бүрдүүлсний үр дүнд “Хятад улс нь ямар ч хувьсгал тарааж чадахгүй тийм дархан нэгдмэл бүхэл гүрэн болсон” /133.228/ нь Чингис хаан, Монголын эзэнт улсын Хятадад бүхэлд нь үзүүлсэн их нөлөөний хамгийн эцсийн том үр дүн мөн. Энэ бол аугаа үнэ цэнэтэй зүйл. Ирээдүйн хятад гүрэн байгуулагдах нөхцлийг бүрдүүлж, түүний үндэс суурийг тавьсанд энэхүү нөлөөний агуу их ач холбогдол оршино.

Чингис хааны баруун зүгт хийсэн их дайны өмнө Дундад Ази, Дорнод Европ, Орос нутагт 80 орчим том, жижиг улсууд оршин тогтнож байжээ. Хамгийн том эзэнт улс болох Визант мөхөхөд хүрч, Лалын Хорезм гүрэн дотоод зөрчилдөө идэгдээд байлаа. Зөвхөн Оросын нутагт 64 жижиг вант улс оршиж, хоорондоо үргэлж тэмцэлдэж байв.

Францын түүхч Гренарын судалгаагаар Монголчуудгүйгээр “Орос хэзээ нэгэн цагт нэгдэх байсан гэж нотлох ямар ч үндэс байхгүй байсан” /33.228/ аж. Оросуудын тархай бутархай байдал, олон жижиг вант улсуудын хоорондын үргэлжийн тэмцэлдээнийг Чингис хаан, Монгол гүрний байлдааны ялалт таслан зогсоож, цаашид хүчээ нэгтгэж, хоцрогдлоо арилгахыг түүхээр тулган шаардсан нь Орос улсын хувь заяанд гүнзгий нөлөө үзүүлжээ. Монгол гүрэн, барууны зүгээс Орос руу довтолж, Оростой тэмцэлдэж, Орост заналхийлж байсан бүх сөргөлдөөнийг зогсоож, Оросыг хамгаалжээ.

Монгол гүрэн, жижиг улсуудыг нэгтгээд Алтан ордны улсыг байгуулсан нь одоогийн Их Орос улсын суурь болжээ. Оросыг нэгтгэж Монголчуудын байгуулсан Алтан Ордны улс буюу Сарайн хаан 240 жилийн турш Оросыг шууд хаанчлан удирдсан байдаг. Оросын эрдэмтэн П.Н.Савицкий “Оросын аймаг, угсаатан, газар нутгийн нэгдлийн асуудал сэтгэл зүрхэнд нь ойр байдаг хэн ч гэсэн Оросын нэгдлийг сахин хамгаалахад Алтан Ордны улсын хаадын гүйцэтгэсэн үүргийг маргах ёсгүй” /104.610/ гэж тэмдэглэжээ.

Монголын байлдан дагуулал Орос орныг шигдсэн намгаас нь сугалан гаргаж /104.575-617/ “Оросыг байгуулсан” /133.299/ түүх ийм бөлгөө. Ингэхлээр “Оросын

эзэнт улс бол Чингис хааны монголчуудын бүтээл мөн” /133.228/ ажгуу. Монголын байлдан дагуулал тархай бутархай, хуучинсаг Оросыг хөдөлгөөнд оруулж нөлөөлсний үр дүн нь ийм буюу.

Чингис хаан, түүнийг залгамжлагчдын байлдан дагуулал, Монгол гүрний үзүүлсэн нөлөө Оросын ирээдүйд ч үлгэр болж Одессоос Ижил мөрөн, Урал, Дундат ази, Сибирийг Оросууд эзэлж, Оросын их гүрнийг байгуулсан нь “бас давхартаа Монголчуудын нөлөөг дахин түгээж тархаасан үйл хэрэг байлаа хэмээн хэлж болно” /78.18/ гэж Доктор Б.Даш-Ёндон дүгнэн бичсэн байдаг.

Чингис, Монголын эзэнт гүрэн, Дундад Ази, Ойрхи дорнод, Европын дорнод, өмнөд, төв хэсгийн улс орнуудад өөрийн нөлөөгөө үзүүлснийг түүхэн баримтууд гэрчилдэг. Их гүрний нөлөөллөөр эдгээр улс орнуудын байдал тогтворжиж, хоорондоо сөргөлдөх, дайтах нь зогссон ажээ. Өөр өөрсдийн бүрэн бүтэн байдлаа хамгаалах, хоорондын харилцаагаа шинэчилж, хүчээ нэгтгэх, нийгэм улс төрийн амьдралдаа өөрчлөлт хийх, цэргийн хүчээ зузаатгах талаар их анхаарал тавихад хүргэсэн байна. Шашин хоорондын мөргөлдөөн, дайн гарах үндэслэл таслагджээ. Түрэг, Уйгур, Австри, Өрнөд Европ /Украин, Беларус/, Литва, Польшийн байдалд ч үлэмж өөрчлөлт гарчээ.

Чингис, түүнийг залгамжлагчдын үед Орост Зүчийн улс буюу Алтан ордны улс, Баруун Азид Хүлэгийн улс буюу Ил хаант улс байгуулагдсанаар дорнод, өрнөд, төв Европын улсууд ба дээрхи улсуудын хооронд шинэ харилцаа тогтож, нийгэм-улс төрийн байдалд нь ихээхэн нөлөө үзүүлэх болсон ажгуу.

Чингис, түүний дараах хаадын байлдан дагуулал Ази, Европын улс орнуудын амьдрал, түүхэн хувь заяанд эргэлт гаргахад хүргэснийг доорхи баримтууд нотолж байна. Солонгосын Монгол судлаач Ким Жан Рэ “Мянган жилийн түүхэн хүн” хэмээх алдарт зохиолдоо “Чингис хаанаас Европчуудын авсан цочрол түүхийн хүрдийг эргүүлэх хэмжээний цочрол байсан” /38.35/ гэж дүгнэн бичсэн байдаг. Үнэхээр Чингис хаан, Монголын эзэнт улсын нөлөө Европчуудын түүхэнд түүхэн эргэлт гаргахад хүргэсэн бөлгөө.

Чингисийн байлдан дагуулал, Монгол их гүрний нөлөө Ази, Европ руу хийсэн аян дайны шинж чанартай салшгүй холбоотой байсан бөлгөө. Чингис, түүний дараах хаадын явуулсан аян дайн бол их хааны санаачлагаар бус эзлэгдсэн орнуудын бодлогын уршгаар хийсэн дайн байсан болой.

Тэд Монгол улсын эв найртай байж, чөлөөтэй худалдаа хийж, иргэд чөлөөтэй зорчиж байх саналыг хүлээн авч хэрэгжүүлсэн бол ийм дайн явагдахгүй байх байсан билээ. Монголчуудын дайн, эзлэн түрэмгийлсэн, сүйтгэл учруулсан дайн байсан боловч колончилох дайн байгаагүй аж. Монголчуудын явуулсан дайны ажиллагаа бол “ХУ-XX зууны үед Европын Испани, Португаль, Нидерланд, Англи, Франц зэрэг улсуудын хийсэн буурайгаа эзлэн түрэмгийлж, сорон мөлжих колончлолын дайны

бурангуй үйлдлээс эрс өөр зүйл байлаа” /78.9/. Колончлолын дайн нь газар нутгийг нь эзэлж, уугуул хүн амыг нь хядахаас гадна тэр орондоо засаг захиргаагаа бүрдүүлж хот, суурин, үйлдвэр уурхайнуудаа байгуулан их ашиг олохын зэрэгцээгээр өөрийн орон лугаа байгалийн асар их баялаг, эрдэнэс, түүхий эдийг тасралтгүй зөөж ихэд баяжиж байжээ. Гэтэл Чингисийн байлдан дагуулагчид ийм өргөн, уршигт үйл ажиллагаа явуулаагүй байна. Их дайны үр дүнд Монгол оронд том хот суурин, үйлдвэр, уурхайнууд нээгдэж, суваг, далангууд баригдан, газар тариалан хөгжиж, суурьшмал иргэншил бий бологгүй билээ. Зөвхөн их хаад, зарим нэг сайд ноёдын жижиг өргөө орд байгуулагдсан юм. Хамгийн том нь Хархорум хот байсан ба гадаадын урчууд, дархан, барилгачдын хоёр хороолол, Их хааны ордон, бусад хэд хэдэн барилга байгууламж, сүм хийдүүд, ноёд язгууртны гэр өргөөнүүд байсан ажээ. Нэгэнт суурьшмал амьдрал бүрэн утгаараа бий болоогүй учир дайнд олзолсон хүмүүсийг бөөнөөр нь ажиллуулах хэрэгцээгүй байсан аж. Монгол орон нүүдэлчдийн соёл иргэншлийн өлгий нутаг хэвээрээ үлдсэн бөлгөө. Хэдийгээр эзлэгдсэн орнуудаас алт эрдэнэс, эд бараа, хоргой торго сэлтийг оруулж ирж, алба, билэг авч байсан боловч тэр нь бүхэлдээ хуримтлал болж чадалгүй, хаад, ноёд, хатад, тэдгээрийн хүүхэд, орд өргөөдийн түр зуурын хэрэгцээнд зарцуулагдаж байжээ. Тэгээд ч эзлэгдсэн орнуудаас Монгол нутаг руугаа алт, мөнгө, баялгийг нь ухаан сөхөөгүй луйвардан зөөсөн гэх түүхэн баримт үгүй билээ. Нүүдэлчин хүн ардад эд баялаг хэрэггүй гэсэн юм огт байхгүй шүү дээ. Энэ бол Чингис хааны онцгой ухаан бүхий бодлого байсан /78.9/ ажгуу.

“Чингис хаан, түүнийг залгамжлагчид бол Наполеон, Гитлер, Македоны Александр /Сулхарнай/-ынхыг бүгдийг нийлүүлснээс илүү 7 сая 770 мянган ам дөрвөлжин километр нутгаар хаяагаа тэлж, дэлхийн хүн амын их зонхи төвлөрсөн Хятад, Араб, Европын соёл иргэншилт орнуудыг Монголын эзэнт гүрэнд нэгтгэсэн юм. Ингэснээрээ дэлхий дахины цаашдын хувь заяанд нөлөөлөх томоохон дэвшил, шинэчлэл даяаршлын эхийг тавьсан юм” /82.8/

Чингис хаан монголчуудын бүтээсэн их “Соёлоор бусдыг ялан дийлэх хүч чадлыг олсон. XIII зууны үеийн монголчууд чухам ийм л учир шалтгаанаар соёл иргэншлийн хүчирхэг төв болон мандсан” /82.14/ ажгуу.

Чингис хааны нөлөө зөвхөн өөрөөрөө дуусаагүй агаад цаашид ч удаан хугацаагаар үргэлжилсэн бөлгөө. Доктор Б.Даш-Ёндон “Македоны Александрын нөлөө Александртайгаа дууссан. Францын Наполеоны нөлөө Наполеонтойгоо төгссөн. Чингис хааны нөлөө Тэмүжинг тэнгэрт хальснаар дуусаагүй. Өдгөөг хүртэл тэр нөлөөг бараг судалж ч амжаагүй байна” /78.7/ гэж бичсэн байдаг билээ. Чингис хаан, Монголын эзэнт улсын нөлөө Өгөдэй, Гүюг, Мөнх хааны үед үргэлжилсээр байсан бөлгөө.

Академич Ш.Нацагдоржийн тодорхойлсноор “Чингис хаан дундад зууны үеийн дэлхий дахиныг донсолгож, орчин үеийн ертөнцийг буй болгосон” /62.304/ агуу их нөлөөтэй Монгол төрийн суут зүтгэлтэн байсан ажгуу. “Орчин үеийн Монголын нэр цуу ч Чингис, Чингис хаанаар тодорхойлогдож байна” /78.4/. Академич Ж.Болдбаатарын үнэлэмжээр Чингис хаан бол “Хүн хүч, шинэ арга технологийг сүлжилдүүлэн дэлхий ертөнцийг ойртуулж нягтруулсан гавьяат хүн” /82.30/ байв.

Чингис хаан, Монголын эзэнт гүрний дэлхий дахинд үзүүлсэн нэн чухал нөлөө бол дайн мөргөлдөөн, сөргөлдөөнийг эцэс болгож, Ази, Европод энх амгаланг тогтоосон явдал мөн. Монголын эзэнт гүрний нутаг дэвсгэр дээр энх амгалан ноёрхох болсон нь тухайн үедээ агуу үйл хэрэг байлаа. Дайн байлдаан, мөргөлдөөн, сөргөлдөөн, үргэлжийн тайван бус байдлыг таслан зогсоосон нь хүн ардын нуруу зоог тэнийлгэж, чөлөөтэй амьдрах нөхцлийг бүрдүүлжээ. Амар тайван байж, чөлөөтэй зорчин, худалдаа арилжаа хийж, аж ахуй, тариалангаа эрхэлж, мал сүргээ өсгөн үржүүлэх бололцоотой болсон нь ард олны амьдралд төдийгүй улс орнуудын сэргэлт, оршин хөгжихүйд эргээд эерэгээр нөлөөлсөн ажгуу.

Түүхч Абул Гази Бахадур “Түрэгийн гарал, үүслийн тухай” зохиолдоо “Чингис хааны үед Иран, Тураны хооронд орших асар уудам нутагт энх амгалан ноёрхож тогтож байв. Хэн боловч наран ургахаас шингэх хүртэл өчүүхэн ч аюулгүйгээр тэрэг дүүрэн алт ачаад хөндлөн гулд явдаг байлаа” /78.7/ хэмээн бичсэн байдаг. Чингис эзлэгдсэн улс орнуудад амар амгалан тогтооход ихэд анхаарч захирагчдыг томилж, тэдний дэргэд цэрэг хамгаалалтын хүч бүрэлдүүлж, эмх цэгцгүй, замбараагүй байдал гаргахаас сэргийлж, хэвийн дэг журмыг хатуу сахиулж байлаа. Английн түүхч Ж.Саундерс, Чингис хаан “Зам харгуйг харуул цагдаатай болгон, нэвтрүүлэх цэгүүд байгуулж, жингийн цувааг зэвсэгт хамгаалалттай болгож, хулгайч дээрэмчдийг устгасан байна” /77.79/ гэж бичжээ. Ард иргэд, төрийн байгууллага, худалдаачид, үйлдвэрлэгчид, гар урчууд, шашин санваартныг төрийн хамгаалалтад байлгаж, амар тайван байх нөхцлийг бүрэлдүүлж чаджээ. Энэ нь эдгээр орнууд дайны сүйтгэлийг арилгах, өөрчлөгдөн шинэчлэгдэх төрх төлөвөө сонгох, дотоодын байдлаа тогтворжуулах, аж ахуй, соёлоо хөгжүүлэхэд нь олгосон түүхэн аятай боломж мөн байсан ажгуу. Чингис хаан, Монголын эзэнт улс, Европын улс орны ард түмэнд эрх чөлөөт байдал олгосон юм.

Европ, Азийн Монголын эзэнт улсын эрхшээлд орсон улс орнуудын ард иргэд харьцангуй эрх чөлөөт байдлыг олж авсан байна. Тэд өөрсдийн хаад, ван, эздийн хэмжээ хязгааргүй дарамт, эзэрхийлэл, түрэмгийллээс бүрмөсөн ангижрах буюу хөнгөвчлөгдөж чаджээ. Улс тус бүрийн төрийн хүчирхийлэл хаад ноёдын эрх мэдэл суларч, ялангуяа Чингис хааны үед харьцангуй чөлөөт бас хоёрдмол байдал бий болж байжээ.

Ард түмний дунд захирагдах шинэ харилцаанд шилжин орж, улс төр, эдийн засгийн хүчирхийллийг тэвчих, эс тэвчих, сөрөн зогсох эсвэл дэмжих, гомдоллох үгүй бол хүлцэнгүй байх шинэ сэтгэхүй бүрэлдэж, хоёрдмол шинжтэй нөхцөл байдалд амьдрах болсон ажгуу.

Чингис хаан, чөлөөт байдал бий болгох, хүчирхийлэл, дарлал мөлжлөгийг багасгах бодлого явуулж, бас ч тухайн үедээ эргэлтийн шинжтэй томоохон арга хэмжээнүүд авч, гагцхүү хуульд захирагдахыг зарлиглаж байв. Даосын номлогчид Чингист зориулж дурсгалын багана босгоод түүн дээр их хааны хэлсэн үгийг бичсэн байдаг. Чингис хаан “Миний хоньчин, адуучны л өмсдөг тэр хувцсыг би өмсдөг, тэдний л иддэг хоолыг би иддэг. Би ард түмэндээ хүүхэд адил үзэж хандан, цэрэг дайчдаа ах дүү нар мэт үздэг.

Байлдаан тулалдаанд орохдоо би ямагт тэдний өмнө явдаг. Долоон жилийн хугацаанд би агуу их үйл хэргийг бүтээсэн бөгөөд энэ цагаас эхлэн орон зайн бүх зургаан хэмжээнд орших юм бүхэн ганцхан хуулинд захирагдмуй” /72.266/ гэж хэлсэн үгийг баганаан дээр бичсэнийг Францын алдарт монгол судлаач Рене Груес “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” хэмээх том бүтээлдээ иш татан өгүүлсэн байдаг билээ. Эзлэгдсэн улс орнуудад томилон суулгасан өөрийн төлөөний сайдууддаа ард түмний амгалан тайван байдлыг хангах, ноёд язгууртнуудын захиргааг хянах, улс төрийн хувьд дур зоргоор аашлах, дураараа алба татвар авах явдал гаргуулахгүй байх, худалдаа арилжаа хийх, шашин шүтлэг явуулах, чөлөөтэй зорчих, дуртай аж ахуйгаа эрхлэх зэргийг хязгаарлахгүй байхыг зарлигаар үүрэг болгож байжээ.

Чингис ба Өгөдэй хаан эзлэгдсэн орнууд дахь алба татварын төрөл хэмжээг зөвхөн Их хаан болон төлөөний сайд тогтоож байх журмыг гарган мөрдсөн нь агуулгаараа эзлэгдсэн орнуудын ван, ноён, язгууртан, хэн хүн ард иргэдээс дураараа алба татвар авахыг хязгаарласан шинжтэй байсан бөлгөө. Эзлэгдсэн орнуудын амьдралд хамгийн аятай чөлөөт байдал олж авч, хишиг хүртсэн нийгмийн бүлэг нь худалдаачид, лам санваартнууд байсан ажгуу. Энэ талаар Английн түүхч Ж.Саундерс “Монголын байлдан дагуулал” зохиолдоо “Чингис итгэл сүжгээ бусдад хүчээр тулгах тийм хандлагыг хэзээ ч гаргаагүй бөгөөд харин ч бүх итгэл, сүжгийн тэгш эрх чөлөөг олгосон. Загалмай, лал, будда зэрэг бүх шашин өөрсдийн итгэл сүжгийн бүрэн эрх чөлөөг эдэлж, Монголын эзэнт улсын хаана ч номлол сургаалаа дэлгэрүүлж, нэг нь нөгөөгийнхөө эрх чөлөөнд ер халддаггүй байлаа...

Энх амгалан, аюулгүйн буян хишгийг худалдаачид залбиран хүртэж байлаа” /77.79.81/ гэж бичсэн байдаг билээ. Чингис хаан, Монголын эзэнт гүрнээс Ази, Европын улс орнуудын ард түмэнд харьцангуй чөлөөт байдал олгосон нь тэднээс өөр өөрсдийн уугуул нутаг худалдаа, соёлын хөгжлийн дэвшил, хурдцыг бий болгоход

хүч чадлаа зориулах боломж олгоход нийгмийн чухал нөлөө үзүүлсэн болой. Чингис хаан, Монголын эзэнт гүрэн Дорно, Өрнө дахины улс орон ялангуяа Хятад, Орос, Дундад Ази, дорнод, Өрнөд, Европын улс орнуудын төрт ёс, засаг захиргаанд ихээхэн нөлөө үзүүлсэн бөлгөө. Дээрхи орнууд Монголын эзэнт гүрэнд захирагдах болсноор төр барих дээд эрх, төрийн бүрэн эрхт байдал нь алдагдсан хэдий ч колончлолын төвлөрсөн хатуу захиргаа, онцгой хурц дэглэмийг тогтоогоогүй болой. Чингис, түүний дараах хаад Монголын эзэнт гүрний хаан байж, хэмжээгүй эрхтэй байсан ч эзлэгдсэн орнуудыг шууд гардан захирах үзэл баримтлалгүй, харин төлөөний сайд, түүний өөрийн нь албаар дамжуулан захирах “аядуу” бодлого явуулжээ. Эзлэгдсэн орнуудыг захирах хүнд нүсэр байгууллага /Засгийн газар, яам гэх мэт/-ыг ч байгуулаагүй, хүчирхийлэн барих байнгын их армийг ч бий болгоогүй ажээ. Төлөөний сайдаар гол төлөв хааны хүү, ач /Зүчи Цагаадай, Бат, Бэрх, Хубилай, Хүлэгүй гэх мэт/ нар болон нутгийн эрдэм номд боловсорсон ард олондоо нэр хүндтэй түшмэд /Мухаммед Ялович гэх мэт/-ийг томилж, дор нь зөвлөх, ахлах ноёд, үйлчилж туслах түшмэлээр орон нутгийнх нь үнэнч шударга хүмүүсийг ажиллуулж байжээ. Вант улс, хотуудыг нутгийнх нь хүнээр захируулж байсан байна.

Чингис хааны эл бодлого нь нэг талаас монголын төрт ёсны элементүүд нэвтрэн орох, нөгөө талаас улс орнуудын төрт ёсны уламжлал өвлөгдөх, улмаар энэ хоёрын хослох төрх төлөв нь тэдгээрийн нийгэм, улс төрийн амьдралын цаашдын хөгжилд гүнзгий нөлөө үзүүлжээ. Энэ тухай Ираны төрийн зүтгэлтэн Жувейни “Чингис олон нутаг орныг эрхшээлдээ оруулсныхаа дараа эдийн засгийг нь хөл дээр нь босгоход анхаарч, сүйрсэн хотуудыг сэргээн босгож, худалдаачид наймаа, гүйлгээнийхээ ажиллагааг монгол цэргийн хамгаалалтын дор үргэлжлүүлэн явуулах тавьж өгчээ” /31.30-31/ гэж бичжээ. Чингис хаан, Монголын эзэнт гүрний Алтан ордны улс, Дундад Ази дахь ил хаант улс байгуулагдан тив, бүсийн шинжтэй төвүүд болж, бусаддаа нөлөөлсөн байна. Оросын нутагт Киев, Москва, Владимир төвтэй вант улсууд харьцангуй биеэ даан хөгжиж, Оросын соёлын томоохон төвүүд болжээ. Цаашдын хөгжлийн явцад дорнод, өрнөд орос хоёр ялгаран салснаар орос ердөө л хоёр том хэсэг болж, улмаар нэгдмэл Орос бий нөхцлийг монголчуудын нөлөө, үлгэр жишээгээр аажмаар бүрдүүлсэн бөлгөө. Мөн Дундад Ази, Иран, Хойд Энэтхэгт Монгол хаадын угсааныхны байгуулсан улсууд дараа дараалан үүсэж Монголын эзэнт гүрний нөлөөг хадгалсаар байжээ. Монголын эзэнт гүрний нөлөөгөөр хятад гүрэн үүсэх нөхцөл алгуураар бүрдэж, улмаар Солонгос, Энэтхэг, Хятадын хойгийн улс орнуудын биеэ даасан байдал хангагдаж, үндэсний улсууд бий болон хөгжихөд эерэг нөлөө үзүүлсэн байна. Монголын эзэнт гүрний нөлөө Турк, Сири, Унгар улсууд тайван нөхцөлд биежин хөгжих аятай нөхцөл нь болжээ.

Чингис хаан, Монголын эзэнт гүрэн Ази, Европын орнуудын аж ахуй, эдийн засгийн амьдралд өөрийн нөлөө, ул мөрөө үлдээсэн ажгуу. Энэхүү нөлөө нь сүйрсэн хот сууринг сэргэж босгох, шинэ хот суурин байгуулах, үйлдвэр, гар урлал, хөдөө аж ахуй, зам, харилцааг хөгжүүлэх, худалдаа арилжааг нээлттэй, чөлөөтэй болгон өргөжүүлэх замаар илрэн хэрэгжсэн аж. Орост гэхэд л Киев, Чернигов, Переслаяль, Рязань, Суздал, Владимир Ростов хотыг сэргээж босгож, Смоленск, Новгород, Пеков, Галич хотыг өргөтгөж, Москва хотыг шинэчлэн байгуулжээ. Дундад Азийн Самарканд, Бухар, Ургенч хотыг сэргээн, Сарай хотыг шинэчлэн байгуулсан байна. Хятадад Бээжин хотыг шинэчлэн байгуулж, бусад олон хотыг сэргээх буюу өргөтгөжээ. Тибелис хот, Персийн аль ч хотоос дутуугүй баян тансаг хот болжээ.

Чингис, түүний дараах их хаадын үед Ази, Европын орнуудын худалдааны хөгжилд эрс өөрчлөлт гарчээ. Чингис хаан, уламжлалт торгоны замыг бүрэн нээлттэй, чөлөөтэй болгож, Ази, Европыг холбосон худалдааны гүүр, их замын түвшинд өргөтгөн хөгжүүлжээ. Английн Ж.Саундерс “Өөртөө эзлэгдсэн олон янзын нутаг орныг эдийн засгийн нэгэн ойр сүлжээнд нэгтгэн оруулах зорилгын үүднээс Чингис олон улсын худалдаанд маш их ач холбогдол өгч ... азийн аялал жуулчлалын их замыг хэзээ ч байгаагүйгээр зассан байна” /77.79/ гэж бичсэн байдаг. Монголын эзэнт гүрний худалдааны талаар авсан арга хэмжээ, тухайлбал, худалдааг бүх талаар дэмжих худалдаачдыг чөлөөтэй зорчих боломжтой болгон татвараас чөлөөлөх, худалдаачдыг төрийн хамгаалалтад авч аюулгүй байдлыг нь хангах, худалдааны их замаар тайван зорчих, нөхцөл бүрдүүлэх, худалдаачдад улсын өртөөний замыг чөлөөтэй ашиглуулах гэх зэргээр арга хэмжээнүүд нь гадаад, дотоод худалдаа хөгжихөд их нөлөө үзүүлсэн аж. Монгол их гүрний үед хятадаас, Европ хүртэлх асар уудам орон зайд худалдаа чөлөөтэй, өргөн явагдаж, улс орнуудын эдийн засгийн хөгжилд ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн болой.

Худалдаачид, ялангуяа “Ашиг хонжоо ихтэй, хөрөнгө зоорьтой нөлөө бүхий худалдаачид Монголын эзэнт улсыг дэмжигчид болон хувирчээ” /77.80/. Монголын эзэнт гүрний үед гадаад худалдаа өргөн дэлгэр болсноор Хятадын бараа таваар Дундад Ази, Орос, Европод нэвтэрч, Европын орнуудын бараа тавар Дундад Ази, Орос, Монголоор дамжин Хятад, Солонгост хүрч байсан нь Дэлхийд худалдааны хамгийн урт зах бий болсныг харуулж байна. Энэ нь Чингис, Монголын эзэнт улсын дэлхий дахинаа үзүүлсэн нэн бодитой нөлөө мөн юм. Академич Ж.Болдбаатар “Өрнө, дорныг холбосон торгоны замыг сэргээж, өртөө, шуудан холбоог үүсгэн тэрлэсэн нь улс түмнүүдийн харилцан ойлголцох, соёлын харилцаа холбоогоо өргөжүүлэхэд хүчирхэг түлхэц үзүүлсэн” /82.8/ хэмээн бичжээ.

Үнэхээр хятадаас Монгол, Орос, дундад Ази, Европ хүртэлх их орон зайд морин өртөө байгуулсан нь тухайн үедээ хамгийн шуурхай шуудан харилцаа болж,

хамгийн богино хугацаанд мэдээлэл солилцох боломж олгож байжээ. Эзэн хааны бие төлөөлөгч, улс хоорондын элч нар энэхүү өртөөгөөр саадгүй агаад тасралтгүй зөрчиж, улс төр, цэрэг, эдийн засаг, худалдаа, соёлын өргөн мэдээлэл дамжуулж байсан нь тухайн үедээ гайхамшигтай амжилт юм. Өртөөлөн явах зам, суурь өртөөдийн бааз /Өртөөний удирдлага сууц, өргөө, хоол хүнс, гал тогоо, улаач /хөтөч/, үйлчлэх алба гэх мэт/ нь олон улс орны хүн ардын хамтын хөдөлмөр, хүч зүтгэлийн үр дүн, тэдний үлэмжийн их бүтээл, том соёл мөн байв. Өртөөлөн явах их зам нь аялал жуулчлалын ба худалдааны зам, тэмээн жин, үхэр тэрэг, жууз тэрэг зорчих их зам болон үйлчилж байсан аж. Түүний буян хишгийг Монгол төдийгүй олон улс орон хүртэж байсан бөлгөө. Монголын их эзэнт гүрний үед Оросоос барууны орнууд/Итали, грек, Австри, Германи, Франц зэрэг/-тай худалдаа хийх явдал ихэд хөгжсөн байна. Алтан Ордны улс, Ил хаант улсуудын хооронд өргөн худалдаа явагдаж байв. Алтан ордны улс Новгород крым ба Азовын тэнгисээс Италийн худалдаачидтай харилцан худалдаалах явдлыг хөгжүүлж байлаа. Ийм байдлаар Монголын их гүрнийг хамарсан өргөн худалдаа улс орнуудын эдийн засаг сэргэн хөгжихөд томоохон нөлөө үзүүлж, ард нийтийн аж амьдрал, ахуй, соёлын хэрэгцээг хангахад ихээхэн дэм тус болж байсан ажгуу.

Чингис хаан, Монголын эзэнт улсын нөлөө дэлхий дахины шашин, шүтлэгийн ертөнц, сүм хийдүүдийн амьдрал, тэдгээрийн хөгжилд эргэлт гаргасан хэмээн үзэж болно.

Юуны өмнө Ази, Европын орнуудад тасралтгүй шахам үргэлжилж ирсэн шашны урсгалуудын сөргөлдөөн, шашин хоорондын дайныг таслан зогсоож, ард түмний амьдрал, эдийн засаг, соёлын хөгжилд тэдгээрийн үзүүлж байсан хор хохирлыг арилгах тэмцэлд нийтийн их хүчийг нэгтгэсэн бөлгөө. Монголын эзэнт гүрэн байгуулагдаж оршин тогтносноор, Английн түүхч Гарольд Дэмбийн тодорхойлсончлон “загалмайтнуудын урт удаан үе дуусгавар болов. Монголчуудын ноёрхлын үед Христийн шашны номлогчид амь насныхаа төлөө санаа зовж айхгүйг Бурхдын авсанд, лалынхан Соломоны сүмд очиж мөргөж залбирдаг болсон байна. Европын гэгээн хуврагууд анх удаа алсын Ази руу зүрхлэн тэнүүчлэх болж, загалмайтнууд Иоаны ламтны улс Хятадыг бут цохин ниргэсэн өндөр уулын өвгөн байлдан дагуулагчийг олж харах хэмээн найдаж явсан юм” /17.163/

Чингис хаан амьд ахуйдаа бүх шашныг хооронд нь ялгаварлан үзэхийг зарлигаар хориглож, бүх шашинд адил тэгш байх, аль ч орны иргэд дуртай шашнаа шүтэх эрх чөлөө олгосон бөлгөө. Энэ бол бөөгийн мөргөлт Чингис хааны хувьд ухаан, зоригийг гаргасан, тухайн нөхцөлдөө тохирсон агуу бодлого, агуу соёл байсан болой. “Эзэн Чингисийн өөрийнх нь болон дараах үеийнх нь Монголын их эзэнт улсад алив шашныг ялгаварлан гадуурхахгүй адил, түвшинд үздэг байлаа. Үүнийг холбогдох бүх ном сударт тэмдэглэжээ.

Энэ бол сайшааж, бахдууштай бодлого мөнөөс мөн байжээ” /78.14/ гэж доктор Б.Даш-Ёндон бичсэн байна. Чингис хааны энэ бодлого нь Монголын эзэнт улсын харъяанд байсан нутаг дэвсгэр дээр лал, христос, буддын шашин чөлөөтэй хөгжих, шашины сүм хийдүүд олноороо байгуулагдах, иргэд дуртай шашнаа чөлөөтэй шүтэх их бололцоо бий болж тэгснээрээ шашны гүн ухаан, ёс суртахуун, зан үйл, жаяг дэг, шашны урлаг, улам бүр боловсрон төлөвшихөд бодитой нөлөөлсөн байна. Академич Ш.Нацагдорж “Монголчууд аливаа шашныг хөхүүлэн хөгжүүлж байсан тул тухайн орны соёл, сүйдэлгүй аврагдан үлдсэн гэж үзэх бүрэн үндэстэй” /61.288/ гэж тэмдэглэсэн нь бий.

Чингис хааны шашны бодлогын үр дүнд Ази, Европын орнуудад шашин чөлөөтэй дэлгэрэн сүм хийдүүд олноор байгуулагдаж, шашны том төвүүд бий болжээ. Алтан улс, ил хаант улсуудад лалын шашин, Орост христосын шашин дэлгэрч оюун санааны амьдралд нь их үүрэг гүйцэтгэж байв. Монголын эзэнт гүрний үед шашин чөлөөтэй дэлгэрч сүм хийдийн төв нь дорно дахинд чиглэх болсон байна. Г.В.Вернадский “Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс” хэмээх бүтээлдээ Чингисийн эзэнт гүрнээс Европчуудын шашинд хэрхэн нөлөөлсөн асуудлыг судлан шинжилсэн байна. Тэрээр “Сүм хийдийн нөлөөний төв нь дорно дахин руу улам чиглэн лавширсаар байв. Сүм хийдийн анхны төв Ром нь газрын дундат тэнгисийн язгуур Ромдоо байсан юм. Гэтэл хоёрдахь, шинэ Ром нь Европ-Азийн зааг дээр Боферын хоолойд Византид оччихсон билээ Гуравдахь Ром нь дорно дахин руу бүүр цааш лавширч дорнын гүнд Монголын Орост, москвад бий болсон юм. ... Дорно дахин руу Ираны Ази, Турк, Монголын тал нутаг руу нестрорианы урсгал тархав” /14.17/. Монголын эзэнт улсын үед шашны Сарай, Москва гэсэн хоёр том төв үүсэж, Оросын шашин сүмийн байгууламжийн голт зүрх нь болжээ. Бүх Оросын дээд санваартны захиргаа /метрополит/ Москвад төвлөрч Крутицад суурьшжээ. Крутицийн дээд хамба нь Оросын соёлд Монголчуудаас үзүүлсэн нөлөөний гүн гүнзгий бэлгэ тэмдэг болж чаджээ /14.28/. Монголд Будда, Лал, Христийн шашин нэвтэрч, сүм хийд нь байгуулагдаж байсан бол Хятадад будда, Бомбын шашин дэлгэрсэн байна. Монголын эзэнт улс шашины зүтгэлтэн, лам санваартныг албан татвараас чөлөөлсөн нь аль ч шашин дэлгэрэн хөгжихөд нэн чухал нөлөө үзүүлжээ.

Чингис хаан, Монголын эзэнт гүрэн, Ази Европын орнуудын эдийн засаг, аж ахуйн амьдралд үлэмж нөлөө үзүүлсэн ажгуу. Чингис хаан өрнө зүг хийсэн аян дайныхаас явцаас улс орнуудын дайнд сүйдсэн аж ахуйг сэргээх, эдийн засгийн цаашдын хөгжлийг жам ёсных нь дагуу түргэтгэх бодлого явуулж эхэлжээ. Монголын эзэнт гүрний үед дайнд доройтсон аж үйлдвэрийн үйлдвэрлэл, гар урлал, хөдөө аж ахуйг сэргээх, шинэчлэн хөгжүүлэхэд анхаарал тавьж, тэтгэх туслаж дэмжих бодлого,

үйл ажиллагаа явуулжээ. Дайны уршгаар Киевийн паалангийн үйлдвэрлэлийн газрууд хаагдаж, угалзат паалангийн орос урлаг тасалдан, гоёл чимэглэлийн үйлдвэрлэл зогссоныг сэргээх ажиллагаа явуулжээ. Москва хотод хонхорхойт, угалзат пааланг гоёл чимэглэлийн үйлдвэрлэл байгуулагдаж, вааран эдлэлийн урлаг сэргээгдсэн байна. Новгород хотод аж үйлдвэрийн үйлдвэрлэл сэргэж, Орост хар төмөрлөгийн үйлдвэрлэл илт сэргэжээ. ХҮИ, ХҮ зууны үед хотуудын гар урлал түргэн хөгжиж, Тверь, Москва, Звенигород хотууд гар урлалын өрнөнгүй хөгжилтэй төвүүд болсон байна /14.35-37/. Өрх гэрийн гар урлал, сүм хийдийн гар урлал хөгжижээ. Сүм хийдийн үйлдвэрлэл, гар урлал хөгжсөн нь тэднийг албан татвараас чөлөөлж байсантай холбоотой аж.

Хөдөө аж ахуй нь монголчуудын байлдан дагуулалд аж үйлдвэр гар урлалаас арай бага өртсөн салбар байжээ. Монголчууд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг аль болохоор бууруулахгүйг хичээж байсан учир ахиц гарах нь түргэн байжээ. Овьёос, улаан буудайн тариалалт нэмэгдэж, ан ав, загас агнуурын салбарт ахиц гарч төмөр боловсруулалт, давс олборлолт, анжис хэрэглэлт өсөж, шинэ маягийн анжис үйлдвэрлэх болжээ. Шинэ техникийн ололт нь Москвагийн төр улс хөгжиж цэцэглэсэн нэг гол шалтгаан байжээ /14.39/. Адуу, үхэрийг тэжээж үржүүлэх, өгөхөд ихээхэн амжилт олсон аж. Чингис хаан, эзэнт гүрний үед Оросын хөдөө аж ахуй хөгжиж байсныг судлаачид нэлээд өргөн тэмдэглэсэн байдаг бөлгөө.

Умард, Өмнөд хятадад дайнд сүйдсэн хот суурин, аж ахуй, газар тариаланг сэргээх, ажил явуулж суурьшмал нэгдмэл эдийн засгийг бий болгоход анхаарсан байна. Сүйдсэн хот сууринг сэргээхийн хамт шинэ шинэ суурингууд байгуулагджээ. Умард хятадад тариа, ногооны талбайг өрнүүлж, шинэ суваг далангууд барьсан байна. Аж үйлдвэрийн үйлдвэрийн үйлдвэрлэл, гар үйлдвэр, усан онгоцны үйлдвэрлэл, бөс бараа ялангуяа торгоны аж ахуй хөгжжээ. Хятад, Монгол, Орос, Дундад Азийг дамжсан гадаад худалдаа хөгжиж, барууны бараа таваарууд хятадад нэвтрэх болжээ. Иран дахь ил хаад “Бага Азийн шинэчлэлийн бодлого явуулсны үр дүнд Ираны эдийн засгийг сэргээсэн байна” /130.285-289/.

Чингис хаан, Монголын эзэнт улс дэлхий дахины соёлын хөгжилд үлэмж нөлөө үзүүлжээ. Оросын Монгол судлаач А.Дугин “Чингис хааны эзэнт улс бол зөвхөн л нутаг газрыг эзлэн дагуулсан хэрэг төдий бус ба онцгой бөгөөд түгээмэл ёс зүйг баталгаажуулсан хэрэг байлаа. Энэ ёс зүйг Чингис хаан өөрөө төгс төгөлдөр ухамсарлаж байсан бөгөөд түүхэн аугаа их учир холбогдолтой “Их засаг” хуулиндаа Тураны оюун санааны хуулийг нэгтгэн эмхлэхийг эрхэмлэсэн юм” /78.45/ гэж өгүүлжээ. Чингис хаан суурьшмал ба нүүдлийн соёлын харилцан хамаарал, бие биедээ нэвтрэлцэх мөн бие биеэ харилцан нөхөлцөх хэрэгцээ шаардлагыг танин мэдэж, улмаар тийнхүү аль

алиндаа нөлөөлөх нөхцлийг бүрэлдүүлсэн нь түүний агуу их гавъяа мөн юм. Чингис хаан, монголчуудын нүүдэлчдийн соёлд хэрэг болох, түүнд эерэг нөлөө үзүүлэх суурьшмал соёлын ололтыг авч хэрэглэсэн болно. Энэ нь Ази, Европын орнуудын суурьшмал соёл монгол оронд Монголын нүүдэлчдийн соёл мөн дээрхи орнуудын соёлд нөлөө үзүүлэхэд хүргэжээ. Чингис хаан түүнийг залгамжлагчид Хятадын Елюй Чуцай, Уйгурын Тататунгаа, Хар Хятаны Елю Даши, Ираны Махмуд Ялавич, Малик Ата Жувейни, Рашид-ад-Дин, Лалын Абу-эль Рахман, Армяны-Хайтхон зэрэг дорно, өрнийн төрийн зүтгэлтэн, эрдэмтэд, ухаан төгс мэргэдийг төрийн үйл хэрэгтээ өргөн хэмжээнд оролцуулж, сайд, зөвлөх, түшмэл, бичгийн албанд ажиллуулж байлаа. Чингис хаан Уйгур, Турк, Армян, Хятаны соёлыг ихэд хүндэтгэж, Уйгуржин бичгийг үндэслэн үндэсний бичиг үсэг бий болгож, улмаар төрийн хэргээ эл бичиг үсгээр хөтлөн явуулж байлаа.

Чингис хаан “Сайхан нумтай болоход сайн уран хүн хэрэгтэй. Эзэнт их гүрнийг удирдахад мэргэн хүн бүхнээс чухал” /17.185/ гэсэн Елюй Чуцайн зөвлөгөөг ихэд анхааран сонсож, нухацтай хүлээн авсан байдаг. Чингис хаан өөрийн дүү нар, алтан ургийнхан, хүүхдүүд, ач гуч, сайд, түшмэл нартаа суурьшмал орны эрдэм номын хүмүүсээр бичиг үсэг заалгаж, ном эрдэмд сургаж, үзэл бодлыг нь төлөвшүүлж байв. Елюй Чуцай хааны ордны дэргэд сургууль байгуулан бичиг үсэг, ном, эрдэм зааж байжээ. Хятадад Мухулай, Хубилай, өрнөдөд Зүчи, Бат, Цагаадай, Өгөдэй, Тулуйн хүүхэд, ач гуч нар тэдгээрийн удмынхан өөр өөрсдийн муж, улс, орныг удирдан жолоодоходоо тухайн орны эрдэмтэн мэргэд, төрийн зүтгэлтэн, ухаалаг хүмүүсийг өөрийн сайд, зөвлөх, түшмэлээр ажиллуулж, муж, хот, суурин захирагчдаар томилон, шашны удирдагч, санваартан лам, сүм хийдүүдийн чөлөөт байдлыг хангаж байсан нь өрнө, дорнын төрийн ёсон, нийгмийн соёлд ихэд эерэг үзүүлсэн байна. Барууны болон Дорнодын соёл, газар тариалан-тэнгис далайн болон талын нүүдэлчдийн соёлыг нэгтгэгч болох Ром, Византийн үүрэг Византийн эзэнт улсыг унасны дараа XIII зууны эхээр Монголчуудын эзэнт улсад шилжжээ /78.71/ гэж Г.З.Веридск бичжээ.

Чингис хаан, түүнийг залгамжлагчид, Монголын эзэнт гүрний байлдааны их соёлыг дэлхий дахинаа дэлгэрүүлсэн ажгуу. Их гүрний аян дайны байлдааны соёл нь ямагт ялан дийлж байсан нүүдэлчдийн армийн байлдааны стратеги, тактик, цэргийн жанжнуудын авьяас билэг, эр цэргийн байлдах ур чадвар, зэвсэг техник, түүнийг бүтээх, хэрэглэх ухаан, байлдааны зохион байгуулалт, үүрэг сахилга, ялагдагчтай харьцах, биедээ татах арга, байлдааны сүйтгэлийг багасгах, засах арилгахад зориулагдсан бүхэл бүтэн цогц том соёл байсан аж.

Энэ агуу соёлыг эзэмшигч нь Монгол цэргийн жанжин, инженер, захирагч, ахлагч, жирийн цэргүүд, тэдгээрт үйлчлэх ар талынхан байсан бөгөөд тэд энэхүү

соёлоо хамтран зүтгэгчид хавсран байлдагчид, түүгээр ч барахгүй ялагдагсаддаа санаатай болон санамсаргүй байдлаар дэлгэрүүлсэн байна.

Монгол гүрэнд дагаар орсон орнуудын Монгол цэрэгт хүч нэмсэн цэргийн ангиуд, дайнд ялагдсан орнуудаас олзлогдсон дайчлагдсан цэргийн ангиуд болон Хятад, Дундад Ази, Европын эзлэгдсэн орнуудын захирагчдын хамгаалах цэргүүд, Алтан орд, Ил хаант улсын цэргүүд тухайн орноос дайчлагдсан цэргийн жанжин, дарга, цэргүүд монгол цэргийн урлагт суралцсан нь цэргийн соёлыг дэлгэрүүлэгч, хэрэглэгч гол хүч болжээ. Монгол гүрний байлдааны соёлыг эзэмшигчид өөр өөрсдийн орны цэргийн хүчийг бэхжүүлэх, байлдах чадварыг дээшлүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлж, тэр нь эргээд монголчуудын ноёрхлыг устгахад тус нэмэр болсон ажээ.

Чингис хаан түүний эзэнт гүрэн яруу найраг, дуу хөгжим, бүжиг, уран зураг хөгжихөд ихээхэн нөлөө үзүүлжээ. Чингис хаанаас эхлээд түүний хамтран зүтгэгчид Мухулай ван, Боорчи, Шихихутаг, Сүбээдэй, Зэв, Зэлмэ жанжин, Бөртэ хатан, Сөнөдийн Гилүгэдэй баатар, Ираны Рашид-ад-Дин зэрэг олон яруу найрагчид болон Дундад Ази, Оросын Европын яруу найрагч, туульчид, зохиолч уран бүтээлчид их гүрэн төдийгүй бусад улс орнуудын соёлын ертөнцөд ихээхэн нөлөө үзүүлжээ. Европын орнуудад сүм хийдийн урлаг, шашин уран зураг, бурхдын хөрөг, хана туурга, дээврийн зураг чимэглэл хөгжжээ. Оросын бурхан бүтээлчид чөлөөтэй өнгө будаг тавих арга, техникийг өргөн хэрэглэх болсон байна. Орост бурхан зураг, түүнийг үндэслэгч Андрей Рублев ихэд алдаршжээ. Сүмийн дуу хуур, аялгуут дуулал найрал дуу ч, бас хөгжсөн байна. Бат хааны Киевт довтолсон тухай, Куликовын тулалдааны тухай, Доныхны амьдралын тухай домог, туульс мөн Иран, Туркийн баатарлаг дууллууд, Татарчуудын баатарлаг гавъяа, тэднээс Христийн сүм хийдийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийн тухай түүхэн зохиол, намтрууд Монголын эзэнт гүрний Орост үзүүлсэн нөлөөний үр дүн мөн юм.

Чингис хаан, Монголын эзэнт гүрний нөлөө Мөнх хааны үеэр дуусаагүй, харин цааш удаан хугацаагаар үргэлжилсэн бөлгөө.



ТАВДУГААР АНГИЙН НОМ ЗҮЙ

Монгол хэлээр

1. Алтан ордны тайлга. Бээжин.1983
2. Алтаншаа Н. Монголын гурван хаан-Өгөдэй, Гүюг, Мөнх. Хайлаар.1985
3. Амар А. Монголын товч түүх. УБ.,1934, 1992
4. Асрагч нэргийн түүх. Хэвлэлд бэлтгэсэн Х.Пэрлээ. УБ.,1960
5. Багана Б.Болдбаатар Биеэр дайлсан тэмдэглэл. Хөх хот. 1979
6. Баярхүү Г. Монголын нэгдсэн төрийн болон дараах үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь. УБ.,1997
7. Баяр Б. Чингисийн үзэл ертөнцийн үзүүртэй болохын учир. 1998
8. Баярсайхан Б. Хууль зүйн товч тайлбар толь. УБ.,2000
9. Бира Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ.,2001
10. БНМАУ-ын түүх. Нэгэн боть. УБ.,1954
11. БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. УБ.,1966
12. Болдбаатар Ж. Лүндээжанцан Д. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.,1997
13. Болдбаатар Ж. Түүх зулсан он жилүүдийн ойлго. I, II боть. 2003
14. Вернадский Г.В. Чингисийн үеийн Монголчууд ба Орос улс. УБ.,1994
15. Вернадский Ж. Чингис хааны их засгийн судалгаа, түүний агуулга УБ.,1992.
16. Галдан. Эрдэнийн эрх. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1960
17. Гарольд Дэмб. Дэлхийн эзэн Чингис хаан. УБ.,2003
18. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.,1998
19. Гонгор Д. Халх товчоон. II боть. УБ.,1976
20. Гомбожав. Гангын урсгал /Чингисийн алтан ургийн түүх/. 1960
21. Гомбосүрэн Ц.Монголын уламжлалт нийгэм феодализм мөн үү. УБ.,1998
22. Гэрэлбадрах Ж. Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх. МЭӨ III-МЭ XIX зуун. УБ.,2002
23. Далай Ч. Монголын түүх. Мх Монгол улс. 1206-1260. УБ.,1994
24. Далай Ч. Эзэн Чингисийн гэрээслэл ба эдүгээ миний бодол. Чингисийн туг. УБ. 1990
25. Джавахарлал Неру. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ.,1958
26. Дашням И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз. УБ.,1997
27. Дорнотив. Чингис хааны цэргийн эрдэм. Хөх хот. 1990
28. Жамбалдорж. Болор толь. УБ.,1981
29. Жамсран Л. нар. Монголын түүхэн бага нэвтэрхий толь I, II. УБ.,1998

30. Жалан-Аажав С. Арван буянт номын цагаан түүх. УБ.,1998
31. Жувейни А. Ертөнцийг байлдаж дагуулагчийн түүх. Хөх хот. 1980
32. Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ.,1987
33. Жүгдэр Ч. Чингисийн төрийн үзэл, цэргийн эрдэм. Хөх хот. 1990
34. Инжнаши. Хөх судар. Хөх хот.1991
35. Ишжамц. Монголын нэгдсэн төр, улс байгуулагдаж феодализм бүрэлдэхүүн тогтсон нь. УБ.,1974
36. Ишжамц Н. Чингис хаан Хятадын эрдэмтэн Чин Чунь бомбыг урьж уулзсан нь. УБ.,1993
37. Ишжамц Н. Монголын төр, ёсны уламжлалын асуудал. УБ.,1986
38. Кимэжон Рэ. Мянган жилийн түүхэн хүн. УБ.,1999
39. Кычанов Е.И. Ертөнцийг эзэгнэн дагуулсан Тэмүжиний үйл амьдрал. УБ.,2000
40. Лааган Б. Монгол хаадын хураангуй товчоон. УБ.,1998
41. Лхагваа Б. Монгол Солонгосын харилцааны уламжлалаас. Сөүл.1996
42. Лиу Жинь Сувэ. Хаадын үндэсний хураангуй Алтан товч. Хөх хот.1980.
43. Лүндэндорж Н. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ.,2002
44. Лувсанданзан. Алтан товч. УБ.,1990
45. Лхаашид. Монголын хаад зүтгэлтнүүдийн жолоодохын урлаг. УБ.,1999
46. Лю-Жэн Со. Монгол үндэстний товч түүх. Хөх хот.
47. Майдар. Чингис хаан ба Монголын их гүрэн. УБ.,1969
48. Марко Поло. Замын тэмдэглэл. УБ.,1975
49. Монголын эрт, эдүгээгийн хууль цаазын түүхийн сэдэв дэвтэр.
Хөрвүүлсэн Б.Баярсайхан. УБ.,2002
50. Монголын нууц товчоо. УБ.,1990
51. Монголын нууц товчоо. УБ.,2004
52. Монголын хаад болон Хятадын түүх. Тайпэй. 1992
53. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил.
(МЭӨ III-МЭ XX зуун). УБ.,1995
54. Монгол улсын түүх. Дэд боть. УБ.,2003
55. Монголын түүхийн дээж бичиг. II дэвтэр. УБ.,1992
56. Монгол хууль. УБ.,1997
57. Монголын соёлын түүх. I боть. УБ.,1999
58. Мишел Хаонг. Эзэн хаан Чингис. УБ.,2000
59. Намжил.Х. Чингис хааны засаг ба билэг. Хөх хот. 1990
60. Нацагдорж Ш. Монголын феодализмын түүхэн замнал. УБ.,1978

61. Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ.,1991
62. Нацагдорж Ш. Чингис хааны түүхэн роль. УБ.,1962
63. Неру Ж. Ертөнцийн түүхийг сөхөн үзвэл. УБ.,1987
64. Ням-Осор Н. XIII зууны Монголын нийгэм-эдийн засгийн амьдралд Чингисийн “Их засаг” хуулийн гүйцэтгэсэн түүхэн үүрэг. УБ.,1999
65. Оссон Д. Монголын түүх. Тэргүүн боть. Бээжин. 1962
66. Отаки Мацуэ. Хубилай хаан. Хөх хот.1984
67. Плано Карпини. Монголын түүх. УБ.,1988
68. Пүрэвжав С. Монголын шашны хураангуй түүх. УБ.,1978
69. Пэрлээ Х. Монголын эрт, дундад үеийн хот, суурины товчоон. УБ.,1861
70. Рашид-ад-Дин. Судрын чуулган. I боть. Хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ.,2002
71. Рашид-ад-Дин. Судрын чуулган. II боть. Хөрвүүлсэн Ц.Сүрэнхорлоо. УБ.,2002
72. Рене Груссе. Орчлонг эзэгнэгч Чингис хаан Ч.Баатарын орчуулга. УБ.,2003
73. Саган Сэцэн. Эрдэнийн товч. Бэлтгэсэн Ц.Насанбалжир. УБ.,1961
74. Сайшаал. Чингис хааны товчоон. Тэргүүн дэвтэр. УБ.,2003
75. Сайшаал. Чингис хааны товчоон. Дэд дэвтэр. УБ.,2003
76. Санждорж М. Монгол төрийн түүхээс (XIII-XIX зуун). УБ.,1998
77. Саундерс Ж.Ж. Монголын байлдан дагуулал. Ж.Гэндэндарамын орчуулга. УБ.,1992
78. Суут богд Чингис хааны түүхэн гавьяа. Б.Даш-Ёндонгийн орчуулга. Софи.2003
79. Сэлэнгэ Х. XIII зууны монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл. УБ.,2004
80. Төрийн минь сүлд өршөө /эмхэтгэсэн Д.Самданмөнх, С.Цэдэндамба/. УБ.,2004
81. Чан Чунь бомбо. Баруун газар зорчсон тэмдэглэл.
82. Үлэмжийн Чингис хаан. /Чингис хааны 840 жилийн ойд зориулсан Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын материал/ УБ.,2002
83. Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг дуурсгах тухай Монголын түүхийн эрдэм шинжилгээний ярилцах хурлын түүвэр. Хөх хот.1962
84. Чингис хааны цэргийн арга ухаан. УБ.,1993
85. Чжоу Яотин. Чингис хааны түүх шастир. УБ.,2002
86. Шагдар Х. Монголчуудын аян дайн цэргийн урлагийн түүх /XIII зуун/ УБ.,2000
87. Шаравнямбуу Цэдэнжанов. Богд Чингис хаан. УБ.,1991
88. Уолкер С.С. Чингис хаан. УБ.,2001

Орос хэлээр

89. Армянские источники о монголах. М.,1962
90. Ахмедов Б.А. Государство кочевых узбеков. М.,1965
91. Бартольд В.В. История культурной жизни Туркстана. Л.,1927

92. Бартольд В.В. Туркстан в эпоху монгольского нашествия. Ч. II. Исследование. СПб. 1900
93. Березин Н.И. Очерк внутреннего устройства улуса Джучева. ТВО. УШ. СПб. 1864
94. Березин Н.И. Нашествие Батые на Россию. ЖМНП. 1855
95. Березин Н.И. Первое нашествие монголов на Россию ЖМНП. 1853
96. Бичурин И.Я. История первых четырех ханов из дома Чингисова. СПб. 1829
97. Бороздин Н.Н. Столица Золотой орды-Старый Крым. Татарская Культура XIII-XIV вв. 1917
98. Ванан Ю.В. Феодалная Корея в XIII-XIV вв. М., 1965
99. Владимирцов Б.Я. Чингис хаан. М., 1922
100. Владимирцов Б.Я. Общественный строй Монголов. Монгольский кочевой феодализм. Л., 1934
101. Греков Б.Д. и Якубовский А.Ю. Золотая Орда /Очерк истории улуса Джучи в период сложения и расцвета в XIII-XIV вв./ 1937
102. Греков Б.Д. и Якубовский А.Ю. Золотая орда и её падение. М., 1998.
103. Гумилев Л.Н. Поиски вымышленного царства. М., 1990
104. Гумилев Л.Н. Русский разлив. Т. I. М., 1996
105. Далай Ч. Монголия в XIII-XV веках. М., 1983
106. Доржи Банзаров. Монгольский мир Человеческое лицо в истории. Улан-Уде. 1992
107. Дугин А. Основы геополитики. М., 2000
108. Кара Дорж. Книги монгольских кочевников. М., 1972
109. Кафаров С. Старинное Монгольское предание Чингис хане. 1866
110. Киселев С.В. Древняя история Южной Сибири. М., 1951
111. Лед фер. Татарское нашествие Венгерские связи с международными событиями. Будапешт. 1953
112. Милый Ангел. Рассветное познание восточного Шейха. М., 1997
113. Мир Льва Гумилева. Русский разлив Т.2. М., 1996
114. Мункуев Н.Ц. Китайский источник о первых монгольских ханах. М., 1965
115. Мункуев Н.Ц. К вопросу об экономическом положении Монголии и Китая в XI-XIX вв. КСИНА. №76. М., 1965
116. Мункуев Н.Ц. Об экономическом положении Монголии и Китая. /Краткие сообщения/ института Народов Азии. 1965, №76
117. Насонов А.Н. Татары и роль /история татарской политики на Руси/ М-Л. 1940
118. Оссон К.Д. История монголов от Чингиз-хана до Тимурлена. Иркутск. 1937

119. Патканов К. История монголов инокса Магаки XIII в. СПб. 1871
120. Патканов К. История монголов по армянским источникам. СПб. 1873-1874
121. Петрушевский И.П. Земледелие и аграрные отношения в Иране XII-XIV веков. МЛ.1960
122. Плато Карпини. История монголов-Вильгельм Рубрук. Пертешествие в восточные страны. 1911
123. Рашид-ад-Дин Сборник летописей. Т.I, II. М-Л.1946-1960
124. Рашид-ад-Дин Сборник летописей. Т.III. М.,1946
125. Рене Грусс. Чингис хан. М.,1958
126. Рязановский.В.А. Монгольское право. Харбин. 1931.
127. Рязановский.В.А. Великая Яса Чингис-хана. Харбин. 1933
128. Саблуков.Г.С. Очерк внутреннего состояния кипчакского Царства. ИКУ-УП. 1895
129. Тизенгаузен В.Г. Сборник материалов, относящихся к истории золотой Орды. I, II. Икчлечения и сочинений арабских. СПб. 1884
130. Татаро-монголы в Азии и Европе. М.,1977.
131. Тихвинский С.А. Татар-монгольские завоевания В Азии и Европе. М.,1970
132. Успенский Ф.Н. Византийские историки о Монголах и Египетских мамлюках. Византийский Временник XIV Л.,1926
133. Фернан Гренерь Чингис хань. София. 1936
134. Якубовский А.Ю. Феодализм на востоке. Стоица Золотой орды Сарай Берке. Л.,1932
135. Эрэнджен Хара-Даван. Русь Монгольская. Чингис хан их Монгол сфера. Аграф. М.,2002

Дорно дахины хэлээр

А.Хятад хэлээр

136. Ван Говэй. “Мэн-гу као” /монголын судалгаа/ ҮИ боть
137. Ван Чжи-лай. “Чжун-Я шиган /Дундат азийн түүхийн тойм/”. Чанша.1986
138. Кэ Шаоминь. “Синь Юан-ши” /Юан улсын шинэ түүх/ Шанхай.1928
139. “Мин-ши” /Мин улсын түүх/. Шанхай.1959
140. “Мэн-да-бэй-лу” /Монгол татарын бүрэн тэмдэглэл/ Шанхай.1927
141. “Мэн-гу-ди-гаши” /Монголын эзэнт улсын түүх/ Бээжин.1989
142. Пэн-Дая, Сюйтин. “хэйда Ши Люе” /Хар татарын хэргийн тэмдэглэл/
143. “Сун ши” /Сун улсын түүх/ Бээжин. 1957.
144. Ту Цзи. “Мэнгуэр ши цзи” /Монголын түүхийн тэмдэглэл/

145. Чжоу Лянь Сяо. “Ху-би-лэ” /Хубилай/. Чанчунь.1986
 146. “Чэн-Жи-Сихан чжуан” /Чингис хааны намтар/ Тайбэй.1983
 147. “Чэн-Чжи-хан янь цзювэнь-цзи” /Чингис хааны судлалын түүвэр/ Хөх хот. 1991
 148. “Юан-Чао-ши” /Юан төрийн түүх/ Бээжин. 1986
 149. “Юань ши” /Юан улсын судар/ Шанхай-Бээжин. 1935
 150. Ян на “Шицзэ Чжэнфу чжэ” /Дэлхийг байлдан дагуулагч/ Бээжин.1997

Б.Япон, Солонгос хэлээр

151. Вада Сей. “Тао ши Кэнкюү” /Моокохэн/ /Дорнод Азийн судалгаа.
 Монголын бүлэг/ Токио.1959
 152. “Дай монгору тэйкоку” /Их монголын эзэнт улс/ 1967
 153. Ивамура Шинобу. “Монгору шякай Кэйзайши но кэнкюү”
 /Монголын нийгэм, эдийн засгийн түүхийн судалгаа/ Киото.1968
 154. Ивамура Шинобу. Кафуджи Такэши. “Дай монгору тэйкоку” /Их монголын эзэнт улс/
 155. Осаке Широ. Чингис хаан. Токио. 1941
 156. Сагууру Тоору. “Монголын эзэнт улс ба Төмөрийн улс”
 Ямакава Шюппиашя. 1987
 157. Сүгляма Масоаки. “Монголын эзэнт улсын мандал, буурал” Кеодашия. 1996
 158. Сүгляма Масоаки. “Их Монголын ертөнц” Кадока. Шетэй.1992
 159. Уймаймото Сэтайзу. Чингис хаан. Мүгдэн.1943
 160. Хонда Минобу. “Мокоши кэнкюү” /Монгол гүрний үеийн түүхийн судалгаа/
 Токио. 1970
 161. Янай Ватару. “Мокоши кэнкюү” /Монголчуудын түүхийн судалгаа/
 Токио.1970
 162. “Коре-са” /Корейн түүх/ Солонгос хэлээр. Пеньян.1973

Өрнө дахины хэлээр

В.Англи хэлээр

163. Boule J.A. (tr.) ‘Ata Malik Juvainni, The History of the Word Conqueror,
 2 vols. Manchester,1958.
 164. The thirteenth-century Mongol’s conception of the after life: the evidence of
 their finery practices. Mongolian Studes 1. 1974,5-14. Reprinted on Boyle,
 The Mongol World Empire.
 165. The Mongol World Empire 1206-13706 London.,1977. – Bretschneider.E.
 Mediaval Researches from Eastern Asiatic Sources, 2 vols. London,1888.

166. The role of the Sino-Mongolian Frontier zone on the rise of Chiggis-Qan. In Schwarz H.G. (ed.) *Studeis on Mongolia: Proceeding of the First North American Conference on Mongolian Studeis*. Bellingham., Washington, 1979. 63-76.
167. *Papal Envoys to the Great Khans*. London, 1971.
168. Some remarks on the ideological foundations of the Chinggis Khan's empire. *Papers in Far Eastern History*. 7. 1973. 21-36.
169. Fennel J.L.I. *The Crisis of Medievel Russia 1200-1304*. London, 1983.
170. Fox R. *Genghis Khan*. London, 1936
171. Halperin C.J. *Russia in the Mongol Impire in comparative*. *Harvard Journal of Asiatic Stugeis* 43/1. 1983. 239-61
172. Hambus L. *Cengis-Khan*. Paris, 1973.
173. Hambly G. (ed.) *Central Asia*. London, 1969
174. B.Ahmedov revised by D.Sinor. "Central Asia under the rule of Chinggis khan successors". "History of Civilizations of Central Asia". IV боть, тэргүүн дэвтэр. UNESCO, 1998.
175. "Word book". *Encyclopedia*. A Scott Fetzer company. Chicago, London, Sydney, Toronto, 1995. боть 13, 719-724-р тал.
176. *The Rise of Chingis Khan and his Conquest of North China*. Baltimore, 1950.
177. *The Mongols in Syria, 1260-1300*. In Edbury P.W. /ed./ *Crusade and Settlement*. Cardiff, 1985. 231-5.
178. *The 'Great Yasa of Chingis Khan' and Mongol law in the Ilkhanate*. *Bulletin of the School of Oriental and African Students* 49/1. 1986. 163-76.
179. Mostaert A. and Cleaves F.W. *Les Lettres de 1289 et 1305 des ilkhans Argun et Oljeitu a Philippe le Bel*. Cambridge, Mass., 1962.
180. *Histoire des Campagnes de gengis khan, Cheng-wu tsin-tscheng-Lon*, trad, et annot, par P.Pelliot, L.Hambis. t.1. Leiden, 1951.



ИШИЙН ДАШНЯМ

МОНГОЛ УЛСЫН ТӨР, ЭРХ ЗҮЙН ТҮҮХ

Тэргүүн боть

/МЭӨ 209-МЭ XIII зууны дунд үе/

Редактор:

**Ж.Амарсанаа /Академич /
Ж.Болдбаатар /Академич /
О.Амархүү /Доктор (Sc.D) /
Ц.Сарантуяа /Доктор (Ph.D)/
Б.Баярсайхан /Доктор (Ph.D)/**

Хэвлэлийн дизайнер:

Г.Ганбаатар

Оператор:

Л.Эрдэнэ-Оюун

Өрөлтөд: 2005.10.20

Хэвлэлтгэд: 2005.11.02

Цаасны хэмжээ: B5

Хэвлэлийн хуудас: 45,9

Хэвлэсэн хувь: 1200

**“Хөх судар принтинг“ ХХК-ий хэвлэх
үйлдвэрт эхийг бэлтгэж хэвлэв.**

Улаанбаатар хот 2005 он